

ШҮҮЛТ

БУРХАНЫ ГЭРЭЭС ЭХЭЛДЭГ

ТӨГС ХҮЧИТ БУРХАНЫ ЧУУЛГАН

ӨМНӨХ ҮГ

Хэдийгээр олон хүн Бурханд итгэдэг ч Бурханд итгэх итгэл гэж юу болохыг, Бурханы хүсэлд нийцэхийн тулд юу хийх ёстойгоо цөөн хүн л ойлгодог. Яагаад гэвэл, хүмүүс “Бурхан” гэх үг, “Бурханы ажил” гэх мэт хэлцийг мэддэг боловч Бурханыг мэддэггүй, Бурханы ажлыг бүр ч мэддэггүй. Тэгэхээр, Бурханыг мэддэггүй тэр бүх хүн будилсан итгэлтэй байдагт гайхах зүйлгүй юм. Бурханд итгэх нь тэдний хувьд хэтэрхий танил бус, хэтэрхий танил бус учраас хүмүүс Бурханд итгэх итгэлийг нухацтай авч үздэггүй. Ийм байдлаар тэд Бурханы шаардлагад нийцдэггүй. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүс Бурханыг мэддэггүй, Түүний ажлыг мэддэггүй бол Бурханаар ашиглуулахад тохирохгүй, Бурханы хүслийг хангаж бүр ч чадахгүй. “Бурханд итгэх итгэл” гэдэг нь Бурхан байдаг гэдэгт итгэх явдал; энэ нь Бурханд итгэх итгэлийн хамгийн энгийн ухагдахуун юм. Үүнээс гадна, Бурхан байдаг гэж итгэх нь үнэхээр Бурханд итгэхтэй адилгүй; харин ч энэ нь шашны өнгө аяс ихтэй энгийн итгэл билээ. Бурханд итгэх жинхэнэ итгэл гэдэг нь Бурхан бүх зүйлийг захирдаг хэмээх итгэлд үндэслэн Бурханы үг ба ажлыг туулж, завхарсан зан чанараасаа ангижирч, Бурханы хүслийг хангаж, Бурханыг мэдэж авна гэсэн үг юм. Ийм төрлийн аяныг л “Бурханд итгэх итгэл” хэмээн нэрлэж болно. Гэсэн ч хүмүүс Бурханд итгэх итгэлийг ихэвчлэн энгийн, хөнгөн хийсвэр асуудал гэж үздэг. Бурханд ийм маягаар итгэдэг хүмүүс Бурханд итгэхийн утга учрыг алдсан байдаг бөгөөд эцсээ хүртэл үргэлжлүүлэн итгэлээ ч гэсэн, Бурханы сайшаалыг хэзээ ч хүртэж чадахгүй, учир нь тэд буруу замаар алхаж байдаг. Өнөөдөр ч гэсэн бичиг үсгийн дагуу, хоосон сургаал дотор Бурханд итгэдэг хүмүүс бий. Өөрсдөд нь Бурханд итгэх итгэлийн мөн чанар байхгүй гэдгийг тэд мэддэггүй бөгөөд Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй. Гэсэн ч амар амгалангийн ерөөл болон арвин их нигүүлслийн төлөө Бурханд залбирсаар байдаг. Бүгдээрээ түр зогсоод, зүрх сэтгэлээ тайван байлгаж, өөрсдөөсөө ингэж асууцгаая: Бурханд итгэх нь үнэхээр газар дэлхий дээрх хамгийн амархан зүйл юм гэж үү? Бурханд итгэнэ гэдэг Бурханаас их нигүүлслийг хүлээн авахаас цаашгүй юм гэж үү? Бурханд итгэдэг боловч Түүнийг мэддэггүй, Бурханд итгэдэг ч Түүнийг эсэргүүцдэг хүмүүс Бурханы хүслийг үнэхээр хангаж чадна гэж үү?

Бурхан, хүн хоёрыг эн тэнцүү мэт ярьж болохгүй. Түүний мөн чанар болон ажил нь хүний хувьд хамгийн ойлгошгүй, мэдэхэд бэрхтэй юм. Хэрвээ Бурхан хүний ертөнцөд биечлэн Өөрийн ажлыг хийж, Өөрийн үгийг хэлээгүй бол хүн

Бурханы хүслийг хэзээ ч ойлгож чадахгүй байх байлаа. Тэгвэл бүхий л амьдралаа Бурханд зориулсан хүмүүс хүртэл Түүний сайшаалыг хүртэж чадахгүй байх байв. Хэрвээ Бурхан ажиллаж эхлэхгүй бол хүн хэчнээн сайн ажиллалаа ч гэсэн, бүгд хий дэмий болно, учир нь Бурханы бодол үргэлж хүний бодлоос дээгүүр байх ба Бурханы мэргэн ухааныг хүн ойлгошгүй билээ. Иймээс Бурханыг болон Түүний ажлыг “бүрэн ойлгодог” гэж хэлдэг хүмүүс бол чадваргүй хүмүүс гэж Би хэлдэг; тэд бүгд биеэ тоосон, мунхаг байдаг. Хүн Бурханы ажлыг тодорхойлох ёсгүй; түүнчлэн, хүн Бурханы ажлыг тодорхойлж чадахгүй. Бурханы нүдээр бол хүн шоргоолж шиг өчүүхэн юм; тэгэхээр хүн яаж Бурханы ажлыг ойлгож чадах юм бэ? “Бурхан ингэж, тэгж ажилладаггүй”, эсвэл “Бурхан ийм, тийм” хэмээн чалчих дуртай хүмүүс биеэ тоосон байдалтай ярьж байгаа бус уу? Махан биетэй хүнийг Сатан завхруулсан гэдгийг бид бүгд мэдэх ёстой. Бурханыг эсэргүүцэх нь хүн төрөлхтний уг чанар юм. Хүн төрөлхтөн Бурхантай эн зэрэгцэж чадахгүй, Бурханы ажилд зөвлөгөө өгч бүр ч чадахгүй. Бурхан хүнийг хэрхэн залж чиглүүлдгийн тухайд бол, энэ нь Бурханы Өөрийн ажил юм. Хүн ийм, тийм гэсэн үзэл бодол илэрхийлэлгүйгээр захирагдах ёстой, учир нь хүн бол тоос шороо төдий билээ. Нэгэнт бид Бурханыг эрж хайхаар зорьж байгаа тул Бурханыг бодолцож үзэг гэсэндээ Бурханы ажилд өөрсдийн үзлийг нэмэх ёсгүй, тэр ч байтугай Бурханы ажлыг зориуд эсэргүүцэхийн тулд завхарсан зан чанараа чадлынхаа хэрээр ашиглах ёсгүй. Тэгвэл бид антихристүүд болох бус уу? Тийм хүмүүс яаж Бурханд итгэж чадах юм бэ? Бид Бурхан байдаг гэдэгт итгэдэг, Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүнийг харахыг хүсдэг учраас үнэний замыг эрэлхийлэх ёстой ба Бурхантай нийцэлтэй байх замыг хайх ёстой. Бид Бурханыг зөрүүдлэн эсэргүүцэж зогсох ёсгүй. Тийм үйлдлээс ямар сайн үр дагавар гарах юм бэ?

Өнөөдөр Бурхан шинэ ажил хийсэн. Чи эдгээр үгийг хүлээн зөвшөөрч чадахгүй байж магад, тэдгээр нь чамд хачин санагдаж магад боловч төрөлхийн чанараа бүү илчил гэж Би чамд зөвлөө, учир нь Бурханы өмнө зөвт байдлын төлөө үнэхээр өлсөж цангадаг хүмүүс л үнэнийг олж авч чадах ба үнэхээр үнэн сүсэгт хүмүүсийг л Бурхан гэгээрүүлж, залж чиглүүлж чадна. Хэрүүл маргаанаар биш, тайван тогтуунаар үнэнийг эрж хайснаар үр дүнд хүрдэг. “Өнөөдөр Бурхан шинэ ажил хийсэн” гэж Би хэлэхдээ Бурхан махбодод эргэн ирсэн явдлыг хэлж байгаа юм. Магадгүй эдгээр үгийг чи тоодоггүй байх; магадгүй чи тэдгээрийг үзэн яддаг; эсвэл магадгүй асар их сонирхдог байх. Ямартай ч, Бурханы илрэлтийг үнэхээр хүсэн хүлээдэг бүх хүн яаран дүгнэлт гаргахын оронд энэ

баримттай нүүр тулж, няхуур шинжлэн үзэж чадна гэж Би найдаж байна; энэ бол ухаалаг хүний хийх ёстой зүйл юм.

Ийм зүйлийг судалж шинжлэх нь хэцүү биш боловч бид дор бүрнээ энэ нэг үнэнийг мэдэх шаардлагатай байдаг: Бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы мөн чанарыг эзэмшинэ, бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы илэрхийллийг эзэмшинэ. Бурхан махбод болдог тул хийхээр зорьж буй ажлаа авчирна, мөн Бурхан махбод болдог тул Өөрийн юу болохыг илэрхийлж, хүнд үнэнийг авчирч, амь хайрлаж, замыг заан харуулж чадна. Бурханы мөн чанаргүй махбод нь бие махбодтой болсон Бурхан лавтайяа биш; үүнд эргэлзэх зүйл үгүй. Хэрвээ хүн, Бурханы махбод болсон бие мөн эсэхийг судалж шинжлэхээр зорьж байгаа бол Түүний илэрхийлдэг зан чанар, хэлдэг үгээс үүнийг нотлох ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон бие мөн эсэх, үнэн зам мөн эсэхийг нотлохын тулд хүн Түүний мөн чанарт үндэслэн ялган таних ёстой. Иймээс Бурханы махбод болсон бие мөн эсэхийг тодорхойлох гол түлхүүр нь гадаад дүр төрхөөс илүүтэйгээр Түүний мөн чанарт (Түүний ажил, Түүний айлдвар, Түүний зан чанар болон өөр олон талд) оршдог. Хэрвээ хүн Түүний гадаад дүр төрхийг л шинжлээд, үүний үр дүнд мөн чанарыг нь орхигдуулбал хүн харанхуй бүдүүлэг, мунхаг гэдгийг энэ нь харуулдаг. Гадаад дүр төрх нь мөн чанарыг тодорхойлж чадахгүй; түүгээр ч үл барам, Бурханы ажил хэзээ ч хүний үзэлтэй нийцэхгүй. Есүсийн гадаад дүр төрх хүний үзэлтэй зөрчилдөөгүй гэж үү? Түүний төрх байдал болон хувцаслалт жинхэнэ ялгамж чанарынх нь талаар ямар нэг сэжүүр өгч чадаагүй бус уу? Эртний фарисайчууд Есүсийн гадаад дүр төрхийг л харж, хэлсэн үгийг нь үнэн сэтгэлээсээ авч үзээгүйгээс болоод Түүнийг эсэргүүцсэн биш үү? Бурханы илрэлтийг эрж хайдаг ах эгч нар нэг бүр түүхийн эмгэнэлт явдлыг давтахгүй гэж Би найдаж байна. Та нар орчин үеийн фарисайчууд болж, Бурханыг загалмайд дахин цовдлох ёсгүй. Бурханыг эргэн ирэхэд хэрхэн угтан авахаа анхааралтай бодолцон үзэж, хэрхэн үнэнд захирагддаг хүн байх тухай тодорхой мэдэж байх ёстой. Есүс үүл хөлөглөн эргэн ирэхийг хүлээж байгаа хүн бүрийн хариуцлага энэ билээ. Бид сүнсний нүдээ арчиж цэвэрлэн, хэтрүүлэгтэй уран зөгнөлийн үгэнд автахгүй байх ёстой. Бурханы бодитой ажлын талаар бодож, Бурханы бодит талыг харах ёстой. Эзэн Есүс үүл хөлөглөн, та нарын дунд гэнэт бууж ирээд, Өөрийг нь хэзээ ч мэдээгүй, хараагүй, Өөрийнх нь хүслийг хэрхэн биелүүлэхээ мэддэггүй та нарыг авах тэр өдрийг үргэлж хүсэн хүлээж, сэтгэл хөдлөлдөө бүү авт, эсвэл мөрөөдөлдөө бүү умба. Бодитой хэрэг явдлыг бодсон чинь дээр!

Чи судлах зорилгоор, эсвэл хүлээн зөвшөөрөх санаатайгаар энэ номыг нээсэн байж магадгүй; хандлага чинь ямар ч байлаа гэсэн үүнийг дуустал нь уншиж, амархан хойш тавихгүй гэж Би найдаж байна. Магадгүй, эдгээр үгийг уншсаны дараа хандлага чинь өөрчлөгдөнө, гэхдээ тэр нь чиний сэдэл, ойлголтын түвшнээс хамаардаг. Гэвч, чиний мэдэх ёстой нэг зүйл бий: Бурханы үгийг хүний үг болгож болохгүй, хүний үгийг Бурханы үг болгож бүр ч болохгүй. Бурханы ашигладаг хүн бол бие махбодтой болсон Бурхан биш, бие махбодтой болсон Бурхан бол Бурханы ашигладаг хүн биш. Энд мөн чанарын ялгаа бий. Эдгээр үгийг уншсанаа дараа чи тэдгээрийг Бурханы үг гэж биш, зүгээр л хүний олж авсан гэгээрэл хэмээн хүлээн зөвшөөрч магадгүй. Тэр тохиолдолд чи мэдлэггүй байдлаас болж сохорсон байна. Бурханы үг яаж хүний олж авсан гэгээрэлтэй адил байж болох юм бэ? Бие махбодтой болсон Бурханы үг шинэ эрин үеийг эхлүүлж, бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлж, нууцуудыг илчилж, шинэ эрин үед барих чиглэлийг нь хүнд харуулдаг. Хүний олж авсан гэгээрэл нь хэрэгжүүлэлтийн энгийн заавар буюу мэдлэг төдий юм. Энэ нь бүх хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү замчилж, эсвэл Бурханы Өөрийн нууцыг илчилж чадахгүй. Эцсийн эцэст Бурхан бол Бурхан, хүн бол хүн. Бурханд Бурханы мөн чанар байдаг ба хүнд хүний мөн чанар байдаг. Хэрвээ хүн Бурханы хэлсэн үгийг зүгээр л Ариун Сүнсний энгийн гэгээрэл гэж үзээд, элчүүд болон эш үзүүлэгчдийн үгийг Бурханы биечлэн хэлсэн үг гэж авч үзэх юм бол тэр нь хүний алдаа юм. Ямар ч байсан чи хэзээ ч зөв бурууг хольж, өндрийг нам болгож, гүн гүнзгийг өнгөц гэж эндүүрэх ёсгүй; ямар ч байсан чи үнэн гэдгийг нь мэддэг зүйлээ хэзээ ч зориуд няцаах ёсгүй. Бурхан байдаг гэж итгэдэг хүн бүр асуудлыг зөв байр сууриас шинжилж, Бурханы бүтээлийн өнцгөөс Түүний шинэ ажил болон үгийг хүлээн зөвшөөрөх ёстой; эс бөгөөс тэднийг Бурхан таягдан хаяна.

Еховагийн ажлын дараа, Өөрийн ажлыг хүмүүсийн дунд хийхийн тулд Есүс махбод болсон. Түүний ажил тусдаа хэрэгжээгүй, харин Еховагийн ажилд тулгуурласан юм. Энэ нь, Хуулийн эрин үеийг төгсгөснийхөө дараа Бурханы хийсэн шинэ эрин үеийн ажил байв. Үүнтэй адилаар, Есүсийн ажил дууссаны дараа Бурхан дараагийн эрин үеийн ажлаа үргэлжлүүлсэн, учир нь Бурханы бүхий л удирдлага үргэлж урагшилж байгаа. Хуучин эрин үе өнгөрөх үедээ шинэ эрин үеэр солигдох ба хуучин ажил дуусмагц Бурханы удирдлагыг үргэлжлүүлэх шинэ ажил байх болно. Энэ удаад бие махбодтой болсон нь Есүсийн ажил дууссаны дараа Бурхан хоёр дахь удаа бие махбод болсон хэрэг юм. Мэдээж, энэ удаа бие махбодтой болсон нь дангаараа тохиолддоггүй; харин энэ нь

Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үеийн дараах, ажлын гурав дахь үе шат юм. Бурхан ажлын шинэ үе шатыг эхлэх бүрд үргэлж шинэ эхлэл байх ёстой, мөн шинэ эрин үеийг үргэлж авчрах ёстой. Иймээс Бурханы зан чанар, Түүний ажиллах арга зам, ажлын байршил болон Түүний нэрэнд ч гэсэн харгалзах өөрчлөлтүүд гардаг. Тиймээс хүний хувьд, шинэ эрин үе дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдагт гайхах зүйлгүй. Гэхдээ Өөрийг нь хүн хэрхэн эсэргүүцэхээс үл хамааран Бурхан үргэлж Өөрийн ажлыг хийж, бүх хүн төрөлхтнийг урагш хөтөлж байгаа. Есүс хүний ертөнцөд ирэх үедээ Нигүүлслийн эрин үеийг эхлүүлж, Хуулийн эрин үеийг төгсгөсөн. Эцсийн өдрүүдэд Бурхан дахин нэг удаа махбод болсон ба энэ удаа бие махбодтой болохдоо Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн юм. Хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн Хаанчлалын эрин үе рүү хүргэгдэж, Бурханы удирдамжийг биечлэн хүлээн авч чадна. Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Ингээд хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна.

Хэрвээ хүмүүс Нигүүлслийн эрин үед гацаж үлдвэл Бурханы төрөлх зан чанарыг мэдэх нь бүү хэл, өөрсдийн завхарсан зан чанараас хэзээ ч ангижрахгүй. Хүмүүс үргэлж арвин их нигүүлслийн дунд амьдардаг мөртөө Бурханыг мэдэж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах боломжийг өөрсдөд нь олгодог амийн замгүй байдаг бол итгэлдээ Бурханыг үнэхээр олж авч хэзээ ч чадахгүй. Энэ төрлийн итгэл үнэхээр өрөвдөлтэй. Энэ номыг уншиж дуусаад, Хаанчлалын эрин үед бие махбодтой болсон Бурханы ажлын алхам бүрийг туулсан үедээ чи олон жил тээсэн итгэл найдвар чинь эцэстээ биелснийг мэдрэх болно. Одоо л чи Бурханыг үнэхээр нүүр тулан харсан гэдгээ мэдэрнэ; одоо л Бурханы царайг ширтэж, Бурханы хувийн айлдварыг сонсож, Бурханы ажлын мэргэн ухааныг ойлгож, Бурхан хэчнээн бодитой бөгөөд төгс хүчтэй болохыг

үнэхээр мэдэрсэн гэж чамд санагдана. Өнгөрсөн үеийн хүмүүсийн хэзээ ч харж, эзэмшиж байгаагүй олон зүйлийг олж авсан гэдгээ чи мэдэрнэ. Энэ үед чи Бурханд итгэх гэж юу болох, Бурханы хүсэлд нийцэх гэж юу болох талаар тодорхой мэднэ. Мэдээж, хэрвээ чи өнгөрсөн үеийн үзэл бодолтой зууралдаж, хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханы тухай баримтыг голж, эсвэл үгүйсгэвэл юу ч олж авалгүй гар хоосон үлдээд, эцэст нь Бурханыг эсэргүүцсэн гэмтэй гэж хэлүүлнэ. Үнэнийг дуулгавартай дагаж, Бурханы ажилд захирагддаг хүмүүс хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурхан—Төгс Хүчитийн нэрэн дор орно. Тэд Бурханы хувийн удирдамжийг хүлээн авч, илүү их, илүү өндөр үнэнийг олж авч, бас жинхэнэ амьдралыг хүлээн авч чадна. Тэд өнгөрсөн үеийн хүмүүсийн хэзээ ч харж байгаагүй үзэгдлийг харна: “Би өөртэй минь ярьсан хоолойн зүг эргэж хараад долоон алтан дэнгийн суурийг үзэв; долоон алтан дэнгийн суурийн голд нь хөлөө хүрсэн өмсгөлтэй, алтан бүсээр цээжээ бүсэлсэн хүний Хүүгийн дүртэй Нэгэн зогсож байв. Түүний толгой болон үс нь ноос мэт, цас мэт цав цагаан; нүд нь галын дөл мэт; хөл нь зууханд шатааж өнгөлсөн гууль адил; дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэрээр баруун гартаа долоон од барьсан: амнаас нь хоёр талдаа хурц иртэй илд гарсан: царайг нь харвал хурц нар мэт гэрэлтэж байв” (Илчлэл 1:12–16). Энэ үзэгдэл нь Бурханы бүхий л зан чанарын илэрхийлэл бөгөөд Түүний бүхий л зан чанарын илэрхийлэл нь бас энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажлын илэрхийлэл юм. Гэсгээлт, шүүлтийн урсгалд хүний Хүү айлдвараараа дамжуулан төрөлх зан чанараа илэрхийлж, Түүний гэсгээлт, шүүлтийг хүлээн авдаг бүх хүнд хүний Хүүгийн жинхэнэ царайг харах боломж олгодог нь Иоханы харсан хүний Хүүгийн нүүр царайн үнэн зөв дүрслэл юм. (Мэдээж, Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлыг хүлээн авдаггүй хүмүүст энэ бүхэн үзэгдэхгүй.) Хүний хэлийг ашиглан Бурханы жинхэнэ нүүр царайг бүрэн илэрхийлж чадахгүй тул Бурхан Өөрийн жинхэнэ царайг хүнд харуулахын тулд төрөлх зан чанараа илэрхийлэх аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, хүний Хүүгийн төрөлх зан чанарыг ойлгосон бүх хүн нь хүний Хүүгийн жинхэнэ царайг харсан билээ, учир нь Бурхан дэндүү агуу бөгөөд хүний хэлээр бүрэн илэрхийлэх аргагүй. Хүн Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлын алхам бүрийг туулмагцаа дэнгүүдийн дундах хүний Хүүгийн талаар хэлсэн Иоханы үгийн жинхэнэ утгыг мэднэ: “Түүний толгой болон үс нь ноос мэт, цас мэт цав цагаан; нүд нь галын дөл мэт; хөл нь зууханд шатааж өнгөлсөн гууль адил; дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэрээр баруун гартаа долоон од барьсан: амнаас нь хоёр талдаа хурц иртэй илд гарсан:

царайг нь харвал хурц нар мэт гэрэлтэж байв.” Тэр үед чи, маш олон үг хэлсэн энэ эгэл махбод нь хоёр дахь удаа бие махбод болсон Бурхан гарцаагүй мөн гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр мэднэ. Түүнчлэн, хэчнээн их ерөөгдсөнөө үнэхээр мэдэрч, хамгийн хувьтай хүн гэдгээ мэдэрнэ. Чи энэхүү ерөөлийг хүлээн авахыг хүсэхгүй байна гэж үү?

ГАРЧИГ

1. Христийн эхэн үеийн айлдварууд (1-р бүлэг)
2. Христийн эхэн үеийн айлдварууд (2-р бүлэг)
3. Христийн эхэн үеийн айлдварууд (3-р бүлэг)
4. Христийн эхэн үеийн айлдварууд (5-р бүлэг)
5. Христийн эхэн үеийн айлдварууд (15-р бүлэг)
6. Христийн эхэн үеийн айлдварууд (88-р бүлэг)
7. Христийн эхэн үеийн айлдварууд (103-р бүлэг)
8. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (4-р бүлэг)
9. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (5-р бүлэг)
10. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (6-р бүлэг)
11. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (8-р бүлэг)
12. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (10-р бүлэг)
13. Хаанчлалын сүлд дуулал
14. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (12-р бүлэг)
15. Хүмүүс ээ, бүгд баярлан хөөрцгөө!
16. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (26-р бүлэг)
17. Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд (29-р бүлэг)
18. Итгэгчид ямар үзэл бодолтой байх учиртай вэ
19. Ялзарсан хүн Бурханыг төлөөлж чадахгүй
20. Шашны үйлчлэлээс ангижрах ёстой
21. Бурханд итгэхдээ Бурханыг дуулгавартай дагах ёстой
22. Төгс болгуулсан хүмүүст өгөх амлалт
23. Хорон муу хүмүүс гарцаагүй шийтгүүлнэ
24. Хэрхэн Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэх вэ
25. Бурхан хүнийг ашиглах талаар
26. Шинэ эрин үеийн тушаал
27. Мянган жилийн хаанчлал ирчихсэн
28. Бодитой Бурхан бол Бурхан Өөрөө гэдгийг чи мэдэх ёстой
29. Бурханы өнөөдрийн ажлыг мэдэх нь
30. Бурханы ажил хүний төсөөлдөг шиг энгийн үү?
31. Чи Бурханд итгэдэг тул үнэний төлөө амьдрах учиртай

32. Долоон Аянгын Нүргээн—Хаанчлалын сайн мэдээ ертөнц даяар
тархахыг зөгнөж байна
33. Бие махбодтой болсон Бурхан болон Бурханы ашигладаг хүмүүсийн
хоорондох үндсэн ялгаа
34. Бурханд итгэхдээ шашны зан үйлд биш бодит байдалд анхаарлаа
хандуулах ёстой
35. Бурханы өнөөдрийн ажлыг мэддэг хүмүүс л Бурханд үйлчилж болно
36. Бурханы шинэхэн ажлыг мэдэж, Түүний мөрийг дага
37. Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүмүүсийг Бурхан төгс болгодог
38. Бурханд үнэнч зүрх сэтгэлээр дуулгавартай байдаг хүмүүсийг Бурхан
гарцаагүй олж авна
39. Хаанчлалын эрин үе бол үгийн эрин үе юм
40. Бүгд Бурханы үгээр биелдэг
41. Төгс болгуулах хүмүүс цэвэршүүлэлт туулах ёстой
42. Зовлонт шалгалтыг туулснаар л Бурханы хайр татам байдлыг мэдэж болно
43. Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг
44. “Мянган жилийн хаанчлал ирчихсэн” тухай товч яриа
45. Бурханыг мэддэг хүмүүс л түүнд гэрчлэл хийж чадна
46. Петр Есүсийг хэрхэн мэдэж авсан тухай
47. Бурханыг хайрладаг хүмүүс Түүний гэрэлд үүрд амьдарна
48. Ариун Сүнсний ажил ба Сатаны ажил
49. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүст өгөх анхааруулга
50. Чи амилсан хүн мөн үү?
51. Бурханыг мэддэггүй бүх хүн бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм
52. Бурханы ажлын үзэгдэл (1)
53. Бурханы ажлын үзэгдэл (2)
54. Бурханы ажлын үзэгдэл (3)
55. Бие махбодтой болохын нууц (1)
56. Бие махбодтой болохын нууц (2)
57. Бие махбодтой болохын нууц (3)
58. Бие махбодтой болохын нууц (4)
59. Хоёр удаа бие махбодтой болох нь бие махбодтой болохын ач холбогдлыг
гүйцээдэг
60. Гурвал оршин байдаг уу?

61. Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (1)
62. Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (3)
63. Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (4)
64. Чи ирээдүйн үүрэгтээ хэрхэн хандах ёстой вэ?
65. Ерөөлүүдийг та нар юу гэж ойлгодог вэ?
66. Бурханы тухай чиний ойлголт юу вэ?
67. Жинхэнэ хүн байхын утга учир
68. Чи итгэлийн талаар юу мэдэх вэ?
69. Унаж буй навчис үндэс рүүгээ буцахад чи өөрийн хийсэн ёрын муу бүхэндээ харамсана
70. Махан биетэй хэн ч уур хилэнгийн өдрөөс зугтаж чадахгүй
71. Аврагч аль хэдийн “цагаан үүлэн” дээр эргэн ирсэн
72. Сайн мэдээ түгээх ажил нь бас хүнийг аврах ажил мөн
73. Хуулийн эрин үе дэх ажил
74. Золин авралын эрин үеийн ажлын цаад үнэн түүх
75. Бүх хүн төрөлхтөн өнөөг хүртэл хэрхэн хөгжсөнийг чи мэдэх ёстой
76. Нэршил болон ялгамж чанарын талаар
77. Та нар байр суурийн ерөөлийг хойш тавьж, хүнийг аврах Бурханы хүслийг ойлгох ёстой
78. Өөрийн үзлээр Бурханыг хязгаарласан хүн Бурханы илчлэлийг хүлээн авч яахан чадах билээ?
79. Бурханыг болон Бурханы ажлыг мэддэг хүмүүс л Түүнийг сэтгэл хангалуун байлгаж чадна
80. Бие махбодтой болсон Бурханы үйлчлэл ба хүний үүргийн ялгаа
81. Бурхан бол бүх бүтээлийн эзэн
82. Амжилт эсвэл бүтэлгүйтэл нь хүний алхдаг замаас хамаардаг
83. Бурханы ажил ба хүний ажил
84. Бурханы ажлын гурван үе шатыг мэдэх нь Бурханыг мэдэх зам юм
85. Завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон бурханы аврал илүү их хэрэгтэй
86. Бурханы оршдог махбодын мөн чанар
87. Бурханы ажил ба хүний хэрэгжүүлэлт
88. Христийн мөн чанар бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байх явдал юм

89. Хүний хэвийн амьдралыг сэргээж, түүнийг гайхалтай сайхан хүрэх газарт аваачих нь
90. Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно
91. Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно
92. Христтэй нийцдэггүй хүмүүс гарцаагүй Бурханыг эсэргүүцэгчид юм
93. Дуудагддаг нь олон ч сонгогддог нь цөөхөн
94. Чи Христтэй нийцэлтэй байх замыг эрж хайх ёстой
95. Чи Бурханы жинхэнэ итгэгч мөн үү?
96. Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг
97. Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү?
98. Эцсийн өдрүүдийн Христ л хүнд мөнх амийн замыг өгч чадна
99. Хүрэх газрынхаа төлөө хангалттай сайн үйл бэлд
100. Чи хэнд үнэнч вэ?
101. Хүрэх газрын тухай
102. Гурван сануулга
103. Гэм буруу нь хүнийг там руу хөтөлнө
104. Бурханы зан чанарыг ойлгох нь маш чухал
105. Газар дээрх Бурханыг хэрхэн мэдэх вэ
106. Тун ноцтой асуудал: Урвалт (1)
107. Тун ноцтой асуудал: Урвалт (2)
108. Та нар үйл хэргээ бодолцож үзэх учиртай
109. Бурхан бол хүний амийн эх сурвалж
110. Төгс Хүчитийн санаа алдалт
111. Бурханы илрэлт шинэ эрин үеийг авчирсан
112. Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг
113. Бурханыг мэдэх нь Бурханаас эмээж, муугаас зайлах зам юм
114. Бурханы шүүлт, гэсгээлтээс илрэлтийг нь харахуй

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (1-Р БҮЛЭГ)

Сионы магтаалын өдөр ирж, Бурханы оршин суудаг газар гарч ирлээ. Бүх ард түмний магтдаг суу алдарт ариун нэр түгж байна. Ай, Төгс Хүчит Бурхан минь! Орчлон ертөнцийн Тэргүүн, эцсийн өдрүүдийн Христ. Тэр бол бүхий л орчлон ертөнцийн дээр сүр жавхлантай, эрхэмсгээр сүндэрлэдэг Сион уулнаа мандсан гэрэлт Нар билээ...

Төгс Хүчит Бурхан минь! Бид Таныг баяр хөөртэйгөөр дууддаг; бид бүжиглэж, дуулдаг. Та бол үнэхээр бидний Золин Аврагч, орчлон ертөнцийн агуу Хаан! Та бүлэг ялагчийг бий болгож, Бурханы удирдлагын төлөвлөгөөг биелүүлсэн. Бүх ард түмэн энэ уул руу цуварна. Бүх ард түмэн сэнтийн өмнө сөгдөн мөргөнө! Та бол цорын ганц жинхэнэ Бурхан бөгөөд алдар, хүндлэл хүртэх эрхтэй билээ. Бүх алдар, магтаал, эрх мэдэл сэнтийд байх болтугай! Амийн булаг сэнтийгээс урсан гарч, Бурханы үй олон ардыг усалж, тэжээдэг. Амь өдөр бүр өөрчлөгддөг; шинэ гэрэл, илчлэлүүд биднийг дагаж, Бурханы тухай шинэ гүнзгий ойлголтыг байнга өгдөг. Бид туршлагын дунд Бурханы талаар бүрэн итгэлтэй болдог. Түүний үг байнга ил болж, зөв хүмүүс дотор илэрдэг. Бид үнэндээ маш их ерөөгдсөн! Өдөр бүр Бурхантай нүүр тулан уулзаж, бүх зүйл дээр Бурхантай ярилцаж, бүх зүйлийг удирдах дээд эрхийг Бурханд өгдөг. Бид Бурханы үгийг сайтар тунгааж, зүрх сэтгэл маань Бурханы дотор тайван болдог, ийм маягаар бид Бурханы өмнө очиж, тэндээс Түүний гэрлийг хүлээн авдаг. Бид өдөр бүр амьдрал, үйлдэл, үг яриа, бодол, санаа бүртээ Бурханы үг дотор амьдарч, цаг ямагт ялган таньж чаддаг. Бурханы үг чадварлагаар залж чиглүүлдэг; санамсаргүй байхад л дотор нуугдсан зүйлс ээлж дараалан ил гарна. Бурхантай нөхөрлөх нөхөрлөлд алгуурлахыг тэвчдэггүй юм; Бодол, санаануудыг маань Бурхан ил болгодог. Хором бүрд бид өөрсдийнхөө шүүлтэд ордог газар болох Христийн суудлын өмнө амьдарч байна. Бидний бие доторх хэсэг бүрийг Сатан эзэмдсэн хэвээр байдаг. Өнөөдөр, Бурханы дээд эрхийг сэргээхийн тулд Түүний сүмийг цэвэрлэх ёстой. Бурханаар бүрэн эзэмдүүлэхийн тулд бид үхэх сэхэхээ үзэн тэмцэх ёстой. Хуучны бид цовдлогдсон цагт л дахин амилсан Христийн амь мандан бадрах болно.

Одоо, Ариун Сүнс бидний сэргэлтийн төлөө тулаан хийхийн тулд булан тохой бүр лүү маань довтлон дайрдаг! Бид өөрсдийгөө үгүйсгэхэд бэлэн байж, Бурхантай хамтран ажиллахыг хүсэж байгаа цагт Бурхан биднийг дотроос

маань үргэлж гэрэлтүүлэн ариусгаж, Сатаны эзэмшсэнийг шинээр сэргээх нь гарцаагүй, ингэснээр Бурхан биднийг аль болох хурдан бүрэн төгс болгож болох юм. Цагаа бүү үр, хором бүрд Бурханы үг дотор амьдар. Ариун хүмүүсийн хамт өсөн хөгжиж, хаанчлалд хүргэгдэж, Бурхантай хамт алдар луу ор.

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (2-Р БҮЛЭГ)

Филадельфийн чуулган хэлбэрээ олсон нь бүхэлдээ Бурханы нигүүлсэл, өршөөлийн ач юм. Үй олон ариун хүмүүсийн зүрх сэтгэлд Бурханыг гэх хайр бий болж, тэд сүнслэг замаараа гуйвж дайвалгүй алхдаг. Цор ганц жинхэнэ Бурхан махбод болсон бөгөөд Тэр бол бүх зүйлийг захирдаг орчлон ертөнцийн Тэргүүн гэсэн итгэлээ тэд бат баримталдаг: Үүнийг Ариун Сүнс баталгаажуулсан бөгөөд энэ нь уулс мэт хөдөлшгүй үнэн юм! Мөн энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй!

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Өнөөдөр Та бидний сүнслэг нүдийг нээж, сохор нь харж, доголон нь алхаж, уяман өвчтөн нь эдгэх боломж олгосон. Та тэнгэрийн цонхыг нээж, бидэнд сүнсний ертөнцийн нууцуудыг ойлгох боломжийг олгосон. Бидэнд Таны ариун үгс шингэж, Сатаны завхруулсан хүн чанараас биднийг аварсан—энэ бол Таны хэмжээлшгүй агуу ажил, Таны хэмжээлшгүй их өршөөл билээ. Бид бол Таныг гэрчлэгч!

Та удаан хугацаанд даруухнаар, чимээгүйхнээр нуугдмал байж ирсэн. Та ахин амилалт, цовдлолын зовлон, хүний амьдралын баяр хөөр, уй гашууг, хавчлага, бэрхшээлийг үзсэн; Та хүний ертөнцийн зовлон шаналлыг туулж, амссан, бас Та эрин үед хаягдсан. Бие махбодтой болсон Бурхан бол Бурхан Өөрөө юм. Бурханы хүслийн төлөө Та биднийг овоолсон өтөг бууцнаас аварч, баруун гараараа биднийг өргөн, нигүүлслээ бидэнд үнэгүй өгсөн. Зовлон шаналлыг үл хайхран, Өөрийн амийг бидэнд оруулсан; цус, хөлс, нулимсаараа Таны төлсөн төлөөс ариун хүмүүс дээр биеллээ олсон. Бид бол Таны уйгагүй хүч чармайлтын үр дүн;^а бид бол Таны төлсөн төлөөс.

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Таны хайр болон өршөөл, Таны зөвт байдал болон сүр жавхлан, Таны ариун агаад даруу байдлаас үүдэн бүх хүн Таны өмнө сөгдөж, үүрд мөнхөд Таныг шүтэн мөргөнө.

Өнөөдөр Та бүх чуулганыг—Филадельфийн чуулганыг—бүрэн төгс болгож, өөрийн 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөгөө хэрэгжүүлсэн. Ариун хүмүүс

а. Эх бичвэрт “үр дүн” гэх хэллэг байдаггүй.

сүнсээрээ холбогдон, хайраар дагалдаж, булгийн эхтэй нэгдэн Таны өмнө даруухнаар захирагдаж чадна. Амийн амьд ус зогсолтгүй урсаж, чуулган дахь бүхий л шавар шавхай, бохир усыг угааж, цэвэрлэн, Таны сүмийг дахин нэгэнтээ ариусгаж байна. Бид бодитой жинхэнэ Бурханыг мэдэж авч, Түүний үгсийн дагуу алхаж, өөрсдийн үүрэг, хариуцлагыг танин мэдэж, чуулганы төлөө өөрсдийгөө зарлагадахын тулд чадах бүхнээ хийсэн. Таны хүслийг саатуулахгүйн тулд бид хором бүрд Таны өмнө тайван байж, Ариун Сүнсний ажлыг анхаарах ёстой. Ариун хүмүүс харилцан бие биеэ хайрладаг бөгөөд заримынх нь давуу тал бусдынхаа алдаа дутагдлыг нөхнө. Тэд цаг ямагт сүнс дотор алхаж, Ариун Сүнсээр гэгээрүүлэгдэж, гэрэлтүүлэгдэж чаддаг. Тэд үнэнийг ойлгосон даруйдаа хэрэгжүүлдэг. Тэд шинэ гэрэлтэй хөл нийлүүлж, Бурханы мөрийг дагадаг.

Бурхантай идэвхтэй хамтран ажилла; Түүнд хяналтыг өгнө гэдэг нь Түүнтэй хамт алхаж буй явдал юм. Бидний бүх санаа, үзэл, бодол, энэ ертөнцийн ээдрээ агаарт утаа мэт замхардаг. Бид Бурханыг сүнсэндээ хаанчлуулж, Түүнтэй хамт алхаж, тэгсэнээрээ ангид оршиж, дэлхий ертөнцийг ялан дийлэх бөгөөд бидний сүнс чөлөөтэй нисэж, чөлөөлөлтөд хүрдэг: Энэ нь Төгс Хүчит Бурхан Хаан болох үеийн үр дүн юм. Бид бүжиглэж, магтан дуулж, магтаалаа өргөж, шинэ дуугаа өргөхгүй байж яаж чадах билээ?

Бурханыг магтах үнэхээр олон зам бий: Түүний нэрийг дуудах, Түүнд ойртох, Түүнийг бодох, залбиран-унших, нөхөрлөх, бодож бясалгах, тунгаах, залбирал болон магтаалын дуу. Эдгээр магтаалын төрөлд таашаал ч бий, тослолт ч бий; магтаалд хүч байдаг, бас ачаа ч байдаг. Магтаалд итгэл байдаг, шинэ ойлголт ч байдаг.

Бурхантай идэвхтэй хамтран ажилла, уялдаатай үйлчилж, нэгд, Төгс Хүчит Бурханы санаа зорилгыг биелүүл, ариун сүнслэг бие болохоор яаравчил, Сатаныг гишгэл, Сатаны хувь заяаг төгсгөл болго. Филадельфийн чуулган Бурханы өмнө өргөгдсөн бөгөөд Бурханы алдраар тунхаглагддаг.

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (3-Р БҮЛЭГ)

Ялгуусан Хаан алдар суут сэнтийдээ заларна. Тэрээр золин авралыг гүйцэлдүүлж, Өөрийн бүх ардыг алдар суутайгаар гарч ирэхэд удирдан хөтөлсөн юм. Тэрээр орчлон ертөнцийг гартаа атгаж, ариун мэргэн ухаан болон сүр хүчээрээ Сионыг барьж, бэхжүүлсэн. Сүр жавхлангаараа Тэр нүгэлт

ертөнцийг шүүдэг; Тэрээр бүх үндэстэн, бүх ард түмэн, газар дэлхий, тэнгис далай хийгээд тэдгээрт буй бүхий л амьд зүйлийг, мөн түүнчлэн садар самууны дарсанд согтогсдыг шүүдэг. Бурхан тэднийг гарцаагүй шүүж, тэдэнд уурсах нь дамжиггүй бөгөөд үүгээр эгшин зуур, сааталгүйгээр шүүлтээ явуулдаг Бурханы сүр жавхлан илчлэгдэнэ. Бурханы уур хилэнгийн гал тэдний жигшүүрт гэмт хэргийг шатааж, хэзээ мөдгүй тэдэнд гай гамшиг тохиолдоно; тэд зугтан зайлах ямар ч арга зам мэдэхгүй, нуугдах ямар ч газаргүй байх ба уйлж, шүдээ хавирна, тэгээд өөрсдөдөө сүйрэл авчирна.

Бурханы ялгуусан хайрт хөвгүүд Сионд үлдэх нь эргэлзээгүй бөгөөд тэндээс хэзээ ч явахгүй. Асар олон ард түмэн Түүний дуу хоолойг анхааран сонсож, үйлдлийг нь нухацтай анхаарах бөгөөд тэдний магтаалын дуу хэзээ ч зогсохгүй. Цорын ганц жинхэнэ Бурхан гарч ирлээ! Бид Түүнд сүнсээрээ итгэлтэй болох бөгөөд Түүнийг ойрхон дагана; хамаг чадлаараа урагш давшиж, дахиж эргэлзэхээ болино. Дэлхийн төгсгөл бидний өмнө дэлгэгдэж байна; чуулганы зөв зохистой амьдрал болон биднийг хүрээлэн буй хүмүүс, юмс, хэрэг явдал одоо ч гэсэн бидний сургуулилалтыг эрчимжүүлж байна. Дэлхий ертөнцийг ихэд хайрладаг зүрх сэтгэлээ буцаан авахаар яаравчилцгаая! Тун их муудсан хараагаа буцаан сайжруулахаар яаравчилцгаая! Хэрээс хэтрэхгүйн тулд хөлөө хорьё. Амаа хамхицгаая, ингэснээр бид Бурханы үгээр амьдарч, өөрсдийн ашиг, алдагдлын төлөө арцалдахаа больж магадгүй юм. Аяа, дэлхий ертөнц болон эд хөрөнгөд шунан дурладгаа зогсоо! Аяа, нөхөр, охид, хөвгүүдтэйгээ зууралдан хоргодохоос өөрсдийгөө чөлөөл! Аяа, өөрсдийн үзэл санаа, атгаг сэжгээс татгалз! Аяа, сэрцгээ; цаг бага байна! Сүнсээрээ дээш хар, дээш хар, Бурханаар удирдуул. Юу тохиолдовч Лотын эхнэр шиг болж болохгүй. Хөсөр хаягдана гэдэг хэчнээн өрөвдөлтэй вэ! Ямар өрөвдөлтэй гээч! Аяа, сэрцгээ!

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (5-Р БҮЛЭГ)

Уулс, гол мөрөн өөрчлөгдөж, ус голдрилоороо урсдаг ба хүний амь газар, тэнгэр шиг удаан оршдоггүй. Зөвхөн Төгс Хүчит Бурхан л үеийн үед үүрд амьдардаг мөнхийн бөгөөд амилсан амь билээ! Бүх зүйл, бүх үйл явдал Түүний гарт байдаг ба Сатан Түүний хөл дор байдаг.

Бурханы урьдчилан тогтоосон сонголтоор өнөөдөр Тэр биднийг Сатаны атганаас аварч байна. Тэр бол үнэхээр бидний Золин Аврагч юм. Биднийг Бурханы амьтай холбохоор зорьж, Христийн мөнхийн, амилсан амийг үнэндээ

бидний дотор урлан хийсээр ирсэн нь бид үнэндээ Түүнтэй нүүр учран, Түүнийг идэж, Түүнийг ууж, Түүнийг эдэлж чадаж болох юм. Энэ бол Бурхан зүрхнийхээ цусаар төлж, амь бие үл хайрлан хийсэн тахил билээ.

Улирлууд салхи, жавар дамжин өнгөрч, амьдралын асар их шаналал, хавчлага, зовлон, дэлхий ертөнцийн асар их үгүйсгэл, гүжирдлэг, засгийн газрын асар их гүтгэлэгтэй нүүр тулан ирж, одовч Бурханы итгэл ч, Түүний шийдэмгий зан ч огт багасдаггүй. Бурханы хүсэл, Бурханы удирдлага болон төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн төлөө чин сэтгэлээсээ биеэ зориулсан Тэр Өөрийн амийг зөнд нь орхидог. Өөрийн бүх үй олон ардын төлөө Тэр биеэ үл хайрлаж, тэднийг болгоомжтой тэжээж, усалдаг. Бид хэчнээн мунхаг, хэчнээн хэцүү байдаг маань хамаагүй, бид зөвхөн Түүний өмнө дуулгавартай байх ёстой ба Христийн амилсан амь бидний хуучин уг чанарыг өөрчилнө... Энэ ууган хөвгүүдийнхээ төлөө Тэр цуцалтгүй хөдөлмөрлөж, нойр хоолоо умартдаг. Хэчнээн олон өдөр, шөнө, хэчнээн шатам халуун, тэсгим хүйтэнд Тэр Сионоос бүх чин сэтгэлээсээ харуулддаг гээч.

Дэлхий ертөнц, гэр орон, ажил болон бүхнийг баяртайгаар, сайн дураараа умартсан, хорвоогийн зугаа цэнгэл Түүнд огт хамаагүй... Түүний амнаас гарсан үг биднийг цохиж, зүрх сэтгэлийн маань гүнд нуугдсан зүйлсийг ил болгодог. Бид үнэмшихгүй байж хэрхэн чадах юм бэ? Түүний амнаас гарсан өгүүлбэр бүр бидний дотор хэдийд ч биелж болно. Түүний нүдэн дээр, эсвэл Түүний нүднээс далд бид юу хийвч Түүнд мэддэггүй, хардаггүй юу ч үгүй, ойлгодоггүй юм Түүнд үгүй. Үнэн хэрэгтээ бидний төлөвлөгөө, зохицуулалтыг эс харгалзан бүгд Түүний өмнө ил гарах болно.

Түүний өмнө суугаад сэтгэлдээ баяр хөөр мэдрэн амгалан тайван байх атал үргэлж хоосон санагдаж, Бурханд үнэхээр өртэйгээ мэдэрдэг: Энэ бол төсөөлшгүй, хүрэх боломжгүй гайхамшиг билээ. Төгс Хүчит Бурхан бол ганц жинхэнэ Бурхан гэдгийг батлахад Ариун Сүнс хангалттай! Энэ бол баараггүй нотолгоо! Энэ бүлгийн бид өгүүлшгүй их ерөөгдсөн! Бурханы нигүүлсэл болон өршөөл байгаагүй бол бид мөхөж, Сатаныг л дагах байсан. Төгс Хүчит Бурхан л биднийг аварч чадна!

Ай! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан минь! Бидний сүнслэг нүдийг нээж, сүнсний ертөнцийн нууцуудыг олж харах боломжийг Та олгосон билээ. Хаанчлалын төлөв хязгааргүй. Хүлээхдээ сонор сэрэмжтэй байя. Тэр өдөр тийм ч хол байж болохгүй.

Дайны гал бургиж, үхэр бууны утаа баагьж, цаг агаар дулаарч, уур амьсгал

өөрчлөгдөж, тахал тархах бөгөөд хүмүүс амьд үлдэх горьдлогогүй, үхэхээс л аргагүй болно.

Ай! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан минь! Та бол бидний дархан цамхаг. Та бол бидний хоргодох газар. Бид Таны жигүүр дор бөөгнөх ба гай гамшиг бидэнд хүрч чадахгүй. Энэ нь Таны бурханлаг хамгаалалт, халамж билээ.

Бид бүгд дуугаа чангалан дуулна: бид магтан дуулж, бидний магтаалын чимээ Сион даяар цуурайтна! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан бидэнд алдар суут хүрэх газрыг бэлдчихсэн. Сэрэмжтэй бай, ай, соргог бай! Хараахан хожигдоогүй байна.

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (15-Р БҮЛЭГ)

Бурханы илрэлт аль хэдийн бүх чуулганд үзэгджээ. Үг хэлж байгаа нь Сүнс билээ, Тэр бол догшрох гал, Түүнд сүр жавхлан бий бөгөөд Тэр шүүж байна; Тэр бол хөлөө хүрсэн дээл өмсөж, цээжээрээ алтан бүс бүсэлсэн хүний Хүү билээ. Түүний толгой ба үс ноос адил цагаан, нүд нь галын дөл адил; хөл нь зууханд улайсгасан цэвэр хүрэл мэт; харин дуу хоолой нь их усны шуугиан мэт байдаг. Түүний баруун гарт долоон од, аманд нь хоёр талдаа иртэй хурц илд байх бөгөөд нүүр царай нь хурцаар гэрэлтэх нар мэт билээ!

Хүний Хүү гэрчлэгдэж, Бурхан Өөрөө ил тод илчлэгдлээ. Бурханы алдар гарч ирэн, аагим халуун нар мэт хурцаар гэрэлтжээ! Бурханы алдар суут нүүр царай нүд гялбам туяарна; хэний нүд Түүн рүү эсэргүүцэн харж зүрхлэх билээ? Эсэргүүцэл нь үхэл рүү хөтөлдөг! Чи зүрх сэтгэлдээ юу ч гэж бодсон, ямар ч үг хэлсэн, эсвэл юу ч хийсэн бай, өчүүхэн төдий ч өршөөл гэж үгүй. Миний шүүлтээс өөр олж авсан зүйлгүй гэдгийгээ та нар бүгд ойлгож, харах болно! Та нар Миний үгийг идэж, уух гэж хичээдэггүй хэр нь Миний бүтээн байгуулалтыг дур зоргоороо тасалдуулж, устгаж байхад Би тэвчээд өнгөрүүлж чадна гэж үү? Би тиймэрхүү хүнд зөөлөн хандахгүй! Зан авир чинь бүр ноцтой доройтвол чи галын дөлд залгиулна! Төгс хүчит Бурхан толгойноосоо өлмий хүртлээ мах, цусны өчүүхэн ч хэсэггүй сүнслэг биед биеллээ олдог. Тэрээр орчлон ертөнцөөс хэтийдэж, гуравдагч тэнгэрт алдар суут сэнтийдээ залран, бүх зүйлийг захирдаг! Орчлон ертөнц болон бүх зүйл Миний гарт бий. Би үг хэлбэл тэр нь биеллээ олно. Би тушаавал тэр ёсоор болно. Сатан Миний хөл дор, ёроолгүй нүхэнд байдаг! Миний дуу гарахад тэнгэр газар өнгөрөн одож, оргүй хоосон болно! Бүх зүйл шинэчлэгдэнэ, энэ бол туйлын зөв, хувиршгүй үнэн. Би дэлхийг

бас бүх муу хүнийг ялан дийлсэн. Би энд суугаад та нартай ярьж байна; чихтэй бүхэн сонсогтун, амьтай бүхэн хүлээн авагтун.

Өдөр хоногууд төгсгөл болно; дэлхий дэх бүх зүйл оргүй хоосон болж, бүх зүйл шинээр төрнө. Үүнийг санагтун! Бүү март! Тэнд ямар ч ойлгомжгүй байдал байх ёсгүй! Тэнгэр газар өнгөрөн одно, гэхдээ Миний үг өнгөрөн одохгүй! Би та нарыг дахин нэг удаа ятгая: Дэмий бүү гүйлд! Сэрцгээ! Гэмшицгээ, аврал ойрхон байна! Би та нарын дунд хэдийн гарч ирж, Миний дуу хоолой сонсогдсон. Миний дуу хоолой та нарт дуулдаж, өдөр бүр та нартай нүүр нүүрээрээ учирдаг бөгөөд өдөр бүр шинэ сэргэг байдаг. Чи Намайг, Би чамайг харсан, Би чамтай байнга ярьдаг, чамтай Би нүүр тулан байна. Гэсэн ч чи Намайг голдог, Намайг мэддэггүй. Миний хонь Миний дуу хоолойг сонсож чадна, гэсэн ч чи тээнэгэлзсээр байдаг! Чи тээнэгэлздэг! Зүрх сэтгэл чинь хатуурч, нүдийг чинь Сатан сохлоод, чи Миний алдар суут нүүр царайг харж чаддаггүй—хэчнээн өрөвдөлтэй вэ! Хэчнээн өрөвдөлтэй вэ!

Миний сэнтийн өмнөх долоон Сүнс дэлхийн өнцөг булан бүрд илгээгддэг ба чуулгануудад хандан яриулахаар Би Өөрийн Элчийг илгээнэ. Би бол зөвт агаад итгэмжит, хүний зүрх сэтгэлийн хамгийн гүнийг шинжилдэг Бурхан билээ. Ариун Сүнс чуулгануудад хандан айлдаж байгаа, энэ бол Миний Хүүгийн дотроос гардаг Миний үг юм; чихтэй бүхэн сонсох ёстой! Амьд бүхэн хүлээн авах ёстой! Тэдгээрийг зүгээр л идэж уу, бүү эргэлз. Миний үгийг дуулгавартай дагаж, анхаардаг бүх хүн асар их ерөөл хүртэнэ! Миний нүүр царайг чин сэтгэлээсээ эрж хайдаг бүх хүн гарцаагүй шинэ гэрэл, шинэ гэгээрэл, шинэ мэдлэг ухаантай болно; бүгд шинэлэг, шинэ байна. Миний үг хэдийд ч чамд үзэгдэж, сүнсний нүдийг чинь нээнэ, ийнхүү чи сүнсний ертөнцийн бүх нууцыг харж, хаанчлал хүмүүсийн дунд байгааг харж чадна. Хоргодох газарт ор, тэгвэл бүх нигүүлсэл болон ерөөл чам дээр ирж, өлсгөлөн тахал чамд хүрч чадахгүй, чоно, могой, бар, цоохор ирвэс ч чамд хөнөөл учруулж чадахгүй. Чи Надтай хамт явж, Надтай хамт алхаж, Надтай хамт алдар луу орно!

Төгс Хүчит Бурхан! Түүний алдар суут бие ил тод үзэгдэж, ариун сүнслэг бие гарч ирсэн, Тэр бол бүрэн төгс Бурхан Өөрөө мөн! Дэлхий ертөнц, бие махбод хоёулаа өөрчлөгдсөн бөгөөд уулан дээрх Түүний хувирал бол Бурханы үнэн бие билээ. Тэр толгойдoo алтан титэм зүүдэг, хувцас нь цав цагаан, цээжээрээ алтан бүстэй ба дэлхий ертөнц болон бүх зүйл Түүний хөлийн гишгүүр юм. Түүний нүд галын дөл адил, хоёр талдаа иртэй хурц илд аманд нь байдаг бөгөөд баруун гарт нь долоон од байдаг. Хаанчлалд хүрэх зам хязгааргүй гэгээлэг,

Түүний алдар мандан гэрэлтэнэ; уулс баяр хөөртэй байж, ус инээн баясаж, нар сар, од эрхэс бүгд зохих зүй тогтлоороо эргэлдэж, ялгуусан эргэн ирэлтээрээ зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гүйцэлдсэнийг зарладаг цор ганц, жинхэнэ Бурханыг угтан авна. Бүгд баяр хөөртэйгөөр дэвхрэн бүжнэ! Хөөрөн баясацгаа! Төгс хүчит Бурхан алдар суут сэнтийдээ заларсан! Дуулцгаа! Төгс Хүчитийн ялгуусан туг далбаа сүр жавхлант, гайхамшигт Сион уулан дээр өндөрт мандлаа! Бүх үндэстэн уухайлж, бүх хүн дуулж, Сион уул баяр хөөртэйгөөр инээж байна, Бурханы алдар манджээ! Би зүүдэндээ ч Бурханы царайг харна гэж огт бодож байгаагүй, гэлээ ч өнөөдөр үүнийг харлаа. Би Түүнтэй өдөр бүр нүүр нүүрээ харан уулзаж, Түүнд зүрх сэтгэлээ нээдэг. Тэр идэж, уудаг бүхнээр харамгүй хангадаг. Амьдрал, үг, үйлдэл, бодол, санаа гээд бүгдийг Түүний алдар суут гэрэл гэрэлтүүлдэг. Тэр замын алхам бүрд хөтөлдөг, аливаа тэрслүү зүрх сэтгэл дээр шүүлт нь нэн даруй буудаг.

Бурхантай хамт идэж, хамт буудаллаж, хамт амьдарч, хамт байж, хамт алхаж, хамт баясаж, алдар, ерөөлийг хамт олж авч, Түүнтэй хамт хааны хэргэмийг хуваалцаж, хаанчлалд хамт оршино—өө, ямар таатай вэ! Өө ямар сайхан бэ! Өдөр бүр нүүр нүүрээ харж, өдөр бүр Түүнтэй үг хэлэлцэж, байнга ярилцаж, өдөр бүр шинэ гэгээрэл, шинэ мэдлэг ухааныг хүртдэг. Бидний сүнслэг нүд нээгдэж, бүхнийг хардаг; сүнсний бүх нууц бидэнд илчлэгдсэн. Ариун амьдрал үнэхээр амарлингуй. Хурдан гүй, бүү зогс, үргэлж урагш тэмүүл, илүү гайхалтай амьдрал урд чинь байна. Чихэрлэг амтанд бүү цад, харин үргэлж Бурхан руу орохоор эрж хай. Тэр бүхнийг хамардаг, элбэг өгөөмөр бөгөөд бидэнд дутагддаг юм бүхэн Түүнд бий. Идэвх санаачилгатайгаар хамтран ажиллаж, Түүн рүү ор, цаашид юу ч урьдынх шигээ байхгүй. Бидний амьдрал ер бусын байх бөгөөд хэн ч, юу ч, ямар ч зүйл бидэнд саад болж чадахгүй.

Ер бусын! Ер бусын! Үнэхээр ер бусын! Бурханы ер бусын амь дотор орших ба бүх зүйл үнэхээр уужуу тайван болдог! Бид дэлхий ертөнц, ертөнцийн юмсаас хэтийдэж, нөхөр, хүүхдүүддээ сэтгэл хоргоддоггүй. Бид өвчин эмгэг, орчны хяналтыг даван гардаг. Сатан бидэнд саад болж зүрхэлдэггүй. Бүх гамшгаас бүрэн ангид болдог. Энэ бол Бурханд хаанчлах боломж олгож буй хэрэг! Бид Сатаныг хөл доороо гишгэлж, чуулганы төлөө гэрчлэлд зогсож, Сатаны муухай царайг бүрэн илчилдэг. Чуулганы бүтээн байгуулалт Христ дотор бий, алдар суут бие гарч ирлээ—энэ нь өргөгдсөн амьдрал билээ!

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (88-Р БҮЛЭГ)

Миний алхаа хэдий хүртэл хурдассаныг хүмүүс ердөө төсөөлж чадахгүй: Хүний ой тойнд багтахааргүй гайхамшиг тохиосон нь энэ юм. Дэлхий ертөнцийн бүтээлээс хойш Миний алхаа үргэлжилж, Миний ажил хэзээ ч зогсоогүй. Орчлон ертөнц бүхэлдээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж, хүмүүс ч бас тогтмол өөрчлөгдөж байна. Энэ бүгд Миний ажил, Миний төлөвлөгөөний хэсэг, тэр ч бүү хэл Миний удирдлагад хамаардаг гэдгийг хэн ч мэдэж, ойлгодоггүй. Намайг Өөрөө та нарт хэлж, та нартай нүүр нүүрээ харан ярилцахад л та нар жаахан мэддэг; өөрөөр бол Миний удирдлагын төлөвлөгөөний төслийг ерөөсөө хэн ч мэддэггүй. Хэний ч өөрчилж чадахгүй Миний агуу хүч чадал, үүнээс ч илүүтэйгээр Миний гайхалтай үйлдэл ийм билээ. Иймээс өнөөдөр Миний хэлсэн зүйл биелдэг, үүнийг зүгээр л өөрчилж болохгүй. Хүний үзэлд Миний тухай өчүүхэн ч мэдлэг байдаггүй—тэр чигтээ л учир утгагүй дэмий яриа байдаг! Өөрсдийгөө ханаж, цадсан гэж бүү бод! Би чамд хэлье, чи үнэхээр болоогүй байна! Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөнөөс та нар ердөө өчүүхэн багыг мэддэг, иймээс та нар Миний хэлэхийг сонсож, хий гэснийг минь хийх ёстой. Бүх зүйл дээр Миний хүслийн дагуу үйлдвэл Миний ерөөлийг лавтай хүртэх болно; итгэдэг хэн ч бай, хүлээн авч чадна, харин итгэдэггүй хэний ч бай төсөөлсөн “оргүй хоосон” өөрт нь биелэх болно. Энэ бол Миний зөвт байдал, түүнээс ч илүүтэйгээр, Миний сүр жавхлан, уур хилэн, бас гэсгээлт билээ. Би хэний ч нэг ч бодол, үйлдлийг өршөөхгүй.

Миний үгийг сонсоод ихэнх хүн айж, санаа зовон духаа үрчийлгэж, салгалан чичирдэг. Би чамд буруу зүйл хийсэн үү? Чи агуу улаан лууны үр сад биш байж болно гэж үү? Чи сайн байх гэж бүр дүр эсгэж байна! Бүр Миний ууган хүүгийн дүр эсгэж байна! Чи Намайг сохор гэж бодоо юу? Намайг хүмүүсийг хооронд нь ялгаж чадахгүй гэж бодоо юу? Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан байна: Би хөвгүүддээ, бас агуу улаан лууны үр сад болох та нарт ингэж хэлдэг. Би бүх зүйлийг тодорхой, өчүүхэн ч алдаа гаргалгүйгээр хардаг. Би хийдэг зүйлээ яахан мэдэхгүй байж болох билээ? Миний хийдэг зүйлс Надад тов тодорхой байна! Би яагаад Өөрийгөө орчлон ертөнц болон бүх зүйлийн Бүтээгч, Бурхан Өөрөө гэдэг вэ? Би яагаад Өөрийгөө хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан гэдэг вэ? Би хүн бүрийн нөхцөл байдлыг сайн мэднэ. Та нар Намайг юу хийх, юу хэлэхээ мэддэггүй гэж бодоо юу? Энэ та нарын санаа тавих зүйл биш—Миний гарт үхэхээс болгоомжил; тэгвэл чи

хохирол амсана. Миний захиргааны зарлиг өршөөдөггүй. Ойлгов уу? Дээрх бүгд нь Миний захиргааны зарлигийн хэсгүүд юм. Урьд нь та нар ойлгоогүй байсан учраас эдгээрийг та нарт хэлсэн өдрөөс эхлэн цаашид ямарваа гэмт хэрэг үйлдвэл залхаан цээрлүүлэх болно.

Одоо Би Өөрийн захиргааны зарлигийг та нарт сонордуулъя (өөр өөр хүмүүст өөр өөр гэсгээлт оноох бөгөөд сонордуулсан өдрөөсөө хүчинтэй):

Би хэлсэндээ хүрдэг, бүх зүйл Миний гарт байдаг: Эргэлзсэн хэн ч бай гарцаагүй хороогдох болно. Ямар ч бодолцох зүйл гэж байхгүй; тэднийг нэн даруй сөнөөж, Миний зүрх сэтгэлээс үзэн ядалтыг үгүй хийнэ. (Хороогдсон хэн ч болов Миний хаанчлалын гишүүдийн нэг биш, Сатаны үр удам байх ёстой гэдэг нь үүнээс хойш баталгаажиж байна.)

Та нар ууган хүүгийн хувиар өөрсдийн байр суурийг хадгалж, үүргээ сайн биелүүлж, бусдын хэрэгт хошуу дүрэхгүй байх ёстой. Та нар Миний удирдлагын төлөвлөгөөнд өөрсдийгөө өргөн барьж, хаа ч явсан Надад сайн гэрчлэл хийж, Миний нэрийг алдаршуулах хэрэгтэй. Ичгүүртэй үйл бүү хий, харин Миний хөвгүүд, Миний ардуудад үлгэр жишээ бол. Хором ч болов цадиггүй бүү бай: Та нар хүн бүрд барлаг шиг бус, ууган хүүгийн хувиар харагдаж, харц дээгүүр урагш алхах, ёстой. Миний нэрийг гутаах биш харин алдаршуулахыг Би та нараас хүсэж байна. Ууган хүү болсон хүмүүс бүхнийг хийж чадахгүй, харин тус бүрдээ өөрийн гэсэн үүрэгтэй. Энэ бол Миний та нарт өгсөн зайлсхийж болохгүй үүрэг хариуцлага. Та нар Миний даалгасан зүйлсийг биелүүлэхэд бүх зүрх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчин чадлаа зориулах ёстой.

Энэ өдрөөс хойш орчлон ертөнц даяар Миний бүх хүү, Миний бүх ардыг хариулах үүргийг биелүүлэх нь Миний ууган хөвгүүдэд оногдох бөгөөд үүнийг биелүүлэхэд бүхий л зүрх сэтгэл, бүхий л оюун ухаанаа зориулж чадаагүй хэнийг ч бай Би гэсгээнэ. Энэ бол Миний зөвт байдал—Би Өөрийн ууган хөвгүүдийг ч өршөөж, зөөлөн хандахгүй.

Хэрэв Миний хөвгүүд, Миний ардууд дунд Миний ууган хөвгүүдийн нэгийг дооглож, доромжилдог хүн байвал Би хатуу шийтгэнэ, учир нь Миний ууган хөвгүүд Намайг төлөөлдөг бөгөөд тэдэнд яаж хандана, Надад бас тэгж хандаж байгаа хэрэг. Энэ бол Миний захиргааны зарлигуудын хамгийн хатуу чанга нь юм. Миний хөвгүүд, Миний ардуудын дунд энэ зарлигийг зөрчсөн хэнд ч бай, Миний зөвт байдлыг хүссэнээрээ хэрэгжүүлэхийг Би Өөрийн ууган хөвгүүдэд зөвшөөрнө.

Намайг өнгөцхөнөөр хардаг; Миний хоол унд, хувцас хунар, нойронд л

анхаардаг; Миний ачааг хайхардаггүй, Миний гадаад хэрэгт л оролцдог, өөрсдийн үүргийг зохистой биелүүлэхэд анхаарал хандуулдаггүй хэнийг ч Би аажмаар хаядаг. Энэ нь чихтэй бүхэнд хамаатай.

Надад үйлчлэл хийж дууссан хэн ч бай, хэл ам гаргалгүй дуулгавартайгаар буцах ёстой. Болгоомжтой бай, эс бөгөөс Би чамайг журамлах болно. (Энэ бол зарлигийн нэмэлт.)

Одооноос Миний ууган хөвгүүд төмөр савааг авч, бүх улс үндэстэн, ард түмнийг захирах Миний эрх мэдлийг хэрэгжүүлж, бүх улс үндэстэн, ард түмний дунд алхаж, Миний шүүлт, зөвт байдал, сүр жавхланг бүх улс үндэстэн, ард түмний дунд хэрэгжүүлж эхэлнэ. Миний удирдлагын төлөвлөгөө биелж, Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилж чаддаг учраас Миний хөвгүүд, Миний ардууд зогсолтгүй Надаас эмээж, Намайг магтаж, Намайг уухайлж, Намайг алдаршуулах болно.

Энэ бол Миний захиргааны зарлигийн нэг хэсэг бөгөөд ажил урагшлахын хирээр дараа нь Би та нарт тэдгээрийг хэлэх болно. Дээрх захиргааны зарлигаас та нар Миний ажлаа хийдэг хурдыг, мөн Миний ажил ямар алхамд хүрснийг харах болно. Энэ бол баталгаа билээ.

Би аль хэдийн Сатаныг шүүсэн. Миний хүсэл саадгүй, бас Миний ууган хөвгүүд Надтай хамт алдрыг олж авсан тул Би Сатанд харьяалагддаг бүх зүйл болон ертөнцөд Өөрийн зөвт байдал, сүр жавхланг аль хэдийн хэрэгжүүлсэн. Би Сатанд анхаарал огт хандуулдаггүй, хуруугаа ч хөдөлгөдөггүй (учир нь тэр Надтай ярих гавьяагүй). Би зүгээр л хийхийг хүссэн зүйлээ хийсээр байдаг. Миний ажил алхам алхмаар төвөггүй урагшилж, Миний хүсэл бүх газарт саадгүй байна. Энэ нь Сатаныг тодорхой хэмжээнд шившиглэж, бүрэн устгасан ч, Миний хүслийг биелүүлээгүй. Би мөн Өөрийн захиргааны зарлигийг тэдэн дээр хэрэгжүүлэхийг Өөрийн ууган хөвгүүдэд зөвшөөрдөг. Нэг талаар, Би Сатанд өөрт нь хандсан уур хилэнгээ харуулдаг; нөгөөтээгүүр Би түүнд Өөрийн алдар сууг харуулдаг (Миний ууган хөвгүүд бол Сатаны доромжлолын хамгийн цангинасан гэрчлэгч нар гэдгийг харуулдаг). Би түүнийг биечлэн шийтгэдэггүй, харин Өөрийн ууган хөвгүүдэд Миний зөвт байдал, сүр жавхланг хэрэгжүүлэх боломж олгодог. Сатан Миний хөвгүүдэд зүй бусаар хандаж, Миний хөвгүүдийг хавчиж, дарладаг байсан учир өнөөдөр түүний үйлчлэл дууссаны дараа Би нас бие гүйцсэн, Өөрийн ууган хөвгүүдэд түүнийг журамлах зөвшөөрөл олгоно. Сатан уналтын эсрэг хүчгүйдсэн. Дэлхий дээрх бүх улс үндэстний зогсонги байдал бол үүний хамгийн сайн гэрч; тулалдаж буй хүмүүс, дайн дажинтай улс

орнууд бол Сатаны хаанчлал нуран унасны илэрхий шинж. Би өмнө нь ямар ч тэмдэг, гайхамшиг үзүүлээгүйн шалтгаан нь Сатаныг шившиглэж, Өөрийн нэрийг алхам алхмаар алдаршуулах гэснийх юм. Сатаныг бүрэн устгасны дараа Би Өөрийн хүчийг үзүүлж эхэлнэ: Миний хэлсэн зүйл биелж, хүний үзэлтэй нийцэхгүй ер бусын зүйлс биелэх болно (энэ нь удахгүй ирэх ерөөлийг хэлж байна). Би бол бодитой Бурхан Өөрөө агаад Надад дүрэм гэж үгүй, Би Өөрийн удирдлагын төлөвлөгөөн дэх өөрчлөлтийн дагуу ярьдаг тул өнгөрсөнд Миний хэлсэн зүйл өнөөдөрт хамаарах албагүй. Өөрсдийн үзэлтэй бүү зууралд! Би дүрэм дагадаг Бурхан биш. Надтай байхад бүх зүйл чөлөөтэй, ер бусын, бас бүрэн чөлөөлөгдсөн байдаг. Магадгүй өчигдөр хэлсэн зүйл өнөөдөр хуучирч эсвэл хөсөр хаягдаж магад (гэвч Миний захиргааны зарлиг тунхаглагдсанаасаа хойш хэзээ ч өөрчлөгдөхгүй). Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний алхмууд юм. Дүрэм журамтай бүү зууралд. Өдөр бүр шинэ гэрэл, шинэ илчлэл байдаг ба тэр бол Миний төлөвлөгөө. Өдөр бүр Миний гэрэл чамд илчлэгдэж, Миний дуу хоолой орчлон ертөнцөд гарах болно. Ойлгов уу? Энэ бол чиний үүрэг, Миний чамд даалгасан хариуцлага. Чи үүнийг хором ч огоорох ёсгүй. Би Өөрийн сайшаадаг хүмүүсийг эцсээ хүртэл ашиглах бөгөөд энэ хэзээ ч өөрчлөгдөхгүй. Би төгс хүчит Бурхан учир ямар хүн юу хийх ёстой, ямар хүн юу хийх чадвартайг мэднэ. Энэ бол Миний бүхнийг чадагч чанар юм.

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД (103-Р БҮЛЭГ)

Аянга мэт нижигнэсэн дуу хоолой гарч, бүхий л орчлонг донсолгодог. Энэ нь хүмүүс замаас нь амжин бултаж чадахааргүй дүлийрүүлэм байдаг. Зарим нь алагдаж, зарим нь устгагдаж, мөн зарим нь шүүгддэг. Энэ бол үнэхээр хэн ч, хэдийд ч хараагүй үзэгдэл юм. Сайн сонс: аянгын нижигнээнийг уйлах дуу дагалдах бөгөөд энэ дуу нь Үхэгсдийн орноос гардаг; тамаас гардаг. Энэ нь Надаар шүүгдсэн тэрслүү хөвгүүдийн гашуун дуу билээ. Миний хэлдгийг сонсоогүй, Миний үгийг хэрэгжүүлээгүй хүмүүс хатуу шүүгдэж, Миний уур хилэнгийн хараалыг хүртсэн. Миний дуу хоолой бол шүүлт ба уур хилэн; Би хэнд ч зөөлөн хандаж, хэнд ч өршөөл үзүүлэхгүй, учир нь Би бол зөвт Бурхан Өөрөө, Би уур хилэн эзэмшдэг, Би бол шатаалт, Би бол цэвэрлэгээ, мөн сүйрлийг эзэмшдэг. Надад нуусан, эсвэл сэтгэл хөдлөх зүйл огт үгүй, харин бүх зүйл ил, зөвт агаад алагчлалгүй юм. Миний ууган хөвгүүд бүх улс үндэстэн, ард түмнийг захиран сэнтий дээр хэдийнээ Надтай хамт байгаа учраас шударга биш, зөвт

бус зүйлс болон хүмүүс одоо шүүгдэж эхлээд байна. Би юуг ч орхилгүй, тэднийг гүйцэд илчлэн, нэг нэгээр нь байцаана. Учир нь, Миний шүүлт бүрэн илчлэгдэж, бүрэн нээлттэй болсон ба Би огт юу ч нуугаагүй; Миний хүсэлд нийцэхгүй бүх зүйлийг Би хаяж, ёроолгүй нүхэнд үүрдийн үүрд мөхөөнө. Тэндээ мөнхөд шатаг. Энэ бол Миний зөвт байдал, энэ бол Миний шударга байдал. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй бөгөөд бүгд Миний тушаал дор байх ёстой.

Ихэнх хүн үг бол ердөө л үг, баримт бол баримт гэж бодон Миний айлдварыг үл ойшоодог. Тэд сохор юм! Би бол итгэмжит Бурхан Өөрөө гэдгийг тэд мэддэггүй гэж үү? Миний үг, баримтууд нэгэн зэрэг тохиолддог. Энэ үнэхээр тийм биш гэж үү? Хүмүүс Миний үгийг ердөө л ухаардаггүй, харин зөвхөн гэгээрсэн хүмүүс л үнэхээр ойлгож чадна. Энэ бол баримт. Хүмүүс Миний шүүлт буух үед байтугай, Миний үгийг хармагцаа ухаан алдталаа айж, нуугдах гэж ийш тийш яаран гүйлддэг. Би бүх зүйлийг бүтээж, дэлхийг устгаж, ууган хөвгүүдийг бүрэн төгс болгох үед энэ бүхэн Миний амнаас гарсан ганц үгээр гүйцэлдсэн. Яагаад гэвэл, Миний үг өөрөө эрх мэдэл, шүүлт юм. Хүн Би бол шүүлт, сүр жавхлан гэж хэлж болно; энэ бол өөрчилж болшгүй баримт юм. Энэ нь Миний захиргааны зарлигийн нэг тал; хүмүүсийг шүүдэг Миний нэг арга зам юм. Миний нүдэнд бол юм бүхэн—бүх хүн, бүх хэрэг явдал, бүх зүйлийг оролцуулаад—Миний гарт, Миний шүүлт дор байдаг. Хэн ч, юу ч дураараа, цадиггүй аашилж зүрхэлдэггүй бөгөөд бүгд Миний амнаас гарах үгийн дагуу гүйцэлдэх ёстой. Хүний үзлээр бол, хүн Миний үгэнд, хүн бүхэн итгэдэг. Миний Сүнс дуу хоолой гаргахад, хүмүүс эргэлздэг. Миний бүхнийг чадагч байдлын талаар хүмүүст өчүүхэн ч мэдлэг байдаггүй бөгөөд Миний эсрэг гүтгэлэг хүртэл хийдэг. Миний үгэнд эргэлздэг хэн ч бай, Миний үгийг басамжилдаг хэн ч бай, тэд бол устгагдах хүмүүс; тэд бол үүрдийн мөхлийн хүүхдүүд юм гэдгийг Би одоо чамд хэлье! Ууган хөвгүүд маш цөөхөн байдаг гэдгийг үүнээс харж болно, учир нь Би ингэж ажилладаг билээ. Би урьд хэлсэнчлэн хуруугаа ч хөдөлгөлгүй бүх зүйлийг гүйцэлдүүлдэг; Би гагцхүү Өөрийнхөө үгийг л ашигладаг. Тэгэхээр энд Миний бүхнийг чадагч байдал оршдог. Миний үгээс Миний хэлэх зүйлийн эх сурвалж, зорилгыг хэн ч олж чадахгүй. Хүмүүс үүнд хүрч чадахгүй бөгөөд зөвхөн Миний удирдлагыг дагахдаа бүхнийг Миний зөвт байдлын дагуу, Миний хүсэлд нийцүүлэн үйлдэн хийж чадсанаар Миний гэр бүлийг зөвт байдалтай, амар тайван байж, үүрд бат, гуйвалтгүй мөнх амьдардаг болгоно.

Миний шүүлт хүн болгонд очиж, Миний захиргааны зарлиг хүн бүрд хүрч, Миний үг ба Миний үнэн бие хүн бүрд илчлэгддэг. Энэ бол Миний Сүнсний агуу

ажлын цаг (энэ үед ерөөгдөх хүмүүс, гай зовлон амсах хүмүүсийг ялган салгана). Миний үг гармагц, Би ерөөгдөх хүмүүс болон гай зовлон амсах хүмүүсийг ялгаж салгачихсан байна. Энэ бүгд тов тодорхой, Би үүнийг бүгдийг нь ганц хяламхийхэд л харж чадна. (Үүнийг Би хүн чанартайгаа холбогдуулан хэлж байна; иймд эдгээр үг нь Миний урьдчилан тогтоож, сонгосонтой зөрчилддөггүй.) Би уул толгод, гол горхи ба бүх зүйлийн дунд, орчлонгийн орон зайгаар газар бүрийг ажиглан, цэвэрлэн хэсүүчилдэг бөгөөд ингэснээр тэдгээр бохир, садар самуун газар нутаг бүгд оршин тогтнохоо больж, Миний үгийн үр дүнд юу ч биш болон чандарлагдана. Надад бүх зүйл хялбархан. Хэрвээ одоо үе нь дэлхийг устгана гэж Миний урьдчилан тогтоосон цаг байсан бол Би үүнийг ганц үгээр л залгих байсан. Гэхдээ одоо үе бол тэр цаг биш. Миний төлөвлөгөөг үймүүлж, Миний удирдлагад саад болохгүйн тулд Намайг энэ ажлыг хийхээс өмнө бүгд бэлэн байх ёстой. Үүнийг хэрхэн ухаалгаар хийхээ Би мэднэ: Надад Миний мэргэн ухаан бий, Надад Миний өөрийн зохицуулалт бий. Хүмүүс хуруугаа ч хөдөлгөх ёсгүй; Миний гарт үхэхээс болгоомжил. Миний захиргааны зарлигт энэ аль хэдийн хүрсэн. Үүнээс хүн, Миний захиргааны зарлигийн хатуу чангыг, мөн тэдгээрийн цаадах хоёр тал бүхий зарчмуудыг харж чаддаг: Нэг талаас, Миний хүсэлтэй нийцдэггүй, Миний захиргааны зарлигийг зөрчдөг бүх хүнийг Би алдаг; нөгөө талаас, Миний захиргааны зарлигийг зөрчдөг бүхнийг Би хилэгнэхдээ хараадаг. Энэ хоёр тал салшгүй бөгөөд Миний захиргааны зарлигийн цаадах гүйцэтгэх зарчмууд юм. Хүн хэчнээн үнэнч байх нь хамаагүй, хүн бүртэй энэ хоёр зарчмын дагуу, ямар ч сэтгэлийн хөдлөлгүйгээр харьцдаг. Газар дэлхийн бүх зүйлийг, ертөнцийн бүх юмыг, мөн Миний хүсэлтэй нийцдэггүй бүх зүйлийг шатаах Миний зөвт байдал, Миний сүр жавхлан, Миний уур хилэнг харуулахад энэ нь хангалттай. Миний үгэнд далдалсан нууц байдаг бөгөөд Миний үгэнд бас илчлэгдсэн нууц байдаг. Иймээс хүний үзлээр бол, Миний үг хүний оюун санаанд хэзээд ойлгогдошгүй, мөн Миний зүрх сэтгэл үргэлж тайлагдашгүй байдаг. Тэгэхээр, Би хүмүүсийг үзэл болон бодол санаанаас нь салгах ёстой. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний хамгийн чухал зүйл. Өөрийн ууган хөвгүүдийг олж авч, хийхийг хүссэн зүйлээ хэрэгжүүлэхийн тулд Би үүнийг ийм маягаар хийх ёстой.

Дэлхийн гай гамшиг өдрөөс өдөрт үлэмж болж, Миний гэрт аюулт гамшгууд улам хүчтэй болж байна. Хүмүүст нуугдах газар, биеэ далдлах газар үнэхээр хаана ч байхгүй. Шилжилт яг одоо явагдаж байгаа учир дараачийн алхмаа хаана өнгөрөөхийг хүмүүс мэддэггүй. Энэ нь Миний шүүлтийн дараа л тодорхой

болно. Санаж яв! Эдгээр нь Миний ажлын алхам бөгөөд Миний ажилладаг арга юм. Би Өөрийн ууган хөвгүүдийг бүгдийг нэг нэгээр нь тайвшруулж, алхам алхмаар өргөнө; үйлчлэл үзүүлэгчийн хувьд гэвэл, Би тэднийг бүгдийг нэг нэгээр нь таягдан хаяж, орхино. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Бүх үйлчлэл үзүүлэгч илчлэгдсэний дараа Миний ууган хөвгүүд ч мөн илчлэгдэнэ. (Миний хувьд, энэ нь хэтэрхий хялбар. Миний үгийг сонссоны дараа тэр бүх үйлчлэл үзүүлэгч Миний үгийн шүүлт ба заналхийлэл дор ухрах бөгөөд зөвхөн Миний ууган хөвгүүд үлдэнэ. Энэ бол сайн дурын зүйл ч биш, хүний хүслээр өөрчилж чадах зүйл ч биш; харин энэ бол Миний Сүнс биечлэн ажиллаж байгаа хэрэг.) Энэ бол алс хэтийн үйл явдал биш бөгөөд та нар Миний ажил болон Миний үгийн энэ үе шатнаас үүнийг зарим нэг хэмжээгээр ойлгож чаддаг байх хэрэгтэй. Би яагаад ийм ихийг хэлдэг, мөн Миний айлдварууд ийм таагдашгүй чанартай байдаг нь хүмүүст ойлгомжгүй юм. Би Өөрийн ууган хөвгүүдтэй тайтгарал, өршөөл болон хайрын өнгөөр ярьдаг (яагаад гэвэл, Би энэ хүмүүсийг үргэлж гэгээрүүлдэг бөгөөд Би тэднийг орхихгүй, учир нь Би тэднийг урьдчилан тогтоосон билээ), харин Би ууган хөвгүүдээсээ бусад хүмүүстэй ширүүн шүүлт, заналхийлэл, сүрдүүлэг хэрэглэн харьцаж, мэдрэлийн төв нь байнга ажилладаг болтол нь тэднийг үргэлж айлгадаг. Нөхцөл байдал тодорхой хэмжээнд солигдоход тэд энэ байдлаасаа зугтана (Намайг дэлхийг сөнөөхөд энэ хүмүүс ёроолгүй нүхэнд байх болно), гэвч тэд хэзээ ч Миний шүүлтийн гараас зугтах юм уу, энэ нөхцөл байдлаас зайлахгүй. Тэгэхээр энэ бол тэдний шүүлт; энэ бол тэдний гэсгээлт. Гаднынхан ирэх өдөр Би энэ хүмүүсийг нэг нэгээр нь илчилнэ. Энэ бол Миний ажлын нэг алхмууд. Өмнө нь Би эдгээр үгийг хэлсний цаад санаа зорилгыг та нар одоо ойлгож байна уу? Миний бодлоор бол биелээгүй аливаа зүйл бол бас биелсэн зүйл, гэвч биелсэн зүйл нь заавал гүйцэлдсэн зүйл байх албагүй. Учир нь Надад Миний мэргэн ухаан, Өөрийн ажиллах арга байдаг ба эдгээр нь хүмүүсийн хувьд ердөө л ухаарахын аргагүй байдаг. Энэ алхмаар үр дүнд хүрчихээд (Намайг эсэргүүцдэг бүх муу хүнийг илчилчхээд) Би дараагийн алхмаа эхлүүлнэ, учир нь Миний хүсэл саад тотгоргүй бөгөөд хэн ч Миний удирдлагын төлөвлөгөөг саатуулж, саад тотгор хийж зүрхэлдэггүй—тэд бүгд замаас зайлах ёстой! Агуу улаан лууны хүүхдүүд ээ, Намайг сонс! Би Өөрийн ууган хөвгүүдийг олж авч, та нарын эцгийг шившиглэж (энэ үгс агуу улаан лууны үр удамд чиглэсэн), Өөрийн ууган хөвгүүдийг дэмжиж, ууган хөвгүүдэд минь хийсэн хилс хэргийг засаж залруулахаар Сионоос ирж, энэ дэлхийд махбод болсон. Иймд дахин бүү зэрлэг

авирла; Би ууган хөвгүүдээрээ та нарын учрыг олуулна. Урьд нь Миний хөвгүүд дээрэлхүүлж, дарлагдсан, харин Эцэг нь хөвгүүдийнхээ төлөө эрх мэдэл эзэмшсэнээс хойш Миний хөвгүүд хайрлан тэврэх тэвэрт минь эргэн ирж, дахин дээрэлхүүлж, дарлагдахгүй. Би бол зөвт бус биш; энэ нь Миний зөвт байдлыг харуулдаг бөгөөд энэ нь үнэхээр “Би хайрладаг хүнээ хайрлаж, үзэн яддаг хүнээ үзэн ядаж” байгаа хэрэг юм. Хэрвээ та нар Намайг зөвт бус гэж хэлдэг бол яаравчлан зайлах хэрэгтэй. Миний гэрт бүү ичгүүргүй авирла, бусдыг бүү завш. Чи гэр лүүгээ хурдан буцах ёстой, ингэснээр Би чамайг дахин харах хэрэггүй болно. Ёроолгүй нүх бол та нарын хүрэх газар бөгөөд та нарын амрах газар. Хэрвээ та нар Миний гэрт байгаа бол та нарт байх газар байхгүй, учир нь та нар бол ачлагын амьтад; Миний ашигладаг багаж юм. Та нар Надад цаашид хэрэггүй болохоор Би та нарыг чандарлахаар галд хаяна. Энэ бол Миний захиргааны зарлиг; Би үүнийг ингэж хийх ёстой; зөвхөн энэ л Миний ажилладаг арга замыг үзүүлдэг бөгөөд Миний зөвт байдал, Миний сүр жавхланг илчилдэг. Үүнээс ч чухал нь, зөвхөн энэ замаар Миний ууган хөвгүүд Надтай хамт эрх мэдэлтэйгээр хаанчилж чадна.

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (4-Р БҮЛЭГ)

Миний өмнө үйлчилдэг Миний бүх ард өнгөрснөө эргэн санах хэрэгтэй: Намайг хайрлах та нарын хайр хольцтой юу? Надад өгсөн үнэнч байдал чинь цэвэр, чин сэтгэлийнх байсан уу? Миний талаарх та нарын мэдлэг үнэн байсан уу? Та нарын зүрх сэтгэлд Би хэр их зай эзэлж байсан бэ? Би зүрх сэтгэлийг чинь бүхэлд нь дүүргэж байсан уу? Миний үг та нарын дотор хэр ихийг биелүүлсэн бэ? Намайг бүү мэхэл! Эдгээр зүйл Надад тов тодорхой байдаг! Өнөөдөр, Миний авралын дуу хоолой айлдаж байхад Намайг хайрлах та нарын хайр жаахан нэмэгдсэн үү? Надад үнэнч байдлын чинь зарим хэсэг цэвэр болсон уу? Миний талаарх та нарын мэдлэг гүнзгийрсэн үү? Өнгөрсөн үеийн магтаал сайшаал өнөөдрийн мэдлэгийн чинь бат бэх суурийг тавьсан уу? Та нарын хэр ихийг Миний Сүнс эзэлдэг вэ? Миний дүр та нарын дотор хэр их зай эзэлдэг вэ? Миний айлдварууд та нарын дотор зорьсондоо хүрсэн үү? Өөрсдийн ичгүүрийг нуух газаргүй гэдгээ та нар үнэхээр мэдэрч байна уу? Та нар Миний ардууд байх эрхгүй гэдэгтээ үнэхээр итгэдэг үү? Хэрвээ та нар дээрх асуултуудыг огт анзаарахгүй байгаа бол булингартай усанд загасчилж, зүгээр л

тоо бүрдүүлж байгааг чинь энэ нь харуулах бөгөөд Миний урьдчилан тогтоосон цагт чи гарцаагүй таягдан хаягдаж, хоёр дахь удаагаа ёроолгүй нүхэнд хаягдана. Энэ бол Миний анхааруулсан үг бөгөөд үүнийг хөнгөн хуумгай авч үзсэн хүмүүс Миний шүүлтэд өртөж, товлосон цагт гай зовлонтой тулгарна. Тийм биз дээ? Үүнийг тайлбарлахын тулд Би бас л жишээ татах хэрэгтэй гэж үү? Та нарыг үлгэр загвараар хангахын тулд Би илүү тодорхой ярих ёстой юу? Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл олон хүн Миний үгэнд дуулгаваргүй хандаж, улмаар Миний дахин сэргээлтийн урсгалаас хаягдаж, таягдуулсан; эцэст нь тэдний бие мөхөж, сүнс нь Үхэгсдийн орон руу хаягдсан бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд хатуу шийтгэлд өртсөөр байгаа. Олон хүн Миний үгийг дагасан боловч тэд Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтийн эсрэг явсан, тиймээс Надад өшиглүүлж, Сатаны эзэмшил дор орж, Намайг эсэргүүцдэг хүмүүс болсон. (Өнөөдөр Намайг шууд эсэргүүцдэг бүх хүн Миний үгийн өнгөн талыг л дуулгавартай дагаж, Миний үгийн мөн чанарт дуулгаваргүй ханддаг.) Мөн өчигдрийн хэлсэн үгийг минь халт сонсож, урьдын “хог новштой” зууралдаж, эдүгээгийн “үр шимийг” эрхэмлэдэггүй олон хүн байсан. Энэ хүмүүс Сатанд олзлогдоод зогсохгүй, мөнхийн нүгэлтнүүд болж, Миний дайснууд болсон ба тэд Намайг шууд эсэргүүцдэг. Тийм хүмүүс бол Миний уур хилэнгийн оргил дахь Миний шүүлтийн байнууд бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд сохор хэвээр байж, харанхуй гяндан дотор байсаар байна (өөрөөр хэлбэл, тийм хүмүүс нь Сатанаар удирдуулсан илжирч, хөшсөн үхдлүүд юм; Би тэдний нүдийг халхалсан учраас тэднийг сохор гэж хэлдэг). Та нарт лавлагаа болох жишээ татаж өгсөн нь дээр, тэгвэл та нар үүнээс суралцаж чадна:

Паулын талаар дурдахад л та нар түүний түүхийг болон түүний талаарх алдаа мадагтай, бодит байдалд нийцэхгүй зарим үйл явдлыг санана. Тэр багаасаа эцэг эхээрээ заалгаж, Миний амийг хүлээн авсан бөгөөд Миний урьдчилан тогтоосны үр дүнд Миний шаарддаг хэв чанарыг эзэмшсэн байв. 19 насандаа тэр амийн тухай янз бүрийн ном уншсан; тиймээс хэв чанараасаа үүдэн, мөн Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтээс үүдэн тэрээр сүнслэг асуудлуудын талаар нэлээд мэдлэгтэй ярьж чаддагаар зогсохгүй, мөн Миний санаа зорилгыг ойлгож чаддаг байсан гэдгийг Би нэг бүрчлэн ярих шаардлагагүй. Мэдээж, энэ нь дотоод ба гадаад хүчин зүйлсийн хослолыг хасаагүй. Гэсэн хэдий ч өөрийн авьяас билгээс болж тэр үргэлж хэлэмгий, онгироо байсан нь түүний нэг өө байсан юм. Үүний үр дүнд, тэргүүн тэнгэрэлчийг шууд төлөөлдөг хэсэг болох дуулгаваргүй байдлынхаа улмаас эхний удаад махан биетэй болоход минь

Намайг сөрөх гэж тэр бүх чадлаараа хичээсэн. Тэр Миний үгийг мэддэггүй хүмүүсийн нэг байсан бөгөөд түүний зүрх сэтгэл дэх Миний байр аль хэдийн алга болсон байлаа. Тийм хүмүүс Миний бурханлаг чанарыг шууд эсэргүүцэн Надад цохигддог ба бүр эцэстээ л өвдөг сөхрөн, нүглээ наманчилдаг. Үүнээс хойш, Би түүний давуу талуудыг ашигласны дараа—өөрөөр хэлбэл, хэсэг хугацаанд Миний төлөө ажилласныхаа дараа тэр хуучин замдаа дахиж орсон бөгөөд хэдийгээр Миний үгэнд шууд дуулгаваргүй хандаагүй ч Миний дотоод удирдамж, гэгээрэлд дуулгаваргүй хандаж, улмаар урьд нь түүний хийсэн бүхэн талаар болсон; өөрөөр хэлбэл, түүний ярьж байсан алдрын титэм хоосон үг, өөрийнх нь төсөөллийн үр дүн болсон, учир нь өнөөдөр ч гэсэн тэр Миний гав гинжин дунд Миний шүүлтэд захирагдаж байдаг.

Намайг эсэргүүцдэг (Миний махан биеийг эсэргүүцээд зогсохгүй хамгийн чухал нь Миний үгийг, Миний Сүнсийг, өөрөөр хэлбэл, Миний бурханлаг чанарыг эсэргүүцдэг) хэн боловч Миний шүүлтийг махан биедээ хүртэнэ гэдгийг дээрх жишээнээс харж болно. Миний Сүнс чамайг орхиход чи доошоо чигээрээ унаж, шууд Үхэгсдийн орон руу бууна. Хэдийгээр махан бие чинь газар дэлхий дээр байвч чи сэтгэцийн өвчнөөр шаналж байгаа хүнтэй адилхан: Чи эрүүл ухаанаа алдаж, тэр даруйдаа үхдэл болсон мэт санагддаг болохоор махан биеийг чинь нэн даруй эцэс болгооч гэж Надаас гуйдаг. Сүнс эзэмшсэн та нарын ихэнх нь эдгээр нөхцөл байдлын талаар гүнзгий ойлгодог бөгөөд Би цааш нь дэлгэрүүлэн ярих хэрэггүй. Урьд нь Намайг хэвийн хүн чанараар ажиллаж байхад ихэнх хүмүүс Миний уур хилэн, сүр жавхлантай аль хэдийн хүчээ үзсэн ба Миний мэргэн ухаан, зан чанарыг аль хэдийн бага зэрэг мэдсэн. Өнөөдөр Би бурханлаг чанараар шууд ярьж, үйлддэг бөгөөд Миний уур хилэн, шүүлтийг өөрсдийн нүдээр харах зарим хүн бас бий; түүнчлэн шүүлтийн эрин үеийн хоёр дахь хэсгийн үндсэн ажил бол Өөрийн бүх ардад Өөрийн махан биеэр хийх үйл хэргийг шууд мэдэгдэж, та нарт бүгдэд нь Өөрийн зан чанарыг шууд харуулах явдал юм. Гэвч Би махбодод байгаа учраас та нарын сул талуудыг харгалзан үздэг. Та нар өөрсдийн сүнс, сэтгэл, биеийг тоглоом шиг үзэж, тэдгээрийг Сатанд хайхрамжгүйгээр хээвнэг зориулахгүй гэж Би найдаж байна. Өөртөө байгаа бүхнийг нандигнаж, үүнд тоглоом шиг хандахгүй байх нь дээр бөгөөд учир нь ийм зүйлс та нарын хувь заяатай холбоотой. Та нар Миний үгийн жинхэнэ утгыг үнэхээр ойлгож чадах уу? Миний чин үнэнч сэтгэлд хайхрамжтай хандах чадвар та нарт үнэхээр бий юү?

Та нар тэнгэрт байдаг ерөөлтэй адил газар дээрх ерөөлийг минь эдлэхэд

бэлэн байна уу? Та нар Миний тухай ойлголт, Миний үгийн таашаал, Миний талаарх мэдлэгийг амьдралынхаа хамгийн үнэ цэнтэй, утга учиртай зүйлс хэмээн үзэхэд бэлэн үү? Та нар өөрсдийн хэтийн ирээдүйг бодолгүйгээр Надад бүрэн захирагдаж үнэхээр чадах уу? Та нар өөрсдийгөө хонь адилаар Надаар нядлуулж, Надаар удирдуулж үнэхээр чадах уу? Тийм зүйлсийг биелүүлж чадах хүн та нарын дунд байна уу? Надаар хүлээн зөвшөөрөгдөж, Миний амлалтыг хүлээн авсан бүх хүн Миний ерөөлийг хүртдэг хүмүүс юм гэж үү? Эдгээр үгээс та нар ямар нэг зүйлийг ойлгов уу? Хэрвээ Би та нарыг туршвал та нар өөрсдийгөө Миний эрхшээлд үнэхээр орхиж, эдгээр шалгалтын дунд Миний санаа зорилгыг эрж хайн, Миний зүрх сэтгэлийг ухамсарлаж чадах уу? Би чамайг сэтгэл хөдөлгөм олон үг хэлж, эсвэл олон сонирхолтой түүх ярьж чаддаг байгаасай гэж хүсэхгүй; харин Надад сайн гэрчлэл хийж, бодит байдал руу бүрэн дүүрэн, гүн гүнзгий орж чаддаг байхыг Би чамаас шаардаж байна. Хэрвээ Би шууд яриагүй бол чи эргэн тойрныхоо бүх зүйлийг хаяж, өөрийгөө Надаар ашиглуулахыг зөвшөөрч чадах байсан уу? Энэ нь Миний шаарддаг бодитой байдал биш гэж үү? Миний үгийн утга учрыг хэн ухаарч чадах вэ? Гэсэн ч цаашид эргэлзээнд автахгүй байж, өөрсдийн оролтод санаачилгатай байж, Миний үгийн мөн чанарыг ухаарахыг Би та нараас шаардаж байна. Энэ нь Миний үгийг буруу ойлгож, Миний утгыг ойлгохгүй байж, улмаар Миний захиргааны зарлигийг зөрчихөөс та нарыг сэргийлнэ. Миний үгээс та нарын төлөө гэсэн Миний санаа зорилгыг та нар ухаарна гэж Би найдаж байна. Өөрсдийн хэтийн ирээдүйн талаар дахин бүү бод, мөн бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалтад захирагдана гэж Миний өмнө шийдвэр гаргасан мэт үйлд. Миний гэр дотор зогсож байгаа тэр бүх хүн чадах чинээгээрээ аль болох ихийг хийх ёстой; чи газар дээрх Миний ажлын сүүлчийн хэсгийн төлөө хамгийн сайнаа өргөн барих ёстой. Чи ийм зүйлсийг хэрэгжүүлэхэд үнэхээр бэлэн байна уу?

1992 оны 2 дугаар сарын 23

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (5-Р БҮЛЭГ)

Миний Сүнсний дуу хоолой бол бүхий л зан чанарын минь илэрхийлэл билээ. Та нар ойлгож байна уу? Энэ зүйлийг тодорхой мэдэхгүй байх нь Намайг шууд эсэргүүцэхтэй адилхан. Энд оршдог ач холбогдлыг та нар үнэхээр харсан уу? Би та нар дээр хэр их хичээл чармайлт, хэр их эрч хүч зарлагадсаныг та нар

үнэхээр мэддэг үү? Та нар өөрсдийн хийсэн зүйлийг, мөн Миний өмнө яаж авирлаж байснаа ил харуулж үнэхээр зүрхэлнэ гэж үү? Бас та нар Миний өмнө өөрсдийгөө Миний ардууд гэж нэрлэх зүрх зоригтой байдаг—та нарт ямар ч ичгүүр сонжуур байхгүй, эрүүл ухаан бүр ч байхгүй! Эрт орой хэзээ нэгэн цагт, та нар шиг хүмүүс Миний гэрээс хөөгдөнө! Миний төлөө гэрчлэлд зогссон гэж бодоод Надад бүү ахарх! Энэ нь хүн төрөлхтний хийж чадах зүйл мөн үү? Санаархал болон зорилгоос чинь юу ч үлдээгүй бол чи аль хэдийн өөр замаар орчихсон байх байлаа. Хүний зүрх сэтгэл хэр ихийг агуулж чадахыг Би мэдэхгүй гэж бодож байна уу? Энэ цагаас эхлээд чи бүх зүйл дээр хэрэгжүүлэлтийн бодит байдал руу орох ёстой; урьдынхтайгаа адилаар зүгээр дэмий чалчаад юунд ч хүрэхгүй. Урьд нь та нараас ихэнх нь Миний дээвэр дор сорон мөлжиж дөнгөсөн; өнөөдөр та нар бат зогсож чадаж байгаа нь бүхэлдээ Миний үгийн хатуу ширүүнээс болж байгаа юм. Намайг санаан зоргоор, ямар ч зорилгогүй ярьдаг гэж бодож байна уу? Боломжгүй хэрэг! Би бүх зүйлийг өндрөөс харж, бүх зүйлийг өндрөөс ноёрхдог. Үүний адилаар Би Өөрийн авралыг газар дээр хэрэгжүүлсэн. Би Өөрийнхөө нууц газраас хүмүүсийн хөдөлгөөн бүрийг, хэлдэг хийдэг бүхнийг хараагүй байх мөч гэж хэзээ ч байдаггүй. Хүмүүс бол Миний хувьд нээлттэй ном: Би тэднийг бүгдийг нь хардаг, бас мэддэг. Нууц газар бол Миний орон байр бөгөөд тэнгэрийн уудам бүхэлдээ Миний хэвтдэг ор билээ. Сатаны хүчнүүд Надад хүрч чадахгүй, учир нь Би сүр жавхлан, зөвт байдал, шүүлтээр бялхаж байна. Үгээр илэрхийлэх аргагүй нууц Миний үгэнд оршдог. Намайг ярих үед сүнс чинь ухаан мэдрэлээ алдсанаас болж та нар ус руу дөнгөж шидэгдээд учраа олохгүй самгардсан шувуу шиг, эсвэл саяхан айж цочоод юугаа ч мэдэхгүй байгаа нялх хүүхэд шиг болдог. Нууц газар бол Миний орон байр гэж Би яагаад хэлдэг вэ? Миний үгийн илүү гүн утгыг чи мэдэх үү? Хүмүүсийн дотор Намайг мэдэх чадвартай хэн байна вэ? Хэн Намайг төрсөн эцэг, эхээ мэддэг шигээ мэдэх чадвартай вэ? Өөрийн орон байранд амрангаа Би анхааралтай ажигладаг: Газар дээрх бүх хүн өөрсдийнхөө хувь заяа, ирээдүйн төлөө үймэн бужигнаж, “дэлхийг тойрон аялж”, өөд уруугүй яаравчилдаг. Гэвч Миний хаанчлалыг байгуулахад зориулах эрч хүч ганцад нь ч байдаггүй, амьсгаа авах хэмжээний хүчин чармайлт ч байдаггүй. Би хүмүүсийг бүтээж, гай зовлонгоос олон удаа аварсан; гэвч, энэ хүмүүс бүгд ач тус мэддэггүй: Тэдний дундаас нэг нь ч Миний авралын бүх тохиолдлыг тоолж чаддаггүй. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл маш олон жил, олон зуун өнгөрсөн; Би маш олон гайхамшиг үзүүлж, маш олон удаа мэргэн ухаанаа

харуулсан. Гэсэн ч, хүмүүс сэтгэцийн өвчтэй мэт солиотой, хөшүүн байдаг бөгөөд заримдаа бүр ойд тэнүүчилж яваа зэрлэг араатан шиг л Миний ажил хэрэгт анхаарал хандуулах өчүүхэн ч бодолгүй байдаг. Би хүмүүст олон удаа үхэх ял өгч, тэднийг үхүүлэхээр ялласан боловч Миний удирдлагын төлөвлөгөөг хэн ч өөрчилж чадахгүй. Тиймээс, Миний гарт хүмүүс өөрсдийн зууралддаг хуучин зүйлсийг илчилсээр байдаг. Өөрийн ажлын алхмуудаас үүдэн Би, доройтож, гажуудсан, балиар, бузар өнөр бүлд төрсөн та нарыг дахин нэгэнтээ аварсан.

Миний төлөвлөсөн ажил нэг ч хором зогсолгүй урагшилсаар байдаг. Хаанчлалын эрин үед орж, та нарыг Өөрийн ардууд болгон хаанчлалдаа оруулсан тул Би та нарт өөр шаардлагууд тавина; өөрөөр хэлбэл, энэхүү эринийг захирахдаа баримтлах үндсэн хуулийг Би та нарын өмнө тунхаглан зарлаж эхэлнэ:

Та нар Миний ардууд гэж нэрлэгддэг тул Миний нэрийг алдаршуулж чаддаг байх ёстой; өөрөөр хэлбэл, шалгалтын дунд гэрчлэлд зогс. Хэрвээ хэн нэгэн Намайг аргалж, Надаас үнэнийг нуух гэж оролдвол, эсвэл Миний араар шившигтэй үйл хийвэл тийм хүмүүс бүгд ялгаагүй Миний гэрээс хөөгдөж, зайлуулагдан, өөрсөдтэй нь харьцахыг минь хүлээнэ. Урьд нь Надад үнэнч бус, ачлалгүй байсан хүмүүс, мөн өнөөдөр Намайг ил тод шүүхээр дахин өндийн босдог хүмүүс ч бас Миний гэрээс хөөгдөнө. Миний ардууд ачаанд минь үргэлж анхаарал хандуулж, түүнчлэн үгийг минь мэдэхээр эрэлхийлэх ёстой. Ийм хүмүүсийг л Би гэгээрүүлэх бөгөөд тэд хэзээ ч гэсгээлт амсахгүйгээр, Миний удирдамж, гэгээрэл дор амьдрах нь гарцаагүй. Миний ачаанд анхаарал хандуулж чадалгүй, өөрсдийнхөө ирээдүйг төлөвлөхөд хамаг анхаарлаа төвлөрүүлдэг хүмүүс—өөрөөр хэлбэл, үйлдлээрээ Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгахаар зорихын оронд өглөг тусламж хайдаг хүмүүс буюу гуйлгачин шиг энэ амьтдыг ашиглахаас Би эрс татгалзана, учир нь тэд төрсөн цагаасаа л Миний ачаанд анхаарал хандуулна гэж юу гэсэн үг болохыг огт мэдээгүй. Тэд бол хэвийн эрүүл ухаанаар дутмаг хүмүүс юм; ийм хүмүүс тархины “тэжээлийн дутагдлаас” болж зовж байгаа ба “шим тэжээл” авахын тулд гэртээ харих хэрэгтэй. Надад ийм хүмүүс ямар ч хэрэггүй. Миний ардуудын дундах хүн бүр, Намайг мэдэх явдлыг идэх, хувцаслах, унтахтай адил хүний хэзээ ч, ганц хором ч мартдаггүй зүйл шиг, эцэст нь хүртэл заавал биелүүлэх үүрэг гэж үзэх шаардлагатай, ингэснээр Намайг мэдэх гэдэг нь эцэстээ хоол идэхтэй адил, дадсан гараар амархан хийдэг зүйл болно. Миний хэлдэг үгийн

тухайд бол, нэг бүрийг нь туйлын итгэлтэйгээр авч үзэн, бүрэн өөрийн болгох ёстой; хааш яаш, хагас дутуу арга хэмжээ байж болохгүй. Миний үгэнд анхаарал хандуулдаггүй хэнийг ч Намайг шууд эсэргүүцэж байна гэж үзнэ; Миний үгийг иддэггүй, эсвэл тэдгээрийг мэдэхээр эрэлхийлдэггүй хэнийг ч Надад анхаарал хандуулахгүй байна гэж үзэх ба Миний гэрийн хаалгаар шууд шүүрдэж гаргана. Яагаад гэвэл, урьд нь Миний хэлсэнчлэн Миний хүсдэг зүйл бол асар олон тооны хүн биш, харин онцгой сайн чанар юм. Зуун хүнээс нэг нь л Миний үгээр дамжуулан Намайг мэдэж чаддаг бол Би энэ ганцхан хүнийг гэгээрүүлж, гэрэлтүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэхийн тулд бусдыг нь бүгдийг хаяхад бэлэн байх болно. Олон тооны хүмүүс дангаараа Намайг илтгэж, Намайг амьдран харуулж чадна гэдэг үнэн байх албагүй гэдгийг эндээс харж болно. Миний хүсдэг зүйл бол (хэдийгээр үр нь дүүрэн биш байж болох ч) улаан буудай бөгөөд (хэдий үр нь бахадмаар боловсорсон байсан ч) үрийн сүүл биш юм. Эрж хайхыг анхаардаггүй, харин хөшүүн хойрго байдлаар авирладаг хүмүүсийн тухайд гэвэл, тэд өөрсдөө явах ёстой; тэд Миний нэрд гутамшиг авчирсаар байх вий гэсэндээ Би тэднийг дахиж харахыг хүсдэггүй. Өөрийн ардуудаас шаарддаг зүйлийн тухайд бол, Би одоохондоо эдгээр журам дээр түр зогсоод, нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамааран дараагийн арга хэмжээ авахаар хүлээнэ.

Урьд нь, хүмүүсийн дийлэнх нь Намайг мэргэн ухааны Бурхан Өөрөө бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг яг тэр Бурхан мөн гэж бодсон; гэвч энэ нь—ердөө өнгөцхөн яриа байсан юм. Хэрвээ хүмүүс үнэхээр Намайг мэддэг байсан бол дүгнэлт хийх гэж яарахгүй, харин оронд нь Миний үгээр дамжуулан Намайг мэдэхээр хичээсээр байх байлаа. Тэр Миний үйл хэргийг үнэхээр харсан үе шатанд очих үедээ л Намайг Ухаалаг, Гайхалтай гэж нэрлэхүйц болох байв. Миний тухай мэдлэг чинь хэтэрхий нимгэн. Эрин үеүдийн турш тун олон хүн, маш олон жилийн турш Надад үйлчилж, Миний үйл хэргийг хараад Миний талаар үнэхээр ямар нэг зүйл мэддэг болсон. Энэ шалтгааны улмаас, тэд үргэлж Надад дуулгавартай зүрх сэтгэлээр хандсан ба Миний мөрийг эрж хайхад хэцүү байдгаас болоод Намайг эсэргүүцэх санаа зорилго өвөрлөж огт зүрхлээгүй. Энэ хүмүүсийн дунд Миний удирдамж байгаагүй бол тэд хөнгөн хуумгай үйлдэж зүрхлэхгүй байх байв. Тиймээс олон жилийн туршлагаараа тэд эцэст нь Миний тухай мэдлэгийн нэг хэсгийг ерөнхийлөн дүгнэж, Намайг Ухаалаг, Гайхалтай агаад Зөвлөгч гэж дуудан, Миний үг давхар иртэй илд мэт, мөн Миний үйл хэрэг агуу, гайхалтай, гайхмаар бөгөөд Би сүр жавхлангаар

хувцаслаж, Миний мэргэн ухаан огторгуйгаас өндөрт хүрдэг гэх мэтийн ойлголтыг хэлсэн. Харин өнөөдөр Миний талаарх та нарын мэдлэг тэдний тавьсан суурин дээр л үндэслэдэг тул та нарын дийлэнх нь тэдний хэлсэн үгийг тоть шиг л давтаж байна. Миний талаарх мэдлэг чинь хэчнээн нимгэн гэдгийг, мөн “боловсрол” чинь хэчнээн тааруухан болохыг Би харгалзаж үзсэн учраас л маш их гэсгээлтээс та нарыг хэлтрүүлсэн юм. Тэгсэн ч гэсэн та нарын дийлэнх олонх нь бас л өөрсдийгөө мэддэггүй, эсвэл өөрсдийн үйл хэргээр Миний хүслийг аль хэдийн биелүүлчихсэн ба энэ шалтгааны улмаас шүүлтээс мултарсан гэж боддог; эсвэл махбод болсныхоо дараа Би хүн төрөлхтний үйлдлийг огт мэдэхээ больчихсон ба энэ шалтгаанаас үүдэн та нар ч бас гэсгээлтээс мултарсан гэж боддог; эсвэл та нарын итгэдэг Бурхан орчлон ертөнцийн уудам зайд оршин байдаггүй гэж боддог тул та нар Бурханыг мэдэх явдлыг өөрсдийн биелүүлэх ёстой үүрэг хэмээн зүрх сэтгэлдээ хадгалахын оронд завтай цагтаа хийх ажил болгон доогуур тавиад, Бурханд итгэх итгэлийг, дэмий өнгөрөөх байсан цагаа нөхцөөх арга зам болгон ашигладаг. Хэрвээ Би эрдэм чадал, эрүүл ухаан, гүн ойлголт дутуу дулимгийг чинь харгалзан үзээгүй бол та нар бүгдээрээ Миний гэсгээлтийн дунд мөхөж, амьдралаас арчигдах байлаа. Гэсэн хэдий ч, газар дээрх Миний ажил дуусах хүртэл Би хүн төрөлхтөнд хүлээцтэй ханддаг хэвээр байна. Энэ нь та бүгдийн мэдэх ёстой зүйл бөгөөд сайн, мууг бүү хольж хутга.

1992 оны 2 дугаар сарын 25

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (6-Р БҮЛЭГ)

Сүнсний доторх хэрэг явдалд, чи нарийн мэдрэмжтэй байх хэрэгтэй; Миний үгийг хичээнгүйлэн анхаарах ёстой. Миний Сүнс ба Миний бие махбодыг, Миний үг ба Миний бие махбодыг хуваагдашгүй нэгэн бүхэл мэт харах тэрхүү төлөв байдлыг зорих хэрэгтэй, ингэснээр бүх хүн Миний өмнө Намайг сэтгэл хангалуун байлгаж чадна. Би орчлон ертөнцийг Өөрийн хөлөөр туулж, харцаа хаяа хязгаарт нь бэлчээж, хүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амтлан бүх хүн төрөлхтний дунд алхсан, гэвч үнэндээ хүн Намайг хэзээ ч таниагүй, Намайг хаа сайгүй явахад ч анзаараагүй. Учир нь Би чимээгүй байж, ямар ч ер бусын үйл хийгээгүй, иймээс үнэндээ Намайг хэн ч, хэзээ ч хараагүй. Юмс одоо урьдынх шигээ байхаа больсон: Би бүтээлийн эхлэлээс хойш хүний

хэзээ ч үзээгүй зүйлсийг хийж, эрин үеүдийн туршид хүний хэзээ ч сонсож байгаагүй үгийг хэлэх гэж байна, учир нь Би бүх хүн төрөлхтнөөс махбод дахь Намайг мэддэг болооч гэж хүсдэг. Энэ бол Миний удирдлагын алхмууд бөгөөд энэ талаарх өчүүхэн төдий ч таамаг хүмүүст байдаггүй. Би энэ талаар илэн далангүй ярьсан ч хүний оюун санаа нь мунгинасаар байдаг болохоор түүнд нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй. Хүний адгийн дорд байдал үүнд оршдог, тийм биз? Энэ бол Миний засахыг хүсдэг яг тэр зүйл юм, үгүй гэж үү? Энэ бүх он жилүүдэд Би хүн дээр юу ч хийгээгүй; энэ бүх он жилүүдэд Миний махбод болсон биетэй шууд холбоотой байсан хүмүүс хүртэл Миний бурханлаг чанараас шууд гарах дуу хоолойг хэзээ ч сонсоогүй. Иймээс Миний талаарх мэдлэг хүмүүст дутмаг байх нь гарцаагүй, гэхдээ эрин үеүдийн туршид энэ нэг зүйл хүн төрөлхтний Намайг гэх хайранд дангаараа нөлөөлөөгүй. Одоо харин Би та нарт гайхамшигт, тайлагдашгүй ажил тоолшгүй олныг авчирч, бас олон үг хэлсэн. Гэтэл иймэрхүү нөхцөл байдалд ч гэсэн маш олон хүн Намайг нүүрэн дээр минь эсэргүүцэж байна. Би чамд цөөн хэдэн жишээ дурдъя:

Чи Миний санаа зорилгыг ухаарч, амийг мэдрэх гээд өдөр бүр тодорхойгүй Бурханд залбирдаг. Гэхдээ Миний үг яг бууж ирэхэд чи тэдгээрийг өөрөөр хардаг: Чи Миний үг болон Миний Сүнснийг хуваагдашгүй нэгэн зүйл гэж үздэг боловч Над шиг хүн ийм үг хэлэх чадваргүй, харин ч энэ нь Миний Сүнсний олгосон үр дүн юм хэмээн бодож хүнийг нь хөсөр хаядаг. Энэ мэт нөхцөл байдлын тухай чи яаж мэдэх юм бэ? Чи Миний үгэнд тодорхой хэмжээгээр итгэдэг ч Миний өмссөн махбодын тухайд их бага хэмжээгээр өөрийн гэсэн үзэл тээж, түүнийгээ өдрөөс өдөрт лавшруулан бодож, “Тэр яагаад аливааг ингэж хийдэг юм бэ? Энэ Бурханаас ирдэг юм гэж үү? Байж боломгүй юм! Миний бодлоор, Тэр надтай бараг адилхан, эгэл, жирийн л хүн” гэж хэлдэг. Дахин хэлэхэд, чи ийм нөхцөл байдлыг хэрхэн тайлбарлах вэ?

Миний дээр хэлсэн зүйлийн тухайд, та нарын дунд ийм үзлээр зэвсэглээгүй хүн байна уу? Үүнийг эзэмшдэггүй хүн байна уу? Чи үүнийг яг л өөрийн нэг өмч шиг зуурчихаад, энэ бүх хугацаанд хаях дургүй байсан мэт харагдаж байна. Тэр ч бүү хэл, чи идэвхтэй хүчин чармайлт гаргахыг бүр ч хүсээгүй; харин Намайг биечлэн ажил хийхийг хүлээдэг. Үнэнийг хэлэхэд, Намайг эрж хайлгүйгээр амар хялбар мэдэж авсан нэг ч хүн байхгүй. Үнэн хэрэгтээ, Би та нарт өнгөц үгээр сургамж номлодог юм биш, учир нь чамд лавлагаа болгох гэж Би өөр өнцгөөс жишээ татаж чадна:

Петрийг дурдмагц хүн бүр магтан шагширч, Бурханыг гурвантаа үгүйсгэсэн,

түүнчлэн Сатанд үйлчилж, улмаар Бурханыг туршсан, гэвч эцэстээ Түүний төлөө загалмайд уруу харж цовдлогдсон гэх зэрэг Петрийн тухай энэ бүх түүхийг тэр дороо санацгаадаг. Петр Намайг хэрхэн мэдэж авсныг, мөн түүний эцсийн үр дүн ямар байсан талаар одоо та нарт өгүүлэх нь маш чухал гэж Би үзэж байна. Петр гэгч энэ хүн гойд сайн хэв чанартай хүн байсан, гэхдээ түүний нөхцөл байдал Паулынхаас өөр байлаа. Түүний эцэг, эх Намайг хавчдаг, Сатанд эзэмдүүлсэн чөтгөрүүдэд харьяалагддаг байсан, энэ шалтгааны улмаас тэд Петрт замыг дамжуулсан гэж хэлж болохгүй юм. Цэцэн цэлмэг, төрөлхийн оюун билэгтэй Петрийг эцэг эх нь бага балчраас нь хайрладаг байжээ; харин өсөж том болсныхоо дараа тэр тэдний дайсан болсон, учир нь тэр үргэлж Намайг мэдэхээр эрэлхийлдэг байсан ба энэ нь түүнийг эцэг эхийгээ орхиход хүргэсэн. Яагаад гэвэл, юуны өмнө тэнгэр, газар, бүх зүйл Төгс Хүчитийн гарт байдаг, бүх эерэг зүйл Бурханаас эхтэй ба Сатаны ямар ч боловсруулалтаар дамжилгүй Түүнээс шууд ирдэг гэдэгт тэр итгэдэг байсан юм. Товойлгогч болон үйлчлэх эцэг эхийнх нь сөрөг жишээ байснаар энэ нь түүнийг Миний хайр, энэрлийг илүү амархан таних боломжтой болгож, улмаар Намайг эрж хайх хүслийг нь улам бадраасан юм. Тэр зөвхөн Миний үгийг идэж, уухад их анхаараад зогсоогүй, Миний санаа зорилгыг ухаарахад бүр ч их анхаарал хандуулсан бөгөөд сүнсэндээ үргэлж гярхай, сүйхээтэй байхын тулд өөрийн бодолд байнга хашир, болгоомжтой байсан, иймд хийсэн бүхэндээ Миний тааллыг хүртэж чадсан юм. Жирийн амьдралдаа тэр бүтэлгүйтлийн занганд унахаас машид айж, хүчин чармайлтаа нэмэхэд өөртөө түлхэц өгөхийн тулд, урьд өмнө бүтэлгүйтсэн хүмүүсээс сургамж авахад онцгой анхаарч байв. Мөн эрин үеүдийн туршид Бурханыг хайрлаж байсан бүх хүний итгэл болон хайрыг өөрийн болгоход сайтар анхаарчээ. Ийм байдлаар тэр өөрийнхөө өсөх үйл явцыг зөвхөн сөрөг талууд дээр төдийгүй, бүр ч чухал нь Миний өмнө Намайг хамгийн сайн мэдэх нэгэн хүн болж чадталаа эерэг талууд дээр хурдасгасан юм. Ийм ч учраас, тэрээр байгаа бүхнээ Миний гарт атгуулж, бүр идэх, өмсөх, унтахдаа ч юм уу ер нь хаана ч байхдаа өөрийнхөө эзэн байхаа больж, харин бүх зүйл дээр Намайг сэтгэл хангалуун байлгасны үндсэн дээр Миний өгөөмөр хишгийг эдэлсэн гэдгийг төсөөлөхөд хэцүү биш. Би түүнийг олон ч удаа шалгалтад оруулж, энэ нь мэдээж хэрэг түүнийг хагас үхлүүт болгож орхисон, гэвч энэ олон зуун шалгалтын дунд ч тэр Надад итгэх итгэлээ хэзээ ч алдаж, урам хугараагүй. Өөрийг нь хэдийн хаячихсан гэж Намайг хэлэхэд ч тэрээр цөхрөөгүй, харин Намайг бодитой байдлаар, урьдын хэрэгжүүлэлтийн зарчимд

нийцэлтэйгээр үргэлжлүүлэн хайрласан. Намайг түүнд ингэж хэлэх үед хэдий тэр Намайг хайрладаг байсан ч Би түүнийг сайшаагаагүй, харин эцэстээ түүнийг Сатаны гарт хаях байсан. Махан биед нь хүрээгүй, зөвхөн үг хэрэглэн явуулсан эдгээр шалгалтын дунд ч тэр Надад залбирсаар л байсан: “Өө, Бурхан минь! Тэнгэр газар хийгээд үй олон зүйлийн дунд Төгс Хүчит Таны гарт эс багтах хүн, бүтээл, эсвэл аливаа зүйл байна уу? Таныг надад өршөөл үзүүлэхийг хүсэх үед, зүрх сэтгэл минь Таны өршөөлд машид баясдаг; Та надад шүүлт хийхийг хүсэх үед, хэдий би үнэ цэнгүй байж мэдэх ч Таны үйл хэргийн гүн гүнзгий нууцыг улам их мэдэрдэг, учир нь Та эрх мэдэл, мэргэн ухаанаар дүүрэн билээ. Миний бие махбод хэдий зововч сүнсэндээ би тайтгардаг. Таны мэргэн ухаан, Таны үйл хэргийг би хэрхэн шагшин магтахгүй байх билээ? Таныг мэдэж авсныхаа дараа үхэх байсан ч би хэзээд бэлэн, дуртай байх болно. Өө, Төгс Хүчит Нэгэн минь! Та Өөрийгөө надад харуулахыг үнэхээр хүсэхгүй байгаа биш биз дээ? Таны шүүлтийг би үнэхээр хүлээн авах үнэ цэнгүй биш биз дээ? Таны харахыг хүсэхгүй байгаа зүйл надад байгаа юм болов уу?” Ийм төрлийн шалгалт дунд Петр хэдийгээр Миний санааг яг таг ухаарч чадаагүй боловч Надад ашиглагдах нь (зөвхөн Миний шүүлтийг хүлээн авч, ингэснээр хүмүүс Миний сүр жавхлан, уур хилэнг үзэх байсан ч бай) нэр төр, хувийн алдрын хэрэг гэж үзсэн нь илэрхий бөгөөд шалгалтад орсондоо ердөө гутраагүй юм. Миний өмнө үнэнч байсан тул, бас өөрийг нь Би ерөөсөн учраас тэрээр хэдэн мянган жилийн турш хүн төрөлхтөнд үлгэр жишээ, дуурайл болсон билээ. Энэ нь чухамдаа та нарын дагавал зохих үлгэр жишээ биш гэж үү? Энэ удаа Намайг Петрийн талаар яагаад ийм урт зүйл ярьсныг та нар ойлгохыг хичээж, сайтар бодох хэрэгтэй. Энэ нь та нарын биеэ авч явах зарчим болох ёстой.

Хэдийгээр Намайг мэддэг маш цөөн хүн байдаг ч, үүнээс болж Би Өөрийн уурыг хүнд гаргахгүй, учир нь хүмүүс маш олон дутагдалтай тул Миний хүссэн түвшинд хүрнэ гэдэг тэдэнд хэцүү. Тиймээс Би өнөөдрийг хүртэл мянга мянган жилийн турш хүнийг өршөөсөөр ирсэн. Гэхдээ Миний өршөөлөөс болж та нар өөрсдийгөө өөгшүүлэх гэж яарахгүй гэдэгт Би найдаж байна; харин ч Петрээр дамжуулан та нар Намайг мэдэж авч, Намайг эрж хайж, Петрийн бүх түүхээр дамжуулан урьд хожид байгаагүй илчлэлийг хүлээн авч, өмнө нь хүний хүрч байгаагүй түвшинд ийм маягаар хүрэх ёстой. Орчлон ертөнц, огторгуй даяар, тэнгэр, газар дахь бүх юм, газар дээрх болон тэнгэр дэх бүх зүйл Миний ажлын сүүлийн үе шатны төлөө бүхий л хүчин чармайлтаа зориулж байна. Та нар Сатаны хүчээр ийш тийш жолоодуулсан хөндлөнгийн ажиглагчид байхыг

хүсэхгүй байлгүй дээ? Миний талаар хүмүүсийн зүрх сэтгэлдээ тээдэг мэдлэгийг Сатан байнга ховх сорж, бас байнга шүдээ ярзайлган, хумсаа сарвайлгаж, сүүлчийн амь тэмцсэн тулаандаа ордог. Энэ мөчид та нар түүний зальжин ов мэхэнд олзлогдохыг хүсэж байна уу? Та нар Миний ажлын сүүлийн үе шат дуусах энэ мөчид өөрийнхөө амийг таслахыг хүсэж байна уу? Мэдээж та нар Намайг өршөөл энэрлээ дахиад нэг удаа хүртээнэ гэж хүлээсээр байгаа юм биш биз дээ? Намайг мэдэхээр эрж хайх нь хамгийн чухал зүйл, гэхдээ та нар бодит хэрэгжүүлэлтэд анхаарал хандуулахаа умартах ёсгүй. Та нар Миний удирдамжид захирагдаж, өөрсдийн хүсэл тэмүүлэл, санаа зорилгод автахаа болино гэж найдсандаа Би нарийн ойлголтыг шууд Өөрийнхөө үгээр та нарт илчилж байна.

1992 оны 2 дугаар сарын 27

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (8-Р БҮЛЭГ)

Миний илчлэлүүд оргилдоо хүрэх үед, мөн Миний шүүлт төгсгөлдөө очих үед энэ нь Миний бүх ард илчлэгдэж, бүрэн төгс болгуулах цаг байх болно. Миний санаа зорилготой нийцдэг, Надаар ашиглуулахад тохирдог хүмүүсийг зогсолтгүй хайхдаа Би орчлон ертөнцийн бүх булан тохойгоор аялдаг. Хэн өндийн босож, Надтай хамтран ажиллаж чадах вэ? Намайг гэсэн хүмүүсийн хайр өчүүхэн бөгөөд Надад итгэх итгэл нь ч бас өрөвдмөөр жаахан. Хэрвээ Би Өөрийн үгийн гол цохилтыг хүмүүсийн сул тал руу чиглээгүй бол тэд бардамнаж, дэгсдүүлэн, газар дэлхийн хэрэг явдлын талаар анддаггүй, бүгдийг мэддэг мэтээр номчирхож, хэрээс хэтэрсэн онолуудыг зохиох байлаа. Урьд нь Надад “үнэнч” байсан хүмүүсээс, мөн өнөөдөр Миний өмнө “бат зогсдог” хүмүүсээс хэн бардамнан ярьсаар байж зүрхэлдэг вэ? Хэн өөрсдийн хэтийн ирээдүйд нууцхан баясдаггүй вэ? Хүмүүсийг шууд илчлээгүй байх үед минь тэд нуугдах газаргүй болж, ичсэндээ шаналж байсан. Хэрвээ Би өөр байдлаар ярьсан бол хэчнээн илүү дор байх байсан бэ? Хүмүүст бүр ч их өртэй санагдах байсан ба өөрсдийг нь юу ч эмчилж чадахгүй гэж бодоод, бүгдээрээ идэвхгүй байдалдаа ягштал баригдах байсан. Хүмүүс итгэл найдвараа алдах үед хаанчлалын ёслолын буудлага албан ёсоор тасхийдэг нь хүмүүсийн хэлснээр “долоо дахин эрчимжсэн Сүнс ажиллаж эхлэх цаг” юм. Өөрөөр хэлбэл, энэ нь хаанчлалын амьдрал албан ёсоор газар дээр эхэлдэг үе; Миний бурханлаг

чанар (уураг тархиар “боловсруулагдалгүйгээр”) шууд ажиллахаар гарч ирдэг үе юм. Бүх хүн завгүй яаравчлан, бүгдээрээ сэргэж, зүүднээсээ сэрээд, сэрэнгүүтээ тийм нөхцөл байдалд байгаагаа мэдээд мэл гайхаж байгаа мэт санагддаг. Урьд нь Би чуулган байгуулах талаар ихээхэн ярьсан; Би олон нууцыг илчилсэн боловч тэр ажил оргилдоо хүрэх үедээ гэнэтхэн төгссөн. Гэхдээ хаанчлалыг байгуулах нь өөр. Сүнсний ертөнц дэх тулаан эцсийн үе шатандаа хүрэх үед л Би газар дээрх ажлаа шинээр эхлүүлдэг. Өөрөөр хэлбэл, бүх хүн ухарч няцахын ирмэг дээр байх үед л Би Өөрийн шинэ ажлыг албан ёсоор эхэлж, өрнүүлдэг. Хаанчлал байгуулах, чуулган байгуулах хоёрын ялгаа гэвэл, чуулганыг байгуулахдаа Би бурханлаг чанараар удирдуулсан хүн чанараар ажилласан; Би хүмүүсийн хуучин уг чанартай шууд харьцаж, тэдний муухай төрхийг шууд илчилж, мөн чанарыг нь ил болгосон. Үүний үр дүнд, энэ суурин дээр тэд өөрсдийгөө мэдэж авч, улмаар зүрх сэтгэлдээ болон үгээрээ үнэмшсэн. Хаанчлалыг байгуулахдаа Би Өөрийн бурханлаг чанараар шууд ажилладаг ба Миний үгийг мэдсэний үндсэн дээр Надад юу байгаа, Би юу болохыг мэдэх боломжийг бүх хүнд олгон, эцэст нь бие махбодтой болсон Өөрийгөө тэдэнд мэдүүлдэг. Тийнхүү тодорхойгүй Бурханы хойноос хөөцөлдөх хүн төрөлхтний эрэл хайгуулыг төгсгөж, хүний зүрх сэтгэлд тэнгэр дэх Бурханы эзэлдэг байрыг үгүй болгодог; өөрөөр хэлбэл, Би бие махбодтой байх зуураа хийдэг үйл хэргээ хүмүүст мэдэгддэг ба ийнхүү Би газар дээр байх хугацаагаа дуусгана.

Хаанчлалыг байгуулах нь сүнсний ертөнц рүү шууд чиглэдэг. Өөрөөр хэлбэл, сүнсний ертөнцийн тулаан Миний бүх ардын дунд шууд ил болдог бөгөөд зөвхөн чуулганд ч төдийгүй ялангуяа Хаанчлалын эрин үед хүн бүр байнга тулалдаж байгаа гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Тэд махан биетэй хэр нь сүнсний ертөнц шууд илчлэгдэж, сүнсний ертөнцийн амьдралтай холбогддог. Тиймээс, та нар үнэнч байж эхлэх үедээ Миний ажлын дараагийн хэсэгт зохих ёсоор бэлдэх ёстой. Та нар зүрх сэтгэлээ бүхэлд нь өгөх ёстой; тэр үед л Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадна. Урьд нь чуулганд юу тохиолдсоныг Би огт тоодоггүй; өнөөдөр энэ нь хаанчлалд байна. Миний төлөвлөгөөнд Сатан алхам бүрийг үргэлж өсгий даран дагасаар ирсэн ба Миний мэргэн ухааны товойлгогчийн хувиар Миний анхдагч төлөвлөгөөг тасалдуулах арга зам олох гэж үргэлж оролдсоор ирсэн. Гэхдээ түүний зальхай явуулгад Би автаж болно гэж үү? Тэнгэр, газар дээр буй бүх зүйл Надад үйлчилдэг; Сатаны зальхай явуулга өөр байж чадна гэж үү? Яг энд Миний мэргэн ухаан огтлолцдог;

энэ нь яг нарийндаа Миний үйл хэргийн гайхалтай байдал бөгөөд Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө хэрэгждэг зарчим юм. Хаанчлалыг байгуулах эринд Би Сатаны зальхай явуулгаас мөн л зайлсхийдэггүй, харин хийх ёстой ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Орчлон ертөнц болон бүх зүйлийн дундаас Би Сатаны үйл хэргийг Өөрийн товойлгогч болгон сонгосон. Энэ нь Миний мэргэн ухааны илрэл биш гэж үү? Миний ажлын гайхалтай байдал яг энэ биш гэж үү? Хаанчлалын эрин үед ороход тэнгэр, газар дахь бүх зүйл бүрмөсөн өөрчлөгдөж, тэмдэглэн баярладаг. Та нар ч гэсэн адилхан бус уу? Зүрх сэтгэлд нь туйлын сайхан санагддаггүй хэн байна вэ? Зүрх сэтгэл нь баяр хөөрөөр бялхдаггүй хэн байна вэ? Баяр бахдалтайгаар бүжиглэдэггүй хэн байна вэ? Магтаалын үг хэлдэггүй хэн байна вэ?

Миний ярьсан, хэлсэн дээрх бүх зүйлийн зорилго, эх үүсвэрийг та нар ухаарч байна уу, үгүй юү? Хэрвээ Би ингэж асуугаагүй бол ихэнх хүмүүс Намайг зүгээр л дэмий чалчиж байна гэж бодоод, Миний үгийн эх сурвалжийг олж мэдэж чадахгүй байх байлаа. Хэрвээ та нар анхааралтай тунгаан бодвол тэдгээрийн ач холбогдлыг мэдэх болно. Тэдгээрийг анхааралтай уншсан чинь дээр: Миний үгийн аль нь чамд ашиг тусгүй байна? Аль нь чиний амийг өсгөхийн төлөө биш байна? Аль нь сүнсний ертөнцийн бодит байдлын талаар хэлэхгүй байна? Ихэнх хүмүүс Миний үгийг ямар ч холбоосгүй, утга учиргүй, мөн тайлбар, тайллаар дутмаг гэж боддог. Миний үг үнэхээр тийм хийсвэр, ойлгохын аргагүй гэж үү? Та нар Миний үгэнд үнэхээр захирагддаг уу? Та нар Миний үгийг үнэхээр хүлээн авдаг уу? Та нар тэдгээрийг тоглоом шиг үздэг бус уу? Чи тэдгээрийг үзэшгүй муухай дүр төрхөө далдлах хувцас болгон ашигладаг бус уу? Энэхүү өргөн уудам дэлхийд хэн өөрийн биеэр Надад шалгуулсан бэ? Хэн Миний Сүнсний үгийг биечлэн сонссон бэ? Маш олон хүн харанхуйд тэмтчиж, хайдаг; маш олон хүн гай зовлон дунд залбирдаг; маш олон хүн өлсөж, дааран, горьдлоготойгоор хардаг; мөн маш олон хүн Сатанд хүлэгддэг; гэсэн ч маш олон хүн хаашаа хандахаа мэддэггүй, маш олон хүн аз жаргалынхаа дунд Надаас урваж, маш олон хүн талархдаггүй ба маш олон хүн Сатаны зальхай явуулгад үнэнч байдаг. Та нарын дундаас хэн Иов бэ? Хэн Петр вэ? Яагаад Би Иовыг ахин дахин дурддаг вэ? Яагаад Би Петрийн тухай маш олон удаа хэлсэн бэ? Та нарын төлөөх итгэл найдварыг минь та нар ер нь ухамсарласан уу? Та нар ийм зүйлсийг тунгаан бодоход илүү их цаг зарцуулах ёстой.

Петр олон жилийн турш Надад үнэнч байсан мөртөө хэзээ ч үглэж гоншигноогүй, гомдоллоогүй; Иов хүртэл түүнтэй эн зэрэгцэж чадаагүй бөгөөд

эрин үеүдийн туршид ариун хүмүүс ч бүгдээрээ Петрээс хамаагүй дор байсан. Тэр Намайг мэдэхээр эрэлхийлээд зогсоогүй, мөн Сатаныг зальхай явуулгаа хэрэгжүүлж байх үеэр Намайг мэдэж авсан юм. Энэ нь Петрийг Надад олон жил үйлчилж, үргэлж Миний хүсэлтэй нийцэхэд хүргэсэн ба иймээс тэр хэзээ ч Сатанд ашиглуулж байгаагүй. Петр Иовын итгэлээс сургамж авсан атлаа Иовын дутагдлыг ч бас тодорхой ойлгож байв. Хэдийгээр Иов агуу итгэлтэй байсан ч түүнд сүнсний ертөнц дэх хэрэг явдлын талаарх мэдлэг дутмаг байсан тул тэр бодит байдалтай зохицоогүй олон үг хэлсэн; Иовын мэдлэг өнгөц байсан бөгөөд төгс болж чадахгүй байсан гэдгийг энэ нь харуулдаг. Тиймээс Петр сүнсний мэдрэмжийг олж авахад үргэлж төвлөрч, сүнсний ертөнцийн хөдөлгөөнийг ажиглахад анхаарлаа үргэлж хандуулдаг байжээ. Үүний үр дүнд, тэр Миний хүслээс ямар нэг зүйл олж мэдэж чадсанаар үл барам, бас Сатаны зальхай явуулгаас жаахан ойлгосон. Үүнээс үүдэн Миний талаарх түүний мэдлэг эрин үеүдийн туршид байсан өөр хэнийхээс ч илүү их байлаа.

Хэрэв хүмүүс Намайг мэдэхийг хүсвэл сүнсэн дотроо анхааралтай эргэцүүлэх ёстой гэдгийг Петрийн туршлагаас харахад хэцүү биш. Гаднаа Надад тодорхой хэмжээгээр “зориулахыг” Би чамаас шаарддаггүй; энэ бол хоёрдогч ач холбогдолтой зүйл. Хэрэв чи Намайг мэдэхгүй бол чиний ярьдаг бүх итгэл, хайр, үнэнч байдал зүгээр л хоосон санаа төдий; тэдгээр нь дэмий яриа бөгөөд чи Миний өмнө асар их бардамнан сайрхдаг ч өөрийгөө мэддэггүй хүн болох нь лавтай. Тиймээс чи дахин нэг удаа Сатанд урхидуулаад өөрийгөө чөлөөлж чадахгүй байх болно; чи мөхлийн хүү, сүйрлийн бай болно. Гэхдээ хэрвээ чи Миний үгэнд хүйтэн хөндий, хайхрамжгүй ханддаг бол Намайг эргэлзээгүй эсэргүүцэж байна. Энэ бол бодит баримт бөгөөд Миний гэсгээсэн олон янзын сүнснүүдийг сүнсний ертөнцийн үүд хаалгаар сайтар харсан чинь дээр. Миний үгтэй тулгараад тэднээс аль нь Миний үгэнд идэвхгүй, хайхрамжгүй, үл зөвшөөрсөн байдлаар хандаагүй вэ? Аль нь Миний үгэнд эрээ цээргүй хандаагүй вэ? Аль нь Миний үгээс өө сэв олох гэж оролдоогүй вэ? Тэднээс аль нь өөрсдийгөө “хамгаалахын” тулд Миний үгийг “хамгаалах зэвсэг” болгон ашиглаагүй вэ? Тэд Миний үгийн агуулгыг Намайг мэдэх арга зам болгон ашиглаагүй, харин зүгээр л тоглодог тоглоом шиг хэрэглэсэн. Ингэснээрээ тэд Намайг шууд эсэргүүцэж байсан бус уу? Миний үг хэн бэ? Миний Сүнс хэн бэ? Би та нарт маш олон удаа ийм асуулт тавьсан атал тэдгээрийн талаарх мэдлэг ухаан чинь ер нь илүү өндөр, тодорхой болсон уу? Та нар ер нь тэдгээрийг үнэхээр туулсан уу? Би та нарт дахин нэг удаа сануулъя: Хэрвээ та нар Миний

үгийг мэддэггүй, хүлээн авдаггүй, хэрэгжүүлдэггүй бол Миний гэсгээлтийн бай болох нь гарцаагүй! Сатаны хохирогч болох нь гарцаагүй!

1992 оны 2 дугаар сарын 29

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (10-Р БҮЛЭГ)

Хаанчлалын эрин үе нь эцсийн эцэст өнгөрсөн үеэс ялгаатай. Энд хүн яаж авирладаг нь хамаагүй; харин ч Би ажлаа биечлэн гүйцэтгэхээр газар дээр бууж ирсэн бөгөөд энэ нь хүмүүсийн ухамсарлаж ч чадахгүй, биелүүлж ч чадахгүй зүйл юм. Дэлхий ертөнц бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл ийм олон жил үргэлж чуулган байгуулах явдал л байсан боловч хаанчлалыг байгуулах талаар хэн ч, хэзээ ч сонсож байгаагүй. Хэдийгээр Би энэ бүхнийг Өөрийн амаар хэлж байгаа ч гэсэн үүний мөн чанарыг мэддэг хүн байна уу? Би нэгэн удаа хүний ертөнцөд буун ирж, тэдний зовлон шаналлыг туулж, ажигласан хэдий ч бие махбодтой болсон Өөрийн зорилгыг гүйцэлдүүлээгүй. Хаанчлалыг байгуулж эхлэх үед Миний махбод болсон бие албан ёсоор үйлчлэлээ гүйцэтгэж эхэлдэг; өөрөөр хэлбэл, хаанчлалын Хаан Өөрийн дээд эрх мэдлийг албан ёсоор авдаг. Үүнээс үзэхэд, хаанчлал хүний ертөнцөд бууж ирсэн нь үгчилсэн илрэл төдийхөн биш, харин бодит байдал гэдэг нь илт юм; энэ бол “хэрэгжүүлэлтийн бодит байдлын” утга учрын нэг тал мөн. Хүмүүс Миний үйлсээс ганцыг нь ч харсан удаагүй, Миний айлдваруудын нэгийг нь ч сонссон удаагүй. Тэр харсан байлаа ч гэсэн юу олж илрүүлэх байсан бэ? Миний ярихыг сонссон ч юу ойлгох байсан бэ? Дэлхий даяар хүн бүр Миний өршөөл, Миний хайр энэрэл дотор оршдог, гэвч бас бүх хүн Миний шүүлтэн дор, түүнчлэн Миний шалгалтан дор оршдог. Хүмүүс бүгдээрээ тодорхой хэмжээнд ялзарсан хэдий ч Би хүн төрөлхтнийг өршөөж, хайрласаар ирсэн; тэд бүгд Миний сэнтийн өмнө захирагдах үед ч Би тэдэнд гэсгээлт оноосон. Гэвч Миний илгээсэн зовлон, цэвэршүүлэлтийн дунд байдаггүй хүн бий юу? Маш олон хүн гэрлийн төлөө харанхуйд тэмтчин явж, маш олон хүн шалгалтаа гашуунаар тэмцэн туулж байна. Иов итгэлтэй байсан, гэсэн ч тэр өөртөө гарах гарц хайж байгаагүй гэж үү? Миний ардууд хэдийгээр шалгалтад бат зогсож чадах боловч чанга хэлэлгүйгээр зүрх сэтгэлдээ итгэдэг хүн бий юу? Хүмүүс зүрх сэтгэлдээ эргэлзэх зуураа өөрсдийн итгэлийг амаараа л хэлдэг биш гэж үү? Шалгалтад бат зогсож, шалгагдах үедээ үнэхээр дуулгавартай байсан нэг ч хүн үгүй. Энэ ертөнцийг

харахаас зайлсхийхийн тулд Би Өөрийн нүүрийг халхлаагүй бол бүх хүн Миний дүрэлзсэн харцан дор нуран унах байсан, учир нь Би хүмүүсээс юу ч хүсдэггүй билээ.

Хаанчлалын ёслолын буудлага тасхийхэд тэр нь мөн долоон аянга нижигнэх үе бөгөөд энэхүү дуу чимээ тэнгэр, газрыг доргиож, дээд тэнгэрийг сэргээж, бүх хүний сэтгэлийн утсыг чичрүүлдэг. Хаанчлалын сүлд дуу агуу улаан лууны газар нутаг даяар албан ёсоор цуурайтан, агуу улаан лууны үндэстнийг устгаж, дараа нь Өөрийн хаанчлалыг байгуулсан гэдгийг минь нотолдог. Үүнээс ч чухал нь, Миний хаанчлал газар дэлхий дээр байгуулагддаг. Энэ мөчид Би дэлхийн улс орон бүхэнд Өөрийн тэнгэрэлч нарыг илгээж эхэлнэ, ингэснээр тэд Миний хөвгүүдийг, Миний ардуудыг хариулж болох юм; энэ нь бас Миний ажлын дараачийн алхмын шаардлагыг хангахын тулд байдаг. Гэхдээ Би тулалдахын тулд агуу улаан лууны цагираглан хэвтэж буй газарт биечлэн очдог. Бүх хүн махбод доторх Намайг мэдэж, махбодоос Миний үйл хэргийг харж чаддаг болох үед агуу улаан лууны ичээ үнс нурам болж, ул мөргүй арилна. Миний хаанчлалын ардуудын хувиар та нар агуу улаан лууг үнэн голоосоо үзэн ядаж, үйлдлээрээ Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгах ёстой ба ийм маягаар агуу улаан лууд ичгүүр авчирна. Агуу улаан луу жигшүүртэй гэдгийг та нар үнэхээр мэдэрч байна уу? Энэ нь хаанчлалын Хааны дайсан гэдгийг та нар үнэхээр мэдэрч байна уу? Надад гайхалтай гэрчлэл хийж чадах тийм итгэл та нарт үнэхээр бий юу? Та нарт агуу улаан лууг ялах итгэл үнэхээр бий юу? Та нараас Миний шаарддаг зүйл энэ; та нар энэ алхамд хүрч чаддаг байх нь л Надад хэрэгтэй. Та нар үүнийг хийж чадах уу? Үүнд хүрэх итгэл та нарт байгаа юу? Хүн юу хийх чадвартай вэ? Харин ч Би үүнийг Өөрөө хийдэг биш гэж үү? Тулаан болох газарт Би биечлэн бууж очдог гэж Би яагаад хэлдэг вэ? Миний хүсдэг зүйл та нарын итгэл болохоос, үйл хэрэг чинь биш. Хүмүүс Миний үгийг шулуухан хүлээн авах чадваргүй, харин зүгээр л хажуугаас ажигладаг. Ингэснээр та нар зорилгодоо хүрсэн үү? Ийм маягаар та нар Намайг мэдэж авсан уу? Үнэнийг хэлэхэд, газар дээрх хүмүүсээс нэг нь ч Миний нүүр өөд эгцлэн харж чадахгүй, нэг нь ч Миний үгийн утгыг цэвэр, хольцгүй хүлээн авч чадахгүй. Иймээс Өөрийнхөө зорилгод хүрч, Өөрийн жинхэнэ дүрийг хүмүүсийн зүрх сэтгэлд байрлуулахын тулд Би урьд өмнө тохиолдож байгаагүй төслийг газар дэлхий дээр явуулсан. Ийм маягаар Би, үзэл нь хүмүүсийг эрхшээлдээ байлгадаг эринийг төгсгөнө.

Өнөөдөр Би агуу улаан лууны улс оронд бууж ирснээр үл барам, Өөрийн

царайг бүхий л орчлон ертөнцийн зүг хандуулж, дээд тэнгэрийг тэр чигт нь донсолгож байна. Миний шүүлтэд өртөхгүй ганц ч гэсэн газар бий юу? Миний буулгасан гамшиг дор оршдоггүй ганц ч гэсэн газар бий юу? Би хаашаа ч явсан бүх төрлийн “гай гамшгийн үрийг” цацсан. Энэ нь Миний ажилладаг арга замуудын нэг, мөн хүнийг аврахын төлөө гэдэг нь эргэлзээгүй бөгөөд тэдэнд Миний хүртээдэг зүйл бол мөн л нэг төрлийн хайр юм. Бүр олон хүн Намайг мэдэж, Намайг харж чаддаг болж, ийм маягаар маш олон жилийн турш хараагүй боловч яг одоо бодитой байгаа Бурханыг хүндэлж эхлээсэй гэж Би хүсдэг. Би энэ дэлхийг ямар шалтгаанаар бүтээсэн бэ? Хүмүүсийг ялзарсан байдалтай болоход Би ямар учраас тэднийг бүрмөсөн устгаагүй вэ? Ямар учраас бүхий л хүн төрөлхтөн гай гамшиг дунд амьдардаг вэ? Махбод өмссөний минь зорилго юу вэ? Намайг ажлаа хэрэгжүүлж байхад амт нь гашуун төдийгүй, бас чихэрлэг болохыг хүмүүс мэддэг. Дэлхий дээрх бүх хүнээс Миний нигүүлсэл дотор амьдардаггүй хэн байна вэ? Би хүмүүст материаллаг ерөөл хүртээгээгүй бол энэ дэлхий дээр хэн ихийг эдэлж чадах байсан бэ? Та нарыг Өөрийн ардуудын байр сууринд аваачих нь ерөөл юм гэж үү? Та нар Миний ардууд биш, харин үйлчлэл үзүүлэгч байсан бол Миний ерөөл дотор оршихгүй байх байсан уу? Та нарын дотроос нэг нь ч Миний үгийн эх сурвалжийг ухан ойлгох чадваргүй. Хүмүүс Миний олгосон цолыг огтхон ч эрхэмлэн дээдэлдэггүй, харин “үйлчлэл үзүүлэгч” гэдэг цолоос үүдэн зүрх сэтгэлдээ гомдол агуулж явдаг нь их олон бөгөөд “Миний ард” гэдэг цолоос үүдэн зүрх сэтгэлдээ Намайг гэх хайраа өсгөдөг хүн олон байдаг. Хэн ч Намайг мэхлэхээр оролдох ёсгүй; Миний нүд бүхнийг хардаг! Та нарын дотроос хэн дуртайяа хүлээн авч, бүрэн дуулгавартай байдаг вэ? Хэрвээ хаанчлалын ёслолын буудлага тасхийгээгүй бол та нар эцэст нь хүртэл үнэхээр дуулгавартай дагаж чадах уу? Хүмүүс юу хийж, юу бодох чадвартайг, мөн хэр хол явж чадахыг—энэ бүх зүйлийг Би аль эрт урьдчилан тодорхойлсон.

Хүмүүсийн асар олонх нь Миний нүүр царайны гэрэлд Миний шатаалтыг хүлээн авдаг. Хүмүүсийн асар олонх нь Миний зоригжуулалтаар өдөөгдөж, эрж хайн урагшлахаар үймэлддэг. Сатаны хүчнүүд Миний ардууд руу дайрах үед Би тэднийг няцаадаг; Сатаны явуулга тэдний амьдралыг сүйтгэх үед Би тэрнийг хэзээ ч эргэж ирэхгүйгээр бут ниргэдэг. Газар дээр төрөл бүрийн муу ёрын сүнс амрах газар хайн үүрд тэнүүчилж, идэж болох хүний цогцсыг эцэс төгсгөлгүй хайж байна. Миний ардууд аа! Та нар Миний халамж, хамгаалалт дотор үлдэх ёстой. Хэзээ ч бүү садар самуун бай! Хэзээ ч бүү болчимгүй авирла! Харин

үнэнч байдлаа Миний гэрт өргөл болго, та нар диаволын арга мэхний эсрэг зөвхөн үнэнч байдлаар л сөрөг дайралт хийж чадна. Та нар ямар ч нөхцөл байдалд, өнгөрсөнтэйгээ адилаар авирлан, Миний өмнө нэгийг хийж, Миний ар хударгаар өөрийг хийх ёсгүй; тэгэх юм бол та нар аль хэдийн аврагдах аргагүй болжээ. Би иймэрхүү үг дэндүү ихийг айлдсан бус уу? Хүний хуучин уг чанар засаршгүй учраас л Би хүмүүст ахин дахин сануулах ёстой болсон. Бүү залх! Миний хэлж байгаа бүхэн та нарын хувь заяаг хамгаалахын төлөө байдаг! Бузар заваан газар л Сатанд яг хэрэгтэй зүйл юм; аврагдах найдваргүй байх тусам, мөн садар самуун байж, хориг хязгаарлалтад захирагдахаас татгалзах тусам бузар сүнснүүд та нарт нэвтрэх аливаа боломжийг төдий чинээ их ашиглана. Та нар энэ цэгт хүрсэн бол үнэнч байдал чинь ямар ч бодит зүйлгүй дэмий яриа болох ба бузар сүнснүүд шийдвэрийг чинь залгиж, дуулгаваргүй байдал юм уу сатанлаг явуулга болгон хувиргаад Миний ажлыг үймүүлэхэд ашиглана. Тэр үеэс Би та нарыг хэдийд ч цохиж болзошгүй. Энэ нөхцөл байдал хэчнээн ноцтой болохыг хэн ч ойлгодоггүй; хүмүүс бүгд сонссон зүйлээ чихнийхээ хажуугаар л өнгөрүүлдэг ба өчүүхэн төдий ч болгоомжтой байдаггүй. Урьд өмнө болсон зүйлсийг Би санадаггүй; Би дахин нэг удаа “мартсанаар” чамд өршөөнгүй хандана гэж чи үнэндээ хүлээсээр байна уу? Хүмүүс Намайг эсэргүүцсэн ч гэсэн Би тэрийг нь тэдний эсрэг хэрэглэхгүй, учир нь тэдний биеийн хэмжээ хэтэрхий жаахан, иймээс Би тэдэнд хэт өндөр шаардлага тавиагүй. Тэднээс Би садар самуун бус байж, хориг хязгаарлалтад захирагд гэж л шаарддаг. Энэ нэг болзлыг хангах нь та нарын чадвараас давсан зүйл биш биз дээ? Ихэнх хүн нүдээ хужирлахын тулд улам олон нууц илчлэхийг минь хүлээдэг. Гэсэн ч тэнгэрийн бүх нууцыг ойлголоо гэхэд чи тэр мэдлэгээрээ юу хийж чадах юм бэ? Энэ нь Намайг гэх хайрыг чинь ихэсгэх байсан уу? Энэ нь Намайг гэх хайрыг чинь төрүүлэх байсан уу? Би хүмүүсийг дутуу үнэлдэггүй, тэдний талаар хөнгөн хуумгай дүгнэлт ч гаргадаггүй. Эдгээр нь хүмүүсийн бодит нөхцөл байдал биш байсан бол Би хүмүүст ийм хаяг шошгыг хэзээ ч санамсаргүйгээр титэм адилаар өмсгөхгүй. Өнгөрснийг эргээд бод: Би та нарыг хэдэн удаа гүтгэсэн бэ? Би та нарыг хэчнээн удаа дутуу үнэлсэн бэ? Хэчнээн удаа Би бодит нөхцөл байдлыг чинь харгалзан үзэлгүйгээр та нарыг харсан бэ? Хэчнээн удаа Миний айлдвар та нарыг бүрэн үнэмшүүлж чадаагүй вэ? Хэчнээн удаа Би та нарын сэтгэлийн утсыг хөндөлгүйгээр ярьсан бэ? Та нарын дундаас хэн чинь Миний үгийг айж, дагжилгүйгээр, өөрийг нь ёроолгүй нүх рүү цохин унагаана гэж гүнээ айлгүйгээр уншсан бэ? Миний үгэн доторх шалгалтыг туулдаггүй хэн байна вэ? Миний

айлдварууд дотор эрх мэдэл оршдог, гэвч энэ нь хүмүүст санамсаргүй шүүлт оноохын төлөө байдаггүй; харин ч Би хүний бодит нөхцөл байдлыг анхааран үзэж, Миний үгэнд угаас байдаг утга учрыг тэдэнд байнга харуулдаг. Үнэндээ, Миний үгэнд буй бүхнийг чадагч хүчийг ухаарах чадвартай хүн байна уу? Миний үгийн шижир алтан бүтээгдэхүүнийг өөртөө хүлээн авч чадах хэн нэгэн байна уу? Би яг хэр олон үг хэлсэн бэ? Тэдгээрийг эрхэмлэсэн хүн ер нь байсан уу?

1992 оны 3 дугаар сарын 3

ХААНЧЛАЛЫН СҮЛД ДУУЛАЛ

Үй түмэн хүн Намайг уухайлдаг, үй олон хүн Намайг магтдаг; бүх ам нэгэн жинхэнэ Бурханыг дуудаж, бүх хүн Миний үйл хэргийг харахаар хараагаа бэлчээдэг. Хаанчлал хүний ертөнцөд бууж ирлээ, Миний үнэн бие баялаг агаад элбэг дэлбэг. Үүнд баясахгүй хэн байх билээ? Баяр хөөртэйгөөр бүжихгүй хэн байх билээ? Өө, Сион! Намайг тэмдэглэхийн тулд ялгуусан тугаа өргө! Ялалтын ялгуусан дуугаа дуулж, Миний ариун нэрийг түгээ! Газар дэлхийн зах хязгаар дахь бүх бүтээл ээ! Миний төлөө тахил болохоор өөрсдийгөө яаран цэвэрлэ! Тэнгэрүүдийн одны орд оо! Даруйхан байрандаа эргэн очиж огторгуйд Миний сүр хүчийг харуул! Намайг гэх дундаршгүй хайр хүндлэлээ шингээсэн газар дээрх хүмүүсийн дууг Би чих тавин сонсож байна! Бүх бүтээл эргэн амилах энэ өдөр, Би хүний ертөнцөд буун ирсэн. Энэ мөчид, яг энэ үед бүх цэцэг цоморлогоо дэлгэж, бүх шувуу нэгэн өнгөөр жиргэж, бүх зүйл баяр хөөрөөр цалгидаг! Хаанчлалын ёслолын буудлагын дуунаар Сатаны хаанчлал нуран унаж, хаанчлалын сүлд дууллын нүргээнд дахин хэзээ ч өндийхгүйгээр устан үгүй болдог!

Газар дээр хэн өндийн босож, эсэргүүцэж зүрхлэх билээ? Газар луу буухдаа Би шатаалт, уур хилэн, бүх гай гамшиг авчирдаг. Газар дээрх хаанчлалууд одоо Миний хаанчлал болсон! Тэнгэрт үүлс хөлбөрөн нүүгэлтдэг; тэнгэрийн дор гол нуурууд долгиж, сэтгэл уярам аялгууг баясалтайгаар урсгадаг. Ичсэн амьтад үүрнээсээ гарч, бүх хүнийг Би зүүд нойрноос нь сэрээдэг. Түмэн олон ардын хүсэн хүлээсэн өдөр эцэстээ ирлээ! Тэд хамгийн сайхан дууг Надад өргөн барьдаг!

Ийм сайхан мөчид, энэхүү баярт цаг үед

дээд тэнгэр, доод газарт хаа сайгүй магтаал ундардаг. Хэн үүнд баярлан хөөрөхгүй байх билээ?

Хэний зүрх сэтгэл уужрахгүй байх билээ? Хэн энэ дүр зурагт нулимс унагахгүй байх билээ?

Тэнгэр урьдын тэнгэр байхаа больж, одоо хаанчлалын тэнгэр болсон.

Газар өмнөх шигээ биш болж, одоо ариун газар болсон.

Аадар бороо өнгөрсний дараа бузар хуучин ертөнц бүрэн шинэчлэгдсэн.

Уулс өөрчлөгдөж байна ... ус өөрчлөгдөж байна...

хүмүүс ч бас өөрчлөгдөж байна ... бүх зүйл өөрчлөгдөж байна...

Ай, аниргүй уулс аа! Босоод Миний төлөө бүж!

Ай, тогтоол ус аа! Цааш чөлөөтэй урс!

Зүүдэлж буй хүмүүс ээ! Сэрээд эрж хай!

Би ирсэн ... Би хаанчилсан...

Бүх хүн Миний царайг нүдээрээ харж, дуу хоолойг минь чихээрээ сонсож, хаанчлалын амьдралаар өөрсдөө амьдарна...

Хэчнээн жаргалтай ... хэчнээн сайхан гээч...

Мартагдашгүй ... мартахын аргагүй...

Миний уур хилэнгийн галд агуу улаан луу тэмцэлдэнэ;

Миний сүр жавхлант шүүлтээр диаволууд жинхэнэ төрхөө харуулна;

Миний хатуу үгэнд хүмүүс бүгд гүнээ ичиж, нүүр хийх газаргүй болдог.

Өөрийг минь дооглож, тохуурхаж байснаа тэд эргэн санадаг.

Онгирч бардаагүй цаг үе тэдэнд огт үгүй, Намайг эсэргүүцэж байгаагүй цаг үе гэж хэзээ ч үгүй.

Өнөөдөр уйлаагүй хэн байна? Гэмшиж харуусаагүй хэн байна?

Орчлон тэр аяараа уйлаан майлаанд автдаг...

баяр баяслын дуугаар бялхдаг ... инээд хөөрөөр цалгидаг...

Зүйрлэшгүй их баяр хөөр ... зүйрлэх аргагүй баяр хөөр...

Зөөлөн бороо шивэрч ... их цас малгайлан бударна...

Хүмүүсийн сэтгэлд баяр хөөр, уйтгар гуниг сүлэлдэнэ ... зарим нь инээнэ... зарим нь уйлна ... бас зарим нь уухайлна...

Үүлэрхэг, хуртай хавар уу, цэцэгс дэлгэрсэн зун уу,

арвин ургацтай намар уу, жавартай хүйтэн өвөл үү гэдгийг

хүн бүр мартчихсан мэт, хэн ч мэдэхгүй...

Тэнгэрт үүлс хөвж, газарт тэнгис цалгилна.

Хөвгүүд гараа даллаж ... хүмүүс цогин бүжнэ...

Тэнгэрэлчүүд ажиллаж ... тэнгэрэлчүүд хонь хариулж байна...

Газар дээрх хүмүүс яаравчилж, газар дээрх бүх зүйл олширч байна.

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (12-Р БҮЛЭГ)

Аянга зүүн зүгээс цахих үе нь бас Би үгээ айлдаж эхлэх яг тэр мөч бөгөөд— аянга цахих үед бүхий л орчлон ертөнц гэрэлтэж, бүх од хувирдаг. Бүх хүн төрөлхтөн ангилагдсан мэт байдаг. Зүүн зүгийн гэрлийн энэхүү цацрагийн туяан дор бүх хүн төрөлхтний анхдагч төрх илчлэгдэж, нүд нь гялбаж, яахаа мэддэггүй бөгөөд үзэшгүй муухай төрхөө яаж нуухаа бүр ч мэддэггүй. Тэд бас Миний гэрлээс зугтан уулын агуй руу дүрвэж байгаа амьтадтай адил байдаг—гэхдээ тэдний дундаас хэн нь ч Миний гэрэл дотроос арчигдан арилж чадахгүй. Бүх хүн гайхаж, бүгд хүлээсээр, бүгд харсаар байгаа; Миний гэрэл ирснээр бүгд өөрсдийн төрсөн өдөрт баярлахын сацуу өөрсдийн төрсөн өдрийг хараадаг. Зөрчилдөөнтэй сэтгэл хөдлөлийг тодорхой илэрхийлэх боломжгүй; өөрийгөө зэмлэсэн нулимс нь гол горхи үүсгэн, хүчтэй ширүүн урсгалд урсаж, нүд ирмэх төдийд ул мөргүй арилна. Миний өдөр дахин нэг удаа хүн төрөлхтөнд ойртож ирэн, хүн төрөлхтнийг дахин нэгэнтээ сэрээж, хүн төрөлхтөнд шинээр эхлэх цэгийг өглөө. Миний зүрх цохилж, Миний зүрхний цохилтыг дагаад уулс баяртайгаар дэвхэрч, ус баярлан бүжиж, давлагаа хадан цохио мөргөнө. Миний зүрх сэтгэлд юу байгааг илэрхийлэхэд хэцүү. Би бүх бохир зүйлийг Өөрийн харцны дор үнс нурам болтол шатаахыг хүсдэг; бүх дуулгаваргүй хөвгүүдийг дахин хэзээ ч оршин тогтноулалгүй, нүднийхээ өмнөөс арилгахыг хүсдэг. Би агуу улаан лууны аж төрдөг газарт шинэ эхлэлийг бий болгоод зогсоогүй, мөн орчлон ертөнц дээр шинэ ажил эхлүүлсэн. Удалгүй дэлхийн хаанчлалууд Миний хаанчлал болно; удалгүй Миний хаанчлалаас болж, мөн Би аль хэдийн ялалтад хүрч, ялгууснаар эргэн ирснээс болж газар дээрх хаанчлалууд оршин тогтнохоо үүрд болино. Агуу улаан луу Миний төлөвлөгөөг тасалдуулахын тулд боломжтой бүр аргыг барж, газар дээрх Миний ажлыг үгүй болгохоор найдсан, гэхдээ түүний зальжин арга мэхнээс болж Миний зориг мохож болох уу? Би түүний заналхийллээс сүрдээд итгэл найдвараа алдаж болох уу? Миний гарт байдаггүй ганц ч зүйл тэнгэрт ч, газарт ч хэзээ ч байгаагүй; товойллогч болж Надад үйлчилдэг энэ хэрэгсэл буюу агуу улаан лууны хувьд бүр ч тийм байдаг бус уу? Тэр ч гэсэн Миний гараар жолоодуулдаг зүйл биш гэж үү?

Намайг хүний ертөнцөд бие махбодтой болсон үед хүн төрөлхтөн Миний удирдамж дор өөрийн мэдэлгүй өдий хүрч, өөрийн мэдэлгүй Намайг мэдэж авсан. Гэвч өмнө нь буй замаар яг хэрхэн алхах талаар хэн ч таамагладаггүй, хэн ч мэддэггүй—тэрхүү зам өөрсдийг нь хааш аваачихыг мэдэх хүн бүр ч байдаггүй. Зөвхөн Төгс Хүчит харж хандвал л хүн замын төгсгөл хүртэл явж чадна; зүүн зүг дэх аянгаар замчлуулснаар л хүн Миний хаанчлалын хаалгаар алхан орж чадна. Хүмүүсийн дунд Миний царайг харсан хүн, зүүн зүгийн аянгыг харсан хүн хэзээ ч байгаагүй; тэгвэл Миний сэнтийгээс гарч буй айлдварыг сонссон хүн хэчнээн цөөхөн байх билээ? Үнэндээ, эрт дээр үеэс хойш нэг ч хүн Миний үнэн биетэй шууд харилцаагүй; өнөөдөр л дэлхий дээр ирсэн үед минь хүмүүс Намайг харах боломжтой болсон. Гэхдээ одоо ч гэсэн хүмүүс Намайг мэдэхгүй хэвээр байна, тэд юу гэж байгааг минь ойлголгүйгээр зүгээр л Миний царайг харж, Миний дуу хоолойг сонсдог. Бүх хүн ийм байдаг. Миний ардуудын нэг болохоор та нар Миний царайг харахдаа гүн гүнзгий бахархлыг мэдэрдэг бус уу? Та нар Намайг мэддэггүй учраас адгийн ичгүүрийг мэдэрдэг бус уу? Би хүмүүсийн дунд алхаж, хүмүүсийн дунд амьдардаг, учир нь Би махбод болж, хүний ертөнцөд ирсэн билээ. Миний зорилго бол хүмүүст Өөрийн махан биеийг харуулах төдийхөн биш; үүнээс ч чухал нь Өөрийгөө мэдүүлэх явдал юм. Түүнчлэн, Би Өөрийн махбод болсон биеэр дамжуулан хүнийг нүглийнх нь төлөө яллана; Өөрийн махбод болсон биеэр дамжуулан Би агуу улаан лууг ялж, ичээг нь бүрмөсөн устгана.

Хэдийгээр газар дэлхийд суурьшсан хүмүүс тэнгэрийн од шиг тоо томшгүй олон боловч Би тэднийг бүгдийг нь алган дээрээ тавьсан мэт тодорхой мэддэг. Мөн Намайг “хайрладаг” хүмүүс далайн элс мэт тоолж баршгүй хэдий ч тун цөөхөн хүнийг л Би сонгодог: Намайг “хайрладаг” хүмүүсээс гадна хурц гэрлийг эрэлхийлдэг хүмүүс л сонгогддог. Би хүнийг хэт өндрөөр үнэлдэггүй, бас дутуу ч үнэлдэггүй; харин угийн шинж чанарт нь тааруулан хүнд шаардлага тавьдаг тул хүмүүсийг сонгох зорилгоо биелүүлэхийн тулд Би Намайг чин сэтгэлээсээ эрж хайдаг хүнийг л шаарддаг. Ууланд тоймгүй олон зэрлэг араатан байдаг ч Миний өмнө бүгд хонь шиг номхон байдаг; далайн давлагаан дор ойлгошгүй олон гайхамшиг оршдог боловч Миний өмнө өөрсдийгөө газрын гадарга дээрх бүх зүйлтэй адил тодорхой харуулдаг; дээд тэнгэрүүдэд хүний хэзээ ч хүрч чадахгүй ертөнц байдаг, харин тэдгээр хүршгүй ертөнцөд Би чөлөөтэй алхалдаг. Хүн Намайг гэрэлд хэзээ ч таниагүй, харин Намайг харанхуйн ертөнцөд л харсан. Та нар ч гэсэн өнөөдөр яг адилхан нөхцөл байдалд байгаа

биш гэж үү? Агуу улаан лууны галзуу хилэн оргилдоо хүрэх цагт Би Өөрийн ажлыг албан ёсоор махбодоор эхлүүлсэн. Агуу улаан луу жинхэнэ дүр төрхөө анх удаа илчилсэн үед Би Өөрийн нэрийг гэрчилсэн. Намайг хүн төрөлхтний замаар алхах үед нэг ч амьтан, нэг ч хүн цочиж сэрээгүй тул бие махбодтой болоод хүний ертөнцөд ирэхэд минь хэн ч мэдээгүй. Гэхдээ Өөрийн махбод болсон биеэр ажлаа хийж эхэлсний дараа Миний нижигнэсэн дуунаар хүмүүс зүүднээсээ цочин сэрж, энэ мөчөөс эхлэн Миний удирдамж дор амьдарч эхэлсэн. Өөрийн ардуудын дунд Би шинэ ажлыг дахин нэгэнтээ эхлүүлсэн. Газар дээрх Миний ажил дуусаагүй гэж хэлсэн нь Миний ярьсан Миний ардууд бол зүрх сэтгэлдээ Миний шаарддаг хүмүүс биш гэдгийг хангалттай харуулдаг, гэсэн ч Би тэдний дундаас заримыг нь мөн л сонгодог. Би Өөрийн ардуудад бие махбодтой болсон Бурханыг мэдүүлээд зогсохгүй, бас тэднийг цэвэрлэдэг нь үүнээс илэрхий юм. Миний захиргааны зарлиг хатуу чандаас болж хүмүүсийн дийлэнх олонх нь Надаар таягдуулах аюулд байсаар байгаа. Та нар өөрсөдтэйгөө харьцахын тулд хамаг хичээл чармайлтаа гаргаж, өөрсдийн биеийг захирахгүй бол—ингэхгүй л бол яг л Паул шууд Миний гараас гэсгээлт хүртээд, үүнээс зугтах аргагүй байсантай адилаар Миний жигшин голдог бай болж, там руу хаягдах нь гарцаагүй. Та нар Миний үгээс ямар нэг зүйлийг олж мэдэж авсан уу? Би бол бүхэлдээ ариун, өө сэвгүй Бурхан Өөрөө учраас урьдын адилаар чуулганыг цэвэрлэж, Өөрт хэрэгтэй хүмүүсийг үргэлжлүүлэн ариусгах нь Миний санаа зорилго юм. Би Өөрийн сүмийг солонгын өнгөөр солонгоруулах төдийгүй дотор талыг нь гадна талтайгаа зохицохуйц өө сэвгүй цэвэрхэн болгоно. Миний өмнө та нар дор бүрнээ урьд нь юу хийснээ тунгаан бодож, өнөөдөр Миний зүрх сэтгэлийг төгс хангалуун болгохоор сэтгэл шулуудаж чадах эсэхээ шийдэх хэрэгтэй.

Хүн ердөө махбодод байгаа Намайг мэддэггүй ч юм биш; үүнээс гадна тэр махан биед оршдог өөрийгөө ч ойлгож чадаагүй. Маш олон жилийн турш хүмүүс Намайг мэхэлж, Надад гаднаас ирсэн зочин мэт хандсаар ирсэн. Маш олон удаа тэд Намайг “гэрийнхээ хаалганы” гадна үлдээн хаалгаа хаасан; маш олон удаа Миний өмнө зогсоод Надад ямар ч анхаарал хандуулаагүй; маш олон удаа тэд бусад хүмүүсийн дунд Надаас татгалзсан; маш олон удаа тэд Намайг диаволын өмнө үгүйсгэсэн; маш олон удаа тэд хэрүүлч амаараа Над руу дайрч давшилсан. Гэсэн ч Би хүний сул талуудыг санадаггүй, дуулгаваргүй байдлаас нь үүдэн шүдийг шүдээр төлөхийг шаарддаггүй. Би гагцхүү түүний эдгэшгүй өвчнийг эдгээж, улмаар эрүүл саруул болгохын тулд өвчинд нь эм хэрэглэсэн

бөгөөд ингэвэл тэр Намайг мэдэж авч магадгүй юм. Миний хийсэн бүхэн хүний оршин тогтнолын төлөө, хүний амьдралд боломж олгохын төлөө байгаагүй гэж үү? Олон удаа Би хүний ертөнцөд ирсэн боловч Өөрийн үнэн биеэр энэ дэлхийд ирснээс болж хүмүүс Намайг огт тоогоогүй; харин ч хүссэнээрээ авирлаж, өөртөө л гарах гарц хайсан. Тэнгэрийн доорх зам нэг бүр Миний гараас бий болдог гэдгийг тэд ер мэддэггүй! Тэнгэрийн доорх юм болгон Миний тушаалд захирагддаг гэдгийг тэд ер гадарладаггүй! Та нараас хэн зүрх сэтгэлдээ гомдол дургүйцэл өвөрлөж зүрхэлдэг вэ? Та нараас хэн яаран дүгнэлт гаргаж зүрхэлдэг вэ? Би зүгээр л хүмүүсийн дунд Өөрийнхөө ажлыг чимээгүйхэн хийсээр ирсэн. Хэрвээ бие махбодтой байх хугацаандаа Би хүний сул талыг өрөвдөөгүй бол гагцхүү бие махбодтой болсноос минь болж бүх хүн ухаанаа алдтал айчхаад, түүнийхээ уршгаар Үхэгсдийн оронд уначихсан байх байлаа. Би Өөрийгөө даруухан байлгаж, Өөрийгөө нуусан учраас л хүмүүс гай гамшгаас зайлж, Миний гэсгээлтээс ангижирсан ба ийм маягаар өнөөдрийг хүрсэн. Өнөөдрийг хүрэх нь хэчнээн хэцүү байсныг бодолцон үзээд та нар хүрэлцэн ирэх маргаашийг бүр ч илүү ихээр нандигнах ёстой бус уу?

1992 оны 3 дугаар сарын 8

ХҮМҮҮС ЭЭ, БҮГД БАЯРЛАН ХӨӨРЦГӨӨ!

Миний гэрэлд хүмүүс гэрлийг дахин хардаг. Миний үгээс хүмүүс таашаадаг зүйлсээ олдог. Би Зүүн зүгээс ирсэн, Би Зүүн зүгээс гаралтай. Миний суу алдар цацрахад бүх үндэстэн гэрэлтэж, бүгд гэрэлд гарч, харанхуйд нэг ч зүйл үлддэггүй. Хаанчлалд, Бурханы ардууд Бурхантай хамт амьдардаг амьдрал хэмжээлшгүй жаргалтай. Хүмүүсийн ерөөлт амьдралд ус баяртайгаар бүжиж, Миний элбэг дэлбэг байдлыг уулс хүмүүстэй хамт эдэлдэг. Миний хаанчлалд бүх хүн чармайж, шаргуу ажиллаж, үнэнч гэдгээ харуулж байна. Хаанчлалд бослого, эсэргүүцэл гэж байхгүй болж, тэнгэр газар хоёр бие биедээ найдаж, хүн бид хоёр бие биедээ түшиглэн, амьдралын баярт цэнгэлээр дамжуулан гүн мэдрэмжээр дотносдог... Энэ цаг үед Би тэнгэр дэх амьдралаа албан ёсоор эхэлдэг. Сатаны үймээн байхаа больж, хүмүүс амралтад ордог. Орчлон даяар, хүмүүс дунд амьдарч буй хүмүүсийн хувиар бус, Бурхантай хамт амьдарч буй хүмүүсийн хувиар Миний сонгосон хүмүүс энгүй их ерөөгдөж, Миний суу алдар дотор амьдардаг. Бүх хүн төрөлхтөн Сатаны завхралыг туулж, амьдралын жаргал зовлонг тултал нь амссан. Одоо Миний гэрэлд амьдарч байгаа хүн

баясахаас өөр яалтай? Энэ сайхан мөчөөс татгалзаж, алдаж өнгөрүүлж яахан чадах билээ? Хүмүүс ээ! Миний төлөө зүрх сэтгэлдээ дуу дуулж, баяртайгаар бүжицгээ! Чин сэтгэлээ аваад Надад өргөн барьцгаа! Миний төлөө бөмбөрөө дэлдэж, баяртайгаар тоглоцгоо! Би баяр баяслаа бүх орчлон даяар цацруулдаг! Хүмүүст Би алдар суут царайгаа илчилдэг! Би чанга дуугаар уриалан дуудна! Би орчлон ертөнцийг давна! Би угаасаа хүмүүсийн дунд хаанчилдаг! Хүмүүс Намайг өргөмжилдөг! Би дээд хөх тэнгэрт хөвж, хүмүүс Надтай хамт алхдаг. Би хүмүүсийн дунд алхаж, Миний ардууд Намайг тойрон хүрээлдэг! Хүмүүсийн зүрх сэтгэл баярлаж, дуу хуур нь орчлонг донсолгож, тэнгэрт ан цав үүсгэдэг! Орчлон ертөнц манан буданд бүрхэгдсэн байхаа больж, шалбаагүй болж, муу ус цуглахаа больдог. Орчлонгийн ариун хүмүүс ээ! Миний шинжилт дор та нар жинхэнэ дүр төрхөө харуулдаг. Та нар бузар булайд бүрхэгдсэн хүмүүс бус, хаш чулуу шиг цэвэр ариун хүмүүс, бүгд Миний хайртууд, бүгд Миний баяр хөөр билээ! Бүх зүйл эргэн амилдаг! Ариун хүмүүс бүгд халуун тэврэлтэд минь орж, мэгшин уйлах, санаа зовохоо больж, өөрсдийгөө Надад өргөж, гэрт минь эргэн ирж, тэнгэрт Надад үйлчлэхээр эргэн ирсэн бөгөөд тэд төрөлх нутагтаа Намайг зогсолтгүй хайрлана! Үүрд мөнхөд үл өөрчлөгдөнө! Уй гуниг хаа байна! Нулимс хаа байна! Махан бие хаа байна! Газар дэлхий улиран оддог ч тэнгэр үүрд. Би бүх ард түмэнд үзэгдэж, бүх ард түмэн Намайг магтдаг. Балар эрт үеэс цаг хугацааны төгсгөл хүртэл энэ амьдрал, энэ гоо үзэсгэлэн өөрчлөгдөхгүй. Хаанчлалын амьдрал энэ билээ.

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (26-Р БҮЛЭГ)

Хэн Миний гэрт амьдран суусан бэ? Хэн Миний төлөө зогссон бэ? Хэн Миний оронд зовсон бэ? Хэн Миний өмнө ам өчгөө өгсөн бэ? Хэн өнөөг хүртэл Намайг дагасан хэр нь хайхрамжгүй болоогүй вэ? Яагаад хүмүүс бүгдээрээ хүйтэн хөндий, хатуу сэтгэлтэй байдаг юм бэ? Хүн төрөлхтөн яагаад Намайг орхисон бэ? Хүмүүс яагаад Надаас залхсан бэ? Хүний ертөнцөд яагаад халуун дулаан байдал байдаггүй юм бэ? Сионд байхдаа Би тэнгэрт байдаг халуун дулааныг амталж, тэнгэрт байдаг ерөөлийг эдэлсэн. Дахин хүн төрөлхтний дунд амьдраад Би хүний ертөнцийн гашуун зовлонг амсаж, хүмүүсийн дунд байдаг янз бүрийн байр байдлыг бүгдийг нь Өөрийн нүдээр харсан. Нэг л мэдэхэд, Намайг “өөрчлөгдөхийн” хэрээр хүн өөрчлөгдсөн, гагцхүү ийм маягаар л тэр өнөөдөртэй

золгожээ. Миний төлөө юу ч хийж чаддаг бай гэж Би хүнээс шаарддаггүй, Миний төлөө ямар нэгэн өсөлт гарга гэж ч шаарддаггүй. Харин Миний төлөвлөгөөний дагуу үйлдэж, Надад дуулгаваргүй хандахгүйгээр, эсвэл Миний ичгүүрийн тэмдэг бололгүйгээр Надад цангинасан гэрчлэл хийж чаддаг байгаасай гэж л Би хүсдэг. Хүмүүсийн дунд Надад сайн гэрчлэл хийж, Миний нэрийг алдаршуулсан хүмүүс байсан ч хүний хэрэгжүүлэлт, биеэ авч явах байдал Миний сэтгэлийг хангалуун болгож яахан чадах билээ? Хүн Миний хүсэлд нийцэж, Миний хүслийг биелүүлж яахан чадах билээ? Газар дээрх уул ус, газар дээрх цэцэг ногоо, өвс ургамал, модод бүгд Миний гарын урыг харуулж, бүгд Миний нэрийн төлөө оршин тогтнодог. Гэтэл хүн яагаад Миний шаардсан стандартад хүрч чаддаггүй юм бэ? Адгийн дорд байдлаасаа болоод тэр үү? Би түүнийг өргөмжилснөөс болоод тэр үү? Хүнд Би хэт харгис хандсанаас болоод тэр үү? Хүн яагаад Миний шаардлагаас цаг ямагт айна вэ? Өнөөдөр хаанчлал дахь олон түмний дундаас та нар дуу хоолойг минь л сонсохоос биш, царайг минь харахыг яагаад хүсдэггүй юм бэ? Миний үгийг Миний Сүнстэй тааруулалгүйгээр яагаад зүгээр л хардаг юм бэ? Яагаад Намайг дээд тэнгэр, доод газарт тусгаарладаг юм бэ? Газар дээр байхдаа Би тэнгэрт байдгаасаа өөр байдаг гэж үү? Тэнгэрт байхдаа Би газарт буун ирж чадахгүй гэж үү? Газарт байхдаа Би тэнгэрт хүрэх үнэ цэнгүй байдаг юм гэж үү? Газарт байх үедээ Би дорд амьтан мэт, тэнгэрт байх үедээ Би өргөмжит оршихуй мэт, тэнгэр газрын дунд эвлэршгүй ан цав байгаа мэт байдаг. Гэвч хүний ертөнцийнхөн эдгээр зүйлийн гарал үүслийн талаар юу ч мэдэхгүй мэт байцгаан, Миний үг дуу чимээнээс цаашгүй, ямар ч утга учиргүй мэтээр үргэлж Миний эсрэг явж ирлээ. Бүх хүн төрөлхтөн Миний үгэнд хичээл зүтгэл гаргаж, гадаад байдлыг минь өөрсдөө шинжилдэг ч бүгд л бүтэлгүйтэж, хичээл чармайлт нь ямар ч үр дүнд хүрдэггүй, харин ч Миний үгэнд цохигдоод дахин босож зүрхэлдэггүй.

Хүн төрөлхтний итгэлийг турших үед минь нэг ч хүн жинхэнэ гэрчлэл хийж чаддаггүй, нэг ч хүн бүхнээ өргөн барьж чаддаггүй; харин зүрх сэтгэлээ Надад булаалгах гэж байгаа мэт хүн үргэлжлүүлэн нуугдаад, сэтгэлээ нээхээс татгалзсаар байдаг. Иов хүртэл шалгалтын үеэр хэзээ ч үнэхээр тууштай зогсоогүй, мөн зовлон шаналал дунд ч сайн сайхныг цацруулаагүй. Хавар цагийн дулаанд бүх хүн ялимгүй ногоордог; өвлийн хүйтэн жаварт тэд хэзээ ч ногооноороо байдаггүй. Яс арьс болж, турж эцсэн биеийн хэмжээтэй хүн Миний санаа зорилгыг биелүүлж чадахгүй. Бүх хүний дунд бусдадаа үлгэр дуурайл болж чадах нэг ч хүн байхгүй, учир нь бүх хүн үндсэндээ адилхан, нэг нэгээсээ

ямар ч ялгаагүй, өөр хоорондоо ялгарах зүйл багатай. Иймээс хүмүүс өнөөдөр ч гэсэн Миний үйл хэргийг бүрэн дүүрэн мэдэх чадваргүй хэвээр байдаг. Миний гэсгээлт бүх хүн төрөлхтөн дээр буух үед л хүмүүс өөрийн мэдэлгүй Миний ажлыг мэддэг болно, мөн Намайг юу ч хийгээгүй, хэнийг ч албадаагүй байхад хүн Намайг мэдэж авч, улмаар Миний үйл хэргийг харна. Энэ бол Миний төлөвлөгөө, Миний харуулсан үйл хэргийн нэг тал бөгөөд хүний мэдэх ёстой зүйл юм. Хаанчлалд тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл дахин сэргэж, амийн хүчээ ахин дахин олж авч эхэлдэг. Газар дэлхийн байр байдал өөрчлөгдсөний улмаас нутаг дэвсгэрийн хил хязгаар ч бас өөрчлөгдөж эхэлдэг. Өмнө нь Би, газар нь газраас тасарч, газар нь газартай нэгдэх үе бол бүх улс үндэстнийг бут цохих үе минь байх болно гэж зөгнөсөн. Энэ үед Би бүх бүтээлийг шинэчлэн бүхий л орчлон ертөнцийг дахин хуваарилж, улмаар орчлон ертөнцийг эмх цэгцэд оруулж, хуучныг шинэ болгон хувиргана—энэ бол Миний төлөвлөгөө, эдгээр нь Миний ажил билээ. Дэлхийн улс үндэстэн, ард түмэн бүгд Миний сэнтийн өмнө буцаж ирэх үед Би тэнгэрийн бүх хишгийг аваад хүний ертөнцөд хүртээнэ, ингэснээр хүний ертөнц Миний ачаар зүйрлэшгүй их хишгээр бялхах болно. Гэхдээ хуучин ертөнц оршсоор байгаа цагт Би Өөрийн уур хилэнг улс үндэстнүүд рүү нь буулгаж, захиргааны зарлигаа орчлон ертөнц даяар ил тод зарлаж, түүнийг зөрчсөн хэнд ч гэсгээлт хүртээнэ:

Намайг үг хэлэхээр орчлон ертөнцийн зүг царайгаа хандуулахад бүх хүн төрөлхтөн Миний дуу хоолойг сонсож, дараа нь орчлон ертөнц даяар Миний хийсэн бүх үйл хэргийг хардаг. Миний хүслийн эсрэг явдаг хүмүүс буюу хүний үйл хэргээр Намайг эсэргүүцдэг хүмүүс Миний гэсгээлт дор унана. Би тэнгэр дэх тоймгүй олон одыг авч шинэчилнэ, Миний ачаар нар сар ч шинэчлэгдэнэ—хурмаст тэнгэр урьдынх шигээ байхаа больж, газар дээрх тоо томшгүй олон зүйл шинэчлэгдэнэ. Миний үгээр дамжуулан бүх зүйл бүрэн төгс болно. Орчлон ертөнц дэх олон улс үндэстэн шинээр хуваагдаж, Миний хаанчлалаар солигдоно, ийнхүү газар дээрх улс орнууд үүрд үгүй болж, бүгдээрээ Надад шүтэн мөргөдөг хаанчлал болно; газар дээрх бүх улс орон сөнөж, оршин тогтнохоо болино. Орчлон ертөнц дэх хүмүүсээс диаволд харьяалагддаг бүх хүн устана; Сатаныг шүтдэг бүх хүн Миний дүрэлзсэн галд унана. Өөрөөр хэлбэл, одоо энэ урсгалд байгаа хүмүүсээс бусад нь үнсэн товрог болно. Олон ард түмнийг гэсгээх үед минь шашны ертөнц дэх хүмүүс цагаан үүл хөлөглөн айсуй Ариун Нэгнийг харсан байх тул Миний ажлаар байлдан дагуулагдаж, өөр өөр түвшинд Миний хаанчлалд эргэн ирнэ. Бүх хүн төрлөөрөө ангилагдаж,

өөрсдийнхөө үйлдэлд тохирсон гэсгээлтийг хүртэнэ. Миний эсрэг зогссон хүмүүс бүгд мөхнө; харин газар дээрх үйл хэрэг нь Надтай хамаагүй байсан хүмүүс биеэ хэрхэн авч явснаасаа үүдэн Миний хөвгүүд, Миний ардуудын засаглал дор газар дэлхий дээр оршсоор байна. Би тоо томшгүй олон хүн, тоймгүй олон улс үндэстэнд Өөрийгөө илчилж, газар дэлхий дээр Өөрийнхөө дуу хоолойгоор үг хэлж, агуу ажлынхаа биелэлтийг тунхаглан, бүх хүн төрөлхтөн үүнийг нүдээрээ харна.

Дуу хоолой минь эрчимжихэд Би орчлон ертөнцийн байр байдлыг ч бас ажигладаг. Тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл бүгд Миний үгээр шинэчлэгддэг. Тэнгэр өөрчлөгдөж, газар ч бас өөрчлөгддөг. Хүмүүсийн анхдагч төрх ил болж, аажмаар хүн бүр төрлийнхөө дагуу ангилагдаж, өөрийн мэдэлгүй гэр бүлийнхнийхээ тэвэрт буцан очих замаа олно. Үүнийг Би ихэд таална. Би саад тотгороос ангид бөгөөд нэг л мэдэхэд Миний агуу ажил гүйцэлдэж, тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл бүгд өөрчлөгддөг. Би дэлхийг бүтээхдээ бүх зүйлийг төрлөөр нь загварчилж, хэлбэр дүрстэй бүх зүйлийг өөрсдийнх нь төрөлтэй хамт тавьсан. Миний удирдлагын төлөвлөгөөний төгсгөл ойртож байгаа тул Би бүтээлийн хуучин байр байдлыг сэргээнэ; Би бүх зүйлийг анхдагч байдалд нь оруулж, бүхнийг гүн гүнзгий өөрчилнө, ингэснээр бүх зүйл Миний төлөвлөгөөнд эргэж ирнэ. Цаг нь ирлээ! Миний төлөвлөгөөний сүүлчийн үе шат гүйцэлдэх гэж байна. Аяа, бузар хуучин ертөнц өө! Чи Миний үгийн дор гарцаагүй унана! Миний төлөвлөгөөгөөр юу ч үгүй болох нь гарцаагүй! Аяа, тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл ээ! Та нар бүгд Миний үгэн дотроос шинэ амь олж авна— захирагч Эзэнтэй болно! Аяа, цэвэр ариун, өө сэвгүй шинэ ертөнц өө! Миний алдар дотор чи гарцаагүй сэргэнэ! Аяа, Сион Уул аа! Чимээгүй байхаа боль— Би ялгууснаар эргэж ирлээ! Бүтээлийн дундаас Би бүх газар дэлхийг шинждэг. Газар дээр хүн төрөлхтөн шинэ амьдрал эхлүүлж, шинэ итгэл найдвартай болсон. Аяа, Миний ардууд аа! Миний гэрэл дотор та нар эргэн амилахгүй байж яаж чадах юм бэ? Миний удирдамж дор баярлан дэвхцэхгүй байж яаж чадах юм бэ? Хуурай газар баясан хашхирч, ус хөгжөөнтэйгөөр инээн долгилно! Аяа, дахин амилсан Израиль аа! Миний урьдчилан тогтоосныг чи бахдахгүй байж яаж чадах юм бэ? Хэн мэгшин уйлсан бэ? Хэн цурхиран уйлсан бэ? Хуучны Израиль үгүй болж, өнөөгийн Израиль дэлхий дээр өндийн, сүндэрлэн байгуулагдаж, бүх хүний зүрх сэтгэлд бослоо. Өнөөдрийн Израиль Миний ардуудаар дамжуулан оршин тогтнолын эх үүсвэрт гарцаагүй хүрнэ! Аяа, заналт Египет ээ! Чи Миний эсрэг зогсохоо больсон байлгүй дээ? Чи Миний

өршөөлийг далимдуулж, Миний гэсгээлтээс зугтахыг оролдож яаж чадна вэ? Миний гэсгээлт дотор оршихгүй байж яаж чадах юм бэ? Миний хайрладаг бүх хүн гарцаагүй үүрд мөнх амьдарна, харин Миний эсрэг зогсдог бүхнийг Би мөнхөд гэсгээх нь гарцаагүй. Учир нь Би хартай Бурхан бөгөөд хийсэн бүхнийх нь төлөө хүмүүсийг амархан хэлтрүүлэхгүй. Би бүхий л газар дэлхийг ажиглан харж, зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн болон гэсгээлттэйгээр ертөнцийн зүүн зүгт гарч ирж, тоймгүй олон хүнд Өөрийгөө илчилнэ!

1992 оны 3 дугаар сарын 29

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД (29-Р БҮЛЭГ)

Бүх зүйл дахин амилсан өдөр Би хүмүүсийн дунд ирсэн ба Би түүнтэй хамт гайхалтай өдөр, шөнүүдийг өнгөрүүлсэн. Зөвхөн энэ үед л хүн Миний ойр дотно байдлыг жаахан мэдэрдэг ба Надтай харилцах нь улам байнгын болох тусам тэрээр Надад юу байгаа, Би юу болох талаар зарим нэгийг ойлгодог—үүний үр дүнд тэр Миний талаар тодорхой хэмжээний мэдлэг олж авдаг. Бүх хүний дунд Би толгойгоо өргөж харахад тэд бүгд Намайг хардаг. Гэсэн ч дэлхийд гай гамшиг тохиолдох үед тэд тэр даруй зовон түгшиж, Миний дүр төрх тэдний зүрх сэтгэлээс арилдаг; гамшиг ирэхэд тэд балмагдаж, Миний сургамжийг үл ойшоодог. Би хүмүүсийн дунд олон жилийг өнгөрүүлсэн боловч хүн дандаа тоомжиргүй хэвээр байж, Намайг ер мэдээгүй. Өнөөдөр Би хүнтэй Өөрийн амаар ярьж, Өөрөөсөө ямар нэг зүйл авхуулахын тулд бүх хүнийг өмнөө ирүүлдэг ч тэд Надаас зай барьсан хэвээр байгаа тул Намайг мэддэггүй. Миний мөр орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаар хүртэл явах үед хүн өөрийгөө эргэцүүлж эхлэх ба бүх хүн Над руу ирж, Миний өмнө мэхийн ёсолж, Намайг шүтэн мөргөнө. Энэ нь Би алдрыг олж авах өдөр, Миний эргэн ирсэн өдөр, мөн Миний явах өдөр байх болно. Одоо Би бүх хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг эхэлчихсэн, бүх орчлон даяар Өөрийн удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийг албан ёсоор эхлүүлчихсэн. Анхаарал болгоомжгүй хэнд ч энэ мөчөөс эхлэн хайр найргүй гэсгээлт оногдож болзошгүй бөгөөд энэ нь хэдийд ч тохиолдож магадгүй. Би цэвдэг сэтгэлтэйдээ энэ биш; харин ч энэ нь Миний удирдлагын төлөвлөгөөний нэг алхам; бүгд Миний төлөвлөгөөний алхмуудын дагуу явах ёстой ба ямар ч хүн үүнийг өөрчилж чадахгүй. Намайг ажлаа албан ёсоор эхлэх үед бүх хүн Намайг хөдлөхөд хөдөлж, тийнхүү орчлон ертөнц даяарх хүмүүс өөрсдөө Миний

алхамтай хөл нийлүүлж, орчлон ертөнц дахинд “баяр баясал” бий болох ба хүн Надаас урам зориг авна. Үүний үр дүнд агуу улаан луу өөрөө Надад шавхуурдуулан будилж, самуурсан байдалд орж, Миний ажилд үйлчлэх ба хэдий дургүй байсан ч өөрийн хүслийг дагаж чадалгүй, Надад захирагдахаас өөр ямар ч аргагүй болно. Миний бүхий л төлөвлөгөөнд агуу улаан луу бол Миний товойлгогч, Миний дайсан, түүнчлэн Миний зарц; тиймээс Би тэрэнд тавих Өөрийн “шаардлагуудыг” хэзээ ч сулруулаагүй. Тийм учраас бие махбодтой болсон Миний ажлын сүүлчийн шат тэрний гэрт гүйцэлддэг. Ийм маягаар агуу улаан луу Миний төлөө зохистойгоор үйлчлэл үзүүлж илүү сайн чадна, үүгээр Би агуу улаан лууг байлдан дагуулж, Өөрийн төлөвлөгөөг гүйцээнэ. Намайг ажиллаж байхад тэнгэрэлчүүд бүгд Надтай хамт шийдвэрлэх тулаан эхлүүлж, сүүлчийн шатанд Миний хүслийг биелүүлэхээр шийддэг, ингээд газар дээрх хүмүүс тэнгэрэлчүүдийн адилаар Миний өмнө буулт хийж, Намайг эсэргүүцэх ямар ч хүсэлгүй болж, Миний эсрэг тэрслэх юу ч хийдэггүй. Эдгээр нь орчлон ертөнц даяарх Миний ажлын чиг хандлага билээ.

Хүмүүсийн дунд Миний ирсэн зорилго болон ач холбогдол нь бүх хүн төрөлхтнийг аварч, бүх хүн төрөлхтнийг Өөрийнхөө гэрт буцааж авчран тэнгэрийг газартай дахин нэгтгэж, мөн хүнийг тэнгэр, газрын хооронд “дохио” дамжуулдаг болгох явдал, учир нь энэ бол хүний төрөлхийн чиг үүрэг билээ. Хүн төрөлхтнийг бүтээх үедээ Би бүх зүйлийг тэдэнд бэлдэж хийсэн ба дараа нь Миний шаардлагын дагуу өөрсдөд нь өгсөн баялгийг хүлээн авахыг хүн төрөлхтөнд зөвшөөрсөн. Тиймээс Миний удирдамж дор хүн төрөлхтөн өнөөдөртэй золгосон гэж Би хэлдэг. Энэ нь бүгд Миний төлөвлөгөө юм. Бүх хүн төрөлхтний дотор тоо томшгүй олон хүн Миний хайрын хамгаалалт дор оршин суудаг, бас тоо томшгүй олон хүн Миний үзэн ядалтын гэсгээлт дор амьдардаг. Хүмүүс бүгдээрээ Надад залбирдаг ч өнөөгийн нөхцөл байдлаа өөрчилж чадахгүй л байдаг; найдвараа алдахаар тэд жам ёсонд захирагдахаас аргагүй болж, Надад дуулгаваргүй хандахаа больж чаддаг, учир нь хүний гүйцэтгэж чадах юм энэ л юм. Хүний амьдралын байдлын тухайд гэвэл, хүн жинхэнэ амьдралыг хараахан олоогүй, тэрээр энэ хорвоогийн шударга бус байдал, гансрал гутрал, золгүй байдлыг ухаарч хараахан чадаагүй—тиймээс, хэрэв гай зовлон гараагүй бол ихэнх хүмүүс мөн л Байгаль Эхийг шүтэх байсан ба өөрсдийнхөө “амьдралын” амтанд татагдсаар байх байсан. Энэ нь хүний ертөнцийн бодит байдал биш гэж үү? Хүнд хэлж буй Миний авралын дуу хоолой энэ биш гэж үү? Яагаад хүн төрөлхтний дотроос нэг нь ч Намайг хэзээ ч үнэхээр

хайрлаж байгаагүй вэ? Хүн яагаад зөвхөн гэсгээлт, шалгалтын дунд байхдаа л Намайг хайрладаг мөртөө Миний хамгаалалт дор байхдаа хэн ч Намайг хайрладаггүй юм бэ? Би Өөрийн гэсгээлтийг хүн төрөлхтөнд олон удаа хүртээсэн. Тэд үүнийг хардаг боловч дараа нь үл ойшоодог, тэгээд тэд үүнийг тухайн үедээ судалж, цэгнэдэггүй, иймээс хүнд очдог бүхэн бол ердөө л хайр найргүй шүүлт юм. Энэ бол Миний ажиллах аргуудын зөвхөн нэг нь боловч энэ нь мөн л хүнийг өөрчилж, хүнээр Өөрийгөө хайрлуулахын тулд байдаг билээ.

Би хаанчлалд хаанчилдаг, цаашлаад Би бүхий л орчлон ертөнцөд хаанчилдаг; Би бол хаанчлалын Хаан, орчлонгийн Тэргүүний аль аль нь билээ. Энэ цагаас эхлээд Би сонгогдоогүй бүх хүнийг цуглуулж, Өөрийн ажлыг Харь үндэстний дотор эхлэх болно, мөн Би Өөрийн захиргааны зарлигийг бүхий л ертөнцөд зарлаж, ингэснээр Өөрийн ажлын дараагийн алхмыг амжилттай эхлүүлнэ. Би Өөрийн ажлыг Харь үндэстнүүдийн дунд түгээхийн тулд гэсгээлт ашиглана, өөрөөр хэлбэл, Би Харь үндэстнүүдийн эсрэг хүч хэрэглэнэ. Мэдээжээр, энэхүү ажил нь сонгогдсон хүмүүсийн дунд явагдах Миний ажилтай зэрэг хийгдэнэ. Миний ардууд газар дээр засаглаж, эрх мэдэл эзэмших үе нь бас газар дээрх бүх хүнийг байлдан дагуулсан өдөр байх бөгөөд цаашлаад энэ нь Миний амрах цаг байна—зөвхөн тэр үед л Би байлдан дагуулагдсан бүхэнд харагдана. Би ариун хаанчлалд харагдаж, бузар газар нутгаас Өөрийгөө нууна. Байлдан дагуулагдсан, Миний өмнө дуулгавартай болсон бүх хүн Миний царайг нүдээрээ харж, Миний дуу хоолойг чихээрээ сонсож чадна. Энэ бол эцсийн өдрүүдэд төрсөн хүмүүсийн ерөөл, энэ бол Миний урьдчилан тогтоосон ерөөл бөгөөд үүнийг ямар ч хүн өөрчилж чадахгүй. Ирээдүйн ажлын төлөө өнөөдөр Би ингэж ажилладаг. Миний бүх ажил хоорондоо хамааралтай, бүгдэд нь дуудлага ба хариу байдаг: Ямар ч алхмыг хэзээ ч гэнэт зогсоодоггүй, хэзээ ч ямар ч алхмыг бусдаас нь тусад нь гүйцэтгэдэггүй. Ийм биш гэж үү? Өнгөрсөн үеийн ажил өнөөдрийн ажлын суурь биш гэж үү? Өнгөрсөн үеийн үг өнөөдрийн үгийн анхдагч биш гэж үү? Өнгөрсөн үеийн алхмууд өнөөдрийн алхмын эхлэл биш гэж үү? Би хуйлмал номыг албан ёсоор нээх үе нь орчлон ертөнц даяарх хүмүүс гэсгээгдэх үе, дэлхий дахины хүмүүст шалгалт тулгарах үе бөгөөд энэ нь Миний ажлын оргил үе юм; бүх хүн гэрэл гэгээгүй газар амьдарч, бүх хүн хүрээлэн буй орчныхоо заналхийлэл дунд амьдардаг. Өөрөөр хэлбэл, бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөг хүртэл хүмүүсийн туулаагүй амьдрал энэ бөгөөд эрин үеүдийн турш хэн ч ийм амьдралыг “эдэлж” байгаагүй, иймээс Би өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийсэн гэж хэлж байгаа юм. Энэ нь хэрэг явдлын

бодит байдал бөгөөд энэ нь дотоод утга учир билээ. Миний өдөр бүх хүн төрөлхтөнд ойртож байгаа учраас, мөн энэ нь хол юм шиг харагдахгүй, харин яг хүний нүдний өмнө байгаа учраас хэн айхгүй байж чадах юм бэ? Бас хэн үүнд баярлахгүй байж чадах юм бэ? Бузар Вавилон хотын төгсгөл эцэстээ ирлээ; хүн цоо шинэ дэлхийтэй дахин учирч, тэнгэр, газар өөрчлөгдөн шинэчлэгдсэн.

Намайг бүх улс үндэстэн, бүх хүнд илрэн харагдах үед тэнгэрт цагаан үүлс хөврөн Намайг далдална. Мөн газар дээрх шувууд Миний төлөө баяртайгаар дуулан бүжиглэж, газар дээрх уур амьсгалыг онцлон тэмдэглэх бөгөөд ингэснээр газар дээрх бүх зүйл амилж, цаашид “аажмаар доош живэхээ” больж, харин эрч хүчтэй уур амьсгал дунд амьдарна. Намайг үүлсийн дунд байхад хүн Миний царай, Миний нүдийг бүдэг бадаг хардаг ба энэ үедээ бага зэрэг айдас мэдэрнэ. Урьд нь тэр Миний тухай түүхэн баримтуудыг домгоос сонссон ба үүний үр дүнд Надад хагас итгэж, хагас эргэлзэж байна. Тэр Миний хаана байгааг, эсвэл Миний царай хэр томыг буюу энэ нь далай шиг өргөн үү, эсвэл ногоон зүлэг шиг хязгааргүй юу гэдгийг мэдэхгүй. Хэн ч эдгээр зүйлийг мэдэхгүй. Хүн Миний царайг өнөөдөр үүлэн дундаас хараад л домогт гардаг Би бол бодит гэдгийг мэдэрнэ, тэгээд Надад арай нааштай хандах ба Миний үйл хэргээс болж л Намайг бахдах нь жаахан ихэснэ. Гэхдээ хүн Намайг мэдэхгүй хэвээр байгаа бөгөөд Миний нэг хэсгийг л үүлэн дундаас хардаг. Дараа нь Би Өөрийн гарыг сунгаж хүнд үзүүлнэ. Хүн гайхширч, гараараа амаа таглан Миний гарт цохиулахаас ихэд айх ба тэгээд бахдалдаа бага зэргийн хүндлэл нэмнэ. Хүн анхааралтай байхгүй л бол Надад цохиулна хэмээн жигтэйхэн айж, Миний хөдөлгөөн бүрийг нүд салгалгүй хардаг—гэхдээ хүн ажигласнаас болж Би хязгаарлагддаггүй, Би гар дахь ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Миний хийдэг бүх үйл хэрэг хүнийг Надад илүү таатай ханддаг болгосон ба ингээд яваандаа Надтай харилцах гээд Миний өмнө ирдэг. Би хэн болох нь хүнд бүхэлдээ илчлэгдэх үед хүн Миний царайг харна, түүнээс хойш Би цаашид ахин нуугдахгүй, эсвэл Өөрийгөө хүнээс далдлахгүй. Орчлон ертөнц даяар Би бүх хүнд ил харагдах ба мах цуснаас бүрдсэн хүн бүр Миний үйл хэргийг бүгдийг нь харна. Бүхий л сүнслэг хүмүүс Миний гэрт гарцаагүй амар амгалан орших ба Надтай хамт гайхалтай ерөөлүүдийг эдлэх нь эргэлзээгүй. Миний анхаардаг бүх хүн гэсгээлтээс гарцаагүй мултрах бөгөөд сүнсний шаналал, бие махбодын зовлонгоос зайлсхийх нь гарцаагүй юм. Би бүх хүнд ил харагдаж, эрх мэдлийг атган ноёрхоно, ингэснээр үхдэлийн үнэр орчлон ертөнцөд тархахаа болино; үүний оронд Миний цэнгэг анхилуун үнэр бүхий л дэлхий даяар тархана, Миний

өдөр ойртож байгаа учраас хүмүүс сэрж, газар дээрх бүх зүйл эмх журамдаа орж, газар дэлхийн оршин байх өдрүүд үгүй болж байна, учир нь Би ирчихсэн!

1992 оны 4 дүгээр сарын 6

ИТГЭГЧИД ЯМАР ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ УЧИРТАЙ ВЭ

Бурханд анх итгэж эхэлснээсээ хойш хүний олж авсан зүйл юу вэ? Чи Бурханы талаар юу мэдэж авсан бэ? Бурханд итгэх итгэлийнхээ улмаас чи хэр их өөрчлөгдсөн бэ? Хүний Бурханд итгэх итгэл нь зөвхөн сүнсний аврал болоод махан биеийн сайн сайхны төлөө биш, мөн энэ нь Бурханы хайраар дамжуулан амьдралаа баяжуулах гэх мэт ч биш гэдгийг одоо та нар бүгд мэдэж байгаа. Үүний дагуу, хэрвээ чи махан биеийн сайн сайхны төлөө, эсвэл түр зуурын таашаалын төлөө Бурханыг хайрладаг бол эцэст нь Бурханыг гэсэн хайр чинь оргилдоо хүрч, чи юу ч гуйгаагүй байсан ч гэсэн чиний эрж хайж буй энэ хайр нь ариун бус хайр хэвээр байх бөгөөд Бурханд таашаагдахгүй юм. Өөрсдийн уйтгартай амьдралыг баяжуулж, зүрх сэтгэл дэх хоосон орон зайгаа дүүргэхийн тулд Бурханыг хайрлах хайрыг ашигладаг хүмүүс нь үнэхээр Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг хүмүүс биш, харин амар хялбар амьдралд шунадаг хүмүүс юм. Ийм төрлийн хайр нь албадсан, сэтгэлийн баяр хөөрийн төлөөх эрэл хайгуул бөгөөд Бурханд ийм төрлийн хайр хэрэггүй. Тэгвэл чиний хайр ямар төрлийн хайр нь вэ? Юуны төлөө чи Бурханыг хайрладаг вэ? Бурханыг гэсэн жинхэнэ хайр чамд одоо хэр их байгаа вэ? Та нарын олонхын чинь хайр дээр дурдсантай адил байдаг. Ийм хайр нь зөвхөн тухайн байдлыг л хадгалдаг; энэ нь хувиршгүй байж чаддаггүй, мөн хүнд үндэслэж ч чаддаггүй. Ийм төрлийн хайр нь цэцэглэснийхээ дараа жимслэлгүй хатаж ганддаг цэцэгтэй адил. Өөрөөр хэлбэл, ийм байдлаар Бурханыг нэгэнтээ хайрласны дараа өмнөх замд чинь чамайг удирдан хөтлөх хэн ч байхгүй бол чи нуран унана. Хэрвээ чи Бурханыг хайрлах үедээ л Бурханыг хайрлаж, дараа нь амь зан чанар чинь өөрчлөгдөөгүй хэвээр бол чи харанхуйн нөлөөний бүрхүүлээс зугтаж чадахгүй хэвээр байх бөгөөд Сатанд хүлэгдэж, түүнд мэхлүүлэхээс чөлөөлөгдөж мөн л чадахгүй байх болно. Тийм ямар ч хүн Бурханаар бүрэн авхуулж чадахгүй; эцэст нь тэдний сүнс, сэтгэл, бие Сатанд харьяалагдсан хэвээр байх болно. Үүнд эргэлзэх зүйл үгүй. Бурханаар бүрэн авхуулж чадахгүй тэдгээр хүмүүс өөрсдийн анхдагч байр луугаа, өөрөөр хэлбэл, Сатан руу буцан очих бөгөөд Бурханаас

ирэх шийтгэлийн дараагийн алхмыг хүлээн авахын тулд гал болон хүхэрт нууранд унана. Бурханаар авхуулсан хүмүүс нь Сатаныг орхиж, эзэмшлээс нь зугтсан хүмүүс юм. Тийм хүмүүсийг албан ёсоор хаанчлалын ардын тоонд оруулна. Ингэж л хаанчлалын ард бий болдог билээ. Чи ийм хүн болохыг хүсэж байна уу? Чи Бурханаар авхуулахыг хүсэж байна уу? Чи Сатаны эзэмшлээс зугтаж, Бурханд эргэн очихыг хүсэж байна уу? Чи одоо Сатанд харьяалагдаж байна уу, эсвэл хаанчлалын ардын тоонд орсон уу? Ийм зүйлс нь бүгд тодорхой байх ёстой бөгөөд ямар ч нэмэлт тайлбар шаардлагагүй.

Өнгөрсөн үед, олон хүн итгэл найдвараасаа үүдэн жолоогүй санаархал болон үзлээр эрж хайсан. Эдгээр асуудлыг одоохондоо хойш тавъя; гол зүйл нь та бүхнийг Бурханы өмнө хэвийн нөхцөл байдалтай байлгаж, Сатаны нөлөөллийн дөнгөнөөс аажмаар ангижруулах хэрэгжүүлэлтийн замыг олох явдал, ингэснээр та нар Бурханаар авхуулж, Бурханы та нараас хүссэн зүйлийг газар дээр амьдран харуулж чадах юм. Ийм маягаар л Бурханы санаа зорилгыг биелүүлж чадна. Олон хүн Бурханд итгэдэг боловч Бурханы хүсдэг зүйл юу болохыг, мөн Сатаны хүсдэг зүйл юу болохыг мэддэггүй. Тэд бусдад мунгинуу байдлаар итгэж, зүгээр л урсгал даган явдаг, иймээс хэзээ ч Христэд итгэгчийн хэвийн амьдралтай байдаггүй; үүнээс гадна, тэдэнд Бурхантай харилцах хэвийн харилцаа байх нь бүү хэл, хүн хоорондын ямар ч хэвийн харилцаа байдаггүй. Бурханы хүсэлд саад учруулж чадах хүний хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал олон гэдгийг үүнээс харж болно. Хүн Бурханд итгэх зөв замд ороогүй, мөн хүний амьдралын жинхэнэ туршлагад ч ороогүй гэдгийг батлахад энэ нь хангалттай юм. Тэгвэл Бурханд итгэх зөв замд орох гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Зөв замд орно гэдэг нь чи Бурханы өмнө зүрх сэтгэлээ үргэлж тайван байлгаж, Бурхантай хэвийн ярилцаж, хүнд дутагдаж байгаа зүйлсийг аажмаар мэдэж, Бурханы талаарх гүнзгий мэдлэгийг алгуур олж авна гэсэн үг юм. Үүгээр дамжуулан чиний сүнс өдөр бүр шинэ ойлголт болон гэгээрлийг олж авдаг; чиний хүсэл эрмэлзэл нэмэгдэж, үнэн рүү орохоор эрэлхийлдэг. Өдөр болгон шинэ гэрэл, шинэ ухаарал байдаг. Энэ замаар дамжуулан чи Сатаны нөлөөллөөс аажмаар ангижирч, амь чинь өсдөг. Ийм хүмүүс зөв замд орчихсон. Өөрийн бодит туршлагаа үнэлж дүгнэн, итгэлдээ эрэлхийлсэн замаа шалга: Дээр дурдсан зүйлстэй эдгээрийг харьцуулаад үзвэл чи зөв замд орсон уу? Ямар зүйлүүд дээр чи Сатаны дөнгө болон нөлөөнөөс ангижирсан бэ? Хэрвээ чи зөв замд хараахан ороогүй бол Сатантай холбогдсон холбоо чинь тасраагүй байна. Ингээд байгаад байвал Бурханыг хайрлахаар эрж хайж байгаа чинь жинхэнэ, үнэнч,

ариун хайранд хүргэх болов уу? Бурханы төлөөх чиний хайр бол гуйвшгүй агаад чин сэтгэлийнх гэж чи хэлдэг боловч Сатаны дөнгөнөөс ангижраагүй. Чи Бурханыг хуурахаар оролдож байгаа биш гэж үү? Хэрэв чи Бурханыг гэсэн ариун хайранд хүрч, Бурханаар бүрэн авхуулж, хаанчлалын ардын тоонд орохыг хүсэж байгаа бол эхлээд Бурханд итгэх зөв замд орох ёстой.

ЯЛЗАРСАН ХҮН БУРХАНЫГ ТӨЛӨӨЛЖ ЧАДАХГҮЙ

Хүн үргэлжид харанхуйн нөлөөний нөмрөг дор, Сатаны нөлөөнд хүлэгдэн, мултарч чадахгүй амьдарч ирсэн бөгөөд түүний зан чанарыг Сатан төлөвшүүлсэн болохоор улам бүр ялзарсаар байдаг. Хүн үргэлж ялзарсан сатанлаг зан чанартаа автан амьдарч, Бурханыг үнэхээр хайрлаж чаддаггүй гэж хэлж болно. Ийм болохоор хэрвээ хүн Бурханыг хайрлахыг хүсвэл өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө өргөмжилдөг, биеэ тоосон, ихэрхүү зан гэх мэт Сатаны зан чанарт харьяалагддаг бүхнээсээ ангижрах ёстой. Эс бөгөөс, түүний хайр бохирдсон, сатанлаг хайр бөгөөд Бурханы сайшаалыг хүртэж яасан ч чадахааргүй хайр юм. Ариун Сүнс шууд төгс болгож, харьцаж, эвдэж, засаж, сахилгажуулж, цохиж, цэвэршүүлэхгүй бол хэн ч Бурханыг жинхэнээсээ хайрлаж чадахгүй. Зан чанарын чинь нэг хэсэг Бурханыг төлөөлдөг, тиймээс өөрийгөө Бурханыг үнэхээр хайрладаг гэж хэлж байгаа бол чи биеэ тоосон яриатай хүн бөгөөд мулгуу нэгэн юм. Ийм хүмүүс бол тэргүүн тэнгэрэлч мөн! Хүний төрөлхийн уг чанар Бурханыг шууд төлөөлж чаддаггүй. Тэр Бурханаар төгс болгуулж төрөлх уг чанараа хаях ёстой бөгөөд зөвхөн Бурханы хүслийг анхаарч, Бурханы санаа зорилгыг биелүүлж, түүнчлэн Ариун Сүнсний ажлыг туулах тэр үед л түүний амьдран харуулдаг зүйлийг Бурхан хүлээн зөвшөөрөх боломжтой. Ариун Сүнсний ашигладаг хүн биш л бол махан биед амьдардаг хэн ч Бурханыг шууд төлөөлж чадахгүй. Гэхдээ, тийм хүний хувьд ч гэсэн зан чанар болон амьдран харуулдаг байдал нь Бурханыг бүрэн төлөөлдөг гэж хэлж болохгүй; түүний амьдран харуулдаг зүйлийг Ариун Сүнс чиглүүлдэг гэж л хэлж болно. Тийм хүний зан чанар Бурханыг төлөөлж чадахгүй.

Хүний зан чанарыг Бурхан тодорхойлдог, энэ нь маргаангүй бөгөөд үүнийг эерэг зүйл гэж үзэж болох боловч, зан чанарыг нь Сатан төлөвшүүлж ирсэн, тиймээс хүний зан чанар бол бүхэлдээ Сатаны зан чанар юм. Бурхан аливааг хийхдээ эрс шулуун зан чанартай байдаг ба ийм зан чанар надад ч бас илэрдэг, би яг адилхан зан ааштай тул миний энэ зан чанар Бурханыг төлөөлдөг гэж

зарим хүн хэлдэг. Энэ ямар төрлийн хүн бэ? Ялзарсан сатанлаг зан чанар Бурханыг төлөөлж чадна гэж үү? Өөрийнх нь зан чанар Бурханыг төлөөлдөг гэж хэлдэг хэн ч бай, Бурханыг доромжилж, Ариун Сүнснийг гутааж байна! Ариун Сүнсний ажилладаг арга замаас харвал, газар дээр Бурханы хийдэг ажил нь гагцхүү байлдан дагуулах явдал билээ. Ийм учраас хүнд хараахан цэвэрлээгүй олон завхарсан сатанлаг зан чанар байдаг, хүн Сатаны дүр төрхийг амьдран харуулсаар л байдаг, тэр үүнийгээ сайн зүйл гэж итгэдэг бөгөөд энэ нь хүний махан биеийн үйл хэргийг төлөөлдөг юм. Бүр тодруулбал, энэ нь Сатаныг төлөөлдөг бөгөөд Бурханыг яавч төлөөлж чадахгүй. Хүн тэнгэрийн амьдралыг газар дээр эдэлж, “Өө Бурхан минь! Би Таныг хайрлаж ханахгүй нь” гэх мэт үг хэлж чадах хэмжээнд Бурханыг аль хэдийн хайрладаг, мөн хамгийн өндөр хүрээнд хүрсэн байсан ч гэсэн тэднийг Бурханыг амьдран харуулдаг юм уу Бурханыг төлөөлдөг гэж хэлж болохгүй, учир нь хүний мөн чанар Бурханыхтай адилгүй билээ. Хүн Бурхан болох нь байтугай Бурханыг хэзээ ч амьдран харуулж чадахгүй. Ариун Сүнсний захирамж дор хүний амьдран харуулдаг зүйл Бурханаас хүнд тавьдаг шаардлагын дагуу л байдаг.

Сатаны бүх үйлдэл, үйл хэрэг хүнээс харагддаг. Одоо хүний бүх үйлдэл, үйл хэрэг бол Сатаны илэрхийлэл юм, иймд Бурханыг төлөөлж чадахгүй. Хүн Сатаны биелэл бөгөөд хүний зан чанар Бурханы зан чанарыг төлөөлж чаддаггүй. Зарим хүн сайн зан ааштай байдаг; Бурхан ийм хүний зан аашаар дамжуулан зарим нэг ажил хийж болох ба тэдний хийдэг ажлыг Ариун Сүнс чиглүүлж байдаг. Гэсэн ч түүний зан чанар Бурханыг төлөөлж чадахгүй. Тэдэн дээр Бурханы хийдэг ажил бол ердөө л аль хэдийн дотор нь байгаа зүйл дээр ажиллаж, өргөжүүлэх явдал юм. Өнгөрсөн эрин үеүдийн эш үзүүлэгчид ч бай, Бурханы ашигласан хүмүүс ч бай, хэн ч Бурханыг шууд төлөөлж чадахгүй. Бүх хүн орчин нөхцөлийн эрхээр л Бурханыг хайрлаж эхэлдэг ба хэн ч өөрийн хүслээр хамтран ажиллахаар чармайдаггүй. Эерэг зүйлс гэж юу вэ? Бурханаас шууд ирдэг бүхэн эерэг юм. Гэхдээ хүний зан чанарыг Сатан төлөвшүүлсэн бөгөөд Бурханыг төлөөлж чадахгүй. Зөвхөн бие махбодтой болсон Бурханы хайр, зовлонг тэвчих хүсэл, зөвт байдал, хүлцэнгүй, даруу, нуугдмал байдал л Бурханыг шууд төлөөдөг. Учир нь Тэр ирэх үедээ нүгэлт уг чанаргүй байсан ба Сатаны төлөвшлийг олж авалгүйгээр Бурханаас шууд ирсэн. Есүс зөвхөн нүгэлт бие махбодын төрхтэй болохоос биш нүглийг төлөөлдөггүй; тиймээс цовдлолоор дамжуулан (цовдлолын мөчийг нь оролцуулаад) ажлаа гүйцэлдүүлэхээс өмнөх үеийг хүртэлх Түүний үйлдэл, үйл хэрэг, үг бүгд

Бурханыг шууд төлөөлдөг. Нүгэлт уг чанартай ямар ч хүн Бурханыг төлөөлж чадахгүй ба хүний нүгэл Сатаныг төлөөлдөг гэдгийг батлахад Есүсийн жишээ хангалттай юм. Өөрөөр хэлбэл, нүгэл Бурханыг төлөөлдөггүй, Бурхан бол нүгэлгүй. Хүнд Ариун Сүнсний хийсэн ажлыг ч гэсэн Ариун Сүнс чиглүүлсэн л гэж үзэж болохоос биш Бурханы оронд хүн хийсэн гэж хэлж болохгүй. Гэхдээ, хүний тухайд бол түүний нүгэл ч, зан чанар ч Бурханыг төлөөлдөггүй. Өнгөрсөн үеэс өнөөдрийг хүртэл Ариун Сүнсний хүнд хийсэн ажлаас дүгнэвэл хүний амьдран харуулж байгаа бүхэн нь Ариун Сүнс хүн дээр ажилласны үр дүн гэдэг нь харагдана. Ариун Сүнс харьцаж, сахилгажуулсны дараа тун цөөн хүн үнэнийг амьдран харуулж чаддаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс л ажиллаад байдаг, хүний зүгээс хамтын ажиллагаа байдаггүй. Үүнийг тодорхой харж байна уу? Ийм болохоор Ариун Сүнсийг ажиллаж байхад Түүнтэй бүх чадлаараа хамтран ажиллаж, улмаар үүргээ биелүүлэхийн тулд чи юу хийх ёстой вэ?

ШАШНЫ ҮЙЛЧЛЭЛЭЭС АНГИЖРАХ ЁСТОЙ

Өөрийн ажлыг бүх орчлон ертөнцөд эхлүүлснээс хойш Бурхан нийгмийн бүх давхаргын хүмүүсийг оролцуулаад Өөрт нь үйлчлэх олон хүнийг урьдчилан тогтоосон. Түүний зорилго бол Өөрийн хүслийг биелүүлж, газар дээрх Өөрийн ажлыг төвөггүй гүйцэлдүүлэхэд оршино. Өөрт нь үйлчлэх хүмүүсийг сонгох Бурханы зорилго энэ билээ. Бурханд үйлчилдэг хүн бүр Бурханы хүслийг ойлгох ёстой. Түүний энэхүү ажил Бурханы мэргэн ухаан болон бүхнийг чадагч хүч, газар дээрх Түүний ажлын зарчмыг хүмүүст илүү тодорхой болгодог. Хүмүүс Түүний үйл хэргийг илүү тодорхой мэдээсэй гэсэндээ Өөрийн ажлыг хийж, хүмүүстэй харилцахын тулд үнэндээ Бурхан газар дээр ирсэн. Өнөөдөр, энэ бүлэг хүмүүс та нар бодитой Бурханд үйлчлэх хувьтай билээ. Энэ бол та нарын хувьд тоо томшгүй их ерөөл—Бурхан та нарыг үнэхээр өргөж байгаа хэрэг юм. Өөртөө үйлчлэх хүнийг сонгоход Бурханд үргэлж Өөрийн гэсэн зарчим байдаг. Бурханд үйлчлэх нь хүмүүсийн төсөөлдөг шиг зүгээр нэг урам зоригийн асуудал ердөө ч биш. Бурханы өмнө үйлчилдэг хэн боловч Бурханы удирдамж болон Ариун Сүнсний ажил тэдэнд байгаа учраас, мөн тэд үнэнийг эрэлхийлдэг хүмүүс учраас тийнхүү үйлчилдэг гэдгийг өнөөдөр та нар хардаг. Эдгээр нь Бурханд үйлчилдэг бүх хүнд байх ёстой хамгийн наад захын болзол билээ.

Бурханд үйлчлэх нь тийм ч амархан ажил биш. Ялзарсан зан чанар нь өөрчлөгдөлгүй үлдсэн хүмүүс хэзээ ч Бурханд үйлчилж чадахгүй. Хэрэв чиний

зан чанар Бурханы үгээр шүүгдэж, гэсгээгдээгүй бол зан чанар чинь Сатаныг төлөөлсөөр байдаг. Чи “сайн санааныхаа” улмаас Бурханд үйлчилдэг, чиний үйлчлэл сатанлаг уг чанарт чинь үндэслэдэг гэдгийг энэ нь баталдаг. Чи төрөлхийн зан аашаараа, өөрийн хувийн хүсэл зоргын дагуу Бурханд үйлчилдэг. Түүгээр ч барахгүй хийхийг хүсэж байгаа зүйлд чинь Бурхан баярлаж, хийхийг хүсдэггүй зүйлийг чинь Бурхан үзэн яддаг гэж чи үргэлж боддог; чи зөвхөн өөрийн хүсэл зоргын дагуу л ажилладаг. Үүнийг Бурханд үйлчилж байна гэж хэлж болох уу? Эцсийн эцэст чиний амь зан чанар өчүүхэн төдий ч өөрчлөгдөхгүй; харин ч үйлчлэл чинь чамайг бүр илүү зөрүүд болгосноор завхарсан зан чанарыг чинь туйлын үхширмэл болгоно. Тийм болохоор, Бурханд үйлчлэх талаар зөвхөн өөрийн чинь зан аашинд голлон суурилсан дүрэм журам, зан чанарынхаа дагуу үйлчилдэг үйлчлэлээс чинь урган гарсан туршлага чамд бий болно. Эдгээр нь хүний туршлага болон сургамж юм. Энэ бол хорвоо дээр амьдрах хүний амьдралын гүн ухаан юм. Ийм хүмүүсийг фарисайчууд, шашны албан тушаалтнууд гэж ангилж болно. Хэрвээ тэд хэзээ ч сэргэж гэмшихгүй бол эцсийн өдрүүдэд хүмүүсийг хууран мэхэлдэг хуурамч Христүүд, антихристүүд болж хувирах нь гарцаагүй. Яриад байсан хуурамч Христүүд болон антихристүүд ийм хүмүүсийн дундаас гарч ирнэ. Хэрвээ Бурханд үйлчилдэг хүмүүс өөрсдийн зан аашаа дагаж, өөрсдийн хүсэл зоригийн дагуу үйлддэг бол тэд хэзээ ч хамаагүй хөөн зайлуулагдах эрсдэлтэй. Бурханд үйлчилж олж авсан олон жилийн туршлагаа бусдын зүрх сэтгэлийг өөртөө татаж, тэднийг сургамжилж, хянаж, өндөр байр суурийг эзлэхэд ашигладаг хүмүүс—хэзээ ч гэмшиж, хэзээ ч нүглээ улайж, байр суурийн ашиг хонжооноос хэзээ ч татгалздаггүй—энэ хүмүүс Бурханы өмнө унах болно. Тэд бол Паултай адил, дээгүүр зиндаагаараа бардамнаж, эрдэм чадлаа гайхуулдаг. Бурхан ийм хүмүүсийг төгс болгохгүй. Ийм үйлчлэл Бурханы ажилд саад учруулдаг. Хүмүүс үргэлж хуучинтайгаа зууралддаг. Тэд өнгөрсөн үеийн үзэлтэй, өнгөрсөн үеийн бүх зүйлтэй зууралддаг. Энэ нь тэдний үйлчлэлд асар их саад бартаа болдог. Хэрэв чи тэдгээрийг хаяж чадахгүй бол эдгээр зүйл бүхий л амьдралыг чинь үгүй хийх болно. Хэдий чи гүйж байгаад хөлөө хугалж, хөдөлмөрлөж байгаад нуруугаа гэмтээсэн ч гэсэн, бүр Бурханд үйлчлэхэд амиа зориулсан ч гэсэн Бурхан чамайг өчүүхэн төдий ч сайшаахгүй. Харин ч эсрэгээрээ: Тэр чамайг мууг үйлдэгч гэж хэлнэ.

Өнөөдрөөс эхлэн, ямар ч шашны үзэлгүй, өөрсдийн хуучин би-гээ орхиход бэлэн, Бурханыг цайлган сэтгэлээр дуулгавартай дагадаг хүмүүсийг Бурхан

албан ёсоор төгс болгож, Бурханы үгийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Тэр төгс болгоно. Энэ хүмүүс өндийн босож Бурханд үйлчлэх ёстой. Бурханд эцэс төгсгөлгүй элбэг дэлбэг байдал, энгүй их мэргэн ухаан байдаг. Түүний гайхалтай ажил, үнэт үгс нь бүр ч олон хүн эдлэхийг хүлээж байгаа. Одоогийн байдлаар, шашны үзэлтэй, дээгүүр зиндаандаа эрддэг, өөрсдийгөө хойш тавьдаггүй хүмүүст эдгээр шинэ зүйлийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдаг. Ариун Сүнс энэ хүмүүсийг төгс болгох боломжгүй юм. Хэрвээ хүн дуулгавартай байхаар шийдээгүй, Бурханы үгээр цангадаггүй бол тэд эдгээр шинэ зүйлийг хүлээн зөвшөөрөх аргагүй байдаг. Тэд зүгээр л улам бүр тэрслүү, улам ов мэхтэй болж, тийнхүү буруу замд орж дуусдаг. Одоо Өөрийн ажлыг хийхдээ Бурхан, Өөрийг нь үнэхээр хайрлаж, шинэ гэрлийг хүлээн зөвшөөрч чадах илүү олон хүнийг өргөж, Тэр дээгүүр зиндаагаараа бардамнадаг шашны албан тушаалтнуудыг бүрмөсөн цавчин унагана. Өөрчлөлтийг зөрүүдлэн эсэргүүцдэг ийм хүмүүсээс нэгийг ч Тэр хүсдэггүй. Чи энэ хүмүүсийн нэг байхыг хүсэж байна уу? Чи үйлчлэлээ дур зоргоороо гүйцэтгэдэг үү, эсвэл Бурханы шаардсаныг хийдэг үү? Энэ бол чиний өөрөө мэдэж байх ёстой зүйл юм. Чи шашны албан тушаалтан уу, эсвэл Бурханаар төгс болгуулсан дөнгөж мэндэлсэн нярай юу? Чиний үйлчлэлээс хэр ихийг нь Ариун Сүнс сайшаадаг вэ? Үүнээс хэр ихийг нь Бурхан бүр санах ч үгүй вэ? Олон жилийн үйлчлэлийн чинь үр дүнд амь чинь хэр их өөрчлөгдсөн бэ? Чи энэ бүхнийг тодорхой мэдэж байна уу? Хэрвээ чамд жинхэнэ итгэл байдаг бол чи урьдын шашны хуучин үзлээ орхиж, Бурханд шинэ арга замаар илүү сайн үйлчлэх болно. Одоо өндийн босоход тийм ч их оройтоогүй байна. Шашны хуучин үзлийн улмаас хүн бүхий л амьдралаа алдаж болно. Хүний олж авсан туршлага Бурханаас төөрч, аливааг өөрсдийнхөөрөө хийхэд хүргэж болно. Хэрэв чи ийм зүйлийг хаяхгүй бол, амийн өсөлтөд чинь саад тээг болно. Өөрт нь үйлчилдэг хүмүүсийг Бурхан үргэлж төгс болгодог, тэднийг амархан хөөн зайлуулдаггүй. Хэрвээ чи Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг үнэхээр хүлээн зөвшөөрч, шашны хуучин хэрэгжүүлэлт болон дүрэм журмаа хаяж, шашны хуучин үзлээр өнөөдрийн Бурханы үгийг хэмжихээ больж чадсан цагт л чамд ирээдүй байх болно. Хэрвээ чи хуучинтайгаа зууралдаж, тэдгээрийг нандигнасан хэвээр байвал чамд аврагдах ямар ч арга үгүй. Бурхан тийм хүмүүсийг огт тоодоггүй. Хэрвээ чи үнэхээр төгс болгуулахыг хүсэж байгаа бол өмнөх бүх зүйлээ бүрмөсөн орхихоор шийдэх ёстой. Өмнө нь хийгдсэн зүйл зөв байсан ч гэсэн, энэ нь Бурханы ажил байсан ч гэсэн чи үүнийг орхиж, үүнтэй зууралдахаа больж чадах ёстой. Энэ нь гарцаагүй Ариун

Сүнсний ажил байгаад Ариун Сүнс шууд хийсэн байсан ч гэсэн өнөөдөр үүнийг орхих ёстой. Үүнтэй зууралдах ёсгүй. Энэ бол Бурханы шаардлага, Бүх зүйл шинэчлэгдэх ёстой. Бурхан Өөрийн ажил болон үгэндээ өмнө нь явагдсан хуучин зүйлийг дурддаггүй, Тэрээр хуучин түүхийг ухдаггүй. Бурхан үргэлж шинэ бөгөөд хэзээ ч хуучин байдаггүй Бурхан билээ. Тэр өнгөрсөн үеийн үгтэйгээ ч зууралддаггүй нь Бурхан ямар ч дүрэм журмыг дагадаггүй гэдгийг харуулдаг. Бурхан өмнө нь хийж байсан арга барилаар ажиллахаа больсон байхад хүн болохын хувьд, чи өнгөрсөн үеийн зүйлстэй үргэлж зууралдаж, тэдгээрийг тавьж явуулахаас татгалзаж, тэдгээрийг улиг болсон байдлаар тууштай хэрэгжүүлдэг бол үг болон үйлдэл чинь балагтай бус уу? Чи Бурхантай дайсагнаж байгаа бус уу? Чи энэ хуучин зүйлсээс болж бүхий л амьдралаа сүйтгэж, үрэн таран хийхийг хүсэж байна уу? Эдгээр хуучин зүйл чамайг Бурханы ажилд саад учруулдаг нэгэн болгох болно. Чи ийм хүн болмоор байна уу? Хэрэв чи тэгэхийг үнэхээр хүсэхгүй байвал хийж байгаа зүйлээ даруй зогсоогоод бүгдийг өөрчил; бүхнийг дахин шинээр эхэл. Бурхан өнгөрсөн үйлчлэлийг чинь санахгүй.

БУРХАНД ИТГЭХДЭЭ БУРХАНЫГ ДУУЛГАВАРТАЙ ДАГАХ ЁСТОЙ

Чи яагаад Бурханд итгэдэг вэ? Ихэнх хүн энэ асуултад будилдаг. Тэд үргэлж, бодитой Бурхан, тэнгэр дэх Бурхан хоёрын талаар тэс ондоо хоёр үзэл бодолтой байдаг нь тэд дуулгавартай дагахын тулд биш, харин тодорхой ашиг тус хүртэхийн тулд, эсвэл гай гамшгаас үүдсэн зовлонгоос мултрах гэж Бурханд итгэдэг гэдгийг харуулдаг. Тэр үед л тэд бага зэрэг дуулгавартай байдаг боловч дуулгавартай байдал нь болзолтой, хэтийн ирээдүйнхээ төлөө, албан хүчээр хийдэг. Тэгэхээр чи яг яагаад Бурханд итгэдэг юм бэ? Хэрвээ энэ нь гагцхүү хэтийн ирээдүй, хувь заяаны чинь төлөө юм бол огт итгэхгүй байсан нь дээр. Иймэрхүү итгэл бол өөрийгөө хуурч, өөрийгөө тайтгаруулж, өөрийгөө биширч буй хэрэг юм. Хэрвээ итгэл чинь Бурханыг дуулгавартай дагах суурин дээр үндэслээгүй бол эцсийн эцэст Бурханд тэрсэлснийхээ төлөө чи шийтгүүлэх болно. Итгэхдээ Бурханд дуулгавартай байхыг эрэлхийлдэггүй бүх хүн Бурханд тэрсэлдэг. Бурхан хүмүүсийг Өөрийг нь дуулгавартай дагадаг болоосой гэсэндээ үнэнийг эрж хайж, Өөрийнх нь үгээр цангаж, Өөрийнх нь үгийг идэж ууж, хэрэгжүүлэхийг тэднээс шаарддаг. Санаа зорилго чинь үнэхээр ийм бол

Бурхан гарцаагүй чамайг өргөж, чамд нигүүлсэнгүй хандах нь лавтай. Энэ бол маргаангүй бөгөөд үүнийг өөрчлөхийн аргагүй билээ. Хэрвээ санаа зорилго чинь Бурханд дуулгавартай байхын тулд биш өөр зорилготой байдаг бол хэлж, хийдэг бүхэн чинь—Бурханы өмнө залбирах залбирал хийгээд үйлдэл бүр чинь хүртэл—Бурханы эсрэг байх болно. Чи зөөлөн дуутай, эелдэг зан ааштай байж болно, үйлдэл, илэрхийлэл бүр чинь зөв мэт, өөрөө чи дуулгавартай нэгэн шиг харагдаж болох ч санаа зорилго, Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлын чинь тухайд гэвэл чиний хийдэг бүхэн Бурханы эсрэг, ёрын муу байдаг. Хонь шиг дуулгавартай харагддаг атлаа зүрх сэтгэлдээ муу санаа тээж явдаг хүмүүс хонины арьс нөмөрсөн чоно бөгөөд Бурханд шууд халддаг тэднээс Бурхан ганцыг нь ч өршөөхгүй. Ариун Сүнс тэднийг нэг бүрчлэн илчилж, хоёр нүүртэн болгоныг Ариун Сүнс гарцаагүй жигшин голох болно гэдгээ бүх хүнд харуулна. Санаа бүү зов, Бурхан тэдэнтэй нэг бүрчлэн харьцаж, ээлж дараалан зайлуулна.

Хэрвээ чи Бурханы шинэ гэрлийг хүлээн зөвшөөрч чаддаггүй, Бурханы өнөөдөр хийдэг бүхнийг ойлгож чаддаггүй, мөн үүнийг эрж хайдаггүй эсвэл үүнд эргэлзэж, шүүмжилж, үүнийг шинжиж, шинжилдэг бол чамд Бурханыг дуулгавартай дагах сэтгэл гэж алга. Өнөө цагийн гэрэл гарч ирэх үед өчигдрийн гэрлийг нандигнасан хэвээр байж, Бурханы шинэ ажлыг эсэргүүцвэл чи хөгийн амьтнаас цаашгүй бөгөөд Бурханд зориуд тэрсэлдэг хүмүүсийн нэг мөн. Бурханд дуулгавартай байхын гол түлхүүр бол шинэ гэрлийг ойлгож, хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх чадвартай байх явдал билээ. Энэ л жинхэнэ дуулгавартай байдал юм. Бурханыг хүсэмжлэх хүсэлгүй хүмүүс зориуд Бурханд захирагдаж чаддаггүй, харин байгаа байдалдаа сэтгэл хангалуун байдгаасаа болж Бурханд тэрсэлж л чадна. Хүн өмнө нь ирсэн зүйлд автсан учраас Бурханыг дуулгавартай дагаж чаддаггүй. Урьд өмнө нь ирсэн зүйлс хүмүүст Бурханы талаарх бүх төрлийн үзэл, төсөөлөл өгч, эдгээр нь тэдний оюун ухаанд Бурханы дүр болсон байдаг. Тиймээс тэд өөрсдийн үзэл болон төсөөлсөн стандартууддаа итгэдэг. Хэрвээ чи, өнөөдөр бодит ажил хийдэг Бурханыг өөрийн төсөөллийн Бурхантай харьцуулдаг бол итгэл чинь Сатанаас гардгийн дээр чиний эрхэмлэдэг зүйлсээр сэвтсэн байна—харин Бурхан ийм итгэлийг хүсдэггүй. Чадвар чансаа нь хэчнээн сүртэй, хэчнээн их зориулдаг нь хамаагүй—бүр бүх насныхаа хичээл зүтгэлийг Түүний ажилд зориулж, зовж тарчилсан ч бай—Бурхан ийм итгэлтэй хэнийг ч сайшаадаггүй. Тэр тэдэнд ердөө л өчүүхэн бага нигүүлсэл хайрлаж, үүнийг хэсэгхэн хугацаанд эдлэх боломж олгодог. Ийм хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг, Ариун

Сүнс тэдний дотор ажилладаггүй бөгөөд Бурхан тэднийг ээлж дараалан таягдан хаях болно. Хөгшин, залуу байхаас үл хамааран, Бурханд итгэхдээ Бурханыг дуулгавартай дагадаггүй, буруу санаа бодолтой хүмүүс бол эсэргүүцэж, саад хийдэг хүмүүс бөгөөд Бурханаар таягдуулах нь дамжиггүй билээ. Бурханд огт дуулгавартай байдаггүй, нэрийг нь хүлээн зөвшөөрөх төдий байдаг, Бурханы сайхан сэтгэл, хайр татам байдлыг бага зэрэг мэдэрдэг ч Ариун Сүнсний алхаатай хөл нийлэн алхдаггүй, Ариун Сүнсний одоогийн ажил, үгийг дуулгавартай дагадаггүй хүмүүс Бурханы нигүүлсэл дунд амьдардаг бөгөөд Бурханаар авхуулж, төгс болгуулахгүй. Бурхан дуулгавартай байдал, Бурханы үгийг идэж, ууж, таашааж байгаагаар нь, мөн амьдралынх нь зовлон шаналал, цэвэршүүлэлтээр дамжуулан хүмүүсийг төгс болгодог. Ийм итгэлээр л хүмүүсийн зан чанар өөрчлөгдөж, ингэснээр л тэд Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг эзэмшиж чаддаг. Ухамсартайгаар Бурханыг дуулгавартай дагана гэдэг бол Бурханы нигүүлсэл дунд амьдрахдаа сэтгэл ханалгүй үнэнийг идэвхтэйгээр хүсэмжилж, үнэнийг хайж, Бурханаар авхуулахыг эрэлхийлнэ гэсэн үг; Бурханы ийм л итгэлийг хүсдэг билээ. Бурханы нигүүлслийг эдлэхээс өөр юу ч хийдэггүй хүмүүс төгс болгуулж, өөрчлөгдөж чадахгүй бөгөөд тэдний дуулгавартай байдал, сүсэг бишрэл, хайр, тэвчээр бүгд өнгөцхөн юм. Бурханы нигүүлслийг л эдэлдэг хүмүүс Бурханыг үнэхээр таньж мэдэж чаддаггүй бөгөөд Бурханыг мэдлээ ч мэдлэг нь өнгөцхөн байдгийн дээр “Бурхан хүнд хайртай”, “Бурхан хүнд энэрэнгүй ханддаг” гэх мэт зүйл ярьдаг. Энэ нь хүний амийг төлөөлдөггүй, бас хүмүүс Бурханыг үнэхээр мэддэг гэдгийг харуулдаггүй. Бурханы үг өөрсдийг нь цэвэршүүлж, Бурханы шалгалт өөрсдөд нь ирэх үед хүмүүс Бурханыг дуулгавартай дагаж чадалгүй, харин ч эргэлзэж, бүтэлгүйтдэг бол тэд огтхон ч дуулгаваргүй юм. Тэдэнд Бурханд итгэх итгэлийн талаарх олон дүрэм, хязгаарлалт, мөн олон жилийн итгэлийн дүнд олж авсан хуучин туршлагууд, Библи дээр үндэслэсэн янз бүрийн дүрэм журам байдаг. Иймэрхүү хүмүүс Бурханд дуулгавартай байж чадах уу? Хүмүүний зүйлс дүүрэн энэ хүмүүс яаж Бурханд дуулгавартай байж чадах юм бэ? Тэд эрхэмлэдэг зүйлийнхээ дагуу “дуулгавартай дагадаг”—иймэрхүү дуулгавартай байдлыг Бурхан хүснэ гэж үү? Энэ бол Бурханыг дуулгавартай дагаж байгаа биш, харин дүрэм журмыг мөрдөж буй хэрэг; мөн өөрсдийгөө тайтгаруулж, сэтгэл хангалуун болгож байгаа явдал юм. Үүнийгээ чи Бурханд дуулгавартай байна гэж хэлбэл Түүнийг доромжилж байгаа хэрэг бус уу? Чи бол мууг үйлддэг, Бурханд тэрслэх ажил онцгойлон хийдэг Египетийн Фараон—Чамайг иймэрхүү үйлчлэл хийхийг

Бурхан хүснэ гэж үү? Чи даруйхан гэмшиж, өөрийгөө бага ч гэсэн мэдэх гэж оролдсон нь дээр. Ингэж чадахгүй бол гэртээ харьсан чинь дээр; ингэсэн нь дүр үзүүлж Бурханд үйлчлэл хийснээс чинь хавьгүй дээр. Чи саад болж, үймүүлэхгүй; байр сууриа мэдэж, сайн сайхан амьдарна—ингэсэн нь дээр биш гэж үү? Бас чи Бурханд тэрсэлсэн гэж шийтгүүлэхгүй!

ТӨГС БОЛГУУЛСАН ХҮМҮҮСТ ӨГӨХ АМЛАЛТ

Хүнийг төгс болгодог Бурханы зам гэж юу вэ? Үүнд ямар талууд багтдаг вэ? Чи Бурханаар төгс болгуулахад бэлэн үү? Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн үү? Чи эдгээр асуултын талаар юу мэдэх вэ? Хэрвээ чи ийм мэдлэгийн талаар ярьж чадахгүй бол Бурханы ажлыг мэддэггүй хэвээр, Ариун Сүнс чамайг огтхон ч гэгээрүүлээгүйг энэ нь нотолж байна. Ийм хүмүүсийг төгс болгох боломжгүй. Тэдэнд түрхэн зуур эдлэх багахан хэмжээний нигүүлслийг л өгдөг бөгөөд энэ нь удаан үргэлжлэхгүй. Бурханы нигүүлслийг л эдэлдэг бол хүмүүс Бурханаар төгс болгуулж чадахгүй. Зарим хүн махан биеийн амар амгалан, зугаа цэнгэлийг эдэлж, амьдрал нь саад тотгор, золгүй явдалгүй, амар хялбар, гэр бүлээрээ ямар ч хэрүүл, тэмцэлгүй эвтэй найртай амьдрахдаа сэтгэл хангалуун байдаг. Тэд бүр үүнийгээ Бурханы ерөөл хэмээн итгэдэг байж болох ч яг үнэндээ бол энэ нь ердөө л Бурханы нигүүлсэл билээ. Та нар Бурханы нигүүлслийг эдлэх төдийдөө сэтгэл ханаж болохгүй. Ийм сэтгэлгээ бол үнэхээр бүдүүлэг юм. Чи өдөр бүр Бурханы үгийг уншиж, өдөр бүр залбирч, сүнс чинь үлэмж их таашаал, онцгой их амар амгаланг мэдэрдэг ч гэсэн, эцэстээ чи Бурхан болон Түүний ажлын тухай мэдлэгийнхээ талаар хэлэх үггүй, юу ч мэдрээгүй, Бурханы үгийг хэчнээн их идэж, уухаас үл хамааран сүнсээрээ л амар амгалан болон таашаалыг мэдэрч, Бурханы үг юутай ч харьцуулшгүй сайхан, эдлээд ханамгүй мэт санагддаг боловч Бурханы үгийн ямар ч бодит туршлага, ямар ч бодит байдал чамд байдаггүй бол Бурханд итгэх ийм итгэлээс чи юу олж авч чадах юм бэ? Хэрвээ чи Бурханы үгийн мөн чанарыг амьдран харуулж чаддаггүй бол эдгээр үгийг идэж, ууж байгаа байдал болон залбирал чинь шашны итгэл үнэмшлээс өөр юу ч биш. Ийм хүмүүсийг Бурхан төгс болгож, авч чадахгүй. Бурханаар авхуулсан хүмүүс бол үнэнийг эрэлхийлдэг хүмүүс юм. Бурханы олж авдаг зүйл нь хүний махан бие биш, түүнд харьяалагддаг зүйлс биш, харин түүний дотор байдаг Бурханд харьяалагддаг хэсэг юм. Тиймээс Бурхан хүмүүсийг төгс болгохдоо махан биеийг нь биш, харин зүрх сэтгэлийг нь

төгс болгосноор тэдний зүрх сэтгэлийг Бурхан авах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг төгс болгодог гэдэг нь мөн чанартаа бол Бурхан хүний зүрх сэтгэлийг төгс болгодог бөгөөд ингэснээр энэхүү зүрх сэтгэл нь Бурхан руу эргэж, Түүнийг хайрлаж болох юм.

Хүний бие мах, цуснаас бүтдэг. Бурханы хувьд хүний махан биеийг олж авах ямар ч хэрэггүй, учир нь энэ бол гарцаагүй илжирч мууддаг зүйл бөгөөд Бурханы өв, ерөөлийг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүний махан биеийг авдаг, хүний махан бие л энэ урсгалд байдаг байсан бол хүн энэ урсгалд нэр төдий л байх боловч зүрх сэтгэл нь Сатанд харьяалагдах байсан. Тийм учраас хүмүүс Бурханы илрэл болж чадахгүйгээр үл барам, харин ч бас л Түүнд дараа болж, Бурхан хүмүүсийг сонгох нь ямар ч утга учиргүй болох байсан. Бурханы төгс болгохоор зорьж буй хүмүүс бүгд Түүний ерөөл болон өвийг хүлээн авна. Өөрөөр хэлбэл, тэд Бурханд юу байгаа, Тэр юу болохыг шингээн авч, ингэснээр энэ нь тэдэнд байдаг зүйл болдог; Бурханы бүх үгийг тэдэнд оруулж өгсөн байдаг; Бурхан юу ч байлаа гэсэн, та нар энэ бүгдийг яг байгаагаар нь шингээн авч, тэгснээрээ үнэнийг амьдран харуулж чаддаг. Энэ бол Бурханаар төгс болгуулж, Бурханаар авхуулдаг хүн юм. Ийм хүн л Бурханы хайрласан ерөөлийг хүртэх эрхтэй:

1. Бурханы хайрыг бүхэлд нь олж авах.
2. Бүх зүйл дээр Бурханы хүслийн дагуу үйлдэх.
3. Бурханы удирдамжийг олж авч, Бурханы гэрэлд амьдарч, Бурханы гэгээрлийг олж авах.
4. Бурханы хайрладаг дүрийг газар дээр амьдран харуулж; Бурханы төлөө цовдлогдон, үхлээрээ Бурханы хайрыг хариулах эрхтэй болсон Петрийн адил Бурханыг үнэхээр хайрлаж; Петртэй адил алдар суутай байх.
5. Газар дээрх бүх хүнээр хайрлуулж, хүндлүүлж, бишрүүлэх.
6. Үхэл болон үхэгсдийн орны хүлээсийг бүхий л талаар даван гарч, Сатаны ажилд ямар ч боломж өгөлгүй, Бурханаар эзэмдүүлж, шинэ соргог, гал цогтой сүнсэнд амьдарч, залхаж ядардаггүй байх.
7. Бурханы алдрын өдөр ирж буйг харсан мэт бүхий л амьдралынхаа туршид үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөр, догдлолыг ямагт мэдэрдэг байх.
8. Бурхантай хамт алдрыг хүртэж, Бурханы хайртай ариун хүмүүстэй адил төрхтэй байх.
9. Газар дээрх Бурханы хайрладаг нэгэн, өөрөөр хэлбэл, Бурханы хайртай хүү болох.

10. Хэлбэрээ өөрчлөн, Бурхантай хамт гурав дахь тэнгэр өөд гарч, махан биеийг даван гарах.

Бурханы ерөөлийг өвлөж чаддаг хүмүүс л Бурханаар төгс болгуулж, авхуулдаг. Эдүгээ чи ямар нэгэн зүйл олж авсан уу? Бурхан чамайг ямар хэмжээнд төгс болгосон бэ? Бурхан хүнийг санаандгүйгээр төгс болгодоггүй; хүнийг Тэрээр болзолтойгоор төгс болгодог бөгөөд илэрхий, харагдахуйц үр дүнтэй байдаг. Энэ нь, Бурханд итгэж байгаа цагт Бурханаар төгс болгуулж, авхуулж чадахын дээр, газар дээр Бурханы ерөөл, өвийг хүлээн авч чадна хэмээн хүний төсөөлдөг шиг биш юм. Тийм зүйлс нь дэндүү хэцүү бөгөөд хэлбэрээ өөрчлөх тухайд бол ярихын ч хэрэггүй. Эдүгээ та нарын голчлон эрж хайх ёстой зүйл бол бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулж, өөрт тулгарсан бүх хүн, хэрэг явдал, зүйлээр дамжуулан Бурханаар төгс болгуулах явдал юм, ингэснээр Бурхан юу болохыг илүү ихээр та нарт оруулах болно. Та нар эхлээд Бурханы өвийг газар дээр хүлээн авах ёстой; тэгсэн цагт л Бурханаас илүү их, илүү агуу ерөөлийг өвлөх эрхтэй болно. Энэ бүгд нь та нарын эрж хайх ёстой, юуны өмнө ойлгох ёстой зүйл юм. Бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулахаар эрж хайх тусмаа чи бүх зүйлээс Бурханы гарыг төдий чинээ их харж чадах бөгөөд тэгснээр янз бүрийн хэрэг явдал дээр, янз бүрийн өнцгөөс Бурханы үгийн оршихуй болон Түүний үгийн бодит байдал руу орохоор идэвхтэйгээр эрж хайна. Чи нүгэл үйлдэхгүй, ямар ч үзэлгүй, амьдралын гүн ухаангүй, хүний хүсэл зориггүй байх төдийхнөөр сөрөг байдалдаа сэтгэл хангалуун болж болохгүй. Бурхан хүнийг үй олон аргаар төгс болгодог; бүх хэрэг явдалд төгс болгуулах боломж бий бөгөөд олж авсан зүйлийг чинь илүү баяжуулахын тулд Тэр чамайг эерэг талаас нь төдийгүй сөрөг талаас нь ч бас төгс болгож чадна. Бурханаар төгс болгуулах боломж, авхуулах тохиол өдөр болгон гарч байдаг. Хэсэг хугацаанд ийнхүү туршлагажсаны дараа чи асар их өөрчлөгдөж, өмнө нь мэддэггүй байсан маш олон зүйлийг аяндаа ойлгоно. Бусдаар заалгах хэрэггүй; мэдээгүй байхад чинь Бурхан чамайг гэгээрүүлэх болно, ингэснээр чи бүх зүйл дээр гэгээрлийг олж, бүх туршлагадаа илүү нарийн орно. Бурхан чамайг баруун зүүн тийш хэлбийлгэхгүйгээр залж чиглүүлнэ. Тэгээд чи Түүгээр төгс болгуулах замд хөл тавина.

Бурханаар төгс болгуулахыг, Бурханы үгийг идэж ууснаар төгс болох явдлаар хязгаарлаж болохгүй. Иймэрхүү туршлага нь хэтэрхий өрөөсгөл, хэтэрхий багыг багтаадаг бөгөөд хүмүүсийг маш бага хүрээнд хязгаарлахаас өөр аргагүй болно. Тийм учраас хүмүүс шаардлагатай сүнслэг шим тэжээлээр

ихээхэн дутагдах болно. Хэрвээ та нар Бурханаар төгс болгуулахыг хүсэж байвал бүх зүйл дээр хэрхэн туршлагажихыг сурч, өөрт тохиолдож буй бүхнээс гэгээрлийг олж авч чаддаг байх ёстой. Сайн ч бай, муу ч бай чи үүнээс үр ашиг хүртэх ёстой бөгөөд энэ нь чамайг сөрөг болгох ёсгүй. Юу ч болсон бай, чи хүний харах өнцгөөс юмыг задлан шинжилж, судлах (ингэх нь чиний туршлагын гажуудал болно) биш Бурханы талд зогсож байхдаа юмыг дэнсэлж чаддаг байх ёстой. Хэрвээ чи ингэж туршлагаждаг бол зүрх сэтгэл чинь чиний амийн ачаагаар дүүрэх болно; чи байнга Бурханы дүр төрхийн гэрэлд амьдарч, хэрэгжүүлэлтийнхээ хувьд тийм ч амар хазайхгүй. Ийм хүмүүсийн өмнө гэгээлэг ирээдүй байдаг. Бурханаар төгс болгуулах маш олон боломж бий. Энэ бүгд нь та нар Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс мөн эсэхээс, Бурханаар төгс болгуулж, Бурханаар авхуулж, Түүний ерөөл, өвийг хүлээн авах шийдэмгий байдал та нарт байгаа эсэхээс хамаардаг. Зөвхөн шийдэмгий байдал байгаад хангалтгүй. Та нар ихээхэн мэдлэгтэй байх ёстой, эс бөгөөс хэрэгжүүлэлтээсээ үргэлж хазайх болно. Бурхан та нарыг нэг бүрчлэн төгс болгохыг хүсдэг. Одоогийн байдлаар, ихэнх хүн Бурханы ажлыг аль хэдийн удаан хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэдий ч Бурханы нигүүлслийг эдлэх төдийхнөөр өөрсдийгөө хязгаарлагдаж, Түүнээс махан биеийн багахан тав тухыг хүлээн авахыг л хүсэж байдаг атлаа илүү их, илүү өндөр илчлэл хүлээн авахыг хүсдэггүй бөгөөд хүний зүрх сэтгэл үргэлж гадна байсаар байгаа гэдгийг энэ нь харуулдаг. Хэдийгээр хүний ажил, үйлчлэл болон Бурханыг гэх хайрын сэтгэлд нь сэв арай бага байдаг ч дотоод мөн чанар, хоцрогдмол сэтгэлгээнийх нь тухайд бол хүн махан биеийн амар амгалан, зугаа цэнгэлийг байнга эрж хайсаар байдгийн дээр хүнийг төгс болгох Бурханы нөхцөл болон зорилго юу болохыг ойшоодоггүй. Иймээс ихэнх хүний амьдрал бүдүүлэг, доройтсон хэвээр, өчүүхэн төдий ч өөрчлөгдөөгүй. Тэд зүгээр л Бурханд итгэх итгэлийг чухал зүйл гэж үздэггүй, бусдын төлөө л итгэж байгаа юм шиг, хэлбэр төдий хийж, хааш яаш аргацаан, урсгал даган зорилгогүй амьдардаг. Цөөн хэд нь л бүх зүйл дээр Бурханы үг рүү орохоор эрж хайж чаддаг, илүү их, баялаг зүйлсийг олж авч, өнөөдөр Бурханы гэр дэх үлэмж их хөрөнгөтэй хүмүүс болж, Бурханы ерөөлийг илүү их хүлээн авдаг хүмүүс юм. Хэрвээ чи бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулахаар эрж хайж, газар дээр Бурханы амласан зүйлийг хүлээн авч чаддаг бол, хэрвээ чи бүх зүйл дээр Бурханаар гэгээрүүлэгдэхээр эрж хайж, цаг хугацааг дэмий өнгөрөөдөггүй бол идэвхтэйгээр ороход хамгийн тохирсон зам энэ мөн билээ. Ийм маягаар л чи Бурханаар төгс болгуулах үнэ цэнтэй, эрхтэй байна. Чи

Бурханаар төгс болгуулахаар эрж хайдаг нэгэн үнэхээр мөн үү? Чи бүх зүйл дээр үнэн сэтгэлээсээ ханддаг нэгэн үнэхээр мөн үү? Петртэй адил Бурханыг гэсэн хайрын сэтгэл чамд байдаг уу? Есүс шиг Бурханыг хайрлах хүсэл зориг бий юу? Чи олон жилийн турш Есүст итгэж ирсэн; Есүс Бурханыг хэрхэн хайрлаж байсныг чи харсан уу? Чиний итгэдэг нэгэн үнэхээр Есүс мөн үү? Чи өнөөдрийн бодитой Бурханд итгэдэг; махбод дахь бодитой Бурхан тэнгэр дэх Бурханыг хэрхэн хайрладгийг чи харсан уу? Эзэн Есүс Христэд чи итгэдэг; яагаад гэвэл хүн төрөлхтнийг золин аврахын төлөө Есүс цовдлогдсон, Түүний үйлдсэн гайхамшиг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэн юм. Гэхдээ хүний итгэл нь Есүс Христийн тухай мэдлэг болон жинхэнэ ойлголтоос гардаггүй. Чи Есүсийн нэрд нь л итгэдэг боловч Түүний Сүнсэнд итгэдэггүй, учир нь чи Есүс Бурханыг хэрхэн хайрлаж байсныг огт ойшоодоггүй билээ. Бурханд итгэх итгэл чинь хэтэрхий гэнэн. Чи Есүст олон жил итгэсэн хэр нь Бурханыг хэрхэн хайрлахаа мэддэггүй. Энэ нь чамайг энэ дэлхийн хамгийн тэнэг хүн болгож байгаа бус уу? Эзэн Есүс Христийн хоолыг олон жил хий дэмий идсэний чинь нотолгоо энэ байна. Би ийм хүмүүст дургүйгээр барахгүй, чиний дээдэлдэг Эзэн Есүс Христ ч гэсэн бас дургүй гэдэгт Би итгэдэг. Ийм хүмүүс яаж төгс болгуулж чадах юм бэ? Ичсэндээ нүүр чинь улайхгүй байна гэж үү? Ичихгүй байна уу? Эзэн Есүс Христээ харах нүүр чамд байсаар байна уу? Та нар бүгдээрээ Миний хэлсэн үгийн утга учрыг ойлгож байна уу?

ХОРОН МУУ ХҮМҮҮС ГАРЦААГҮЙ ШИЙТГҮҮЛНЭ

Хийдэг бүхэндээ зөв шударга байдлыг хэрэгжүүлдэг эсэхээ, мөн бүх үйлдлийг чинь Бурхан ажиглаж байгаа эсэхийг мэдэхийн тулд өөрсдөдөө дүн шинжилгээ хий: Бурханд итгэдэг хүмүүсийн үйл хэргийн зарчим энэ юм. Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаг, мөн Бурханы халамж, хамгаалалтыг хүлээн авдаг учраас та нар зөв шударга гэж нэрлэгдэнэ. Бурханы халамж, хамгаалалт, төгс болголтыг хүлээн авдаг, Түүгээр авхуулсан бүх хүн Бурханы нүдэнд зөв шударга бөгөөд тэднийг бүгдийг нь Бурхан эрхэм нандин гэж үздэг. Чи Бурханы одоогийн үгийг хүлээн авах тусмаа Бурханы хүслийг төдий чинээ хүлээн авч, ойлгож чадна, тэгснээр Бурханы үгийг төдий чинээ амьдран харуулж, Түүний шаардлагыг хангаж чадна. Энэ нь та нарт өгсөн Бурханы даалгавар бөгөөд та бүхний биелүүлж чадах зүйл юм. Хэрвээ та нар өөрсдийн үзлээр Бурханыг өөрчлөгдөшгүй шавар хөшөө аятай хэмжиж, хязгаарладаг бол, Бурханыг тэр

чигт нь Библийн хэмжүүрээр хязгаарлаж, хязгаарлагдмал цар хүрээний ажлаар хайрцагладаг бол Бурханыг ялласан гэдгийг чинь энэ нь баталдаг. Хуучин Гэрээний эрин үед иудейчүүд Бурханыг Мессиа л гэж нэрлэж болох мэт, Мессиа гэгддэг Нэгэн л Бурхан байж болох юм шиг Бурханыг өөрсдийнхөө зүрх сэтгэлдээ тээдэг тогтсон хэлбэртэй шүтээн шигээ бодсон учраас, мөн хүн төрөлхтөн Бурханд (амьгүй) шавар хөшөө мэт үйлчилж, шүтэн мөргөдөг байсан учраас тухайн үеийн Есүсийг загалмайд цовдолж, үхлийн ял оноосон бөгөөд гэмгүй Есүсийг тийнхүү үхлээр ялласан юм. Бурхан ямар ч гэм буруугүй байсан атал хүн Түүнийг өршөөхөөс татгалзаж, үхлийн ял оноохоор зүтгэсэн болохоор Есүс цовдлогдсон билээ. Хүн Бурханы удирдлагад төгс нэвтэрсэн мэт, Бурханы хийдэг бүхнийг гарын арван хуруу шигээ мэддэг юм шиг Бурханыг өөрчлөгдөшгүй гэж үргэлж боддог бөгөөд ганцхан ном буюу Библийн үндсэн дээр Түүнийг тодорхойлдог. Хүмүүс дэндүү утгагүй, дээд зэргээр биеэ тоосон байдаг ба бүгдээрээ дэгсдүүлэх чадвартай. Бурханы тухай мэдлэг чинь хэр их байх нь хамаагүй, Би чамайг бас л Бурханыг мэддэггүй, Бурханыг хамгийн их эсэргүүцдэг хүн, мөн Бурханыг ялласан гэж хэлдэг, учир нь чи Бурханы ажлыг дуулгавартай дагах, Бурханаар төгс болгуулах замаар алхах ямар ч чадваргүй. Яагаад Бурхан хүний үйлдэлд хэзээ ч сэтгэл ханадаггүй вэ? Учир нь хүн хэтэрхий их үзэлтэй болохоороо Бурханыг мэддэггүй бөгөөд Бурханы тухай мэдлэг нь бодит байдалтай өчүүхэн ч нийцдэггүй, харин нэг сэдвийг өөрчлөлтгүйгээр, нэгэн хэмээр давтаж, нөхцөл байдал болгонд нэг аргаа ашигладаг. Иймээс өнөөдөр Бурхан газар дээр ирээд хүнээр дахин нэг удаа загалмайд цовдлуулсан. Харгис хүн төрөлхтөн! Нэг нэгнийхээ эсрэг хуйвалдах, булаалцаж тэмцэлдэх, алдар нэр, ашиг хонжоо булаалдах, харилцан бие биеэ хүйс тэмтрэх—энэ ер нь хэзээ төгсөх юм бэ? Бурхан олон зуун мянган үг хэлсэн боловч хэн ч сэхээрээгүй. Хүмүүс гэр бүл, хөвгүүд, охид, ажил мэргэжил, хэтийн ирээдүй, байр суурь, хоосон нэр алдар, мөнгөний төлөө, бас хоол хүнс, хувцас хунар, махан биеийн төлөө үйлддэг, харин үйлдэл нь үнэхээр Бурханы төлөө байдаг хүн байна уу? Бурханы төлөө үйлддэг хүмүүсийн дунд ч гэсэн Бурханыг мэддэг хүн цөөхөн. Өөрсдийнхөө ашиг сонирхлын төлөө үйлддэггүй хүн хэд вэ? Өөрсдийн байр суурийг хамгаалахын тулд бусдыг дарлаж, гадуурхдаггүй хүн хэчнээн бэ? Иймээс Бурханд тоймгүй олон удаа үхэх ял хүчээр тулгасан, мөн тоо томшгүй олон хэрцгий шүүгч Бурханыг яллаж, дахин нэг удаа загалмайд цовдолсон. Үнэхээр Бурханы төлөө үйлддэг учраас зөв шударга гэж нэрлэгдэж болох хүн хэд байдаг вэ?

Бурханы өмнө ариун хүн юм уу зөв шударга хүн болж төгс болгуулах маш амархан уу? “Энэ газар дэлхий дээр зөв шударга хүн үгүй, зөв шударга нь энэ дэлхийд үгүй” гэдэг нь үнэн үг юм. Бурханы өмнө очих үедээ та нар юу өмсөж байгаагаа, үг, үйлдэл бүрээ, бодол, санаа болгоноо, тэр ч бүү хэл өдөр бүр зүүдэлдэг зүүдээ цэгнээд үз—эдгээр нь бүгд өөрсдийн чинь төлөө байдаг. Хэрэг явдлын үнэн байдал энэ биш гэж үү? “Зөв шударга байдал” гэдэг нь бусдад өглөг өгнө гэсэн үг биш, хөршөө өөр шигээ хайрлана гэсэн үг биш, мөн маргаж, хэрэлдэх, дээрэмдэж, хулгай хийхийг цээрлэнэ гэсэн үг биш юм. Зөв шударга байдал гэдэг нь Эзэн Есүсийн хийсэн бүхэнтэй адилаар цаг хугацаа, орон зайг үл харгалзан Бурханы даалгаврыг өөрийн үүрэг гэж авч үзэн, Бурханы зохион байгуулалт, зохицуулалтыг тэнгэрээс илгээсэн ажил мэргэжил хэмээн дуулгавартай дагана гэсэн үг юм. Энэ бол Бурханы ярьсан зөв шударга байдал мөн. Лот өөрийнхөө ашиг, алдагдлыг бодож үзэлгүйгээр Бурханы илгээсэн хоёр тэнгэрэлчийг аварсан болохоор зөв шударга хүн хэмээн нэрлэгдэж чадсан; тухайн үед түүний хийсэн зүйлийг зөв шударга гэж нэрлэж болох боловч түүнийг зөв шударга хүн гэж нэрлэж болохгүй гэж л хэлж болно. Лот Бурханыг харсан учраас л хоёр охиноо тэнгэрэлчүүдийн оронд өгсөн болохоос биш түүний урьдын бүх зан авир нь зөв шударга байдлын төлөө байгаагүй юм. Иймээс Би “энэ газар дэлхий дээр зөв шударга хүн үгүй” гэж хэлдэг. Сэргэлтийн урсгалд байгаа хүмүүсээс хүртэл хэнийг нь ч зөв шударга гэж нэрлэх боломжгүй. Чиний үйлдэл хэчнээн сайн байлаа ч, чи Бурханы нэрийг хэчнээн их алдаршуулдаг мэт харагдлаа ч хамаагүй, бусдыг цохиж хараадаггүй, бусдаас хулгайлж дээрэмддэггүй байлаа ч гэсэн чамайг бас л зөв шударга гэж нэрлэж болохгүй, учир нь энэ бол хэвийн хүний эзэмшиж чадах зүйл билээ. Яг одоо гол нь юу вэ гэвэл, чи Бурханыг мэддэггүй. Одоогоор чамд бага зэрэг хэвийн хүн чанар байгаа ч Бурханы ярьсан зөв шударга байдлын ямар ч элемент байхгүй гэж хэлж болно, иймээс чиний хийж байгаа зүйлсийн аль нь ч Бурханыг мэддэг гэдгийг чинь нотолж чадахгүй.

Өмнө нь, Бурханыг тэнгэрт байх үед хүн Түүнийг хуурах үйлдэл гаргадаг байлаа. Өнөөдөр Бурхан хүмүүсийн дунд байгаа, хэчнээн олон жил болсныг хэн ч мэдэхгүй, гэхдээ хүн аливааг хийхдээ бас л дүр эсгэж, Түүнийг хуурахыг оролдсоор л байна. Хүний бодол хэтэрхий хоцрогдмол биш гэж үү? Иудас ч гэсэн ийм байсан: Есүсийг ирэхээс өмнө тэр үргэлж худал хэлж, ах эгч нараа хуурдаг байсан, Есүсийг ирсний дараа ч гэсэн өөрчлөгдөөгүй; тэр Есүсийг өчүүхэн төдий ч мэддэггүй байсан бөгөөд эцэст нь Есүсээс урвасан юм. Энэ нь

Бурханыг мэддэггүй байснаас нь болсон бус уу? Хэрвээ өнөөдөр та нар Бурханыг мэдэхгүй хэвээр байгаа бол та нар өөр нэгэн Иудас болж, үүнээс үүдэн хоёр мянган жилийн өмнөх Нигүүлслийн эрин үед Есүсийг цовдолсон эмгэнэлт явдал дахин давтагдах боломжтой. Та нар үүнд итгэхгүй байна уу? Энэ бол баримт! Одоогоор ихэнх хүн иймэрхүү нөхцөл байдалтай байгаа (Би үүнийг арай эрт хэлж байж магадгүй) ба ийм хүмүүс бүгд Иудасын дүрд тоглож байгаа юм. Би утгагүй юм яриагүй, харин баримтад үндэслэн ярьж байгаа бөгөөд чи үнэмшихээс өөр аргагүй. Олон хүн даруу төлөв дүр үзүүлдэг ч зүрх сэтгэлд нь тогтоол усан цөөрөм, өмхий усны шуудуунаас өөр юу ч байдаггүй. Яг одоо чуулганд ийм хүн дэндүү олон байгаа бөгөөд та нар Намайг үүнийг огт мэддэггүй гэж боддог. Миний Сүнс өнөөдөр Миний төлөө шийдвэр гаргаж, Надад гэрчлэл хийдэг. Намайг юу ч мэдэхгүй гэж чи бодож байна уу? Та нарын зүрх сэтгэл доторх зальхай бодол, зүрх сэтгэл дотроо хадгалдаг зүйлсийг Намайг огт ойлгодоггүй гэж бодож байна уу? Бурханыг дарлахад ийм амархан гэж үү? Түүнд хүссэнээрээ хандаж болно гэж бодоо юу? Урьд нь Би та нарыг хязгаарлагдах вий гэж санаа зовсондоо эрх чөлөө өгсөөр байсан боловч хүмүүс өөрсдөд нь сайн хандаж байгааг ухаарч чадалгүй, өгөх тусам минь улам даварч байлаа. Нэг нэгнээсээ асууцгаа: Би бараг хэзээ ч, хэнд ч харьцалт хийгээгүй, бараг хэзээ ч, хэнийг ч хялбархан зэмлээгүй, гэсэн ч Би хүний үзэл, сэдлийг маш тодорхой мэднэ. Бурханы гэрчилдэг Бурхан Өөрөө тэнэг гэж чи бодож байна уу? Тийм бол, Би чамайг хэтэрхий харалган байна гэж хэлнэ! Би чамайг илчлэхгүй, харин хэр их завхрахыг чинь л харцгаая. Ухаалаг бяцхан ов мэх чинь чамайг аврах нь уу, Бурханыг хайрлах гэж чадах чинээгээрээ хичээх нь чамайг аврах нь уу гэдгийг харцгаая. Өнөөдөр Би чамайг яллахгүй; Бурханы цаг ирэхэд чамайг хэрхэн залхаан цээрлүүлэхийг харцгаая. Одоо чамтай дэмий чалчих зав алга, ганц чиний төлөө Би илүү агуу ажлаа хойшлуулмааргүй байна. Чам шиг өт хорхойтой харьцах гэж Бурхан цаг заваа зориулахад хайран байна—иймээс хэр садар самуун болохыг чинь л харцгаая. Ийм хүмүүс Бурханы тухай мэдлэгийг өчүүхэн ч эрэлхийлдэггүй, Түүнд өчүүхэн төдий ч хайргүй байдаг атлаа Бурханаар зөв шударга гэж дуудуулахыг хүссээр байдаг—энэ чинь инээдтэй хэрэг биш үү? Цөөн тооны хүн үнэхээр үнэнч байдаг учраас Би хүмүүсийг амиар үргэлжлүүлэн хангахад л анхаарал хандуулна. Би өнөөдөр хийх ёстой зүйлээ л хийж дуусгана, харин хожим нь хүн бүрд хийсэн зүйлийнх нь дагуу залхаан цээрлүүлэлт авчирна. Би хэлж болох бүхнийг хэллээ, учир нь энэ бол чухам Миний хийдэг ажил юм. Би хийх ёстой зүйлээ л хийдэг, хийх ёсгүй зүйлээ

хийдэггүй. Ямартай ч та нар илүү их цаг зарцуулж эргэцүүлэн бодно гэж Би найдаж байна: Бурханы талаарх мэдлэгийн чинь яг хэр зэрэг нь үнэн бэ? Чи Бурханыг дахин нэг удаа загалмайд цовдолсон хүн мөн үү? Эцэст нь хэлэх үг минь энэ: Бурханыг цовдолдог хүмүүс золгүй еэ.

ХЭРХЭН БУРХАНЫ ХҮСЭЛД НИЙЦҮҮЛЭН ҮЙЛЧЛЭХ ВЭ

Хүн Бурханд итгэхдээ Түүнд яг яаж үйлчлэх ёстой вэ? Бурханд үйлчилдэг хүмүүс ямар нөхцөл байдлыг хангаж, ямар үнэнийг ойлгосон байх ёстой вэ? Мөн та нарын үйлчлэл хаана гажууддаг байж болох вэ? Энэ бүхний хариултыг та нар мэддэг байх ёстой. Эдгээр асуудал нь Бурханд хэрхэн итгэх, Ариун Сүнсний хөтөлсөн замаар хэрхэн алхах, мөн бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалтад хэрхэн захирагдах талаар хөндсөнөөрөө та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийг ойлгох боломжийг та бүхэнд олгох болно. Та нар тэр түвшинд хүрэх үедээ Бурханд итгэх итгэл гэж юу болох, Бурханд хэрхэн зөв зохистой итгэх, Бурханы хүсэлд нийцүүлэн юу хийх хэрэгтэйг ойлгоно. Энэ нь та нарыг Бурханы ажилд бүрэн дүүрэн, туйлын дуулгавартай болгоно; та нар Бурханы ажилд гомдоллохгүй, Түүнийг шүүж, задлан шинжлэхгүй, тэр ч бүү хэл судлахгүй. Тийм болохоор, та бүхэн үхэн үхтлээ Бурханд дуулгавартай байх чадвартай болж, Бурханаар удирдуулан жолоодуулж, өөрсдийгөө хонь шиг нядлахыг Бурханд зөвшөөрснөөрөө 1990-ээд оны Петр болж, загалмай дээр байсан ч гэсэн өчүүхэн ч гомдолгүйгээр Бурханыг хамгийн ихээр хайрлаж чадна. Зөвхөн тэгсэн цагт л та нар 1990-ээд оны Петр шиг амьдарч чадна.

Шийдсэн хүн бүхэн Бурханд үйлчилж чадна—гэхдээ зөвхөн Бурханы хүсэлд бүхий л талаар санаа тавьдаг, Бурханы хүслийг ойлгодог хүмүүс л Бурханд үйлчлэх эрхтэй, шаардлага хангасан байх ёстой. Би үүнийг та нарын дундаас олж мэдсэн: Бурханы төлөө гал халуунаар сайн мэдээ түгээж, Бурханы төлөө цааш явж, Бурханы төлөө өөрсдийгөө зарлагдаж, аливаа зүйлээс татгалзах гэх мэтийг хийж байгаа цагт энэ нь Бурханд үйлчилж байгаа хэрэг гэж олон хүн боддог. Бурханд үйлчлэх гэдэг нь гартаа Библи барин, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж, гэмшүүлж, улайлгах замаар хүмүүсийг аврах явдал гэж шашны бүр ч олон хүн боддог. Мөн Бурханд үйлчлэх гэдэг нь шашны сургуульд сурч, боловсорсны дараа сүмд номлож, Библийн судраас унших замаар хүмүүст зааж сургах явдал юм гэж боддог шашны олон албан тушаалтан бий.

Түүнчлэн Бурханд үйлчлэх гэдэг нь ах эгч нарынхаа дундаас өвчтэйг нь эдгээж, чөтгөрүүдийг нь хөөн зайлуулж, эсвэл тэдний төлөө залбирч, тэдэнд үйлчлэх явдал гэж ядуу тарчиг газар нутгийн хүмүүс үздэг. Бурханд үйлчлэх гэдэг нь өдөр бүр Бурханы үгийг идэж ууж, Бурханд залбирч, хаа сайгүй чуулгануудаар алхаж, ажил хийх явдал гэж боддог хүмүүс та нарын дунд олон бий. Бурханд үйлчлэх гэдэг нь хэзээ ч гэрлэхгүй, гэр бүлтэй болохгүй, өөрийгөө бүхэлд нь Бурханд зориулахын нэр гэж үздэг зарим ах эгч байдаг. Гэвч Бурханд үйлчлэх гэдэг нь үнэндээ юу гэсэн үг болохыг тун цөөхөн хүн л мэддэг. Хэдий тэнгэрийн од шиг олон хүн Бурханд үйлчилдэг боловч шууд үйлчилж чадах, мөн Бурханы хүслийн дагуу үйлчлэх чадвартай хүмүүсийн тоо шалихгүй—өчүүхэн бага. Яагаад Би ингэж хэлдэг вэ? Та нар “Бурханд үзүүлэх үйлчлэл” гэдэг үгийн мөн чанарыг ойлгодоггүй, Бурханы хүслийн дагуу яаж үйлчлэх талаар маш бага ойлгодог учраас Би ингэж хэлдэг. Бурханд үзүүлэх яг ямар үйлчлэл Түүний хүсэлд нийцэж чадах вэ гэдгийг хүмүүс нэн даруй ойлгох хэрэгтэй.

Хэрвээ та нар Бурханы хүсэлд нийцүүлж үйлчлэхийг хүсдэг бол ямар хүмүүсийг Бурхан таашаадаг, ямар хүмүүсийг Бурхан жигшдэг, ямар хүмүүсийг Бурхан төгс болгодог, мөн ямар хүн Бурханд үйлчлэх шаардлага хангадгийг эхлээд ойлгох ёстой. Энэ бол та нарын хамгийн наад захын мэдвэл зохих зүйл юм. Түүнээс гадна, та нар Бурханы ажлын зорилтуудыг, мөн одоо, энд хийх гэж байгаа Бурханы ажлыг мэдэх ёстой. Үүнийг ойлгосныхоо дараа, Бурханы үгийн удирдамжаар дамжуулан та нар эхлээд орж, Бурханы даалгаврыг хүлээн авах ёстой. Та нар Бурханы үгийн талаар бодит туршлагатай болмогцоо, мөн Бурханы ажлыг үнэхээр мэддэг болох үедээ Бурханд үйлчлэх шаардлагыг хангах болно. Та нарыг Бурханд үйлчлэх үед Тэр сүнслэг нүдийг чинь нээж, Түүний ажлын тухай илүү их ойлголттой болж, илүү тодорхой харах боломжийг та нарт олгодог. Энэ бодит байдалд орох үед туршлага чинь илүү гүнзгий, бодит болж ийм туршлагатай хүн бүхэн чуулгануудаар алхаж, ах эгч нарыг тань хангаж чадна. Ингэснээр та нар нэг нь нөгөөгийнхөө давуу талаар дутагдлаа нөхөж, сүнсэндээ илүү баялаг мэдлэгийг олж авч чадна. Зөвхөн ийм үр дүнд хүрснийхээ дараа л та нар Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэх чадвартай болж, үйлчлэлийнхээ явцад Бурханаар төгс болгуулж чадна.

Бурханд үйлчилдэг хүмүүс нь Бурханы дотнын хүмүүс байх ёстой, тэд Бурханд таашаагдаж, Бурханд туйлын үнэнч байж чадах ёстой. Чи ганцаараа эсвэл олны өмнө үйлдсэн ч бай, Бурханы өмнө Бурханы баяр баяслыг олж авч, Бурханы өмнө бат зогсож чаддаг бөгөөд бусад хүн чамд хэрхэн хандахаас үл

хамааран үргэлж алхах ёстой замаараа алхаж, Бурханы ачаанд бүхий л талаар санаа тавьдаг. Зөвхөн ийм л хүн Бурханы дотнын хүн юм. Бурханы дотнын хүмүүс Бурханы агуу даалгавар болон Бурханы ачааг авсан учир Түүнд шууд үйлчлэх чадвартай, Бурханы зүрх сэтгэлийг өөрийн болгож, Бурханы ачааг өөрийн болгож авах чадвартай бөгөөд хэтийн ирээдүйгээ эс хайхардаг. Тэд хэтийн ирээдүйгүй, юу ч олж авахгүй байсан ч хайрлах сэтгэлээр Бурханд үргэлж итгэх болно. Иймээс ч ийм хүн бол Бурханы дотнын хүн юм. Бурханы дотнын хүмүүс нь бас Түүний итгэлт хүмүүс юм; Бурханы итгэлт хүмүүс л Түүний санаа зовнил, бодлыг хуваалцаж чадна. Мөн махан бие нь өвдөж, сул дорой байсан ч Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд тэд хайрладаг зүйлээ орхиж, зовлон шаналлыг тэсэх чадвартай. Бурхан ийм хүмүүст илүү их ачаа өгдөг агаад Бурханы хийхийг хүсдэг зүйл ийм хүмүүсийн гэрчлэлээс төрөн гардаг. Иймийн учир энэ хүмүүс Бурханд таашаагддаг, тэд бол Бурханы Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух зарц нар нь бөгөөд ийм хүмүүс л Бурхантай хамт хаанчилж чадна. Чи үнэхээр Бурханы дотнын хүн болох яг тэр үе нь Бурхантай хамт хаанчлах үе байх болно.

Есүс өөртөө ямар нэг төлөвлөгөө гаргаж, зохицуулалт хийлгүйгээр Бурханы хүсэлд бүрэн санаа тавьсан учраас Бурханы даалгавар буюу бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлыг биелүүлэх чадвартай байсан. Тэрээр бас та бүхний маш сайн ойлгодог Бурханы дотнын хүн—Бурхан Өөрөө байсан. (Үнэндээ Тэр бол Бурханаар гэрчлэгдсэн Бурхан Өөрөө байсан; хэрэг явдлыг тайлбарлах үүднээс Би Есүсийн энэ баримтыг дурдав.) Тэрээр Бурханы удирдлагын төлөвлөгөөний ажлыг хамгийн голд нь тавьж чаддаг, үргэлж тэнгэрлэг Эцэгт залбирч, тэнгэрлэг Эцэгийн хүслийг эрж хайдаг байлаа. Тэрээр залбиран: “Эцэг Бурхан минь! Өөрийн хүслийг гүйцэлдүүлж, Миний хүслийн дагуу биш, Өөрийн төлөвлөгөөний дагуу үйлдээч. Хүн сул дорой байж болно, гэхдээ яагаад Та түүнд санаа тавих ёстой гэж? Таны алган дээрх шоргоолж шиг хүн яаж Таны анхаарал халамжийг хүртэх эрхтэй байж чадах юм бэ? Зүрх сэтгэлдээ Би зөвхөн Таны хүслийг гүйцэлдүүлэхийг л хүсэж байна, Та Өөрийн тааллаар Надад хийх зүйлээ хийгээсэй гэж Би хүсэж байна” гэсэн юм. Иерусалим руу явах замд Есүс яг л зүрхийг нь хутгаар сийчиж буй мэт шаналлыг мэдэрч байсан ч үгнээсээ буцах өчүүхэн төдий ч санаа Түүнд байгаагүй; цовдлогдох газар луу нь нэгэн их хүч үргэлж Түүнийг түлхэж байв. Эцэст нь Тэр загалмайд цовдлогдож, нүгэлт махан биеийн төрхтэй болж, хүн төрөлхтнийг золин аврах ажлыг гүйцэлдүүлээд, үхэл хийгээд Үхэгсдийн орны дөнгөнөөс

чөлөөлөгдсөн юм. Түүний өмнө үхэл, там, Үхэгсдийн орон хүч чадлаа алдаж, Түүнд ялагдсан билээ. Тэрээр гучин гурван жил амьдрах хугацаандаа тухайн үеийн Бурханы ажлын дагуу Бурханы хүслийг биелүүлэхийн тулд үргэлж чадах бүхнээ хийж, Өөрийн хувийн ашиг хонжоо, хохирлыг хэзээ ч бодож үзээгүй, Эцэг Бурханы хүслийг үргэлж бодож байсан. Иймээс Түүнийг баптисм хүртсэний дараа Бурхан: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” гэж хэлсэн юм. Бурханы өмнөх Түүний үйлчлэл Бурханы хүсэлтэй нийцэж байсан учраас Бурхан бүх хүн төрөлхтнийг золин аврах хүнд хэцүү ачааг Түүнд үүрүүлж, Түүгээр гүйцэлдүүлсэн бөгөөд Тэрээр энэ чухал даалгаврыг биелүүлэх эрхтэй, шаардлага хангасан байв. Амьдралынхаа туршид Тэрээр Бурханы төлөө хэмжээлшгүй их зовлон туулж, тоо томшгүй олон удаа Сатаны сорилтод орсон боловч хэзээ ч мохоогүй. Бурхан Түүнд итгэж, Түүнийг хайрласан учраас ийм агуу даалгавар өгсөн, тиймээс ч Бурхан: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” хэмээн Өөрөө хэлсэн билээ. Тухайн үед зөвхөн Есүс л энэхүү даалгаврыг биелүүлж чадах байсан агаад Нигүүлслийн эрин үед бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлаа Бурхан гүйцээсний нэг бодитой тал нь энэ байлаа.

Хэрэв та нар Есүс шиг Бурханы ачаанд бүхий л талаар санаа тавьж, махан биеэсээ татгалзаж чаддаг бол, Бурхан чухал даалгавраа та нарт даалгана, ингэснээр та нар Бурханд үйлчлэх нөхцөлийг хангах болно. Ийм нөхцөл байдалд л та нар Бурханы хүслийг гүйцэлдүүлж, Түүний даалгаврыг биелүүлж байна хэмээн хэлж зүрхэлнэ, тэр үед л та нар Бурханд үнэхээр үйлчилж байна гэж хэлж зүрхэлнэ. Есүсийн жишээтэй харьцуулбал чи өөрийгөө Бурханы дотнын хүн гэж хэлж зүрхлэх үү? Чи Бурханы хүслийг гүйцэлдүүлж байгаа гэж хэлж зүрхлэх үү? Чи үнэхээр Бурханд үйлчилж байна гэж хэлж зүрхлэх үү? Өнөөдөр чи Бурханд хэрхэн үйлчлэхээ мэддэггүй байж өөрийгөө Бурханы дотнын хүн гэж хэлж зүрхлэх үү? Чи Бурханд үйлчилдэг гэж хэлбэл Түүнийг доромжилж буй хэрэг биш гэж үү? Энэ тухай бодоод үзээрэй: Чи Бурханд үйлчилж байна уу, эсвэл өөртөө үйлчилж байна уу? Чи Сатанд үйлчилдэг атлаа Бурханд үйлчилж байгаа гэж зөрүүдлэн хэлснээрээ Бурханыг доромжилж байгаа хэрэг биш гэж үү? Миний ардуур олон хүн байр суурийн ерөөлд шунаж, ховдоглон идэж, нойронд шимтэж, махан биедээ бүх анхаарлаа хандуулан, махан бие нь гарах гарцгүй болохоос үргэлж айдаг. Тэд зүй ёсны чиг үүргээ чуулганд биелүүлдэггүй, харин чуулганыг сорон мөлжиж эсвэл ах эгч нараа Миний үгээр сургамжилж, эрх мэдлийн байр сууринаас бусдыг захирдаг. Энэ

хүмүүс өөрсдийгөө Бурханы хүслийг биелүүлж байна гэж хэлсээр, үргэлж өөрсдийгөө Бурханы дотнын хүн гэж хэлдэг нь утгагүй хэрэг биш гэж үү? Хэрвээ санаа чинь зөв боловч Бурханы хүслийн дагуу үйлчлэх чадваргүй бол чи мунхаг байна; харин санаа чинь буруу атал өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж хэлсээр байвал чи Бурханыг эсэргүүцдэг нэгэн тул Бурханд шийтгүүлэх учиртай! Би ийм хүмүүсийг огт өрөвддөггүй! Бурханы гэрт тэд сорон мөлжиж, үргэлж махан биеийн тав тухад шунаж, Бурханы ашиг сонирхлыг хайхардаггүй; тэд үргэлж өөрсдөдөө сайн зүйлсийг эрж хайж, Бурханы хүсэлд ямар ч анхаарал хандуулдаггүй. Хийдэг бүхнийг нь Бурханы Сүнс шинжихийг тэд хүлээн зөвшөөрдөггүй. Тэд үргэлж ах эгч нараа залилж, мэхлэн, яг л усан үзмийн талбайг үргэлж гишгэчиж, усан үзэм хулгайлдаг үнэг шиг хоёр нүүртэй байдаг. Ийм хүмүүс Бурханы дотнын хүн байж чадах уу? Чи Бурханы ерөөлийг хүлээж авахад тохирно гэж үү? Өөрийн амь болон чуулганы төлөө ямар ч ачаа үүрдэггүй байж чи Бурханы даалгаврыг хүлээж авахад тохирно гэж үү? Чам шиг хүнд хэн итгэж зүрхлэх вэ? Чамайг ингэж үйлчилж байхад Бурхан чамд илүү их ажил даалгаж чадна гэж үү? Ажилд энэ нь садаа болох бус уу?

Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэхийн тулд ямар нөхцөлүүдийг биелүүлэх ёстойг та нарт мэдүүлэх гэж Би үүнийг хэлдэг. Хэрвээ та нар Бурханд зүрх сэтгэлээ өгдөггүй, Есүс шиг Бурханы хүсэлд бүхий л талаар санаа тавьдаггүй бол Бурханы итгэлийг олж чадахгүй, харин ч эцэстээ Бурханаар шүүгдэх болно. Магадгүй өнөөдөр ч гэсэн, Бурханд үйлчлэхдээ чи үргэлж Бурханыг мэхлэх санаа агуулж, Түүнд үргэлж хааш яаш хандаж байдаг. Товчхондоо, өөр юунаас ч үл хамааран хэрвээ чи Бурханыг хуурвал хахир хатуу шүүлт чам дээр ирнэ. Та нар Түүнд үйлчлэх зөв зам руу орсноор дамжуулан хоёргүй үнэнч сэтгэлээ Бурханд өгөх нь зүйтэй. Бурханы өмнө эсвэл бусад хүмүүсийн өмнө байгаа эсэхээс үл хамааран зүрх сэтгэл чинь үргэлж Бурханд хандаж байх ёстойн дээр чи Бурханыг яг л Есүс шиг хайрлахаар шийдсэн байх ёстой. Ийм маягаар Бурхан чамайг төгс болгож, ингэснээр чи Бурханы зүрх сэтгэлийн төлөө явдаг, Түүний зарц болно. Хэрвээ чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж, үйлчлэл чинь Түүний хүсэлд нийцэж байхыг хүсэж байвал Бурханд итгэх итгэлийн талаарх өмнөх үзэл бодлоо өөрчилж, Бурханд үйлчилж байсан хуучин арга барилаа өөрчлөх ёстой, ингэснээр чи Бурханаар илүү их төгс болгуулна. Ингэвэл Бурхан чамайг орхихгүй, мөн чи Петр шиг, Бурханыг хайрладаг хүмүүсийн тэргүүн эгнээнд байх болно. Хэрвээ чи гэмшихгүй хэвээр үлдвэл Иудас шиг төгсгөл чамд ирнэ. Бурханд итгэдэг бүх хүн үүнийг ойлгох ёстой.

БУРХАН ХҮНИЙГ АШИГЛАХ ТАЛААР

Ариун Сүнс тусгай чиглэл, удирдамж өгсөн хүмүүсээс өөр хэн ч бие даан амьдрах чадваргүй, учир нь тэдэнд Бурханаар ашиглагдаж буй хүмүүсийн үйлчлэл болон хариулга шаардлагатай байдаг. Тиймээс эрин үе болгонд Бурхан, Өөрийнх нь ажлын төлөө чуулгануудыг хариулахаар завгүй яаравчлан ажилладаг өөр өөр хүмүүсийг өргөн босгодог. Өөрөөр хэлбэл, Бурханы ажил нь Түүний нааштайгаар онцлон үзэж, зөвшөөрдөг хүмүүсээр дамжин хийгдэх ёстой; Ариун Сүнс ажиллахын тулд тэдний дотор байгаа ашиглаж болох хэсгийг нь ашиглах ёстой байдаг ба Ариун Сүнсээр төгс болгуулснаар дамжуулан тэд Бурхан ашиглахад тохиромжтой болдог. Хүний ойлгох чадвар хэтэрхий дутмаг учраас Бурханы ашигладаг хүмүүс тэднийг хариулах ёстой; Бурхан Мосег ашиглахад ч ийм байсан, Тэр түүнээс тухайн үед ашиглахад тохиромжтой олон зүйлийг олсон бөгөөд тухайн үе шатан дахь Бурханы ажлыг хийхдээ үүнийг нь ашигласан юм. Энэ үе шатанд Бурхан, Ариун Сүнс ажиллахад хэрэглэж болох хэсгээр нь дамжуулан хүнийг ашигладаг бөгөөд Ариун Сүнс хүнийг чиглүүлэхийн зэрэгцээ ашиглаж болохгүй, үлдсэн хэсгийг нь ч төгс болгож байдаг.

Бурханы ашигладаг хүний гүйцэтгэдэг ажил нь Христ юм уу Ариун Сүнсний ажилтай хамтран ажиллахын төлөө байдаг. Энэ хүнийг Бурхан хүмүүсийн дундаас өргөдөг бөгөөд тэрээр Бурханы сонгосон бүх хүнийг удирдан хөтлөхийн төлөө, бас хүний хамтын ажиллагааны ажлыг гүйцэтгэхийн тулд Бурханаар өргөгддөг билээ. Хүний хамтын ажиллагааны ажлыг хийх чадвартай ийм хүн байснаар хүнд тавих Бурханы шаардлага болон хүмүүсийн дунд Ариун Сүнсний хийх ёстой ажлын дийлэнх нь түүгээр дамжин биелж болно. Үүнийг өөрөөр хэлэх юм бол: Энэ хүнийг ашиглах Бурханы зорилго нь Бурханыг дагадаг бүх хүнд Бурханы хүслийг илүү сайн ойлгуулж, тэднийг Бурханы илүү олон шаардлагад хүрч чаддаг болгохын төлөө байдаг. Хүмүүс Бурханы үгийг, эсвэл Бурханы хүслийг шууд ойлгох чадваргүй учраас тийм ажил гүйцэтгэхэд ашиглагдах хэн нэгнийг Бурхан өргөсөн. Бурханы ашигладаг энэ хүнийг хүмүүсийг залж чиглүүлдэг Бурханы зууч, Бурхан хүн хоёрыг хэл нэвтрэлцүүлдэг “орчуулагч” хэмээн тодорхойлж бас болно. Тиймээс ийм хүн бол Бурханы гэрт ажилладаг хүмүүс, эсвэл Түүний элчүүдийн хэнтэй ч адилгүй юм. Тэдний адилаар, түүнийг Бурханд үйлчилдэг нэгэн гэж хэлж болох ч түүний ажлын мөн чанар болон Бурханаар ашиглагдаж буйн цаад шалтгаан нь бусад ажилчид, элчүүдээс асар

их ялгаатай байдаг. Түүний ажлын мөн чанар болон түүнийг ашиглах цаад шалтгааны тухайд гэвэл, Бурханаар ашиглагддаг хүнийг Бурхан өргөдөг, мөн Бурхан түүнийг Бурханы ажлын төлөө бэлдэж, тэрээр Бурханы Өөрийн ажилд хамтран ажилладаг. Хэн ч, хэзээ ч түүний ажлыг орлож чадахгүй—энэ нь бурханлаг ажлаас салшгүй хүний хамтын ажиллагаа юм. Харин бусад ажилчид юм уу элчүүдийн гүйцэтгэдэг ажил нь зүгээр л цаг үе болгонд чуулгануудын зохицуулалтын олон талыг хэрэгжүүлж, дамжуулах явдал, эсвэл чуулганы амьдралыг хэвээр хадгалахын тулд амиар хангах зарим нэг энгийн ажил байдаг. Энэ ажилчид болон элчүүдийг Бурхан томилдоггүй, тэднийг Ариун Сүнсний ашигладаг хүмүүс гэж нэрлэж бүр ч болохгүй. Тэднийг чуулгануудын дотроос сонгодог бөгөөд хэсэг хугацаанд сургаж, боловсруулсны дараа тохирох хүмүүсийг нь үлдээдэг, харин тохирохгүй хүмүүсийг ирсэн газар луу нь буцаан илгээдэг. Энэ хүмүүсийг чуулгануудын дотроос сонгодог учраас зарим нь удирдагч болсныхоо дараа жинхэнэ нүүр царайгаа харуулж, зарим нь олон муу зүйл ч хийж, эцэстээ таягдан хаягддаг. Нөгөө талаар, Бурханы ашигладаг хүн бол Бурханаар бэлтгэгдсэн, тодорхой хэв чанартай, хүн чанартай хүн юм. Түүнийг Ариун Сүнс урьдчилан бэлтгэж, төгс болгосон байдаг бөгөөд Ариун Сүнс бүрэн удирддаг, ялангуяа түүний ажлын тухайд гэвэл Ариун Сүнс түүнийг чиглүүлж, захирч байдаг—үүний үр дүнд Бурханы сонгосон хүмүүсийг залж чиглүүлэх замд ямар ч гажуудал байдаггүй, учир нь Бурхан Өөрийн ажлыг гарцаагүй хариуцдаг бөгөөд Өөрийн ажлыг цаг ямагт хийж байдаг билээ.

ШИНЭ ЭРИН ҮЕИЙН ТУШААЛ

Бурханы ажлыг туулахдаа та нар Бурханы үгийг анхааралтай уншиж, өөрсдийгөө үнэнээр зэвсэглэх ёстой. Харин юу хийхийг хүсдэг, хэрхэн хийхийг хүсдэгийн чинь тухайд бол та нарын чин сэтгэлийн залбирал юм уу гуйлт хэрэггүй бөгөөд үнэндээ тэдгээр нь нэмэргүй. Гэвч одоогийн байдлаар та нарт тулгараад байгаа асуудал бол та нар Бурханы ажлыг хэрхэн туулахаа мэддэггүй, мөн дотор чинь ихээхэн идэвхгүй байдал байгаа явдал юм. Олон хоосон сургаал мэддэг хэр нь та нарт бодит байдал нэг их байдаггүй. Энэ нь эндүүрлийн тэмдэг бус уу? Энэ бүлэг хүн та нарт маш их төөрөгдөл байгаа нь илэрхий байна. Өнөөдөр та нар “үйлчлэл үзүүлэгч” гэх мэт шалгалтыг хүртэх чадваргүй, мөн Бурханы үгтэй холбоотой бусад шалгалт, цэвэршүүлэлтийг төсөөлж, хүртэх чадваргүй байдаг. Та нар өөрсдийн хэрэгжүүлэх учиртай олон

зүйлийг даган мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийн биелүүлэх ёстой олон үүргийг баримтлах ёстой байдаг. Үүнийг хүмүүс дагаж мөрдөх ёстой, үүнийг тэд хэрэгжүүлэх ёстой. Ариун Сүнсний хийх ёстой зүйлийг Ариун Сүнсээр хийлгэ; хүн үүнд оролцож болохгүй. Хүн өөрийн хийх ёстой зүйлийг л баримтлах хэрэгтэй ба энэ нь Ариун Сүнстэй ямар ч холбоогүй. Энэ нь хүний хийх учиртай зүйлээс өөр юу ч биш бөгөөд Хуучин Гэрээн дэх хуулийг дагахтай яг л адил тушаал мэт даган мөрдөх ёстой. Хэдийгээр одоо Хуулийн эрин үе биш боловч Хуулийн эрин үед ярьдаг байсантай адил дагаж мөрдөх ёстой олон үг байсаар байгаа. Ариун Сүнс сэтгэл хөдөлгөдөгт найдсанаар л эдгээр үгийг хэрэгжүүлдэггүй, харин эдгээр нь хүний даган мөрдөх ёстой зүйл юм. Жишээлбэл: Та нар бодитой Бурханы ажлыг шүүх ёсгүй. Бурханы гэрчилсэн хүнийг эсэргүүцэх ёсгүй. Бурханы өмнө та нар зөв зохистой авирлах ёстой, замбараагүй байж болохгүй. Хэл яриа чинь боломжийн байж, үг, үйлдэл чинь Бурханы гэрчилсэн хүний зохицуулалтыг дагах ёстой. Та нар Бурханы гэрчлэлийг хүндлэх ёстой. Бурханы ажлыг болон Түүний амнаас гарч байгаа үгийг үл тоох ёсгүй. Та нар Бурханы айлдварын өнгө, зорилгыг дуурайх ёсгүй. Гаднаа та нар Бурханы гэрчилсэн хүнийг илэрхий эсэргүүцэх ямар нэг зүйл хийж болохгүй, гэх мэтчилэн эдгээрийг хүн бүр даган мөрдөх ёстой. Эрин үе бүрд Бурхан хуультай төстэй олон дүрэм журмыг тогтоосон бөгөөд тэдгээрийг хүн даган мөрдөх ёстой байдаг. Үүгээр дамжуулан Тэр хүний зан чанарыг хязгаарлан барьж, чин сэтгэлийг нь илрүүлдэг. Жишээ нь, Хуучин Гэрээний эрин үеийн “Эцэг эхээ хүндэл” гэдэг үгийг аваад үз. Эдгээр үг нь өнөөдөр хэрэглэгдэхгүй; тухайн үед, эдгээр үг нь ердөө л хүний зарим гаднах зан чанарыг хазаарлаж, Бурханд итгэх хүний итгэлийн чин сэтгэлийг харуулахын тулд ашиглагдаж байсан, Бурханд итгэж байсан хүмүүсийн тэмдэг байв. Хэдийгээр одоо Хаанчлалын эрин үе ч гэсэн, хүний даган мөрдөх ёстой олон дүрэм журам байсаар байгаа. Өнгөрсөн үеийн дүрэм журам хэрэглэгддэггүй; өнөөдөр, хүн хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой бөгөөд шаардлагатай олон хэрэгжүүлэлт байгаа. Тэдгээрт Ариун Сүнсний ажил хамаарахгүйн дээр хүн хийх ёстой байдаг.

Нигүүлслийн эрин үед Хуулийн эрин үеийн олон хэрэгжүүлэлт хаягдсан, учир нь эдгээр хууль тухайн үеийн ажилд тодорхой үр нөлөөтэй байгаагүй. Тэдгээрийг хаясны дараа тухайн эрин үед тохиромжтой олон хэрэгжүүлэлтийг гаргаж тавьсан нь өнөөдрийн олон дүрэм журам болсон билээ. Өнөөдрийн Бурхан ирэхдээ эдгээр дүрэм журмыг хаяж, цаашид даган мөрдөх хэрэггүй

болсны дээр өнөөдрийн ажилд зохимжтой олон хэрэгжүүлэлтийг гаргаж тавьсан. Өнөөдөр, эдгээр хэрэгжүүлэлт нь дүрэм журам биш хэдий ч тодорхой үр дүнд хүрэхийг зорьдог; тэдгээр нь өнөөдөр тохиромжтой—магадгүй маргааш тэдгээр нь дүрэм журам болох болно. Дүгнээд хэлэхэд, чи өнөөдрийн ажилд үр өгөөжтэй дүрмийг даган мөрдөх ёстой. Маргаашийг бүү анхаар: Өнөөдөр хийгдэж байгаа зүйл өнөөдрийн төлөө байдаг. Магадгүй маргааш болоход, чиний хэрэгжүүлэх шаардлагатай илүү дээр хэрэгжүүлэлт гарах болно—гэхдээ түүнд хэтэрхий их анхаарал бүү хандуул. Харин Бурханыг эсэргүүцэхээс зайлсхийхийн тулд өнөөдөр даган мөрдөх ёстой зүйлээ л даган мөрд. Өнөөдөр хүний хувьд, дараах зүйлийг сахин мөрдөхөөс илүү чухал зүйл үгүй: Нүдний чинь өмнө зогсож байгаа Бурханыг чи аргалахаар оролдох юм уу Түүнээс юу ч нуух ёсгүй. Урд чинь байгаа Бурханы өмнө чи бузар заваан, биеэ тоосон юм ярьж болохгүй. Бурханы итгэлийг олж авах гэж нүдний чинь өмнө байгаа Бурханыг чихэр шиг үг, сайхан яриагаар хуурч болохгүй. Бурханы өмнө чи хүндэтгэлгүй авирлаж болохгүй. Чи Бурханы амнаас гарсан үг бүрийг дуулгавартай дагах ёстой бөгөөд Түүний үгийг сөрж, эсэргүүцэж, маргаж болохгүй. Чи Бурханы амнаас гарсан үгийг хүссэнээрээ тайлбарлаж болохгүй. Хорон муу хүмүүсийн ов мэхтэй урхинд орохоос зайлсхийж үг хэлээ хянах ёстой. Чамд зориулан Бурханы тогтоосон хил хязгаарыг давахаас зайлсхийж алхаагаа хянах ёстой. Хэрэв чи хил хязгаарыг давбал Бурханы байр сууринд зогсож, ихэрхүү, ихэмсэг үгээр ярихад хүрч, тэгснээр Бурханд жигшигдэх болно. Чи Бурханы амнаас гарсан үгийг хайхрамжгүйгээр түгээж болохгүй, тэгвээс бусад хүн чамайг дооглон тохуурхаж, диаволууд чамайг маллах вий. Чи өнөөдрийн Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах болно. Чи ойлгоогүй ч гэсэн үүнийг шүүж болохгүй; чи эрж хайж, нөхөрлөхөөс өөрийг хийж чадахгүй. Ямар ч хүн Бурханы анхдагч байр сууринд халдах ёсгүй. Чи хүний байр сууринаас өнөөдрийн Бурханд үйлчлэхээс өөр юу ч хийж чадахгүй. Чи хүний байр сууриас өнөөдрийн Бурханд зааж болохгүй—ингэх нь буруу юм. Бурханы гэрчилсэн хүний байранд хэн ч зогсож болохгүй; үг, үйлдэл, сэтгэлийн гүн дэх бодлоороо чи хүний байр сууринд зогсдог. Үүнийг баримтлах ёстой, энэ бол хүний хариуцлага, үүнийг хэн ч өөрчилж болохгүй бөгөөд ингэх нь захиргааны зарлигийг зөрчинө. Үүнийг хүн бүхэн санах ёстой.

Бурхан үгээ хэлж, айлдахад удаан хугацаа зарцуулсан нь, Бурханы үгийг уншиж цээжлэх нь түүний үндсэн үүрэг гэж бодоход хүнийг хүргэсэн. Хэн ч хэрэгжүүлэлтэд анхаарал хандуулдаггүй, баримтлах ёстой зүйлээ ч та нар

баримталдаггүй. Энэ нь та нарын үйлчлэлд олон бэрхшээл, асуудал авчирсан. Хэрвээ Бурханы үгийг хэрэгжүүлэхээсээ өмнө дагаж мөрдөх ёстой зүйлсээ дагаж мөрдөөгүй бол чи Бурханы жигшин, голдог хүмүүсийн нэг юм. Эдгээр хэрэгжүүлэлтийг дагаж мөрдөхдөө чи хичээнгүй, чин сэтгэлээсээ байх ёстой. Чи тэдгээрийг гав дөнгө гэж үзэлгүй, харин тушаал шиг дагаж мөрдөх ёстой. Өнөөдөр чи ямар үр дүнд хүрэх тухай санаа зовох учиргүй; товчхондоо Ариун Сүнс ингэж ажилладаг бөгөөд зөрчил гаргасан ямар ч хүн шийтгүүлэх ёстой. Ариун Сүнс сэтгэл хөдлөлгүй бөгөөд чиний одоогийн ойлголтыг анхаарч үздэггүй. Хэрвээ чи өнөөдөр Бурханд халдвал Тэр чамайг шийтгэнэ. Хэрвээ чи Өөрийнх нь эрх мэдлийн хүрээнд Түүнд халдвал Тэр чамайг өршөөхгүй. Есүсийн үгийг дагаж мөрдөхдөө хэчнээн нухацтай байдаг чинь Түүнд хамаагүй. Хэрвээ чи Бурханы өнөөдрийн тушаалуудыг зөрчвөл Тэр чамайг шийтгэж, үхэх ял онооно. Тэдгээрийг даган мөрдөхгүй байхыг чинь яаж хүлээн зөвшөөрч болох юм бэ? Бага зэргийн зовлон шаналал амсах байсан ч гэсэн чи дагаж мөрдөх ёстой! Ямар шашин, салбар, үндэстэн, урсгал байх нь хамаагүй ирээдүйд тэд бүгд эдгээр хэрэгжүүлэлтийг дагаж мөрдөх ёстой. Хэнийг ч чөлөөлж, хэнийг ч өршөөхгүй! Учир нь тэдгээр нь Ариун Сүнсний өнөөдөр хийх зүйл бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй. Хэдий тэдгээр нь агуу зүйл биш ч гэсэн хүн бүхний хийх ёстой бөгөөд дахин амилаад тэнгэр өөд гарсан Есүс хүний төлөө тогтоосон тушаалууд юм. Чиний зөв шударга эсвэл нүгэлтэй эсэхийг тодорхойлсон Есүсийн тодорхойлолт өнөөдөр Бурханд хандах хандлагаас чинь хамаардаг гэж “Зам... (7)” хэлээгүй гэж үү? Хэн ч энэ санааг орхигдуулж болохгүй. Хуулийн эрин үед фарисайчууд үе дамжин Бурханд итгэдэг байсан боловч Нигүүлслийн эрин үе ирэхэд тэд Есүсийг мэдэхгүй, Түүнийг эсэргүүцэж байсан. Иймээс тэдний хийсэн бүхэн нь юу ч биш болж, талаар өнгөрөн, үйл хэргийг нь Бурхан хүлээн зөвшөөрөөгүй. Хэрвээ чи үүнийг ухан ойлгож чадвал тийм ч амархан нүгэл үйлдэхгүй. Магадгүй олон хүн өөрийгөө Бурхантай харьцуулж байсан. Бурханыг эсэргүүцэх нь ямар санагдав? Гашуун байна уу, чихэрлэг байна уу? Чи үүнийг ойлгох ёстой—мэдэхгүй дүр бүү үзүүл. Зарим хүн зүрх сэтгэлдээ итгэхгүй хэвээр байж болох юм. Гэсэн ч, Би чамд оролдоод үзэхийг зөвлөж байна—ямар амтагдаж байгааг үз. Энэ нь олон хүн үргэлж үүнийг сэжиглэхээс сэргийлэх болно. Олон хүн Бурханы үгийг уншдаг атлаа зүрх сэтгэлдээ Түүнийг нууцхан эсэргүүцдэг. Түүнийг ингэж эсэргүүцсэний дараа зүрхийг чинь хутгаар сийчиж байгаа мэт чамд санагддаггүй гэж үү? Гэр бүл чинь эв найртай биш бол бие махбод чинь тав тухгүй байх буюу хүү, охинд чинь өвчин

зовлон тохиолдоно. Хэдийгээр махан бие чинь үхлээс хэлтэрсэн ч Бурханы гар чамаас хэзээ ч холдохгүй. Энэ тийм энгийн байж болно гэж чи бодож байна уу? Ялангуяа, Бурханд ойр байгаа олон хүний хувьд үүн дээр анхаарлаа төвлөрүүлэх нь бүр ч чухал юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр чи үүнийг мартана, тэгээд өөрийн мэдэлгүйгээр уруу таталтад автаж, бүх зүйлийг үл анхаарах бөгөөд энэ нь нүгэл үйлдэхийн чинь эхлэл байх болно. Энэ чамд шалихгүй зүйл мэт санагдаж байна уу? Хэрвээ чи үүнийг сайн хийж чадвал чамд төгс болгуулах боломж—Бурханы өмнө очиж, Өөрийнх нь амаар залуулж чиглүүлэх боломж байна. Хэрвээ чи болгоомжгүй байвал чамд гай тохиолдоно—чи Бурханыг үл тоож, үг үйлдэл чинь замбараагүй болж, эрт орой хэзээ нэгэн цагт ширүүн салхи, хүчтэй давлагаанд туугдан одно. Эдгээр тушаалыг та нар дор бүрнээ анхаарах ёстой. Хэрвээ чи тэдгээрийг зөрчвөл Бурханы гэрчилсэн хүн чамайг яллахгүй байж магадгүй ч Бурханы Сүнс чамтай тооцоо дуусахгүй, Тэр чамайг өршөөхгүй. Зөрчлийнхөө үр дагаврыг дааж чадах уу? Тиймээс, Бурхан юу ч гэж хэлсэн чи Түүний үгийг хэрэгжүүлж, бүхий л чадлаараа дагаж мөрдөх ёстой. Энэ бол энгийн зүйл биш!

МЯНГАН ЖИЛИЙН ХААНЧЛАЛ ИРЧИХСЭН

Бурхан энэ бүлэг хүмүүст ямар ажил гүйцэтгэхийг та нар харсан уу? Мянган жилийн хаанчлалд ч гэсэн хүмүүс айлдварыг нь цаашид дагасаар байх ёстой бөгөөд ирээдүйд Бурханы айлдварууд нь Канааны сайхан газар нутаг дахь хүний амьдралыг мөн л шууд залж чиглүүлнэ гэж Бурхан нэгэнтээ хэлсэн. Мосег цөлд байхад Бурхан түүнтэй шууд ярьж, зааварчилсан. Хүмүүст эдлүүлэхийн тулд Бурхан тэнгэрээс хоол хүнс, ус болон манна илгээсэн бөгөөд өнөөдөр ч гэсэн энэ хэвээр байдаг: Бурхан хүмүүст эдлүүлэхийн тулд идэж, уух зүйлийг доош биечлэн илгээсэн ба хүмүүсийг гэсгээхийн тулд биечлэн хараал илгээсэн. Иймээс Өөрийнхөө ажлын алхам бүрийг Бурхан биечлэн гүйцэтгэдэг. Өнөөдөр хүмүүс бодит баримтуудыг эрж хайж, тэмдэг, гайхамшгуудыг эрж хайдаг ба тийм хүмүүс бүгд хаягдана, учир нь Бурханы ажил улам бүр бодитой болж байгаа. Бурхан тэнгэрээс бууж ирснийг хэн ч мэддэггүй, Бурхан хоол хүнс, тамиржуулах бэлдмэлийг тэнгэрээс доош илгээсэн гэдгийг ч бас мэддэггүй—гэхдээ Бурхан үнэхээр оршин байдаг бөгөөд хүмүүсийн төсөөлдөг Мянган жилийн хаанчлалын халуун дотно дүр зураг ч бас Бурханы хувийн айлдвар юм. Энэ нь бодит баримт бөгөөд зөвхөн үүнийг л газар дээр Бурхантай хамт хаанчлах гэж нэрлэдэг. Газар

дээр Бурхантай хамт хаанчлах гэдэг нь махан биеийг хэлдэг. Махан биеийнх биш зүйл газар дээр оршин байдаггүй бөгөөд тиймээс гурав дахь тэнгэр лүү явахад анхаарлаа төвлөрүүлдэг бүх хүн дэмий юм хийж байна. Нэг өдөр бүхий л орчлон ертөнц Бурхан руу буцаж очиход сансар огторгуй даяарх Түүний ажлын төв Түүний айлдваруудыг дагана; өөр хаа нэгтээ Бурханы айлдварыг хүлээн авахын тулд зарим хүн утас ашиглана, зарим нь онгоцоор явна, зарим нь завиар тэнгис гатална, мөн зарим нь лазер ашиглана. Хүн бүр бахдан биширч, хүсэн эрмэлзэх ба бүгд Бурханд ойртон ирж, Бурхан руу цугларч, бүгд Бурханд шүтэн мөргөнө—энэ бүхэн нь Бурханы үйл хэрэг байх болно. Үүнийг сана! Бурхан хэзээ ч хаа нэгтээ дахин эхлэхгүй нь гарцаагүй. Бурхан энэ баримтыг гүйцэлдүүлнэ: Тэр орчлон ертөнц даяар бүх хүнийг Өөрийнхөө өмнө ирүүлж, газар дээрх Бурханыг шүтүүлэх ба өөр газрууд дахь Түүний ажил зогсож, хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Энэ нь Иосеф шиг байх болно: Түүнд идэх юм байсан учраас хүн бүр хоол хүнс авахаар түүн рүү очиж, түүнд бөхийдөг байсан. Өлсгөлөнгөөс зайлсхийхийн тулд хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Шашны нийгэмлэг тэр чигтээ асар их өлсгөлөн амсах ба зөвхөн өнөөдрийн Бурхан л хүний таашаалыг хангах мөнх урсах булагтай амийн усны ширгэшгүй булаг бөгөөд хүмүүс Түүн рүү очиж, Түүнд найдна. Тэр нь Бурханы үйл хэрэг илчлэгдэж, Бурхан алдрыг олж авах цаг байх болно; орчлон ертөнц даяар бүх хүн хэнд ч анзаарагдамгүй энэ “хүнд” шүтэн мөргөнө. Энэ нь Бурханы алдрын өдөр байх бус уу? Нэг өдөр ахмад пасторууд амийн усны ширгэшгүй булгаас ус хайн цахилгаан мэдээ илгээнэ. Тэд өндөр настай байх боловч өөрсдийнхөө дорд үзэж байсан энэ хүнийг шүтэн мөргөхөөр ирнэ. Тэд Түүнийг амаараа хүлээн зөвшөөрч, чин сэтгэлээсээ Түүнд итгэнэ—энэ нь тэмдэг, гайхамшиг биш гэж үү? Хаанчлал бүхэлдээ хөөрөн баярлах үе нь Бурханы алдрын өдөр байх ба та нар дээр ирж, Бурханы сайн мэдээг хүлээн авдаг хэн боловч Бурханаар ерөөгдөнө, улс орнууд, хүмүүс Бурханаар ерөөгдөж, халамжлуулна. Ирээдүйн чиглэл ийм байна: Бурханы амнаас гарсан айлдварыг олж авсан хүмүүс газар дээр алхах замтай байх бөгөөд бизнес эрхлэгчид, эрдэмтэд, сурган хүмүүжүүлэгчид, аж үйлдвэр эрхлэгчид ч бай, Бурханы үггүй хүмүүсийн хувьд ганц алхам хийхэд ч хэцүү байх бөгөөд албан хүчээр үнэн замыг эрж хайна. “Үнэнтэй бол чи дэлхий даяар алхана; үнэнгүй бол хаана ч хүрч чадахгүй” гэдгийн учир энэ юм. Бодит баримт ийм байдаг: Бүх орчлон ертөнцийг захирч, хүн төрөлхтнийг удирдаж, байлдан дагуулахын тулд Бурхан Замыг (Өөрийн бүх үгийг гэсэн утгатай) ашиглана. Бурханы ажилладаг

арга барилд асар их өөрчлөлт гарна гэж хүмүүс үргэлж найдаж байгаа. Шулуухан хэлэхэд, Бурхан хүмүүсийг үгээр дамжуулан хянадаг ба чи хүссэн, хүсээгүй Түүний хэлдэг зүйлийг хийх ёстой; энэ бол бодит баримт, үүнийг бүгд дуулгавартай дагах ёстой, иймээс энэ нь бас гуйвшгүй бөгөөд бүх хүний мэддэг зүйл юм.

Ариун Сүнс хүмүүст мэдрэмж өгдөг. Бурханы үгийг уншсаны дараа хүмүүсийн сэтгэлд тогтвортой, амар амгалан санагддаг, харин Бурханы үгийг олж аваагүй хүмүүст хоосон санагддаг. Бурханы үгийн хүч чадал энэ юм. Хүмүүс тэдгээрийг унших ёстой ба уншсанахаа дараа тэд тэжээгдэж, Бурханы үггүйгээр байж чадахгүй. Хүмүүс хар тамхи хэрэглэдэгтэй энэ нь адилхан: Энэ нь тэдэнд хүч чадал өгдөг, хэрэглэхгүй бол үүнд асар их татагдаж, ямар ч хүчгүй болдог. Энэ бол өнөөгийн хүмүүсийн дундах чиг хандлага юм. Бурханы үгийг унших нь хүмүүст хүч чадал өгдөг. Хэрвээ тэд үүнийг уншихгүй бол үлбэгэр хойрго болдог, харин уншсанахаа дараа “хэвтрээсээ” даруй өндийн босдог. Энэ бол Бурханы үг газар дээр эрх мэдэл эзэмшиж, Бурхан газар дэлхий дээр захирч байгаа хэрэг юм. Зарим хүн орхин явахыг хүсдэг, эсвэл Бурханы ажлаас залхдаг. Гэсэн ч тэд Бурханы үгээс салж чадахгүй; хэчнээн сул дорой ч тэд мөн л Бурханы үгээр амьдрах ёстой, хэчнээн тэрслүү ч Бурханы үгийг орхиж мөн л зүрхэлдэггүй. Бурханы үг сүр хүчээ үнэхээр харуулах үе бол Бурхан хаанчилж, эрх барих үе юм; Бурхан ингэж ажилладаг. Эцсийн эцэст энэ нь Бурханы ажилладаг арга барил бөгөөд хэн ч үүнийг орхиж болохгүй. Бурханы үг тоо томшгүй олон айл өрхөд түгж, бүгдэд мэдэгдэнэ, тэр үед л Түүний ажил орчлон ертөнц даяар түгнэ. Өөрөөр хэлбэл, хэрвээ Бурханы ажлыг бүх орчлон ертөнц даяар түгээх гэвэл Түүний үгийг түгээх ёстой. Бурханы алдрын өдөр Бурханы үг хүч чадал, эрх мэдлээ харуулна. Балар эртний үеэс өнөөдрийг хүртэлх Түүний үг нэг бүр гүйцэлдэж, биелнэ. Ийм маягаар Бурхан газар дээр алдар суугаа олж авна— өөрөөр хэлбэл, Түүний үг газар дээр хаанчилна. Хорон муу хүмүүс бүгд Бурханы амнаас гарсан үгээр гэсгээгдэж, зөв шударга хүмүүс бүгд Түүний амнаас гарсан үгээр ерөөгдөх ба бүгд Түүний амнаас гарсан үгээр тогтоогдож, бүрэн төгс болгуулна. Тэр ямар нэгэн тэмдэг, гайхамшиг ч үзүүлэхгүй; Түүний үгээр бүх зүйл гүйцэлдэж, Түүний үг бодит баримтыг бий болгоно. Газар дээрх хүн бүр Бурханы үгийг магтан тэмдэглэж, томчуул, хүүхдүүд, эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу бүх хүн Бурханы үгийн дор захирагдана. Бурханы үг махбодоор илэрч, тэдгээрийг тод томруун, бодитоор газар дээр харах боломжийг хүмүүст олгодог. Үг махбод болох гэдгийн утга учир энэ юм. “Үг махбод болох” баримтыг голчлон

гүйцэлдүүлэхийн тулд Бурхан газар дээр ирсэн, өөрөөр хэлбэл, Өөрийнхөө үгийг махбодоос гаргахын тулд (Бурханы дуу хоолой шууд тэнгэрээс гардаг байсан Хуучин Гэрээний Мосегийн цаг үе шиг биш) Тэр ирсэн. Үүний дараа Мянгын жилийн хаанчлалын эрин үед Түүний бүх үг биелж, хүмүүсийн нүдний өмнө харагдахуйц бодит баримт болох ба хүмүүс тэдгээрийг өөрсдийн нүдээр яг тэр хэвээр нь харна. Энэ бол Бурхан бие махбодтой болохын эрхэм дээд ач холбогдол юм. Өөрөөр хэлбэл, Сүнсний ажил махбодоор, үгээр гүйцэлддэг. Энэ бол “Үг махбод болох”, “Үг махбодоор илрэх” гэдгийн жинхэнэ утга учир юм. Бурхан л Сүнсний хүслийг ярьж чадах ба махбод дахь Бурхан л Сүнсний өмнөөс ярьж чадна; Бурханы үг бие махбодтой болсон Бурханаар илэрхийлэгдэж, бусад нь үүгээр замчлуулна. Хэн ч үүнээс ангид биш, тэд бүгдээрээ энэ цар хүрээн дотор оршдог. Зөвхөн эдгээр айлдвараас л хүмүүс мэддэг болж чадна; ийм маягаар олж аваагүй хүмүүс өөрсдийгөө тэнгэрийн айлдварыг олж авч чадна гэж бодож байгаа бол сэрүүн зүүдэлж байна. Бүх хүнийг үүнд бүрэн итгүүлэх нь Бурханы махбод болсон биеэс харагддаг илэрхийлэгддэг эрх мэдэл юм. Хамгийн хүндэт мэргэжилтнүүд болон шашны пасторууд хүртэл эдгээр үгийг хэлж чадахгүй. Тэд бүгд эдгээр үгэнд захирагдах ёстой ба хэн ч өөрийг эхлүүлж чадахгүй. Бурхан орчлон ертөнцийг байлдан дагуулахын тулд үг ашиглана. Тэр үүнийг Өөрийн махбод болсон биеэр хийхгүй, харин махбод болсон Бурханы амнаас гарах айлдваруудыг ашиглан бүхий л орчлон ертөнц дэх бүх хүнийг байлдан дагуулна; энэ л Үг махбод болох явдал, мөн энэ л Үг махбодоор илрэх явдал юм. Бурхан төдийлөн их ажил хийгээгүй мэт хүмүүст санагдаж магадгүй—гэхдээ Бурханыг үгээ айлдмагц хүмүүс бүрмөсөн үнэмшиж, мэл гайхна. Бодит баримт байхгүй бол хүмүүс орилж хашхирдаг; Бурханы үг байвал тэд чимээгүй болдог. Бурхан энэ баримтыг гарцаагүй гүйцэлдүүлнэ, учир нь энэ бол Бурханы аль хэдийн тогтоосон төлөвлөгөө буюу Үг газар дээр ирсэн баримтыг гүйцэлдүүлэх явдал юм. Үнэндээ, Мянгын жилийн хаанчлал газар дээр ирсэн нь Бурханы үг газар дээр ирсэн хэрэг юм гэдгийг тайлбарлах хэрэг Надад байхгүй. Шинэ Иерусалим тэнгэрээс бууж ирсэн нь Бурханы үг хүмүүсийн дунд амьдрахаар ирж, хүний үйлдэл бүрийг болон үнэн сэтгэлийн бүх бодлыг нь дагалдаж буй хэрэг юм. Энэ нь бас Бурханы гүйцэлдүүлэх баримт; Мянгын жилийн хаанчлалын гоо үзэсгэлэн билээ. Энэ бол Бурханы тогтоосон төлөвлөгөө: Түүний үг газар дээр мянгын жилийн турш харагдаж, Түүний бүх үйл хэргийг харуулж, газар дээрх Түүний бүх ажлыг дуусгана, үүний дараа хүн төрөлхтний энэ үе шат төгсгөлдөө очно.

БОДИТОЙ БУРХАН БОЛ БУРХАН ӨӨРӨӨ ГЭДГИЙГ ЧИ МЭДЭХ ЁСТОЙ

Бодитой Бурханы талаар чи юу мэдэх хэрэгтэй вэ? Бодитой Бурханыг Сүнс, Хүн болон Үг бүрдүүлдэг бөгөөд энэ бол бодитой Бурханы Өөрийн жинхэнэ утга учир юм. Хэрэв чи Түүний зуршил, зан төлөвийг буюу Хүнийг л мэддэг бөгөөд Сүнсний ажлын талаар болон Сүнс махбодод юу хийдгийг мэддэггүй бол, мөн хэрвээ чи бодитой Бурхан дахь Бурханы Сүнсний ажлыг мэдэлгүй Сүнс, Үг хоёрт л анхаарал хандуулж, зөвхөн Сүнсний өмнө залбирдаг бол бодитой Бурханыг мэддэггүй гэдгийг чинь энэ нь баталдаг. Бодитой Бурханы талаарх мэдлэг нь, Түүний үгийг мэдэж, туулах, Ариун Сүнсний ажлын дүрэм журам, зарчмуудыг болон Бурханы Сүнс махбодод хэрхэн ажилладгийг ойлгохоос бүрддэг. Түүнчлэн махбод дахь Бурханы үйлдэл бүрийг Сүнс удирддаг бөгөөд Түүний хэлсэн үг бол Сүнсний шууд илэрхийлэл юм гэдгийг мэдэх явдал ч бас үүнд багтдаг. Тиймээс, бодитой Бурханыг мэдэхийн тулд Бурхан хүн чанар болон бурханлаг чанараар хэрхэн ажилладгийг мэдэх нь хамгийн чухал; энэ нь эргээд, бүх хүний холбогддог Сүнсний илэрхийлэлтэй хамаатай юм.

Сүнсний илэрхийллийн талууд юу вэ? Бурхан заримдаа хүн чанараар, заримдаа бурханлаг чанараар ажилладаг боловч аль ч тохиолдолд Сүнс захирч байдаг. Хүмүүсийн дотор ямар сүнс байна, гадаад илэрхийлэл нь тийм байдаг. Сүнс хэвийн байдлаар ажилладаг боловч Сүнсээр удирдуулахад хоёр хэсэг бий: Нэг хэсэг нь Түүний хүн чанар дахь ажил, нөгөөх нь бурханлаг чанарын ажил юм. Үүнийг чи тодорхой мэдэх ёстой. Сүнсний ажил нөхцөл байдлаас хамааран янз бүр байдаг: Түүний хүн чанарын ажил шаардлагатай үед Сүнс энэхүү хүн чанарын ажлыг чиглүүлдэг, харин бурханлаг ажил нь шаардлагатай үед үүнийг хэрэгжүүлэхээр бурханлаг чанар нь шууд гарч ирдэг. Бурхан махбодоор ажиллаж, махбодоор илэрдэг учраас хүн чанар, бурханлаг чанарын аль алинд ажилладаг. Түүний хүн чанар дахь ажил Сүнсээр удирдуулдаг ба хүмүүсийн махан биеийн хэрэгцээг хангах, Түүнтэй харилцах тэдний харилцааг хөнгөвчлөх, тэдэнд Бурханы бодит байдал болон хэвийн байдлыг харуулах, түүнчлэн Бурханы Сүнс махбодод ирээд, хүмүүсийн дунд, хүнтэй хамт амьдарч, хүнтэй харилцаж байгаа гэдгийг харуулахын төлөө байдаг. Түүний бурханлаг чанар дахь ажил нь хүмүүсийн амийг хангаж, бүх зүйл дээр эерэг талаас нь хүмүүсийг залж чиглүүлж, хүмүүсийн зан чанарыг өөрчилж, махбод дахь Ариун Сүнсний илрэлтийг тэдэнд үнэхээр харуулахын төлөө байдаг. Үндсэндээ, хүний

амийн өсөлт нь бурханлаг чанар дахь Бурханы ажил ба үгээр дамжин шууд биелдэг. Бурханы бурханлаг чанар дахь ажлыг хүлээн зөвшөөрч байж л хүмүүсийн зан чанар өөрчлөгдөх ба тэр үед л тэдний сүнс цадна; үүн дээр хүн чанарын ажил буюу Бурханы хүн чанар дахь хариулга, дэмжлэг, хангалтыг нэмсэн тохиолдолд л Бурханы ажлын үр дүнд бүрэн хүрч чадна. Өнөөдөр яригдаж буй бодитой Бурхан Өөрөө хүн чанар болон бурханлаг чанарын аль алианаар ажилладаг. Бодитой Бурханы илрэлтээр дамжуулан хэвийн хүн чанарын ажил, амьдрал болон бүрэн бурханлаг ажил нь хийгддэг. Түүний хүн чанар, бурханлаг чанар хоёр нэг болж, аль алиных нь ажил үгээр дамжин хэрэгждэг; хүн чанараар ч бай, бурханлаг чанараар ч бай, Тэр үг айлддаг. Бурхан хүн чанараар ажиллахдаа хүмүүсийг ойлгож, харилцдаг гэж хүн чанарын хэлээр ярьдаг. Түүний үг илэн далангүй, ойлгоход хялбар болохоор бүх хүнийг хангаж чадна; хүмүүс мэдлэгтэй ч бай, боловсрол муутай ч бай, Бурханы үгийг бүгд хүлээн авч чаддаг. Бурханы бурханлаг чанар дахь ажил ч мөн үгээр хийгддэг боловч энэ нь хангалтаар дүүрэн, амиар дүүрэн байдаг бөгөөд хүний санаа холилдоогүй, хүний шилэлт сонголтыг агуулаагүй, хүн чанарын хязгаарт захирагддаггүй, ямар ч хэвийн хүн чанарын хязгаараас гадна оршдог; энэ нь мөн л махбодоор хийгддэг боловч Сүнсний шууд илэрхийлэл юм. Хэрвээ хүмүүс Бурханы хүн чанар дахь ажлыг л хүлээн зөвшөөрвөл өөрсдийгөө тодорхой хүрээнд хорих тул өчүүхэн төдий өөрчлөлт гаргахын тулд урт удаан хугацааны харьцалт, засалт, сахилгажуулалт шаардагдана. Гэхдээ Ариун Сүнс дэргэд нь байж ажиллахгүй л бол тэд үргэлж бахь байдагтаа эргэн орно; бурханлаг чанар дахь ажлаар л дамжуулан эдгээр эмгэг, дутагдлыг залруулж болох ба тэр үед л хүмүүс бүрэн төгс болгуулж чадна. Байнгын харьцалт, засалтын оронд бүх дутагдлыг залруулахад үг ашиглах, хүмүүсийн бүх байр байдлыг илчлэхэд үг ашиглах, тэдний амьдрал, үг яриа, үйлдэл бүрийг чиглүүлж, санаа зорилго, сэдлийг нь илчлэхэд үг ашиглах эерэг хангалт л шаардлагатай байдаг; энэ нь бодитой Бурханы бодит ажил юм. Тиймээс та нар бодитой Бурханд хандах хандлагаараа Түүний хүн чанарын өмнө захирагдан, Түүнийг таньж, хүлээн зөвшөөрөх ёстой, түүнчлэн чи бурханлаг ажил болон үгийг нь хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагах ёстой. Бурхан махбодоор илэрнэ гэдэг нь Бурханы Сүнсний бүх үг, ажил Түүний хэвийн хүн чанар болон Бурханы махбод болсон биеэр хийгддэг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс хүн чанарын ажлаа чиглүүлж, бурханлаг чанарын ажлыг махбодоор гүйцэтгэдэг бөгөөд бие махбодтой болсон Бурханаас чи хүн чанар дахь Бурханы ажил болон бүрэн

дүүрэн бурханлаг ажлын аль алийг харж чадна; энэ бол бодитой Бурхан махбодоор гарч ирэхийн ач холбогдол билээ. Хэрвээ чи үүнийг тодорхой харж чадвал Бурханы бүх ялгаатай хэсгийг холбож чадна; мөн бурханлаг чанар дахь ажлыг нь хэтэрхий чухалчлахаа больж, хүн чанар дахь ажлыг нь хэтэрхий их үл ойшоохоо болиод, хэт туйлшрахгүй, мөн ямар ч тойруу замаар явахгүй. Ерөнхийдөө, бодитой Бурханы утга учир гэвэл Сүнсээр удирдуулсан Түүний хүн чанар болон бурханлаг чанарын ажил нь Түүний махбодоор илэрхийлэгддэг, ингэснээр хүмүүс Тэр бол тод томруун, амьд, үнэн бодитой гэдгийг харж чадна.

Хүн чанар дахь Бурханы Сүнсний ажилд шилжилтийн үеүд бий. Хүн чанараа төгс болгосноор Түүний хүн чанар Сүнсний удирдамжийг хүлээн авах боломжтой болдог, үүний дараа Түүний хүн чанар чуулгануудыг хангаж, хариулах чаддаг. Энэ бол Бурханы хэвийн ажлын нэг илэрхийлэл юм. Тиймээс хэрвээ чи Бурханы хүн чанар дахь ажлын зарчмыг тодорхой ойлгосон бол Бурханы хүн чанарын ажлын талаар үзэл өвөрлөх нь юу л бол. Бусад нь ямар ч бай, Бурханы Сүнс буруутна гэж үгүй. Түүний зөв, Тэр алдана гэж үгүй; ямар ч зүйлийг Тэр буруу хийхгүй. Бурханлаг ажил бол хүн чанарын хөндлөнгийн оролцоогүй Бурханы хүслийн шууд илэрхийлэл юм. Энэ нь төгс болголтыг туулалгүй Сүнснээс шууд ирдэг. Гэсэн ч үнэндээ Тэр хэвийн хүн чанараасаа үүдэн бурханлаг чанараар ажиллаж чаддаг; энэ нь ер бусын зүйл огтхон ч биш бөгөөд хэвийн хүн хийж байгаа мэт харагддаг. Бурхан үндсэндээ махбодоор дамжуулан үгээ илэрхийлж, махбод ашиглан Бурханы Сүнсний ажлыг гүйцээхийн тулд тэнгэрээс газар луу ирсэн юм.

Өнөөдөр, бодитой Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг хэтэрхий нэг талыг барьсан хэвээр бөгөөд бие махбодтой болсон Бурханы ач холбогдлын талаарх ойлголт нь хэтэрхий өчүүхэн байсаар байна. Бурханы махбод байгаа болохоор Түүний ажил болон үгээр дамжуулан хүмүүс, Бурханы Сүнс ийм ихийг агуулдаг, Тэрээр маш баялаг гэдгийг хардаг. Гэвч үүнээс үл хамааран Бурхан махбодоор юу хийдэг, ямар зарчмаар ажилладаг, хүн чанараар юу хийдэг, бурханлаг чанараар юу хийдэг гэх мэт Бурханы гэрчлэл эцсийн дүндээ Бурханы Сүнснээс ирдэг. Хүмүүс энэ талаар мэдлэгтэй байх ёстой. Өнөөдөр чи энэ хүнд шүтэн мөргөж байж болох ч үнэндээ Сүнсийг шүтэж байгаа хэрэг бөгөөд махбодоор дамжуулан Сүнсний мөн чанарыг мэдэх, махбод дахь Сүнсний бурханлаг ажил болон хүн чанарын ажлыг мэдэх, махбод дахь Сүнсний бүх үг, айлдварыг хүлээн авах, Бурханы Сүнс махбодыг хэрхэн удирдаж, махбодоор хүч чадлаа харуулдгийг харах зэрэг нь бие махбодтой болсон Бурханы талаар хүмүүсийн

олж авах ёстой наад захын мэдлэг билээ. Өөрөөр хэлбэл, хүн махбодоор дамжуулан тэнгэр дэх Сүнсийг мэдэж авдаг; хүмүүсийн дундах бодитой Бурханы Өөрийн илрэлт хүмүүсийн үзэл дэх тодорхойгүй Бурханыг арилгасан. Хүмүүс бодитой Бурханыг Өөрийг нь шүтэн мөргөснөөр Бурханд дуулгавартай байдал нь нэмэгдэж, Бурханы Сүнсний махбод дахь бурханлаг ажил болон хүн чанарын ажлаар дамжуулан хүн илчлэл, хариулгыг хүлээн авч, амь зан чанарт нь өөрчлөлт гардаг. Сүнс махбодод ирсний жинхэнэ утга учир үүнд л оршдог бөгөөд үндсэндээ ингэснээр хүмүүс Бурхантай холбогдож, Бурханд найдан, Бурханы талаарх мэдлэгийг олж авч болох юм.

Ер нь хүмүүс бодитой Бурханы талаар ямар хандлага баримтлах ёстой вэ? Бие махбодтой болсон Бурханы талаар, Үг нь махбодоор илэрсэн талаар, Бурхан махбодоор илэрсэн талаар болон бодитой Бурханы үйл хэргийн талаар чи юу мэдэх вэ? Өнөөдрийн ярианы үндсэн сэдэв юу вэ? Бие махбодтой болсон Бурхан, Үг нь махбодод ирэх, Бурхан махбодоор илрэх гэдэг нь та нарын ойлгох ёстой асуудлууд юм. Та нар биеийн хэмжээндээ болон эрин үед үндэслэн эдгээр асуудлыг аажмаар ойлгож, амийн туршлагынхаа явцад эдгээрийг тодорхой мэддэг болох ёстой. Хүмүүс Бурханы үгийг туулах үйл явц нь Бурханы үг махбодоор илрэхийг мэдэж авахтай ижил үйл явц юм. Хүмүүс Бурханы үгийг хэдий чинээ их туулна, Бурханы Сүнсийг төдий чинээ их мэдэх болно; Бурханы үгийг туулснаар хүмүүс Сүнсний ажлын зарчмыг ухаарч, бодитой Бурханыг Өөрийг нь мэдэж авдаг. Үнэндээ Бурхан хүмүүсийг төгс болгож, олж авах үедээ бодитой Бурханы үйл хэргийг тэдэнд мэдэгдэж байгаа; Тэрээр хүмүүст бие махбодтой болсон Бурханы бодит ач холбогдлыг харуулж, Бурханы Сүнс хүний өмнө үнэхээр илэрсэн гэдгийг үзүүлэхийн тулд бодитой Бурханы ажлыг ашиглаж байна. Хүмүүс Бурханаар авхуулж, Бурханаар төгс болгуулах үед бодитой Бурханы илэрхийлэл тэднийг байлдан дагуулсан; бодитой Бурханы үг тэднийг өөрчилж, Өөрийн амийг тэдэн дотор оруулж, Тэр юу болохоор (Тэр хүн чанарын хувьд юу болох, бурханлаг чанарын хувьд юу болохын аль нь ч бай) тэднийг дүүргэж, Түүний үгийн мөн чанараар тэднийг дүүргэж, Түүний үгийг амьдран харуулахад хүмүүсийг хүргэсэн. Бурхан хүмүүсийг олж авахдаа голчлон бодитой Бурханы үг, айлдварыг ашиглах замаар хүмүүсийн дутагдалтай харьцаж, тэрслүү зан чанарыг нь шүүж, илчилдэг ба хэрэгтэй зүйлээ олж авахад тэднийг хүргэж, Бурхан хүмүүсийн дунд ирсэн гэдгийг харуулдаг. Хамгийн чухал нь, бодитой Бурханы хийдэг ажил хүн бүрийг Сатаны нөлөөнөөс аварч, бохир заваан газраас холдуулж, завхарсан зан чанарыг нь арилгадаг. Бодитой

Бурханаар авхуулахын хамгийн гүн гүнзгий ач холбогдол нь бодитой Бурханыг үлгэр жишээ, үлгэр дуурайлаа болгон, хэвийн хүн чанарыг амьдран харуулж, бодитой Бурханы үг, шаардлагын дагуу өчүүхэн ч гажилт, хазайлтгүйгээр хэрэгжүүлж, Түүний хэлсэн ямар ч байдлаар хэрэгжүүлж, шаардсан болгоныг нь биелүүлж чаддаг байх явдал юм. Ийм маягаар Бурхан чамайг олж авах болно. Бурхан чамайг олж авах үед чи зөвхөн Ариун Сүнсний ажлыг эзэмшихгүй; гол нь чи бодитой Бурханы шаардлагыг амьдран харуулж чаддаг байна. Ариун Сүнсний ажилтай байлаа гээд чамд амь байгаа гэсэн үг биш. Гол нь бодитой Бурханы шаардлагын дагуу үйлдэж чадах уу, үгүй юү гэдэг бөгөөд энэ нь Бурхан чамайг олж авч чадах эсэхтэй холбоотой. Эдгээр нь махбод дахь бодитой Бурханы ажлын хамгийн том утга учир юм. Өөрөөр хэлбэл, Бурхан үнэхээр, бодитоор махбодод илэрч, хүмүүст тод томруун, амьд харагдаж, Сүнсний ажлыг махбодоор бодитоор хийж, махбодоор хүмүүст үлгэр дуурайл болсноороо бүлэг хүмүүсийг олж авдаг. Бурхан махбодод ирдэг нь үндсэндээ хүмүүст Бурханы жинхэнэ үйл хэргийг харуулах, хэлбэр дүрсгүй Сүнсийг махбодод биежүүлэх, Түүнийг харах, Түүнд хүрэх боломжийг хүмүүст олгохын төлөө байдаг. Энэ маягаар, Түүгээр бүрэн төгс болгуулсан хүмүүс Түүнийг амьдран харуулж, Түүгээр авхуулж, Түүний зүрх сэтгэлийн дагуу болно. Хэрвээ Бурхан зөвхөн тэнгэрт яриад, газар дээр бодитоор ирээгүй бол хүмүүс Бурханыг одоо ч мэдэж чадахгүй байх байв; тэд хоосон онол ашиглан Бурханы үйл хэргийг номлож л чадахаас биш, Бурханы үгийг бодит байдал болгон авч чадахгүй байх байлаа. Бурхан үндсэндээ, олж авсан хүмүүстээ үлгэр жишээ, загвар болохын тулд л газар дээр ирсэн; ийм маягаар л хүмүүс Бурханыг үнэхээр мэдэж, Бурханд хүрч, Түүнийг харж чадах ба тэр үед л Бурхан тэднийг үнэхээр олж авч чадна.

БУРХАНЫ ӨНӨӨДРИЙН АЖЛЫГ МЭДЭХ НЬ

Өнөө үед Бурханы ажлыг мэдэх нь голчлон, эцсийн өдрүүд дэх бие махбодтой болсон Бурханы үндсэн үйлчлэл юу болохыг болон Тэр юу хийхээр газар дээр ирснийг мэдэх явдал юм. Бурхан явахаасаа өмнө үлгэр жишээ үзүүлэхийн тулд (эцсийн өдрүүдэд) газар дээр ирсэн гэдгийг Би Өөрийнхөө үгэнд өмнө нь дурдсан. Бурхан энэ үлгэр жишээг хэрхэн үзүүлдэг вэ? Үг хэлснээр, бүх газар нутаг даяар ажиллаж, үг хэлснээр үзүүлдэг. Энэ бол эцсийн өдрүүд дэх Бурханы ажил юм; Тэрээр газар дэлхийг үгийн ертөнц болгохын тулд

зөвхөн үг хэлдэг, ингэснээр хүн бүрийг Түүний үг хангаж, гэгээрүүлдэг, мөн хүний сүнс сэргэж, хүн үзэгдлүүдийн талаар тодорхой мэдэж авдаг. Эцсийн өдрүүдэд, бие махбодтой болсон Бурхан голчлон үг хэлэхийн тулд газар дээр ирсэн. Есүс ирэхдээ тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж, цовдлолын золин авралын ажлыг гүйцэлдүүлсэн. Тэрээр Хуулийн эрин үеийг төгсгөж, бүх хуучин зүйлийг халсан. Есүсийн ирэлт нь Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг авчирсан; эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы ирэлт нь Нигүүлслийн эрин үеийг төгсгөл болгосон юм. Тэрээр үндсэндээ Өөрийн үгийг хэлэхээр, үг ашиглан хүнийг төгс болгож, гэгээрүүлж, гэрэлтүүлэхээр, хүний зүрх сэтгэл доторх тодорхойгүй Бурханы орон зайг арилгахаар ирсэн билээ. Есүс ирэх үедээ энэ үе шатны ажлыг хийгээгүй. Есүс ирээд олон ид шид үзүүлсэн, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулсан ба цовдлолын золин авралын ажлыг хийсэн юм. Үүний үр дүнд, өөрсдийн үзэлдээ хүмүүс Бурхан ийм л байх ёстой гэж итгэдэг. Учир нь Есүс ирэхдээ хүний зүрх сэтгэлээс тодорхойгүй Бурханы дүрийг арилгах ажил хийгээгүй; харин Тэр цовдлогдож, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээсэн. Нэг талаар, эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан нь хүний үзэл дэх тодорхойгүй Бурханы эзэлж буй орон зайг арилгадаг, ингэснээр тодорхойгүй Бурханы дүр хүний зүрх сэтгэлд байхаа больдог. Өөрийн бодит үг, бодит ажил, бүх газар нутаг даяарх Өөрийн шилжилт хөдөлгөөн, хүмүүсийн дунд хийдэг хосгүй бодитой, хэвийн ажлаар дамжуулан Тэрбээр Бурханы бодит байдлыг хүнд мэдүүлж, хүний зүрх сэтгэл дэх тодорхойгүй Бурханы байр суурийг арилгадаг. Нөгөө талаар, Бурхан хүнийг бүрэн төгс болгохын тулд Өөрийн махбодын хэлсэн үгийг ашиглаж, бүх зүйлийг гүйцэлдүүлдэг. Энэ бол эцсийн өдрүүдэд Бурханы биелүүлэх ажил юм.

Та нарын мэдэх ёстой зүйл бол:

1. Бурханы ажил ер бусын биш бөгөөд та нар энэ талаар үзэл өвөрлөх ёсгүй.
2. Бие махбодтой болсон Бурхан энэ удаа үндсэндээ ямар ажил хийхээр ирснийг та нар ойлгох ёстой.

Тэрээр өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, эсвэл ид шид үзүүлэхээр ирээгүй, мөн гэмшлийн сайн мэдээг түгээж, эсвэл хүнд золин аврал хайрлахаар ирээгүй. Яагаад гэвэл, Есүс энэ ажлыг аль хэдийн хийчихсэн бөгөөд Бурхан нэг ажлыг давтдаггүй. Өнөөдөр Бурхан Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийн бүх хэрэгжүүлэлтийг хаяхаар ирсэн. Жинхэнэ гэдгээ голчлон харуулахын тулд бодитой Бурхан ирсэн юм. Есүс ирэхдээ цөөхөн үг

хэлсэн; Тэрээр голдуу ид шид үзүүлж, тэмдэг гайхамшгуудыг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулсан, аль эсвэл хүмүүсийг үнэмшүүлж, үнэхээр Бурхан, сэтгэл хөдлөлгүй Бурхан мөн гэдгээ хүнд харуулахын тулд зөгнөл хэлсэн. Эцэст нь Тэр цовдлолын ажлыг гүйцэлдүүлсэн. Өнөөдрийн Бурхан тэмдэг, гайхамшгуудыг харуулдаггүй, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг ч хөөн зайлуулдаггүй. Есүсийг ирэх үед Түүний хийсэн ажил Бурханы нэг хэсгийг төлөөлсөн, харин энэ удаа Бурхан хийвэл зохих ажлын үе шатыг хийхийн тулд ирсэн, учир нь Бурхан нэг ажлыг дахин давтдаггүй; Тэр бол үргэлж шинэлэг байдаг, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан юм, иймээс өнөөдөр чи бодитой Бурханы үг болон ажлыг л хардаг билээ.

Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан голчлон үгээ хэлж, хүний аминд шаардлагатай бүхнийг тайлбарлаж, хүний орох ёстой зүйлийг заан үзүүлж, Бурханы үйл хэргийг хүнд харуулж, Бурханы мэргэн ухаан, бүхнийг чадагч, гайхалтай байдлыг хүнд харуулахын тулд ирсэн юм. Бурханы ярьдаг олон арга замаар дамжуулан хүн Бурханы эрхэм дээд, агуу байдал, мөн түүнчлэн Бурханы даруу, нууцлаг байдлыг хардаг. Бурхан эрхэм дээд боловч даруу, нууцлаг бөгөөд хамгийн өчүүхэн нь болж чадна гэдгийг хүн хардаг. Түүний үгийн зарим нь шууд Сүнсний өнцгөөс хэлэгддэг, зарим нь хүний өнцгөөс шууд хэлэгддэг ба зарим нь гуравдагч хүний өнцгөөс хэлэгддэг. Үүнээс, Бурханы ажилладаг байдал асар олон янз байдгийг харж болох ба Тэр үгээр дамжуулан хүнд үүнийг харуулдаг. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил хэвийн бөгөөд бодитой байдаг, тиймээс эцсийн өдрүүдийн бүлэг хүмүүст хамгийн том шалгалт тулгардаг. Бурханы хэвийн болон бодитой байдлаас үүдэн бүх хүн тийм шалгалтын дунд орсон; хүн Бурханы шалгалт руу унасан нь Бурханы хэвийн болон бодитой байдлаас болдог. Есүсийн эрин үед ямар ч үзэл, эсвэл шалгалт байгаагүй. Есүсийн хийсэн ихэнх ажил хүний үзэлтэй нийцэж байсан учраас хүмүүс Түүнийг дагасан ба Түүний талаар ямар ч үзэл өвөрлөөгүй. Өнөөдрийн шалгалт нь хүнд тулгарч байсан шалгалтуудаас хамгийн том нь бөгөөд энэ хүмүүс асар их гай зовлонгоос гарч ирсэн гэж хэлэх үед хэлээд буй гай зовлон нь энэ юм. Өнөөдөр, энэ хүмүүст итгэл, хайр, хатуужил, дуулгавартай байдлыг бий болгохын тулд Бурхан үгээ хэлдэг. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы хэлсэн үг нь хүний уг чанар, мөн чанарын дагуу, хүний зан авирын дагуу, өнөөдөр хүний орох ёстой зүйлийн дагуу байдаг. Түүний үг бодитойн сацуу хэвийн байдаг: Тэр маргаашийн тухай ярьдаггүй, өчигдрийг ч эргэж хардаггүй; Тэр өнөөдрийн орох, хэрэгжүүлэх,

ойлгох ёстой зүйлийн талаар л ярьдаг. Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй. Бурханы ажил хүний үзэлтэй нийцэшгүй байдаг; жишээлбэл, Хуучин Гэрээнд Мессиа ирнэ гэж зөгнөсөн боловч Есүс ирсэн нь энэ зөгнөлийн үр дүн байв. Энэ нь аль хэдийн тохиолдсон болохоор өөр Мессиа дахин ирэх нь буруу юм. Есүс аль хэдийн нэг удаа ирсэн ба энэ удаад Есүс дахин ирсэн бол буруу байх байв. Эрин үе болгонд нэг нэр байдаг, нэр болгон нь эрин үеийн шинж чанарыг агуулдаг. Хүний үзлээр бол Бурхан үргэлж тэмдэг, гайхамшиг үзүүлэх ёстой, үргэлж өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулах ёстой, үргэлж яг л Есүс шиг байх ёстой. Гэвч энэ удаа Бурхан ердөө ч тийм байдаггүй. Хэрвээ эцсийн өдрүүдэд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлсээр, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээсээр—яг Есүс шиг үйлдсэн бол нэг ажлаа давтаж байгаа хэрэг болж, Есүсийн ажил ямар ч ач холбогдол, үнэ цэнгүй байх байсан юм. Тиймээс Бурхан эрин үе бүрд ажлын нэг үе шатыг хэрэгжүүлдэг. Түүний ажлын үе шат бүрийг гүйцэлдмэгц муу ёрын сүнснүүд удалгүй дуурайдаг ба Сатан Бурханыг өсгий даран дагаж эхэлсний дараа Бурхан өөр арга барилд шилждэг. Бурхан ажлынхаа нэг үе шатыг биелүүлмэгц муу ёрын сүнснүүд үүнийг нь дуурайдаг. Та нар энэ талаар тодорхой ойлгох ёстой. Яагаад өнөөдрийн Бурханы ажил Есүсийн ажлаас өөр байдаг юм бэ? Яагаад өнөөдөр Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг зайлуулж, өвчтэйг эдгээдэггүй юм бэ? Хэрвээ Есүсийн ажил нь Хуулийн эрин үед явагдсан ажилтай адилхан байсан бол Нигүүлслийн эрин үеийн Бурханыг төлөөлж чадах байсан уу? Цовдлолын ажлыг гүйцэлдүүлж чадах байсан уу? Хэрвээ Хуулийн эрин үед байсантай адилаар Есүс сүмд орж, амралтын өдрийг сахисан бол хэн ч Түүнийг хавчихгүй байх байсан бөгөөд бүгд тойрон хүрээлэх байсан. Тэгсэн бол Тэр цовдлогдох байсан уу? Золин авралын ажлыг гүйцэлдүүлж чадах байсан уу? Хэрвээ эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан Есүстэй адилаар тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол ямар хэрэгтэй байх юм бэ? Бурхан эцсийн өдрүүдэд Өөрийн ажлын өөр нэг хэсгийг буюу удирдлагын төлөвлөгөөнийх нь нэг хэсгийг төлөөлөх зүйлийг хийсэн цагт л хүн Бурханы талаар илүү гүн гүнзгий мэдлэгтэй болж, тэр үед л Бурханы удирдлагын төлөвлөгөө биелж чадна.

Эцсийн өдрүүдэд Бурхан голчлон Өөрийн үгийг хэлэхийн тулд ирсэн. Тэрээр Сүнсний өнцгөөс, хүний өнцгөөс болон гуравдагч хүний өнцгөөс ярьдаг; Тэрээр хэсэг хугацаанд нэг арга зам ашиглан өөр өөр байдлаар ярьдаг ба хүний үзлийг өөрчилж, хүний зүрх сэтгэлээс тодорхойгүй Бурханы дүрийг арилгахын тулд үг хэлэх арга барилыг ашигладаг. Энэ бол Бурханы хийдэг үндсэн ажил юм. Бурхан өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, ид шид үзүүлж, эд материалын ерөөлийг хүнд хайрлахаар ирсэн гэж хүн итгэдэг учраас тийм зүйлсийг хүний үзлээс арилгахын тулд Бурхан ажлын энэ үе шатыг буюу гэсгээлт, шүүлтийн ажлыг хэрэгжүүлдэг, ингэснээр хүн Бурханы бодитой болон хэвийн байдлыг мэдэж, зүрх сэтгэлээс нь Есүсийн дүр арилж, Бурханы шинэ дүрээр солигдож болох юм. Хүний доторх Бурханы дүр хуучин болмогцоо шүтээн болдог. Есүс ирээд ажлын тухайн үе шатыг биелүүлэхдээ Бурханыг бүхэлд нь төлөөлөөгүй. Тэр зарим нэг тэмдэг, гайхамшиг үзүүлж, зарим үгийг хэлж, эцэст нь цовдлогдсон юм. Тэрээр Бурханы нэг хэсгийг төлөөлж байв. Бурхан юу болох бүхнийг Тэр төлөөлж чадаагүй, харин Бурханы ажлын нэг хэсгийг хийхдээ Бурханыг төлөөлсөн юм. Учир нь, Бурхан маш агуу, маш гайхалтай, ойлгошгүй бөгөөд эрин үе болгонд ажлынхаа нэг хэсгийг л хийдэг билээ. Энэ эрин үед Бурханы хийдэг ажил нь үндсэндээ хүний амийг үгээр хангах; хүний уг чанар, мөн чанар, завхарсан зан чанарыг илчлэх; шашны үзэл, бурангуй нийгмийн үзэл бодол, хоцрогдсон үзэл бодол, хүний мэдлэг, соёлыг таягдан хаях явдал. Эдгээр нь Бурханы үгээр илчлэгдэн цэвэрлэгдэх ёстой. Эцсийн өдрүүдэд хүнийг төгс болгохын тулд Бурхан тэмдэг гайхамшиг биш, харин үг ашигладаг. Тэрээр хүнийг ил болгож, шүүж, гэсгээж, төгс болгохын тулд Өөрийн үгийг ашигладаг, ингэснээр Бурханы үгээс хүн Бурханы мэргэн ухаан, хайр татам байдлыг харж, Бурханы зан чанарыг ойлгож авдаг, мөн Бурханы үгээр дамжуулан Бурханы үйл хэргийг хардаг. Хуулийн эрин үед Ехова Өөрийн үгээр Мосег Египетээс удирдан гаргасан ба израильчуудад зарим үгийг хэлсэн; тэр үед Бурханы үйл хэргийн нэг хэсэг нь ил тод болсон боловч хүний хэв чанар хязгаарлагдмал бөгөөд мэдлэгийг нь юу ч бүрэн дүүрэн болгож чадаагүй учраас Бурхан үргэлжлүүлэн үг хэлж, ажилласан юм. Нигүүлслийн эрин үед хүн Бурханы үйл хэргийн нэг хэсгийг дахин нэгэнтээ харсан. Есүс тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж чадсан ба цовдлогоод гурван өдрийн дараа амилж, хүний өмнө махбодоор харагдсан юм. Бурханы талаар хүн үүнээс илүү юу ч мэдээгүй. Бурханаас өөрт нь харуулсныг л хүн мэддэг ба хэрвээ Бурхан хүнд өөр юу ч харуулахгүй бол хүн тийм хэмжээнд л Бурханыг

хязгаарлана. Тиймээс Бурханы талаарх хүний мэдлэгийг гүнзгийрүүлэх гэсэндээ, Бурханы мөн чанарыг хүн аажмаар мэдэж аваг гэсэндээ Бурхан үргэлжлүүлэн ажилладаг. Эцсийн өдрүүдэд, хүнийг төгс болгохын тулд Бурхан Өөрийн үгийг ашигладаг. Чиний завхарсан зан чанар Бурханы үгээр илчлэгддэг бөгөөд шашны үзэл чинь Бурханы бодит байдлаар солигддог. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан үндсэндээ “Үг махбод болж, Үг махбодод ирж, Үг нь махбодоор илэрдэг” гэсэн үгийг биелүүлэхээр ирсэн бөгөөд хэрвээ чамд энэ тухай бүрэн гүйцэд мэдлэг байхгүй бол чи бат зогсож чадахгүй. Эцсийн өдрүүдэд Бурхан, Үг нь махбодоор илэрдэг ажлын үе шатыг гүйцэлдүүлэхийг үндсэндээ зорьдог бөгөөд энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Тиймээс та нарын мэдлэг тодорхой байх ёстой; Бурхан хэрхэн ажиллахаас үл хамааран, Өөрийг нь хязгаарлахыг Бурхан хүнд зөвшөөрдөггүй. Хэрвээ Бурхан эцсийн өдрүүдэд энэ ажлыг хийгээгүй бол Түүний талаарх хүний мэдлэг цааш ахиж чадахгүй. Бурхан цовдлогдож, Содомыг устгаж чадна, мөн Есүс үхлээс амилж, Петрт харагдаж чадна гэдгийг л чи мэдэх байсан... Гэхдээ чи Бурханы үг бүхнийг гүйцэлдүүлж, хүнийг байлдан дагуулж чадна гэж хэзээ ч хэлэхгүй. Бурханы үгийг туулснаар л чи тийм мэдлэгийн талаар ярьж чадна, Бурханы ажлыг туулах тусам Түүний талаарх мэдлэг чинь төдий чинээ бүрэн гүйцэд болно. Тэр үед л чи Бурханыг өөрийн үзэл дотор хязгаарлахаа болино. Хүн Бурханы ажлыг туулснаар л Түүнийг мэдэж авдаг; Бурханыг мэдэж авах өөр зөв арга зам гэж үгүй. Өнөөдөр олон хүн юу ч хийлгүй зүгээр л тэмдэг, гайхамшгууд болон агуу гамшгийн цаг үеийг харахаар хүлээдэг. Чи Бурханд итгэдэг үү, эсвэл агуу гамшигт итгэдэг үү? Агуу гамшиг ирэх үед хэтэрхий оройтсон байх бөгөөд хэрвээ Бурхан агуу гамшиг илгээхгүй бол Тэр тэгээд Бурхан биш гэж үү? Чи тэмдэг, гайхамшгуудад итгэдэг үү, эсвэл Бурханд Өөрт нь итгэдэг үү? Есүс бусдад дооглуулж байх үедээ тэмдэг, гайхамшиг үзүүлээгүй, гэхдээ Тэр Бурхан байсан бус уу? Чи тэмдэг, гайхамшгуудад итгэдэг үү, эсвэл Бурханы мөн чанарт итгэдэг үү? Бурханд итгэх итгэлийн талаарх хүний үзэл бодол буруу! Хуулийн эрин үед Ехова олон үг хэлсэн боловч өнөөдөр ч гэсэн тэдгээрийн зарим нь хараахан биелээгүй байгаа. Ехова бол Бурхан биш байсан гэж чи хэлж чадах уу?

Эцсийн өдрүүдэд Бурхан үндсэндээ “Үг махбод болдог” гэх баримтыг биелүүлдэг гэдгийг өнөөдөр та бүхэн тодорхой мэдэж байх ёстой. Газар дээрх бодит ажлаараа дамжуулан Тэрээр, Түүнийг мэдэж, Түүнтэй харилцаж, Түүний бодит үйл хэргийг харахад хүнийг хүргэдэг. Тэрээр тэмдэг, гайхамшиг үзүүлж чадна, бас тэгж чадахгүй үе ч Түүнд байдаг; энэ нь эрин үеэс хамаардаг гэдгийг

хүнд тодорхой ойлгуулдаг. Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадваргүй байдаг юм биш, харин хийгдэх ажлын дагуу, мөн эрин үеийн дагуу ажиллах арга замаа өөрчилдөг гэдгийг чи үүнээс харж болно. Ажлын одоогийн үе шатанд Тэр тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй; Тэрээр Есүсийн эрин үед зарим тэмдэг, гайхамшгийг үзүүлж байсан нь тухайн эрин үе дэх Түүний ажил өөр байснаас болсон юм. Бурхан өнөөдөр тэр ажлыг хийдэггүй ба зарим хүн Түүнийг тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадваргүй гэж итгэдэг, аль эсвэл тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй л бол Тэр Бурхан биш гэж боддог. Энэ нь төөрөгдөл биш гэж үү? Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлж чаддаг боловч өөр эрин үед ажиллаж байгаа тул тийм ажил хийдэггүй. Энэ нь өөр эрин үе учраас, мөн Бурханы ажлын өөр үе шат учраас Бурханы ил тод болгох үйл хэрэг нь ч бас өөр байдаг. Бурханд итгэх хүний итгэл бол тэмдэг, гайхамшигт итгэх итгэл биш, ид шидэд итгэх итгэл ч биш, харин шинэ эрин үе дэх Түүний бодит ажилд итгэх итгэл билээ. Бурханы ажилладаг байдлаар дамжуулан хүн Бурханыг мэдэж авдаг ба энэ мэдлэг нь Бурханд итгэх итгэлийг буюу Бурханы ажил болон үйл хэрэгт итгэх итгэлийг хүнд төрүүлдэг. Ажлын энэ үе шатанд Бурхан үндсэндээ үг хэлдэг. Тэмдэг, гайхамшгуудыг харна гэж бүү хүлээ; чи нэгийг ч харахгүй! Учир нь чи Нигүүлслийн эрин үед төрөөгүй. Хэрвээ тэр үед төрсөн бол чи тэмдэг, гайхамшгийг харах байсан, гэхдээ эцсийн өдрүүдэд төрсөн тул Бурханы бодит, хэвийн байдлыг л харж чадна. Эцсийн өдрүүдэд ер бусын Есүсийг харна гэж бүү хүлээ. Чи хэвийн хүнээс ямар ч ялгаагүй бие махбодтой болсон бодитой Бурханыг л харж чадна. Эрин үе болгонд Бурхан өөр өөр үйл хэргийг ил болгодог. Эрин үе бүрд Тэрээр Бурханы үйл хэргийн нэг хэсгийг ил болгодог ба эрин үе бүрийн ажил нь Бурханы зан чанарын нэг хэсгийг төлөөлж, Бурханы үйл хэргийн нэг хэсгийг төлөөлдөг. Түүний ил тод болгодог үйл хэрэг ажиллаж буй эрин үетэй нь хамт өөрчлөгддөг боловч тэдгээр нь бүгд Бурханы талаарх илүү гүнзгий мэдлэгийг, Бурханд итгэх илүү ул суурьтай, илүү жинхэнэ итгэлийг хүнд өгдөг. Бурханы бүх үйл хэргээс болж, мөн Бурхан маш гайхалтай, маш агуу, төгс хүчит, ойлгошгүй байдгаас болж хүн Бурханд итгэдэг. Бурхан тэмдэг, гайхамшгуудыг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж чаддаг учраас л Түүнд итгэдэг бол үзэл бодол чинь буруу байгаа бөгөөд зарим хүн чамд “Муу ёрын сүнснүүд ч бас тийм зүйл хийж чаддаг бус уу?” хэмээн хэлнэ. Энэ нь Бурханы дүрийг Сатаны дүртэй андуурсан хэрэг болох биш үү? Өнөөдөр, Бурханы олон үйл хэрэг болон хийдэг ажлынх нь асар их хэмжээ, үгээ хэлдэг олон арга замаас болж хүн Бурханд итгэдэг. Хүнийг байлдан дагуулж, төгс

болгохын тулд Бурхан Өөрийн айлдварыг ашигладаг. Тэр тэмдэг, гайхамшиг үзүүлж чаддагаас болж биш, харин олон үйл хэргээс нь болж хүн Бурханд итгэдэг; үйл хэргийг нь хардаг учраас л хүн Бурханыг мэдэж авдаг. Бурханы бодитой үйл хэрэг, Тэр хэрхэн ажилладаг, ямар ухаалаг арга барил хэрэглэдэг, хэрхэн үг хэлдэг, хүнийг хэрхэн төгс болгодгийг мэдсэнээр—зөвхөн эдгээр талыг мэдсэнээр л чи Бурханы бодит байдлыг ухамсарлаж, Түүний зан чанарыг ойлгож, Тэр юунд дуртай, юуг үзэн яддаг, хүн дээр хэрхэн ажилладгийг ойлгож чадна. Бурханы дуртай, дургүй зүйлсийг ойлгосноор чи эерэг, сөрөг зүйлсийг ялгаж чадах ба Бурханы талаарх мэдлэгээр дамжуулан аминд чинь ахиц дэвшил гардаг. Товчхондоо, чи Бурханы ажлын тухай мэдлэгийг олж авах ёстой бөгөөд Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлоо цэгцлэх ёстой.

БУРХАНЫ АЖИЛ ХҮНИЙ ТӨСӨӨЛДӨГ ШИГ ЭНГИЙН ҮҮ?

Бурханд итгэгчийн хувьд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг болон өнөөдөр чамд хийдэг Бурханы төлөвлөсөн ажлыг хүлээн авснаараа Бурханаас үнэхээр агуу өргөмжлөл, авралыг хүртсэн гэдгээ та нар хүн бүрчлэн ойлгох ёстой. Бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы бүх ажил зөвхөн энэ бүлэг хүмүүс дээр төвлөрсөн. Тэрээр та нарын төлөө бүхнээ золиосолсон; Тэрээр орчлон ертөнц даяарх Сүнсний бүх ажлыг буцаан авч, та нарт өгсөн. Тийм учраас та нар бол хувьтай хүмүүс. Түүнчлэн Тэрээр алдар суугаа Өөрийн сонгосон хүмүүс болох Израилиас та нар луу шилжүүлсэн, Өөрийн төлөвлөгөөний зорилгыг энэ бүлэг хүнээр дамжуулан бүрэн харуулна. Тиймээс та нар бол Бурханы өвийг хүлээн авах хүмүүс, бүр түүгээр ч барахгүй Бурханы алдрын өв залгамжлагчид билээ. Магадгүй та бүхэн эдгээр үгийг санаж байгаа байх: “Учир нь цаг зуурын хөнгөн зовлон маань бидэнд зориулан алдрын мөнхийн жинг үлэмж арвин болгодог.” Урьд нь та нар бүгд энэ үгийг сонссон атлаа хэн ч энэ үгийн жинхэнэ утгыг ойлгоогүй. Өнөөдөр тэдгээрийн бодит ач холбогдлыг та нар сайн мэднэ. Бурхан эцсийн өдрүүдэд эдгээр үгийг биелүүлнэ, эдгээр нь агуу улаан лууны цагариглан хэвтэж байдаг газар нутагт үүний харгисаар хяхан хавчсан хүмүүс дээр биелэх болно. Агуу улаан луу Бурханыг хавчдаг, Бурханы дайсан тул энэ газар нутагт Бурханд итгэдэг хүмүүс ийнхүү доромжлол, хавчлагад өртдөг бөгөөд эдгээр үг энэ бүлэг хүмүүс, та нарт биелдэг. Бурханыг эсэргүүцдэг газарт эхлүүлсэн учраас Бурханы бүх ажилд асар их саад тотгор учирч, Түүний олон

үгийг гүйцэлдүүлэхэд цаг хугацаа ордог; иймээс Бурханы үгийн улмаас хүмүүс цэвэршүүлэгддэг. Энэ нь бас зовлонгийн нэг хэсэг юм. Агуу улаан лууны газар нутагт Өөрийн ажлыг явуулах нь Бурханд асар хэцүү байдаг боловч ийм бэрхшээлээр дамжуулан Бурхан Өөрийн ажлын нэг үе шатыг хэрэгжүүлж, Өөрийн мэргэн ухаан, гайхалтай үйл хэргийг харуулдгийн дээр энэ бүлэг хүнийг бүрэн төгс болгохын тулд энэхүү боломжийг ашигладаг. Хүмүүсийн амссан зовлон, тэдний хэв чанар болон энэ бузар газар нутаг дахь хүмүүсийн бүх сатанлаг зан чанарын улмаас Бурхан ариусгалт, байлдан дагуулалтын ажлаа явуулдаг, ингэснээр Тэр үүнээс алдар сууг олж, Өөрийнх нь үйл хэргийг гэрчилдэг хүмүүсийг олж авч болох юм. Энэ бүлэг хүмүүсийн төлөө Бурханы гаргасан бүх золиосны утга учир бүхэлдээ ийм билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийг нь эсэргүүцдэг хүмүүсээр л дамжуулан байлдан дагуулах ажлыг хийдэг. Ингэж байж л Бурханы агуу хүч чадлыг харуулж чадна. Өөрөөр хэлбэл, бохир газар нутагт байгаа хүмүүс л Бурханы алдрыг өвлөн авбал зохих бөгөөд энэ л Бурханы агуу хүч чадлыг тодотгож чадна. Иймээс бохир заваан газар нутгаас, бохир заваан газар амьдардаг хүмүүсээс Бурханы алдрыг олж авдаг. Бурханы хүсэл ийм билээ. Есүсийн ажлын үе шат үүнтэй ижил байсан: Тэрээр Өөрийг нь хяхан хавчсан фарисайчуудын дунд л алдрыг олж авч чадах байсан. Фарисайчууд хяхан хавчиж, Иудас урваагүй бол Есүс цовдлуулах нь бүү хэл доог тохуу болж, гүжирдүүлэхгүй, ингэснээрээ алдрыг олж авч чадахгүй байх байсан. Бурхан эрин үе болгонд, махбодод ажлаа хийхдээ алдрыг олж авч, олж авахаар зорьсон хүмүүсээ олж авдаг. Энэ бол Бурханы ажлын төлөвлөгөө, Түүний удирдлага билээ.

Хэдэн мянган жилийн Бурханы төлөвлөгөөнд хоёр хэсэг ажлыг махбодоор хийдэг: Эхнийх нь цовдлогдох ажил, үүгээр Тэр алдрыг олж авдаг; нөгөө нь эцсийн өдрүүд дэх байлдан дагуулж, төгс болгох ажил, үүгээр Тэр алдрыг олж авдаг. Энэ бол Бурханы удирдлага юм. Тиймээс Бурханы ажил болоод Бурханы та нарт өгсөн даалгаврыг энгийн зүйл гэж бүү бод. Та нар бүгдээрээ Бурханы үлэмж арвин, мөнхийн алдрын өв залгамжлагчид бөгөөд үүнийг Бурхан онцгойлон зарлигдсан. Түүний алдрын хоёр хэсгээс нэг нь та нарт илэрдэг; Бурханы алдрын нэг хэсгийг бүхэлд нь та нарт хайрласан агаад энэ нь та нарын өв байж болох юм. Бурхан та нарыг ийнхүү өргөмжилдгийн дээр энэ нь бас аль эртнээс урьдаас шийдсэн Түүний төлөвлөгөө билээ. Агуу улаан луу байдаг нутагт Бурханы хийсэн ажлын агуу байдлыг харгалзан үзвэл, тийм ажлыг хэрвээ өөр хаа нэг газар хийсэн бол аль хэдийн асар их үр дүнд хүрч, хүн амархан

хүлээн зөвшөөрөх байсан. Бурханд итгэдэг Барууны санваартнуудын хувьд ийм ажлыг хүлээн зөвшөөрөх хэтэрхий амархан байх байсан, учир нь Есүсийн ажлын үе шат урьдын жишээ болдог. Ийм учраас өөр хаа нэгтээ байсан бол Бурхан алдар суу олж авах ажлын энэ үе шатанд хүрч чадахгүй; ажлыг хүмүүс дэмжиж, улс үндэстнүүд хүлээн зөвшөөрөх үед Бурханы алдар суу амжилттай болж чадахгүй. Энэхүү газар нутагт ажлын энэ үе шатыг хэрэгжүүлсний хосгүй ач холбогдол нь яг энэ юм. Та нарын дунд хуулиар хамгаалагддаг нэг ч хүн байхгүй; харин ч та нар хуулиар хориглуулдаг. Хүмүүс та нарыг ойлгодоггүй нь бүр ч илүү асуудалтай: Хамаатан садан, эцэг эх, найзууд, хамтран ажиллагсдын хэн нь ч та нарыг ойлгодоггүй. Бурхан та нарыг хаях үед газар дэлхий дээр үргэлжлүүлэн амьдрах ямар ч аргагүй болсон байлаа ч гэсэн хүмүүс Бурханыг орхиж явж тэвчдэггүй; энэ бол Бурхан хүмүүсийг байлдан дагуулахын ач холбогдол, мөн Бурханы алдар билээ. Өнөөдөр та нарын өвлөж авсан зүйл эрин үеүдийн туршид байсан элч, эш үзүүлэгч нарынхаас хавьгүй илүү, бүр Мосе, Петр хоёрынхоос ч үлэмж их юм. Ерөөлийг ганц, хоёрхон өдөрт хүртэж чадахгүй; асар ихийг золиосолж байж олж авах ёстой. Өөрөөр хэлбэл, цэвэршүүлэлтийг туулсан хайр, асар их итгэл, Бурхан та нараас хүрэхийг шаарддаг олон үнэн та нарт байх ёстой; дээр нь та нар бэргэж, зугталгүй шударга ёсыг сонгож, Бурханыг үхэх хүртлээ тууштай хайрлах ёстой. Та нар шийдэмгий байж, амь зан чанараа өөрчилж завхралаа арилгаж, Бурханы зохион байгуулалтыг бүгдийг нь ямар ч гомдолгүйгээр хүлээн зөвшөөрч, бүр үхэх хүртлээ дуулгавартай байх ёстой. Та нарын үүнд хүрэх учиртай. Энэ бол Бурханы ажлын эцсийн зорилт, мөн энэхүү бүлэг хүмүүсээс Бурханы шаарддаг зүйл билээ. Тэр та нарт өгдөг болохоор хариуд нь та нараас шаардах нь гарцаагүй, зүй ёсны шаардлага тавих нь дамжиггүй. Тиймээс Бурханы бүх ажилд учир шалтгаан байдаг бөгөөд өндөр стандарт, хатуу чанд шаардлага тогтоосон ажлыг Бурхан яагаад ахин дахин хийдгийг үүнээс харж болно. Ийм учраас та нар Бурханд итгэх итгэлээр дүүрэх учиртай. Товчхондоо Өөрийнх нь өвийг хүлээж авбал зохих хүмүүс болоосой гэсэндээ Бурхан бүх ажлаа та нарын төлөө хийдэг. Бурхан Өөрийн алдрын төлөө биш та нарын авралын төлөө, бохир газарт гүнээ зовж шаналсан энэ бүлэг хүмүүсийг төгс болгохын төлөө үүнийг хийдэг билээ. Та нар Бурханы хүслийг ойлгох ёстой. Иймээс ямар ч мэдлэг ухаан, эрүүл ухаан байхгүй харанхуй бүдүүлэг олон хүнд Бурханыг бүү турш, эсэргүүцэхээ боль гэж Би захидаг. Хүний хэзээ ч туулаагүй зовлонг Бурхан аль хэдийн туулж, аль хэдийнээ хүний оронд илүү их доромжлол

амссан. Өөр юуг та нар зүгээр орхиж чадахгүй вэ? Юу Бурханы хүслээс илүү чухал байж болох билээ? Юу Бурханы хайраас дээгүүр байж болох билээ? Энэхүү бохир газарт Өөрийн ажлыг хэрэгжүүлэх нь Бурханд хангалттай хэцүү байгаа; дээр нь нэмээд хүн мэдсээр байж санаатайгаар гэм бурууг үйлдвэл Бурханы ажил сунжрах ёстой болно. Товчоор хэлбэл энэ нь хэнд ч ашиггүй, хэнд ч тусгүй. Бурхан цаг хугацаанд баригддаггүй; Түүний ажил болоод алдар суу нэгдүгээрт байдаг. Тиймээс, хэчнээн удсан ч хамаагүй Өөрийн ажлын төлөө Тэр юугаа ч хайрлахгүй. Энэ бол Бурханы зан чанар: Ажлаа дуусгах хүртлээ Тэр санаа амрахгүй. Өөрийн алдрын хоёр дахь хэсгийг олж авсан цагт л ажил нь дуусна. Бурхан алдрыг олж авах ажлын хоёр дахь хэсгийг бүх орчлон ертөнцөд дуусгахгүй бол Түүний өдөр хэзээ ч ирэхгүй, Түүний гар сонгосон хүмүүсээ хэзээ ч орхихгүй, Түүний алдар Израильд хэзээ ч ирэхгүй, мөн төлөвлөгөө нь хэзээ ч гүйцэлдэхгүй. Та нар Бурханы хүслийг харж чаддаг, Бурханы ажил нь тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээхтэй адил энгийн биш гэдгийг харах ёстой. Яагаад гэвэл, өнөөдрийн ажил нь завхарсан, хөшүүн болсон хүмүүсийг дээд зэргээр өөрчилж, бүтээгдсэн мөртөө Сатанаар боловсруулагдсан хүмүүсийг ариусгах явдал юм. Энэ нь Адам, Еваг бүтээх биш, тэр ч байтугай гэрлийг бий болгох, ургамал, амьтан бүрийг бүтээх ч биш. Сатаны завхруулсан зүйлсийг Бурхан ариун болгосныхоо дараа шинээр олж авдаг; тэдгээр нь Түүнд харьяалагддаг зүйл, Түүний алдар болдог. Энэ бол хүний төсөөлдөг шиг биш, тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн шиг эсвэл Сатаныг ёроолгүй нүх рүү хараах ажил шиг энгийн биш. Харин ч энэ нь хүнийг өөрчилж, сөрөг зүйлийг эерэг болгож, Өөрт нь харьяалагддаггүй зүйлийг Өөрийн болгох ажил билээ. Энэ бол Бурханы ажлын энэ үе шатны цаадах үнэн юм. Та нар үүнийг ойлгож, асуудлыг хэт энгийн болгохоос зайлсхийх ёстой. Бурханы ажил ямар ч энгийн ажилтай адилгүй. Үүний гайхалтай байдал, мэргэн ухааныг хүн ухаарч ойлгохын аргагүй билээ. Ажлын энэ үе шатанд Бурхан бүх зүйлийг бүтээдэггүй боловч бас устгадаг ч үгүй. Харин ч, Тэр бүтээсэн бүх зүйлээ өөрчилж, Сатаны бузарласан бүх зүйлийг ариусгадаг. Тиймээс Бурхан асар их хэмжээний ажлыг эхлүүлсэн нь Түүний ажлын утга учир тэр чигээрээ юм. Эдгээр үгээс чи Бурханы ажил үнэхээр тийм энгийн гэдгийг харж байна уу?

ЧИ БУРХАНД ИТГЭДЭГ ТУЛ ҮНЭНИЙ ТӨЛӨӨ АМЬДРАХ УЧИРТАЙ

Бүх хүнд байдаг нийтлэг асуудал бол үнэнийг ойлгодог хэр нь хэрэгжүүлж чаддаггүйд оршино. Энэ нь нэг талаар тэд төлөөс төлөхийг хүсдэггүй, нөгөө талаар тэдний ялган таних чадвар хэтэрхий хангалтгүй учраас тэр юм; тэд өдөр тутмын амьдрал дээрх олон бэрхшээлийн мөн чанарыг харж чаддаггүй, хэрхэн зүй зохистойгоор хэрэгжүүлэхээ мэддэггүй. Хүн хэтэрхий туршлага нимгэн, ядмаг хэв чанартай, үнэний талаар хязгаарлагдмал ойлголттой байдаг болохоор өдөр тутмын амьдралд тулгарах бэрхшээлийг шийдвэрлэх аргагүй байдаг. Тэд аман дээрээ л Бурханд итгэдэг болохоос Бурханыг өдөр тутмын амьдралдаа оруулах чадваргүй байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан бол Бурхан, амьдрал бол амьдрал бөгөөд Бурхан хүний амьдралд ямар ч хамаагүй мэт байдаг. Бүх хүн ингэж боддог. Хүмүүс Бурханд ингэж итгэснээрээ бодит байдал дээр Бурханаар авхуулж, төгс болгуулахгүй. Үнэндээ, Бурханы үг дутуу илэрхийлэгдсэн хэрэг биш, харин үгийг нь хүлээн авах хүмүүсийн чадвар л хэтэрхий хангалтгүй байгаа юм. Бараг хэн ч Бурханы анхны санаа зорилгын дагуу үйлддэггүй гэж хэлж болно. Харин ч тэд өөрсдийн санаа зорилго, өмнө нь баримталж байсан шашны үзэл, юмыг хийх арга барилынхаа дагуу Бурханд итгэдэг. Тун цөөн хүн Бурханы үгийг хүлээн зөвшөөрснийхөө дараа өөрчлөгдөж, Бурханы хүслийн дагуу үйлдэж эхэлдэг. Харин тэд буруу итгэлээ хадгалсаар байдаг. Хүн Бурханд итгэж эхлэхдээ шашны хэвшмэл дүрэмд тулгуурлан итгэдгийн дээр амьдралын талаарх гүн ухаан дээрээ л үндэслэн аж төрж, бусадтай харилцдаг. Арван хүн тутмын ес нь иймэрхүү байдаг гэж хэлж болно. Тун цөөхөн хүн л Бурханд итгэж эхэлснийхээ дараа өөр төлөвлөгөө боловсруулж, шинэ амьдрал эхэлдэг. Хүн төрөлхтөн Бурханы үгийг үнэн гэж боддоггүй, үнэн гэж үзэж, хэрэгжүүлдэггүй.

Жишээлбэл Есүст итгэх итгэлийг аваад үзье. Хүн дөнгөж итгэж эхэлсэн ч бай, эсвэл удаан хугацаанд итгэсэн ч бай, бүгд ердөө л өөрт нь ямар “авьяас” байна түүнийгээ ашиглаж, ямар “ур чадвар” эзэмшсэн түүнийгээ харуулсан. Хүмүүс ердөө л “Бурханд итгэх итгэл” гэсэн гурван үгийг ердийн амьдралдаа нэмсэн болохоос зан чанартаа ямар ч өөрчлөлт гаргаагүй бөгөөд Бурханд итгэх итгэл нь өчүүхэн төдий ч өсөөгүй. Тэдний эрэл хайгуул үлбэгэр байв. Тэд итгэхээ болино гэж хэлээгүй боловч бас Бурханд бүхнээ зориулаагүй. Хэзээ ч Бурханыг үнэн голоосоо хайрлаж, дуулгавартай дагаж байгаагүй. Бурханд

итгэх итгэл нь үнэн худал хоёрын холимог, нэг нүдээ нээж, нөгөө нүдээ аньж хандсан бөгөөд итгэлээ хэрэгжүүлэхдээ үнэн сэтгэлээсээ хандаагүй. Тэд ийм төөрөлдсөн байдлаар үргэлжлүүлсээр эцэст нь самуурч үхсэн. Энэ бүхэн ямар учиртай вэ? Өнөөдөр чи бодитой Бурханд итгэхийн тулд зөв замд хөл тавих ёстой. Чи Бурханд итгэдэг бол зөвхөн ерөөл эрж хайх биш, харин Бурханыг хайрлаж, Бурханыг мэдэхээр эрж хайх ёстой. Чи Түүний гэгээрэл болоод өөрийнхөө эрлээр дамжуулан Түүний үгийг идэж, ууж, Бурханы талаар жинхэнэ ойлголттой болж, зүрх сэтгэлийнхээ гүнээс Бурханыг жинхэнээсээ хайрладаг болж чадна. Өөрөөр хэлбэл, Бурханыг гэсэн хайр чинь хэн ч сүйтгэж, саад болж чадахааргүй хамгийн жинхэнэ байх үед чи Бурханд итгэх зөв замаар явж байдаг. Чамайг Бурханд харьяалагддагийг энэ нь батална, учир нь зүрх сэтгэл чинь аль хэдийн Бурханы өмч болж өөр юу ч чамайг эрхшээлдээ оруулж чадахгүй. Өөрийн туршлага, төлсөн төлөөс болон Бурханы ажлын улмаас чи Бурханыг өөрийн эрхгүй хайрлаж чаддаг. Тэр үед чи Сатаны нөлөөнөөс ангижирч, Бурханы үгийн гэрэлд ирж амьдарна. Чи харанхуйн нөлөөнөөс ангижирсан үедээ л Бурханыг олж авсан гэж хэлж чадна. Бурханд итгэхдээ чи энэ зорилгыг эрж хайхыг хичээх ёстой. Энэ бол та нарын хүн нэг бүрийн үүрэг билээ. Та нараас хэн нь ч хэрэг явдлын одоогийн байгаа байдалд сэтгэл хангалуун байх ёсгүй. Та нар Бурханы ажилд хоёрдмол сэтгэлээр, хөнгөн хуумгай хандаж болохгүй. Та нар Бурханыг бүхий л талаар, цаг үргэлжид бодож, бүх зүйлийг Түүний төлөө хийх ёстой. Та нар ярих юм уу үйлдэх болгондоо Бурханы гэрийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Зөвхөн ингэснээр л Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадна.

Хүмүүсийн Бурханд итгэхдээ гаргадаг хамгийн том алдаа нь тэд аман дээрээ л итгэдэг бөгөөд өдөр тутмын амьдралд нь Бурхан огт байдаггүй. Бүх хүн Бурханы оршихуйд үнэхээр итгэдэг хэр нь Бурхан өдөр тутмын амьдралынх нь нэг хэсэг биш байдаг. Бурханд хандсан олон залбирал хүмүүсийн амнаас гардаг боловч зүрх сэтгэлд нь Бурхан маш бага зай эзэлдэг учраас Бурхан тэднийг ахин дахин шалгадаг. Хүн цэвэр ариун биш болохоор хүмүүсийг шалгахаас өөр сонголт Бурханд байдаггүй, ингэснээр шалгалтын дунд тэд ичгүүрийг мэдэрч, өөрсдийгөө мэдэж авч болох юм. Эс бөгөөс хүн төрөлхтөн тэргүүн тэнгэр элчийн үр удам болж, улам бүр завхардаг. Хүн бүр Бурханд итгэх явцдаа Бурханаар тасралтгүй цэвэрлэгддэг учраас хувийн олон сэдэл, зорилгоо хөсөр хаядаг. Эс бөгөөс, Бурхан хэнийг ч ашиглах аргагүй, хийх ёстой ажлаа хүнд хийх ямар ч аргагүй болно. Бурхан эхлээд хүмүүсийг цэвэрлэдэг. Ийнхүү цэвэрлэх явцад

хүмүүс өөрсдийгөө мэдэж авч, Бурхан тэднийг өөрчилж болох юм. Үүний дараа л Бурхан Өөрийн амийг тэдэн рүү оруулдаг бөгөөд ингэж байж л зүрх сэтгэл нь Бурхан руу бүрэн эргэж чадна. Тиймээс Бурханд итгэх нь хүмүүсийн хэлдэг шиг энгийн зүйл биш гэж Би хэлдэг. Бурханы харж байгаагаар чи зөвхөн мэдлэгтэй атлаа Түүний үгийг амиа болгоогүй бол; чи зөвхөн мэдлэгээр хязгаарлагдаад, үнэнийг хэрэгжүүлж, Бурханы үгийг амьдран харуулж чаддаггүй бол, энэ нь чамд одоог хүртэл Бурханыг хайрлах зүрх сэтгэл байхгүй гэдгийн баталгаа бөгөөд зүрх сэтгэл чинь Бурханд харьяалагддаггүй гэдгийг харуулдаг. Бурханд итгэснээрээ хүн Түүнийг мэдэж авч чадна: Энэ бол хүний эрж хайх учиртай эцсийн зорилго юм. Бурханы үгийг өөрийн биеэр хэрэгжүүлэхийн тулд чи тэдгээрийг амьдран харуулахад хүчин чармайлт гаргах ёстой. Хэрвээ чи зөвхөн хоосон сургаалын талаар мэддэг бол Бурханд итгээд ямар ч үр дүнгүй. Түүний үгийг бас хэрэгжүүлж, амьдран харуулж байгаа цагт л итгэл чинь бүрэн дүүрэн агаад Бурханы хүсэлд нийцэж байна гэж үзэх боломжтой. Энэ зам дээр их мэдлэгийн талаар олон хүн ярьж чадах хэдий ч үхэх цаг нь ирэхэд нүдэнд нь нулимс цийлгэнэн, нэг насны амьдралаа дэмий үрж, насан өндөр болтлоо хий дэмий амьдарсандаа өөрсдийгөө үзэн яддаг. Тэд сургаалыг л ойлгодог болохоос үнэнийг хэрэгжүүлж, Бурханд гэрчлэл хийж чаддаггүй; харин гагцхүү бүхий л амьдралаа хаа сайгүй гүйж, зөгий шиг завгүй өнгөрүүлдэг; үхлийн ирмэгт ирэхдээ л өөрт нь жинхэнэ гэрчлэл байхгүй, Бурханыг огт мэддэггүй гэдгээ олж хардаг. Тэр үед хэтэрхий хожимдсон байх бус уу? Яагаад чи өнөөдрийг ашиглан, өөрийн хайрладаг үнэнийг эрж хайж болохгүй гэж? Яагаад маргааш хүртэл хүлээх гэж? Амьдралдаа чи үнэний төлөө зовдоггүй, үүнийг олж авахаар эрж хайдаггүй бол үхэх мөчдөө харууслыг мэдэrmээр байгаа хэрэг үү? Хэрэв тийм бол яагаад Бурханд итгэнэ вэ? Үнэндээ, хүмүүс өчүүхэн төдий л чармайлт гаргавал үнэнийг хэрэгжүүлж, ингэснээрээ Бурханыг сэтгэл хангалуун болгож чадах олон хэрэг явдал бий. Хүмүүсийн зүрх сэтгэлийг чөтгөрүүд байнга эзэмддэг учраас л тэд Бурханы төлөө үйлдэж чадахгүй, махан биеийн төлөө байнга нааш цааш гүйсээр, эцэстээ юунд ч хүрдэггүй. Ийм учраас хүмүүс байнга төвөг, бэрхшээлд шаналж байдаг. Сатаны тамлалт энэ бус уу? Махан биеийн ялзрал энэ бус уу? Чи аман дээрээ дагасан болж Бурханыг хуурах гэж оролдох хэрэггүй. Харин бодитой үйлдэл хийх хэрэгтэй. Өөрийгөө бүү хуур; тэгэх ямар хэрэг байна? Махан биеийнхээ төлөө амьдарч, нэр алдар, ашиг хонжооны төлөө тэмцсэнээр чи юу олж авч чадах юм бэ?

ДОЛООН АЯНГЫН НҮРГЭЭН— ХААНЧЛАЛЫН САЙН МЭДЭЭ ЕРТӨНЦ ДАЯАР ТАРХАХЫГ ЗӨГНӨЖ БАЙНА

Би өөрийн ажлыг Харь үндэстнүүдийн дунд түгээж байна. Миний алдар суу ертөнц даяар гялалздаг; од-од-цэг-цэг хүмүүс бүгд Миний хүслийг дотроо тээж, бүгд Миний гараар залуурдуулж, Миний даалгасан даалгаврыг эхлүүлэхээр бэлддэг. Энэ мөчөөс эхлэн би шинэ эрин үе рүү орж, бүх хүнийг өөр ертөнцөд авчирлаа. Би “эх нутаг” руугаа буцахдаа анхны төлөвлөгөөнийхөө өөр нэгэн хэсгийг эхлүүлсэн, ингэснээр хүн Намайг илүү гүнзгий мэддэг болно. Би хорвоо ертөнцийг бүхэлд нь хардаг бөгөөд энэ цаг үеийг миний ажилд тохиромжтой гэж үзэж байна^а. Тиймээс Би хаа сайгүй яаравчлан, хүн дээр шинэ ажлаа гүйцэтгэж байна. Эцсийн эцэст энэ бол шинэ эрин үе бөгөөд Би илүү олон шинэ хүнийг шинэ эрин үе рүү оруулах, таягдах ёстой хүмүүсээсээ илүү олныг хөсөр хаяхын тулд шинэ ажлыг авчирлаа. Агуу улаан лууны улсад Би хүн төрөлхтний ойлгошгүй ажлын үе шатыг хэрэгжүүлсэн бөгөөд үүний улмаас хүн төрөлхтөн салхинд ганхаж, дараагаар нь олонх нь үлээх салхинд туугдан чимээгүй одсон. Чухамдаа, энэ бол Миний цэвэрлэх гэж буй “шигшүүрийн талбай”; энэ бол Миний хүсэж буй зүйл бөгөөд Миний төлөвлөгөө юм. Намайг ажлаа гүйцэтгэж байхад олон хорон санаатан шургалан орж ирсэн ч Би тэднийг хөөх гэж яарахгүй байна. Харин цаг нь болоход Би тэднийг тараан сарниулна. Түүний дараа л Би амийн ундарга болж, Намайг үнэхээр хайрладаг хүмүүст Надаас инжир модны үр жимс, сараана цэцгийн үнэрийг авах боломж олгоно. Сатан оршин суудаг, тоос шороотой газарт шижир алт үлдээгүй, элс л байдаг тул эдгээр нөхцөл байдалтай тулгараад Би ажлын ийм үе шатыг хийдэг. Миний эндээс олж авах зүйл бол элс биш шижир, тунгаамал алт гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Хорон санаатнууд Миний гэрт яахан үлдэж болох билээ? Миний диваажинд үнэг шимэгч болохыг Би яахан зөвшөөрөх билээ? Эднийг зайлуулахын тулд Би ашиглаж болох бүх аргыг ашиглана. Миний хүсэл илчлэгдэхээс өмнө хэн ч Миний юу хийх гэж буйг мэддэггүй. Энэ завшааныг ашиглан Би тэдгээр хорон санаатныг хөөж, тэд Миний дэргэдээс холдохоос өөр аргагүй болно. Хорон санаатнуудад Би ийм зүйл хийдэг ч Надад үйлчлэл хийх өдөр тэдэнд бас ирнэ. Хүмүүсийн адислал хүртэх хүсэл хэтэрхий хүчтэй байна;

а. Эх бичвэрт “гэж үзэж байна” гэх хэллэг байдаггүй.

тиймээс Би эргэн харж, Харь үндэстнүүдэд алдар суут төрхөө харуулах болно. Ингэснээр хүмүүс бүгд өөрсдийн ертөнцөд амьдарч, өөрсдийгөө шүүх хооронд Би хэлэх ёстой үгээ хэлж, хүмүүсийг хэрэгтэй зүйлээр нь хангасаар байна. Хүн төрөлхтөн ухаан ороход Би ажлаа аль эрт түгээчихсэн байх болно. Дараа нь Би хүмүүст хүслээ илэрхийлж, ажлынхаа хоёр дахь хэсгийг хүмүүс дээр эхлүүлж, ажилтай минь зохицохын тулд Намайг ойрхон дагахыг бүх хүнд зөвшөөрч, хийх ёстой ажлыг минь хамт хийлцэхийн тулд чадах бүхнээ хийх боломжийг хүнд олгоно.

Миний алдар сууг харна гэж хэн ч итгэдэггүй бөгөөд Би ч тэднийг албаддаггүй, харин хүн төрөлхтний дундаас алдар суугаа салган авч, өөр ертөнцөд аваачдаг. Харин хүмүүс дахин гэмшихэд Би алдар суугаа авч ирэн, итгэл үнэмшилтэй илүү олон хүнд үзүүлэх болно. Энэ бол Миний ажилладаг зарчим. Миний алдар суу Канааныг орхих цаг байдгийн адил Миний алдар суу сонгогдсон хүмүүсийг орхих үе бас бий. Цаашилбал Миний алдар суу бүх дэлхийг орхин, дэлхий ертөнц бүүдийж, харанхуй руу умбах цаг үе бий. Канааны нутаг хүртэл нарны гэрлийг харахгүй; бүх хүн итгэлээ алдах болно, гэхдээ Канаан нутгийн анхилам үнэрийг хэн ч орхиж түвдэхгүй. Шинэ тэнгэр газар руу орохдоо л Би алдар сууныхаа нөгөө хэсгийг авч ирэн, Канааны нутагт анхлан дэлгэж, улмаар шөнийн тас харанхуйд живсэн дэлхий даяар сүүмэлзэх гэрэл гаргана, ингэснээр бүх дэлхий гэрэлд гарна; газар дэлхийн өнцөг булан бүрд байгаа хүмүүс гэрлийн хүчнээс хүч чадал авахаар ирж, алдар сууг минь улам бүр нэмэгдүүлэн, улс орон бүрд шинээр гарч ирэх боломж олгоно; Намайг хүний ертөнцөд аль эрт ирж, алдар суугаа аль эрт Израилаас зүүн зүгт аваачсаныг бүх хүн төрөлхтөн ухаарна; учир нь Миний алдар суу Зүүн зүгээс гэрэлтдэг бөгөөд үүнийг Нигүүлслийн эрин үеэс энэ өдөрт авчирсан. Гэхдээ Израиль бол Миний орхиж гарсан нутаг бөгөөд тэндээс би зүүн зүгт ирсэн. Зүүн зүгийн гэрэл аажмаар цайрах үед л дэлхий даяарх харанхуй аажмаар гэгээрч эхлэх ба тэр үед л Намайг Израилиас олон жилийн өмнө яваад зүүн зүгт шинээр мандаж буйг хүн төрөлхтөн олж мэднэ. Нэгэн цагт Би Израильд бууж, дараа нь тэндээс явсан учир Израильд дахин төрж чадахгүй. Учир нь Миний ажил бүх орчлон ертөнцийг удирдан чиглүүлдэг бөгөөд үүнээс гадна аянга шууд зүүнээс Баруун зүгт цахидаг. Энэ шалтгааны улмаас Би зүүн зүгт бууж, Канааныг зүүн зүгийн хүмүүст авчирсан. Би хүмүүсийг дэлхийн өнцөг булан бүрээс Канааны нутагт авчирна, тиймээс бүх ертөнцийг удирдахын тулд Канааны нутагт айлдвараа айлдсаар байх болно. Одоо Канаанаас бусад бүх газарт гэрэл байхгүй бөгөөд

бүх хүн өлсгөлөн, хүйтний аюулд нэрвэгдээд байна. Би алдар суугаа Израильд өгч, дараа нь буцаан авсан, улмаар израильчуудыг болон бүх хүн төрөлхтнийг зүүн зүгт аваачсан. Би бүгдийг нь гэрэлд авчирсан, ингэснээр тэд дахин гэрэлтэй золгож, холбоотой болж, цаашид гэрлийг хайх шаардлагагүй болно. Гэрлийг хайж буй бүх хүнд гэрлийг дахин харуулж, Израильд байсан алдар суугаа Би харуулна; Би аль эрт хүн төрөлхтний дунд цагаан үүл хөлөглөн бууж ирснийг, тоолж баршгүй цагаан үүл, элбэг дэлбэг жимсийг багц багцаар нь тэдэнд харуулж, цаашлаад Израилийн Ехова Бурханыг харуулна. Би тэдэнд иудейчүүдийн Эзэн, удаан хүлээсэн Мессияг болон үеийн үед хаадад хавчигдан шахагдаж ирсэн Өөрийнхөө дүр төрхийг бүтнээр нь харуулна. Би орчлон ертөнц даяар ажиллаж, агуу ажил гүйцэтгэн, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд бүхий л алдар суу, үйлээ илчилнэ. Би олон жил Намайг хүлээж байсан хүмүүст, Намайг цагаан үүл хөлөглөн ирэхийг хүсэн хүлээсэн хүмүүст, дахин нэг удаа гарч ирэхийг минь хүсэн хүлээж байсан Израильд болон Намайг хавчин шахдаг бүхий л хүн төрөлхтөнд өөрийн алдар суут төрхөө бүрэн дүүрэн харуулна. Ингэснээр Би аль эрт алдар суугаа аваад, зүүн зүгт авчирсан, Миний алдар суу Иудейн нутагт байхаа больсон гэдгийг бүгд мэдэх болно. Учир нь эцсийн өдрүүд аль хэдийн ирсэн!

Орчлон даяар Би Өөрийн ажлыг хийж байна, зүүн зүгт аянга цахилгаан зогсолтгүй цахилж, бүхий л үндэстэн, урсгалыг доргиодог. Миний дуу хоолой бүх хүнийг өнөөдөр лүү хөтөлсөн. Би бүх хүнийг дуу хоолойгоороо байлдан дагуулж, энэ урсгалд оруулж, Өөрийнхөө өмнө дуулгавартай байлгадаг, учир нь Би аль эрт Өөрийн алдар сууг бүх дэлхийгээс эгүүлэн татаж, зүүн зүгт шинээр гаргасан. Миний алдар сууг харахыг хүсэн хүлээдэггүй хэн байна вэ? Намайг эргэн ирэхийг сэтгэл түгшин хүлээдэггүй хэн байна вэ? Миний дахин илрэлтээр цангахгүй хэн байна вэ? Миний хайр татам байдлыг санагалзахгүй хэн байна вэ? Гэрэл рүү гарч ирэхгүй байх хэн байна вэ? Канааны баян тансаг руу хараа бэлчээхгүй хэн байх вэ? Золин аврагч эргэн ирэхийг хүсэн хүлээхгүй хэн байх вэ? Агуу эрх мэдэлтэй Түүнийг эрхэмлэн хайрладаггүй хэн байна вэ? Миний дуу хоолой дэлхий даяар тархах болно; Би сонгосон хүмүүстэйгээ нүүр тулж, тэдэнд илүү олон үг хэлнэ. Уул, усыг доргиох хүчит аянга шиг бүх орчлон ертөнц, хүн төрөлхтөнд хандан Би үгээ хэлсэн. Тиймээс, Миний аман дахь үгс хүний эрдэнэ болж, хүмүүс бүгд Миний үгийг нандигнадаг. Аянга цахилгаан зүүнээс баруун зүг хүртэл цахилдаг. Миний үгс хүн татгалзахааргүй байхын зэрэгцээ ойлгохын аргагүй боловч тэгэх тусмаа баярлан хөөрмөөр байдаг. Бүх хүн дөнгөж төрсөн

нярай мэт Миний ирснийг тэмдэглэж, баяр хөөртэй байна. Дуу хоолойгоороо дамжуулан Би бүх хүнийг Өөрийнхөө өмнө авчрах болно. Түүнээс хойш Би албан ёсоор хүмүүсийн эгнээнд орох бөгөөд ингэснээр тэд Намайг шүтэн биширнэ. Цацруулж буй алдар суу, аман дахь үгээрээ Би бүх хүнийг өмнөө ирүүлэн, зүүн зүгээс аянга цахилж, зүүн зүгийн “Чидун жимсний уулан” дээр Өөрийгөө бууж ирснийг харуулна. Намайг иудейчүүдийн Хүүгийн хувьд биш, харин Зүүн зүгийн аянга болж газар дээр аль эртнээс байсныг тэд харах болно. Учир нь Би дахин амилж, хүн төрөлхтний дундаас холдон яваад удаж байгаа бөгөөд хүмүүсийн дунд алдар суутайгаар дахин гарч ирсэн. Би бол одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө шүтэгдэж байсан Тэр нэгэн, мөн Би одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө израильчуудын хаясан нярай билээ. Түүнээс гадна, Би энэ эрин үеийн хамгийн алдар суут Төгс Хүчит Бурхан билээ! Бүгд Миний сэнтийн өмнө ирж, Миний алдар суут төрхийг харж, дуу хоолойг минь сонсож, Миний үйлсийг харцгаа. Энэ бол Миний бүхий л хүсэл; Миний төлөвлөгөөний төгсгөл, оргил үе, мөн Миний удирдлагын зорилго: улс орон болгон Намайг шүтэн мөргөж, хэл болгон Намайг хүлээн зөвшөөрч, хүн бүр итгэлээ Надад өгч, бүх хүн Надад захирагдана!

БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАН БОЛОН БУРХАНЫ АШИГЛАДАГ ХҮМҮҮСИЙН ХООРОНДОХ ҮНДСЭН ЯЛГАА

Олон жилийн турш Бурханы Сүнс газар дээр ажиллангаа тасралтгүй хайсаар ирсэн бөгөөд эрин үеүдийн туршид Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан олон хүнийг ашиглажээ. Гэсэн ч энэ бүх хугацаанд Бурханы Сүнс тохиромжтой амрах газаргүй байсаар ирсэн учраас Бурхан ажлаа хийхийн тулд өөр өөр хүмүүсийн хооронд шилждэг. Ерөнхийдөө Түүний ажил хүмүүсээр дамжин хийгддэг. Өөрөөр хэлбэл, энэ бүх жилүүдэд Бурханы ажил хэзээ ч зогсоогүй, харин өнөөг хүртэл хүмүүсээр дамжин явагдсаар ирсэн юм. Бурхан маш олон үг хэлж, маш их ажил хийсэн хэдий ч Бурхан хүнд хэзээ ч харагдаж байгаагүй учраас, бас Түүнд бодит хэлбэр дүрс байдаггүй учраас хүн Бурханыг мөн л мэддэггүй. Иймээс Бурхан, бодитой Бурханы бодит ач холбогдлыг бүх хүнд мэдүүлэх энэхүү ажлыг гүйцэлдүүлэх ёстой. Энэ үр дүнд хүрэхийн тулд Бурхан Өөрийн Сүнснийг хүмүүст бодитоор илчилж, тэдний дунд ажлаа хийх ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс бие махбодын хэлбэртэй, мах цустай болж,

хүмүүсийн дунд харагдахуйцаар алхаж, амьдралд нь тэднийг дагалдаж, Өөрийгөө заримдаа харуулж, заримдаа нуун далдалж байх үед л хүмүүс Түүний талаар илүү гүнзгий ойлголттой болж чадна. Хэрвээ Бурхан зөвхөн махбодод үлдсэн бол Өөрийн ажлыг бүхэлд нь биелүүлж чадахгүй байх байв. Есүс хэсэг хугацаанд хэвийн хүн чанараар ажиллаж, гүйцэлдүүлэх хэрэгтэй байсан бүх ажлаа дуусгасны дараа явсантай яг адилаар Бурхан махбодод хэсэг хугацаанд ажиллаж, махбодоор хийх хэрэгтэй үйлчлэлийг гүйцэтгэснийхээ дараа махбодыг орхиж, махбодын дүрээр сүнсний ертөнцөд ажиллана. Та нар “Зам... (5)”-ын энэ хэсгийг санаж байгаа байх: “Эцэг минь Надад ‘Газар дэлхий дээр Эцэгийнхээ хүслийг биелүүлж, Түүний даалгаврыг биелүүлэхийг л хичээ. Өөр юу ч Чамд хамаагүй’ гэж хэлснийг Би санадаг.” Чи энэ хэсгээс юу харж байна вэ? Бурхан газар дээр ирэх үедээ Өөрийнхөө ажлыг л бурханлаг чанараар хийдэг бөгөөд энэ бол бие махбодтой болсон Бурханд тэнгэрлэг Сүнсний даалгасан зүйл юм. Ирэх үедээ Тэр гагцхүү газар нутаг даяар үгээ хэлж, Өөрийн айлдваруудыг өөр өөр аргаар, өөр өөр өнцгөөс айлддаг. Тэр үндсэндээ хүнийг хангаж, хүнд зааж сургах явдлыг Өөрийн зорилго, ажиллах зарчим гэж авч үздэг бөгөөд хүн хоорондын харилцаа юм уу хүмүүсийн амьдралын нарийн ширийнийг анхаардаггүй. Түүний гол үйлчлэл нь Сүнсний өмнөөс ярих явдал юм. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс махбодод бодитоор илрэх үедээ зөвхөн хүний амийг хангаж, үнэнийг гаргадаг. Тэр хүний ажилд хутгалддаггүй, өөрөөр хэлбэл, хүмүүсийн ажилд оролцдоггүй. Хүмүүс бурханлаг ажил хийж чаддаггүй, Бурхан хүний ажилд оролцдоггүй. Бурхан Өөрийн ажлыг хийхээр энэ газар дэлхийд ирснээсээ хойш энэ бүх хугацаанд үүнийгээ үргэлж хүмүүсээр дамжуулан хийсэн юм. Гэхдээ энэ хүмүүсийг бие махбодтой болсон Бурхан гэж үзэж болохгүй, Бурханы ашигладаг хүмүүс л гэж үзэж болно. Харин өнөөдрийн Бурхан шууд бурханлаг чанарын өнцгөөс үг хэлж, Сүнсний дуу хоолойг илэрхийлж, Сүнсний өмнөөс ажиллаж чадна. Эрин үеүдийн туршид Бурханы ашигласан бүх хүн нь мөн л Бурханы Сүнс махан бие дотор ажилласан тохиолдол мөн—тэгвэл яагаад тэднийг Бурхан гэж нэрлэж болдоггүй юм бэ? Гэхдээ, өнөөдрийн Бурхан ч бас Бурханы сүнс шууд махбодоор ажиллаж буй хэрэг бөгөөд Есүс ч гэсэн махбодоор ажилласан Бурханы Сүнс байсан; энэ хоёрыг хоёуланг нь Бурхан гэж нэрлэдэг. Тэгвэл ялгаа нь юу вэ? Эрин үеүдийн туршид Бурханы ашигласан хүмүүс бүгд хэвийн бодолтой, эрүүл ухаантай байж чадсан. Тэд бүгд биеэ авч явах зарчмыг ойлгосон байв. Тэдэнд хэвийн хүний үзэл санаа байсан бөгөөд хэвийн хүмүүст байх ёстой бүх зүйлийг эзэмшсэн

байлаа. Тэдний олонх нь ер бусын ур чадвартай, төрөлхийн ухаантай байсан юм. Энэ хүмүүс дээр ажиллахдаа Бурханы Сүнс, тэдэнд Бурханаас заяасан билиг авьяас болох ур чадварыг нь ашигладаг. Бурханы Сүнс тэдний ур чадварыг нь ажиллуулж, Бурханы төлөө үйлчлэхэд давуу талыг нь ашигладаг. Гэсэн ч Бурханы мөн чанар нь үзэл санаа, бодлоос ангид, хүний далд санаа холилдоогүй байдаг ба хэвийн хүмүүсийн эзэмшдэг зүйл ч дутмаг байдаг. Өөрөөр хэлбэл, хүний биеэ авч явах зарчмыг ч Тэр сайн мэддэггүй. Өнөөдрийн Бурхан газар дээр ирэх үедээ ийм л байдаг. Түүний ажил болон үгэнд хүний санаа зорилго юм уу хүний бодол холилдоогүй байдаг, харин тэдгээр нь Сүнсний санаа зорилгын шууд илрэл бөгөөд Тэрээр Бурханы өмнөөс шууд ажилладаг. Энэ нь, Сүнс шууд үг хэлдэг буюу хүний санаа зорилгыг өчүүхэн төдий ч холилгүйгээр бурханлаг чанар шууд ажил хийдэг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан бурханлаг чанарыг шууд агуулдаг, хүний бодол, үзэл санаанаас ангид байдаг бөгөөд хүний биеэ авч явах зарчмыг огт ойлгодоггүй. Хэрвээ зөвхөн бурханлаг чанар ажиллаж байсан бол (өөрөөр хэлбэл, зөвхөн Бурхан Өөрөө ажиллаж байсан бол) Бурханы ажлыг газар дээр гүйцэтгэх ямар ч аргагүй байх байлаа. Иймээс Бурханыг газар дээр ирэх үед, бурханлаг чанараар хийдэг ажлынхаа хамтаар хүн чанар дотор ажиллахдаа ашиглах цөөн тооны хүн Түүнд байх ёстой. Өөрөөр хэлбэл, бурханлаг чанарын ажлаа хадгалахын тулд Бурхан хүний ажлыг ашигладаг. Тэгэхгүй бол хүн бурханлаг ажилтай шууд холбогдох ямар ч аргагүй байх болно. Есүс болон Түүний шавь нарын хувьд ч ийм л байсан. Дэлхий дээр байх хугацаандаа Есүс хуучин хуулийг хүчингүй болгож, шинэ тушаалуудыг тогтоосон. Тэр бас олон үг хэлсэн юм. Энэ бүх ажил бурханлаг чанараар хийгджээ. Петр, Паул, Иохан гэх мэт бусад хүмүүс дараа нь Есүсийн үгэнд суурилан ажилласан билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан тухайн үед Өөрийн ажлыг эхлүүлж, Нигүүлслийн эрин үеийн эхлэлийг тавьсан буюу шинэ эрин үеийг авчран, хуучин эрин үеийг халсан бөгөөд бас “Бурхан бол Эхлэл ба Төгсгөл” хэмээх үгийг биелүүлсэн. Өөрөөр хэлбэл, хүн бурханлаг ажлын суурин дээр хүний ажлыг хийх ёстой. Есүс хэлэх хэрэгтэй бүхнээ хэлж, газар дээрх ажлаа дуусгамагцаа хүнийг орхиж одсон. Үүний дараа, ажиллаж байхдаа бүх хүн Түүний үгэнд илэрхийлэгдсэн зарчмын дагуу үйлдэж, Түүний хэлсэн үнэний дагуу хэрэгжүүлсэн юм. Энэ бүх хүн Есүсийн төлөө ажилласан. Хэрвээ Есүс ганцаараа ажил хийж байсан бол Тэр хэчнээн их үг хэлсэн ч бай, хүмүүс Түүний үгтэй холбогдох аргагүй байх байв, учир нь Тэр бурханлаг чанараар ажиллаж, бурханлаг чанарын үгийг л хэлж

чадах байсан ба хэвийн хүмүүс үгийг нь ойлгож чадах хэмжээнд аливааг тайлбарлаж чадахгүй байх байлаа. Иймээс Түүний ажилд нэмэр болохоор араас нь ирсэн элчүүд болон эш үзүүлэгчид Түүнд хэрэгтэй байсан юм. Бурханлаг чанарын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд махбод болсон биеийг ашиглан үг хэлж, ажиллаад, дараа нь Өөрийн ажилд нэмэр болгохоор Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг цөөн хэдэн, эсвэл арай олон хүнийг ашиглах нь бие махбодтой болсон Бурханы ажилладаг зарчим билээ. Өөрөөр хэлбэл, Бурханы сонгосон хүмүүсийг үнэний бодит байдалд оруулахын тулд Бурхан, хүмүүсийг хариулж, услах ажил хийлгэхээр Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийг ашигладаг.

Хэрвээ Бурхан махбодод ирэхдээ бурханлаг чанарын ажлыг л хийсэн ба зүрх сэтгэлийнх нь дагуу байдаг цөөн хэдэн хүн Түүнтэй хамтран ажиллаагүй бол хүн Бурханы хүслийг ойлгож, эсвэл Бурхантай харилцаж чадахгүй байх байв. Энэ ажлыг гүйцэлдүүлж, чуулгануудыг харж хандаж, хариулж, мөн хүний сэтгэхүй, уураг тархи төсөөлж чадах түвшинд хүрэхийн тулд Бурхан Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хэвийн хүмүүсийг ашиглах ёстой. Өөрөөр хэлбэл, Бурхан бурханлаг чанар дотор хийж байгаа ажлаа “орчуулахын” тулд Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг цөөн тооны хүмүүсийг ашигладаг, ингэснээр үүнийг тайлж—бурханлаг хэлийг хүний хэл болгон хөрвүүлж чадах бөгөөд хүмүүс үүнийг ухамсарлаж, ойлгож чадна. Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүс эцсийн эцэст тун цөөхөн байдаг ба хүний ухамсарлах чадвар сул байдаг учраас хэрвээ Бурхан ийнхүү хийгээгүй бол хэн ч Бурханы бурханлаг хэлийг ойлгож чадахгүй байх байлаа. Тийм учраас махбод болсон биеэр ажиллаж байх үедээ л Бурхан энэ аргыг сонгодог. Хүн Бурханы хэлийг ойлгодоггүй учраас хэрвээ зөвхөн бурханлаг ажил л байсан бол хүний хувьд Бурханыг мэдэж, Түүнтэй холбогдох ямар ч аргагүй байх байв. Гагцхүү Түүний үгийг ойлгомжтой болгодог, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийн дэмжлэгтэйгээр л хүн энэ хэлийг ойлгож чадна. Гэхдээ, хүн чанар дотор ажилладаг тийм хүмүүс л байсан бол тэр нь хүний хэвийн амьдралыг хадгалж л чадах байлаа; энэ нь хүний зан чанарыг өөрчилж чадахгүй байх байв. Тэгвэл Бурханы ажил шинэ эхлэлийн цэгтэй байж чадахгүй; нэгэн хэвийн хуучин зүйлс, нэгэн хэвийн улиг болсон үгс л байх байсан юм. Бие махбодтой байх хугацаандаа хэлэх хэрэгтэй бүхнийг хэлж, хийх хэрэгтэй бүхнийг хийдэг бие махбодтой болсон Бурханы тусламжтайгаар л, мөн дараа нь хүмүүс Түүний үгийн дагуу ажиллаж, туулснаар л хүмүүсийн амь зан чанар өөрчлөгдөж чадах ба тэгж байж л тэд цаг хугацааны

урсгалыг дагаж чадна. Бурханлаг чанар дотор ажилладаг Нэгэн нь Бурханыг төлөөлдөг, харин хүн чанар дотор ажилладаг хүмүүс Бурханаар ашиглагддаг. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан нь Бурханы ашигладаг хүмүүсээс мөн чанартаа өөр юм. Бие махбодтой болсон Бурхан бурханлаг чанарын ажлыг хийж чаддаг байхад Бурханы ашигладаг хүмүүс тэгж чаддаггүй. Эрин үе болгоны эхэнд, хүнийг шинэ эхлэл рүү аваачихын тулд Бурханы Сүнс биечлэн үг хэлж, шинэ эринийг эхлүүлдэг. Түүнийг үг хэлж дуусах үед, бурханлаг чанар доторх Бурханы ажил дууссан гэдгийг энэ нь илтгэдэг. Үүний дараа, амийн туршлага руу орохын тулд хүмүүс бүгд Бурханы ашигладаг хүмүүсийн удирдлагыг дагадаг. Тэрчлэн энэ нь бас Бурхан хүнийг шинэ эрин рүү аваачиж, хүмүүст шинэ эхлэлийн цэг өгдөг үе шат юм—энэ үед махбод дахь Бурханы ажил дуусдаг.

Бурхан хэвийн хүн чанараа төгс болгохын тулд газар дэлхий дээр ирдэггүй, хэвийн хүн чанарын ажлыг хийхийн тулд ч ирдэггүй. Гагцхүү хэвийн хүн чанараар бурханлаг ажил хийхийн тулд л ирдэг. Хэвийн хүн чанарын талаар Бурханы ярьдаг зүйл хүмүүсийн төсөөлдөгтэй адилгүй. Хүн “хэвийн хүн чанарыг” эхнэр, нөхөр, хөвгүүд, охидтой байх явдал гэж тодорхойлдог ба эдгээр нь тухайн хүн хэвийн хүн мөн гэдгийн нотолгоо юм; харин Бурхан ингэж үздэггүй. Тэрээр хэвийн хүн чанарыг, хэвийн хүний бодолтой, хэвийн хүний амьдралтай байж, хэвийн хүмүүсээс төрөх явдал гэж үздэг. Гэхдээ Түүний хэвийн байдал нь, хүн хэвийн байдлын талаар ярьдаг шиг эхнэр, нөхөр, үр хүүхэдтэй байхтай хамаагүй. Өөрөөр хэлбэл, Бурханы ярьдаг хэвийн хүн чанар нь, хүн чанаргүй, бараг сэтгэл хөдлөлгүй, хараажаар бие махбодын хэрэгцээгүй, яг л Есүстэй адил хэвийн хүний гадаад төрхтэй, хэвийн хүний дүртэй мөртөө мөн чанартаа хэвийн хүний эзэмших ёстой бүхнийг бүрэн эзэмшээгүй гэж хүний үздэг зүйл юм. Үүнээс, бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь хэвийн хүн чанарыг бүхэлд нь агуулдаггүй, харин хэвийн хүний амьдралын хэвшлийг хангах, хэвийн хүний эрүүл ухааныг хадгалахын тулд хүмүүст байх ёстой зүйлийн нэг хэсгийг л агуулдаг гэдгийг харж болно. Гэхдээ эдгээр зүйл нь, хэвийн хүн чанар гэж хүний үздэг зүйлтэй ямар ч хамаагүй байдаг. Тэдгээр нь бие махбодтой болсон Бурханд байх ёстой зүйл юм. Гэсэн ч, бие махбодтой болсон Бурхан эхнэртэй, хөвгүүд охидтой, гэр бүлтэй л байх юм бол хэвийн хүн чанартай гэж хэлж болно хэмээн зүтгэдэг хүмүүс бий; эдгээр зүйл байхгүй бол Тэр хэвийн хүн биш гэж тэд хэлдэг. Тэгвэл Би та нараас ингэж асууя: “Бурханд эхнэр байдаг уу? Бурханы хувьд нөхөртэй байх боломжтой юу? Бурхан хүүхдүүдтэй байж болох

уу?" Эдгээр нь төөрөгдөл биш гэж үү? Гэхдээ бие махбодтой болсон Бурхан хад чулууны хоорондох ан цаваас үсрэн гарах юм уу тэнгэрээс унаж ирж чадахгүй. Тэр гагцхүү хэвийн хүний гэр бүлд л төрж болно. Тийм учраас Түүнд эцэг эх, эгч дүүс байдаг. Эдгээр нь бие махбодтой болсон Бурханы хэвийн хүн чанарт байх ёстой зүйл юм. Есүсийн хувьд ч тийм байсан; Есүст эцэг эх, ах эгч дүүс байсан ба энэ бүхэн нь хэвийн байлаа. Гэвч хэрвээ Тэрээр эхнэр, хөвгүүд, охидтой байсан бол тэр нь бие махбодтой болсон Бурханд байх ёстой гэж Бурханы төлөвлөсөн хэвийн хүн чанар биш байх байлаа. Хэрвээ тийм байсан бол Тэр бурханлаг чанарын өмнөөс ажиллаж чадахгүй байх байв. Түүнд эхнэр, хүүхэд байгаагүй ч хэвийн гэр бүлд хэвийн хүмүүсээс төрсөн учраас л Тэрээр бурханлаг чанарын ажлыг хийж чадсан билээ. Үүнийг цааш тодруулбал, Бурханы хэвийн хүн гэж үздэг зүйл нь хэвийн гэр бүлд төрсөн хүн юм. Зөвхөн тийм хүн л бурханлаг ажил хийхэд тохирно. Нөгөө талаар, хэрвээ хүн эхнэр, хүүхэдтэй, эсвэл нөхөртэй байсан бол бурханлаг ажил хийж чадахгүй, учир нь тэр хүн хүмүүсийн шаарддаг хэвийн хүн чанарыг л эзэмших боловч Бурханы шаарддаг хэвийн хүн чанарыг эзэмшихгүй байх байв. Бурханы боддог зүйл болон хүмүүсийн ойлгодог зүйл ихэнхдээ асар их ялгаатай, шал өөр байдаг. Бурханы ажлын энэ үе шатанд хүмүүсийн үзэлтэй зөрчилддөг, хүмүүсийн үзлээс асар их зөрдөг зүйл олон бий. Бурханы ажлын энэ үе шат нь бүхэлдээ бурханлаг чанар шууд ажиллаж, хүн чанар дэмжих үүрэг гүйцэтгэхээс бүрддэг гэж хэлж болно. Учир нь Бурхан Өөрийн ажлыг хүний гараар хийлгэхийн оронд Өөрөө хийхээр газар дэлхий дээр ирдэг ба Өөрийн ажлыг хийхийн тулд Тэр Өөрөө бие махбодтой (бүрэн бус, хэвийн хүн) болдог. Тэрээр хүн төрөлхтөнд шинэ эрин үеийг харуулж, Өөрийн ажлын дараагийн алхмын талаар хүн төрөлхтөнд хэлэхийн тулд энэ бие махбодыг ашигладаг бөгөөд Өөрийнх нь үгэнд дүрсэлсэн замын дагуу хэрэгжүүлэхийг хүмүүсээс шаарддаг. Ийнхүү махбод дахь Бурханы ажил дуусдаг; Тэрээр хүн төрөлхтнөөс хагацаж, хэвийн хүн чанартай махбодод оршин байхаа болиод, харин ч Өөрийн ажлын өөр нэг хэсгийг явуулахын тулд хүнээс холдон явах гэж байна. Дараа нь, Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийг ашиглан Тэрээр энэ бүлэг хүмүүсийн дунд газар дээрх ажлаа үргэлжлүүлдэг боловч тэдний хүн чанараар ажилладаг.

Бурханд өөр хийх ажил маш их байдаг учраас бие махбодтой болсон Бурхан хүнтэй хамт үүрд байж чадахгүй. Тэр махбодоор хязгаарлагдаж болохгүй; хэдийгээр Тэр тус ажлыг махбодын дүрээр хийдэг ч хийх ёстой ажлаа хийхийн тулд махбодыг тайлан хаях хэрэгтэй болдог. Бурхан газар дээр ирэх үедээ

хэвийн хүний хүрэх учиртай хэлбэрт хүрэхээ хүлээж, дараа нь насан эцэслээд, хүн төрөлхтнийг орхидоггүй. Түүний махбод хэдэн настай байх нь хамаагүй, ажил нь дуусах үед Тэр хүнийг орхиж явдаг. Түүний хувьд нас гэх зүйл байдаггүй, Тэр хүний амьдралын хугацааны дагуу Өөрийн өдөр хоногийг тоолдоггүй; оронд нь Өөрийн ажлын алхмуудад нийцүүлэн махбод дахь амиа төгсгөдөг. Бурхан махбодод ирээд тодорхой үе шат хүртэл өсөж, насанд хүрч, хөгшрөөд, тэрхүү бие махбод нь насан эцэслэх үед л явах ёстой гэж боддог хүмүүс байж магадгүй. Энэ бол хүний төсөөлөл; Бурхан тэгж ажилладаггүй. Тэрээр хийх ёстой ажлаа хийхийн тулд л махбодод ирдэг бөгөөд хэвийн хүний бүх үйл ажиллагаа буюу эцэг эхээс төрж, өсөж, гэр бүл зохиож, ажил мэргэжилтэй болж, үр хүүхэд төрүүлж өсгөж, эсвэл амьдралын сайн мууг туулан хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд ирдэггүй. Бурхан газар дээр ирэх үед Бурханы Сүнс махбод өмсөж, махбодод ирж буй хэрэг боловч Бурхан хэвийн хүний амьдралаар амьдардаггүй. Тэрээр удирдлагын төлөвлөгөөнийхөө нэг хэсгийг биелүүлэхийн тулд л ирдэг. Үүний дараа Тэр хүн төрөлхтнийг орхин явна. Махбодод ирэх үедээ Бурханы Сүнс бие махбодын хэвийн хүн чанарыг төгс болгодоггүй. Харин ч Бурханы урьдчилан тодорхойлсон цагт бурханлаг чанар шууд ажилладаг. Тэгээд Өөрийн хийх хэрэгтэй бүхнийг хийж, Өөрийн үйлчлэлийг бүрэн биелүүлсний дараа энэ үе шатан дахь Бурханы Сүнсний ажил дуусдаг, энэ мөчид бие махбодынх нь амьдрах хугацаа дууссан эсэхээс үл хамааран бие махбодтой болсон Бурханы амь ч бас төгсдөг. Өөрөөр хэлбэл, бие махбод амьдралын ямар үе шатанд хүрэх нь, газар дээр хэр урт наслах нь бүгд Сүнсний ажлаар шийдэгддэг. Энэ нь хүний хэвийн хүн чанар гэж үздэг зүйлтэй ямар ч хамаагүй. Есүсийг жишээ болгон авч үзье. Тэрээр махбодод гучин гурван жил хагас амьдарсан. Хүний биеийн амьдралын хугацааны хувьд бол Тэр уг насандаа үхэх ёсгүй байсан ба явах ёсгүй байсан юм. Гэхдээ үүнийг Бурханы Сүнс огт анхаараагүй. Түүний ажил дууссан, тэр мөчид биеийг нь авч одож, бие нь Сүнстэй хамт алга болсон. Энэ нь Бурханы махбодод ажилладаг зарчим юм. Иймээс нарийн яривал, бие махбодтой болсон Бурханы хүн чанар гол чухал биш. Дахин хэлэхэд, Тэрээр хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд газар дээр ирдэггүй. Тэр эхлээд хэвийн хүний амьдралыг бүтээгээд дараа нь ажиллаж эхэлдэггүй. Харин ч хэвийн хүний гэр бүлд төрсөн л бол Тэрээр бурханлаг ажил буюу хүний санаа зорилго холилдоогүй, махан биеийн бус, мөн мэдээж нийгмийн арга замуудыг хэрэглэдэггүй, хүний бодол, үзлийг агуулдаггүй, түүнчлэн хүний амьдралын гүн ухаантай хамаагүй ажлыг хийж

чадна. Энэ нь бие махбодтой болсон Бурханы хийхээр зорьдог ажил бөгөөд энэ нь бас Бурхан бие махбодтой болохын бодит ач холбогдол юм. Бурхан бусад ялихгүй үйл явцыг туулалгүйгээр үндсэндээ махбодоор хийх хэрэгтэй ажлын үе шатыг хийхийн тулд махбодод ирдэг бөгөөд Түүнд хэвийн хүний туршлага байдаггүй. Бурханы махбод болсон биеийн хийх хэрэгтэй ажил нь хэвийн хүний туршлагыг агуулдаггүй. Иймээс Бурхан махбодоор биелүүлэх хэрэгтэй ажлаа гүйцэлдүүлэхийн төлөө л махбодод ирдэг. Үлдсэн нь Түүнтэй ямар ч хамаагүй. Тэр маш олон ялихгүй үйл явцыг туулдаггүй. Түүний ажил дуусмагц бие махбодтой болохын ач холбогдол нь ч бас төгсдөг. Энэ үе шатыг дуусгах гэдэг нь махбодоор хийх хэрэгтэй Түүний ажил гүйцэлдсэн, Түүний махбодын үйлчлэл гүйцсэн гэсэн үг юм. Гэхдээ Тэр махбодод хязгааргүй хугацаагаар ажиллаад байж болохгүй. Тэр ажиллахын тулд өөр газар луу буюу махбодын гадна орших газар луу шилжих ёстой. Ийм маягаар л Түүний ажил бүрэн биелж, илүү их үр нөлөө үзүүлж чадна. Бурхан Өөрийн анхдагч төлөвлөгөөний дагуу ажилладаг. Ямар ажил хийх хэрэгтэйг болон ямар ажил гүйцэлдүүлснээ Тэр гарын арван хуруу шигээ тодорхой мэддэг. Бурхан Өөрийн аль хэдийн урьдчилан тодорхойлсон замаар алхахад нь хүн нэг бүрийг хөтөлдөг. Хэн ч үүнээс зугтаж чадахгүй. Бурханы Сүнсний удирдамжийг дагадаг хүмүүс л амралтад орж чадна. Магадгүй хожмын ажилд хүнийг залж чиглүүлэхийн тулд Бурхан махбодоор ярихгүй, харин биет хэлбэртэй Сүнс хүний амьдралыг залж чиглүүлнэ. Тэр үед л хүн Бурханд бодитоор хүрч, Бурханыг харж чадах ба бодитой Бурханаар төгс болгуулахын тулд Бурханы шаарддаг бодит байдалд илүү сайн орж чадна. Энэ нь Бурханы биелүүлэхээр зорьж буй ажил, Түүний аль эртнээс төлөвлөсөн зүйл юм. Үүнээс та бүхэн өөрсдийн явах ёстой замыг харах ёстой!

БУРХАНД ИТГЭХДЭЭ ШАШНЫ ЗАН ҮЙЛД БИШ БОДИТ БАЙДАЛД АНХААРЛАА ХАНДУУЛАХ ЁСТОЙ

Чи шашны хэдэн зан үйл мөрддөг вэ? Чи хэдэн удаа Бурханы үгийн эсрэг тэрсэлж, өөрийнхөөрөө хийж байсан бэ? Бурханы ачаанд үнэхээр анхаарал хандуулж, Түүний хүслийг биелүүлэхийг эрэлхийлдгээсээ болоод чи хэдэн удаа Бурханы үгийг хэрэгжүүлж байсан бэ? Чи Бурханы үгийг ойлгож, хэрэгжүүлэх ёстой. Өөрийн бүх үйлдэл, үйл хэрэгт зарчимтай бай, гэхдээ энэ нь дүрэмд баригдах юм уу зөвхөн нүд хуурахын тулд арай ядан хийх явдал биш; харин

Бурханы үгээр амьдарч, үнэнийг хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Ийм хэрэгжүүлэлт л Бурханыг хангалуун байлгадаг. Бурханы таалалд нийцэх аливаа үйл ажиллагаа нь дүрэм биш, харин үнэний хэрэгжүүлэлт билээ. Зарим хүн олны анхаарлыг өөртөө татах дуртай байдаг. Ах эгч нарынхаа дэргэд Бурханд өртэй гэж ярьдаг ч ар хударгаар нь үнэнийг хэрэгжүүлэлгүй, шал эсрэгээр нь хийдэг. Тэд шашны фарисайчууд биш гэж үү? Бурханыг үнэн голоосоо хайрладаг, үнэнтэй хүн нь Бурханд үнэнч нэгэн боловч үүнийгээ ил гаргадаггүй. Асуудал үүсэхэд тэрээр үнэнийг хэрэгжүүлэхэд бэлэн байдаг ба мөс чанарынхаа эсрэг үг, үйлдэл хийдэггүй. Орчин нөхцөл ямар ч байсан хамаагүй, асуудал үүсэх үед тэрээр мэргэн ухаанаа харуулдаг, үйл хэрэгтээ зарчимтай байдаг. Ийм хүн л жинхэнээсээ үйлчилдэг нэгэн юм. Бурханд өртэй тухайгаа үргэлж дүр эсгэдэг хүмүүс байдаг; тэд өдөржин санаа зовнисон байдлаар хөмсгөө зангидаж, дүр эсгэн, өрөвдөлтэй царайлж өдөр хоногоо өнгөрүүлдэг. Хэчнээн жигшүүртэй гээч! “Бурханд ямар өртэй тухайгаа надад хэлж болох уу?” гэж асуувал тэд хэлэх үггүй болно. Хэрвээ чи Бурханд үнэнч бол гаднаа энэ талаар бүү ярь; харин бодит хэрэгжүүлэлтээр Бурханыг гэх хайраа харуулж, чин үнэнч сэтгэлээр Түүнд залбир. Бурхантай үг хэлээрээ, хааш яаш л харьцдаг хүмүүс бол бүгд хоёр нүүртнүүд! Зарим нь залбирах болгондоо Бурханд өртэйгөө ярьж, Ариун Сүнс хөдөлгөөгүй байхад хүртэл залбирах бүрдээ мэгшин уйлж эхэлдэг. Ийм хүмүүс шашны зан үйл болон үзэлтэй байдаг; тэд ийм зан үйл, үзлээр амьдран, ийм үйлдлийг Бурхан таалдаг, бас өнгөц сүсэг бишрэл, гунигт нулимс бол Бурхан таашаадаг зүйл гэдэгт үргэлж итгэдэг. Ийм хөгийн хүмүүсээс ямар сайн юм гарах билээ? Зарим нь даруу байдлаа харуулахын тулд бусдын дэргэд ярих үедээ журамтай дүр үзүүлдэг. Зарим нь бусдын өмнө ямар ч хүч чадалгүй хурга адил зориуд зусарддаг. Хаанчлалын ардуудад тохирох төрх байдал энэ мөн үү? Хаанчлалын ардууд цог золбоотой агаад эрх чөлөөтэй, гэм зэмгүй агаад нээлттэй, үнэнч агаад хайр татам байж, эрх чөлөөтэй амьдардаг байх ёстой. Тэд жудагтай, нэр төртэй, хаашаа ч явсан гэрчлэлд зогсож чаддаг байх ёстой; тийм хүмүүсийг Бурхан болон хүмүүсийн аль аль нь хайрладаг. Шинээр итгэж байгаа хүмүүс гадаад талын хэт олон хэрэгжүүлэлттэй байдаг; тэд эхлээд харьцалт, эвдэлтийн үеийг туулах ёстой. Зүрх сэтгэлдээ Бурханд итгэдэг хүмүүс гаднаа бусдаас ялгардаггүй, гэвч үйлдэл болон үйл хэрэг нь бусдад магтууштай байдаг. Ийм хүмүүсийг л Бурханы үгийг амьдран харуулж байна гэж үзэж болно. Хэрвээ чи өдөр болгон энэ, тэр хүнд сайн мэдээ номлож, тэднийг аврал руу аваачдаг ч эцсийн эцэст

дүрэм, сургаал дотор амьдарч байгаа бол Бурханд алдрыг авчирч чадахгүй. Ийм хүмүүс бол шашны хүмүүс, бас хоёр нүүртнүүд юм.

Шашны хүмүүс цугларах болгондоо “Эгч минь, ойрд та ямаршуухан байв даа?” гэж асуудаг. Эгч хариуд нь, “Би Бурханд өртэй, бас Түүний хүслийг биелүүлж чадахгүй байгаа юм шиг санагддаг” гэдэг. Өөр нэг нь “Би ч гэсэн Бурханд өртэй, бас Түүнийг хангалуун байлгаж чаддаггүй” гэж хэлдэг. Энэ цөөн хэдэн үг, өгүүлбэр л дангаараа тэдний зүрх сэтгэлийн гүн дэх бузар булай зүйлсийг илэрхийлдэг; ийм үг хамгийн жигшүүртэй, дэндүү ой гутам байдаг. Ийм хүмүүсийн уг чанар Бурханыг эсэргүүцдэг. Бодит байдалд анхаарлаа хандуулдаг хүмүүс зүрх сэтгэл доторх бүхнээ ярилцаж, нөхөрлөлдөө яриандаа өөрсдийн зүрх сэтгэлийг уудалж байдаг. Үүнд ганц ч худал ааль аяг, ёсорхуу байдал, хоосон нялуун үг гэж байхгүй. Тэд үргэлж шулуун шударга байж, ертөнцийн дүрэм журамд захирагддаггүй. Ямар ч мэдрэмжгүй ч гэлээ, гаднаа гаргаж үзүүлэх дуртай хүмүүс байдаг. Өөр хэн нэгнийг дуулах үед тэд саван дахь будаа нь аль хэдийн түлэгдсэнийг ч анзааралгүй бүжиглэж эхэлдэг. Ийм хүмүүс нь үнэн сүсэгт, хүндлүүштэй бус, хэтэрхий хөнгөмсөг байдаг. Энэ бүх зүйл бол бодит байдлаас тасарсны илрэл юм. Зарим хүн сүнслэг амийн хэрэг явдлын талаар ярилцах үедээ хэдий Бурханд өртэйгөө ярьдаггүй ч зүрх сэтгэл дотроо Түүнийг гэсэн жинхэнэ хайрыг тээж байдаг. Бурханд өртэй чинь бусадтай ямар ч хамаагүй; чи хүнд биш, Бурханд өртэй. Тэгэхээр энэ тухай бусдад байнга ярих ямар хэрэгтэй юм бэ? Чи гаднах чармайлт, илэрхийлэлд биш, харин бодит байдалд ороход анхаарлаа хандуулах ёстой.

Хүмүүсийн өнгөц сайн үйл хэрэг юуг төлөөлдөг вэ? Тэдгээр нь махан биеийг төлөөлдөг ба хамгийн сайн гадаад талын хэрэгжүүлэлт ч амийг бус, харин хувийн зан чанарыг чинь л төлөөлдөг. Хүний гадаад талын хэрэгжүүлэлт Бурханы хүслийг биелүүлж чадахгүй. Чи байнга Бурханд өртэй тухайгаа ярьдаг ч бусдын амийг хангаж, Бурханыг хайрлахад бусдыг өдөөж чаддаггүй. Чиний ийм үйлдлүүд Бурханыг сэтгэл хангалуун байлгана гэж чи итгэж байна уу? Энэ нь Бурханы хүсэл, энэ нь сүнснийх гэж чи боддог боловч үнэн хэрэгтээ энэ чинь утгагүй зүйл! Чиний таашаадаг, хүсдэг зүйл бол Бурханыг баясгадаг зүйл гэж чи үздэг. Чиний таашаадаг зүйл Бурханыг төлөөлж чадах уу? Хүний зан авир Бурханыг төлөөлж чадах уу? Чиний таашаадаг зүйл бол яг Бурханы үзэн яддаг зүйл бөгөөд чиний зуршлууд бол Бурханы жигшин голдог зүйл юм. Хэрвээ чамд өртэй санагдвал Бурханы өмнө очиж залбир. Энэ талаар бусдад ярих ямар ч хэрэггүй. Хэрвээ чи Бурханы өмнө залбиралгүй, оронд нь бусдын анхаарлыг

байнга өөртөө татдаг бол энэ чинь Бурханы хүслийг биелүүлж чадах уу? Хэрвээ чиний үйлдэл үргэлж нүд хуурахаас цаашгүй байдаг бол чи дээд зэргийн нэрэлхүү гэсэн үг. Өнгөц сайн үйл л хийдэг, бодит байдалгүй хүмүүс ямар байдалтай хүмүүс вэ? Ийм хүмүүс бол зүгээр л хоёр нүүртэй фарисайчууд, шашны хүмүүс юм! Хэрвээ та нар гадаад талын хэрэгжүүлэлтийг хойш тавьж, өөрчлөлт хийж чадахгүй бол та нарт байгаа хоёр нүүртэй зангийн элементүүд улам ихэснэ. Хоёр нүүртэй зангийн элементүүд хэдий чинээ ихэснэ, Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл төдий чинээ их байдаг. Эцэст нь ийм хүмүүс гарцаагүй таягдан хаягдана!

БУРХАНЫ ӨНӨӨДРИЙН АЖЛЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л БУРХАНД ҮЙЛЧИЛЖ БОЛНО

Бурханд гэрчлэл хийж, агуу улаан лууг шившиглэхийн тулд хүн зарчимтай байх ёстой, мөн нэг нөхцөлийг хангаж байх ёстой: Хүн зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлаж, Түүний үг рүү орох ёстой. Хэрвээ чи Бурханы үг рүү орохгүй бол Сатаныг шившиглэх ямар ч аргагүй байх болно. Амь чинь өссөнөөр чи агуу улаан лууг орхиж, түүнд туйлын их доромжлол авчирдаг; энэ нь л агуу улаан лууг үнэхээр шившиглэж байгаа хэрэг юм. Чи Бурханы үгийг хэрэгжүүлэхийг хэдий чинээ их хүснэ, Бурханыг гэх хайр, агуу улаан лууг гэх үзэн ядалт чинь төдий чинээ нотлогддог; чи Бурханы үгэнд дуулгавартай байх тусам, үнэнийг хүсэн эрмэлздэг чинь төдий чинээ батлагддаг. Бурханы үгийг хүсэн эрмэлздэггүй хүмүүс бол амьгүй хүмүүс юм. Тийм хүмүүс бол Бурханы үгийн гаднах, шашинд харьяалагддаг хүмүүс билээ. Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс Бурханы үгийг идэж, ууснаар дамжуулан үгийнх нь талаар илүү гүн гүнзгий мэдлэгтэй байдаг. Хэрвээ чи Бурханы үгийг хүсэн эрмэлздэггүй бол Бурханы үгийг жинхэнээсээ идэж, ууж чадахгүй бөгөөд Бурханы үгийн талаар ямар ч мэдлэггүй бол Бурханыг гэрчилж, сэтгэлийг нь хангалуун болгох ямар ч аргагүй байна.

Бурханд итгэхдээ хүн Бурханыг хэрхэн мэдэх ёстой вэ? Хүн гажуудал, төөрөгдөлгүйгээр өнөөдрийн Бурханы үг, ажилд үндэслэн Бурханыг мэдэж авах ёстой ба юун түрүүнд Бурханы ажлыг мэдэх ёстой. Энэ бол Бурханыг мэдэх суурь юм. Бурханы үгийг хольцгүйгээр ойлгодоггүй тэр бүх олон янзын гажууд онол бол шашны үзэл юм; тэдгээр нь гажууд, эндүү ташаа ойлголт билээ. Шашны хүмүүсийн хамгийн агуу ур чадвар бол урьд нь ойлгосон Бурханы үгийг авч, өнөөдрийн Бурханы үгтэй харьцуулан шалгадаг явдал юм. Хэрвээ

өнөөдрийн Бурханд үйлчилж байхдаа чи Ариун Сүнсний урьдын гэгээрлээр илчлэгдсэн зүйлстэй зууралдвал үйлчлэл чинь саад учруулж, хэрэгжүүлэлт чинь хоцрогдож, шашны зан үйлээс цаашгүй болно. Бурханд үйлчилдэг хүмүүс бусад чанаруудын дундаас гаднаа даруухан, тэвчээртэй байх ёстой гэж чи итгэдэг бөгөөд ийм төрлийн мэдлэгийг өнөөдөр хэрэгжүүлдэг бол тийм мэдлэг нь шашны үзэл; тийм хэрэгжүүлэлт нь хоёр нүүртэй гүйцэтгэл болжээ. “Шашны үзэл” гэх хэллэг нь хоцрогдсон, үеэ өнгөрөөсөн зүйлсийг (урьд нь Бурханы хэлсэн үг болон Ариун Сүнсний шууд илчилсэн гэрлийн тухай ойлголтыг оролцуулаад) хэлдэг бөгөөд хэрвээ тэдгээрийг өнөөдөр хэрэгжүүлбэл Бурханы ажлыг тасалдуулах ба хүнд ямар ч ашиг тус авчрахгүй. Хэрвээ хүмүүс өөрсдийн дотор байгаа, шашны үзэлд хамаарах тэдгээр зүйлээс ангижирч чадахгүй бол эдгээр зүйл Бурханд үйлчлэх үйлчлэлд нь асар их саад болно. Шашны үзэлтэй хүмүүс Ариун Сүнсний ажлын алхамуудтай хөл нийлүүлэх ямар ч аргагүй—тэд эхлээд нэг, дараа нь хоёр алхмын хойно хоцордог. Яагаад гэвэл, эдгээр шашны үзэл нь хүнийг ер бусын ихээр өөрийгөө зөвтгөдөг, биеэ тоосон зантай болгодог. Бурхан өнгөрсөн үед юу ярьж, хийж байснаа эргэн дурсдаггүй; ямар нэг зүйл хоцрогдсон л бол Тэр үүнийг таягдан хаядаг. Чи өөрийнхөө үзлийг үнэхээр орхиж чадахгүй гэж үү? Хэрвээ чи урьд нь Бурханы хэлсэн үгтэй зууралдвал Бурханы ажлыг мэддэг гэдгийг чинь энэ нь нотлох уу? Хэрвээ чи өнөөдөр Ариун Сүнсний гэрлийг хүлээн зөвшөөрч чадалгүй, оронд нь өнгөрсөн үеийн гэрэлтэй зууралдвал, Бурханы мөрийг дагадгийг чинь энэ нь баталж чадах уу? Чи шашны үзлийг орхиж чадахгүй л байна уу? Хэрвээ тийм бол чи Бурханыг эсэргүүцдэг хүн болно.

Хэрвээ хүмүүс шашны үзлийг орхиж чадах юм бол өнөөдрийн Бурханы үг, ажлыг хэмжихдээ оюун ухаанаа ашиглахгүй, харин шууд дуулгавартай дагана. Хэдийгээр өнөөдрийн Бурханы ажил өнгөрсөн үеийнхтэй илт адилгүй ч чи урьдын үзэл бодлоо орхин, өнөөдрийн Бурханы ажлыг шууд дуулгавартай дагаж чадна. Бурхан урьд нь хэрхэн ажиллаж байснаас үл хамааран Бурханы өнөөдрийн ажилд хамгийн чухал байр суурийг өгөх ёстой гэдгийг ойлгож чаддаг бол чи өөрийн үзлийг орхисон, Бурханыг дуулгавартай дагадаг, Бурханы ажил болон үгэнд дуулгавартай байж, Бурханы мөрийг дагаж чаддаг хүн юм. Ингэснээр чи Бурханыг үнэхээр дуулгавартай дагадаг нэгэн болох болно. Чи Бурханы ажлыг задлан шинжилж, нягтлан үздэггүй; яг л Бурхан өмнөх ажлаа мартсантай адил чи ч гэсэн үүнийг мартсан. Одоо бол одоо, өнгөрсөн бол өнгөрсөн бөгөөд өнөөдөр Бурхан урьд нь хийсэн зүйлээ хойш тавьсан болохоор

чи энэ талаар бодох ёсгүй. Тийм хүн л Бурханыг бүрэн дүүрэн дуулгавартай дагадаг, шашны үзлээ бүрмөсөн орхисон хүн билээ.

Бурханы ажилд үргэлж шинэ хөгжил явагдаж байдаг учраас шинэ ажил гарч ирэхэд хоцрогдож, хуучирдаг ажил гэж бий. Хуучин ба шинэ эдгээр өөр өөр төрлийн ажил нь нэг нэгтэйгээ зөрчилддөггүй, харин харилцан бие биеэ нөхдөг; алхам бүр нь сүүлийн алхмаасаа үргэлжилдэг. Шинэ ажил байгаа учраас, хуучин зүйлс мэдээж таягдан хаягдах ёстой. Жишээ нь, аль эртнээс хэвшиж тогтсон хүний зарим хэрэгжүүлэлт болон дадал болсон үгс нь хүний олон жилийн туршлага, сургаалтай хослон хүний сэтгэлд элдэв янзын үзлийг бий болгожээ. Бурхан Өөрийн жинхэнэ царай болон төрөлх зан чанарыг хүнд хараахан бүрэн илчлээгүй нь эрт цагийн уламжлалт онолууд олон жилийн туршид түгэн дэлгэрсэнтэй хавсран хүний тийм үзэл бүрэлдэхэд илүү тааламжтай байсаар ирсэн юм. Бурханд итгэх хүний итгэлийн явцад янз бүрийн үзэл нөлөөлснөөр Бурханы талаарх элдэв янзын үзэл бүхий ойлголт хүмүүст тасралтгүй бий болж, хувьсан өөрчлөгдөхөд хүрсэн бөгөөд үүний үр дүнд Бурханд үйлчилдэг шашны олон хүн Түүний дайсан болсон гэж хэлж болох юм. Иймээс, хүмүүсийн шашны үзэл хүчтэй байх тусам Бурханыг улам эсэргүүцдэг ба төдий чинээ Бурханы дайснууд болдог. Бурханы ажил үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй; энэ нь хэзээ ч хоосон сургаалыг бий болгодоггүй, харин их бага хэмжээгээр тасралтгүй өөрчлөгдөн, шинэчлэгдэж байдаг. Ийм маягаар ажиллах нь Бурханы Өөрийн төрөлх зан чанарын илэрхийлэл билээ. Энэ нь бас Бурханы ажлын угийн зарчим бөгөөд Өөрийн удирдлагыг хэрэгжүүлдэг Бурханы арга барилын нэг юм. Хэрвээ Бурхан ийм маягаар ажиллаагүй бол хүн өөрчлөгдөхгүй, эсвэл Бурханыг мэдэж чадахгүй, Сатан ялагдахгүй байх байсан. Тиймээс, замбараагүй харагддаг ч үнэндээ тогтмол мөчлөгтэй тасралтгүй өөрчлөлтүүд Түүний ажилд гарч байдаг. Гэхдээ хүний Бурханд итгэдэг байдал нэлээд өөр. Хүн хуучны, танил сургаал болон системтэй зууралддаг бөгөөд тэдгээр нь хуучных байх тусам, төдий чинээ таатай байдаг. Хүний хад чулуу мэт өөрчлөгдөшгүй, мунхаг ухаан санаа Бурханы ойлгохын аргагүй шинэ ажил, үгийг хэрхэн хүлээн зөвшөөрч чадах билээ? Үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй Бурханыг хүн үзэн яддаг; тэрээр хөгшин хөвөө, буурал үстэй, хөдөлгөөнгүй, хуучин Бурхандаа л дуртай. Тиймээс, Бурхан, хүн хоёрын аль алинд өөрсдийн гэсэн дуртай зүйл байдаг учраас хүн Бурханы дайсан болжээ. Бурхан шинэ ажлаа бараг зургаан мянган жилийн турш хийсээр ирсэн үе буюу өнөөдөр ч гэсэн энэ олон зөрчилдөөн оршсоор л байна. Тэгэхээр тэдгээр нь

засаршгүй ажээ. Магадгүй энэ нь хүний зөрүүд зангаас, эсвэл Бурханы захиргааны зарлигийг хэн ч зөрчих аргагүйгээс болдог байх—гэхдээ тэдгээр шашны албан тушаалтнуудыг өгөршсөн хуучин ном, цаастай зууралдсаар байхад Бурхан дэргэд нь хэн ч байхгүй мэт дуусаагүй удирдлагын ажлаа хийдэг. Эдгээр зөрчилдөөн нь Бурхан, хүн хоёрыг дайснууд болгодог ба эвлэрэхийн аргагүй байдаг ч гэсэн Бурхан тэдгээрт огт анхаарал хандуулдаггүй, тийм зүйл байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг ханддаг. Харин хүн итгэл, үзэлтэйгээ зууралдсаар, тэдгээрийгээ хэзээ ч орхидоггүй. Гэхдээ нэг зүйл илэрхий: Хэдий хүн байрнаасаа хазайдаггүй ч Бурханы хөл үргэлж хөдөлж, нөхцөл байдлаас хамааран байраа үргэлж өөрчилж байдаг. Эцэст нь хүн л ямар ч тэмцэлгүйгээр ялагдана. Харин Бурхан бол ялагдсан дайснуудынхаа хамгийн том дайсан нь, бас ялагдсан болон ялагдаагүй хүн төрөлхтний бүгдийнх нь аварга юм. Хэн Бурхантай тэмцэж, ялалт байгуулж чадах юм бэ? Хүний үзлийн ихэнх нь Бурханы ажлаас үүдэн гарсан учраас Бурханаас үүсэлтэй мэт санагддаг. Гэсэн ч үүнээс болоод Бурхан хүнийг уучилдаггүй, түүнчлэн Бурханы ажлаас үүдэн Бурханы ажилд хамааралгүй бүтээгдэхүүнийг багц багцаар нь “Бурханы төлөө” бүтээсэнд нь хүнийг магтаалаар булдаг ч үгүй. Харин ч Тэрээр хүний үзэл болон хуучин сүсэг бишрэлийг туйлын их зэвүүцдэг ба эдгээр үзэл анх гарч ирсэн хугацааг ч хүлээн зөвшөөрөх бодолгүй байдаг. Хүний үзлийг хүн түгээдэг учраас Өөрийнх нь ажлаас үүдэн эдгээр үзэл бий болсон гэдгийг Бурхан огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй; тэдгээрийн эх сурвалж нь хүний бодол, оюун ухаан бөгөөд Бурхан биш, харин Сатан юм. Бурханы санаа зорилго нь үргэлж Өөрийнхөө ажлыг хуучин үхмэл биш, харин шинэлэг, эрч хүчтэй байлгахын төлөө байсаар ирсэн ба хүнээр баримтлуулдаг зүйлс нь үүрд мөнхийн, хувиршгүй биш, харин эрин үе, цаг хугацааны хамтаар өөрчлөгддөг. Учир нь Тэр бол хүнийг үхүүлж, хуучинсаг байлгадаг диавол биш, харин амьдруулж, шинэлэг байлгадаг Бурхан билээ. Та нар үүнийг ойлгоогүй л байна уу? Хуучинсаг үзэл бодолтой учраас ч Бурханы тухай үзэлтэй байдаг бөгөөд тэдгээрийгээ хаяж чаддаггүй. Энэ нь, Бурханы ажилд эрүүл ухаан бараг байдаггүй, эсвэл Бурханы ажил хүний хүслээс зөрдгөөс болдог юм биш, түүнчлэн Бурхан үүргээ үргэлж цалгардуулдгаас ч болдог юм биш. Харин ч хэтэрхий дуулгаваргүй учраас, мөн чамд Бурханы бүтээлийн төрх өчүүхэн төдий ч байдаггүй учраас үзлээ орхиж чаддаггүй; Бурхан чамд хүндрэл учруулаад байдаг юм биш. Энэ бүхэн чамаас болсон ба Бурхантай ямар ч хамаагүй; бүх зовлон, золгүй явдлыг хүн бий болгодог. Бурханы бодол үргэлж сайн байдаг: Тэр чамайг үзэл бий болгоосой

гэж хүсдэггүй, харин эрин үе өнгөрөхийн хэрээр өөрчлөгдөж, шинэчлэгдээсэй гэж хүсдэг. Гэсэн ч чи өөрт чинь юу сайн болохыг мэддэггүй, үргэлж шинжлэн шалгаж, аль эсвэл нягтлан үзэж байдаг. Бурхан чамд хүндрэл учруулаад байгаа юм биш, харин чи Бурханыг огт хүндэлдэггүй, мөн дуулгаваргүй байдал чинь дэндүү их. Өчүүхэн жаахан бүтээгдсэн зүйл урьд нь Бурханы өгсөн зүйлийн ялимгүй бага хэсгийг авч зүрхэлдэг, дараа нь эргээд үүнийгээ ашиглан Бурхан руу дайрч давшилдаг—энэ нь хүний дуулгаваргүй байдал биш гэж үү? Хүмүүст өөрсдийн үзэл бодлыг Бурханы өмнө илэрхийлэх эрх огт байхгүй, үнэ цэнгүй, олиггүй, илжирсэн, уран цэцэн үг хэлээ хүссэнээрээ гайхуулах эрх бүр ч байхгүй—өнөөх илжирсэн үзлүүдийг бол дурдахын ч хэрэггүй гэж хэлж болно. Тэдгээр нь бүр ч үнэ цэнгүй бус уу?

Бурханд үнэхээр үйлчилдэг хүн бол Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг, Бурхан ашиглахад тохирсон хүн бөгөөд шашны үзлийг орхиж чаддаг. Хэрвээ чи Бурханы үгийг үр өгөөжтэйгөөр идэж, уухыг хүсвэл шашны үзлээ орхих учиртай. Хэрвээ чи Бурханд үйлчлэхийг хүсдэг бол эхлээд шашны үзлээ орхиж, бүх зүйл дээр Бурханы үгийг дуулгавартай дагах нь бүр ч чухал юм. Бурханд үйлчилдэг хүний эзэмших ёстой зүйл энэ билээ. Хэрвээ чамд ийм мэдлэг байхгүй бол үйлчилж эхэлмэгцээ л саад тотгор, үймээн учруулах ба өөрийн үзлийг баримталсаар байвал Бурхан чамайг хэзээ ч дахин босохооргүй болтол цохин унагах нь гарцаагүй. Жишээлбэл, өнөө үеийг аваад үзье: Өнөөдрийн олон айлдвар болон ажил Библитэй нийцдэггүй, урьд нь Бурханы хийсэн ажилтай таардаггүй бөгөөд хэрвээ чамд дуулгавартай дагах хүсэл байхгүй бол чи хэдийд ч унаж магадгүй. Хэрвээ чи Бурханы хүслийн дагуу үйлчлэхийг хүсэж байвал эхлээд шашны үзлээ орхиж, өөрийн үзэл бодлыг засаж залруулах ёстой. Ирээдүйд хэлэх зүйлсийн ихэнх нь өнгөрсөнд хэлж байсантай нийцэхгүй ба хэрвээ одоо чамд дуулгавартай дагах хүсэл байхгүй бол өмнөх замаараа алхаж чадахгүй. Хэрвээ Бурханы ажилладаг аргуудын нэг нь чиний дотор үндэслэж, чи үүнийг хэзээ ч орхиогүй бол тэр арга чиний шашны үзэл болно. Хэрвээ Бурхан юу болох нь дотор чинь үндэслэсэн бол чи үнэнийг олж авсан бөгөөд Бурханы үг болон үнэн амь чинь болж чаддаг бол Бурханы талаар үзэлтэй байхаа болино. Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй хүмүүс ямар ч үзэлгүй байх бөгөөд хоосон сургаал баримтлахгүй.

Сонор сэрэмжтэй байхын тулд эдгээр асуултыг асуу:

1. Чамд байгаа мэдлэг Бурханд үйлчлэхэд чинь саад болдог уу?
2. Өдөр тутмын амьдралд чинь хэр олон шашны хэрэгжүүлэлт байдаг вэ?

Хэрвээ чи зөвхөн сүсэг бишрэлтэй мэт харагддаг бол амь чинь өсөж, төлөвшсөн гэсэн үг мөн үү?

3. Чи Бурханы үгийг идэж, уух үедээ шашны үзлээ орхиж чаддаг уу?
4. Залбирах үедээ чи шашны зан үйлээс ангижирч чаддаг уу?
5. Чи Бурхан ашиглахад тохирсон хүн мөн үү?
6. Бурханы талаарх мэдлэгийн чинь хэр их нь шашны үзэл агуулдаг вэ?

БУРХАНЫ ШИНЭХЭН АЖЛЫГ МЭДЭЖ, ТҮҮНИЙ МӨРИЙГ ДАГА

Одоо та нар Бурханы ардууд болохоор эрэлхийлж, бүх зүйл зөв замд орж эхэлнэ. Бурханы ардууд байна гэдэг нь Хаанчлалын эрин үед орно гэсэн үг юм. Өнөөдөр та нар албан ёсоор хаанчлалын сургалтад орж эхэлдэг бөгөөд ирээдүйн амьдрал чинь урьдынх шигээ назгай, хайнга байхаа болино; тийм маягаар амьдарвал Бурханы шаардсан стандартад хүрэх боломжгүй. Хэрвээ чи жаахан ч гэсэн яардаггүй бол чамд өөрийгөө сайжруулах хүсэл байхгүй, чиний эрэл хайгуул будилуу, мунгинуу байгааг энэ нь харуулдаг бөгөөд чи Бурханы хүслийг биелүүлэх чадваргүй. Хаанчлалын сургалтад орох гэдэг нь Бурханы ардын амьдралаар амьдарч эхэлнэ гэсэн үг—чи тийм сургалтыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна уу? Яарсан мэдрэмжтэй байхад бэлэн үү? Бурханы сахилгажуулалт дор амьдрахад бэлэн үү? Бурханы гэсгээлт дор амьдрахад бэлэн үү? Бурханы үг чам дээр ирж, чамайг турших үед чи хэрхэн үйлдэх вэ? Бүх төрлийн баримттай тулгарах үедээ чи юу хийх вэ? Урьд нь чи амь дээр анхаарлаа төвлөрүүлээгүй; өнөөдөр чи амийн бодит байдалд орж, амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой. Энэ нь хаанчлалын ардуудын биелүүлэх ёстой зүйл юм. Бурханы ард болох бүх хүн амийг эзэмших ёстой бөгөөд хаанчлалын сургалтыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой. Хаанчлалын ардуудаас Бурханы шаарддаг зүйл энэ юм.

Хаанчлалын ардуудад Бурхан дараах шаардлагыг тавьдаг:

1. Тэд Бурханы даалгаврыг хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы эцсийн өдрүүдийн ажилд хэлэгдсэн бүх үгийг хүлээн зөвшөөрөх ёстой.
2. Тэд хаанчлалын сургалтад орох ёстой.
3. Тэд зүрх сэтгэлээ Бурханаар хөдөлгүүлэхээр эрэлхийлэх ёстой. Зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрмөсөн эргэж, хэвийн сүнслэг амьдралтай болох

үедээ чи эрх чөлөөтэй ертөнцөд амьдарна, энэ нь Бурханы хайрын халамж, хамгаалалт дор амьдарна гэсэн үг юм. Бурханы халамж, хамгаалалт дор амьдрах үедээ л чи Бурханд харьяалагдана.

4. Тэд Бурханаар авхуулах ёстой.

5. Тэд газар дээрх Бурханы алдрын илрэл болох ёстой.

Энэ таван зүйл бол та нарт Миний даалгасан даалгавар юм. Би үгээ Бурханы ардуудад хэлдэг бөгөөд хэрвээ чи эдгээр даалгаврыг хүлээн зөвшөөрөх дургүй байгаа бол Би хүчлэхгүй—гэхдээ тэдгээрийг үнэхээр хүлээн зөвшөөрвөл чи Бурханы хүслийг биелүүлж чадна. Өнөөдөр та нар Бурханы даалгаврыг хүлээн зөвшөөрч эхэлдэг ба хаанчлалын ардууд болж, хаанчлалын ардуудаас шаарддаг стандартад хүрэхээр эрэлхийлдэг. Энэ нь оролтын эхний алхам юм. Хэрвээ чи Бурханы хүслийг бүрэн биелүүлэхийг хүсвэл энэ таван даалгаврыг хүлээн зөвшөөрөх ёстой ба тэдгээрийг биелүүлж чадвал Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж, Бурханд асар их ашиглагдах нь гарцаагүй. Өнөөдрийн хамгийн чухал зүйл бол хаанчлалын сургалтад орох явдал юм. Хаанчлалын сургалтад орох нь сүнслэг амьдралтай хамаатай. Урьд нь сүнслэг амьдралын талаар огт яриагүй, харин өнөөдөр хаанчлалын сургалтад орж эхлэхдээ чи албан ёсоор сүнслэг амьдралд ордог.

Сүнслэг амьдрал гэж ямархуу амьдрал вэ? Сүнслэг амьдрал гэдэг нь, зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрмөсөн эргэсэн, Бурханы хайрыг анхаарч чаддаг амьдрал юм. Энэ нь Бурханы үгэн дотор амьдардаг, зүрх сэтгэлийг чинь өөр юу ч эзэмддэггүй, Бурханы өнөөгийн хүслийг ухаарч чаддаг, мөн үүргээ биелүүлэхийн тулд Ариун Сүнсний өнөөгийн гэрлээр замчлуулдаг амьдрал юм. Хүн, Бурхан хоёрын хоорондох ийм амьдрал нь сүнслэг амьдрал мөн. Хэрвээ чи өнөөдрийн гэрлийг дагаж чаддаггүй бол Бурхантай харилцах харилцаанд чинь зай гарч, тэр ч байтугай таслагдсан байж болох бөгөөд чамд хэвийн сүнслэг амьдрал байдаггүй. Бурхантай харилцах хэвийн харилцаа нь Бурханы өнөөгийн үгийг хүлээн зөвшөөрсөн суурин дээр бий болдог. Чи хэвийн сүнслэг амьдралтай юу? Бурхантай хэвийн харилцаатай юу? Чи Ариун Сүнсний ажлыг дагадаг нэгэн мөн үү? Хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагаж чаддаг бөгөөд Бурханы үгэн дотроос хүслийг нь ухаарч, эдгээр үгэнд орж чаддаг бол Ариун Сүнсний урсгалыг дагадаг нэгэн мөн. Хэрвээ Ариун Сүнсний урсгалыг дагаж чадахгүй бол үнэнийг эрж хайдаггүй хүн гэдэг чинь эргэлзээгүй. Өөрсдийгөө сайжруулах хүсэлгүй хүмүүсийн дотор Ариун Сүнс ажиллах ямар ч боломжгүй бөгөөд үүний үрээр тийм хүмүүс хүч чадлаа дайчилж хэзээ ч

чаддаггүй, үргэлж идэвхгүй байдаг. Өнөөдөр чи Ариун Сүнсний урсгалыг дагадаг уу? Ариун Сүнсний урсгалд байдаг уу? Чи идэвхгүй байдлаас гарсан уу? Бурханы үгэнд итгэдэг, Бурханы ажлыг сууриа болгож, Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагадаг бүх хүн Ариун Сүнсний урсгалд байгаа. Хэрвээ чи, Бурханы үг маргаангүй үнэн, зөв гэж итгэдэг бол; Бурхан юу ч хэлсэн бай, үгэнд нь итгэдэг бол Бурханы ажилд орохоор эрэлхийлдэг хүн бөгөөд ийм маягаар чи Бурханы хүслийг биелүүлдэг.

Ариун Сүнсний урсгалд орохын тулд чи Бурхантай хэвийн харилцаатай байх ёстой бөгөөд эхлээд идэвхгүй байдлаасаа ангижрах ёстой. Зарим хүн үргэлж олонхыг дагадаг ба зүрх сэтгэл нь Бурханаас хэтэрхий хол хадуурсан байдаг; тийм хүмүүст өөрсдийгөө сайжруулах ямар ч хүсэл байдаггүй бөгөөд эрэлхийлдэг стандарт нь дэндүү доогуур байдаг. Бурханыг хайрлах, Бурханаар авхуулах эрэл хайгуул л Бурханы хүсэл юм. Бурханы хайрыг хариулахын тулд мөс чанараа л ашигладаг хүмүүс байдаг боловч энэ нь Бурханы хүсэлд нийцэж чадахгүй; чи өндөр стандартыг эрэлхийлэх тусам, энэ нь Бурханы хүсэлтэй төдий чинээ зохицолтой байх болно. Хэвийн хүн болохын хувьд, мөн Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг хүн болохын хувьд хаанчлалд орж, Бурханы ардуудын нэг болох нь та нарын жинхэнэ ирээдүй бөгөөд дээд зэргийн үнэ цэн, ач холбогдолтой амьдрал юм; та нараас илүү ерөөгдсөн хэн ч байхгүй. Би яагаад ингэж хэлдэг вэ? Учир нь Бурханд итгэдэггүй хүмүүс махан биеийн төлөө, Сатаны төлөө амьдардаг, гэхдээ өнөөдөр та нар Бурханы төлөө амьдарч, Бурханы хүслийг биелүүлэхээр амьдардаг. Тийм учраас, та нарын амьдрал дээд зэргийн ач холбогдолтой гэж Би хэлдэг. Бурханы сонгосон энэ бүлэг хүмүүс л дээд зэргийн ач холбогдолтой амьдралыг амьдран харуулж чаддаг: Газар дэлхий дээр өөр хэн ч тийм үнэ цэн, утга учиртай амьдралыг амьдран харуулж чадахгүй. Та нарыг Бурхан сонгож, Бурхан өргөсөн учраас, түүнчлэн та нарыг гэх Бурханы хайраас болж та нар жинхэнэ амьдралд хүрч, дээд зэргийн үнэ цэнэтэй амьдралаар хэрхэн амьдрах тухай мэдсэн. Энэ нь та нарын эрэл хайгуул сайнаас болоогүй, харин Бурханы нигүүлслээс болсон юм; та нарын сүнслэг нүдийг Бурхан нээж, зүрх сэтгэлийг чинь Бурханы Сүнс хөдөлгөж, Түүний өмнө очих сайн зол завшаан өгсөн билээ. Хэрвээ Бурханы Сүнс та нарыг гэгээрүүлээгүй бол та нар Бурханы хайр татам байдлыг харах чадваргүй байх байсан, мөн Бурханыг хайрлах ч боломжгүй байх байсан. Үндсэндээ Бурханы Сүнс хүмүүсийн зүрх сэтгэлийг хөдөлгөсөн учраас л тэдний зүрх сэтгэл Бурхан руу эргэсэн. Заримдаа Бурханы үгийг таашааж байх үед сүнс чинь хөдөлж, чи өөрийн эрхгүй Бурханыг

хайрлаж, дотор чинь асар их хүч чадал байгааг, чиний хувьд хойш тавьж чадахгүй юу ч байхгүй гэдгийг мэдэрдэг. Хэрвээ чамд ингэж санагддаг бол Бурханы Сүнс чамайг хөдөлгөж, зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрэн эргэсэн бөгөөд чи Бурханд залбирч, “Өө Бурхан минь! Биднийг үнэхээр Та урьдчилан тогтоож, сонгосон. Таны алдар надад бахархал хайрлаж, Таны ардуудын нэг байх нь миний хувьд алдар цуутай санагддаг. Таны хүслийг биелүүлэхийн тулд би юуг ч зарлагадаж, юуг ч өгнө, өөрийн бүх амьдрал, насан туршийн бүхий л эрч хүчийг Танд зориулна” гэж хэлнэ. Ингэж залбирах үед зүрх сэтгэлд чинь Бурханыг гэх эцэс төгсгөлгүй хайр болон жинхэнэ дуулгавартай байдал байх болно. Чамд ер нь иймэрхүү туршлага байсан уу? Хэрвээ хүмүүсийн сэтгэлийг Бурханы Сүнс үргэлж хөдөлгөдөг бол тэд ялангуяа залбиралдаа өөрсдийгөө Бурханд зориулахад бэлэн байдаг: “Өө Бурхан минь! Би Таны алдрын өдрийг харахыг хүсэж байна, би Таны төлөө амьдрахыг хүсэж байна—Таны төлөө амьдрахаас илүү үнэ цэнтэй, утга учиртай юу ч үгүй бөгөөд надад Сатан болон махан биеийн төлөө амьдрах өчүүхэн төдий ч хүсэл алга. Өнөөдөр Таны төлөө амьдрах боломж олгосноороо Та намайг өргөсөн.” Ийм маягаар залбирах үедээ чи, зүрх сэтгэлээ Бурханд өгөхгүй байж чадахгүй гэдгээ, Бурханыг олж авах ёстойгоо, амьд ахуйдаа Бурханыг олж авалгүйгээр үхэж тэвчихгүй гэдгээ мэдэрнэ. Ийм залбирал хэлсний дараа чиний дотор барагдашгүй их хүч байх ба энэ нь хаанаас ирдгийг чи мэдэхгүй; зүрх сэтгэл чинь хязгааргүй их хүч чадалтай байж, Бурхан бол маш хайр татам, Түүнийг хайрлууштай гэдгийг чи мэдэрнэ. Энэ үед Бурхан сэтгэлийг чинь хөдөлгөсөн байх болно. Ийм туршлагатай бүх хүний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн байдаг. Бурхан үргэлж сэтгэлийг нь хөдөлгөдөг хүмүүсийн амь нь өөрчлөгддөг, тэд шийдвэрээ гаргаж чаддаг, Бурханыг бүрэн олж авахад бэлэн байдаг, зүрх сэтгэл дэх Бурханыг гэх хайр нь илүү хүчтэй байж, зүрх сэтгэл нь Бурхан руу бүрмөсөн эргэсэн байдаг, тэд гэр бүл, дэлхий ертөнц, ээдрээтэй асуудлууд, эсвэл өөрсдийн ирээдүйг тоодоггүй, мөн насан туршийн эрч хүчээ Бурханд зориулахад бэлэн байдаг. Бурханы Сүнсээр хөдөлгөгдсөн бүх хүн бол үнэнийг эрэлхийлдэг, Бурханаар төгс болгуулах итгэл найдвартай хүмүүс юм.

Чи зүрх сэтгэлээ Бурхан руу хандуулсан уу? Чиний зүрх сэтгэлийг Бурханы Сүнс хөдөлгөсөн үү? Хэрвээ чамд тийм туршлага огт байгаагүй бол, хэрвээ чи хэзээ ч ийм маягаар залбирч байгаагүй бол зүрх сэтгэлд чинь Бурхан ямар ч зай эзэлдэггүй гэдгийг энэ нь харуулдаг. Бурханы Сүнсээр замчлуулдаг, Бурханы Сүнсээр хөдөлгөгдсөн бүх хүн Бурханы ажлыг эзэмшдэг нь Бурханы үг болон хайр тэдний дотор үндэслэсэн гэдгийг харуулдаг. Зарим хүн ингэж

хэлдэг: “Би залбиралдаа чам шиг чин үнэнч байдаггүй, бас Бурхан миний сэтгэлийг тийм ч их хөдөлгөдөггүй; заримдаа бясалгаж, залбирах үедээ би Бурхан хайр татам гэдгийг мэдэрч, миний зүрх сэтгэлийг Бурхан хөдөлгөдөг.” Хүний зүрх сэтгэлээс илүү чухал юу ч үгүй. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэх үед бүхий л оршихуй чинь Бурхан руу эргэсэн байх ба тэр үед зүрх сэтгэлийг чинь Бурханы Сүнс хөдөлгөсөн байх болно. Та нарын дундаас ихэнхэд нь ийм туршлага байгаа—зүгээр л туршлагын чинь гүн гүнзгий байдал нь адилхан биш. Зарим хүн: “Би залбирлын олон үг хэлдэггүй, зүгээр л бусдын яриаг сонсоод миний доторх хүч чадал нэмэгддэг” гэж хэлдэг. Энэ нь сэтгэлийг чинь Бурхан хөдөлгөсөн гэдгийг харуулдаг. Зүрх сэтгэлийг нь Бурхан хөдөлгөсөн хүмүүс бусдын яриаг сонсох үедээ зоригждог; зоригжуулж урамшуулсан үгийг сонсох үедээ хүний зүрх сэтгэл огт хөдлөхгүй хэвээр байвал Ариун Сүнсний ажил түүний дотор байхгүй гэдгийг энэ нь баталдаг. Тэдний дотор хүсэл эрмэлзэл байдаггүй нь тэдэнд ямар ч шийдвэр байхгүй гэдгийг баталдаг, тиймээс тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй. Хэрвээ хүний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн бол Бурханы үгийг сонсох үедээ тэрээр хариу үйлдэл үзүүлнэ; харин Бурхан сэтгэлийг нь хөдөлгөөгүй бол тэрээр Бурханы үгтэй холбогдоогүй, тэдгээртэй ямар ч хамаагүй байдаг бөгөөд гэгээрүүлэгдэж чадахгүй. Бурханы үгийг сонссон агаад ямар ч хариу үйлдэлгүй байсан хүмүүс нь Бурханаар хөдөлгөгдөөгүй хүмүүс юм—тэд бол Ариун Сүнсний ажилгүй хүмүүс билээ. Шинэ гэрлийг хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн хөдөлгөгдсөн байдаг бөгөөд Ариун Сүнсний ажилтай байдаг.

Өөрийгөө үнэлээрэй:

1. Чи Ариун Сүнсний өнөөгийн ажлын дунд байгаа юу?
2. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэсэн үү? Чиний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн үү?
3. Бурханы үг чиний дотор үндэслэсэн үү?
4. Чиний хэрэгжүүлэлт Бурханы шаардлагад суурилсан уу?
5. Чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийн удирдамж дор амьдардаг уу?
6. Чиний зүрх сэтгэлийг хуучин үзэл захирдаг уу, эсвэл Бурханы өнөөгийн үг захирдаг уу?

Эдгээр үгийг сонсоод та нарын доторх хариу үйлдэл юу вэ? Ийм олон жил итгэхээд чи Бурханы үгийг өөрийн амь болгосон уу? Урьдын завхарсан зан чанарт чинь өөрчлөлт гарсан уу? Бурханы өнөөгийн үгийн дагуу бол, амьтай байх болон амьгүй байх гэж юу гэсэн үг болохыг чи мэдэх үү? Энэ нь та нарт

тодорхой байна уу? Бурханыг дагахад хамгийн чухал нь бүх зүйл Бурханы өнөөгийн үгийн дагуу байх ёстой: Чи амийн оролтыг эрэлхийлж байна уу, эсвэл Бурханы хүслийг хангалуун байлгахаар эрэлхийлж байна уу хамаагүй, бүх зүйл Бурханы өнөөгийн үгэнд төвлөрөх ёстой. Хэрвээ чиний ярилцаж, эрэлхийлдэг зүйл Бурханы өнөөгийн үгэнд төвлөрдөггүй бол чи Бурханы үгийн гадна байгаа хүн бөгөөд Ариун Сүнсний ажил огт байхгүй. Өөрийнх нь мөрийг дагадаг хүмүүсийг Бурхан хүсдэг. Урьд нь ойлгосон зүйл чинь хэчнээн гайхалтай, хольцгүй байх нь хамаагүй Бурхан үүнийг хүсдэггүй бөгөөд хэрвээ чи тийм зүйлсийг хойш тавьж чадахгүй бол тэдгээр нь ирээдүйн оролтод чинь асар их саад бартаа болно. Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагаж чаддаг бүх хүн ерөөгддөг. Өнгөрсөн эрин үеүдийн хүмүүс ч бас Бурханы мөрийг дагасан, гэхдээ тэд өнөөдрийг хүртэл дагаж чадаагүй; энэ бол эцсийн өдрүүдийн хүмүүсийн ерөөл юм. Ариун Сүнсний өнөөгийн ажлыг дагаж чаддаг, мөн Бурханы мөрийг дагаж чаддаг, улмаар Бурхан өөрсдийг нь хаашаа ч хөтөлсөн дагадаг хүмүүс бол Бурханаар ерөөгддөг хүмүүс билээ. Ариун Сүнсний өнөөгийн ажлыг дагадаггүй хүмүүс Бурханы үгийн ажилд ороогүй бөгөөд хэчнээн их ажиллаж, хэдий их зовж, хэчнээн ийш тийш гүйлээ ч гэсэн Бурханы хувьд энэ нь ямар ч утгагүй бөгөөд Бурхан тэднийг сайшаахгүй. Өнөөдөр, Бурханы өнөөгийн үгийг дагадаг бүх хүн Ариун Сүнсний урсгалд байдаг; Бурханы өнөөгийн үгээс ангид хүмүүс Ариун Сүнсний урсгалын гадна байдаг бөгөөд тийм хүмүүсийг Бурхан сайшаадаггүй. Ариун Сүнсний өнөөгийн айлдвараас салсан үйлчлэл бол махан биеийн үйлчлэл, үзлийн үйлчлэл бөгөөд Бурханы хүсэлтэй нийцэлтэй байх боломжгүй. Хэрвээ хүмүүс шашны үзэл дунд амьдардаг бол Бурханы хүсэлд нийцэх юу ч хийж чадахгүй бөгөөд Бурханд үйлчиллээ ч гэсэн үзэл, төсөөллийнхөө дунд үйлчлэн, Бурханы хүслийн дагуу үйлчлэх ямар ч чадваргүй байдаг. Ариун Сүнсний ажлыг дагаж чаддаггүй хүмүүс Бурханы хүслийг ойлгодоггүй ба Бурханы хүслийг ойлгодоггүй хүмүүс Бурханд үйлчилж чадахгүй. Бурхан Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух үйлчлэлийг хүсдэг; харин үзлийн болон махан биеийн үйлчлэлийг хүсдэггүй. Хүмүүс Ариун Сүнсний ажлын алхмуудыг дагах чадваргүй бол үзэл дунд амьдардаг. Ийм хүмүүсийн үйлчлэл саад болж, төвөг уддаг бөгөөд ийм үйлчлэл Бурханы эсрэг байдаг. Тиймээс Бурханы мөрийг дагаж чаддаггүй хүмүүс Бурханд үйлчилж чаддаггүй; Бурханы мөрийг дагаж чаддаггүй хүмүүс Бурханыг гарцаагүй эсэргүүцдэг ба Бурхантай нийцэлтэй байж чаддаггүй. “Ариун Сүнсний ажлыг дагах” гэдэг нь Бурханы өнөөгийн хүслийг ойлгож, Бурханы өнөөгийн шаардлагын дагуу үйлдэж чаддаг

байж, өнөөдрийн Бурханд захирагдаж, Түүнийг дагаж, Бурханы хамгийн шинэ айлдваруудын дагуу орж чаддаг байна гэсэн үг юм. Зөвхөн энэ л Ариун Сүнсний ажлыг дагадаг, Ариун Сүнсний урсгалд байдаг хүн юм. Тийм хүмүүс Бурханы сайшаалыг хүртэж, Бурханыг харж чаддаг төдийгүй хамгийн сүүлийн үеийн ажлаас нь Бурханы зан чанарыг мэдэж, хүний үзэл, дуулгаваргүй байдал, уг чанар болон мөн чанарыг мэдэж чаддаг; түүнчлэн тэд үйлчлэлийнхээ үеэр өөрсдийн зан чанарыг аажмаар өөрчилж чаддаг. Ийм хүмүүс л Бурханыг олж авах чадвартай, үнэн замыг үнэхээр олсон хүмүүс юм. Ариун Сүнсний ажлаар таягдан хаягдсан хүмүүс бүгдээрээ Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлыг дагаж чаддаггүй, харин Бурханы хамгийн сүүлийн үеийн ажилд тэрсэлдэг хүмүүс юм. Тийм хүмүүс Бурханыг илт эсэргүүцдэг нь Бурхан шинэ ажил хийснээс болдог, мөн Бурханы дүр, өөрсдийнх нь үзэлд байдаг дүрээс өөр байгаагаас болдог—иймээс тэд Бурханыг илт эсэргүүцэж, шүүж, улмаар Бурхан тэднийг жигшин голоход хүрдэг. Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлын талаар мэдэх нь амархан хэрэг биш боловч хэрвээ хүмүүс Бурханы ажлыг дуулгавартай дагаж, Бурханы ажлыг эрж хайх санаатай байвал Бурханыг харж, Ариун Сүнсний шинэхэн удирдамжийг олж авах боломжтой байх болно. Бурханы ажлыг зориуд эсэргүүцдэг хүмүүс Ариун Сүнсний гэгээрэл юм уу Бурханы удирдамжийг хүлээн авч чадахгүй. Тиймээс хүмүүс Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлыг хүлээн авч чадах уу, үгүй юу гэдэг нь Бурханы нигүүлслээс хамаардаг, мөн тэдний эрэл хайгуул болон санаа зорилгоос хамаардаг.

Ариун Сүнсний өнөөгийн айлдваруудыг дуулгавартай дагаж чаддаг бүх хүн ерөөгддөг. Тэд өмнө нь ямар байсан, эсвэл Ариун Сүнс тэдэн дотор хэрхэн ажилладаг байсан нь хамаагүй—Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлыг олж авсан хүмүүс хамгийн их ерөөгддөг бөгөөд өнөөдөр хамгийн сүүлийн үеийн ажлыг дагаж чаддаггүй хүмүүс таягдан хаягддаг. Бурхан шинэ гэрлийг хүлээн зөвшөөрч чаддаг хүмүүсийг хүсдэг бөгөөд Өөрийнх нь хамгийн сүүлийн үеийн ажлыг хүлээн зөвшөөрдөг, мэддэг хүмүүсийг хүсдэг. Та нарыг ухаалаг охид байх ёстой гэж яагаад хэлдэг вэ? Ухаалаг охид Ариун Сүнсний ажлыг эрж хайж, шинэ зүйлсийг ойлгож, цаашлаад хуучин үзлээ хойш тавьж, Бурханы өнөөдрийн ажлыг дуулгавартай дагаж чаддаг. Өнөөдрийн шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөг энэ бүлэг хүмүүсийг Бурхан аль эрт урьдчилан тогтоосон бөгөөд хамгийн их ерөөгдсөн хүмүүс билээ. Та нар Бурханы дуу хоолойг шууд сонсож, Бурханы илрэлтийг хардаг, иймээс тэнгэр газар даяар, эрин үеүдийн туршид хэн ч энэ бүлэг хүмүүс та нараас илүү ерөөгдөөгүй. Энэ бүхэн нь Бурханы ажлаас,

Бурханы урьдчилан тогтоолт, сонголтоос, мөн Бурханы нигүүлслээс болж байгаа; хэрвээ Бурхан үг хэлж, Өөрийн үгийг айлдаагүй бол та нарын нөхцөл байдал өнөөдрийнх шиг байж чадах уу? Тиймээс Бурханд бүх алдар, магтаал нь байх болтугай, учир нь энэ бүхэн Бурхан та нарыг өргөснөөс болж байгаа юм. Чи эдгээр зүйлийг бодох үедээ идэвхгүй хэвээр байж чадах уу? Хүч чадлаа нэмэгдүүлж чадахгүй хэвээр байх уу?

Өнөөдөр Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, цохилт, цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрч, түүнчлэн Бурханы даалгаврыг хүлээн зөвшөөрч чадаж байгаа чинь эрин үеүдээс өмнө Бурханаар урьдчилан тогтоогдсон, тиймээс чи гэсгээгдэх үедээ хэтэрхий их гутрах ёсгүй. Та нарт хийгдсэн ажлыг болон та нарт хайрласан ерөөлийг хэн ч булаан авч чадахгүй, мөн та нарт өгсөн бүхнийг хэн ч булаан авч чадахгүй. Шашны хүмүүсийг та нартай харьцуулах аргагүй. Та нар Библийг тийм ч сайн мэддэггүй, шашны онолоор зэвсэглээгүй боловч Бурхан та нарын дотор ажилласан учраас та нар эрин үеүдийн туршид байсан хэнээс ч илүү ихийг олж авсан—иймээс энэ нь та нарын хамгийн агуу ерөөл билээ. Үүнээс үүдэн та нар Бурханд өөрсдийгөө бүр ч их зориулж, бүр ч их үнэнч байх ёстой. Бурхан чамайг өргөсөн учраас чи хичээл чармайлтаа нэмэгдүүлэх ёстой бөгөөд Бурханы даалгаврыг хүлээн авахад биеийн хэмжээгээ бэлдэх ёстой. Чи Бурханы өгсөн байр сууринд бат зогсож, Бурханы ардуудын нэг болохоор зорьж, хаанчлалын сургалтыг хүлээн зөвшөөрч, Бурханаар авхуулж, эцэст нь Бурханы алдар суут гэрчлэл болох ёстой. Ийм шийдвэр чамд байгаа юу? Хэрвээ чамд тийм шийдвэр байгаа бол эцэстээ чи Бурханаар авхуулж, Бурханы алдар суут гэрчлэл болох нь гарцаагүй. Гол чухал даалгавар бол Бурханаар авхуулж, Бурханы алдар суут гэрчлэл болох явдал гэдгийг чи ойлгох ёстой. Энэ нь Бурханы хүсэл билээ.

Ариун Сүнсний өнөөгийн үг бол Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн бөгөөд энэ хугацаанд Ариун Сүнс хүнийг байнга гэгээрүүлдэг нь Ариун Сүнсний ажлын чиг хандлага юм. Тэгвэл Ариун Сүнсний өнөөгийн ажлын чиг хандлага юу вэ? Энэ нь, хүмүүсийг Бурханы өнөөгийн ажил руу, хэвийн сүнслэг амьдрал руу удирдах явдал юм. Хэвийн сүнслэг амьдралд орох оролтод хэд хэдэн алхам бий:

1. Эхлээд чи зүрх сэтгэлээ Бурханы үгэнд зориулах ёстой. Чи Бурханы урьдын үгийг эрэлхийлэх ёсгүй бөгөөд тэдгээрийг судалж, эсвэл өнөөдрийн үгтэй харьцуулах ёсгүй. Харин ч чи өөрийнхөө зүрх сэтгэлийг Бурханы өнөөгийн үгэнд бүрмөсөн зориулах ёстой. Өнгөрсөн үеийн Бурханы үг, сүнслэг номууд, эсвэл бусад номлолын тэмдэглэлүүдийг уншихыг хүсдэг бөгөөд Ариун Сүнсний

өнөөгийн үгийг дагадаггүй хүмүүс байвал тэд хамгийн тэнэг хүмүүс юм; Бурхан тийм хүмүүсийг жигшдэг. Хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа бол зүрх сэтгэлээ Бурханы өнөөгийн айлдваруудад бүрмөсөн зориул. Энэ бол чиний биелүүлэх ёстой эхний зүйл юм.

2. Чи Бурханы өнөөдөр хэлсэн үгийн суурин дээр залбирч, Бурханы үгэнд орж, Бурхантай ярилцаж, Бурханы өмнө шийдвэр гаргаж, ямар стандартыг биелүүлэхээр зорих гэж байгаагаа тодорхойлох ёстой.

3. Чи Ариун Сүнсний өнөөгийн ажлын суурин дээр үнэнд гүн гүнзгий орохоор эрэлхийлэх ёстой. Урьдын хуучирсан айлдвар болон онолуудтай бүү зууралд.

4. Чи Ариун Сүнсээр хөдөлгөгдөхөөр эрж хайж, Бурханы үгэнд орох ёстой.

5. Өнөөдөр Ариун Сүнсний явж буй замд орохоор эрэлхийлэх ёстой.

Чи яаж Ариун Сүнсээр хөдөлгүүлэхээр эрж хайдаг вэ? Гол чухал зүйл бол Бурханы өнөөгийн үгэн дотор амьдарч, Бурханы шаардлагад суурилан залбирах явдал юм. Ийм маягаар залбирахад Ариун Сүнс гарцаагүй чиний сэтгэлийг хөдөлгөнө. Хэрвээ чи Бурханы өнөөдөр хэлсэн үгэнд үндэслэн эрж хайдаггүй бол энэ нь үр дүнгүй. Чи залбирч, ингэж хэлэх ёстой: “Өө Бурхан минь! Би Таныг эсэргүүцдэг, бас Танд маш их өртэй; би маш дуулгаваргүй агаад Таныг хангалуун байлгаж хэзээ ч чаддаггүй. Өө Бурхан минь, Та намайг авраасай гэж би хүсэж байна, эцсээ хүртэл Танд үйлчлэл үзүүлэхийг хүсэж байна, Таны төлөө үхэхийг хүсэж байна. Та намайг шүүж, гэсгээдэг, гэхдээ надад ямар ч гомдол байхгүй; би Таныг эсэргүүцдэг ба үхвэл таарна, ингэснээр бүх хүн миний үхлээс Таны зөвт зан чанарыг харж болох юм.” Ийм маягаар зүрх сэтгэлийнхээ гүнээс залбирах үед чинь Бурхан чамайг сонсож, чамайг залж чиглүүлнэ; хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн үгийн суурин дээр залбирдаггүй бол Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөх боломжгүй. Хэрвээ чи Бурханы хүслийн дагуу, Бурханы өнөөдөр хийхийг хүсэж байгаа зүйлийн дагуу залбирдаг бол ингэж хэлнэ: “Өө Бурхан минь! Би Таны даалгаврыг хүлээн зөвшөөрч, Таны даалгаварт үнэнч байхыг хүсэж байна, хийж байгаа бүхнээ Бурханы ардуудын стандартад хүргэхийн тулд бүхий л амьдралаа Таны алдрын төлөө зориулахыг хүсэж байна. Та миний сэтгэлийг хөдөлгөх болтугай. Таны Сүнс намайг үргэлж гэгээрүүлж, миний хийдэг бүхнээр Сатаныг шившиглэж, эцэст нь Та намайг олж аваасай гэж хүсэж байна.” Хэрвээ чи Бурханы хүсэл дээр төвлөрөн ийм маягаар залбирвал Ариун Сүнс гарцаагүй чиний дотор ажиллана. Залбирлын чинь үг хэчнээн олон байх нь хамаагүй—Бурханы хүслийг ухаарсан уу, үгүй юу гэдэг чинь гол нь юм. Та нарт бүгдэд нь дараах туршлага байгаа байх:

Заримдаа цуглаан дээр залбирч байхад Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн оргилдоо хүрч, хүн бүрийн хүч чадлыг нэмэгдүүлдэг. Зарим хүн залбирах зуураа гашуунаар уйлан, нулимс асгаруулж, Бурханы өмнө харуусалд автдаг ба зарим хүн шийдвэрээ харуулж, тангараг өргөдөг. Тэр нь Ариун Сүнсний ажлаар хүрдэг үр дүн юм. Өнөөдөр бүх хүн Бурханы үгэнд зүрх сэтгэлээ зориулах нь хамгийн чухал. Урьд нь хэлэгдсэн үгэнд бүү төвлөр; хэрвээ чи өмнө нь болж өнгөрсөн зүйлтэй зууралдсаар байвал Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй. Энэ нь хэчнээн чухал болохыг чи харав уу?

Та нар Ариун Сүнсний өнөөгийн алхаж байгаа замыг мэдэх үү? Дээр дурдсан хэдэн зүйл бол өнөөдөр, бас ирээдүйд Ариун Сүнсний гүйцэлдүүлэх зүйл юм; тэдгээр нь Ариун Сүнсний явдаг зам бөгөөд хүний эрэлхийлэх учиртай оролт билээ. Амийн оролтдоо чи ядаж л зүрх сэтгэлээ Бурханы үгэнд зориулж, Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрч чаддаг байх ёстой; чиний зүрх сэтгэл Бурханыг хүсэн эрмэлзэх ёстой ба чи үнэний гүн гүнзгий оролтыг болон Бурханы шаардсан зорилгыг эрэлхийлэх ёстой. Чамд ийм хүч чадал байгаа бол сэтгэлийг чинь Бурхан хөдөлгөж, зүрх сэтгэл чинь Бурхан руу хандаж эхэлснийг энэ нь харуулдаг.

Амийн оролтын эхний алхам нь зүрх сэтгэлээ Бурханы үгэнд бүрэн зориулах явдал бөгөөд хоёр дахь алхам нь Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөхийг хүлээн зөвшөөрөх явдал юм. Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөхийг хүлээн зөвшөөрснөөр хүрэх үр дүн юу вэ? Энэ нь, илүү гүн гүнзгий үнэнийг хүсэн эрмэлзэж, эрж хайж, судалж шинжлэх чадвартай байх болон эерэг байдлаар Бурхантай хамтран ажиллах чадвартай байх явдал юм. Өнөөдөр чи Бурхантай хамтран ажилладаг, өөрөөр хэлбэл, эрж хайж, залбирч, Бурханы үгийг ярилцахдаа зорилготой байдаг ба Бурханы шаардлагад нийцүүлэн үүргээ биелүүлдэг—зөвхөн энэ л Бурхантай хамтран ажиллах явдал юм. Хэрвээ чи Бурханаар хийлгэх тухай л ярьдаг боловч өөрөө ямар ч үйлдэл хийдэггүй, залбирдаггүй, бас эрж хайдаггүй бол үүнийг яаж хамтын ажиллагаа гэж нэрлэж болох юм бэ? Хэрвээ чамд хүний хамтын ажиллагааны ямар ч ул мөр байхгүй, зорилго бүхий оролтын сургалт байхгүй бол үүнийг хамтран ажиллаж байна гэж хэлэхгүй. Зарим хүн: “Бүх зүйл Бурханы урьдчилан тогтоолтоос хамаардаг, энэ бүгдийг Бурхан Өөрөө хийдэг; хэрвээ Бурхан үүнийг хийгээгүй бол хүн яаж чадах юм бэ?” гэдэг. Бурханы ажил хэвийн, өчүүхэн төдий ч ер бусын зүйлгүй бөгөөд идэвхтэй эрж хайснаар чинь л дамжуулан Ариун Сүнс ажилладаг, учир нь Бурхан хүнийг хүчилдэггүй—чи Бурханд ажиллах боломж олгох ёстой ба эрж

хайдаггүй, эсвэл ордоггүй, өчүүхэн төдий ч хүсэн тэмүүлэх зүрх сэтгэлгүй бол Бурхан огт ажиллах боломжгүй. Бурханаар хөдөлгөгдөхийн тулд чи ямар замаар эрж хайж болох вэ? Залбирлаар, мөн Бурхантай ойр дотно болсноор. Гэхдээ хамгийн чухал нь, энэ нь Бурханы хэлсэн үгэнд үндэслэх ёстойг сана. Бурхан сэтгэлийг чинь байнга хөдөлгөх үед чи махан биед захирагддаггүй: Нөхөр, эхнэр, хүүхдүүд, мөнгө—тэдгээр нь бүгд чамайг дөнгөлөх чадваргүй бөгөөд чи үнэнийг эрэлхийлж, Бурханы өмнө амьдрахыг л хүснэ. Энэ үед чи эрх чөлөөт ертөнцөд амьдардаг хүн байх болно.

ӨӨРИЙНХ НЬ ЗҮРХ СЭТГЭЛИЙН ДАГУУХ ХҮМҮҮСИЙГ БУРХАН ТӨГС БОЛГОДОГ

Өөртэй нь хамтран ажиллахыг хичээдэг, Түүний ажлыг дуулгавартай дагаж чаддаг, Бурханы хэлдэг үгийг үнэн гэж итгэдэг, Бурханы шаардлагыг хэрэгжүүлж чаддаг хүмүүсээс бүрддэг тодорхой бүлэг хүмүүсийг Бурхан одоо олж авахыг хүсдэг; тэд бол зүрх сэтгэлдээ жинхэнэ ойлголттой, төгс болгуулж чадах хүмүүс бөгөөд төгс болгуулах замаар гарцаагүй алхаж чадна. Төгс болгуулж чадахгүй хүмүүс нь Бурханы ажлын талаар тодорхой ойлголтгүй, Бурханы үгийг идэж уудаггүй, Түүний үгийг анхаардаггүй, зүрх сэтгэлдээ Бурханыг гэх хайргүй хүмүүс юм. Бие махбодтой болсон Бурханд эргэлзэж, Түүний талаар үргэлж тээнэгэлзэн, үгийг нь хэзээ ч нухацтайгаар авч үзэлгүй, Түүнийг үргэлж мэхэлдэг хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг, Сатанд харьяалагддаг хүмүүс юм; ийм хүмүүсийг төгс болгох ямар ч аргагүй.

Хэрвээ чи төгс болгуулахыг хүсвэл эхлээд Бурханд таалагдах ёстой, учир нь Тэр Өөрт нь таалагддаг, Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүмүүсийг төгс болгодог билээ. Хэрэв чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхыг хүсвэл Түүний ажлыг дуулгавартай дагадаг зүрх сэтгэлтэй байж, үнэнийг эрэлхийлэхээр хичээж, бүх зүйл дээр Бурханы шинжилтийг хүлээн зөвшөөрөх ёстой. Чиний хийдэг бүхэн Бурханы шинжилтийг давсан уу? Санаа зорилго чинь зөв үү? Хэрэв санаа зорилго чинь зөв бол Бурхан чамайг сайшаана; хэрэв санаа зорилго чинь буруу бол зүрх сэтгэлийн чинь хайрладаг зүйл Бурхан биш, харин махан бие, Сатан юм гэдгийг харуулдаг. Тиймээс чи бүх зүйл дээр Бурханы шинжилтийг хүлээн зөвшөөрөх арга зам болгож залбирлыг ашиглах ёстой. Залбирах үед чинь Би хэдийгээр өмнө чинь биечлэн зогсож байхгүй ч Ариун Сүнс чамтай хамт байдаг бөгөөд Надад болон Бурханы Сүнсэнд хоёуланд нь

чи залбирч байгаа. Чи энэ махбодод яагаад итгэдэг вэ? Түүнд Бурханы Сүнс байдаг учраас чи итгэдэг. Энэ хүнд Бурханы Сүнс байхгүй байсан бол чи Түүнд итгэх байсан уу? Чи энэ хүнд итгэхдээ Бурханы Сүнсэнд итгэдэг. Чи энэ хүнээс эмээхдээ Бурханы Сүнснээс эмээдэг. Бурханы Сүнсэнд итгэх итгэл нь энэ хүнд итгэх итгэл бөгөөд энэ хүнд итгэх итгэл нь мөн Бурханы Сүнсэнд итгэх итгэл юм. Чи залбирах үедээ Бурханы Сүнс чамтай хамт байгааг, Бурхан чиний өмнө байгааг мэдэрдэг, тиймээс ч чи Түүний Сүнсэнд залбирдаг. Өнөөдөр ихэнх хүмүүс үйлдлээ Бурханы өмнө авчрахаас хэтэрхий их айдаг; чи Түүний махбодыг мэхэлж магадгүй ч Түүний Сүнсийг мэхэлж чадахгүй. Бурханы шинжилтийг тэсвэрлэж чадахгүй аливаа хэрэг явдал үнэнтэй таардаггүй бөгөөд үүнийг хаях хэрэгтэй; үүнээс өөрөөр хийх нь Бурханы эсрэг нүгэл үйлдэж байгаа хэрэг. Иймээс чи залбирах үедээ, ах эгч нартайгаа ярилцаж, нөхөрлөх үедээ, үүргээ гүйцэтгэж, ажил хэргээ явуулах үедээ зүрх сэтгэлээ цаг үргэлж Бурханы өмнө тавих ёстой. Үүргээ биелүүлэх үед чинь Бурхан чамтай хамт байдаг бөгөөд санаа зорилго чинь зөв, Бурханы гэрийн ажлын төлөө байгаа цагт хийдэг бүхнийг чинь Тэр хүлээн зөвшөөрнө; чи үүргээ биелүүлэхэд чин сэтгэлээсээ өөрийгөө зориулах хэрэгтэй. Залбирах үедээ зүрх сэтгэлд чинь Бурханыг гэсэн хайр байдаг, Бурханы халамж, хамгаалалт, шинжилтийг эрэлхийлдэг бол, хэрэв эдгээр зүйл санаа зорилго чинь бол чиний залбирал үр дүнтэй байна. Жишээлбэл, цуглаан дээр залбирах үедээ чи зүрх сэтгэлээ нээж, Бурханд залбиран, худал хуурмаг зүйл ярилгүйгээр зүрх сэтгэлдээ байгаа зүйлийг Түүнд хэлбэл залбирал чинь гарцаагүй үр дүнтэй болно. Хэрэв чи зүрх сэтгэлдээ Бурханыг үнэхээр хайрладаг бол “Тэнгэр, газарт болон бүх зүйлийн дунд байдаг Бурхан Танд би амлая: Таны Сүнс миний хийдэг бүхнийг шалгаж, намайг цаг үргэлж хамгаалж, халамжлан, хийдэг бүх зүйлээ Таны өмнө байлгах боломж олгох болтугай. Миний зүрх сэтгэл Таныг хайрлахаа боливол, эсвэл хэзээ нэгэн цагт Танаас урвавал намайг хатуу чангаар гэсгээж, хараа. Энэ амьдралд ч, дараагийн амьдралд ч намайг бүү өршөө!” хэмээн Бурханд тангарагла. Чи ийм тангараг өгч зүрхлэх үү? Хэрэв чи ингэж зүрхлэхгүй бол хулчгар бөгөөд өөрийгөө хайрласаар байгааг чинь энэ нь харуулдаг. Чамд ингэх шийдвэр байна уу? Хэрэв үнэхээр ингэж шийдсэн бол ийм тангараг өгөх хэрэгтэй. Хэрэв чамд ингэж тангараглах шийдвэр байгаа бол Бурхан шийдвэрийг чинь биелүүлнэ. Чамайг Бурханд тангараг өгөхөд Тэр сонсдог. Чиний залбирал, хэрэгжүүлэлтийг хэмжсэнээр Бурхан нүгэлтэй юу, эсвэл зөв шударга уу гэдгийг чинь тодорхойлдог. Энэ нь одоо та нарыг төгс болгох үйл явц бөгөөд хэрэв чамд төгс

болгуулах итгэл үнэхээр байвал хийдэг бүхнээ Бурханы өмнө авчирч, Түүний шинжилтийг хүлээж авах болно; хэрэв чи хэтэрхий тэрслүү зүйл хийх юм уу Бурханаас урвавал Тэр тангаргийг чинь биелүүлнэ, ингэснээр мөхөл ч бай, гэсгээлт ч бай, чамд юу ч тохиолдсон хамаагүй, энэ нь өөрийн чинь хийсэн хэрэг юм. Чи тангараг өгсөн тул үүнийгээ мөрдөх ёстой. Хэрэв чи тангараг өгдөг боловч мөрддөггүй бол мөхөх болно. Чинийх тангараг байсан болохоор Бурхан тангаргийг чинь биелүүлнэ. Зарим хүн залбирсныхаа дараа айж, “Бүх зүйл өнгөрлөө! Миний самуун амьдрах боломж үгүй боллоо; хорон муу зүйл хийх боломж үгүй боллоо; орчлон хорвоогийн хүсэлд ташуурах боломж үгүй боллоо!” хэмээн халагладаг. Энэ хүмүүс хорвоогийн юмс болон нүглийг хайрласаар байдаг бөгөөд мөхөх нь гарцаагүй.

Бурханд итгэгч байна гэдэг нь хийж буй бүхнээ Түүний өмнө авчирч, шинжүүлэх ёстой гэсэн үг юм. Хийж буй зүйлээ Бурханы Сүнсний өмнө авчирч болох боловч Бурханы махбодын өмнө авчирч болохгүй бол чи Түүний Сүнсээр шинжүүлж байгаагүйг харуулж байна. Бурханы Сүнс гэж хэн бэ? Бурхан гэрчлэл хийдэг хүн хэн бэ? Тэд нэг биш гэж үү? Ихэнх нь Тэднийг хоёр тусдаа оршихуй гэж үзэн, Бурханы Сүнс бол Бурханы л Сүнс, харин Бурхан гэрчлэл хийдэг хүн бол ердөө л нэг хүн гэж итгэдэг. Гэвч чи андуурсан бус уу? Энэ хүн хэний өмнөөс ажилладаг вэ? Бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй хүмүүст сүнслэг ойлголт байдаггүй. Бурханы Сүнс, Түүний махбод болсон бие хоёр нэг бөгөөд учир нь Бурханы Сүнс махбодод биеллээ олдог. Энэ хүн чамд базаахгүй хандвал Бурханы Сүнс эелдэг хандана гэж үү? Чи будилсан бус уу? Өнөөдөр Бурханы шинжихийг хүлээн авч чаддаггүй бүхэн Түүний сайшаалыг хүртэж чадахгүй бөгөөд бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй хүмүүс төгс болгуулж чадахгүй. Хийж байгаа бүхнээ хараад Бурханы өмнө авчирч болох эсэхийг үзээрэй. Хийж байгаа бүхнээ Бурханы өмнө авчирч чадахгүй бол энэ нь мууг үйлдэгч болохыг чинь харуулж байна. Мууг үйлдэгч төгс болгуулж чадах уу? Үйлдэл, санаа зорилго, хариу үйлдэл бүр гээд хийж буй бүхнээ Бурханы өмнө авчрах хэрэгтэй. Чиний залбирал, Бурхантай ойр дотно байдал, Бурханы үгийг хэрхэн идэж уудаг, ах эгч нартайгаа хийсэн нөхөрлөл, чуулган доторх амьдрал, түншлэл дэх үйлчлэл гээд өдөр тутмын сүнслэг амьдралаа хүртэл Бурханы өмнө авчирч шинжүүлэх хэрэгтэй. Ийм хэрэгжүүлэлт амиа өсгөхөд чинь тусална. Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрөх явц нь ариусах явц юм. Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрч чадах тусам улам их ариусаж, Бурханы хүсэлд улам их нийцсэнээрээ самуун явдалд татагдахгүй, зүрх сэтгэл чинь

Түүний өмнө амьдарна. Түүний шинжлэхийг хүлээн зөвшөөрөх тусам Сатан улам их шившиглэгдэж, махан биеэ хаях чадвар чинь улам нэмэгдэнэ. Тиймээс Бурханы шинжлэхийг хүлээн зөвшөөрөх нь хүмүүсийн дагах ёстой хэрэгжүүлэлтийн зам юм. Чи юу ч хийж байсан бай, ах эгч нартайгаа ярилцахдаа хүртэл үйлдлээ Бурханы өмнө авчирч, Түүнээр шинжүүлэхийг хичээж, Бурханыг Өөрийг нь дуулгавартай дагахаар зорьж болно. Энэ нь хэрэгжүүлдэг зүйлийг чинь хавьгүй илүү зөв болгоно. Чи хийж байгаа бүхнээ Бурханы өмнө авчирч, Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрөх л юм бол Бурханы өмнө амьдардаг нэгэн болж чадна.

Бурханы талаар ойлгодоггүй хүмүүс Бурханыг хэзээ ч бүрэн дуулгавартай дагаж чадахгүй. Ийм хүмүүс бол дуулгаваргүй байдлын хөвгүүд юм. Тэд хэтэрхий их санаатай, дотроо хэтэрхий их тэрслүү учраас Бурханаас холдож, Түүний шинжилтийг хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байдаг. Ийм хүмүүсийг төгс болгоход амаргүй. Зарим хүн Бурханы үгийг идэж уух болон хүлээн зөвшөөрөхдөө голж шилдэг. Тэд Бурханы үгээс өөрсдийнх нь үзэлд нийцдэг тодорхой хэсгийг хүлээн зөвшөөрөөд, нийцэхгүйг нь үл хэрэгсдэг. Энэ чинь Бурханы эсрэг хамгийн илэрхий тэрслэлт, эсэргүүцэл биш гэж үү? Хүн Бурханы талаар өчүүхэн ч ойлголт олж авалгүйгээр олон жил итгэж байгаа бол үл итгэгч юм. Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа хүмүүс бол Түүнийг ойлгохоор эрэлхийлдэг, Түүний үгийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэг хүмүүс юм. Тэд Бурханы өв болон ерөөлийг хүлээн авах хүмүүс бөгөөд хамгийн их ерөөгдсөн хүмүүс юм. Зүрх сэтгэлд нь Түүнд зориулсан орон зай үгүй хүмүүсийг Бурхан харааж, ийм хүмүүсийг гэсгээж, хаядаг. Чи Бурханыг хайрладаггүй бол Тэр чамайг хаяна, Миний хэлэхийг сонсдоггүй бол Бурханы Сүнс чамайг хаяна гэдгийг Би амлая. Итгэхгүй бол оролдоод үз! Өнөөдөр Би чамд хэрэгжүүлэлтийн замыг тодруулж өгье, гэвч хэрэгжүүлэх эсэхээ өөрөө шийд. Хэрэв чи үүнд итгэдэггүй бол, үүнийг хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнс дотор чинь ажилладаг эсэхийг өөрөө харах болно! Чи Бурханыг ойлгохоор эрэлхийлдэггүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй. Үгийг нь эрэлхийлж, эрхэмлэдэг хүмүүсийн дотор Бурхан ажилладаг. Бурханы үгийг эрхэмлэх тусам Ариун Сүнс чиний дотор илүү их ажиллана. Хүн Бурханы үгийг эрхэмлэх тусам Бурханаар төгс болгуулах боломж нь төдий чинээ нэмэгдэнэ. Өөрийг нь үнэхээр хайрладаг хүмүүсийг Бурхан төгс болгодог бөгөөд Өөрийнх нь өмнө зүрх сэтгэлээ тайван байлгадаг хүмүүсийг Тэр төгс болгодог. Бурханы бүх ажлыг эрхэмлэх, Бурханы гэгээрлийг эрхэмлэх, Бурханы хамт байгааг эрхэмлэх, Бурханы халамж, хамгаалалтыг

эрхэмлэх, Бурханы үг хэрхэн бодит байдал чинь болж, амийг чинь хангаж байгааг эрхэмлэх нь бүгд Бурханы зүрх сэтгэлтэй хамгийн сайн нийцдэг. Хэрвээ чи Бурханы ажлыг эрхэмлэдэг бол, өөрөөр хэлбэл, чам дээр хийсэн Түүний бүх ажлыг эрхэмлэдэг бол Тэр чамайг ерөөж, чиний бүх зүйлийг өсгөж үржүүлэх болно. Чи Бурханы үгийг эрхэмлэдэггүй бол Тэр чиний дотор ажиллахгүй, харин итгэлийн чинь төлөө өчүүхэн нигүүлсэл соёрхоно, эсвэл чамайг багахан эд баялаг, гэр бүлийг чинь багахан амар амгалан байдлаар ерөөнө. Чи Бурханы үгийг бодит байдлаа болгон, Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүний зүрх сэтгэлийн дагуу байж чаддаг байхаар хичээх ёстой. Ердөө л Түүний нигүүлслийг эдлэхийн төлөө мэрийх ёсгүй. Итгэгчдийн хувьд Бурханы ажлыг хүлээн авч, төгс болгуулж, Бурханы хүслийг биелүүлдэг хүмүүс болохоос илүү чухал зүйл үгүй. Энэ бол чиний эрэлхийлэх ёстой зорилго юм.

Нигүүлслийн эрин үед хүний эрэлхийлж байсан бүхэн одоо үеэ өнгөрөөсөн, учир нь одоо эрэл хайгуулын илүү өндөр стандарт гэж бий, эрэлхийлдэг зүйл илүү сүрлэг, илүү бодитой бөгөөд эрэлхийлж буй зүйл хүний дотоод хэрэгцээ шаардлагыг илүү сайн хангаж чадна. Бурхан өнгөрсөн эрин үеүдэд, өнөөдрийнх шигээ хүмүүс дээр ажиллаагүй; өнөөдрийнх шигээ хүмүүстэй ярилцаагүй; хүмүүст тавьдаг Түүний шаардлагууд ч өнөөдрийнх шиг өндөр байгаагүй. Бурхан одоо эдгээр зүйлийг та нарт хэлж байгаа нь Бурханы эцсийн санаа зорилго энэ хэсэг хүмүүс, та нар дээр төвлөрдгийг харуулж байна. Хэрэв чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж байгаа бол үүнийг гол зорилгоо болгон эрэлхийл. Ийш тийшээ гүйж байна уу, өөрийгөө зарлагадаж байна уу, чиг үүрэг биелүүлж байна уу, эсвэл Бурханы даалгаврыг хүлээж авсан уу гэдэг нь хамаагүй, зорилго нь үргэлж төгс болгуулж, Бурханы хүслийг биелүүлж, эдгээр зорилгод хүрэхийн төлөө байдаг. Хэрвээ хүн Бурханаар төгс болгуулахаар, эсвэл амь руу орохоор эрэлхийлдэггүй, харин бие махбодын амар амгалан, баяр хөөрийг л эрэлхийлдэг бол хамгийн сохор хүн юм. Амийн бодит байдлыг эрэлхийлдэггүй, харин зөвхөн ирэх ертөнц дэх үүрдийн амьдрал, энэ ертөнц дэх аюулгүй байдлыг л эрэлхийлдэг бол тэд хамгийн сохор хүмүүс юм. Тиймээс хийж буй бүхнээ Бурханаар төгс болгуулж, авхуулах зорилгоор хийх хэрэгтэй.

Хүмүүст Бурханы хийдэг ажил бол өөр өөр шаардлагад нь үндэслэн тэднийг хангах явдал юм. Хүний амь том байх тусмаа ихийг шаардаж, ихийг эрэлхийлдэг. Энэ үе шатанд чамд ямар ч эрэл хайгуул байдаггүй бол Ариун Сүнс чамайг орхисон гэдгийг энэ нь баталж байна. Амийг эрэлхийлдэг бүх

хүнийг Ариун Сүнс хэзээ ч хаяхгүй, ийм хүмүүс үргэлж эрэлхийлж, зүрх сэтгэлдээ үргэлж хүсэл тэмүүлэлтэй байдаг. Ийм хүмүүс байгаа байдалдаа хэзээ ч сэтгэл ханадаггүй. Ариун Сүнсний ажлын үе шат бүр чамд үр нөлөө үзүүлэхийг зорьдог боловч хэрэв чи өөртөө сэтгэл ханавал, чамд хэрэгцээ байхаа боливол, Ариун Сүнсний ажлыг хүлээн зөвшөөрөхөө боливол Тэр чамайг хаях болно. Хүмүүс өдөр бүр Бурханаар шинжүүлэх шаардлагатай; тэдэнд Бурханы элбэг дэлбэг хангалт өдөр бүр хэрэгтэй. Хүмүүс Бурханы үгийг өдөр бүр идэж уулгүйгээр байж чадах болов уу? Хэрэв хэн нэгэнд Бурханы үгийг хангалттай идэж ууж чадахгүй байгаа мэт санагдаж, үргэлж эрж хайж, Түүний үгээр өлсөж цангаж байвал Ариун Сүнс үргэлж дотор нь ажиллана. Хүн хүсэж эрмэлзэх тусам нөхөрлөлөөс нь илүү бодитой зүйлс гарч болно. Хүн үнэнийг эрчимтэйгээр эрж хайх тусам амийн өсөлтөд улам хурдан хүрч, Бурханы гэрийн арвин туршлагатай, чинээлэг оршин суугч болно.

БУРХАНД ҮНЭНЧ ЗҮРХ СЭТГЭЛЭЭР ДУУЛГАВАРТАЙ БАЙДАГ ХҮМҮҮСИЙГ БУРХАН ГАРЦААГҮЙ ОЛЖ АВНА

Ариун Сүнсний ажил өдрөөс өдөрт өөрчлөгдөж, алхам тутамдаа улам өндөрт дээшилж, маргаашийн илчлэл алхам алхмаар бүр ч өндөрт өгсөн, өнөөдрийнхөөс ч илүү өндөр болдог. Бурхан хүнийг төгс болгодог ажил нь ийм юм. Хүмүүс хөл нийлүүлэн алхаж чадахгүй бол хэдийд ч таягдан хаягдаж магадгүй. Хүмүүст дуулгавартай байх зүрх сэтгэл үгүй бол эцэст нь хүртэл дагаж чадахгүй. Урьдын эрин үе өнгөрчихсөн; энэ бол шинэ эрин үе. Шинэ эрин үед шинэ ажил хийгдэх ёстой. Ялангуяа хүмүүсийг төгс болгох сүүлчийн эрин үед Бурхан илүү шинэ ажлыг бүр ч хурдан гүйцэтгэнэ. Тийм учраас зүрх сэтгэлд нь дуулгавартай байдал байхгүй бол хүмүүст Бурханы мөрийг дагахад хэцүү байдаг. Бурхан ямар ч дүрэмд баригддаггүй, мөн Өөрийн ажлын аль ч шатыг хувиршгүй гэж үздэггүй. Харин ч Түүний хийдэг ажил хэзээд илүү шинэ, улам өндөр байдаг. Түүний ажил алхам бүрд улам бодитой болж, хүний бодит хэрэгцээнд улам бүр нийцдэг. Хүмүүс ийм ажлыг туулсныхаа дараа л зан чанарынхаа сүүлчийн өөрчлөлтөд хүрч чадна. Амийн тухай хүний мэдлэг улам өндөр түвшинд хүрдэг, иймээс Бурханы ажил ч мөн адил улам өндөр түвшинд хүрдэг. Хүн ийм маягаар л төгс болгуулж, Бурхан ашиглахад тохиромжтой болж чаддаг. Бурхан нэг талаар, хүний үзлийг няцааж, өөрчилж, нөгөө талаар, хүнийг

илүү өндөр, илүү бодитой байдал руу, Бурханд итгэх итгэлийн хамгийн өндөр түвшин рүү хөтлөхийн тулд ийм маягаар ажилладаг, тэгснээр Бурханы хүсэл эцэст нь биелж чадна. Дур зоргоороо тэрсэлдэг дуулгаваргүй уг чанартай хүмүүс, Бурханы хурдтай бөгөөд эрчтэй урагшлах ажлын энэ үе шатанд бүгдээрээ таягдан хаягдах болно; сайн дураараа дуулгавартай байдаг, дуртайяа өөрсдийгөө даруу болгодог хүмүүс л замын төгсгөл хүртэл урагшилж чадна. Энэ төрлийн ажилд хэрхэн захирагдахыг, мөн өөрийн үзлийг хэрхэн хаяхыг та нар бүгдээрээ сурах хэрэгтэй. Алхам бүрдээ хянуур байх хэрэгтэй. Хайнга байвал чи Ариун Сүнсэнд гологдож, Бурханы ажлыг үймүүлдэг нэгэн болох нь дамжиггүй. Ажлын энэ үе шатыг туулахаас өмнө хүний хуучны хууль, дүрэм тоогоо алдаж, хүн учраа олохоо больсон ба үүний уршгаар биеэ тоож, өөрийгөө мартсан. Эдгээр нь цөм Бурханы шинэ ажлыг хүлээж авахаас хүнийг хазаарлаж байдаг саад тотгор юм; тэдгээр нь Бурханы талаарх хүний мэдлэгт дайсагнаж байдаг. Хүмүүс зүрх сэтгэлдээ дуулгавартай биш, бас үнэнийг эгээрэн хүсдэг ч үгүй байх нь аюултай байдаг. Хэрвээ чи зөвхөн энгийн ажил болон үгэнд л захирагддаг, илүү гүн гүнзгий зүйлийг хүлээн авах чадваргүй бол чи хуучнаа баримталдаг, Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлж чадахгүй нэгэн юм. Бурханы хийдэг ажил эрин бүрд ялгаатай байдаг. Чи нэг үе шатанд асар их дуулгавартай байснаа дараагийн үед муу юм уу дуулгавартай байж чадахгүй байвал Бурхан чамайг орхих болно. Бурханыг энэ алхмаар явахад нь чи хөл нийлүүлэн явбал Түүнийг дараачийн алхмаар өгсөхөд үргэлжлүүлэн хөл нийлүүлэн явах ёстой. Гагцхүү тэгсэн цагт л чи Ариун Сүнсэнд дуулгавартай нэгэн байна. Нэгэнт чи Бурханд итгэдэг тул дуулгавартай байдалдаа тууштай хэвээр байх ёстой. Чи зүгээр л дураа хүрэхээр дуулгавартай байж, дургүйгээ хүрэхээр дуулгаваргүй байж болохгүй. Иймэрхүү маягийн дуулгавартай байдлыг Бурхан сайшаадаггүй. Миний нөхөрлөдөг шинэ ажилтай чи алхаа нийлүүлж чадахгүй, урьдын үгтэй зууралдсаар байвал аминд чинь яаж ахиц гарч чадах юм бэ? Бурханы ажил бол үгээрээ дамжуулан чамайг хангах явдал юм. Чи Түүний үгийг дуулгавартай дагаж, хүлээн авсан цагт Ариун Сүнс чам дээр гарцаагүй ажиллана. Ариун Сүнс яг л Миний ярьсны дагуу ажилладаг. Миний хэлснээр хий, тэгээд Ариун Сүнс даруй чам дээр ажиллана. Би та нарыг хараг гэж шинэ гэрэл гаргаж, та нарыг эдүгээ цагийн гэрэл рүү авчирдаг. Чамайг энэ гэрэл рүү алхах үед Ариун Сүнс чам дээр нэн даруй ажиллах болно. “Би зүгээр л Таны хэлсэн зүйлийг хийхгүй” гэж зарим хүн гөжүүдлэн хэлж магадгүй. Тэгэхэд нь Би чамд, одоо чи замын төгсгөлд ирж, хатаж хорчийгоод амьгүй

болжээ гэж хэлнэ. Тиймээс зан чанарынхаа өөрчлөлтийг туулах үедээ өнөөгийн гэрэлтэй хөл нийлүүлэн алхах нь хамгийн чухал юм. Ариун Сүнс Бурханы ашигладаг зарим хүн дээр ажиллаад зогсохгүй, мөн чуулганд ажилладаг. Тэр хэн дээр ч ажиллаж байж болно. Одоогоор Тэр чам дээр ажиллаж байж магадгүй бөгөөд чи энэ ажлыг туулна. Дараагийн цаг хугацаанд Тэр өөр хүн дээр ажиллаж болох бөгөөд тэр тохиолдолд чи яаравчлан дагах ёстой; өнөөгийн гэрлийг ойр дагах тусам амь чинь улам их өсөж чадна. Тухайн хүн ямар байх нь хамаагүй, Ариун Сүнс түүн дээр ажиллаж байгаа л бол чи дагах ёстой. Өөрийнхөө туршлагаар дамжуулан түүний туршлагыг мэдэр, тэгээд чи бүр ч өндөр зүйлсийг хүлээж авна. Ингэснээр чи илүү хурдан ахиц гаргана. Энэ бол хүний төгс болгуулах зам, амиа өсгөдөг арга зам юм. Чи Ариун Сүнсний ажилд дуулгавартай байснаар төгс болгуулах замд хүрдэг. Чамайг төгс болгохын тулд Бурхан ямар төрлийн хүнээр дамжуулж ажиллахыг чи мэдэхгүй, мөн ямар хүн, үйл явдал, эсвэл зүйлээр дамжуулан Тэр чамд юмсыг олж авч эсвэл харах боломж олгохыг ч мэдэхгүй. Хэрвээ чи энэ зөв замд алхан орж чадвал чамд Бурханаар төгс болгуулах асар их найдлага байгааг энэ нь харуулдаг. Хэрвээ чи тэгж чадахгүй бол ирээдүй чинь баргар, гэрэлгүй гэдгийг энэ нь харуулдаг. Зөв замд ормогцоо чи бүх зүйл дээр илчлэл олж авна. Ариун Сүнс бусдад юу илчилдэг байх нь хамаагүй, хэрвээ чи тэдний мэдлэгт үндэслэн аливааг өөрөө туулж мэдэрвэл энэ туршлага амийн чинь нэг хэсэг болох ба энэ туршлагаасаа бусдыг хангаж чадна. Үгийг тоть шиг давтаж бусдыг хангадаг хүмүүс бол ямар ч туршлагагүй хүмүүс юм; чи өөрийн бодит туршлага, мэдлэгийн тухай ярьж эхлэхээсээ өмнө бусдын гэгээрэл, гэрэлтүүлэлтээр дамжуулан хэрэгжүүлэлтийн замыг олж сурах ёстой. Энэ нь чиний өөрийн аминд илүү их ашиг тустай байх болно. Чи Бурханаас ирдэг бүхнийг дуулгавартай дагаж ийм маягаар туршлагажих хэрэгтэй. Чи бүх зүйл дээр Бурханы хүслийг эрж хайж, бүх зүйлээс хичээл сурах хэрэгтэй, тэгвэл чиний амь өснө. Ийм хэрэгжүүлэлт нь хамгийн хурдан ахиц гаргадаг.

Ариун Сүнс бодит туршлагаар чинь дамжуулан чамайг гэгээрүүлж, итгэлээр чинь дамжуулан төгс болгодог. Чи төгс болгуулахыг үнэхээр хүсэж байна уу? Хэрвээ чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж байгаа бол махан биеэ хаях зоригтой, Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаг, мөн идэвхгүй эсвэл сул дорой биш байх болно. Чи Бурханаас ирдэг юм бүхэнд дуулгавартай байж чаддаг, ил, далд хийдэг бүх үйлдэл чинь Бурханд харуулахуйц байх болно. Хэрвээ чи үнэнч шударга бөгөөд бүх зүйл дээр үнэнийг хэрэгжүүлдэг бол төгс болгуулна. Бусдын

нүүрэн дээр нэг янзаар, ар хударгаар нь өөр янзаар авирладаг зальжин хүмүүс төгс болгуулах хүсэлгүй байдаг. Тэд бүгдээрээ мөхөл болон сүйрлийн хүүхдүүд билээ; тэд Бурханд биш, харин Сатанд харьяалагддаг. Тэд бол Бурханы сонгодог төрлийн хүн биш! Хэрвээ чиний үйлдэл, зан авир Бурханы өмнө үзүүлж, Бурханы Сүнс шинжилж болохооргүй бол энэ нь чамд асуудал байгаагийн баталгаа юм. Чи Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авч, зан чанарынхаа өөрчлөлтөд санаа тавьсан цагт л төгс болгуулах замд хөл тавьж чадна. Бурханаар төгс болгуулж, Бурханы хүслийг гүйцэтгэхийг үнэхээр хүсэж байгаа бол гомдлын ганц ч үг ган хийхгүй, Бурханы ажлыг үнэлэх буюу шүүж зүрхлэхгүйгээр Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах хэрэгтэй. Эдгээр нь Бурханаар төгс болгуулах наад захын шаардлагууд юм. Бурханаар төгс болгуулахаар эрж хайдаг хүмүүсээс шаарддаг хамгийн чухал шаардлага бол бүх зүйлийг Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээр үйлдэх юм. “Бурханыг хайрлах зүрх сэтгэлээр үйлдэх” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь чиний бүх үйлдэл, зан авир Бурханы өмнө үзүүлж болохуйц байна гэсэн үг. Зөв санаа зорилготой учраас үйлдэл чинь зөв ч бай, буруу ч бай, тэрийгээ Бурханд юм уу ах, эгч нартаа харуулахаас айхгүй байж; чи Бурханы өмнө тангараг өргөж зүрхэлдэг. Чи Бурханаар шинжүүлэхийн тулд санаа зорилго, бодол, санаа болгоноо Түүний өмнө үзүүлэх ёстой; ийм маягаар хэрэгжүүлж, орох юм бол чиний амийн ахиц дэвшил хурдан байх болно.

Чи Бурханд итгэдэг учраас Бурханы бүх үг, Түүний бүх ажилд итгэлээ өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, чи Бурханд итгэдэг учраас Түүнийг дуулгавартай дагах ёстой. Хэрвээ чи ингэж чадахгүй бол Бурханд итгэдэг эсэх чинь хамаагүй. Бурханд олон жил итгэсэн атлаа Түүнийг хэзээ ч дуулгавартай дагаагүй, Түүний бүх үгийг хүлээн аваагүй, харин ч чамд захирагдаж, чиний үзлийн дагуу үйлдэхийг Бурханаас шаарддаг бол чи хамгийн тэрслүү бөгөөд үл итгэгч мөн. Хүний үзэлтэй нийцдэггүй Бурханы ажил болон үгийг ийм хүмүүс яаж дуулгавартай дагаж чадах юм бэ? Хамгийн тэрслүү хүн бол Бурханаас санаатайгаар зөрж, эсэргүүцдэг нэгэн юм. Тэд бол Бурханы дайсан, антихрист мөн. Ийм хүмүүс Бурханы шинэ ажилд үргэлж дайсагнасан хандлагатай байдаг, захирагдах өчүүхэн ч дур сонирхол хэзээ ч байгаагүй бөгөөд дуртайяа захирагдаж, өөрийгөө даруу болгосон удаа огт байхгүй. Тэд бусдын өмнө өөрсдийгөө өргөмжилж, хэнд ч хэзээ ч захирагддаггүй. Бурханы өмнө тэд үг номлоход хамгийн шилдэг нь бөгөөд бусад дээр ажиллахдаа хамгийн чадамгай гэж өөрсдийгөө үздэг. Тэд эзэмшсэн “эрдэнэсээ” хэзээ ч хаядаггүй, харин

тэдгээрийг шүтэн мөргөх, бусдад номлох гэр бүлийн удам дамжсан эд зүйл мэт үздэг ба өөрсдийг нь шүтдэг тэр мунхгуудад сургаал айлдахдаа тэдгээрийг ашигладаг. Чуулганд үнэндээ иймэрхүү хэдэн хүн байдаг. Тэднийг үеэс үед Бурханы гэрт түр оршин суудаг “мохошгүй баатрууд” гэж хэлж болох юм. Тэд үг (хоосон сургаал) номлохыг өөрсдийн хамгийн эрхэм үүрэг болгодог. Тэд “ариун агаад халдашгүй дархан” үүргээ жилээс жилд, үеэс үед идэвхтэй хэрэгжүүлж явдаг. Тэдэнд хэн ч хүрч зүрхэлдэггүй, ганц ч хүн тэднийг илт зэмлэж зүрхэлдэггүй. Эрин үеэс эрин үед тэд эрээгүй аашлан бусдыг эзэрхэж, Бурханы гэрт “хаан” болдог. Энэ сүрэг чөтгөр гар нийлэн, Миний ажлыг нураах гэж оролддог; энэ амьд диаволууд Миний нүдний өмнө оршин тогтнохыг Би хэрхэн зөвшөөрч чадах билээ? Хагас дутуу дуулгавартай хүмүүс ч эцсийг нь хүртэл үргэлжлүүлж чаддаггүй байхад зүрх сэтгэлдээ өчүүхэн төдий ч дуулгавартай байдалгүй эдгээр эзэрхэг этгээд бүр ч чадахгүй! Бурханы ажлыг хүн олж авахад хялбар биш. Хүмүүс хамаг хүч чадлаа хэрэглээд ч жаахан хэсгийг л олж авч, эцэстээ төгс болгуулж чадна. Тэгэхээр Бурханы ажлыг сүйрүүлэх гэж оролддог тэргүүн тэнгэрэлчийн үр удмын тухайд ямар вэ? Бурханаар авхуулах найдвар тэдэнд бүр ч бага байх бус уу? Байлдан дагуулах ажил хийх Миний зорилго бол гагцхүү байлдан дагуулалтын төлөө байлдан дагуулах бус, харин зөв шударга байдал ба зөв шударга бус байдлыг илчлэх, хүнийг шийтгэх нотолгоо олж авах, хорон мууг яллах, түүнчлэн дуртайяа дуулгавартай дагадаг хүмүүсийг төгс болгохын төлөө байлдан дагуулах явдал билээ. Эцэстээ бүгд төрлийнхөө дагуу ангилагдах бөгөөд төгс болгуулдаг хүмүүсийн бодол, санаа нь ч дуулгавартай байдлаар дүүрдэг. Энэ нь эцэстээ гүйцэлдэх ёстой ажил юм. Харин үйлдэл болгон нь тэрслүү хүмүүс шийтгүүлж, мөнхийн хараалын объект, галд шатаагдахаар хаягдах болно. Тэр цаг ирэхэд өнгөрсөн эрин үеийн “агуу агаад мохошгүй баатрууд” хамгийн адгийн, хамгийн их адлагдсан “үхээнц, сул дорой хулчгарууд” болно. Зөвхөн энэ л Бурханы зөвт байдлын бүх талыг, хүний халдаж чадахгүй Түүний зан чанарыг харуулж чадна. Зөвхөн энэ л Миний зүрх сэтгэл дэх үзэн ядалтыг намдааж чадна. Энэ бүхэн үндэслэлтэй гэдэгтэй та нар санал нийлэхгүй гэж үү?

Ариун Сүнсний ажлыг туулдаг хүн бүр амь олж авч чаддаггүй, энэ урсгалд буй хүмүүс ч бас амь олж авч чаддаггүй. Амь бол бүх хүний хуваалцдаг нийтийн өмч биш бөгөөд зан чанарын өөрчлөлт нь хүн бүхний хялбар хүрдэг зүйл биш билээ. Бурханы ажилд захирагдах нь бодитой байх ёстой бөгөөд амьдран харуулдаг байх ёстой. Дан ганц өнгөн дээрээ захирагдаад Бурханы сайшаалыг

хүртэж чадахгүй бөгөөд зан чанараа өөрчлөх гэж эрж хайлгүйгээр Бурханы үгийн өнгөц талуудыг дуулгавартай дагах төдий байх нь Бурханы зүрх сэтгэлийн дагуу байх биш юм. Бурханд дуулгавартай байх болон Бурханы ажилд захирагдах нь яг адилхан юм. Бурханд л захирагдаад, Түүний ажилд захирагддаггүй хүмүүсийг дуулгавартайд тооцож болохгүй, үнэнээсээ захирагддаггүй атлаа гаднаа зулгуйдан зусарддаг хүмүүсийг бүр ч тооцож болохгүй. Бурханд үнэнээсээ захирагддаг хүмүүс бүгдээрээ ажлаас нь хүртэж, Бурханы зан чанар болон ажлын талаарх ойлголтод хүрдэг. Зөвхөн ийм л хүмүүс Бурханд үнэхээр захирагддаг. Ийм хүмүүс шинэ ажлаас шинэ мэдлэг олж авч, мөн үүнээс шинэ өөрчлөлтийг туулж чаддаг. Зөвхөн ийм хүмүүсийг л Бурхан сайшаадаг; ийм хүмүүс л төгс болгуулдаг, зан чанараа өөрчилсөн хүмүүс билээ. Бурханы сайшаадаг хүмүүс нь Бурханд, түүнчлэн Түүний үг болон ажилд баяртайяа захирагддаг хүмүүс юм. Зөвхөн ийм хүмүүс л зөв; ийм хүмүүс л Бурханыг чин сэтгэлээсээ хүсэж, Бурханыг чин сэтгэлээсээ эрж хайдаг. Аман дээрээ л Бурханд итгэдгээ ярихаас биш, мөн чанартаа Түүнийг хараадаг хүмүүсийн тухайд гэвэл, тэд нар бол баг зүүж, могойн хор агуулсан, хамгийн хар санаатай хүмүүс юм. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ адгийн амьтдын бузар багийг хуу татаж хаяна. Энэ өнөөдөр хийгдэж буй ажил бус уу? Хорон муу хүмүүс үргэлж хорон муу байх бөгөөд шийтгэлийн өдрөөс хэзээ ч зугтахгүй. Сайн хүмүүс ямагт сайн байх бөгөөд Бурханы ажил төгсгөлдөө ирэхэд илчлэгдэнэ. Хорон муу хүмүүсийн нэг нь ч зөв шударга гэж тооцогдохгүй, зөв шударга хүмүүсийн нэг нь ч хорон муу гэж тооцогдохгүй. Ямар ч хүн хилсээр яллагдан зогсохыг Би зөвшөөрнө гэж үү?

Амь чинь ахиж дэвшихийн хэрээр чи үргэлж шинэ оролттой, илүү өндөр, шинэ мэдлэг ухаантай байх ёстой ба энэ нь алхам бүрд гүнзгийрч байдаг. Энэ нь бүх хүний орох ёстой зүйл юм. Ярилцсанаар, сургаал сонссоноор, Бурханы үгийг уншсанаар, эсвэл тодорхой хэрэг явдлыг зохицуулснаар чи шинэ мэдлэг ухаан, шинэ гэгээрэл олж авч, хуучны дүрмээр, хуучин цагт амьдрахгүй, үргэлж шинэ гэрэлд амьдрах ба Бурханы үгээс гажихгүй. Үүнийг зөв замд орох гэж хэлдэг. Аль нэг өнгөцхөн түвшинд төлөөс төлөөд нэмэргүй. Бурханы үг өдрөөс өдөрт улам өндөр хүрээнд орж өдөр бүр шинэ зүйлс гарч ирдэг. Хүн ч бас өдөр бүр шинэ оролт хийх ёстой. Бурхан ярингаа хэлсэн бүхнээ биелүүлдэг, чи хөл нийлүүлж чадахгүй бол ард хоцорно. Чи залбиралдаа илүү гүн орох ёстой; Бурханы үгийг идэж, уухаа тасалдуулж болохгүй. Хүлээн авдаг гэгээрэл, гэрэлтүүлэлтээ гүнзгийрүүл, тэгвэл үзэл, төсөөлөл чинь аажмаар багасах ёстой. Чи шүүмжээ сайжруулах ёстой, чамд юу ч тулгарсан бай, энэ талаар өөрийн

гэсэн бодол, үзэл бодолтой байх ёстой. Сүнсэн дэх зарим зүйлийг ойлгосноор чи гадаад зүйлсийн талаар мэдэж авч, аливаа асуудлын мөн чанарыг ухаж ойлгох ёстой. Хэрвээ чи эдгээрээр зэвсэглээгүй бол чуулганыг яаж удирдаж чадах юм бэ? Хэрвээ чи ямар ч бодит байдал, хэрэгжүүлэлтийн замгүйгээр зөвхөн бичиг үсэг, хоосон сургаалын талаар ярьдаг бол хэсэгхэн хугацаанд л хийж дөнгөнө. Шинэ итгэгчдэд ярихад энэ нь бага зэрэг боломжийн байж магадгүй боловч хэсэг хугацааны дараа шинэ итгэгчид зарим нэг бодит туршлагатай болох үед чи тэднийг хангаж чадахаа болино. Тэгэхээр чи Бурханаар ашиглуулахад яаж тохирох юм бэ? Шинэ гэгээрэлгүйгээр чи ажиллаж чадахгүй. Шинэ гэгээрэлгүй хүмүүс нь яаж туршлагажихаа мэддэггүй хүмүүс бөгөөд ийм хүмүүс хэзээ ч шинэ мэдлэг, шинэ туршлага олж авдаггүй. Мөн амийг хангах асуудлын тухайд гэвэл, тэд өөрсдийн үүргийг хэзээ ч гүйцэтгэж чадахгүй, бас Бурхан ашиглахад тохиромжтой болж ч чадахгүй. Ийм төрлийн хүн бол ямар ч хэрэггүй, гологдол төдий юм. Үнэндээ ийм хүмүүс ажил дахь үүргээ огт гүйцэтгэх чадваргүй, бүгд ямар ч хэрэггүй амьтад байдаг. Тэд үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаад зогсохгүй, үнэндээ чуулганд ихээхэн хэрэггүй дарамт учруулдаг. Энэ “эрхэм өвгөдийг” яаравчлан чуулганаас яв, тэгвэл бусад хүн чамайг харах хэрэггүй болно гэж Би шавдуулдаг. Ийм хүмүүс шинэ ажлын талаар ямар ч ойлголтгүй боловч тоймгүй их үзлээр дүүрэн байдаг. Тэд чуулганд ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй; харин ч хутган үймүүлж, газар сайгүй сөрөг байдлыг түгээж, тэр ч байтугай элдэв төрлийн буруу хэрэг хийж, чуулганд үймээн тарьж, тэгснээр ялган таних чадвар дутмаг хүмүүсийг төөрөлдүүлж, будилуулдаг. Энэ амьд диаволууд, энэ ёрын муу сүнснүүд чуулганаас аль болох хурдан явах ёстой, чамаас болж чуулган сүйдэх вий. Чи өнөөдрийн ажлаас айдаггүй байж болно, гэхдээ маргаашийн зөвт шийтгэлээс айхгүй байна гэж үү? Чуулганд бусдыг сорон мөлждөг маш олон хүн, бас Бурханы хэвийн ажилд саад хийх гэж оролддог асар олон чоно бий. Эдгээр нь бүгдээрээ чөтгөрийн хааны явуулсан чөтгөрүүд, мэдлэггүй хургануудыг залгих гэж оролддог хэрцгий чононууд юм. Эдгээр хүн гэгчийг хөөн зайлуулахгүй бол тэд чуулган дахь шимэгч хорхой, тахил цөлмөдөг хивэн хорхой болно. Энэ жигшмээр, мунхаг, адгийн, ой гутам өт хорхойнууд шийтгэгдэх өдөр эрт орой хэзээ нэг цагт ирэх л болно!

ХААНЧЛАЛЫН ЭРИН ҮЕ БОЛ ҮГИЙН ЭРИН ҮЕ ЮМ

Хаанчлалын эрин үед Бурхан үг ашиглан шинэ эрин үеийг эхлүүлж, Өөрийн ажилладаг арга барилыг өөрчилж, бүхий л эрин үеийн ажлыг хийдэг. Энэ нь Үгийн эрин үед Бурханы ажилладаг зарчим билээ. Тэрээр өөр өөр өнцгөөс ярихын тулд махбод болсон, ингэснээр хүн Үг махбодоор илэрсэн Бурханыг үнэхээр харж, Түүний мэргэн ухаан, гайхалтай байдлыг нүдээр харж чадах байв. Хүнийг байлдан дагуулж, төгс болгож, таягдах зорилгод илүү сайн хүрэхийн тулд ийм ажил хийгддэг ба энэ нь Үгийн эрин үед ажиллахдаа үг ашиглахын жинхэнэ утга учир юм. Эдгээр үгээр дамжуулан хүмүүс Бурханы ажил, Бурханы зан чанар, хүний мөн чанар болон хүн юунд орох учиртайг мэдэж авдаг. Үгийн эрин үед Бурханы хийхийг хүсдэг ажил үгээр дамжуулан бүхэлдээ биелдэг. Эдгээр үгээр хүмүүсийг илчилж, таягдан хаяж, шалгадаг. Хүмүүс Бурханы үгийг харж, эдгээр үгийг сонсож, эдгээр үгийн оршин тогтнолыг танин мэдсэн. Үүний үр дүнд тэд Бурханы оршин тогтнол, Бурханы бүхнийг чадагч байдал, мэргэн ухаан, мөн түүнчлэн хүнийг гэх Бурханы хайр, хүнийг аврах Түүний хүсэлд итгэх болсон. “Үг” хэмээх үг энгийн, жирийн байж болох ч бие махбодтой болсон Бурханы амнаас гардаг үг орчлон ертөнцийг донсолгож, хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчилж, тэдний үзэл, хуучин зан чанарыг өөрчилж, бүхий л дэлхий ертөнцийн харагддаг байсан байдлыг өөрчилдөг. Эрин үеүдийн туршид өнөөдрийн Бурхан л ийм маягаар ажилласан бөгөөд зөвхөн Тэр л ийнхүү ярьж, хүнийг ингэж авардаг. Энэ мөчөөс эхлээд хүн Бурханы үгийн удирдамж дор амьдарч, Түүний үгээр хариулуулж, хангагддаг. Хүмүүс Бурханы үгийн ертөнцөд, Бурханы үгийн хараал болон ерөөл дотор амьдардаг бөгөөд Түүний үгийн шүүлт, гэсгээлт дор амьдарч эхэлсэн хүмүүс бүр ч олон бий. Эдгээр үг болон энэ ажил бүгд хүний авралын төлөө, Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө, хуучин дэлхий ертөнцийн анхдагч төрхийг өөрчлөхийн төлөө байдаг. Бурхан үг ашиглан дэлхийг бүтээсэн, орчлон ертөнц дахины хүмүүсийг үг ашиглан удирддаг бөгөөд тэднийг үгээр байлдан дагуулж, авардаг. Эцэст нь Тэр бүхий л хуучин ертөнцийг төгсгөхийн тулд үг ашиглаж, улмаар удирдлагын төлөвлөгөөгөө бүхэлд нь гүйцэлдүүлнэ. Хаанчлалын эрин үеийн туршид Өөрийн ажлыг хийж, ажлынхаа үр дүнд хүрэхийн тулд Бурхан үг ашигладаг. Тэрээр гайхамшиг болон хүчит үйлс үзүүлдэггүй, харин ердөө үгээр дамжуулан ажлаа хийдэг. Эдгээр үгээс болж хүн тэжээгдэн хангагдаж, мэдлэг болон жинхэнэ туршлага олж авдаг. Үгийн эрин үед хүн үнэхээр гойд

их ерөөгдсөн. Хүн бие махбодын ямар ч шаналал амсдаггүй ба зүгээр л Бурханы үгийн элбэг дэлбэг хангалтыг эдэлдэг; тэр сохроор эрж хайж, сохроор бэдрэх шаардлагагүйгээр тайвнаар Бурханы илрэлтийг харж, Өөрийнхөө амаар ярихыг нь сонсож, Түүний хангадаг зүйлийг хүлээн авч, ажлаа биечлэн хийж байгааг нь хардаг. Эдгээр нь өмнөх эрин үеүдийн хүмүүсийн эдэлж чадаагүй зүйлс, хэзээ ч хүртэж байгаагүй ерөөл юм.

Бурхан хүнийг бүрэн төгс болгохоор шийдсэн бөгөөд Тэр ямар өнцгөөс ярих нь хамаагүй, бүгд хүмүүсийг төгс болгохын төлөө байдаг. Сүнсний өнцгөөс ярьсан үгийг хүмүүс ойлгоход хэцүү байдаг; тэд хэрэгжүүлэлтийн замыг олох аргагүй байдаг, учир нь тэдний ойлгох чадвар хязгаарлагдмал. Бурханы ажил өөр өөр үр дүнд хүрдэг бөгөөд ажлын алхам бүрийг хийхдээ Тэр Өөрийн гэсэн зорилготой байдаг. Түүнчлэн, Тэрээр өөр өөр өнцгөөс ярих шаардлагатай, учир нь ингэснээр л хүнийг төгс болгож чадна. Хэрвээ Тэр зөвхөн Сүнсний өнцгөөс ярьдаг байсан бол Бурханы ажлын энэ үе шатыг гүйцэлдүүлэх аргагүй байх байлаа. Түүний ярианы өнгөнөөс энэ бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгохоор шийдсэнийг нь чи харж болно. Тэгвэл, төгс болгуулахыг хүсдэг хүн нэг бүрийн эхний алхам нь юу байх ёстой вэ? Юун түрүүнд, Бурханы ажлыг мэдэх ёстой. Өнөөдөр, Бурханы ажилд шинэ арга барил нэвтэрсэн; эрин үе шилжиж, Бурханы ажлын арга барил ч өөрчлөгдсөн ба Бурханы үг хэлдэг арга барил өөр болсон. Өнөөдөр Түүний ажлын арга барил өөрчлөгдөөд зогсоогүй, эрин үе ч бас өөрчлөгдсөн. Одоо үе бол Хаанчлалын эрин үе. Түүнчлэн энэ нь Бурханыг хайрлах эрин үе юм. Мөн энэ бол Мянгын жилийн хаанчлалын эрин үеийн урьтал—бас Үгийн эрин үе бөгөөд хүнийг төгс болгохын тулд Бурхан олон янзын арга барилаар ярьж, хүнийг хангахын тулд өөр өөр өнцгөөс ярьдаг. Мянгын жилийн хаанчлалын эрин үед ормогц хүнийг төгс болгохын тулд Бурхан үг ашиглаж эхлэн, хүнийг амийн бодит байдалд оруулж, зөв зам руу хөтөлнө. Хүн Бурханы ажлын маш олон алхмыг туулаад Бурханы ажил өөрчлөгдөхгүй хэвээр үлддэггүй, харин тасралтгүй өөрчлөгдөж, гүнзгийрч байгаа гэдгийг харсан юм. Хүмүүс үүнийг маш удаан хугацаанд туулсны дараа уг ажил удаа дараа хувирч, ахин дахин өөрчлөгдсөн. Гэхдээ энэ нь хэчнээн ч их өөрчлөгдсөн бай, хүмүүст аврал авчрах Бурханы зорилгоос хэзээ ч хазайдаггүй. Арван мянган өөрчлөлт тууллаа ч гэсэн, анхдагч зорилгоосоо хэзээ ч хазайдаггүй. Бурханы ажлын арга барил яаж ч өөрчлөгдлөө гэсэн, энэхүү ажил үнэнээс юм уу амиас хэзээ ч холддоггүй. Ажиллах арга барилын өөрчлөлт нь ердөө ажлын хэлбэр болон Бурханы ярих өнцгийн өөрчлөлттэй хамаатай байдаг; Бурханы ажлын гол

зорилго огт өөрчлөгддөггүй. Бурханы хоолойны өнгө болон ажлын арга барил дахь өөрчлөлт нь үр дүнд хүрэхийн тулд хийгддэг. Дуу хоолойн өнгөний өөрчлөлт нь ажлын ар дахь зорилго юм уу зарчим өөрчлөгдсөн гэсэн үг биш. Хүмүүс голчлон амийг эрж хайхын тулд л Бурханд итгэдэг; хэрвээ чи Бурханд итгэдэг атлаа амийг эрж хайдаггүй, эсвэл үнэнийг юм уу Бурханы талаарх мэдлэгийг эрэлхийлдэггүй бол энэ нь Бурханд итгэх итгэл биш! Хаан болохын тулд хаанчлалд орохоор эрэлхийлсээр байх нь бодитой юу? Амийг эрж хайснаар Бурханыг гэх жинхэнэ хайранд хүрэх нь л бодит байдал; үнэнийг эрж хайж, хэрэгжүүлэх нь бүгд бодит байдал билээ. Бурханы үгийг уншиж, эдгээр үгийг туулснаар чи бодит туршлагаараа Бурханы тухай мэдлэгийг мэдэж авна, үнэхээр эрэлхийлэх гэдэг нь энэ юм.

Одоо бол Хаанчлалын эрин үе. Энэхүү шинэ эрин үед орсон эсэх чинь Бурханы үгийн бодит байдалд орсон эсэхээр чинь, мөн Түүний үг чиний амь-бодит байдал болсон эсэхээс хамаардаг. Бурханы үг хүн бүрд мэдэгддэг болохоор эцэстээ бүх хүн үгийн ертөнцөд амьдарч, Бурханы үг хүн бүрийг дотроос нь гэгээрүүлж, гэрэлтүүлнэ. Хэрвээ чи энэ хугацаанд Бурханы үгийг уншихдаа хайхрамжгүй байж, Түүний үгийг огт сонирхдоггүй бол байр байдал чинь буруу байгааг энэ нь харуулдаг. Хэрвээ чи Үгийн эрин үед орж чадахгүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй; хэрвээ чи энэ эрин үед орсон бол Тэр Өөрийн ажлыг хийнэ. Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд чи Үгийн эрин үеийн эхлэлд юу хийж болох вэ? Энэ эрин үед Бурхан дараах баримтыг та нарын дунд гүйцэлдүүлнэ: хүн бүр Бурханы үгийг амьдран харуулаад, үнэнийг хэрэгжүүлж чаддаг байж, Бурханыг чин сэтгэлээсээ хайрлана; бүх хүн Бурханы үгийг үндэс суурь, бодит байдлаа болгон ашиглаж, Бурханыг хүндлэх зүрх сэтгэлтэй байна; Бурханы үгийг хэрэгжүүлснээр хүн Бурхантай хамт хааны эрх мэдлийг эзэмшинэ. Энэ бол Бурханы биелүүлэх ажил юм. Чи Бурханы үгийг уншихгүй байж чадах уу? Өнөөдөр, Бурханы үгийг уншихгүйгээр ганц, хоёр хонож ч чадахгүй мэт санадаг олон хүн бий. Тэд Түүний үгийг өдөр бүр унших хэрэгтэй байдаг бөгөөд цаг зав гарахгүй бол Түүний үгийг сонсох нь хангалттай байдаг. Энэ бол хүмүүст Ариун Сүнсний өгдөг мэдрэмж бөгөөд тэдний зүрх сэтгэлийг хөдөлгөж эхэлдэг Түүний арга зам юм. Өөрөөр хэлбэл, Тэр хүмүүсийг үгээр захирдаг, ингэснээр тэд Бурханы үгийн бодит байдалд орж чаддаг. Хэрвээ Бурханы үгийг идэж, уулгүй ганц хоносны дараа дотор чинь харанхуйлж, цангаж, тэсэхийн аргагүй санагдаж байвал Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөсөн бөгөөд Тэр чамаас нүүр буруулаагүйг энэ нь харуулдаг. Тэгвэл чи

энэ урсгалд байгаа нэгэн юм. Харин Бурханы үгийг идэж, уулгүйгээр ганц хоёр хоносны дараа чамд юу ч мэдрэгдэхгүй, огт цангахгүй байвал, мөн сэтгэл чинь огтхон ч хөдлөхгүй бол Ариун Сүнс чамаас нүүр буруулсныг энэ нь харуулдаг. Тэгвэл чиний дотоод байдалд ямар нэг юм буруу байна гэсэн үг; чи Үгийн эрин үед ороогүй бөгөөд хоцорч үлдсэн хүмүүсийн нэг юм. Бурхан хүмүүсийг захирахдаа үг ашигладаг; Бурханы үгийг идэж, уувал чамд сайхан санагддаг ба хэрвээ идэж уухгүй бол чамд дагах ямар ч зам байдаггүй. Бурханы үг нь хүмүүсийн хоол, мөн тэднийг хөдөлгөгч хүч болдог. Библид “Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг” гэсэн байдаг. Бурхан өнөөдөр энэ ажлыг биелүүлж, энэ баримтыг та нар дээр гүйцэлдүүлнэ. Урьд нь хүмүүс Бурханы үгийг уншилгүй олон өдөр явсан ч ердийнхөөрөө хооллож, ажиллаж чаддаг байсан мөртөө яагаад өнөөдөр тэгдэггүй юм бэ? Энэ эрин үед Бурхан бүхнийг захирахын тулд голчлон үг ашигладаг. Бурханы үгээр хүн шүүгдэж, төгс болгуулж, эцэстээ хаанчлал руу хүргэгддэг. Ялангуяа Хаанчлалын эрин үед зөвхөн Бурханы үг л хүний амийг хангаж чадна, Бурханы үг л хүнд гэрэл болон хэрэгжүүлэлтийн замыг өгч чадна. Чи Бурханы үгийн бодит байдлаас холдолгүйгээр өдөр бүр Түүний үгийг идэж, ууж байгаа цагт Бурхан чамайг төгс болгож чадна.

Амийг эрэлхийлэх нь яарч болдог зүйл биш; амийн өсөлт ганц хоёрхон хоногийн дотор явагддаггүй. Бурханы ажил хэвийн, бодитой байдаг бөгөөд зайлшгүй туулах ёстой үйл явц гэж бий. Есүс бие махбодтой болж цовдлолын ажлаа гүйцэлдүүлэхэд гучин гурван жил хагас шаардагдсан—хүнийг ариусгаж, түүний амийг өөрчлөх нь туйлын хэцүү ажил биш үү? Бурханыг илэрхийлдэг хэвийн хүнийг бий болгох нь тийм ч амаргүй. Ялангуяа агуу улаан лууны үндэстэнд төрсөн, хэв чанар муутай хүмүүсийн хувьд ийм байдаг бөгөөд удаан хугацааны Бурханы үг болон ажил шаардагддаг. Иймээс үр дүн харах гэж бүү тэсэн яд. Чи Бурханы үгийг идэж, уухдаа идэвх санаачилгатай байж, Бурханы үгэнд илүү их хичээл чармайлт гаргах ёстой. Түүний үгийг уншиж дуусах үедээ бодитоор хэрэгжүүлж, Бурханы үгээс мэдлэг, ойлголт, ялган таних чадвар, мэргэн ухаанаа нэмэгдүүлж чаддаг байх ёстой. Үүгээр дамжуулан чи өөрийн мэдэлгүй өөрчлөгдөнө. Хэрвээ чи Бурханы үгийг идэж уух, унших, мэдэж авах, мэдэрч туулах, хэрэгжүүлэхийг өөрийн зарчим болгож чаддаг бол өөрийн мэдэлгүй төлөвшинө. Бурханы үгийг уншсанаа дараа ч хэрэгжүүлж чаддаггүй гэж хэлдэг хүмүүс бий. Чи юунд яарна вэ? Тодорхой биеийн хэмжээнд хүрэх үедээ чи Түүний үгийг хэрэгжүүлж чадна. Дөрөв юм уу таван настай хүүхэд, эцэг

эхийгээ тэжээж, хүндэлж чаддаггүй гэж хэлнэ гэж үү? Одоогийн биеийн хэмжээ чинь хэр том болохыг чи мэдэх ёстой. Хэрэгжүүлж чадах зүйлээ хэрэгжүүл, Бурханы удирдлагыг үймүүлдэг нэгэн байхаас зайлсхий. Зүгээр л Бурханы үгийг идэж уу, мөн одоогоос эхлээд үүнийг зарчмаа болго. Бурхан чамайг бүрэн төгс болгож чадах эсэхэд одоохондоо бүү санаа зов. Үүнийг хараахан бүү судал. Бурханы үгийг аваад зүгээр л идэж уу, тэгвэл Бурхан чамайг бүрэн төгс болгох нь гарцаагүй. Гэхдээ Түүний үгийг идэж уухдаа баримтлах ёстой зарчим гэж бий. Сохроор бүү хий. Бурханы үгийг идэж уухдаа нэг талаар, өөрийн мэдэж авах ёстой үгийг—өөрөөр хэлбэл, үзэгдэлтэй холбоотой үгийг эрж хай—нөгөөтээгүүр бодитоор хэрэгжүүлэх ёстой буюу орох ёстой үгийг эрж хай. Нэг тал нь мэдлэгтэй хамаатай, нөгөө нь орохтой холбоотой. Хоёуланг нь ухаармагцаа—юуг мэдэх ёстой, юуг хэрэгжүүлэх ёстойгоо ухаарсан үедээ чи Бурханы үгийг хэрхэн идэж, уухаа мэднэ.

Цаашид, Бурханы үгийн тухай ярих нь чиний ярих зарчим байх ёстой. Ердийн үед цугларахдаа та нар Бурханы үгийн тухай нөхөрлөж, Бурханы үгийг ярианахаа гол агуулга болгон авч үзэж, эдгээр үгийн талаар юу мэддэг, Түүний үгийг хэрхэн хэрэгжүүлдэг, Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар нөхөрлөх ёстой. Бурханы үгийг нөхөрлөж байгаа цагт Ариун Сүнс чамайг гэрэлтүүлнэ. Бурханы үгийн ертөнцийг бий болгоход хүний хамтын ажиллагаа шаардлагатай. Хэрвээ чи үүнд орохгүй бол Бурхан ажиллах ямар ч аргагүй байх болно; хэрвээ чи амаа хамхиад, Түүний үгийн талаар ярьдаггүй бол Бурхан чамайг гэрэлтүүлэх ямар ч аргагүй. Чи завгүй байгаа л биш бол Бурханы үгийн тухай ярь, дэмий бүү чалч! Өөрийн амьдралыг Бурханы үгээр дүүргэ—тэр үед л чи үнэн сүсэгт итгэгч болно. Нөхөрлөл чинь өнгөц байсан ч зүгээр. Өнгөц гэж үгүй бол гүн гэж үгүй. Үйл явц байх ёстой. Дадлагаараа дамжуулан чи чам дээрх Ариун Сүнсний гэрэлтүүлэлтийг ухаарч, Бурханы үгийг хэрхэн үр ашигтайгаар идэж уухаа ухаардаг. Хэсэг хугацаанд судалсныхаа дараа чи Бурханы үгийн бодит байдал руу орно. Хамтран ажиллахаар шийдсэн л бол чи Ариун Сүнсний ажлыг хүлээн авч чадна.

Бурханы үгийг идэж уух зарчмуудын нэг нь мэдлэгтэй, нөгөө нь оролттой холбоотой. Чи аль үгийг мэдэж авах ёстой вэ? Үзэгдэлтэй холбоотой үгийг мэдэж авах ёстой (жишээлбэл, Бурханы ажил одоо ямар эрин үед орсон, Бурхан одоо юу биелүүлэхийг хүсдэг, бие махбодтой болох гэж юу болох гэх зэрэг үг; энэ бүхэн нь үзэгдэлтэй холбоотой). Хүний орох ёстой зам гэдэг нь юуг хэлж байна вэ? Энэ нь хүний хэрэгжүүлж, орох ёстой Бурханы үгийг хэлдэг.

Дээр буй зүйл бол Бурханы үгийг идэж уухын хоёр тал юм. Одоогоос эхлээд ийм маягаар Бурханы үгийг идэж уу. Хэрвээ чи үзэгдэлтэй хамаатай үгийг тодорхой ойлгочихвол цаг үргэлж уншаад байх хэрэггүй. Харин зүрх сэтгэлээ хэрхэн Бурхан руу эргүүлэх, Бурханы өмнө зүрх сэтгэлээ хэрхэн тайван байлгах, махан биеийг хэрхэн хаях гэх мэт оролтын талаарх үгийг илүү их идэж уух нь хамгийн чухал юм. Эдгээр нь чиний хэрэгжүүлэх ёстой зүйл мөн. Бурханы үгийг хэрхэн идэж уухаа мэдэхгүй бол жинхэнээсээ нөхөрлөх боломжгүй. Түүний үгийг хэрхэн идэж уухаа мэдэж, гол зүйлийг нь ухаармагц нөхөрлөл чинь чөлөөтэй болох ба ямар ч асуудал гарлаа гэсэн чи нөхөрлөж, бодит байдлыг ухаарч чадна. Бурханы үгийн талаар нөхөрлөхдөө бодит байдалгүй байвал чи гол зүйлийг ухаараагүй бөгөөд Бурханы үгийг хэрхэн идэж уухаа мэддэггүйг чинь энэ нь харуулдаг. Зарим хүнд Бурханы үгийг унших нь залхмаар санагддаг ба энэ нь хэвийн байдал биш. Бурханы үгээс хэзээ ч залхахгүй байж, үргэлж үүгээр цангаж, Бурханы үгийг үргэлж сайн гэж бодох нь хэвийн байдал юм. Үнэхээр орсон хүн Бурханы үгийг ингэж идэж уудаг. Бурханы үг дэндүү бодитой агаад хүний орох ёстой яг тэр зүйл мөн гэдгийг мэдрэх үед чинь; Түүний үг хүнд асар их тустай, ашигтай бөгөөд хүний амийн хангалт мөн гэдгийг мэдрэх үед чинь—Ариун Сүнс чамд ийм мэдрэмжийг өгдөг бөгөөд Ариун Сүнс чамайг хөдөлгөдөг. Энэ нь Ариун Сүнс чам дээр ажиллаж байгаа ба Бурхан чамаас нүүр буруулаагүй гэдгийг нотолдог. Бурхан үргэлж үг хэлж байгааг хараад зарим хүн Түүний үгээс залхаж, энийг уншсан ч бай, үгүй ч бай ямар ч ялгаагүй гэж боддог—энэ нь хэвийн байдал биш. Тэдэнд бодит байдалд орохоор цангадаг зүрх сэтгэл байдаггүй бөгөөд тийм хүмүүс төгс болгуулах гэж шимтдэггүй, мөн үүнд ач холбогдол өгдөггүй. Бурханы үгээр цангахгүй байгаа бол хэвийн бус байдалтай байгааг чинь энэ нь харуулдаг. Урьд нь, Бурхан чамаас нүүр буруулсан эсэхийг, дотроо амар тайван байгаа эсэх болон таашаал мэдэрсэн эсэхээр чинь тодорхойлдог байсан. Одоо бол, Бурханы үгээр цангадаг эсэх, Түүний үгийг бодит байдлаа болгосон эсэх, чи үнэнч эсэх, мөн Бурханы төлөө чадах бүхнээ хийж чаддаг эсэх чинь гол түлхүүр нь юм. Өөрөөр хэлбэл, хүн Бурханы үгийн бодит байдлаар үнэлэгддэг. Бурхан Өөрийн үгийг бүх хүн рүү чиглүүлдэг. Хэрвээ чи үүнийг уншихыг хүсдэг бол Тэр чамайг гэгээрүүлнэ, харин чи хүсэхгүй бол Тэр чамайг гэгээрүүлэхгүй. Зөвт байдлаар өлсөж, цангадаг, Өөрийг нь эрж хайдаг хүмүүсийг Бурхан гэгээрүүлдэг. Үгийг нь уншсаны дараа ч гэсэн Бурхан өөрсдийг нь гэгээрүүлээгүй гэж зарим хүн хэлдэг. Гэхдээ чи эдгээр үгийг ямархуу байдлаар уншсан бэ? Хэрвээ чи морин дэл дээрээс цэцэгс

харж буй хүнтэй адилаар Түүний үгийг уншиж, бодит байдалд ямар ч ач холбогдол өгөөгүй бол Бурхан чамайг гэгээрүүлж яаж чадах юм бэ? Бурханы үгийг нандигнадаггүй хүн яаж Түүгээр төгс болгуулж чадах юм бэ? Хэрвээ чи Бурханы үгийг нандигнадаггүй бол чамд үнэн ч байхгүй, бодит байдал ч байхгүй байх болно. Хэрвээ чи Түүний үгийг нандигнадаг бол үнэнийг хэрэгжүүлж чадна; тэр үед л чи бодит байдлыг эзэмшинэ. Ийм учраас чи завтай ч бай, үгүй ч бай, орчин нөхцөл таатай ч бай, үгүй ч бай, шалгагдаж байгаа ч бай, үгүй ч бай цаг ямагт Бурханы үгийг идэж уух ёстой. Ерөнхийдөө, Бурханы үг бол хүний оршин тогтнолын суурь юм. Түүний үгээс хэн ч салж чадахгүй, харин өдөрт гурван хоол иддэг шигээ Түүний үгийг идэх ёстой. Бурханаар төгс болгуулж, авхуулах нь тийм амархан гэж үү? Чи одоо ойлгодог ч бай, үгүй ч бай, мөн Бурханы ажлыг тодорхой харсан ч бай, үгүй ч бай Бурханы үгийг аль болох их идэж уух ёстой. Энэ бол идэвх санаачилгатайгаар орж байгаа хэрэг юм. Бурханы үгийг уншсаны дараа орж чадах зүйлсээ яаравчлан хэрэгжүүлж, чадахгүй зүйлээ түр хойш тавь. Эхэндээ чиний ойлгож чадахгүй Бурханы үг их байж болох ч хоёр, гурван сарын дараа, магадгүй бүр жилийн дараа чи ойлгоно. Яагаад тэр вэ? Учир нь Бурхан хүмүүсийг ганц, хоёрхон хоногт төгс болгож чадахгүй. Ихэнх тохиолдолд, Түүний үгийг унших үедээ чи тэр дороо ойлгохгүй байж магадгүй. Тэр үед энэ нь ердөө бичвэрээс цаашгүй харагдаж магад; чи тэдгээрийг хэсэг хугацаанд туулсныхаа дараа л ойлгож чадна. Бурхан маш ихийг ярьсан болохоор Түүний үгийг идэж, уухын тулд чи чадах бүхнээ хийх ёстой, дараа нь чи өөрийн мэдэлгүй ойлгож авах бөгөөд нэг л мэдэхэд Ариун Сүнс чамайг гэгээрүүлнэ. Ариун Сүнс хүнийг гэгээрүүлэх үедээ хүнд ихэвчлэн мэдэгддэггүй. Цангаж, эрж хайх үед чинь Тэр чамайг гэгээрүүлж, залж чиглүүлдэг. Ариун Сүнсний ажилладаг зарчим нь чиний идэж уудаг Бурханы үгэнд төвлөрдөг. Бурханы үгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй, Түүний үгэнд үргэлж өөр хандлага баримталдаг—Түүний үгийг уншсан ч бай, үгүй ч бай ялгаагүй гэж мунгинан боддог бүх хүн бол бодит байдлыг эзэмшдэггүй хүмүүс юм. Ийм хүнээс Ариун Сүнсний ажлыг ч, Түүний гэгээрлийг ч харах аргагүй. Иймэрхүү хүмүүс бол сургаалт үлгэрийн^а Нангуо гуайтай адил, бусдын хүчээр амьдардаг дүр үзүүлэгчид юм.

Бурханы үгийг бодит байдлаа болгохгүй бол чамд ямар ч бодитой биеийн хэмжээ байдаггүй. Шалгагдах цаг ирэхэд чи гарцаагүй унана, тэр үед жинхэнэ биеийн хэмжээ чинь илчлэгдэнэ. Харин бодит байдалд орохоор байнга эрж

а. Эх бичвэрт “сургаалт үлгэрийн” гэх хэллэг байдаггүй.

хайдаг хүмүүс шалгалтад өртөх үедээ Бурханы ажлын зорилгыг ойлгож авдаг. Мөс чанартай бөгөөд Бурханаар цангадаг хүн Бурханы хайрыг хариулахын тулд бодитой үйлдэл хийх ёстой. Бодит байдал эзэмшээгүй хүмүүс ялимгүй хэрэг явдлын өмнө ч бат зогсож чадахгүй. Бодитой биеийн хэмжээтэй болон биеийн хэмжээгүй хүмүүсийн хоорондох ялгаа энэ юм. Аль аль нь Бурханы үгийг идэж, уудаг ч яагаад зарим нь шалгалт дунд бат зогсож чаддаг байхад бусад нь зугтдаг юм бэ? Илт ялгаа бол заримд нь бодитой биеийн хэмжээ дутмаг байдаг; тэд Бурханы үгийг бодит байдлаа болгоогүй бөгөөд Түүний үг тэдний дотор үндэслээгүй. Шалгагдмагцаа тэд замынхаа төгсгөлд очдог. Тэгвэл яагаад зарим нь шалгалтуудын дунд бат зогсож чаддаг юм бэ? Учир нь тэд үнэнийг ойлгодог, үзэгдэлтэй байдаг, мөн Бурханы үг болон шаардлагыг ойлгож, улмаар шалгалтад бат зогсож чаддаг. Энэ бол бодитой биеийн хэмжээ, энэ нь бас амь юм. Зарим хүн Бурханы үгийг уншдаг боловч хэрэгжүүлдэггүй, эсвэл тэдгээрийг нухацтай авч үздэггүй; тэдгээрийг нухацтай авч үздэггүй хүмүүс хэрэгжүүлэлтэд ач холбогдол өгдөггүй. Бурханы үгийг бодит байдлаа болгоогүй хүмүүс бол бодитой биеийн хэмжээгүй бөгөөд тийм хүмүүс шалгалтад бат зогсож чадахгүй.

Бурханы үг гарах үед чи даруй хүлээн авч, идэж, уух ёстой. Хэчнээн ихийг ойлгодог чинь хамаагүй, чиний тууштай баримтлах ёстой нэг үзэл бодол бол Түүний үгийг идэж, ууж, мэдэж, хэрэгжүүлэх явдал юм. Энэ бол чиний хийж чаддаг байх ёстой зүйл билээ. Биеийн хэмжээ чинь хэр том болж болох талаар бүү санаа зов; Түүний үгийг идэж, уухад л анхаарлаа төвлөрүүл. Энэ бол хүний хамтран ажиллах ёстой зүйл билээ. Сүнслэг амьдрал чинь үндсэндээ Бурханы үгийг идэж уух болон тэдгээрийг хэрэгжүүлэх бодит байдалд орохоор хичээх явдал юм. Өөр ямар нэг зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэх нь чиний хэрэг биш. Чуулганы удирдагчид бүх ах, эгч нараа удирдаж, Бурханы үгийг яаж идэж уухаа мэддэг болгох ёстой. Энэ бол чуулганы удирдагч нэг бүрийн хариуцлага мөн. Тэд залуу ч бай, хөгшин ч бай, бүгд Бурханы үгийг идэж уухыг асар чухалд тооцож, Түүний үгийг зүрх сэтгэлдээ байлгах ёстой. Ийм бодит байдалд орох нь Хаанчлалын эрин үед орсон гэсэн үг юм. Өнөөдөр, ихэнх хүнд Бурханы үгийг идэж уухгүйгээр амьдарч чадахгүй гэж санагддаг бөгөөд Түүний үг цаг ямагт шинэхэн санагддаг. Энэ нь, тэд зөв замд орж эхэлж байна гэсэн үг юм. Бурхан ажлаа хийж, хүнийг хангахын тулд үг ашигладаг. Хүн бүхэн Бурханы үгийг хүсэн эрмэлзэж, Бурханы үгээр цангах үед хүмүүс Түүний үгийн ертөнцөд орно.

Бурхан асар ихийг ярьсан. Чи хэр ихийг нь мэдэж авсан бэ? Хэр их рүү нь орсон бэ? Хэрвээ чуулганы удирдагч ах, эгч нараа Бурханы үгийн бодит байдал

руу замчлаагүй бол үүргээ хөсөрдүүлж, хариуцлагаа биелүүлж чадаагүй байх болно! Ойлголт чинь гүн гүнзгий юм уу өнгөц байх нь хамаагүй, ойлголтынхоо түвшнээс үл хамааран чи Түүний үгийг хэрхэн идэж, уухаа мэддэг байх ёстой, мөн Түүний үгэнд асар их анхаарал хандуулж, тэдгээрийг идэж уухын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг ойлгох ёстой. Бурхан маш ихийг ярьчаад байхад чи Түүний үгийг идэж уухгүй, эрж хайхгүй, эсвэл хэрэгжүүлэхгүй бол үүнийг Бурханд итгэх гэж нэрлэж болохгүй. Чи Бурханд итгэдэг тул Түүний үгийг идэж ууж, Түүний үгийг туулж, Түүний үгийг амьдран харуулах ёстой. Зөвхөн үүнийг л Бурханд итгэх итгэл гэж нэрлэж болно! Чи Бурханд итгэдэг гэж амаараа хэлдэг атлаа Түүний үгийн алийг нь ч хэрэгжүүлж, бодит байдал болгож чадахгүй бол үүнийг Бурханд итгэх гэж нэрлэхгүй. Харин ч, энэ нь “өлсгөлөнгөө дарахын тулд талх хайх” явдал юм. Өчүүхэн төдий ч бодит байдал эзэмшихгүйгээр ялихгүй гэрчлэл, хэрэггүй зүйлс болон өнгөц хэрэг явдлын талаар л ярих: эдгээр нь Бурханд итгэх итгэлийг бүрдүүлдэггүй бөгөөд чи Бурханд итгэх зөв замыг ердөө ухаарсангүй. Яагаад Бурханы үгийг аль болох их идэж уух ёстой вэ? Хэрвээ Түүний үгийг идэж уухгүй, зөвхөн тэнгэрт гарахыг л хичээдэг бол энэ нь Бурханд итгэж байгаа хэрэг үү? Бурханд итгэдэг хүний хийх ёстой эхний алхам юу вэ? Бурхан ямар замаар хүнийг төгс болгодог вэ? Бурханы үгийг идэж уухгүйгээр төгс болгуулж чадах уу? Бурханы үгийг өөрийн бодит байдал болгохгүй бол чамайг хаанчлалын ард гэж үзэж болох уу? Бурханд итгэх итгэл гэдэг нь яг юу гэсэн үг вэ? Бурханд итгэгч ядаж гаднаа ааш зан сайтай байх ёстой; хамгийн чухал нь Бурханы үгийг эзэмших явдал юм. Юу ч болж байсан чи Түүний үгээс хэзээ ч салж болохгүй. Бурханыг мэдэх, Түүний санаа зорилгыг биелүүлэх нь бүгд Түүний үгээр дамжин биелдэг. Ирээдүйд, улс үндэстэн, урсгал, шашин, салбар болгоныг Бурханы үгээр байлдан дагуулна. Бурхан шууд ярьж, бүх хүн Бурханы үгийг гартаа барьж, ийм арга замаар хүмүүс төгс болгуулна. Дотор гадна хааяагүй Бурханы үг тархана: Хүмүүс амаараа Бурханы үгийг ярьж, Бурханы үгийн дагуу хэрэгжүүлж, Бурханы үгийг дотроо хадгалж, дотор гаднагүй Бурханы үг нэвчсэн байх болно. Тийнхүү хүмүүс төгс болгуулна. Бурханы санаа зорилгыг биелүүлдэг, Түүнд гэрчлэл хийж чаддаг хүмүүс бол Бурханы үгийг бодит байдлаа болгосон хүмүүс юм.

Үгийн эрин үе буюу Мянгын жилийн хаанчлалын эрин үед орох нь өнөөдөр хийгдэж буй ажил юм. Одоогоос эхлээд Бурханы үгийн талаар нөхөрлө. Бурханы үгийг идэж, ууж, туулснаар чи Бурханы үгийг амьдран харуулж чадна. Бусдыг үнэмшүүлэхийн тулд чи бодитой туршлагатай байх ёстой. Хэрвээ чи

Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж чадахгүй бол хэн ч үнэмшихгүй! Бурханы ашигладаг бүх хүн Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж чадна. Хэрвээ чи ийм бодит байдлыг бий болгож, Бурханд гэрчлэл хийж чадахгүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллаагүй, бас чи төгс болгуулаагүй гэдгийг энэ нь харуулдаг. Энэ бол Бурханы үгийн ач холбогдол билээ. Бурханы үгээр цангадаг зүрх сэтгэл чамд байгаа юу? Бурханы үгээр цангадаг хүмүүс үнэнээр цангадаг бөгөөд зөвхөн тийм хүмүүс л Бурханаар ерөөгддөг. Ирээдүйд Бурхан бүх шашин болон бүх урсгалд илүү олон үг хэлнэ. Тэрээр та нарыг бүрэн төгс болгохын тулд эхлээд та нарын дунд үг хэлж, дуу хоолойгоороо айлдаад, дараа нь Харь үндэстнүүдийг байлдан дагуулахын тулд тэдний дунд үгээ хэлж, Өөрийн дуу хоолойгоор айлдана. Түүний үгээр дамжуулан бүгд чин сэтгэлээсээ бүрэн дүүрэн үнэмшинэ. Бурханы үг болон Түүний илчлэлээр дамжуулан хүний завхарсан зан чанар багасаж, хүний дүр төрхтэй болж, тэрслүү зан чанар нь цөөрдөг. Үг эрх мэдэлтэйгээр хүн дээр ажиллаж, Бурханы гэрэл дотор хүнийг байлдан дагуулдаг. Одоогийн эрин үед Бурханы хийдэг ажил болон Түүний ажлын эргэлтийн цэгийг бүгдийг нь Түүний үгэн дотроос олж болно. Хэрвээ чи Түүний үгийг уншдаггүй бол юу ч ойлгохгүй. Түүний үгийг идэж ууснаар, ах эгч нартайгаа нөхөрлөснөөр, өөрийн бодит туршлагаар дамжуулан чи Бурханы үгийн талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болно. Тэр үед л чи Бурханы үгийн бодит байдлыг үнэхээр амьдран харуулж чадна.

БҮГД БУРХАНЫ ҮГЭЭР БИЕЛДЭГ

Бурхан өөр өөр эрин үеийн дагуу үгээ хэлж, ажлаа хийдэг ба өөр эрин үе бүрд өөр өөр үг хэлдэг. Бурхан дүрэмд захирагддаггүй, нэг ажлаа давтдаггүй, өнгөрсөн үеийн зүйлсийг санагалздаггүй; Тэр бол үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан бөгөөд өдөр бүр шинэ үг хэлдэг. Өнөөдөр баримтлах ёстой зүйлийг чи баримтлах л ёстой; энэ бол хүний хариуцлага, үүрэг билээ. Бурханы одоогийн гэрэл болон үгэнд төвлөрөн хэрэгжүүлэх нь маш чухал. Бурхан дүрэмд захирагддаггүй бөгөөд Өөрийнхөө мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлыг ил болгохын тулд олон өөр өнцгөөс ярьж чаддаг. Бурхан Сүнсний өнцгөөс ярьж байна уу, хүний өнцгөөс ярьж байна уу, эсвэл гуравдагч хүний өнцгөөс ярьж байна уу гэдэг нь хамаагүй—Бурхан бол үргэлж Бурхан байх ба хүний өнцгөөс ярьдаг байлаа гээд Түүнийг чи Бурхан биш гэж хэлж болохгүй. Бурханы ярьдаг өөр өөр өнцгөөс үүдэн зарим хүмүүсийн дунд үзэл бий болжээ.

Иймэрхүү хүмүүст Бурханы тухай, мөн Түүний ажлын тухай ямар ч мэдлэг байдаггүй. Хэрвээ Бурхан үргэлж л нэг өнцгөөс яриад байвал, хүмүүс Бурханы тухай дүрэм гаргахгүй гэж үү? Бурхан хүнд ингэж авирлахыг зөвшөөрөх байсан уу? Бурхан ямар ч өнцгөөс ярьж байлаа гэсэн, Түүнд ингэх шалтгаан бий. Хэрвээ Бурхан үргэлж Сүнсний өнцгөөс ярьдаг байсан бол чи Түүнтэй харилцаж чадах байсан уу? Тиймээс Тэр заримдаа гуравдагч хүний өнцгөөс ярьж, Өөрийн үгээр чамайг хангаж, бодит байдал руу хөтөлдөг. Бурханы хийж байгаа юм бүхэн тохиромжтой байдаг. Товчоор хэлбэл, үүнийг бүгдийг нь Бурхан хийдэг бөгөөд үүнд чи эргэлзэх хэрэггүй. Тэрээр Бурхан учраас ямар ч өнцгөөс ярилаа гэсэн Бурхан хэвээрээ л байна. Энэ бол хувиршгүй үнэн. Тэр яаж ч ажилласан Бурхан хэвээр байх ба Түүний мөн чанар өөрчлөгдөхгүй! Петр Бурханыг маш их хайрладаг, Бурханы сэтгэлд яг нийцдэг хүн байсан ч Бурхан түүнийг Эзэн юм уу Христ гэж гэрчлээгүй, учир нь оршихуйн мөн чанар нь юу байна, түүгээрээ л байх ба хэзээ ч өөрчлөгдөхгүй. Өөрийнхөө ажилд Бурхан дүрэмд баригддаггүй, харин ажлаа үр дүнд хүргэж, хүнийг Өөрийнхөө тухай илүү гүнзгий мэдлэгтэй болгохын тулд янз бүрийн арга барил хэрэглэдэг. Бурханы ажиллах арга барил бүр нь хүнд Бурханыг мэдэхэд хэрэг болдог бөгөөд хүмүүсийг төгс болгох зорилготой байдаг. Тэр ажлын ямар арга барил ашиглахаас үл хамааран, бүгд л хүнийг хөгжүүлж, төгс болгох зорилго агуулдаг. Хэдийгээр Түүний ажиллах арга барилуудын нэг нь маш удаан хугацаанд үргэлжилсэн ч гэсэн энэ нь Түүнд итгэх хүний итгэлийг хатуужуулахын төлөө юм. Тиймээс та бүхэн сэтгэлдээ эргэлзэх хэрэггүй. Эдгээр нь бүгд Бурханы ажлын алхам бөгөөд та нар үүнийг дуулгавартай дагах ёстой.

Өнөөдөр яригдаж байгаа зүйл бол бодит байдал руу орох тухай юм. Тэнгэр өөд гарах тухай, хаан болж захирах тухай яриагүй байна; яригдаж байгаа бүх зүйл бодит байдал руу орохоор эрэлхийлэх тухай байдаг. Үүнээс илүү бодитой эрэл хайгуул байхгүй ба хаан болж захирах тухай ярих нь бодитой зүйл биш юм. Хүмүүс маш сониуч зантай бөгөөд өнөөдрийн Бурханы ажлыг өөрсдийн шашны үзлээр хэмжсээр байдаг. Бурханы ажиллах арга барилын маш олныг туулсан мөртөө хүн одоо хэр нь Бурханы ажлыг мэддэггүй, тэмдэг, гайхамшгийг эрж хайсаар, Бурханы үг биелсэн эсэхийг шалгаж харсаар л байдаг. Энэ нь гайхширмаар мунхаг байдал биш гэж үү? Бурханы үг биеллээ олоогүй бол Тэр бол Бурхан гэж чи итгэсээр байх байсан уу? Өнөөдөр, чуулганы олон ийм хүн тэмдэг, гайхамшгийг олж харахаар хүлээж байгаа. Бурханы үг биелбэл Тэр Бурхан мөн; харин биелэхгүй бол Тэр Бурхан биш гэж тэд хэлдэг. Тэгвэл чи үг

нь биелдэг учраас Бурханд итгэдэг үү, эсвэл Тэр бол Бурхан Өөрөө мөн учраас итгэдэг үү? Хүний Бурханд итгэх тухай үзлийг залруулах шаардлагатай! Бурханы үг биелээгүйг хараад чи зугтан оддог—энэ чинь Бурханд итгэх итгэл мөн үү? Бурханд итгэх үедээ чи бүх зүйлийг Бурханы эрхшээлд орхиж, Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах ёстой. Бурхан Хуучин Гэрээнд маш олон үг хэлсэн, тэдгээрийн аль нь биелснийг чи нүдээрээ харсан бэ? Чи өөрөө хараагүй болохоор Ехова бол жинхэнэ Бурхан биш гэж хэлж чадах уу? Олон үг биелсэн байж болох ч хүнд үнэн байхгүй, тэр юу ч ойлгодоггүй учраас үүнийг тодорхой харж чаддаггүй. Бурханы үг биелээгүй гэж санагдах үед зарим хүн зугтахыг хүсдэг. Оролдоод үз л дээ, чи зугтаж чадах эсэхээ хар. Зугтсаныхаа дараа чи эргээд ирэх л болно. Бурхан үгээрээ чамайг хянадаг, чи чуулганыг болон Бурханы үгийг орхивол чамд цааш амьдрах зам үгүй болно. Итгэхгүй байгаа бол, өөрөө оролдоод үз—зүгээр л орхиод явчхаж чадна гэж чи бодоо юу? Бурханы Сүнс чамайг хянадаг ба чи явж чадахгүй. Энэ бол Бурханы захиргааны зарлиг юм! Зарим хүн оролдоод үзэхийг хүсвэл, яах вэ, тэгж болно! Чи энэ хүнийг Бурхан биш гэж хэлдэг, тэгвэл Түүний эсрэг нүгэл үйлдээд, Түүний юу хийхийг хар. Махан бие чинь үхэхгүй, чи өөрийгөө хооллож, хувцаслах чадвартай хэвээр байж болох ч сэтгэл санааны хувьд тэвчишгүй байх болно; чи хямарч, шаналах ба үүнээс илүү зовлонтой зүйл гэж байхгүй. Хүмүүс оюун санааны тарчлаан, тамлалыг тэсэж чаддаггүй. Магадгүй чи махан биеийн зовлонг тэсэж чаддаг байж болох ч оюун санааны хямрал, удаан хугацааны тарчлалыг тэсвэрлэж огт чаддаггүй. Өнөөдөр, ямар нэг тэмдэг, гайхамшиг харж чадаагүйгээсээ болоод зарим хүн сөрөг болдог мөртөө хэчнээн сөрөг болсон ч бай, хэн ч зугтаж зүрхэлдэггүй, учир нь Бурхан хүмүүсийг үгээрээ хянадаг. Ямар нэг баримт гарч ирээгүй атал хэн ч зугтаж чаддаггүй. Эдгээр нь Бурханы үйлдэл биш гэж үү? Өнөөдөр Бурхан хүнийг амиар хангах гэж газар дэлхий дээр ирчихсэн байна. Тэр хүмүүсийн төсөөлдөг шиг, Бурхан, хүн хоёрын хоорондох энх амгалан харилцааг бататгахын тулд тэмдэг, гайхамшиг үзүүлж чамайг хуурдаггүй. Аминд анхаарлаа хандуулдаггүй, харин оронд нь Бурханы үзүүлэх тэмдэг гайхамшигт анхаардаг бүх хүн бол фарисайчууд юм! Есүсийг загалмайд цовдолсон хүмүүс нь фарисайчууд байсан. Хэрвээ чи, Бурханд итгэх өөрийн үзэл бодлын дагуу Бурханыг хэмжиж, Бурханы үг биелэхэд Түүнд итгэж, биелэхгүй бол эргэлзэн, бүр Түүнийг доромжилдог бол чи ч бас Түүнийг загалмайд цовдолж байгаа бус уу? Ийм хүмүүс өөрсдийн үүргийг умартаж, ая тухтай байдалд шунахайран зугаацдаг!

Нэг талаасаа, Бурханы ажлыг мэддэггүй нь хүний хамгийн том асуудал. Хүн үгүйсгэх хандлагагүй ч эргэлзэх хандлагатай байдаг; тэр үгүйсгэдэггүй боловч бүрэн хүлээн зөвшөөрдөггүй. Хэрвээ хүмүүс Бурханы ажлын талаар нэгд нэггүй мэдлэгтэй бол зугтахгүй. Өөр нэг асуудал нь хүн бодит байдлыг мэддэггүй. Өнөөдөр хүн бүрийн харьцаж байгаа зүйл нь Бурханы үг л юм; үнэндээ чи ирээдүйд тэмдэг, гайхамшиг харна хэмээн бодох хэрэггүй. Би чамд илэн далангүй хэлье: Өнөөгийн үе шатанд, чиний харж чадах ганц зүйл бол Бурханы үг бөгөөд баримт байхгүй ч, Бурханы амь хүний дотор орох боломжтой л байдаг. Мянган жилийн хаанчлалын гол ажил нь энэ бөгөөд хэрвээ чи энэ ажлыг ойлгож чадахгүй бол сул дорой болж, унана. Чи шалгалт дунд буух бөгөөд бүр хамгийн аймшигтай нь, Сатанд олзлогдох болно. Бурхан үндсэндээ үгээ хэлэхээр газар дээр ирсэн; харьцаж байгаа зүйл чинь Бурханы үг, харж байгаа зүйл чинь Бурханы үг, сонсож байгаа зүйл чинь Бурханы үг, баримталдаг зүйл чинь Бурханы үг, туулдаг зүйл чинь Бурханы үг бөгөөд Бурхан энэ удаа бие махбодтой болж, хүнийг төгс болгохын тулд голчлон үгийг ашигладаг. Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй, ялангуяа өнгөрсөн үед Есүсийн хийсэн ажлыг хийдэггүй. Тэр хоёр бол Бурхан бөгөөд хоёулаа махбодтой боловч, Тэдний үйлчлэл нь өөр билээ. Есүс ирэх үедээ бас Бурханы ажлын нэг хэсгийг хийж, зарим нэг үг хэлсэн, гэхдээ Түүний гүйцэлдүүлсэн гол ажил юу байсан бэ? Түүний гүйцэлдүүлсэн гол ажил бол цовдлогдох байсан билээ. Тэрээр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж, бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд нүгэлт махан биеийн дүртэй болсон ба бүх хүн төрөлхтний нүглийн төлөө нүглийн тахил болсон юм. Энэ бол Түүний гүйцэлдүүлсэн гол ажил билээ. Эцэст нь Тэр хожим ирэх хүмүүсийг замчлах загалмайн замыг бэлдэж өгчээ. Есүсийн ирсэн гол зорилго нь золин аврах ажлыг гүйцэлдүүлэх явдал байсан. Тэрээр бүх хүн төрөлхтнийг золин аварч, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг хүнд авчирч, улмаар тэнгэрийн хаанчлалд хүрэх замыг авчирсан. Үүний үр дүнд, хожим ирсэн хүмүүс бүгд: “Бид загалмайн замаар алхаж, загалмайн төлөө өөрсдийгөө золиослох хэрэгтэй” гэцгээсэн. Мэдээж анх Есүс бас өөр бусад ажил хийсэн бөгөөд хүнийг гэмшүүлж, нүглийг нь улайлгахын тулд зарим нэг үг хэлсэн. Гэхдээ л Түүний үйлчлэл нь цовдлол байсан ба замыг номлож өнгөрүүлсэн гурван жил хагасын хугацаа нь хожим тохиох цовдлолд бэлдэхийн төлөө байсан. Есүс хэд хэдэн удаа залбирсан нь ч бас цовдлолын төлөө байсан юм. Түүний туулсан хэвийн хүний амьдрал болон газар дэлхий дээр амьдарсан гучин гурван жил хагасын хугацаа нь үндсэндээ цовдлолын ажлыг гүйцээхийн

төлөө, Түүнд энэ ажлыг явуулах хүч өгөхийн төлөө байсан ба үүний үр дүнд Бурхан цовдлолын ажлыг Түүнд даалгасан. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан ямар ажлыг гүйцэлдүүлэх вэ? Өнөөдөр Бурхан ерөнхийдөө “Үг махбодоор илрэх” ажлыг гүйцэлдүүлж, үг ашиглан хүнийг төгс болгож, үгийн харьцалт, цэвэршүүлэлтийг хүнээр хүлээн авхуулахын тулд бие махбодтой болсон юм. Өөрийнхөө үгээр Тэр чамд хангалт болон амийг хүртээдэг; Түүний үгээс чи ажил болон үйл хэргийг нь хардаг. Бурхан чамайг гэсгээж, цэвэршүүлэхийн тулд үг ашигладаг, иймээс чи хүндрэл бэрхшээл туулж байвал, энэ чинь бас Бурханы үгээс үүдэлтэй. Өнөөдөр, Бурхан баримт бус, үг ашиглан ажлаа явуулдаг. Түүний үг чамд хүрсний дараа л Ариун Сүнс чиний дотор ажиллаж, чамд зовлон шаналал юм уу баяр баясгаланг мэдрүүлж чадна. Бурханы үг л чамайг бодит байдал руу аваачиж чадах ба Бурханы үг л чамайг төгс болгох чадвартай. Иймээс чи ядаж л үүнийг ойлгох ёстой: Эцсийн өдрүүдэд Бурханы хийдэг ажил нь үндсэндээ хүн бүрийг төгс болгож, хүнийг замчлахад Өөрийн үгийг ашиглах явдал юм. Тэр бүх ажлаа үгээр дамжуулан хийдэг; чамайг гэсгээхдээ Тэр баримт ашигладаггүй. Зарим хүн Бурханыг эсэргүүцэх үе гардаг. Бурхан чиний тав тухыг ихэд алдагдуулахгүй, махан биеийг чинь гэсгээхгүй, бас чи бэрхшээл ч туулахгүй боловч Бурханы үг чам дээр бууж, чамайг цэвэршүүлмэгц энэ нь тэсвэрлэшгүй санагддаг. Тийм биш гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үед Бурхан хүнийг ёроолгүй нүхэнд хая гэж хэлсэн. Үнэхээр хүн ёроолгүй нүхэнд орсон гэж үү? Хүнийг цэвэршүүлэхдээ үг ашигласнаар л хүнийг ёроолгүй нүхэнд оруулсан. Тиймээс эцсийн өдрүүдэд Бурхан бие махбодтой болох үедээ бүгдийг гүйцэлдүүлж, бүхнийг ил болгохын тулд үндсэндээ үг ашигладаг. Тэр юу болохыг чи үгээс нь л харж чадна; Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг чи үгээс нь л харж чадна. Бие махбодтой болсон Бурхан газар дэлхийд ирэх үедээ үг хэлэхээс өөр ажил хийдэггүй—тиймээс баримт шаардлагагүй; үг л хангалттай юм. Яагаад гэвэл, Тэрээр гол нь энэ ажлыг хийхээр, Өөрийн хүч чадал болон дээдийн дээд байдлыг хүнд үгээрээ үзүүлж, Өөрийгөө хэрхэн даруухнаар нууж байдгаа хүнд үгээрээ харуулж, мөн Өөрийг нь бүрэн дүүрэн мэдэх боломжийг хүнд үгээрээ олгохын тулд ирсэн. Түүнд юу байгаа, Тэр юу болох нь бүгд Түүний үгэнд бий. Түүний мэргэн ухаан, гайхалтай байдал нь Түүний үгэнд оршдог. Эндээс Бурханы үгээ хэлдэг олон арга барил чамд харагддаг. Энэ бүх хугацаанд Бурханы ажлын дийлэнх нь хүнд чиглэсэн хангалт, илчлэл, харьцалт байсан. Бурхан хүнийг амархан хараагаад байдаггүй, хараасан ч гэсэн үүнийгээ үгээр дамжуулан үйлддэг. Иймээс, Бурхан махбод

болсон энэ эрин үед, Бурхан өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөж байгааг дахин үзэх гэж бүү хичээ, үргэлж тэмдэг хүлээхээ боль—энэ нь ямар ч хэрэггүй! Тэдгээр тэмдэг хүнийг төгс болгож чадахгүй! Ний нуугүй хэлэхэд: Өнөөдөр махбод дахь бодитой Бурхан Өөрөө үг л хэлдэг болохоос үйлддэггүй. Энэ бол үнэн! Тэрээр үг ашиглан чамайг төгс болгож, үг ашиглан чамайг хооллож, ундалдаг. Тэр бас үг ашиглан ажилладаг ба Өөрийнхөө бодит байдлыг чамд мэдүүлэхийн тулд баримтын оронд үг ашигладаг. Хэрвээ чи Бурханы ийм төрлийн ажлыг ухамсарлах чадвартай бол амархан сөрөг болохгүй. Та нар сөрөг зүйлд анхаарал хандуулахын оронд эерэг зүйлд л анхаарах ёстой—өөрөөр хэлбэл, Бурханы үг биелсэн ч бай үгүй ч бай, баримт гарч ирсэн ч бай үгүй ч бай, Бурхан хүнийг Өөрийнхөө үгээс амь олж авахад хүргэдэг нь хамгийн агуу тэмдэг төдийгүй маргашгүй баримт юм. Энэ нь Бурханы тухай мэдлэг олж авах хамгийн сайн нотолгоо бөгөөд тэмдгээс агуу тэмдэг юм. Зөвхөн эдгээр үг л хүнийг төгс болгож чадна.

Хаанчлалын эрин үе эхэлмэгц Бурхан үгээ хэлж эхэлсэн. Ирээдүйд эдгээр үг бага багаар биелэх болно, тэр үе нь мөн хүмүүсийн амь өсөж төлөвших үе байх болно. Бурхан хүний ялзарсан зан чанарыг илчлэхдээ үг ашиглах нь илүү бодит, бас илүү чухал бөгөөд хүний итгэлийг төгс болгох ажлаа хийхийн тулд Бурхан гагцхүү үг ашигладаг, учир нь өнөөдөр бол Үгийн эрин үе бөгөөд энэ эрин хүнээс итгэл, шийдэмгий байдал болон хамтын ажиллагааг шаарддаг. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы ажил нь үгээ ашиглан хүнд үйлчилж, хүнийг хангах явдал юм. Бие махбодтой болсон Бурхан үгээ хэлж дууссаны дараа л тэдгээр нь биелж эхлэх болно. Түүнийг үг хэлж байх үед үг нь биелдэггүй, учир нь Түүнийг махбодын үе шатанд байхад үг нь биелэх боломжгүй. Ингэснээр Бурхан бол Сүнс биш, махбод гэдгийг хүн харж, Бурханы бодит байдлыг нүдээрээ үзэх болно. Түүний ажил дууссан өдөр, газар дэлхий дээр хэлэх ёстой бүх үгээ хэлсэн үед нь Түүний үг биелж эхэлнэ. Тэр үгээ хэлж дуусаагүй тул одоо Бурханы үгийн биелэлтийн эрин үе биш юм. Иймээс Бурхан газар дэлхий дээр үгээ хэлсээр байгааг харах үедээ чи Түүний үг биелэхийг бүү хүлээ; Бурхан үг хэлэхээ больж, газар дэлхий дээрх ажлаа дуусгах үе нь Түүний хэлсэн үг биелж эхлэх цаг үе байх болно. Түүний газар дэлхий дээр хэлсэн үгс дотор нэг талаар амийн хангалт, нөгөө талаар болох зүйлс, хийгдэх зүйлс болон хараахан биелээгүй байгаа зүйлсийн тухай зөгнөл агуулагддаг. Есүсийн үгэнд ч бас зөгнөл байсан. Нэг талаар Тэр амиар хангаж, нөгөөтээгүүр зөгнөл хэлсэн юм. Хүмүүсийн нүдээрээ харж чадах зүйлс болон Бурханы хийдэг зүйлс

хоорондоо асар их ялгаатай учраас өнөөдөр үг болон баримтыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх тухай огт ярьдаггүй. Бурханы ажил дууссаны дараа л Түүний үг биелэх ба үгийн араас баримт гарч ирэх болно. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан газар дээр үгийн үйлчлэлийг гүйцэтгэдэг ба үгийн үйлчлэлийг гүйцэтгэхдээ зөвхөн үг хэлж, харин өөр хэрэг явдлыг хайхардаггүй. Бурханы ажил өөрчлөгдмөгц Түүний үг биелж эхэлнэ. Өнөөдөр үгийг эхлээд чамайг төгс болгоход ашигладаг; Тэр бүхий л орчлон ертөнцөд алдар суутай болох үед Түүний ажил бүрэн төгс болж, хэлэх ёстой бүх үг хэлэгдэж, бүх үг баримт болсон байх болно. Өөрийнх нь үгээс хүн Түүнийг мэдэж, Тэр юу болохыг, Түүний мэргэн ухаан болон бүх гайхалтай үйл хэргийг хараг гэсэндээ Бурхан эцсийн өдрүүдэд үгийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээр газар дээр ирсэн юм. Хаанчлалын эрин үед Бурхан үндсэндээ үгээрээ бүх хүнийг байлдан дагуулдаг. Ирээдүйд Түүний үг бүх шашин, бүлэглэл, үндэстэн, урсгалд бас хүрнэ. Бурхан байлдан дагуулахын тулд, мөн үг нь хүч, эрх мэдлийг агуулдаг гэдгийг бүх хүнд харуулахын тулд үг ашигладаг—иймээс өнөөдөр та нар зөвхөн Бурханы үгтэй нүүр тулдаг.

Энэ эрин үед Бурханы хэлсэн үг нь Хуулийн эрин үед хэлсэн үгээс өөр, мөн Нигүүлслийн эрин үед хэлсэн үгээс ч ялгаатай байдаг. Нигүүлслийн эрин үед Бурхан үгийн ажил хийгээгүй, харин бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд ердөө цовдлолыг л үзүүлсэн. Библид зөвхөн, Есүс яагаад цовдлогдох болсныг, загалмай дээр байхдаа Түүний мэдэрсэн зовлонг болон хүн Бурханы төлөө хэрхэн цовдлогдох ёстой тухай л дурдсан байдаг. Тэрхүү эрин үед Бурханы хийсэн бүх ажил цовдлол дээр төвлөрч байсан. Хаанчлалын эрин үед бие махбодтой болсон Бурхан үгээрээ Өөрт нь итгэдэг бүх хүнийг байлдан дагуулдаг. Энэ нь “Үг нь махбодоор илэрсэн” хэрэг юм; Бурхан эцсийн өдрүүдэд энэ ажлыг хийхээр ирсэн, өөрөөр хэлбэл, “Үг нь махбодоор илэрсэн” бодит ач холбогдлыг биелүүлэхээр ирсэн юм. Тэр зөвхөн үг хэлдэг ба баримт гарч ирэх нь ховор байдаг. Үг нь махбодоор илрэхийн мөн чанар яг энэ бөгөөд бие махбодтой болсон Бурхан үгээ хэлэх үе бол Үг нь махбодоор илэрч, Үг нь махбодод ирж байгаа хэрэг юм. “Анх Үг байв, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байлаа, тэгээд Үг нь махбод болсон юм.” Энэ (Үг нь махбодоор илрэх ажил) нь эцсийн өдрүүдэд Бурханы гүйцэтгэх ажил бөгөөд Түүний бүхий л удирдлагын төлөвлөгөөний сүүлчийн бүлэг юм, иймээс Бурхан газар дээр ирж, үгээ махбодоор илэрхийлэх ёстой. Өнөөдөр хийдэг зүйл, хожим хийх зүйл, Бурханы гүйцэлдүүлэх зүйл, хүний эцсийн хүрэх газар, аврагдах хүмүүс,

устгагдах хүмүүс гэх мэт эцэст нь биелэх ёстой энэ бүх ажлыг бүгдийг нь тодорхой өгүүлсэн ба бүгд Үг нь махбодоор илрэхийн бодит ач холбогдлыг биелүүлэхийн төлөө байдаг. Өмнө нь тунхагласан захиргааны зарлиг болон хууль, устгагдах хүмүүс, амралтад орох хүмүүс зэрэг эдгээр үг бүгд биелэх ёстой. Энэ бол эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханы голлон биелүүлдэг ажил юм. Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс хаана харьяалагдах болон Бурханы урьдчилан тогтоогоогүй хүмүүс хаана харьяалагдахыг, Түүний ардууд болон хөвгүүд хэрхэн ангилагдахыг, Израильд юу тохиолдохыг, Египетэд юу тохиолдохыг Тэрээр хүмүүст ойлгуулдаг бөгөөд ирээдүйд эдгээр үг нэг бүрчлэн биелнэ. Бурханы ажлын алхмууд эрчээ авч байна. Эрин үе бүрд хийгдэх зүйлийг, бие махбодтой болсон Бурханы эцсийн өдрүүдэд хийх зүйлийг болон Түүний биелүүлэх гэж байгаа үйлчлэлийг хүнд илчлэхдээ Бурхан үгийн арга барилыг ашигладаг бөгөөд эдгээр үг нь бүгд Үг нь махбодоор илрэхийн бодит ач холбогдлыг биелүүлэхийн тулд байдаг.

“Бурханы тэмдэг, гайхамшгийг харахад анхаарлаа төвлөрүүлдэг бүх хүн хаягдана; тэд төгс болгуулах хүмүүс биш” гэж Би өмнө нь хэлж байсан. Би маш олон үг хэлсэн атал хүн энэ ажлын талаар өчүүхэн төдий ч мэдлэггүй байдаг бөгөөд энэ хүртэл ирчхээд бас л тэмдэг гайхамшиг гуйсаар байдаг. Бурханд итгэх итгэл чинь тэмдэг, гайхамшгийн эрэл хайгуул төдийхөн зүйл үү, эсвэл энэ нь амь олж авахын төлөө байдаг уу? Тухайн үед Есүс ч бас олон үг хэлсэн бөгөөд зарим нь хараахан биелээгүй байгаа. Есүс бол Бурхан биш гэж чи хэлж чадах уу? Тэр бол Христ бөгөөд Бурханы хайртай Хүү гэдгийг Бурхан гэрчилсэн. Чи үүнийг үгүйсгэж чадах уу? Өнөөдөр, Бурхан зөвхөн үг хэлдэг тул хэрвээ чи үгийг нь нэгд нэггүй мэдэж чадахгүй бол бат зогсож чадахгүй. Чи Түүнийг Бурхан болохоор нь Түүнд итгэдэг юм уу, эсвэл үг нь биелдэг эсэхээс нь хамаарч Түүнд итгэдэг юм уу? Чи тэмдэг гайхамшигт итгэдэг үү, эсвэл Бурханд итгэдэг үү? Өнөөдөр Тэр тэмдэг гайхамшиг үзүүлдэггүй—Тэр үнэхээр Бурхан мөн үү? Хэлсэн үг нь биелдэггүй бол Тэр үнэхээр Бурхан мөн үү? Хэлсэн үг нь биелдэг эсэхээр Бурханы мөн чанар тодорхойлогддог уу? Яагаад зарим хүн дандаа л Бурханы үг биелсний дараа Түүнд итгэнэ гэж хүлээж суудаг вэ? Энэ нь, тэд Түүнийг мэддэггүй гэсэн үг биш үү? Ийм үзэлтэй хүмүүс бүгд Бурханыг үгүйсгэдэг хүмүүс юм. Тэд Бурханыг хэмжихдээ үзэл ашигладаг; үг нь биелдэг бол Бурханд итгэж, биелдэггүй бол итгэдэггүй; тэд үргэлж тэмдэг, гайхамшгийг эрэлхийлдэг. Тэд орчин үеийн фарисайчууд биш гэж үү? Чиний бат зогсож чадах эсэх нь бодитой Бурханыг мэддэг эсэхээс чинь хамаардаг—энэ бол амин

чухал! Чамд Бурханы үгийн бодит байдал хэдий чинээ их байна, Бурханы бодит байдлын тухай мэдлэг чинь төдий чинээ их байдаг бөгөөд шалгалтуудын үеэр чи илүү бат зогсож чаддаг. Чи тэмдэг, гайхамшиг харахад хэдий чинээ их анхаарна, төдий чинээ бат зогсож чадахгүй бөгөөд шалгалтын дунд унах болно. Тэмдэг, гайхамшиг бол суурь биш; Бурханы бодит байдал л амь мөн. Бурханы ажлаас гарах үр нөлөөг зарим хүн мэддэггүй. Тэд Бурханы ажлын тухай мэдлэгийг эрэлхийлэлгүй, будилаан дунд өдөр хоногоо өнгөрүүлдэг. Тэдний эрэл хайгуул нь үргэлж Бурханаар хүслээ хангуулах л зорилготой байдаг бөгөөд үүний дараа л нухацтайгаар итгэдэг. Бурханы үг биелсэн үед л амийг эрэлхийлнэ, харин биелэхгүй бол тэдний хувьд амийг эрэлхийлэх ямар ч боломжгүй гэж тэд хэлдэг. Бурханд итгэх итгэл нь тэмдэг, гайхамшигийг харах эрэл хайгуул, мөн тэнгэр лүү болон гуравдагч тэнгэр өөд гарах эрэл хайгуул гэж хүн боддог. Бурханд итгэх итгэл нь бодит байдалд орох эрэл хайгуул, амийн эрэл хайгуул, мөн Бурханаар авхуулах эрэл хайгуул гэж хэлэх хэн ч байхгүй. Ийм эрэл хайгуулд ямар үнэ цэн байх юм бэ? Бурханы тухай мэдлэгийг, мөн Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг эрэлхийлдэггүй хүмүүс бол Бурханд итгэдэггүй хүмүүс бөгөөд тэд бол Бурханыг доромжлогчид юм!

Одоо Бурханд итгэх итгэл гэж юу болохыг та нар ойлгож байна уу? Бурханд итгэнэ гэдэг нь тэмдэг, гайхамшигийг харах явдал уу? Энэ нь тэнгэр өөд гарах явдал уу? Бурханд итгэх огтхон ч амаргүй. Тэдгээр шашны итгэлийг үгүй хийх ёстой; өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулахаар эрэлхийлэх, тэмдэг, гайхамшиг дээр төвлөрөх, Бурханы нигүүлсэл, амар амгалан, баяр хөөрт илүү их шунах, махан биеийн хэтийн ирээдүй, тав тухыг эрэлхийлэх зэрэг нь шашны хэрэгжүүлэлт бөгөөд шашны ийм хэрэгжүүлэлт нь тодорхойгүй төрлийн итгэл байдаг. Өнөөдөр Бурханд итгэх бодитой итгэл гэж юу вэ? Энэ бол Бурханы үгийг амийн бодит байдлаа болгон хүлээж авах, мөн Бурханы үгээс Түүнийг мэдэж, Түүнийг жинхэнээсээ хайрлах юм. Тодруулбал: Энэ нь, Бурханыг дуулгавартай дагаж, Бурханыг хайрлаж, Бурханы бүтээлийн биелүүлэх ёстой үүргийг гүйцэтгэхийн төлөө Бурханд итгэх итгэл юм. Энэ бол Бурханд итгэхийн зорилго билээ. Та нар, Бурханы хайр татам байдлын тухай, Бурхан хэр хүндлүүлэх үнэ цэнтэй тухай, Бурхан бүтээлүүддээ хэрхэн авралын ажил хийж, тэднийг төгс болгодог тухай мэдлэгийг олж авах ёстой—энэ бол Бурханд итгэхдээ эзэмших ёстой наад захын зүйл юм. Бурханд итгэх итгэл нь үндсэндээ махан биеийн амьдралаа Бурханыг хайрлах амьдрал болгон өөрчилж, завхрал доторх амьдралаа Бурханы үгийн амь доторх амьдрал болгон өөрчилж, Сатаны

эзэмшлээс гарч, Бурханы халамж, хамгаалалт дор амьдрахын нэр юм. Энэ бол, махан биедээ бус, Бурханд дуулгавартай байж чадах явдал, бүхий л зүрх сэтгэлийг чинь олж авч, чамайг төгс болгох боломжийг Бурханд олгож, ялзарсан сатанлаг зан чанараас өөрийгөө чөлөөлөх явдал юм. Бурханд итгэх итгэл нь үндсэндээ Бурханы агуу хүч чадал, алдар сууг чам дээр илэрхийлэхийн төлөө, мөн чамайг Бурханы хүслийг биелүүлж, Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлж, Сатаны өмнө Бурханд гэрчлэл хийж чаддаг байлгахын төлөө байдаг. Бурханд итгэх итгэл нь тэмдэг гайхамшиг харах хүсэлд л төвлөрсөн зүйл байж болохгүй, өөрийн махан биеийн төлөө ч байх ёсгүй. Бурханыг мэдэх эрэл хайгуулын төлөө, Бурханд дуулгавартай байж, Петр шиг үхэн үхтлээ Бурханыг дуулгавартай дагахын төлөө Бурханд итгэх ёстой. Эдгээр нь Бурханд итгэхийн гол зорилт юм. Хүн Бурханыг мэдэж, Бурханыг сэтгэл хангалуун болгохын тулд Бурханы үгийг идэж уудаг. Бурханы үгийг идэж, уух нь чамд Бурханы тухай илүү их мэдлэг өгдөг, үүний дараа л чи Бурханд дуулгавартай байж чадна. Бурханы талаар мэдлэгтэй байж л чи Бурханыг хайрлаж чадна, энэ бол хүний Бурханд итгэх итгэлд байх ёстой зорилго юм. Бурханд итгэхдээ чи үргэлж тэмдэг, гайхамшиг харахаар оролддог бол Бурханд итгэх энэ үзэл санаа чинь буруу байна. Бурханд итгэх нь үндсэндээ Бурханы үгийг амийн бодит байдал болгон хүлээн зөвшөөрөх явдал юм. Бурханы амнаас гарсан үгийг хэрэгжүүлж, тэдгээрийг өөрсдийнхөө дотор биелүүлэх нь л Бурханы зорилгын биелэлт билээ. Бурханд итгэхдээ хүн Бурханаар төгс болгуулж, Бурханд захирагдаж, Бурханд бүрэн дуулгавартай байхаар мэрийх хэрэгтэй. Хэрвээ чи гомдолгүйгээр Бурханд дуулгавартай байж, Бурханы хүслийг анхаарч, Петрийн биеийн хэмжээнд хүрч, Бурханы хэлсэн Петрийн хэв маягийг эзэмшиж чадвал Бурханд итгэх итгэлдээ амжилт олсон байх бөгөөд Бурханаар авхуулсныг чинь энэ нь илтгэнэ.

Бурхан ажлаа бүхий л орчлон ертөнц даяар хийдэг. Түүнд итгэдэг бүх хүн Түүний үгийг хүлээн авч, Түүний үгийг идэж уух ёстой; Бурханы үзүүлдэг тэмдэг, гайхамшигийг харлаа гээд Бурханаар авхуулж чадах хүн нэг ч байхгүй. Эрин үеүдийн туршид хүнийг төгс болгохын тулд Бурхан үргэлж үг ашиглаж ирсэн. Тиймээс та нар хамаг анхаарлаа тэмдэг, гайхамшигт хандуулах ёсгүй, харин Бурханаар төгс болгуулахаар мэрийх ёстой. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Бурхан зарим нэг үг хэлсэн ба Нигүүлслийн эрин үед Есүс ч бас олон үг хэлсэн. Есүсийг олон үг хэлсний дараа хожмын элч, шавь нар нь хүмүүсийг Есүсийн гаргасан тушаалуудын дагуу хэрэгжүүлж, Есүсийн хэлсэн үг, зарчмын дагуу

туршлагажихад залж чиглүүлсэн юм. Эцсийн өдрүүдэд, хүнийг төгс болгохын тулд Бурхан үндсэндээ үг ашигладаг. Тэр хүнийг дарангуйлах юм уу үнэмшүүлэхийн тулд тэмдэг, гайхамшиг ашигладаггүй; Бурханы хүч чадлыг энэ нь ил болгож чадахгүй. Бурхан зөвхөн тэмдэг, гайхамшиг үзүүлсэн бол Бурханы бодит байдлыг илэрхий болгох боломжгүй болж, улмаар хүнийг төгс болгох ч боломжгүй байх байв. Бурхан тэмдэг, гайхамшгаар хүнийг төгс болгодоггүй, харин үгээр хүнийг усалж, хариулдаг бөгөөд үүний дараа л хүн бүрэн дуулгавартай болж, Бурханы талаар мэдлэгтэй болдог. Энэ бол Түүний хийдэг ажил, хэлдэг үгийн зорилго юм. Бурхан хүнийг төгс болгохын тулд тэмдэг, гайхамшиг үзүүлэх арга барил ашигладаггүй—Тэрээр хүнийг төгс болгохын тулд үг ашигладаг ба ажлын олон өөр арга барилыг ашиглаж хүнийг төгс болгодог. Үгийн цэвэршүүлэлт, харьцалт, засалт, хангалтын аль нь байх нь хамаагүй, Бурхан хүнийг төгс болгож, Бурханы ажил, мэргэн ухаан, гайхалтай байдлын талаар хүнд илүү их мэдлэг өгөхийн тулд олон өөр өнцгөөс ярьдаг. Бурхан эцсийн өдрүүдэд эрин үеийг төгсгөх цагт хүн бүрэн төгс болгуулсныхаа дараа тэмдэг, гайхамшгийг харах шаардлагыг хангана. Бурханыг мэдэж авч, Бурханыг юу ч хийсэн бай, дуулгавартай дагаж чаддаг байх үедээ чи тэмдэг, гайхамшгийг харсан ч Бурханы талаар ямар нэг үзэл тээхээ болино. Одоогоор чи ялзарсан, Бурханд бүрэн дуулгавартай байх чадваргүй, ийм байдалтай байж чи өөрийгөө тэмдэг, гайхамшиг харах эрхтэй гэж бодоо юу? Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэг үе нь Бурхан хүнийг шийтгэх үе, эрин үе солигдох үе, түүнчлэн эрин үе дуусах үе байдаг. Бурхан ажлаа хэвийн явуулж байх үедээ тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй. Тэмдэг, гайхамшиг үзүүлэх нь инээд хүрэм амархан боловч энэ нь Бурханы ажлын зарчим биш, мөн Бурхан хүнийг удирдахын зорилго ч биш. Хэрвээ хүн тэмдэг, гайхамшиг харсан бол, хэрвээ Бурханы сүнслэг бие хүнд харагдсан бол бүх хүн Бурханд итгэхгүй гэж үү? Асар их гай гамшиг дундаас гарч ирдэг бүлэг ялагчдыг Зүүн зүгээс олж авдаг гэдгийг Би өмнө нь хэлсэн. Эдгээр үг ямар утга учиртай вэ? Авхуулсан энэ хүмүүс шүүлт, гэсгээлт, харьцалт, засалт болон бүх төрлийн цэвэршүүлэлтийг туулсны дараа л үнэхээр дуулгавартай болсон гэсэн үг юм. Ийм хүмүүсийн итгэл нь тодорхойгүй, хийсвэр бус, харин бодитой байдаг. Тэд ямар ч тэмдэг, гайхамшиг, ямар ч ер бусын зүйл хараагүй; тэд ойлгоход бэрх бичиг үсэг, хоосон номлол, гүн гүнзгий ойлголтын тухай ярьдаггүй; харин тэдэнд бодит байдал, Бурханы үг болон Бурханы бодит байдлын тухай жинхэнэ мэдлэг байдаг. Ийм бүлэг хүмүүс Бурханы хүч чадлыг илэрхий болгож илүү сайн чадах бус уу? Эцсийн өдрүүд

дэх Бурханы ажил нь бодитой ажил юм. Өөрийнхөө эрин үед Есүс хүнийг төгс болгох гэж бус, харин золин аврах гэж ирсэн, иймээс хүмүүсээр Өөрийгөө дагуулахын тулд зарим нэг ер бусын зүйл үзүүлсэн. Учир нь Тэр гол нь цовдлолын ажлыг гүйцэтгэхээр ирсэн ба тэмдэг үзүүлэх нь Түүний үйлчлэлийн хүрээн дэх ажил биш байсан юм. Тэр тэмдэг, гайхамшгууд нь Түүний ажлыг илүү үр нөлөөтэй болгохын тулд хийгдсэн; тэдгээр нь нэмэлт ажил байсан ба бүхий л эрин үеийн ажлыг төлөөлж байгаагүй юм. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Бурхан бас зарим нэг тэмдэг, гайхамшиг үзүүлсэн—гэхдээ Бурханы өнөөдөр хийдэг ажил нь бодитой ажил бөгөөд Тэр одоо тэмдэг, гайхамшиг үзүүлэхгүй нь лавтай. Түүнийг тэмдэг, гайхамшиг үзүүлбэл бодитой ажил нь эмх замбараагаа алдаж, Тэрээр ажлаа цааш хийх боломжгүй болох байсан. Бурхан үг ашиглан хүнийг төгс болгоно гэж хэлчхээд мөн л тэмдэг, гайхамшиг үзүүлсэн бол хүн Түүнд үнэхээр итгэдэг эсэх нь илэрхий болж чадах байсан уу? Иймээс Бурхан тиймэрхүү зүйл хийдэггүй. Хүний дотор хэтэрхий их шашны зүйл бий; Бурхан, хүний доторх шашны бүх үзэл болон ер бусын зүйлсийг хөөн зайлуулж, Бурханы бодитой байдлыг хүнд мэдэгдэхийн тулд эцсийн өдрүүдэд ирсэн. Тэрээр хийсвэр, бодит бус Бурханы дүрийг, өөрөөр хэлбэл, ерөөсөө оршин байдаггүй Бурханы дүрийг арилгахаар ирсэн юм. Иймээс одоо цорын ганц эрхэм чухал зүйл бол чи бодит байдлын тухай мэдлэгтэй байх явдал! Үнэн бүхнийг дийлдэг. Чамд өнөөдөр хэр их үнэн байна вэ? Тэмдэг, гайхамшиг үзүүлдэг бүхэн Бурхан мөн үү? Муу ёрын сүнснүүд ч бас тэмдэг гайхамшиг үзүүлж чадна; тэд бүгд Бурхан мөн үү? Бурханд итгэхдээ хүний эрж хайдаг зүйл нь үнэн, эрэлхийлдэг зүйл нь амь болохоос тэмдэг, гайхамшиг биш билээ. Бүх хүний Бурханд итгэх зорилго ийм байх ёстой.

ТӨГС БОЛГУУЛАХ ХҮМҮҮС ЦЭВЭРШҮҮЛЭЛТ ТУУЛАХ ЁСТОЙ

Чи Бурханд итгэдэг бол Бурханыг дуулгавартай дагаж, үнэнийг хэрэгжүүлэн бүх үүргээ биелүүлэх ёстой. Үүнээс гадна чи туршлагажих хэрэгтэй зүйлсээ ойлгох ёстой. Чи зөвхөн харьцалт, сахилгажуулалт, шүүлтийг туулж, Бурханд дуртай байж чаддаг мөртөө Бурхан чамайг сахилгажуулж, чамтай харьцаж байгааг мэдэрч чадахгүй л байгаад байх юм бол энэ чинь хүлээн зөвшөөрөхийн аргагүй зүйл юм. Магадгүй энэ удаагийн цэвэршүүлэлтэд чи дороо бат зогсож чадах ч энэ чинь бас л хангалтгүй; чи урагш алхсаар байх ёстой. Бурханыг

хайрлах хичээл хэзээ ч дуусдаггүй бөгөөд эцэс төгсгөл гэж үгүй. Бурханд итгэх нь туйлын энгийн зүйл гэж хүмүүс үздэг боловч бодитой туршлага олж авмагцаа Бурханд итгэх итгэл нь хүмүүсийн төсөөлдөг шиг хялбар зүйл биш гэдгийг ухамсарладаг. Бурхан хүнийг цэвэршүүлэхээр ажиллах үед хүн зовдог. Хүний цэвэршүүлэлт их байх тусам түүний Бурханыг хайрлах хайр өсөн нэмэгдэж, Бурханы сүр хүч түүнд илүү ихээр илчлэгдэх болно. Эсрэгээрээ, хүн цэвэршүүлэлт бага хүртэх тусам Бурханыг хайрлах түүний хайр өсөн нэмэгдэх нь багасаж, Бурханы сүр хүч түүнд илчлэгдэх нь ч багасна. Хүний цэвэршүүлэлт, зовлон шаналал их байх тусам, тарчлалыг илүү их туулах тусам, түүний Бурханыг хайрлах хайр улам гүнзгийрч, Бурханд итгэх итгэл нь илүү үнэн бодитой, Бурханы талаарх мэдлэг нь илүү гүн гүнзгий болдог. Цэвэршүүлэгдэх явцдаа ихээхэн зовж, ихээхэн харьцалт, сахилгажуулалт туулсан хүмүүс Бурханыг гүнзгий хайрладаг, Бурханы талаар илүү гүн гүнзгий, нэвтэрхий мэдлэгтэй байдгийг чиг туршлагаараа харна. Харин харьцалт туулаагүй хүмүүс өнгөцхөн мэдлэгтэй байдаг бөгөөд тэд “Бурхан үнэхээр сайн, Тэр хүмүүст нигүүлсэл хайрладаг болохоор хүмүүс Түүнд дуртай байдаг” гэж хэлэхээс хэтэрдэггүй. Хүмүүс харьцалт, сахилгажуулалт туулбал Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийн тухай ярих чадвартай болдог. Тиймээс хүнд хийх Бурханы ажил гайхалтай байх тусмаа илүү үнэ цэн, ач холбогдолтой байдаг. Чиний хувьд ухаарахын аргагүй, үзэлтэй чинь нийцэшгүй байх тусмаа Бурханы ажил чамайг илүү их байлдан дагуулж, олж авч, төгс болгож чаддаг. Бурханы ажлын ач холбогдол хэчнээн их билээ! Хэрэв Бурхан хүнийг ийм байдлаар цэвэршүүлээгүй, энэхүү арга барилын дагуу ажиллаагүй бол Түүний ажил үр дүнгүй, ач холбогдолгүй байх байсан. Бурхан энэ бүлэг хүмүүсийг сонгож, олж аваад, эцсийн өдрүүдэд бүрэн төгс болгоно хэмээн урьд өмнө нь яригдаж байсан; үүнд ер бусын ач холбогдол бий. Бурханы та нарын дотор хийдэг ажил агуу байх тусам Бурханыг хайрлах та нарын хайр илүү гүнзгий, ариун байх юм. Бурханы ажил агуу байх тусам хүн Түүний мэргэн ухаанаас төдий чинээ ихийг ухаарч чадах ба Бурханы талаарх хүний мэдлэг төдий чинээ гүнзгийрдэг. Эцсийн өдрүүдэд Бурханы удирдлагын төлөвлөгөөний зургаан мянган жил төгсгөл болно. Тийм амархан төгсөж чадах болов уу? Тэр хүн төрөлхтнийг байлдан дагуулмагц Түүний ажил дуусах уу? Ийм хялбар байж болно гэж үү? Хүмүүс үнэхээр ийм л хялбар хэмээн төсөөлдөг боловч Бурханы хийдэг зүйл тийм ч хялбар биш юм. Чи Бурханы ажлын аль ч хэсгийг дурдсан бай хүний хувьд бүгд ойлгохын аргагүй юм. Хэрэв чи үүнийг ухан ойлгож чаддаг байсан

бол Бурханы ажил ач холбогдолгүй, үнэ цэнгүй байх байлаа. Бурханы хийсэн ажлыг ойлгохын аргагүй; чиний үзлээс тэс ондоо юм. Чиний үзэлтэй нийцэхгүй байх тусам Бурханы ажил ямар их утга учиртай болох нь илүү их харагддаг; чиний үзэлтэй таардаг байсан бол утга учиргүй байх байлаа. Өнөөдөр чи Бурханы ажил үнэхээр гайхалтай болохыг мэдэрдэг бөгөөд гайхалтай гэдгийг нь мэдрэх тусам Бурхан чамд улам ойлгохын аргагүй санагдаж, Бурханы үйл хэрэг ямар агуу болохыг чи хардаг. Хэрэв Тэр хүнийг байлдан дагуулахын тулд хэдхэн өнгөцхөн, хааш яаш ажил хийгээд л дараа нь юу ч хийгээгүй бол хүн Бурханы ажлын ач холбогдлыг олж харж чадахгүй байх байсан. Одоо чи бага зэргийн цэвэршүүлэлт хүлээн авч байгаа ч энэ нь амийн өсөлтөд чинь асар их ашиг тустай; тиймээс ийм бэрхшээл зовлон туулах нь та нарт нэн чухал шаардлагатай билээ. Өнөөдөр чи багахан цэвэршүүлэлт хүлээн авч байгаа ч дараа нь чи Бурханы үйл хэргийг үнэхээр олж харж чаддаг болж, эцэст нь “Бурханы үйл хэрэг үнэхээр гайхалтай юм аа!” гэж хэлнэ. Энэ нь чиний зүрх сэтгэл дэх үгс байх болно. Бурханы цэвэршүүлэлтийг хэсэг хугацаанд туулаад (үйлчлэл үзүүлэгчдийг шалгах шалгалт ба гэсгээлтийн цаг үе) зарим хүн эцэст нь “Бурханд итгэх үнэхээр хэцүү!” гэж хэлсэн. Тэд “үнэхээр хэцүү” гэдэг үгийг хэрэглэсэн нь Бурханы үйлдлүүдийг ойлгохын аргагүй, Бурханы ажил маш их ач холбогдол, үнэ цэнтэй бөгөөд хүн Түүний ажлыг эрхэмлэвэл туйлын зохилтой болохыг үнэндээ харуулж байна. Намайг тийм их ажил хийсний дараа чи өчүүхэн ч мэдлэг эзэмшээгүй байвал Миний ажил үнэ цэнтэй хэвээр байж чадах уу? Энэ нь чамайг “Бурханд үйлчлэх үнэхээр хэцүү, Бурханы үйлдлүүд үнэхээр гайхалтай, Бурхан үнэхээр мэргэн ухаантай! Бурхан их хайр татам юм!” гэж хэлэхэд хүргэнэ. Хэрэв туршлагажих үеийг туулсныхаа дараа чи ийм үг хэлж чадаж байвал Бурханы ажлыг олж авсныг чинь энэ нотолж байгаа юм. Нэг өдөр хилийн чанадад сайн мэдээ түгээж байхад чинь хэн нэгэн чамаас “Чиний Бурханд итгэх итгэл хэр байна?” гэж асуувал чи “Бурханы үйлдэл үнэхээр гайхамшигтай!” гэж хэлж чадна. Хүмүүс чиний үг бодит туршлагыг илэрхийлж буйг мэдрэх болно. Энэ л үнэхээр гэрчлэл хийж буй явдал юм. Бурханы ажил мэргэн ухаанаар дүүрэн, Түүний чамд хийсэн ажил чамайг бүрэн үнэмшүүлж, зүрх сэтгэлийг чинь байлдан дагуулсан гэж чи хэлнэ. Чи Түүнийг үргэлж хайрлах болно. Учир нь Тэр хүн төрөлхтний хайрыг хүртэх хангалттай гавьяатай! Хэрэв чи ийм зүйлсийг ярьж чадвал хүмүүсийн зүрх сэтгэлийг хөдөлгөж чадна. Энэ бүгд нь гэрчлэл хийж буй хэрэг юм. Хэрэв чи цангинасан гэрчлэл хийж, хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөн уйлуулж чадвал энэ нь Бурханд хайртай нэгэн

мөн болохыг чинь харуулдаг. Учир нь чи Бурханд хайртайгаа гэрчилж чаддаг, чамаар дамжин Бурханы үйлдэл гэрчлэгдэж чаддаг билээ. Чиний гэрчлэлээр дамжуулан бусад хүн Бурханы ажлыг эрж хайн, туулах болсон бөгөөд ямар ч орчинд туулдаг байсан тэд бат зогсож чадна. Энэ бол гэрчлэл хийх цорын ганц жинхэнэ зам бөгөөд чамаас одоо яг үүнийг л шаарддаг. Бурханы ажил туйлын үнэ цэнтэй бөгөөд хүмүүс үүнийг нандигнах учиртай, Бурхан бол маш эрхэм нандин бөгөөд элбэг дэлбэг болохыг чи олж харах ёстой; Тэр үг хэлж чаддаг төдийгүй бас хүмүүсийг шүүж, зүрх сэтгэлийг нь цэвэршүүлж, тэдэнд баяр баясгалан авчирч, тэднийг олж авч, байлдан дагуулж, төгс болгож чадна. Бурхан ихэд хайр татам гэдгийг чи өөрийн туршлагаас харна. Тэгэхээр чи одоо Бурханыг хэр их хайрладаг вэ? Эдгээр зүйлийг чи үнэхээр зүрх сэтгэлээсээ хэлж чадах уу? Чи энэ үгийг зүрх сэтгэлийнхээ гүнээс илэрхийлж чаддаг болох үедээ л гэрчлэл хийж чаддаг болно. Туршлага чинь энэ түвшинд хүрсэн цагт чи Бурханыг гэрчлэгч байх чадвартай болох бөгөөд шаардлага хангахуйц болсон байна. Чи туршлагаараа энэ түвшинд хүрэхгүй бол болоогүй л байна гэсэн үг. Цэвэршүүлэлтийн явцад хүмүүс сул дорой байдал гаргах нь жирийн үзэгдэл боловч цэвэршүүлэлтийн дараа чи “Бурхан маш ухаалгаар ажилдаг юм байна!” гэж хэлж чадах учиртай. Эдгээр үгийн бодит ойлголтод чи үнэхээр хүрч чадсан бол энэ нь чиний нандигнадаг зүйлс болж, чиний туршлага үнэ цэнтэй болно.

Одоо чи юуг эрэлхийлэх ёстой вэ? Чи Бурханы ажлыг гэрчлэх чадвартай эсэх, Бурханы гэрчлэл болон илрэл болж чадах эсэх, Бурханаар ашиглуулахад тохирох эсэх—эдгээр нь чиний эрж хайх ёстой зүйлс юм. Бурхан яг хэр их ажил чамд хийсэн бэ? Хэр ихийг чи харж, хэр их нь чамд хүрсэн бэ? Хэр ихийг чи туулж, амссан бэ? Бурхан чамайг туршиж, чамтай харьцаж, чамайг сахилгажуулж байсан эсэхээс үл хамааран Түүний үйлдэл, ажил чам дээр хэрэгжиж ирсэн. Гэвч Бурханд итгэгч бөгөөд Бурханаар төгс болгуулахыг эрэлхийлэхэд бэлэн хүний хувьд чи бодитой туршлага дээрээ үндэслэн Бурханы ажлыг гэрчилж чаддаг уу? Чи бодитой туршлагаараа Бурханы үгийг амьдран харуулж чаддаг уу? Чи бодитой туршлагаараа дамжуулан бусдыг хангаж, Бурханы ажлыг гэрчлэхэд бүхий л амьдралаа зарлагадаж чаддаг уу? Бурханы ажилд гэрчлэл хийхдээ чи туршлага, мэдлэг, төлсөн төлөөсөндөө найдах ёстой. Ингэж байж л Түүний хүслийг гүйцэлдүүлж чадна. Чи Бурханы ажилд гэрчлэл хийдэг хүн мөн үү? Чамд ийм эрмэлзэл бий юу? Хэрэв чи Түүний нэрийг, цаашлаад Түүний ажлыг гэрчилж чаддаг, Өөрийнхөө хүмүүсээс Түүний шаарддаг дүр төрхийг амьдран харуулж чаддаг бол чи Бурханыг гэрчлэгч мөн

билээ. Чи Бурханд яг хэрхэн гэрчлэл хийдэг вэ? Бурханы үгийг амьдран харуулахаар эрж хайж, тэмүүлэн, өөрийн үгээр гэрчлэл хийж, хүмүүст Түүний ажлыг мэдүүлж, Түүний үйлдлийг харуулснаараа үүнийг хийдэг. Хэрэв чи энэ бүхнийг үнэхээр эрж хайвал, Бурхан чамайг төгс болгоно. Хэрэв чи зөвхөн Бурханаар төгс болгуулж, эцэс төгсгөлд нь ерөөгдөхийн төлөө л эрж хайдаг бол Бурханд итгэх итгэлийн чинь харах өнцөг цэвэр биш байна. Чи, Бурханы үйл хэргийг бодит амьдрал дээр хэрхэн харахыг, чамд хүслээ илчлэх үед нь Түүнийг хэрхэн сэтгэл хангалуун байлгахыг эрэлхийлэх ёстой; Түүний гайхалтай байдал, мэргэн ухааныг хэрхэн гэрчлэхийг, Тэр яаж чамайг сахилгажуулж, чамтай харьцдагийг хэрхэн гэрчлэхийг эрэлхийлэх ёстой. Энэ бүхэн нь одоо чиний тунгаан бодож байх ёстой зүйл юм. Бурханыг хайрлах хайр чинь гагцхүү төгс болгуулсныхаа дараа Бурханы алдрыг хуваалцаж чаддаг байхын төлөө юм бол энэ нь бас л хангалтгүй бөгөөд Бурханы шаардлагад нийцэж чадахгүй. Чи Бурханы ажилд гэрчлэл хийж, Түүний шаардлагыг хангаж, хүмүүс дээр хийсэн Түүний ажлыг бодитойгоор туулж чаддаг байх хэрэгтэй. Өвчин, нулимс, гунигийн аль нь ч бай чи энэ бүгдийг хэрэгжүүлэлтээрээ туулах ёстой. Эдгээр нь чамайг Бурханыг гэрчилдэг нэгэн болгож төгс болгох учиртай юм. Чи одоо яг юунаас болоод зовж, төгс болгуулахаар эрж хайдаг вэ? Одоогийн зовлон зүдүүр чинь үнэхээр Бурханыг хайрлаж, Түүнийг гэрчлэхийн төлөө байдаг уу? Эсвэл энэ нь махан биеийн ерөөл, хэтийн ирээдүй, хувь заяаны чинь төлөө байдаг уу? Чи бүх санаа зорилго, сэдэл, эрэлхийлдэг зорилгоо залруулах ёстой бөгөөд өөрийн хүсэлд хөтлөгдөж болохгүй. Нэг нь ерөөл хүртэж, эрх мэдлээр ноёрхохын тулд төгс болгуулахыг эрж хайдаг байхад нөгөө нь Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, Бурханы ажилд бодитой гэрчлэл хийхийн тулд төгс болгуулахыг эрэлхийлдэг бол энэ хоёр эрэл хайгуулын арга замаас чи алийг нь сонгох байсан бэ? Хэрэв чи эхнийхийг нь сонгосон бол Бурханы стандартад хүрэхэд бас л хэтэрхий хол байх болно. Орчлон ертөнц даяар Миний үйлдлийг ил тод мэдэх болно, орчлон ертөнцөд Би Хаан сууна гэж Би нэгэнтээ хэлсэн. Нөгөөтээгүүр, та нарт даалгасан зүйл бол гадуур явж Бурханы ажилд гэрчлэл хийх болохоос хаад болж, бүхий л орчлон ертөнцөд харагдах биш юм. Бурханы үйл хэргээр сансар болон тэнгэр огторгуйг дүүргүүл. Хүн бүрд үүнийг харуулж, хүлээн зөвшөөрүүл. Эдгээр үгийг Бурханд Өөрт нь хамааруулан хэлсэн бөгөөд хүмүүсийн хийх ёстой зүйл бол Бурханы төлөө гэрчлэл хийх билээ. Бурханы талаар чи одоо хэр ихийг мэддэг вэ? Бурханы талаар чи одоо хэр ихийг гэрчилж чадах вэ? Бурхан хүнийг төгс болгохын зорилго юу вэ? Бурханы хүслийг

ойлгомогцоо чи Түүний хүсэлд хэрхэн санаа тавих ёстой вэ? Хэрэв чи төгс болгуулж, амьдран харуулдаг зүйлээрээ Бурханы ажилд гэрчлэл хийхийг хүсэж байгаа бол, чамд ийм хөдөлгөх хүч байгаа бол, юу ч хэтэрхий хэцүү биш. Хүмүүст одоо хэрэгтэй байгаа зүйл бол итгэл юм. Хэрэв чамд ийм хөдөлгөх хүч байгаа бол аливаа сөрөг байдал, идэвхгүй байдал, залхуурал болон махан биеийн үзэл, амьдралын гүн ухаан, тэрслүү зан чанар, сэтгэл хөдлөл гэх мэтээ орхиход хялбар байдаг.

Шалгалтыг туулж байхдаа хүмүүс сул дорой болж, дотроо сөрөг байдал тээж, Бурханы хүсэл болон хэрэгжүүлэлтийн замыг тодорхой харж чадахгүй байх нь хэвийн юм. Гэвч ямар ч тохиолдолд Иовын адилаар Бурханы ажилд итгэх итгэл чамд байх ёстой бөгөөд Бурханыг үгүйсгэх ёсгүй. Хэдийгээр Иов сул дорой байж, төрсөн өдрөө хараасан боловч Ехова хүний амьдрал дахь бүх зүйлийг хайрласан, мөн Ехова бол тэднийг бүгдийг нь авч явах Нэгэн мөн гэдгийг тэр үгүйсгээгүй. Түүнийг яаж ч шалгасан тэр энэ итгэлээ хадгалсан. Туршлагынхаа явцад чи Бурханы үгээр дамжуулан ямар цэвэршүүлэлт туулах нь хамаагүй, хүн төрөлхтнөөс Бурханы шаарддаг зүйл бол товчхондоо тэдний итгэл, Өөрийг нь гэх хайр юм. Ийм байдлаар ажилласнаараа Тэр хүмүүсийн итгэл, хайр, тэмүүллийг төгс болгодог. Бурхан төгс болгох ажлыг хүмүүс дээр хийдэг бөгөөд хүмүүс үүнийг харж, мэдэрч чаддаггүй; ийм нөхцөлд чиний итгэл шаардлагатай. Юмыг энгийн нүдээр харах боломжгүй үед хүмүүст итгэл шаардлагатай болдог бөгөөд үзлээ орхиж чадахгүй үед чинь чамд итгэл хэрэгтэй байдаг. Бурханы ажлын талаар тодорхой ойлголтгүй байх үедээ чиний хийх ёстой зүйл бол итгэлтэй байж, дороо бат зогсож, гэрчлэлд зогсох юм. Иов энэ цэгт хүрэх үед Бурхан түүнд харагдаж, түүнтэй ярьсан. Өөрөөр хэлбэл, итгэл дотроосоо л чи Бурханыг харж чадах бөгөөд итгэл байгаа цагт Бурхан чамайг төгс болгоно. Итгэл үгүй бол Тэр үүнийг хийж чадахгүй. Чиний олж авахаар найдаж байгаа бүхнийг Бурхан чамд хайрлана. Чамд итгэл байхгүй бол төгс болгуулж чадахгүй бөгөөд чи Бурханы үйлсийг харж чадахгүй, Түүний төгс хүчийг харж бүр ч чадахгүй. Бодитой туршлагаараа Түүний үйлдлийг харна гэсэн итгэл чамд байгаа үед Бурхан чамд харагдаж, Тэр чамайг дотроос чинь гэгээрүүлж, чиглүүлэх болно. Ийм итгэл үгүй бол Бурхан үүнийг хийж чадахгүй. Хэрэв чи Бурханд найдах найдвараа алдсан бол Түүний ажлыг хэрхэн туулж чадах юм бэ? Тиймээс чамд итгэл байгаа бөгөөд Бурханд эргэлзэх эргэлзээ тээгээгүй үед л, Түүнийг юу ч хийсэн, Түүнд итгэх жинхэнэ итгэл чамд байгаа үед л туршлагаар чинь дамжуулан Тэр чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлэх бөгөөд

тэр цагт л чи Түүний үйлдлийг харж чадна. Энэ бүхэнд бүгдэд нь итгэлээр дамжуулан хүрдэг. Итгэл зөвхөн цэвэршүүлэлтээр дамжин ирдэг бөгөөд цэвэршүүлэлт байхгүй бол итгэл бий болж чадахгүй. “Итгэл” хэмээх энэхүү үг юуг хэлдэг вэ? Итгэл гэдэг нь аливаа зүйлийг харж, барьж чадахгүй үед, Бурханы ажил хүний үзэлтэй нийцэхгүй үед, хүн хүрэхийн аргагүй үед хүнд байх ёстой жинхэнэ итгэл үнэмшил, чин үнэн зүрх сэтгэл юм. Энэ бол Миний ярьдаг итгэл юм. Бэрхшээл зовлон, цэвэршүүлэлтийн цаг үед хүмүүст итгэл хэрэгтэй бөгөөд итгэл нь цэвэршүүлэлтийг дагаж ирдэг зүйл юм; цэвэршүүлэлт, итгэл хоёрыг салгах боломжгүй. Бурхан яаж ч ажилласан, орчин нөхцөл чинь ямар ч байсан чи амийг эрэлхийлж, үнэнийг эрж хайж, Бурханы ажлын талаарх мэдлэгийг эрж хайж, Түүний үйлдлийн талаар ойлголттой байж, үнэний дагуу үйлдэж чаддаг. Ингэх нь жинхэнэ итгэлтэй байх явдал бөгөөд үүгээрээ чи Бурханд итгэх итгэлээ алдаагүй гэдгээ харуулдаг. Цэвэршүүлэлтээр дамжуулан үнэнийг эрэлхийлэхдээ туйлбартай байж чаддаг бол, Бурханыг үнэхээр хайрлаж чаддаг, Түүний талаарх эргэлзээ бий болгодоггүй бол, Тэр юу ч хийсэн Түүнийг сэтгэл хангалуун байлгахын тулд үнэнийг хэрэгжүүлсээр байдаг бол, Түүний хүслийг гүн гүнзгий эрж хайж, Түүний хүсэлд санаа тавьж чаддаг бол л чи Бурханд итгэх жинхэнэ итгэлтэй байж чадна. Урьд нь чамайг хаан суух болно гэж Бурхан айлдахад чи Түүнийг хайрласан бөгөөд Тэр чамд Өөрийгөө ил тод харуулахад чи Түүнийг эрж хайсан. Гэвч одоо Бурхан нуугдсан, Түүнийг харж чадахгүй, чамд саад тотгор таарсан энэ үед чи одоо Бурханд найдах найдвараа алдах уу? Тэгэхээр чи цаг үргэлж амийг эрэлхийлж, Бурханы хүслийг хангахаар эрж хайх ёстой. Үүнийг л жинхэнэ итгэл гэдэг бөгөөд энэ бол хамгийн үнэн, хамгийн сайхан хайр билээ.

Урьд нь хүмүүс амлалтаа өгөхөөр Бурханы өмнө бүгд ирж “Өөр хэн ч Бурханыг хайрладаггүй байсан ч гэсэн би Түүнийг хайрлах ёстой” гэж хэлдэг байсан. Гэвч одоо цэвэршүүлэлт чам дээр ирж, энэ нь чиний үзэлтэй нийцэхгүй болохоор чи Бурханд итгэх итгэлээ алддаг. Энэ жинхэнэ хайр мөн гэж үү? Иовын үйл хэргийн тухай чи олон удаа уншиж байсан байж тэр талаар мартлаа гэж үү? Жинхэнэ хайр итгэл дотроос л хэлбэрээ олдог. Чиний туулдаг цэвэршүүлэлтээр дамжин Бурханыг гэх бодит хайр чинь бий болдог бөгөөд чи итгэлээрээ дамжуулан бодитой туршлагадаа Бурханы хүсэлд санаа тавьж чаддаг ба мөн л итгэлээр дамжуулан махан биеэ хаяж, амийг эрж хайдаг; энэ бол хүмүүсийн хийх ёстой зүйл юм. Хэрэв чи үүнийг хийдэг бол Бурханы үйлдлийг харж чаддаг болно, харин чамд итгэл дутагдаж байвал Бурханы

үйлдлийг харж, Түүнийг ажлыг туулж чадахгүй. Бурханаар ашиглуулж, төгс болгуулахыг хүсдэг бол зовж зүдрэх хүсэл, итгэл, тэсвэр хатуужил, дуулгавартай байдал, Бурханы ажлыг туулах, Түүний хүслийг ухаж ойлгох, Түүний уй гашуунд санаа тавих чадвар гээд бүгдийг чи эзэмших ёстой. Хүнийг төгс болгох хялбар биш бөгөөд туулсан цэвэршүүлэлт бүр чинь чамаас итгэл, хайр шаарддаг. Чи Бурханаар төгс болгуулахыг хүсдэг бол замаар ердөө хурдлан урагшлах нь хангалтгүй, Бурханы төлөө ердөө өөрийгөө зарлагадах ч бас хангалтгүй. Бурханаар төгс болгуулдаг хүн болж чадахын тулд чи олон зүйлийг эзэмших ёстой. Зовлон зүдүүртэй тулгарах үедээ чи махан биеийн төлөөх зовнилоо хойш тавьж, Бурханы эсрэг гомдол гаргахгүй байж чаддаг байх ёстой. Бурхан Өөрийгөө чамаас нуух үед Түүнийг дагах итгэлтэй байж, урьдын хайраа бөхөөж, сарниулалгүйгээр хадгалж чаддаг байх ёстой. Бурхан юу ч хийсэн чи Түүний зохицуулалтад захирагдаж, Түүний эсрэг гомдол гаргахаасаа илүү махан биеэ хараахад бэлэн байх ёстой. Чи шалгалттай тулгарах үедээ хэдийгээр гашуун нулимс унагаж, хайртай эд зүйлээсээ хагацах дургүй байсан ч гэсэн Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой. Энэ л жинхэнэ хайр, итгэл билээ. Чиний жинхэнэ биеийн хэмжээ ямар ч байсан гэсэн бэрхшээл зовлонг эдлэх хүсэл болон жинхэнэ итгэлийн аль алиныг нь чи эхлээд эзэмших ёстой бөгөөд махан биеийг хаях хүсэл мөн чамд байх ёстой. Чи Бурханы хүслийг хангахын тулд хувийн бэрхшээл зовлонг тэсэж даван, хувийн ашиг сонирхолдоо хохирол амсахад бэлэн байх хэрэгтэй. Мөн чи зүрх сэтгэлдээ харамслыг мэдэрч чаддаг байх ёстой: Урьд нь чи Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаггүй байсан, одоо чи харамсаж чадна. Эдгээрийн аль нь ч чамд дутагдах ёсгүй—ийм зүйлсээр дамжуулан Бурхан чамайг төгс болгоно. Хэрэв чи эдгээр шалгуурыг хангаж чадахгүй бол төгс болгуулж чадахгүй.

Бурханд үйлчилдэг хүн Түүний төлөө хэрхэн зовохыг л гагцхүү мэддэг байх ёсгүй; түүгээр зогсохгүй Бурханд итгэх нь Бурханы хайрыг эрэлхийлэх зорилготой гэдгийг ойлгох ёстой. Бурхан чамайг зөвхөн цэвэршүүлэх гэж, эсвэл зовоохын төлөө ашигладаггүй, харин чамайг Түүний үйлдлийг мэдэж, хүний амийн жинхэнэ ач холбогдлыг мэдээсэй, тэр тусмаа Бурханд үйлчлэх амар ажил биш гэдгийг мэдээсэй гэсэндээ ашигладаг. Бурханы ажлыг туулах нь нигүүлслийг эдлэх биш, харин Бурханыг хайрлах хайрынхаа төлөө зовох юм. Чи Бурханы нигүүлслийг эдэлдэг юм чинь Түүний гэсгээлтийг ч бас эдлэх ёстой; чи энэ бүхнийг туулах ёстой. Чи Бурханы гэгээрлийг дотроо мэдэрч чадна, Тэр чамтай хэрхэн харьцаж, шүүж байгааг мөн туулж чадна. Ингэснээр чиний

туршлага иж бүрэн болно. Бурхан шүүлт, гэсгээлтийн ажлаа чам дээр хэрэгжүүлсэн. Бурханы үг чамтай харьцсан, түүгээр ч барахгүй мөн чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлсэн. Чамайг сөрөг, сул дорой байх үед Бурхан чиний төлөө санаа зовдог. Энэ бүх ажил нь хүний бүх зүйл Бурханы зохион байгуулалтын дотор байдаг гэдгийг чамд мэдүүлэхийн тулд юм. Бурханд итгэх гэдэг нь зовох, эсвэл Түүний төлөө төрөл бүрийн юм хийх явдал гэж чи бодож болох юм; Бурханд итгэхийн зорилго нь махан бие чинь амар тайван байх, чиний амьдралын бүх зүйл төвөггүй байх, эсвэл бүх зүйлд амгалан, тав тухтай байхын тулд байдаг гэж ч бодож болно. Гэхдээ эдгээрийн аль нь ч хүмүүсийн Бурханд итгэх итгэлтэйгээ холбох ёстой зорилго биш юм. Хэрэв чи эдгээр зорилгын төлөө итгэдэг бол харах өнцөг чинь буруу бөгөөд чамайг төгс болгох угаас боломжгүй. Бурханы үйлдэл, Бурханы зөвт зан чанар, Түүний мэргэн ухаан, Түүний үг, Түүний гайхалтай байдал, ойлгошгүй байдал нь бүгд хүмүүсийн ойлгох учиртай зүйлс юм. Чи ийм ойлголтоор дамжуулан өөрийн зүрх сэтгэл дэх бүх хувийн хэрэгцээ, найдвар, үзлийг арилгаж болох юм. Эдгээр зүйлийг арилгаж байж л Бурханы шаардсан нөхцөлд нийцэж чадна, үүнийг хийж байж л чи амьтай болж, Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадна. Бурханд итгэх нь Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүний шаарддаг зан чанарыг амьдран харуулах зорилготой байдаг, ингэснээр Түүний үйлдэл, алдар энэхүү ямар ч үнэ цэнгүй бүлэг хүнээр дамжин илэрч болох юм. Энэ бол Бурханд итгэх зөв харах өнцөг бөгөөд мөн чиний эрж хайх ёстой зорилт юм. Чи Бурханд итгэх талаар зөв үзэл бодолтой байж, Бурханы үгийг олж авахаар эрж хайх ёстой. Чи Бурханы үгийг идэж, уух хэрэгтэй, үнэнийг амьдран харуулж чаддаг байх ёстой, ялангуяа Түүний бодитой үйл хэрэг, орчлон даяарх гайхамшигтай үйл хэрэг, мөн махбодод хийдэг бодитой ажлыг нь харж чаддаг байх ёстой. Хүмүүс бодитой туршлагаараа дамжуулан Бурхан Өөрийн ажлыг тэдэн дээр яг хэрхэн хийдэг, тэдэнд чиглэсэн Түүний хүсэл юу болохыг үнэлж чадна. Энэ бүгд нь хүмүүсийн завхарсан сатанлаг зан чанарыг таягдан хаях зорилготой юм. Дотроо байгаа бүх цэвэр бус байдал, зөвт бус байдлыг хаяж, буруу санаа зорилгоо хаяж, Бурханд итгэх жинхэнэ итгэлийг бий болгосноор, жинхэнэ итгэлээр л чи Бурханыг үнэхээр хайрлаж чадна. Бурханд итгэх итгэлийнхээ суурин дээр л чи Түүнийг жинхэнээсээ хайрлаж чадна. Бурханд итгэхгүйгээр Түүнийг хайрлаж чадах уу? Чи Бурханд итгэдэг болохоор энэ талаар мунгинаад байж болохгүй. Зарим хүн Бурханд итгэх итгэл тэдэнд ерөөл авчирна гэдгийг харангуутаа эрч хүчээр дүүрэн болдог боловч цэвэршүүлэлтийг эдлэх ёстой гэдгийг харангуутаа

бүх эрч хүчээ алддаг. Энэ нь Бурханд итгэх мөн үү? Эцсийн дүнд итгэлдээ чи Бурханы өмнө бүрэн дүүрэн дуулгавартай дагадаг болох ёстой. Чи Бурханд итгэдэг мөртөө Түүнээс юм нэхсээр байдаг, тавьж чадахгүй шашны олон үзэл, салж чадахгүй хувийн ашиг сонирхол чамд байдаг, махан биеийн ерөөлийг эрж хайсаар байдаг, махан биеийг чинь аварч, сүнсийг чинь аврахыг Бурханаас хүсдэг бол эдгээр нь бүгд харах өнцөг нь буруу хүмүүсийн зан авир юм. Шашны итгэл үнэмшилтэй хүмүүс Бурханд итгэдэг хэдий ч зан чанараа өөрчлөхөөр эрж хайдаггүй, Бурханыг мэдэхээр эрэлхийлдэггүй, харин махан биеийн ашиг сонирхлын араас л хөөцөлддөг. Та нарын дотор олон хүн шашны итгэл үнэмшлийн ангилалд хамаарах итгэлтэй байдаг; энэ бол Бурханд итгэх жинхэнэ итгэл биш юм. Бурханд итгэхийн тулд хүмүүс Түүний төлөө зовоход бэлэн зүрх сэтгэл, өөрийгөө хаях хүсэлтэй байх ёстой. Хүмүүс энэ хоёр нөхцөлийг хангахгүй л бол Бурханд итгэх тэдний итгэл хүчингүй, тэд зан чанарын өөрчлөлтөд хүрч чадахгүй. Үнэнийг жинхэнээсээ эрэлхийлдэг, Бурханы мэдлэгийг эрж хайдаг, амийг эрэлхийлдэг хүмүүс л Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс билээ.

Чам дээр шалгалт ирэхэд тэдгээр шалгалтыг зохицуулахдаа Бурханы ажлыг хэрхэн хэрэглэх вэ? Чи сөрөг байх уу эсвэл хүн дээр хийх Бурханы шалгалт, цэвэршүүлэлтийг эерэг талаас нь ойлгох уу? Чи Бурханы шалгалт, цэвэршүүлэлтээр дамжуулан юуг олж авах вэ? Бурханыг гэх чиний хайр өсөх үү? Цэвэршүүлэлтэд орох үедээ Иовын шалгалтыг хэрэглэж, Бурханы чамд хийдэг ажилд чин сэтгэлээсээ оролцож чадах уу? Иовын шалгалтаар дамжуулан Бурхан хүнийг хэрхэн шалгадгийг чи харж чадах уу? Иовын ажил чамд ямар урам зориг өгч чадах вэ? Цэвэршүүлэлтийнхээ дунд чи Бурханы төлөө гэрчлэлд зогсоход бэлэн байх уу, эсвэл тав тухтай орчинд махан биеийг хангалуун байлгахыг хүсэх үү? Бурханд итгэх итгэлийн талаарх чиний харах өнцөг үнэндээ ямар вэ? Энэ нь үнэхээр махан биеийн төлөө биш, Түүний төлөө байдаг уу? Эрж хайхдаа эрэлхийлдэг зорилт чамд үнэхээр байдаг уу? Чи Бурханаар төгс болгуулахын тулд цэвэршүүлэлт туулахад бэлэн байна уу, эсвэл Бурханаар гэсгээгдэж, хараагдахыг илүүд үзэх үү? Бурханы төлөө гэрчлэл хийх хэрэг явдлын тухайд чи үнэндээ ямар үзэл бодолтой вэ? Бурханы төлөө жинхэнэ гэрчлэл хийх тодорхой орчин нөхцөлд хүмүүс юу хийх ёстой вэ? Чамд хийсэн жинхэнэ ажилдаа бодитой Бурхан маш ихийг илчилсэн байтал яагаад чи үргэлж явах тухай боддог вэ? Бурханд итгэх чиний итгэл Бурханы төлөө байдаг уу? Та нарын ихэнхийнх нь хувьд итгэл бол өөрийн хувийн ашиг тусыг эрэлхийлэхийн

төлөө, өөрийнхөө тусын тулд хийдэг тооцооны хэсэг юм. Маш цөөхөн хүн Бурханы төлөө Бурханд итгэдэг; энэ чинь тэрслүү байдал бус уу?

Цэвэршүүлэлтийн ажлын гол зорилго нь хүмүүсийн итгэлийг төгс болгох юм. Эцэст нь юунд хүрэх вэ гэхээр чи явахыг хүссэн ч явж чадахгүй, зарим хүн үлдсэн өчүүхэн найдвараа алдсан байсан ч гэсэн итгэсээр байж чадна, мөн хүмүүс хэтийн төлөвийнхөө төлөө ямар ч найдвар тээхээ болих юм. Зөвхөн энэ үед л Бурханы цэвэршүүлэлт дуусдаг. Амьдрал, үхлийн хооронд эргэлддэг үе шатанд хүн хүрээгүй л байгаа, тэд үхлийг үзээгүй учраас цэвэршүүлэлтийн явц хараахан дуусаагүй байна. Үйлчлэл үзүүлэгчийн шатанд байсан хүмүүс хүртэл дээд зэргээр цэвэршүүлэгдээгүй. Иов дээд зэргийн цэвэршүүлэлтийг туулсан, түүнд итгэж найдах юу ч байгаагүй. Хүмүүс ямар ч найдваргүй, итгэж найдах юу ч байхгүй болох хүртлээ цэвэршүүлэлтийг туулах ёстой—энэ л жинхэнэ цэвэршүүлэлт билээ. Үйлчлэл үзүүлэгчийн цаг үед зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван байсан бол, Тэр юу ч хийсэн, чиний төлөө гэсэн Түүний хүсэл ямар ч байсан, чи Түүний зохицуулалтыг үргэлж дуулгавартай дагасан бол замын төгсгөлд Бурханы хийсэн бүхнийг чи ойлгох болно. Чи Иовын шалгалтыг туулдаг, мөн нэгэн зэрэг Петрийн шалгалтыг туулдаг. Иовыг турших үед тэр гэрчлэлд зогсож, эцэст нь Ехова түүнд илчлэгдсэн. Гэрчлэлд зогссоны дараа л тэр Бурханы нүүр царайг харах эрхтэй болсон. “Би бузар газар нутгаас нуугдаж, ариун хаанчлалд Өөрийгөө харуулдаг” гэж яагаад хэлдэг вэ? Энэ нь чи ариун байж, гэрчлэлд зогссон үед л Бурханы нүүр царайг харах нэр хүндтэй болж чадна гэсэн үг юм. Хэрэв чи Түүний төлөө гэрчлэлд зогсож чадахгүй бол Түүний нүүр царайг харах нэр хүнд чамд байхгүй. Цэвэршүүлэлттэй тулгарахад ухарч няцан, Бурханы эсрэг гомдол гаргаж, ингэснээрээ Түүний төлөө гэрчлэлд зогсож чадалгүй, Сатаны доог тохуу болбол чи Бурханы илрэлтийг олж харахгүй. Хэрэв чи шалгалтын дунд өөрийн махан биеийг харааж, Бурханы эсрэг гомдоллолгүй, гомдоллож, үгээрээ нүгэл үйлдэлгүйгээр өөрийн махан биеийг жигшиж чадсан Иов шиг байвал гэрчлэлд зогсох болно. Цэвэршүүлэлтийг тодорхой хэмжээгээр туулсан ч Иов шиг хэвээр байж, Бурханы өмнө бүрэн дуулгавартай байж, Түүнээс өөр зүйл шаардахгүй, бас өөрийн үзэлгүй байж чадах аваас Бурхан чамд харагдана. Одоо чамд Бурхан харагддаггүйн учир нь чамд маш олон өөрийн гэсэн үзэл, хувийн алагчлал, хувиа хичээсэн бодол, хувийн шаардлага, махан биеийн ашиг сонирхол байдаг бөгөөд чи Түүний царай төрхийг харахад тэнцэхгүй. Хэрэв чи Бурханыг хардаг байсан бол өөрийн үзлээр Түүнийг хэмжинэ, ингэснээрээ чи Түүнийг загалмайд цовдлох байсан. Чиний үзэлтэй нийцэхгүй

олон зүйл чамд тохиолддог боловч чи тэдгээрийг хойш тавьж, тэдгээр зүйлээс Бурханы үйлдлийн талаар мэдлэг олж авч чаддаг бөгөөд цэвэршүүлэлтийн дунд Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээ илчилдэг бол энэ нь гэрчлэлд зогсох билээ. Гэр чинь амар тайван, махан биеийн тав тухад чи дуртай, хэн ч чамайг мөрдөн мөшгөхгүй, чуулган дахь ах эгч нар чинь чамайг дуулгавартай дагадаг бол чи Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээ харуулж чадах уу? Ийм нөхцөл байдал чамайг цэвэршүүлж чадах уу? Цэвэршүүлэлтээр л дамжуулан Бурханыг гэх хайраа харуулж чадна, чиний үзэлтэй нийцдэггүй зүйл тохиолдсоноор л чи төгс болгуулж чадна. Олон эсрэг, сөрөг зүйлийн үйлчлэлээр, мөн Сатаны үйлдэл, буруушаалт, үймээн, мэхлэлт гээд бүх төрлийн илрэлийг хэрэглэснээр Сатаны дургүй хүрмээр царайг Бурхан чамд тодорхой харуулж, ингэснээрээ Сатаныг ялган таних, Сатаныг үзэн ядаж, хаях чадварыг чинь төгс болгодог.

Чиний бүтэлгүйтэл, сул дорой байдлын олон туршлага, сөрөг байдалтай байх үеийг бүгдийг нь Бурханы шалгалт гэж хэлж болно. Учир нь бүх зүйл Бурханаас ирдэг, бүх зүйл, үйл явдал Түүний гарт байдаг. Чиний бүтэлгүйтэх эсэх эсвэл чиний сул дорой байж, бүдрэх эсэх нь бүгд Бурханаас шалтгаалах бөгөөд Бурханы гарт байдаг. Бурханы харах өнцгөөс энэ бол чиний шалгалт, хэрэв чи үүнийг таньж чадахгүй бол энэ нь уруу таталт болох болно. Хүмүүсийн таних ёстой хоёр төрлийн байдал байдаг: Нэг нь Ариун Сүнснээс ирдэг ба нөгөөгийнх нь магадлалтай эх үүсвэр нь Сатан юм. Нэг нь, Ариун Сүнс чамайг гэрэлтүүлснээр чамд өөрийгөө мэдэх, өөрийгөө жигших, өөртөө харамсах сэтгэл төрж, Бурханыг үнэхээр хайрлах, Түүнийг сэтгэл хангалуун байлгахад зүрх сэтгэлээ зориулах боломж олгодог байр байдал юм. Нөгөө нь чи өөрийгөө мэддэг боловч, сөрөг, сул дорой байдаг байр байдал юм. Энэ байдлыг Бурханы цэвэршүүлэлт, мөн Сатаны уруу таталт ч гэж хэлж болно. Хэрэв чи үүнийг чамайг аврах Бурханы аврал гэж танивал, мөн одоо Түүнд гүнээ өртэй гэдгээ мэдэрвэл, хэрэв одоогоос эхлэн Түүний ачийг хариулахаар хичээж, цаашид ийм доройтолд унахаа боливол, Түүний үгийг идэж, уухад хүчин чармайлт гаргавал, өөрийгөө үргэлж дутуу байна гэж үзэж, хүсэн тэмүүлэх зүрх сэтгэлтэй байвал энэ нь Бурханы шалгалт юм. Зовлон зүдүүр дуусаж, чи дахин нэгэнтээ урагшлах үед Бурхан чамайг хөтөлж, гэрэлтүүлж, гэгээрүүлж, тэжээн тэтгэсээр байх болно. Харин чи үүнийг танихгүй, сөрөг байж, өөрийгөө зүгээр л цөхрөлд оруулж, ийм байдлаар бодвол Сатаны уруу таталт чам дээр ирсэн байх болно. Иов шалгалт туулах үед Бурхан, Сатан хоёр хоорондоо мөрий тавьж байсан бөгөөд Иовыг зовоохыг Бурхан Сатанд зөвшөөрсөн. Хэдийгээр энэ нь Бурханы

Иовыг шалгах шалгалт байсан ч гэсэн үнэн хэрэгтээ Сатан түүн дээр ирсэн. Сатаны хувьд тэр Иовыг уруу татаж байсан боловч Иов Бурханы талд байсан. Тийм байгаагүй бол Иов уруу таталтад орох байсан. Хүмүүс уруу таталтад ормогцоо аюулд ордог. Цэвэршүүлэлт туулахыг Бурханы шалгалт гэж хэлж болох боловч хэрэв чи сайн байдалтай биш бол үүнийг Сатаны уруу таталт гэж хэлж болно. Үзэгдэл чамд тодорхой биш бол Сатан чамайг буруутгаж, үзэгдлийг чинь тодорхойгүй болгоно. Чи өөрөө ч мэдэлгүй уруу таталтад автана.

Чи Бурханы ажлыг туулахгүй бол хэзээ ч төгс болгуулж чадахгүй. Туршлагаараа чи мөн жижиг зүйлс рүү орох ёстой. Жишээ нь ямар зүйлс чамайг үзэл болон хэт их сэдэлтэй болгоход хүргэдэг, ямар төрлийн тохирох хэрэгжүүлэлтээр эдгээр асуудалд хандах ёстой болдог вэ? Хэрэв чи Бурханы ажлыг туулж чаддаг бол энэ нь чамд биеийн хэмжээ байна гэсэн үг юм. Хэрэв чамд эрч хүч байгаа юм шиг л харагддаг бол энэ нь жинхэнэ биеийн хэмжээ биш бөгөөд чи баттай зогсож огт чадахгүй байх болно. Чи Бурханы ажлыг туулж чаддаг, үүнийг хэзээ ч хаана ч туулж, тунгаан бодож чаддаг, хоньчдыг орхиж, Бурханыг түшиж бие даан амьдарч чаддаг, Бурханы бодит үйлдлийг харж чаддаг болсон цагт л Бурханы хүсэл биелэх болно. Яг одоо ихэнх хүн хэрхэн туршлагажихаа мэддэггүй бөгөөд тэд асуудалтай тулгарах үедээ хэрхэн зохицуулахаа мэддэггүй; тэд Бурханы ажлыг туулах чадваргүй, сүнслэг амьдралаар амьдарч чаддаггүй. Чи Бурханы үгийг авч, бодитой амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.

Заримдаа Бурхан чамд тодорхой нэг төрлийн мэдрэмжийг буюу дотоод баяр жаргал болон Бурханд ойр байдлаа алдахад хүргэж, харанхуйд живүүлдэг тийм мэдрэмжийг өгдөг. Энэ бол цэвэршүүлэлтийн нэг төрөл юм. Чи аливаа зүйлийг хийх болгондоо бүтэлгүйтэх юм уу эсвэл хана мөргөдөг. Энэ бол Бурханы сахилгажуулалт юм. Заримдаа чамайг Бурханд дуулгаваргүй, тэрслүү зүйл хийхэд хэн ч мэдэхгүй байж болох боловч Бурхан мэддэг. Тэр чамайг зүгээр өнгөрөөхгүй, сахилгажуулах болно. Ариун Сүнсний ажил маш нарийн байдаг. Тэр хүмүүсийн үг үйлдэл, үйл хөдлөл, бодол санаа бүрийг сайтар ажиглаж, ингэснээр хүмүүс эдгээр зүйлийн талаар дотоод мэдлэг ойлголт олж авдаг. Чи ямар нэг зүйлийг хийгээд бүтэлгүй болж, дахин хийгээд бас л бүтэлгүйтдэг, аажмаар чи Ариун Сүнсний ажлыг ойлгож авах болно. Олон удаагийн сахилгажуулалтаар дамжуулан чи Бурханы хүсэлд нийцүүлэхийн тулд юу хийх ёстой, Түүний хүсэлд юу нийцдэггүйг мэдэх болно. Эцэст нь чамайг дотроос чинь чиглүүлэх Ариун Сүнсний удирдамжид чи зөв хариу өгөх болно. Заримдаа

чи тэрслүү байх бөгөөд Бурхан чамайг дотроос чинь зэмлэх болно. Энэ бүхэн Бурханы сахилгажуулалтаас ирдэг. Хэрэв чи Бурханы үгийг нандигнадаггүй бол, Түүний ажилд хайнга хандвал Тэр чамайг хайхрахаа болино. Бурханы үгийг хэдий чинээ нухацтай авч үзнэ, Тэр чамайг төдий чинээ гэгээрүүлэх болно. Яг одоо чуулганд будилж, төөрөлдсөн итгэлтэй зарим хүн байгаа бөгөөд тэд маш олон зохисгүй зүйл хийж, сахилга батгүй үйлдэл гаргадаг учраас Ариун Сүнсний ажлыг тэднээс тодорхой харах боломжгүй байдаг. Зарим хүн мөнгө олохын тулд үүргээ умартаж, сахилгажуулагдалгүйгээр гарч бизнес хийдэг; ийм хүн илүү их аюулд ордог. Одоогоор тэдэнд Ариун Сүнсний ажил байхгүй төдийгүй ирээдүйд ч тэднийг төгс болгоход хэцүү байх болно. Олон хүнээс Ариун Сүнсний ажил, Бурханы сахилгажуулалтыг харах боломжгүй байдаг. Тэд бол Бурханы хүслийн талаар тодорхой ойлгоогүй, Түүний ажлыг мэддэггүй хүмүүс юм. Цэвэршүүлэлтийн дунд бат бөх зогсож чаддаг, Бурхан юу ч хийсэн Түүнийг дагадаг, ядаж л явахгүй байж чаддаг эсвэл Петрийн хүрсэн зүйлийн 0,1%-д нь хүрч чаддаг хүмүүс дажгүй явж байгаа боловч Бурханы тэднийг ашиглах тухайд гэвэл тэдэнд ямар ч үнэ цэн байхгүй. Олон хүн юмыг хурдан ойлгож, Бурханыг үнэхээр хайрлаж, Петрийн түвшнийг давж чаддаг бөгөөд Бурхан төгс болгох ажлаа тэдэн дээр хийдэг. Ийм хүмүүст сахилгажуулалт, гэгээрэл ирдэг бөгөөд Бурханы хүсэлтэй нийцэхгүй ямар нэг зүйл тэдэнд байвал тэд даруйхан хаяж чаддаг. Ийм хүмүүс бол алт, мөнгө, үнэт чулуунууд бөгөөд тэдний үнэ цэн хамгийн өндөр! Бурхан олон төрлийн ажил хийсэн боловч чи элс, чулуу мэт хэвээр байх юм бол ямар ч үнэ цэнгүй!

Агуу улаан лууны улс оронд хийсэн Бурханы ажил гайхамшигтай бөгөөд ойлгохын аргагүй билээ. Тэр нэг бүлэг хүнийг төгс болгож, бусдыг нь таягдан хаях болно, учир нь чуулганд бүхий л төрлийн хүн байдаг—үнэнийг хайрладаг хүмүүс байна, хайрладаггүй хүмүүс байна; Бурханы ажлыг туулдаг хүмүүс байна, туулдаггүй хүмүүс байна; үүргээ биелүүлдэг хүмүүс байна, биелүүлдэггүй хүмүүс байна; Бурханыг гэрчилдэг хүмүүс байна, гэрчилдэггүй хүмүүс байна, мөн тэдгээрийн тодорхой хэсэг нь үл итгэгчид, ёрын муу хүмүүс бөгөөд тэднийг гарцаагүй таягдан хаях болно. Хэрэв чи Бурханы ажлыг тодорхой мэддэггүй бол сөрөг байх болно; учир нь хүмүүсийн цөөнхөөс л Бурханы ажлыг харж болно. Энэ цаг үед хэн Бурханыг үнэхээр хайрладаг, хэн хайрладаггүй нь тодорхой болох болно. Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүст Ариун Сүнсний ажил байдаг байхад Түүнийг үнэхээр хайрладаггүй хүмүүс Түүний ажлын алхам бүрийн явцад илчлэгдэх болно. Тэд таягдан хаягдах объект болох болно. Байлдан

дагуулалтын ажлын явцад эдгээр хүн илчлэгдэх бөгөөд тэд бол төгс болгуулах үнэ цэнгүй хүмүүс билээ. Төгс болгуулсан хүмүүс бүгд Бурханаар авхуулсан бөгөөд Петрийн хайрладаг байсан шиг Бурханыг хайрлах чадвартай байдаг. Байлдан дагуулагдсан хүмүүст өөрөө үүссэн хайр биш харин идэвхгүй хайр л байдаг бөгөөд тэд албадлагаар Бурханыг хайрладаг. Өөрөө үүсдэг хайр нь бодит туршлагаар олж авсан ойлголтоор дамжин бий болдог. Энэ хайр хүний зүрх сэтгэлийг эзэмдэж, сайн дураараа Бурханы төлөө зүтгэхэд хүргэдэг; Бурханы үг тэдний үндэс суурь болж, тэд Бурханы төлөө зовж зүдэрч чаддаг. Мэдээж эдгээр нь Бурханаар төгс болгуулсан хүнд байдаг зүйлс юм. Хэрэв чи байлдан дагуулагдахыг л эрэлхийлдэг бол Бурханы төлөө гэрчлэл хийж чадахгүй; Бурхан хүмүүсийг байлдан дагуулах замаар л авралын зорилгодоо хүрдэг бол үйлчлэл үзүүлэгчдийн алхам ажлыг дуусгах байсан. Гэхдээ Бурханы эцсийн зорилго нь хүмүүсийг байлдан дагуулах биш, харин хүмүүсийг төгс болгох юм. Тиймээс энэ үе шатыг байлдан дагуулалтын ажил гэж хэлэхийн оронд төгс болгох, таягдан хаях ажил гэж хэл. Зарим хүн бүрэн байлдан дагуулагдаагүй бөгөөд тэднийг байлдан дагуулах явцад бүлэг хүн төгс болох болно. Энэ хоёр хэсэг ажлыг нэгэн зэрэг хэрэгжүүлдэг. Ийм урт хугацааны ажлын туршид хүртэл хүмүүс орхиж яваагүй бөгөөд энэ нь байлдан дагуулалт зорилгодоо хүрсэн гэдгийг харуулдаг—энэ бол байлдан дагуулагдсаны баримт юм. Цэвэршүүлэлт нь байлдан дагуулагдахын төлөө биш, харин төгс болгуулахын төлөө байдаг. Цэвэршүүлэлтгүйгээр хүмүүсийг төгс болгох боломжгүй. Тиймээс цэвэршүүлэлт үнэхээр үнэ цэнтэй! Өнөөдөр нэг бүлэг хүмүүс төгс болгуулж, авхуулагдаж байна. Өмнө нь дурдагдсан арван ерөөл нь бүгд төгс болгуулсан хүмүүст чиглэсэн юм. Газар дээрх дүр төрхөө өөрчлөх тухай зүйл нь бүгд төгс болгуулсан хүмүүст чиглэдэг. Төгс болгуулаагүй хүмүүс Бурханы амлалтыг хүлээж авах шаардлага хангадаггүй.

ЗОВЛОНТ ШАЛГАЛТЫГ ТУУЛСНААР Л БУРХАНЫ ХАЙР ТАТАМ БАЙДЛЫГ МЭДЭЖ БОЛНО

Өнөөдөр чи Бурханыг яг хэр их хайрладаг вэ? Бурханы чамд хийсэн бүхний талаар яг хэр ихийг мэддэг вэ? Эдгээр нь чиний сурах ёстой зүйлс юм. Бурхан газар дээр ирээд хүнд хийсэн, хүнд харуулсан бүхэн нь хүнээр Өөрийгөө хайрлуулж, Өөрийгөө мэдүүлэхийн төлөө байдаг. Хүн Бурханы төлөө зовж, өдий хүрч чадсан нь нэг талаар Бурханы хайраас, нөгөө талаар Бурханы

авралаас болдог; түүнчлэн энэ нь хүний дотор Бурханы хийдэг шүүлт, гэсгээлтийн ажлаас болдог. Хэрэв та нарт Бурханы шүүлт, гэсгээлт, шалгалт байхгүй бол, хэрэв Бурхан та нарыг зовоогоогүй бол ний нуугүй хэлэхэд, та нар Бурханыг үнэхээр хайрладаггүй юм байна. Хүний доторх Бурханы ажил их байх тусам, хүний зовлон их байх тусам Бурханы ажил хэчнээн утга учиртай нь төдий чинээ илэрхий байдаг бөгөөд хүний зүрх сэтгэл Бурханыг төдий чинээ жинхэнээсээ хайрлаж чаддаг. Чи Бурханыг хэрхэн хайрлаж сурах вэ? Тарчлаан, цэвэршүүлэлтгүйгээр, зовлонт шалгалтгүйгээр, мөн түүнчлэн Бурхан хүнд нигүүлсэл, хайр, өршөөлийг л өгдөг байсан бол чи Бурханыг үнэхээр хайрлаж чадах хэмжээнд хүрэх байсан уу? Бурханы шалгалтын үеэр хүн нэг талаар, өөрийнхөө дутагдлыг мэдэж авч, өчүүхэн, олиггүй, дорд гэдгээ болон өөрт нь юу ч байхгүй, өөрөө юу ч биш гэдгийг хардаг; нөгөө талаар, шалгалтынхаа үеэр Бурхан хүнд зориулан өөр өөр орчин бүтээж, хүнийг Бурханы хайр татам байдлыг улам илүү мэдрэх чадвартай болгодог. Өвдөлт шаналал асар их, заримдаа гэтлэхийн аргагүй байдаг ч—бүр няц дарам гаслангийн хэмжээнд хүрдэг ч—үүнийг туулаад хүн өөрийнх нь доторх Бурханы ажил хэчнээн хайр татам болохыг хардаг бөгөөд энэ суурин дээр л Бурханыг гэх жинхэнэ хайр хүний дотор төрдөг. Өнөөдөр хүн, гагцхүү Бурханы нигүүлсэл, хайр, өршөөлтэйгээр өөрийгөө үнэхээр мэдэж чадахгүй, хүний мөн чанарыг мэдэж бүр ч чадахгүй гэдгийг хардаг. Бурханы цэвэршүүлэлт, шүүлтийн аль алинаар л дамжуулан, цэвэршүүлэлтийн үйл явцын үеэр л хүн дутагдлаа мэдэж, өөрт нь юу ч байхгүй гэдгийг мэдэж чадна. Тиймээс Бурханыг гэх хүний хайр Бурханы цэвэршүүлэлт, шүүлтийн суурин дээр бий болдог. Хэрэв чи зөвхөн Бурханы нигүүлслийг эдэлж, амар тайван гэр бүлтэй, эсвэл материаллаг ерөөлтэй байгаа бол Бурханыг хараахан олж аваагүй бөгөөд Бурханд итгэх итгэлийг чинь амжилттай гэж үзэж болохгүй. Бурхан нигүүлслийн ажлын нэг үе шатыг аль хэдийн махбодоор гүйцэтгэчихсэн, бас хүнд материаллаг ерөөл аль хэдийн хүртээчихсэн, гэхдээ хүн гагцхүү нигүүлсэл, хайр, өршөөлөөр төгс болгуулж чадахгүй. Хүмүүс туршлагаараа Бурханы хайрын заримыг мэдэрч, Бурханы хайр, өршөөлийг хардаг ч үүнийг хэсэгхэн хугацаанд туулаад, Бурханы нигүүлсэл, хайр, өршөөл нь хүнийг төгс болгож чадахгүй, хүний доторх завхарсан зүйлийг илчилж чадахгүй, хүнийг завхарсан зан чанараас нь ангижруулж чадахгүй, хайр, итгэлийг нь төгс болгож чадахгүй гэдгийг хардаг. Бурханы нигүүлслийн ажил нь нэг үе шатны ажил байсан бөгөөд хүн Бурханы нигүүлслийг эдэлснээр Бурханыг мэдэж авч чадахгүй.

Бурхан ямар арга барилаар дамжуулан хүнийг төгс болгодог вэ? Өөрийнхөө зөвт зан чанараар үүнийг гүйцэтгэдэг. Бурханы зан чанар нь үндсэндээ зөвт байдал, уур хилэн, сүр жавхлан, шүүлт, хараалаас бүрддэг бөгөөд Тэрээр хүнийг үндсэндээ шүүлтээрээ дамжуулан төгс болгодог. Зарим хүн ойлгодоггүй бөгөөд Бурхан яагаад хүнийг шүүлт, хараалаар л төгс болгож чаддаг юм бэ гэж асуудаг. Тэд: “Бурхан хүнийг хараавал хүн үхэхгүй гэж үү? Хэрэв Бурхан хүнийг шүүвэл хүн яллагдахгүй гэж үү? Тэгвэл түүнийг яаж бас төгс болгож чадах юм бэ?” гэгцгээдэг. Энэ бол Бурханы ажлыг мэддэггүй хүмүүсийн үг юм. Бурхан хүний дуулгаваргүй занг харааж, хүний нүглийг шүүдэг. Тэрээр хатуу ширүүнээр, хайр найргүйгээр ярьдаг хэдий ч хүний дотор буй бүхнийг илчилж, эдгээр хатуу үгээр хүний доторх гол зүйлийг ил болгож, ийм шүүлтээр дамжуулан махан биеийн мөн чанарын талаар хүнд гүн гүнзгий мэдлэг өгч, улмаар хүн Бурханы өмнө дуулгавартай байдаг. Хүний махан бие нүгэл болон Сатанд харьяалагддаг, энэ нь дуулгаваргүй бөгөөд Бурханы гэсгээлтийн бай юм. Тиймээс хүнд өөрийгөө мэдэх боломжийг олгохын тулд Бурханы шүүлтийн үг түүн дээр буух ёстой ба төрөл бүрийн цэвэршүүлэлт хэрэглэх ёстой; зөвхөн тэр үед л Бурханы ажил үр нөлөөтэй болж чадна.

Бурханы хэлсэн үгээс үзэхэд хүний махан биеийг Тэр аль хэдийн ялласан нь харагддаг. Тэгэхээр эдгээр үг нь хараалын үг биш гэж үү? Бурханы хэлсэн үг хүний үнэн царайг илчилж, тийм илчлэлээр дамжуулан хүнийг шүүдэг бөгөөд Бурханы хүслийг хангаж чадахгүй гэдгээ мэдэх үедээ хүн дотроо гашуудан харуусаж, Бурханд маш их өртэйгөө, Бурханы хүсэлд хүрч чадахгүй гэдгээ мэдэрдэг. Ариун Сүнс чамайг дотроос чинь сахилгажуулах үе байдаг ба энэ сахилгажуулалт Бурханы шүүлтээс гардаг; Бурхан чамайг зэмлэж, чамаас царайгаа нуун, чамайг үл хайхарч, дотор чинь ажиллахгүй байж, чамайг цэвэршүүлэхийн тулд чимээгүйхэн гэсгээх үе бий. Хүний доторх Бурханы ажил нь үндсэндээ Өөрийн зөвт зан чанарыг ил болгохын төлөө байдаг. Эцэстээ хүн Бурханы өмнө ямар гэрчлэл хийдэг вэ? Бурхан бол зөвт Бурхан, Түүний зан чанар бол зөвт байдал, уур хилэн, гэсгээлт, шүүлт юм гэдгийг хүн гэрчилдэг; хүн Бурханы зөвт зан чанарыг гэрчилдэг. Хүнийг төгс болгохын тулд Бурхан шүүлтээ хэрэглэдэг, Тэр хүнийг хайрлаж, аварсан—гэхдээ Түүний хайр хэр ихийг агуулдаг вэ? Тэнд шүүлт, сүр жавхлан, уур хилэн, хараал бий. Урьд нь Бурхан хүнийг хараасан хэдий ч ёроолгүй нүхэнд бүрмөсөн хаяагүй, харин хүний итгэлийг цэвэршүүлэхийн тулд тэр аргыг ашигласан; хүнийг Тэр үхүүлээгүй, харин хүнийг төгс болгохын төлөө үйлдсэн юм. Махан биеийн мөн

чанар Сатаных байдаг—Бурхан үүнийг яг зөв хэлсэн—гэхдээ Бурханы гүйцэтгэсэн баримт хэлсэн үгийнх нь дагуу гүйцэлддэггүй. Тэр Өөрийгөө хайрлуулах гэж, мөн махан биеийн мөн чанарыг мэдүүлэх гэж чамайг хараадаг; чамайг сэрээж, чамд буй дутагдлыг ухааруулж, хүний туйлын үнэ цэнгүй байдлыг мэдүүлэх гэсэндээ Тэр чамайг гэсгээдэг. Тиймээс Бурханы хараал, Түүний шүүлт, Түүний сүр жавхлан, уур хилэн—бүгд хүнийг төгс болгохын төлөө байдаг билээ. Өнөөдөр Бурханы хийдэг бүхэн, мөн та нарын дотор Түүний ил болгодог зөвт зан чанар—энэ бүхэн нь хүнийг төгс болгохын төлөө байдаг. Энэ нь Бурханы хайр юм.

Хүний уламжлалт үзлээр, Бурханы хайр бол Түүний нигүүлсэл, өршөөл, хүний сул талыг өрөвдөх хайр энэрэл юм гэж хүн боддог. Хэдий эдгээр зүйл ч бас Бурханы хайр мөн боловч хэтэрхий өрөөсгөл бөгөөд хүнийг төгс болгодог Бурханы үндсэн арга барил биш. Зарим хүн өвчнөөс болоод Бурханд итгэж эхэлсэн. Энэ өвчин бол чамд зориулсан Бурханы нигүүлсэл; үүнгүйгээр ч Бурханд итгэхгүй байх байсан бөгөөд хэрвээ ч Бурханд итгээгүй бол өдий хүрч чадахгүй байх байсан—тиймээс энэ нигүүлсэл ч гэсэн Бурханы хайр юм. Есүст итгэдэг байсан цаг үед хүмүүс үнэнийг ойлгоогүй учраас Бурханы дургүйг хүргэх юм их хийсэн, гэвч Бурханд хайр, өршөөл байдаг бөгөөд Тэрээр хүнийг өдий хүргэсэн, мөн хүн юу ч ойлгодоггүй хэдий ч Өөрийг нь дагахыг Бурхан хүнд зөвшөөрдгөөс гадна хүнийг эдүгээ хүртэл удирдан хөтөлсөн. Энэ Бурханы хайр биш гэж үү? Бурханы зан чанараас харагддаг зүйл бол Бурханы хайр юм—энэ бол туйлын үнэн! Чуулганыг байгуулах явдал оргилдоо хүрэх үед Бурхан үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхмыг хийж, хүнийг ёроолгүй нүхэнд хаясан. Үйлчлэл үзүүлэгчдийн үеийн үгс бүгд махан биеийг чинь хараах, завхарсан сатанлаг зан чанарыг чинь хараах, мөн Бурханы хүслийг хангалуун байлгадаггүй зүйлсийг чинь хараах хараал байлаа. Тэрхүү алхамд Бурханы хийсэн ажил сүр жавхлан мэт харагдаж, үүний дараахан Бурхан гэсгээлтийн ажлын алхмыг гүйцэтгээд, үхлийн шалгалт эхэлжээ. Ийм ажлаас хүн Бурханы уур хилэн, сүр жавхлан, шүүлт, гэсгээлтийг харахын зэрэгцээ бас Бурханы нигүүлсэл, хайр, өршөөлийг харсан юм; Бурханы хийсэн бүхэн, Түүний зан чанар болж харагдсан бүхэн нь хүнийг гэх Бурханы хайр байсан бөгөөд Бурханы хийсэн бүхэн хүний хэрэгцээг хангаж чадсан. Хүнийг төгс болгохын тулд Тэр үүнийг хийсэн ба биеийнх нь хэмжээний дагуу хүнийг хангажээ. Бурхан үүнийг хийгээгүй бол хүн Бурханы өмнө ирж чадахгүй, Бурханы үнэн нүүр царайг мэдэх аргагүй байх байлаа. Хүн анх Бурханд итгэж эхэлсэн цагаас өнөөг хүртэл

Бурхан хүнийг биеийн хэмжээнд нь тааруулан зугуухан хангаж байсан ба ингэснээр хүн дотроо Бурханыг аажмаар мэдэж авчээ. Өнөөдөр л хүн Бурханы шүүлт хэчнээн гайхалтайг ухаарч байна. Үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхам нь бүтээлийн цаг үеэс өнөөг хүртэлх хараах ажлын анхны тохиолдол байв. Хүн ёроолгүй нүх рүү хараагдсан. Хэрвээ Бурхан тэгээгүй бол хүн өнөөдөр Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болохгүй байх байлаа; Бурханы хараалаар л дамжуулан хүн Бурханы зан чанартай албан ёсоор тулгарсан юм. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаар дамжуулан хүн илчлэгдсэн. Тэрээр өөрийнх нь үнэнч зан хүлээн зөвшөөрөхийн аргагүй, биеийн хэмжээ нь дэндүү жаахан, Бурханы хүслийг хангах чадваргүй, бас Бурханыг цаг үргэлж хангалуун байлгана гэж хэлдэг нь хоосон үгээс цаашгүй гэдгийг харжээ. Үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхамд Бурхан хүнийг хараасан хэдий ч одоо эргээд харахад Бурханы ажлын тэрхүү алхам гайхалтай байлаа: Энэ нь хүний хувьд агуу эргэлтийн цэг болж, түүний амь зан чанарт асар их өөрчлөлт гаргажээ. Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үеэс өмнө хүн амийн эрэл хайгуулын талаар, Бурханд итгэх нь юу гэсэн үг болох талаар, эсвэл Бурханы ажлын мэргэн ухааны талаар юу ч ойлгоогүй, мөн Бурханы ажил хүнийг туршиж чадна гэдгийг ч ойлгоогүй. Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үеэс өнөөдрийг хүртэлх Бурханы ажил хэчнээн гайхалтай болохыг, хүний ухаан хүрэмгүй гэдгийг олж хардаг. Хүн толгойгоо ажиллуулаад ч Бурхан хэрхэн ажилладгийг төсөөлж чадахгүй гэдгээ харж, түүнчлэн өөрийнх нь биеийн хэмжээ үнэхээр өчүүхэн ба өөрт нь дуулгаваргүй зүйл хэтэрхий их байдгийг хардаг. Бурхан хүнийг хараах үед энэ нь үр дүнд хүрэхийн төлөө байсан бөгөөд Тэр хүнийг үхүүлээгүй юм. Хэдийгээр Тэр хүнийг хараасан ч үгээр л үүнийгээ хийсэн бөгөөд Түүний хараал үнэндээ хүнд тусаагүй, учир нь Бурханы хараасан зүйл хүний дуулгаваргүй байдал байсан тул Түүний хараалын үг ч бас хүнийг төгс болгохын төлөө хэлэгдсэн. Бурхан хүнийг шүүсэн ч бай, хараасан ч бай, аль аль нь хүнийг төгс болгодог: Хоёулаа хүний доторх ариун бус зүйлийг төгс болгохын төлөө хийгддэг. Энэ аргаар дамжуулан хүн цэвэршүүлэгдэж, хүний дотор дутагдаж байгаа зүйл Түүний үг, ажлаар дамжуулан төгс болдог. Бурханы ажлын алхам бүр—хатуу ширүүн үг ч бай, шүүлт ч бай, эсвэл гэсгээлт ч бай—хүнийг төгс болгодог бөгөөд туйлын зохистой байдаг. Эрин үеүдийн туршид Бурхан ийм ажил хэзээ ч хийж байгаагүй; өнөөдөр Тэр та нарын дотор ажилладаг болохоор та нар Түүний мэргэн ухааныг ойлгодог. Та нар дотроо жаахан өвдөж шаналсан ч зүрх сэтгэл чинь тууштай, амар амгалан байгаа; Бурханы ажлын энэ үе шатыг эдлэх чадвартай байгаа нь та нарын ерөөл билээ.

Ирээдүйд юу олж авч чадах чинь хамаагүй, өнөөдөр та нарын дотор Бурханы хийсэн ажил бүхэлдээ хайр гэдгийг л та нар хардаг. Хэрвээ хүн Бурханы шүүлт, цэвэршүүлэлтийг туулдаггүй бол түүний үйлдэл, урам зориг үргэлж өнгөцхөн түвшинд үлдэж, зан чанар нь үргэлж өөрчлөгдөөгүй хэвээр үлдэнэ. Үүнийг Бурханаар авхуулсанд тооцдог уу? Эдүгээ хүний дотор биеэ тоосон, ихэрхүү зан ихээхэн байсаар байгаа боловч хүний зан чанар урьдынхаасаа хавьгүй илүү тогтвортой байдаг. Бурхан чамтай харьцдаг нь чамайг аврахын төлөө байдаг бөгөөд чи тухайн үед хэсэг шаналж магадгүй боловч зан чанарт чинь өөрчлөлт гарах өдөр ирнэ. Тэр үед чи эргэж хараад, Бурханы ажил хэчнээн ухаалаг болохыг ойлгоно, тэр үед л чи Бурханы хүслийг үнэхээр ойлгож чадна. Өнөөдөр Бурханы хүслийг ойлгодог гэж хэлдэг зарим хүн байдаг боловч тэр нь дэндүү бодитой бус юм. Үнэн хэрэгтээ тэд худал ярьж байна, яагаад гэвэл, Бурханы хүсэл хүнийг аврахын төлөө байдаг уу, эсвэл хараахын төлөө байдаг уу гэдгийг тэд одоогоор хараахан ойлгоогүй байгаа. Чи одоо үүнийг тодорхой харж чадахгүй байж болох ч Бурхан алдрыг олж авсан өдөр ирснийг харах үе ирж, Бурханыг хайрлах нь хэчнээн утга учиртайг харна, ингэснээр чи хүний амьдралыг мэдэж авч, махан бие чинь Бурханыг хайрлах ертөнцөд амьдарч, сүнс чинь эрх чөлөөтэй болж, амьдрал чинь баяр хөөрөөр дүүрч, чи үргэлж Бурханд ойр байж, үргэлж Бурхан руу харан найдах болно. Тэр цагт чи өнөөдрийн Бурханы ажил хэчнээн үнэ цэнтэйг лавтайяа мэднэ.

Өнөөдөр ихэнх хүмүүст тийм мэдлэг байдаггүй. Тэд зовлон үнэ цэнгүй, дэлхий ертөнц өөрсдийг нь хаясан, ар гэрийнх нь амьдрал төвөгтэй, өөрсдийг нь Бурхан хайрладаггүй, хэтийн ирээдүй нь бүрхэг гэж итгэдэг. Зарим хүний зовлон дээд цэгтээ хүрэхэд тэдний бодол үхэл рүү ханддаг. Энэ бол Бурханыг гэх жинхэнэ хайр биш; тийм хүмүүс бол хулчгарууд, тэд ямар ч хатуужилгүй, сул дорой, хүчин мөхөс! Хүн Өөрийг нь хайрлаасай хэмээн Бурхан хүсэмжилдэг, гэвч хүн Түүнийг хайрлах тусам хүний зовлон улам ихэсдэг бөгөөд хүн Түүнийг хайрлах тусам хүний шалгалт улам ихэсдэг. Хэрвээ чи Түүнийг хайрлавал төрөл бүрийн зовлон чамайг нөмөрнө, хэрвээ хайрлахгүй бол магадгүй бүх зүйл төвөггүй явагдаж, эргэн тойрны чинь бүх юм амар жимэр болно. Бурханыг хайрлах үедээ чи, эргэн тойрны чинь ихэнх зүйл даван туулшгүй гэдгийг, бас биеийн хэмжээ чинь дэндүү жаахан учраас цэвэршүүлэгдэнэ гэдгээ мэдэрнэ; түүнчлэн, чи Бурханыг хангалуун байлгах чадваргүй байх бөгөөд Бурханы хүсэл хэтэрхий өндөр дээд, хүн хүрэхийн аргагүй гэдгийг үргэлж мэдэрнэ. Энэ бүхнээс болж чи цэвэршүүлэгдэнэ—чиний дотор ихээхэн сул тал байдаг, мөн Бурханы

хүслийг хангах чадваргүй зүйл их байдаг учраас чи дотроо цэвэршүүлэгдэнэ. Гэсэн ч цэвэршүүлэлтээр л дамжуулан ариусгалтад хүрдэг гэдгийг та нар тодорхой харах ёстой. Тиймээс эцсийн энэ өдрүүдэд та нар Бурханд гэрчлэл хийх ёстой. Зовлон чинь хэчнээн их байх нь хамаагүй, та нар бүр эцсийг нь хүртэл алхах ёстой, эцсийн амьсгалаа авч байхдаа ч Бурханд үнэнч байж, Бурханы зохицуулалтад захирагдсаар байх ёстой; энэ нь л Бурханыг үнэхээр хайрлаж байгаа хэрэг бөгөөд энэ нь л хүчтэй, цангинасан гэрчлэл юм. Сатанд уруу татагдах үедээ чи: “Миний зүрх сэтгэл Бурханд харьяалагддаг, Бурхан намайг аль хэдийн олж авсан. Би чамайг хангалуун байлгаж чадахгүй—би Бурханыг хангалуун байлгахын төлөө бүхнээ зориулах ёстой” гэж хэлэх хэрэгтэй. Чи Бурханыг хангалуун байлгах тусам Бурхан чамайг улам их ерөөж, Бурханыг гэх хайр чинь төдий чинээ хүчтэй байдаг; иймээс чи бас итгэлтэй, шийдвэртэй байж, Бурханыг хайрлаж өнгөрүүлсэн амьдралаас илүү үнэ цэнтэй, ач холбогдолтой юу ч үгүй гэдгийг мэдэрнэ. Хүн Бурханыг хайрлаж байж л уй гашуугүй байдаг гэж хэлж болно. Махан бие чинь сульдаж, олон бодит зовлонд ороогдох үе байдаг боловч тийм үеүдэд чи Бурханд үнэхээр найдах бөгөөд сүнсэн дотроо тайтгарч, итгэлтэй байж, түшиглэх ямар нэгэн зүйл чамд байгааг мэдэрнэ. Ийм маягаар чи олон орчин нөхцөлийг даван гарч чадах тул амсдаг зовлон шаналлаасаа болоод Бурханы талаар гомдоллохгүй. Харин дуулж, бүжиглэж, залбирч, цугларч, нөхөрлөж, Бурханыг бодохыг хүсэх бөгөөд эргэн тойронд чинь Бурханы зохицуулдаг бүх хүн, хэрэг явдал, зүйл тохиромжтой гэдгийг мэдэрнэ. Чи Бурханыг хайрладаггүй бол харсан бүхэн чинь чамд яршигтай санагдаж, нүдэнд чинь юу ч аятайхан харагдахгүй; сүнсээрээ чи чөлөөтэй бус, харин сэтгэлийн дарамттай байх ба зүрх сэтгэл чинь үргэлж Бурханы талаар гомдоллоно, мөн маш их тарчлаан амсаж байгаа чинь тун шударга бус юм гэж чамд үргэлж санагдана. Хэрвээ чи аз жаргалын хойноос хөөцөлддөггүй, харин Бурханыг хангалуун байлгахын тулд, Сатанаар буруутгагдахгүйн төлөө эрэлхийлдэг бол ийм эрэл хайгуул чамд Бурханыг хайрлах асар их хүч өгнө. Хүн Бурханы хэлсэн бүхнийг хэрэгжүүлэх чадвартай, бас хийдэг бүхэн нь Бурханыг хангалуун байлгах чадвартай—бодит байдлыг эзэмших гэдэг нь энэ юм. Бурханыг хангалуун байлгахаар эрэлхийлнэ гэдэг нь Бурханы үгийг хэрэгжүүлэхийн тулд Бурханыг гэх хайраа ашиглах явдал юм; цаг хугацаанаас үл хамааран—бусад хүн хүч чадалгүй байлаа ч гэсэн—чиний дотор Бурханыг хайрладаг, Бурханыг гүнээ эгээрэн хүсэж, Бурханыг үгүйлдэг зүрх сэтгэл байсаар байгаа. Энэ бол жинхэнэ биеийн хэмжээ юм. Чиний биеийн

хэмжээ яг хэр том болох нь Бурханыг хэр их хайрладгаас чинь, туршигдах үедээ бат зогсож чаддаг эсэхээс чинь, тодорхой орчин нөхцөл тохиолдоход сул дорой болдог эсэхээс чинь, мөн ах, эгч нар чинь чамайг голох үед байр сууриндаа бат зогсож чаддаг эсэхээс чинь хамаардаг; Бурханыг гэх хайр чинь яг ямархуу болохыг бодит баримтууд харуулна. Бурхан хүнд үнэхээр хайртай гэдгийг Бурханы олон ажлаас харж болно, гэхдээ хүний сүнсний нүд хараахан бүрэн нээгдээгүй бөгөөд тэрээр Бурханы ажил болон хүслийн ихээхнийг тодорхой харж чаддаггүй, Бурханы хайр татам олон зүйлийг ч тодорхой харж чаддаггүй; хүнд Бурханыг гэх жинхэнэ хайр дэндүү бага байдаг. Чи энэ бүх хугацаанд Бурханд итгэсэн ба өнөөдөр Бурхан зугтах бүх арга замыг чинь хаасан. Үнэнийг хэлэхэд, чи зөв замыг буюу Бурханы хатуу шүүлт, дээд авралаар чамайг удирдан хөтөлсөөр ирсэн зөв замыг сонгохоос өөр аргагүй. Бэрхшээл, цэвэршүүлэлт туулсны дараа л хүн Бурхан хайр татам гэдгийг мэддэг. Өнөөдрийг хүртэл туулсан болохоор хүн Бурханы хайр татам байдлын нэг хэсгийг мэдэж авсан гэж хэлж болно, гэхдээ хүн маш дутуу дулимаг учраас энэ нь бас л хангалтгүй. Хүн Бурханы гайхалтай ажлыг, мөн Бурханы зохицуулсан зовлонгийн бүх цэвэршүүлэлтийг илүү их туулах ёстой. Тэр үед л хүний амь зан чанар өөрчлөгдөж чадна.

БУРХАНЫГ ХАЙРЛАХ НЬ Л ҮНЭХЭЭР БУРХАНД ИТГЭЖ БУЙ ХЭРЭГ

Өнөөдөр та нар Бурханыг мэдэж, хайрлахаар эрж хайхдаа нэг талаар зовлон бэрхшээл, цэвэршүүлэлт туулж, нөгөө талаар төлөөс төлөх ёстой. Бурханыг хайрлах хичээлээс илүү гүн гүнзгий хичээл гэж үгүй бөгөөд насан туршдаа итгэхдээ хүмүүсийн авдаг сургамж нь Бурханыг хэрхэн хайрлах тухай байдаг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи Бурханд итгэдэг бол Бурханыг хайрлах ёстой. Чи Бурханд итгэдэг л болохоос Түүнийг хайрладаггүй, Бурханы тухай мэдлэгийг олж аваагүй, зүрх сэтгэлийн гүнээс гардаг жинхэнэ хайраар Бурханыг хэзээ ч хайрлаж байгаагүй бол Бурханд итгэх итгэл чинь ямар ч үр ашиггүй юм; хэрвээ чи Бурханд итгэхдээ Бурханыг хайрладаггүй бол чи хий дэмий амьдарч байгаа бөгөөд амьдрал чинь тэр чигээрээ бүхий л амьдралаас хамгийн дорд байдаг. Чи бүх амьдралынхаа туршид Бурханыг хэзээ ч хайрлаж, сэтгэл хангалуун байлгаж байгаагүй бол амьдрахын хэрэг юу байна? Мөн чи Бурханд итгэхийн хэрэг юу байна? Энэ чинь хүчин чармайлтын гарз бус уу?

Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүс Бурханд итгэж, хайрлах гэж байгаа бол төлөөс төлөх ёстой. Гаднаа тодорхой нэг байдлаар үйлдэх гэж оролдохоос илүүтэйгээр зүрх сэтгэлийнхээ гүнээс жинхэнэ мэдлэг ухааныг эрж хайх хэрэгтэй. Хэрвээ чи урам зоригтойгоор дуулж, бүжиглэдэг боловч үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй бол Бурханыг хайрладаг гэж чамайг хэлж болох уу? Бурханыг хайрлахад Бурханы хүслийг бүх зүйлээс эрж хайхыг шаарддагийн дээр ямар нэгэн зүйл тохиолдох үед сэтгэлийнхээ гүнээс эрж хайн, Бурханы хүслийг ухаарч ойлгохыг оролдож, хэрэг явдлаас Бурханы хүсэл юу болох, чамайг юунд хүрээсэй гэж Тэр хүсдэг, Түүний хүсэлд хэрхэн санаа тавих хэрэгтэйг харах гэж оролдохыг шаарддаг. Жишээ нь: Зовлон бэрхшээл туулахыг шаардсан ямар нэг зүйл тохиолдоход Бурханы хүсэл юу болох, Түүний хүсэлд хэрхэн санаа тавих хэрэгтэйгээ чи ойлгох ёстой. Чи өөрийгөө сэтгэл хангалуун байлгах ёсгүй: Эхлээд өөрийгөө хойш тавь. Махан биеэс илүү жигшүүртэй юу ч байхгүй. Чи Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрэлхийлж, үүргээ биелүүлэх ёстой. Ийм бодолтой байхад энэ хэрэг явдал дээр Бурхан чамд онцгой гэгээрэл авчирч, зүрх сэтгэл чинь бас тайтгарлыг олох болно. Чамд том ч бай, жижиг ч бай ямар нэг асуудал тохиолдоход чи эхлээд өөрийгөө хойш тавьж, махан биеийг бүх зүйлээс хамгийн дорд зүйл гэж үзэх ёстой. Чи махан биеийг хэдий чинээ их хангалуун байлгана, төдий чинээ дураараа аашилдаг; энэ удаа чи түүнийг хангалуун болговол дараагийн удаа илүү ихийг хүснэ. Ийнхүү үргэлжлэхийн хэрээр хүмүүс махан биеийг бүр ч их хайрлаж эхэлдэг. Махан бие үргэлж хэрээс хэтэрсэн хүсэлтэй, тэрийгээ хангахыг, идэх, өмсөх зүйлс байна уу, эсвэл уураа барьж дийлэхгүй байх, сул тал, залхуурлаа өөгшүүлэх байна уу аль нь ч байсан хүслийг нь хангахыг үргэлж чамаас шаарддаг... Чи махан биеийг сэтгэл хангалуун байлгах тусам дур хүсэл нь үлэмж их болж, улам цадиггүй болсоор хүмүүсийн махан бие илүү гүн гүнзгий үзэл тээж, Бурханд дуулгаваргүй хандаж, өөрийгөө өргөмжилж, Бурханы ажилд эргэлздэг болох хэмжээнд хүрдэг. Чи махан биеийг сэтгэл хангалуун байлгах тусам махан биеийн сул тал төдий чинээ их болдог; сул талыг чинь хэн ч өрөвдөхгүй байгаа мэт чамд үргэлж санагдаж, Бурхан хэтэрхий даварсан гэж чи үргэлж итгэнэ, тэгээд чи: “Бурхан яаж ийм хахир хатуу байж чадаж байна вэ? Тэр яагаад хүмүүст зөөлөн хандахгүй байна вэ?” гэж хэлэх болно. Хүмүүс махан биеийг сэтгэл хангалуун байлгаж, хэтэрхий их энхрийлэхээрээ өөрсдийгөө сүйрүүлдэг. Хэрвээ чи Бурханыг үнэхээр хайрладаг, махан биеийг сэтгэл хангалуун байлгадаггүй бол Бурханы хийдэг бүхэн маш зөв, маш сайн бөгөөд Тэрээр тэрслүү байдлыг чинь харааж, зөв

шударга бус байдлыг чинь шүүх нь зүй ёсных гэдгийг харна. Бурхан чамайг цээрлүүлж, сахилгажуулан, хатуужуулах орчныг чинь бий болгож, чамайг Өөрийнхөө өмнө албадан ирүүлэх цаг ирнэ—тэр үед Бурханы хийж байгаа зүйлс гайхалтай гэдгийг чи үргэлж мэдрэх болно. Тиймээс чамд тийм ч их шаналал байхгүй мэт санагдаж, Бурхан үнэхээр хайр татам гэдгийг мэдэрнэ. Хэрвээ чи махан биеийн сул талыг өөгшүүлж, Бурхан дэндэж байна гэж хэлдэг бол үргэлж шаналж, үргэлж сэтгэлээр унаж, Бурханы бүх ажлын талаар тодорхой мэдэхгүй байхын дээр Бурхан хүний сул талуудыг огтхон ч өрөвддөггүй мэт, хүний бэрхшээлүүдийг мэддэггүй мэт санагдана. Иймээс чи туйлын шударга бус явдлыг туулсан мэт үргэлж золгүй ганцаардмал байдлыг мэдрэх үедээ гомдоллож эхэлнэ. Ийм маягаар махан биеийн сул талуудыг чи хэдий чинээ их өөгшүүлнэ, Бурхан дэндэж байна гэж улам их санагдсаар, бүр Бурханы ажлыг үгүйсгэж, Бурханыг эсэргүүцэж эхлэн, огтхон ч дуулгаваргүй байдаг болох хүртлээ дордоно. Тиймээс чи махан биеийг эсэргүүцэж, өөгшүүлэхгүй байх ёстой: “Миний нөхөр (эхнэр), хүүхдүүд, хэтийн ирээдүй, гэрлэлт, гэр бүл—аль нь ч хамаагүй! Зүрх сэтгэлд минь Бурхан л байдаг, махан биеийг биш Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд би чадах бүхнээ хийх ёстой.” Чи ингэж шийдэх ёстой. Хэрвээ чи үргэлж ийм шийдэмгий байвал багахан хүчин чармайлтаар л үнэнийг хэрэгжүүлж, өөрийгөө хойш тавьж чадна. Урьд цагт нэгэн тариачин зам дээр хөлдөж хөшсөн могой байхыг олж үзжээ. Тариачин түүнийг аваад цээжиндээ тэвэрсэн бөгөөд амь орсныхоо дараа могой тариачныг хатгаж амийг нь хөнөөжээ гэж ярьдаг. Хүний махан бие энэ могойтой адил: Үүний мөн чанар нь хүмүүсийн амийг хорлох байдаг учраас махан бие хүссэн бүхнээ авах үед чи амиа алддаг. Махан бие бол Сатаных. Түүнд хэрээс хэтэрсэн хүсэл байдаг, өөрийгөө л боддог, тав тухыг эдэлж, зугаа цэнгэлд умбахыг хүсэж, залхуу хойргод баригддагийн дээр тодорхой хэмжээнд сэтгэл хангалуун байлгавал эцэстээ чамайг залгих болно. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи энэ удаад үүнийг сэтгэл хангалуун байлгавал дараагийн удаа илүү ихийг хүсэж ирэх болно. Махан биед үргэлж хэрээс хэтэрсэн хүсэл, шинэ хэрэгцээ шаардлага байдаг ба чамаар бүр илүү эрхэмлүүлж, тав тухтай байдал дунд амьдрахын тулд махан биеэ өөгшүүлдгийг чинь ашигладаг—хэрвээ чи үүнийг дийлж гарч чадахгүй бол эцэстээ өөрийгөө сүйрүүлнэ. Бурханы өмнө амийг олж авч чадах эсэх, мөн эцсийн төгсгөл чинь ямар байх нь махан биеэ хэрхэн эсэргүүцэхээс чинь шалтгаалдаг. Бурхан чамайг аварч, чамайг сонгож, заяа төөргийг чинь тогтоосон атал өнөөдөр чи Түүнийг сэтгэл хангалуун байлгаж,

үнэнийг хэрэгжүүлж, Бурханыг үнэхээр хайрладаг зүрх сэтгэлээр махан биеэ эсэргүүцэхийг хүсдэггүй бол эцэстээ чи өөрийгөө сүйрүүлж, улмаар асар их шаналлыг туулах болно. Хэрвээ чи махан биеийг үргэлж өөгшүүлдэг бол дотор чинь бүрмөсөн харанхуй болох тэр өдөр ирэх хүртэл Сатан аажмаар чамайг залгиж, амьгүй, эсвэл өчүүхэн ч Сүнсгүй болгож орхино. Харанхуйд амьдрах үедээ чи Сатанд олзлогдож, зүрх сэтгэлд чинь Бурхан байхаа болих бөгөөд тэр үед чи Бурханы оршихуйг үгүйсгэж, Түүнийг орхино. Тиймээс, хэрвээ хүмүүс Бурханыг хайрлахыг хүсдэг бол шаналлын төлөөс төлж, зовлон бэрхшээл туулах ёстой. Гаднаа омголон, бэрхшээл зовлонтой байж, илүү ихийг уншиж, илүү их гүйх хэрэггүй; үүний оронд тэд хэрээс хэтэрсэн бодол, хувийн ашиг сонирхол, өөрийн санаа тавьдаг зүйл, үзэл, санаа зорилго гэх мэт дотроо байдаг зүйлийг хойш тавих ёстой. Бурханы хүсэл ийм билээ.

Бурхан хүмүүсийн гадаад зан чанартай харьцах нь Түүний ажлын бас нэг хэсэг юм; жишээлбэл, хүмүүсийн гадаад, хэвийн бус хүн чанар, эсвэл тэдний амьдралын хэв маяг, зуршил, арга зам, ёс заншил, түүнчлэн тэдний гадаад хэрэгжүүлэлт болон омголон зантай харьцдаг. Гэвч Тэр үнэнийг хэрэгжүүлж, зан чанараа өөрчлөхийг хүмүүсээс шаардахдаа, тэдний дотоод санаа бодол болон үзэлтэй нь голлон харьцдаг. Зөвхөн өөрийнхөө гадаад зан чанартай харьцах тийм ч хэцүү биш; дуртай зүйлээ идэхгүй байхыг өөрөөсөө шаардахтай л адил, амархан. Гэвч доторх үзлийг чинь хөнддөг зүйлийг тавьж явуулахад тийм ч хялбар биш. Махан биеийг эсэргүүцэж, төлөөс төлж, Бурханы өмнө зовохыг энэ нь хүмүүсээс шаарддаг. Хүмүүсийн санаа бодлын тухайд ялангуяа ийм байдаг. Бурханд итгэж эхэлсэн цагаасаа хойш хүмүүс олон буруу санаа бодол өвөрлөж ирсэн. Үнэнийг хэрэгжүүлэхгүй байх үед бүх санаа бодол чинь зөв мэт чамд санагддаг боловч ямар нэг зүйл тохиолдоход чамд маш олон буруу санаа бодол байгааг чи харах болно. Тиймээс, Бурхан хүмүүсийг төгс болгохдоо Бурханы талаарх мэдлэгт нь саад болж буй олон үзэл тэдэнд байгааг ойлгуулдаг. Санаа бодол чинь буруу гэдгийг ухаарах үедээ чи хэрвээ өөрийн үзэл болон санаа бодлын дагуу хэрэгжүүлэхээ больж чаддаг, мөн чамд юу ч тохиолдож байсан Бурханд гэрчлэл хийж, байр сууриндаа бат зогсож чаддаг бол махан биеийг эсэргүүцсэнийг чинь энэ нь нотолдог. Махан биеийг эсэргүүцэх үед чиний дотор тэмцэл болох нь гарцаагүй. Сатан хүмүүсээр өөрийгөө дагуулах гэж оролдож, махан биеийн үзлийг дагаж, махан биеийн ашиг сонирхлыг хамгаалуулах гэж оролддог—гэхдээ Бурханы үг хүмүүсийг дотроос нь гэгээрүүлж, гэрэлтүүлэх бөгөөд энэ үед Бурханыг дагах уу, эсвэл Сатаныг дагах уу гэдгээ чи өөрөө

шийддэг. Бурхан гол нь хүмүүсийн дотоод зүйлтэй харьцаж, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаггүй бодол болон үзэлтэй нь харьцахын тулд үнэнийг хэрэгжүүлэхийг хүмүүсээс хүсдэг. Ариун Сүнс хүмүүсийн зүрх сэтгэлийг хөдөлгөж, гэгээрүүлж, гэрэлтүүлдэг. Иймээс болж буй бүх зүйлийн цаана тэмцэл байдаг: Хүмүүс үнэнийг, Бурханыг гэх хайрыг хэрэгжүүлэх бүрд агуу тэмцэл болж байдаг бөгөөд махан бие нь бүхэлдээ зүгээр мэт байх боловч зүрх сэтгэлийнх нь гүнд үнэндээ үхэл амьдралын тэмцэл явагдаж байх болно— энэхүү хүчтэй тэмцлийн дараа, асар их эргэцүүллийн дараа л ялалт, ялагдал нь шийдэгддэг. Хүн уйлах уу, эсвэл инээх үү гэдгээ мэддэггүй. Хүмүүсийн санаа бодлын ихэнх нь буруу, эсвэл Бурханы ажлын ихээхэн хэсэг нь тэдний үзэлтэй зөрчилддөг учраас хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх үед нүднээс далд асар их тэмцэл болж байдаг. Энэхүү үнэнийг хэрэгжүүлснээр хүмүүс, Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эргэлт буцалтгүй шийдэхээсээ өмнө бусдын нүднээс далдуур уйтгар гунигийн нулимсыг хэмжээлшгүй их урсгасан байх болно. Энэхүү тэмцлээс болж хүмүүс зовлон зүдүүр, цэвэршүүлэлт туулдаг; энэ нь жинхэнэ зовлон юм. Тэмцэл чам дээр ирэх үед хэрвээ чи Бурханы талд үнэхээр зогсож чаддаг бол Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна. Үнэнийг хэрэгжүүлэх явцад хүн дотроо зовох нь гарцаагүй; хэрвээ үнэнийг хэрэгжүүлэх үед хүмүүсийн доторх бүх зүйл зөв байдаг байсан бол тэд Бурханаар төгс болгуулах хэрэггүй, мөн ямар ч тэмцэл болохгүй, тэд зовж зүдрэхгүй байх байсан. Бурхан ашиглахад тохирохгүй олон зүйл хүмүүст байдаг, махан биеийн тэрслүү зан чанар их байдаг учраас хүмүүс махан биеийг эсэргүүцэх хичээлийг илүү гүн гүнзгий сурах хэрэгтэй байдаг. Үүнийг Бурхан зовлон гэж нэрлэдэг бөгөөд Өөртэй нь хамт үүнийг туулахыг хүнээс Тэр хүссэн. Бэрхшээлтэй тулгарах үедээ чи яаран Бурханд залбирдаг: “Өө, Бурхан минь! Би Таныг сэтгэл хангалуун байлгахыг хүсэж байна, Таны зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд сүүлчийн зовлон бэрхшээлийг туулахыг хүсэж байна, надад тулгарах саад бэрхшээл хэчнээн их байх нь хамаагүй, би Таныг сэтгэл хангалуун байлгах ёстой. Амиа бүхэлд нь өгөх ёстой байсан ч гэсэн би Таныг сэтгэл хангалуун байлгах ёстой!” Ийм шийдэмгий байдалтайгаар, ингэж залбирахдаа чи гэрчлэлдээ бат зогсож чадна. Үнэнийг хэрэгжүүлэх болгондоо, цэвэршүүлэлт туулах бүрдээ, шалгуулах болгондоо, мөн Бурханы ажил өөрсөд дээр нь ирэх бүрд хүмүүс асар их шаналал амсах ёстой болдог. Энэ бүхэн нь хүмүүст зориулсан туршилт учраас тэдний бүгдийнх нь дотор тэмцэл болж байдаг. Энэ бол тэдний төлдөг бодит төлөөс юм. Бурханы үгийг илүү их уншиж, илүү их гүйх

нь тодорхой хэмжээний төлөөс мөн. Үүнийг хүмүүс хийх учиртай, энэ бол тэдний үүрэг, тэдний биелүүлэх ёстой хариуцлага мөн боловч хүмүүс дотроо байгаа хаях хэрэгтэй зүйлсээ хаях ёстой. Тэгэхгүй бол гадаад зовлон зүдүүр чинь хэчнээн их байх, хэчнээн их гүйх чинь хамаагүй бүх зүйл хий дэмий болох болно! Өөрөөр хэлбэл, чиний дотоод өөрчлөлтүүд л гадаад зовлон зүдүүр чинь үнэ цэнтэй байх эсэхийг тодорхойлдог. Чиний дотоод зан чанар өөрчлөгдөж, үнэнийг хэрэгжүүлэх үед гадаад бүх зовлон зүдүүр чинь Бурханы сайшаалыг хүртэнэ; хэрвээ чиний дотоод зан чанарт ямар нэгэн өөрчлөлт гараагүй бол гаднаа хэчнээн их зовлон зүдүүр амсаж, хэр их гүйх чинь хамаагүй Бурханы сайшаал хүртэхгүй—Бурханы баталгаажуулаагүй зовлон бэрхшээл хий дэмий байдаг. Тиймээс чиний төлсөн төлөөсийг Бурхан сайшаах эсэх нь чамд өөрчлөлт гарсан эсэх, мөн Бурханы хүслийг хангаж, Бурханы тухай мэдлэгтэй болж, Бурханд үнэнч байхын тулд үнэнийг хэрэгжүүлж, өөрийн санаа бодол болон үзлийг эсэргүүцдэг эсэхээр чинь тодорхойлогддог. Хэчнээн их гүйх чинь хамаагүй, хэрвээ чи өөрийн санаа бодлыг эсэргүүцэхийг хэзээ ч мэдэхгүй зөвхөн гаднаа үйлдэж, омголон байхыг л эрж хайж, өөрийн аминд хэзээ ч анхаарал хандуулж байгаагүй бол зовлон бэрхшээл чинь хий дэмий байх болно. Хэрвээ тодорхой орчинд, хэлмээр байгаа зарим зүйл чамд байдаг ч үүнийг хэлэх нь буруу, ингэж хэлэх нь ах, эгч нарт ашиг тусгүй, тэднийг гомдоож болзошгүй гэж санагдвал чи үүнийг хэлэхгүйгээр дотроо шаналахыг илүүд үзнэ, учир нь эдгээр үг Бурханы хүсэлд нийцэж чадахгүй. Энэ үед чиний дотор тэмцэл өрнөх боловч чи хайртай зүйлээ орхиж, шаналахад бэлэн байна. Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд энэхүү зовлон бэрхшээлийг туулахад бэлэн байна, хэдий чи дотроо шаналах боловч махан биеийг өөгшүүлэхгүй, Бурханы зүрх сэтгэл хангалуун байх учраас чи ч бас дотроо тайвшрах болно. Энэ бол үнэхээр төлөөс төлж байгаа хэрэг бөгөөд ийм төлөөсийг Бурхан хүсдэг. Хэрвээ чи ийм маягаар хэрэгжүүлбэл Бурхан чамайг маргаангүй ерөөнө; хэрвээ чи үүнд хүрч чадахгүй бол хэр их ойлгосон, хэр сайн ярьж чаддаг чинь хамаагүй, энэ бүхэн ямар ч хэрэггүй байх болно! Хэрвээ Бурханыг хайрлах замдаа чи, Бурханыг Сатантай тулалдахад Бурханы талд зогсох чадвартай байж, Сатан руу эргэж очихгүй бол Бурханыг гэх хайрыг олж авч, гэрчлэлдээ бат зогссон байх болно.

Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож

буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг. Жишээлбэл, ах эгч нараа алагчилж үздэг бол Бурханд таалагдахгүй болов уу гэж чамд санагддаг, хэлэхийг хүсдэг үг байх боловч хэлэхгүй бол чиний дотор таагүй санагдаж, энэ мөчид чиний дотор тэмцэл эхэлнэ: “Би хэлэх үү, болих уу?” Энэ бол тэмцэл. Иймээс чамтай тулгардаг бүх зүйлд тэмцэл байдаг, чиний дотор тэмцэл байх үед, чи бодитоор хамтран ажиллаж, бодитоор зовсны ачаар Бурхан чиний дотор ажилладаг. Эцэст нь чи сэтгэл доторх асуудлыг хойш тавьж чаддаг болж, уур бухимдал аяндаа намждаг. Энэ бол Бурхантай хамтран ажилласны чинь үр дүн юм. Хүмүүс бүх зүйлийг хийхэд хүчин чармайлтдаа тодорхой хэмжээний төлөөс төлөх шаардлагатай болдог. Бодит зовлон бэрхшээлгүйгээр Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй; Бурханыг сэтгэл хангалуун болгоход дөхөж очих ч үгүй, хоосон уриа лоозон урсгахаас цаашгүй! Эдгээр хоосон уриа лоозон нь Бурханыг сэтгэл хангалуун болгож чадах уу? Бурхан, Сатан хоёр сүнсний ертөнцөд тулаан хийх үед чи Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун болгож, Түүнд хийх гэрчлэлдээ хэрхэн бат зогсох ёстой вэ? Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой. Гаднаа тэдгээр нь чухал биш юм шиг байж болох ч эдгээр зүйл тохиолдох үед Бурханд хайртай юу, үгүй юу гэдэг чинь харагддаг. Хэрвээ хайртай бол чи Түүнд гэрчлэл хийхдээ бат зогсож чадна, хэрвээ чи Түүнийг гэх хайрыг хэрэгжүүлээгүй бол үнэнийг хэрэгжүүлдэг хүн биш гэдгийг, мөн чамд үнэн, амь байхгүй агаад чамайг хог хаягдал гэдгийг чинь энэ нь харуулдаг! Хүмүүст тохиолддог бүхэн нь Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсох хэрэгтэй үед нь тохиолддог. Одоохондоо чамд ямар ч томоохон зүйл тохиолдоогүй, чи агуу гэрчлэл хийдэггүй хэдий ч өдөр тутмын амьдралын чинь нарийн ширийн болгон Бурханд гэрчлэл хийх асуудал байдаг. Хэрвээ чи ах эгч нар, гэр бүлийн гишүүд, эргэн тойронд чинь байгаа хүн бүрийн бахдал бишрэлийг олж авч чадвал; хэрвээ нэгэн өдөр үл итгэгч ирээд хийдэг бүхнийг чинь биширч, Бурханы хийдэг бүхэн гайхалтай гэдгийг харвал чи гэрчлэл хийсэн байх болно. Чамд мэдлэг ухаан байхгүй, хэв чанар чинь дорд байсан хэдий ч Бурхан чамайг төгс болгосноор чи Түүнийг сэтгэл хангалуун болгож, Түүний хүсэлд санаа тавьж,

Бурхан хамгийн дорд хэв чанартай хүмүүст ямар агуу ажил хийснийг бусдад харуулж чаддаг. Хүмүүс Бурханыг мэдэж авч, Сатаны өмнө ялагчид болж, Бурханд туйлын үнэнч байх үед энэ бүлэг хүмүүсээс илүү ноён нуруутай хэн ч байхгүй байх бөгөөд энэ нь хамгийн агуу гэрчлэл юм. Хэдийгээр чи агуу ажил хийх чадваргүй ч Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг. Бусад хүн үзлээ хойш тавьж чаддаггүй боловч чи чадна; бусад хүн өөрсдийн бодит туршлагын үеэр Бурханд гэрчлэл хийж чаддаггүй ч чи бодит биеийн хэмжээ болон үйлдлээрээ Бурханы хайрыг хариулж, Түүнд цангинасан гэрчлэл хийж чадна. Зөвхөн үүнийг л Бурханыг үнэхээр хайрлаж байгаад тооцно. Хэрвээ чи ингэж чадахгүй бол гэр бүлийнхээ гишүүд, ах эгч нарынхаа дунд, эсвэл дэлхийн хүмүүсийн өмнө гэрчлэл хийдэггүй. Хэрвээ чи Сатаны өмнө гэрчлэл хийж чадахгүй бол Сатан чамайг шоолон инээж, чамайг доог тохуу, тоглоом мэт үзэх болно, тэр үргэлж чамайг шоглож, ухаан мэдрэлийг чинь алдуулна. Ирээдүйд агуу шалгалт чамд тулгарч болзошгүй боловч өнөөдөр хэрвээ чи Бурханыг үнэн сэтгэлээсээ хайрладаг бол, өмнө чинь хэчнээн агуу шалгалт байгаа нь хамаагүй, чамд юу тохиолдохоос үл хамааран, гэрчлэлдээ бат зогсож, Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг бол зүрх сэтгэл чинь тайвширч, ирээдүйд хэчнээн агуу шалгалттай тулгарсан ч чи айхгүй. Ирээдүйд юу тохиолдохыг та нар харж чадахгүй; өнөөдрийн нөхцөл байдалд л та нар Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна. Та нар ямар нэгэн агуу ажил хийх чадваргүй бөгөөд бодит амьдрал дээр үгийг нь туулснаар Бурханыг сэтгэл хангалуун болгож, Сатаныг ичгүүрт оруулах хүчтэй, цангинасан гэрчлэл хийхэд анхаарах ёстой. Хэдийгээр махан бие чинь сэтгэл хангалуун бус үлдэж, зовж шаналсан ч чи Бурханыг сэтгэл хангалуун болгож, Сатаныг ичгүүрт оруулсан байх болно. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлдэг бол Бурхан өмнөх замыг чинь нээж өгнө. Нэг л өдөр агуу шалгалт ирэхэд бусад хүн доош унах боловч чи бат зогсох чадвартай хэвээр байна: Төлсөн төлөөснөөс чинь болж Бурхан чамайг хамгаалах учраас чи бат зогсож, доош унахгүй байж чадна. Ерөнхийдөө чи үнэнийг хэрэгжүүлж, Өөрийг нь үнэхээр хайрладаг зүрх сэтгэлээр Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг бол хожмын шалгалтуудын үеэр Бурхан чамайг гарцаагүй хамгаална. Чи мунхаг агаад биеийн хэмжээ бага, дорд хэв чанартай байсан ч Бурхан чамайг ялгаварлан гадуурхахгүй. Чиний санаа бодол зөв эсэхээс энэ нь хамаардаг. Өнөөдөр чи Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна, ингэхдээ чи хамгийн өчүүхэн жижиг зүйлд ч гэсэн анхаарал хандуулж, бүх зүйл дээр Бурханыг сэтгэл хангалуун болгож, Бурханыг үнэхээр хайрладаг зүрх

сэтгэлтэй байж, чин зүрх сэтгэлээ Бурханд өгдөг бөгөөд ойлгож чадахгүй зарим зүйл байсан ч чи санаа бодлоо зөв болгож, Бурханы хүслийг эрж хайхаар Бурханы өмнө ирж, Бурханыг сэтгэл хангалуун болгохын тулд хэрэгтэй бүхнийг хийж чаддаг. Магадгүй ах эгч нар чинь чамайг хаяж болох ч зүрх сэтгэл чинь Бурханыг сэтгэл хангалуун болгож, чи махан биеийн жаргалд шунахгүй. Хэрвээ чи үргэлж ийм байдлаар хэрэгжүүлбэл агуу шалгалтууд чам дээр ирэх үед хамгаалагдах болно.

Шалгалтууд хүмүүсийн ямар дотоод байдал руу чиглэдэг вэ? Тэдгээр нь Бурханыг сэтгэл хангалуун болгох чадваргүй тэрслүү зан чанарт нь чиглэсэн байдаг. Хүмүүсийн дотор ихээхэн бохир зүйл, ихээхэн хуурамч зүйл байдаг учраас Бурхан тэднийг ариусгахын тулд шалгалтад оруулдаг. Гэхдээ хэрвээ өнөөдөр чи Бурханыг хангалуун болгож чаддаг бол ирээдүйн шалгалтууд чамайг төгс болгоно. Хэрвээ өнөөдөр чи Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаггүй бол хожмын шалгалтууд чамайг сорьж, чи өөрөө ч мэдэлгүй доош унана, тэр үед чи өөртөө ч тусалж чадахгүй байх болно, учир нь чи Бурханы ажилтай хөл нийлүүлж чаддаггүй, бодит биеийн хэмжээгүй байдаг. Иймээс хэрвээ чи ирээдүйд бат зогсож, Бурханыг илүү сэтгэл хангалуун байлгаж, эцсээ хүртэл Түүнийг дагаж чаддаг байхыг хүсэж байгаа бол өнөөдөр бат бөх суурь тавих ёстой. Бүх зүйл дээр үнэнийг хэрэгжүүлснээр Бурханыг сэтгэл хангалуун болгож, Түүний хүсэлд санаа тавих ёстой. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлбэл чиний дотор суурь бий болж, Өөрийг нь хайрлах зүрх сэтгэлийг Бурхан чамд төрүүлж, чамд итгэл өгөх болно. Нэг л өдөр шалгалт жинхэнээсээ тулгарахад чи зовлон шаналал ихэд амсаж, тодорхой хэмжээгээр цөхөрч, үхсэн мэт аймшигтай уй гашууг туулж магадгүй юм—гэхдээ Бурханыг гэх чиний хайр өөрчлөгдөхгүй, улам гүнзгийрэх болно. Бурханы ерөөл ийм билээ. Хэрвээ чи Бурханы өнөөдөр хэлдэг, хийдэг бүхнийг дуулгавартай зүрх сэтгэлээр хүлээн зөвшөөрч чаддаг бол Бурхан чамайг гарцаагүй ерөөх учраас чи Бурханаар ерөөгдсөн, Түүний амлалтуудыг хүлээн авдаг хүн болно. Хэрвээ өнөөдөр хэрэгжүүлэхгүй бол нэг л өдөр шалгалт тулгарахад чамд итгэл, хайрлах зүрх сэтгэл байхгүй байх бөгөөд тэр үед шалгалт нь уруу таталт болно; чи Сатаны уруу таталтад автаж, зугтах ямар ч аргагүй болно. Өнөөдөр, багахан шалгалт чамд тулгарахад чи бат зогсож чадах ч нэг л өдөр томоохон шалгалт тулгарахад чи гарцаагүй бат зогсож чадахгүй. Зарим хүн ихэрхүү зантай байдаг бөгөөд өөрсдийгөө аль хэдийн бараг төгс болсон гэж боддог. Хэрвээ тийм үед чи илүү гүнзгий явахгүйгээр өөртөө сэтгэл хангалуун хэвээр үлдвэл аюулд орох болно.

Өнөөдөр Бурхан илүү агуу шалгалтын ажлыг хийдэггүй, бүх зүйл гаднаа зүгээр мэт харагдах боловч Бурхан чамайг шалгах үед чи хэтэрхий дутуу дулимаг гэдгээ олж мэднэ, учир нь чиний биеийн хэмжээ хэтэрхий жаахан бөгөөд чи агуу шалгалтуудыг туулах чадваргүй билээ. Хэрвээ чи байгаагаараа, үлбэгэр байдалтай хэвээр байвал шалгалт ирэхэд унана. Биеийн хэмжээ чинь хэр жижиг болохыг та нар байнга харах хэрэгтэй; ийм маягаар л та нар өсөж дэвшинэ. Хэрвээ чи зөвхөн шалгалтын үеэр л биеийн хэмжээ чинь маш жаахан, сэтгэлийн тэнхээ чинь үнэхээр сул дорой, чиний дотор бодитой зүйл хэтэрхий бага, Бурханы хүсэлд хангалтгүй гэдгээ ойлговол—тэр үед л үүнийг ойлговол хэтэрхий оройтсон байх болно.

Хэрвээ чи Бурханы зан чанарыг мэддэггүй бол шалгалтын үеэр гарцаагүй унана, яагаад гэвэл Бурхан яаж хүмүүсийг төгс болгодог, ямар арга замаар тэднийг төгс болгодгийг мэддэггүй бөгөөд Бурханы шалгалт чам дээр ирж, үзэлтэй чинь нийцэхгүй байх үед чи бат зогсож чадахгүй. Бурханы жинхэнэ хайр бол Түүний бүхий л зан чанар бөгөөд Бурханы зан чанар бүхэлдээ хүмүүст харагдах үед энэ нь махан биед юу авчирдаг вэ? Бурханы зөвт зан чанар хүмүүст харагдах үед тэдний махан бие ихээхэн өвдөлт шаналал амсах нь гарцаагүй. Хэрвээ чи энэ шаналлыг амсахгүй бол Бурханаар төгс болгуулж чадахгүй, Бурханд жинхэнэ хайрыг зориулж бас чадахгүй. Хэрвээ Бурхан чамайг төгс болговол Өөрийн бүх зан чанарыг чамд гарцаагүй харуулна. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Бурхан Өөрийн зан чанарыг бүхэлд нь хүнд хэзээ ч харуулж байгаагүй, харин Өөрийн урьдчилан тогтоож, сонгосон энэ бүлэг хүмүүст эцсийн өдрүүдэд илчилдэг бөгөөд хүмүүсийг төгс болгосноор Өөрийн зан чанарыг ил болгож, үүгээр дамжуулан бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгодог. Хүмүүсийн төлөө гэсэн Бурханы жинхэнэ хайр ийм билээ. Бурханы жинхэнэ хайрыг мэдрэхэд туйлын их зовлон шаналал туулж, өндөр төлөөс төлөхийг шаарддаг. Зөвхөн үүний дараа л тэд Бурханаар авхуулж, Бурханд жинхэнэ хайраа буцаан өгч чадах бөгөөд тэр үед л Бурханы зүрх сэтгэл хангалуун байх болно. Хэрвээ хүмүүс Бурханаар төгс болгуулахыг, Түүний хүслийг биелүүлж, жинхэнэ хайраа Бурханд бүрэн дүүрэн өгөхийг хүсдэг бол үхэхээс дор өвдөлтийг амсахын тулд нөхцөл байдлаасаа ихээхэн зовлон зүдүүр, тарчлалыг туулах ёстой бөгөөд эцэстээ тэд жинхэнэ зүрх сэтгэлээ Бурханд буцааж өгөхөөс аргагүй болно. Хүн Бурханд үнэхээр хайртай эсэх нь зовлон бэрхшээл болон цэвэршүүлэлтийн үеэр илчлэгддэг. Бурхан хүмүүсийн хайрыг ариусгадаг, энэ нь ч бас зовлон бэрхшээл, цэвэршүүлэлтийн дунд л хийгддэг билээ.

“МЯНГАН ЖИЛИЙН ХААНЧЛАЛ ИРЧИХСЭН” ТУХАЙ ТОВЧ ЯРИА

Мянган жилийн хаанчлалын үзэгдлийн талаар та нар юу гэж боддог вэ? Зарим хүн энэ тухай их боддог бөгөөд “Мянган жилийн хаанчлал газар дээр мянган жилийн турш оршин тогтноно, тиймээс хэрэв чуулганы ахмад гишүүд гэрлээгүй бол гэрлэх ёстой юу? Манай гэр бүл мөнгөгүй байгаа, би мөнгө олж эхлэх ёстой юу? ...” гэгцгээдэг. Мянган жилийн хаанчлал гэж юу вэ? Та нар мэдэх үү? Хүмүүс харалган бөгөөд асар их зовлон зүдүүр туулдаг. Үнэндээ Мянган жилийн хаанчлал хараахан албан ёсоор ирээгүй. Хүмүүсийг төгс болгох үе шатанд Мянган жилийн хаанчлал ердөө үүсэл төдий байдаг; Бурханы ярьсан Мянган жилийн хаанчлалын цаг үед хүн төгс болгуулсан байх болно. Хүмүүс ариун хүмүүс шиг байж, Синимийн газар нутагт бат зогсоно гэж өмнө нь хэлсэн. Хүмүүс төгс болгуулсан байх үед—Бурханы ярьсан ариун хүмүүс болох үед л—Мянган жилийн хаанчлал ирсэн байх болно. Бурхан хүмүүсийг төгс болгох үедээ тэднийг ариусгадаг ба тэд хэдий чинээ ариун байна, Бурханаар төдий чинээ төгс болгуулдаг. Чиний доторх бохир зүйл, тэрслүү байдал, эсэргүүцэл болон махан биеийн зүйлс хөөн зайлуулагдах үед, мөн ариусгагдсан байх үедээ чи Бурханаар хайрлуулна (өөрөөр хэлбэл, чи ариун хүн болно); Бурханаар төгс болгуулж, ариун хүн болсон үедээ чи Мянган жилийн хаанчлалд байх болно. Одоо үе бол Хаанчлалын эрин үе. Мянган жилийн хаанчлалын эрин үед хүмүүс Бурханы үгэнд найдан амьдарна, мөн бүх үндэстэн Бурханы нэрийн дор ирж, бүгд Бурханы үгийг уншихаар ирнэ. Тэр үед зарим нь утсаар залгана, зарим нь факсдана ... тэд Бурханы үгэнд хандахын тулд бүхий л аргыг ашиглана, та нар ч бас Бурханы үгийн дор ирнэ. Энэ бүхэн нь хүмүүс төгс болгуулсны дараа тохиолддог зүйл юм. Өнөөдөр хүмүүс үгээр төгс болгуулж, цэвэршүүлэгдэж, гэгээрүүлэгдэж, удирдуулдаг; энэ бол Хаанчлалын эрин үе, мөн хүмүүсийг төгс болгодог үе шат бөгөөд Мянган жилийн хаанчлалын эрин үетэй ямар ч холбоогүй. Мянган жилийн хаанчлалын эрин үед, хүмүүс аль хэдийн төгс болгуулж, тэдний доторх завхарсан зан чанар ариуссан байх болно. Тэр үед, Бурханы хэлсэн үг хүмүүсийг алхам алхмаар залж чиглүүлж, бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэлх Бурханы ажлын бүх нууцыг илчлэх бөгөөд эрин үе болгон дахь, өдөр тутам дахь Бурханы үйлдлүүдийн тухай, Тэрээр хүмүүсийг дотроос нь хэрхэн залж чиглүүлдэг тухай болон сүнсний ертөнцөд Түүний хийдэг ажлын тухай Түүний үг хүмүүст хэлж, мөн сүнсний ертөнцийн

хөдөлгөөний талаар хэлнэ. Тэр үе л үнэхээр Үгийн эрин үе байх болно; одоо үе бол ердөө л үүсэл төдий юм. Хэрвээ хүмүүс төгс болгуулаагүй, ариусгагдаагүй бол газар дээр мянган жил амьдрах ямар ч аргагүй байх ба тэдний махан бие гарцаагүй илжирнэ; хэрвээ хүмүүс дотроо ариусгагдаж, Сатаных болон махан биеийнх байхаа боливол газар дээр амьд үлдэнэ. Энэ үе шатанд чи бас л харалган байна, та нарын туулдаг бүхэн бол газар дээр амьдарч буй өдөр болгондоо Бурханыг хайрлах, Түүнд гэрчлэл хийх явдал юм.

“Мянган жилийн хаанчлал ирчихсэн” гэдэг бол зөгнөл, энэ нь эш үзүүлэгчийн зөгнөлтэй төстэй бөгөөд Бурхан үүгээр ирээдүйд юу тохиолдохыг зөгнөдөг. Бурханы ирээдүйд хэлдэг үг болон өнөөдөр хэлдэг үг адилгүй: Ирээдүйн үг нь эрин үеийг залж чиглүүлнэ, харин өнөөдөр хэлдэг үг нь хүмүүсийг төгс болгож, цэвэршүүлж, тэдэнтэй харьцдаг. Ирээдүйн Үгийн эрин үе нь өнөөдрийн Үгийн эрин үеэс ялгаатай. Өнөөдөр, Бурханы хэлдэг бүх үг—ямар аргаар хэлдгээс нь үл хамааран—хүмүүсийг төгс болгох, доторх бохир зүйлийг нь ариусгах, Бурханы өмнө тэднийг ариун агаад зөв шударга болгохын төлөө байдаг. Өнөөдөр хэлдэг үг болон ирээдүйд хэлдэг үг нь хоёр тусдаа зүйл юм. Хаанчлалын эрин үед хэлдэг үг нь хүмүүсийг бүх сургалтад оруулж, хүмүүсийг бүх зүйл дээр зөв замд аваачиж, тэдний доторх бохир бүхнийг хөөн зайлуулахын төлөө байдаг. Энэ эрин үед Бурханы хийдэг зүйл энэ юм. Тэрээр хүн болгонд үгийнхээ суурийг тавьж, үгээ хүн бүрийн амь болгож, тэднийг дотроос нь байнга гэгээрүүлж, залж чиглүүлэхийн тулд үгээ ашигладаг. Бурханы хүслийг хайхрахгүй байх үед нь Бурханы үг тэднийг дотроос нь зэмлэж, сахилгажуулна. Өнөөдрийн үг хүний амь болох учиртай; тэдгээр нь хүнд хэрэгтэй бүхнийг шууд хангадаг, дотор чинь дутагдаж байгаа бүхнийг Бурханы үг хангадаг ба Бурханы үгийг хүлээн авдаг бүхэн Түүний үгийг идэж ууснаар гэгээрдэг. Ирээдүйд Бурханы хэлдэг үг бүхий л орчлон ертөнцийн хүмүүсийг залж чиглүүлдэг; өнөөдөр эдгээр үгийг Хятадад л хэлдэг бөгөөд бүхий л орчлон ертөнц даяар хэлдэг үгийг эдгээр нь төлөөлдөггүй. Мянган жилийн хаанчлал ирэх үед л Бурхан бүх орчлон ертөнцөд хандан ярина. Өнөөдөр Бурханы хэлдэг үг бүгд хүмүүсийг төгс болгохын төлөө байдаг гэдгийг мэдэж ав; энэ үе шатанд Бурханы хэлдэг үг нь хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой болохоос чамд нууцуудыг мэдэгдэх юм уу Бурханы гайхамшгуудыг харуулах зорилготой биш. Тэр олон арга барилаар ярьдаг нь хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой. Мянган жилийн хаанчлалын эрин үе хараахан ирээгүй—яригдаж буй Мянган жилийн хаанчлалын эрин үе нь Бурханы алдрын өдөр юм. Иудей дэх Есүсийн

ажил дууссаны дараа Бурхан ажлаа Хятадын эх газарт шилжүүлж, өөр төлөвлөгөө зохиосон. Тэр та нар дээр ажлынхаа өөр нэг хэсгийг хийдэг, мөн үгээр хүмүүсийг төгс болгох ажлыг хийдэг ба хүмүүсээр асар их шаналал зовлон туулуулж, Бурханы ихээхэн нигүүлслийг тэдэнд хүртээхдээ үг ашигладаг. Ажлын энэ үе шат бүлэг ялагчдыг бий болгох ба энэхүү бүлэг ялагчдыг бий болгосны дараа тэд Түүний үйл хэргийг гэрчилж, бодит байдлыг амьдран харуулж, Түүнийг үнэхээр сэтгэл хангалуун болгож, үхэн үхтлээ Түүнд үнэнч байна, ийм маягаар Бурхан алдрыг олж авна. Бурхан алдрыг олж авах үе буюу энэ бүлэг хүмүүсийг Тэр төгс болгох үе нь Мянган жилийн хаанчлалын эрин үе байх болно.

Есүс газар дээр гучин гурван жил хагас амьдарсан. Тэр цовдлолын ажлыг хийхээр ирсэн ба цовдлолоор дамжуулан Бурхан алдрынхаа нэг хэсгийг олж авсан юм. Бурхан махбодоор ирэх үедээ даруу, нууцлаг байж, тоймгүй их зовлонг тэсвэрлэж чадсан. Тэр Бурхан Өөрөө байсан хэдий ч доромжлол, гүтгэлэг бүрийг мөн л тэвчсэн бөгөөд золин авралын ажлыг дуусгахын тулд загалмайд цовдлогдох асар их өвдөлтийг тэсвэрлэсэн билээ. Ажлын энэ үе шат дууссаны дараа Бурхан агуу алдар суу олж авсныг хүмүүс харсан хэдий ч энэ нь Түүний алдар суу бүхэлдээ биш байсан; энэ нь Есүсээс олж авсан алдрынх нь нэг хэсэг л байсан юм. Хэдийгээр Есүс бэрхшээл бүрийг тэсвэрлэж, даруу, нууцлаг байж, Бурханы төлөө цовдлогдож чадсан ч алдрынхаа нэг хэсгийг л олж авсан ба алдар суугаа Израильд олж авсан. Бурханд бас алдрын өөр нэг хэсэг бий: бодитоор ажиллаж, бүлэг хүмүүсийг төгс болгохын тулд газар дээр ирэх явдал. Есүс ажлынхаа үе шатны үеэр зарим нэг ер бусын зүйл хийсэн боловч ажлын тэр үе шат нь яавч тэмдэг, гайхамшиг л үзүүлэхийн төлөө байгаагүй. Энэ нь үндсэндээ, Есүс зовж шаналж, Бурханы төлөө цовдлогдож чадсан, мөн Бурханд хайртай учраас асар их зовлонг тэвчиж чадсан, бас Бурхан Өөрийг нь орхисон ч Бурханы хүслийн төлөө амьдралаа золиослоход бэлэн байсан гэдгийг харуулах зорилготой байсан юм. Бурхан Израиль дахь ажлаа дуусгаж, Есүс загалмайд цовдлогдсоны дараа Бурхан алдрыг олж авсан бөгөөд Сатаны өмнө гэрчлэл хийсэн билээ. Та нар Бурхан Хятадад махбод болсныг мэдээ ч үгүй, хараа ч үгүй болохоор Бурхан алдрыг олж авсаныг яаж харж чадах юм бэ? Бурхан та нар дээр байлдан дагуулалтын ихээхэн ажил хийж, та нарыг бат зогсох үед Бурханы ажлын энэ үе шат амжилттай болдог бөгөөд энэ нь Бурханы алдрын нэг хэсэг юм. Та нар үүнийг л хардаг ба Бурханаар хараахан төгс болгуулаагүй, зүрх сэтгэлээ Бурханд хараахан бүрэн өгөөгүй. Та нар энэхүү

алдрыг хараахан бүхэлд нь хараагүй; Бурхан зүрх сэтгэлийг чинь аль хэдийн байлдан дагуулсан гэдгийг, Түүнийг хэзээ ч орхиж чадахгүй, эцсийг нь хүртэл Бурханыг дагана, зүрх сэтгэл чинь өөрчлөгдөхгүй гэдгийг л та нар хардаг бөгөөд энэ бол Бурханы алдар юм. Бурханы алдрыг юунаас хардаг вэ? Хүмүүс дээрх Түүний ажлын үр нөлөөнөөс. Бурхан бол маш хайр татам гэдгийг хүмүүс хардаг, зүрх сэтгэлдээ Бурхантай байдаг, Бурханыг орхихыг хүсдэггүй бөгөөд энэ нь Бурханы алдар суу билээ. Чуулгануудын ах эгч нарын хүч нэмэгдэж, Бурханыг чин сэтгэлээсээ хайрлаж, Бурханы хийсэн ажлын хамгийн агуу сүр хүчийг болон Түүний үгийн харьцуулшгүй их сүр хүчийг харж чадах үед, Түүний үг эрх мэдэл агуулдаг, Тэрээр эзгүйрсэн хот болох Хятадын эх газарт Өөрийн ажлыг өрнүүлж чадна гэдгийг харах үед, хүмүүс хэдий сул дорой ч зүрх сэтгэл нь Бурханы өмнө бөхийж, Бурханы үгийг хүлээн авахад бэлэн байх үед, хэдийгээр тэд сул дорой, зохисгүй боловч Бурханы үг маш хайр татам, нандигнаваас зохилтой гэдгийг харж чаддаг байх үед энэ нь Бурханы алдар юм. Хүмүүс Бурханаар төгс болгуулж, Түүний өмнө бууж өгч чаддаг болж, Бурханд бүрэн дуулгавартай байж, хэтийн ирээдүй, хувь заяагаа Бурханы гарт даатгаж чадах өдөр ирэх үед Бурханы алдрын хоёр дахь хэсгийг бүрэн олж авсан байх болно. Өөрөөр хэлбэл, бодитой Бурханы ажил бүрэн дуусах үед Хятадын эх газар дахь Түүний ажил төгсөнө. Өөрөөр хэлбэл, Бурханы урьдчилан тогтоож, сонгосон хүмүүс төгс болгуулах үед Бурхан алдрыг олж авсан байх болно. Бурхан алдрынхаа хоёр дахь хэсгийг Зүүн зүгт аваачсан гэж хэлсэн, гэхдээ энэ нь энгийн нүдэнд үзэгдэхгүй. Бурхан ажлаа Зүүн зүгт аваачсан: Тэрээр аль хэдийнээ Зүүн зүгт ирчихсэн ба энэ нь Бурханы алдар юм. Өнөөдөр Түүний ажил хараахан дуусаагүй хэдий ч Бурхан ажиллахаар шийдсэн учраас энэ нь гарцаагүй гүйцэлдэнэ. Бурхан энэ ажлыг Хятадад гүйцэлдүүлэхээр шийдсэн бөгөөд та нарыг бүрэн төгс болгохоор шийдсэн. Тиймээс Тэр та нарт ямар ч гарах гарц өгдөггүй—Тэр зүрх сэтгэлийг чинь аль хэдийн байлдан дагуулсан, чи хүссэн ч, хүсээгүй ч цааш явах ёстой ба та нарыг Бурханаар авхуулах үед Бурхан алдрыг олж авдаг. Өнөөдөр, та нар хараахан төгс болгуулаагүй учраас Бурхан хараахан алдрыг олж аваагүй. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэж очсон хэдий ч махан биед чинь олон сул тал байсаар байгаа, та нар Бурханыг сэтгэл хангалуун болгох чадваргүй, Бурханы хүслийг анхаарч чаддаггүй, ангижрах ёстой олон сөрөг зүйлийг эзэмшсээр байдаг бөгөөд бас олон шалгалт, цэвэршүүлэлт туулах ёстой. Ийм маягаар л амь зан чанар чинь өөрчлөгдөж, Бурханаар авхуулж чадна.

БУРХАНЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л ТҮҮНД ГЭРЧЛЭЛ ХИЙЖ ЧАДНА

Бурханд итгэж, Бурханыг мэдэх нь Тэнгэрээр тогтоогдож, газраар хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд өнөөдөр бие махбодтой болсон Бурхан ажлаа Өөрийн биеэр хийж байгаа эрин үе бол Бурханыг мэдэх нэн сайн цаг үе юм. Бурханыг сэтгэл хангалуун байлгах нь Бурханы хүслийг ойлгосны үндсэн дээр хийдэг зүйл бөгөөд Бурханы хүслийг ойлгохын тулд Бурханы талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Бурханы талаарх энэхүү мэдлэг нь Бурханд итгэдэг нэгэнд байх ёстой үзэгдэл юм; энэ нь хүний Бурханд итгэх итгэлийн үндэс билээ. Энэхүү мэдлэг байхгүй бол хүний Бурханд итгэх итгэл тодорхойгүй байдалд, хоосон онол дунд орших байсан. Ийм хүмүүс Бурханыг дагахыг шийдсэн ч гэсэн юу ч олж авахгүй. Энэхүү урсгалд юу ч олж аваагүй бүх хүн таягдуулах хүмүүс юм. Тэд бүгдээрээ сорон мөлжигчид мөн. Бурханы ажлын аль ч үе шатыг туулсан бай, чамайг агуу үзэгдэл дагалдах ёстой. Эс бөгөөс, шинэ ажлын алхам бүрийг хүлээн авах нь чиний хувьд хэцүү байх байсан. Учир нь Бурханы шинэ ажил хүний төсөөлөх чадвараас хэтэрсэн, хүний сэтгэхүйн хязгаараас давсан байдаг. Иймээс хариулах хоньчингүйгээр, үзэгдлийн тухай нөхөрлөх хоньчингүйгээр хүн энэ шинэ ажлыг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүн үзэгдлийг хүлээн авч чадахгүй бол Бурханы шинэ ажлыг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүн Бурханы шинэ ажлыг дуулгавартай дагаж чадахгүй бол Бурханы хүслийг ойлгож чадахгүй. Иймээс Бурханы талаарх түүний мэдлэг ямар ч ач холбогдолгүй байх болно. Хүн Бурханы үгийг хэрэгжүүлэхээсээ өмнө Бурханы үгийг мэдэх ёстой, өөрөөр хэлбэл, Бурханы хүслийг ойлгох ёстой. Зөвхөн ингэж л Бурханы үгийг үнэн зөв, Бурханы хүслийн дагуу хэрэгжүүлж чадна. Энэ бол үнэнийг эрж хайдаг хүн бүрд байх ёстой зүйл, бас Бурханыг мэдэхээр хичээдэг хүн бүрийн туулах ёстой үйл явц юм. Бурханы үгийг мэдэж авах үйл явц нь Бурханыг мэдэж авах, мөн түүнчлэн Бурханы ажлыг мэдэж авах үйл явц билээ. Иймээс үзэгдлийг мэдэх гэдэг нь бие махбодтой болсон Бурханы хүн чанарыг мэдэхийг хэлэхээр үл барам, Бурханы үг болон ажлыг мэдэхийг хэлдэг. Бурханы үгээс хүмүүс Бурханы хүслийг ойлгож авч, Бурханы ажлаас Бурханы зан чанарыг, Бурхан юу болохыг мэдэж авдаг. Бурханд итгэх итгэл бол Бурханыг мэдэх эхний алхам юм. Бурханд итгэх энэхүү анхны итгэлээс Бурханд итгэх хамгийн гүн гүнзгий итгэл хүртэл ахин дэвших үйл явц нь Бурханыг мэдэж авах, Бурханы ажлыг мэдэрч туулах үйл явц билээ. Хэрвээ чи Бурханыг мэдэж авахын тулд биш, харин

Бурханд итгэхийн тулд л итгэдэг бол итгэлд чинь ямар ч бодит байдал байхгүй бөгөөд итгэл чинь ариун болж чадахгүй гэдэгт эргэлзэх зүйлгүй. Хэрвээ Бурханы ажлыг туулах үйл явцдаа хүн аажмаар Бурханыг мэдэж авбал зан чанар нь аажмаар өөрчлөгдөж итгэл нь улам бүр жинхэнэ болно. Ингэж Бурханд итгэх итгэлдээ амжилт олохдоо хүн Бурханыг бүрэн олж авсан байх болно. Ажлаа Өөрийн биеэр хийхийн тулд Бурхан хоёр дахь удаагаа махбод болох гэж асар их хүчин чармайлт гаргасны шалтгаан нь хүнд Өөрийгөө мэдүүлж, Өөрийгөө харуулахад оршиж байсан. Бурханыг мэдэх^а гэдэг нь Бурханы ажлын төгсгөлд хүрэх эцсийн үр дүн юм. Хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы сүүлчийн шаардлага энэ билээ. Өөрийн сүүлчийн гэрчлэлийн төлөө Тэр үүнийг хийдэг. Хүнийг Өөр лүүгээ эргэлт буцалтгүй, бүрэн дүүрэн эргүүлэхийн төлөө Тэр энэ ажлыг хийдэг. Хүн Бурханыг мэдэж байж л Бурханыг хайрлаж эхэлдэг бөгөөд Бурханыг хайрлахын тулд Түүнийг мэдэх ёстой. Хүн хэрхэн эрж хайх эсвэл юу олж авахаар эрж хайх нь хамаагүй Бурханы талаарх мэдлэгт хүрэх чадвартай байх ёстой. Зөвхөн ийм маягаар л хүн Бурханы зүрх сэтгэлийг хангалуун болгож чадна. Бурханыг мэдэж байж л хүн Бурханд жинхэнээсээ итгэж, мөн Бурханыг мэдэж байж л Түүнийг үнэхээр хүндэлж, дуулгавартай дагаж чадна. Бурханыг мэддэггүй хүмүүс Бурханыг үнэхээр дуулгавартай дагаж, хүндэлж хэзээ ч чадахгүй. Бурханыг мэдэх гэдэгт Бурханы зан чанарыг мэдэх, Түүний хүслийг ойлгох, Тэр юу болохыг мэдэх багтдаг. Гэхдээ хүн аль ч талыг нь мэдэж авсан бай, аль аль нь төлөөс төлөхийг, дуулгавартай байх хүслийг хүнээс шаарддаг. Үүнгүйгээр хэн ч эцсээ хүртэл дуулгавартай дагаж чадахгүй. Бурханы ажил хүний үзлээс хэтэрхий хол. Бурханы зан чанар, Бурхан юу болохыг мэдэхэд хүнд хэтэрхий хэцүү бөгөөд Бурханы хэлдэг, хийдэг бүхэн хүнд хэтэрхий ойлгохын аргагүй байдаг. Хэрвээ хүн Бурханыг дагахыг хүсдэг ч Түүнд дуулгавартай байх хүсэлгүй бол тэр юу ч олж авахгүй. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл, хүнд ойлгомжгүй, хүн хүлээн зөвшөөрөхөд хэцүү маш их ажлыг Бурхан хийсэн, мөн хүний үзлийг засахад хүндрэл учруулах маш ихийг Бурхан хэлсэн. Гэхдээ хүнд хэтэрхий их бэрхшээл тулгарсан болохоор Тэр ажлаа хэзээ ч зогсоогоогүй. Харин ч Тэр үргэлжлүүлэн ажиллаж, ярьж, асар олон тооны “дайчин” унаж байсан ч ажлаа хийсээр, Өөрийнх нь шинэ ажилд захирагдах хүсэлтэй бүлэг хүмүүсийг ээлж дараалан тасралтгүй сонгосоор байдаг. Унасан тэр “баатруудыг” Тэр өрөвддөггүй, харин ч Өөрийнх нь шинэ

а. Эх бичвэрт “Бурханыг мэдэх ажил” гэж байдаг.

ажил, үгийг хүлээн авдаг хүмүүсийг нандигнадаг. Гэхдээ юуны төлөө Тэр ингэж алхам алхмаар ажилладаг вэ? Тэр яагаад үргэлж нэг хэсэг хүнийг таягдан хаяж, нөгөөг нь сонгож байна вэ? Тэр яагаад үргэлж ийм арга барил хэрэглэдэг вэ? Түүний ажлын зорилго бол хүнд Өөрийгөө мэдүүлж, тэгснээрээ Өөрөөр нь авхуулах боломжийг хүнд олгох явдал юм. Түүний ажлын зарчим нь өнөөдөр Түүний хийдэг ажлыг эсэргүүцдэг мөртөө өнгөрсөн үед хийсэн ажилд нь захирагддаг хүмүүс дээр ажиллах бус, харин өнөөдөр Өөрийнх нь хийдэг ажилд захирагдах чадвартай хүмүүс дээр ажиллах явдал билээ. Түүний маш олон хүнийг таягдан хаясаар ирсний шалтгаан нь энэ юм.

Бурханыг мэдэж авах сургамжийг ганц хоёрхон өдрийн дотор авч чадахгүй: Хүн туршлагажиж, зовлон туулж, жинхэнээсээ захирагддаг болох ёстой. Юуны өмнө Бурханы ажил болон үгээс эхэл. Бурханы тухай мэдлэгт юу багтдаг, энэ мэдлэгт хэрхэн хүрэх болон туршлагаараа Бурханыг яаж харахыг чи ойлгох шаардлагатай. Бурханыг хараахан мэдэхгүй байхдаа хүн бүрийн хийх ёстой зүйл нь энэ юм. Бурханы ажил, үгийг хэн ч нэг дор ухаарч чадахгүй бөгөөд хэн ч Бурханы талаарх бүрэн дүүрэн мэдлэгт богинохон хугацаанд хүрч чадахгүй. Үүнд шаардлагатай туршлагажих арга барил байдаг агаад үүнгүйгээр хэн ч Бурханыг мэдэж, Бурханыг чин сэтгэлээсээ дагаж чадахгүй. Бурхан хэдий чинээ их ажил хийнэ, хүн Түүнийг төдий чинээ их мэдэж авдаг. Бурханы ажил хүний үзэлтэй зөрчилдөх тусам, Түүний талаарх хүний мэдлэг төдий чинээ шинэчлэгдэж, гүнзгийрч байдаг. Хэрвээ Бурханы ажил үүрд нэгэн хэвийн, өөрчлөгдөхгүй хэвээр байдаг байсан бол Түүний талаарх хүний мэдлэг их биш байх байсан. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үед Бурхан юу хийсэн, Хаанчлалын эрин үед Тэр юу хийдэг гээд эдгээр үзэгдлийн талаар та нар тов тодорхой мэдэх ёстой. Та нар Бурханы ажлыг мэдэх ёстой. Петр Есүсийг дагаж байж л Есүст хийсэн Сүнсний ажлаас нэлээдийг нь аажмаар мэдэж авсан. Тэрээр “Хүний туршлагад түшиглэх нь бүрэн мэдлэгт хүрэхэд хангалттай биш; Бурханыг мэдэхэд бидэнд туслах олон шинэ зүйл Түүний ажилд байх ёстой” гэж хэлсэн. Есүс бол элч нарын адилаар Бурханы илгээсэн нэгэн гэж Петр эхэндээ итгэж, Есүсийг Христ гэж үздэггүй байсан. Өөрийг нь дагаж эхлэх үед Есүс Петрээс “Ионагийн хүү Симон оо, чи Намайг дагах уу?” гэж асуусан. Петр, “Тэнгэрлэг Эцэгийн илгээсэн нэгнийг би дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг би хүлээн зөвшөөрөх ёстой. Би Таныг дагах болно” гэж хариулсан юм. Петрийн үгээс Есүсийн талаар тэр ямар ч мэдлэггүй байсныг харж болно; тэр Бурханы үгийг туулж, өөртэйгөө харьцаж,

Бурханы төлөө зовлон туулсан боловч Бурханы ажлын талаар ямар ч мэдлэггүй байсан. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа Петр Бурханы олон үйл хэргийг Есүсээс олж харж, Бурханы хайр татам байдлыг харж, Бурханы оршихуйгаас нэлээдийг нь Есүсээс олж харсан. Есүсийн хэлсэн үгийг хүн хэлж чадахгүй, Есүсийн хийсэн ажлыг хүн хийж чадахгүй байсан гэдгийг ч бас тэр харсан юм. Түүнчлэн Петр Бурханы мэргэн ухаанаас ихээхнийг, бурханлаг чанарын ихээхэн ажлыг Есүсийн үг болоод үйлдлээс харсан. Туршлагажих явцдаа тэр зөвхөн өөрийгөө мэдээд зогсохгүй, Есүсийн үйлдэл бүрийг сайтар анхаарч, үүнээсээ олон шинэ зүйл олж мэдсэн; тухайлбал, Есүсээр дамжуулан Бурханы хийсэн ажилд бодитой Бурханы олон илэрхийлэл байсан бөгөөд хэлсэн үг, хийсэн үйлдэл, түүнчлэн чуулгануудыг хариулсан байдал, хэрэгжүүлсэн ажлаараа Есүс энгийн хүнээс ялгаатай байлаа. Иймээс Петр сурах ёстой олон хичээлээ Есүсээс авсан бөгөөд Есүсийг загалмайд цовдлогдох гэж байх үед Есүсийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон байв. Тэрхүү мэдлэг нь насан туршдаа Есүст үнэнч байж, Эзэний төлөө толгойгоо доош харуулж цовдлогдохынх нь үндэс болсон юм. Хэдийгээр тэр эхэндээ зарим нэг үзэлтэй, Есүсийн талаар тодорхой мэдлэггүй байсан боловч эдгээр нь завхарсан хүнд зайлшгүй байдаг зүйл юм. Явах гэж байхдаа Өөрийнх нь хийх гэж ирсэн ажил нь цовдлуулалт байсан гэдгийг Есүс Петрт хэлсэн: Эрин үе Түүнийг хаяж, энэхүү бузар заваан хуучин эрин үе Түүнийг загалмайд цовдлох нь зайлшгүй шаардлагатай зүйл байв; Тэр золин авралын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд ирсэн агаад энэ ажлыг гүйцэлдүүлснээр Түүний үйлчлэл дуусах байлаа. Үүнийг сонсоод Петр уй гашууд автаж, Есүст бүр ч их татагдсан юм. Есүсийг загалмайд цовдлогдох үед Петр ганцаархнаа гашуудан уйлжээ. Үүний өмнөхөн тэр Есүсээс “Эзэн минь! Өөрийгөө цовдлогдоно гэж Та хэлэх юм. Явсны тань дараа хэзээ бид Тантай дахин уулзах вэ?” гэж асуусан. Түүний хэлсэн үгэнд ямар ч хольц байгаагүй юу? Ямар ч үзэл холилдоогүй байсан уу? Бурханы ажлын нэг хэсгийг гүйцэлдүүлэхээр Есүс ирсэн, Есүсийг явсны дараа Сүнс өөртэй нь хамт байх болно, хэдий Есүс загалмайд цовдлогдож, тэнгэрт өргөгдсөн ч гэсэн Бурханы Сүнс өөртэй нь хамт байна гэдгийг Петр зүрх сэтгэлдээ мэдэж байв. Тухайн үед Петр Есүсийн талаар зарим нэг мэдлэгтэй болсон байсан: Есүсийг Бурханы Сүнс илгээсэн, Бурханы Сүнс Түүний дотор байдаг, Есүс бол Бурхан Өөрөө, Тэр бол Христ гэдгийг тэр мэдэж байсан юм. Гэсэн ч Есүсийг гэх хайр, мөн хүний сул дорой байдлынхаа улмаас Петр тийм үг хэлжээ. Хэрвээ хүн Бурханы ажлын алхам бүрд ажиглаж, хичээнгүйлэн туршлагажиж чадвал Бурханы хайр татам

байдлыг аажмаар олж мэдэж чадах болно. Паулын үзэгдэл юу байсан бэ? Есүс өөрт нь харагдах үед Паул “Та хэн бэ, Эзэн минь?” гэсэн. Есүс “Би бол чиний хяхан хавчдаг Есүс байна” гэж хэлсэн юм. Энэ нь Паулын үзэгдэл байв. Петр Есүсийн амилал болон 40 өдрийн турш харагдсаныг нь, мөн Есүсийн амьдарч байх хугацааны номлолыг өөрийн аяны төгсгөл хүртэл үзэгдлээ болгосон юм.

Хүн Бурханы ажлыг туулж, өөрийгөө мэдэж авч, завхарсан зан чанараасаа ангижирч, амийн өсөлтийг эрж хайх нь бүгд Бурханыг мэдэхийн төлөө байдаг. Хэрвээ чи зөвхөн өөрийгөө мэдэж, завхарсан зан чанартайгаа харьцахыг л хичээдэг атлаа Бурхан хүн дээр ямар ажил хийдэг, Түүний аврал хэр агуу болох, хэрхэн Бурханы ажлыг туулж, Бурханы үйл хэргийг нүдээр харах тухай ямар ч мэдлэггүй бол туршлага чинь ямар ч утгагүй. Үнэнийг хэрэгжүүлж, тэвчиж чаддаг л бол амь нь төлөвшсөн байгаа гэж чи бодож байвал амийн жинхэнэ утга учрыг эсвэл хүнийг төгс болгох Бурханы зорилгыг бас л ухаараагүй байна гэсэн үг юм. Нэг л өдөр чи шашны чуулгануудад, Гэмшлийн Чуулган юм уу Амийн Чуулганы гишүүдийн дунд ороод, залбирал нь “үзэгдлийг” агуулдаг, амийг эрж хайхдаа үгээр замчлуулж, сэтгэл нь хөдөлдөг үнэн сүсэгт олон хүнтэй таарах болно. Түүнчлэн, олон хэрэг явдал дээр тэд тэвчиж, өөрсдийгөө хойш тавьж, махан биедээ захирагдахгүй байж чаддаг. Тэр үед чи ялгааг нь хэлж чадахгүй: Тэдний хийдэг бүхнийг зөв, амийн төрөлхийн илэрхийлэл гэж чи бодно, харин тэдний итгэдэг нэр буруу байдаг нь хэчнээн харамсалтай билээ. Тийм үзэл бодол мунхаг биш гэж үү? Олон хүнд амь байдаггүй гэж яагаад хэлдэг вэ? Учир нь тэд Бурханыг мэддэггүй болохоор зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй, тэдэнд амь байхгүй гэж хэлдэг. Хэрвээ Бурханд итгэх итгэл чинь тодорхой түвшинд хүрч, Бурханы үйл хэрэг, Бурханы бодит байдал, Бурханы ажлын үе шат бүрийг бүрэн дүүрэн мэдэх чадвартай болсон бол чи үнэнийг эзэмшсэн байна. Хэрвээ чи Бурханы ажил болон зан чанарыг мэддэггүй бол туршлагад чинь ямар нэг зүйл дутуу л байна. Есүс ажлынхаа тэр үе шатыг хэрхэн хэрэгжүүлсэн, энэ үе шат хэрхэн хэрэгжиж байгаа, Нигүүлслийн эрин үед Бурхан ажлаа хэрхэн хийсэн, ямар ажил хийгдсэн, энэ үе шатанд ямар ажил хийгдэж байгаа гээд эдгээр зүйлийн талаар чи нэгд нэгэнгүй мэдэхгүй бол хэзээ ч итгэлтэй байж чадахгүй, үргэлж тээнэгэлзэх болно. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа чи Бурханы хийсэн ажлыг, Түүний ажлын алхам бүрийг мэдэж чадвал, мөн Бурхан үгээ хэлж байгаагийн зорилго, Түүний хэлсэн ийм их үг яагаад биелээгүй тухай бүрэн дүүрэн мэдлэг олж авсан бол сэтгэлийн түгшүүр, цэвэршүүлэлтээс ангид байж, түдгэлзэлгүйгээр, зоригтойгоор өмнөх замаа даган явж чадна. Бурхан

Өөрийн ажлаас үлэмж ихийг нь ямар аргаар биелүүлдгийг та нар харах ёстой. Тэр Өөрийн хэлдэг үгийг ашиглан, олон янзын үгээр дамжуулан хүнийг цэвэршүүлж, хүний үзлийг өөрчилдөг. Та нарын амссан бүх зовлон, туулсан бүх цэвэршүүлэлт, дотроо хүлээн авсан харьцалт, туулсан гэгээрэл бүхэн Бурханы хэлсэн үгээр дамжин биелсэн юм. Юунаас болж хүн Бурханыг дагадаг вэ? Бурханы үгээс болж! Бурханы үг туйлын нууцлагаас гадна хүний зүрх сэтгэлийг хөдөлгөж, сэтгэлийнх нь гүн дэх зүйлсийг илчилж, өнгөрсөнд болсон зүйлсийг хүнд мэдүүлж, ирээдүйд болох зүйлсийг тодорхой харах боломж олгож чаддаг. Иймээс Бурханы үгээс болж хүн зовлон туулж, мөн Бурханы үгээс болж төгс болгуулдаг: Энэ үед л хүн Бурханыг дагадаг. Энэ үе шатанд хүний хийх ёстой зүйл бол Бурханы үгийг хүлээн авах явдал бөгөөд төгс болгуулах ч бай, цэвэршүүлэлт амсах ч бай, гол түлхүүр нь Бурханы үг билээ. Энэ бол Бурханы ажил, бас өнөөдөр хүний мэдвэл зохих үзэгдэл юм.

Бурхан хүнийг яаж төгс болгодог вэ? Бурханы зан чанар юу вэ? Түүний зан чанарт юу агуулагддаг вэ? Энэ бүх зүйлийг тодруулбал: үүнийг Бурханы нэрийг түгээх гэж нэрлэдэг, үүнийг Бурханд гэрчлэл хийх, Бурханыг өргөмжлөх гэж нэрлэдэг. Бурханыг мэдсэн суурин дээр үндэслэн эцэстээ хүний амь зан чанар өөрчлөгдөнө. Хүн хэдий чинээ их харьцалт, цэвэршүүлэлт туулна, төдий чинээ хүч чадалтай байдаг; Бурханы ажлын үе шат олон байх тусам, хүн төдий чинээ төгс болгуулдаг. Өнөөдөр хүний туршлагаар бол, Бурханы ажлын алхам бүр нь хүний үзэл рүү дайрч, хүний оюун ухааныг бүгд даван гарч, хүлээлтээс нь давсан байдаг. Бурхан хүнийг хэрэгтэй бүхнээр нь хангадаг атал энэ нь бүх талаараа хүний үзэлтэй зөрчилддөг. Чамайг сул дорой байх үед Бурхан Өөрийн үгийг айлддаг; ингэж л Тэр чиний амийг хангаж чаддаг. Чиний үзэл рүү дайрснаараа Тэр чамаар Бурханы харьцалтыг хүлээн авхуулдаг; зөвхөн ингэж л чи завхралаасаа ангижирч чадна. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан нэг талаараа бурханлаг чанар дотор ажилладаг боловч нөгөө талаараа хэвийн хүн чанараар ажилладаг. Бурханы хийдэг ямар ч ажлыг чи үгүйсгэхгүй байж, Бурхан хэвийн хүн чанараар юу ч хэлж, хийсэн бай захирагдаж чаддаг болж, Тэр хэчнээн хэвийн харагдсан ч хамаагүй Түүнд захирагдаж, Түүнийг ойлгож чаддаг болж, бодит туршлагатай болох үедээ л Тэр бол Бурхан гэдгийг чи гарцаагүй мэдэж, чамд ямар ч үзэл төрөхөө больж, Түүнийг эцсээ хүртэл дагах чадвартай болно. Бурханы ажилд мэргэн ухаан байдаг. Түүний гэрчлэлд хүн хэрхэн бат зогсож чадахыг Тэр мэддэг. Хүний амин газар хаана оршдогийг Тэр мэддэг, Түүний хэлдэг үг чиний амин газарт цохиж чаддаг боловч Тэр бас сүр жавхлант,

мэргэн үгээрээ чамайг Өөрийн гэрчлэлд бат зогсоодог. Бурханы гайхамшигт үйл хэрэг ийм билээ. Бурханы хийдэг ажил хүний оюун ухаанд төсөөлөхийн аргагүй. Махан биетэй оршихуй болох хүнд ямар төрлийн завхрал байдаг, хүний мөн чанарыг юу бүрдүүлдэг гээд энэ бүхнийг Бурханы шүүлт илчилдэг нь хүнийг ичгүүрээ нуух газаргүй болгодог.

Өөрийнх нь тухай мэдлэгийг хүн олж аваасай гэсэндээ, мөн Өөрийнхөө гэрчлэлийн төлөө Бурхан шүүлт, гэсгээлтийн ажил хийдэг. Завхарсан зан чанарыг нь Тэр шүүхгүй л бол хүн, халдахыг тэвчдэггүй Түүний зөвт зан чанарыг мэдэж чадахгүй, Бурханы талаарх хуучин мэдлэгээ шинэ болгож бас чадахгүй байх байсан. Өөрийн гэрчлэлийн төлөө, Өөрийн удирдлагын төлөө Тэр Өөрийгөө бүхэлд нь ил болгож, улмаар ил тод илрэлтээрээ дамжуулан Бурханы талаарх мэдлэгт хүрч, зан чанараа өөрчилж, Бурханд цангинасан гэрчлэл хийх боломжийг хүнд олгодог. Бурханы төрөл бүрийн олон ажлаар дамжуулан хүний зан чанарт өөрчлөлт гардаг; зан чанар нь ингэж өөрчлөгдөхгүйгээр хүн Бурханд гэрчлэл хийж, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадахгүй. Хүний зан чанарын өөрчлөлт нь хүн өөрийгөө Сатаны хүлээс, харанхуйн нөлөөнөөс чөлөөлж, үнэхээр Бурханы ажлын үлгэр дуурайл, загвар, Бурханы гэрч, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг нэгэн болсныг илтгэдэг. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан газар дээр ажлаа хийхээр ирсэн бөгөөд Өөрийнх нь талаар мэдлэгтэй болж, Өөрт нь дуулгавартай байж, Өөрийг нь гэрчилж, Өөрийнх нь бодитой агаад хэвийн ажлыг мэдэж, хүний үзэлтэй нийцдэггүй Өөрийнх нь бүх үг, ажлыг дуулгавартай дагаж, хүнийг аврахаар Өөрийнх нь хийдэг бүх ажил хийгээд хүнийг байлдан дагуулахаар гүйцэлдүүлдэг Өөрийнх нь бүх үйл хэрэгт гэрчлэл хийхийг хүнээс шаарддаг. Бурханд гэрчлэл хийдэг хүмүүс Бурханы тухай мэдлэгтэй байх ёстой; ийм гэрчлэл л үнэн зөв, бодитой байдаг, ийм гэрчлэл л Сатаныг ичээж чадна. Шүүлт, гэсгээлт болон харьцалт, засалтыг нь туулж Түүнийг мэдэж авсан хүмүүсийг Бурхан Өөртөө гэрчлэл хийлгэхэд ашигладаг. Өөртөө гэрчлэл хийлгэхдээ Тэр Сатаны завхруулсан хүмүүсийг ашиглаж, зан чанар нь өөрчлөгдөж, Түүний ерөөлийг хүртсэн хүмүүсийг ч бас ашигладаг. Хүн зөвхөн амаараа магтах нь Түүнд хэрэггүй, мөн Өөрийнх нь авраагүй Сатаны төрлийнхний магтаал, гэрчлэл ч Түүнд хэрэггүй. Бурханыг мэддэг хүмүүс л Бурханд гэрчлэл хийхэд тохирно, зан чанар нь өөрчлөгдсөн хүмүүс л Түүнд гэрчлэл хийхэд тохирно. Өөрийнх нь нэрийг санаатайгаар шившиглэхийг Бурхан хүнд зөвшөөрөхгүй.

ПЕТР ЕСҮСИЙГ ХЭРХЭН МЭДЭЖ АВСАН ТУХАЙ

Есүстэй хамт өнгөрөөсөн хугацаандаа Петр, Есүсээс олон хайр татам чанарыг, даган дуурайхуйц олон талыг болон өөрийг нь хангасан олон талыг олж харжээ. Хэдийгээр Петр олон арга замаар Бурханы оршихуй болон хайр татам байдлыг Есүсээс олж харсан боловч анх тэрээр Есүсийг мэдээгүй юм. Петр Есүсийг 20 настай байхаасаа дагаж эхэлсэн бөгөөд зургаан жилийн турш үргэлжлүүлэн дагажээ. Энэ хугацаанд тэр Есүсийг хэзээ ч мэдэж аваагүй; Петр дан ганц бахдал бишрэлээрээ Есүсийг дагахад бэлэн байлаа. Есүс анх түүнийг Галил нуурын эрэг дээр байхад нь дуудаад: “Ионагийн хүү Симон оо, чи Намайг дагах уу?” гэж асуужээ. Петр: “Би тэнгэрлэг Эцэгийн илгээсэн хүнийг дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Би Таныг дагана” гэсэн юм. Тухайн үед Петр, хамгийн агуу эш үзүүлэгч, Бурханы хайртай Хүү болох Есүс нэртэй хүний тухай яриаг сонссон байсан бөгөөд Түүнийг олно гэдэгтээ байнга найдаж, мөн Түүнийг харах боломж тохионо гэдэгт найдаж байв (учир нь Ариун Сүнс түүнийг ийнхүү удирдаж байлаа). Хэдий Петр Түүнийг хэзээ ч харж байгаагүй, харин Түүний тухай цуу яриа л сонсож байсан боловч Петрийн зүрх сэтгэлд Есүсийг гэх хүсэл тэмүүлэл, бишрэл хүндэтгэл аажмаар өсөж, нэг л өдөр Есүсийг харна хэмээн байнга эрмэлзэж байв. Есүс Петрийг хэрхэн дуудсан бэ? Тэр ч бас Петр гэдэг хүний тухай яриаг сонссон, гэхдээ Ариун Сүнс Түүнд: “Галил хэмээх нуур луу яв, тэнд Ионагийн хүү Симон хэмээх нэгэн байгаа” хэмээн зааварчлаагүй юм. Есүс, Ионагийн хүү Симон хэмээх хүн байдаг, хүмүүс түүний номлолыг сонсдог бөгөөд тэр ч бас тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, түүнийг сонссон хүмүүсийн сэтгэл хөдлөн уйлж байсан гэж хэн нэгний ярихыг сонсжээ. Үүнийг сонссоныхоо дараа Есүс тэр хүнийг дагаж, Галил нуур луу очсон; Петр Есүсийн дуудлагыг хүлээн авч, Түүнийг дагасан билээ.

Есүсийг дагах хугацаанд Петрт Есүсийн талаар олон санаа бодол төрсөн бөгөөд Түүнийг үргэлж өөрийн өнцгөөс шүүдэг байв. Петр Сүнсний талаар тодорхой түвшний ойлголттой байсан хэдий ч түүний ойлголт зарим талаар тодорхой бус байсан тул тэрээр: “Би тэнгэрлэг Эцэгийн илгээсэн хүнийг дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг би хүлээн зөвшөөрөх ёстой” гэж хэлсэн юм. Тэрээр Есүсийн хийсэн зүйлсийг ойлгоогүй, тэдгээрийг тодорхой мэдээгүй. Есүсийг хэсэг хугацаанд дагасныхаа дараа тэр Есүсийн хэлсэн, хийсэн зүйлийг болон Есүсийг Өөрийг нь сонирхож эхэлсэн. Есүс хайр, хүндэтгэлийн аль

алиныг төрүүлж буйг тэр мэдэрсэн; тэр Түүнтэй холбогдож, Түүний дэргэд байх дуртай байсан бөгөөд Есүсийн үгийг сонсох нь түүнд хангалт, тусламж үзүүлсэн юм. Есүсийг дагасан хугацаандаа Петр, Түүний амьдралын бүх зүйлийг буюу үйлдэл, үг, хөдөлгөөн, илэрхийллийг нь ажиглаж, үнэн сэтгэлээсээ авч үзсэн. Тэгээд Есүс бол эгэл хүмүүстэй адилгүй гэх гүн гүнзгий ойлголтыг олж авчээ. Хэдийгээр Есүсийн гадаад төрх дэндүү хэвийн байсан ч Тэрээр хүнийг гэх хайр, энэрэл, хүлээцтэй байдлаар дүүрэн байсан юм. Түүний хийсэн, эсвэл хэлсэн бүхэн нь бусдад асар их тус дэм болсон бөгөөд Петр өмнө нь хэзээ ч хараагүй, өөрт нь ч бас байгаагүй зүйлсийг Есүсээс харж, олж авсан. Хэдийгээр Есүс асар том бие бялдар ч, ер бусын хүн чанар ч байхгүй боловч Түүнд үнэхээр хосгүй, эгэл бус байдал байдаг гэж Петр харсан юм. Петр үүнийг бүрэн тайлбарлаж чадахгүй байсан хэдий ч Есүс өрөөл бусдаас өөрөөр үйлддэгийг харсан, учир нь Түүний хийсэн зүйлс хэвийн хүмүүсийн хийдгээс тун өөр байсан билээ. Есүстэй харилцсан цагаасаа хойш Петр, Түүний зан араншин жирийн хүнийхээс өөр гэдгийг бас харжээ. Есүс үргэлж тууштай үйлддэг, хэзээ ч яардаггүй, аливааг хэзээ ч дэгсдүүлдэггүй, эсвэл дарж хэлдэггүй, харин хэвийн агаад биширмээр зан араншинг харуулан амьдардаг байлаа. Ярихдаа Есүс илэн далангүй, нигүүлсэнгүй ярьж, үргэлж хөгжилтэй атлаа амарлингуй байдлаар ярилцдаг байсан ч Өөрийнхөө ажлыг гүйцэтгэхдээ эрхэм чанараа хэзээ ч алдаагүй юм. Есүс заримдаа үг дуу цөөтэй байх мөртөө бусад үед зогсоо чөлөөгүй ярьж байхыг Петр харсан. Заримдаа Тэр маш их баярласандаа наадан тоглож, дэвэн дэгдэх тагтаа мэт харагддаг байсан ч зарим үед маш их гунигласандаа юу ч ярилгүй, орь гунигт автан, хал үзэж, хашир суусан эх хүн шиг байдаг байв. Заримдаа Тэр дайснаа устгахаар давшиж буй баатарлаг цэрэг шиг уур хилэнгээр дүүрэн байдаг ба заримдаа бүр архирч буй арслантай төстэй байдаг байлаа. Заримдаа Тэр баярлан инээж, бусад үед нь залбирч, уйлж байв. Есүс хэрхэн авирлаж байснаас үл хамааран, Петр Түүнийг хязгааргүй хайрлаж, хүндлэх болжээ. Есүсийн инээд түүнийг аз жаргалаар бялхуулж, Есүсийн уй гашуу түүнийг уйтгар гунигт автуулж, уур хилэн нь түүнийг айлгаж, харин өршөөл, уучлал, хүмүүст тавьдаг хатуу чанд шаардлага нь түүнийг Есүст үнэхээр хайртай болгож, Түүнийг үнэхээр хүндэлж, хүсэн тэмүүлэх эрмэлзлийг нь бий болгожээ. Мэдээж, Петр хэдэн жилийн турш Есүсийн хажууд амьдарч байхдаа энэ бүхнийг аажмаар ухаарч эхэлсэн юм.

Петр төрөлхийн саруул ухаантай, гойд хэрсүү хүн байсан боловч Есүсийг дагах үедээ олон тэнэг зүйл хийжээ. Бүр анх, Есүсийн талаар зарим нэг үзэл

түүнд байлаа. Тэрээр: “Хүмүүс Таныг эш үзүүлэгч гэдэг, тэгвэл Та найман настай, юмны учир ойлгож эхэлж байхдаа Бурхан гэдгээ мэдэж байсан уу? Та Ариун Сүнснээс олдсон гэдгээ мэдэж байсан уу?” гэж асуусан юм. Есүс хариуд нь: “Үгүй ээ, Би мэдээгүй! Би чамд ердөө л маш эгэл жирийн хүн шиг санагдаж байгаа биз дээ? Би бусадтай адилхан. Эцэгийн илгээдэг хүн бол ер бусын биш, харин хэвийн л хүн. Хэдийгээр Миний хийдэг ажил тэнгэрлэг Эцэгийг минь төлөөлдөг боловч Миний дүр, хүн болох Би, энэхүү махан бие тэнгэрлэг Эцэгийг минь бүрэн төлөөлж чадахгүй, харин Түүний нэг хэсгийг л төлөөлж чадна. Хэдий Би Сүнснээс ирсэн боловч хэвийн хүн хэвээр бөгөөд Миний Эцэг Намайг ер бусын нэгэн биш, жирийн хүн болгон энэ газар дэлхий рүү илгээсэн юм” гэжээ. Петр үүнийг сонсох үедээ л Есүсийн талаар бага зэргийн ойлголттой болсон юм. Тэрээр Есүсийн ажил, сургаал, хариулга, хангалтын тоо томшгүй олон цагийг туулсныхаа дараа л тун гүн гүнзгий ойлголт олж авчээ. 30 настай байхдаа Есүс Петрт удахгүй болох цовдлолынхоо талаар хэлж, бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд ажлын нэг үе шатыг—цовдлолын ажлыг хийхээр ирсэн гэдгээ хэлсэн. Есүс бас, цовдлолоос гурав хоногийн дараа хүний Хүү дахин амилна, амилангуутаа хүмүүст 40 хоног харагдана гэдгийг Петрт хэлсэн юм. Энэ үгийг сонсоод Петр гуниглаж, эдгээр үгийг үнэн сэтгэлээсээ авч үзсэн; тэр үеэс эхлээд тэрээр Есүстэй улам илүү дотно байх болжээ. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа Петр, Есүсийн хийсэн бүхэн нь Бурханы оршихуйнх гэдгийг ухаарч эхэлсэн бөгөөд Есүс бол гойд хайр татам гэж бодох болжээ. Ийм ойлголттой болох үед л Ариун Сүнс түүнийг дотроос нь гэгээрүүлсэн юм. Тэр үед Есүс шавь нар болон бусад дагалдагчдадаа хандан: “Иохан, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуужээ. Иохан: “Та бол Мосе” гэв. Дараа нь Тэр Лукт хандан: “Лук, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” гэхэд Лук: “Та бол хамгийн агуу эш үзүүлэгч” гэжээ. Дараа нь нэгэн эгчээс асуухад тэрээр: “Та бол мөнхөөс мөнхөд олон үг хэлдэг хамгийн агуу эш үзүүлэгч билээ. Хэний ч зөгнөл Таных шиг агуу байдаггүй, мөн хэний ч мэдлэг Таныхаас давдаггүй; Та бол эш үзүүлэгч” гэв. Дараа нь Есүс Петрт хандан: “Петр, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” гэж асуулаа. Петр хариуд нь: “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн. Та тэнгэрээс ирсэн, Та газрынх биш, Та Бурханы бүтээлүүдтэй адилгүй. Бид газар дээр байдаг, Та бидэнтэй хамт энд байгаа боловч Та бол тэнгэрийнх, Та энэ дэлхийнх биш, мөн Та газрынх биш” гэсэн юм. Туршлагаар нь дамжуулан Ариун Сүнс түүнийг гэгээрүүлж, ийм ойлголтод хүрэх боломж олгожээ. Энэ гэгээрлийн дараа тэрээр Есүсийн хийсэн бүхнийг бүр ч их гайхан биширч, Түүнийг бүр илүү хайр татам гэж бодсон бөгөөд

зүрх сэтгэлдээ Есүсээс хагацах ер дургүй байв. Иймээс Есүс цовдлогдоод дахин амилсныхаа дараа анх удаа Петрт Өөрийгөө харуулахад Петр ер бусын аз жаргалтайгаар: “Эзэн минь! Та дахин амилжээ!” хэмээн дуу алдсан юм. Тэгээд уйлангаа Петр тун том загас барьж хоол хийн, Есүст өргөн барьжээ. Есүс инээмсэглэсэн боловч үг хэлсэнгүй. Петр Есүсийн дахин амилсныг мэдэж байсан хэдий ч үүний нууцыг ойлгоогүй байв. Түүнийг Есүст загас идүүлэхээр өгөх үед Есүс татгалзаагүй боловч үг хэлээгүй, мөн хооллохоор суугаагүй. Харин гэнэт алга болжээ. Энэ нь Петрийг асар их цочролд оруулсан бөгөөд тэр үед л дахин амилсан Есүс нь урьдын Есүсээс өөр болохыг ойлгосон юм. Үүнийг ухаармагцаа Петр гашуудсан боловч Эзэн ажлаа биелүүлснийг мэдээд бас тайтгарчээ. Есүс Өөрийн ажлыг гүйцэтгэсэн, хүнтэй хамт байх хугацаа нь дууссан, мөн тэр цагаас эхлээд хүн өөрийнхөө замаар алхах ёстой болсон гэдгийг Петр мэдлээ. Есүс нэгэнтээ түүнд: “Чи ч бас Миний уусан гашуун аяганаас уух ёстой (үүнийг Тэр амиллынхаа дараа хэлсэн). Чи ч бас Миний алхсан замаар алхах ёстой. Миний төлөө амиа өгөх ёстой” гэж хэлсэн юм. Одоогоос ялгаатай нь тухайн үеийн ажил нүүр тулсан яриа хэлбэртэй байгаагүй. Нигүүлслийн эрин үед Ариун Сүнсний ажил нэн нууцлаг байсан ба Петр ихээхэн бэрхшээл туулсан юм. Заримдаа Петр: “Бурхан минь! Надад энэ амиас өөр юу ч байхгүй. Хэдийгээр энэ нь Таны хувьд төдийлөн үнэ цэнгүй боловч би үүнийгээ Танд зориулахыг хүсэж байна. Хэдий хүмүүс Таныг хайрлахад тохирохгүй, хайр болон зүрх сэтгэл нь үнэ цэнгүй боловч Та хүмүүсийн чин сэтгэлийн хүслийг мэддэг гэж би итгэж байна. Хүмүүсийн бие Таны зөвшөөрөлд нийцэхгүй ч гэсэн би Танаас зүрх сэтгэлийг минь хүлээн авахыг хүсэж байна” хэмээн уулга алдахад хүрдэг байлаа. Ийм залбирлыг хэлж, ялангуяа: “Би зүрх сэтгэлээ Бурханд бүрэн зориулахыг хүсэж байна. Хэдийгээр би Бурханы төлөө юу ч хийж чадахгүй боловч үнэнчээр Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, өөрийгөө Түүнд чин сэтгэлээсээ зориулахыг хүсэж байна. Бурхан зүрх сэтгэлийг минь гарцаагүй харна гэдэгт би итгэж байна” хэмээн залбирах үедээ тэр урам зориг авдаг байв. Тэрээр: “Бурханыг хайрлах бодол болон чин сэтгэлийн хүслийг минь Бурхан хүлээн зөвшөөрөөсэй гэдгээс өөр юуг ч би амьдралдаа гуйхгүй. Би Эзэн Есүстэй маш удаан хугацаанд хамт байсан ч Түүнийг хэзээ ч хайрлаж байгаагүй; энэ бол миний хамгийн том өр. Би Түүнтэй хамт байсан ч гэсэн Түүнийг мэдээгүй, тэр ч байтугай Түүний ар хударгаар зохисгүй зүйл хэлж байсан. Эдгээр зүйлийг бодохоор би Эзэн Есүст улам их өртэй санагддаг” гэж хэлсэн юм. Тэр үргэлж ийм байдлаар залбирдаг байв.

Тэрээр: “Би тоос шорооноос ч өчүүхэн. Энэ үнэнч сэтгэлээ Бурханд зориулахаас өөр хийж чадах зүйл надад үгүй” хэмээн хэлжээ.

Петрийн туршлага оргилдоо хүрч, түүний бие бараг бүхэлдээ тамирдсан ч Есүс дотроос нь зоригжуулсаар байлаа. Тэгээд Есүс нэг удаа Петрт үзэгджээ. Петр асар их зовж, зүрх сэтгэл нь шархалсан мэт санагдаж байх үед Есүс түүнд ийнхүү зааварчилсан юм: “Чи газар дээр Надтай хамт байсан, Би чамтай хамт энд байсан. Хэдийгээр өмнө нь бид тэнгэрт хамт байсан ч энэ нь эцсийн эцэст сүнсний ертөнцийнх юм. Одоо Би сүнсний ертөнцөд эргэн очсон, чи газар дээр байна. Учир нь Би газрынх биш, хэдий чи ч бас газрынх биш боловч чи газар дээр өөрийн чиг үүргийг биелүүлэх ёстой. Чи зарц тул үүргээ биелүүлэх ёстой.” Бурханы хажууд буцаж очиж чадна гэдгээ сонсоод Петр тайтгарчээ. Петр тийнхүү тэсэхийн аргагүй шаналж, бараг хэвтэрт орох үедээ: “Би маш их завхарсан болохоор Бурханыг сэтгэл хангалуун байлгах чадваргүй” гэж хэлэх хүртлээ харуусан гэмшсэн юм. Есүс түүнд үзэгдэж: “Петр ээ, чи нэгэнтээ Миний өмнө гаргаж байсан шийдвэрээ мартчихсан юм гэж үү? Чи үнэхээр Миний хэлсэн бүхнийг мартчихсан юм уу? Чи Надад өгсөн шийдвэрээ мартчихсан юм уу?” гэжээ. Есүсийн байгааг хараад Петр орноосоо өндийхөд Есүс түүнийг ингэж тайтгаруулсан юм: “Би газрынх биш гэдгээ чамд аль эрт хэлсэн—үүнийг чи ойлгох ёстой, гэхдээ чамд Би бас нэг зүйл хэлснийг чи мартчихав уу? ‘Чи ч бас газрынх биш, энэ дэлхийнх биш.’ Яг одоо хийх хэрэгтэй ажил чамд байна. Чи энэ мэт гашуудаж болохгүй. Чи ингэж зовж болохгүй. Хэдийгээр хүн, Бурхан хоёр нэг ертөнцөд хамт оршиж чадахгүй ч Надад Миний ажил, чамд чиний ажил байгаа, чиний ажил дуусах тэр өдөр бид нэг ертөнцөд хамтдаа байж, Би чамайг Өөртэйгөө үүрд хамт байлгана.” Энэ үгийг сонссоныхоо дараа Петр тайтгарч, санаа нь амарсан. Энэ зовлон нь түүний тэвчих ёстой, туулах ёстой зүйл гэдгийг тэрээр мэдсэн бөгөөд тэр цагаас хойш зориг оржээ. Есүс ялангуяа гол чухал мөчүүдэд түүнд харагдаж, онцгой гэгээрэл, удирдамж өгч, түүн дээр ихээхэн ажил хийж байсан юм. Петр юунд хамгийн их харамсаж байсан бэ? Петрийг “Та бол амьд Бурханы Хүү” гэж хэлсний дараахан Есүс Петрээс өөр нэг асуулт асуусан (гэхдээ үүнийг Библид ийм маягаар тэмдэглээгүй байдаг). Есүс: “Петр ээ! Чи Намайг ер нь хайрлаж байсан уу?” гэж түүнээс асуусан юм. Түүний хэлж байгааг Петр ойлгоод: “Эзэн минь! Би нэгэнтээ тэнгэр дэх Эцэгийг хайрлаж байсан боловч Таныг хэзээ ч хайрлаж байгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна” гэжээ. Тэгэхэд Есүс: “Хэрвээ хүмүүс тэнгэр дэх Эцэгийг хайрладаггүй бол газар дээрх Хүүг хайрлаж яахан чадах билээ? Хэрвээ хүмүүс Эцэг Бурханы илгээсэн

Хүүг хайрладаггүй бол яаж тэнгэр дэх Эцэгийг хайрлаж чадах билээ? Хэрвээ хүмүүс газар дээрх Хүүг үнэхээр хайрладаг бол тэнгэр дэх Эцэгийг ч үнэхээр хайрладаг” гэв. Петр энэ үгийг сонсоод, дутагдлаа ухаарчээ. Тэрээр “Би тэнгэр дэх Эцэгийг нэгэнтээ хайрласан боловч Таныг хэзээ ч хайрлаагүй” хэмээх үгээсээ болж нулимс урсгах хэмжээнд үргэлж харуусдаг байлаа. Есүсийг дахин амилж, дээш өргөгдсөний дараа тэрээр энэ үгэндээ бүр ч их харуусаж, гашууджээ. Урьдын ажил болон одоогийн биеийн хэмжээгээ эргээд бодохоороо тэр үргэлж Есүсийн өмнө очин залбирч, Бурханы хүслийг хангалуун байлгаагүй, мөн Бурханы стандартад нийцэхгүй байгаадаа үргэлж харамсан, өртэй санагддаг байлаа. Эдгээр асуудал нь түүний хамгийн том ачаа болсон билээ. Тэрээр: “Нэг л өдөр би Танд өөрт байгаа бүхнийг болон өөрийгөө бүхэлд нь зориулна, би Танд хамгийн үнэ цэнтэй болгоныг өгнө” гэсэн. Тэрээр: “Бурхан минь! Надад нэг л итгэл, нэг л хайр бий. Амь минь ямар ч үнэ цэнгүй, бас бие минь ч үнэ цэнгүй. Надад нэг л итгэл, нэг л хайр бий. Оюун ухаанд минь Танд итгэх итгэл, зүрх сэтгэлд минь Таныг хайрлах хайр байдаг; Танд миний өгч чадах зүйл өөр юу ч биш, энэ хоёр л байна” гэжээ. Петр Есүсийн үгээр асар их зоригжсон, учир нь цовдлогдохоосоо өмнө Есүс түүнд: “Би энэ дэлхийнх биш, чи ч бас энэ дэлхийнх биш” гэсэн. Дараа нь Петрийг асар их өвдөх үед Есүс түүнд: “Петр ээ, чи мартчихав уу? Би дэлхийнх биш, Өөрийнхөө ажлын төлөө л Би арай эрт явж одсон. Чи ч бас дэлхийнх биш, чи үнэхээр мартчихаа юу? Би чамд хоёр удаа хэлсэн, санахгүй байна уу?” хэмээн сануулсан юм. Үүнийг сонсоод Петр: “Би мартаагүй!” гэв. Тэгэхэд Есүс ингэж хэлсэн: “Чи нэгэнтээ тэнгэрт Надтай хамт аз жаргалтай байж, хэсэг хугацааг Миний хажууд өнгөрүүлсэн. Чи Намайг санаж, Би чамайг санадаг. Хэдийгээр Миний нүдээр бол бүтээлүүдийг дурдахын ч хэрэггүй боловч гэм зэмгүй агаад хайр татам нэгнийг Би яаж хайрлахгүй байж чадах юм бэ? Чи Миний амлалтыг мартчихаа юу? Чи газар дээрх Миний даалгаврыг хүлээн зөвшөөрөх ёстой; Миний даалгасан үүргийг биелүүлэх ёстой. Нэг л өдөр Би чамайг заавал хажуудаа аваачна.” Үүнийг сонсоод Петр улам их зоригжиж, бүр ч их урам зориг авсан болохоор загалмай дээр байхдаа тэр: “Бурхан минь! Би Таныг хангалттай хайрлаж чадахгүй! Та надаас үхэхийг гуйсан ч гэсэн би Таныг бас л хангалттай хайрлаж чадахгүй! Та сүнсийг минь хааш нь ч илгээсэн, Өөрийнхөө урьдын амлалтыг биелүүлэх ч бай, үгүй ч бай, дараа нь Та юу ч хийсэн бай, би Таныг хайрлаж, Танд итгэдэг” гэж хэлж чадсан юм. Тэрээр өөрийн итгэл, жинхэнэ хайрыг баримталж байлаа.

Нэгэн орой Петрийг оролцуулаад хэдэн шавь нар загас агнуурын завин дээр Есүстэй хамт байсан ба Петр Есүсээс маш гэнэн асуулт асууж: “Эзэн минь! Их удаан бодсон нэг асуултаа би Танаас асуумаар байна” гэсэн. Есүс: “Тэгвэл асуу, асуу!” гэж хариулав. Петр тэгэхэд нь: “Хуулийн эрин үед хийгдсэн ажил Таны хийсэн зүйл байсан уу?” гэжээ. Есүс: “Энэ хүүхэд, хэчнээн ч гэнэн юм бэ дээ!” гэж буй мэт инээмсэглэв. Дараа нь Тэр зоримгоор цааш үргэлжлүүлэн: “Энэ Минийх байгаагүй. Энэ бол Ехова болон Мосегийн хийсэн зүйл байсан юм” гэжээ. Петр үүнийг сонсоод дуу алдан: “Өө! Тэгвэл Таны хийсэн зүйл биш байжээ” гэв. Петрийг ингэж хэлмэгц Есүс өөр юу ч хэлсэнгүй. Петр дотроо: “Үүнийг Та хийгээгүй юм байна, тэгэхээр энэ Таны хийсэн зүйл биш болохоор хуулийг үгүй хийхээр ирсэнд тань гайхах юм алга” гэж бодлоо. Түүний зүрх сэтгэл ч бас уужирчээ. Дараа нь Есүс, Петр нэлээд гэнэн гэдгийг ухаарсан боловч тухайн үед Петрт ямар ч ойлголт байгаагүй учраас Есүс өөр юу ч хэлээгүй, түүнийг шууд няцаагаагүй. Нэг удаа Есүсийг синагогт номлол айлдахад Петрийг оролцуулаад олон хүн тэнд байжээ. Номлолдоо Есүс: “Мөнхөөс мөнхөд ирэх Нэгэн бүх хүн төрөлхтнийг нүглээс золин аврахын тулд Нигүүлслийн эрин үед золин авралын ажлыг хийх боловч хүнийг нүглээс хөтлөн гаргахдаа ямар ч дүрмээр хязгаарлагдахгүй. Тэрээр хуулиас алхан гарч, Нигүүлслийн эрин үед орно. Бүх хүн төрөлхтнийг золин аварна. Тэр Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе рүү алхах боловч Еховагаас ирсэн Түүнийг хэн ч мэдэхгүй. Мосегийн хийсэн ажлыг Ехова хайрласан; Еховагийн хийсэн ажлаас үүдэн Мосе хуулийг боловсруулсан” гэв. Ингэж хэлмэгцээ Тэр: “Нигүүлслийн эрин үед Нигүүлслийн эрин үеийн тушаалуудыг хүчингүй болгодог хүмүүст гай гамшиг тохионо. Тэд сүмд зогсоод Бурханы сүйрлийг хүлээн авах ёстой ба тэдэн дээр гал бууна” хэмээн үргэлжлүүллээ. Эдгээр үгийг сонссон нь Петрт бага зэргийн нөлөө үзүүлсэн бөгөөд туршлагажих хугацаанд нь Есүс Петрийг хариулж, хангаж, чин сэтгэлээсээ ярилцаж байсан тул энэ нь Петрт Есүсийн талаар арай илүү ойлголт өгсөн юм. Петр тухайн өдөр Есүсийн номлосон зүйл, загас агнуурын завин дээр байх үедээ Есүсээс асуусан асуулт, Есүсийн өгсөн хариулт, мөн түүнчлэн Тэр хэрхэн инээмсэглэсэн тухай бодох үедээ л энэ бүхнийг эцэст нь ойлгож авсан билээ. Дараа нь Ариун Сүнс Петрийг гэгээрүүлсэн бөгөөд тэр үед л Петр Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг ойлгосон. Петрийн ойлголт Ариун Сүнсний гэгээрлээс урган гарсан боловч ойлголт нь тодорхой үйл явцтай байлаа. Асуулт асууж, Есүсийн номлохыг сонссоноор, тэгээд Есүсийн онцгой нөхөрлөл, онцгой хариулгыг хүлээн авснаар

Петр, Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг ухаарчээ. Ийм ухааралд нэг л шөнийн дотор хүрсэн юм биш; үүнд үйл явц байсан бөгөөд түүний хожмын туршлагад тус нэмэр болсон юм. Есүс төгс болгох ажлыг бусад хүмүүст хийгээгүй мөртөө яагаад зөвхөн Петрт л хийсэн юм бэ? Учир нь, Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг зөвхөн Петр л ойлгосон; өөр хэн ч үүнийг мэдээгүй. Түүнийг дагаж байх хугацаандаа ихийг мэдсэн олон шавь байсан боловч тэдний мэдлэг өнгөцхөн байв. Ийм учраас Есүс Петрийг төгс болгуулах үлгэр загвар болгон сонгосон юм. Есүс тэр үед Петрт хэлсэн зүйлээ өнөөдөр хүмүүст хэлдэг бөгөөд тэдний мэдлэг болон амийн оролт Петрийн дайр хүрэх ёстой. Энэ шаардлага болон энэ замын дагуу Бурхан хүн бүрийг төгс болгоно. Өнөөдөр яагаад хүмүүсээс бодит итгэл, жинхэнэ хайртай байхыг шаарддаг вэ? Петрийн туулсан зүйлийг та нар ч бас туулах ёстой; Петрийн туршлагаараа олж авсан үр жимс та нараас ч бас харагдах ёстой; Петрийн амссан зовлон шаналлыг та нар ч бас гарцаагүй туулах ёстой. Та нарын алхдаг зам Петрийн алхаж байсантай адилхан. Та нарын амсдаг шаналал бол Петрийн амссан зовлон шаналал юм. Та нар алдрыг хүлээн авах үедээ, мөн бодит амьдралыг амьдран харуулах үедээ Петрийн дүрийг амьдран харуулдаг. Зам нь адилхан бөгөөд үүнийг дагаснаар хүн төгс болгуулдаг. Гэсэн хэдий ч, Петрийнхтэй харьцуулахад та нарын хэв чанар арай дутуу дулимаг байдаг, учир нь цаг үе өөрчлөгдсөн, хүмүүсийн завхралын хэмжээ ч бас өөр болсон, түүнчлэн Иудей нь эртний соёлтой, урт удаан оршин тогтносон хаант улс байлаа. Тиймээс та нар хэв чанараа сайжруулахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Петр маш хэрсүү, хийдэг юм бүхэндээ самбаатай, туйлын үнэнч шударга хүн байсан юм. Тэр олон бүтэлгүйтэл амссан. Тэрээр 14 настайдаа нийгэмд хөл тавьж, сургуульд сурч байсны зэрэгцээ синагогт ойр ойрхон очдог байв. Тэр ихээхэн урам зоригтой, цуглаанд оролцоход үргэлж бэлэн байдаг байлаа. Тэр үед Есүс Өөрийнхөө ажлыг хараахан албан ёсоор эхлээгүй байв; энэ нь ердөө Нигүүлслийн эрин үеийн эхлэл байсан юм. Петр 14 настайдаа шашны хүмүүстэй харилцаж эхэлсэн; 18 настайдаа тэрээр шашны дээдчүүлтэй холбоо тогтоосон ч нүднээс далд өрнөдөг шашны эмх замбараагүй байдлыг харсныхаа дараа орхин явжээ. Энэ хүмүүс хэчнээн зальхай, башир, хуйвалдаач болохыг хараад тэр туйлын их зэвүүцсэн (түүнийг төгс болгохын тулд тухайн үед Ариун Сүнс ийнхүү ажилласан юм. Тэр ялангуяа түүний сэтгэлийг хөдөлгөж, түүнд зарим нэгэн онцгой ажил хийсэн), иймээс тэр 18 настайдаа синагогоос гарсан юм. Эцэг эх нь түүнийг хяхан хавчиж, итгүүлэхгүй байв (тэд диаволд

харьяалагддаг, үл итгэгчид байсан). Эцэст нь Петр гэрээ орхиод хаа сайгүй аялж, хоёр жилийн турш загасчилж, номлол айлдсан бөгөөд энэ хугацаанд тэр бас нэлээд хэдэн хүнийг удирдаж байлаа. Одоо чи Петрийн явсан яг тэр замыг тодорхой харж чадах ёстой. Хэрвээ чи Петрийн замыг тодорхой харж чаддаг бол өнөөдөр хийгдэж байгаа ажлын талаар тодорхой мэдэж байх тул гомдоллож, идэвхгүй болохгүй, эсвэл ямар нэгэн зүйлийг хүсэн эрмэлзэхгүй. Чи тухайн үеийн Петрийн сэтгэл санааны байдлыг мэдрэх ёстой: Тэр уй гашууд автсан; ямар нэг ирээдүйг, эсвэл ямар нэгэн ерөөлийг гуйхаа больсон. Тэр ашиг хонжоо, аз жаргал, алдар нэр, эсвэл дэлхий дээрх эд хөрөнгийг эрж хайгаагүй; зөвхөн хамгийн утга учиртай амьдралаар амьдрах гэж эрэлхийлсэн ба энэ нь Бурханы хайрыг хариулж, өөртөө байгаа хамгийн эрхэм нандин зүйлийг Бурханд зориулахын төлөө байлаа. Тэгвэл тэр сэтгэл хангалуун байх байв. Тэрээр: “Эзэн Есүс Христ ээ, би нэгэнтээ Таныг хайрласан боловч Таныг хэзээ ч үнэхээр хайрлаагүй. Хэдийгээр би Танд итгэдэг гэж хэлсэн боловч хэзээ ч Таныг үнэн сэтгэлээсээ хайрлаагүй. Би Таныг хүндэлж, Таныг гайхан биширч, Таныг санаснаас л биш, хэзээ ч Таныг хайрлаагүй, бас Танд жинхэнээсээ итгээгүй” хэмээх үгээр Есүст ихэвчлэн залбирдаг байв. Петр шийдвэрээ гаргахын тулд байнга залбирч, Есүсийн үгээр үргэлж зоригжиж, үүнээс сэдэл авдаг байжээ. Хожим нь, хэсэг хугацаанд туршлагажсаных нь дараа Есүс түүнийг шалгаж, Өөрийг нь улам илүү хүсэн эрмэлзэхэд хүргэсэн юм. Тэрээр: “Эзэн Есүс Христ минь! Би Таныг хэчнээн их санаж, Таныг харахыг хэчнээн хүсэж байна гээч. Би маш дутуу дулимаг бөгөөд Таны хайрыг нөхөж чадахгүй. Намайг хурдан авахыг би Танаас гуйж байна. Танд би хэзээ хэрэгтэй болох юм бэ? Та намайг хэзээ авах юм бэ? Би хэзээ Таны царайг дахин нэг удаа харах вэ? Би цаашид энэ биед амьдарч, үргэлжлүүлэн завхарсаар байхыг хүсэхгүй байна, дахиад тэрслэхийг ч хүсэхгүй байна. Би өөрт байгаа бүхнээ Танд аль болох хурдан зориулахад бэлэн байна, цаашид Таныг гуниглуулахыг хүсэхгүй байна” гэсэн юм. Тэр ийнхүү залбирсан боловч Есүс түүний юуг төгс болгохыг тухайн үед мэдээгүй байлаа. Туршилтад зовж шаналах үеэр Есүс түүнд дахин харагдаж: “Петр ээ, Би чамайг төгс болгохыг хүсэж байна, тэгснээр чи үр жимс буюу Би чамайг төгс болгосны биелэл болж, үүнийг Би таалах болно. Чи үнэхээр Намайг гэрчилж чадах уу? Миний хий гэж шаардсаныг чи хийсэн үү? Чи Миний хэлсэн үгийг амьдран харуулсан уу? Чи нэгэнтээ Намайг хайрласан боловч Намайг амьдран харуулсан уу? Чи Миний төлөө юу хийсэн бэ? Чи Миний хайрыг хүртэх үнэ цэнгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг мөртөө Миний төлөө юу хийсэн юм

бэ?” гэжээ. Петр Есүсийн төлөө юу ч хийгээгүйгээ ойлгосон бөгөөд Бурханы төлөө амиа өгөх урьдын тангаргаа санав. Иймээс тэр дахиж гомдоллоогүй бөгөөд дараа нь түүний залбирал хавьгүй илүү дээр болжээ. Тэр залбирч, “Эзэн Есүс Христ минь! Би нэгэнтээ Таныг орхиж, Та ч бас нэгэнтээ намайг орхисон. Бидэнд тусдаа байсан цаг хугацаа бий, мөн хамтдаа байсан цаг хугацаа бий. Гэсэн ч Та намайг өрөөл бусдаас илүү хайрладаг. Би Таны эсрэг ахин дахин тэрсэлж, Таныг удаа дараа гуниглуулсан. Би яаж ийм зүйлийг мартаж чадах билээ? Таны надад хийсэн ажил, надад даалгасан зүйлийг би хэзээ ч мартаггүй, үргэлж сэтгэлдээ тээж байгаа. Таны надад хийсэн ажлын төлөө би чадах бүхнээ хийсэн. Юу хийж чадахыг минь Та мэддэг, ямар үүрэг гүйцэтгэж чадахыг минь ч Та мэддэг. Би Таны зохион байгуулалтад захирагдахад бэлэн байна, би өөрт байгаа бүхнээ Танд зориулна. Таны төлөө юу хийж чадахыг минь зөвхөн Та л мэднэ. Хэдийгээр би Сатанд маш их хууртаж, Таны эсрэг тэрсэлсэн боловч тэдгээр гэм нүглээр минь Та намайг санадаггүй, тэдгээрт үндэслэн надад ханддаггүй гэдэгт би итгэдэг. Би бүхий л амьдралаа Танд зориулахыг хүсэж байна. Би юу ч гуйхгүй, мөн надад өөр ямар ч итгэл найдвар, төлөвлөгөө байхгүй; би зөвхөн Таны санаа зорилгын дагуу үйлдэж, Таны хүслийг биелүүлэхийг л хүсэж байна. Би Таны гашуун аяганаас ууж, Танд захирагдана” хэмээн хэлсэн юм.

Та нар алхаж байгаа замынхаа талаар тодорхой мэдэж байх ёстой; ирээдүйд явах замынхаа талаар, Бурхан юуг төгс болгох талаар болон та нарт юу даалгасан талаар тодорхой мэдэж байх ёстой. Магадгүй нэг л өдөр та нарыг шалгана, тэр цаг ирэхэд та нар Петрийн туршлагаас урам зориг авч чадвал үнэхээр Петрийн замаар алхаж байгааг чинь энэ нь харуулна. Бурхан Петрийг жинхэнэ итгэл, хайрынх нь төлөө, бас Өөрт нь үнэнч байсных нь төлөө сайшаасан юм. Үнэнч шударга зантай, зүрх сэтгэлдээ Бурханыг хүсэн эрмэлзэж байсных нь төлөө Бурхан түүнийг төгс болгосон билээ. Хэрвээ чамд үнэхээр Петрийнх шиг хайр, итгэл бий бол Есүс чамайг гарцаагүй төгс болгоно.

БУРХАНЫГ ХАЙРЛАДАГ ХҮМҮҮС ТҮҮНИЙ ГЭРЭЛД ҮҮРД АМЬДАРНА

Ихэнх хүмүүсийн Бурханд итгэх итгэлийн мөн чанар нь шашны итгэл үнэмшил байдаг: Тэд Бурханыг хайрлах чадваргүй, Бурханыг робот шиг л дагаж чаддаг, Бурханыг үнэхээр хүсэмжилж, эрхэмлэн хайрлаж чаддаггүй. Тэд ердөө

л Бурханыг чимээгүйхэн дагадаг. Олон хүн Бурханд итгэдэг ч Түүнийг хайрладаг хүн тун цөөн; тэд гай гамшгаас айдаг учраас л Бурханыг “хүндэлдэг”, эсвэл Бурхан өндөр дээд агаад хүчирхэг учраас л тэд Түүнийг “биширдэг”—гэхдээ тэдний хүндлэл, бишрэлд ямар ч хайр, жинхэнээсээ хүсэмжлэх сэтгэл байдаггүй. Тэд өөрсдийн туршлагаар үнэний өчүүхэн хэсэг, эсвэл чухал бус зарим нууцыг эрж хайдаг. Ихэнх хүмүүс зүгээр л дагаж, сиймхий тааруулж ерөөл хүртэх гэж оролддог; тэд үнэнийг эрж хайдаггүй, Бурханы ерөөлийг хүртэхийн тулд Бурханд үнэхээр дуулгавартай ч байдаггүй. Бүх хүний Бурханд итгэх итгэлийн амьдрал нь учир утгагүй, үнэ цэнгүй бөгөөд энэ амьдралд өөрсдийнх нь хувийн анхаардаг зүйл, эрэл хайгуул байдаг; тэд Бурханыг хайрлахын тулд биш, харин ерөөгдөхийн тулд Бурханд итгэдэг. Олон хүн хүссэнээрээ авирлаж, хүссэн бүхнээ хийж, Бурханы ашиг сонирхлыг болон өөрсдийнх нь хийж байгаа зүйл Бурханы хүсэлд нийцэж байгаа эсэхийг хэзээ ч анхаарч үздэггүй. Ийм хүмүүс Бурханыг хайрлах нь байтугай жинхэнэ итгэлд ч хүрч чаддаггүй. Бурханы мөн чанар бол зөвхөн хүнээр итгүүлэх биш; бас хүнээр хайрлуулах явдал юм. Гэвч Бурханд итгэдэг олон хүн энэ “нууцыг” олж мэдэх чадваргүй байдаг. Хүмүүс Бурханыг хайрлаж зүрхэлдэггүй, Түүнийг хайрлах гэж хичээдэг ч үгүй. Бурханд хайр татам зүйл маш олон байгааг тэд хэзээ ч олж мэдээгүй; Бурхан бол хүнийг хайрладаг Бурхан, Тэр бол хүнээр хайрлуулах ёстой Бурхан гэдгийг тэд хэзээ ч олж мэдээгүй. Бурханы хайр татам байдал Түүний ажлаас илэрдэг: Бурханы ажлыг туулсан үедээ л хүмүүс хайр татам байдлыг нь олж мэдэж, бодит туршлагаараа л Бурханы хайр татам байдлыг ойлгож чаддаг бөгөөд бодит амьдрал дээр ажиглахгүйгээр хэн ч Бурханы хайр татам байдлыг олж мэдэж чадахгүй. Бурханд хайр татам зүйл зөндөө бий боловч Түүнтэй бодитоор харилцахгүйгээр хүмүүс үүнийг олж мэдэж чадахгүй. Өөрөөр хэлбэл, хэрвээ Бурхан махбод болоогүй бол хүмүүс бодитоор Түүнтэй харилцаж чадахгүй байх байсан. Хэрэв тэд бодитоор Түүнтэй харилцах чадахгүй байсан бол Түүний ажлыг бас мэдэрч чадахгүй байх байсан—иймээс Бурханыг хайрлах тэдний хайр ихээхэн худал хуурмаг болон төсөөллөөр сэвтэх байлаа. Тэнгэр дэх Бурханыг хайрлах нь газар дээрх Бурханыг хайрлахтай адил бодитой биш юм, учир нь тэнгэр дэх Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг өөрсдийн нүдээр харж, биеэр туулсан зүйлээс илүүтэйгээр төсөөлөл дээр нь үндэслэн бий болсон байдаг. Бурхан газар дээр ирэх үед хүмүүс Түүний бодит үйл хэрэг, хайр татам байдлыг харж чаддагийн дээр тэд Түүний бодитой болоод хэвийн зан чанарыг бүгдийг нь харж чадна, энэ бүхэн нь тэнгэр дэх Бурханы талаарх

мэдлэгээс хэдэн мянга дахин илүү бодитой юм. Тэнгэр дэх Бурханыг хүмүүс хэр их хайрладгаас үл хамааран, энэ хайранд бодитой зүйл юу ч байхгүй, хүмүүний санаагаар дүүрэн байдаг. Газар дэлхий дээрх Бурханыг хайрлах тэдний хайр хэчнээн бага байх нь хамаагүй, энэ хайр бол жинхэнэ; өчүүхэн бага байлаа ч гэсэн, жинхэнэ юм. Бурхан бодитой ажлаар дамжуулан хүмүүст Өөрийгөө мэдүүлдэг бөгөөд уг мэдлэгээр дамжуулан тэдний хайрыг олж авдаг. Яг л Петр шиг: Хэрвээ тэр Есүстэй хамт амьдраагүй бол түүний хувьд Есүсийг эрхэмлэн хайрлах боломжгүй байх байсан. Есүсийг гэх үнэнч сэтгэл нь мөн л Есүстэй хамт байснаас үүссэн. Өөрийгөө хүнээр хайрлуулахын тулд Бурхан хүмүүсийн дунд ирж, хүнтэй хамт амьдардаг бөгөөд хүмүүст харуулж, мэдрүүлдэг бүхэн нь Бурханы бодит байдал юм.

Бурхан бодит байдал болон бий болсон баримтыг ашиглан хүмүүсийг төгс болгодог; Бурханы үг нь хүмүүсийг төгс болгох Түүний ажлын нэг хэсгийг биелүүлдэг бөгөөд энэ бол удирдамжийн ажил, зам нээх ажил юм. Өөрөөр хэлбэл, Бурханы үгээс чи хэрэгжүүлэлтийн зам, үзэгдлийн талаарх мэдлэгийг олох ёстой. Эдгээр зүйлийг ойлгосноор, хүн бодитоор хэрэгжүүлэх зам, үзэгдэлтэй болох болно, мөн Бурханы үгээр дамжуулан гэгээрлийг олж чадах бөгөөд эдгээр зүйл Бурханаас ирдэг гэдгийг ойлгож, ихээхэн ялган таних чадвартай болно. Ойлгосныхоо дараа хүн энэ бодит байдал руу даруйхан орж, бодит амьдралдаа Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд Бурханы үгийг ашиглах ёстой. Бурхан чамайг бүх зүйл дээр залж чиглүүлж, хэрэгжүүлэх замыг чамд өгч, Өөрийгөө маш хайр татам гэдгийг чамд мэдрүүлэн, мөн чамд хийдэг Өөрийнх нь ажлын алхам бүр чамайг төгс болгохын тулд байдаг гэдгийг чамд харуулна. Хэрвээ чи Бурханы хайрыг харахыг хүсвэл, хэрвээ чи Бурханы хайрыг үнэхээр мэдэrmээр байвал бодит байдал руу гүн орж, бодит амьдралд гүн орж Бурханы хийдэг бүхэн нь хайр, аврал юм гэдгийг, мөн хүмүүсийн бохир зүйлийг нь хаяулж, тэдэнд байдаг, Бурханы хүслийг хангаж чадахгүй зүйлсийг нь цэвэршүүлэхийн төлөө Бурхан бүхнийг хийдэг гэдгийг харах ёстой. Бурхан үг ашиглаж хүнийг хангадаг; хүмүүсээр туулуулах гэж бодит амьдралын нөхцөл байдлыг бий болгодог, хэрвээ хүмүүс Бурханы үгээс ихийг идэж, уувал тэдгээрийг бодитоор хэрэгжүүлэх үед, Бурханы олон үгийг ашиглан өөрсдийн амьдрал дахь бүх бэрхшээлийг шийдвэрлэж чадна. Өөрөөр хэлбэл, бодит байдалд гүн орохын тулд чамд Бурханы үг байх ёстой; хэрвээ чи Бурханы үгийг идэж уудаггүй, Бурханы ажил чамд байдаггүй бол бодит амьдрал дээр чамд зам байхгүй байх болно. Хэрвээ чи Бурханы үгийг хэзээ ч идэж уухгүй бол ямар

нэгэн зүйл тохиолдоход чи сандарч будилна. Чи Бурханыг хайрлах ёстой гэдгээ л мэддэг боловч ямар ч ялгах чадваргүй, хэрэгжүүлэх ямар ч замгүй байдаг; чи төөрөлдөж, будилдаг, махан биеийг сэтгэл хангалуун байлгаснаар Бурханыг сэтгэл хангалуун болгож байна гэж хүртэл заримдаа итгэдэг—энэ бүхэн нь Бурханы үгийг идэж уугаагүйн үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, хэрвээ чамд Бурханы үгийн тусламж үгүй бөгөөд бодит байдал дунд зөвхөн тэмтчин явж байгаа бол чи үндсэндээ хэрэгжүүлэх замыг олох чадваргүй юм. Иймэрхүү хүмүүс Бурханд итгэх гэдэг нь юу гэсэн үг болохыг зүгээр л ойлгодоггүй, тэр ч бүү хэл Бурханыг хайрлана гэдэг нь юу гэсэн үг болохыг ч ойлгодоггүй. Хэрвээ Бурханы үг чамайг гэгээрүүлж, удирдан чиглүүлж байгааг ашиглан, үргэлж залбирч, судалж, эрж хайж, үүгээрээ дамжуулан юуг хэрэгжүүлэх учиртайгаа мэдэж, Ариун Сүнс ажиллах боломжийг олж, Бурхантай үнэхээр хамтран ажиллаж, төөрч будилдаггүй бол бодит амьдрал дээр замтай болж, Бурханыг үнэхээр сэтгэл хангалуун байлгах болно. Бурханыг сэтгэл хангалуун болгох үед Бурхан чамайг дотроос чинь удирдан чиглүүлж, Бурхан чамайг онцгойлон ерөөхөд чамд баяр хөөр төрнө: Бурханыг сэтгэл хангалуун болгосондоо чи тун их баярлан бахдаж, дотор чинь үлэмж цэлмэсэн санагдаж зүрх, сэтгэлдээ хиргүй тунгалаг, амар амгалан болж, мөс чанар чинь тайвширч, буруушаалтаас ангид болж, ах, эгч нараа хараад чамд таатай санагдана. Бурханы хайрыг эдлэх гэдэг нь энэ бөгөөд зөвхөн энэ л Бурханыг үнэхээр таашааж байгаа хэрэг билээ. Хүмүүс туршлагаар дамжуулан Бурханы хайрыг эдэлдэг: Бэрхшээлийг туулж, үнэнийг хэрэгжүүлж туршлагажсанаар тэд Бурханы ерөөлийг олж авдаг. Бурхан чамд үнэхээр хайртай, Бурхан үнэхээр хүмүүсийн төлөө өндөр төлөөс төлж, Тэр тэвчээртэйгээр, сайхан сэтгэлээр маш олон үг хэлсэн бөгөөд үргэлж хүмүүсийг авардаг гэж л гагцхүү чи хэлэх юм бол эдгээр үгийг хэлж байгаа чинь Бурханыг таашаахын зөвхөн нэг тал нь юм. Гэхдээ илүү их бодитой таашаал нь хүмүүс бодит амьдралдаа үнэнийг хэрэгжүүлэх явдал бөгөөд үүний дараа тэдний зүрх сэтгэл нь амар амгалан, хиргүй тунгалаг болж, сэтгэл нь ихэд хөдөлж, Бурхан бол хамгийн хайр татам гэдгийг мэдэрдэг. Чиний төлсөн төлөөс туйлын хангалттай байсныг чи мэдэрнэ. Хичээл зүтгэлдээ асар их төлөөс төлснөөр дотор чинь үлэмж цэлмэх болно: Чи Бурханы хайрыг үнэхээр эдэлж байгаагаа мэдэрч, Бурхан хүмүүст авралын ажлаа хийчихсэнийг, хүмүүсийг цэвэршүүлдэг нь тэднийг ариусгахын төлөө байдаг гэдгийг, Өөрийг нь үнэхээр хайрладаг эсэхийг туршихын тулд Бурхан хүмүүсийг шалгадаг гэдгийг ойлгоно. Хэрвээ чи үргэлж ийм маягаар үнэнийг хэрэгжүүлбэл аажмаар Бурханы олон ажлын

талаар тодорхой мэдлэгтэй болох ба тэр үед чиний өмнө байгаа Бурханы үг болор мэт тунгалаг болохыг мэдэрнэ. Хэрвээ чи олон үнэнийг тодорхой ойлгож чадвал, бүх хэрэг явдлыг хэрэгжүүлэхэд амархан, аливаа асуудал, аливаа сорилтыг давж чадна гэдгээ мэдэрч, мөн чиний хувьд юу ч асуудал биш гэдгийг хараад чи маш эрх чөлөөтэй болно. Энэ мөчид чи Бурханы хайрыг эдэлж, Бурханы жинхэнэ хайр чам дээр ирсэн байх болно. Үзэгдэлтэй, үнэнтэй, мэдлэгтэй агаад Өөрийг нь үнэхээр хайрладаг хүмүүсийг Бурхан ерөөдөг. Хэрвээ хүмүүс Бурханы хайрыг харахыг хүсвэл үнэнийг бодит амьдралд хэрэгжүүлэх ёстой, тэд Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд зовлон шаналлыг туулж, хайрладаг зүйлсээ хаяхад бэлэн байх ёстой бөгөөд нүдэндээ нулимстай байсан ч Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадсаар байх ёстой. Ийм маягаар, Бурхан гарцаагүй чамайг ерөөнө, хэрвээ чи иймэрхүү бэрхшээлийг туулбал үүнийг Ариун Сүнсний ажил дагалдана. Бодит амьдралаар дамжуулан, Бурханы үгийг туулснаар хүмүүс Бурханы хайр татам байдлыг харж чаддагийн дээр Бурханы хайрыг амталсан л бол Бурханыг үнэхээр хайрлаж чадна.

Чи үнэнийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, төдий чинээ их үнэнтэй болно; чи үнэнийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, Бурханы хайрыг төдий чинээ их олж авна; чи үнэнийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, Бурханаар төдий чинээ их ерөөгдөнө. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлбэл яг л Петр Бурханыг мэдэж авсантай адилаар чамайг гэх Бурханы хайр чамд аажмаар харуулна: Бурханд тэнгэр, газар болон бүх зүйлийг бүтээх мэргэн ухаан байгаад зогсохгүй, бас хүмүүст бодит ажил хийх мэргэн ухаан бий гэж Петр хэлсэн. Петр хэлэхдээ, Тэр зөвхөн тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээснийхээ төлөө төдийгүй, цаашлаад хүмүүсийг бүтээх, аврах, төгс болгох, Өөрийн хайрыг хүмүүст өвлүүлэх чадварынхаа улмаас хүмүүсийн хайрыг хүртэх эрхтэй гэсэн. Мөн хүний хайрыг хүртэх эрхтэй маш их зүйл Түүнд байдаг хэмээн Петр хэлсэн. Петр Есүст хэлэхдээ: “Та тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээсэн болохоор л хүмүүсийн хайрыг хүртэх эрхтэй гэж үү? Танд илүү их хайр татам зүйл бий. Та бодит амьдрал дээр үйлдэж, хөдөлдөг, Таны Сүнс сэтгэлийг минь хөдөлгөж, Та намайг сахилгажуулж, зэмлэдэг—эдгээр зүйл чинь хүмүүсийн хайрыг бүр ч илүү хүртэх эрхтэй” гэсэн. Хэрвээ чи Бурханы хайрыг харж, мэдрэхийг хүсвэл, бодит амьдрал дээр эрж хайж, судлах ёстойн дээр махан биеэ хаяхад бэлэн байх хэрэгтэй. Чи ийм шийдвэр гаргах ёстой. Чи залхуурч, махан биеийн зугаа цэнгэлд шуналгүйгээр, махан биеийн төлөө бус харин Бурханы төлөө амьдарч

бүх зүйл дээр Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадах шийдэмгий хүн байх ёстой. Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадахгүй үе байж болно. Яагаад гэвэл чи Бурханы хүслийг ойлгодоггүй учраас тэр юм; дараагийн удаа, чамаас илүү их хүчин чармайлт шаардах байсан ч гэсэн чи махан биеийг бус Бурханыг сэтгэл хангалуун байлгах ёстой. Ийм маягаар туршлагажвал чи Бурханыг мэдэж авах болно. Бурхан тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээж чадсан, хүмүүс Түүнийг үнэхээр, бодитоор харж, Түүнтэй бодитоор харилцаж чадаасай гэсэндээ Тэр махбод болсон, Тэр хүмүүсийн дунд алхаж чаддаг, Түүний Сүнс бодит амьдрал дээр хүмүүсийг төгс болгож, Түүний хайр татам байдлыг харж, Түүний сахилгажуулалт, цээрлүүлэлт болон ерөөлийг мэдрэх боломж олгодгийг чи харна. Хэрвээ чи үргэлж ийм маягаар туршлагажвал бодит амьдрал дээр Бурханаас салшгүй байх ба хэзээ нэг өдөр Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байхаа боливол чи зэмлэл хүртэж, гэмшиж чаддаг болно. Бурхантай хэвийн харилцаатай байхдаа чи Бурханыг орхихыг хэзээ ч хүсэхгүй бөгөөд хэрвээ нэг өдөр л Бурхан чамайг орхино гэдгээ хэлбэл чи айж, Бурханд хаягдсанаас үхсэн нь дээр гэж чи хэлнэ. Чамд ийм сэтгэл хөдлөл төрмөгц Бурханыг орхиж чадахгүй гэдгээ чи мэдэрнэ, ийм маягаар чи үндэс суурьтай болж, Бурханы хайрыг жинхэнээр нь эдэлнэ.

Хүмүүс Бурханыг өөрсдийн амь болгох тухай байнга ярьдаг боловч хараахан тийм түвшинд хүртэл туршлагажаагүй байна. Бурхан миний амь, Тэр намайг өдөр бүр залж чиглүүлдэг, би Түүний үгийг өдөр бүр идэж уудаг, Түүнд өдөр бүр залбирдаг, иймээс Тэр миний амь болсон гэж чи зүгээр л хэлдэг. Ингэж хэлдэг хүмүүсийн мэдлэг тун өнгөц байдаг. Олон хүнд ямар ч суурь байдаггүй; Бурханы үгийг тэдэнд суулгасан байдаг боловч ямар нэгэн жимс гарах нь байтугай, соёолоогүй ч гүй байдаг. Өнөөдөр чи ямар хэмжээнд туршлагажсан бэ? Бурхан чамайг энэ хүртэл явтал чинь хүчилсний дараа, одоо л Бурханыг орхиж чадахгүй гэдгээ чи мэдэрдэг. Нэг л өдөр, чамайг тодорхой хэмжээнд туршлагажсан үед Бурхан чамайг явуулахаар боллоо гэхэд чи явж чадахгүй байх болно. Бурхангүйгээр байж чадахгүй гэдгээ чи дотроо үргэлж мэдрэх болно; чи эхнэр, нөхөр, хүүхэд, гэр бүл, эцэг, эхгүй, махан биеийн зугаа цэнгэлгүйгээр амьдарч чадах ч Бурхангүйгээр байж чадахгүй. Бурхангүй байх нь амиа алдаж байгаатай адил байх болно; чи Бурхангүйгээр амьдарч чадахгүй. Чи энэ түвшинд хүртэл туршлагажихад Бурханд итгэх итгэлдээ хүссэн үр дүнд хүрсэн байх болно, ийм маягаар Бурхан чиний амь болж, чиний оршин тогтнолын суурь болсон байх бөгөөд чи Бурханыг хэзээ ч дахин орхиж чадахгүй. Чи энэ түвшинд хүртэл

туршлагажихдаа Бурханы хайрыг үнэхээр эдэлсэн байх болно, Бурхантай хангалттай дотно харилцаатай болоход, Тэр чиний амь, чиний хайр болж, тэр үед чи Бурханд залбираад ингэж хэлнэ: “Ээ, Бурхан минь! Би Таныг орхиж чадахгүй, Та бол миний амь, би өөр бусад бүх зүйлгүйгээр явж чадна, гэвч Тангүйгээр амьдарч чадахгүй.” Энэ бол хүмүүсийн жинхэнэ биеийн хэмжээ; энэ бол бодит амь. Зарим хүн өнөөдрийг хүртэл албан хүчээр ирж байсан: Тэд хүссэн ч хүсээгүй ч үргэлжлүүлэх ёстой бөгөөд хадны завсар хавчуулагдсан мэт тэдэнд үргэлж санагддаг. Бурхан бол чиний амь, тийм болохоор хэрвээ зүрх сэтгэлээс чинь Бурханыг авчихвал амиа алдахтай адил тийм мэдрэмж чамд төрөх ёстой; Бурхан чиний амь байж, чи Түүнийг орхиж чадахааргүй байх ёстой. Ингэвээс чи Бурханыг үнэхээр бодитоор мэдэрсэн байх болно, тэр үед чи Бурханыг хайрлахдаа жинхэнээсээ хайрлах бөгөөд энэ нь цорын ганц, ариун хайр байна. Нэг л өдөр, амь чинь тодорхой түвшинд хүртэл туршлагажих үед, чи Бурханд залбирч, Бурханы үгийг идэж уух үед Бурханыг дотроо орхиж чадахаа больж, хүссэн ч гэсэн Түүнийг мартаж чадахгүй байх болно. Бурхан чиний амь болсон байна; чи хорвоо ертөнцийг, эхнэр, нөхөр, хүүхдүүдээ мартаж чадах боловч Бурханыг мартахад хэцүү байх болно—мартах боломжгүй, энэ бол чиний жинхэнэ амь бөгөөд Бурханыг гэх жинхэнэ хайр юм. Бурханыг хайрлах хүмүүсийн хайр тодорхой түвшинд хүрэх үед тэдний хайрладаг юу ч Бурханыг гэсэн хайртай нь тэнцэхгүй; Бурханыг гэх тэдний хайр нэн тэргүүнд байдаг. Ийм маягаар бусад бүх зүйлийг орхих чадвартай болж, Бурханы бүх харьцалт, засалтыг хүлээн авахад бэлэн байдаг. Бусад бүх зүйлээс илүү Бурханыг гэх хайрыг олсон үедээ чи бодит байдалд, Бурханы хайранд амьдрах болно.

Бурхан хүмүүсийн амь нь болмогц тэд Бурханыг орхиж чадахаа больдог. Бурханы үйл хэрэг энэ бус уу? Үүнээс илүү гэрчлэл гэж үгүй! Бурхан тодорхой түвшинд хүртэл ажилласан; Тэр хүмүүст үйлчлэл хий, гэсгээлт хүрт, эсвэл үх гэж хэлсэн бөгөөд хүмүүс үүнээс ухраагүй нь Бурханаар байлдан дагуулагдсан гэдгийг харуулдаг. Үнэнтэй хүмүүс бол бодит туршлагаараа гэрчлэлдээ бат зогсож, байр сууриа чанд хадгалж, Бурханы талд хэзээ ч ухрахгүйгээр зогсож, Бурханыг хайрладаг хүмүүстэй хэвийн харилцаатай байж чаддаг, ямар нэг зүйл тохиолдоход Бурханыг бүрэн дуулгавартай дагаж, үхэн үхтлээ Бурханыг дуулгавартай дагаж чаддаг хүмүүс юм. Чиний бодит амьдрал дахь хэрэгжүүлэлт болон илчлэл бол Бурханы гэрчлэл, хүний амьдран харуулдаг Бурханы гэрчлэл, мөн энэ нь Бурханы хайрыг үнэхээр эдлэх билээ; чи энэ түвшинд хүртэл туршлагажсан үедээ үр дүнд хүрэх болно. Чи бодитоор амьдран харуулдаг

бөгөөд чиний үйлдэл бүрийг бусад хүн гайхан биширдэг. Чиний хувцаслалт, гадаад дүр төрх бусдаас ялгарах юмгүй ч чи хамгийн их сүсэг бишрэлтэй амьдралыг амьдран харуулдгийн дээр Бурханы үгийг дамжуулахад Тэр чамайг залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Чи өөрийн үгээр Бурханы хүслийг ярьж, бодит байдлыг дамжуулж чадах ба сүнсээр үйлчлэх тухай их зүйлийг ойлгодог. Чи ний нуугүй ярьдаг, төлөв төвшин, шулуун шударга, зөрж сөргөлддөггүй, соёлтой боловсон, ямар нэг зүйл тохиолдоход Бурханы зохицуулалтыг дуулгавартай дагаж, гэрчлэлдээ бат зогсож чаддаг, юутай ч харьцаж байсан биеэ барьж, тайван байдаг. Ийм хүн Бурханы хайрыг үнэхээр харсан байдаг. Зарим хүн залуухан хэр нь ахимаг насны хүмүүс шиг үйлддэг; тэд төлөвшсөн, үнэнийг олж авсан, бусдын хүндлэлийг хүлээсэн байдаг, тэд бол гэрчлэлтэй хүмүүс бөгөөд Бурханы илрэл билээ. Өөрөөр хэлбэл, тэд тодорхой түвшинд хүртэл туршлагажсан үед Бурханы талаар мэдлэг ухаантай болж, гадаад зан чанар нь ч мөн тогтуун болно. Олон хүн үнэнийг хэрэгжүүлж, гэрчлэлдээ бат зогсдоггүй. Ийм хүмүүст Бурханыг гэх хайр, Түүнд хийх гэрчлэл байдаггүй бөгөөд тэд бол Бурханы хамгийн их жигшдэг хүмүүс билээ. Тэд цуглаан дээр Бурханы үгийг уншдаг боловч амьдран харуулдаг зүйл нь Сатан агаад энэ нь Бурханыг шившиглэж, гутааж, доромжилж байгаа хэрэг юм. Ийм хүмүүст Бурханы хайрын өчүүхэн ч шинж тэмдэг байдаггүй, Ариун Сүнсний ажил огт байдаггүй. Иймээс тэдний үг, үйлдэл Сатаныг төлөөлдөг. Хэрвээ зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван амгалан байж, эргэн тойрныхоо хүмүүс, эд зүйлд болон эргэн тойронд чинь юу болж байгаад үргэлж анхаарал тавьдаг бол, мөн чи Бурханы ачаанд санаа тавьж, үргэлж Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлтэй байдаг бол Бурхан чамайг дандаа дотроос чинь гэгээрүүлнэ. Чуулганд “хянагч” хүмүүс байдаг ба тэд эхлээд бусдын алдаа дутагдлыг ажиглаж, дараа нь хуулбарлаж, дуурайдаг. Тэд ялган салгах чадваргүй, нүглийг үзэн яддаггүй, Сатаны аливаа зүйлийг жигшин зэвүүцдэггүй. Тийм хүмүүс Сатаны зүйлсээр дүүрсэн байдаг бөгөөд эцэстээ Бурханд бүрэн хаягдах болно. Зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж хүндэтгэлтэй байж, үг, үйлдэл чинь боломжийн байх ёстой бөгөөд Бурханыг эсэргүүцэж, гонсойлгохыг хэзээ ч хүсэж болохгүй. Чамд хийсэн Бурханы ажил хий дэмий болохыг чи хэзээ ч хүсэх ёсгүй, чиний туулсан бүх бэрхшээл зовлон, чиний хэрэгжүүлсэн бүхэн талаар өнгөрөхийг зөвшөөрөх ёсгүй. Чи цаашдын замдаа илүү шаргуу ажиллаж, Бурханыг илүү их хайрлахад бэлэн байх ёстой. Үзэгдлийг сууриа болгосон хүмүүс ийм байдаг. Өсөж дэвшихийг эрж хайдаг хүмүүс ийм байдаг.

Хэрвээ хүмүүс Бурханыг хүндлэх сэтгэлээр Бурханд итгэж, Түүний үгийг туулдаг бол тийм хүмүүсээс Бурханы аврал болон Бурханы хайрыг харж болно. Энэ хүмүүс Бурханыг гэрчилж чаддаг; тэд үнэнийг амьдран харуулдаг бөгөөд тэд бас үнэнийг, Бурхан юу болохыг, Бурханы зан чанарыг гэрчилдэг. Тэд Бурханы хайран дунд амьдардаг, Бурханы хайрыг харсан байдаг. Хэрвээ хүмүүс Бурханыг хайрлахыг хүсвэл Бурханы хайр татам байдлыг амсаж, харах ёстой; ингэсэн цагт л Бурханыг хайрлах сэтгэл, Бурханы төлөө өөрийгөө үнэнчээр өгөхийг зоригжуулах зүрх сэтгэл тэдэнд төрөх болно. Бурхан үг хэллэг, эсвэл төсөөллөөр нь дамжуулан хүмүүсээр Өөрийгөө хайрлуулдаггүй, Өөрийгөө хайрлуулахаар хүмүүсийг албаддаггүй. Харин Тэр өөрсдийнх нь хүслээр тэднээр Өөрийгөө хайрлуулж, Өөрийн ажил, айлдвараараа хайр татам байдлаа харуулснаар Бурханыг хайрлах хайр тэдэнд бий болдог. Зөвхөн ийм маягаар л хүмүүс Бурханд үнэхээр гэрчлэл хийж чадна. Хүмүүс бусдаар шаардуулж, бас түр зуурын сэтгэлийн хөөрлөөс болж Бурханыг хайрладаг юм биш. Тэд Бурханы хайр татам байдлыг, хүмүүсийн хайрлууштай маш их зүйл Түүнд байдгийг харсан учраас, мөн Түүний аврал, мэргэн ухаан, гайхалтай үйл хэргийг харсан учраас Бурханыг хайрладаг—тийм учраас тэд Бурханыг үнэхээр магтаж, хүсэмжилж, Бурханыг олж авахгүйгээр амьдарч чадахгүй юм шиг тийм оргилсон сэтгэл тэдэнд төрдөг. Бурханыг үнэхээр гэрчилдэг хүмүүс яагаад Түүнд цангинасан гэрчлэл хийх чадвартай байдгийн шалтгаан нь тэдний гэрчлэл Бурханыг гэх жинхэнэ мэдлэг болон жинхэнэ хүсэл тэмүүлэлд суурилдагт оршино. Ийм гэрчлэлийг сэтгэл хөдлөлөөр биш, харин Бурхан болон Түүний зан чанарын талаарх мэдлэгийн дагуу хийдэг. Тэд Бурханыг мэдэж авсан учраас Бурханыг гарцаагүй гэрчилж, Бурханыг хүсэмжилдэг бүх хүнд Бурханыг мэдүүлж, Бурханы хайр татам байдал, бодитой байдлын талаар мэддэг байх ёстой гэдгээ мэдэрдэг. Яг л хүмүүсийн Бурханыг хайрлах хайр шиг, тэдний гэрчлэл хар аяндаа бий болдог бөгөөд бодитой, бодит ач холбогдолтой, үнэ цэнтэй байдаг. Энэ нь идэвхгүй, хий хоосон, утгагүй зүйл биш юм. Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүсийн амьдрал хамгийн үнэ цэнтэй, утга учиртай байдаг, зөвхөн тэд л Бурханд үнэхээр итгэдгийн шалтгаан нь энэ хүмүүс Бурханы гэрэлд амьдарч, Бурханы ажил болон удирдлагын төлөө амьдарч чаддагаас болдог. Учир нь тэд харанхуйд биш, харин гэрэлд амьдардаг; тэд утга учиргүй амьдралаар биш, харин Бурханы ерөөсөн амьдралаар амьдардаг. Бурханыг хайрладаг хүмүүс л Бурханыг гэрчлэх чадвартай, зөвхөн тэд л Бурханыг гэрчлэгчид, тэднийг л Бурхан ерөөдөг, зөвхөн тэд л Бурханы амлалтыг хүлээн

авах чадвартай юм. Бурханыг хайрладаг хүмүүс нь Бурханы дотнын хүмүүс; тэд бол Бурханы хайрладаг хүмүүс бөгөөд Бурхантай хамт ерөөл эдэлж чадна. Зөвхөн ийм хүмүүс л мөнх амьдарч, зөвхөн тэд л Бурханы хайр халамж, хамгаалалт дор үүрд амьдрах болно. Бурхан хүмүүсээр хайрлуулахын тулд байдаг, Тэрээр бүх хүний хайрыг хүртэх эрхтэй боловч бүх хүн Бурханыг хайрлаж чаддаггүй, мөн бүх хүн Бурханыг гэрчилж, Бурхантай хамт эрх барьж чадахгүй. Тэд Бурханыг гэрчилж, Бурханы ажилд бүхий л хүчин чармайлтаа зориулж чаддаг учраас Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс өөрсдийг нь эсэргүүцэж зүрхлэх хүнгүйгээр тэнгэрийн дор хаа сайгүй алхан явж, газар дээр эрх мэдэл эзэмшиж, Бурханы бүх ард түмнийг захирч чадна. Энэ хүмүүс дэлхийн өнцөг булан бүрээс нэгдэн нийлсэн бөгөөд өөр өөр хэлээр ярьдаг, арьсны өнгө нь өөр боловч оршихуй нь нэгэн адил утга учиртай; тэд бүгд Бурханыг хайрладаг зүрх сэтгэлтэй, бүгд адилхан гэрчлэл хийдэг, адилхан шийдвэртэй, адилхан хүсэлтэй байдаг. Бурханыг хайрладаг хүмүүс дэлхий даяар чөлөөтэй алхаж, Бурханыг гэрчилдэг хүмүүс орчлон ертөнц даяар аялж чадна. Энэ хүмүүс бол Бурханы хайртай хүмүүс, Бурхан тэднийг ерөөсөн бөгөөд тэд үүрд Түүний гэрэлд амьдрах болно.

АРИУН СҮНСНИЙ АЖИЛ БА САТАНЫ АЖИЛ

Хүн сүнсний нарийн ширийнийг хэрхэн ойлгож авдаг вэ? Ариун Сүнс хүн дотор хэрхэн ажилладаг вэ? Сатан хүн дотор яаж ажилладаг вэ? Муу ёрын сүнснүүд хүн дотор хэрхэн ажилладаг вэ? Илрэлүүд нь юу вэ? Чамд ямар нэгэн зүйл тохиолдох үед энэ нь Ариун Сүнснээс ирдэг үү, чи үүнийг дуулгавартай дагах ёстой юу, эсвэл голох ёстой юу? Хүмүүсийн бодит хэрэгжүүлэлтэд хүний хүслээс ихээхэн зүйл гардаг ч хүмүүс үүнийг Ариун Сүнснээс ирдэг гэж тууштай итгэдэг. Зарим зүйл муу ёрын сүнснээс ирдэг атал хүмүүс тэдгээрийг Ариун Сүнснээс ирсэн гэж бодсоор байдаг бөгөөд заримдаа Ариун Сүнс хүмүүсийг дотроос нь залж чиглүүлдэг ч хүмүүс, ийм удирдамж Сатанаас ирдэг хэмээн айж, дуулгавартай дагаж зүрхэлдэггүй, гэтэл бодит байдал дээр тэр удирдамж нь Ариун Сүнсний гэгээрэл байдаг. Тиймээс хүн ялган салгахгүй л бол бодит туршлагаараа туулах ямар ч аргагүй юм; ялгаж салгахгүйгээр амь олж авах аргагүй. Ариун Сүнс яаж ажилладаг вэ? Муу ёрын сүнс яаж ажилладаг вэ? Хүний хүслээс юу гардаг вэ? Мөн Ариун Сүнсний удирдамж болон гэгээрлээс юу төрөн гардаг вэ? Хэрвээ чи хүний доторх Ариун Сүнсний ажлын хэв маягийг

ухаарвал өдөр тутмын амьдралдаа болон бодит туршлагынхаа явцад мэдлэгээ өсгөж, ялган салгаж чадна; та нар Бурханыг мэдэж авч, Сатаныг ойлгож, ялган таньж чадна; мөн өөрсдийн дуулгавартай байдал юм уу эрэл хайгуулдаа будилж төөрөлдөхгүй бөгөөд бодол санаа нь саруул тунгалаг, Ариун Сүнсний ажлыг дуулгавартай дагадаг нэгэн байх болно.

Ариун Сүнсний ажил бол идэвх санаачилгатай удирдамж болон эерэг гэгээрлийн нэг хэлбэр юм. Энэ нь хүмүүст идэвхгүй байхыг зөвшөөрдөггүй. Энэ нь тэдэнд тайтгарал авчирч, итгэл болон шийдэмгий байдлыг өгдөг ба Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлэх боломж олгодог. Ариун Сүнс ажиллах үед хүмүүс идэвхтэйгээр орж чаддаг; тэд идэвхгүй, албадуулсан байдаггүй, харин идэвх санаачилгаараа үйлддэг. Ариун Сүнс ажиллах үед хүмүүс баяртай агаад бэлэн байдаг бөгөөд дуулгавартай байхыг хүсэж, өөрсдийгөө даруу болгохдоо баяртай байдаг. Тэд дотроо шаналалтай, сул дорой байдаг хэрнээ хамтран ажиллах шийдвэртэй байдаг; тэд дуртайяа зовж, дуулгавартай байж чаддаг, мөн хүний хүсэл, хүний бодлоор сэвтээгүй, хүний шунал болон сэдлээр лавтайяа сэвтээгүй байдаг. Ариун Сүнсний ажлыг туулах үедээ тэд дотроо тун ариун байдаг. Ариун Сүнсний ажилтай хүмүүс Бурханыг гэх хайрыг болон ах эгч нарыг гэх хайрыг амьдран харуулдаг; тэд Бурханы баярладаг зүйлд баярлаж, Бурханы үзэн яддаг зүйлийг үзэн яддаг. Ариун Сүнсний ажлаар хөдөлгөгддөг хүмүүс хэвийн хүн чанартай байдаг бөгөөд үнэнийг байнга эрэлхийлдэг, мөн хүн чанарыг эзэмшдэг. Ариун Сүнс дотор нь ажиллах үед хүмүүсийн байр байдал улам бүр сайжирч, хүн чанар нь улам бүр хэвийн болдог бөгөөд зарим хамтын ажиллагаа нь мунхаг байж болох ч сэдэл нь зөв, оролт нь эерэг байдаг, тэд саад хийх гэж оролддоггүй, мөн тэдний дотор ямар ч хорон санаа байдаггүй. Ариун Сүнсний ажил хэвийн агаад бодитой, Ариун Сүнс хүний хэвийн амьдралын дүрмийн дагуу хүн дээр ажиллаж, хэвийн хүмүүсийн бодит эрэл хайгуулын дагуу хүмүүсийг гэгээрүүлж, залж чиглүүлдэг. Ариун Сүнс хүмүүс дээр ажиллах үедээ хэвийн хүмүүсийн хэрэгцээний дагуу залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Тэрээр хэрэгцээнийх нь дагуу тэднийг хангаж, дутагддаг зүйл болон дутагдлынх нь дагуу эергээр залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Ариун Сүнсний ажил хүмүүсийг бодит амьдрал дээр гэгээрүүлж, залж чиглүүлэхийн төлөө байдаг; тэд бодит амьдрал дээр Бурханы үгийг туулж байж л Ариун Сүнсний ажлыг харж чаддаг. Хүмүүс өдөр тутмын амьдралдаа эерэг байр байдалтай, хэвийн сүнслэг амьдралтай байвал Ариун Сүнсний ажилтай байдаг. Ийм байдалд тэд Бурханы үгийг идэж, уух үедээ итгэлтэй байдаг; залбирах үедээ урам зоригтой байдаг;

ямарваа зүйл тохиолдоход идэвхгүй бус байдаг; ийм зүйл тохиолдож байхад тэд Бурханы сур хэмээн шаарддаг сургамжийг тэдгээр зүйлийн дотроос харж чаддаг. Тэд идэвхгүй, сул дорой биш байдаг бөгөөд бодит бэрхшээлтэй тулгарсан хэдий ч Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагахад бэлэн байдаг.

Ариун Сүнсний ажил ямар үр дүнд хүрдэг вэ? Чи мунхаг, ялган таних чадваргүй байж болох боловч Ариун Сүнс ажиллаж л байгаа цагт чи итгэлтэй болж, Бурханыг хангалттай хайрлаж чадахгүй байгаагаа үргэлж мэдэрнэ. Урдах бэрхшээл чинь хэчнээн их байлаа ч, чи хамтран ажиллахад бэлэн байна. Чамд ямар нэгэн юм тохиолдож, тэр нь Бурханаас ирсэн үү, эсвэл Сатанаас ирсэн үү гэдэг нь тодорхойгүй байх боловч чи хүлээж чадна, мөн идэвхгүй ч биш, хайнга ч биш байх болно. Энэ бол Ариун Сүнсний хэвийн ажил юм. Ариун Сүнс дотор чинь ажиллах үед чамд бодит бэрхшээл тулгарсаар байдаг: Заримдаа чи уйлж, заримдаа чиний даван гарч чадахгүй зүйлс байдаг боловч энэ нь бүхэлдээ Ариун Сүнсний ердийн ажлын л үе шат юм. Хэдийгээр чи тэдгээр бэрхшээлийг даван гараагүй ч, хэдийгээр тухайн үед сул дорой, гомдлоор дүүрэн байсан ч дараа нь туйлын итгэлээр Бурханыг хайрлаж бас л чадсан. Чиний идэвхгүй байдал хэвийн туршлагатай байхад чинь саад хийж чадахгүй бөгөөд бусад хүн юу ч хэлж байсан, бусад нь чам руу яаж ч дайрч довтолж байсан, Бурханыг хайрлаж мөн л чаддаг. Залбирлын үеэр чи, урьд нь Бурханд маш их өртэй байдаг байсан гэдгээ үргэлж мэдэрдэг бөгөөд тийм зүйлстэй дахин тулгарах болгондоо Бурханыг хангалуун байлгаж, махан биеэс татгалзахаар шийддэг. Энэхүү хүч чадал нь дотор чинь Ариун Сүнсний ажил байгааг харуулдаг. Энэ нь Ариун Сүнсний ажлын хэвийн байр байдал юм.

Сатанаас гардаг ажил гэж юу вэ? Сатанаас гардаг ажилд хүмүүсийн доторх үзэгдэл тодорхойгүй байдаг; хүмүүс хэвийн хүн чанаргүй, үйлдлийнх нь цаад сэдэл буруу байдаг бөгөөд хэдийгээр Бурханыг хайрлахыг хүсдэг ч дотор нь үргэлж буруутгал байдаг, эдгээр буруутгал болон бодол тэдний дотор байнга саад болж, амийнх нь өсөлтийг хязгаарлаж, Бурханы өмнө хэвийн нөхцөл байдалтай байхад нь саад хийдэг. Өөрөөр хэлбэл, Сатаны ажил хүмүүсийн дотор ормогц зүрх сэтгэл нь Бурханы өмнө тайван байж чаддаггүй. Тийм хүмүүс өөрсдийгөө яахаа мэддэггүй—хүмүүс цугларч байгааг харах үедээ зугтахыг хүсэж, бусдыг залбирч байхад нүдээ аньж чаддаггүй. Муу ёрын сүнсний ажил нь Бурхан, хүн хоёрын хоорондох хэвийн харилцааг сүйтгэж, хүмүүсийн урьдын үзэгдэл болон амийн оролтын замыг самууруулдаг; зүрх сэтгэлдээ тэд хэзээ ч

Бурханд ойртож чаддаггүй ба тэднийг үймүүлж, дөнгөлөх зүйлс үргэлж тохиолддог. Тэдний зүрх сэтгэл амар тайван байж чаддаггүй бөгөөд тэдэнд Бурханыг хайрлах ямар ч хүч чадал үлдэлгүй, сүнсээрээ унасан байдаг. Энэ нь Сатаны ажлын илрэл юм. Сатаны ажлын илрэл нь: үзэл бодолдоо бат зогсож, гэрчлэлд зогсож чадахгүй байх, чамайг Бурханы өмнө буруутай, Бурханд үнэнч бус нэгэн болгох зэрэг юм. Сатан хөндлөнгөөс оролцох үед чи өөрийн доторх Бурханыг гэх хайр болон үнэнч байдлаа алдаж, Бурхантай харилцах хэвийн харилцаагаа үгүй хийдэг бөгөөд үнэнийг юм уу өөрийгөө сайжруулахаар эрэлхийлдэггүй; харин доройтож, идэвхгүй болж, өөрийгөө өөгшүүлж, нүглийн тархалтыг зоргоор нь тавьдаг ба нүглийг үзэн яддаггүй; түүнчлэн Сатаны хөндлөнгийн оролцоо нь чамайг замбараагүй болгодог; чиний дотор Бурхан сэтгэлийг чинь хөдөлгөдөг байдлыг алга болгон, Бурханы талаар гомдоллож, Бурханыг эсэргүүцэж, сэжиглэхэд чамайг хүргэдэг; тэр ч бүү хэл, чи Бурханыг орхих эрсдэлд ордог. Энэ бүхэн Сатанаас гардаг.

Өдөр тутмын амьдралд чинь ямар нэгэн зүйл тохиолдох үед Ариун Сүнсний ажлаас гарсан уу, эсвэл Сатаны ажлаас гарсан уу гэдгийг нь чи хэрхэн ялган салгах ёстой вэ? Хүмүүсийн нөхцөл байдал хэвийн байх үед сүнслэг амьдрал болон махан бие дэх амьдрал нь хэвийн байдаг, эрүүл ухаан нь хэвийн, эмх цэгцтэй байдаг. Ийм нөхцөл байдалд байх үед тэдний дотроо туулж, мэдэж авдаг зүйлийг ерөнхийд нь Ариун Сүнсээр хөдөлгөгдсөнөөс гардаг (Бурханы үгийг идэж, уух үедээ мэдлэг ухаантай байх юм уу зарим нэг энгийн мэдлэг эзэмшиж, эсвэл зарим зүйл дээр үнэнч байж, эсвэл зарим зүйл дээр Бурханыг хайрлах чадалтай байх—энэ бүхэн Ариун Сүнснээс гардаг) гэж хэлж болно. Хүн дэх Ариун Сүнсний ажил тун хэвийн байдаг; хүн үүнийг мэдрэх чадваргүй бөгөөд энэ нь хүнээр өөрөөр нь дамжиж байгаа мэт санагддаг, гэхдээ үнэндээ энэ нь Ариун Сүнсний ажил юм. Өдөр тутмын амьдралд, Ариун Сүнс хүн бүрд их, бага ажлын аль алийг хийдэг бөгөөд гагцхүү энэ ажлын хэмжээ л ялгаатай байдаг. Зарим хүн сайн хэв чанартай байдаг бөгөөд аливааг хурдан ойлгодог, тэдний доторх Ариун Сүнсний гэгээрэл ялангуяа их байдаг. Харин зарим хүн хэв чанар муутай, аливааг ойлгохдоо удаан байдаг боловч Ариун Сүнс тэднийг дотроос нь хөдөлгөдөг бөгөөд тэд ч бас Бурханд үнэнч байж чадна—Ариун Сүнс Бурханыг эрэлхийлдэг бүх хүнд ажилладаг. Өдөр тутмын амьдралдаа хүмүүс Бурханыг эсэргүүцдэггүй, эсвэл Бурханы эсрэг тэрсэлдэггүй, Бурханы удирдлагад харшлах зүйлсийг хийдэггүй, Бурханы ажилд саад болдоггүй байх үед хүн нэг бүрд Бурханы Сүнс их, бага хэмжээгээр ажилладаг; Тэрээр тэднийг

хөдөлгөж, гэгээрүүлж, тэдэнд итгэл, хүч чадал өгч, идэвх санаачилгатайгаар ороход хүргэж, мөн залхуурахгүй, махан биеийн зугаа цэнгэлд шунахгүй, үнэнийг хэрэгжүүлэхэд бэлэн байж, Бурханы үгийг хүсэн эрмэлзэхэд хүргэдэг. Энэ бүхэн нь Ариун Сүнснээс ирдэг ажил билээ.

Хүмүүсийн байр байдал хэвийн бус байх үед тэднийг Ариун Сүнс хаядаг; тэд оюун санаандаа гомдомтгой, буруу сэдэлтэй байдаг, мөн залхуурч, махан биеэ өөгшүүлж, зүрх сэтгэл нь үнэний эсрэг тэрсэлдэг. Энэ бүхэн Сатанаас гардаг. Хүмүүсийн нөхцөл байдал хэвийн бус байх үед, мөн тэдний дотор харанхуй байж, хэвийн эрүүл ухаанаа алдаж, Ариун Сүнсэнд хаягдаж, өөрсдийнхөө дотор Бурханыг мэдэрч чадахгүй байх үед дотор нь Сатан ажиллаж байгаа юм. Хэрвээ хүмүүс дотроо үргэлж хүч чадалтай байж, Бурханыг үргэлж хайрладаг бол ерөнхийдөө аливаа зүйлс тэдэнд тохиолдох үед тэдгээр нь Ариун Сүнснээс ирдэг ба тэд хэнтэй ч уулзсан бай, тэр уулзалт нь Бурханы зохицуулалтын үр дүн байдаг. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдал чинь хэвийн байх үед, мөн чамайг Ариун Сүнсний агуу ажил дотор байх үед Сатан чамайг ганхуулах боломжгүй. Энэхүү суурин дээр юм бүхэн Ариун Сүнснээс ирдэг гэж хэлж болох бөгөөд хэдий чамд буруу бодол байж болох ч тэдгээрээс татгалзаж, дагахгүй байж чадна. Энэ бүхэн Ариун Сүнсний ажлаас гардаг. Сатан ямар нөхцөл байдалд хөндлөнгөөс оролцдог вэ? Нөхцөл байдал чинь хэвийн бус байх үед, Бурханаар хөдөлгөгдөөгүй, Бурханы ажилгүй, дотроо уйтгартай, хоосон байх үед, Бурханд залбирсан ч юу ч ухаарахгүй, Бурханы үгийг идэж, уухдаа ч гэгээрүүлэгдэж, гэрэлтүүлэгдэхгүй байх үед та нарын дотор Сатан ажиллахад амархан байдаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнсэнд хаягдаж, Бурханыг мэдэрч чадахгүй байх үед чинь Сатаны уруу таталтаас гардаг олон зүйл та нарт тохиолддог. Ариун Сүнсийг ажиллаж байхад Сатан ч бас нэгэн зэрэг ажилладаг байгаа. Ариун Сүнс хүний сэтгэл доторхыг хөдөлгөхийн сацуу Сатан хүнд саад болдог. Гэхдээ Ариун Сүнсний ажил тэргүүлэх байр суурийг эзэлдэг бөгөөд нөхцөл байдал нь хэвийн хүмүүс ялалт байгуулж чаддаг, энэ нь Ариун Сүнсний ажил Сатаны ажлыг ялан дийлж байгаа хэрэг юм. Харин Ариун Сүнсийг ажиллах үед хүмүүсийн дотор завхарсан зан чанар байсаар байдаг; гэхдээ Ариун Сүнсний ажлын үеэр хүмүүсийн хувьд өөрсдийнхөө тэрслүү байдал, сэдэл, хольцыг олж мэдэж, танихад амархан байдаг. Тэр үед л хүмүүс харуусаж, гэмших хүсэлтэй болдог. Ийм болохоор тэдний тэрслүү, завхарсан зан чанар Бурханы ажил дотор аажмаар хаягддаг. Ариун Сүнсний ажил нэн хэвийн байдаг; Түүнийг хүмүүс дээр ажиллахад хүмүүст мөн л бэрхшээл тохиолдоно, тэд мөн л уйлж,

зовж, сул дорой байдаг бөгөөд тэдний хувьд тодорхойгүй зүйл их байсаар байдаг, гэхдээ ийм байдалд тэд уруудан доройтохоо больж, Бурханыг хайрлаж чаддаг, мөн хэдий тэд уйлж, дотроо шаналж байсан ч Бурханыг магтах чадвартай хэвээр байдаг; Ариун Сүнсний ажил тун хэвийн бөгөөд өчүүхэн төдий ч ер бусын биш. Ариун Сүнсийг ажиллаж эхэлмэгц хүмүүсийн байр байдалд өөрчлөлт гарч, тэдний хувьд үндсэн зүйлс арилдаг гэж ихэнх хүмүүс итгэдэг. Тийм итгэл нь эндүү ташаа юм. Ариун Сүнс хүний дотор ажиллах үед хүний идэвхгүй зүйлс байсаар байдаг бөгөөд биеийн хэмжээ нь өөрчлөгдөлгүй хэвээр үлддэг ч тэрээр Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг олж авдаг тул түүний байр байдал илүү идэвх санаачилгатай, доторх нөхцөл байдал нь хэвийн байдаг ба тэрээр хурдан өөрчлөгддөг. Бодит туршлагаараа хүмүүс үндсэндээ Ариун Сүнсний юм уу Сатаны ажлыг туулдаг бөгөөд хэрвээ тэд эдгээр байр байдлыг ухаарч, ялган салгаж чадахгүй бол бодит туршлагад орох огт боломжгүй, зан чанарын өөрчлөлтийн тухайд бол ярихын ч хэрэггүй. Тиймээс Бурханы ажлыг туулахын гол түлхүүр нь ийм зүйлсийг нэвт шувт харж чаддаг байх явдал юм; ийм маягаар, тэдний хувьд үүнийг туулахад илүү амархан байх болно.

Ариун Сүнсний ажил нь эерэг үйл явц байдаг байхад Сатаны ажил нь ухралт, сөрөг байдал, тэрслүү байдал, Бурханыг эсэргүүцэх, Бурханд итгэл алдах, мөн магтан дуу дуулах ч дургүй байх, үүргээ биелүүлэхэд дэндүү сул дорой байх явдал юм. Ариун Сүнсний гэгээрлээс үүдэн гардаг бүхэн нь нэлээд ердийн байдаг; энэ нь чамайг хүчилдэггүй. Хэрвээ чи үүнийг дагавал амар тайван байна; хэрвээ дагахгүй бол дараа нь зэмлүүлнэ. Ариун Сүнсний гэгээрэлтэйгээр чиний хийдэг юу ч хязгаарлагдаж, саатуулагдахгүй, чи чөлөөтэй байх ба чиний үйлдлүүдэд хэрэгжүүлэх зам байх болно, чи ямар нэгэн хязгаарлалтад автахгүй, харин Бурханы хүсэлд үндэслэн үйлдэж чадна. Сатаны ажил олон зүйл дээр чамд саад учруулдаг; энэ нь чамайг залбирах хүсэлгүй, Бурханы үгийг идэж, уухад хэтэрхий залхуу, чуулганы амьдралаар амьдрах дургүй болгодог бөгөөд чамайг сүнслэг амьдралаас хөндийрүүлдэг. Ариун Сүнсний ажил өдөр тутмын амьдралд чинь саад болдоггүй бөгөөд хэвийн сүнслэг амьдралд чинь саад болдоггүй. Тохиолдож байх яг тэр хоромд нь та нар олон зүйлийг ялган салгаж чаддаггүй ч хэдэн өдрийн дараа зүрх сэтгэл чинь гэрэлтэж, оюун санаа чинь цэлмэдэг. Чи сүнсний зүйлсийн талаар бага зэрэг мэдэрдэг болж, тухайн бодол Бурханаас ирсэн үү, Сатанаас ирсэн үү гэдгийг аажмаар ялган таньж чаддаг. Зарим зүйл чамайг Бурханыг илт эсэргүүцэж,

Бурханы эсрэг тэрслэхэд хүргэдэг, эсвэл Бурханы үгийг хэрэгжүүлэхийг чинь болиулдаг; эдгээр зүйл бүгд Сатанаас гардаг. Зарим зүйл илэрхий биш байдаг бөгөөд тухайн үедээ та нар ялган таньж чаддаггүй; дараа нь тэдгээрийн илрэлийг хараад, ялган таньж чаддаг. Хэрвээ чи аль зүйл Сатанаас гардаг, алийг нь Ариун Сүнс чиглүүлдгийг тодорхой ялган салгаж чаддаг бол өөрсдийнхөө туршлагад амархан төөрөлдөхгүй. Заримдаа нөхцөл байдал чинь сайнгүй байх үед чамайг идэвхгүй байдлаас гаргах тодорхой бодол чамд төрдөг. Нөхцөл байдал чинь таагүй байх үед ч зарим бодол чинь Ариун Сүнснээс бас гарч болно гэдгийг энэ нь харуулдаг. Чамайг идэвхгүй байх үед бүх бодлыг чинь Сатан илгээдэг юм биш; хэрвээ тийм байсан бол чи хэзээ идэвхтэй байдал руу өөрчлөгдөж чадах юм бэ? Хэсэг хугацаанд идэвхгүй байснаа Ариун Сүнс чамд төгс болгуулах боломж өгдөг; Тэрээр чамайг хөдөлгөж, идэвхгүй байдлаас чинь гаргадаг.

Ариун Сүнсний ажил юу болохыг, Сатаны ажил юу болохыг мэдсэнээр туршлагынхаа явцад чи эдгээрийг өөрийнхөө байр байдалтай болон хувийн туршлагатай харьцуулж болох бөгөөд ийм маягаар, зарчимтай холбоотой илүү олон үнэн туршлагад чинь байх болно. Зарчмын тухай эдгээр үнэнийг ойлгоод чи өөрийнхөө бодит байдлыг хянах чадвартай болж, хүмүүс, үйл явдлыг ялган салгаж чаддаг болох бөгөөд Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд маш их хичээл чармайлт зарцуулах хэрэггүй болно. Мэдээж, энэ нь чиний сэдэл зөв байгаагаас, эрж хайж, хэрэгжүүлэхийг хүсэж байгаагаас хамаардаг. Иймэрхүү хэл—зарчимтай холбоотой хэл нь чиний туршлагад байх ёстой. Үүнгүйгээр чиний туршлага Сатаны хөндлөнгийн оролцоо болон мунхаг мэдлэгээр дүүрэн байх болно. Хэрвээ чи Ариун Сүнс хэрхэн ажилладгийг ойлгодоггүй бол хэрхэн орохоо ойлгодоггүй, хэрвээ чи Сатан хэрхэн ажилладгийг ойлгодоггүй бол авч байгаа алхам бүрдээ хэрхэн хянамгай байх ёстойгоо ойлгодоггүй. Хүмүүс Ариун Сүнс хэрхэн ажилладгийг болон Сатан хэрхэн ажилладгийг хоёуланг нь ойлгох ёстой; аль аль нь хүмүүсийн туршлагын зайлшгүй чухал хэсэг юм.

ҮНЭНИЙГ ХЭРЭГЖҮҮЛДЭГГҮЙ ХҮМҮҮСТ ӨГӨХ АНХААРУУЛГА

Ах эгч нарын дунд сөрөг байдлаа үргэлжид гаргагчид нь Сатаны боолууд бөгөөд тэд чуулганыг үймүүлдэг. Тийм хүмүүс нэг л өдөр хөөгдөж, таягдан хаягдах ёстой. Хүмүүс Бурханд итгэхдээ Бурханыг хүндлэх сэтгэл өвөрлөдөггүй,

Бурханыг дуулгавартай дагах зүрх сэтгэлгүй бол Түүний төлөө ямар ч ажил хийж чадахгүйгээр үл барам, харин ч эсрэгээрээ Түүний ажлыг үймүүлж, Түүнийг үл ойшоодог хүмүүс болно. Бурханд итгэдэг боловч Түүнд дуулгавартай байж, Түүнийг хүндлэлгүй, харин ч Түүнийг эсэргүүцэх нь итгэгчийн хувьд асар их гутамшиг юм. Хэрвээ итгэгчид, үл итгэгчдийн адилаар үг хэл, үйл хөдлөл нь ямагт хайхрамжгүй, цадиггүй байдаг бол тийм хүмүүс үл итгэгчдээс ч илүү ёрын муу юм; тэд бол жинхэнэ чөтгөр мөн. Чуулган дотор хорт, хорон муу яриагаа дэгдээдэг, ах эгч нарын дунд цуу яриа тарааж, зөрчил үүсгэж, бүлэглэл бий болгодог хүмүүс чуулганаас хөөгдсөн байх ёстой. Гэвч одоо Бурханы ажлын өөр эрин үе тул энэ хүмүүсийг хязгаарласан, учир нь тэд таягдан хаягдах нь гарцаагүй. Сатаны завхруулсан бүх хүн завхарсан зан чанартай байдаг. Зарим хүн завхарсан зан чанараас цаашгүй байхад бусад нь тийм биш: Тэд завхарсан сатанлаг зан чанартайгаар зогсохгүй, уг чанар нь ч бас туйлын хорон муу байдаг. Тэдний үг, үйлдэл завхарсан сатанлаг зан чанарыг нь илчилдгээр үл барам, энэ хүмүүс бол жинхэнэ диавол Сатан юм. Тэдний зан авир Бурханы ажилд саад болж, үймүүлэн, ах эгч нарын амийн оролтыг үймүүлж, чуулганы хэвийн амьдралд саад хийж байдаг. Хонины арьс нөмөрсөн энэ чононуудыг эрт орой хэзээ нэгэн цагт цэвэрлэх ёстой; Сатаны энэ боолуудад өршөөлгүй хандаж голж харьцах ёстой. Ингэх нь л Бурханы талд зогсож буй хэрэг; ингэж чаддаггүй хүмүүс Сатантай хамт намаг балчигт хөлбөрч байна. Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан үргэлж байдаг агаад Бурханыг хүндэлж, хайрладаг зүрх сэтгэлийг дотроо үргэлж тээдэг. Бурханд итгэдэг хүмүүс аливааг хянамгай, болгоомжтой хийх ёстой, бүх зүйлийг Бурханы шаардлагад нийцүүлж, Түүний зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд хийх хэрэгтэй. Тэд дур зоргоороо байж, хүссэн болгоноо хийх ёсгүй; ариун хүний ёс журамд энэ тохирохгүй. Хүмүүс галзууран гүйж, хаа сайгүй Бурханы туг далбааг намируулангаа энд тэндгүй сайрхаж, хууран мэхэлж болохгүй; энэ нь хамгийн тэрслүү үйлдэл юм. Гэр бүлд дүрэм журам, улс үндэстэнд хууль цааз гэж бий; тэгвэл Бурханы гэрт үүнээс ч илүү байх бус уу? Стандарт нь бүр ч хатуу чанд байх бус уу? Бүр их захиргааны зарлиг байдаг бус уу? Хүмүүс юу хүссэнээ хийж болох боловч Бурханы захиргааны зарлигийг хүссэнээрээ өөрчилж болохгүй. Бурхан бол хүмүүсийн халдахыг тэвчдэггүй Бурхан; Тэр бол хүмүүсийг үхүүлдэг Бурхан. Хүмүүс үүнийг үнэхээр аль хэдийн мэдэх бус уу?

Чуулганыг үймүүлж, Бурханы ажилд саад болдог хүмүүс чуулган болгонд бий. Тэд бүгд Бурханы гэрт шургалан орсон, зүсээ хувиргасан Сатан юм. Ийм

хүмүүс дүр эсгэхдээ нэн сайн байдаг; тэд Миний өмнө хүндэтгэлтэйгээр ирж, бөхөлзөн, хамуутай нохой шиг амьдарч, хувийн зорилгодоо хүрэхийн тулд “бүхнээ” зориулдаг боловч ах эгч нартай нүүр тулах үедээ муу муухай талаа харуулдаг. Тэд үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүсийг хараад тэдэн рүү дайрч давшлан, хажуу тийш нь түлхэж хаядаг; өөрсдөөс нь илүү аймшигтай хүмүүсийг харахаараа долигонож, зусарддаг, чуулган дотор дураараа дургиддаг. Иймэрхүү “орон нутгийн дээрэнгүй этгээд”, иймэрхүү “уяаны нохой” ихэнх чуулган дотор байдаг гэж хэлж болно. Тэд хамтдаа диавол шиг үйлдэж, нэг нэгэн рүүгээ ирмэн, сэмхэн дохио өгдгийн дээр хэн нь ч үнэнийг хэрэгжүүлдэггүй. Хамгийн хорт нэгэн нь “ахлах чөтгөр” болж, хамгийн нэр хүндтэй нь бусдыгаа удирдаж, туг далбаагаа өндөрт өргөдөг. Энэ хүмүүс чуулган даяар галзуурсан мэт авирлаж, сөрөг байдлаа тарааж, үхэл ханхлуулж, хүссэнээ хийж, юу дуртайгаа хэлдэг; хэн ч тэднийг зогсоож зүрхэлдэггүй, тэд сатанлаг зан чанараар дүүрэн байдаг. Тэднийг үймээн тарьж эхлэнгүүт үхлийн уур амьсгал чуулганд орж ирдэг. Үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс чуулганаас таягдан хаягдаж, бүхнээ зориулах боломжгүй болдог байхад чуулганыг үймүүлж, үхэл тараадаг хүмүүс чуулган дотор галзуурсан мэт авирлаж байдаг. Түүгээр ч үл барам, ихэнх хүн тэднийг дагадаг. Ийм чуулганыг гагцхүү Сатан захирч байдаг; диавол хаан нь юм. Хэрвээ чуулганы гишүүд өндийн босож, эдгээр ахлах чөтгөрийг эсэргүүцэхгүй бол өөрсдөө ч гэсэн эрт орой хэзээ нэгэн цагт сүйрэх болно. Одоогоос эхлэн, ийм чуулгануудын эсрэг арга хэмжээ авах ёстой. Үнэнийг бага ч гэсэн хэрэгжүүлэх чадвартай хүмүүс үнэнийг эрж хайдаггүй бол тэр чуулганыг бүр мөсөн устгана. Үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй нэг ч хүн үгүй, Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадах хэн ч байхгүй бол тэр чуулганыг нэгмөсөн тусгаарлаж, бусад чуулганаас холбоог нь таслах ёстой. Үүнийг “үхлийг булшлах” гэж нэрлэдэг; Сатаныг хөөн зайлуулах гэдэг нь энэ юм. Хэрэв чуулганд нутгийн хэдэн дээрэнгүй этгээд байдаг агаад ямар ч ялган таних чадваргүй “жигжиг ялаанууд” тэднийг дагадаг бол, хэрэв чуулганы гишүүд үнэнийг харсныхаа дараа ч гэсэн эдгээр дээрэнгүй этгээдийн хүлээс, явуулгаас салж чадахгүй хэвээр байгаа бол тэр тэнэгүүд эцэстээ бүгд таягдуулна. Энэхүү жигжиг ялаанууд ямар нэгэн аймшигтай зүйл хийгээгүй байж болох ч бүр илүү ов мэхтэй, бүр илүү зальхай, булзамхай байдаг, ийм хүн бүрийг таягдан хаяна. Ганцыг ч үлдээхгүй! Сатанд харьяалагддаг хүмүүс Сатан руу буцах бол Бурханд харьяалагддаг хүмүүс үнэнийг эрж хайж явах нь гарцаагүй; энэ нь тэдний уг чанараар шийдэгддэг. Сатаныг дагадаг бүх хүн мөхөөсэй! Ийм хүмүүст өрөвч

сэтгэл огт гаргахгүй. Үнэнийг хайдаг хүмүүс хангалт хүртэж, шавайгаа ханатал Бурханы үгэнд баясах болтугай. Бурхан бол зөвт; Тэр хэнийг ч алагчилдаггүй. Хэрвээ чи диавол бол үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг; хэрвээ чи үнэнийг хайдаг нэгэн бол Сатанд олзлогдохгүй нь лавтай. Энэ ямар ч эргэлзээгүй.

Ахиж дэвшихээр чармайдаггүй хүмүүс бусдыг өөрсөд шигээ идэвхгүй, хойрго байгаасай гэж үргэлж хүсдэг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс хэрэгжүүлдэг хүмүүст атаархаж, мунгинуу, ялган таних чадвараар дутмаг хүмүүсийг хуурч мэхлэхийг үргэлж оролддог. Энэ хүмүүсийн гаргадаг зүйлс нь чамайг доройтуулж, хөл алдуулж, хэвийн бус байдалтай болгож, харанхуйгаар дүүргэж чадна; тэд чамайг Бурханаас холдуулж, махан биеэ энхрийлэн, өөрийгөө өөгшүүлэхэд хүргэдэг. Үнэнийг хайрладаггүй, Бурхантай үргэлж хааш яаш харьцдаг хүмүүс өөрийгөө мэддэггүй; тийм хүмүүсийн зан чанар нь бусдыг нүгэл үйлдэж, Бурханыг үл ойшооход уруу татдаг. Тэд үнэнийг хэрэгжүүлдэггүй, бусдаар ч хэрэгжүүлүүлдэггүй. Тэд нүглийг нандигнадгийн дээр өөрсдийгөө жигшинэ гэж байдаггүй. Тэд өөрсдийгөө мэддэггүй, бусдад өөрсдийгөө танин мэдэхэд нь саад болдог; бас бусдад үнэнийг хүсэн тэмүүлэхэд нь саад болдог. Тэдэнд мэхлэгдсэн хүмүүс гэрлийг харж чадалгүй харанхуйд унаж, өөрсдийгөө мэдэхгүй, үнэний талаар тодорхой мэдэхгүй, Бурханаас улам бүр холддог. Тэд үнэнийг хэрэгжүүлдэггүй, бусад хүнд үнэнийг хэрэгжүүлэхэд саад болж, тэр бүх мунхаг хүнийг өөрсдийн өмнө авчирдаг. Бурханд итгэдэг гэж хэлэхийн оронд тэд өвөг дээдэстээ итгэдэг эсвэл итгэдэг зүйл нь тэдний зүрх сэтгэл дэх шүтээнүүд гэдгээ хэлбэл дээр сэн. Бурханыг дагадаг гэцгээдэг хүмүүс нүдээ нээгээд, яг хэнд итгэдгээ нэг сайн харсан нь дээр шүү: Итгэдэг зүйл чинь үнэхээр Бурхан уу, эсвэл Сатан уу? Хэрвээ итгэдэг зүйл чинь Бурхан биш, харин өөрийн чинь шүтээнүүд гэдгийг мэдэж байгаа бол өөрийгөө итгэгч гэж хэлэхгүй байсан нь дээр. Хэрвээ чи хэнд итгэдгээ үнэхээр мэдэхгүй байгаа бол мөн л өөрийгөө итгэгч гэж хэлэхгүй байсан нь дээр. Тэгж хэлэх нь доромжлол болно! Хэн ч чамайг Бурханд итгэ гэж хүчлээгүй. Надад итгэдэг гэж та нар бүү хэл; ийм яриаг Би хангалттай их сонссон бөгөөд дахин сонсохыг хүсэхгүй байна, учир нь итгэдэг зүйл чинь та нарын зүрх сэтгэл дэх шүтээнүүд, мөн та нарын дундах нутгийн дээрэнгүй этгээдүүд юм. Үнэнийг сонсох үедээ толгойгоо сэгсэрч, үхлийн талаарх яриа сонсоод учиргүй инээдэг хүмүүс бүгд Сатаны үр сад; тэд бүгд таягдан хаягдах болно. Чуулганд ялган таних чадваргүй олон хүн бий. Ямар нэгэн төөрөлдүүлсэн зүйл болоход тэд санамсаргүй Сатаны талд зогсдог; Сатаны боол гэж дуудсанд бүр гомддог. Өөрт нь ялган таних чадвар байхгүй

гэж хүмүүс хэлж магад боловч тэд үргэлж үнэнгүй талд зогсдог, шийдвэрлэх чухал цаг үед үнэний талд хэзээ ч зогсож байгаагүй, хэзээ ч үнэний төлөө өндийн босож, мэтгэлцэж байгаагүй. Тэд үнэхээр ялган таних чадваргүй гэж үү? Тэд яагаад санаандгүйгээр Сатаны талд ордог юм бэ? Яагаад тэд үнэнийг дэмжиж нэг ч болтугай шударга, үндэслэлтэй үг хэлдэггүй юм бэ? Энэ нөхцөл байдал үнэхээр тэдний агшин зуурын төөрөгдлөөс үүссэн гэж үү? Хүмүүст ялган таних чадвар хэдий чинээ бага байна, үнэний талд зогсох чадвар нь төдий чинээ бага байдаг. Энэ юуг харуулдаг вэ? Ялган таних чадваргүй хүмүүс ёрын мууд хайртай гэдгийг харуулдаг бус уу? Тэд бол Сатаны үнэнч үр сад гэдгийг харуулдаг бус уу? Яагаад тэд үргэлж Сатаны талд зогсож, түүний хэлээр ярьж чаддаг юм бэ? Үг үйлдэл бүр нь, нүүр царайны илэрхийлэл нь тэд ямар ч үнэнийг хайрлагч биш гэдгийг хангалттай нотолдог; харин ч тэд үнэнийг жигшдэг хүмүүс юм. Бүх амьдралаа өөрийнх нь төлөө тэмцэж өнгөрүүлдэг эдгээр өчүүхэн диаволд Сатан үнэхээр хайртай гэдгийг Сатаны талд тэд зогсож чаддаг нь хангалттай нотолдог. Энэ бүх баримт дэндүү тодорхой бус уу? Хэрвээ чи үнэхээр үнэнийг хайрладаг хүн мөн бол яагаад үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүсийг хүндэлдэггүй юм бэ, үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс дөнгөж харангуут нь яагаад тэднийг тэр даруй дагадаг юм бэ? Энэ ямар гэгчийн асуудал вэ? Чамд ялган таних чадвар байгаа эсэх нь Надад хамаагүй. Хэчнээн их төлөөс төлсөн чинь Надад хамаагүй. Хэчнээн их хүчтэй чинь Надад хамаагүй, нутгийн дээрэнгүй этгээд байна уу эсвэл туг баригч удирдагч байна уу Надад хамаагүй. Хүч чинь асар их байвал Сатаны хүч чадал л тусалсных. Нэр хүнд чинь өндөр байвал эргэн тойронд чинь үнэнийг хэрэгжүүлдэггүй хүн дэндүү олон байгаагийнх. Хэрвээ чи хөөгдөөгүй байгаа бол одоо хөөн зайлуулах ажлын цаг үе болоогүй байгаагийнх; харин ч таягдах ажлын цаг үе юм. Чамайг одоо хөөх гэж яарахгүй. Таягдуулсны чинь дараа чамайг шийтгэх тэр өдөр ирэхийг л Би хүлээж байгаа. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хэн бүхэн таягдуулах болно!

Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүс бол Бурханы үгийг хэрэгжүүлэх хүсэлтэй, үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй хүмүүс юм. Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсож үнэхээр чаддаг хүмүүс нь бас Түүний үгийг хэрэгжүүлэх хүсэлтэй, үнэний талд жинхэнээсээ зогсож чадах хүмүүс юм. Заль мэх хэрэглэж, шударга бусыг үйлддэг хүмүүс нь бүгд үнэнээр дутагддаг бөгөөд бүгдээрээ Бурханд шившиг авчирдаг. Чуулганд хэрүүл маргаан үүсгэдэг хүмүүс нь Сатаны боолууд, Сатаны биелэл юм. Ийм хүмүүс маш хорлонтой. Ялган таних чадваргүй, үнэний талд зогсох чадваргүй хүмүүс бүгд хорон муу санаа өвөрлөж,

үнэнийг гутаадаг. Түүгээр ч барахгүй тэд Сатаны жинхэнэ төлөөлөгч юм. Тэднийг золин аврахын аргагүй, мэдээжийн хэрэг таягдан хаях болно. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүсийг Бурханы гэр бүл үлдэхийг зөвшөөрдөггүй, чуулганыг санаатайгаар нураадаг хүмүүст ч үлдэхийг зөвшөөрдөггүй. Гэвч одоо бол хөөн зайлуулах ажил хийх цаг биш; тийм хүмүүс эцэстээ зүгээр л илчлэгдэж, таягдуулна. Энэ хүмүүс дээр дахин ямар ч хэрэггүй ажил зарлагадахгүй; Сатанд харьяалагддаг хүмүүс үнэний талд зогсож чаддаггүй байхад үнэнийг эрж хайдаг хүмүүс чаддаг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс үнэний замыг сонсож, үнэнийг гэрчлэх эрхгүй. Үнэн ердөө л тэдний чихэнд зориулагдаагүй; харин ч хэрэгжүүлдэг хүмүүст хандсан байдаг. Хүн бүрийн төгсгөл илчлэгдэхээс өмнө чуулганыг үймүүлж, Бурханы ажилд саад хийдэг хүмүүсийг одоохондоо эхлээд хойш тавьж, дараа нь харьцана. Ажил дуусмагц энэ хүмүүсийг нэг нэгээр нь илчилж, дараа нь таягдан хаяна. Одоохондоо, үнэнээр хангаж байх үед тэднийг үл ойшооно. Үнэн бүхэлдээ хүнд илчлэгдэх үед тэр хүмүүсийг таягдан хаях ёстой; тэр цаг үе нь бүх хүнийг төрлийнх нь дагуу ангилах цаг үе байна. Ялган таних чадваргүй хүмүүс ялихгүй заль мэхнийхээ улмаас ёрын муу хүмүүсийн гарт сүйрч, уруу татагдан, хэзээ ч эргэж ирэхгүй. Тэд үнэнийг хайрладаггүй, үнэний талд зогсох чадваргүй, муу хүмүүсийг дагаж, тэдний талд зогсдог, муу хүмүүстэй сүлбэлдэж, Бурханыг эсэргүүцдэг учраас тэдэнд ингэж хандвал зохино. Муу хүмүүс ёрын мууг ялгаруулдаг гэдгийг тэд маш сайн мэддэг атлаа зүрх сэтгэлээ чангалан, үнэнээс нүүр буруулж тэднийг дагадаг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй мөртөө хөнөөлтэй, ой гутам зүйлсийг хийгч энэ хүмүүс бүгд мууг үйлдэж байгаа бус уу? Тэдний дунд өөрсдийгөө хаан гэж нэрийддэг, мөн тэднийг дагадаг бусад хүн байгаа хэдий ч Бурханыг эсэргүүцдэг уг чанар нь бүгд адил бус уу? Бурхан өөрсдийг нь авардаггүй гэж хэлэх ямар шалтаг тэдэнд байх юм бэ? Бурханыг зөвт бус гэж хэлэх ямар шалтаг тэдэнд байх юм вэ? Өөрсдийнх нь ёрын муу байдал тэднийг сүйрүүлж байгаа бус уу? Өөрсдийнх нь тэрслүү байдал там руу чирч байгаа бус уу? Үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс эцэст нь үнэний улмаас аврагдаж, төгс болгуулна. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс эцэстээ үнэний улмаас өөртөө сүйрэл авчрах болно. Үнэнийг хэрэгжүүлдэг болон хэрэгжүүлдэггүй хүмүүсийг хүлээж буй төгсгөл ийм билээ. Бүр илүү их нүгэл үйлдэхээс зайлсхийж нэн даруй чуулганыг орхи гэж Би үнэнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй хүмүүст зөвлөө. Цаг нь ирэхээр гэмшихэд хэтэрхий оройтсон байх болно. Ялангуяа бүлэглэл бий болгож, хагарал үүсгэдэг хүмүүс, чуулган доторх нутгийн дээрэнгүй этгээдүүд бүр эрт явах ёстой. Ёрын муу чонын

уг чанартай ийм хүмүүс өөрчлөгдөж чадахгүй. Тэд Бурханы шийтгэлээс зайлсхийхийн тулд аль болох эртхэн чуулганаас явж ах эгч нарын хэвийн амьдралыг дахин хэзээ ч үймүүлэхгүй байсан нь дээр. Тэднийг дагаж явсан хүмүүс та нар энэ боломжийг ашиглаж, өөрсдөө эргэцүүлбэл сайн. Та нар ёрын муу хүмүүстэй хамт чуулганаас явах уу эсвэл үлдэж, дуулгавартай дагах уу? Энэ асуудлыг няхуур авч үзэх ёстой. Би та нарт сонголт хийх дахин нэг боломж өгье; хариултыг чинь Би хүлээж байна.

ЧИ АМИЛСАН ХҮН МӨН ҮҮ?

Завхарсан зан чанараа хаяж, хэвийн хүн чанарыг амьдран харуулдаг болсон үедээ л чи төгс болгуулна. Чи зөгнөл хэлж чадахгүй, аливаа нууцын тухай ярьж чадахгүй боловч хүний дүрийг амьдран харуулж, илчилнэ. Хүнийг Бурхан бүтээсэн боловч дараа нь Сатан тэднийг завхруулснаар тэд “үхмэл хүмүүс” болсон юм. Иймээс өөрчлөгдсөнийхөө дараа чи эдгээр “үхмэл хүмүүс” шиг байхаа болино. Бурханы үг л хүмүүсийн сүнсийг сэхээж, тэднийг дахин төрүүлдэг бөгөөд хүмүүсийн сүнс дахин төрөх үед тэд амилсан байх болно. “Үхмэл хүмүүс” гэж ярих үедээ Би сүнсгүй цогцос болон сүнс нь дотроо үхсэн хүмүүсийг хэлж байгаа юм. Хүмүүсийн сүнсийг амийн очоор сэхээх үед тэд амилдаг. Урьд нь ярьж байсан ариун хүмүүс гэдэг нь амилсан хүмүүс буюу Сатаны эзэмшил дор байсан ч Сатаныг ялсан хүмүүсийг хэлдэг. Хятадын сонгогдсон хүмүүс агуу улаан лууны харгис, балмад хавчлага, заль мэхийг амссанаасаа болж сэтгэл санаагаар сүйрч, амьдрах өчүүхэн ч эр зориггүй болж орхисон. Иймээс, тэдний сүнсийг мөн чанараас нь эхлэн сэрээх ёстой: Бага багаар, мөн чанар дотроо тэдний сүнс сэрэх ёстой. Нэг л өдөр тэднийг амилах үед саад тотгор гэж байхаа больж, бүх зүйл төвөггүй урагшлах болно. Одоогоор энэ нь биелэх аргагүй хэвээр байна. Ихэнх хүн амьдралын хэв маягаараа үхлийн уур амьсгалыг ихээр амьдран харуулдаг, тэд үхлийн аурагаар хүрээлэгдсэн байдаг ба хэтэрхий их зүйлээр дулимаг байдаг. Зарим хүний үг нь үхэл дагуулж, үйлдэл нь үхэл тээн, амьдран харуулдаг бараг бүх зүйл нь үхлээс бүрдсэн байдаг. Өнөөдөр хүмүүс Бурханд ил тод гэрчлэл хийвэл бүтэлгүйтэх болно, учир нь тэд бүрэн амилах болоогүй, бас та нарын дунд асар олон үхдэл бий. Өнөөдөр зарим хүн, Бурхан Харь үндэстэн дунд ажлаа хурдан түгээхийн тулд яагаад тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй юм бэ гэж асуудаг. Үхэгсэд Бурханд гэрчлэл хийж чаддаггүй; энэ нь амьд хүмүүсийн л чаддаг зүйл боловч өнөөдрийн ихэнх хүн “үхмэл хүмүүс” юм, тэд асар олуулаа

үхлийн нөмрөг, Сатаны нөлөөн дор амьдардаг бөгөөд ялалтыг олж авах чадваргүй. Тэгэхээр тэд яаж Бурханд гэрчлэл хийж чадах юм бэ? Тэд яаж сайн мэдээний ажлыг түгээж чадах юм бэ?

Харанхуйн нөлөөн дор амьдардаг хүмүүс бол үхэл дунд амьдардаг, Сатанд эзэмдүүлсэн хүмүүс юм. Хүмүүс Бурханаар аврагдаж, Бурханаар шүүгдэж, гэсгээгдэлгүйгээр үхлийн нөлөөнөөс зугтаж чадахгүй, амьд болж чадахгүй. Энэ “үхмэл хүмүүс” Бурханд гэрчлэл хийж чаддаггүй, Бурханд ашиглагдаж ч чаддаггүй, хаанчлалд орж бүр ч чадахгүй. Бурхан үхэгсдийн бус, амьд хүмүүсийн гэрчлэлийг хүсдэг ба үхэгсдээс бус, амьд хүмүүсээс Өөрийнх нь төлөө ажиллахыг шаарддаг. “Үхэгсэд” бол Бурханыг эсэргүүцэн тэрсэлдэг хүмүүс юм; тэд бол сүнс нь мэдрэлгүй бөгөөд Бурханы үгийг ойлгодоггүй хүмүүс, үнэнийг хэрэгжүүлдэггүй, Бурханд өчүүхэн төдий ч үнэнч биш, мөн Сатаны эзэмшил дор амьдарч, Сатанд ашиглагддаг хүмүүс юм. Үхэгсэд үнэний эсрэг зогсож, Бурханы эсрэг тэрслэн, дорд, жигшүүрт, хорон, хэрцгий, зальхай, муу санаатай байснаараа өөрсдийгөө харуулдаг. Ийм хүмүүс Бурханы үгийг идэж уусан ч гэсэн Бурханы үгийг амьдран харуулж чаддаггүй; тэд амьд боловч алхаж буй үхдэлүүд, амьсгалдаг цогцсууд юм. Үхэгсэд Бурханыг сэтгэл хангалуун байлгах ямар ч чадваргүй бөгөөд Түүнд бүрэн дүүрэн дуулгавартай байж бүр ч чаддаггүй. Тэд ердөө л Түүнийг мэхэлж, доромжилж, Түүнээс урваж чаддаг бөгөөд амьдран харуулдаг бүх хэв маягаараа Сатаны уг чанарыг илчилдэг. Хүмүүс амьд хүн болж, Бурханд гэрчлэл хийж, Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхийг хүсвэл Бурханы авралыг хүлээн зөвшөөрөх ёстой; Түүний шүүлт, гэсгээлтэд баяртайгаар захирагдах ёстой, мөн Бурханы засалт, харьцалтыг баяртайгаар хүлээн авах ёстой. Тэр үед л тэд Бурханы шаарддаг бүх үнэнийг хэрэгжүүлэх чадвартай болно, тэр үед л тэд Бурханы авралыг олж авч, үнэхээр амьд хүн болох болно. Амьд хүмүүс бол Бурханаар аврагдсан хүмүүс, тэд Бурханаар шүүгдэж, гэсгээгдсэн бөгөөд өөрсдийгөө зориулахад бэлэн байдаг, амиа Бурханд дуртайяа өгч, бүхий л амьдралаа Бурханд баяртайгаар зориулдаг. Амьд хүмүүс Бурханд гэрчлэл хийх үед л Сатан шившиглэгдэнэ, амьд хүмүүс л Бурханы сайн мэдээний ажлыг түгээж чадна, амьд хүмүүс л Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадна, амьд хүмүүс л жинхэнэ хүн юм. Анх Бурханы бүтээсэн хүн амьд байсан боловч Сатаны завхралын улмаас хүн үхлийн дунд, Сатаны нөлөөн дор амьдардаг, иймээс хүмүүс сүнсгүй үхэгсэд болсон, Бурханыг эсэргүүцдэг дайснууд болсон, Сатаны хэрэгсэл болсон, мөн Сатаны хоригдол болцгоосон. Бурханы бүтээсэн бүх амьд

хүн үхдэл болсон учраас Бурхан гэрчлэлээ алдсан, мөн Тэр Өөрийнхөө бүтээсэн, Өөрийнх нь амьсгалыг агуулдаг цорын ганц зүйл болох хүн төрөлхтнийг алдсан юм. Бурхан гэрчлэлээ буцаан авч, Өөрийнх нь гараар бүтээгдсэн боловч Сатанд олзлогдсон хүмүүсийг буцааж авъя гэвэл тэднийг амьд хүн болгохын тулд дахин амилуулах ёстой, тэгээд Тэр тэднийг гэрэлдээ амьдруулахын тулд буцаан авах ёстой. Үхэгсэд бол сүнсгүй, туйлын хөшүүн, Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм. Хамгийн гол нь тэд бол Бурханыг мэддэггүй хүмүүс. Энэ хүмүүс Бурханд дуулгавартай байх өчүүхэн төдий ч санаа зорилгогүй, зөвхөн Түүний эсрэг тэрсэлж, Түүнийг эсэргүүцдэг ба өчүүхэн ч үнэнч сэтгэлгүй байдаг. Амьд хүмүүс бол сүнс нь дахин төрсөн, Бурханд дуулгавартай байхаа мэддэг, Бурханд үнэнч хүмүүс юм. Тэд үнэн болон гэрчлэлийг эзэмшдэг бөгөөд энэ хүмүүс л Бурханы гэрт Түүний таалалд нийцдэг. Бурхан амилж, авралыг нь харж, Өөрт нь үнэнч байж чадах, Өөрийг нь эрж хайхыг хүсдэг хүмүүсийг авардаг. Тэрээр бие махбодтой болсон Бурханд болон Түүний илрэлтэд итгэдэг хүмүүсийг авардаг. Зарим хүн амилж чаддаг бол зарим нь чаддаггүй; уг чанар нь аврагдаж чадах эсэхээс энэ нь шалтгаалдаг. Олон хүн Бурханы үгээс ихийг сонссон атлаа Бурханы хүслийг ойлгодоггүй, тэдгээрийг хэрэгжүүлэх ч чадваргүй байдаг. Тэр хүмүүс ямар ч үнэнийг амьдран харуулах чадваргүй бөгөөд Бурханы ажилд мөн санаатайгаар саад учруулдаг. Тэд Бурханы төлөө ямар ч ажил хийх чадваргүй, Түүний төлөө юу ч зориулж чаддаггүй, мөн нууцаар чуулганы мөнгийг үрж, Бурханы гэрт үнэгүй хооллодог. Энэ хүмүүс бол үхдэлүүд, тэд аврагдахгүй. Бурхан Өөрийнх нь ажлын дунд байгаа бүх хүнийг авардаг хэдий ч Бурханы авралыг хүлээж авч чаддаггүй нэг хэсэг хүн бий; цөөн тооны хүн л Түүний авралыг хүлээн авч чадна. Учир нь ихэнх хүн хэтэрхий гүн завхарч, үхдэл болсон ба тэд аврагдах аргагүй; тэднийг Сатан бүрэн ашигласан, тэдний уг чанар дэндүү хорлонтой. Мөн тэрхүү цөөн тооны хүн ч Бурханд бүрэн дуулгавартай байж чаддаггүй. Тэд анхнаасаа Бурханд туйлын үнэнч, туйлын хайртай байсан хүмүүс биш; харин тэд Бурханы байлдан дагуулах ажлаас болж дуулгавартай болсон, Бурханы дээдийн дээд хайраас болж Бурханыг хардаг, Бурханы зөвт зан чанараас болж тэдний зан чанарт өөрчлөлт гардаг, мөн Бурханы бодитой агаад энгийн ажлаас болж Бурханыг мэдэж авдаг юм. Бурханы энэ ажилгүйгээр энэхүү хүмүүс хэчнээн ч сайн байсан, Сатан болон үхэлд харьяалагдсан хэвээр, үхсэн хэвээр байх байсан. Өнөөдөр энэ хүмүүс Бурханы авралыг хүлээж авч чаддаг нь гагцхүү тэд Бурхантай хамтран ажиллахыг хүсдэгийнх юм.

Амьд хүмүүс Бурханд үнэнч байдгаасаа үүдэн Бурханаар авхуулж, Түүний амлалт дунд амьдрах болно, харин үхэгсэд Бурханыг эсэргүүцдэгээсээ болж Бурханаар жигшигдэн гологдож, Түүний шийтгэл болон хараалын дунд амьдрах болно. Энэ бол Бурханы зөвт зан чанар бөгөөд ямар ч хүн үүнийг өөрчлөх аргагүй. Хүмүүс өөрсдийнхөө эрэл хайгуулаас үүдэн Бурханы сайшаалыг хүртэж, гэрэлд амьдардаг; овжин явуулгынхаа улмаас хүмүүс Бурханаар хараагдаж, шийтгэл дунд буудаг; муу үйлээсээ болж хүмүүс Бурханаар шийтгэгддэг; мөн хүсэл тэмүүлэл болон үнэнч зангаасаа болж хүмүүс Бурханы ерөөлийг хүртдэг. Бурхан бол зөвт: Тэр амьд хүмүүсийг ерөөж, үхэгсдийг хараадаг, ингэснээр тэд үргэлж үхэл дунд байж, Бурханы гэрэлд дахин хэзээ ч амьдрахгүй. Бурхан амьд хүмүүсийг Өөртэйгөө үүрд хамт байлгахаар хаанчлал, ерөөл рүүгээ аваачна. Харин үхэгсдийг Тэр нам цохиж, мөнхийн үхэл рүү хүргэнэ; тэд бол Түүний сүйрлийн бай бөгөөд үргэлжид Сатанд харьяалагдана. Бурхан хэнд ч шударга бус ханддаггүй. Бурханыг үнэхээр эрж хайдаг бүхэн Бурханы гэрт үлдэж, Бурханд дуулгаваргүй, таарамжгүй бүхэн Түүний шийтгэл дунд амьдрах нь гарцаагүй. Магадгүй, чи Бурханы махбод дахь ажилд эргэлзэж байж болох юм—гэвч нэг л өдөр Бурханы махбод хүний төгсгөлийг шууд зохицуулахгүй; харин Түүний Сүнс хүний хүрэх газрыг зохицуулах болно, тэр үед хүмүүс Бурханы махбод болон Түүний Сүнс нэг юм, Түүний махбод алдаа гаргадаггүй бөгөөд Түүний Сүнс алдаа гаргах бүр ч боломжгүй юм гэдгийг мэдэх болно. Эцэст нь Тэр амилсан хүмүүсийг нэг ч илүү, дутуугүйгээр хаанчлалдаа аваачна. Харин амилаагүй үхэгсдийг бол Сатаны үүр луу хаяна.

БУРХАНЫГ МЭДДЭГГҮЙ БҮХ ХҮН БОЛ БУРХАНЫГ ЭСЭРГҮҮЦДЭГ ХҮМҮҮС ЮМ

Бурханы ажлын зорилго, хүн дээр хүрдэг үр нөлөө болон хүний төлөөх Бурханы хүсэл яг юу болохыг ухаарах нь Бурханыг дагадаг хүн бүрийн хүрэх ёстой зүйл юм. Өнөө үед бүх хүнд дутагддаг зүйл бол Бурханы ажлын тухай мэдлэг билээ. Дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш өнөөг хүртэл хүмүүс дээр ажилласан Бурханы үйл хэрэг, Бурханы бүхий л ажил болон хүнийг гэх Бурханы хүсэл яг юу болох—эдгээр нь хүний мэддэг ч үгүй, ойлгодог ч үгүй зүйлс юм. Энэхүү дутагдал зөвхөн шашны ертөнц даяар харагдаад зогсохгүй, бас Бурханд итгэдэг бүх хүнээс ч харагддаг. Чи үнэхээр Бурханыг харж, Бурханы мэргэн ухааныг үнэхээр ухаарч, Бурханы хийсэн бүх үйл хэргийг харж, Бурханд юу

байгаа, Тэр юу болохыг таньж—Түүний элбэг дэлбэг байдал, мэргэн ухаан, гайхамшиг болон хүмүүст хийсэн бүх ажлыг нь харах өдөр ирэхэд—тэр үед чи Бурханд итгэх итгэлдээ амжилт гаргасан байх болно. Бурхан бүхнийг хамардаг ба бүхэлдээ элбэг дэлбэг гэж хэлэх үед чухамдаа Тэр ямар байдлаар бүхнийг хамардаг вэ, мөн ямархуу маягаар бүхэлдээ элбэг дэлбэг байдаг вэ? Хэрвээ чи үүнийг ойлгохгүй бол чамайг Бурханд итгэдэг гэж үзэж болохгүй. Шашны ертөнц дэх хүмүүс Бурханд итгэгчид бус, харин мууг үйлдэгч, диаволын төрлийнх гэж Би яагаад хэлдэг вэ? Тэд бол мууг үйлдэгчид гэж хэлж байгаа минь тэд Бурханы хүслийг ойлгодоггүй, мэргэн ухааныг нь хардаггүйгээс болж байгаа юм. Бурхан Өөрийн ажлыг хэзээ ч тэдэнд илчилдэггүй. Тэд бол сохор; тэд Бурханы үйл хэргийг харж чаддаггүй, Бурханд хаягдсан ба тэдэнд Бурханы халамж, хамгаалалт огтхон ч байдаггүй, Ариун Сүнсний ажил бүр ч байдаггүй. Бурханы ажилгүй хүмүүс бол бүгд мууг үйлдэгчид, Бурханыг эсэргүүцэгчид юм. Миний ярьдаг, Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл нь Бурханыг мэддэггүй хүмүүс, Бурханыг амаараа хүлээн зөвшөөрдөг атлаа Түүнийг мэддэггүй хүмүүс, Бурханыг дагадаг атлаа Түүнд дуулгавартай байдаггүй хүмүүс, Бурханы нигүүлслийг эдэлдэг атлаа Түүний гэрчлэлд зогсож чаддаггүй хүмүүсийг хэлдэг. Бурханы ажлын зорилгыг ойлгохгүйгээр, хүнд Бурханы хийдэг ажлыг ойлгохгүйгээр хүн Бурханы хүсэлтэй нийцэж чадахгүй, Бурханы гэрчлэлд зогсож ч чадахгүй. Хүн Бурханыг эсэргүүцдэгийн шалтгаан нь нэг талаар хүний завхарсан зан чанараас, нөгөө талаар Бурханыг мэддэггүйгээс болон Бурханы ажилладаг зарчим, хүнийг гэх Түүний хүслийг ойлгодоггүйгээс болдог. Энэ хоёр тал нь хамтдаа Бурханд хандах хүний эсэргүүцлийн түүхийг бүрдүүлдэг. Хүний уг чанар дотор Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл байдаг учраас шинэхэн итгэгчид Бурханыг эсэргүүцдэг байхад олон жил итгэсэн хүмүүс завхарсан зан чанар дээрээ нэмээд Бурханыг мэддэггүйгээсээ болж Түүнийг эсэргүүцдэг. Бурханыг махбод болохоос өмнөх хугацаанд, хүн тэнгэр дэх Бурханы тогтоосон зарлигуудыг мөрддөг эсэхэд үндэслэн Бурханыг эсэргүүцдэг эсэх нь хэмжигддэг байв. Тухайлбал, Хуулийн эрин үед Еховагийн хуулийг мөрддөггүй хэнийг ч бай Бурханыг эсэргүүцдэг хүн гэж үздэг байлаа; Еховагийн тахилыг хулгайлсан хэнийг ч, Еховагийн тааллыг олсон хүмүүсийг эсэргүүцдэг хэнийг ч Бурханыг эсэргүүцдэг хүн гэж үзээд чулуугаар шидэж хөнөөдөг байв; эцэг, эхээ хүндэлдэггүй хэнийг ч, мөн бусдыг цохисон юм уу хараасан хэнийг ч хуулийг мөрдөөгүй хүн гэж үздэг байлаа. Еховагийн хуулийг мөрдөөгүй бүх хүнийг Түүнийг эсэргүүцэж байна гэж үздэг байсан юм. Нигүүлслийн эрин үед ийм

байхаа больж, Есүсийг эсэргүүцдэг хэнийг ч Бурханыг эсэргүүцсэн хүн гэж үзээд, Есүсийн айлдсан үгийг дуулгавартай дагаагүй хэнийг ч Бурханыг эсэргүүцсэн нэгэн гэж үзсэн билээ. Энэ удаа, Бурханыг эсэргүүцдэг арга замыг илүү үнэн зөв, илүү бодитоор тодорхойлсон. Бурханыг хараахан махбод болоогүй байх үед хүн Бурханыг эсэргүүцдэг эсэх нь тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд шүтэн мөргөж, Түүнийг хүндэлдэг эсэхэд нь үндэслэн хэмжигддэг байлаа. Тухайн үед Бурханыг эсэргүүцэх арга замыг төдийлөн бодитой тодорхойлоогүй, учир нь тэр үед хүн Бурханыг харж чадаагүй, Бурханы дүр ямархуу болохыг ч, Тэр хэрхэн ажиллаж, ярьдгийг ч мэдээгүй байсан юм. Бурхан хүнд хараахан харагдаагүй байсан учраас хүнд Бурханы талаар ямар ч үзэл байгаагүй ба тодорхойгүй байдлаар Бурханд итгэж байлаа. Тиймээс, хүн төсөөлөлдөө Бурханд яаж ч итгэж байсан бай, Бурхан хүнийг яллаагүй, хүнд хэтэрхий их шаардлага ч тавиагүй, учир нь хүн Бурханыг огтхон ч харж чадахгүй байв. Бурханыг махбод болж, хүмүүсийн дунд ажиллахаар ирэх үед бүгд Бурханыг харж, үгийг нь сонсож, махбодоороо Бурханы хийдэг бүх үйл хэргийг хардаг. Тэр үед хүний бүх үзэл хөөс болдог. Бурхан махбодоор гарч ирэхийг харсан хүмүүсийн хувьд, хэрвээ тэд Түүнийг дуртайяа дуулгавартай дагадаг бол яллагдахгүй, харин зориуд Түүний эсрэг зогсдог хүмүүсийг Бурханыг эсэргүүцэгч гэж үзэх болно. Тийм хүмүүс бол антихристүүд, Бурханыг зориуд эсэргүүцдэг дайснууд юм. Бурханы талаар үзэл өвөрлөдөг боловч Түүнийг дуулгавартай дагахад бэлэн, дуулгавартай дагахыг хүсдэг хүмүүс яллагдахгүй. Бурхан бодол, санаанд нь үндэслэж бус, харин санаа зорилго, үйлдэлд нь үндэслэн хүнийг ялладаг. Хэрвээ хүнийг бодол, санааных нь үндсэн дээр ялладаг байсан бол Бурханы хилэнт гараас зугтаж чадах ганц ч хүн үгүй. Бие махбодтой болсон Бурханыг санаатайгаар эсэргүүцдэг хүмүүс дуулгаваргүй байдлынхаа улмаас шийтгүүлнэ. Бурханыг дур зоргоороо эсэргүүцдэг энэ хүмүүсийн тухайд бол, тэдний эсэргүүцэл Бурханы талаарх үзлээс нь үүдэн гардаг ба энэ нь Бурханы ажлыг үймүүлэх үйлдэл хийхэд хүргэдэг. Энэ хүмүүс Бурханы ажлыг зориуд эсэргүүцэж, сүйрүүлдэг. Тэд Бурханы талаар үзэлтэй байгаад зогсохгүй Түүний ажлыг үймүүлэх зүйлсийг хийдэг, энэ шалтгааны улмаас ийм төрлийн хүмүүс ялагдана. Бурханы ажлыг дур зоргоороо үймүүлдэггүй хүмүүсийг нүгэлтнүүд хэмээн яллахгүй, учир нь тэд дуртайяа дуулгавартай дагаж чаддаг бөгөөд үймээн, саад тотгор учруулах үйлдэл хийдэггүй. Ийм хүмүүс яллагдахгүй. Гэхдээ хүмүүс Бурханы ажлыг олон жилийн турш туулсан ч Бурханы талаар үзэл өвөрлөсөөр, бие махбодтой болсон

Бурханы ажлыг мэдэх чадваргүй хэвээр байж, хэчнээн олон жил Түүний ажлыг туулсан ч Бурханы талаар үзэл тээсээр, Бурханыг мэдэж авч чадахгүй хэвээр байвал үймүүлэх юм хийгээгүй ч гэсэн тэдний зүрх сэтгэл Бурханы талаарх олон үзлээр дүүрсэн байх ба эдгээр үзэл ил болоогүй ч гэсэн, тийм хүмүүс Бурханы ажилд ямар ч тус дэмгүй байдаг. Тэд Бурханы төлөө сайн мэдээ түгээж, эсвэл Түүний төлөө гэрчлэлд зогсож чадахгүй. Ийм хүмүүс бол ямар ч хэрэггүй, тэнэгүүд билээ. Тэд Бурханыг мэддэггүй, түүнчлэн Бурханы талаарх үзлээ хаяж огт чаддаггүй учраас яллагддаг. Үүнийг ингэж хэлж болно: Шинэхэн итгэсэн хүмүүсийн хувьд Бурханы талаар үзэл тээх юм уу Түүний талаар юу ч мэдэхгүй байх нь хэвийн юм, харин Бурханд олон жил итгэж, Бурханы ихээхэн ажлыг туулсан хүн үзэл өвөрлөсөөр байх нь хэвийн бус бөгөөд Бурханы талаар ямар ч мэдлэггүй байх нь бүр ч хэвийн бус юм. Энэ нь хэвийн бус байдал учраас тэд яллагддаг. Энэ хэвийн бус хүмүүс бүгд хог новш; тэд бол Бурханыг хамгийн их эсэргүүцдэг хүмүүс бөгөөд Бурханы нигүүлслийг хий дэмий эдэлсэн хүмүүс юм. Ийм хүмүүс эцэстээ бүгд таягдан хаягдана!

Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс бөгөөд Бурханы ажлын зорилгыг ойлгож авсан атлаа Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрж хайдаггүй хүмүүс бол Бурханыг бүр ч их эсэргүүцдэг хүмүүс юм. Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы нэрээр далайлгадаг атлаа Түүнийг дур зоргоороо эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд “эрүүл чийрэг бие махбодтой” харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд хүмүүсийг хөтөлдөг антихристүүдээс цаашгүй гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Бурханы өмнө өөрсдийгөө өндрөөр үнэлдэг хүмүүс бол хамгийн дорд хүмүүс, харин өөрсдийгөө даруухан байлгадаг хүмүүс бол хамгийн эрхэм юм. Бурханы ажлыг мэддэг гэж боддог, түүнчлэн Бурханыг шууд харж байхдаа ч Түүний ажлыг асар чангаар бусдад тунхагладаг хүмүүс бол хамгийн мэдлэггүй хүмүүс юм. Ийм

хүмүүс бол Бурханы гэрчлэлгүй хүмүүс, биеэ тоосон, ихэрхүү хүмүүс билээ. Бодит туршлагатай, Бурханы талаар бодитой мэдлэгтэй атлаа өөрсдийгөө Бурханы талаар дэндүү бага мэдлэгтэй гэж боддог хүмүүсийг Тэр хамгийн их хайрладаг. Ийм хүмүүс л үнэхээр гэрчлэлтэй байдаг ба Бурханаар төгс болгуулж үнэхээр чаддаг. Бурханы хүслийг ойлгодоггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханы хүслийг ойлгодог атлаа үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханы үгийг идэж, уудаг атлаа Бурханы үгийн мөн чанарын эсрэг явдаг хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; бие махбодтой болсон Бурханы талаар үзэл тээдэг, түүнчлэн тэрслүү санаа бодолтой хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханыг шүүдэг хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханыг мэдэж, эсвэл Түүнд гэрчлэл хийж чаддаггүй хэн боловч Бурханыг эсэргүүцэгчид билээ. Иймээс Би та нарыг шавдуулж байна: Хэрвээ та нарт энэ замаар алхах итгэл үнэхээр байгаа бол үргэлжлүүлэн дага. Харин та нар Бурханыг эсэргүүцэхгүй байж чадахгүй бол хэтэрхий оройтохоосоо өмнө явсан чинь дээр. Тэгэхгүй бол, та нарын хувьд юмс муугаар эргэх магадлал туйлын өндөр, учир нь та нарын уг чанар зүгээр л дэндүү их завхарсан. Та нарт үнэнч сэтгэл, дуулгавартай байдал, зөвт байдал, үнэнээр цангасан зүрх сэтгэл, Бурханыг гэх хайр өчүүхэн төдий ч байхгүй. Бурханы өмнөх нөхцөл байдал чинь туйлын замбараагүй байдаг гэж хэлж болно. Та нар баримтлах учиртай зүйлээ баримталдаггүй, ярих учиртай зүйлээ ярьж чаддаггүй. Мөн хэрэгжүүлэх учиртай зүйлээ хэрэгжүүлж чадаагүй, биелүүлэх учиртай чиг үүргээ биелүүлж чадаагүй. Та нарт байх учиртай үнэнч зан, мөс чанар, дуулгавартай байдал юм уу шийдвэр байдаггүй. Туулах ёстой зовлонгоо туулаагүй, та нарт байх учиртай итгэл ч байхгүй. Нэлээд энгийнээр хэлбэл, та нарт ямар ч гавьяа байхгүй: Үргэлжлүүлэн амьдрахаас ичихгүй байна гэж үү? Та нар мөнхөд амрахаар нүдээ аньж, тэгснээрээ та нарын тусын тулд санаа зовж, та нарын төлөө зовлон туулахаас Бурханыг хэлтрүүлсэн нь дээр гэж Би ятгаж байна. Та нар Бурханд итгэдэг ч Түүний хүслийг мэддэггүй; Бурханы үгийг идэж, уудаг ч хүнээс Бурханы шаарддаг зүйлийг биелүүлж чаддаггүй. Бурханд итгэдэг ч Түүнийг мэддэггүй бөгөөд ямар ч зорьсон зорилгогүй, ямар ч үнэ цэнгүй, ямар ч утга учиргүй амьдардаг. Та нар хүний хувиар амьдардаг ч ямар ч мөс чанар, ёс жудаг, өчүүхэн төдий ч найдвартай байдал байдаггүй—та нар өөрсдийгөө хүн гэж нэрлэж чадна гэж үү? Та нар Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэхэлдэг; түүнээс гадна, Бурханы мөнгийг аваад, Түүнд өргөсөн тахилыг иддэг. Гэсэн ч эцэст нь Бурханы мэдрэмжийг өчүүхэн төдий ч хайхардаггүй, Бурханыг

гэх жаахан ч болов мөс чанар харуулдаггүй. Та нар Бурханы хамгийн ялихгүй шаардлагыг ч биелүүлж чаддаггүй. Та нар өөрсдийгөө хүн гэж нэрлэж чадна гэж үү? Бурханы хангасан хоолыг идэж, Түүний өгсөн хүчилтөрөгчөөр амьсгалж, нигүүлслийг нь эдэлдэг ч эцэст нь та нар Бурханы талаар өчүүхэн төдий ч мэддэггүй. Харин ч та нар Бурханыг эсэргүүцдэг ямар ч хэрэггүй хүмүүс болсон. Тэгэхээр та нар нохойноос ч дор араатан бус уу? Амьтдын дунд та нараас илүү хорлонтой амьтан байгаа гэж үү?

Өндөр индэр дээр зогсоод бусдад зааж сургадаг тэдгээр пастор, ахлагч бол Бурханыг эсэргүүцэгчид бөгөөд Сатаны хамсаатан юм; өндөр индэр дээр зогсоод бусдад зааж сургадаггүй та нар Бурханыг бүр ч их эсэргүүцдэг бус уу? Та нар бүр тэднээс ч илүү Сатантай сүлбэлддэг бус уу? Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй хүмүүс Бурханы хүсэлд хэрхэн нийцэхээ мэддэггүй. Мэдээж, Бурханы ажлын зорилгыг ойлгодог хүмүүс Бурханы хүсэлд хэрхэн нийцэхээ мэдэхгүй байна гэж үгүй. Бурханы ажил хэзээ ч алдаа мадаггүй байдаг; харин ч хүний эрэл хайгуул л дутагдалтай. Бурханыг дур зоргоороо эсэргүүцдэг өөдгүй хүмүүс тэр пастор, ахлагч нараас ч илүү зэвүүн, хорлонтой бус уу? Бурханыг эсэргүүцдэг хүн маш олон байдаг ч тэдний дунд Бурханыг эсэргүүцдэг олон өөр арга зам байдаг. Төрөл бүрийн итгэгчид байдгийн адилаар Бурханыг эсэргүүцдэг, өөр хоорондоо адилгүй янз бүрийн хүмүүс бий. Бурханы ажлын зорилгыг тодорхой танин мэдэж чаддаггүй хүмүүсийн нэг нь ч аврагдаж чадахгүй. Хүн урьд нь Бурханыг хэрхэн эсэргүүцэж байснаас үл хамааран, Бурханы ажлын зорилгыг ойлгож авч, Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд хичээл чармайлтаа зориулах үед түүний урьдын бүх нүглийг Бурхан арилгах болно. Хүн үнэнийг эрж хайж, үнэнийг хэрэгжүүлж байгаа цагт хийсэн зүйлийг нь Бурхан санахгүй. Түүнчлэн, үнэнийг хэрэгжүүлснийх нь үндсэн дээр Бурхан хүнийг зөвтгөдөг. Энэ нь Бурханы зөвт байдал юм. Хүн Бурханыг харж, Түүний ажлыг туулахаасаа өмнө Бурханд хэрхэн хандаж байсан нь хамаагүй, Тэр үүнийг санадаггүй. Харин Бурханыг харж, Түүний ажлыг туулмагц хүний бүх үйлдэл, үйл хэргийг Бурхан “түүхэн бичигт” бичнэ, учир нь хүн Бурханыг харж, Түүний ажил дотор амьдарсан билээ.

Хүн Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг үнэхээр харж, дээдийн дээд байдлыг нь харж, Бурханы ажлыг үнэхээр мэдэж авах үед, түүнчлэн хүний хуучин зан чанар өөрчлөгдөх үед Бурханыг эсэргүүцдэг тэрслүү зан чанараа бүрэн хаясан байх болно. Нэгэн цагт хүн бүр Бурханыг эсэргүүцсэн ба нэгэн цагт хүн бүр Бурханы эсрэг тэрсэлсэн гэж хэлж болно. Гэвч хэрвээ чи бие

махбодтой болсон Бурханыг дуртайяа дуулгавартай дагаж, энэ үеэс эхлэн үнэнч байдлаараа Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж, хэрэгжүүлэх учиртай үнэнийг хэрэгжүүлж, биелүүлэх учиртай үүргээ биелүүлж, мөрдөх учиртай дэг журмыг мөрддөг бол чи Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд тэрслүү байдлаа хаяхыг хүсдэг, Бурханаар төгс болгуулж чадах хүн юм. Чи алдаагаа харахаас татгалзаж, гэмших санаагүй байвал, мөн Бурхантай хамтран ажиллаж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах өчүүхэн ч болов санаа зорилгогүйгээр тэрслүү үйлдлээ хэвээр үргэлжлүүлж байвал чам шиг ийм зөрүүд, тэнэг хүн гарцаагүй шийтгүүлэх ба Бурханаар төгс болгуулах нэгэн байж хэзээ ч чадахгүй. Тийм болохоор чи өнөөдөр Бурханы дайсан, маргааш ч бас Бурханы дайсан байх бөгөөд цаашид ч Бурханы дайсан хэвээр үлдэх болно; чи үүрд Бурханыг эсэргүүцэгч, Бурханы дайсан байх болно. Тэгвэл Бурхан чамайг яаж хэлтрүүлж чадах юм бэ? Бурханыг эсэргүүцэх нь хүний уг чанар боловч уг чанараа өөрчлөх нь дааж давшгүй байдгаас болоод хүн Бурханыг эсэргүүцэх “нууцыг” зориуд эрж хайх ёсгүй. Хэрвээ тийм бол хэтэрхий оройтохоосоо өмнө явсан чинь дээр, ирээдүйд гэсгээлт чинь илүү хатуу ширүүн болох вий, мөн зэрлэг догшин уг чанар чинь гарч ирж, махан бие чинь эцэстээ Бурханаар устгуулахдаа тултал дийлдэшгүй болох вий. Чи ерөөл хүртэхийн тулд Бурханд итгэдэг; гэвч эцэст нь золгүй явдал л чамд тохиолдох юм бол ичгүүртэй байх бус уу? Өөр төлөвлөгөө зохиосон нь хамаагүй дээр гэж Би та нарыг шавдуулж байна. Өөр юу ч хийсэн бай, Бурханд итгэхээс дээр байх болно: Мэдээж ганцхан энэ зам л байдаг байж таарахгүй. Та нар үнэнийг эрж хайгаагүй бол үргэлжлүүлэн амьдрах байсан биз дээ? Яах гэж ийм маягаар Бурхантай зөрөлдөх ёстой гэж?

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ (1)

Иохан Есүсийн төлөө долоон жил ажиллаж, Есүсийг ирэх үед аль хэдийн зам зассан байв. Үүнээс өмнө, Иоханы тунхагласан тэнгэрийн хаанчлалын сайн мэдээ газар нутаг даяар сонсогдсон тул Иудей даяар түгж, хүн бүр түүнийг эш үзүүлэгч гэж нэрлэсэн юм. Тухайн үед Херод Хаан Иоханыг хөнөөхийг хүсэж байсан ч тэгж зүрхлээгүй, учир нь хүмүүс Иоханыг ихэд хүндэлдэг байсан бөгөөд хэрвээ Иоханыг хөнөөвөл тэд өөрийнх нь эсрэг босно гэдгээс Херод айжээ. Иоханы хийсэн ажил жирийн хүмүүсийн дунд үндэслэсэн ба тэрээр иудейчүүдэд хүндлэгдсэн юм. Есүс үйлчлэлээ гүйцэтгэж эхлэх үе хүртэл долоон жилийн туршид тэрээр Есүсийн замыг засжээ. Энэ шалтгааны улмаас Иохан бүх

эш үзүүлэгчдээс хамгийн агуу нь байлаа. Иоханыг шоронд орсны дараа л Есүс албан ёсны ажлаа эхэлсэн юм. Иоханаас өмнө Бурханд зориулан зам зассан эш үзүүлэгч хэзээ ч байгаагүй, учир нь Есүсээс өмнө Бурхан хэзээ ч махбод болоогүй. Иймээс Иоханыг хүртэлх бүх эш үзүүлэгчээс Иохан л бие махбодтой болсон Бурханд зориулсан замыг засах цорын ганц хүн байсан бөгөөд ийм маягаар Иохан Хуучин болон Шинэ Гэрээний хамгийн агуу эш үзүүлэгч болжээ. Иохан Есүсийн баптисмаас долоон жилийн өмнө тэнгэрийн хаанчлалын тухай сайн мэдээг түгээж эхэлсэн юм. Түүний хийсэн ажил нь хүмүүст, Есүсийн хожим хийх ажлаас илүү дээгүүр мэт санагдсан ч тэрээр ердөө л эш үзүүлэгч байлаа. Тэр сүмийн дотор бус, харин үүний гаднах хот, тосгонд ажиллаж, үг хэлдэг байв. Тэр үүнийг мэдээж Иудейн ард түмний дунд, ялангуяа ядуу зүдүү хүмүүсийн дунд хийсэн юм. Иохан нийгмийн дээд зиндааны хүмүүстэй ховорхон уулзаж, зөвхөн Иудейн энгийн иргэдийн дунд сайн мэдээ түгээж байлаа. Энэ нь Эзэн Есүсийн төлөө зөв зохистой хүмүүсийг бэлтгэх, мөн ажиллахад тохиромжтой газрыг Түүнд зориулан бэлтгэхийн төлөө байв. Замыг нь засах Иохан мэтийн эш үзүүлэгч байсан тул Эзэн Есүс ирэнгүүтээ Өөрийн цовдлолын замыг шууд эхлүүлж чадсан юм. Бурхан ажлаа хийхээр махбод болох үедээ хүмүүсийг сонгох ажлыг хийх хэрэггүй байсан, мөн хүмүүсийг, эсвэл ажиллах газрыг биечлэн эрж хайх ч шаардлагагүй байв. Тэр ирэхдээ ийм ажил хийгээгүй; Түүнийг ирэхээс өмнө тохиромжтой хүн Түүний төлөө ийм зүйлийг аль хэдийн бэлдчихсэн байсан юм. Есүс Өөрийн ажлыг эхлэхээс өмнө Иохан энэ ажлыг аль хэдийн дуусгасан байлаа, учир нь бие махбодтой болсон Бурхан ажлаа хийхээр ирэх үедээ Өөрийг нь удаан хугацаанд хүлээж байсан хүмүүс дээр шууд ажилласан юм. Есүс, засаж залруулах хүний ажлыг хийхээр ирээгүй. Тэр зөвхөн Өөрийн гүйцэтгэх үйлчлэлийг гүйцэтгэхээр ирсэн; өөр бусад зүйлс Түүнтэй ямар ч хамаагүй байлаа. Иохан ирэх үедээ Эзэн Есүсийн ажлын бай болгохын тулд сүмээс болон иудейчүүд дундаас тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн бүлэг хүмүүсийг гаргаж ирэх төдийг л хийсэн юм. Иохан долоон жилийн турш ажилласан, өөрөөр хэлбэл, тэрээр тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг долоон жилийн турш түгээсэн юм. Ажлынхаа үеэр Иохан олон гайхамшиг үзүүлээгүй, учир нь түүний ажил бол замыг засах явдал байсан; энэ нь бэлтгэл ажил байсан билээ. Бусад бүх ажил буюу Есүсийн хийх гэж байсан ажил түүнтэй хамаагүй байв; тэрбээр зөвхөн нүглээ улайж, гэмшихийг хүмүүсээс хүсэж, хүмүүст баптисм хүртээж байсан ба ингэснээр хүмүүс аврагдаж чадах байлаа. Хэдийгээр тэр шинэ ажил хийж, урьд нь хүний хэзээ ч алхаж байгаагүй замыг

нээсэн боловч мөн л Есүст зориулан зам зассан юм. Тэр ердөө л бэлтгэл ажил хийсэн эш үзүүлэгч байсан бөгөөд Есүсийн ажлыг хийх чадваргүй байв. Есүс хэдийгээр тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглах эхний хүн байгаагүй ч, мөн Иоханы эхлүүлсэн замаар үргэлжлүүлэн явсан ч Түүний ажлыг хийж чадах өөр хэн ч байгаагүй бөгөөд энэ нь Иоханы ажлаас илүү дээгүүр байсан юм. Есүс Өөрийн замыг бэлдэж чадаагүй; Түүний ажил шууд Бурханы өмнөөс хийгдсэн. Иймээс, Иохан хичнээн олон жил ажилласан нь хамаагүй, зүгээр л эш үзүүлэгч, ердөө л замыг зассан нэгэн хэвээр юм. Есүсийн хийсэн гурван жилийн ажил Иоханы долоон жилийн ажлаас давсан, учир нь Түүний ажлын мөн чанар адилхан байгаагүй. Есүс үйлчлэлээ гүйцэтгэж эхлэх үед буюу Иоханы ажил төгсөх үед Эзэн Есүсийн ашиглах хангалттай хүмүүс болон газруудыг Иохан бэлтгэсэн байсан бөгөөд тэдгээр нь Эзэн Есүс гурван жилийн ажлаа эхлэхэд хангалттай байв. Иймээс Иоханы ажил дуусангуут Эзэн Есүс Өөрийн ажлыг албан ёсоор эхэлж, Иоханы хэлсэн үг хаягдсан. Яагаад гэвэл, Иоханы хийсэн ажил зөвхөн шилжилт өөрчлөлтийн төлөө байсан бөгөөд түүний үг хүнийг шинэ өсөлтөд хөтлөх амийн үг байгаагүй; эцсийн эцэст түүний үг түр зуур хэрэглэгдсэн юм.

Есүсийн хийсэн ажил ер бусын байгаагүй; үүнд үйл явц байсан бөгөөд энэ бүхэн нь аливаа юмсын хэвийн хуулийн дагуу ахиж дэвшсэн. Амьдралынхаа сүүлчийн зургаан сард, энэ ажлыг хийхээр ирсэн гэдгээ Есүс гарцаагүй мэдэж байсан бөгөөд загалмайд цовдлогдохын тулд ирсэн гэдгээ мэдэж байв. Тэр Гетсемани цэцэрлэгт гурвантаа залбирсан шиг цовдлогдохоосоо өмнө Есүс Эцэг Бурханд тасралтгүй залбирсан юм. Баптисм хүртсэнийхээ дараа Есүс гурван жил хагасын хугацаанд Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэсэн бөгөөд албан ёсны ажил нь хоёр жил хагас үргэлжилжээ. Эхний жилд Түүнийг Сатан буруутгаж, хүн үймүүлсэн ба Тэрээр хүний сорилтод өртсөн юм. Тэр Өөрийн ажлыг гүйцэтгэх зуураа олон сорилтыг давж гарсан. Сүүлийн зургаан сард Есүсийг удалгүй цовдлогдох гэж байх үед Петрийн амнаас, Тэр бол амьд Бурханы Хүү, Тэр бол Христ гэх үг гарсан юм. Зөвхөн тэр үед л Түүний ажил бүгдэд мэдэгдэж, тэр үед л Түүний ялгамж чанар олон нийтэд илчлэгдсэн билээ. Түүний дараа Есүс, хүний төлөө цовдлогдоно, тэгээд гурван өдрийн дараа дахин амилна; мөн Тэр золин авралын ажлыг биелүүлэхээр ирсэн ба Аврагч мөн гэдгээ шавь нартаа хэлсэн. Сүүлийн зургаан сард л Тэр Өөрийн ялгамж чанар болон хийхээр төлөвлөж буй ажлаа илчилсэн юм. Энэ нь бас Бурханы цаг үе байсан бөгөөд ажил ийнхүү хийгдэх байлаа. Тухайн үед Есүсийн ажлын

нэг хэсэг нь Хуучин Гэрээний дагуу, түүнчлэн Хуулийн эрин үеийн Мосегийн хууль, Еховагийн үгийн дагуу байв. Есүс Өөрийн ажлын нэг хэсгийг хийхдээ энэ бүхнийг ашигласан юм. Тэрээр хүмүүст номлож, синагогт тэдэнд зааж сургаж, Өөртэй нь дайсагнадаг фарисайчуудыг зэмлэхийн тулд Хуучин Гэрээн дэх эш үзүүлэгчдийн зөгнөлийг хэрэглэж, тэдний дуулгаваргүй байдлыг илчилж, улмаар тэднийг яллахын тулд Бичвэрийн үгийг ашигласан. Учир нь тэд Есүсийн хийсэн зүйлийг үзэн ядсан; ялангуяа Есүсийн ажлын ихэнх нь Бичвэр дэх хуулийн дагуу байгаагүй, түүнчлэн Түүний зааж сургасан зүйл тэдний өөрсдийнх нь үгээс илүү өндөр, Бичвэр дэх эш үзүүлэгчдийн зөгнөсөн зүйлээс ч илүү дээгүүр байсан учраас тэд үзэн яджээ. Есүсийн ажил зөвхөн хүний золин аврал болон цовдлолын төлөө л байсан тул ямар нэгэн хүнийг байлдан дагуулахын тулд илүү их үг хэлэх хэрэггүй байсан юм. Хүмүүст Түүний заасан зүйлийн ихэнх нь Бичвэрийн үгээс гарсан бөгөөд Түүний ажил Бичвэрээс хэтрээгүй ч гэсэн, Тэрээр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж мөн л чадсан юм. Түүний ажил үгийн ажил байгаагүй, хүн төрөлхтнийг байлдан дагуулахын төлөө ч хийгдээгүй, харин хүн төрөлхтнийг золин аврахын төлөө хийгдсэн ажил билээ. Тэр зөвхөн хүн төрөлхтний төлөө нүглийн тахил болсон бөгөөд хүн төрөлхтний төлөөх үгийн эх сурвалж болоогүй. Тэрээр хүнийг байлдан дагуулах ажил болох Харь үндэстний ажлыг хийгээгүй, харин Бурхан байдаг гэдэгт итгэдэг хүмүүсийн дунд хийгдсэн цовдлолын ажлыг хийсэн юм. Хэдийгээр ажил нь Бичвэрийн суурин дээр хийгдэж, Тэрээр фарисайчуудыг яллахын тулд эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг ашигласан боловч энэ нь цовдлолын ажлыг гүйцэлдүүлэхэд хангалттай байв. Хэрвээ өнөөдрийн ажил мөн л Бичвэр дэх эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийн суурин дээр хийгдсэн бол та нарыг байлдан дагуулах боломжгүй байх байсан, учир нь Хуучин Гэрээнд Хятадын ард түмэн та нарын дуулгаваргүй байдал болон нүглийг тэмдэглээгүй байдаг ба та нарын нүглийн тухай ямар ч түүх байдаггүй. Иймээс хэрвээ энэ ажил мөн л Библид тулгуурласан бол та нар хэзээ ч буулт хийхгүй байсан. Библи нь израильчуудын хязгаарлагдмал түүхийг л тэмдэглэсэн байдаг бөгөөд сайн муу эсэхийг чинь тогтоох юм уу та нарыг шүүх чадваргүй. Би та нарыг израильчуудын түүхийн дагуу шүүх байлаа гээд төсөөлөөд үз—та нар Намайг өнөөдрийнх шигээ дагасаар байх байсан уу? Та нар хэчнээн хэцүү гэдгээ мэдэх үү? Энэ үе шатанд ямар ч үг хэлээгүй бол байлдан дагуулах ажлыг гүйцэлдүүлэх боломжгүй байх байв. Би загалмайд цовдлуулах гэж ирээгүй учраас та нарыг байлдан дагуулахын тулд Библиэс тусдаа үгийг хэлэх ёстой. Есүсийн хийсэн ажил

Хуучин Гэрээнээс ердөө нэг үе шатаар өндөр байв; энэ нь эрин үеийг эхлүүлж, тэрхүү эрин үеийг удирдахад ашиглагдсан. Яагаад Тэр: “Би хуулийг хэрэгсэхгүй болгохын тулд биш, харин гүйцэлдүүлэхийн тулд ирсэн” гэж хэлсэн бэ? Гэсэн ч Хуучин гэрээний израильчуудын хэрэгжүүлж байсан хууль болон даган мөрдөж байсан тушаалуудаас ялгаатай зүйл Түүний ажилд их байсан, учир нь Тэр хуулийг дуулгавартай дагахаар биш, харин гүйцэлдүүлэхээр ирсэн билээ. Үүнийг гүйцэлдүүлэх үйл явц нь олон бодитой зүйлсийг агуулж байсан: Түүний ажил илүү жинхэнэ, бодитой байсан, цаашлаад энэ нь илүү амьд агаад дүрэм журмыг сохроор баримтлах явдал биш байсан. Израильчууд Амралтын өдрийг сахиагүй гэж үү? Есүс ирэхдээ Амралтын өдрийг чанд мөрдөөгүй, учир нь Тэрээр, хүний Хүү бол Амралтын өдрийн Эзэн бөгөөд Амралтын өдрийн Эзэн ирэх үедээ хүссэнээрээ хийнэ гэж хэлсэн юм. Тэрээр Хуучин гэрээний хуулиудыг гүйцэлдүүлж, хуулийг өөрчлөхийн тулд ирсэн билээ. Өнөөдөр хийгддэг бүхэн өнөө үед үндэслэдэг ч Хуулийн эрин үе дэх Еховагийн ажлын суурин дээр тулгуурладаг бөгөөд энэ цар хүрээг давдаггүй. Жишээлбэл, хэлэх үгээ хянах, садар самуун үйлдэхгүй байх зэрэг нь Хуучин Гэрээний хууль биш гэж үү? Өнөөдөр та нараас шаарддаг зүйл зөвхөн Арван Тушаалаар хязгаарлагддаггүй, харин урьд байснаас илүү өндөр зэрэглэлийн тушаал болон хуулиас бүрддэг. Гэхдээ энэ нь урьдын зүйлсийг хэрэгсэхгүй болгоно гэсэн үг биш, учир нь Бурханы ажлын үе шат бүр урьд нь явагдсан үе шатны суурин дээр хийгддэг. Тахил өргөх, эцэг эхээ хүндлэх, хуурамч шүтээн шүтэхгүй байх, бусдыг дайрч доромжлохгүй, эсвэл хараахгүй байх, садар самуун үйлдэхгүй байх, тамхи татахгүй, архи уухгүй байх, үхсэн юм идэхгүй, цус уухгүй байх гэх мэт тухайн үед Еховагийн Израильд хийсэн ажлын тухайд бол, өнөөдөр ч гэсэн энэ нь хэрэгжүүлэлтийн чинь суурийг бүрдүүлдэггүй гэж үү? Өнгөрсөн үеийн суурин дээр л өнөөдрийг хүртэл ажил хийгдсээр ирсэн. Хэдийгээр өнгөрсөн үеийн хуулиудыг дурдахаа больж, чамд шинэ шаардлага тавьсан боловч эдгээр хууль хүчингүй болоогүйгээр үл барам, харин ч илүү өндөрт өргөгдсөн юм. Тэдгээрийг хүчингүй болгосон гэж хэлбэл өмнөх эрин үе хуучирсан гэсэн үг, гэхдээ зарим тушаалыг чи мөн л үүрд мөнхөд баримтлах ёстой. Өнгөрсөн үеийн тушаалууд аль хэдийн хэрэгжиж, аль хэдийн хүний оршихуй болсон бөгөөд “тамхи татаж болохгүй”, “архи ууж болохгүй” гэх мэт тушаалуудыг онцлон тэмдэглэх хэрэггүй. Энэ суурин дээр, өнөөдрийн хэрэгцээний чинь дагуу, биеийн хэмжээний чинь дагуу, өнөөдрийн ажлын дагуу шинэ тушаалуудыг гаргадаг. Шинэ эрин үеийн тушаалуудыг тунхаглах нь хуучин эрин үеийн тушаалуудыг хэрэгсэхгүй болгоно

гэсэн үг биш, харин хүний үйлдлийг илүү бүрэн гүйцэд болгож, бодит байдалтай илүү зохицолтой болгохын тулд энэ суурин дээр тэдгээрийг илүү өндөрт өргөх явдал юм. Хэрвээ өнөөдөр та нараас израильчуудын адилаар зөвхөн Хуучин Гэрээний тушаалыг дагаж, хуулийг мөрдөхийг л шаардсан бол, тэр ч бүү хэл Еховагийн тогтоосон хуулийг цээжлэхийг шаардсан бол та нар өөрчлөгдөх ямар ч боломжгүй байх байлаа. Хэрвээ та нар тэр хэдхэн хязгаарлагдмал тушаалуудыг дагаж, эсвэл тоо томшгүй олон хууль цээжилсэн бол хуучин зан чанар чинь гүнзгий шингэсэн хэвээр үлдэх байсан бөгөөд үүнийг үндсээр нь арилгах ямар ч аргагүй байх байв. Тиймээс та нар улам бүр доройтох байсан бөгөөд та нарын нэг нь ч дуулгавартай болохгүй байх байсан юм. Өөрөөр хэлбэл, хэдхэн энгийн тушаал, эсвэл тоймгүй олон хууль Еховагийн үйл хэргийг мэдэхэд чинь туслах чадваргүй. Та нар израильчуудтай адилхан биш: Хуулийг дагаж, тушаалыг цээжилснээр тэд Еховагийн үйл хэргийг нүдээр харж, өөрсдийн чин үнэнч байдлыг ганцхан Түүнд өгч чаддаг байсан. Харин та нар үүнд хүрч чадахгүй бөгөөд Хуучин Гэрээний эрин үеийн хэдхэн тушаал нь та нарыг зүрх сэтгэлээ өгөхөд хүргэх, эсвэл та нарыг хамгаалах чадваргүйгээр үл барам, харин ч та нарыг цалгар болгож, Үхэгсдийн орон руу унагана. Учир нь Миний ажил байлдан дагуулалтын ажил бөгөөд энэ нь та нарын дуулгаваргүй байдал болон хуучин зан чанар луу чиглэдэг. Ехова, Есүс хоёрын эелдэг үг өнөөгийн шүүлтийн хатуу үгээс хавьгүй дутмаг байдаг. Тийм хатуу үггүйгээр, хэдэн мянган жилийн турш дуулгаваргүй байсаар ирсэн “мэргэжилтнүүд” та нарыг байлдан дагуулах боломжгүй юм. Хуучин Гэрээний хуулиуд нь та нарт нөлөөлөх хүчээ аль хэдийн алдсан ба өнөөдрийн шүүлт хуучин хуулиас хавьгүй илүү хатуу. Та нарт хамгийн тохиромжтой зүйл бол хуулийн шалихгүй хязгаарлалтууд биш, харин шүүлт юм, учир нь та нар хамгийн анхны хүн төрөлхтөн биш, харин хэдэн мянган жилийн турш ялзруулагдсан хүн төрөлхтөн билээ. Хүний одоо хүрэх ёстой зүйл өнөөдрийн хүний бодит байр байдлын дагуу, өнөө цагийн хүний хэв чанар болон бодит биеийн хэмжээний дагуу байдаг бөгөөд дүрэм журам баримтлахыг чамаас шаарддаггүй. Ингэснээр хуучин зан чанарт чинь өөрчлөлт гарч, чи өөрийн үзлийг хаяж болох юм. Тушаалууд бол дүрэм журам гэж чи бодож байна уу? Тэдгээрийг хүнд тавьдаг хэвийн шаардлага гэж хэлж болно. Тэдгээр нь чиний дагах ёстой дүрэм журам биш. Жишээ нь, тамхи татахыг хориглох явдлыг аваад үз—энэ нь дүрэм журам уу? Энэ нь дүрэм журам биш! Үүнийг хэвийн хүн чанар шаарддаг; энэ нь дүрэм журам биш, харин бүх хүн төрөлхтөнд тавьсан болзол билээ. Өнөөдөр

тогтоосон арав гаруй тушаал ч бас дүрэм журам биш, харин хэвийн хүн чанарт хүрэхэд шаардагддаг зүйл юм. Хүмүүс өнгөрсөн үед тийм зүйлсийг эзэмшдэг, эсвэл мэддэг байгаагүй тул тэдгээрт хүрэхийг өнөөдөр хүмүүсээс шаарддаг бөгөөд ийм зүйлсийг дүрэм журам гэж тооцдоггүй. Хуулиуд нь дүрэм журамтай адилхан биш. Миний ярьж байгаа дүрэм журам нь ёслол, хэлбэрдэл, эсвэл хүний эндүү ташаа хэрэгжүүлэлтийг хэлдэг; эдгээр нь хүнд ямар ч нэмэргүй, ямар ч ач тусгүй зааврууд юм; эдгээр нь ямар ч утга учиргүй үйл ажиллагааг бий болгодог. Энэ нь стандарт дүрэм журам бөгөөд хүнд ямар ч ашиг тус өгдөггүй учир ийм дүрэм журмыг хаях учиртай. Хүнд ашиг тустай зүйлийг л хэрэгжүүлэх ёстой.

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ (2)

Нигүүлслийн эрин үед гэмшлийн сайн мэдээ тунхаглагдсан бөгөөд хүн итгэх л юм бол аврагдах байв. Өнөөдөр авралын оронд байлдан дагуулалт болон төгс болголтын тухай яриа л байдаг. Хэрвээ хүн итгэвэл бүхий л гэр бүлийнхэн нь ерөөгдөнө, эсвэл нэг л аврагдсан бол үүрд аврагдсан гэж хэзээ ч хэлдэггүй. Өнөөдөр хэн ч эдгээр үгийг хэлдэггүй бөгөөд тийм зүйлс нь хоцрогдсон. Тухайн үед Есүсийн ажил бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө байв. Түүнд итгэсэн бүх хүний нүгэл уучлагдсан; Түүнд итгэдэг л бол Тэр чамайг золин аварна; хэрвээ Түүнд итгэсэн бол чи нүглийнх байхаа больж, нүглээсээ чөлөөлөгдөх байв. Аврагдах, итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь энэ юм. Гэхдээ итгэсэн хүмүүст ч Бурханыг эсэргүүцдэг, тэрслүү зүйл үлдсэн бөгөөд үүнийг мөн л аажмаар арилгах хэрэгтэй байлаа. Аврал гэдэг нь Есүс хүнийг бүрэн олж авсан гэсэн үг биш, харин хүн нүгэлтэн байхаа больж, нүглээ уучлуулсан гэсэн үг юм. Чи итгэх л юм бол дахиад хэзээ ч нүглийнх байхаа болих юм. Тухайн үед Есүс Өөрийнх нь шавь нарт үл ойлгогдох ихээхэн ажил хийж, хүмүүсийн ойлгоогүй зүйл ихийг хэлсэн. Учир нь тухайн үед Тэр ямар ч тайлбар өгөөгүй. Тиймээс Түүнийг явснаас хойш хэдэн жилийн дараа Матай Есүст зориулсан угийн бичгийг бүтээж, бусад нь ч бас хүний хүслээс гарсан ихээхэн ажил хийжээ. Есүс хүнийг төгс болгож, олж авахын төлөө ирээгүй, харин ажлын нэг үе шат буюу тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг авчирч, цовдлолын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд ирсэн юм. Иймээс Есүсийг цовдлогдмогц Түүний ажил бүрэн дууссан. Харин одоогийн үе шатанд—байлдан дагуулалтын ажилд—илүү олон үг хэлж, илүү их ажил хийх ёстой бөгөөд олон үйл явц байх ёстой. Иймээс Есүс, Ехова хоёрын

ажлын нууц илчлэгдэх ёстой, ингэснээр бүх хүн итгэлээрээ илүү их ойлгож, тодорхой мэдэж авах болно, учир нь энэ бол эцсийн өдрүүдийн ажил бөгөөд эцсийн өдрүүд нь Бурханы ажлын төгсгөл, ажлын сүүлчийн цаг үе юм. Ажлын энэ үе шат нь чамд Еховагийн хууль болон Есүсийн золин авралыг тодорхой ойлгуулна, ингэснээр чи үндсэндээ Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний бүхий л ажлыг ойлгож, энэхүү зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний бүх ач холбогдол, мөн чанарыг ойлгож, Есүсийн хийсэн ажил, хэлсэн үг бүхний зорилгыг, тэр ч бүү хэл Библид сохроор итгэж, биширч байснаа ойлгож болох юм. Энэ бүхэн нь чамд нэгд нэггүй ойлгох боломж олгоно. Чи Есүсийн хийсэн ажил болон өнөөдрийн Бурханы ажлын аль алиныг ойлгож авна; чи бүх үнэн, амь, замыг ойлгож, нүдээр харна. Есүсийн хийсэн ажлын үе шатанд Есүс яагаад эцсийн ажлыг хийлгүй явсан бэ? Учир нь, Есүсийн ажлын үе шат нь эцсийн ажил байгаагүй. Түүнийг загалмайд цовдлох үед үг нь ч бас төгсгөл болсон; цовдлогдсоных нь дараа Түүний ажил бүрмөсөн дууссан. Одоогийн үе шат бол өөр: Үгийг дуустал хэлж, Бурханы бүх ажил гүйцэлдсэний дараа л Түүний ажил дууссан байх болно. Есүсийн ажлын үе шатанд хэлэлгүй үлдээсэн, эсвэл тодорхой илэрхийлээгүй олон үг байсан юм. Гэсэн ч Есүс юуг хэлсэн, юуг хэлээгүйгээ тоогоогүй, учир нь Түүний үйлчлэл бол үгийн үйлчлэл биш байсан бөгөөд загалмайд цовдлогдсоныхоо дараа Тэр явж одсон. Ажлын тэр үе шат нь ерөөсөө цовдлолын төлөө байсан бөгөөд одоогийн үе шаттай адилгүй. Ажлын энэ үе шат нь үндсэндээ төгсгөлийн төлөө, эмхэлж цэгцэлж, бүх ажлыг дуусгахын төлөө байдаг. Хэрвээ үгийг бүр дуустал нь хэлэхгүй бол энэхүү ажлыг гүйцэлдүүлэх ямар ч аргагүй байх болно, учир нь ажлын энэ үе шатанд үгийг ашиглан бүх ажил төгсгөлдөө очиж, гүйцэлддэг. Тухайн үед Есүс хүмүүст үл ойлгогдох их ажил хийсэн. Тэрээр чимээгүй явж одсон бөгөөд өнөөдөр ч гэсэн Түүний үгийг ойлгодоггүй, ойлголт нь буруу ч зөв гэж итгэсээр байдаг, буруу гэдгээ ч мэддэггүй олон хүн байсаар байгаа. Эцсийн үе шат Бурханы ажлыг бүрэн төгсгөж, гүйцэлдүүлнэ. Бурханы удирдлагын төлөвлөгөөг бүгд ойлгож, мэдэж авна. Хүмүүсийн доторх үзэл, санаа зорилго, эндүү ташаа, утгагүй ойлголт, Ехова болон Есүсийн ажлын талаарх үзэл, Харь үндэстний тухай үзэл бодол болон бусад бүх алдаа, гажуудал засагдана. Тэгээд хүн амьдралын бүх зөв зам, Бурханы хийсэн бүх ажил, бүхий л үнэнийг ойлгоно. Тийм зүйл болох үед ажлын энэ үе шат төгсгөлдөө очно. Еховагийн ажил нь дэлхийг бүтээх явдал байсан бөгөөд энэ нь эхлэл байсан юм; ажлын энэ үе шат бол ажлын сүүлч бөгөөд төгсгөл юм. Эхэндээ Бурханы ажил Израилийн

сонгогдсон хүмүүсийн дунд хийгдсэн бөгөөд энэ нь бүх газраас хамгийн ариун газар дахь шинэ эриний эхлэл байв. Ажлын сүүлчийн үе шат нь, дэлхийг шүүж, эрин үеийг төгсгөхийн тулд бүх улс орноос хамгийн бузар заваан оронд хийгддэг. Эхний үе шатанд Бурханы ажил хамгийн гэрэл гэгээтэй газар хийгдсэн бол сүүлчийн үе шат нь хамгийн харанхуй газарт хийгддэг бөгөөд энэхүү харанхуйг хөөн зайлуулж, гэрлийг авчирч, бүх хүнийг байлдан дагуулна. Бүх газраас хамгийн бузар заваан, харанхуй газрын ард түмэн байлдан дагуулагдаж, жинхэнэ Бурхан байдгийг бүх хүн ам хүлээн зөвшөөрч, хүн болгон бүрэн үнэмших үед бүхий л орчлон ертөнц даяар байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэхэд энэхүү баримтыг ашиглана. Ажлын энэ үе шат бэлгэдлийн чанартай: Энэ эрин үеийн ажил дуусмагц зургаан мянган жилийн удирдлагын ажил бүрмөсөн төгсөнө. Хамгийн харанхуй газарт байгаа хүмүүс байлдан дагуулагдмагц хаа сайгүй ийм зүйл болно гэдэг нь илэрхий юм. Ийм болохоор зөвхөн Хятад дахь байлдан дагуулалтын ажил л утга учиртай бэлгэдлийг агуулдаг. Хятад улс харанхуйн бүх хүчийг илтгэдэг бөгөөд Хятадын ард түмэн нь Сатан, махан бие, мах цуснаас бүтсэн бүх хүнийг төлөөлдөг. Хятадын ард түмнийг агуу улаан луу хамгийн их завхруулсан, тэд Бурханыг хамгийн хүчтэй эсэргүүцдэг бөгөөд хүн чанар нь хамгийн олиггүй, ариун бус тул бүх завхарсан хүн төрөлхтний төлөөлөгч билээ. Бусад улс оронд ямар ч асуудал байхгүй гэж хэлж байгаа юм биш; хүний үзэл бүгд адилхан бөгөөд эдгээр улс орны хүмүүс сайн хэв чанартай байж болох хэдий ч хэрвээ Бурханыг мэддэггүй бол Түүнийг эсэргүүцдэг байж таарна. Яагаад иудейчүүд ч бас Бурханыг эсэргүүцэж, сөрсөн бэ? Яагаад фарисайчууд ч бас Түүнийг эсэргүүцсэн бэ? Яагаад Иудас Есүсээс урвасан бэ? Тэр үед шавь нарынх нь олонх нь Есүсийг мэдээгүй. Есүсийг цовдлогдож, дахин амилсны дараа ч яагаад хүмүүс Түүнд итгээгүй вэ? Хүний дуулгаваргүй байдал бүгд адилхан бус уу? Зүгээр л Хятадын ард түмнийг жишээ болгож байгаа ба байлдан дагуулагдах үедээ тэд үлгэр дуурайл, загвар болж, бусдад лавлагаа болох болно. Та нар бол Миний удирдлагын төлөвлөгөөний хавсралт гэж Би яагаад үргэлж хэлдэг вэ? Учир нь Хятадын ард түмэнд завхрал, бузар, шударга бус байдал, эсэргүүцэл, тэрслүү байдал хамгийн бүрэн дүүрэн илэрхийлэгдэж, янз бүрийн хэлбэрээрээ илчлэгддэг. Нэг талаас, тэд дорд хэв чанартай, нөгөө талаас, амьдрал, сэтгэлгээ нь хоцрогдмол, мөн зуршил, нийгмийн орчин, төрсөн гэр бүл нь бүгд ядуу дорд, хамгийн их хоцрогдсон байдаг. Тэдний байр суурь ч бас дорд. Энэ газарт хийж байгаа ажил бэлгэдлийн чанартай бөгөөд туршилтын энэ ажлыг бүхэлд нь хийж дуусгасны дараа

Бурханы дараагийн ажил хавьгүй илүү амархан байх болно. Хэрвээ ажлын энэ үе шатыг дуусгаж чадвал дараагийн ажлыг хэлэхийн ч хэрэггүй. Ажлын энэ үе шат гүйцэлдвэл агуу амжилтад бүрэн хүрч, бүхий л орчлон ертөнц даяарх байлдан дагуулалтын ажил бүрмөсөн төгсөнө. Үнэндээ, та нарын дундах ажил амжилттай болмогц энэ нь бүх орчлон ертөнц даяарх амжилттай тэнцүү байх болно. Би та нарыг үлгэр жишээ, загвар болгосны ач холбогдол энэ юм. Тэрслүү байдал, эсэргүүцэл, бузар бохир байдал, шударга бус байдал—энэ бүхэн нь энэхүү хүмүүст байдаг бөгөөд тэдэнд байдаг зүйл хүн төрөлхтний бүх тэрслүү байдлыг төлөөлдөг. Тэд үнэхээр амаргүй. Тиймээс тэднийг байлдан дагуулалтын загвар болгодог ба байлдан дагуулагдмагцаа тэд аяндаа бусдын үлгэр жишээ, загвар болно. Израильд хийгдсэн эхний үе шат хамгийн их бэлгэдлийн чанартай байсан: Израильчууд хамгийн ариун, хамгийн бага завхарсан хүмүүс байсан тул энэ газар нутагт шинэ эринийг эхлүүлэх нь дээд зэргийн ач холбогдолтой байлаа. Хүн төрөлхтний өвөг дээдэс Израильд үүссэн ба Израиль бол Бурханы ажлын өлгий нутаг байсан гэж хэлж болно. Эхэндээ энэ хүмүүс хамгийн ариун байж, бүгд Еховаг шүтэн мөргөж байсан бөгөөд тэдэн дэх Бурханы ажил хамгийн их үр дүн гаргаж чадсан. Библи нь бүхэлдээ хоёр эрин үеийн ажлыг тэмдэглэсэн байдаг: Нэг нь Хуулийн эрин үеийн ажил, нөгөө нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан юм. Хуучин гэрээ нь израильчуудад хэлсэн Еховагийн үгийг болон Израиль дахь Түүний ажлыг тэмдэглэсэн байдаг; Шинэ гэрээ нь Иудей дахь Есүсийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Гэхдээ Библид яагаад ямар ч хятад нэр байдаггүй вэ? Бурханы ажлын эхний хоёр хэсэг Израильд хийгдсэн учраас, Израилийн хүмүүс сонгогдсон хүмүүс байсан учраас—өөрөөр хэлбэл, тэд Еховагийн ажлыг хүлээн авах эхний хүмүүс байлаа. Тэд хүн төрөлхтнөөс хамгийн бага завхарсан нь байсан бөгөөд эхэндээ Бурханыг дээдэлж, хүндлэх сэтгэлтэй байсан юм. Тэд Еховагийн үгийг дуулгавартай дагаж, үргэлж сүмд үйлчилж, тахилчийн өмсгөл юм уу титэм зүүдэг байв. Тэд Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн эртний хүмүүс, Түүний ажлын хамгийн эртний бай байлаа. Энэ хүмүүс бүх хүн төрөлхтний үлгэр дуурайл, загвар байв. Тэд бол ариун байдал, зөв шударга хүмүүсийн үлгэр дуурайл, загвар байсан юм. Иов, Абрахам, Лот, Петр, Тимот гэх мэтийн хүмүүс бүгд израильчууд байсан ба хамгийн ариун үлгэр дуурайл, загвар байлаа. Израиль нь хүн төрөлхтний дундаас Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн анхны улс орон байсан бөгөөд зөв шударга хүмүүс өөр хаанаас ч илүүтэйгээр эндээс төрөн гарчээ. Ирээдүйд бүх газар нутаг даяарх хүн төрөлхтнийг илүү сайн

удирдахын тулд Бурхан тэдэн дээр ажилласан. Тэдний ололт амжилт, Еховаг шүтэн мөргөсөн зөв шударга үйл хэрэг тэмдэглэгдсэн, ингэснээр тэд Нигүүлслийн эрин үед Израилиас цааших газар нутгийн хүмүүст үлгэр дуурайл, загвар болж чадах байв; тэдний үйлдэл өнөөдрийг хүртэл хэдэн мянган жилийн ажлыг хадгалсан юм.

Дэлхийг бүтээсний дараа Бурханы ажлын эхний үе шат Израильд хийгдсэн, тиймээс Израиль нь газар дээрх Бурханы ажлын төрсөн нутаг, газар дээрх Бурханы ажлын бааз байсан юм. Есүсийн ажлын цар хүрээ Иудейг бүхэлд нь хамарсан. Есүс Иудейн гадна ямар ч ажил хийгээгүй учраас Түүний ажлын үеэр Иудейн гаднах тун цөөхөн хүн энэ талаар мэдсэн юм. Өнөөдөр Бурханы ажлыг Хятадад авчирсан бөгөөд энэ нь гагцхүү энэ цар хүрээн дотор л хийгддэг. Энэ үед ямар ч ажил Хятадын гадна эхлээгүй; Хятадаас цааш түгэх явдал бол дараа нь хийгдэх ажил юм. Ажлын энэ үе шат Есүсийн ажлын үе шатнаас үргэлжлүүлэн явдаг. Есүс золин авралын ажил хийсэн бөгөөд энэ үе шат нь тэрхүү ажлаас үргэлжлэн хийгдэж байгаа ажил; золин авралын ажил гүйцэлдсэн бөгөөд энэ үе шатанд Ариун Сүнснээс үр тогтох хэрэггүй учир нь ажлын энэ үе шат өмнөх үе шаттай адилгүй, цаашлаад Хятад бол Израильтай адилгүй. Есүс золин авралын ажлын нэг үе шатыг гүйцэтгэсэн. Хүн Есүсийг харсан ба удалгүй Түүний ажил Харь үндэстнүүдэд түгэж эхэлсэн юм. Өнөөдөр Америк, Нэгдсэн Вант улс болон Орост Бурханд итгэдэг олон хүн байдаг, тэгвэл яагаад Хятадад, итгэдэг хүн цөөхөн байдаг юм бэ? Учир нь Хятад бол хамгийн хаалттай үндэстэн юм. Тийм болохоор Хятад орон Бурханы замыг хамгийн сүүлд хүлээн зөвшөөрсөн ба одоо ч гэсэн тэгснээс нь хойш зуу хүрэхгүй жил болж байна—энэ нь Америк болон Нэгдсэн Вант улсаас хавьгүй сүүлд болсон юм. Өөрийн ажлыг төгсгөхийн тулд, Өөрийн бүх ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Бурханы ажлын сүүлчийн үе шат Хятадын газар нутагт хийгдсэн. Израиль дахь хүмүүс бүгд Еховаг өөрсдийн Эзэн гэж дуудаж байсан. Тухайн үед тэд Түүнийг гэр бүлийнхээ тэргүүн нь гэж үзэж байсан бөгөөд бүхий л Израиль нь, хүн бүхэн өөрсдийн Эзэн Еховаг шүтэн биширсэн асар том гэр бүл болсон юм. Еховагийн Сүнс тэдэнд үргэлж харагдаж, тэдэнтэй ярилцаж, Өөрийн дуу хоолойг айлдсан бөгөөд тэдний амьдралыг залж чиглүүлэхийн тулд үүлэн багана болон дуу чимээг ашигласан. Тухайн үед Сүнс Өөрийн удирдамжийг Израильд шууд өгч, Өөрийн дуу хоолойгоор хүмүүстэй ярьж, айлдаж байсан бөгөөд тэд үүл харж, аянгын нүргээнийг сонссон, ийм маягаар Тэр тэдний амьдралыг хэдэн мянган жилийн турш залж чиглүүлсэн юм. Тиймээс Израилийн ард түмэн л Еховад

үргэлж шүтэн мөргөсөн. Ехова бол тэдний Бурхан бөгөөд Харь үндэстнүүдийн Бурхан биш гэж тэд итгэдэг. Энэ нь гайхмаар зүйл биш: эцсийн эцэст Ехова тэдний дунд бараг 4,000 жилийн турш ажилласан. Хятадын газар нутагт хэдэн мянган жилийн турш үхсэн мэт унтсаныхаа дараа, тэнгэр газар, бүх зүйл аяндаа бий болоогүй, харин Бүтээгч бүтээсэн гэдгийг доройтмол хүмүүс одоо л мэдэж эхэлсэн. Энэхүү сайн мэдээ хилийн чанадаас ирсэн учраас энэ сайн мэдээг хүлээн зөвшөөрдөг бүх хүн тэрслүү бөгөөд тэд бол өөрсдийнхөө өвөг дээдэс болох Буддагаас урвасан өөдгүй амьтад гэж феодалын эсэргүү үзэлтнүүд итгэдэг. Түүнчлэн, эдгээр феодалын үзэл санаатай хүмүүсийн олонх нь: “Хятад хүмүүс яаж гадныхны Бурханд итгэж болох юм бэ? Тэд өвөг дээдсээсээ урваж байгаа бус уу? Тэд мууг үйлдэж байгаа бус уу?” гэж асуудаг. Ехова бол өөрсдийнх нь Бурхан гэдгийг өнөөдөр хүмүүс аль хэдийн мартчихсан. Тэд Бүтээгчийг аль эрт умартсан бөгөөд оронд нь, хүн бичнээс үүссэн ба байгаль ертөнц жамаараа бий болсон гэх утгатай хувьслын онолд итгэдэг. Мөн хүн төрөлхтний эдэлж хэрэглэдэг сайн хоол хүнсийг бүгдийг нь байгаль хангадаг, хүний амьдрал, үхэлд дэг журам байдаг бөгөөд энэ бүхнийг захирдаг Бурхан оршин байдаггүй гэж итгэдэг. Түүнчлэн, Бурхан бүх зүйлийг захирдаг гэдэг нь мухар сүсэг бөгөөд шинжлэх ухаанч биш гэж хэлдэг бурхангүй үзэлтнүүд олон бий. Гэхдээ шинжлэх ухаан Бурханы ажлыг орлож чадах уу? Шинжлэх ухаан хүн төрөлхтнийг захирч чадах уу? Бурхангүй үзэлд захирагддаг улс оронд сайн мэдээ тунхаглах нь амаргүй ажил бөгөөд асар их саад бартаа агуулдаг. Өнөөдөр ийм маягаар Бурханыг эсэргүүцдэг хүмүүс олон байгаа бус уу?

Есүсийг ажлаа хийхээр ирэх үед олон хүн Түүний ажлыг Еховагийн ажилтай харьцуулж, нийцэлгүй зүйл олоод Есүсийг загалмайд цовдолсон. Тэд яагаад Тэдний ажлаас ямар ч нийцэл олоогүй вэ? Нэг талаараа энэ нь Есүс шинэ ажил хийснээс болсон, бас Есүсийг ажлаа эхлэхээс өмнө хэн ч Түүний угийн бичгийг бичээгүй байснаас болсон. Хэн нэгэн бичсэн бол сайн байх байсан—тэгсэн бол хэн Есүсийг загалмайд цовдлох юм бэ? Хэрвээ Матай хэдэн арван жилийн өмнө Есүсийн угийн бичгийг бичсэн бол Есүс тийм их хавчлага амсахгүй байх байсан юм. Тийм биз дээ? Есүсийн угийн бичгийг—Тэр бол Абрахамын хүү, мөн Давидын удам—гэдгийг уншмагцаа хүмүүс Түүнийг хяхан хавчихаа болих байв. Түүний угийн бичгийг хэтэрхий орой бичсэн нь харамсалтай биш гэж үү? Харамсалтай зүйл юу вэ гэхээр Библи Бурханы ажлын хоёр үе шатыг л тэмдэглэсэн байдаг: нэг үе шат нь Хуулийн эрин үеийн ажил, нөгөө нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан; нэг үе шат нь Еховагийн ажил, нөгөө нь

Есүсийн ажил байсан. Хэрвээ агуу эш үзүүлэгч өнөөдрийн ажлыг зөгнөчихсөн байсан бол хэчнээн сайн байх сан билээ. Библид “Эцсийн өдрүүдийн ажил” гэсэн гарчигтай нэмэлт хэсэг байсан бол—тэр нь хавьгүй дээр байх байсан бус уу? Яагаад хүн өнөөдөр маш их зовлон бэрхшээлд өртөх ёстой юм бэ? Та нар үнэхээр хүнд хэцүү үеийг туулсан! Хэрвээ хэн нэгэн үзэн ядуулах учиртай бол эцсийн өдрүүдийн ажлыг зөгнөөгүйнхээ төлөө Исаиа, Даниел хоёр, хэн нэгэн буруутгагдах ёстой бол хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы угийн бичгийг арай эрт жагсаан бичээгүй Шинэ гэрээний элч нар байдаг. Ямар ичгүүртэй хэрэг вэ! Та нар хаа сайгүй нотлох баримт хайх хэрэгтэй бөгөөд үгийн жаахан хэлтэрхий олсныхоо дараа ч тэдгээр нь үнэхээр нотолгоо мөн эсэхийг таньж чаддаггүй. Ямар ичмээр юм бэ! Бурхан Өөрийнхөө ажилд яагаад ийм нууцлаг байдаг юм бэ? Өнөөдөр олон хүн нотлох баримт хараахан олоогүй ч бас үүнийг үгүйсгэж чаддаггүй. Тэгвэл тэд юу хийх ёстой вэ? Тэд Бурханыг шийдэмгийгээр дагаж чаддаггүй, гэхдээ бас тийм эргэлзээтэйгээр урагш явж ч чаддаггүй. Иймээс олон “ухаалаг, авьяастай эрдэмтэн” Бурханыг дагах үедээ “оролдоод үзэх” хандлага өвөрлөдөг. Энэ нь хэтэрхий төвөгтэй! Хэрвээ Матай, Марк, Лук, Иохан нар ирээдүйг зөгнөж чаддаг байсан бол юмс хавьгүй илүү амархан байх байсан бус уу? Иохан хаанчлал дахь амьдралын дотоод үнэнийг харсан бол илүү дээр байх байв—тэр зөвхөн үзэгдэл хараад, газар дээрх бодитой материаллаг ажлыг хараагүй нь хэчнээн харамсалтай билээ! Үнэхээр өрөвдөлтэй! Бурхан яачихаа вэ? Түүний ажил Израильд маш сайн явагдсаны дараа яагаад одоо Хятадад ирсэн юм бэ, бас яагаад махбод болж, хүмүүсийн дунд биечлэн ажиллаж, амьдрах хэрэгтэй болсон юм бэ? Бурхан үнэхээр хүнийг хайхардаггүй! Тэр хүмүүст урьдчилан хэлээгүйгээр үл барам, Өөрийн гэсгээлт, шүүлтийг гэнэтхэн авчирсан. Үнэхээр ойлгохын аргагүй! Бурхан анх махбод болохдоо бүх дотоод үнэнийг хүнд урьдчилан хэлээгүйнхээ улмаас ихээхэн бэрхшээл амссан. Тэр үүнийг мартсан байж таарахгүй биз дээ? Тэгвэл Тэр яагаад энэ удаа хүнд бас л хэлдэггүй юм бэ? Өнөөдөр Библид зөвхөн жаран зургаан ном байдаг нь хэчнээн золгүй хэрэг билээ дээ. Эцсийн өдрүүдийн ажлыг зөгнөсөн дахиад ганцхан ном хэрэгтэй байсан юм! Чи тэгж бодохгүй байна уу? Ехова, Исаиа, Давид нар ч өнөөдрийн ажлыг огт дурдаагүй. Тэд 4,000 орчим жилээр тусгаарлагдан өнөө үеэс улам цааш холдсон. Есүс ч гэсэн өнөөдрийн ажлыг бүрэн зөгнөөгүй, энэ талаар бага зэрэг л ярьсан бөгөөд хүн мөн л хангалтгүй нотолгоо олдог. Хэрвээ чи өнөөдрийн ажлыг өмнөхтэй харьцуулбал энэ хоёр бие биетэйгээ хэрхэн таарч тохирдог вэ? Еховагийн ажлын үе шат

Израиль руу чиглэж байсан, иймээс хэрвээ чи өнөөдрийн ажлыг үүнтэй харьцуулбал үл нийцэл бүр ч их байх болно; энэ хоёрыг ердөө харьцуулах аргагүй. Чи Израиль эсвэл Иудейнх биш; хэв чанар болон бүх зүйл чинь дутуу дулимаг—чи яаж өөрийгөө тэдэнтэй харьцуулж болох юм бэ? Энэ нь боломжтой юу? Өнөөдөр бол Хаанчлалын эрин үе гэдгийг мэдэж ав, энэ нь Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеэс өөр. Ямар ч тохиолдолд томъёо хэрэглэхээр бүү оролд; Бурханыг тийм ямар ч томъёоноос олж чадахгүй.

Есүс төрснөөсөө хойших 29 жилийн хугацаанд хэрхэн амьдарсан бэ? Түүний хүүхэд нас болон залуу насны талаар Библид юу ч тэмдэглээгүй байдаг; тэдгээр нь ямархуу байсныг чи мэдэх үү? Түүнд ямар ч хүүхэд нас, эсвэл залуу нас гэж байгаагүй ба төрөх үедээ л Тэр аль хэдийн 30 настай байсан байж болох уу? Чи дэндүү багыг мэддэг, иймээс өөрийн үзэл бодлоо хэлэхдээ хайхрамжгүй бүү бай. Энэ нь чамд ямар ч сайн зүйл болохгүй! Есүс 30 насныхаа төрсөн өдрөөс өмнө баптисм хүртэж, диаволын сорилтыг амсахын тулд цөл рүү Ариун Сүнсээр удирдуулсан гэдгийг л Библи тэмдэглэсэн байдаг. Мөн Дөрвөн Сайн мэдээ нь Түүний гурван жил хагасын ажлыг тэмдэглэсэн байдаг. Түүний хүүхэд нас болон залуу насны талаар ямар ч тэмдэглэл байдаггүй боловч Түүнд хүүхэд нас, залуу нас байгаагүй гэдгийг энэ нь нотолдоггүй; зүгээр л анх Тэр ямар ч ажил хийгээгүй бөгөөд хэвийн хүн байсан юм. Тэгвэл, Есүс залуу нас, эсвэл хүүхэд насгүйгээр 33 жил амьдарсан гэж та нар хэлэх үү? Тэр гэнэтхэн гучин гурван нас хагастай болсон байж болох уу? Түүний талаар хүний боддог бүхэн ер бусын, бодит бус байдаг. Бие махбодтой болсон Бурхан эгэл, хэвийн хүн чанарыг эзэмшдэг нь эргэлзээгүй боловч ажлаа хийхдээ бүрэн бус хүн чанар болон бүрэн бурханлаг чанараар шууд хийдэг. Үүний улмаас хүмүүс өнөөдрийн ажлын талаар, бүр Есүсийн ажлын талаар ч эргэлзээ өвөрлөдөг. Бурханы ажил хэдийгээр махбод болсон хоёр удаадаа ялгаатай байдаг боловч Түүний мөн чанар адилхан. Мэдээж хэрвээ чи Дөрвөн Сайн мэдээний тэмдэглэлийг унших юм бол ялгаа нь бүр их. Есүсийн хүүхэд нас болон залуу насны амьдралыг чи хэрхэн эргэн санах вэ? Чи Есүсийн хэвийн хүн чанарыг хэрхэн ойлгох вэ? Магадгүй чи өнөөдрийн Бурханы хүн чанарын талаар хүчтэй ойлголттой байж болох ч Есүсийн хүн чанарыг ухаардаггүй, тэр ч бүү хэл, үүнийг ойлгодоггүй. Хэрвээ Матай тэмдэглээгүй бол чамд Есүсийн хүн чанарын талаар ямар ч таамаг байхгүй байх байсан юм. Магадгүй Намайг Есүсийн амьдралын түүхийг ярьж, Есүсийн бага нас болон залуу насны дотоод үнэнийг хэлэх юм бол чи толгой сэгсрэн: “Үгүй! Тэр тийм байж таарахгүй. Түүнд ямар нэгэн сул тал байх

учиргүй, тэр ч байтугай, ямар нэгэн хүн чанар байх ёсгүй!” гэж хэлнэ. Чи бүр орилж, хашхирна. Чи Есүсийг ойлгодоггүй учраас л Миний талаар үзэлтэй байдаг. Есүс бол дэндүү бурханлаг, Түүнд бие махбодын юу ч байхгүй гэж чи итгэдэг. Гэхдээ баримт бол баримт хэвээр юм. Үнэн баримтуудыг үл хэрэгсэн ярихыг хэн ч хүсдэггүй, учир нь Намайг ярих үед энэ нь үнэнтэй холбоотой байдаг; энэ нь таамаглал ч биш, зөгнөл ч биш. Бурхан агуу өндөрт өгсөж чадна, түүнчлэн агуу гүнд нуугдаж чадна гэдгийг мэдэж ав. Тэр бол санаанаасаа зохиодог зүйл чинь биш—Тэрээр тодорхой нэг хүний бодож олсон хувийн Бурхан биш, бүх бүтээлийн Бурхан билээ.

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ (3)

Бурхан анх махбод болохдоо Ариун Сүнснээс олдсон бөгөөд энэ нь Түүний хийхээр зорьсон ажилтай холбоотой байлаа. Нигүүлслийн эрин үе Есүсийн нэрээр эхэлсэн юм. Есүсийг үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхэд Ариун Сүнс Есүсийн нэрийг гэрчилж эхэлсэн бөгөөд Еховагийн нэрийг хэлэхээ больсон; харин үүний оронд Ариун Сүнс үндсэндээ Есүсийн нэрийн дор шинэ ажил хийжээ. Түүнд итгэж байсан хүмүүсийн гэрчлэл Есүс Христийн төлөө хийгдсэн ба тэдний хийсэн ажил ч бас Есүс Христийн төлөө байлаа. Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийн төгсгөл нь үндсэндээ Еховагийн нэрийн дор явагдсан ажил дууссан гэсэн утгатай байв. Үүнээс хойш Бурханы нэр Ехова байхаа больсон; оронд нь Тэр Есүс гэж нэрлэгдсэн бөгөөд энэ үеэс эхлээд Ариун Сүнс үндсэндээ Есүсийн нэрийн дор ажил эхлүүлжээ. Иймээс өнөөдөр Еховагийн үгийг идэж, уусаар байгаа, мөн Хуулийн эрин үеийн ажлын дагуу бүхнийг хийсээр байгаа хүн—чи дүрэм журмыг сохроор мөрдөж байгаа бус уу? Чи өнгөрсөн үед гацчихаагүй гэж үү? Эцсийн өдрүүд ирсэн гэдгийг чи одоо мэднэ. Есүс ирэх үедээ Есүс гэж нэрлэгдсээр л байх юм гэж үү? Ехова Израилийн ард түмэнд Мессиа ирнэ гэж хэлсэн ч ирэх үедээ Тэрээр Мессиа биш, харин Есүс гэж нэрлэгдэж байв. Өөрөө дахин ирнэ, явсан шигээ ирнэ гэж Есүс хэлсэн. Эдгээр нь Есүсийн үг байсан боловч Есүс ямар байдлаар явсныг чи харсан уу? Есүс цагаан үүл хөлөглөн явж одсон, гэхдээ Тэр цагаан үүл хөлөглөн хүмүүсийн дунд биечлэн ирэх юм гэж үү? Хэрвээ тэгсэн бол Түүнийг Есүс гэж нэрлэсээр байх бус уу? Есүсийг дахин ирэх үед эрин үе аль хэдийн өөрчлөгдсөн байх тул Түүнийг Есүс гэж нэрлэсээр байж болох уу? Бурханыг зөвхөн Есүсийн нэрээр л мэдэж болох юм гэж үү? Түүнийг шинэ эрин үед шинэ нэрээр нэрлэж болохгүй гэж үү? Нэг хүний дүр төрх болон

тодорхой нэг нэр Бурханыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Эрин үе бүрд Бурхан шинэ ажил хийж, шинэ нэрээр нэрлэгддэг; Тэр яаж өөр өөр эрин үед адилхан ажил хийж чадах юм бэ? Тэр яаж хуучинтай зууралдаж чадах юм бэ? Есүсийн нэрийг золин авралын төлөө авсан, иймээс эцсийн өдрүүдэд эргэж ирэх үедээ Тэр адилхан нэрээр нэрлэгдсээр байх уу? Тэр золин авралын ажлыг хийсээр байх уу? Ехова, Есүс хоёр нэг атлаа яагаад өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгддэг юм бэ? Тэдний ажлын эрин үе ялгаатайгаас болдоггүй гэж үү? Ганц нэр Бурханыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Тийм болохоор Бурхан өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгдэх ёстой бөгөөд эрин үеийг өөрчилж, эрин үеийг төлөөлөхийн тулд нэр ашиглах ёстой. Учир нь нэг ч нэр Бурханыг Өөрийг нь бүрэн төлөөлж чадахгүй бөгөөд нэр болгон тухайн эрин үе дэх цаг хугацааны талын Бурханы зан чанарыг л төлөөлж чаддаг; энэ нь Түүний ажлыг төлөөлдөг байхад л хангалттай. Тиймээс бүхий л эрин үеийг төлөөлөхийн тулд Бурхан Өөрийн зан чанарт тохирох ямар ч нэрийг сонгож болно. Еховагийн эрин үе, эсвэл Есүсийн эрин үе байх нь хамаагүй, эрин үе бүрийг нэр төлөөлдөг. Нигүүлслийн эрин үеийн төгсгөлд эцсийн эрин үе хүрэлцэн ирсэн бөгөөд Есүс аль хэдийн ирчихсэн. Түүнийг яаж Есүс гэж нэрлэсээр байж болох юм бэ? Тэр яаж хүмүүсийн дунд Есүсийн дүртэй хэвээр байж болох юм бэ? Есүс Назарын дүр төрхтэйгөөс цаашгүй байсныг чи мартчихав уу? Есүс хүн төрөлхтний Золин аврагч л байсныг чи мартчихсан уу? Эцсийн өдрүүдэд хүнийг байлдан дагуулж, төгс болгох ажлыг Тэр яаж хариуцаж чадах юм бэ? Есүс цагаан үүл хөлөглөн явсан—энэ бол баримт—гэхдээ Тэр яаж хүмүүсийн дунд цагаан үүлэн дээр эргэн ирж, Есүс гэж нэрлэгдсээр байж болох юм бэ? Хэрвээ Тэр үнэхээр үүлэн дээр ирсэн бол хүн яаж Түүнийг танихгүй байх юм бэ? Дэлхий дахины хүмүүс Түүнийг танихгүй гэж үү? Тэр тохиолдолд, Есүс ганцаараа Бурхан байх бус уу? Тэр тохиолдолд Бурханы дүр нь Иудей хүний төрх байх байсан бөгөөд түүнчлэн үүрд өөрчлөгдөхгүй байх байлаа. Явсан шигээ ирэх болно гэж Есүс хэлсэн боловч Түүний үгийн жинхэнэ утгыг чи мэдэх үү? Тэр энэ бүлэг хүмүүс та нарт хэлсэн юм гэж үү? Тэрээр үүл хөлөглөн явсан шигээ ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Бурхан Өөрөө ажлаа яг яаж хийдгийг мэдэх үү? Хэрвээ чи үнэхээр харж чаддаг байсан бол Есүсийн хэлсэн үгийг хэрхэн тайлбарлах вэ? Тэрээр: Эцсийн өдрүүдэд хүний Хүүг ирэхэд Тэр Өөрөө мэдэхгүй, тэнгэрэлчүүд мэдэхгүй, тэнгэр дэх элчүүд мэдэхгүй, бүх хүн мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ, өөрөөр хэлбэл, Сүнс л мэднэ гэж хэлсэн юм. Хүний Хүү Өөрөө ч мэдэхгүй атал чи харж, мэдэж чадна гэж үү? Хэрвээ чи мэдэх, нүдээрээ харах чадвартай байсан бол эдгээр

үгийг хий дэмий хэлсэн юм биш үү? Тухайн үед Есүс юу гэж хэлсэн бэ? “Харин тэр өдөр цагийг хэн ч мэдэхгүй, тэнгэрийн тэнгэрэлчүүд ч мэдэхгүй, Хүү ч мэдэхгүй, зөвхөн Миний Эцэг л мэднэ. Гэхдээ хүний Хүүгийн ирэлт нь ч бас Ноагийн өдрүүд шиг байх болно... Тиймээс та нар бас бэлэн бай. Хүний Хүү та нарын бодоогүй цаг мөчид ирнэ.” Тэр өдөр ирэхэд хүний Хүү Өөрөө ч мэдэхгүй. Хүний Хүү гэдэг нь Бурханы махбод болсон биеийг, хэвийн агаад эгэл жирийн хүнийг хэлдэг. Хүний Хүү Өөрөө ч мэддэггүй, тэгвэл чи яаж мэдэж чадах юм бэ? Явсан шигээ ирнэ гэж Есүс хэлсэн. Ирэх үедээ Тэр Өөрөө ч мэдэхгүй, тэгвэл Тэр чамд урьдчилан мэдэгдэж чадах уу? Чи Түүний ирэхийг харж чадах уу? Тэр нь инээдтэй хэрэг биш үү? Бурхан газар дээр ирэх бүрдээ Өөрийн нэр, хүйс, дүр төрх болон ажлыг өөрчилдөг; Тэр Өөрийн ажлыг давтдаггүй. Тэр бол үргэлж шинэ агаад хэзээ ч хуучин байдаггүй Бурхан билээ. Өмнө нь ирэх үедээ Тэр Есүс гэж нэрлэгддэг байв; энэ удаа дахин ирэх үедээ Тэр Есүс гэж нэрлэгдсээр байж болох уу? Өмнө нь ирэх үедээ Тэр эрэгтэй байсан; энэ удаа Тэр дахиад эрэгтэй байж болох уу? Нигүүлслийн эрин үед ирэхдээ Түүний ажил нь загалмайд цовдлогдох явдал байсан; дахин ирэх үедээ Тэр мөн л хүн төрөлхтнийг нүглээс золин аварч болох уу? Тэр дахин загалмайд цовдлогдож болох уу? Тэгэх нь Өөрийн ажлыг давтаж байгаа хэрэг болох бус уу? Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүйг чи мэдэхгүй гэж үү? Бурхан хувиршгүй гэж хэлдэг хүмүүс бий. Тэр зөв, гэхдээ энэ нь Бурханы зан чанар болон мөн чанарын хувиршгүй байдлыг хэлдэг. Түүний нэр болон ажилд гарсан өөрчлөлт нь Түүний мөн чанар өөрчлөгдсөн гэдгийг нотолдоггүй; өөрөөр хэлбэл, Бурхан үргэлж Бурхан байх бөгөөд энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханы ажил өөрчлөгдөшгүй гэж хэлбэл зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө Тэр дуусгаж чадах байсан уу? Бурхан үүрд өөрчлөгдөшгүй гэдгийг л чи мэднэ, гэхдээ Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш гэдгийг чи мэдэх үү? Хэрвээ Бурханы ажил өөрчлөгдөшгүй юм бол Тэр хүн төрөлхтнийг өнөөг хүртэл удирдаж чадах байсан гэж үү? Хэрвээ Бурхан хувиршгүй юм бол Тэр яагаад хоёр эрин үеийн ажлыг аль хэдийн хийчихсэн юм бэ? Түүний ажил урагшлахаа хэзээ ч больдоггүй, өөрөөр хэлбэл, Түүний зан чанар хүнд аажмаар илчлэгддэг бөгөөд илчлэгддэг зүйл нь Түүний төрөлх зан чанар юм. Анх Бурханы зан чанар хүнээс нуугдмал байсан, Тэр Өөрийн зан чанарыг хүнд хэзээ ч ил тод илчилж байгаагүй бөгөөд хүн Түүний талаар огт мэддэггүй байсан. Үүнээс болоод Тэр зан чанараа хүнд аажмаар илчлэхийн тулд Өөрийн ажлыг ашигладаг боловч ийм маягаар ажиллах нь Бурханы зан чанар эрин үе бүрд

өөрчлөгддөг гэсэн үг биш юм. Бурханы хүсэл үргэлж өөрчлөгдөж байгаа учраас зан чанар нь байнга өөрчлөгдөж байдаг юм биш. Харин ч Түүний ажлын эрин үеүд өөр өөр байдгаас болоод Бурхан, хүн Өөрийг нь мэддэг болж чадах байх гэсэндээ Өөрийн төрөлх зан чанарыг бүхэлд нь аваад, хүнд алхам алхмаар илчилдэг. Гэхдээ энэ нь, Бурхан анх ямар ч тодорхой зан чанаргүй байсан, эсвэл эрин үе өөрчлөгдөхийн хэрээр Түүний зан чанар аажмаар өөрчлөгдсөн гэдгийн нотолгоо яавч биш—ийм ойлголт нь андуу ташаа юм. Өөр өөр эрин үеийн дагуу Бурхан Өөрийн төрөлхийн болон тодорхой зан чанарыг—Тэр юу болохоо хүнд илчилдэг; ганц эрин үеийн ажил Бурханы бүх зан чанарыг илэрхийлж чадахгүй. Иймээс “Бурхан үргэлж шинэ агаад хэзээ ч хуучин биш” хэмээх үг нь Түүний ажлыг хэлдэг бөгөөд “Бурхан хувиршгүй” хэмээх үг нь Бурханд төрөлхөөсөө юу байгаа, Тэр юу болохыг хэлдэг. Ямартай ч чи зургаан мянган жилийн ажлыг ганц зүйлд хамааруулж болохгүй, эсвэл үхмэл үгээр хязгаарлаж болохгүй. Энэ нь хүний тэнэглэл юм. Бурхан хүний төсөөлдөг шиг энгийн биш бөгөөд Түүний ажил аль нэг эрин үед саатаж болохгүй. Жишээ нь, Ехова гэдэг нэр үүрд Бурханы нэр байж болохгүй; Бурхан Өөрийн ажлыг Есүсийн нэрээр ч бас хийж чадна. Энэ бол Бурханы ажил үргэлж урагш ахиж байдгийн тэмдэг билээ.

Бурхан бол үргэлж Бурхан бөгөөд хэзээ ч Сатан болохгүй; Сатан бол үргэлж Сатан ба хэзээ ч Бурхан болохгүй. Бурханы мэргэн ухаан, Бурханы гайхалтай байдал, Бурханы зөвт байдал, Бурханы сүр жавхлан хэзээ ч өөрчлөгдөхгүй. Түүний мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Харин Түүний ажлын тухайд бол, энэ нь үргэлж урагшилж, үргэлж гүнзгийрч байдаг, учир нь Тэр бол үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш билээ. Эрин үе болгонд Бурхан шинэ нэр авдаг, эрин үе бүрд Тэр шинэ ажил хийдэг, эрин үе бүрд Тэрээр бүтээлүүддээ Өөрийн шинэ хүсэл, шинэ зан чанарыг харуулдаг. Хэрвээ шинэ эрин үед хүмүүс Бурханы шинэ зан чанарын илэрхийллийг харж чадахгүй бол Түүнийг загалмайд үүрд цовдлохгүй гэж үү? Ингэснээрээ тэд Бурханыг хязгаарлахгүй гэж үү? Хэрвээ Бурхан зөвхөн эрэгтэй болж махбодод ирсэн бол хүмүүс Түүнийг эрэгтэй гэж, эрэгтэй хүмүүсийн Бурхан гэж хязгаарлах байсан бөгөөд Тэр бол эмэгтэйчүүдийн Бурхан гэдэгт хэзээ ч итгэхгүй байх байв. Эрэгтэйчүүд тэгээд, Бурхан бол эрэгтэй хүмүүстэй адилхан хүйстэй, Бурхан бол эрэгтэйчүүдийн тэргүүн гэж үзэх байлаа—тэгвэл эмэгтэйчүүд яах вэ? Энэ бол шударга бус; энэ нь ялгаварласан хандлага биш гэж үү? Хэрвээ тийм байсан бол Бурханы аварсан хүмүүс бүгд Түүнтэй адил эрэгтэй байх

байсан бөгөөд ганц ч эмэгтэй хүн аврагдахгүй байх байсан юм. Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ Адамыг бүтээсэн, мөн Еваг бүтээсэн. Тэрээр Адамыг бүтээснээр үл барам, эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь Өөрийнхөө дүрээр бүтээсэн юм. Бурхан зөвхөн эрэгтэйчүүдийн Бурхан биш—Тэр бас эмэгтэйчүүдийн Бурхан. Бурхан эцсийн өдрүүд дэх ажлын шинэ үе шатанд орсон. Тэрээр Өөрийн зан чанарыг улам их илчлэх бөгөөд энэ нь Есүсийн цаг үеийн энэрэл, хайр биш байх болно. Түүнд шинэ ажил байгаа тул энэ шинэ ажлыг шинэ зан чанар дагалдана. Иймээс хэрвээ энэ ажлыг Сүнс хийсэн бол—хэрвээ Бурхан махбод болоогүй, харин оронд нь Сүнс аянгын дуугаар дамжуулан шууд ярьж, хүн Түүнтэй харилцах ямар ч аргагүй байсан бол хүн Түүний зан чанарыг мэдэж чадах байсан уу? Хэрвээ ажлыг гагцхүү Сүнс хийсэн бол хүн Бурханы зан чанарыг мэдэж авах ямар ч аргагүй байх байлаа. Бурханыг махбод болох үед, Үг махбодоор илрэх үед л хүмүүс Бурханы зан чанарыг нүдээрээ харж чадах бөгөөд Тэр Өөрийн бүх зан чанарыг махбодоор илэрхийлдэг. Бурхан үнэхээр, жинхэнээсээ хүмүүсийн дунд амьдардаг. Тэр бол биет; хүн Түүний зан чанартай бодитоор харилцаж, Түүнд юу байгаа, Тэр юу болохтой харилцаж чадна; зөвхөн ийм маягаар л хүн Түүнийг үнэхээр мэдэж авч чадна. Үүний зэрэгцээ Бурхан бас “Бурхан бол эрэгтэйчүүдийн Бурхан, мөн эмэгтэйчүүдийн Бурхан” гэх ажлыг гүйцэлдүүлж, махбод дахь ажлаа бүхэлд нь гүйцэтгэсэн юм. Тэр ямар ч эрин үед ажлыг давхардуулдаггүй. Эцсийн өдрүүд ирчихсэн тул Тэр эцсийн өдрүүдэд хийдэг ажлаа хийх бөгөөд эцсийн өдрүүд дэх бүхий л зан чанараа илчилдэг. Эцсийн өдрүүдийн тухай ярих юм бол, энэ нь тусдаа эрин үеийг хэлдэг, Есүсийн хэлснээр энэ эрин үед та нарт гарцаагүй гамшиг тулгарч, газар хөдлөлт, өлсгөлөн, тахал тулгарах бөгөөд хуучны Нигүүлслийн эрин үе байхаа болиод, шинэ эрин үе иржээ гэдгийг энэ нь харуулна. Хүмүүсийн хэлдгээр Бурхан үүрд өөрчлөгдөшгүй, зан чанар нь үргэлж өршөөнгүй агаад хайр энэрэлтэй, хүнийг Өөр шигээ хайрладаг, хүн бүрд аврал өгч, хүнийг хэзээ ч үзэн яддаггүй байсан бол Түүний ажил ер нь дуусаж чадах байсан уу? Есүс ирж, загалмайд цовдлогдон, бүх нүгэлтний төлөө Өөрийгөө золиосолж, тахилын ширээн дээр Өөрийгөө өргөл болгохдоо золин авралын ажлыг аль хэдийн гүйцэлдүүлж, Нигүүлслийн эрин үеийг төгсгөсөн юм. Тэгвэл тэр эрин үеийн ажлыг эцсийн өдрүүдэд давтах нь ямар хэрэгтэй юм бэ? Нэг зүйлээ хийх нь Есүсийн ажлыг үгүйсгэсэн хэрэг бус уу? Хэрвээ Бурхан энэ үе шатанд ирэхдээ цовдлолын ажил хийгээгүй боловч хайр энэрэлтэй, өршөөнгүй хэвээр үлдсэн бол эрин үеийг төгсгөж чадах байсан уу? Хайр энэрэлтэй,

өршөөнгүй Бурхан эрин үеийг төгсгөж чадах байсан уу? Эрин үеийг төгсгөх эцсийн ажилд Бурханы зан чанар нь гэсгээлт, шүүлтийн зан чанар байдаг бөгөөд Тэрээр бүх хүнийг ил тод шүүж, Өөрийг нь чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүсийг төгс болгохын тулд зөв шударга бус бүхнийг илчилдэг. Зөвхөн ийм зан чанар л эрин үеийг төгсгөж чадна. Эцсийн өдрүүд аль хэдийн ирчихсэн. Бүтээлийн бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдаж, уг чанарынхаа үндсэн дээр өөр өөр төрөлд хуваагдана. Энэ бол Бурхан хүмүүсийн төгсгөлийг, мөн хүрэх газрыг илчилдэг мөч юм. Хэрвээ хүмүүс гэсгээлт, шүүлт туулахгүй бол дуулгаваргүй байдал болон зөв шударга бус байдлыг нь ил болгох ямар ч аргагүй байх болно. Гэсгээлт, шүүлтээр л бүх бүтээлийн төгсгөлийг илчилж болно. Гэсгээгдэж, шүүгдэх үедээ л хүн жинхэнэ төрхөө харуулдаг. Мууг нь муутай, сайныг нь сайнтай тавих бөгөөд бүх хүн төрлийнхөө дагуу ангилагдана. Гэсгээлт, шүүлтээр дамжуулан бүх бүтээлийн төгсгөл илчлэгдэнэ, ингэснээр муу нь шийтгүүлж, сайн нь шагнуулж, бүх хүн Бурханы эрх мэдэлд харьяалагдаж болох юм. Энэ бүх ажил зөв шударга гэсгээлт, шүүлтээр хийгдэх ёстой. Хүний завхрал дээд цэгтээ хүрч, дуулгаваргүй байдал нь хэтэрхий ноцтой болсон учраас үндсэндээ гэсгээлт, шүүлтээс бүрддэг, эцсийн өдрүүдэд илчлэгддэг Бурханы зөвт зан чанар л хүнийг бүрмөсөн өөрчилж, бүрэн төгс болгож чадна. Энэ зан чанар л мууг ил болгож, улмаар зөв шударга бус бүхнийг хатуу шийтгэж чадна. Тиймээс ийм зан чанарт эрин үеийн ач холбогдол шингэсэн байдаг бөгөөд Түүний зан чанарын илчлэл болон илрэл нь шинэ эрин үе бүрийн ажлын төлөө илэрхийлэгддэг. Бурхан Өөрийн зан чанарыг дур зоргоороо, ач холбогдолгүйгээр илчилдэг юм биш. Эцсийн өдрүүдэд хүний төгсгөлийг илчлэхдээ Бурхан хүнд хязгааргүй өршөөл, хайр харуулж, түүнийг үргэлжлүүлэн хайрлаж, хүнд зөвт шүүлт хүртээхгүй, харин ч хүлээцтэй байдал, тэвчээр, уучлал үзүүлж, нүгэл нь хэчнээн ноцтой байсан ч өчүүхэн ч зөвт шүүлтгүйгээр хүнийг өршөөсөөр байсан бол Бурханы бүх удирдлага хэзээ ер нь дуусах юм бэ? Ийм зан чанар хэзээ хүмүүсийг хүн төрөлхтөнд тохирох хүрэх газар луу хөтөлж чадах юм бэ? Жишээлбэл, үргэлж бусдыг хайрладаг, эелдэг царай, зөөлөн зүрх сэтгэлээр шүүдэг шүүгчийг аваад үз. Тэрээр, үйлдсэн нүглээс нь үл хамааран хүмүүсийг хайрладаг ба хэн ч байлаа гэсэн, хайр энэрэлтэй, тэвчээртэй ханддаг. Тийм тохиолдолд тэр хэзээ ер нь шударга ялын тогтоол гаргаж чадах юм бэ? Эцсийн өдрүүдийн үеэр зөвт шүүлт л хүнийг төрлөөр нь ангилж, шинэ ертөнцөд аваачиж чадна. Ийм маягаар, Бурханы шүүлт, гэсгээлтийн зөвт зан чанараар дамжуулан бүхий л эрин үе төгсдөг.

Бурханы бүх удирдлага дахь ажил тов тодорхой байдаг: Нигүүлслийн эрин үе бол Нигүүлслийн эрин үе, эцсийн өдрүүд бол эцсийн өдрүүд юм. Эрин үе бүрийн хооронд тодорхой ялгаа байдаг, учир нь эрин үе бүрд Бурхан, тухайн эрин үеийг төлөөлөх ажлыг хийдэг. Эцсийн өдрүүдийн ажил хийгдэхийн тулд эрин үеийг төгсгөлд нь аваачих шатаалт, шүүлт, гэсгээлт, уур хилэн, сүйрэл байх ёстой. Эцсийн өдрүүд гэж сүүлчийн эрин үеийг хэлдэг. Сүүлчийн эрин үед Бурхан эрин үеийг төгсгөхгүй гэж үү? Эрин үеийг төгсгөхийн тулд Бурхан гэсгээлт, шүүлт авчрах ёстой. Ийм маягаар л Тэр эрин үеийг төгсгөж чадна. Есүсийн зорилго нь хүнийг үргэлжлүүлэн амьд үлдээж, амьдруулж, илүү дээр байдлаар оршин тогтноулахын төлөө байсан юм. Тэрээр хүний доройтохыг болиулж, Үхэгсдийн орон болон тамд амьдрахыг нь болиулахын тулд нүглээс аварсан бөгөөд хүнийг Үхэгсдийн орон болон тамаас аварснаараа Есүс үргэлжлүүлэн амьдрах боломжийг хүнд олгосон билээ. Одоо эцсийн өдрүүд ирчихсэн. Бурхан хүнийг устгаж, хүн төрөлхтнийг бүрмөсөн сүйрүүлнэ, өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний тэрслүү байдлыг өөрчилнө. Энэ шалтгааны улмаас, урьдын өршөөнгүй, хайр энэрэлтэй зан чанараар Бурхан эрин үеийг төгсгөх юм уу зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө биелүүлэх боломжгүй байх байв. Эрин үе бүрд онцгой төлөөлөх зан чанар байдаг ба эрин үе бүр Бурханы хийх ёстой ажлыг агуулдаг. Иймээс, эрин үе бүрд Бурханы Өөрийн хийдэг ажил жинхэнэ зан чанарынх нь илэрхийллийг агуулдаг бөгөөд Түүний нэр болон Түүний хийдэг ажил хоёулаа эрин үеийн хамтаар өөрчлөгддөг— тэдгээр нь бүгд шинэ байдаг. Хуулийн эрин үед хүн төрөлхтнийг залж чиглүүлэх ажил Еховагийн нэрийн дор хийгдсэн бөгөөд ажлын эхний үе шат газар дээр хийгдсэн. Энэ үе шатны ажил нь сүм болон тахилын ширээ барих, мөн Израилийн ард түмнийг залж чиглүүлж, тэдний дунд ажиллахын тулд хууль ашиглахаас бүрдэж байв. Израилийн ард түмнийг залж чиглүүлснээр Тэр газар дээрх Өөрийн ажлын суурийг тавьсан юм. Энэ суурин дээрээс Тэр Өөрийн ажлыг Израилиас цааш өргөжүүлсэн, өөрөөр хэлбэл, Израилиас эхлээд Өөрийн ажлыг гадагш тэлсэн, ингэснээр хожмын үеийнхэн, Ехова бол Бурхан бөгөөд тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн, мөн Ехова бүх бүтээлийг бүтээсэн гэдгийг мэдэж авсан билээ. Израилийн ард түмнээр дамжуулан Тэрээр Өөрийн ажлыг тэднээс цааш түгээсэн юм. Израилийн газар нутаг Еховагийн газар дээрх ажлын анхны ариун газар байсан бөгөөд Израилийн газар нутагт Бурхан анх ажиллахаар очжээ. Тэр нь Хуулийн эрин үеийн ажил байв. Нигүүлслийн эрин үед Есүс хүнийг аварсан Бурхан байлаа. Түүнд юу байсан, Тэр юу болох нь

нигүүлсэл, хайр, энэрэл, өршөөл, тэвчээр, даруу төлөв байдал, халамж, хүлээцтэй байдал байсан бөгөөд Түүний хийсэн ажлын дийлэнх нь хүнийг золин аврахын төлөө байв. Түүний зан чанар энэрэл, хайрын зан чанар байсан ба Тэр энэрэнгүй, элэгсэг байсан учраас тэдний төлөө Өөрийгөө бүхэлд нь өргөл болгож чадах хэмжээнд Бурхан хүнийг Өөр шигээ хайрладаг гэдгийг харуулахын тулд хүний төлөө загалмайд цовдлогдох ёстой болсон юм. Нигүүлслийн эрин үед Бурханы нэр Есүс байсан, өөрөөр хэлбэл, Бурхан бол хүнийг аварсан Бурхан байсан бөгөөд энэрэнгүй, элэгсэг Бурхан байв. Бурхан хүнтэй хамт байлаа. Түүний хайр, Түүний энэрэл, Түүний аврал хүн нэг бүрийг дагалджээ. Есүсийн нэрийг болон Түүнийг байгааг хүлээн авснаар л хүн амар амгалан, баяр хөөрийг олж авч, Түүний ерөөл, асар их, хэмжээлшгүй нигүүлсэл, авралыг хүртэж чадсан юм. Есүсийн цовдолоор дамжуулан Түүнийг дагаж байсан бүх хүн аврал хүртэж, нүглээ уучлуулжээ. Нигүүлслийн эрин үед Есүс гэдэг нь Бурханы нэр байлаа. Өөрөөр хэлбэл, Нигүүлслийн эрин үеийн ажил үндсэндээ Есүсийн нэрийн дор хийгдсэн юм. Нигүүлслийн эрин үед Бурханыг Есүс гэж нэрлэж байв. Тэрээр Хуучин Гэрээнээс даван гарсан шинэ ажлын үе шатыг хийсэн бөгөөд цовдлолын хамтаар Түүний ажил дуусчээ. Энэ нь бүхэлдээ Түүний ажил байв. Тиймээс Хуулийн эрин үед Ехова гэдэг нь Бурханы нэр байсан ба Нигүүлслийн эрин үед Есүсийн нэр Бурханыг төлөөлсөн юм. Эцсийн өдрүүдэд Түүний нэр бол Төгс Хүчит Бурхан—хүнийг залж чиглүүлж, байлдан дагуулж, олж авч, эцэст нь эрин үеийг төгсгөхийн тулд Өөрийн хүч чадлыг ашигладаг Төгс Хүчит билээ. Эрин үе бүрд, Түүний ажлын үе шат болгонд Бурханы зан чанар илэрхий байдаг.

Анх Хуучин Гэрээний Хуулийн эрин үед хүнийг залж чиглүүлэх нь хүүхдийн амьдралыг залж чиглүүлэхтэй адилхан байлаа. Анхны хүн төрөлхтөн Еховагаас дөнгөж төрсөн байв; тэд бол израильчууд байсан юм. Тэдэнд Бурханыг хэрхэн хүндлэх тухай, эсвэл газар дээр хэрхэн амьдрах талаар ямар ч ойлголт байсангүй. Өөрөөр хэлбэл, Ехова хүн төрөлхтнийг буюу Адам, Еваг бүтээсэн боловч тэдэнд Еховаг хэрхэн хүндэлж, газар дээр Еховагийн хуулийг хэрхэн дагах талаар ойлгох эрхтэн өгөөгүй байсан юм. Еховагийн шууд удирдамжгүйгээр хэн ч үүнийг шууд мэдэж чадаагүй, учир нь анх хүнд тийм эрхтэн байхгүй байв. Ехова бол Бурхан гэдгийг л хүн мэдэж байсан, харин Түүнийг хэрхэн хүндлэх, яаж биеэ авч явбал Түүнийг хүндэлж байгаад тооцогдох, ямар сэтгэлээр Түүнийг хүндлэх ёстой, эсвэл Түүнийг хүндлэхдээ юуг тахил болгох ёстойг хүн огт мэддэггүй байлаа. Еховагийн бүтээсэн бүх зүйлийн

дундаас эдэлж болох зүйлийг хэрхэн эдлэхээ л хүн мэддэг байсан, харин газар дээр чухам яаж амьдрах нь Бурханы бүтээл гэх нэрд зохих талаар огт мэддэггүй байв. Тэдэнд зааварлах хэн ч байхгүй бол, тэднийг биечлэн залж чиглүүлэх хэн ч байхгүй бол энэ хүн төрөлхтөн, хүмүүст зүй ёсоор тохирох амьдралаар хэзээ ч амьдрахгүй, харин үл анзаарагдам байдлаар Сатанд олзлогдсоор байх байсан юм. Ехова хүн төрөлхтнийг бүтээсэн, өөрөөр хэлбэл, Тэрээр хүн төрөлхтний өвөг дээдэс болох Адам, Еваг бүтээсэн боловч тэдэнд илүү их оюун ухаан, эсвэл мэргэн ухаан хайрлаагүй юм. Хэдий тэд аль хэдийн газар дээр амьдарч байсан ч бараг юу ч ойлгоогүй юм. Иймээс хүн төрөлхтнийг бүтээх Еховагийн ажлын хагас нь л дууссан бөгөөд бүрэн гүйцэлдээгүй байв. Тэрээр зөвхөн шорооноос хүний загварыг бүтээгээд Өөрийн амьсгалыг өгсөн боловч Өөрийг нь хүндлэх хангалттай хүсэл зоригийг хүнд хайрлаагүй юм. Анх хүнд Түүнийг хүндлэх, эсвэл Түүнээс эмээх оюун санаа байгаагүй. Хүн Түүний үгийг хэрхэн сонсохоо л мэддэг байсан боловч газар дээрх амьдрал болон хүний амьдралын хэвийн дүрэм журмын талаарх үндсэн мэдлэгийг мэддэггүй байлаа. Иймээс хэдийгээр Ехова эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээж, долоон өдрийн туурвилаа дуусгасан боловч хүнийг бүтээх үйлээ яавч бүрэн төгс болгоогүй, учир нь хүн гадаад бүрхүүл төдий байсан ба хүн байх бодит байдалгүй байлаа. Хүн төрөлхтнийг Ехова бүтээсэн гэдгийг л хүн мэддэг байсан боловч Еховагийн үгийг юм уу хуулийг хэрхэн мөрдөх талаар өчүүхэн ч мэддэггүй байв. Иймээс хүн төрөлхтөн бий болсны дараа Еховагийн ажил огтхон ч дуусах болоогүй байсан юм. Тэрээр хүн төрөлхтнийг Өөрийнхөө өмнө ирүүлэхийн тулд мөн л бүрэн залж чиглүүлэх хэрэгтэй байлаа, ингэснээр тэд газар дээр хамт амьдарч, Түүнийг хүндэлж чаддаг болж магад байсан ба Түүний удирдамжтайгаар газар дээрх хэвийн хүний амьдралын зөв замд орж магад байв. Ийм маягаар л үндсэндээ Еховагийн нэрийн дор явагдсан ажил бүрэн дууссан; өөрөөр хэлбэл, зөвхөн ийм маягаар л дэлхийг бүтээх Еховагийн ажил бүрэн дууссан юм. Иймээс, хүн төрөлхтнийг бүтээгээд Тэр хэдэн мянган жилийн турш газар дээрх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх хэрэгтэй болсон ба ийнхүү хүн төрөлхтөн Түүний зарлиг болон хуулийг мөрдөж, газар дээрх хэвийн хүний амьдралын бүх үйл ажиллагаанд оролцож чадах байсан юм. Тэр үед л Еховагийн ажил бүрэн дууссан. Хүн төрөлхтнийг бүтээсний дараа Тэр энэ ажлыг хийж, Иаковын эрин хүртэл үүнийг үргэлжлүүлсэн ба тухайн үед Тэрээр Иаковын арван хоёр хүүг Израилийн арван хоёр овог болгосон билээ. Тэр цагаас эхлээд Израилийн бүх ард түмэн газар дээр Түүгээр албан ёсоор

удирдуулсан хүмүүс болж, Израиль нь газар дээрх Түүний ажлын тусгай байршил болсон билээ. Ехова энэ хүмүүсийг, газар дээрх ажлаа албан ёсоор хийх эхний бүлэг хүмүүс болгосон бөгөөд Израилийн бүх газар нутгийг Өөрийн ажлын эхлэлийн цэг болгож, тэднийг бүр ч илүү агуу ажлын эхлэл болгон ашигласан, ингэснээр газар дээр Түүнээс төрсөн бүх хүн Түүнийг хэрхэн хүндэлж, газар дээр хэрхэн амьдрахаа мэдэх байсан юм. Иймээс израильчуудын үйл хэрэг нь Харь үндэстний хүмүүсийн дагах үлгэр жишээ болсон бөгөөд Израилийн ард түмний дунд хэлсэн зүйл нь Харь үндэстний хүмүүсийн сонсох үг болжээ. Учир нь тэд Еховагийн хууль болон тушаалыг эхлээд хүлээн авах хүмүүс байсан ба иймээс ч тэд бас Еховагийн замыг хэрхэн хүндлэхээ эхлээд мэдэж авах хүмүүс байсан юм. Тэд бол Еховагийн замыг мэддэг хүн төрөлхтний өвөг дээдэс, түүнчлэн Еховагийн сонгосон хүн төрөлхтний төлөөлөл байлаа. Нигүүлслийн эрин үе ирэхэд Ехова хүнийг ийм маягаар залж чиглүүлэхээ больсон. Хүн нүгэл үйлдэж, нүгэлд автсан тул Тэрээр хүнийг нүглээс аварч эхэлсэн юм. Ийм маягаар Тэр, нүглээс бүрэн гэтэлгэх хүртлээ хүнийг зэмлэжээ. Эцсийн өдрүүдэд хүн ийм түвшинд хүртлээ доройтсон учраас энэ үе шатны ажлыг зөвхөн шүүлт, гэгсгээлтээр л дамжин явуулж болно. Ийм маягаар л ажлыг гүйцэлдүүлж болно. Энэ нь хэд хэдэн эрин үеийн ажил байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, нэг эрин үеийг нөгөөгөөс зааглаж, тэдгээрийн хооронд шилжилт хийхдээ Бурхан Өөрийн нэр, Өөрийн ажил болон өөр өөр Бурханы дүрийг ашигладаг; Бурханы нэр болон ажил нь Түүний эрин үеийг төлөөлж, эрин үе бүр дэх Түүний ажлыг төлөөлдөг. Эрин үе бүр дэх Бурханы ажил үргэлж адилхан байж, Түүнийг үргэлж нэг нэрээр нэрлэдэг байсан бол хүн Түүнийг яаж мэдэх юм бэ? Бурханыг Ехова гэж нэрлэх ёстой, Бурханыг Ехова гэж нэрлэхээс бусдаар, өөр ямар нэг нэрээр нэрлэгддэг нэгэн бол Бурхан биш. Аль эсвэл Бурхан зөвхөн Есүс байж болох ба Есүсийн нэрээс өөр ямар ч нэрээр Түүнийг нэрлэж болохгүй; Есүсээс бусад тохиолдолд, Ехова бол Бурхан биш, Төгс Хүчит Бурхан ч бас Бурхан биш. Бурхан төгс хүчит гэдэг нь үнэн боловч Бурхан бол хүнтэй хамт байдаг Бурхан, Түүнийг Есүс гэж нэрлэх ёстой, учир нь Бурхан хүнтэй хамт байдаг гэж хүн итгэдэг. Ингэх нь хоосон сургаал мөрдөж, Бурханыг тодорхой цар хүрээнд хязгаарлаж байгаа хэрэг юм. Иймээс эрин үе бүрд Бурханы хийдэг ажил, Түүнийг нэрлэдэг нэр, Түүний авдаг дүр төрх—өнөөдрийг хүртэлх үе шат болгонд Түүний хийдэг ажил—эдгээр нь ганц ч дэг журмыг дагадаггүй ба ямар ч хязгаарлалтад баригддаггүй. Тэр бол Ехова, гэхдээ Тэр бас Есүс, түүнчлэн Мессиа, Төгс Хүчит Бурхан юм. Түүний ажил

алгуур өөрчлөлт туулж, Түүний нэрэнд зохих өөрчлөлт гардаг. Ганц ч нэр Түүнийг бүрэн төлөөлж чадахгүй, гэхдээ Түүнийг нэрлэдэг бүх нэр Түүнийг төлөөлж чаддаг бөгөөд эрин үе бүрд Түүний хийдэг ажил зан чанарыг нь төлөөлдөг. Эцсийн өдрүүд ирэх үед чиний хардаг Бурхан Есүс хэвээр байхаас гадна цагаан үүл хөлөглөн ирж, Есүсийн гадаад төрхтэй хэвээр байж, хэлдэг үг нь “Та нар хөршөө өөр шигээ хайрлах ёстой, мацаг барьж, залбирч, өөрийн амийг нандигнадаг шигээ дайснаа хайрлаж, бусдад хүлээцтэй хандаж, тэвчээртэй, даруу байх ёстой. Та нар Миний шавь болохоосоо өмнө энэ бүх зүйлийг хийх ёстой. Энэ бүх зүйлийг хийснээр Миний хаанчлалд орж болох юм” хэмээх Есүсийн үг байлаа гэж үзье. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн ажилд харьяалагдах бус уу? Түүний хэлдэг зүйл Нигүүлслийн эрин үеийн зам байх бус уу? Хэрвээ эдгээр үгийг сонссон бол та нарт ямар санагдах байсан бэ? Энэ нь мөн л Есүсийн ажил гэж санагдахгүй гэж үү? Энэ нь ажлыг давтаж байгаа хэрэг биш үү? Хүн үүнээс таашаал авч чадах уу? Бурханы ажил энэ хэвээрээ л үлдээд, цааш ахиц гарахгүй. Түүнд ийм л хүч чадал байдаг ба хийх ямар ч шинэ ажил байхгүй, Түүний хүч чадал хязгаартаа хүрчихсэн гэж та нарт санагдах байсан. Одоогоос хоёр мянган жилийн өмнө Нигүүлслийн эрин үе байсан ба хоёр мянган жилийн дараа ч Тэр бас л Нигүүлслийн эрин үеийн замыг номлосоор, хүмүүсийг гэмшүүлсээр байвал хүмүүс: “Бурхан минь, Танд ердөө ийм л хүч чадал байдаг. Та маш ухаалаг гэж би бодож байна, гэхдээ Та зөвхөн хүлээцтэй байдлыг л мэддэг ба тэвчээрийг л анхаардаг, Та дайснаа хайрлахаас өөрийг мэддэггүй” гэх байлаа. Хүний оюун санаанд Бурхан үүрд Нигүүлслийн эрин үед байсантайгаа адил байх байсан бөгөөд Бурхан бол элэгсэг, энэрэнгүй гэж хүн үргэлж бодох байв. Бурханы ажил үргэлж хуучин замаараа алхана гэж чи бодож байна уу? Иймээс Өөрийнхөө ажлын энэ үе шатанд Тэр цовдлогдохгүй бөгөөд хардаг, хүрдэг бүхэн чинь та нарын төсөөлсөн юм уу сонссон юутай ч адилгүй байх болно. Өнөөдөр Бурхан фарисайчуудтай харилцдаггүй, мөн дэлхий ертөнцөд ч мэдэгддэггүй бөгөөд Түүнийг мэддэг хүмүүс бол Түүнийг дагадаг та нар л юм, учир нь Тэр дахин цовдлогдохгүй. Нигүүлслийн эрин үед Есүс сайн мэдээний ажлынхаа төлөө газар нутаг даяар ил тод номлосон. Цовдлолын ажлын төлөө Тэр фарисайчуудтай харилцсан; хэрвээ Тэр фарисайчуудтай харилцаагүй, эрх мэдэлтэй байсан хүмүүс Түүнийг огт мэддэггүй байсан бол яаж Тэр яллагдаж, дараа нь урвалт амсаж, загалмайд цовдлогдож чадах юм бэ? Иймээс Тэр цовдлолын төлөө фарисайчуудтай харилцсан юм. Өнөөдөр Тэр сорилтоос зайлсхийхийн тулд Өөрийн ажлыг

нууцаар хийдэг. Бурхан хоёр удаа бие махбодтой болоход ажил болон ач холбогдол нь өөр, орчин нөхцөл нь ч өөр байдаг, тэгвэл Түүний хийдэг ажил яаж бүхэлдээ адилхан байж болох юм бэ?

“Бурхан бидэнтэй хамт” гэх Есүсийн нэр Бурханы зан чанарыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Бурханыг бүрэн илэрхийлж чадах уу? Бурханыг Есүс л гэж нэрлэж болно, Бурхан Өөрийн зан чанарыг өөрчилж болохгүй учраас өөр ямар ч нэртэй байж болохгүй гэж хүн хэлбэл энэ нь үнэхээр доромжлол юм! Бурхан бидэнтэй хамт хэмээх Есүс гэдэг нэр ганцаараа Бурханыг бүхэлд нь төлөөлж чадна гэж чи итгэж байна уу? Бурханыг олон нэрээр нэрлэж болно, гэхдээ энэ олон нэрийн дунд Бурханыг бүхэлд нь товчоор илэрхийлж чадах, Бурханыг бүрэн төлөөлж чадах ганц ч нэр байхгүй. Иймээс Бурханд олон нэр байдаг боловч энэ олон нэр нь Бурханы зан чанарыг бүрэн илэрхийлж чадахгүй, учир нь Бурханы зан чанар маш баялаг болохоор энэ нь Түүнийг мэдэх хүний чадвараас даван гардаг. Хүн төрөлхтний хэлийг ашиглан Бурханыг бүрэн илэрхийлэх ямар ч арга хүнд үгүй. Хүн төрөлхтний хувьд, Бурханы зан чанарын талаар мэддэг бүхнээ товчоор илэрхийлэх үгсийн сан хязгаарлагдмал байдаг: агуу, эрхэмсэг, гайхалтай, ойлгохын аргагүй, эрхэм дээд, ариун, зөвт, ухаалаг гэх мэт. Маш олон үг! Ийм хязгаарлагдмал үгсийн сан нь Бурханы зан чанарын талаар хүний харсан өчүүхэн жаахан зүйлийг ч дүрслэх чадваргүй. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөр олон хүн, өөрсдийнх нь доторх оргилсон сэтгэлийг илүү сайн дүрсэлж чадна гэж бодсон үгийг нэмсэн: Бурхан маш агуу! Бурхан маш ариун! Бурхан маш хайр татам! Өнөөдөр хүний иймэрхүү үг хэллэг оргилдоо хүрсэн атал хүн өөрийгөө тодорхой илэрхийлэх чадваргүй хэвээр байгаа. Иймээс хүний хувьд, Бурхан олон нэртэй атлаа нэг ч нэргүй байдаг, учир нь Бурханы оршихуй маш элбэг арвин агаад хүний хэл тун хомсхон. Тодорхой нэг үг, эсвэл нэр Бурханыг бүхэлд нь төлөөлөх чадваргүй, тэгвэл Тэрээр тогтсон нэг нэртэй байж болно гэж чи бодож байна уу? Бурхан маш агуу, маш ариун атал шинэ эрин үе бүрд нэрээ өөрчлөхийг чи Түүнд зөвшөөрөхгүй юу? Тиймээс Өөрийн ажлыг биечлэн хийж байгаа эрин үе бүрдээ Бурхан, хийхээр зорьж буй ажлаа товчоор илэрхийлэхийн тулд тухайн эрин үед тохирох нэрийг ашигладаг. Тэрээр тухайн эрин үе дэх Өөрийн зан чанарыг төлөөлөхийн тулд цаг хугацааны ач холбогдол бүхий энэхүү тодорхой нэрийг ашигладаг. Энэ бол Өөрийн зан чанарыг илэрхийлэхийн тулд Бурхан хүн төрөлхтний хэлийг ашиглаж байгаа хэрэг юм. Тэгсэн ч гэсэн сүнслэг туршлагатай агаад Бурханыг биечлэн харсан олон хүнд, энэхүү тодорхой нэг нэр Бурханыг бүхэлд нь төлөөлөх чадваргүй гэж

санагдсаар байдаг—аяа, үүнийг яах ч аргагүй—иймээс хүн Бурханыг ямар нэг нэрээр нэрлэхээ больж, Түүнийг зүгээр л “Бурхан” гэж дууддаг. Хүний зүрх сэтгэл хайраар дүүрэн мөртөө бас зөрчилдөөнд автсан мэт байдаг, учир нь хүн Бурханыг хэрхэн тайлбарлахаа мэддэггүй. Бурхан юу болох нь хэтэрхий элбэг дэлбэг тул үүнийг ердөө дүрслэх аргагүй. Бурханы зан чанарыг нэгтгэн дүгнэж чадах ганц ч нэр байхгүй бөгөөд Бурханд юу байгаа, Тэр юу болохыг дүрсэлж чадах ганц ч нэр байхгүй. Хэрвээ хүн Надаас, “Та яг ямар нэр ашигладаг вэ?” гэж асуувал Би түүнд “Бурхан бол Бурхан!” гэж хэлнэ. Тэр нь Бурханы хувьд хамгийн сайн нэр биш гэж үү? Бурханы зан чанарын хамгийн шилдэг товч илэрхийлэл биш гэж үү? Ийм байтал та нар яагаад Бурханы нэрийг эрж хайхад маш их хичээл чармайлт гаргадаг юм бэ? Ганц нэрийн төлөө яагаад тархиа гашилгаж, нойр, хоолоо умартана вэ? Бурханыг Ехова, Есүс, Мессиа гэж нэрлэхгүй өдөр ирнэ—Тэр зүгээр л Бүтээгч байх болно. Тэр үед, газар дээр Түүний авсан бүх нэр төгсгөл болно, учир нь газар дээрх Түүний ажил дуусчихсан байх бөгөөд үүний дараа Түүний нэрс байхаа болино. Бүх зүйл Бүтээгчийн эрх мэдэл дор очих үед туйлын зохистой атлаа бүрэн бус нэр Түүнд ямар хэрэгтэй байх юм бэ? Чи одоо ч Бурханы нэрийн араас хөөцөлдсөөр байна уу? Чи Бурханыг гагцхүү Ехова гэж нэрлэж болно гэж хэлж зүрхэлсээр байна уу? Бурханыг Есүс л гэж нэрлэж болно хэмээн хэлж зүрхэлсээр байна уу? Бурханыг доромжилсон нүглийг чи үүрч чадах уу? Бурхан анхнаасаа ямар ч нэргүй байсан гэдгийг чи мэдэж байх ёстой. Түүнд хийх ажил байсан ба хүн төрөлхтнийг удирдах хэрэгтэй болсон учраас л Тэр нэг, хоёр, эсвэл олон нэртэй болсон юм. Түүнийг ямар ч нэрээр нэрлэсэн бай—үүнийг Тэр Өөрөө чөлөөтэйгээр сонгоогүй гэж үү? Өөрийн бүтээлийн нэг болох чамаар Тэр үүнийг шийдүүлэх хэрэгтэй юу? Бурханыг нэрлэдэг нэр нь хүний ойлгож чадах зүйлтэй, мөн хүн төрөлхтний хэлтэй нийцдэг нэр боловч энэ нэр бол хүний нэгтгэн дүгнэж чадах зүйл биш юм. Тэнгэрт нэг Бурхан байдаг, Түүнийг Бурхан гэж нэрлэдэг, Тэр бол агуу хүч чадалтай, маш ухаалаг, маш өргөмжит, тун гайхалтай, тун нууцлаг, үнэхээр төгс хүчит Бурхан Өөрөө юм гэж л чи хэлж чадна, тэгээд өөр юу ч хэлж чадахгүй; мэддэг бүхэн чинь ийм жаахан байдаг. Тийм болохоор ганцхан Есүсийн нэр Бурханыг Өөрийг нь төлөөлж чадах уу? Эцсийн өдрүүд ирэхэд Бурхан ажлаа хийж байгаа хэвээр хэдий ч Түүний нэр өөрчлөгдөх ёстой, учир нь энэ бол өөр эрин үе билээ.

Бурхан орчлон ертөнц даяар болон орчлон ертөнцийн дээр хамгийн агуу нь болохоор махбодын дүрийг ашиглаад Өөрийгөө бүрэн тайлбарлаж чадах уу?

Бурхан ажлынхаа нэг үе шатыг хийхийн тулд энэ махбодыг өмсдөг. Махбодын энэ дүр төрхөд ямар ч онцгой утга учир байхгүй, энэ нь эрин үе өнгөрөхтэй ямар ч холбоогүй, мөн Бурханы зан чанартай ч хамаагүй. Яагаад Есүс Өөрийн дүр зургийг үлдээгээгүй вэ? Яагаад Тэр дараагийн үеийнхэнд дамжуулахын тулд хүнээр Өөрийнхөө дүрийг зуруулаагүй вэ? Түүний дүр төрх бол Бурханы дүр төрх гэдгийг Тэр яагаад хүмүүсээр хүлээн зөвшөөрүүлээгүй вэ? Хэдийгээр хүний дүр төрх Бурханы дүрээр бүтээгдсэн боловч хүний гадаад төрх нь Бурханы өргөмжит дүрийг төлөөлөх боломжтой гэж үү? Бурхан махбод болохдоо тодорхой нэг махбодод тэнгэрээс бууж ирсэн төдий юм. Түүний Сүнс махбодод бууж ирсэн ба махбодоор дамжуулан Тэр Сүнсний ажлыг хийдэг. Сүнс махбодоор илэрхийлэгдэж, Өөрийн ажлыг махбодоор хийдэг. Махбодоор хийгддэг ажил нь Сүнсийг бүрэн төлөөлдөг бөгөөд уг махбод ажлын төлөө байдаг боловч махбодын дүр төрх нь Бурханы Өөрийн жинхэнэ дүр төрхийг орлодог гэсэн үг биш; энэ нь Бурхан махбод болсны зорилго, ач холбогдол биш юм. Тэр махбод болсон болохоор л Сүнс Өөрийн ажилд тохирох оршин суух газрыг олж, махбод дахь ажлаа илүү сайн биелүүлж болох бөгөөд ингэснээр хүмүүс Түүний үйл хэргийг харж, Түүний зан чанарыг ойлгож, Түүний үгийг сонсож, Түүний ажлын гайхамшгийг мэдэж чадна. Түүний нэр зан чанарыг нь төлөөлдөг, Түүний ажил ялгамж чанарыг нь төлөөлдөг боловч махбодынх нь гадаад төрх Өөрийнх нь дүр төрхийг төлөөлдөг гэж Тэр хэзээ ч хэлээгүй; тэр нь ердөө л хүний үзэл юм. Иймээс бие махбодтой болсон Бурханы гол чухал талууд нь Түүний нэр, Түүний ажил, Түүний зан чанар болон Түүний хүйс билээ. Энэ эрин үе дэх Түүний удирдлагыг төлөөлөхөд эдгээр нь ашиглагддаг. Махбод дахь Түүний гадаад төрх нь Түүний удирдлагад ямар ч хамаагүй бөгөөд тухайн үеийн Түүний ажлын төлөө л байдаг. Гэсэн ч бие махбодтой болсон Бурханы хувьд ямар ч тодорхой гадаад төрхгүй байх боломжгүй тул Өөрийнх нь гадаад төрхийг шийдэх тохиромжтой гэр бүлийг Тэр сонгодог. Хэрвээ Бурханы гадаад төрх төлөөллийн ач холбогдолтой бол Түүнтэй төстэй царайтай бүх хүн ч бас Бурханыг төлөөлөх байсан. Тэгэх нь ноцтой алдаа байх бус уу? Хүнээр шүтүүлэхийн тулд Есүсийн хөргийг хүн зурсан. Тухайн үед Ариун Сүнс ямар ч онцгой удирдамж өгөөгүй тул хүн төсөөллийн тэрхүү хөрөг зургийг өнөөдрийг хүртэл дамжуулсан юм. Үнэндээ Бурханы анхдагч санаа зорилгоор бол хүн ингэх ёсгүй байсан. Хүний хичээл зүтгэл л Есүсийн хөрөг зургийг өнөөдрийг хүртэл үлдээсэн юм. Бурхан бол Сүнс бөгөөд Түүний дүр төрх яг ямар болохыг хүн хэзээ ч нэгтгэн дүгнэж чадахгүй. Түүний дүр төрхийг Түүний зан чанар л

төлөөлж чадна. Түүний хамар, ам, нүд, үсний харагдах байдлын тухайд бол эдгээр нь нэгтгэн дүгнэх чадвараас чинь давдаг. Иоханд илчлэл ирэх үед тэр хүний Хүүгийн дүрийг харсан: Түүний амнаас хоёр талдаа иртэй хурц сэлэм гарсан, нүд нь галын дөл шиг, толгой болон үс нь ноос шиг цагаан, хөл нь өнгөлсөн хүрэл шиг байсан ба Түүний цээжинд алтлаг тууз байв. Түүний үг туйлын тодорхой байсан хэдий ч түүний дүрсэлсэн Бурханы дүр төрх нь бүтээгдсэн зүйлийн дүр төрх байгаагүй юм. Түүний харсан зүйл ердөө л үзэгдэл байсан ба материаллаг ертөнцийн хүний дүр төрх биш байлаа. Иохан үзэгдэл харсан боловч Бурханы жинхэнэ төрхийг хараагүй. Бурханы махбод болсон биеийн дүр төрх нь бүтээгдсэн зүйлийн дүр болохоор Бурханы зан чанарыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Ехова хүн төрөлхтнийг бүтээх үедээ Өөрийн дүрээр бүтээсэн гэж хэлсэн бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээсэн. Тухайн үед Тэр эрэгтэй, эмэгтэй хүнийг Бурханы дүрээр бүтээсэн гэж хэлсэн билээ. Хэдийгээр хүний дүр төрх Бурханы дүртэй төстэй боловч хүний гадаад төрх бол Бурханы дүр мөн гэсэн утгатай хэмээн тайлбарлаж болохгүй. Мөн Бурханы дүр төрхийг бүрэн илэрхийлэхийн тулд хүний хэлийг ашиглаж ч болохгүй, учир нь Бурхан маш өндөр дээд, маш агуу, тун гайхалтай агаад ойлгохын аргагүй билээ!

Есүс Өөрийн ажлыг хийхээр ирсэн нь Ариун Сүнсний зааварчилгааны дор явагдсан; Тэрээр Ариун Сүнсний хүссэн зүйлийг хийсэн бөгөөд энэ нь Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийн дагуу, эсвэл Еховагийн ажлын дагуу байгаагүй. Хэдийгээр Есүсийн хийхээр ирсэн ажил нь Еховагийн хууль, эсвэл Еховагийн тушаалуудыг мөрдөх явдал биш байсан ч Тэдний эх сурвалж ав адилхан байсан юм. Есүсийн хийсэн ажил Есүсийн нэрийг төлөөлж, Нигүүлслийн эрин үеийг төлөөлсөн; Еховагийн хийсэн ажлын тухайд бол энэ нь Еховаг төлөөлсөн бөгөөд Хуулийн эрин үеийг төлөөлсөн. Тэдний ажил бол хоёр өөр эрин үе дэх нэг Сүнсний ажил байсан юм. Есүсийн хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг л төлөөлж чадсан бөгөөд Еховагийн хийсэн ажил зөвхөн Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийг л төлөөлж байв. Ехова зөвхөн Израиль, Египетийн ард түмэн болон Израилийн гаднах бүх үндэстний хүмүүсийг л удирдан чиглүүлсэн юм. Шинэ Гэрээний Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн ажил нь, эрин үеийг залж чиглүүлэнгээ Есүсийн нэрээр ажилласан Бурханы ажил байлаа. Хэрвээ чи, Есүсийн ажил нь Еховагийнх дээр суурилсан, Тэр ямар ч шинэ ажил эхлүүлээгүй, Түүний хийсэн бүхэн Еховагийн үгийн дагуу, Еховагийн ажлын дагуу, Исаиагийн зөгнөлийн дагуу байсан гэж хэлбэл Есүс махбод болсон Бурхан биш байх байв. Хэрвээ Тэр ийм маягаар ажлаа явуулсан бол Хуулийн

эрин үеийн элч юм уу ажилчин байх байлаа. Хэрвээ чиний хэлдэг шиг байсан бол Есүс эрин үеийг эхлүүлж чадахгүй, өөр ямар ч ажил хийж чадахгүй байх байсан юм. Үүний адилаар, Ариун Сүнс Өөрийн ажлыг үндсэндээ Еховагаар дамжуулан хийх ёстой ба Еховагаар дамжуулахгүй л бол Ариун Сүнс ямар ч шинэ ажил хийж чадахгүй байх байв. Хүн Есүсийн ажлыг ийм маягаар ойлгох нь буруу юм. Есүсийн хийсэн ажил Еховагийн үг болон Исаиагийн зөгнөлийн дагуу байсан гэж хүн итгэдэг бол Есүс бие махбодтой болсон Бурхан байсан уу, эсвэл эш үзүүлэгчдийн нэг байсан уу? Энэ үзэл бодлоор бол Нигүүлслийн эрин үе гэж байхгүй ба Есүс бие махбодтой болсон Бурхан биш байх байв, учир нь Түүний хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг төлөөлж чадахгүй, харин Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийг л төлөөлж чадах байлаа. Есүс шинэ ажил хийхээр ирж, шинэ эрин үеийг эхлүүлж, урьд нь Израильд хийгдсэн ажлаас халин гарч, Өөрийн ажлыг Еховагийн Израильд хийсэн ажлын дагуу явуулалгүй, Түүний хуучин дүрэм журамд баригдалгүй, ямар ч ёс заншлыг дагалгүй, харин Өөрийн хийх ёстой шинэ ажлыг хийсэн үед л шинэ эрин үе бий болох байсан юм. Эрин үеийг эхлүүлэхийн тулд Бурхан Өөрөө ирдэг ба эрин үеийг төгсгөхийн тулд Бурхан Өөрөө ирдэг. Хүн эрин үеийг эхлүүлэх болон эрин үеийг төгсгөх ажлыг хийх чадваргүй. Хэрвээ Есүс ирснийхээ дараа Еховагийн ажлыг төгсгөөгүй бол Тэр ердөө хүн байсан ба Бурханыг төлөөлөх чадваргүй байсан гэдгийг энэ нь нотлох байв. Есүс ирж, Еховагийн ажлыг дуусгаж, Еховагийн ажлыг үргэлжлүүлж, улмаар Өөрийнхөө ажлыг буюу шинэ ажлыг гүйцэтгэсэн учраас л энэ бол шинэ эрин үе байсан бөгөөд Есүс бол Бурхан Өөрөө байсан гэдгийг энэ нь нотолдог. Тэд ажлын илт өөр хоёр үе шатыг гүйцэтгэсэн. Нэг үе шат нь сүмд явагдсан ба нөгөө нь сүмийн гадна хийгджээ. Нэг үе шат нь хуулийн дагуу хүний амьдралыг удирдан хөтлөх, харин нөгөө нь нүглийн тахил өргөхийн төлөө байв. Ажлын энэ хоёр үе шат харваас өөр байсан; энэ нь шинэ эрин үеийг хуучнаас салгадаг бөгөөд тэдгээр нь хоёр өөр эрин үе юм гэж хэлэх нь туйлын зөв. Тэдний ажлын байршил өөр байсан, ажлынх нь агуулга өөр байсан, ажлынх нь зорилго өөр байсан юм. Иймээс тэдгээрийг хоёр эрин үед хувааж болно: Шинэ ба Хуучин Гэрээ буюу шинэ ба хуучин эрин үе. Есүс ирэхдээ сүм рүү очоогүй нь Еховагийн эрин үе төгссөнийг нотолдог. Сүм дэх Еховагийн ажил дууссан, дахин хийх хэрэггүй байсан учраас Тэр сүмд ороогүй бөгөөд үүнийг дахин хийх нь давтаж байгаа хэрэг болох байв. Сүмийг орхин явж, сүмийн гадна шинэ ажил эхлүүлж, шинэ замыг нээснээр л Тэр Бурханы ажлыг дээд цэгт нь аваачиж чадах байлаа. Хэрвээ Тэр Өөрийн ажлыг хийхийн тулд сүмээс гараагүй бол Бурханы ажил

сүмийн суурин дээр зогсож, ямар ч шинэ өөрчлөлт гарахгүй байх байв. Иймээс Есүс ирэх үедээ сүмд ороогүй ба Өөрийн ажлыг сүмд хийгээгүй юм. Тэрээр ажлаа сүмийн гадна хийж, шавь нараа дагуулан Өөрийн ажлыг чөлөөтэй хийж эхэлсэн билээ. Бурхан Өөрийн ажлыг хийхээр сүмээс явсан нь Бурханд шинэ төлөвлөгөө бий гэсэн утгатай байв. Түүний ажил сүмийн гадна явагдах ёстой байсан бөгөөд хэрэгжих байдлаараа хязгаарлагдахгүй шинэ ажил байх ёстой байлаа. Есүс ирмэгцээ Хуучин Гэрээний эрин үе дэх Еховагийн ажлыг төгсгөсөн юм. Хэдийгээр Тэднийг хоёр өөр нэрээр нэрлэж байсан ч ажлын хоёр үе шатыг хоёуланг нь нэг Сүнс хийсэн бөгөөд хийгдсэн ажил нь үргэлжилсэн ажил байв. Нэр нь өөр байсны адилаар ажлын агуулга өөр, эрин үе өөр байсан. Еховаг ирэх үед тэр нь Еховагийн эрин үе байсан бөгөөд Есүсийг ирэх үед Есүсийн эрин үе байв. Иймээс ирэх болгондоо Бурхан нэг нэрээр нэрлэгдэж, нэг эрин үеийг төлөөлж, шинэ замыг нээдэг; шинэ зам болгонд Тэрээр шинэ нэр авдаг нь Бурхан үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй, Түүний ажил урагш ахихаа хэзээ ч больдоггүй гэдгийг харуулдаг. Түүх үргэлж урагшилж байгаа ба Бурханы ажил үргэлж урагшилж байгаа. Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө төгсгөлдөө хүрэхийн тулд ямагт урагшлан ахисаар байх ёстой. Өдөр бүр Тэр шинэ ажил хийх ёстой, жил болгон Тэр шинэ ажил хийх ёстой; Тэр шинэ замыг нээж, шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ, илүү агуу ажлыг эхлүүлж, эдгээрийн хамтаар шинэ нэр, шинэ ажлыг авчрах ёстой. Хором бүрд Бурханы Сүнс үргэлж шинэ ажил хийж байгаа ба хуучин арга зам, дүрэм журамтай хэзээ ч зууралддаггүй. Мөн Түүний ажил хэзээ ч зогсоогүй, харин хором мөч өнгөрөх бүрд хийгдсээр байгаа. Хэрвээ чи, Ариун Сүнсний ажил хэзээ ч хувиршгүй гэж хэлдэг бол, сүм дотор Өөрт нь үйлчлэхийг Ехова тахилчдаас шаардсан атал Есүсийг ирэх үед хүмүүс Түүнийг тэргүүн тахилч, Давидын гэрийн нэгэн, түүнчлэн тэргүүн тахилч, агуу Хаан гэж хэлж байсан ч Есүс яагаад сүмд ороогүй юм бэ? Яагаад Тэр тахил өргөөгүй вэ? Сүмд орсон ч бай, эсвэл үгүй ч бай—энэ нь бүгд Бурханы Өөрийн ажил биш гэж үү? Хэрвээ хүний төсөөлдгөөр Есүс дахин ирж, эцсийн өдрүүдэд Есүс гэж нэрлэгдсэн хэвээр байж, Есүсийн дүрээр хүмүүсийн дунд цагаан үүл хөлөглөн бууж ирсэн бол Түүний ажил давтагдсан хэрэг болох бус уу? Ариун Сүнс хуучин зүйлтэй зууралдаж чадах уу? Хүний боддог бүхэн нь үзэл бөгөөд хүний ойлгодог бүхэн нь үгчилсэн утгын дагуу, бас өөрсдийнх нь төсөөллийн дагуу байдаг; тэр нь Ариун Сүнсний ажлын зарчимтай тохирдоггүй бөгөөд Бурханы санаа зорилгод нийцдэггүй. Бурхан тийм маягаар ажиллахгүй; Бурхан тийм ч мунхаг, тэнэг биш

бөгөөд Түүний ажил чиний төсөөлдөг шиг тийм энгийн биш. Хүмүүсийн төсөөлдөг бүхэнд үндэслэвэл Есүс үүл хөлөглөн ирж, та нарын дунд бууна. Үүл хөлөглөсөн Тэрээр Өөрийгөө Есүс мөн гэж хэлэхийг та нар харна. Та нар бас Түүний гар дахь хадаасны сорвийг олж хараад, Есүс мөн гэдгийг нь мэднэ. Тэрээр та нарыг дахин аварч, та нарын хүчирхэг Бурхан байх болно. Тэр та нарыг аварч, та нарт шинэ нэр хайрлаж, дор бүрд чинь цагаан чулуу өгнө, үүний дараа та нар тэнгэрийн хаанчлалд орох боломжтой болж, диваажин руу хүргэгдэнэ. Ийм итгэл нь хүний үзэл биш гэж үү? Бурхан хүний үзлийн дагуу ажилладаг уу, эсвэл хүний үзлийн эсрэг ажилладаг уу? Хүний бүх үзэл Сатанаас үүдэн гардаггүй гэж үү? Бүх хүнийг Сатан завхруулаагүй гэж үү? Хэрвээ Бурхан Өөрийн ажлыг хүний үзлийн дагуу хийсэн бол Сатан болчихгүй гэж үү? Тэр Өөрийнхөө бүтээлүүдтэй адил төрлийнх байх бус уу? Түүний бүтээлүүдийг одоо Сатан маш их завхруулж, хүн Сатаны биелэл болсон тул хэрвээ Бурхан, Сатаны зүйлсэд нийцүүлэн ажилласан бол Сатантай хуйвалдаж байгаа хэрэг болох бус уу? Хүн Бурханы ажлыг яаж ойлгож чадах юм бэ? Тиймээс Бурхан хэзээ ч хүний үзлийн дагуу ажиллахгүй, хэзээ ч чиний төсөөлдөг шигээр ажиллахгүй. Үүлэн дээр ирнэ гэж Бурхан Өөрөө хэлсэн гэгцгээдэг хүмүүс бий. Бурхан Өөрөө ингэж хэлсэн нь үнэн боловч Бурханы нууцыг нэг ч хүн ухан ойлгож чадахгүй гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Бурханы үгийг нэг ч хүн тайлбарлаж чадахгүй гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Ариун Сүнс чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлсэн гэдэгт чи өчүүхэн ч эргэлзэхгүйгээр итгэж байна уу? Мэдээж Ариун Сүнс чамд тийм шууд байдлаар харуулаагүй биз дээ? Үүнийг Ариун Сүнс зааварласан уу, эсвэл өөрийн чинь үзэл чамайг ингэж бодоход хүргэсэн үү? Чи: “Үүнийг Бурхан Өөрөө хэлсэн” гэсэн. Гэхдээ Бурханы үгийг хэмжихдээ бид өөрсдийн үзэл, оюун ухааныг ашиглаж болохгүй. Исаиагийн хэлсэн үгийн тухайд гэвэл, чи түүний үгийг туйлын итгэлтэйгээр тайлбарлаж чадах уу? Чи түүний үгийг тайлбарлаж зүрхлэх үү? Чи Исаиагийн үгийг тайлбарлаж зүрхлэхгүй юм бол яагаад Есүсийн үгийг тайлбарлаж зүрхэлдэг юм бэ? Есүс, Исаиа хоёрын хэн нь илүү өндөр дээд вэ? Хариулт нь Есүс байхад чи яагаад Есүсийн хэлсэн үгийг тайлбарладаг юм бэ? Бурхан Өөрийнхөө ажлын талаар чамд урьдчилан хэлэх үү? Ганц ч бүтээгдсэн зүйл, бүр тэнгэр дэх элчүүд, хүний Хүү ч мэдэж чадахгүй, тэгвэл чи яаж мэдэж чадах юм бэ? Хүн хэтэрхий дутуу дулимаг. Одоо чиний хувьд хамгийн чухал зүйл бол ажлын гурван үе шатыг мэдэх явдал юм. Еховагийн ажлаас Есүсийнхийг хүртэл, Есүсийн ажлаас одоогийн энэ үе шатны ажил хүртэлх энэ гурван үе шат тасралтгүй уялдаатайгаар Бурханы удирдлагын

бүхий л цар хүрээг хамардаг ба бүгдээрээ нэг Сүнсний ажил юм. Дэлхий ертөнцийн бүтээлээс хойш Бурхан үргэлж хүн төрөлхтнийг удирдан ажилласаар ирсэн. Тэр бол Эхлэл ба Төгсгөл, Эхэн ба Эцэс, эрин үеийг эхлүүлдэг Нэгэн, бас эрин үеийг төгсгөдөг Нэгэн юм. Өөр өөр эрин үе, өөр өөр байршил дахь ажлын гурван үе шат нь гарцаагүй нэг Сүнсний ажил мөн. Энэ гурван үе шатыг хуваадаг бүх хүн Бурханыг эсэргүүцэн зогсдог. Эхний үе шатнаас өнөөдрийг хүртэлх бүх ажил нь нэг Бурханы ажил, нэг Сүнсний ажил юм гэдгийг одоо ч ийлговол зохино. Үүнд эргэлзэх юмгүй.

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ (1)

Нигүүлслийн эрин үед Иохан Есүст зориулан зам тавьсан. Иохан Бурханы Өөрийн ажлыг хийж чадаагүй, харин ердөө хүний үүргийг л биелүүлсэн юм. Хэдийгээр Иохан Эзэний анхдагч байсан ч Бурханыг төлөөлж чадаагүй; тэр ердөө Ариун Сүнсний ашигладаг хүн байлаа. Есүсийг баптисм хүртсэний дараа Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт буужээ. Дараа нь Тэрээр ажлаа эхэлсэн, өөрөөр хэлбэл, Христийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлсэн юм. Тийм учраас Тэр Бурханы ялгамж чанарыг авсан, учир нь Тэр Бурханаас ирсэн билээ. Үүнээс өмнө Түүний итгэл ямар байсан нь хамаагүй—заримдаа сул дорой, заримдаа хүчтэй байсан байж болох ч—бүгд Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхээс өмнөх хэвийн хүний амьдралд нь харьяалагдаж байв. Түүнийг баптисм хүртсэний (өөрөөр хэлбэл, тосолсны) дараа Бурханы хүч чадал, алдар суу нэн даруй Түүнтэй хамт байсан тул Тэрээр үйлчлэлээ гүйцэтгэж эхэлсэн юм. Тэрээр тэмдэг, гайхамшиг бүтээж, ид шид үзүүлж чаддаг байсан бөгөөд хүч чадал, эрх мэдэлтэй байлаа, учир нь Тэр Бурханы Өөрийн өмнөөс шууд ажиллаж байсан билээ; Тэрээр Сүнсний өмнөөс ажил хийж, Сүнсний дуу хоолойг илэрхийлж байв. Тиймээс Тэр бол Бурхан Өөрөө байсан юм; энэ нь маргаангүй. Иохан бол Ариун Сүнсний ашигладаг хүн байсан. Тэр Бурханыг төлөөлж чадаагүй, түүний хувьд Бурханыг төлөөлөх боломж ч байгаагүй. Хэрвээ тэр ингэхийг хүссэн бол Ариун Сүнс зөвшөөрөхгүй байх байлаа, учир нь Бурханы Өөрийн биелүүлэхээр зорьсон ажлыг тэр хийх чадваргүй байсан юм. Магадгүй түүнд хүний хүсэл ихээхэн байсан, эсвэл ямар нэгэн гажуудал байсан байх; ямар ч тохиолдолд тэр Бурханыг шууд төлөөлж чадахгүй байв. Түүний алдаа, утгагүй явдал зөвхөн түүнийг төлөөлж байсан боловч ажил нь харин Ариун Сүнсийг төлөөлж байлаа. Гэвч түүний бүх зүйл Бурханыг төлөөлж байсан гэж хэлж болохгүй. Түүний

гажуудал, алдаа мадаг нь ч бас Бурханыг төлөөлж чадсан гэж үү? Хүнийг илэрхийлэхдээ алдаа мадагтай байх нь хэвийн зүйл боловч Бурханыг төлөөлөхдөө гажуудалтай бол Бурханыг гутаасан хэрэг болох биш үү? Тэр нь Ариун Сүнсний эсрэг доромжлол байх бус уу? Бусдаар өргөмжлүүлдэг байсан ч гэсэн тухайн хүнийг Бурханы байр сууринд зогсохыг Ариун Сүнс хялбархан зөвшөөрдөггүй. Хэрвээ тэр Бурхан л биш бол эцэст нь бат зогсож чадахгүй. Ариун Сүнс, Бурханыг хүссэнээрээ төлөөлөхийг хүнд зөвшөөрдөггүй! Жишээ нь, Ариун Сүнс Иоханд гэрчлэл хийсэн бөгөөд Есүст зориулан зам тавих нэгэн болохыг нь ч бас илчилсэн боловч түүн дээр Ариун Сүнсний хийсэн ажил нэлээд хянамгай байв. Есүсийн төлөө зам тавигч байж, Түүнд зориулсан замыг бэлдэхийг л Иоханаас хүссэн юм. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс зам тавих ажлыг нь л дэмжиж, тийм ажил хийхийг л түүнд зөвшөөрсөн—өөр ажил хийхийг түүнд зөвшөөрөөгүй. Иохан Елиаг төлөөлсөн бөгөөд зам тавьсан эш үзүүлэгчийг төлөөлсөн юм. Ариун Сүнс үүнд нь түүнийг дэмжсэн; түүний ажил зам тавихын төлөө байсан цагт Ариун Сүнс түүнийг дэмжсэн. Гэвч хэрвээ тэр өөрийгөө Бурхан Өөрөө хэмээж, золин авралын ажлыг дуусгахын төлөө ирсэн гэж хэлсэн бол Ариун Сүнс түүнийг сахилгажуулах ёстой байлаа. Иоханы ажил хэчнээн агуу байсан нь хамаагүй, үүнийг Ариун Сүнс дэмжиж байсан ч гэсэн түүний ажил хил хязгааргүй байгаагүй юм. Ариун Сүнс үнэхээр түүний ажлыг дэмжсэн нь үнэн боловч тухайн үед түүнд өгсөн хүч чадал зам тавих явдлаар л хязгаарлагдаж байв. Тэрээр өөр ажил хийж огт чадаагүй, учир нь тэр бол Есүс биш, харин зам тавьсан Иохан байлаа. Тиймээс Ариун Сүнсний гэрчлэл гол түлхүүр нь боловч хүнээр хийлгэхээр Ариун Сүнсний зөвшөөрдөг ажил бүр ч илүү чухал юм. Иохан тухайн үед цангинасан гэрчлэл хүлээн аваагүй гэж үү? Түүний ажил ч бас асар их байгаагүй гэж үү? Гэхдээ түүний хийсэн ажил Есүсийнхээс хэтрээгүй, учир нь тэр ердөө л Ариун Сүнсний ашигласан хүн байсан бөгөөд Бурханыг шууд төлөөлж чадаагүй тул хийсэн ажил нь хязгаарлагдмал байлаа. Түүнийг зам тавих ажлаа дуусгасны дараа Ариун Сүнс түүний гэрчлэлийг хадгалахаа больж, ямар ч шинэ ажил түүнийг дагаагүй бөгөөд Бурханы Өөрийн ажил эхлэхэд тэр орхин явсан юм.

Муу ёрын сүнсэнд эзэмдүүлж, “Би бол Бурхан!” хэмээн бархиран хашхирдаг зарим хүн бий. Гэсэн ч, тэдний төлөөлдөг зүйл буруу учраас эцэстээ тэд илчлэгддэг. Тэд Сатаныг төлөөлдөг ба Ариун Сүнс тэдэнд огт анхаарал хандуулдаггүй. Чи өөрийгөө хэчнээн өндөрт өргөмжилж, хэр чанга хашхирсан ч Сатанд харьяалагддаг бүтээгдсэн зүйл хэвээрээ л байна. Би хэзээ ч “Би бол

Бурхан, Би бол Бурханы хайртай Хүү!” гэж хашхирдаггүй. Гэвч Миний хийдэг ажил бол Бурханы ажил юм. Би хашхирах хэрэгтэй гэж үү? Ямар ч өргөмжлөл хэрэггүй. Бурхан Өөрийнхөө ажлыг Өөрөө хийдэг бөгөөд хүн Түүнд байр суурь олгож, эсвэл хүндэт цол олгох хэрэггүй: Түүний ажил ялгамж чанар болон байр суурийг нь төлөөлдөг. Баптизм хүртэхээсээ өмнө Есүс, Бурхан Өөрөө байгаагүй гэж үү? Тэрээр Бурханы махбод болсон бие байгаагүй гэж үү? Тэр гэрчлэл хүлээн авсныхаа дараа л Бурханы цорын ганц Хүү болсон гэж хэлж мэдээж болохгүй биз дээ? Түүнийг ажлаа эхлэхээс ч өмнө Есүс гэдэг нэртэй хүн байгаагүй гэж үү? Чи шинэ зам гаргаж, эсвэл Сүнснийг төлөөлж чадахгүй. Сүнсний ажил болон хэлдэг үгийг илэрхийлж чадахгүй. Чи Бурханы Өөрийн ажлыг хийж чадахгүй, Сүнсний ажлыг ч хийж чадахгүй. Бурханы мэргэн ухаан, гайхамшиг, ойлгогдошгүй байдал болон хүнийг гэсгээдэг бүх зан чанар—энэ бүхнийг чи илэрхийлж чадахгүй. Тиймээс өөрийгөө Бурхан гэж зүтгэх нь нэмэргүй; чамд зөвхөн нэр л байх ба ямар ч мөн чанар байхгүй. Бурхан Өөрөө ирсэн боловч хэн ч Түүнийг таниагүй, гэсэн ч Тэр Өөрийн ажлыг үргэлжлүүлж, Сүнснийг төлөөлөн үүнийг хийдэг. Чи Түүнийг хүн юм уу Бурхан, Эзэн юм уу Христ гэж дуудсан ч, эсвэл Түүнийг эгч гэж дуудсан ч энэ нь хамаагүй. Харин Түүний хийдэг ажил Сүнснийх бөгөөд Бурханы Өөрийн ажлыг төлөөлдөг. Хүн Өөрийг нь ямар нэрээр дуудаж байгааг Тэр анхаардаггүй. Тэрхүү нэр Түүний ажлыг тодорхойлж чадах уу? Чи Түүнийг юу гэж дуудахаас үл хамааран, Бурханы тухайд гэвэл Тэрээр Бурханы Сүнсний махбод болсон бие юм; Тэр Сүнснийг төлөөлж, Сүнсээр сайшаагддаг. Хэрвээ чи шинэ эрин үед зориулсан замыг тавьж, хуучин эрин үеийг төгсгөж, шинэ эрин үеийг эхлүүлж, эсвэл шинэ ажил хийж чадахгүй бол чамайг Бурхан гэж нэрлэж болохгүй!

Ариун Сүнсний ашигладаг хүн хүртэл Бурханыг Өөрийг нь төлөөлж чадахгүй. Тийм хүн Бурханыг төлөөлж чадахгүйгээс гадна түүний хийдэг ажил ч бас Бурханыг шууд төлөөлж чадахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, хүний туршлагыг Бурханы удирдлага дотор шууд тавьж болохгүй бөгөөд энэ нь Бурханы удирдлагыг төлөөлж чадахгүй. Бурханы Өөрийн хийдэг ажил нь тэр чигтээ удирдлагын төлөвлөгөөндөө Түүний хийхээр зорьдог ажил бөгөөд агуу удирдлагатай хамаатай юм. Хүний хийдэг ажил нь өөрсдийн хувийн туршлагаар хангахаас бүрддэг. Энэ нь, өмнө явсан хүмүүсийнхээс давсан туршлагын шинэ замыг олж, Ариун Сүнсний удирдамж дор байх зуураа ах эгч нараа залж чиглүүлэхээс бүрддэг. Энэ хүмүүс хувийн туршлага, эсвэл сүнслэг хүмүүсийн сүнслэг бичвэрээр хангадаг. Тэднийг Ариун Сүнс ашигладаг хэдий ч тэдний

хийдэг ажил зургаан мянган жилийн төлөвлөгөөний агуу удирдлагын ажилтай холбоогүй. Тэд бол биелүүлэх чиг үүрэг нь дуусаж, эсвэл амьдрал нь төгсөх хүртэл Ариун Сүнсний урсгал дахь хүмүүсийг удирдахын тулд өөр өөр цаг хугацаанд Ариун Сүнсний өргөсөн хүмүүс төдий юм. Тэдний хийдэг ажил нь Бурханд Өөрт нь зориулсан тохиромжтой замыг бэлдэж, эсвэл газар дээрх Бурханы Өөрийн удирдлагын тодорхой талыг үргэлжлүүлэхийн төлөө байдаг. Энэ хүмүүс өөрсдөө Түүний удирдлагын агуу ажлыг хийж чадахгүй, шинэ замыг ч нээж чадахгүй, тэр ч бүү хэл тэдний хэн нь ч өмнөх эрин үеийн Бурханы бүх ажлыг төгсгөж чадахгүй. Тиймээс тэдний хийдэг ажил нь бүтээгдсэн зүйл чиг үүргээ биелүүлж байгааг л төлөөлдөг бөгөөд Бурхан Өөрөө үйлчлэлээ гүйцэтгэж байгааг төлөөлдөггүй. Яагаад гэвэл, тэдний хийдэг ажил Бурханы Өөрийн хийсэн ажилтай адилгүй. Шинэ эрин үеийг эхлүүлэх ажил нь Бурханы оронд хүний хийж чадах зүйл биш. Үүнийг Бурханаас Өөрөөс нь өөр хэн ч хийж чадахгүй. Хүний хийдэг бүх ажил нь бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ гүйцэтгэж байгаагаас бүрддэг бөгөөд Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөж, эсвэл гэгээрүүлэх үед хүн үүнийг хийдэг. Энэ хүмүүсийн өгдөг удирдамж нь өдөр тутмын амьдрал дахь хэрэгжүүлэлтийн замыг болон Бурханы хүсэлтэй зохицолтойгоор хэрхэн үйлдэх ёстойг хүнд харуулахаас бүрддэг. Хүний ажил Бурханы удирдлагатай холбоогүй, Сүнсний ажлыг ч төлөөлдөггүй. Жишээ нь, Витнес Ли, Ватчман Ни хоёрын ажил нь зам заах явдал байсан юм. Зам шинэ ч бай, эсвэл хуучин ч бай, тухайн ажил Библийн дотор үлдэх зарчимд үндэслэсэн байв. Орон нутгийн чуулганыг сэргээхийн төлөө байсан ч бай, эсвэл барьж байгуулахын төлөө байсан ч бай, тэдний ажил чуулгануудыг байгуулахтай холбоотой байсан юм. Тэдний хийсэн ажил Есүс болон Түүний элчүүдийн дуусгалгүй орхисон ажил буюу Нигүүлслийн эрин үед цааш хөгжөөгүй ажлыг үргэлжлүүлжээ. Өөрсдийнхөө ажлаар тэдний хийсэн зүйл нь, тухайн үеийн ажилдаа Есүсийн дараагийн үеийнхнээсээ шаардсан зүйл болох толгойгоо бүтээх, баптисм хүртэх, талх хуваах, эсвэл дарс уух гэх мэтийг сэргээхийн төлөө байлаа. Тэдний ажил Библийг баримталж, Библи дотроос замыг эрж хайх явдал байсан гэж хэлж болно. Тэд ямар ч шинэ ахиц дэвшил гаргаагүй. Тиймээс тэдний ажлаас хүн, Библи доторх шинэ замуудын нээлтийг, мөн түүнчлэн илүү сайн, илүү бодитой хэрэгжүүлэлтүүдийг л харж чадна. Гэхдээ тэдний ажлаас хүн Бурханы одоогийн хүслийг олж чадахгүй, эцсийн өдрүүдэд Бурханы хийхээр төлөвлөдөг шинэ ажлыг олж бүр ч чадахгүй. Учир нь тэдний алхсан зам хуучин зам хэвээр байсан—ямар ч шинэчлэлт, ямар ч ахиц дэвшил байгаагүй. Тэд

Есүсийн цовдлолын бодит баримттай зууралдаж, гэмшиж, нүглээ улайхыг хүмүүсээс шаардах дадлыг баримталж, эцсээ хүртэл тэвчсэн хүн аврагдах болно, эрэгтэй хүн бол эмэгтэй хүний тэргүүн бөгөөд эмэгтэй хүн нөхөртөө захирагдах ёстой гэсэн үгийг мөрдөж, тэр ч бүү хэл эгч нар номлож болохгүй, зөвхөн дуулгавартай дагах ёстой гэсэн уламжлалт үзлийг мөрдсөөр байв. Хэрвээ ийм маягийн удирдлагыг үргэлжлүүлэн мөрдсөн бол Ариун Сүнс шинэ ажлаа хэрэгжүүлж, хүмүүсийг дүрэм журмаас чөлөөлж, эсвэл тэднийг эрх чөлөө болон гоо сайхны ертөнц рүү хөтөлж хэзээ ч чадахгүй байх байлаа. Тиймээс эрин үеийг өөрчилдөг ажлын энэ үе шатанд Бурхан Өөрөө ажиллаж, үг хэлэх шаардлагатай байдаг; эс бөгөөс ямар ч хүн Түүний оронд ингэж хийж чадахгүй. Одоог хүртэл энэ урсгалаас гаднах Ариун Сүнсний бүх ажил зогсонги байдалд орж, Ариун Сүнсний ашигласан хүмүүс өөрсдийн тулгуурыг алдсан. Тиймээс Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн ажил нь Бурханы Өөрийн хийдэг ажлаас ялгаатай тул тэдний ялгамж чанар болон тэд хэний нэрийн өмнөөс үйлддэг нь ч бас өөр байдаг. Яагаад гэвэл, Ариун Сүнсний хийхээр зорьдог ажил өөр бөгөөд үүнээс үүдэн, адилхан ажил хийж байгаа хүмүүст өөр өөр ялгамж чанар болон байр суурийг олгодог. Ариун Сүнсний ашигладаг хүмүүс бас зарим нэг шинэ ажил хийж болох ба урьдын эрин үед хийгдсэн зарим ажлыг таягдан хаяж бас болох боловч тэдний хийдэг зүйл шинэ эрин үе дэх Бурханы зан чанар болон хүслийг илэрхийлж чадахгүй. Тэд зөвхөн хуучин эрин үеийн ажлыг халахын тулд л ажилладаг бөгөөд Бурханы Өөрийн зан чанарыг шууд төлөөлөх зорилгоор шинэ ажил хийхийн тулд ажилладаггүй. Иймд тэд хэчнээн олон хоцрогдсон хэрэгжүүлэлтийг цуцалж, эсвэл хэчнээн олон шинэ хэрэгжүүлэлт нэвтрүүлэх нь хамаагүй, хүнийг болон бүтээгдсэн зүйлийг төлөөлсөн хэвээр байдаг. Харин Бурхан Өөрөө ажил гүйцэтгэх үед хуучин эрин үеийн хэрэгжүүлэлтийг цуцалсныг ил тод зарладаггүй, шинэ эрин үе эхэлснийг шууд тунхагладаггүй. Тэр Өөрийнхөө ажилд шууд шулуухан байдаг. Тэрээр Өөрийн хийхээр зорьсон ажлыг шууд хийдэг; өөрөөр хэлбэл, Тэр Өөрийн авчирсан ажлыг шууд илэрхийлж, Өөрийн ажлыг анх зорьсноороо шууд хийж, Өөрийн оршихуй болон зан чанарыг илэрхийлдэг. Хүний харж байгаагаар, Түүний зан чанар болон Түүний ажил ч гэсэн өмнөх эрин үеүдийнхээс өөр байдаг. Гэвч Бурханы Өөрийн үзэл бодлоор бол энэ нь ердөө Түүний ажлын үргэлжлэл, цаашдын хөгжил юм. Бурхан Өөрөө ажиллах үедээ үгээ илэрхийлж, шинэ ажлыг шууд авчирдаг. Эсрэгээрээ, хүн ажиллах үед энэ нь нягтлан цэгнэж, судлах замаар, эсвэл бусдын ажилд суурилсан хэрэгжүүлэлтийг системчлэх, мэдлэгээ

өргөжүүлэх замаар хийгддэг. Өөрөөр хэлбэл, хүний хийдэг ажлын мөн чанар нь тогтсон дэг журмыг дагаж, “хуучин замаар шинэ гуталтай алхах” явдал мөн. Энэ нь, Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн алхдаг зам ч гэсэн Бурханы Өөрийн нээсэн зам дээр үндэслэдэг гэсэн үг юм. Тиймээс, эцсийн эцэст хүн бол хүн, Бурхан бол Бурхан билээ.

Исаак Абрахамаас төрсөнтэй адилаар Иохан амлалтаар төрсөн. Есүсийн замыг засаж, ихээхэн ажил хийсэн боловч тэр Бурхан байгаагүй юм. Харин ч тэр ердөө Есүсийн төлөөх замыг тавьсан учраас эш үзүүлэгчдийн нэг байлаа. Түүний ажил ч бас асар их байсан бөгөөд түүнийг зам тавьсны дараа л Есүс Өөрийн ажлыг албан ёсоор эхэлсэн юм. Мөн чанартаа тэр зүгээр л Есүсийн төлөө хөдөлмөрлөсөн, түүний хийсэн ажил нь Есүсийн ажилд үйлчилж байв. Иоханыг зам засаж дууссаны дараа Есүс Өөрийн ажлыг буюу илүү шинэ, илүү тодорхой, илүү дэлгэрэнгүй ажлыг эхэлжээ. Иохан ажлын эхний хэсгийг л хийсэн; шинэ ажлын илүү их хэсгийг Есүс хийсэн юм. Иохан ч гэсэн шинэ ажил хийсэн боловч шинэ эрин үеийг эхлүүлсэн нэгэн байгаагүй. Иохан амлалтаар төрсөн бөгөөд түүний нэрийг тэнгэрэлч өгсөн. Тухайн үед зарим нь түүнийг аавынх нь нэрээр Зехариа гэж нэрлэхийг хүсэж байсан боловч эх нь “Энэ хүүхдийг тэр нэрээр нэрлэж болохгүй. Түүнийг Иохан гэж нэрлэх ёстой” гэж хэлжээ. Энэ нь бүгд Ариун Сүнсний тушаалаар болсон юм. Есүсийг ч бас Ариун Сүнсний тушаалаар нэрлэсэн, Тэрээр Ариун Сүнснээс төрсөн бөгөөд Түүнийг Ариун Сүнс амласан байв. Есүс бол Бурхан, Христ, мөн хүний Хүү байлаа. Гэхдээ Иоханы ажил ч бас агуу байсан атал яагаад түүнийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Есүсийн хийсэн ажил болон Иоханы хийсэн ажлын хооронд яг ямар ялгаа байсан юм бэ? Иохан Есүсийн замыг зассан нэгэн байсан гэдэг нь цорын ганц шалтгаан байсан уу? Эсвэл үүнийг Бурхан урьдчилан тогтоосноос болсон уу? Хэдийгээр Иохан ч бас “Та нар гэмшицгээ: учир нь тэнгэрийн хаанчлал ойрхон байна” хэмээн хэлж, тэнгэрийн хаанчлалын тухай сайн мэдээг номлож байсан боловч түүний ажил цаашид хөгжилгүй, ердөө л эхлэлийг бүрдүүлсэн юм. Эсрэгээрээ, Есүс шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөл болгосон, гэхдээ Тэр бас Хуучин Гэрээний хуулийг биелүүлсэн билээ. Түүний хийсэн ажил Иоханыхаас илүү агуу байснаас гадна Тэрээр бүх хүн төрөлхтнийг золин аврахаар ирсэн—Тэр ажлын тэрхүү үе шатыг гүйцэлдүүлсэн юм. Иоханы тухайд бол тэр зүгээр л замыг бэлдсэн. Хэдийгээр ажил нь агуу, үг нь олон, дагаж байсан шавь нар нь тоо томшгүй олон байсан боловч түүний ажил хүмүүст шинэ эхлэлийг авчрахаас хэтрээгүй. Хүн түүнээс амь, зам юм уу илүү

гүн гүнзгий үнэнийг хүлээн аваагүй, мөн түүгээр дамжуулан Бурханы хүслийг ч ойлгоогүй. Иохан нь Есүсийн ажилд зориулсан шинэ газрыг нээж, сонгогдсон хүмүүсийг бэлдсэн агуу эш үзүүлэгч (Елиа) байсан юм; тэрээр Нигүүлслийн эрин үеийн анхдагч байлаа. Зүгээр л хэвийн хүний гадаад төрхийг нь ажиглаад ийм зүйлсийг ялган таних боломжгүй. Ялангуяа Иохан нэлээд их ажил хийсэн, мөн түүнчлэн түүнийг Ариун Сүнс амласан байсан ба ажлыг нь Ариун Сүнс дэмжиж байсан. Ийм болохоор хийдэг ажлаар нь л дамжуулан тэдний тус тусын ялгамж чанарыг хүн ялгаж чадна, учир нь хүний мөн чанарыг гадаад төрхөөс нь ялгаж мэдэх ямар ч аргагүй, мөн хүний хувьд, Ариун Сүнсний гэрчлэл юу болохыг тогтоох ямар ч аргагүй. Иохан, Есүс хоёрын хийсэн ажил адилгүй байсан бөгөөд өөр шинж чанартай байсан. Иохан Бурхан мөн байсан уу, үгүй юү гэдгийг хүн үүнээс тодорхойлж болно. Есүсийн ажил эхлүүлж, үргэлжлүүлж, дуусгаж, үр дүнд хүргэхийн төлөө байв. Тэрээр эдгээр үе шат болгоныг гүйцэтгэсэн байхад Иоханы ажил эхлэл тавихаас хэтрээгүй. Эхэндээ Есүс сайн мэдээ түгээж, гэмшлийн замыг тунхагласан ба дараа нь хүнд баптисм хүртээж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулж байлаа. Эцэст нь Тэр хүн төрөлхтнийг нүглээс золин аварч, бүхий л эрин үеийн төлөөх Өөрийн ажлыг дуусгасан юм. Түүнчлэн хаа сайгүй явж, хүнд номлож, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээжээ. Энэ талаараа Иохан Тэр хоёр адилхан байсан бөгөөд ялгаа нь Есүс шинэ эрин үеийг эхлүүлж, хүнд Нигүүлслийн эрин үеийг авчирсан юм. Түүний амнаас, Нигүүлслийн эрин үед хүний хэрэгжүүлэх ёстой үг, хүний дагах ёстой зам гарч, эцэст нь Тэрээр золин авралын ажлыг дуусгажээ. Ийм ажлыг Иохан хэзээ ч хийж чадахгүй байх байв. Иймд Бурханы Өөрийн ажлыг Есүс хийсэн ба Тэр бол Бурханыг шууд төлөөлдөг Бурхан Өөрөө байсан билээ. Хүний үзлээр бол, амлалтаар төрж, Сүнснээс төрж, Ариун Сүнсээр дэмжүүлж, шинэ замуудыг нээдэг бүх хүн бол Бурхан юм. Энэ тайлбарын дагуу бол Иохан ч гэсэн Бурхан байх байсан ба Мосе, Абрахам, Давид... ч гэсэн мөн л Бурхан байх байв. Энэ нь туйлын инээдтэй зүйл биш гэж үү?

Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхээсээ өмнө Есүс ч бас Ариун Сүнсний хийсэн бүхэнтэй нийцүүлэн үйлдэж байсан хэвийн л нэг хүн байлаа. Тухайн үед Өөрийн ялгамж чанарыг мэдэж байсан эсэхээс үл хамааран Тэрээр Бурханаас ирсэн бүхнийг дуулгавартай дагаж байв. Түүний үйлчлэл эхлэхээс өмнө Ариун Сүнс Түүний ялгамж чанарыг хэзээ ч илчлээгүй. Өөрийн үйлчлэлийг эхэлснийхээ дараа л Тэр тэдгээр дүрэм журам, хуулийг хүчингүй болгож, Өөрийн үйлчлэлийг албан ёсоор гүйцэтгэж эхэлсний дараа л Түүний үгэнд эрх мэдэл, хүч чадал

шингэсэн юм. Үйлчлэлээ эхэлснийх нь дараа л шинэ эрин үеийг бий болгох Түүний ажил эхэлжээ. Үүнээс өмнө Ариун Сүнс Түүний дотор 29 жилийн турш нуугдмал хэвээр үлдсэн, энэ хугацаанд Тэр зөвхөн хүнийг төлөөлсөн бөгөөд Бурханы ялгамж чанаргүй байсан юм. Түүнийг ажиллаж, үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхэд Бурханы ажил эхэлсэн, хүн Өөрийг нь хэр их мэдэж байгааг үл хайхран Тэрээр дотоод төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа хийсэн бөгөөд Түүний хийсэн ажил Бурханыг Өөрийг нь шууд төлөөлж байлаа. Тухайн үед Есүс эргэн тойрныхоо хүмүүсээс “Та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуусан юм. Тэд: “Та бол эш үзүүлэгчдээс хамгийн агуу нь бөгөөд бидний сайн эмч билээ” хэмээн хариулжээ. Бас зарим нь “Та бол бидний тэргүүн тахилч” гэсэн юм... Төрөл бүрийн хариулт өгөгдөж, зарим нь бүр Түүнийг Иохан, мөн Елиа гэж хэлжээ. Дараа нь Есүс Симон Петрт хандан “Чи Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуухад Петр “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” гэж хариулсан байна. Тэр үеэс эхлээд хүмүүс Тэр бол Бурхан гэдгийг мэддэг болсон. Түүний ялгамж чанар мэдэгдэх үед анх мэдсэн хүн нь Петр байсан бөгөөд түүний амаар энэ нь хэлэгджээ. Тэгэхэд Есүс “Чиний хэлсэн зүйлийг мах цус чамд илчлээгүй, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм” хэмээн өгүүлсэн. Түүнийг баптисм хүртсэний дараа бусад хүн энэ тухай мэдэж байсан эсэх нь хамаагүй, Түүний хийсэн ажил Бурханы өмнөөс хийгдсэн юм. Тэрээр ялгамж чанараа илчлэхийн тулд биш, Өөрийн ажлыг хэрэгжүүлэхийн тулд ирсэн билээ. Петр энэ тухай хэлсний дараа л Түүний ялгамж чанар хүнд ил болсон юм. Тэр бол Бурхан Өөрөө байсан гэдгийг мэдэж байгаа эсэхээс чинь үл хамааран, цаг нь болоход Тэр ажлаа эхлүүлсэн. Чи үүнийг мэдэж байсан ч бай, үгүй ч бай, Тэр Өөрийн ажлыг урьдынх шигээ үргэлжлүүлсэн юм. Чи үүнийг үгүйсгэсэн ч гэсэн Тэр мөн л Өөрийн ажлыг гүйцэтгэх байсан ба цаг нь болоход үүнийг хийх л байсан. Хүн махбодыг нь мэдээсэй гэсэндээ биш, харин Өөрийнх нь ажлыг хүлээн аваасай гэсэндээ Тэр ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэхээр ирсэн билээ. Хэрвээ чи өнөө үеийн ажлын үе шат нь Бурханы Өөрийн ажил гэдгийг танин мэдэж чадаагүй бол чамд үзэгдэл дутагдаж байна. Гэсэн ч чи ажлын энэ үе шатыг үгүйсгэж чадахгүй; танин мэдэж чадахгүй байгаа чинь Ариун Сүнс ажиллахгүй байгааг, эсвэл Түүний ажил буруу гэдгийг нотлохгүй. Одоогийн ажлыг Библи дэх Есүсийн ажилтай тулгаад, таарч тохирохгүй байгаа зүйлийг нь ашиглан ажлын энэ үе шатыг үгүйсгэдэг хүмүүс ч бий. Энэ нь харалган хүний үйлдэл биш гэж үү? Библид тэмдэглэгдсэн зүйлс хязгаарлагдмал; тэдгээр нь Бурханы ажлыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Дөрвөн сайн мэдээ нийлээд зуугаас цөөхөн

бүлэгтэй ба тэнд Есүс инжрийн модыг хараасан, Петр Эзэнийг гурван удаа үгүйсгэсэн, Есүс цовдлол болон амиллынхаа дараа шавь нартаа харагдсан, мацаг барих тухай сургаал, залбирлын тухай сургаал, салалтын тухай сургаал, Есүсийн төрөлт ба угийн бичиг, Есүс шавь нараа томилсон тухай гэх мэт хязгаарлагдмал тооны үйл явдлыг бичсэн байдаг. Гэсэн хэдий ч хүн тэдгээрийг эрдэнэс мэт үнэлж, бүр өнөөдрийн ажлыг тэдгээртэй харьцуулан шалгадаг. Тэр ч бүү хэл тэд Есүсийн амьдралдаа хийсэн бүх ажил нь ердөө тийм хэмжээтэй, Бурхан ердөө тийм зүйлийг л хийх чадвартай ба илүү ихийг хийж чадахгүй гэж итгэдэг. Энэ нь утгагүй хэрэг биш гэж үү?

Есүсийн газар дээр өнгөрүүлсэн хугацаа нь гучин гурван жил хагас байсан, өөрөөр хэлбэл, Тэр газар дээр гучин гурван жил хагас амьдарчээ. Энэ хугацааны ердөө гурван жил хагасыг л Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхэд зарцуулсан; үлдсэн хугацаанд нь Тэр зүгээр л хэвийн хүний амьдралаар амьдарсан юм. Эхэндээ Тэр синагогын үйл ажиллагаанд оролцож, тахилчдын Судар тайлбарлахыг болон бусдын номлохыг тэнд сонсдог байлаа. Тэрээр Библийн талаар ихээхэн мэдлэг олж авсан юм: Тэр тийм мэдлэгтэй төрөөгүй бөгөөд уншиж, сонссоноор л үүнийг олж авсан юм. Тэр арван хоёр настай байхдаа синагогын багш нараас “Эртний эш үзүүлэгчдийн зөгнөлүүд юу байсан бэ? Мосегийн хуулийн тухайд ямар вэ? Хуучин Гэрээний тухайд? Сүмд тахилчийн хувцастайгаар Бурханд үйлчилж байгаа хүний тухайд ямар вэ? ...” гэх мэт асуултуудыг асуусан нь Библид тодорхой тэмдэглэгджээ. Тэр олон асуулт асуусан, учир нь Түүнд мэдлэг ч, ойлголт ч байгаагүй юм. Хэдийгээр Тэр Ариун Сүнснээс олдсон ч гэсэн бүхэлдээ хэвийн хүн болон төрсөн; Тэр тодорхой нэг онцгой зан араншинтай байсан боловч бас л хэвийн хүн байсан юм. Түүний мэргэн ухаан, бие хаа болон настай нь хамааралтайгаар тасралтгүй өссөн бөгөөд Тэр хэвийн хүний амьдралын үе шатыг туулжээ. Хүмүүсийн төсөөллөөр бол Есүс ямар ч хүүхэд нас, өсвөр насыг туулаагүй; Тэр төрмөгцөө гучин гурван настай хүний амьдралаар амьдарч эхэлсэн ба ажлаа дуусгаад цовдлогдсон. Тэр магадгүй хэвийн хүний амьдралын үе шатыг туулаагүй; юм иддэггүй, бусад хүнтэй ч харилцдаггүй байсан, хүмүүсийн хувьд Түүнийг зэрвэс харахад амаргүй байсан. Тэр Бурхан байсан учраас магадгүй Өөрийг нь харсан хүмүүсийг айлгах гажигтай нэгэн байсан байх. Махбодод ирдэг Бурхан хэвийн хүн шиг амьдардаггүй нь лавтай гэж хүмүүс итгэдэг; Тэр ариун хүн учраас шүдээ юм уу нүүрээ угаах хэрэггүй цэвэрхэн гэж тэд итгэдэг. Эдгээр нь гагцхүү хүний үзэл биш гэж үү? Библид Есүсийн хувь хүний амьдралын талаар тэмдэглээгүй

зөвхөн Түүний ажлын тухай байдаг боловч Түүнд хэвийн хүн чанар байгаагүй, эсвэл Тэр гучин нас хүртлээ хэвийн хүний амьдралаар амьдраагүй гэдгийг энэ нь нотолдоггүй. Тэр 29 насандаа ажлаа албан ёсоор эхэлсэн боловч тэр наснаас өмнө хүний хувиар өнгөрөөсөн Түүний бүх амьдралыг чи няцааж болохгүй. Библи ердөө тэр хугацааг тэмдэглэлдээ оруулаагүй; Түүний амьдрал нь хэвийн хүний амьдрал байсан ба бурханлаг ажлынх нь цаг үе байгаагүй тул бичиж тэмдэглэх хэрэггүй байлаа. Есүсийг баптисм хүртэхээс өмнө Ариун Сүнс шууд ажиллаагүй, харин Есүсийн үйлчлэлээ гүйцэтгэх өдөр болох хүртэл Түүний амьдралыг жирийн хүн байдлаар байлгаж байв. Хэдийгээр Тэр бие махбодтой болсон Бурхан байсан боловч хэвийн хүний адилаар нас бие гүйцэх үйл явцыг туулсан билээ. Нас бие гүйцэх үйл явцыг Библиэс хассан. Энэ нь хүний амийн өсөлтөд ямар ч тусламж үзүүлж чадахгүй учраас үүнийг хассан юм. Баптисм хүртэхээс өмнөх хугацаа нь нууцлаг үе байсан ба Тэр ямар ч тэмдэг, гайхамшиг үзүүлээгүй. Есүс баптисм хүртсэнийхээ дараа л хүн төрөлхтнийг золин аврах бүх ажлыг буюу нигүүлсэл, үнэн болон хайр, өршөөлөөр элбэг дэлбэг ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажлын эхлэл нь бас яг нарийндаа Нигүүлслийн эрин үеийн эхлэл байв; энэ шалтгааны улмаас үүнийг бичиж тэмдэглэж, өнөөг хүртэл дамжуулжээ. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн хүмүүсийн хувьд, Нигүүлслийн эрин үеийн замаар алхах, цовдлолын замаар алхах замыг нээж, бүхнийг үр дүнд хүргэхийн төлөө байв. Хэдийгээр энэ нь хүний бичиж тэмдэглэсэн зүйлээс гарсан боловч энд, тэндээ жаахан алдаатай байхыг үл тооцвол бүгд бодит баримт билээ. Гэсэн хэдий ч, тийм тэмдэглэлүүдийг худал гэж хэлж болохгүй. Тэмдэглэгдсэн хэрэг явдал бүхэлдээ баримттай, гагцхүү тэдгээрийг бичихдээ л хүмүүс алдаа гаргасан юм. Хэрвээ Есүс хэвийн, эгэл хүн чанартай байсан юм бол яаж тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвартай байсан байх юм бэ? хэмээн хэлэх зарим хүн бий. Есүсийн туулсан дөчин өдрийн сорилт нь гайхамшигт тэмдэг бөгөөд хэвийн хүний биелүүлж чадахгүй зүйл юм. Түүний дөчин өдрийн сорилт нь Ариун Сүнсний ажилд харьяалагдаж байсан; тэгэхээр Түүнд өчүүхэн төдий ч ер бусын зүйл байхгүй гэж хүн хэлж яахан чадах юм бэ? Түүний тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвар нь Тэр бол хэвийн хүн биш, харин ер бусын хүн байсан гэдгийг нотолдоггүй; ердөө л Ариун Сүнс Түүн шиг хэвийн хүн дээр ажиллаж, улмаар Түүнийг гайхамшиг үзүүлж, бүр ч агуу ажил хийх боломжтой болгосон юм. Үйлчлэлээ гүйцэтгэхээс өмнө, эсвэл Библид бичсэнчлэн Ариун Сүнс Өөр дээр нь бууж ирэхээс өмнө Есүс зүгээр л хэвийн хүн байсан ба огтхон ч ер бусын биш байв. Ариун Сүнс Түүн дээр бууж ирэх үед

буюу үйлчлэлээ эхлүүлэх үед нь Түүнд ер бусын зүйл шингэжээ. Ийм маягаар хүн, Бурханы махбод болсон биед хэвийн хүн чанар байхгүй гэж итгэж эхэлдэг; түүнчлэн, бие махбодтой болсон Бурханд хүн чанар байхгүй, бурханлаг чанар л байдаг гэж эндүүрэн боддог. Мэдээж, Бурханыг ажлаа хийхээр газар дээр ирэх үед хүн ер бусын үйл явдлуудыг л хардаг. Түүний ажил болон үг тэдний хувьд ойлгохын аргагүй, хүрэхийн аргагүй байдаг учраас нүдээрээ харж, чихээрээ сонсдог зүйл нь бүгд ер бусын байдаг. Хэрвээ тэнгэрийн ямар нэг зүйлийг газарт авчирсан бол тэр нь ер бусын байхаас өөр яах юм бэ? Хүн ойлгошгүй, ухааршгүй, дэндүү гайхалтай, ухаалаг нууц болох тэнгэрийн хаанчлалын нууцуудыг газарт авчрах үед—тэдгээр нь бүгд ер бусын байдаг бус уу? Гэхдээ, энэ нь хэчнээн ер бусын байсан ч бүх зүйл Түүний хэвийн хүн чанар дотор хийгддэг гэдгийг чи мэдэх ёстой. Бурханы махбод болсон биед хүн чанар байдаг; эс бөгөөс Тэр Бурханы махбод болсон бие биш байх байв. Өөрийнхөө цаг үед Есүс асар олон гайхамшиг үзүүлсэн. Тухайн үеийн израильчуудын харсан зүйл нь ер бусын зүйлсээр дүүрэн байсан; тэд тэнгэрэлчүүд болон элч нарыг харж, Еховагийн дуу хоолойг сонссон. Эдгээр нь бүгд ер бусын байгаагүй гэж үү? Мэдээж, өнөөдөр хүнийг ер бусын зүйлсээр мэхэлдэг зарим муу ёрын сүнс бий; өнөө үед Ариун Сүнсний хийдэггүй ажлаар дамжуулан хүнийг мэхлэх нь тэдний хувьд дуурайж байгаа явдал төдийхөн юм. Олон хүн гайхамшиг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг; эдгээр нь муу ёрын сүнсний ажлаас өөр юу ч биш, учир нь Ариун Сүнс өнөө үед тийм ажил хийхээ больсон бөгөөд Ариун Сүнсний тухайн үеийн ажлыг дараа нь дуурайсан бүх хүн бол үнэндээ муу ёрын сүнснүүд юм. Тухайн үед Израильд хийгдсэн бүх ажил ер бусын байсан хэдий ч Ариун Сүнс одоо тийм байдлаар ажилладаггүй бөгөөд одоогийн тийм ямар ч ажил бол Сатан дуурайж, дүр үзүүлж байгаа хэрэг, мөн түүний үймээн самуун юм. Гэхдээ ямар ч ер бусын зүйл муу ёрын сүнснээс гардаг гэж чи хэлж болохгүй—энэ нь Бурханы ажлын эрин үеэс хамаарна. Өнөө үед бие махбодтой болсон Бурханы хийсэн ажлыг аваад үз: Үүний ямар тал нь ер бусын биш вэ? Түүний үг чиний хувьд ойлгохын аргагүй, биелүүлэхийн аргагүй байдаг бөгөөд Түүний хийдэг ажлыг ямар ч хүн хийж чадахгүй. Түүний ойлгодог зүйлийг хүн ер ойлгох аргагүй, мөн Түүний мэдлэг хаанаас ирдгийг ч хүн мэдэхгүй. “Би ч гэсэн Тантай адил хэвийн хүн, тэгвэл би яагаад Таны мэддэг зүйлийг мэддэггүй юм бэ? Би насаар ахмад, туршлагаар арвин атал Та яаж миний мэддэггүй зүйлийг мэддэг юм бэ?” гэж зарим хүн хэлдэг. Хүний тухайд гэвэл, энэ бүхэн нь хүн хүрэхийн аргагүй зүйл юм. Тэгтэл, “Израильд хийгдсэн

ажлын талаар хэн ч мэддэггүй, Библийг тайлбарлагчид хүртэл ямар ч тайлбар хийж чаддаггүй; Та яаж ер нь мэддэг юм бэ?” гэдэг хүмүүс ч бий. Эдгээр нь бүгд ер бусын хэрэг явдал биш гэж үү? Тэрээр ямар ч гайхамшиг туулаагүй мөртөө бүхнийг мэддэг; Тэрээр хамгийн амархнаар үг хэлж, үнэнийг илэрхийлдэг. Энэ нь ер бусын биш гэж үү? Түүний ажил махан биеийн хүрч чадах зүйлээс даван гардаг. Махан биетэй ямар ч хүний бодлоор үүнийг биелүүлэхийн аргагүй бөгөөд хүний уураг тархи үүнийг огтоос бодож чадахгүй. Хэдийгээр Тэр Библийг огт уншаагүй ч Израиль дахь Бурханы ажлыг ойлгодог. Тэр газар дээр зогсоод ярьж байгаа хэдий ч гуравдагч тэнгэрийн нууцуудын тухай ярьдаг. Эдгээр үгийг унших үед: “Энэ нь гуравдагч тэнгэрийн хэл биш гэж үү?” гэсэн мэдрэмж хүнийг эзэмддэг. Эдгээр нь бүгд хэвийн хүний биелүүлж чадах зүйлээс давсан хэрэг явдал биш гэж үү? Есүс дөчин өдөр мацаг барих тэр үе ер бусын байгаагүй гэж үү? Хэрвээ чи дөчин өдрийн мацаг нь ямартай ч ер бусын бөгөөд муу ёрын сүнсний үйл хэрэг мөн гэж хэлэх юм бол Есүсийг яллаж байгаа бус уу? Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээсээ өмнө Есүс хэвийн хүнтэй адил байсан. Тэр ч бас сургуульд сурсан; тэгээгүй бол Тэр яаж уншиж, бичиж сурах юм бэ? Бурхан махбод болох үед Сүнс махбод дотор нуугдан оршиж байв. Гэсэн хэдий ч, хэвийн хүн байсан болохоор Түүний хувьд өсөж, нас бие гүйцэх үйл явцыг туулах шаардлагатай байсан бөгөөд танин мэдэх чадвар нь төлөвшиж, аливаа зүйлийг ялган салгаж чадах хүртлээ Тэр хэвийн хүн гэж тооцогдсон билээ. Хүн чанар нь төлөвшсөний дараа л Тэр Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж чадсан юм. Хэвийн хүн чанар нь хараахан төлөвшөөгүй, бодол нь үндэслэлгүй байх үед Тэр яаж үйлчлэлээ хэрэгжүүлж чадах юм бэ? Зургаа юм уу долоон настайдаа үйлчлэлээ хэрэгжүүлэхийг Түүнээс хүлээж болохгүй нь лавтай! Анх махбод болох үедээ Бурхан яагаад Өөрийгөө ил тод харуулаагүй юм бэ? Яагаад гэвэл, Түүний махбодын хүн чанар хараахан төлөвшөөгүй байсан; Өөрийн махбодын сэтгэхүйн үйл явц, мөн түүнчлэн энэ махбодын хэвийн хүн чанарыг Тэр бүрэн эзэмшээгүй байв. Ийм учраас ажлаа эхлэхээсээ өмнө Тэрээр, Өөрийн ажлыг махбодоор хийхэд хангалттай зэвсэглэсэн байх хэмжээнд хэвийн хүн чанар болон хэвийн хүний эрүүл саруул сэтгэлгээг зайлшгүй эзэмших шаардлагатай байсан билээ. Хэрвээ Тэр энэ ажилд тэнцэхгүй байсан бол Түүний хувьд үргэлжлүүлэн өсөж, төлөвших шаардлагатай байх байв. Есүс Өөрийн ажлыг долоо юм уу найман насандаа эхэлсэн бол хүн Түүнийг гоц авьяастан гэж үзэх байсан биш гэж үү? Бүх хүн Түүнийг хүүхэд гэж бодох байсан бус уу? Хэн Түүнд үнэмших юм бэ? Зогсож байгаа индрээсээ өндөргүй долоо юм уу найман настай

хүүхэд—номлоход тохирох байсан уу? Хүн чанар нь төлөвшихөөс өмнө Тэр уг ажилд тэнцээгүй. Хараахан төлөвшөөгүй байсан Түүний хүн чанарын тухайд гэвэл, ажлын ихээхэн хэсэг нь ердөө биелүүлэхийн аргагүй байлаа. Махбод дахь Бурханы Сүнсний ажил нь бас өөрийн гэсэн зарчимд захирагддаг. Хэвийн хүн чанарыг эзэмших үедээ л Тэр ажлыг өөртөө авч, Эцгийн даалгаврыг хүлээн авч чадна. Зөвхөн тэр үед л Тэрээр Өөрийн ажлыг эхэлж болох юм. Хүүхэд насандаа Есүс, эрт цагт тохиолдсон ихэнх зүйлийн талаар ердөө ойлгож чадахгүй байсан ба синагогын багш нараас асууж байж л ойлгож авчээ. Хэрвээ Тэр дөнгөж ярьж сурангуутаа л ажлаа хийж эхэлсэн бол Түүний хувьд ямар ч алдаа гаргахгүй байх боломжтой байх байсан уу? Бурхан яаж алдаа гаргаж болох юм бэ? Тиймээс ажиллаж чаддаг болсныхоо дараа л Тэр Өөрийн ажлыг эхэлсэн; Тэр үүнийг хийх бүрэн чадвартай болтлоо ямар ч ажил гүйцэтгээгүй. Хорин есөн настайдаа Есүс аль хэдийн нэлээд төлөвшсөн байсан бөгөөд Түүний хүн чанар, хийх гэж байсан ажлаа явуулахад нь тохирохуйц болсон байлаа. Тэр үед л Бурханы Сүнс албан ёсоор Түүн дотор ажиллаж эхэлсэн юм. Тэр үед Иохан Түүнд зориулсан замыг нээхийн тулд долоон жилийн турш бэлдсэн бөгөөд ажлаа дуусгасны дараа шоронд оржээ. Тэгээд ачаа бүхэлдээ Есүс дээр унасан. Хэрвээ Тэр энэ ажлыг 21 юм уу 22 насандаа, хүн чанар нь дутуу дулимаг байх үед, дөнгөж нас биед хүрэх үедээ, мөн олон зүйлийг ойлгоогүй байхдаа хүлээн авсан бол хяналтыг гартаа авч чадахгүй байх байлаа. Тухайн үед, Есүсийг ажлаа эхлэхээс өмнө Иохан өөрийн ажлыг аль хэдийн хэсэг зуур хийчихсэн байсан ба тэгэхэд Есүс аль хэдийн дунд эргэм настай байв. Тийм насандаа Түүний хэвийн хүн чанар нь Өөрийн хийх ёстой ажлыг хийхэд хангалттай болсон байлаа. Одоо, бие махбодтой болсон Бурхан ч бас хэвийн хүн чанартай бөгөөд хэдийгээр та нарын дундах арай ахмадуудтай нь харьцуулахуйц төлөвшөөгүй ч гэсэн энэхүү хүн чанар нь Түүний ажлыг биелүүлэхэд хэдийнээ хангалттай. Өнөөдрийн ажлын орчин нөхцөл Есүсийн үеийнхтэй бүхэлдээ адилхан биш. Есүс яагаад арван хоёр элчийг сонгосон бэ? Энэ нь бүгд Түүний ажлыг дэмжиж, хамтран ажиллахын төлөө байв. Нэг талаар энэ нь тухайн үеийн Түүний ажлын суурийг тавихын төлөө, харин нөгөө талаар, ирэх өдрүүд дэх Түүний ажилд суурь тавихын төлөө байсан юм. Тухайн үеийн ажилтай нийцүүлэн арван хоёр элчийг сонгох нь Есүсийн хүсэл, мөн түүнчлэн Бурханы Өөрийн хүсэл байлаа. Арван хоёр элчийг сонгоод, дараа нь газар сайгүй номлоход тэднийг залж чиглүүлэх ёстой гэж Тэр итгэж байв. Гэхдээ өнөөдөр та нарын дунд ингэх хэрэггүй! Бие махбодтой болсон Бурхан

махбодоор ажиллах үед олон зарчим байдаг бөгөөд хүний ердөө ойлгодоггүй олон зүйл байдаг; Бурханыг хэмжихдээ, эсвэл Бурханд хэт их шаардлага тавихдаа хүн өөрийн үзлийг байнга ашигладаг. Гэхдээ одоо ч гэсэн, өөрсдийнх нь мэдлэг ганцхан өөрсдийнх нь үзлээс бүрддэг гэдгийг олон хүн огт мэддэггүй. Бурханы бие махбодтой болсон эрин үе юм уу газар ямар ч байсан бай, махбод дахь Түүний ажлын зарчим өөрчлөгдөлгүй үлддэг. Тэр махбод болчихоод махбодоосоо даван гарч ажиллаж чадахгүй; тэр ч бүү хэл махбод болчихоод махбодын хэвийн хүн чанар дотор ажиллахгүй байж чадахгүй. Эс бөгөөс Бурхан бие махбодтой болохын ач холбогдол үгүй болж, Үг махбод болсон гэдэг нь тэр чигтээ утгагүй болох байв. Түүнчлэн, Бурхан бие махбодтой болсныг зөвхөн тэнгэр дэх Эцэг (Сүнс) мэдэх ба өөр хэн ч, бүр махбод Өөрөө ч, эсвэл тэнгэрийн элч нар ч мэдэхгүй. Ийм болохоор махбод дахь Бурханы ажил бүр ч илүү хэвийн байж, Үг үнэхээр махбод болсныг бүр ч сайн илчилж чадах бөгөөд махбод гэдэг нь жирийн, хэвийн хүн гэсэн үг юм.

Зарим хүн: “Эрин үеийг яагаад Бурхан Өөрөө эхлүүлэх ёстой юм бол? Бүтээгдсэн зүйл Түүнийг орлож болохгүй гэж үү?” хэмээн гайхширч магадгүй. Бурхан махбод болсон нь шинэ эрин үеийг эхлүүлэх тодорхой зорилготой байсан ба мэдээж шинэ эрин үеийг эхлүүлэхдээ Тэрээр хуучин эрин үеийг ч нэгэн зэрэг дуусгасан байх болно гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Бурхан бол Эхлэл ба Төгсгөл; Тэр Өөрөө ажлаа явуулдаг тул Тэр Өөрөө л өмнөх эрин үеийг төгсгөх ёстой. Энэ нь Тэр Сатаныг ялж, дэлхийг байлдан дагуулдгийн баталгаа. Тэр Өөрөө хүмүүсийн дунд ажиллах бүрд энэ нь шинэ тулааны эхлэл байдаг. Шинэ ажлыг эхлүүлэлгүйгээр хуучныг нь дуусгана гэж мэдээж үгүй. Хуучныг нь дуусгаагүй байх үед Сатантай хийх тулаан хараахан төгсгөлдөө очоогүйг энэ нь нотолно. Зөвхөн Бурхан Өөрөө хүмүүсийн дунд ирж, шинэ ажил гүйцэтгэх л юм бол хүн Сатаны эзэмшлээс бүрэн чөлөөлөгдөж, шинэ амьдрал, шинэ эхлэлийг олж авч чадна. Эс бөгөөс, хүн үүрд хуучин эрин үед амьдарч, Сатаны хуучин нөлөөн дор үүрд амьдарна. Бурханы удирдаж буй эрин үе бүрд хүний нэг хэсэг сул чөлөөтэй болж, тэгснээр хүн Бурханы ажилтай хамт шинэ эрин үе рүү урагшилдаг. Бурханы ялалт гэдэг нь Түүнийг дагадаг бүх хүний ялалт юм. Хэрвээ бүтээгдсэн хүн төрөлхтөнд эрин үеийг төгсгөх үүрэг өгсөн бол хүний үзэл бодлоор ч бай, эсвэл Сатаныхаар ч бай, энэ нь Бурханыг эсэргүүцэж, Түүнээс урвах, мөн Бурханд дуулгаваргүй байхаас цаашгүй байх байсан бөгөөд хүний ажил Сатаны хэрэгсэл болох байв. Бурханы Өөрийн эхлүүлсэн эрин үед хүн дуулгавартай байж, Бурханыг дагасан үед л Сатаныг бүрэн үнэмшүүлж чадна,

учир нь энэ бол бүтээгдсэн зүйлийн үүрэг билээ. Тиймээс та нар зөвхөн дагаж, дуулгавартай байх хэрэгтэй бөгөөд үүнээс илүүг та нараас шаарддаггүй гэж Би хэлдэг. Энэ нь, хүн бүр үүргээ сахиж, тус тусын чиг үүргээ гүйцэтгэх гэдгийн учир юм. Бурхан Өөрийнхөө ажлыг хийдэг ба хүн Түүний оронд хийх хэрэггүй байдаг, мөн Тэр бүтээгдсэн зүйлийн ажилд ч оролцдоггүй. Хүн өөрийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Бурханы ажилд оролцдоггүй. Зөвхөн энэ л дуулгавартай байдал, мөн Сатаны ялагдлын баталгаа билээ. Бурхан Өөрөө шинэ эрин үеийг эхлүүлж дууссанахаа дараа хүн төрөлхтний дунд ажиллахаар ирэхээ больдог. Зөвхөн тэр үед л хүн, бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлж, даалгавраа гүйцэтгэхээр шинэ эрин үе рүү албан ёсоор алхан ордог. Эдгээр нь Бурханы ажилладаг зарчмууд бөгөөд хэн ч зөрчиж болохгүй. Ийм маягаар ажиллах нь л ухаалаг, бас үндэслэлтэй юм. Бурханы ажлыг Бурхан Өөрөө хийдэг. Тэр Өөрийн ажлыг явуулж, Өөрийн ажлыг дуусгадаг. Тэрээр ажлыг төлөвлөж, удирддаг бөгөөд үүнээс ч илүүтэйгээр ажлыг үр дүнтэй болгодог. Библид өгүүлсэнчлэн “Би бол Эхлэл ба Төгсгөл; Би бол Тариалагч ба Хураагч.” Өөрийнх нь удирдлагын ажилтай холбоотой бүхнийг Бурхан Өөрөө хийдэг. Тэр бол зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний Захирагч; Тэр бүх зүйлийг гартаа атгаж байдаг тул өөр хэн ч Түүний ажлыг Түүний оронд хийж чадахгүй, хэн ч Түүний ажлыг дуусгаж чадахгүй. Дэлхий ертөнцийг бүтээсэн болохоор Тэрээр бүх ертөнцийг Өөрийнх нь гэрэлд амьдрахад хүргэнэ, бас бүхэл бүтэн эрин үеийг дуусгаж, улмаар Өөрийн бүх төлөвлөгөөг гүйцэлдүүлнэ!

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ (2)

Есүс Иудейд ажиллаж байх үедээ үүнийгээ ил тод хийсэн, харин одоо Би та нарын дунд нууцаар ажиллаж, үг хэлдэг. Үл итгэгчид үүнийг огт мэддэггүй. Та нарын дундах Миний ажил гадна байгаа хүмүүст хаалттай. Эдгээр үг, эдгээр гэсгээлт болон шүүлтийг бусдад биш, зөвхөн та нарт мэдэгддэг. Энэ бүх ажлыг та нарын дунд хийдэг ба зөвхөн та нарт нээлттэй байдаг; үл итгэгчдийн дундаас хэн ч үүнийг мэддэггүй, учир нь цаг нь хараахан ирээгүй байна. Энд байгаа энэ хүмүүс гэсгээлт туулсныхаа дараа бүрэн төгс болгуулах дөхөж байгаа боловч гадна буй хүмүүс энэ тухай юу ч мэддэггүй. Энэ ажил хэтэрхий их нуугдмал! Тэдний хувьд, махбод болсон Бурхан нуугдмал байдаг боловч энэ урсгалд байгаа хүмүүст нээлттэй байдаг гэж хэлж болно. Бурханд бүгд нээлттэй, бүгд илчлэгдсэн, бүгд чөлөөлөгдсөн байдаг боловч Түүнд итгэдэг хүмүүсийн хувьд л

ийм байдаг; бусад нь болох үл итгэгчдийн тухайд бол юу ч мэдэгддэггүй. Та нарын дунд болон Хятадад одоогоор хийгдэж байгаа ажлыг тэдэнд мэдэгдэхгүйн тулд чанд битүүмжилдэг. Тэд энэ ажлыг олж мэдэх юм бол үүнийг яллаж, хавчлага тулгахаас өөрийг хийхгүй. Тэд үүнд итгэхгүй. Агуу улаан лууны улс буюу хамгийн их хоцрогдсон энэ газар ажиллах нь амар даалгавар биш билээ. Хэрвээ энэ ажлыг ил гарган тавьсан бол үргэлжлүүлэх боломжгүй байх байсан юм. Ажлын энэ үе шатыг энэ газарт явуулж ердөө чадахгүй. Хэрвээ энэ ажлыг ил тод гүйцэтгэсэн бол үүнийг тэд яаж зөвшөөрч чадах юм бэ? Энэ нь ажлыг бүр ч их эрсдэлд оруулах бус уу? Хэрвээ энэ ажлыг нууцлаагүй, харин ч Есүс гайхамшигтай байдлаар өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөдөг байсан цаг үеийнхтэй адилаар явуулсан бол диаволууд аль хэдийн үүнийг “олзолчихсон” байх биш үү? Тэд Бурханы оршин тогтнолыг тэвчиж чадах уу? Хэрвээ Би одоо хүмүүст номлож, сургамжлахын тулд синагогт орсон бол Намайг аль хэдийн хэдэн хэсэг болгочих байсан биш үү? Хэрвээ тэгсэн бол Миний ажил яаж үргэлжлэн явагдаж чадах юм бэ? Тэмдэг, гайхамшгийг ил тод харуулахгүй байгаагийн шалтгаан нь бүхэлдээ нуун далдлахын төлөө юм. Иймээс үл итгэгчдэд Миний ажил харагдахгүй, мэдэгдэхгүй, эсвэл олдохгүй. Хэрвээ ажлын энэ үе шатыг Нигүүлслийн эрин үед Есүсийн хийсэнтэй адил байдлаар хийсэн бол одоогийнх шигээ ийм тогтвортой байж чадахгүй байсан. Иймд энэ маягаар нууцаар ажиллах нь та нарт болон ажилд бүхэлд нь ач тустай. Газар дээрх Бурханы ажил дуусах үед, өөрөөр хэлбэл, энэ нууц ажил төгсөх үед ажлын энэхүү үе шат ил тод болно. Хятадад бүлэг ялагч байгааг бүгд мэднэ; Бурхан Хятадад махбод болсон бөгөөд Түүний ажил дууссаныг бүгд мэднэ. Зөвхөн тэр үед л, Хятад улс яагаад хараахан уруудан доройтож, нуран унахгүй байна вэ? гэдэг нь хүнд ойлгомжтой болно. Бурхан Өөрийн ажлыг Хятадад биечлэн хийж байгаа ба бүлэг хүмүүсийг ялагч болгон төгс болгосон болж таардаг.

Махбод болсон Бурхан ажлаа биечлэн хийж байх энэ хугацаандаа бүх бүтээлд бус, Өөрийг нь дагадаг зарим хүнд л Өөрийгөө харуулдаг. Тэрээр хүнд Өөрийн дүрийг харуулахын төлөө бус, ажлынхаа нэг үе шатыг гүйцэлдүүлэхийн тулд л махбод болсон юм. Гэхдээ, ажлаа Өөрөө хийх ёстой учраас Түүний хувьд махбодоор үүнийг хийх шаардлагатай. Энэ ажил дуусахад Тэр хүний ертөнцийг орхино; хожмын ажилд саад болох вий гэсэндээ Тэр хүн төрөлхтний дунд удаан хугацаагаар үлдэж чадахгүй. Олон нийтэд Түүний харуулдаг зүйл нь зөвхөн Түүний зөвт зан чанар болон Түүний бүх үйл хэрэг болохоос хоёр удаа махбод болох үеийнх нь дүр биш юм, учир нь Бурханы дүрийг зан чанараар нь л

дамжуулан харж болохоос биш, Түүний махбод болсон биеийн дүрээр орлуулж болохгүй. Түүний махбодын дүр нь, махбодод ажиллаж байхад нь Түүнийг дагадаг хүмүүст буюу хязгаарлагдмал тооны хүмүүст л харагддаг. Ийм учраас одоо гүйцэтгэж байгаа ажлыг нууцаар хийдэг. Энэ нь, Есүс ажлаа хийх үедээ Өөрийгөө зөвхөн иудейчүүдэд л харуулаад, бусад улс үндэстэнд Өөрийгөө хэзээ ч ил харуулаагүйтэй адил юм. Тиймээс Өөрийн ажлыг дуусгамагцаа Тэрээр үлдэлгүй, хүний ертөнцөөс даруй явсан; дараа нь, Түүний энэ дүр Өөрийгөө хүнд харуулсан юм биш, харин Ариун Сүнс ажлыг шууд гүйцэтгэсэн юм. Махбод болсон Бурханы ажил бүрэн дуусмагц Тэрээр зуурдын ертөнцийг орхин одох бөгөөд махбодод байхдаа хийсэнтэйгээ адилхан ажлыг дахин хэзээ ч хийхгүй. Үүний дараа ажлыг бүгдийг нь Ариун Сүнс шууд хийдэг. Энэ хугацаанд хүн Түүний махбодын дүрийг бараг харж чаддаггүй; Тэр Өөрийгөө хүнд огтхон ч харуулдаггүй, харин үүрд нуугдмал үлддэг. Махбод болсон Бурханы ажлын цаг хугацаа хязгаарлагдмал. Үүнийг тодорхой эрин үе, цаг хугацаа, улс үндэстэн, тодорхой хүмүүсийн дунд хийдэг. Энэ ажил нь Бурханы бие махбодтой байх үеийн ажлыг л төлөөлдөг; энэ нь эрин үеийг төлөөлж, Бурханы Сүнсний тодорхой нэг эрин үед хийсэн ажлыг төлөөлдөг ба Түүний ажлыг бүхэлд нь төлөөлдөггүй. Тиймээс махбод болсон Бурханы дүр бүх хүнд харагдахгүй. Олон түмэнд харагддаг зүйл нь Бурханы зөвт байдал, зан чанар бүхэлдээ болохоос биш, хоёр удаа махбод болох үеийн Бурханы дүр биш юм. Ганц дүр нь ч хүнд харагддаггүй, хоёр дүр нь хамтдаа ч харагддаггүй. Тиймээс Бурханы махбод болсон бие хийх учиртай ажлаа дуусгамагцаа газар дэлхийг орхин явах шаардлагатай, учир нь Тэрээр Өөрийн хийх учиртай ажлыг л хийхээр ирдгээс биш Өөрийн дүрийг хүмүүст харуулах гэж ирдэггүй. Бурхан хоёр удаа махбод болсноор бие махбодтой болохын ач холбогдлыг аль хэдийн гүйцээсэн боловч Өөрийг нь өмнө нь хэзээ ч хараагүй улс үндэстэнд Өөрийгөө ил тод харуулахгүй. Есүс зөвт байдлын Нар болж Өөрийгөө иудейчүүдэд дахин хэзээ ч харуулахгүй, мөн Чидун уулан дээр зогсож, бүх хүнд ч үзэгдэхгүй; иудейчүүд Иудейд байх үеийн Есүсийн хөрөг зургийг л харсан. Учир нь, бие махбодтой болсон Есүсийн ажил хоёр мянган жилийн өмнө дууссан; Тэр дахин хэзээ ч иудей хүний дүрээр Иудейд эргэн ирэхгүй, тэр ч бүү хэл Иудейд байх үеийн дүрээрээ Харь үндэстнүүдийн алинд ч Өөрийгөө харуулахгүй, учир нь махбод болсон Есүсийн дүр ердөө л иудей хүний дүр бөгөөд Иоханы харсан хүний Хүүгийн дүр биш билээ. Есүс дахин ирнэ гэж дагалдагчдадаа амласан хэдий ч Харь үндэстнүүд дэх бүх хүнд иудей хүний дүрээр ердөө харагдахгүй.

Махбод болсон Бурханы ажил бол шинэ эрин үеийг нээх явдал гэдгийг та нар мэдэх учиртай. Энэхүү ажил хэдхэн жилээр хязгаарлагддаг ба Тэрээр Бурханы Сүнсний бүх ажлыг гүйцэлдүүлж чадахгүй, яг л иудей хүн болох Есүсийн дүр нь Иудейд ажиллаж байх үеийн Бурханы дүрийг л төлөөлж, цовдлолын ажил л хийж чадсантай адилхан. Есүс махбодод байх хугацаандаа эрин үеийг төгсгөх, эсвэл хүн төрөлхтнийг устгах ажлыг хийж чадаагүй. Тиймээс цовдлогдож, ажлаа дуусгасныхаа дараа Тэр хамгийн өндөрт гараад, хүнээс Өөрийгөө үүрд нуусан юм. Тэр цагаас эхлээд Харь үндэстнүүдийн үнэнч итгэгчид Эзэн Есүсийн илрэлийг харж чадалгүй, хананд наасан хөрөг зургийг нь л харах болсон. Энэ хөрөг зураг нь хүний зурсан зураг болохоос биш, Бурхан Өөрийгөө хүнд харуулах үеийн Бурханы дүр зураг биш юм. Бурхан хоёр удаа махбод болсон үеийн дүрээрээ олон түмэнд Өөрийгөө ил харуулахгүй. Хүн төрөлхтний дунд Бурханы хийдэг ажил нь Өөрийнхөө зан чанарыг ойлгуулахын төлөө байдаг. Өөр өөр эрин үеийн ажлаар дамжуулан энэ бүхнийг хүнд харуулдаг; Есүсийн илрэлээр дамжуулахын оронд Өөрийн мэдэгдсэн зан чанар болон хийсэн ажлаар дамжуулан үүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл, махбодын дүрээр дамжуулж биш, харин дүр төрх, хэлбэр галбир бүхий, бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэсэн ажлаар дамжуулан Бурханы дүр хүнд илчлэгддэг; ажлаар нь дамжуулан Түүний дүр харагдаж, зан чанар нь ил болдог. Энэ бол махбодоор хийхийг хүсдэг ажлынх нь ач холбогдол юм.

Хоёр удаа бие махбодтой болсон Бурханы ажил дуусмагц Тэр зөвт зан чанараа шүтлэггүй бүх улс үндэстэн даяар үзүүлж, Өөрийн дүрийг олон түмэнд харуулж эхэлнэ. Тэрээр зан чанараа харуулж, үүгээрээ өөр өөр төрлийн хүмүүсийн төгсгөлийг тодорхой болгож, улмаар хуучин эрин үеийг бүхэлд нь төгсгөнө. Махбод дахь Түүний ажил асар өргөн хүрээнд өргөждөггүйн шалтгаан нь (Есүс зөвхөн Иудейд ажиллаж байсан шиг өнөөдөр Би зөвхөн та нарын дунд ажилладаг) махбод дахь Түүний ажил зааг, хязгаартай байдаг. Тэр ердөө богино хугацааны ажлыг эгэл жирийн, хэвийн махбодын дүрээр гүйцэтгэж байгаа; Тэр үүрдийн ажил хийж, эсвэл шүтлэггүй улс үндэстнүүдийн ард түмэнд харагдах ажлыг хийхийн тулд Бурханы махбод болсон энэ биеийг ашиглаагүй. Махбод дахь ажил нь цар хүрээгээрээ л хязгаарлагдмал байж болох (зөвхөн Иудейд, эсвэл зөвхөн та нарын дунд ажиллах гэх мэт) бөгөөд дараа нь эдгээр хил хязгаар дотор хийгддэг ажлаар дамжин цар хүрээ нь өргөжиж болно. Мэдээж өргөжилтийн ажлыг Түүний Сүнс шууд гүйцэтгэдэг бөгөөд тэр үед Түүний махбод болсон биеийн ажил байхаа болино. Учир нь махбод дахь ажил

хил хязгаартай байдаг ба орчлон ертөнцийн бүх өнцөг буланд хүрч чадахгүй— үүнийг энэ нь биелүүлж чадахгүй. Махбод дахь ажлаар дамжуулан Түүний Сүнс дараагийн ажлыг нь гүйцэтгэдэг. Тиймээс махбодоор хийдэг ажил нь тодорхой хил хязгаар дотор гүйцэлддэг, эхлэлийн чанартай байдаг; үүний дараа Түүний Сүнс уг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, түүнчлэн өргөжүүлсэн цар хүрээнд үүнийг хийдэг.

Бурхан эрин үеийг залж чиглүүлэхийн тулд л газар дээр ажиллахаар ирсэн; Тэрээр шинэ эрин үеийг нээж, хуучныг нь төгсгөл болгох л зорилготой. Тэрээр хүний амьдралын замналыг газар дээр амьдран харуулж, хүний ертөнц дэх амьдралын баяр гунигийг Өөрөө мэдрэх гэж, тодорхой нэг хүнийг Өөрийн гараар төгс болгох гэж, эсвэл хэн нэгний өсөж байгааг биечлэн харах гэж ирээгүй. Энэ бол Түүний ажил биш; Түүний ажил бол ердөө шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөл болгох явдал. Өөрөөр хэлбэл, Тэр биечлэн шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь биечлэн төгсгөл болгоод, Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээр Сатаныг ялна. Өөрийн ажлыг биечлэн хийх болгондоо Тэр тулааны талбарт хөл тавьж байгаа мэт байдаг. Эхлээд Тэр махбодод байхдаа дэлхий ертөнцийг ялан дийлж, Сатаныг ялдаг; Тэр бүх алдрыг эзэмшиж, бүхэл бүтэн хоёр мянган жилийн ажлын оршлыг эхлүүлж, тэгснээрээ газар дээрх бүх хүнийг алхах зөв замтай, амар амгалан, баяр хөөртэй амьдрах амьдралтай болгодог. Гэхдээ Бурхан газар дээр хүнтэй хамт удаан амьдарч чадахгүй, учир нь Бурхан бол Бурхан бөгөөд эцсийн эцэст хүнтэй адилгүй юм. Тэр насан туршдаа хэвийн хүний амьдралаар амьдарч чадахгүй, өөрөөр хэлбэл, Тэр туйлын эгэл жирийн хүний байдлаар газар дээр оршин сууж чадахгүй, учир нь Түүний амьдралыг хангах хэвийн хүний хэвийн хүн чанар Түүнд тун бага байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан яаж газар дээр гэр бүлтэй болж, ажил мэргэжилтэй болж, үр хүүхдээ өсгөж чадах билээ? Энэ нь Түүний хувьд шившигтэй хэрэг болох биш үү? Түүнд байдаг хэвийн хүн чанар нь, хэвийн хүний адилаар гэр бүл, ажил мэргэжилтэй болох боломжийг Түүнд олгохын тулд биш, хэвийн байдлаар ажиллах зорилготой байдаг. Түүний эрүүл ухаан, хэвийн оюун санаа, Түүний махбодын хэвийн хооллолт болон хувцаслалт нь хэвийн хүн чанартай гэдгийг нь батлахад хангалттай; хэвийн хүн чанартай гэдгээ нотлохын тулд Тэр гэр бүлтэй, эсвэл ажил мэргэжилтэй байх хэрэггүй. Ингэх шаардлага огт байхгүй! Бурхан газар дээр ирнэ гэдэг нь Үг махбод болж байгаа хэрэг; Тэр зүгээр л хүнд үгээ ойлгуулж, үгээ харуулж байгаа, өөрөөр хэлбэл, махбодоор гүйцэтгэдэг ажлыг хүнд харуулж байгаа юм. Хүмүүс Түүний махбодод тодорхой

байдлаар хандах бус, харин эцсээ хүртэл дуулгавартай байх буюу Түүний амнаас гарах үг бүрд дуулгавартай байж, Түүний хийдэг бүх ажилд захирагдах нь Түүний санаа зорилго билээ. Тэр зүгээр л махбодод ажиллаж байгаа; Тэрээр Өөрийнх нь махбодын агуу, ариун байдлыг өргөмжлөхийг хүнээс зориуд шаардаж байгаа юм биш, харин Өөрийн ажлын мэргэн ухаан болон Өөрт байгаа бүх эрх мэдлийг хүнд харуулж байгаа юм. Тиймээс хэдийгээр Түүнд гайхамшигтай хүн чанар байгаа боловч Тэр огт зарладаггүй, хийх ёстой ажилдаа л анхаарлаа төвлөрүүлдэг. Бурхан махбод болсон ч Өөрийн хэвийн хүн чанарыг олон нийтэд зарлах юм уу гэрчлэхийн оронд яагаад зүгээр л хийхийг хүссэн ажлаа гүйцэтгэдэг болохыг та нар мэдэх ёстой. Тиймээс, бие махбодтой болсон Бурханаас та нар бурханлаг чанар нь юу болохыг л харж чадна; яагаад гэвэл, Өөрийнх нь хүн чанар бол хүний дуурайх зүйл гэж Тэр хэзээ ч зарладаггүй. Хүн бусдыг удирдах үедээ л тэдний бахдал бишрэл, итгэл үнэмшлийг илүү их олж авч, тэгснээрээ бусдыг манлайлахын тулд өөрөө хүн чанарын хувьд ямар вэ гэдэг тухайгаа ярьдаг. Гэтэл Бурхан гагцхүү Өөрийн ажлаар (өөрөөр хэлбэл, хүний хүршгүй ажил) дамжуулан хүнийг байлдан дагуулдаг; хүн Түүнийг гайхан бахдаж, эсвэл Түүнийг бишрэх эсэх нь чухал бус. Харин Тэрээр Өөрийг нь хүндэтгэх сэтгэлийг, эсвэл Өөрийнх нь ойлгогдошгүй байдлыг мэдрэх мэдрэмжийг л хүнд шингээдэг. Бурханд хүнээр бишрүүлэх шаардлага байхгүй; зан чанарыг нь хармагцаа чи Түүнийг хүндэтгэх нь л Түүнд хэрэгтэй. Бурханы хийдэг ажил бол Түүний Өөрийнх нь; хүн Түүнийг орлон хийж чадахгүй, мөн үүнд хүрч ч чадахгүй. Зөвхөн Бурхан Өөрөө л Өөрийнхөө ажлыг хийж, хүнийг шинэ амьдрал руу хөтлөхийн тулд шинэ эрин үеийг эхлүүлж чадна. Бурханы хийдэг ажил нь хүнийг шинэ амьдралтай болгож, шинэ эрин үе рүү оруулахын төлөө байдаг. Үлдсэн ажлыг нь хэвийн хүн чанартай, бусдаар шагшигдан гайхагдсан хүмүүст хүлээлгэн өгдөг. Тиймээс, Нигүүлслийн эрин үед Тэрээр махбодод байсан гучин гурван жилийнхээ ердөө гурван жил хагасын хугацаанд л хоёр мянган жилийн ажлыг гүйцэлдүүлсэн юм. Бурхан Өөрийн ажлыг гүйцэтгэхээр газар дээр ирэх үедээ хоёр мянган жилийн ажлыг буюу бүхий л эрин үеийн ажлыг ердөө хэдхэн жилийн дотор үргэлж дуусгадаг. Тэрээр оройтуулдаггүй ба хойшлуулдаггүй; цөөн хэдхэн жилийн дотор хийж дуусгах гэсэндээ л олон жилийн ажлыг товчилдог. Яагаад гэвэл, Түүний биечлэн хийдэг ажил бүхэлдээ, шинэ замыг нээж, шинэ эрин үеийг удирдахын төлөө байдаг билээ.

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ (3)

Бурхан ажлаа гүйцэтгэх үедээ ямар нэг бүтээн байгуулалт юм уу хөдөлгөөнүүдэд оролцдоггүй, харин Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхэлдэг. Түүнийг махбод болох болгонд энэ нь зөвхөн ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлж, шинэ эрин үеийг нээхийн төлөө л байдаг. Одоо Хаанчлалын эрин үе ирсэн, хаанчлалын сургалт ч бас ирсэн. Ажлын энэ үе шат нь хүний ажил биш, хүнийг тодорхой хэмжээнд боловсруулах явдал биш, харин Бурханы ажлын нэг хэсгийг л гүйцээх явдал юм. Түүний хийдэг зүйл хүний ажил биш, газар дэлхийг орхин явахаасаа өмнө хүнийг боловсруулахдаа тодорхой үр дүнд хүрэхийн төлөө биш; харин Өөрийн үйлчлэлийг биелүүлж, хийх учиртай ажлаа дуусгах явдал буюу газар дээрх ажилдаа зүй зохистой зохицуулалт хийж, улмаар алдрыг олж авах явдал юм. Бие махбодтой болсон Бурханы ажил нь Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийнхтэй адилгүй. Бурхан Өөрийн ажлыг газар дээр хийхээр ирэхдээ зөвхөн Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхэд л анхаардаг. Түүний үйлчлэлтэй холбоогүй бусад бүх хэрэг явдлын тухайд бол, Тэрээр бараг оролцдоггүй, бүр хараагүй мэт өнгөрүүлэхдээ тулдаг. Тэр зүгээр л хийх ёстой ажлаа хийдэг ба хүний хийх учиртай зүйлд хамгийн бага анхаардаг. Түүний хийдэг ажил нь гагцхүү Түүний байгаа эрин үе болон гүйцэтгэх учиртай үйлчлэлтэй нь хамаатай байдаг бөгөөд бусад бүх хэрэг явдал Түүний үйл ажиллагааны хүрээний гадна оршдог мэт байдаг. Тэрээр хүн төрөлхтний дунд нэг нь болж амьдрах тухай илүү үндсэн мэдлэгээр Өөрийгөө зэвсэглэдэггүй, нийгмийн илүү их ур чадварт ч суралцдаггүй, мөн хүний ойлгодог өөр бусад зүйлээр ч Өөрийгөө зэвсэглэдэггүй. Хүний эзэмших ёстой бүхнийг Тэр огт анхаардаггүй ба Өөрийнх нь үүрэг болох ажлыг л хийдэг. Иймээс, хүний харж байгаагаар бол, бие махбодтой болсон Бурхан маш их дутагдалтай болохоор хүнд байх учиртай олон зүйлд бүр анхаарлаа ч хандуулдаггүй, мөн тийм зүйлсийн талаар ямар ч ойлголтгүй байдаг. Амьдралын тухай ерөнхий мэдлэг, түүнчлэн биеэ авч явах, бусадтай харилцах зарчим Түүнд ямар ч хамаагүй мэт харагддаг. Гэхдээ чи бие махбодтой болсон Бурханаас өчүүхэн төдий ч хэвийн бус байдлыг мэдэрч чадахгүй. Өөрөөр хэлбэл, Түүний хүн чанар нь хэвийн хүний амьдрал болон уураг тархиных нь хэвийн ухааныг л хадгалан, зөв бурууг ялгах чадварыг Түүнд өгдөг. Гэхдээ Тэр өөр юугаар ч зэвсэглэдэггүй, энэ бүхэн нь гагцхүү хүний (бүтээгдсэн зүйлийн) эзэмших ёстой зүйл юм. Бурхан үйлчлэлээ хэрэгжүүлэхийн тулд л махбод болдог. Түүний ажил бүхий л эрин үед чиглэдэг ба ямар нэг хүн

юм уу газар луу биш, харин бүх орчлон ертөнцөд чиглэдэг. Энэ бол Түүний ажлын чиглэл, Түүний ажилладаг зарчим билээ. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, хүн үүнд оролцох ямар ч аргагүй. Бурхан махбод болох болгондоо тухайн эрин үеийн ажлыг авчирдаг бөгөөд хүнд Өөрийгөө илүү сайн ойлгуулж, мэдүүлэхийн тулд хүний дэргэд хорь, гуч, дөч, эсвэл бүр дал, наян жил амьдрах ямар ч санаа зорилго байдаггүй. Тэгэх шаардлагагүй! Ингэх нь Бурханы төрөлх зан чанарын талаарх хүний мэдлэгийг яавч гүнзгийрүүлэхгүй; харин ч хүний үзлийг л нэмэгдүүлж, хүний үзэл болон бодлыг хуучинсаг болгох байсан. Тиймээс бие махбодтой болсон Бурханы ажил яг юу болохыг та нар бүгд ойлговоос зохино. “Би хэвийн хүний амьдралыг туулахаар ирээгүй” гэж хэлснийг минь та нар мэдээж ойлгосон байлгүй дээ? “Бурхан хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд газар дээр ирээгүй” хэмээх үгийг та нар мартчихсан уу? Та нар Бурхан махбод болохын зорилгыг ойлгодоггүй, мөн “Бурхан яалаа гэж бүтээгдсэн зүйлийн амьдралыг туулах зорилгоор газар дээр ирэх юм бэ?” гэх үгийн утгыг ч мэддэггүй. Бурхан газар дээр гагцхүү Өөрийн ажлыг дуусгах гэж л ирдэг тул газар дээрх Түүний ажил түр зуурынх байдаг. Бие махбодоо чуулганыг удирдах гоц гойд хүн болгон боловсруулахад Бурханы Сүнснийг хүргэх санаа зорилгоор Тэр газар дээр ирдэггүй. Бурханыг газар дээр ирэхэд Үг махбод болдог; харин хүн Түүний ажлыг мэддэггүй ба Түүнд аливааг хүчээр тулгадаг. Гэхдээ, Бурхан бол Үг махбод болсон хэрэг болохоос бус, Бурханы үүргийг хэсэг зуур авахын тулд Бурханы Сүнсний боловсруулсан махан бие биш юм гэдгийг та нар бүгд ухаарах ёстой. Бурхан Өөрөө боловсруулалтын үр дүн биш, харин Үг махбод болсон хэрэг бөгөөд өнөөдөр Тэр та бүхний дунд Өөрийн ажлыг албан ёсоор гүйцэтгэдэг. Бурхан бие махбодтой болсон нь бодит үнэн гэдгийг та нар бүгд мэддэг, хүлээн зөвшөөрдөг ч үүнийг ойлгодог мэт авирладаг. Бие махбодтой болсон Бурханы ажлаас эхлээд Бурхан бие махбодтой болохын ач холбогдол, мөн чанарыг хүртэл, та нар эдгээрийг өчүүхэн ч ухаарч чаддаггүй бөгөөд зүгээр л үгийг үнэмшилтэйгээр цээжээр уншихад нь бусдыг дагадаг. Бие махбодтой болсон Бурхан чиний төсөөлдөгтэй адил гэж чи итгэж байна уу?

Бурхан гагцхүү эрин үеийг удирдаж, шинэ ажил явуулахын тулд махбод болдог. Та нар үүнийг ойлгох шаардлагатай. Энэ нь хүний чиг үүргээс ихээхэн өөр бөгөөд энэ хоёрыг эн зэрэгцүүлэн дурдаж болохгүй. Ажил гүйцэтгэхэд хүнийг ашиглахаас өмнө түүнийг удаан хугацааны турш боловсруулж, төгс болгох хэрэгтэй байдаг бөгөөд хүн чанар нь нэн өндөр түвшнийх байх хэрэгтэй байдаг. Хүн хэвийн хүн чанарын эрүүл ухаанаа хадгалж чаддаг байх ёстойгоор

үл барам, цаашлаад бусадтай харилцахдаа биеэ авч явах олон дүрэм, зарчмыг ойлгох ёстой, түүнчлэн хүний мэргэн ухаан, ёс зүйн мэдлэгийн талаар бүр ч ихийг сурах ёстой. Энэ бол хүний эзэмших ёстой зүйл. Гэвч махбод болсон Бурханы хувьд тийм биш, учир нь Түүний ажил хүнийг төлөөлдөггүй, хүний ажлыг ч төлөөлдөггүй; харин ч энэ нь Түүний оршихуйн шууд илэрхийлэл бөгөөд Түүний хийх учиртай ажлын шууд хэрэгжүүлэлт юм. (Мэдээж Түүний ажил тохиромжтой цагт хийгддэг болохоос санаандгүйгээр, хааш яаш хийгддэггүй бөгөөд үйлчлэлээ хэрэгжүүлэх цаг болоход энэ нь эхэлдэг.) Тэрээр хүний амьдрал, эсвэл хүний ажилд оролцдоггүй, өөрөөр хэлбэл, Түүний хүн чанарт эдгээрийн аль нь ч байдаггүй (гэхдээ энэ нь Түүний ажилд нөлөөлдөггүй). Цаг нь болоход Тэр Өөрийн үйлчлэлийг л хэрэгжүүлдэг; Түүний байр суурь ямар ч байсан Тэрээр хийх учиртай ажлаа зүгээр л хийдэг. Түүний талаар хүн юу мэддэг нь, мөн Түүний тухай ямар бодолтой байх нь Түүний ажилд ердөө нөлөөлдөггүй. Жишээ нь, Есүсийг ажлаа хийх үед Тэр яг хэн байсныг хэн ч мэдээгүй, гэхдээ Тэр зүгээр л ажлаа хийж байсан. Хийх учиртай ажлаа хийхэд нь эдгээрийн аль нь ч Түүнд саад болоогүй. Тиймээс Тэр эхэндээ Өөрийнхөө ялгамж чанарыг илчилж, зарлаагүй ба ердөө л хүнээр Өөрийгөө дагуулсан. Мэдээж энэ нь Бурханы даруу зан төдийгүй, бас махбодод ажилладаг арга зам нь байсан юм. Тэр ийм маягаар л ажиллаж чадах байлаа, учир нь хүн Түүнийг энгийн нүдээр хараад огт таних аргагүй байв. Хүн Түүнийг таньсан ч гэсэн Түүний ажилд тусалж чадахгүй байх байлаа. Үүнээс гадна, Тэрээр хүнд Өөрийнхөө махбодыг мэдэгдэх гэж бус, харин ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэхийн тулд махбод болсон юм. Энэ шалтгааны улмаас Тэр Өөрийн ялгамж чанарыг зарлахад ямар ч ач холбогдол өгөөгүй. Хийх учиртай бүх ажлаа дуусгасных нь дараа Түүний бүхий л ялгамж чанар, байр суурь хүнд аяндаа тодорхой болчихно. Махбод болсон Бурхан чимээгүй байдаг ба хэзээ ч, юуг ч тунхагладаггүй. Тэрээр хүнд ч, эсвэл хүн Өөрийг нь яаж дагаж байгаад ч анхаарал хандуулдаггүй, харин зүгээр л үйлчлэлээ хэрэгжүүлэн, хийх учиртай ажлаа гүйцэтгэдэг. Түүний ажилд хэн ч саад тотгор учруулж чадахгүй. Түүний хувьд ажлаа дуусгах цаг ирэхэд үүнийг гарцаагүй дуусгаж, төгсгөлд нь аваачих ба хэн ч өөрөөр тушааж чадахгүй. Түүнийг ажлаа дуусгаад хүнийг орхин одсоны дараа л хүн Түүний хийдэг ажлыг ойлгох боловч бүрэн тодорхой ойлгож мөн л чадахгүй. Түүний анх ажлаа хийж эхэлсэн санаа зорилгыг бүрэн ойлгохын тулд хүн урт удаан хугацаа зарцуулна. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы эрин үеийн ажлыг хоёр хэсэгт хувааж болно. Нэг хэсэг нь, Бурханы

Өөрийн махбод болсон биеийн хийдэг ажил болон Бурханы Өөрийн махбод болсон биеийн хэлдэг үгээс бүрддэг. Түүний махбодын үйлчлэл бүрэн дуусмагц Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн хийх, ажлын нөгөө хэсэг үлддэг. Энэ үед хүн чиг үүргээ гүйцэтгэх ёстой болдог, учир нь Бурхан аль хэдийн замыг нээчихсэн ба хүн өөрөө алхах хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, махбод болсон Бурхан ажлын нэг хэсгийг гүйцэтгээд, дараа нь Ариун Сүнс болон Ариун Сүнсний ашигладаг хүмүүс энэ ажлыг залгамжилна. Тиймээс, энэ үе шатанд, махбод болсон Бурханы голчлон гүйцэтгэдэг ажил юунд хүргэдгийг хүн мэдэх ёстой бөгөөд Бурхан махбод болохын ач холбогдол яг юу болохыг болон Түүний хийх учиртай ажил юу болохыг ойлгох ёстой болохоос хүнд тавьсан шаардлагын дагуу Бурханд шаардлага тавих ёсгүй. Энд хүний алдаа, түүний үзэл, үүнээс ч илүүтэйгээр түүний дуулгаваргүй байдал оршдог.

Бурхан махбод болох нь хүнд Өөрийн махбодыг мэдүүлэх зорилготой биш, эсвэл Бурханы махбод болсон бие болон хүний махан биеийн хоорондох ялгааг таниулах зорилготой биш; Бурхан хүний ялган таних чадварыг дадлагажуулахын тулд ч махбод болдоггүй, тэр ч бүү хэл, Бурханы махбод болсон биеийг шүтэн мөргөх боломжийг хүнд олгож, улмаар асар их алдрыг олж авах зорилгоор тэгдэггүй. Эдгээрийн аль нь ч Бурхан махбод болохын санаа зорилго биш. Бурхан хүнийг яллахын тулд, эсвэл зориуд хүнийг илчилж, түүнд хүндрэл учруулахын тулд махбод болдоггүй. Эдгээр зүйлийн аль нь ч Бурханы санаа зорилго биш. Бурхан махбод болох бүр нь ажлын зайлшгүй хэлбэр юм. Тэрээр хүний төсөөлдөг шалтгаанаар бус, харин Өөрийн илүү агуу ажил, илүү агуу удирдлагын төлөө ийнхүү үйлддэг. Бурхан зөвхөн ажлынхаа шаардлагаар л, хэрэгтэй үед л газар дээр ирдэг. Тэрээр зүгээр л эргэн тойрныг харах зорилгоор биш, харин Өөрийн хийх учиртай ажлыг гүйцэтгэхээр газар дэлхийд ирдэг. Эс бөгөөс Тэр яах гэж энэ ажлыг хийхийн тулд ийм хүнд ачаа үүрч, ийм агуу эрсдэл хүлээх билээ? Бурхан шаардлагатай үедээ л махбод болдог ба үргэлж өвөрмөц ач холбогдолтой байдаг. Хэрэв энэ нь ердөө хүмүүст Өөрийгөө харуулж, тэдний мэдлэгийн хүрээг тэлэхийн төлөө л байсан бол Тэрээр ийм хөнгөхнөөр хүмүүсийн дунд хэзээ ч ирэхгүй байсан нь лавтай. Тэрээр Өөрийн удирдлага болон агуу ажлын төлөө, мөн хүн төрөлхтнөөс илүү олныг олж авахын тулд газар дээр ирдэг. Түүнчлэн эрин үеийг төлөөлж, Сатаныг ялахаар ирдэг ба Сатаныг ялахын тулд махбодоор Өөрийгөө хувцасладаг. Үүнээс ч илүүтэйгээр, бүх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэхийн тулд Тэр ирдэг. Энэ бүхэн Түүний удирдлагатай хамаатай, бүх орчлон ертөнцийн ажилтай хамаатай.

Хэрвээ Бурхан хүмүүст Өөрийн махбодыг таниулж, хүмүүсийн нүдийг нээхийн тулд л махбод болсон бол яагаад бүх улсаар аялдаггүй юм бэ? Энэ нь туйлын амархан байх бус уу? Гэвч Тэр тэгээгүй, үүний оронд суурьшиж, хийх учиртай ажлаа эхлэхэд тохиромжтой газрыг сонгосон. Энэ махбод ганцаараа л гэхэд үлэмж ач холбогдолтой. Тэрээр эрин үеийг бүхэлд нь төлөөлж, бас бүхий л эрин үеийн ажлыг гүйцэтгэдэг; хуучин эрин үеийг төгсгөл болгохын сацуу шинэ эрин үеийг эхлүүлдэг. Энэ бүхэн нь Бурханы удирдлагатай холбоотой чухал асуудал бөгөөд энэ бүхэн нь газар дээр Бурханы гүйцэтгэхээр ирдэг ажлын нэг үе шатны ач холбогдол юм. Есүс газар дээр ирэхдээ зөвхөн зарим нэг үгийг хэлж, зарим ажлыг хийсэн; Тэр хүний амийн талаар санаа тавиагүй ба ажлаа дуусгамагцаа явсан. Өнөөдөр Би үг хэлж, Өөрийн үгийг та нарт дамжуулж дуусах үед, мөн та нар бүгд ойлгох үед амь чинь ямар байх нь хамаагүй, Миний ажлын энэ алхам дууссан байх болно. Хожим нь, Миний ажил дахь энэ алхмыг үргэлжлүүлж, эдгээр үгийн дагуу газар дээр үргэлжлүүлэн ажиллах зарим хүн байх ёстой; тэр үед хүний ажил болон хүний бүтээн байгуулалт эхэлнэ. Гэхдээ одоогоор, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж, ажлынхаа нэг алхмыг гүйцээхийн тулд Бурхан Өөрийн ажлыг л хийдэг. Бурхан хүнийхтэй адилгүй байдлаар ажилладаг. Хүн цуглаан, чуулга уулзалтад дуртай, баяр ёслолд чухал ач холбогдол өгдөг байхад Бурхан яг хүний цуглаан болон уулзалтуудыг л хамгийн их жигшдэг. Бурхан хүнтэй албан бусаар хэлэлцэж, ярилцдаг; энэ бол ер бусын чөлөөтэй агаад та нарыг чөлөөлдөг Бурханы ажил билээ. Гэхдээ Би та нартай хамт цугларахыг туйлын их жигшдэг ба та нарынх шиг их дэг журамтай амьдралд дасаж чаддаггүй. Би дүрэм журмыг хамгийн их жигшдэг; тэдгээр нь хүнийг үйлдэл хийхээс айж, үг хэлэхээс айж, дуулахаас айж, нүд нь чам руу гөлрөн ширтэх хүртэл хэмжээнд хязгаарладаг. Би та нарын цугларалтын байдлыг туйлаас жигшдэг, мөн томоохон цуглаануудыг үнэхээр жигшдэг. Би ийм маягаар та нартай цугларахаас татгалздаг, учир нь ийм байдалтай амьдрахад дөнгөлүүлсэн мэт санагддаг бөгөөд та нар хэтэрхий их баяр ёслол, хэтэрхий олон дүрэм журмыг мөрддөг. Хэрвээ та нарт хүмүүсийг удирдах боломж олгосон бол та нар бүгдийг нь дүрэм журмын эзэмшил рүү хөтлөх бөгөөд та нарын удирдлага дор хүмүүс дүрэм журмыг хаях ямар ч аргагүй байх байсан; харин шашны уур амьсгал улам бүр эрчимжиж, хүний дадлууд нэмэгдсээр байх байлаа. Зарим хүн цугларах үедээ үг хэлж, ярьсаар байдаг ба хэзээ ч залхдаггүй, зарим нь арав гаруй хоног зогсолтгүй номлож чадна. Эдгээрийг бүгдийг нь хүний томоохон цуглаан, уулзалтууд гэж тооцдог; тэдгээр нь идэж

уух болон эдэлж таашаах амьдралтай, эсвэл сүнсийг чөлөөлдөг амьдралтай огтхон ч хамаагүй. Бүгд уулзалт! Хамтран зүтгэгчдийн уулзалт, мөн том, жижиг цуглаанууд чинь бүгд Миний хувьд зэвүүцмээр байдаг бөгөөд Би хэзээ ч тэдгээрийг сонирхож байгаагүй. Энэ бол Миний ажилладаг зарчим: Би цуглааны үеэр номлохыг хүсдэггүй, мөн томоохон олон нийтийн цугларалт дээр ямар нэгэн юм тунхаглахыг ч хүсдэггүй, та бүхнийг хэдэн өдрийн онцгой хуралдаанд хуралдуулахыг бүр ч хүсдэггүй. Та нар цуглаан дээр бүгд ёсорхуу, зөв суух ёстой гэдгийг Би тохиромжтой гэж үздэггүй; ямар нэгэн ёслолын хязгаар дотор амьдарч байгааг чинь Би харах дургүй, үүнээс гадна Би та нарын тийм ёслолд оролцохоос татгалздаг. Та нар хэдий чинээ үүнийг хийнэ, энэ нь Надад төдий чинээ зэвүүцмээр санагддаг. Би та нарын энэ ёслол, дүрэм журмыг өчүүхэн төдий ч сонирхдоггүй; та нар тэдгээрийгээ хэчнээн сайн хийх нь хамаагүй Миний хувьд бүгд зэвүүцмээр байдаг. Та нарын зохицуулалт тохиромжгүй, эсвэл та нар хэтэрхий дорд байгаа юм биш; Би зүгээр л амьдралын хэв маягийг чинь жигшдэг, түүнээс гадна Би үүнд дасаж чаддаггүй. Та нар хийхийг хүсдэг ажлыг минь өчүүхэн ч ойлгодоггүй. Тухайн үед Есүс Өөрийн ажлыг хийж байхдаа, зарим газарт номлож дуусаад шавь нараа дагуулан хотоос гарч, ойлговол зохих замынх нь талаар тэдэнтэй ярилцдаг байв; Тэр ихэвчлэн ийм байдлаар ажилласан юм. Үй олон хүний дундах Түүний ажил ховорхон байлаа. Түүнээс шаарддаг зүйлийн чинь дагуу бол, махбод болсон Бурхан хэвийн хүний амьдралтай байх ёсгүй; Тэрээр ажлаа гүйцэтгэх ёстой ба сууж, зогсож, эсвэл алхаж байсан ч үг хэлэх ёстой. Тэр цаг ямагт ажиллах ёстой ба Өөрийн “үйл ажиллагааг” хэзээ ч зогсоож болохгүй, эс тэгвээс Тэр үүргээ цалгардуулах байсан. Хүний эдгээр шаардлага нь хүний эрүүл ухаанд зохистой юу? Та нарын ёс жудаг хаана байна вэ? Та нар хэтэрхий ихийг шаардаж байгаа бус уу? Ажиллаж байхдаа Би чамаар шалгуулах хэрэгтэй гэж үү? Үйлчлэлээ хэрэгжүүлж байхдаа Би чамаар хянуулах хэрэгтэй гэж үү? Ямар ажил хийх ёстойгоо болон хэзээ хийх учиртайгаа Би сайн мэддэг; бусад хүн хөндлөнгөөс оролцох хэрэггүй. Би төдийлөн ихийг хийгээгүй мэт чамд санагдаж магадгүй боловч тэр үед Миний ажил дуусаж байдаг. Жишээ нь, Дөрвөн Сайн мэдээн дэх Есүсийн үгийг аваад үз: Тэдгээр нь ч бас хязгаарлагдмал байгаагүй гэж үү? Тухайн үед Есүс синагогт орж, номлол айлдах үедээ хамгийн ихдээ л хэдэн минутын дотор дуусгасан бөгөөд ярьж дууссанахаа дараа шавь нараа дагуулан завь руу очиж, ямар ч тайлбаргүйгээр явж одсон. Хамгийн ихдээ л синагогт байсан хүмүүс үүнийг өөр хоорондоо хэлэлцсэн боловч Есүс үүнд оролцоогүй. Бурхан хийх учиртай ажлаа

л хийдэг, үүнээс илүү юу ч хийдэггүй. Тэгвэл одоо, өдөрт ядаж хэдэн цагийн турш илүү их ярьж, үг хэлэхийг олон хүн Надаас хүсдэг. Та нарын харж байгаагаар, Бурхан үг хэлэхгүй л бол Бурхан байхаа болих бөгөөд үг хэлдэг Нэгэн л Бурхан юм. Та нар бүгд сохор! Бүгд мал адгуус шиг! Бүгд ямар ч эрүүл ухаангүй, мэдлэггүй юмнууд! Та нарт хэтэрхий олон үзэл байдаг! Шаардлага чинь дэндүү их! Та нар хүний үнэргүй! Бурхан юу гэснийг ядаж ойлгодоггүй! Бүх илтгэгч болон уран илтгэгч бол Бурхан, та нарыг үгээр хангахад бэлэн байгаа хэн боловч та нарын эцэг гэж та нар итгэдэг. Надад хэл дээ, сайхан галбиртай, содон дүр төрхтэй та бүхэнд өчүүхэн төдий ч гэсэн эрүүл ухаан байгаа юу? Та нар тэнгэрнарыг одоогоор мэдэх үү! Та нар бүгдээрээ, шунахай агаад авлигад автсан албан тушаалтантай адилхан тул эрүүл ухааныг ойлгож яаж чадах билээ? Зөв бурууг ялгаж яаж чадах билээ? Би та нарт ихийг хайрласан боловч та нарын дундаас хэчнээн нь үүнийг үнэлсэн бэ? Үүнийг хэн бүрэн эзэмшсэн вэ? Өнөөдөр алхдаг замыг чинь хэн нээснийг та нар мэддэггүй тул Надад үргэлжлүүлэн шаардлага тавьж, эдгээр хөгийн, утгагүй шаардлагыг тавьдаг. Ичсэнээсээ болоод нүүр чинь улайхгүй байна уу? Би хангалттай яриагүй гэж үү? Би хангалттай хийгээгүй гэж үү? Та нарын дундаас хэн Миний үгийг үнэт эрдэнэс мэт үнэхээр нандигнадаг вэ? Та нар Миний өмнө Надад долигонодог боловч Миний ардуур худлаа ярьж, хуурдаг! Та нарын үйлдэл хэтэрхий жигшмээр бөгөөд Миний дургүйг хүргэдэг! Та нар амьдралаа өөрчлөхийн тулд биш, харин нүдээ хужирлаж, мэдлэгийн хүрээгээ тэлэх гэсэндээ л үг хэлж, ажиллахыг Надаас гуйдгийг чинь Би мэднэ. Би та нарт маш ихийг хэлсэн. Та нарын амьдрал аль хэдийн өөрчлөгдчих ёстой байсан, тэгтэл та нар яагаад одоо ч гэсэн хуучин байдлаа давтсаар байдаг юм бэ? Та нар Миний үгийг дээрэмдүүлчхээд, тэдгээрийг хүлээн аваагүй юм гэж үү? Үнэнийг хэлэхэд Би та нар шиг ийм доройтмол хүмүүст өөр юу ч хэлэхийг хүсдэггүй—энэ нь хий дэмий байх болно! Би ийм их үр ашиггүй ажил хийхийг хүсдэггүй! Та нар амийг олж авахыг биш, харин зөвхөн мэдлэгийн хүрээгээ тэлж, эсвэл нүдээ хужирлахыг л хүсдэг! Та нар бүгд өөрсдийгөө хуурч байна! Би та нараас асууя, та нартай нүүр тулан ярьсан зүйлийн минь хэр ихийг та нар хэрэгжүүлсэн бэ? Та нар бусдыг мэхлэхийн тулд заль гаргахаас өөрийг хийдэггүй! Та нарын дунд байгаа, үзэгч мэт харах дуртай хүмүүсийг Би жигшдэг бөгөөд сониуч зан чинь Миний хувьд гүнээ зэвүүцмээр байдаг. Хэрвээ үнэн замыг эрэлхийлэхийн тулд, эсвэл үнэнээр цангасандаа энд ирээгүй бол та нар Миний жигшлийн бай юм! Та нар сониуч зангаа хангахын тулд, эсвэл шуналт хүслийнхээ аль нэгийг биелүүлэхийн тулд л Миний ярихыг

сонсдог гэдгийг Би мэднэ. Та нарт үнэний оршин тогтнолыг эрж хайх, эсвэл амь руу орох зөв замыг судалж шинжлэх бодол байдаггүй; эдгээр шаардлага та нарын дунд ердөө оршдоггүй. Та нар Бурханыг судалж, гайхан бишрэх тоглоом мэт үздэгээс цаашгүй. Та нар амийг эрэлхийлэхдээ хэтэрхий бага хүсэл тэмүүлэлтэй байдаг боловч сониуч хүсэл чинь их байдаг! Тийм хүмүүст амийн замын тайлбарлах нь оргүй хоосонтой ярихтай адил; Би огт ярихгүй байсан нь дээр! Би та нарт хэлье! Хэрвээ та нар зүгээр л зүрх сэтгэл дэх хоосон зайгаа дүүргэхээр хичээж байгаа бол Над руу ирэхгүй байсан чинь дээр! Та нар амь олж авахад ач холбогдол өгөх учиртай! Өөрсдийгөө бүү хуур! Та нар сониуч зангаа амийн эрэл хайгуулынхаа үндэс болгож, эсвэл өөрсдөд чинь үгээ хэлэхийг Надаас гуйх шалтаг болгон ашиглахгүй байсан нь дээр. Энэ бүхэн нь та нарын тун сурамгай хийдэг заль мэх юм! Би чамаас дахин асууя: Орохыг шаардсан зүйлийн минь хэр их рүү чи үнэхээр орсон бэ? Чамд хэлсэн бүхнийг минь чи ухаарсан уу? Чамд хэлсэн бүхнийг чи хэрэгжүүлж амжсан уу?

Эрин үе бүрийн ажлыг Бурхан Өөрөө эхлүүлдэг боловч Бурхан ямар ч замаар ажилласан бай, Тэрээр та нарын өмнөөс ямар нэг хөдөлгөөн эхлүүлэх гэж, тусгай хурал хийх гэж, эсвэл ямар нэг байгууллага байгуулах гэж ирдэггүй гэдгийг чи мэдэх ёстой. Тэр Өөрийн хийх учиртай ажлыг гүйцэтгэхийн тулд л ирдэг. Түүний ажил ямар нэг хүний хязгаарлалтад автдаггүй. Тэр Өөрийн ажлыг хүссэнээрээ хийдэг; хүн үүний талаар юу бодож, юу мэдэж байгаагаас үл хамааран Тэрээр Өөрийн ажлыг гүйцэтгэхэд л анхаарлаа хандуулдаг. Дэлхийг бүтээснээс эхлээд өнөөдрийг хүртэл ажлын гурван үе шат байсан; Еховагаас Есүс хүртэл, Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе хүртэл Бурхан хэзээ ч хүмүүст зориулан тусгай хурал зарлаагүй, мөн олон улсын тусгай хурал зарлан хуралдуулж, тэгснээрээ Өөрийн ажлын хүрээг өргөжүүлэхийн төлөө бүх хүн төрөлхтнийг хэзээ ч цуглуулаагүй. Түүний хийдэг бүхэн нь, бүхий л эрин үеийн эхний ажлыг зөв цаг, зүй зохистой орон зайд гүйцэтгэж, улмаар эрин үеийг эхлүүлж, хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх явдал юм. Тусгай хурлууд нь хүний цугларалт юм; хүмүүсийг цуглуулж, баяр тэмдэглэх нь хүний л ажил. Бурхан амралтын өдрүүдийг мөрддөггүй, цаашлаад тэдгээрт зэвүүцдэг; Тэрээр тусгай хурал зарлан хуралдуулдаггүй ба тэдгээрийг ч бас зэвүүцмээр гэж үздэг. Одоо чи бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил яг юу болохыг ойлгосон байх ёстой!

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ (4)

Та нар Библийн ар дахь түүх болон туурвилыг мэдэх ёстой. Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүст ийм мэдлэг байдаггүй. Тэд мэддэггүй. Хэрвээ чи тэдэнд мөн чанарын эдгээр асуудлын талаар ний нуугүй ярьсан бол тэд Библийг хамгаалан зүтгэхээ болих байсан. Тэд, энэ үг биелсэн үү? Тэр үг биелсэн үү? хэмээн зөгнөгдсөн зүйлсийг байнга ухаж төнхөж байдаг. Тэд Библийн дагуу сайн мэдээг хүлээн зөвшөөрч, Библийн дагуу сайн мэдээ номлодог. Бурханд итгэх итгэл нь Библийн үгэнд тулгуурладаг; Библигүйгээр тэд Бурханд итгэхгүй. Тэд ийм байдалтай амьдарч, Библийг ухаж төнхөх байдлаар амьдардаг. Тэд дахин нэгэнтээ Библийг ухаж төнхөн, чамаас тайлбар хүсэх үед чи ийнхүү хэлнэ: “Эхлээд үг бүрийг баталгаажуулахгүй байцгаая. Харин Ариун Сүнс хэрхэн ажилладгийг харцгаая. Өөрсдийнхөө алхдаг замыг авч үзээд, энэ зам Ариун Сүнсний ажилтай үнэхээр нийцэж байгаа эсэхийг харахын тулд үнэнтэй харьцуулъя, мөн Ариун Сүнсний ажлыг ашиглаад тийм зам зөв эсэхийг шалгая. Энэ үг, эсвэл тэр үг зөгнөсний дагуу биелсэн эсэхийн тухайд гэвэл хүмүүс бид хошуу дүрэх ёсгүй. Харин ч бид Ариун Сүнсний ажлыг болон Бурханы хийсээр ирсэн сүүлийн үеийн ажлын талаар ярьсан нь дээр.” Библи дэх зөгнөлүүд бол тухайн үед эш үзүүлэгчдийн дамжуулсан Бурханы үг болон Бурханы ашиглаж байсан хүмүүсийн, онгод хүртээд бичсэн үг юм; Бурхан Өөрөө л тэдгээр үгийг тайлбарлаж чадна, Ариун Сүнс л тэдгээр үгийн утга учрыг мэдэгдэж чадна, мөн Бурхан Өөрөө л долоон лацыг эвдэж, хуйлмал номыг нээж чадна. “Чи Бурхан биш, би ч бас биш болохоор хэн Бурханы үгийг хөнгөхнөөр тайлбарлаж зүрхлэх юм бэ? Чи тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэх үү? Эш үзүүлэгч Иеремиа, Иохан, Елиа нар энд байсан ч гэсэн тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэхгүй, учир нь тэд бол Хурга биш билээ. Гагцхүү Хурга л долоон лацыг эвдэж, хуйлмал номыг нээж чадна, өөр хэн ч Түүний үгийг тайлбарлаж чадахгүй. Би Бурханы нэрийг булаан авч зүрхлэхгүй, Бурханы үгийг тайлбарлахаар оролдож бүр ч зүрхлэхгүй. Би Бурханд дуулгавартай байдаг нэгэн л байж чадна. Чи Бурхан юм уу? Бурханы бүтээлүүдийн нэг нь ч хуйлмал номыг нээж, тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэхгүй, иймээс би ч гэсэн тайлбарлаж зүрхлэхгүй. Чи тэдгээрийг тайлбарлахаар оролдоогүй нь дээр. Хэн ч тэдгээрийг тайлбарлахаар оролдох ёсгүй. Ариун Сүнсний ажлын талаар ярилцацгаая; хүн үүнийг л хийж чадна. Би Ехова, Есүс хоёрын ажлын талаар бага зэрэг мэддэг боловч тийм ажлыг биечлэн туулаагүй болохоор багахан

хэмжээнд л энэ талаар ярьж чадна. Тухайн үеийн Исаиа, эсвэл Есүсийн хэлсэн үгийн утгын тухайд гэвэл би ямар ч тайлбар хийхгүй. Би Библийг судалдаггүй, харин Бурханы өнөөгийн ажлыг дагадаг. Чи үнэндээ Библийг бяцхан хуйлмал ном мэт үздэг ч энэ нь Хурганы л нээж чадах зүйл биш гэж үү? Хурганаас өөр хэн үүнийг нээж чадах юм бэ? Чи Хурга биш, би өөрийгөө Бурхан Өөрөө гэж хэлж бүр ч зүрхлэхгүй, иймээс Библийг судалж, ухаж төнхөхгүй байцгаая. Ариун Сүнсний хийсэн ажлыг буюу Бурханы Өөрийн хийсэн өнөөгийн ажлыг хэлэлцсэн нь хавьгүй дээр. Бурханы ажилладаг зарчмууд юу болохыг, Түүний ажлын мөн чанар юу болохыг хараад, өнөөдөр бидний алхаж буй зам зөв эсэхийг магадлахын тулд эдгээрийг ашиглацгаая, ийм маягаар үүнийг тодорхой болгоцгооё” гэж чи хэлнэ. Хэрвээ та нар, ялангуяа шашны ертөнц дэх хүмүүст сайн мэдээ номлохыг хүсвэл Библийг ойлгож, үүний дотоод түүхүүдийг эзэмшсэн байх ёстой; эс бөгөөс, чиний хувьд сайн мэдээ номлох арга үгүй. Чи ерөнхий дүр зургийг эзэмшиж, Библийн үхмэл үгсийг нягтлан шинжлэхээ больж, зөвхөн Бурханы ажил болон амийн үнэний талаар ярьдаг болмогцоо үнэн сэтгэлээсээ эрж хайдаг хүмүүсийг олж авч чадна.

Еховагийн хийсэн ажил, Түүний тогтоосон хуулиуд, хүний амьдралыг залж чиглүүлдэг зарчмууд, Хуулийн эрин үед хийсэн ажлынх нь агуулга, хууль тогтооход өгсөн ач холбогдол, Нигүүлслийн эрин үе дэх ажлынх нь ач холбогдол болон сүүлчийн энэ үе шатанд Бурхан ямар ажил хийдэг: эдгээр нь та нарын ойлгох ёстой зүйл билээ. Эхний үе шат нь Хуулийн эрин үеийн ажил, хоёр дахь нь Нигүүлслийн эрин үеийн ажил бөгөөд гурав дахь нь эцсийн өдрүүдийн ажил юм. Та нар Бурханы ажлын эдгээр үе шатыг тодорхой ойлгох ёстой. Эхнээсээ дуустлаа нийт гурван үе шат байдаг. Ажлын үе шат болгоны мөн чанар юу вэ? Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний ажилд хэдэн үе шат хэрэгжсэн бэ? Эдгээр үе шатыг хэрхэн гүйцэтгэсэн, мөн яагаад тус бүрийг нь тодорхой арга замаар гүйцэтгэдэг вэ? Эдгээр нь бүгд амин чухал асуултууд билээ. Эрин үе болгоны ажилд бэлгэдлийн үнэ цэн байдаг. Ехова ямар ажил гүйцэтгэсэн бэ? Яагаад Тэр яг тийм маягаар хийсэн бэ? Яагаад Түүнийг Ехова гэж нэрлэсэн бэ? Бас Нигүүлслийн эрин үед Есүс ямар ажил гүйцэтгэсэн, Тэр ямар байдлаар үүнийг хийсэн бэ? Ажлын үе шат болгон нь, эрин үе бүр нь Бурханы зан чанарын ямар талуудыг төлөөлдөг вэ? Түүний зан чанарын ямар талууд Хуулийн эрин үед илэрхийлэгдсэн бэ? Нигүүлслийн эрин үед аль нь илэрхийлэгдсэн бэ? Тэгээд бас эцсийн эрин үед аль нь илэрхийлэгдсэн бэ? Эдгээр нь та нарын тодорхой ойлгох ёстой мөн чанарын асуултууд юм. Зургаан

мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний явцад Бурханы бүх зан чанар илчлэгдсэн. Энэ нь зөвхөн Нигүүлслийн эрин үед ч илчлэгдээгүй, зөвхөн Хуулийн эрин үед ч илчлэгдээгүй, тэр ч бүү хэл зөвхөн эцсийн өдрүүдийн энэ цаг хугацаанд ч илчлэгдээгүй. Эцсийн өдрүүдэд гүйцэтгэдэг ажил нь шүүлт, уур хилэн, гэсгээлтийг төлөөлдөг. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил нь Хуулийн эрин үеийн ажил болон Нигүүлслийн эрин үеийн ажлыг орлож чадахгүй. Гэвч энэ гурван үе шат нь хоорондоо холбогдон нэг болдог бөгөөд бүгдээрээ нэгэн Бурханы ажил юм. Мэдээж энэ ажлын гүйцэтгэл нь тусдаа эрин үеүдэд хуваагддаг. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил бүх зүйлийг төгсгөлд нь аваачдаг; Хуулийн эрин үед хийгдсэн нь эхлэлийн ажил байсан; Нигүүлслийн эрин үед хийгдсэн нь золин авралын ажил байсан. Бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх ажлын үзэгдлүүдийн тухайд бол хэн ч ухаарч, ойлгож чадахгүй бөгөөд эдгээр үзэгдэл нь оньсого хэвээр үлддэг. Эцсийн өдрүүдэд, Хаанчлалын эрин үеийг эхлүүлэхийн тулд үгийн ажил л хийгддэг боловч энэ нь бүх эрин үеийг төлөөлдөггүй. Эцсийн өдрүүд нь эцсийн өдрүүдээс хэтрэхгүй, Хаанчлалын эрин үеэс хэтрэхгүй бөгөөд Нигүүлслийн эрин үеийг, эсвэл Хуулийн эрин үеийг төлөөлдөггүй. Эцсийн өдрүүдэд ердөө л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх бүх ажил та нарт илчлэгддэг. Энэ бол нууцыг тайлж байгаа хэрэг. Ийм төрлийн нууц нь ямар ч хүний тайлж чадахгүй зүйл юм. Хүн Библийн талаар хэчнээн их ойлгодог байх нь хамаагүй, энэ нь үгээс цаашгүй хэвээр үлддэг, учир нь хүн Библийн мөн чанарыг ойлгодоггүй. Библийг уншихдаа хүн зарим нэг үнэнийг ойлгож, зарим үгийг тайлбарлаж, эсвэл зарим алдартай хэсэг болон бүлгийг багахан ухааж төнхөж болох боловч эдгээр үгэн дотор агуулагддаг утгыг ухан гаргаж хэзээ ч чадахгүй, учир нь хүн Ехова, Есүс хоёрын хийсэн ажлын дүр зургийг биш, үхмэл үгсийг л хардаг бөгөөд энэ ажлын нууцыг тайлах ямар ч аргагүй байдаг. Тиймээс зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний нууц нь хамгийн гүн гүнзгий нуугдсан, хамгийн агуу нууц бөгөөд хүний хувьд бүхэлдээ ойлгошгүй юм. Бурхан Өөрөө л хүнд тайлбарлаж, илчлэхгүй бол хэн ч Бурханы хүслийг шууд ухаарч чадахгүй; эс бөгөөс, хүний хувьд эдгээр зүйл үүрд оньсого хэвээр үлдэж, үүрд битүүмжлэгдсэн нууц хэвээр үлдэнэ. Шашны ертөнц дэх хүмүүсийг хэлэхийн ч хэрэггүй; хэрвээ өнөөдөр та нарт хэлээгүй бол та нар ч бас үүнийг ойлгохгүй байх байсан. Зургаан мянган жилийн энэхүү ажил нь эш үзүүлэгчдийн бүх зөгнөлөөс ч илүү нууцлаг. Энэ нь бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэлх хамгийн агуу нууц бөгөөд эрин үеүдийн туршид байсан эш үзүүлэгчдийн

дундаас нэг нь ч үүнийг ухан ойлгож чадаагүй, учир нь энэхүү нууц зөвхөн эцсийн эрин үед л тайлагддаг ба өмнө нь хэзээ ч илчлэгдээгүй билээ. Хэрвээ та нар энэ нууцыг ойлгож чаддаг бол, үүнийг бүхэлд нь хүлээн авч чаддаг бол шашны бүх хүнийг энэ нууц ялан дийлэх болно. Зөвхөн энэ л хамгийн агуу үзэгдэл; энэ нь хүний хамгийн их ойлгохыг хүсэн эрмэлзсэн боловч түүний хувьд бас хамгийн тодорхой бус байсан зүйл юм. Нигүүлслийн эрин үед байх үедээ та нар, Есүсийн хийсэн ажил, Еховагийн хийсэн ажил юу байсныг мэдээгүй. Ехова яагаад хууь тогтоосныг, яагаад Тэр хуулийг мөрдөхийг олон түмнээс шаардсаныг, эсвэл яагаад сүм байгуулах хэрэгтэй байсныг хүмүүс ойлгоогүй бөгөөд израильчуудыг яагаад Египетээс цөл рүү, дараа нь Канаан руу удирдан дагуулсныг хүмүүс бүр ч ойлгоогүй. Өнөөдөр л эдгээр хэрэг явдал илчлэгдсэн юм.

Эцсийн өдрүүд дэх ажил нь гурван үе шатны сүүлчийнх нь юм. Энэ нь өөр нэг шинэ эрин үеийн ажил бөгөөд удирдлагын ажлыг бүхэлд нь төлөөлдөггүй. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь ажлын гурван үе шатанд хуваагддаг. Аль ч үе шат нь дангаараа гурван эрин үеийн ажлыг төлөөлж чадахгүй, харин нэг хэсгийг нь л төлөөлж чадна. Ехова гэх нэр Бурханы бүх зан чанарыг төлөөлж чадахгүй. Тэрээр Хуулийн эрин үед Өөрийн ажлыг гүйцэтгэсэн гэх баримт нь Бурхан бол хуулийн дор л Бурхан байж чадна гэдгийг баталдаггүй. Ехова хүний төлөө хууль гаргаж, тушаал буулгасан ба сүм болон тахилын ширээ барихыг хүмүүсээс хүссэн; Түүний хийсэн ажил Хуулийн эрин үеийг л төлөөлдөг. Түүний хийсэн ажил нь Бурхан бол хүнээс хууль мөрдөхийг л шаарддаг Бурхан, эсвэл сүм дэх Бурхан, тахилын ширээний өмнөх Бурхан гэдгийг нотолдоггүй. Ингэж хэлбэл буруу байх болно. Хуулийн доорх ажил нэг эрин үеийг л төлөөлж чадна. Тиймээс хэрвээ Бурхан Хуулийн эрин үеийн ажлыг л хийсэн бол хүн Бурханыг дараах тодорхойлолт дотор хорьж, “Бурхан бол сүм дэх Бурхан бөгөөд Бурханд үйлчлэхийн тулд бид тахилчийн нөмрөг өмсөж, сүмд орох ёстой” хэмээн хэлэх байв. Хэрвээ Нигүүлслийн эрин үеийн ажил хэзээ ч хийгдээгүй ба Хуулийн эрин үе өнөөг хүртэл үргэлжилсэн бол Бурхан бас өршөөнгүй агаад хайр энэрэлтэй гэдгийг хүн мэдэхгүй байх байлаа. Хэрвээ Хуулийн эрин үеийн ажил хийгдээгүй, харин Нигүүлслийн эрин үеийн ажил л хийгдсэн бол Бурхан зөвхөн хүнийг золин аварч, нүглийг нь өршөөж чадна гэдгийг л хүн мэдэх байв. Тэр бол ариун агаад гэм зэмгүй, мөн хүний төлөө Өөрийгөө золиосолж, цовдлогдож чадна гэдгийг л хүн мэдэх байлаа. Хүн эдгээр зүйлийг л мэдэх боловч бусад бүх зүйлийн талаар ямар ч ойлголтгүй байх байсан юм. Тиймээс эрин үе бүр Бурханы зан чанарын нэг хэсгийг төлөөлдөг.

Бурханы зан чанарын ямар талыг Хуулийн эрин үе, ямрыг нь Нигүүлслийн эрин үе, ямрыг нь өнөөгийн үе шат төлөөлдгийн тухайд бол: гурван үе шатыг бүгдийг нь нэгэн бүхэл болгон нэгтгэсэн цагт л Бурханы зан чанарыг бүхэлд нь илчилж чадна. Хүн гурван үе шатны ажлыг бүгдийг нь мэдэж авсан цагтаа л үүнийг бүрэн ойлгож чадна. Гурван үе шатны алийг нь ч орхигдуулж болохгүй. Чи ажлын энэ гурван үе шатыг мэдэж авсныхаа дараа л Бурханы зан чанарыг бүхэлд нь харах болно. Бурхан Хуулийн эрин үе дэх ажлаа дуусгасан гэх баримт нь Тэр бол зөвхөн хуулийн доорх Бурхан гэдгийг баталдаггүй бөгөөд Тэр золин авралын ажлаа дуусгасан гэх баримт нь Бурхан үүрд хүн төрөлхтнийг золин аварна гэсэн үг биш. Эдгээр нь бүгд хүний гаргасан дүгнэлт юм. Нигүүлслийн эрин үе дууссан болохоор чи, Бурхан зөвхөн загалмайд харьяалагддаг, загалмай ганцаараа Бурханы авралыг төлөөлдөг гэж хэлж болохгүй. Тэгэх нь Бурханыг хязгаарлаж буй хэрэг. Өнөөгийн үе шатанд Бурхан үндсэндээ үгийн ажил хийж байгаа боловч Бурхан хэзээ ч хүнд өршөөнгүй хандаж байгаагүй, гагцхүү гэсгээлт, шүүлт л авчирдаг гэж чи хэлж болохгүй. Эцсийн өдрүүд дэх ажил нь хүн төрөлхтний хүрэх газар, төгсгөлийг илчилж, хүн төрөлхтний дундах авралын бүх ажлыг төгсгөхийн тулд Ехова, Есүс хоёрын ажлыг болон хүний ойлгодоггүй бүх нууцыг ил болгодог. Эцсийн өдрүүд дэх ажлын энэ үе шат нь бүх зүйлийг дуусгавар болгодог. Эдгээр нууцын гүнд нь орж, зүрх сэтгэлдээ тов тодорхой ойлгох боломжийг хүнд олгохын тулд хүний ойлгоогүй бүх нууцыг дэлгэх ёстой. Тэр үед л хүн төрөлхтнийг төрлийнх нь дагуу ангилж болно. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө дууссаны дараа л хүн Бурханы зан чанарыг бүхэлд нь ойлгож авна, учир нь Түүний удирдлага тэр үед дуусчихсан байх болно. Одоо та нар эцсийн эрин үе дэх Бурханы ажлыг туулсан, тэгвэл Бурханы зан чанар юу вэ? Бурхан бол үг хэлдэг Бурханаас цаашгүй гэж чи хэлж зүрхлэх үү? Чи ийм дүгнэлт хийж зүрхлэхгүй. Бурхан бол нууцуудыг тайлдаг Бурхан, Бурхан бол Хурга, мөн долоон лацыг эвддэг Нэгэн гэж зарим хүн хэлнэ. Гэхдээ хэн ч ийм дүгнэлт гаргаж зүрхэлдэггүй. Бусад нь Бурхан бол махбод болсон бие гэж хэлж болзошгүй боловч энэ нь мөн л буруу байна. Бас зарим нь бие махбодтой болсон Бурхан зөвхөн үг хэлдэг бөгөөд тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй гэж хэлж магад боловч чи ийм маягаар ярьж бүр ч зүрхлэхгүй, учир нь Есүс махбод болж, тэмдэг гайхамшиг үзүүлсэн, иймээс чи Бурханыг ийм хөнгөхнөөр тодорхойлж зүрхлэхгүй. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний туршид хийгдсэн бүх ажил одоо л төгсгөлдөө ирсэн. Энэ бүх ажлыг хүнд илчилж, хүн төрөлхтний дунд гүйцэтгэсний дараа л тэд

Бурханы бүх зан чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг мэдэх болно. Энэ үе шатны ажил бүрэн дуусахад хүний ойлгодоггүй бүх нууц илчлэгдсэн байх бөгөөд урьд нь ойлгоогүй байсан бүх үнэн ойлгомжтой болж, хүн төрөлхтөнд ирээдүйн зам, хүрэх газрыг нь хэлсэн байх болно. Энэ бол өнөөгийн үе шатанд хийгдэх бүхий л ажил юм. Хэдийгээр хүний өнөөдөр алхдаг зам ч бас загалмайн зам, зовлонгийн зам боловч өнөөдөр хүний хэрэгжүүлж, идэж, ууж, эдэлдэг зүйлс нь хуулийн дор болон Нигүүлслийн эрин үед байсан хүмүүсийнхээс асар өөр билээ. Өнөөдөр хүнээс шаарддаг зүйл өнгөрсөн үеийнхтэй адилгүй бөгөөд Хуулийн эрин үед хүнээс шаардаж байсантай бүр ч адилгүй. Тэгвэл Бурханы Израильд ажлаа хийж байхдаа хуулийн дор байгаа хүнээс юу шаардсан бэ? Энэ нь, хүн Амралтын өдрийг болон Еховагийн хуулийг мөрдөх ёстой гэдгээс хэтрээгүй. Хэн ч Амралтын өдрөөр ажиллаж, эсвэл Еховагийн хуулийг зөрчиж болохгүй байв. Гэхдээ одоо тийм биш. Амралтын өдөр хүн ердийнхөөрөө ажиллаж, цугларч, залбирдаг ба хүнд ямар ч хориг хязгаарлалт тавьдаггүй. Нигүүлслийн эрин үеийн хүмүүс баптисм хүртэх хэрэгтэй байсан, улмаар мацаг барьж, талх хугалж, дарс ууж, толгойгоо бүтээж, хөлөө угаахыг тэднээс шаардсан. Одоо энэ дүрмүүд хүчингүй болсон боловч хүнд бүр ч их шаардлага тавьдаг, учир нь Бурханы ажил улам бүр гүнзгийрч, хүний оролт улам өндөрсөж байдаг. Урьд нь Есүс хүн дээр гараа тавин залбирсан, харин одоо бүхнийг хэлсэн болохоор гараа тавихын хэрэг юу байх билээ? Дан ганц үгээр үр дүнд хүрч болно. Урьд нь Тэрээр хүн дээр гараа тавих үед энэ нь хүнийг ерөөж, бас өвчнийг нь эдгээх зорилготой байлаа. Тухайн үед Ариун Сүнс ингэж ажилладаг байсан, гэхдээ одоо тийм биш. Одоо Ариун Сүнс ажиллаж, үр дүнд хүрэхийн тулд үг ашигладаг. Түүний үг та нарт тодорхой болсон бөгөөд та нар хэлсний дагуу хэрэгжүүлэх ёстой. Түүний үг бол Түүний хүсэл; тэдгээр нь Түүний хийхийг хүсдэг ажил. Үгээр нь дамжуулан чи Түүний хүслийг ойлгож, юунд хүрэхийг чамаас шаардаж байгааг ойлгоно, мөн гар тавих ямар ч хэрэггүйгээр Түүний үгийг шууд хэрэгжүүлж болно. Зарим хүн: “Гараа над дээр тавиач! Гараа над дээр тавивал би Таны ерөөлийг хүртэж, Танаас хуваалцаж болох юм” гэж хэлж болзошгүй. Энэ бүхэн нь өнгөрсөн үеийн хоцрогдсон хэрэгжүүлэлт бөгөөд эрин үе солигдсон учраас одоо хэрэглэхээ больсон. Ариун Сүнс санамсаргүй байдлаар ч биш, эсвэл тогтсон дүрмийн дагуу ч биш, харин эрин үед нийцүүлэн ажилладаг. Эрин үе өөрчлөгдсөн бөгөөд шинэ эрин үе шинэ ажлыг зайлшгүй авчирдаг. Ажлын үе шат бүр ийм байдаг тул Түүний ажил хэзээ ч давтагддаггүй. Нигүүлслийн эрин үед Есүс өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөх, хүний төлөө

залбирахын тулд гараа хүн дээр тавих, хүнийг ерөөх гэх зэрэг ажлыг хангалттай хэмжээнд хийсэн. Гэвч өнөө үед үүнийг дахин хийх нь утга учиргүй байх байв. Ариун Сүнс тухайн үед тийм маягаар ажилласан, учир нь энэ нь Нигүүлслийн эрин үе байсан ба хүний эдлэх нигүүлсэл хангалттай байлаа. Хүнээс ямар ч төлөөс төлөхийг шаардаагүй бөгөөд итгэлтэй байх л юм бол нигүүлсэл хүртэх байв. Бүгдэд маш нигүүлсэнгүйгээр хандаж байсан юм. Одоо эрин үе өөрчлөгдсөн бөгөөд Бурханы ажил цааш улам ахисан; гэсгээлт, шүүлтээр дамжуулан хүний тэрслүү байдлыг болон доторх бохир зүйлсийг нь арилгана. Тэр үе шат золин авралын үе шат байсан болохоор Бурхан тийм маягаар ажиллаж, эдлэх хангалттай нигүүлслийг хүнд харуулах ёстой байв, ингэснээр хүнийг нүглээс золин аварч, нигүүлслээр дамжуулан нүглийг нь уучилж болох байлаа. Өнөөгийн энэ үе шат нь хүмүүсийг дараа нь аврахын тулд гэсгээлт, шүүлт, үгийн цохилт, түүнчлэн үгийн сахилгажуулалт болон илчлэлийн аргаар хүний доторх шударга бус байдлыг ил болгодог. Энэ бол золин авралаас ч илүү гүнзгий ажил билээ. Нигүүлслийн эрин үе дэх нигүүлсэл нь хүн эдлэхэд хангалттай байсан; одоо хүн энэ нигүүлслийг аль хэдийн мэдэрсэн болохоор цаашид дахиж эдлэхгүй. Энэ ажил одоо үеэ өнгөрөөсөн ба цаашид дахиж хийгдэхгүй. Одоо хүнийг үгийн шүүлтээр дамжуулан аварна. Хүнийг шүүж, гэсгээж цэвэршүүлсний дараа зан чанар нь өөрчлөгддөг. Энэ нь бүгд Миний хэлсэн үгээс болдоггүй гэж үү? Ажлын үе шат бүр нь бүх хүн төрөлхтний ахиц дэвшил болон эрин үеийн дагуу хийгддэг. Ажил бүхэлдээ ач холбогдолтой байдаг, энэ бүхэн нь эцсийн авралын төлөө, хүн төрөлхтөн ирээдүйд сайн сайхан хүрэх газартай байхын төлөө, эцэст нь хүмүүс төрлөөрөө ангилагдахын төлөө хийгддэг.

Эцсийн өдрүүдийн ажил бол үг хэлэх явдал юм. Үгийн тусламжтайгаар хүнд асар их өөрчлөлт гарч болно. Эдгээр үгийг хүлээн зөвшөөрснөөр өнөөгийн хүмүүст гарч байгаа өөрчлөлтүүд нь Нигүүлслийн эрин үеийн тэмдэг, гайхамшгийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийнхээс хамаагүй их. Учир нь Нигүүлслийн эрин үед гараа дээр нь тавьж, залбирснаар хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж байсан боловч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдсэн юм. Хүний өвчнийг эдгээж, нүглийг нь өршөөсөн боловч хүний доторх завхарсан сатанлаг зан чанарыг яг яаж арилгах тухайд бол энэ ажил хараахан хийгдээгүй. Хүн итгэлээсээ үүдэн аврагдаж, нүглээ уучлуулсан боловч хүний нүгэлт уг чанар арилаагүй бөгөөд дотор нь үлдсэн юм. Бие махбодтой болсон Бурханы тусламжтайгаар хүний нүглийг уучилсан боловч хүний дотор нүгэл байхаа

больсон гэсэн үг биш. Нүглийн тахилаар дамжуулан хүний нүглийг өршөөж болох боловч хүний нүгэл үйлдэхийг яг яаж болиулах, нүгэлт уг чанарыг нь яаж бүрэн арилгаж, өөрчлөх тухайд бол хүн энэ асуудлыг шийдвэрлэх ямар ч аргагүй байдаг. Хүний нүглийг өршөөсөн нь Бурханы цовдлолын ажлаас үүдсэн боловч хүн хуучны, завхарсан сатанлаг зан чанар дотроо үргэлжлүүлэн амьдарсан юм. Ийм болохоор хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн аврах ёстой, ингэснээр түүний нүгэлт уг чанар дахин хэзээ ч хөгжихгүйгээр бүрэн арилж, улмаар хүний зан чанар өөрчлөгдөх боломжтой болох юм. Энэ нь амийн өсөлтийн замыг, амийн замыг болон зан чанараа өөрчлөх замыг ухаарахыг хүнээс шаарддаг. Түүнчлэн, энэ замын дагуу хэрэгжүүлж, зан чанараа аажмаар өөрчилж, гэрлийн гялбаан дор амьдарч, хийдэг бүхнээ Бурханы хүслийн дагуу байлгаж, завхарсан сатанлаг зан чанараа хаяж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, улмаар нүглээс бүрэн ангижрахыг хүнээс шаарддаг. Тэгсэн цагт л хүн бүрэн аврал хүртэнэ. Есүсийг ажлаа хийж байх үед Түүний талаарх хүний мэдлэг мөн л бүдэг бадаг, тодорхойгүй байв. Тэр бол Давидын хүү гэдэгт хүн үргэлж итгэж байсан ба Тэр бол агуу эш үзүүлэгч, хүний нүглийг золин аварсан энэрэнгүй Эзэн хэмээн тунхагласан юм. Итгэлийнхээ хүчээр зарим нь Түүний хувцасны заханд хүрэх төдийд эдгэж, сохор хүн харж, үхсэн хүн ч дахин амилж байлаа. Гэвч хүн өөрийнх нь дотор гүн үндэслэсэн завхарсан сатанлаг зан чанарыг олж мэдэж чадаагүй, үүнийг хэрхэн хаяхыг ч мэдээгүй. Хүн махан биеийн амар амгалан, аз жаргал, нэг гишүүнийх нь итгэл бүхий л гэр бүлийнхэнд ерөөл авчрах, өвчнийг эдгээх гэх мэт ихээхэн нигүүлслийг хүлээн авчээ. Үлдсэн нь хүний сайн үйл хэрэг, мөн түүний сүсэг бишрэлтэй төрх байдал байв; хэрвээ хүн эдгээрт үндэслэн амьдарч чаддаг бол түүнийг боломжийн итгэгч гэж үздэг байлаа. Ийм итгэгчид л үхсэнийхээ дараа диваажинд орж чадах байсан ба энэ нь тэд аврагдсан гэсэн үг байлаа. Гэвч энэ хүмүүс амьдрах хугацаандаа амийн замыг огт ойлгоогүй юм. Тэд зан чанараа өөрчлөх ямар ч замгүйгээр тогтмол давтамжтайгаар нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайдаг байсан: Нигүүлслийн эрин үе дэх хүний нөхцөл байдал ийм байлаа. Хүн бүрэн аврал хүртсэн үү? Үгүй! Тиймээс ажлын тэрхүү үе шат дууссаны дараа шүүлт, гэсгээлтийн ажил хэвээр үлдсэн юм. Энэ үе шат нь үгийн тусламжтайгаар хүнийг ариусгаж, улмаар түүнд дагах зам өгөхийн төлөө байдаг. Хэрвээ чөтгөрийг хөөн зайлуулахаа үргэлжлүүлсээр байсан бол энэ үе шат үр дүнгүй, утга учиргүй байх байлаа, учир нь энэ нь хүний нүгэлт уг чанарыг арилгаж чадахгүй бөгөөд хүн нүглээ уучлуулаад л зогсонги байдалд орох байв.

Цовдлолын ажил аль хэдийн дуусаж, Бурхан Сатаныг ялан дийлсэн учраас нүглийн тахилаар дамжуулан хүн нүглээ уучлуулсан. Гэвч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдэж, хүн нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэж мөн л чаддаг бөгөөд Бурхан хүн төрөлхтнийг олж аваагүй. Тиймээс ажлын энэ үе шатанд Бурхан хүний завхарсан зан чанарыг илчлэхдээ үг ашиглаж, зөв замын дагуу хэрэгжүүлэхэд түүнийг хүргэдэг. Энэ үе шат нь өмнөхийг бодвол илүү утга учиртай, мөн түүнчлэн илүү үр дүнтэй байдаг, учир нь одоо цагт хүний амийг шууд хангаж, хүний зан чанарыг бүрэн шинэчлэхэд хүргэдэг зүйл нь үг билээ; энэ нь ажлын илүү бүрэн гүйцэд үе шат юм. Тиймээс эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан нь Бурхан бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцээж, хүнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөөг бүрэн дуусгасан юм.

Бурхан хүнийг аврахдаа Сүнсний арга барил, Сүнсний ялгамж чанарыг шууд ашиглан хийдэггүй, учир нь хүн Түүний Сүнсэнд хүрч чадахгүй, харж чадахгүй, мөн ойртож ч чадахгүй. Хэрвээ Тэр Сүнс байдлаар хүнийг шууд аврахаар оролдсон бол хүн Түүний авралыг хүртэж чадахгүй байх байлаа. Хэрвээ Бурхан бүтээгдсэн хүний гадаад хэлбэртэй болоогүй бол хүний хувьд энэ авралыг хүртэх ямар ч аргагүй байх байв. Учир нь хэн ч Еховагийн үүлэнд дөхөн очиж хүн Түүнд ойртох ямар ч аргагүй байдаг. Зөвхөн бүтээгдсэн хүн болсноор, өөрөөр хэлбэл, Өөрийн болох гэж буй махбодод үгээ оруулснаар л Тэр Өөрийг нь дагадаг бүх хүнд үгийг биечлэн хүргэж чадна. Тэр үед л хүн өөрийн биеэр Түүний үгийг харж, сонсож, түүнчлэн Түүний үгийг эзэмшиж, үүгээр дамжуулан бүрэн аврагдаж чадна. Хэрвээ Бурхан махбод болоогүй бол мах цуснаас бүтсэн нэг ч хүн ийм агуу авралыг хүртэж чадахгүй байсан бөгөөд ганц ч хүн аврагдахгүй байх байлаа. Хэрвээ Бурханы Сүнс шууд хүн төрөлхтний дунд ажилласан бол бүх хүн цохиулж, эсвэл Бурхантай холбогдох ямар ч аргагүйн улмаас Сатанд бүрмөсөн олзлогдох байв. Эхний удаа бие махбодтой болсон нь хүнийг нүглээс золин аварсан ба Есүсийн бие махбодын тусламжтайгаар хүнийг золин аварсан юм. Өөрөөр хэлбэл, Тэр хүнийг загалмайнаас аварсан боловч хүний дотор завхарсан сатанлаг зан чанар мөн л үлджээ. Хоёр дахь удаа бие махбодтой болсон нь дахиж нүглийн тахил болж үйлчлэхгүй, харин ч нүглээс золин аврагдсан хүмүүсийг бүрэн аврахын төлөө байдаг. Энэ нь уучлагдсан хүмүүсийг нүглээс нь гэтэлгэж, бүрэн ариусгаж, мөн зан чанарын өөрчлөлтөд хүргэснээр Сатаны харанхуй нөлөөнөөс ангижруулж, Бурханы сэнтийн өмнө буцаан авчрахын тулд хийгддэг. Ийм маягаар л хүн бүрэн ариусаж чадна. Хуулийн эрин үе дууссаны дараа Нигүүлслийн эрин үе эхлэхийн хамтаар

Бурхан авралын ажлыг эхлүүлсэн ба энэ нь эцсийн өдрүүдэд хүн төрөлхтний тэрслүү байдлыг шүүж, гэсгээж, тэднийг бүрмөсөн ариусгах хүртэл үргэлжилдэг. Дараа нь л Бурхан авралын ажлаа төгсгөөд амралтад орно. Тиймээс ажлын гурван үе шатанд Өөрийн ажлыг хүмүүсийн дунд биечлэн гүйцэтгэхийн тулд Бурхан хоёр удаа л махбод болсон юм. Яагаад гэвэл, ажлын гурван үе шатны ердөө нэг нь л хүмүүсийн амьдралыг залж чиглүүлэх явдал байсан, харин нөгөө хоёр нь авралын ажлаас бүрддэг. Бурхан махбод болсноор л хүмүүстэй хамт амьдарч, дэлхий ертөнцийн зовлонг туулж, хэвийн махан биед амьдарч чадна. Зөвхөн ийм маягаар л Тэр, бүтээгдсэн зүйлийн хувиар хүмүүст хэрэгтэй байдаг бодитой үгээр хүмүүсийг хангаж чадна. Хүн бие махбодтой болсон Бурханаар дамжуулан Бурханаас бүрэн аврал хүртдэг болохоос биш, залбирлынхаа хариуд тэнгэрээс шууд хүртдэггүй. Хүн мах, цуснаас бүрдсэн учраас Бурханы Сүнсэнд ойртох нь бүү хэл, Түүний Сүнсийг харах ямар ч аргагүй байдаг. Хүн Бурханы махбод болсон биетэй л харилцаж чадах бөгөөд үүгээр л дамжуулан бүх зам, бүх үнэнийг ойлгож, бүрэн авралыг хүлээн авч чадна. Хоёр дахь удаа бие махбодтой болох нь хүний нүглийг арилгаж, хүнийг бүрэн ариусгахад хангалттай байх болно. Иймд хоёр дахь удаа бие махбодтой болоход махбод дахь Бурханы бүх ажил төгсөж, Бурхан бие махбодтой болохын ач холбогдол бүрэн гүйцэд болно. Энэ үеэс махбод дахь Бурханы ажил бүхэлдээ дууссан байх болно. Хоёр дахь удаа бие махбодтой болсныхоо дараа Тэр гурав дахь удаа бие махбодтой болох ажлыг хийхгүй. Учир нь Түүний удирдлага бүхэлдээ төгсчихсөн байна. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан Өөрийн сонгосон хүмүүсийг бүрэн олж авсан байх ба эцсийн өдрүүд дэх хүмүүс бүгд төрлөөрөө ангилагдсан байх болно. Тэр авралын ажлыг дахин хийхгүй, мөн ямар нэг ажил хийхийн тулд махбодод ч эргэн ирэхгүй. Эцсийн өдрүүдийн ажилд үг нь тэмдэг, гайхамшгийн илрэлээс илүү сүр хүчтэй байдаг бөгөөд үгийн эрх мэдэл нь тэмдэг, гайхамшгийнхаас давдаг. Үг нь хүний зүрх сэтгэлийн гүнд булагдсан бүх ялзарсан зан чанарыг ил болгодог. Чи тэдгээрийг өөрөө таних ямар ч аргагүй. Үгээр дамжуулан тэдгээрийг өмнө чинь ил болгоход чи аяндаа олж мэднэ; чи тэдгээрийг үгүйсгэж чадахгүй бөгөөд бүрэн үнэмшинэ. Энэ нь үгийн эрх мэдэл биш гэж үү? Энэ бол өнөөдрийн үгийн ажлаар хүрсэн үр дүн юм. Тиймээс өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулснаар хүнийг нүглээс бүрэн аварч чадахгүй, мөн тэмдэг, гайхамшиг үзүүлснээр дамжуулан бүрэн төгс болгож ч чадахгүй. Өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулах эрх мэдэл нь хүнд нигүүлсэл л өгдөг боловч хүний махан бие Сатанд харьяалагдсаар байдаг ба

завхарсан сатанлаг зан чанар хүний дотор байсаар байдаг. Өөрөөр хэлбэл, цэвэр болгоогүй зүйл нүгэл болон бузарт хамаатай хэвээр байдаг. Үгийн тусламжтайгаар цэвэр болгуулсны дараа л хүн Бурханаар авхуулж, ариусаж чаддаг. Хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж, түүнийг золин аврах үед энэ нь, түүнийг Сатаны гараас булаан авч, Бурханд буцааж өгсөн гэсэн утгатай байв. Гэвч тэр Бурханаар ариусгагдаж, өөрчлөгдөөгүй учраас завхарсан хүн хэвээр үлддэг. Хүний дотор бузар буртаг, эсэргүүцэл, тэрслүү байдал оршсоор байдаг; хүн зөвхөн Бурханы золин авралаар дамжуулж Түүн рүү буцаж очсон боловч Бурханы тухай өчүүхэн төдий ч мэдлэггүй байдаг бөгөөд Түүнийг эсэргүүцэж, Түүнээс урваж мөн л чаддаг. Хүнийг золин аврахаас өмнө Сатаны олон хор аль хэдийн түүний дотор суучихсан бөгөөд Сатанаар олон мянган жил завхруулагдсаны дараа хүний дотор Бурханыг эсэргүүцэх уг чанар тогтсон байдаг. Тиймээс хүнийг золин аврах нь хүнийг өндөр үнээр буцаан авсан золин авралаас цаашгүй байсан боловч хүний доторх хорт уг чанарыг таягдан хаяагүй юм. Ингэж их бузартсан хүн Бурханд үйлчлэхүйц болохоосоо өмнө өөрчлөгдөх ёстой. Шүүлт, гэсгээлтийн энэ ажлаар дамжуулан өөрийнхөө доторх бохир, завхарсан мөн чанарын талаар хүн бүрэн мэдэж авах бөгөөд бүрэн өөрчлөгдөж, цэвэр болж чадна. Ийм маягаар л хүн Бурханы сэнтийн өмнө буцан очих үнэ цэнтэй болж чадна. Өнөөдөр хийгдэж байгаа бүх ажил нь хүнийг цэвэрлэж, өөрчлөхийн төлөө байдаг; үгийн шүүлт, гэсгээлт, мөн цэвэршүүлэлтээр дамжуулан хүн завхралаа хаяж, ариусгагдаж чадна. Ажлын энэ үе шатыг авралын ажил гэж үзэхээс илүүгээр ариусгалтын ажил гэж нэрлэх нь илүү тохиромжтой. Үнэндээ энэ үе шат нь байлдан дагуулалтын шат, мөн түүнчлэн авралын ажлын хоёр дахь үе шат юм. Үгийн шүүлт, гэсгээлтээр дамжуулан хүнийг Бурхан олж авдаг; цэвэршүүлж, шүүж, ил болгоход үгийг ашигласнаар хүний зүрх сэтгэлийн доторх хольц, үзэл, сэдэл, хувийн хүсэл эрмэлзэл бүгд бүрэн илчлэгддэг. Хүнийг золин аварч, нүглийг нь уучилсан тухайд бол, Бурхан хүний гэм бурууг санадаггүй, гэм буруугийнх нь дагуу хүнд ханддаггүй гэж л авч үзэж болох юм. Гэвч махан биед амьдардаг хүн нүглээс ангижраагүй бол үргэлжлүүлэн нүгэл үйлдэж, завхарсан сатанлаг зан чанараа эцэс төгсгөлгүй илчилж л чадна. Энэ бол хүний амьдардаг, нүгэл үйлдэж, нүглээ уучлуулдаг эцэс төгсгөлгүй орчлын амьдрал юм. Хүн төрөлхтний ихэнх нь өдөр нь нүгэл үйлдээд орой нь нүглээ улайдаг. Ийм маягаар нүглийн тахил хүний хувьд үүрд хүчинтэй байдаг ч энэ нь хүнийг нүглээс аварч чадахгүй. Хүн завхарсан зан чанартай байсаар байгаа тул авралын ажлын хагас нь л гүйцэлдсэн. Тухайлбал,

хүмүүс Моабын үр удам гэдгээ ухаарах үедээ гомдлын үг хэлж, амийг эрэлхийлэхээ больж, туйлын сөрөг болдог. Хүмүүс Бурханы ноёрхол дор бүрэн захирагдаж чадахгүй байсаар байгааг энэ нь харуулдаггүй гэж үү? Энэ нь яг нарийндаа завхарсан сатанлаг зан чанар биш гэж үү? Гэсгээлтэд өртөөгүй байх үедээ чи гараа бусдынхаас, бүр Есүсийнхээс ч илүү өндөрт өргөж байсан. Тэгээд чи чанга дуугаар ийнхүү хашхирсан: “Бурханы хайртай хүү болно! Бурханы дотнын хүн болно! Сатанд сөгдөхийн оронд бид үхэхийг илүүд үзнэ! Хөгшин Сатаны эсрэг босоцгоо! Агуу улаан лууны эсрэг босоцгоо! Агуу улаан луу арчаагүйгээр эрх мэдлээ алдах болтугай! Бурхан биднийг бүрэн төгс болгох болтугай!” Хашхираан чинь бусад бүх хүнийхээс ч илүү чанга байсан. Харин дараа нь гэсгээлтийн цаг үе ирэхэд хүмүүсийн завхарсан зан чанар дахин нэгэнтээ илчлэгдсэн юм. Тэгээд тэдний хашхираан намжиж, шийдэмгий байдал нь бүтэлгүйтсэн. Энэ бол хүний завхрал; нүглээс илүү гүн нэвчсэн энэ нь Сатаны суулгасан, хүний дотор гүнзгий үндэслэсэн зүйл юм. Хүн өөрийнхөө нүглийг мэддэг болох нь маш амаргүй; тэр өөрийнх нь дотор гүнзгий үндэслэсэн уг чанарыг таних ямар ч аргагүй байдаг бөгөөд энэ үр дүнд хүрэхийн тулд үгийн шүүлтэд найдах ёстой. Тэгж байж л хүн энэ үеэс эхлэн аажмаар өөрчлөгдөж чадна. Хүн төрөлхийн завхарсан зан чанараа огт ойлгодоггүй байсан учраас өмнө нь тэгж хашхирсан юм. Энэ нь хүний дотор оршдог бохир хольц билээ. Тийм удаан хугацааны шүүлт, гэсгээлтийн хугацаанд хүн түгшүүртэй орчинд амьдарсан. Энэ бүхэн нь үгийн тусламжтайгаар хийгдээгүй гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаас өмнө чи ч бас маш чанга дуугаар хашхираагүй гэж үү? “Хаанчлалд орлоо! Энэ нэрийг хүлээн зөвшөөрдөг бүхэн хаанчлалд орно! Бүгд Бурхантай хуваалцана!” Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт ирэхэд чи хашхирахаа больсон. Эхэндээ бүгд: “Өө Бурхан минь! Та намайг хаана ч тавьсан, би Таны жолоодлогод захирагдана” гэж хашхирсан. “Хэн Миний Паул байх вэ?” хэмээх Бурханы үгийг уншаад хүмүүс “Би бэлэн!” гэгцээсэн. Тэгээд тэд “Иовын итгэл ямар вэ?” хэмээх үгийг харсан ба “Би Иовын итгэлийг авахад бэлэн байна. Бурхан минь, туршилтад оруулаач!” гэсэн юм. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт ирэх үед тэд дорхноо нуран унаад, дахин босож чадахгүй байх шахсан. Түүний дараа тэдний зүрх сэтгэл дэх хольц яваандаа багассан. Энэ нь үгээр хийгдээгүй гэж үү? Иймээс өнөөдөр та нарын туулсан зүйл бол үгээр дамжин хүрсэн үр дүн бөгөөд Есүсийн үзүүлсэн тэмдэг, гайхамшгуудын хүрсэн үр дүнгээс ч илүү агуу юм. Чиний хардаг Бурханы алдар болон Бурханы Өөрийн эрх мэдэл нь ердөө цовдлолын тусламжтайгаар, мөн өвчнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн

зайлуулснаар харагддаг юм биш, харин Түүний үгийн шүүлтээр дамжуулан бүр ч их харагддаг. Бурханы эрх мэдэл, хүч чадал нь зөвхөн тэмдэг үзүүлж, өвчнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулахаас бүрддэг юм биш, харин Бурханы үгийн шүүлт нь Бурханы эрх мэдлийг илүү сайн төлөөлж, Түүний төгс хүчнийг илүү сайн илчилж чаддаг гэдгийг энэ нь харуулдаг.

Хүний одоо хүрсэн зүйл—түүний өнөөгийн биеийн хэмжээ, мэдлэг, хайр, үнэнч зан, дуулгавартай байдал, мэдлэг ухаан—эдгээр нь үгийн шүүлтээр хүрсэн үр дүн юм. Үгийн тусламжтайгаар чи үнэнч байж, өнөөг хүртэл зогссон хэвээр байж чаддаг. Одоо хүн бие махбодтой болсон Бурханы ажил нь үнэхээр ер бусын гэдгийг хардаг бөгөөд үүнд хүний хүрч чадахгүй олон зүйл байдаг, тэдгээр нь нууц болон гайхамшгууд юм. Тиймээс олон хүн захирагдсан. Зарим нь төрснөөсөө хойш хэнд ч, хэзээ ч захирагдаж байгаагүй мөртөө Бурханы өнөөдрийн үгийг харах үедээ өөрийн мэдэлгүй бүрэн захирагддаг бөгөөд үүнийг судалж, эсвэл өөр юм хэлж зүрхэлдэггүй. Хүмүүс үгэн дор унаж, үгийн шүүлт дор нүүрээрээ газар унан мөргөсөн. Хэрэв Бурханы Сүнс хүнтэй шууд ярьсан бол хүн төрөлхтөн бүгд дуу хоолойд захирагдаж, Дамаск явах замдаа Паул гэрэл дунд газар унасантай яг адилаар хүмүүс бүгд илчлэлийн үггүйгээр доош унах байсан юм. Хэрвээ Бурхан ийм маягаар үргэлжлүүлэн ажилласан бол хүн үгийн шүүлтээр дамжуулан өөрийн завхралыг хэзээ ч мэдэж авч чадахгүй, улмаар аврал хүртэхгүй байх байв. Зөвхөн махбод болсноор л Бурхан Өөрийн үгийг хүн нэг бүрийн чихэнд биечлэн хүргэж чадна, ингэснээр чихтэй бүхэн Түүний үгийг сонсож, Түүний үгийн шүүлтийн ажлыг хүлээн авч болох юм. Энэ нь л Түүний үгийн хүрдэг үр дүн болохоос биш, Сүнс илэрч, хүнийг айлган эрхшээлдээ оруулдаг юм биш. Зөвхөн ийм бодит атлаа ер бусын ажлаар дамжуулан хүний дотор олон жил гүн нуугдсан хуучин зан чанар бүрэн ил болдог, ингэснээр хүн үүнийг таньж, өөрчилж болох юм. Эдгээр нь бүгд бие махбодтой болсон Бурханы бодитой ажил бөгөөд бодитой байдлаар ярьж, шүүлт явуулснаар Тэр үгээр хүнийг шүүх үр дүнд хүрдэг. Энэ бол бие махбодтой болсон Бурханы эрх мэдэл бөгөөд Бурхан бие махбодтой болохын ач холбогдол билээ. Бие махбодтой болсон Бурханы эрх мэдлийг ил болгохын тулд, үгийн ажлаар хүрсэн үр дүнг ил болгож, Сүнс махбодод ирчихсэн ба хүнийг үгээр шүүснээр дамжуулан эрх мэдлээ харуулж байгааг ил болгох гэж үүнийг хийдэг. Түүний махбод хэдийгээр жирийн, хэвийн хүн чанарын гадаад хэлбэртэй боловч Түүний үгийн хүрдэг үр дүн нь Тэр бол эрх мэдлээр дүүрэн, Тэр бол Бурхан Өөрөө, Түүний үг бол Бурханы Өөрийн илэрхийлэл гэдгийг хүнд

харуулдаг. Энэ аргаар Тэр бол Бурхан Өөрөө, Тэр бол махбод болсон Бурхан Өөрөө, Түүнд хэн ч халдаж болохгүй, Түүний үгийн шүүлтийг хэн ч давж чадахгүй, мөн ямар ч харанхуйн хүч Түүний эрх мэдлийг дийлж чадахгүй гэдгийг бүх хүнд харуулдаг. Тэр бол Үг болсон махбод учраас, мөн Түүний эрх мэдлээс болж, Түүний үгийн шүүлтээс болж хүн Түүнд захирагддаг. Бурханы махбод болсон биеийн авчирсан ажил нь Түүний эзэмшдэг эрх мэдэл билээ. Махбод ч гэсэн эрх мэдэл эзэмшдэг учраас Тэр махбод болсон бөгөөд хүн төрөлхтний дунд бодитой байдлаар ажиллаж чаддаг, ийм маягаар хүн харж, хүрч болдог. Энэ ажил нь, бүх эрх мэдлийг эзэмшдэг Бурханы Сүнсний шууд хийдэг ажлаас илүү бодитой, үр дүн нь ч бас илэрхий байдаг. Яагаад гэвэл, Бурханы махбод болсон бие бодитоор ярьж, ажиллаж чаддаг. Түүний махбодын гадаад хэлбэр төрх ямар ч эрх мэдэл агуулдаггүй бөгөөд хүн ойртож болдог байхад Түүний мөн чанар эрх мэдлийг агуулдаг, гэхдээ эрх мэдэл нь хэнд ч харагддаггүй. Түүнийг ярьж, ажиллаж байх үед хүн Түүнд эрх мэдэл байгааг олж илрүүлж чаддаггүй; энэ нь Түүний бодитой ажилд нэмэр болдог. Энэ бүх бодитой ажил үр дүнд хүрч чадна. Хэн ч Түүнд эрх мэдэл байгааг ухаардаггүй, халдашгүй гэдгийг нь хардаггүй, эсвэл Түүний уур хилэнг хардаггүй боловч далдлагдсан эрх мэдэл, нуугдмал уур хилэн болон ил тод хэлдэг үгээрээ дамжуулан Тэр Өөрийн үгийн зорьсон үр дүнд хүрдэг. Өөрөөр хэлбэл, Өөрийн дуу хоолойн өнгө, ярианы хатуу чанга байдал, Өөрийн үгийн бүх мэргэн ухаанаар дамжуулан хүнийг бүрэн үнэмшүүлдэг. Ийм маягаар харваас ямар ч эрх мэдэлгүй, бие махбодтой болсон Бурханы үгэнд хүн захирагдаж, улмаар хүнийг аврах Бурханы зорилго биелдэг. Илүү бодитоор ярьж, үгийнх нь бодит байдал хүнд үр нөлөө үзүүлэх боломж олгож, хүнд Бурханы үгийн хүч чадлыг харуулах нь Бурхан бие махбодтой болсны ач холбогдлын өөр нэг тал юм. Тиймээс энэ ажлыг бие махбодтой болсноор дамжуулан хийхгүй бол өчүүхэн төдий ч үр дүнд хүрэхгүй бөгөөд нүгэлт хүмүүсийг бүрэн аварч чадахгүй байх байлаа. Хэрвээ Бурхан махбод болоогүй бол хүнд үзэгдэшгүй, баригдашгүй Сүнс хэвээр үлдэх байв. Хүн махан биетэй бүтээл тул Бурхан, хүн хоёр өөр өөр ертөнцөд харьяалагддаг бөгөөд өөр өөр шинж чанартай байдаг. Бурханы Сүнс махан биетэй хүнтэй огт нийцдэггүй, тэдний хооронд харилцаа тогтоох ямар ч аргагүй бөгөөд хүн сүнс болох чадваргүйг дурдахын ч хэрэггүй. Ийм болохоор Өөрийн анхдагч ажлыг хийхийн тулд Бурханы Сүнс бүтээгдсэн зүйл болох ёстой. Бурхан хамгийн өндөр газарт гарч чадахын сацуу Өөрийгөө даруу болгон бүтээгдсэн хүн болж, хүн төрөлхтний дунд ажиллаж, тэдний дунд амьдарч чаддаг, харин

хүн өндөрт гарч, сүнс болж чадахгүй, хамгийн доод газарт буун очиж бүр ч чадахгүй. Ийм учраас Бурхан Өөрийн ажлыг гүйцэтгэхийн тулд махбод болох ёстой. Тэрчлэн, эхний удаа бие махбодтой болох үеэр бие махбодтой болсон Бурханы махбод л цовдлолоор дамжуулан хүнийг золин аварч чадсан, харин Бурханы Сүнсний хувьд хүний төлөө нүглийн тахил болон цовдлогдох ямар ч аргагүй байв. Хүний төлөөх нүглийн тахил болохын тулд Бурхан шууд махбод болж чаддаг боловч хүн шууд тэнгэрт гарч, өөрийнх нь төлөө Бурханы бэлтгэсэн нүглийн тахилыг авч чадахгүй. Ийм болохоор энэ авралыг авахын тулд хүнийг тэнгэр лүү гаргалгүйгээр, тэнгэр, газрын хооронд хэд хэдэн удаа нааш цааш явахыг Бурханаас гуйх нь л боломжтой байв, учир нь хүн унаж доройтсон бөгөөд нүглийн тахилыг олж авах нь бүү хэл, тэнгэр өөд гарч ч ер чадахгүй. Тиймээс Есүс хүн төрөлхтний дунд ирж, хүний ердөө хийж чадахгүй ажлыг биечлэн хийх хэрэгтэй байлаа. Бурхан махбод болох бүрд энэ нь зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрвээ эдгээр үе шатны аль нэгийг Бурханы Сүнс шууд хийж чадах байсан бол Тэр бие махбодтой болохын доромжлолд өртөхгүй байх байлаа.

Ажлын энэ эцсийн үе шатанд үгээр дамжуулан үр дүнд хүрдэг. Үгээр дамжуулан хүн олон нууцыг болон өнгөрсөн үеүдийн туршид Бурханы хийсэн ажлын талаар ойлгож авдаг; үгээр дамжуулан хүнийг Ариун Сүнс гэгээрүүлдэг; үгээр дамжуулан хүн өмнөх үеийнхний хэзээ ч тайлаагүй нууцуудыг, мөн түүнчлэн өнгөрсөн үеийн эш үзүүлэгч, элч нарын ажлыг, тэдний ажилласан зарчмыг ойлгож авдаг; үгээр дамжуулан хүн бас Бурханы Өөрийн зан чанарыг болон хүний тэрслүү байдал, эсэргүүцлийг ойлгож, өөрийнхөө мөн чанарыг мэдэж авдаг. Ажлын эдгээр алхам болон хэлсэн бүх үгээр дамжуулан хүн Сүнсний ажлыг, бие махбодтой болсон Бурханы хийдэг ажлыг, үүнээс ч илүүтэйгээр Түүний бүхий л зан чанарыг мэдэж авдаг. Бурханы зургаан мянган жилийн удирдлагын ажлын тухай мэдлэгийг чи бас үгээр дамжуулан олж авсан. Урьдын үзлийн талаарх мэдлэг болон тэдгээрийг орхисон амжилтад бас л үгээр дамжин хүрээгүй гэж үү? Өмнөх үе шатанд Есүс тэмдэг, гайхамшиг үзүүлсэн боловч энэ үе шатанд тэмдэг, гайхамшиг байхгүй. Бурхан яагаад тэмдэг, гайхамшиг илчилдэггүй тухай ойлголтод ч чи бас үгээр дамжин хүрээгүй гэж үү? Тиймээс энэ үе шатанд хэлсэн үг өнгөрсөн үеийн элч нар болон эш үзүүлэгчдийн хийсэн ажлаас даван гардаг. Эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлүүд ч ийм үр дүнд хүрч чадаагүй. Эш үзүүлэгчид зөвхөн зөгнөл хэлсэн ба тухайн үед Бурханы хийхийг хүсэж байсан ажлыг биш, харин ирээдүйд юу болох тухай л хэлсэн. Тэд хүний амьдралыг залж чиглүүлж, хүнд үнэнийг хайрлаж, эсвэл

тэдэнд нууцыг илчлэхийн тулд, тэр ч бүү хэл амь хайрлахын тулд үг хэлээгүй. Энэ үе шатанд хэлсэн үгэнд зөгнөл болон үнэн байдаг боловч үндсэндээ эдгээр үг нь хүнд амь хайрлахын төлөө байдаг. Одоо үеийн үг нь эш үзүүлэгчдийн зөгнөлүүдтэй адилгүй. Энэ нь зөгнөл хэлэхийн төлөө биш, харин хүний амийн төлөөх, хүний амь зан чанарыг өөрчлөхийн төлөөх ажлын үе шат юм. Эхний үе шат нь Еховагийн ажил байсан: Түүний ажил нь газар дээр Бурханыг шүтэн мөргөх замыг хүнд зориулан бэлдэхийн төлөө байв. Энэ нь газар дээрх ажлын анхдагч газар нутгийг олох эхлэлийн ажил байсан юм. Тэр үед Ехова Амралтын өдрийг сахиж, эцэг эхээ хүндэтгэж, бие биетэйгээ эв найртай амьдрахад израильчуудыг сургасан. Учир нь, тухайн үеийн хүмүүс хүн гэж юу болохыг ойлгоогүй, мөн газар дээр яаж амьдрахыг ч ойлгоогүй. Ажлын эхний үе шатанд Тэрээр хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх шаардлагатай байсан юм. Еховагийн тэдэнд ярьсан бүхэн нь хүн төрөлхтний урьд нь мэддэггүй, эсвэл эзэмшдэггүй байсан зүйл байлаа. Тэр үед Бурхан олон эш үзүүлэгчийг зөгнөл хэлүүлэхээр өргөсөн ба тэд бүгд Еховагийн удирдамж дор ийнхүү хийсэн юм. Энэ нь зүгээр л Бурханы ажлын нэг хэсэг байв. Эхний үе шатанд Бурхан махбод болоогүй, иймээс Тэр эш үзүүлэгчдээр дамжуулан бүх овог болон үндэстэнд зааварчилсан. Өөрийнхөө цаг үед ажиллаж байхдаа Есүс одоогийнх шиг их яриагүй. Эцсийн өдрүүд дэх үгийн ажлын энэ үе шатыг өмнө нь ямар ч эрин үед хийж байгаагүй юм. Хэдийгээр Исаиа, Даниел, Иохан нар олон зөгнөл хэлсэн боловч тэдний зөгнөлүүд одоо хэлж байгаа үгээс шал өөр байв. Тэдний хэлсэн зүйл ердөө зөгнөл байсан боловч одоо хэлдэг үг тийм биш. Хэрвээ Би одоо ярьдаг бүхнээ зөгнөл болгон хувиргавал та нар ойлгож чадах уу? Миний хэлсэн зүйл Намайг явсны дараах хэрэг явдлын тухай байсан гэж үзвэл та нар яаж ойлгож чадах юм бэ? Есүсийн цаг үед, эсвэл Хуулийн эрин үед үгийн ажил хэзээ ч хийгдээгүй. Магадгүй зарим нь: “Ехова ч бас ажиллаж байх үедээ үг хэлээгүй гэж үү? Өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулж, тэмдэг, гайхамшиг үзүүлэхээс гадна ажиллаж байхдаа Есүс ч бас үг хэлээгүй гэж үү?” хэмээн хэлэх байх. Хэлсэн зүйлсийн хооронд ялгаа байдаг. Еховагийн айлдсан үгийн мөн чанар юу байсан бэ? Тэр ердөө газар дээр амьдрахад нь хүмүүсийг залж чиглүүлж байсан ба амийн сүнслэг хэрэг явдлыг хөндөөгүй. Еховаг ярих үед энэ нь бүх газар нутгийн хүмүүст зааварчлахын төлөө байсан гэж яагаад хэлдэг вэ? “Зааварчлах” гэдэг үг нь тодорхой хэлж, шууд тушаах гэсэн үг. Тэрээр хүнийг амиар хангаагүй; харин, төдийлөн их сургаалт зүйрлэлгүйгээр, хүнийг зүгээр л гараас нь хөтөлж, Түүнийг яаж хүндэтгэхийг хүнд заасан. Еховагийн Израильд

хийсэн ажил нь хүнтэй харьцаж, хүнийг сахилгажуулж, эсвэл хүнд шүүлт, гэсгээлт оноохын төлөө байгаагүй, харин хүнийг залж чиглүүлэхийн төлөө байсан юм. Цөлөөс манна цуглуул гэж Өөрийнх нь ардуудад хэлэхийг Ехова Мосед тушаасан. Өглөө бүр нар мандахаас өмнө тэд тухайн өдөр идэхэд нь л хангалттай хэмжээний манна түүдэг байлаа. Муудчихдаг байсан болохоор маннаг дараагийн өдөр болтол нь хадгалж болдоггүй байжээ. Тэр хүмүүст сургамжлаагүй, уг чанарыг нь ч илчлээгүй, мөн тэдний санаа бодлыг ч ил болгоогүй. Тэрээр хүмүүсийг өөрчлөөгүй, харин ч амьдралыг нь залж чиглүүлсэн юм. Тухайн үеийн хүмүүс яг л хүүхдүүд шиг, юу ч ойлгодоггүй байсан бөгөөд үндсэн хэдэн механик хөдөлгөөн л хийж чаддаг байсан тул Ехова олон түмнийг залж чиглүүлэхийн тулд л хууль гаргасан юм.

Үнэн сэтгэлээсээ эрж хайдаг бүх хүнийг өнөөдөр хийгдэж буй ажлын талаар мэдлэгтэй болгож, бүрмөсөн үнэмшүүлэхийн тулд сайн мэдээ түгээе гэвэл чи үе шат бүрд хийгдсэн ажлын дотоод түүх, мөн чанар, ач холбогдлыг тодорхой ойлгодог байх ёстой. Нөхөрлөлийг чинь сонсоод хүмүүс Еховагийн ажлыг болон Есүсийн ажлыг, тэр тусмаа өнөөдрийн Бурханы ажлыг, мөн ажлын гурван үе шатны холбоо болон ялгааг ойлгож болохуйц байлга. Сонсож дуусаад хүмүүс, гурван үе шат нь нэг нэгэндээ саад болдоггүй, харин бүгд нэг Сүнсний ажил, мөн хэдийгээр Тэд өөр өөр эрин үед ажиллаж, гүйцэтгэдэг ажлынх нь агуулга өөр, хэлдэг үг нь ч бас өөр байдаг боловч ажилладаг зарчим нь нэгэн ижил гэдгийг харахуйц байлга. Эдгээр зүйл бол Бурханыг дагадаг бүх хүний ойлгох ёстой хамгийн агуу үзэгдэл билээ.

ХОЁР УДАА БИЕ МАХБОДТОЙ БОЛОХ НЬ БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ГҮЙЦЭЭДЭГ

Бурханы хийсэн ажлын үе шат болгон өөрийн гэсэн бодит ач холбогдолтой. Тухайн үед Есүс ирэхдээ эрэгтэй хэлбэрээр ирсэн бол Бурхан энэ удаад эмэгтэй хэлбэрээр ирсэн. Үүнээс чи, Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн нь Өөрийнх нь ажилд хэрэгтэй байж болохыг харж чадах ба Түүнд хүйсийн ялгаа байдаггүй. Түүний Сүнс ирэхдээ Өөрийн хүссэн ямар ч махбодыг сонгон авч болох бөгөөд тэрхүү махбод Түүнийг төлөөлж чадна; эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, Түүний махбод болсон бие мөн л бол Бурханыг төлөөлж чадна. Хэрвээ Есүс ирэхдээ эмэгтэй хүн болж гарч ирсэн бол, өөрөөр хэлбэл, Ариун

Сүнснээс хүү биш, харин охин олдсон бол ажлын тэрхүү үе шат мөн л адилхан гүйцэлдэх байв. Хэрвээ тийм байсан бол ажлын одоогийн үе шатыг эрэгтэй хүн гүйцэлдүүлэх байсан, тэгсэн ч ажил мөн л адилхан хийгдэж дуусах байв. Үе шат бүрд хийгдсэн ажил өөрийн гэсэн ач холбогдолтой; ажлын аль ч үе шат давтагддаггүй, нөгөөтэйгөө ч зөрчилддөггүй. Тухайн үед, Есүс Өөрийн ажлыг хийж байхдаа цорын ганц Хүү гэж нэрлэгдэж байсан бөгөөд “Хүү” гэдэг нь эрэгтэй хүйс гэсэн утгыг агуулдаг. Тэгвэл одоогийн энэ үе шатанд яагаад цорын ганц Хүү гэж дурддаггүй вэ? Яагаад гэвэл, ажил нь Есүсийнхээс өөр хүйстэй байхыг шаардсан юм. Бурханы хувьд хүйсийн ялгаа ер байхгүй. Тэр Өөрийнхөө ажлыг хүссэнээрээ хийдэг ба ажлаа хийхдээ ямар ч хязгаарлалтад баригддаггүй, харин маш чөлөөтэй байдаг. Гэхдээ ажлын үе шат болгон өөрийн гэсэн бодит ач холбогдолтой. Бурхан хоёр удаа махбод болсон бөгөөд эцсийн өдрүүдийн үеэр бие махбодтой болдог нь сүүлчийнх гэдэг нь илэрхий юм. Тэрээр Өөрийн бүх үйл хэргийг мэдэгдэхийн тулд ирсэн. Хэрвээ энэ үе шатанд хүнд харуулах ажлаа биечлэн хийхийн тулд Тэр махбод болоогүй бол, Бурхан эмэгтэй биш, зөвхөн эрэгтэй гэсэн үзэлтэй хүн үүрд зууралдах байлаа. Үүнээс өмнө, Бурхан зөвхөн эрэгтэй байж болох бөгөөд эмэгтэй хүнийг Бурхан гэж нэрлэж болохгүй гэж бүх хүн итгэдэг байв, учир нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү эрх мэдэлтэй гэж бүгд үздэг байсан юм. Ямар ч эмэгтэй хүн эрх мэдлийг авч чадахгүй, зөвхөн эрэгтэй хүн л чадна гэж тэд итгэдэг байлаа. Тэр ч бүү хэл тэд, эрэгтэй хүн нь эмэгтэй хүний тэргүүн бөгөөд эмэгтэй хүн эрэгтэй хүнд дуулгавартай байх ёстой, эрэгтэй хүнээс илүү байж болохгүй гэж ч хэлдэг байв. Урьд нь, эрэгтэй хүн эмэгтэй хүний тэргүүн байсан гэж хэлэх үед энэ нь могойд мэхлэгдсэн Адам, Евад чиглэсэн болохоос бус, анх Еховагийн бүтээсэн эрэгтэй, эмэгтэй хүн рүү чиглээгүй юм. Мэдээж эмэгтэй хүн нөхөртөө дуулгавартай байж, түүнийг хайрлах ёстой, нөхөр нь гэр бүлээ тэжээж, тулж түшиж сурах ёстой. Энэ нь Еховагийн тогтоосон хууль, зарлиг бөгөөд хүн төрөлхтөн газар дээрх амьдралдаа үүнийг дагаж мөрдөх ёстой. Ехова эмэгтэй хүнд, “Эр нөхрөө чи эрмэлзэнэ, нөхөр чинь чамайг захирах болно” гэж хэлсэн. Хүн төрөлхтөн (өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүн хоёулаа) Еховагийн ноёрхол дор хэвийн амьдралаар амьдарч, хүн төрөлхтний амьдрал зохион байгуулалттай, зөв зохистой дэг журмаа алдахгүй байгаасай гэсэндээ Тэр ингэж хэлсэн юм. Тиймээс Ехова эрэгтэй, эмэгтэй хүн хэрхэн үйлдэх ёстой талаар зөв зохистой дүрэм журам гаргасан, гэхдээ энэ нь газар дээр амьдарч байгаа бүх бүтээгдсэн зүйлд хамаатай байсан бөгөөд Бурханы махбод болсон биед ямар ч хамаагүй

байлаа. Бурхан яаж Өөрийн бүтээсэн зүйлстэй адил байж болох юм бэ? Түүний үг Өөрийнх нь бүтээл болох хүн төрөлхтөн рүү л чиглэж байсан; хүн төрөлхтнийг хэвийн амьдралаар амьдруулахын тулд Тэр эрэгтэй, эмэгтэй хүнд зориулж дүрэм журам тогтоосон билээ. Анх Ехова хүн төрөлхтнийг бүтээхдээ хоёр төрлийн хүнийг буюу эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн; иймээс Түүний махбод болсон бие ч бас эрэгтэй, эмэгтэй болж хуваагддаг. Тэр Адам, Ева хоёрт хэлсэн үгэндээ үндэслэн Өөрийн ажлыг шийдээгүй. Тэр хоёр удаа махбод болсон нь бүхэлдээ, хүн төрөлхтнийг анх бүтээх үеийн Түүний бодлын дагуу тодорхойлогдсон, өөрөөр хэлбэл, ялзруулагдахаас өмнөх эрэгтэй, эмэгтэй хүнд үндэслэн Тэрээр хоёр удаа бие махбодтой болох ажлаа гүйцэтгэсэн юм. Хэрэв хүмүүс могойд мэхлэгдсэн Адам, Ева хоёрт Еховагийн хэлсэн үгийг аваад бие махбодтой болсон Бурханы ажилд хэрэглэсэн бол Есүс ч бас эхнэрээ хайрлах учиртай байсан бус уу? Тэгвэл Бурхан бас Бурхан хэвээр байх байсан уу? Хэрвээ тийм байсан бол Тэр Өөрийн ажлыг гүйцэлдүүлж мөн л чадах байсан уу? Хэрвээ Бурханы махбод болсон бие эмэгтэй байх нь буруу юм бол Бурхан эмэгтэй хүнийг бүтээсэн нь мөн асар том алдаа болохгүй гэж үү? Бурхан эмэгтэй хүн болж бие махбодтой болох нь буруу гэж хүмүүс итгэсээр байгаа бол гэрлээгүй, тийм ч болохоор Өөрийн эхнэрийг хайрлаж чадаагүй Есүс одоогийн бие махбодтой болсон Бурхантай адил ихээхэн алдаатай байх бус уу? Өнөө үеийн бие махбодтой болсон Бурханы үнэнийг хэмжихдээ чи Евад хэлсэн Еховагийн үгийг ашигладаг бол Нигүүлслийн эрин үед бие махбодтой болсон Эзэн Есүсийг үнэлэхдээ Адамд хэлсэн Еховагийн үгийг ашиглах ёстой. Энэ хоёр адилхан биш гэж үү? Чи могойд мэхлэгдээгүй эрэгтэйгээр Эзэн Есүсийг хэмждэг бол өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы үнэнийг могойд мэхлэгдсэн эмэгтэйгээр хэмжиж болохгүй. Энэ нь шударга бус! Бурханыг ингэж хэмжиж байгаа нь чамд саруул ухаан дутаж байгааг нотолдог. Ехова хоёр удаа махбод болох үед Түүний махбодын хүйс нь могойд мэхлэгдээгүй эрэгтэй, эмэгтэй хүнтэй хамаатай байсан; могойд мэхлэгдээгүй эрэгтэй, эмэгтэй хүний дагуу Тэр хоёр удаа махбод болсон юм. Есүсийн эрэгтэй чанар нь могойд мэхлэгдсэн Адамтай адил байсан гэж бүү бод. Тэр хоёр хоорондоо огт хамаагүй бөгөөд тэд бол өөр өөр шинж чанартай хоёр эрэгтэй юм. Есүсийн эрэгтэй чанар нь Тэрээр бүх эрэгтэй хүний бус, бүх эмэгтэй хүний тэргүүн гэдгийг баталж байгаа хэрэг биш биз дээ? Тэр бүх Иудейн (эрэгтэй болоод эмэгтэй аль алийг нь багтаагаад) Хаан биш гэж үү? Тэр бол Бурхан Өөрөө бөгөөд зөвхөн эмэгтэй хүний тэргүүн биш, бас эрэгтэй хүний ч

тэргүүн юм. Тэрээр бүх бүтээлийн Эзэн бөгөөд бүх бүтээлийн тэргүүн билээ. Есүсийн эрэгтэй чанар нь эмэгтэй хүний тэргүүн байхын бэлгэ тэмдэг гэж чи яаж тодорхойлж чадаж байна вэ? Энэ нь доромжлол биш гэж үү? Есүс бол ялзруулагдаагүй эрэгтэй. Тэр бол Бурхан; Тэр бол Христ; Тэр бол Эзэн. Тэр яаж ялзарсан Адамтай адилхан эрэгтэй байх юм бэ? Есүс бол хамгийн ариун Бурханы Сүнсний өмссөн махбод юм. Тэр бол Адамын эрэгтэй чанарыг эзэмшдэг Бурхан гэж чи яаж хэлж чадаж байна вэ? Тэр тохиолдолд Бурханы бүх ажил буруу байх байсан биш гэж үү? Ехова могойд мэхлэгдсэн Адамын эрэгтэй чанарыг Есүсийн дотор нэгтгэх байсан уу? Өнөө үеийн бие махбодтой Бурхан нь хүйсээрээ Есүсээс ялгаатай боловч уг чанараараа адилхан бие махбодтой болсон Бурханы ажлын өөр нэг тохиолдол биш гэж үү? Могойд эхлээд мэхлэгдсэн хүн нь эмэгтэй байсан учраас бие махбодтой болсон Бурхан эмэгтэй байж болохгүй гэж чи одоо ч хэлж зүрхлэх үү? Эмэгтэй хүн бол хамгийн бузар бөгөөд хүн төрөлхтний ялзалын эх сурвалж тул Бурхан эмэгтэй хүнтэй адил махбод болж болохгүй гэж мөн л хэлж зүрхлэх үү? Чи, “эмэгтэй хүн үргэлж эрэгтэй хүнд дуулгавартай байх ёстой, хэзээ ч Бурханыг илэрхийлж, эсвэл шууд төлөөлж чадахгүй” гэж хэлж зүрхэлсээр л байна уу? Чи өмнө нь ойлгоогүй байсан боловч одоо ч гэсэн Бурханы ажлыг, ялангуяа Бурханы махбод болсон биеийг доромжилсоор байж чадах уу? Хэрвээ чи үүнийг тов тодорхой ойлгож чадахгүй бол хэл амаа анхаарч байсан нь дээр, тэнэглэл болон мэдлэггүй байдал чинь илчлэгдэж, муу муухай чинь илрэх вий. Чи бүхнийг ойлгодог гэж бүү бод. Миний удирдлагын төлөвлөгөөний мянганы нэг хэсгийг ч ойлгоход харсан, туулсан бүхэн чинь хангалттай биш гэдгийг Би чамд хэлж байна. Тэгвэл яагаад чи ийм ихэрхүү авирладаг юм бэ? Чиний өчүүхэн жаахан авьяас, туйлын бага мэдлэгийг Есүс Өөрийнхөө ажлын нэг секундэд ч ашиглахад хангалтгүй юм! Чи үнэндээ хэр их туршлагатай вэ? Бүх насаараа харсан, сонссон, төсөөлсөн бүхэн чинь Миний агшин зуур хийдэг ажлаас ч бага! Чи өөнтөглөхгүй байсан нь дээр. Чи хүссэнээрээ биеэ тоож болно, гэхдээ чи бол шоргоолжны хэмжээнд ч хүрэхгүй бүтээлээс цаашгүй! Гэдсэн дотроо агуулдаг бүхэн чинь шоргоолжны гэдсэнд байдгаас ч бага! Бага зэрэг туршлага, зэрэг зиндаа олж авсан учраас энэ нь чамд цадиггүйгээр дохиж зангаж, сайрхах эрх олгодог гэж бүү бод. Чиний туршлага болон зэрэг зиндаа Миний айлдсан үгийн үр дүн биш гэж үү? Чи тэдгээрийг шаргуу ажил, хөдөлмөрийн чинь үр дүнд ирсэн гэж итгэж байна уу? Өнөөдөр чи махбод болсныг минь харж байна, гагцхүү үүнээс л болж чиний дотор хангалттай баялаг

ойлголт, хязгааргүй их үзэл байдаг. Хэрвээ Би бие махбодтой болоогүй бол чи ер бусын авьяастай байсан ч гэсэн ийм олон ухагдахуунтай болохгүй байх байсан; эдгээрээс чиний үзэл гарч ирдэггүй гэж үү? Хэрвээ Есүс анх махбод болоогүй байсан бол чи бие махбодтой болох талаар мэдэх байсан гэж үү? Эхний удаа бие махбодтой болсон нь чамд мэдлэг өгсөн болохоор хоёр дахь удаа бие махбодтой болсныг нь шүүх гэж оролдох эрээ цээргүй зан чамд байгаа бус уу? Дуулгавартай дагагч байхын оронд чи яагаад үүнийг судалж шинжлэх ёстой юм бэ? Чамайг энэ урсгалд орж, бие махбодтой болсон Бурханы өмнө ирэх үед үүнийг судлахыг чинь Тэр чамд зөвшөөрөх үү? Чи гэр бүлийнхээ түүхийг судалж болно, гэтэл Бурханы “гэр бүлийн түүхийг” судлахаар оролдвол өнөөдрийн Бурхан ийм судалгаа хийхийг чинь зөвшөөрөх үү? Чи сохор бус уу? Чи жигшил зэвүүцэл төрүүлдэггүй гэж үү?

Хэрвээ эцсийн өдрүүдийн энэхүү үе шатан дахь ажлыг нэмэхгүйгээр зөвхөн Есүсийн ажил хийгдсэн бол, Есүс ганцаараа л Бурханы цорын ганц Хүү, өөрөөр хэлбэл, Бурханд цорын ганц хүү байдаг бөгөөд дараа нь өөр нэрээр ирсэн хэн боловч Бурхан Өөрөө байх нь бүү хэл, Бурханы цорын ганц Хүү ч биш гэсэн үзлийг хүн үүрд хадгалах байсан юм. Нүглийн тахил болон үйлчилж, эсвэл Бурханы өмнөөс эрх мэдлийг гартаа авч, бүх хүн төрөлхтнийг золин авардаг хүн л Бурханы цорын ганц Хүү юм гэсэн үзэл хүнд байдаг. Ирдэг Нэгэн нь эрэгтэй байх л юм бол Түүнийг Бурханы цорын ганц Хүү болон Бурханы төлөөлөгч гэж үзэж болно хэмээн итгэдэг зарим хүн байдаг бөгөөд Есүс бол Еховагийн Хүү, Түүний цорын ганц Хүү гэж хэлдэг ч хүмүүс бий. Энэ нь хүний хэтрүүлэгтэй үзэл биш гэж үү? Хэрвээ ажлын энэ үе шат нь эцсийн эрин үед хийгдээгүй байсан бол Бурханы тухайд бүх хүн төрөлхтөн харанхуйн сүүдэрт хучигдах байв. Хэрвээ ийм байсан бол эрэгтэй хүн өөрийгөө эмэгтэй хүнээс илүү дээр гэж бодох байсан ба эмэгтэйчүүд хэзээ ч толгой өргөн явж чадахгүй байх байсан, тэгвэл ганц ч эмэгтэй хүн аврагдаж чадахгүй байх байлаа. Бурхан бол эрэгтэй, түүнээс гадна Тэр үргэлж эмэгтэй хүнийг үзэн яддаг бөгөөд түүнд аврал хайрлахгүй байсан гэдэгт хүмүүс үргэлж итгэдэг. Хэрвээ ийм байсан бол Еховагийн бүтээсэн, бас ялзарсан бүх эмэгтэй хүн хэзээ ч аврагдах боломжгүй байх байсан бус уу? Тэгвэл Ехова эмэгтэй хүнийг бүтээсэн нь, өөрөөр хэлбэл, Еваг бүтээсэн нь утгагүй байх байсан бус уу? Эмэгтэй хүн мөнхөд мөхөх байсан бус уу? Ийм шалтгааны улмаас, эцсийн өдрүүд дэх ажлын үе шат нь зөвхөн эмэгтэй хүнийг биш, харин бүх хүн төрөлхтнийг аврахын тулд хийгддэг. Бурхан эмэгтэй хүний дүрээр бие махбодтой болбол, тэр нь гагцхүү эмэгтэй хүнийг

аврахын төлөө байна гэж хэн нэгэн бодох юм бол тэр хүн үнэхээр тэнэг юм!

Өнөөдрийн ажил Нигүүлслийн эрин үеийн ажлыг урагшлуулсан; өөрөөр хэлбэл, бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх ажил урагшилсан. Хэдийгээр Нигүүлслийн эрин үе дууссан ч Бурханы ажилд ахиц гарлаа. Ажлын энэ үе шат нь Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үед үндэслэн хийгддэг гэж Би яагаад ахин дахин хэлдэг вэ? Яагаад гэвэл, өнөөдрийн ажил бол Нигүүлслийн эрин үед хийгдсэн ажлын үргэлжлэл бөгөөд Хуулийн эрин үед хийгдсэн зүйлийн ахиц дэвшил юм. Гурван үе шат нь өөр хоорондоо нягт харилцан холбогдсон ба гинжин холбоос нэг бүр нь дараагийнхтайгаа нягт холбогдсон байдаг. Ажлын энэхүү үе шат нь Есүсийн хийсэн дээр тулгуурлан хийгддэг гэж Би бас яагаад хэлдэг вэ? Энэ үе шат Есүсийн хийсэн ажилд тулгуурлан хийгдээгүй гэж үзвэл энэ үе шатанд өөр цовдлол явагдах хэрэгтэй болох байсан бөгөөд өмнөх үе шатны золин аврах ажлыг дахиад эхнээс нь хийх хэрэгтэй болох байв. Энэ нь утгагүй байх байлаа. Иймээс ажил бүрэн дууссан юм биш, харин эрин үе урагшилсан бөгөөд ажлын түвшин өмнөхөөсөө бүр ч илүү өндөрт өргөгдсөн юм. Ажлын энэхүү үе шат Хуулийн эрин үеийн суурин дээр, Есүсийн ажлын суурин дээр хийгдсэн гэж хэлж болно. Бурханы ажил шат шатаар хийгдсэн бөгөөд энэ үе шат нь шинэ эхлэл биш юм. Ажлын гурван үе шатны хослолыг л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гэж үзэж болно. Энэ үе шатны ажил нь Нигүүлслийн эрин үеийн ажлын суурин дээр хийгддэг. Хэрвээ ажлын энэ хоёр үе шат хоорондоо хамааралгүй байсан бол яагаад энэ үе шатанд цовдлол давтагддаггүй вэ? Яагаад Би хүний нүглийг үүрэхийн оронд хүнийг шууд шүүж, гэсгээдэг вэ? Хэрвээ хүнийг шүүж, гэсгээх Миний ажил цовдлолын дараа болоогүй, одоо ирж байгаа минь Ариун Сүнснээс олдож төрөөгүй бол Би хүнийг шүүж, гэсгээх эрхгүй байх байлаа. Би Есүстэй нэг учраас л хүнийг шууд гэсгээж, шүүж эхэлдэг. Энэ үе шатан дахь ажил бүхэлдээ өмнөх үе шатны ажил дээр суурилсан. Тийм учраас, ийм ажил л хүнийг алхам алхмаар авралд хүргэж чадна. Есүс Бид хоёр нэг Сүнснээс ирсэн. Бидний махбод ямар ч хамаагүй хэдий ч Бидний Сүнс нэг юм; Бидний хийдэг зүйлийн агуулга болон Бидний хариуцдаг ажил адилхан биш хэдий ч мөн чанартаа Бид адилхан; Бидний махбод өөр өөр дүр төрхтэй болсон нь эрин үеийн өөрчлөлт болон ажлын маань өөр өөр шаардлагаас үүдэлтэй; Бидний үйлчлэл адилгүй, иймээс Бидний авчирдаг ажил болон хүнд илчилдэг Бидний зан чанар бас өөр. Тийм учраас өнөөдөр хүний харж, ойлгодог зүйл өнгөрсөн үеийнхтэй адилгүй байдаг нь эрин

үеийн өөрчлөлтөөс үүддэг. Хэдийгээр Тэдний махбодын хүйс, дүр төрх өөр, мөн Тэд нэгэн цаг үед байтугай, нэг гэр бүлд төрөөгүй боловч Тэдний Сүнс нэг билээ. Тэдний махбод ямарваа төрлийн мах цусны барилдлагагүй ч Тэд бол хоёр өөр цаг хугацаанд бие махбодтой болсон Бурхан гэдгийг үгүйсгэж болохгүй. Тэд бол Бурханы махбод болсон бие гэдэг нь няцаашгүй үнэн. Гэхдээ, Тэд нэг удам сударгүй, эсвэл нэг хэлээр ярьдаггүй (нэг нь иудейчүүдийн хэлээр ярьдаг эрэгтэй хүн байсан, нөгөө нь Хятад хэлээр л ярьдаг эмэгтэй хүн). Эдгээр шалтгааны улмаас Өөрсдийн хийх учиртай ажлыг хийхийн тулд Тэд өөр өөр улс оронд, бас өөр өөр цаг үед амьдарсан. Тэд адилхан мөн чанартай Сүнс хэдий ч Тэдний махбодын гадаад бүрхүүлийн хооронд туйлын адил төстэй зүйл огтхон ч байхгүй. Тэд адилхан хүн чанартай ч Тэдний махбодын гадаад төрх болон төрөлтийн нөхцөл байдал адилгүй. Эдгээр зүйл Тэдний тус тусын ажил юм уу Тэдний талаарх хүний мэдлэгт ямар ч нөлөөгүй, учир нь эцсийн дүндээ Тэд бол адилхан Сүнс бөгөөд хэн ч Тэднийг салгаж чадахгүй. Хэдий Тэд цусан холбоогүй боловч Тэдний бүхий л оршихуйг Өөрсдийнх нь Сүнс захирдаг, энэ нь Тэдэнд өөр өөр цаг үед, өөр өөр ажил оноодог ба Тэдний махбод өөр өөр удам судартай. Еховагийн Сүнс нь Есүсийн Сүнсний эцэг биш, мөн Есүсийн Сүнс нь Еховагийн Сүнсний хүү биш: Тэд бол нэг Сүнс юм. Үүний адилаар өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан, Есүс хоёр цусан хамааралгүй ч Тэд бол нэг; яагаад гэвэл, Тэдний Сүнс нэг юм. Бурхан өршөөл, хайр энэрлийн ажлыг, түүнчлэн хүнийг зөв шударгаар шүүж, гэсгээх ажлыг, мөн хүнд хараал учруулах ажлыг хийж чадна; эцэст нь Тэрээр дэлхийг устгаж, хорон муу хүмүүсийг шийтгэх ажлыг хийж чадна. Тэр Өөрөө энэ бүхнийг хийдэггүй гэж үү? Энэ нь Бурханы бүхнийг чадагч байдал биш гэж үү? Тэрээр хүний төлөө хууль тогтоож, түүнд зориулан тушаал гаргахын аль алиныг хийж чадсан ба түүнчлэн тухайн үеийн израильчуудыг газар дээр амьдрахад нь залж чиглүүлж, сүм болон тахилын ширээ барихад нь тэдэнд зааварчилж, бүх израильчуудыг Өөрийнхөө эрх мэдэл дор байлгаж чадсан. Өөрийнхөө эрх мэдлээс үүдэн Тэр Израилийн ард түмэнтэй хамт газар дээр хоёр мянган жилийн турш амьдарсан юм. Израильчууд Түүний эсрэг тэрсэлж зүрхлээгүй; бүгд Еховаг хүндэтгэж, Түүний тушаалуудыг мөрджээ. Энэ нь, Түүний эрх мэдэл, бүхнийг чадагч байдалд түшиглэн хийгдсэн ажил байв. Дараа нь Нигүүлслийн эрин үед Есүс унасан бүх хүн төрөлхтнийг (зөвхөн израильчуудыг ч биш) золин аврахаар ирсэн юм. Тэрээр хүнд өршөөл, хайр энэрлийг харуулсан. Нигүүлслийн эрин үед хүний харсан Есүс хайр энэрлээр бялхаж, хүнийг үргэлж хайрладаг байсан, учир

нь Тэр хүмүүсийг нүглээс аврахаар ирсэн юм. Өөрийнх нь цовдлол хүн төрөлхтнийг нүглээс бүрэн золин аврах хүртэл Тэр хүмүүсийн нүглийг уучилж чаддаг байлаа. Тэр үед, Бурхан хүний өмнө өршөөл, хайр энэрэлтэйгээр гарч ирсэн; өөрөөр хэлбэл, Тэр хүний төлөө нүглийн тахил болж, хүний нүглийн төлөө цовдлогдож, нүглийг нь үүрд уучилсан билээ. Тэрээр өршөөнгүй, энэрэнгүй, тэвчээртэй агаад элэгсэг байсан юм. Нигүүлслийн эрин үед Есүсийг дагасан хүмүүс ч бас бүх зүйл дээр тэвчээртэй, энэрэнгүй байхаар хичээж байсан. Тэд урт удаан хугацаанд зовсон бөгөөд зодуулж, хараалгаж, эсвэл чулуугаар шидүүлж байсан ч хэзээ ч эсэргүүцээгүй. Гэхдээ сүүлийн үе шатанд дахин тийм байж болохгүй. Есүс, Ехова хоёрын Сүнс нэг байсан хэдий ч Тэдний ажил бүхэлдээ адилхан байгаагүй. Еховагийн ажил эрин үеийг төгсгөөгүй, харин эрин үеийг удирдаж, газар дээрх хүн төрөлхтний амьдралыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн ажил нь Харь үндэстнүүд дэх гүнзгий ялзруулагдсан хүмүүсийг байлдан дагуулж, Хятад дахь Бурханы сонгосон хүмүүсийг төдийгүй, бүхий л орчлон ертөнц, бүх хүн төрөлхтнийг удирдахын төлөө байдаг. Энэ ажил одоо зөвхөн Хятадад хийгдэж байна гэж чамд харагдаж болох боловч үнэндээ энэ нь аль хэдийн хилийн чанадад түгэж эхэлсэн. Хятадын гаднах хүмүүс яагаад үнэн замыг ахин дахин эрж хайдаг юм бэ? Яагаад гэвэл Сүнс аль хэдийн ажиллаж эхэлсэн ба өнөөдөр хэлсэн үг орчлон ертөнц дахины хүмүүст чиглэдэг. Үүний хамтаар ажлын тэн хагас аль хэдийн хийгдсэн. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл Бурханы Сүнс ийм агуу ажлыг хийж эхэлсэн бөгөөд түүнчлэн өөр өөр эрин үед, өөр өөр улс үндэстэнд ялгаатай ажил хийсэн юм. Эрин үе бүрийн хүмүүс Түүний хийдэг өөр өөр ажлаар аяндаа илчлэгддэг өөр өөр зан чанарыг нь хардаг. Тэр бол өршөөл, хайр энэрлээр дүүрэн Бурхан; Тэр бол хүний төлөөх нүглийн тахил бөгөөд хүний хоньчин; гэхдээ Тэр бас хүний шүүлт, гэсгээлт болон хараал юм. Тэрээр хүнийг газар дээр амьдрахад нь хоёр мянган жилийн турш удирдаж, бас ялзарсан хүн төрөлхтнийг нүглээс золин аварч чадсан. Өнөөдөр Тэр бас Өөрийг нь мэддэггүй хүн төрөлхтнийг байлдан дагуулж, Өөрийнхөө эрх мэдэл дор байлгаж, бүгдийг нь Өөртөө бүрэн захирагдуулж чаддаг. Эцэст нь, Тэрээр орчлон ертөнц дахины хүмүүсийн доторх бузар, зөв шударга бус бүгдийг шатаан, Тэр бол өршөөнгүй, энэрэнгүй Бурхан, мэргэн ухаан, гайхамшгийн Бурхан, мөн ариун Бурхан байгаад зогсохгүй, түүнчлэн хүнийг шүүдэг Бурхан юм гэдгийг хүмүүст харуулна. Хүн төрөлхтний дундах муу хүмүүст Тэр бол шатаалт, шүүлт, шийтгэл; төгс болгуулах хүмүүст Тэр бол гай зовлон, цэвэршүүлэлт, шалгалт, түүнчлэн тайтгарал, дэмжлэг, үгийн хангалт,

харьцалт, засалт юм. Таягдуулах хүмүүст бол Тэрээр шийтгэл, мөн залхаан цээрлүүлэлт билээ. Надад хэлээч, Бурхан төгс хүчит биш гэж үү? Тэр чиний төсөөлдөг шиг зөвхөн цовдлолыг биш, харин аливаа бүх ажлыг хийх чадвартай. Чи Бурханыг хэтэрхий доогуур бодож байна! Тэрээр цовдолоор дамжуулан бүх хүн төрөлхтнийг золин аварч л чадна, тэгээд л тэр гэж чи итгэж байна уу? Үүний дараа чи амийн модны жимсийг идэж, амийн голоос уухын тулд тэнгэр өөд Түүнийг дагах уу?... Ийм энгийн байж болно гэж үү? Надад хэл дээ, чи юу хийж гүйцэлдүүлсэн юм бэ? Чамд Есүсийн амь байгаа юу? Чи үнэндээ Түүгээр золин авруулсан, гэхдээ цовдлол нь Есүсийн Өөрийнх нь ажил байсан. Хүний хувиар чи ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Чамд гадаад талын сүсэг бишрэл л байдаг боловч Түүний замыг ойлгодоггүй. Ингэж чи Түүнийг харуулдаг юм уу? Хэрвээ чи Бурханы амийг олж аваагүй, эсвэл Түүний зөвт зан чанарыг бүхэлд нь хараагүй бол өөрийгөө амьтай нэгэн гэж хэлж болохгүй бөгөөд тэнгэрийн хаанчлалын хаалгаар ороход тэнцэхгүй.

Бурхан Сүнс байгаад зогсохгүй, бас махбод болж чаддаг. Түүнчлэн Тэр бол алдрын бие мөн. Хэдий та нар Есүсийг хараагүй боловч тухайн үеийн израильчууд буюу иудейчүүд Түүнийг нүдээрээ харсан. Тэр эхлээд махбодтой бие байсан, харин цовдлогдсоныхоо дараа алдрын бие болсон. Тэр бол бүхнийг хамрагч Сүнс бөгөөд газар бүрд ажиллаж чаддаг. Тэр Ехова, Есүс, эсвэл Мессиа байж чадна; эцэст нь Тэр бас Төгс Хүчит Бурхан болж чадна. Тэр бол зөвт байдал, шүүлт, гэсгээлт; Тэр бол хараал, уур хилэн; гэхдээ Тэр бас өршөөл, хайр энэрэл юм. Түүний хийсэн бүх ажил Түүнийг төлөөлөх чадвартай. Түүнийг ямархуу Бурхан гэж чи хэлэх вэ? Чи тайлбарлаж чадахгүй. Хэрвээ чи үнэхээр тайлбарлаж чадахгүй бол Бурханы талаар дүгнэлт гаргах ёсгүй. Нэг үе шатанд золин авралын ажил хийснээс нь болж Бурхан бол үүрд өршөөл, хайр энэрлийн Бурхан байна гэсэн дүгнэлт бүү гарга. Тэр зөвхөн өршөөнгүй, энэрэнгүй Бурхан байна гэдэгт чи итгэлтэй байж чадах уу? Хэрвээ Тэр ердөө өршөөнгүй, энэрэнгүй Бурхан юм бол яагаад эцсийн өдрүүдэд эрин үеийг төгсгөх вэ? Яагаад маш олон гамшгийг илгээх вэ? Хүмүүсийн үзэл, бодлын дагуу бол хүн төрөлхтний гишүүн нэг бүрийг аврахын тулд Бурхан бүр эцсээ хүртэл өршөөнгүй, энэрэнгүй байх ёстой. Гэтэл эцсийн өдрүүдэд, Бурханыг дайснаа гэж үздэг ёрын муу энэ хүн төрөлхтнийг устгахын тулд Тэр яагаад газар хөдлөлт, тахал, өлсгөлөн гэх мэтийн агуу гамшгийг буулгадаг юм бэ? Яагаад Тэр хүнийг эдгээр гамшгаас болж зовохыг зөвшөөрдөг вэ? Бурхан ямархуу болохыг та нарын дундаас хэн ч хэлж зүрхэлдэггүй, хэн ч тайлбарлаж

чаддаггүй. Тэр бол үнэхээр Сүнс гэж чи хэлж зүрхлэх үү? Тэр бол Есүсийн махбодоос өөр хэн ч биш гэж хэлж зүрхлэх үү? Мөн чи Түүнийг хүний төлөө үүрд цовдлогдох Бурхан гэж хэлж зүрхлэх үү?

ГУРВАЛ ОРШИН БАЙДАГ УУ?

Есүс махбод болсон тухай үнэн ил болсны дараа хүн тэнгэрт Эцэг байдгаар үл барам, мөн Хүү, бүр Сүнс ч байдаг. Тэнгэрт ийм Бурхан буюу Эцэг, Хүү, Ариун Сүнс гэх гурвал Бурхан байдаг гэдэг нь хүний уламжлалт үзэл юм. Бүх хүн төрөлхтөнд ийм үзэл байдаг: Бурхан бол нэг Бурхан, гэхдээ гурван хэсгээс бүрддэг ба уламжлалт үзэлд ноцтойгоор заншиж тогтсон зүйлс нь Эцэг, Хүү, Ариун Сүнс юм. Энэ гурван хэсгийг нийлүүлсэн нь л Бурхан бүхэлдээ юм. Ариун Эцэггүйгээр Бурхан бүрэн гүйцэд байж чадахгүй. Үүнтэй адилаар Хүү, эсвэл Ариун Сүнсгүйгээр Бурхан мөн л бүрэн гүйцэд байхгүй. Өөрсдийн үзэлд хүмүүс Эцгийг ганцааранг нь, мөн Хүүг ганцааранг нь Бурхан гэж үзэж болохгүй хэмээн итгэдэг. Зөвхөн Эцэг, Хүү, Ариун Сүнснийг хамтад нь Бурхан Өөрөө гэж үзэж болно. Одоо шашны бүх итгэгч, бүр та нарын дундах дагалдагч болгон энэ итгэлийг баримталдаг. Гэсэн ч та нар Бурханы Өөрийн хэрэг явдлын талаар үргэлж төөрөгдлийн манан дунд байдаг учраас энэхүү итгэл зөв эсэх талаар хэн ч тайлбарлаж чадахгүй. Хэдий эдгээр нь үзэл боловч та нар зөв, буруу эсэхийг нь мэддэггүй, учир нь шашны үзэл та нарт хэтэрхий ноцтойгоор халдварласан. Та нар шашны эдгээр уламжлалт үзлийг хэтэрхий гүн гүнзгий хүлээн зөвшөөрсөн ба энэхүү хор дотор чинь дэндүү гүн нэвчсэн. Тиймээс энэхүү асуудал дээр ч та нар энэ хортой нөлөөнд автсан, учир нь гурвал Бурхан ердөө оршин байдаггүй. Өөрөөр хэлбэл, Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвал ердөө оршин байдаггүй. Эдгээр нь бүгд хүний уламжлалт үзэл, хүний эндүү ташаа ойлголт билээ. Олон зууны туршид, хүний оюун санаан дахь үзлээс бий болсон, хүний зохиосон, урьд нь хэзээ ч хүнд үзэгдэж байгаагүй энэхүү Гурвалд хүн итгэсэн. Энэ олон жилийн туршид Гурвалын “жинхэнэ утгыг” тайлбарласан Библийн тайлбарлагчид олон байсан боловч гурвал Бурханыг гурван өөр нэгдмэл бодгаль хэмээсэн тийм тайлбар нь тодорхой бус, ойлгомжгүй байсан ба хүмүүс бүгд Бурханы “бүтцийн” талаар будилдаг. Ямар ч агуу хүн бүрэн гүйцэд тайлбар өгч огт чадаагүй; ихэнх тайлбар нь учир шалтгааны хувьд болон бичиг цаасан дээр шаардлага хангадаг боловч нэг ч хүн үүний утга учрыг тов тодорхой ойлгодоггүй. Яагаад гэвэл, хүний зүрх сэтгэлдээ хадгалдаг агуу

Гурвал ердөө оршин байдаггүй. Учир нь хэн ч Бурханы жинхэнэ төрхийг харж байгаагүй, мөн Бурханы оршдог газарт ямар зүйл байдгийг шинжлэхийн тулд, “Бурханы гэр”-т яг хэдэн арван мянга, хэдэн зуун сая үе удам байгааг тодорхойлохын тулд, эсвэл Бурханы төрөлхийн бүтцийг яг хэдэн хэсэг бүрдүүлдгийг шалгахын тулд Бурханы оршин байгаа газарт зочлохоор дээш гарах хувьтай хүн нэг ч байгаагүй. Үндсэндээ юуг шинжлэх хэрэгтэй вэ гэвэл: Эцэг, Хүү, бас Ариун Сүнсний нас; бодгаль тус бүрийн харагдах байдал; Тэд яг хэрхэн хуваагддаг болон хэрхэн нэг болдог явдал юм. Харамсалтай нь, энэ бүх жилүүдэд нэг ч хүн энэ хэрэг явдлын үнэнийг тодорхойлж чадаагүй. Гурвалын талаар анхаардаг, шашны тэр бүх үнэн сүсэгт, цогтой итгэгчдэд хэрэг явдлын үнэнийг тайлагнахын тулд хэн ч, хэзээ ч тэнгэр лүү зочлохоор дээш гарч, бүх хүн төрөлхтөнд зориулсан “эрэн сурвалжлах тайлантайгаар” буцаж ирээгүй учраас тэд бүгдээрээ зүгээр л таамагладаг. Мэдээж ийм үзлийг бий болгосных нь төлөө хүнийг буруутгаж болохгүй, тэгвэл яагаад Эцэг Ехова хүн төрөлхтнийг бүтээхдээ Хүү Есүсийг дагуулж яваагүй юм бэ? Эхэндээ бүгд Еховагийн нэрээр явсан бол энэ нь илүү дээр байх байсан юм. Хэрвээ буруутгах ёстой юм бол, бүтээлийн цаг үед Хүү болон Ариун Сүнсийг Өөрийнхөө өмнө дуудалгүй, харин ч Өөрийн ажлыг ганцаараа хийсэн Ехова Бурханы түр зуурын ташаарлыг л буруутга. Тэд бүгд нэгэн зэрэг ажилласан бол нэг болох байсан бус уу? Хэрвээ бүр эхнээсээ эцсээ хүртэл зөвхөн Ехова гэх нэр байж, Нигүүлслийн эрин үеийн Есүсийн нэр байгаагүй бол, эсвэл тухайн үед Бурхан Ехова гэж нэрлэгдсээр байсан бол хүн төрөлхтний үүсгэсэн энэхүү хуваагдлын зовлонгоос салах байсан бус уу? Мэдээж, энэ бүхний төлөө Еховаг буруутгаж болохгүй; хэрвээ буруутгах ёстой бол олон мянган жилийн турш Ехова, Есүс, тэр ч бүү хэл Ариун Сүнсний нэрээр Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийж, Бурхан гэж яг юу вэ гэдгийг мэдэхээ больтол нь хүнийг будилуулж, төөрөлдүүлсэн Ариун Сүнсийг л буруутга. Хэрвээ Ариун Сүнс Өөрөө хэлбэр дүрс, дүр төрхгүйгээр, түүнчлэн Есүс гэх мэт нэргүйгээр ажиллаж, хүн Түүнд хүрч ч, харж ч чадахгүй, зөвхөн аянгын дууг сонсдог байсан бол ийм төрлийн ажил нь хүн төрөлхтөнд илүү их ач тустай байх байсан бус уу? Тэгвэл одоо юу хийж болох вэ? Хүний үзэл уул шиг өндөр, далай шиг өргөн уудам болж овоорсон ба өнөөгийн Бурхан цаашид тэдгээрийг тэвчиж чадахгүй, яахаа мэдэхгүй байх хэмжээнд очсон. Урьд нь Ехова, Есүс болон Тэдний дундах Ариун Сүнс байх үед хүн яаж учрыг нь олохоо аль хэдийн мэдэхээ больсон байсан ба одоо үүн дээр нэмээд мөн л Бурханы нэг хэсэг гэж хэлэгддэг Төгс Хүчит байгаа. Тэр хэн бэ гэдгийг болон Гурвалын

аль бодгальтай Тэр холилдсон, эсвэл хэчнээн олон жилийн турш дотор нь нуугдсан гэдгийг хэн мэдэх билээ? Хүн яаж үүнийг тэвчиж чадах юм бэ? Насан туршдаа тайлбарлахад гурвал Бурхан дангаараа хангалттай байсан атал одоо “дөрвөн бодгаль дахь нэг Бурхан” байна. Үүнийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Чи тайлбарлаж чадах уу? Ах, эгч нар аа! Өнөөдрийг хүртэл та нар ийм Бурханд яаж итгэж байсан юм бэ? Би та нарыг биширч байна. Гурвал Бурханыг тэвчих нь аль хэдийн хангалттай байсан; гэтэл та нар дөрвөн бодгаль дахь энэ нэг Бурханд ийм тууштай итгэсээр байж яаж чадаж байна вэ? Та нараас явахыг шаардсан ч та нар татгалздаг. Үнэхээр санаанд багтамгүй! Та нар үнэхээр сүрхий юм! Хүн үнэндээ дөрвөн Бурханд ч гэсэн итгээд, үүнийгээ юман чинээ бодохгүй байж чадна; та нар үүнийг гайхамшиг гэж бодохгүй байна уу? Та нарыг хараад ийм агуу гайхамшиг үзүүлж чадна гэдгийг чинь хэн ч мэдэхгүй! Үнэндээ энэ орчлон ертөнцийн хаа ч гурвал Бурхан оршдоггүй гэдгийг Би та нарт хэлье. Бурханд Эцэг байхгүй, Хүү байхгүй, тэр ч бүү хэл Эцэг, Хүү хоёр хамтдаа Ариун Сүнсийг хэрэгсэл болгон ашигладаг гэх ухагдахуун ч байхгүй. Энэ бүхэн нь энэ дэлхийн хамгийн гажууд онол бөгөөд огт оршдоггүй! Гэхдээ ийм гажууд онол ч гэсэн эх сурвалжтай байдаг бөгөөд огт үндэслэлгүй байдаггүй, учир нь та нарын оюун санаа тийм ч энгийн биш, мөн та нарын бодол үндэслэлгүй биш билээ. Харин ч тэдгээр нь нэлээд зохистой, ухаалаг, бүр ямар ч Сатан нэвтэршгүй байдаг. Харамсалтай нь эдгээр бодол бүгд гажууд онол бөгөөд зүгээр л оршин байдаггүй! Та нар жинхэнэ үнэнийг огтхон ч хараагүй; та нар бусдын итгэлийг овжноор олж, оюуны чадамжгүй буюу эрүүл ухаангүй хамгийн тэнэг хүмүүсийг ноёлж, тэднийг агуу, алдартай “мэргэжилтний сургаал”-даа итгүүлэхийн тулд зүгээр л таамаглал, төсөөлөл бий болгож, үүнийгээ янз бүрийн түүх болгон зохиодог. Энэ нь үнэн үү? Энэ нь хүний хүлээн авах ёстой амийн зам уу? Энэ бүхэн ямар ч утгагүй! Ганц ч үг нь зүй зохистой биш! Энэ олон жилийн турш Бурханыг та нар ийм маягаар хуваасан, энэ нь үеэс үед илүү нарийн болж хуваагдсаар нэг Бурхан нь гурван Бурхан болж илт хуваагдах хэмжээнд очсон. Одоо хүний хувьд Бурханыг нэг болгон буцаан нийлүүлэх ердөө боломжгүй, учир нь та нар Түүнийг хэтэрхий нарийн хуваасан! Хэтэрхий оройтохоос нь өмнө Миний шуурхай ажил хийгдээгүй бол хэр удаан ийм байдлаар ичгүүр сонжуургүйгээр үргэлжлүүлэх байсныг чинь хэлэхэд хэцүү юм! Бурханыг ийм байдлаар хуваасаар байвал Тэр яаж та нарын Бурхан хэвээр байж чадах юм бэ? Та нар Бурханыг таньж чадна гэж үү? Гарал үүслээ бас л олно гэж үү? Хэрвээ Би арай оройтож ирсэн бол “Эцэг, Хүү” Ехова Есүс хоёрыг Израиль руу

буцаан илгээчихээд та нар өөрсдийгөө Бурханы нэг хэсэг гэгцгээх байлаа. Азаар одоо бол эцсийн өдрүүд. Эцэстээ Миний удаан хүлээсэн энэ өдөр ирсэн ба ажлын энэ үе шатыг Өөрийн гараар хэрэгжүүлсний дараа л Би Бурханыг Өөрийг нь хуваадгийг чинь болиулсан. Хэрвээ тэгээгүй бол та нар нөхцөл байдлыг хурцатгаж, тэр ч бүү хэл өөрсдийн дунд байгаа бүх Сатаныг шүтэхээр ширээн дээрээ тавих байлаа. Энэ бол та нарын арга чарга! Бурханыг хуваах та нарын арга барил! Та нар одоо ч ингэсээр л байх уу? Би та нараас асууж: Хэдэн Бурхан байдаг вэ? Аль Бурхан нь та нарт аврал авчрах вэ? Та нарын үргэлж залбирдаг Бурхан чинь эхнийх нь үү, хоёр дахь нь уу, эсвэл гурав дахь нь уу? Алинд нь та нар үргэлж итгэдэг вэ? Эцэгт үү? Хүүд үү? Аль эсвэл Сүнсэнд үү? Чи хэнд нь итгэдгээ Надад хэл. Чи үг хэлэх бүрдээ Бурханд итгэдэг гэж хэлдэг хэдий ч үнэндээ уураг тархиндаа л итгэдэг! Та нарын зүрх сэтгэлд Бурхан ердөө байхгүй! Гэсэн ч та нарын оюун санаанд өдий төдий тийм Гурвалууд байдаг! Та нар санал нийлэхгүй байна гэж үү?

Хэрвээ ажлын гурван үе шатыг Гурвалын тухай энэхүү ухагдахууны дагуу үнэлбэл тус бүрийнх нь хийсэн ажил адилхан байгаагүй болохоор гурван Бурхан байх учиртай. Хэрвээ та нарын дундаас хэн нэг нь Гурвал үнэхээр оршдог гэж хэлбэл гурван бодгаль дахь энэ нэг Бурхан яг юу вэ гэдгийг тайлбарла. Ариун Эцэг гэж юу вэ? Хүү нь юу вэ? Ариун Сүнс гэж юу вэ? Ехова Ариун Эцэг үү? Есүс Хүү юу? Тэгвэл Ариун Сүнс юу вэ? Эцэг нь Сүнс биш гэж үү? Хүүгийн мөн чанар ч бас Сүнс биш гэж үү? Есүсийн ажил нь Ариун Сүнсний ажил байгаагүй гэж үү? Тухайн үеийн Еховагийн ажлыг ч гэсэн Есүсийнхтэй адил Сүнс хийгээгүй гэж үү? Бурхан хэдэн Сүнстэй вэ? Чиний тайлбараар бол Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгаль нь нэг; хэрвээ тийм бол гурван Сүнс байна, гэхдээ гурван Сүнс байна гэдэг нь гурван Бурхан байна гэсэн үг. Тэгвэл цор ганц жинхэнэ Бурхан байхгүй гэсэн үг; ийм Бурхан яаж Бурханы төрөлх мөн чанартай байж чадах юм бэ? Хэрвээ чи цорын ганц Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрвөл Тэр яаж хүүтэй байж, мөн эцэг байж чадах юм бэ? Эдгээр нь бүгдээрээ зүгээр л чиний үзэл биш гэж үү? Цорын ганц Бурхан байдаг, энэ Бурханд цорын ганц бодгаль байдаг, цорын ганц Бурханы Сүнс байдаг, яг л Библид бичсэнчлэн “Цорын ганц Ариун Сүнс, цорын ганц Бурхан байдаг.” Чиний ярьдаг Эцэг, Хүү оршдог эсэхээс үл хамааран, эцсийн эцэст цорын ганц Бурхан байдаг бөгөөд та нарын итгэдэг Эцэг, Хүү, Ариун Сүнсний мөн чанар бол Ариун Сүнсний мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, Бурхан бол Сүнс, гэхдээ Тэр махбод болж, хүмүүсийн дунд амьдарч, түүнчлэн бүх зүйлээс дээгүүр байж чаддаг. Түүний Сүнс бүхнийг-хамардаг

бөгөөд хаа сайгүй оршдог. Тэрээр махбодод болон бүхий л орчлон ертөнцөд нэгэн зэрэг оршиж чадна. Бурхан бол цорын ганц жинхэнэ Бурхан гэж бүх хүн хэлдэг тул хэний ч хүслээр хуваагдашгүй ганцхан Бурхан байдаг! Бурхан бол цорын ганц Сүнс, цорын ганц бодгаль; тэр нь Бурханы Сүнс юм. Хэрвээ чиний хэлдгээр Эцэг, Хүү, Ариун Сүнс байсан бол Тэд гурван Бурхан биш гэж үү? Ариун Сүнс бол нэг зүйл, Хүү өөр зүйл бөгөөд Эцэг бас нэг өөр зүйл. Тэдний бодгаль өөр, бас мөн чанар нь ялгаатай тул Тэд яаж ганц Бурханы нэг хэсэг байж чадах юм бэ? Ариун Сүнс бол Сүнс; энэ нь хүний хувьд ойлгоход амархан. Хэрвээ тийм бол, Эцэг нь бүр ч Сүнс юм. Тэр хэзээ ч газар дээр буугаагүй, хэзээ ч махбод болоогүй; Тэр бол хүний зүрх сэтгэл дэх Ехова Бурхан бөгөөд Сүнс мөн гэдэг нь гарцаагүй. Тэгвэл Ариун Сүнс, Тэр хоёрын хоорондох харилцаа юу вэ? Эцэг, Хүүгийн хоорондох харилцаа юу? Эсвэл Ариун Сүнс болон Эцэгийн Сүнсний хоорондох харилцаа юу? Сүнс бүрийн мөн чанар адилхан уу? Эсвэл Ариун Сүнс нь Эцэгийн хэрэгсэл юм уу? Үүнийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Тэгвэл Хүү болон Ариун Сүнсний хоорондох харилцаа юу вэ? Энэ нь хоёр Сүнсний хоорондох харилцаа юу, эсвэл хүн, Сүнс хоёрын хоорондох харилцаа юу? Эдгээр нь бүгд ямар ч тайлбаргүй асуудлууд юм! Хэрвээ Тэд бүгд нэг Сүнс юм бол гурван бодгалийн тухай яриа байх учиргүй, учир нь Тэд нэг Сүнсийг эзэмшдэг билээ. Хэрвээ Тэд өөр өөр бодгалиуд байсан бол Тэдний Сүнс хүч чадлаараа ялгаатай байх байсан ба Тэд нэг Сүнс байж ердөө чадахгүй. Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай энэ үзэл баримтлал хамгийн утгагүй! Энэ нь Бурханыг хэсэглэж, тус бүрдээ байр суурьтай, Сүнстэй гурван бодгаль болгон хуваадаг; тэгвэл Тэр яаж ганц Сүнс, ганц Бурхан байж чадах юм бэ? Надад хэл дээ, тэнгэр, газар болон бүх зүйлийг Эцэг бүтээсэн үү, Хүү бүтээсэн үү, эсвэл Ариун Сүнс бүтээсэн үү? Тэд бүгдээрээ хамт бүтээсэн гэж зарим хүн хэлдэг. Тэгвэл хүн төрөлхтнийг хэн золин аварсан бэ? Ариун Сүнс үү, Хүү юу, эсвэл Эцэг үү? Хүү хүн төрөлхтнийг золин аварсан гэж зарим нь хэлдэг. Тэгвэл мөн чанартаа Хүү нь хэн юм бэ? Тэр бол бие махбодтой болсон Бурханы Сүнс биш гэж үү? Бие махбодтой болсон Бурхан нь, бүтээгдсэн хүний өнцгөөс тэнгэр дэх Бурханыг Эцэг гэж дуудаж байсан. Есүс Ариун Сүнснээс олдож төрсөн гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Түүний дотор Ариун Сүнс байдаг; чи юу ч хэлсэн бай, Тэрээр тэнгэр дэх Бурхантай нэг юм, учир нь Тэр бол бие махбодтой болсон Бурханы Сүнс билээ. Хүүгийн талаарх энэхүү үзэл санаа зүгээр л худал юм. Ганц Сүнс бүх ажлыг хэрэгжүүлсэн; Бурхан Өөрөө буюу Бурханы Сүнс л Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг. Бурханы Сүнс гэж хэн бэ? Энэ нь Ариун Сүнс биш гэж үү?

Есүст ажилладаг Ариун Сүнс биш гэж үү? Хэрвээ ажлыг Ариун Сүнс (өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс) хэрэгжүүлээгүй бол Түүний ажил Бурханыг Өөрийг нь төлөөлж чадах байсан уу? Есүс залбирахдаа тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудаж байсан нь зөвхөн бүтээгдсэн хүний өнцгөөс, мөн Бурханы Сүнс эгэл, хэвийн махбод өмсөж, бүтээгдсэн зүйлийн гадаад бүрхүүлтэй болсон учраас л тэгсэн юм. Түүний дотор Бурханы Сүнс байсан ч гэсэн гадаад төрх нь хэвийн хүнийх байсан; өөрөөр хэлбэл, Есүсийг Өөрийг нь оролцуулаад бүх хүний хэлдгээр Тэр “хүний Хүү” болсон байлаа. Хүний Хүү гэж дуудагдаж байсныг нь харгалзан үзвэл, Тэрээр эгэл жирийн хүмүүсийн хэвийн гэр бүлд төрсөн хүн (эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, ямартай ч хүний гадаад төрхтэй) байсан юм. Тиймээс Есүс тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудсан нь анх та нар Түүнийг Эцэг гэж дуудсантай адил; Тэрээр бүтээгдсэн хүний өнцгөөс ингэсэн. Та нарт цээжлүүлэх гэж Есүсийн заасан Эзэний Залбирлыг та нар санаж байна уу? “Тэнгэр дэх бидний Аав аа...” Тэнгэр дэх Бурханыг Эцэгийн нэрээр дуудахыг Тэр бүх хүнээс шаардсан. Тэр ч гэсэн Бурханыг Аав гэж дуудсан ба та бүхэнтэй адил байр сууринд зогсож байгаа хүний өнцгөөс ингэсэн юм. Нэгэнт та нар тэнгэр дэх Бурханыг Эцэгийн нэрээр дууддаг учраас Есүс Өөрийгөө та нартай адил байр сууринд байгаагаар, мөн Бурханы сонгосон газар дээрх хүн (өөрөөр хэлбэл, Бурханы Хүү) мэтээр үзжээ. Хэрвээ та нар Бурханыг “Эцэг” хэмээн дуудвал, энэ нь бүтээгдсэн зүйл гэдгээс чинь болж байгаа бус уу? Газар дээрх Есүсийн эрх мэдэл хэчнээн агуу байсан ч цовдлолоос өмнө Тэр бол зүгээр л Ариун Сүнсээр (өөрөөр хэлбэл, Бурханаар) удирдуулсан хүний Хүү байсан бөгөөд газар дээрх бүтээгдсэн зүйлсийн нэгэн байсан, учир нь Тэр Өөрийн ажлыг хараахан биелүүлээгүй байсан юм. Тиймээс, тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудсан нь гагцхүү Түүний даруу зан, дуулгавартай байдал байлаа. Тэрээр Бурханыг (өөрөөр хэлбэл, тэнгэр дэх Сүнсийг) тийм байдлаар дуудаж байсан нь Тэр бол тэнгэр дэх Бурханы Сүнсний Хүү гэдгийг нотолдоггүй. Харин ч Тэр өөр бодгаль байсан юм биш, зүгээр л Түүний харах өнцөг өөр байсан юм. Өөр өөр бодгалийн оршин тогтнол гэдэг нь гажууд онол юм! Цовдлогдохоосоо өмнө Есүс махан биеийн хязгаарлалтад баригдсан хүний Хүү байсан бөгөөд Сүнсний эрх мэдлийг бүрэн эзэмшээгүй. Тийм учраас Тэр бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Эцэг Бурханы хүслийг эрж хайж л чадсан юм. Тэрээр Гетсеманид: “Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” хэмээн гурвантаа залбирсантай адил. Загалмай дээр цовдлогдохоосоо өмнө Тэр иудейчүүдийн Хаан байсан; Тэрээр алдрын бие биш, харин Христ, хүний Хүү байлаа. Тийм

учраас бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Тэрээр Бурханыг Эцэг гэж дуудсан юм. Тэгэхээр чи, Бурханыг Эцэг хэмээн дууддаг бүхэн нь Хүү юм гэж хэлж болохгүй. Хэрвээ тийм байсан бол Есүс та нарт Эзэний Залбирлыг заамагц та нар бүгдээрээ Хүү болох бус уу? Хэрвээ та нар одоо ч үнэмшихгүй байгаа бол Надад хэл дээ, та нарын Эцэг гэж дууддаг нэгэн чинь хэн бэ? Хэрвээ та нар Есүсийг хэлж байгаа бол Есүсийн Эцэг та нарын хувьд хэн бэ? Есүсийг явж одсоны дараа Эцэг, Хүү гэх энэ санаа байхаа больсон. Энэхүү санаа нь Есүсийг махбод болсон байх тэр жилүүдэд л тохиромжтой байв; бусад бүх нөхцөл байдалд та нар Бурханыг Эцэг хэмээн дуудах үед, энэ нь бүтээлийн Эзэн болон бүтээгдсэн зүйлийн хоорондын харилцаа байдаг. Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвалын тухай энэхүү санаа хэзээ ч байж болохгүй; энэ нь эрин үеүдэд ховорхон харагддаг гажууд онол бөгөөд оршин байдаггүй!

Энэ нь Эхлэл дэх Бурханы үгийг ихэнх хүнд сануулж магадгүй: “Бид өөрсөдтэйгээ адилаар, өөрсдийн дүр төрхөөр хүнийг бүтээцгээе.” “Бид хүнийг Өөрсдийнхөө дүрээр бүтээе” гэж Бурханы хэлснийг авч үзвэл “Бид” гэдэг нь хоёр буюу түүнээс олон гэдгийг илэрхийлж байна; нэгэнт Тэр “Бид” гэж хэлсэн учраас зөвхөн ганц Бурхан байдаггүй. Ийм маягаар хүн өөр өөр бодгалийг хийсвэрээр бодож эхэлсэн бөгөөд эдгээр үгээс Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай санаа төрсөн. Тэгвэл Эцэг ямархуу вэ? Хүү ямархуу вэ? Мөн Ариун Сүнс ямархуу вэ? Өнөөдрийн хүн төрөлхтөн энэ гурвыг нийлүүлсэн нэгний дүрээр бүтээгдсэн юм гэж үү? Тэгвэл хүний дүр Эцэг, Хүү, эсвэл Ариун Сүнснийхтэй адилхан уу? Бурханы эдгээр бодгалийн алиных нь дүрээр хүн бүтээгдсэн бэ? Хүний энэ санаа зүгээр л буруу бөгөөд ямар ч утгагүй! Энэ нь ердөө нэгэн Бурханыг хэд хэдэн Бурхан болгон хувааж л чадна. Дэлхийн бүтээлийн дараагаар хүн төрөлхтөн бүтээгдсэний хойно Мосе Эхлэлийг бичсэн. Хамгийн анх дэлхий ертөнц бий болох үед Мосе байгаагүй. Мосе Библийг их сүүлд бичсэн юм, тэгвэл тэнгэр дэх Бурханы юу хэлснийг тэр яаж мэдсэн байх юм бэ? Бурхан энэ дэлхийг хэрхэн бүтээсэн талаар тэр огт мэдэхгүй. Библийн Хуучин Гэрээнд Эцэг, Хүү, Ариун Сүнсний талаар огт дурддаггүй, зөвхөн цорын ганц жинхэнэ Бурхан, Ехова Өөрийн ажлыг Израильд хийж буй тухай дурддаг. Эрин үе өөрчлөгдөхийн хэрээр Тэр өөр өөр нэрээр нэрлэгдсэн, гэхдээ нэр бүхэн нь өөр бодгалийг хэлдэг гэдгийг энэ нь нотолж чадахгүй. Хэрвээ тийм байсан бол Бурханд тоо томшгүй олон бодгаль байх байсан бус уу? Хуучин Гэрээнд бичигдсэн зүйл бол Еховагийн ажил, Хуулийн эрин үед эхлүүлсэн Бурханы Өөрийн ажлын үе шат юм. Энэ нь Бурханы ажил байсан ба Түүнийг ярих үед

бий болж, Түүнийг тушаах үед биелж байсан. Тэр бол ажлаа гүйцэтгэхээр ирсэн Эцэг гэж Ехова хэзээ ч хэлээгүй, эсвэл хүн төрөлхтнийг золин аврахын тулд Хүү ирэх тухай хэзээ ч зөгнөөгүй. Есүсийн цаг үеийн тухайд гэвэл, бүх хүн төрөлхтнийг аврахын тулд Бурхан махбод болсон гэж л хэлсэн байдаг, харин Хүү ирсэн гэж хэлээгүй. Эрин үеүд адилгүй бөгөөд Бурханы Өөрийн хийдэг ажил ч бас ялгаатай байдаг учраас Тэр Өөрийн ажлыг өөр өөр хүрээнд хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Ийм маягаар, Түүний төлөөлдөг ялгамж чанар ч бас ялгаатай байдаг. Ехова бол Есүсийн Эцэг гэж хүн итгэдэг, гэхдээ үнэндээ үүнийг Есүс хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд “Бид Эцэг, Хүү хэмээн хэзээ ч ялгардаггүй; тэнгэр дэх Эцэг Бид хоёр нэг юм. Эцэг Миний дотор, Би Эцэгийн дотор байдаг; Хүүг харах үедээ хүн тэнгэрлэг Эцэгийг харж байгаа юм” хэмээн хэлсэн. Эцсийн эцэст, Эцэг ч бай, эсвэл Хүү ч бай Тэд нэг Сүнс бөгөөд тусдаа бодгаль болон хуваагддаггүй. Хүн тайлбарлахаар оролдмогц, өөр өөр бодгалийн тухай санаа, мөн түүнчлэн Эцэг, Хүү, Ариун Сүнсний хоорондын харилцаа нь асуудлыг төвөгтэй болгодог. Хүн тусдаа бодгалиудын тухай ярих үед, энэ нь Бурханыг материаллаг болгож байгаа бус уу? Хүн бодгалийг нь нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар гэж ч эрэмбэлдэг; эдгээр нь бүгд хүний төсөөлөл, лавлагаа болох ямар ч үнэ цэнгүй бөгөөд туйлын бодит бус! Хэрвээ чи түүнээс: “Хэдэн Бурхан байдаг вэ?” гэж асуувал тэр, Бурхан бол Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвал буюу ганц жинхэнэ Бурхан юм гэж хэлэх болно. Хэрвээ чи цааш нь: “Эцэг хэн бэ?” гэж асуувал тэрээр: “Эцэг бол тэнгэр дэх Бурханы Сүнс; Тэр бүхнийг хариуцдаг ба тэнгэрийн Эзэн юм” гэж хэлнэ. “Тэгвэл Ехова Сүнс мөн үү?” гэхэд тэрээр “Тийм!” гэж хариулна. Хэрвээ дараа нь чи түүнээс “Хүү хэн бэ?” гэж асуувал мэдээж Есүс бол Хүү гэх болно. “Тэгвэл Есүсийн түүх юу вэ? Тэр хаанаас ирсэн бэ?” гэхэд тэр ингэж хэлнэ: “Есүс Ариун Сүнснээс олдож Мариагаас төрсөн.” Тэгвэл Түүний мөн чанар ч бас Сүнс биш гэж үү? Түүний ажил ч бас Ариун Сүнсний ажлын төлөөлөл биш гэж үү? Ехова бол Сүнс, Есүсийн мөн чанар ч бас адилхан. Одоо эцсийн өдрүүдэд, энэ нь мөн л Сүнс юм гэдгийг хэлэх бүр ч шаардлагагүй; Тэд яаж өөр өөр бодгаль байх юм бэ? Ердөө л Бурханы Сүнс өөр өөр өнцгөөс Сүнсний ажлыг хэрэгжүүлж байгаа хэрэг биш гэж үү? Тийм болохоор бодгалиудын хооронд ялгаа байдаггүй. Есүс Ариун Сүнснээс олдсон, Түүний ажил яг тэр Ариун Сүнснийх байсан нь маргаангүй. Гүйцэтгэсэн ажлынхаа эхний үе шатанд Ехова махбод болоогүй, бас хүнд ч харагдаагүй. Иймээс хүн хэзээ ч Түүний гадаад төрхийг хараагүй. Тэр хэчнээн агуу, хэчнээн өндөр байсан нь хамаагүй, хүнийг анх бүтээсэн Бурхан Өөрөө буюу Сүнс хэвээр байсан. Өөрөөр

хэлбэл, Тэрээр Бурханы Сүнс байлаа. Үүлэн дундаас хүнтэй ярих үедээ Тэр ердөө л Сүнс байсан ба Түүний гадаад төрхийг хэн ч нүдээр үзээгүй; зөвхөн Нигүүлслийн эрин үед Бурханы Сүнс махбодод ирж, Иудейд бие махбодтой болоход л хүн бие махбодтой болсон Бурханыг иудей хүний дүрээр анх харсан. Түүнд Еховагийн гэх юу ч байгаагүй. Гэсэн ч Тэр Ариун Сүнснээс олдсон, өөрөөр хэлбэл, Еховагийн Өөрийн Сүнснээс олдсон бөгөөд Есүс мөн л Бурханы Сүнсний биелэл болон төрсөн билээ. Ариун Сүнс Есүс дээр тагтаа мэт буухыг л хүн анх харсан; энэ нь ганцхан Есүсийн Сүнс байгаагүй, харин ч Ариун Сүнс байсан юм. Тэгвэл Есүсийн Сүнсийг Ариун Сүнснээс салгаж болох уу? Хэрвээ Есүс нь Есүс, Хүү бөгөөд Ариун Сүнс нь Ариун Сүнс юм бол Тэд яаж нэг байж чадах юм бэ? Хэрвээ тийм байсан бол ажлыг хэрэгжүүлж чадахгүй байх байв. Есүсийн доторх Сүнс, тэнгэр дэх Сүнс болон Еховагийн Сүнс бүгд нэг юм. Үүнийг Ариун Сүнс, Бурханы Сүнс, долоо дахин эрчимжсэн Сүнс, бүгдийг хамарсан Сүнс гэж нэрлэж болно. Бурханы Сүнс их ажил гүйцэтгэж чадна. Тэр дэлхийг бүтээж, бас үерээр газар дэлхийг устгаж чадна; Тэр бүх хүн төрөлхтнийг золин аварч чадна, түүнчлэн бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бас устгаж чадна. Энэ ажлыг бүгдийг нь Бурхан Өөрөө хийдэг бөгөөд Түүний оронд Бурханы өөр ямар ч бодгаль хийж чадахгүй байх байв. Түүний Сүнсийг Ехова, Есүс, түүнчлэн Төгс Хүчит гэж нэрлэж болно. Тэр бол Эзэн бөгөөд Христ юм. Тэр бас хүний Хүү болж чадна. Тэр тэнгэрт, бас газарт байдаг; Тэр орчлон ертөнцөөс дээш өндөрт байдаг бөгөөд олон түмний дунд байдаг. Тэр бол тэнгэр, газрын цорын ганц Эзэн билээ! Бүтээлийн цаг үеэс эхлээд одоог хүртэл энэ ажлыг Бурханы Өөрийн Сүнс хийсээр ирсэн. Тэнгэр дэх ажил ч бай, эсвэл махбод дахь ажил бай бүгдийг нь Түүний Сүнс хийдэг. Тэнгэр дэх ч бай, эсвэл газар дахь ч бай бүх бүтээл Түүний төгс хүчит гарын алганд байдаг; энэ бүхэн нь Бурханы Өөрийн ажил бөгөөд Түүний оронд өөр хэн ч хийж чадахгүй. Тэнгэрт Тэр бол Сүнс, бас Бурхан Өөрөө; хүмүүсийн дунд Тэр махбод боловч Бурхан Өөрөө хэвээр. Хэдэн зуун мянган нэрээр нэрлэж болох ч Тэр Өөрөө хэвээр бөгөөд Түүний Сүнсний шууд илэрхийлэл юм. Түүний цовдлолоор дамжин ирсэн бүх хүн төрөлхтний золин аврал нь Түүний Сүнсний шууд ажил байсан бөгөөд эцсийн өдрүүдэд бүх улс орон, газар нутагт илгээх тунхаглал ч Түүний Сүнсний шууд ажил. Бурханыг цаг ямагт төгс хүчит, ганц жинхэнэ Бурхан, бүгдийг хамарсан Бурхан Өөрөө гэж л нэрлэж болно. Тусдаа бодгалиуд оршин тогтнодоггүй, Эцэг, Хүү, Ариун Сүнс хэмээх санаа бүр ч оршдоггүй. Тэнгэрт болон газарт цорын ганц Бурхан байдаг!

Бурханы удирдлагын төлөвлөгөө зургаан мянган жил үргэлжилдэг бөгөөд Түүний ажлын ялгаанд үндэслэн гурван эрин үед хуваагддаг: Эхний эрин үе нь Хуучин Гэрээний Хуулийн эрин үе; хоёр дахь нь Нигүүлслийн эрин үе; гурав дахь нь эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үе юм. Эрин үе болгонд өөр өөр ялгамж чанарыг төлөөлдөг. Энэ нь зөвхөн ажлын ялгаанаас буюу ажлын шаардлагаас болдог. Хуулийн эрин үе дэх ажлын эхний үе шат Израильд явагдсан ба золин авралын ажлыг төгсгөсөн хоёр дахь үе шат нь Иудейд хийгдсэн. Золин авралын ажлын төлөө Есүс Ариун Сүнснээс олдож, цорын ганц Хүү болон төрсөн. Энэ бүхэн нь ажлын шаардлагаас болсон юм. Эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийн ажлыг Харь үндэстнүүдэд өргөжүүлж, тэндхийн хүмүүсийг байлдан дагуулахыг хүсдэг, ингэснээр Түүний нэр тэдний дунд агуу болж болох юм. Тэрээр бүх үнэнийг ойлгож, ороход нь хүнийг залж чиглүүлэхийг хүсдэг. Энэ бүх ажлыг нэг Сүнс хийдэг. Хэдий Тэр өөр өөр өнцгөөс ингэж хийдэг боловч ажлын шинж чанар болон зарчим адилхан хэвээр үлддэг. Тэдний гүйцэтгэсэн ажлын зарчим, шинж чанарыг ажигламагцаа энэ бүхнийг нэг Сүнс хийсэн гэдгийг чи мэднэ. Гэсэн ч зарим хүн: “Эцэг бол Эцэг; Хүү бол Хүү; Ариун Сүнс бол Ариун Сүнс бөгөөд эцэстээ Тэд нэг болно” хэмээн хэлсээр байж магадгүй. Тэгвэл чи Тэднийг хэрхэн нэг болгох ёстой вэ? Эцэг, Ариун Сүнс хоёрыг яаж нэг болгож чадах вэ? Хэрвээ Тэд угаасаа хоёр байсан бол Тэднийг яаж ч нийлүүлсэн хамаагүй хоёр хэсэг хэвээр үлдэхгүй гэж үү? Тэднийг нэг болгох тухай ярих нь, нэг бүхэл болгохын тулд хоёр тусдаа хэсгийг нийлүүлж байгаа хэрэг биш гэж үү? Гэхдээ бүхэл болгуулахаасаа өмнө Тэд хоёр хэсэг байгаагүй гэж үү? Сүнс бүрд өөр өөр мөн чанар байдаг бөгөөд хоёр Сүнсийг ганц болгож болохгүй. Сүнс бол материаллаг зүйл биш, материаллаг ертөнц дээрх юутай ч адилгүй. Хүний үздэгээр, Эцэг нь нэг Сүнс, Хүү өөр Сүнс, Ариун Сүнс бас нэг Сүнс юм, тэгээд нэг бүхэл болгохын тулд гурван Сүнсийг гурван аягатай ус шиг хольж болно. Тэгвэл энэ гурав нэг болох бус уу? Энэ бол гарцаагүй эндүү ташаа, утгагүй тайлбар юм! Энэ нь Бурханыг хувааж байгаа хэрэг биш үү? Яаж Эцэг, Хүү, Ариун Сүнсийг нэг болгож болох юм бэ? Тэд бол тус бүрдээ өөр шинж чанартай гурван хэсэг биш гэж үү? “Есүс бол Түүний хайртай Хүү гэж Бурхан тов тодорхой хэлээгүй гэж үү?” хэмээн хэлдэг хүмүүс бий. Есүс бол Бурханы хайртай Хүү, Түүнийг Тэр ихэд таалдаг гэж Бурхан Өөрөө гарцаагүй хэлсэн. Тэр нь, Бурхан Өөрийгөө гэрчилж байсан хэрэг боловч ердөө өөр өнцгөөс буюу тэнгэр дэх Сүнсний өнцгөөс бие махбодтой болсон Өөртөө гэрчлэл хийж байсан хэрэг юм. Есүс бол Түүний тэнгэр дэх Хүү биш, бие

махбодтой болсон Бурхан юм. Чи ойлгов уу? “Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байдаг” хэмээх Есүсийн үг нь Тэд бол нэг Сүнс гэдгийг илтгэдэггүй гэж үү? Бие махбодтой болсноос болж Тэд тэнгэр, газрын хооронд тусгаарлагдаагүй гэж үү? Үнэндээ Тэд нэг хэвээр байгаа; ямар ч байсан энэ нь Бурхан зүгээр л Өөрийгөө гэрчилж байгаа хэрэг. Эрин үеүдийн өөрчлөлт, ажлын шаардлага болон удирдлагын төлөвлөгөөнийх нь ялгаатай үе шатуудаас шалтгаалан хүний Түүнийг дууддаг нэр ч бас өөр өөр байдаг. Ажлын эхний үе шатыг хэрэгжүүлэхээр ирэхдээ Тэр зүгээр л Ехова гэж нэрлэгддэг, израильчуудын хоньчин байсан. Хоёр дахь үе шатанд бие махбодтой болсон Бурхан зөвхөн Эзэн, Христ гэж нэрлэгдэж байв. Гэхдээ тухайн үед, Тэр бол Бурханы хайртай Хүү гэж тэнгэр дэх Сүнс хэлсэн бөгөөд Түүнийг Бурханы цорын ганц Хүү гэж огт дурдаагүй. Энэ нь ердөө тохиолдоогүй. Бурхан яаж ганц хүүхэдтэй байх юм бэ? Тэгвэл Бурхан хүн болчихгүй гэж үү? Тэр бие махбодтой болсон байсан учраас Түүнийг Бурханы хайртай Хүү гэж дуудсан бөгөөд эндээс Эцэг, Хүүгийн хоорондын харилцаа гарч ирсэн. Энэ нь зүгээр л тэнгэр, газрын хоорондох тусгаарлалтаас болсон юм. Есүс махбодын өнцгөөс залбирсан. Тэр тийм хэвийн хүн чанартай махбод өмссөн байсан учраас махбодын өнцгөөс Тэрээр: “Миний гадаад бүрхүүл бүтээгдсэн зүйлийнх. Би энэ дэлхийд ирэхийн тулд махбод өмссөн тул тэнгэрээс холын хол байна” гэж хэлсэн юм. Энэ шалтгааны улмаас Тэр зөвхөн махбодын өнцгөөс л Эцэг Бурханд залбирч байв. Энэ нь Түүний үүрэг байсан бөгөөд бие махбодтой болсон Бурханы Сүнсний эзэмших ёстой зүйл байлаа. Махбодын өнцгөөс Эцэгт залбирч байснаас нь болоод Түүнийг Бурхан биш гэж хэлж болохгүй. Хэдий Бурханы хайртай Хүү гэж дуудагдаж байсан ч Тэр бол Бурхан Өөрөө хэвээр юм, учир нь Тэр бол бие махбодтой болсон Сүнс бөгөөд Түүний мөн чанар бас л Сүнс юм. Хэрвээ Тэр Бурхан Өөрөө байсан юм бол яагаад залбирсан юм бэ гэж хүмүүс гайхдаг. Үүний учир нь, Тэр бол тэнгэр дэх Сүнс биш, харин бие махбодтой болсон Бурхан, махбод дотор амьдарч байгаа Бурхан байсан билээ. Хүний харж байгаагаар, Эцэг, Хүү, Ариун Сүнс нь бүгд Бурхан. Зөвхөн энэ гурвыг нэг болгосон үед л нэг жинхэнэ Бурхан гэж үзэж болох ба ийм маягаар Түүний хүч чадал ер бусын агуу юм. Ийм маягаар л Тэр бол долоо дахин эрчимжсэн Сүнс мөн гэж хэлдэг хүмүүс бий. Ирснийхээ дараа Хүү залбирах үед Түүний залбирсан зүйл нь тэрхүү Сүнс байсан. Үнэндээ Тэр бүтээгдсэн зүйлийн өнцгөөс л залбирч байлаа. Махбод бүрэн гүйцэд биш учраас Тэр махбодод ирэх үедээ бүрэн гүйцэд байгаагүй, олон сул талтай байсан, мөн Өөрийн ажлыг махбодоор гүйцэтгэхэд Түүнд ихээхэн төвөг учирсан. Тийм учраас Тэр

цовдлогдохоосоо өмнө Эцэг Бурханд гурвантаа залбирсан, түүнчлэн тэрнээс өмнө ч олон удаа залбирсан. Тэр шавь нарынхаа дунд залбирсан; уулан дээр ганцаараа залбирсан; загасчны завин дээр залбирсан; үй олон хүмүүсийн дунд залбирсан; талх хувааж байхдаа залбирсан; мөн бусдыг ерөөхдөө залбирсан билээ. Яагаад тэгсэн бэ? Тэрээр Сүнсэнд хандаж залбирсан; Тэр махбодын өнцгөөс Сүнсэнд, тэнгэр дэх Бурханд залбирч байсан. Тиймээс хүний үзэл бодлоор бол, ажлын тэрхүү үе шатанд Есүс Хүү болсон юм. Гэхдээ энэ үе шатанд Тэр залбирдаггүй. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Түүний авчирдаг зүйл нь үгийн ажил бөгөөд үгийн шүүлт, гэсгээлт юм. Тэр залбирах хэрэггүй, Түүний үйлчлэл бол үг хэлэх явдал билээ. Тэр загалмайд цовдлогдохгүй бөгөөд хүн Түүнийг эрх мэдэлтнүүдэд барьж өгөхгүй. Тэр зүгээр л Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг. Есүс залбирч байх үедээ, тэнгэрийн хаанчлал бууж ирэхийн төлөө, Эцэгийн хүсэл биелэгдэхийн төлөө болон хожмын ажлын төлөө Эцэг Бурханд залбирсан. Энэ үе шатанд тэнгэрийн хаанчлал аль хэдийн бууж ирсэн тул залбирах хэрэг Түүнд байгаа гэж үү? Түүний ажил бол эрин үеийг төгсгөх явдал бөгөөд цаашид шинэ эрин үе гэж байхгүй, иймд дараагийн үе шатны төлөө залбирах хэрэг байгаа юу? Үгүй байх аа!

Хүний тайлбарт олон зөрчилдөөн байдаг. Үнэндээ, эдгээр нь бүгд хүний үзэл юм; та бүхэн цааш нь нарийвчлан судлалгүйгээр тэдгээрийг үнэн зөв хэмээн итгэдэг. Гурвал Бурхан гэх ийм санаа нь хүний үзэл гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Хүний ямар ч мэдлэг бүрэн гүйцэд биш. Үүнд үргэлж хольц байдаг ба хүнд хэтэрхий олон санаа бий; бүтээгдсэн зүйл Бурханы ажлыг тайлбарлаж ер чадахгүй гэдгийг энэ нь харуулдаг. Хүний оюун санаанд хэтэрхий их зүйл байдаг ба эдгээр нь бүгд үнэнтэй зөрчилддөг логик болон бодлоос үүсэн гардаг. Чиний логик Бурханы ажлыг бүрэн гүйцэд задлан шинжилж чадах уу? Еховагийн бүх ажлыг нэвт харж чадах уу? Энэ бүхнийг нэвт шувт хардаг нь хүн чи юу, эсвэл мөнхөөс мөнхөд харж чаддаг нэгэн нь Бурхан Өөрөө юу? Мөнхийн эрт дээр үеэс үүрдийн мөнхийг харж чаддаг нь чи юу, эсвэл мөнхийн эрт дээр үеэс ирээдүйн мөнхийг хүртэл харж чаддаг нь Бурхан уу? Чи юу гэх вэ? Бурханыг тайлбарлахад чи яаж тохирох юм бэ? Чиний тайлбар юунд үндэслэдэг вэ? Чи Бурхан уу? Тэнгэр, газар болон бүх зүйлийг Бурхан Өөрөө бүтээсэн. Чи үүнийг хийгээгүй, тэгвэл чи яагаад буруу тайлбар өгч байгаа юм бэ? Одоо чи гурвал Бурханд итгэсээр байна уу? Ингэх нь хэтэрхий ядаргаатай гэж бодохгүй байна уу? Гурав биш ганц Бурханд итгэх нь чиний хувьд хамгийн сайн байх болно. Хөнгөн байх нь хавьгүй дээр, учир нь Эзэний ачаа хөнгөн билээ.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН (1)

Сатаны маш гүн гүнзгий завхруулсан хүн төрөлхтөн Бурхан байдаг гэдгийг мэддэггүй ба Бурханд шүтэн мөргөхөө больжээ. Анх Адам, Ева хоёрыг бүтээгдэх үед Еховагийн алдар болон гэрчлэл үргэлж байдаг байлаа. Гэхдээ завхруулагдсанахаа дараа хүн алдар болон гэрчлэлийг алджээ, учир нь хүн бүр Бурханы эсрэг тэрсэлж, Түүнийг хүндлэхээ бүрмөсөн больсон юм. Өнөөдрийн байлдан дагуулалтын ажил нь, бүтээгдсэн зүйлсийн дунд гэрчлэлтэй байхын тулд бүх алдар суу, гэрчлэлийг буцаан авч, бүх хүнээр Бурханыг шүтүүлэхийн төлөө байдаг; энэхүү үе шатанд хийгдэх ажил нь энэ юм. Хүн төрөлхтнийг яг яаж байлдан дагуулдаг вэ? Хүнийг бүрэн дүүрэн үнэмшүүлэхийн тулд энэ үе шатны үгийн ажлыг ашигласнаар; хүнийг бүрэн ятгахын тулд илчлэлт, шүүлт, гэсгээлт, өршөөлгүй хараал ашигласнаар; хүний тэрслүү байдлыг илчилж, эсэргүүцлийг нь шүүснээр хийгддэг, ийнхүү тэрээр хүн төрөлхтний шударга бус, бузар булай байдлыг мэдэж, улмаар Бурханы зөвт зан чанарын товойлгогч болгон эдгээр зүйлийг ашиглаж чадна. Үндсэндээ эдгээр үгээр дамжуулан хүнийг байлдан дагуулж, бүрэн үнэмшүүлдэг. Үг бол хүн төрөлхтнийг эцэстээ байлдан дагуулах арга барил бөгөөд Бурханы байлдан дагуулалтыг хүлээн зөвшөөрдөг бүх хүн Түүний үгийн цохилт, шүүлтийг хүлээн зөвшөөрөх ёстой. Өнөөгийн ярих үйл явц нь яг нарийндаа байлдан дагуулах үйл явц юм. Тэгвэл хүмүүс яг яаж хамтран ажиллах ёстой вэ? Эдгээр үгийг хэрхэн идэж, уухаа мэдэж, тэдгээрийг ойлгосноор. Хүмүүс хэрхэн байлдан дагуулагддаг тухайд гэвэл, энэ нь тэдний өөрсдөө хийж чадахгүй зүйл юм. Чи эдгээр үгийг идэж ууснаар дамжуулан өөрийн завхрал, бохир заваан, тэрслүү, зөв шударга бус байдлыг мэдэж авч, Бурханы өмнө сөхрөн унаж л чадна. Хэрвээ чи Бурханы хүслийг ухаарсныхаа дараа ч хэрэгжүүлж чаддаг бол, мөн үзэгдэлтэй байж, эдгээр үгэнд бүрэн захирагдаж чаддаг, өөрөө ямар ч сонголт хийдэггүй бол чи байлдан дагуулагдсан байх болно—энэ нь эдгээр үгийн үр дүн байна. Хүн төрөлхтөн яагаад гэрчлэлээ алдсан бэ? Хэн ч Бурханд итгэдэггүй учраас, хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан зай эзэлдэггүй учраас. Хүн төрөлхтнийг байлдан дагуулах нь хүн төрөлхтний итгэлийг сэргээх явдал юм. Хүмүүс дэлхий ертөнц рүү ухаан жолоогүй гүйхийг үргэлж хүсэж, хэтэрхий их итгэл найдвар өвөрлөж, ирээдүйнхээ төлөө дэндүү ихийг хүсэж, хэрээс хэтэрсэн шаардлага дэндүү их тавьдаг. Тэд үргэлж махан биеийн талаар бодож, төлөвлөдөг бөгөөд Бурханд итгэх замыг эрж хайх талаар огт сонирхдоггүй. Тэдний зүрх сэтгэлийг Сатан

булаан авч, тэд Бурханыг хүндлэх хүндлэлээ алдсан ба Сатанд анхаарлаа хандуулдаг. Гэхдээ хүнийг Бурхан бүтээсэн. Тиймээс хүн гэрчлэлээ алдсан гэдэг нь Бурханы алдрыг алдсан гэсэн үг юм. Хүн төрөлхтнийг байлдан дагуулахын зорилго нь Бурханыг гэх хүний хүндлэлийн алдар сууг эргүүлэн авах явдал юм. Үүнийг ингэж хэлж болно: Амийг эрэлхийлдэггүй хүмүүс олон байдаг; амийг эрэлхийлдэг зарим хүн байдаг ч гэсэн тоо хэмжээгээрээ тун цөөхөн. Хүмүүс ирээдүйдээ санаа зовдог бөгөөд аминд ямар ч анхаарал хандуулдаггүй. Зарим нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцэж, ар хударгаар нь Түүнийг шүүдэг ба үнэнийг хэрэгжүүлдэггүй. Одоогоор энэ хүмүүсийг үл ойшоодог; одоохондоо энэ төрлийн тэрслүү хөвгүүдэд юу ч хийдэггүй боловч ирээдүйд чи харанхуйд амьдран, уйлж, шүдээ хавирах болно. Чи гэрэлд амьдарч байх үедээ эрхэм нандин байдлыг нь мэдэрдэггүй боловч харанхуй шөнөөр амьдармагцаа тэрхүү эрхэм нандин байдлыг ухаарч, дараа нь харамсана. Чамд одоо зүгээр санагдаж байгаа ч харамсах өдөр чинь ирнэ. Тэрхүү өдөр ирж, харанхуй нөмрөн авч, цаашид гэрэл гэж байхаа болих үед харамсахад хэтэрхий оройтсон байна. Чи өнөөдрийн ажлыг мөн л ойлгодоггүй болохоор одоо өөрт чинь байгаа цаг хугацааг нандигнаж чаддаггүй. Бүхий л орчлон ертөнцийн ажил эхэлмэгц буюу өнөөдөр Миний хэлж байгаа бүхэн биелэх үед олон хүн толгойгоо барин, шаналан уйлна. Ингэснээрээ тэд уйлж, шүдээ хавиран харанхуйд унасан байх бус уу? Амийг үнэхээр эрэлхийлдэг, бүрэн төгс болгуулсан бүхнийг ашиглаж болдог байхад ашиглагдахад тохирохгүй бүх тэрслүү хөвгүүд харанхуйд унана. Тэд Ариун Сүнсний ажилгүй, юуны ч учрыг олох чадваргүй байна. Тиймээс тэд шийтгэлд унаад тарчлан уйлна. Хэрвээ чи ажлын энэ үе шатанд сайтар зэвсэглэж, амиа өсгөсөн бол ашиглагдахад тохирох хүн юм. Харин муухан зэвсэглэсэн бол хэдий чи ажлын дараагийн үе шатанд дуудагдсан ч гэсэн ашиглуулахад тохирохгүй—энэ үед өөрийгөө зэвсэглэхийг хүссэн ч гэсэн чамд өөр боломж олдохгүй. Бурхан явчихсан байх болно; тэгвэл одоо өмнө чинь байгаатай адил боломжийг олохын тулд чи хаашаа явах юм бэ? Бурханы биечлэн өгдөг сургуулилыг хүлээн авахын тулд чи хаашаа явах юм бэ? Тэр үед Бурхан биечлэн үгээ хэлж, Өөрийн дуу хоолойг илэрхийлэхгүй; чи өнөөдөр хэлж байгаа зүйлийг л уншиж чадна—тэгвэл яаж амархан ойлгох юм бэ? Хожмын амьдрал яаж өнөөдрийнхөөс дээр байж чадах юм бэ? Тэр үед чи уйлж, шүдээ хавирангаа амьд үхлийг туулахгүй гэж үү? Одоо чамд ерөөл өгөгдөж байгаа боловч чи үүнийг хэрхэн эдлэхээ мэддэггүй; чи ерөөгдсөн байдал дунд амьдарч байгаа атлаа мэдэхгүй хэвээр үлддэг. Чи бол зовох заяатай гэдгийг энэ нь

нотолдог! Өнөөдөр зарим хүн эсэргүүцэж, зарим нь тэрсэлж, зарим нь энэ тэрийг хийдэг бөгөөд Би үүнийг зүгээр л үл ойшоодог—гэхдээ яах гэж байгааг чинь мэддэггүй гэж бүү бод. Би та нарын мөн чанарыг ойлгодоггүй гэж үү? Яагаад Надтай сөргөлдсөөр байгаа юм бэ? Чи өөрийнхөө төлөө амь болон ерөөлийг эрэлхийлэхийн тулд Бурханд итгэдэг бус уу? Өөрийнхөө төлөө л итгэлтэй байдаг бус уу? Одоогийн хоромд Би зөвхөн үг хэлснээр байлдан дагуулалтын ажлыг хийж байгаа бөгөөд байлдан дагуулалтын энэ ажил дуусмагц төгсгөл чинь илэрхий болно. Би бүр илүү тодорхой хэлэх хэрэгтэй юу?

Өнөөдрийн байлдан дагуулалтын ажил нь хүний төгсгөл ямар байхыг ил болгохоор зорьдог. Өнөөдрийн шүүлт, гэсгээлт нь эцсийн өдрүүдийн агуу цагаан сэнтийн өмнөх шүүлт юм гэж яагаад хэлдэг вэ? Чи үүнийг харахгүй байна уу? Байлдан дагуулалтын ажил яагаад сүүлчийн үе шат вэ? Энэ нь яг нарийндаа төрөл бүрийн хүний төгсгөл ямар байхыг харуулахын төлөө байдаг бус уу? Энэ нь гэсгээлт, шүүлтээр байлдан дагуулах ажлын явцад, жинхэнэ нүүр царайгаа харуулж, дараа нь төрлийнхөө дагуу ангилагдах боломжийг хүн бүрд олгохын төлөө байдаг бус уу? Энэ нь хүн төрөлхтнийг байлдан дагуулж байгаа хэрэг гэж хэлэхийн оронд төрөл бүрийн хүний төгсгөл ямар байхыг харуулж байгаа хэрэг гэж хэлсэн нь дээр байж магад. Энэ нь, хүмүүсийн нүглийг шүүж, дараа нь хүний янз бүрийн төрлийг илчилж, улмаар ёрын муу, эсвэл зөв шударга эсэхийг нь шийдэх явдал юм. Байлдан дагуулалтын ажлын дараа сайныг шагнаж, мууг шийтгэх ажил явагддаг. Бүрэн дуулгавартай дагадаг буюу бүрмөсөн байлдан дагуулагдсан хүмүүсийг бүхий л орчлон ертөнцөд Бурханы ажлыг түгээх дараагийн алхамд байрлуулна; байлдан дагуулагдаагүй хүмүүсийг харанхуйд байрлуулах ба тэд гай гамшигтай тулгарна. Тиймээс хүн төрлийнхөө дагуу ангилагдаж, мууг үйлдэгчид муугийн бүлэгт ангилагдаж, дахин хэзээ ч нарны гэрэлд байхгүй бөгөөд зөв шударга хүмүүс сайнтай ангилагдан гэрлийг хүлээн авч, үүрд гэрэлд амьдарна. Бүх зүйлийн төгсгөл ойрхон байна; хүний төгсгөл нүдэнд нь тодорхой харагдсан бөгөөд бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдана. Тэгвэл хүмүүс дор бүрнээ төрлөөрөө ангилагдахын зовлонгоос хэрхэн зугтаж чадах вэ? Бүх зүйлийн төгсгөл ойртох үед төрөл бүрийн хүний төгсгөл илчлэгддэг ба энэ нь бүхий л орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлын явцад (өнөөгийн ажлаас эхлээд байлдан дагуулалтын бүх ажлыг оролцуулан) хийгддэг. Бүх хүн төрөлхтний төгсгөлийг илчлэх илчлэлт нь гэсгээлтийн явцад, мөн эцсийн өдрүүдийн байлдан дагуулах ажлын явцад шүүх суудлын өмнө хийгддэг. Хүмүүсийг төрлийнх нь дагуу ангилах нь тэднийг

анхдагч ангилал руу нь буцаах явдал биш, учир нь бүтээлийн цаг үед хүнийг бүтээхэд ердөө нэг төрлийн хүн байсан ба эрэгтэй, эмэгтэй хүний хооронд л зааг байсан. Олон өөр төрлийн хүн байгаагүй. Зөвхөн хэдэн мянган жилийн завхралын дараа л өөр өөр төрлийн хүмүүс гарч ирсэн бөгөөд зарим нь бузар диаволын эзэмшил дор, зарим нь муу ёрын диаволын эзэмшил дор, амийн замыг эрэлхийлдэг хүмүүс нь Төгс Хүчитийн ноёрхол дор гарч ирсэн. Ийм маягаар л хүмүүсийн дунд аажмаар анги давхарга бий болж, ингэснээр л хүмүүс, хүн төрөлхтний өнөр гэр бүл дотор хүмүүс тус тусын анги давхаргад хуваагдсан. Хүмүүс бүгд өөр өөр “эцэгтэй” болж эхэлсэн; хүн бүр бүхэлдээ Төгс Хүчитийн ноёрхол дор байдаг юм биш, учир нь хүн дэндүү тэрслүү. Зөв шударга шүүлт нь төрөл бүрийн хүний жинхэнэ төрхийг ил болгож, нууцлаг зүйл юу ч үлдээдэггүй. Гэрэлд хүн бүхэн жинхэнэ нүүр царайгаа харуулдаг. Өдгөө хүн анхных шигээ байхаа больж, өвөг дээдсийнх нь анхдагч төрх аль хэдийн үгүй болсон, учир нь Адам Евагийн тоо томшгүй олон үр удам хэдийнээ Сатанд олзлогдож, тэнгэрнарыг дахин хэзээ ч мэдэхээргүй болж, хүмүүс Сатаны бүх төрлийн хороор дүүрчээ. Тиймээс хүмүүс өөрсдөд нь тохирох хүрэх газартай байдаг. Түүнчлэн, өөр өөр хорынхоо үндсэн дээр тэд төрлөөрөө ангилагддаг, өөрөөр хэлбэл, тэд өнөөдөр байлдан дагуулагддаг хэмжээгээрээ ангилагддаг. Хүний төгсгөл нь дэлхий бүтээгдсэнээс хойш урьдчилан тогтоогдчихсон зүйл биш юм. Яагаад гэвэл, эхэндээ нэг л төрөл байсныг нийтэд нь “хүн төрөлхтөн” гэж нэрлэдэг байсан бөгөөд анх хүнийг Сатан завхруулаагүй байсан, мөн хүмүүс бүгд Бурханы гэрэлд амьдарч, ямар ч харанхуй нөмрөөгүй байв. Гэхдээ хүнийг Сатан завхруулсны дараа төрөл, зүйл бүрийн хүмүүс буюу нийтэд нь “хүн төрөлхтөн” гэж нэрлэдэг, эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн гэр бүлээс гарсан төрөл, зүйл бүрийн хүмүүс газар дэлхий даяар тархсан. Тэднийг бүгдийг нь өвөг дээдэс нь удирдан хөтөлж, хамгийн дээд өвөг дээдэс болох эрэгтэй, эмэгтэй хүнээс бүрдсэн хүн төрөлхтнөөс (өөрөөр хэлбэл, хамгийн дээд өвөг дээдэс болох анхны Адам, Ева хоёроос) холдуулжээ. Тухайн үед газар дээр амьдрахдаа Еховагаар удирдуулж байсан цорын ганц хүмүүс нь израильчууд байсан билээ. Бүхий л Израилиас (анхдагч гэр бүлийн овгоос гэсэн үг) төрөл бүрийн хүмүүс үүсэн гарч, дараа нь Еховагийн удирдамжийг алдсан юм. Энэ эртний хүмүүс хүний ертөнцийн хэрэг явдлуудыг огт мэдэлгүй, өвөг дээдсээ даган, өөрсдийн эзэмшсэн газар нутагтаа амьдарч ирсэн нь өнөөг хүртэл үргэлжилжээ. Тиймээс тэд Еховагаас хэрхэн хөндийрч, өнөөдрийг хүртэл төрөл бүрийн бузар чөтгөр болон муу ёрын сүнсээр хэрхэн завхруулагдсан тухайгаа

мэдэхгүй хэвээр байдаг. Өнөөг хүртэл хамгийн гүн гүнзгий завхарч, хордсон хүмүүс—эцэстээ аврагдаж чадахгүй хүмүүс—өөрсдийг нь завхруулсан бузар диаволууд буюу өөрсдийн өвөг дээдэстэй хамт явахаас өөр сонголтгүй байх болно. Эцэстээ аврагдаж чадах хүмүүс хүн төрөлхтөнд тохирох хүрэх газар буюу аврагдаж, байлдан дагуулагдсан хүмүүст зориулсан төгсгөл рүү явна. Аврагдаж болох бүх хүнийг аврахын төлөө бүхнийг хийх болно—харин мэдрэмжгүй, засаршгүй хүмүүсийн хувьд, цорын ганц сонголт нь өвөг дээдсээ даган гэсгээлтийн ёроолгүй нүх рүү унах явдал юм. Чиний төгсгөл анхнаасаа урьдчилан тогтоогдсон ба одоо л илчлэгдлээ гэж бүү бод. Хэрвээ чи тэгж боддог бол хүн төрөлхтнийг анх бүтээх үед сатанлаг төрөл тусдаа бүтээгдээгүй гэдгийг мартаа юу? Адам, Ева хоёроос бүрдсэн (зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүн бүтээгдсэн гэсэн үг) цорын ганц хүн төрөлхтөн бүтээгдсэн гэдгийг мартчихаа юу? Хэрвээ чи анхнаасаа Сатаны үр удам байсан бол, Ехова хүнийг бүтээхдээ Өөрийн бүтээлд сатанлаг бүлгийг багтаасан гэсэн үг болох бус уу? Тэр үнэхээр тиймэрхүү зүйл хийх байсан гэж үү? Тэрээр Өөрийнхөө гэрчлэлийн төлөө хүнийг бүтээсэн; Өөрийнхөө алдрын төлөө хүнийг бүтээсэн. Санаатайгаар Өөрийг нь эсэргүүцэх Сатаны үр удмын төрлийг Тэр яагаад зориуд бүтээнэ гэж? Ехова яаж ийм зүйл хийж чадах юм бэ? Хэрвээ тэгсэн бол хэн Түүнийг зөвт Бурхан гэж хэлэх юм бэ? Та нарын зарим нь эцэстээ Сатантай хамт явах болно гэж одоо хэлж байгаа минь чи анхнаасаа Сатантай хамт байсан гэсэн үг биш; харин ч, Бурхан чамайг аврах гэж оролдсон ч гэсэн чи тэрхүү авралыг хүртэж чадахааргүй болтлоо доройтсон гэсэн үг юм. Чамайг Сатантай хамт ангилахаас өөр сонголт үгүй. Чи аврагдахын аргагүй учраас ийм байгаа бөгөөд Бурхан чамд шударга бус хандаж, хувь заяаг чинь санаатайгаар Сатаны биелэл болгон тогтоож, улмаар чамайг Сатантай хамт ангилж, зориуд зовоохыг хүсдэгээс болж байгаа юм биш. Энэ нь байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн биш. Хэрвээ чи ингэж итгэдэг бол ойлголт чинь маш өрөөсгөл байна! Байлдан дагуулахлтынэцсийн үе шат нь хүмүүсийг аварч, тэдний төгсгөлийг илчлэх учиртай. Энэ нь, шүүлтээр дамжуулан хүмүүсийн доройтлыг ил болгож, улмаар гэмшиж, өндийн босож, амь болоод хүний амьдралын зөв замыг эрэлхийлэхэд тэднийг хүргэх явдал юм. Энэ нь хөшүүн, маанаг хүмүүсийн зүрх сэтгэлийг сэрээж, шүүлтээр дамжуулан доторх тэрслүү байдлыг нь харуулахын төлөө байдаг. Гэсэн хэдий ч, хүмүүс гэмшиж чадахгүй, хүний амьдралын зөв замыг эрэлхийлж чадахгүй, эдгээр завхралыг хөсөр хаях чадваргүй хэвээр байвал аврагдах аргагүй бөгөөд Сатанд залгиулна. Хүмүүсийг аварч, бас тэдний төгсгөлийг харуулах нь Бурханы

байлдан дагуулалтын ач холбогдол билээ. Сайн, муу төгсгөл нь бүгд байлдан дагуулалтын ажлаар илчлэгддэг. Хүмүүс аврагдах, хараагдах эсэх нь бүгд байлдан дагуулалтын ажлын явцад илчлэгддэг.

Эцсийн өдрүүд нь байлдан дагуулалтаар дамжуулан бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах үе юм. Байлдан дагуулах нь эцсийн өдрүүдийн ажил; өөрөөр хэлбэл, хүн бүрийн нүглийг шүүх нь эцсийн өдрүүдийн ажил билээ. Эс бөгөөс, хүмүүсийг яаж ангилж чадах юм бэ? Та нарын дунд хийгдэж байгаа ангилах ажил нь бүхий л орчлон ертөнц дэх ийм ажлын эхлэл юм. Үүний дараа, бүх газар нутгийн хүмүүс болон бүх ард түмэн ч бас байлдан дагуулалтын ажлыг хүлээн авна. Энэ нь, бүтээл дэх хүн бүр төрлөөрөө ангилагдаж, шүүгдэхийн тулд шүүх суудлын өмнө захирагдана гэсэн үг юм. Хэн ч, юу ч энэхүү гэсгээлт, шүүлтийг туулахаас зугтаж чадахгүй, мөн төрлөөрөө ангилагддаггүй ямар ч хүн, ямар ч зүйл үгүй; хүн бүр ангилагдана, учир нь бүх зүйлийн төгсгөл ойртож, тэнгэр, газар бүгд төгсгөлдөө хүрсэн. Хүний оршин тогтнолын сүүлчийн өдрүүдээс хүн хэрхэн зугтаж чадах билээ? Тиймээс та нарын дуулгаваргүй үйл хэр удаан үргэлжилж чадах вэ? Эцсийн өдрүүд чинь ойрхон байгааг та нар харахгүй байна гэж үү? Бурханыг хүндэлж, Түүний гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүс Бурханы зөвт байдлын илрэлтийн өдрийг харахгүй байж яаж чадах юм бэ? Тэд сайн сайхан байдлын сүүлчийн шагналыг хүлээн авахгүй байж яаж чадах билээ? Чи сайныг хийдэг нэгэн үү, эсвэл ёрын мууг хийдэг нэгэн үү? Чи зөв шударга шүүлтийг хүлээн зөвшөөрөөд, дуулгавартай дагадаг нэгэн үү, эсвэл зөв шударга шүүлтийг хүлээн зөвшөөрөөд, дараа нь харагддаг нэгэн үү? Чи шүүх суудлын өмнө гэрэлд амьдардаг уу, эсвэл Үхэгсдийн оронд харанхуйн дунд амьдардаг уу? Төгсгөл чинь шагнал байх уу, эсвэл шийтгэл байх уу гэдгийг хамгийн тодорхой мэддэг хүн чи өөрөө биш гэж үү? Бурхан бол зөвт гэдгийг хамгийн тодорхой мэдэж, хамгийн гүнзгий ойлгодог нэгэн чи биш гэж үү? Тэгвэл биеэ авч явах байдал болон зүрх сэтгэл чинь яг чухамдаа ямар вэ? Өнөөдөр чамайг байлдан дагуулахдаа Би, зан авир чинь сайн, муу эсэхийг үнэхээр нэг бүрчлэн хэлэх хэрэгтэй гэж үү? Чи Миний төлөө хэр ихийг орхисон бэ? Чи Надад хэр гүн гүнзгий шүтэн мөргөдөг вэ? Надад хэрхэн ханддагаа чи өөрөө хамгийн сайн мэддэг бус уу? Эцэстээ ямар үр дүнтэй тулгарахаа чи хэнээс ч илүү сайн мэдэж байх ёстой! Би чамд үнэнээсээ хэлж байна: Би зөвхөн хүн төрөлхтнийг бүтээж, чамайг бүтээсэн боловч та нарыг Сатанд өгөөгүй; Миний эсрэг тэрсэлж, Намайг эсэргүүцэж, улмаар Надаар шийтгүүлэхэд Би та нарыг зориуд хүргээгүй. Энэ бүх гай гамшиг, зовлон шаналал нь зүрх сэтгэл чинь хэтэрхий хатуу, биеэ

авч явах байдал чинь хэтэрхий жигшүүртэй байснаас болоогүй гэж үү? Тэгвэл өөрсдөд чинь тулгарах төгсгөлийг та нар өөрсдөө тодорхойлдог бус уу? Та нар хэрхэн төгсөхөө зүрх сэтгэлдээ хэнээс ч илүү сайн мэддэг бус уу? Би хүмүүсийг байлдан дагуулдгийн шалтгаан нь тэднийг илчлэхийн төлөө, мөн чамайг илүү сайн аврахын төлөө байдаг. Энэ нь чамаар мууг үйлдүүлэхийн төлөө байдаггүй, чамайг зориуд сүйрлийн там руу алхуулахын төлөө ч байдаггүй. Цаг нь ирэх үед асар их зовлон чинь, уйлж, шүдээ хавирах чинь бүгд чиний нүглээс болохгүй гэж үү? Тиймээс сайн сайхан, эсвэл хорон муу чинь чамайг хамгийн сайн шүүдэггүй гэж үү? Чиний төгсгөл ямар байхын хамгийн сайн нотолгоо энэ биш гэж үү?

Өнөөдөр Би бүх тэрслүү зан чанарыг нь илчилж, бүх муу муухай байдлыг нь ил болгохын тулд Хятад дахь, Бурханы сонгосон хүмүүс дээр ажилладаг бөгөөд хэлэх хэрэгтэй бүхнээ хэлж байгаагийн минь нөхцөл байдал энэ юм. Дараа нь Би бүх орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлын дараагийн алхмыг хийхдээ бүхий л орчлон ертөнц дээрх хүн бүрийн зөв шударга бусыг шүүхдээ та нарыг шүүх шүүлтээ ашиглана, учир нь хүмүүс та нар бол хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийн төлөөлөгчид билээ. Урагшилж сайжирч чаддаггүй хүмүүс ердөө л товойлгогч, хүчин зүтгэгчид болно, харин сайжирч чаддаг хүмүүс ашиглагдана. Урагшилж сайжирч чадахгүй хүмүүс зөвхөн товойлгогч болж үйлчилнэ гэж Би яагаад хэлдэг вэ? Учир нь Миний өнөөгийн үг, ажил бүгд та нарын нөхцөл байдлыг онилдог, мөн та нар бүх хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийн төлөөлөл, загвар болсон. Хожим нь Би та нарыг байлдан дагуулдаг эдгээр үгийг харийн улс орнуудад аваачиж, тэндхийн хүмүүсийг байлдан дагуулахад ашиглана, гэсэн ч чи тэдгээрийг олж аваагүй байх болно. Тэр нь та нарыг товойлгогч болгохгүй гэж үү? Бүх хүн төрөлхтний завхарсан зан чанар, хүний тэрслүү үйлс, хүний муухай дүр төрх, нүүр царай бүгд, өнөөдөр та нарыг байлдан дагуулахад ашигласан үгэнд тэмдэглэгддэг. Та нар үлгэр дуурайл, өмнөх жишээ учраас улс үндэстэн, урсгал бүрийн хүмүүсийг байлдан дагуулахын тулд Би эдгээр үгийг ашиглана. Гэхдээ Би та нарыг зориуд орхихоор төлөвлөөгүй; хэрвээ чи эрэл хайгуулаа сайн хийж чадалгүй, улмаар засаршгүй гэдгээ нотолбол зүгээр л хүчин зүтгэгч, товойлгогч болохгүй гэж үү? Миний мэргэн ухаан Сатаны арга мэхэнд үндэслэн хэрэгждэг гэдгийг Би нэгэнтээ хэлсэн. Яагаад Би тэгж хэлсэн бэ? Миний яг одоо хэлж, хийж байгаа зүйлийн ар дахь үнэн энэ биш гэж үү? Хэрвээ чи урагшлан сайжирч чадахгүй бол, хэрвээ чи төгс болгуулалгүй, харин ч шийтгүүлдэг бол товойлгогч болохгүй гэж үү? Магадгүй чи амьдралдаа асар их зовсон байж болох ч юу ч ойлгоогүй хэвээр

байгаа; чи амийн талаар юу ч мэддэггүй. Гэсгээгдэж, шүүгдсэн хэдий ч чи огт өөрчлөгдөөгүй бөгөөд сэтгэлийн гүндээ амийг олж аваагүй. Чиний ажлыг турших цаг ирэх үед чи гал мэт ширүүн шалгалтыг болон бүр ч их гай зовлонг туулна. Энэхүү гал бүхий л оршихуйг чинь үнс нурам болгон хувиргана. Амийг эзэмшдэггүй хүн, дотроо өчүүхэн төдий ч шижир алтгүй хүн, завхарсан хуучин зан чанартайгаа зууралдсан хүн, товойлгогч байхыг ч сайн хийж чаддаггүй хүний хувьд чи яаж таягдан хаягдахгүй байж чадах юм бэ? Сохор зоосноос ч долоон дор үнэтэй, амьгүй хүн байлдан дагуулалтын ажилд хэрэгтэй байж чадна гэж үү? Тэр цаг ирэх үед өдөр хоногууд чинь Ноа болон Содомынхоос ч хэцүү байх болно! Тэр үед залбирлууд чинь чамд тус болохгүй. Авралын ажил хэдийнээ дуусчихсан байх үед чи яаж дараа нь буцаж ирээд, шинээр гэмшиж эхэлж чадах юм бэ? Бүх авралын ажил дуусмагц авралын ажил гэж байхаа болино; харин ёрын муу хүмүүсийг шийтгэх ажлын эхлэл л байх байна. Чи эсэргүүцэж, тэрсэлдэг бөгөөд ёрын муу гэдгийг нь мэддэг зүйлээ хийдэг. Чи хатуу чанга шийтгэлийн бай биш гэж үү? Өнөөдөр Би чиний төлөө энэ бүхнийг ойлгомжтой тайлбарлаж байна. Хэрвээ чи сонсохгүй гэж шийдвэл, хожим нь гай гамшиг тохиолдох үед харамсаж, итгэж эхэлсэн ч гэсэн хэтэрхий оройтохгүй гэж үү? Би чамд өнөөдөр гэмших боломж олгож байгаа ч чи тэгэхийг хүсэхгүй байна. Чи хэр удаан хүлээхийг хүсэж байгаа юм бэ? Гэсгээлтийн өдөр хүртэл үү? Урьдын гэм бурууг чинь Би өнөөдөр санадаггүй; Би чамайг ахин дахин уучилж, зөвхөн эерэг талыг чинь л харахын тулд чиний сөрөг талаас нүүр буруулдаг, учир нь Миний одоогийн бүх үг болон ажил чамайг аврах учиртай бөгөөд Би чамд ямар ч муу санаа агуулаагүй. Гэсэн ч чи орохоос татгалздаг; чи сайн мууг ялгаж чаддаггүй, бас сайхан сэтгэлд хэрхэн талархахаа мэддэггүй. Ийм хүмүүс зүгээр л шийтгэл болон зөв шударга цээрлүүлэлт ирэхийг хүлээдэг бус уу?

Моше хадыг цохиход Еховагийн хайрласан ус оргилсон нь түүний итгэлээс үүдэлтэй. Давид Ехова Намайг магтан лир хөгжим хөгжимдөж, зүрх сэтгэл нь баяр баяслаар дүүрдэг байсан нь түүний итгэлээс үүдэлтэй. Иов уул толгодыг бүрхсэн мал сүрэг, асар их эд хөрөнгөө алдан, бие нь яр шарханд баригдсан нь түүний итгэлээс үүдсэн. Ехова Миний дуу хоолойг сонсож, Ехова Миний алдар сууг харж чадсан нь ч түүний итгэлээс үүдэлтэй. Есүс Христийг Петр дагаж чадсан нь түүний итгэлээс улбаатай. Миний төлөө загалмайд цовдлогдож, алдар суут гэрчлэл хийж чадсан нь ч түүний итгэлээс улбаатай. Хүний Хүүгийн алдар суут дүрийг Иохан харсан нь түүний итгэлээс улбаатай. Эцсийн өдрүүдийн үзэгдлийг харсан нь түүний итгэлээс бүр ч их улбаатай. Харь

үндэстний гэгдэх үй олон хүн Миний илчлэлийг олж авч, хүмүүсийн дунд ажлаа хийхээр махбодод эргэн ирсэн гэдгийг минь олж мэдсэн нь ч бас тэдний итгэлээс үүдэлтэй. Миний хатуу чанга үгээр цохиулдаг ч тэдгээрээр тайтгаруулагдаж, аврагддаг бүх хүн, итгэлээсээ болж ингээгүй гэж үү? Хүмүүс итгэлээсээ үүдэн маш ихийг хүлээн авсан бөгөөд энэ нь үргэлж ерөөл байдаггүй. Тэд Давидын мэдэрсэн аз жаргал, баяр хөөрийг хүлээн авахгүй, эсвэл Мосе шиг Еховагийн хайрласан усыг авахгүй байж магад. Жишээлбэл, Иов итгэлээсээ үүдэн Еховагаар ерөөгдсөн боловч бас гай гамшиг амссан. Чи ерөөгдсөн ч, эсвэл гай гамшиг амссан ч, аль аль нь ерөөлтэй үйл явдал юм. Итгэлгүйгээр чи байлдан дагуулалтын энэхүү ажлыг хүлээн авч чадахгүй, өнөөдөр нүдний чинь өмнө харагддаг Еховгийн үйл хэргийг харж бүр ч чадахгүй. Чи харж чадахгүй, тэр ч бүү хэл хүлээн авч чадахгүй байх болно. Эдгээр гай зовлон, гамшиг болон бүх шүүлт—хэрвээ эдгээр нь чамд тохиолдоогүй бол чи өнөөдөр Еховагийн үйл хэргийг харж чадах байсан уу? Өнөөдөр, итгэл нь чамд байлдан дагуулагдах боломж олгодог бөгөөд байлдан дагуулагдах нь чамд Еховагийн үйл хэрэг бүрд итгэх боломжийг олгодог. Итгэлийн улмаас л чи ийм гэсгээлт, шүүлтийг хүлээн авдаг. Энэ гэсгээлт, шүүлтээр дамжуулан чи байлдан дагуулагдаж, төгс болдог. Өнөөдөр чиний хүлээн авч байгаа ийм гэсгээлт, шүүлтгүйгээр итгэл чинь хий дэмий байх болно, учир нь чи Бурханыг мэддэггүй байна; Түүнд хэчнээн итгэсэн чинь хамаагүй, итгэл чинь бодит байдалд үндэслээгүй, хоосон илэрхийлэл төдий байна. Чамайг бүрэн дуулгавартай болгодог байлдан дагуулалтын энэ ажлыг хүлээн авсны дараа л чиний итгэл жинхэнэ, бат бөх болж, зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэдэг. “Итгэл” хэмээх энэхүү үгээс болж чи асар их шүүлт, хараал амсдаг ч гэсэн, жинхэнэ итгэлтэй байж, хамгийн жинхэнэ, хамгийн бодитой, хамгийн үнэ цэнтэй зүйлийг хүлээн авдаг. Яагаад гэвэл, зөвхөн шүүлтийн явцад л чи Бурханы бүтээлийн эцсийн хүрэх газрыг хардаг; энэхүү шүүлтээс л чи Бүтээгч хайрлагдах ёстой гэдгийг хардаг; ийм байлдан дагуулалтын ажлаас л чи Бурханы гарыг хардаг; энэ байлдан дагуулалтаас чи хүний амьдралыг бүрэн ойлгож эхэлдэг; энэ байлдан дагуулалтаас чи хүний амьдралын зөв замыг олж авч, “хүн” гэдгийн жинхэнэ утга учрыг ойлгож эхэлдэг; зөвхөн энэ байлдан дагуулалтаас л чи Төгс Хүчитийн зөвт зан чанар болон үзэсгэлэнтэй сайхан, алдарт дүр төрхийг хардаг; энэхүү байлдан дагуулалтын ажлаас л чи хүний гарал үүслийг мэдэж авч, бүх хүн төрөлхтний “үхэшгүй мөнхийн түүхийг” ойлгодог; энэ байлдан дагуулалтаас л чи хүн төрөлхтний өвөг дээдэс болоод хүн төрөлхтний завхралын уг сурвалжийг

танин мэдэж авдаг; энэ байлдан дагуулалтаас чи баяр хөөр, тайтгарал, түүнчлэн эцэс төгсгөлгүй цээрлүүлэлт, сахилгажуулалт болон Бүтээгчээс Өөрийн бүтээсэн хүн төрөлхтөнд өгсөн зэмлэлийн үгийг хүлээн авдаг; энэ байлдан дагуулалтын ажлаас чи ерөөл хүлээн авдаг, мөн хүний хүртэх ёстой гай гамшгийг хүлээн авдаг... Энэ нь бүгд өчүүхэн итгэлээс чинь болж байгаа бус уу? Эдгээр зүйлийг олж авсны дараа итгэл чинь өсөөгүй гэж үү? Чи үлэмж ихийг олж аваагүй гэж үү? Бурханы үгийг сонсож, Бурханы мэргэн ухааныг харснаар үл барам, чи бас ажлын алхам бүрийг биечлэн туулсан. Хэрвээ итгэлгүй байсан бол ийм төрлийн гэсгээлт, эсвэл ийм төрлийн шүүлтийг амсахгүй байх байсан гэж чи хэлж магадгүй. Гэвч итгэлгүйгээр чи Төгс Хүчитээс ийм гэсгээлт, ийм халамжийг хүлээн авч чадахгүйгээр зогсохгүй, Бүтээгчтэй уулзах боломжоо үүрд алдах байсан гэдгээ мэдэж байх ёстой. Чи хүн төрөлхтний гарал үүслийг хэзээ ч мэдэхгүй, хүний амьдралын ач холбогдлыг хэзээ ч ойлгохгүй байх байсан. Бие чинь үхэж, сүнс чинь одсон ч гэсэн чи Бүтээгчийн бүх үйл хэргийг мөн л ойлгож чадахгүй байх байсан, тэр ч бүү хэл, Бүтээгч хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа газар дээр үнэхээр агуу ажил хийсэн гэдгийг мэдэхгүй байх байв. Түүний бүтээсэн энэхүү хүн төрөлхтний нэгэн гишүүн болохын хувьд чи ийм маягаар мунхаглан харанхуй руу унаж, мөнхийн шийтгэл амсахыг хүсэж байна уу? Хэрвээ чи өөрийгөө өнөөдрийн гэсгээлт, шүүлтээс салгавал чамд юу тулгарах вэ? Өнөөгийн шүүлтээс салмагц энэхүү хүнд хэцүү амьдралаас зугтаж чадна гэж чи бодож байна уу? Хэрвээ чи “энэ газрыг” орхиж явбал зовлонт тарчлаан, эсвэл диаволын учруулсан харгис хүчирхийлэлтэй л тулгарна гэдэг худлаа гэж үү? Тэвчихийн аргагүй өдөр, шөнүүд тулгарч магад бус уу? Өнөөдрийн энэ шүүлтээс л зугтдаг учраас чи ирээдүйн тарчлаанаас үүрд зайлж чадна гэж бодож байна уу? Чиний замд юу тулгарах вэ? Энэ нь үнэхээр чиний хүсдэг Диваажингийн орон байх юм гэж үү? Чи одоогийнх шигээ бодит байдлаас зугтсанаар хожмын мөнхийн гэсгээлтээс зайлж чадна гэж бодож байна уу? Өнөөдрөөс хойш чи ийм боломж, ийм ерөөлийг дахиад ер нь олж чадах уу? Гай гамшиг чамд тохиолдох үед чи тэдгээрийг олж чадах уу? Бүх хүн төрөлхтөн амралтад орох үед чи тэдгээрийг олж чадах уу? Өнөөгийн аз жаргалтай амьдрал болон эв зохицолтой бяцхан гэр бүл чинь ирээдүйн мөнхийн хүрэх газрыг чинь орлож чадах уу? Хэрвээ чи жинхэнэ итгэлтэй бол, мөн хэрвээ чи итгэлээсээ үүдэн асар ихийг олж авдаг бол тэр бүхэн нь бүтээгдсэн зүйл болох чиний олж авах ёстой, бас анхнаасаа чамд байх ёстой байсан зүйл юм. Ийм байлдан дагуулалт чиний итгэл болон аминд хамгийн их ач тустай.

Өнөөдөр чи, байлдан дагуулагддаг хүмүүсээс Бурхан юу шаарддагийг, төгс болгуулдаг хүмүүст хандах Түүний хандлага ямар болохыг, мөн одоо юунд орох ёстойгоо ойлгох хэрэгтэй. Зарим зүйлийг нь чи бага зэрэг л ойлгох хэрэгтэй. Нууцын тухай зарим үгийг чи судалж шинжлэх хэрэггүй; тэдгээр нь аминд тийм ч их нэмэргүй бөгөөд хальт харахад л болно. Тэгээд Адам Ева хоёрын нууц гэх мэт нууцуудыг буюу тухайн үед Адам, Ева хоёр ямар байсан, Бурхан өнөөдөр ямар ажил хийхийг хүсдэг зэргийг уншиж болно. Хүнийг байлдан дагуулж, төгс болгохдоо Бурхан түүнийг Адам, Ева хоёрын байсан байдалд буцаан аваачихыг хүсдэгийг чи ойлгох хэрэгтэй. Бурханы стандартад нийцэхийн тулд хүрэх ёстой төгс төгөлдрийн түвшний талаар сайн мэддэг байж, үүнд хүрэхээр хичээх ёстой. Энэ нь чиний хэрэгжүүлэлттэй хамаатай бөгөөд чиний ойлгох ёстой зүйл юм. Эдгээр асуудлын тухайд чи Бурханы үгийн дагуу орохоор эрж хайхад хангалттай. “Хүн төрөлхтний хөгжлийн түүх хэдэн арван мянган жилийн тэртээгээс эхэлсэн” гэдгийг унших үедээ чи сониуч болдог тул ах эгч нарын хамтаар хариулт олохоор оролддог. “Хүн төрөлхтний хөгжил зургаан мянган жилийн өмнөөс эхэлсэн гэж Бурхан хэлдэг биз дээ? Тэгвэл энэ хэдэн арван мянган жил гэдэг нь юу гэсэн үг вэ?” Энэ асуултын хариултыг олохоор оролдох нь ямар хэрэгтэй юм бэ? Бурхан Өөрөө хэдэн арван мянган жилийн турш, эсвэл хэдэн зуун сая жилийн турш ажилласаар ирсэн—энэ талаар мэдэх чинь Түүнд үнэхээр хэрэгтэй гэж үү? Энэ нь бүтээгдсэн зүйл болох чиний мэдэх хэрэгтэй зүйл биш. Чи иймэрхүү яриаг цухасхан авч үзэхэд л болно; үүнийг үзэгдэл шиг ойлгохоор бүү оролд. Чи өнөөдөр юунд орж, ойлгох ёстойгоо мэддэг байх хэрэгтэй, тэгээд энэ талаар баттай ойлгодог байх хэрэгтэй. Тэр үед л чи байлдан дагуулагдана. Дээрхийг уншсаны дараа чамд хэвийн хариу үйлдэл байх ёстой: Бурхан асар их түгшиж байгаа, Тэрээр биднийг байлдан дагуулж, алдар суу болон гэрчлэлийг олж авахыг хүсдэг, тэгвэл бид Түүнтэй хэрхэн хамтран ажиллах ёстой вэ? Түүгээр бүрэн байлдан дагуулагдаж, Түүний гэрчлэл болохын тулд бид юу хийх ёстой вэ? Бурханд алдар суу олж авах боломж олгохын тулд юу хийх ёстой вэ? Өөрсдийгөө Сатаны эзэмшил дор биш, харин Бурханы ноёрхол дор амьдруулахын тулд бид юу хийх ёстой вэ? Энэ нь хүмүүсийн бодож байх ёстой зүйл юм. Бурханы байлдан дагуулалтын ач холбогдлын талаар та нар дор бүрнээ тодорхой мэдэж байх ёстой. Тэр бол та нарын хариуцлага. Ингэж тодорхой ойлгосныхоо дараа л та нар оролттой байж, ажлын энэ үе шатыг мэдэж, бүрэн дуулгавартай болох болно. Эс бөгөөс, та нар жинхэнэ дуулгавартай байдалд хүрэхгүй.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН (3)

Байлдан дагуулалтын ажлын зорьсон үр нөлөө нь юун түрүүнд хүний махан бие тэрслэхээ болих явдал юм; өөрөөр хэлбэл, хүний оюун ухаан Бурханы талаар шинэ мэдлэгтэй болж, зүрх сэтгэл нь Бурханыг бүрэн дуулгавартай дагаж, Бурханы төлөө тэмүүлэх явдал юм. Ааш авир юм уу махан бие нь өөрчлөгдөхөд хүмүүсийг байлдан дагуулагдсан гэж тооцдоггүй; хүний бодол, ухамсар болон эрүүл ухаан өөрчлөгдөх үед, өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хандлага чинь бүхэлдээ өөрчлөгдөх үед—чи Бурханаар байлдан дагуулагдсан байх болно. Чи дуулгавартай байхаар шийдэж, шинэ сэтгэлгээтэй болж, өөрийн ямар ч үзэл, санаа зорилгыг Бурханы үг болон ажилтай холихоо больж, уураг тархи чинь хэвийн байдлаар бодож чадах үед—өөрөөр хэлбэл, бүх зүрх сэтгэлээрээ Бурханы төлөө зүтгэх үед—чи бүрэн байлдан дагуулагдсан төрлийн хүн юм. Шашинд олон хүн насан туршдаа асар их зовдог: Тэд биеэ захирч, загалмайгаа үүрч, бүр үхлийн ирмэгт байх үедээ ч зовж, тэвчсээр байдаг! Зарим нь өөрсдийнхөө насан эцэслэх өглөө ч мацаг барьж байдаг. Бүхий л амьдралдаа тэд сайхан хоол хүнс, хувцас хунараас татгалзаж, зовоход л анхаарлаа хандуулдаг. Тэд биеэ захирч, махан биеэ хаяж чаддаг. Зовлон тэвчсэнийх нь төлөө тэдний эр зоригийг магтууштай. Гэвч тэдний бодол, үзэл, сэтгэл санааны байдал болон хуучин уг чанар нь өчүүхэн төдий ч харьцалт туулаагүй байдаг. Тэдэнд өөрсдийнх нь талаарх ямар ч жинхэнэ мэдлэг байдаггүй. Тэдний сэтгэл дэх Бурханы дүр нь тодорхойгүй Бурханы уламжлалт дүр байдаг. Бурханы төлөө зовох шийдвэр нь тэдний урам зориг болон хүн чанарынх нь сайн ёс жудгаас үүдэн гардаг. Хэдий тэд Бурханд итгэдэг ч Бурханыг ойлгодоггүй, Түүний хүслийг ч мэддэггүй. Тэд ердөө л Бурханы төлөө сохроор ажиллаж, зовдог. Тэд ялган таних чадварт ямар ч ач холбогдол өгдөггүй, үйлчлэл нь яаж Бурханы хүслийг үнэхээр биелүүлэх талаар багахан анхаардаг бөгөөд Бурханы талаарх мэдлэгт хэрхэн хүрэхээ бүр ч мэддэггүй. Тэдний үйлчилдэг Бурхан нь төрөлх дүрээрээ байгаа Бурхан биш, харин өөрсдийнх нь төсөөлсөн Бурхан, өөрсдийнх нь сонсож дуулсан юм уу ном зохиолын үлгэр домгоос уншсан л Бурхан юм. Тэгээд тэд өөрсдийн баялаг төсөөлөл, сүсэг бишрэлээ ашиглан Бурханы төлөө зовж, Бурханы хийхийг хүсдэг ажлыг хариуцдаг. Тэдний үйлчлэл хэтэрхий оновчгүй байдаг болохоор чухамдаа хэн нь ч Бурханы хүслийн дагуу үйлчилж үнэхээр чаддаггүй. Тэд Бурханы шүүлт, гэсгээлт, цэвэршүүлэлт, төгс болголтыг туулаагүй, мөн үнэнийг

ашиглан хэн ч тэднийг залж чиглүүлээгүй учраас хэчнээн дуртай зовдгоос үл хамааран үйлчлэлийн талаарх анхдагч үзэл бодол болон сэтгэлд нь байгаа Бурханы дүр өөрчлөгдөлгүй үлддэг. Аврагч Есүст итгэдэг байлаа ч гэсэн, тэдний нэг нь ч Аврагчийг ер харж байгаагүй. Тэд үлгэр домог, цуу ярианаас л Түүний талаар мэддэг. Үүний үр дүнд, тэдний үйлчлэл нь сохор хүн эцэгтээ үйлчлэхтэй адилаар нүдээ анин таамгаар үйлчлэхээс хэтэрдэггүй. Ийм төрлийн үйлчлэлээр эцэстээ юунд хүрч чадах вэ? Хэн үүнийг сайшаах юм бэ? Эхнээсээ эцсээ хүртэл тэдний үйлчлэл нэгэн хэвийн хэвээр үлддэг; тэд зөвхөн хүний сургаалыг л хүлээн авдаг бөгөөд байгаа байдал, дуртай зүйлдээ л үндэслэн үйлчилдэг. Энэ нь ямар шагнал авчирч чадах юм бэ? Есүсийг харсан Петр хүртэл Бурханы хүслийн дагуу хэрхэн үйлчлэхээ мэдээгүй; тэрээр эцэст нь хөгширсөн хойноо л мэдэж авсан юм. Тэгвэл өчүүхэн төдий ч харьцалт, засалт туулаагүй, залж чиглүүлэх хэн ч байхгүй тэр сохор хүмүүсийн тухайд юу гэх вэ? Өнөөдөр та нарын дундах олон хүний үйлчлэл энэ сохор хүмүүсийнхтэй адилхан биш гэж үү? Шүүлт, засалт, харьцалт хүлээн аваагүй, өөрчлөгдөөгүй бүх хүн—бүгд бүрэн байлдан дагуулагдаагүй хүмүүс бус уу? Ийм хүмүүс ямар хэрэгтэй юм бэ? Чиний сэтгэхүй, амьдралын талаарх мэдлэг, Бурханы талаарх мэдлэгт ямар ч шинэ өөрчлөлт гардаггүй, үнэндээ юу ч олж авдаггүй бол чи үйлчлэлээрээ ер бусын юунд ч хүрэхгүй! Үзэгдэл болон Бурханы ажлын тухай шинэ мэдлэггүй бол чи байлдан дагуулагдаагүй. Тэгвэл Бурханыг дагаж байгаа чинь зовж, мацаг барьдаг хүмүүстэй адил, өчүүхэн үнэ цэнтэй байх болно! Хийдэг зүйлд нь багахан гэрчлэл байдаг учраас л тэдний үйлчлэл хий дэмий юм гэж Би хэлдэг! Тэр хүмүүс насан туршдаа зовж, шоронд цагаа өнгөрүүлдэг; тэд ямагт тэвчиж, хайрлан, үргэлж загалмай үүрдэг, дэлхий ертөнцөд дооглуулж, гологдож, бэрхшээл бүрийг туулж, эцсээ хүртэл дуулгавартай байдаг ч мөн л байлдан дагуулагддаггүй бөгөөд байлдан дагуулагдах тухай ямар ч гэрчлэл хийж чаддаггүй. Тэд асар их зовсон ч дотроо Бурханыг огт мэддэггүй. Тэдний хуучин сэтгэхүй, хуучин үзэл, шашны зан үйл, хүний бий болгосон мэдлэг болон хүний үзэл санааны аль нь ч харьцалт амсаагүй. Шинэ ойлголтын өчүүхэн ч сэжүүр тэдэнд байдаггүй. Бурханы талаарх тэдний мэдлэгийн багахан нь ч үнэн зөв, оновчтой байдаггүй. Тэд Бурханы хүслийг буруугаар ойлгосон. Энэ нь Бурханд үйлчилж байгаа хэрэг үү? Бурханы талаарх урьдын мэдлэг чинь ямар ч байлаа гэсэн, өнөөдөр хэвээрээ үлдэж, Бурхан юу ч хийлээ гэсэн Бурханы талаарх мэдлэг чинь өөрийн үзэл, санаанд үндэслэсээр байвал, өөрөөр хэлбэл, Бурханы талаарх ямар ч шинэ, жинхэнэ мэдлэг чамд байдаггүй, чи Бурханы

жинхэнэ дүр төрх болон зан чанарыг мэдэж чаддаггүй бол, мөн Бурханы талаарх мэдлэг чинь одоо ч феодалын, мухар сүсэгт сэтгэлгээгээр удирдуулж, хүний үзэл, төсөөллөөс төрөн гардаг хэвээр бол чи байлдан дагуулагдсангүй. Одоо чамд Миний хэлж буй олон үг бүгд чамайг мэдлэгтэй болгож, энэхүү мэдлэгээр чамайг илүү шинэлэг, үнэн зөв мэдлэг рүү хөтлөх зорилготой; бас чамд байгаа хуучин үзэл, хуучин мэдлэгийг үгүй хийх зорилготой, ингэснээр чи шинэ мэдлэгтэй болно. Хэрвээ чи Миний үгийг үнэхээр идэж уувал мэдлэг чинь мэдэгдэхүйц өөрчлөгдөнө. Чи дуулгавартай зүрх сэтгэлээр Бурханы үгийг идэж, ууж байгаа цагт үзэл бодол чинь өөрчлөгдөнө. Чи удаа дараагийн гэсгээлтийг хүлээн авч чадаж байгаа цагт хуучин сэтгэхүй чинь аажмаар өөрчлөгдөнө. Чиний хуучин сэтгэхүй бүхэлдээ шинээр солигдсон цагт хэрэгжүүлэлт чинь ч бас үүнийг даган өөрчлөгдөнө. Ийм маягаар чиний үйлчлэл улам бүр оновчтой болж, Бурханы хүслийг улам их биелүүлж чадна. Хэрвээ чи өөрийн амьдрал, хүний амьдралын талаарх мэдлэг болон Бурханы талаарх олон үзлээ өөрчилж чадвал төрөлх байдал чинь аажмаар багасна. Гагцхүү энэ нь л Бурхан хүмүүсийг байлдан дагуулах үеийн үр нөлөө бөгөөд хүмүүст гардаг өөрчлөлт юм. Бурханд итгэхдээ чи биеэ захирч, тэвчиж, зовохыг л мэддэг бөгөөд энэ нь зөв үү, буруу юу гэдгийг мэддэггүй, бүр хэний төлөө хийдгээ ч мэддэггүй бол ийм хэрэгжүүлэлт яаж өөрчлөлт рүү хөтөлж чадах юм бэ?

Та нараас Миний шаарддаг зүйл бол махан биеэ хазаарлаж, эсвэл уураг тархиа дураараа бодож сэтгэхийг нь болиулах явдал биш гэдгийг ойлгож ав. Энэ нь ажлын зорилго ч биш, яг одоо хийх хэрэгтэй ажил ч биш. Өөрсдийгөө өөрчлөхийн тулд яг одоо та нар эерэг талаас мэдлэгтэй болох ёстой. Хамгийн их хэрэгтэй үйлдэл бол өөрсдийгөө Бурханы үгээр зэвсэглэх буюу өнөөгийн үзэгдэл болон үнэнээр өөрсдийгөө бүрэн зэвсэглэж, цаашлаад тэдгээрийг хэрэгжүүлэх явдал юм. Энэ бол та нарын хариуцлага. Би та нараас бүр илүү их гэрэлтүүлэлтийг эрж хайж, олж авахыг шаардаагүй байна. Одоогоор та нарт тийм биеийн хэмжээ ердөө байхгүй. Та нараас шаарддаг зүйл бол Бурханы үгийг идэж, уухын тулд чадах бүхнээ хийх явдал юм. Та нар Бурханы ажлыг ойлгож, өөрсдийн уг чанар, мөн чанар болон хуучин амьдралыг мэдэх ёстой. Ялангуяа та нар урьдын андуу ташаа, утгагүй хэрэгжүүлэлт болон хийсэн үйлдлээ мэдэх хэрэгтэй. Өөрчлөгдөхийн тулд сэтгэхүйгээ өөрчлөхөөс эхлэх ёстой. Эхлээд хуучин сэтгэхүйгээ шинээр сольж, шинэ сэтгэхүйгээрээ өөрийн үг, үйлдэл, амьдралыг удирдуул. Өнөөдөр та бүгдээс шаарддаг зүйл энэ юм. Сохроор бүү хэрэгжүүл, эсвэл сохроор бүү дага. Та нар үндэс суурь, зорилготой

байх ёстой. Өөрсдийгөө бүү хуур. Бурханд итгэх итгэл чинь яг юуны төлөө болох, үүнээс юу олж авах ёстой болон яг одоо юунд орох ёстойгоо та нар мэдэх ёстой. Чи энэ бүхнийг мэдэх шаардлагатай.

Та нарын одоо орох ёстой зүйл бол амьдралаа дээшлүүлж, хэв чанараа өсгөх явдал юм. Түүнчлэн, урьдын хуучин үзэл бодлоо өөрчилж, сэтгэхүйгээ өөрчилж, үзлээ өөрчлөх хэрэгтэй. Бүхий л амьдралд чинь шинэчлэлт хэрэгтэй. Бурханы үйл хэргийн талаарх мэдлэг чинь өөрчлөгдөж, Бурханы хэлдэг бүхний үнэний талаар шинэ мэдлэгтэй болж, доторх мэдлэг чинь өсөх үед чиний амьдрал сайжирч эхэлнэ. Одоо хүмүүсийн хийдэг, хэлдэг бүх зүйл бодитой. Эдгээр нь хоосон сургаал биш, харин ч хүмүүсийн аминд хэрэгтэй, тэдний эзэмших ёстой зүйлс юм. Энэ нь байлдан дагуулалтын ажлын үеэр хүмүүст гардаг өөрчлөлт, хүмүүсийн туулах ёстой өөрчлөлт, байлдан дагуулагдсаных нь дараах үр нөлөө билээ. Чи сэтгэхүйгээ өөрчилж, сэтгэл санааны шинэ хандлагатай болж, өөрийн үзэл, санаа зорилго болон урьдын логик үндэслэлийг няцааж, дотор чинь гүн үндэслэсэн зүйлсийг хаяж, Бурханд итгэх итгэлийн талаар шинэ мэдлэгтэй болсон үед гэрчлэл чинь өргөгдөж, бүхий л оршихуй чинь үнэхээр өөрчлөгдсөн байх болно. Энэ бүхэн нь хамгийн бодитой, хамгийн жинхэнэ, хамгийн үндсэн зүйлс—өнгөрсөн үед хүмүүсийн хүрч чадаагүй зүйлс, мөн тэдний харилцаж чаддаггүй байсан зүйлс юм. Тэдгээр нь Сүнсний жинхэнэ ажил билээ. Чи урьд нь Библийг яг яаж ойлгож байсан бэ? Үүнийг өнөөдөр харьцуулаад үзвэл чи мэдэх болно. Урьд нь чи Мосе, Петр, Паул эсвэл библийн тэр бүх үг, үзэл бодлыг сэтгэл санаандаа дээдэлж, өндөрт өргөсөн. Одоо хэрвээ чамаас Библийг өндөрт өргөхийг хүсвэл чи үүнийг хийх үү? Библи нь хүний бичсэн хэтэрхий олон тэмдэглэлийг агуулдаг ба Бурханы ажлын хоёр үе шатны тухай хүний бүртгэл төдий юм гэдгийг чи харна. Энэ бол түүхийн ном юм. Тэгвэл үүний талаарх мэдлэг чинь өөрчлөгдсөн гэсэн үг биш гэж үү? Хэрвээ чи өнөөдөр Матайн Сайн мэдээнд бичигдсэн Есүсийн угийн бичгийг харвал “Есүсийн угийн бичиг ээ? Утгагүй юм! Энэ бол Есүсийн биш, Иосефын угийн бичиг. Есүс, Иосеф хоёрын хооронд ямар ч холбоо байхгүй” хэмээн хэлнэ. Одоо Библийг харах үед үүний талаарх мэдлэг чинь өөр байдаг, өөрөөр хэлбэл, чиний үзэл бодол өөрчлөгдсөн бөгөөд чи шашны ахмад эрдэмтдээс илүү өндөр түвшний мэдлэгтэй байдаг. Энэхүү угийн бичигт ямар нэгэн зүйл байна гэж хэн нэгэн хэлбэл чи: “Үүнд юу байх юм бэ? Тэгвэл тайлбарлаад өг дөө. Есүс, Иосеф хоёр хоорондоо хамаагүй. Чи тэрийг мэддэггүй гэж үү? Есүст угийн бичиг байж болох уу? Есүс яаж өвөг дээдэстэй байж болох юм бэ? Тэр яаж хүний үр удам байж

болох юм бэ? Түүний махбод Мариагаас төрсөн; Түүний Сүнс бол хүний сүнс биш, харин Бурханы Сүнс. Есүс бол Бурханы хайртай хүү, тэгэхээр Тэр угийн бичигтэй байж болох уу? Газар дээр байхдаа Тэр хүн төрөлхтний нэгэн гишүүн байгаагүй, иймээс Тэр яаж угийн бичигтэй байх юм бэ?” гэж хариулна. Чи угийн бичгийг шинжилж, дотоод үнэнийг тодорхой тайлбарлаж, ойлгосон зүйлээ хуваалцах үед тэр хүн хэлэх үггүй болно. Зарим хүн Библиэс эш татаж, “Есүс угийн бичигтэй байсан. Чиний өнөөдрийн Бурхан угийн бичигтэй юү?” гэж асууна. Чи тэгэхэд нь тэдэнд өөрийн хамгийн бодитой мэдлэгийнхээ талаар хэлж, ийм маягаар мэдлэг чинь үр нөлөө үзүүлсэн байх болно. Үнэндээ Есүс Иосефтэй ямар ч хамаагүй бөгөөд Абрахамтай бүр ч холбоогүй; Есүс зүгээр л Израильд төрсөн юм. Гэхдээ Бурхан бол израиль хүн биш, израильчуудын үр удам ч биш. Израильд төрлөө гээд Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэсэн утгатай байх албагүй. Өөрийнхөө ажлын төлөө л Тэр бие махбодтой болох ажлыг гүйцэтгэсэн юм. Бурхан бол орчлон ертөнц дээрх бүх бүтээлийн Бурхан билээ. Тэр зүгээр л ажлынхаа нэг үе шатыг Израильд хийгээд, дараа нь Харь үндэстнүүдийн дунд ажиллаж эхэлсэн. Гэсэн ч хүмүүс Есүсийг израильчуудын Бурхан гэж үзсэн бөгөөд цаашлаад Түүнийг израильчуудын дунд, Давидын үр удмын дунд тавьсан. Эцсийн өдрүүдэд Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд агуу болно гэж Библид бичсэн байдаг, энэ нь Бурхан эцсийн өдрүүдэд Харь үндэстнүүдийн дунд ажиллана гэсэн үг юм. Бурхан Иудейд бие махбодтой болсон нь Бурхан зөвхөн иудейчүүдийг хайрладаг гэдгийг илтгэдэггүй. Ажил нь шаардсан учраас л тийм зүйл болсон; (израильчууд Түүний сонгосон хүмүүс байсан учраас) Бурхан Израильд л бие махбодтой болох ёстой байсан юм биш. Бурханы сонгосон хүмүүс Харь үндэстнүүдийн дунд ч бас байдаг бус уу? Есүс Иудейд ажиллаж дууссаны дараа уг ажил Харь үндэстнүүдэд өргөжсөн. (Израильчууд Израилиас бусад бүх үндэстнийг “Харь үндэстнүүд” гэж нэрлэдэг байв.) Үнэндээ тэр Харь үндэстнүүдэд ч гэсэн Бурханы сонгосон хүмүүс байсан; зүгээр л тухайн үед тэнд ямар ч ажил хараахан хийгдээгүй байсан юм. Харь үндэстнүүдэд ямар ч ажил хийгдээгүй байхад Израильд ажлын хоёр үе шат явагдсан учраас хүмүүс Израилийг тэгж их онцолдог. Харь үндэстнүүдийн дундах ажил өнөөдөр л эхэлж байгаа бөгөөд тийм учраас үүнийг хүлээн зөвшөөрөх нь хүмүүст тун хэцүү байдаг. Хэрвээ чи энэ бүхнийг тодорхой ойлгож, өөрийн болгож, зөвөөр авч үзэж чадвал өнөөдрийн болон урьдын Бурханы талаар нарийн зөв мэдлэгтэй болох бөгөөд энэ шинэ мэдлэг нь түүхэн туршид ариун хүмүүсийн эзэмшиж байсан Бурханы талаарх мэдлэгээс илүү

өндөр байх болно. Хэрвээ чи өнөөдрийн ажлыг туулж, Бурханы хувийн айлдварыг өнөөдөр сонсдог ч Бурханыг бүхэлд нь мэддэггүй бол, эрэл хайгуул чинь үргэлж байсан шигээ үлдэн, ямар ч шинэ зүйлээр солигддоггүй бол, ялангуяа хэрвээ чи энэ бүх байлдан дагуулалтын ажлыг туулдаг ч эцэстээ чамаас ямар ч өөрчлөлт харагддаггүй бол итгэл чинь, өлсгөлөнгөө дарахын тулд л талх хайдаг хүмүүсийнхтэй адил биш гэж үү? Тэр тохиолдолд байлдан дагуулалтын ажил чамд ямар ч үр нөлөө үзүүлээгүй байх болно. Тэгвэл чи таягдан хаягдах хүмүүсийн нэг болохгүй гэж үү?

Байлдан дагуулалтын бүх ажил төгсгөлдөө очих үед, Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан биш, харин бүх бүтээлийн Бурхан юм гэдгийг та нар бүгд ойлгох шаардлагатай. Тэрээр зөвхөн израильчуудыг ч биш, бүх хүн төрөлхтнийг бүтээсэн. Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан, эсвэл Бурхан Израилийн гаднах өөр ямар ч үндэстэнд бие махбодтой болох боломжгүй гэж хэлдэг бол чи байлдан дагуулалтын ажлын үеэр ямар нэгэн мэдлэг хараахан олж аваагүй бөгөөд Бурхан бол чиний Бурхан гэдгийг өчүүхэн төдий ч таньдаггүй; Бурхан Израилиас Хятад руу шилжиж, арга буюу чиний Бурхан болсон гэж л чи хүлээн зөвшөөрдөг. Хэрвээ чи аливааг ингэж үзсээр байгаа бол Миний ажил чамд ямар ч үр өгөөжгүй байсан ба чи Миний хэлсэн нэг ч зүйлийг ойлгосонгүй. Эцэст нь хэрвээ чи Матай шиг Надад зориулсан өөр нэг угийн бичгийг бичиж, Надад тохирох өвөг дээдсийг олж, Миний “зөв” уг үндсийг олж өгөөд—ингэснээр Бурхан хоёр удаа бие махбод болохдоо хоёр угийн бичигтэй байвал энэ нь дэлхий дээрх хамгийн том хошин шог болохгүй гэж үү? Надад угийн бичиг олж өгсөн энэ “сайн санаатай хүн” чи Бурханыг хуваасан хүн болохгүй гэж үү? Чи энэ нүглийн ачааг үүрч чадах уу? Энэ бүх байлдан дагуулалтын ажлын дараа хэрвээ чи одоо ч Бурхан бол бүх бүтээлийн Бурхан гэдэгт итгэхгүй байгаа бол, Бурхан бол израильчуудын л Бурхан гэж бодсоор байгаа бол чи Бурханыг ил тод эсэргүүцдэг хүн биш гэж үү? Өнөөдөр чамайг байлдан дагуулахын зорилго нь Бурхан бол чиний Бурхан, бас бусдын Бурхан, хамгийн чухал нь Түүнийг хайрладаг бүхний Бурхан, бүх бүтээлийн Бурхан гэдгийг чамаар хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. Тэр бол израильчуудын Бурхан бөгөөд Египетийн ард түмний ч Бурхан юм. Тэр бол англичуудын Бурхан, америкчуудын Бурхан билээ. Тэр бол зөвхөн Адам Евагийн Бурхан биш, бас тэдний бүх үр удмын Бурхан. Тэр бол тэнгэр дэх бүх зүйлийн, мөн газар дахь бүх зүйлийн Бурхан билээ. Израильчууд ч бай, Харь үндэстэн ч бай, бүх гэр бүл бүгд нэгэн Бурханы гарт байдаг. Тэр Израильд хэдэн мянган жил ажиллаж, Иудейд нэгэнтээ төрөөд

зогсохгүй, өнөөдөр агуу улаан лууны цагариглан хэвтдэг газар болох Хятадад бууж ирсэн. Хэрвээ Иудейд төрсөн нь Түүнийг иудейчүүдийн Хаан болгодог юм бол та бүхний дунд өнөөдөр бууж ирэх нь Түүнийг та бүгдийн Бурхан болгохгүй гэж үү? Тэр израильчуудыг удирдаж, Иудейд төрсөн бөгөөд бас Харь үндэстний нутагт төрсөн. Түүний бүх ажил Өөрийн бүтээсэн бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг бус уу? Тэр израильчуудыг зуу дахин их хайрлаж, Харь үндэстнүүдийг мянга дахин их жигшдэг үү? Энэ та нарын үзэл биш гэж үү? Бурхан хэзээ ч та нарын Бурхан байгаагүй юм биш, харин ч та нар л Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй; Бурхан та нарын Бурхан байхыг хүсдэггүй юм биш, харин ч та нар л Бурханыг голдог. Бүтээгдсэн зүйлийн дотроос хэн Төгс Хүчитийн гарт байдаггүй вэ? Та нарыг өнөөдөр байлдан дагуулахын зорилго нь Бурхан бол та нарын Бурханаас өөр хэн ч биш гэдгийг та нараар хүлээн зөвшөөрүүлэх явдал биш гэж үү? Хэрвээ та нар, Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэж үзсэн хэвээр, мөн Израиль дахь Давидын гэр бол Бурханы төрөлтийн уг сурвалж бөгөөд Израилиас өөр ямар ч үндэстэн Бурханыг “бий болгох” эрхгүй, тэр ч бүү хэл ямар ч Харь үндэстний гэр бүл Еховагийн ажлыг биечлэн хүлээн авч чадахгүй гэж бодсоор байвал энэ нь чамайг зөрүүд эсэргүүцэгч болгохгүй гэж үү? Израиль дээр үргэлж харцаа бүү тогтоо. Бурхан өнөөдөр яг энд та нарын дунд байгаа. Бас тэнгэр лүү ч бүү ширтсээр бай. Тэнгэр дэх Бурханаа хүсэмжлэхээ боль! Бурхан та нарын дунд ирсэн, тэгэхээр Тэр яаж тэнгэрт байж болох юм бэ? Чи Бурханд тийм ч удаан итгээгүй атлаа Түүний талаар ихээхэн үзэл өвөрлөн, израильчуудын Бурхан Өөрийн биеэр та нарыг нигүүлсэнэ гэдгийг нягтлан бодохгүй байж зүрхлэхдээ тулдаг. Өөрсдөө тэвчихийн аргагүй бохир болохоор та нар Бурхан биечлэн гарч ирэхийг хэрхэн харах талаар бодохгүй байж зүрхлэхдээ ч тулдаг. Бас Бурхан Харь үндэстний нутагт хэрхэн биечлэн бууж ирэх талаар хэзээ ч бодож байгаагүй. Тэр Синаи Уул, эсвэл Чидун Уулан дээр буун ирж, израильчуудад харагдах учиртай. Харь үндэстнүүд (өөрөөр хэлбэл, Израилийн гаднах хүмүүс) нь бүгд Түүний жигшил зэвүүцлийн бай биш гэж үү? Тэр яаж тэдний дунд биечлэн ажиллаж чадах юм бэ? Энэ бүхэн нь олон жилийн туршид та нарын бий болгосон, гүн үндэслэсэн үзэл юм. Та нарыг өнөөдөр байлдан дагуулахын зорилго нь эдгээр үзлийг чинь эвдэх явдал. Тиймээс Бурхан Синаи Уулан дээр, эсвэл Чидун Уулан дээр биш, харин урьд нь хэзээ ч удирдаж байгаагүй хүмүүсийнхээ дунд—та нарын дунд биечлэн илрэхийг та нар хардаг. Бурхан Өөрийн ажлын хоёр үе шатыг Израильд хийсний дараа израильчууд болон бүх Харь үндэстний аль аль нь, Бурхан бүх зүйлийг бүтээсэн

нь үнэн боловч Харь үндэстнүүдийн Бурхан биш, зөвхөн израильчуудын Бурхан байхыг л хүсэж байгаа гэх үзэлтэй болсон. Израильчууд, Бурхан зөвхөн бидний Бурхан байж болно, харин Харь үндэстнүүд та нарын Бурхан биш, та нар Еховаг хүндэлдэггүй учраас бидний Бурхан—Ехова та нарыг жигшдэг гэж итгэдэг. Иудей хүмүүс ч бас ингэж итгэдэг: Эзэн Есүс иудей хүмүүс бидний дүр төрхийг авсан бөгөөд иудей хүмүүсийн тэмдгийг тээдэг Бурхан юм. Бидний дунд л Бурхан ажилладаг. Бурханы дүр төрх болон бидний дүр төрх адилхан; бидний дүр төрх Бурханыхтай төстэй. Эзэн Есүс бол иудейчүүд бидний Хаан; Харь үндэстнүүд тийм агуу авралыг хүлээн авах эрхгүй. Эзэн Есүс бол иудейчүүд бидний төлөөх нүглийн тахил. Ажлын тэр хоёр үе шатны үндсэн дээр л израильчууд болон иудей хүмүүс энэ бүх үзлийг бий болгосон. Тэд Бурханыг өөрсдийнх нь гэж түрэмгийлэн зарладаг ба Бурхан бол Харь үндэстнүүдийн ч Бурхан мөн гэдгийг зөвшөөрдөггүй. Ийм маягаар Харь үндэстнүүдийн зүрх сэтгэлд Бурхан хоосон зай болсон. Учир нь, Бурхан Харь үндэстнүүдийн Бурхан байхыг хүсдэггүй, Тэр зөвхөн израильчуудад буюу Өөрийн сонгосон хүмүүст л дуртай ба ялангуяа Өөрийг нь дагаж байсан шавь нар болох иудейчүүдэд л дуртай гэж хүн бүр итгэх болсон юм. Ехова, Есүс хоёрын хийсэн ажил бүх хүн төрөлхтнийг амьд үлдээхийн төлөө гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Бурхан бол Израилийн гадна төрсөн та бүхний Бурхан юм гэдгийг чи одоо хүлээн зөвшөөрч байна уу? Бурхан өнөөдөр яг энд та нарын дунд байгаа бус уу? Энэ нь зүүд байж болохгүй биз дээ? Та нар энэ бодит байдлыг хүлээн зөвшөөрдөггүй юу? Та нар үүнд итгэж, эсвэл энэ талаар бодож зүрхэлдэггүй. Үүнийг яаж харахаас чинь үл хамааран, Бурхан яг энд та нарын дунд байгаа бус уу? Та нар энэ үгэнд итгэхээс мөн л айж байна уу? Энэ өдрөөс эхлээд бүх байлдан дагуулагдсан хүмүүс болон Бурханы дагагчид болохыг хүсдэг бүхэн Бурханы сонгосон хүмүүс биш гэж үү? Өнөөдрийн дагагчид та бүхэн, Израилийн гаднах сонгогдсон хүмүүс биш гэж үү? Та нарын байр суурь израильчуудынхтай адилгүй гэж үү? Та нарын танин мэдэх ёстой зүйл чинь энэ бүхэн биш үү? Энэ нь та нарыг байлдан дагуулах ажлын зорилго биш гэж үү? Нэгэнт та нар Бурханыг харж чадах учраас Тэр эхнээсээ аваад ирээдүйд ч үүрд та нарын Бурхан байх болно. Та нар бүгд Түүнийг дагаж, Түүний үнэнч дуулгавартай бүтээл байхыг хүссээр байгаа цагт Тэр та нарыг орхихгүй.

Хүмүүс Бурханыг хайрлахаар хэр их эрмэлздэгээс үл хамааран, тэд өдий хүртэл Түүнийг дагахдаа ерөнхийдөө дуулгавартай байсаар ирсэн. Ажлын энэ үе шат дуусаж, эцэстээ хүрэх үед л тэд бүрэн дүүрэн гэмшинэ. Тэр нь хүмүүс

үнэхээр байлдан дагуулагдсан байх үе юм. Яг одоо тэд байлдан дагуулагдах үйл явцад л байгаа. Ажил дуусах мөчид тэд бүрэн байлдан дагуулагдана, гэхдээ яг одоо тийм биш! Хүн болгон үнэмшдэг байлаа ч, тэд бүрэн байлдан дагуулагдсан гэсэн үг биш. Яагаад гэвэл, одоогоор хүмүүс бодит үйл явдлыг биш, зөвхөн үгийг харсан бөгөөд тэд хэчнээн гүн гүнзгий итгэдэг нь хамаагүй, тодорхой мэдэхгүй хэвээр үлддэг. Тийм учраас тэрхүү хамгийн сүүлчийн бодит үйл явдлаар л үг бодит байдал болж, хүмүүс бүрэн байлдан дагуулагдана. Яг одоо, хүмүүс урьд нь хэзээ ч сонсож байгаагүй олон нууцыг сонсдог учраас байлдан дагуулагддаг. Гэхдээ дотроо тэд дор бүрнээ, Бурханы үг бүр биелж байгааг өөрсдөд нь харуулдаг зарим бодит үйл явдлыг эрж хайж, хүлээсээр байдаг. Зөвхөн тэр үед л тэд бүрэн үнэмшинэ. Эцэстээ бүгд эдгээр биелсэн бодит байдлыг харж, эдгээр бодит байдал нь тэднийг итгэлтэй болгох үед тэд зүрх сэтгэлдээ, үг яриандаа, нүдэндээ итгэл үнэмшлийг харуулж, зүрх сэтгэлийнхээ гүнээс бүрэн үнэмшинэ. Хүний уг чанар ийм байдаг: Та нар үг бүгд биелж байгааг харах хэрэгтэй байдаг, мөн зарим бодитой үйл явдал тохиолдож байгааг харж, зарим хүнд гай гамшиг тохиож байгааг харах хэрэгтэй байдаг, тэгвэл зүрх сэтгэлийнхээ гүнд бүрэн үнэмшинэ. Иудейчүүдийн адилаар та нар тэмдэг, гайхамшгуудыг харахад асар их ач холбогдол өгдөг. Гэсэн ч та нар тэмдэг, гайхамшиг байдаг гэдгийг, мөн нүдийг чинь асар ихээр нээх учиртай бодит байдал тохиолдсоор байгаа гэдгийг харж ер чаддаггүй. Хэн нэгэн тэнгэрээс бууж ирэх ч бай, үүлэн багана та нарт үг хэлэх ч бай, та нарын нэгнээс Би чөтгөр шулмыг зайлуулах ч бай, эсвэл Миний дуу хоолой та нарын дунд аянга шиг нүргэлэх ч бай, та нар үргэлж иймэрхүү үйл явдлыг харахыг хүссэн, үргэлж хүссээр ч байх болно. Бурханд итгэхэд хамгийн том хүсэл чинь Бурхан ирж, та нарт биечлэн тэмдэг үзүүлэхийг харах явдал гэж хэлж болно. Тэгвэл сэтгэл чинь ханана. Хүмүүс та нарыг байлдан дагуулахын тулд Би тэнгэр, газрыг бүтээхтэй төстэй ажил гүйцэтгэж, дээр нь нэмээд нэг төрлийн тэмдэг үзүүлэх хэрэгтэй. Тэгвэл та нарын зүрх сэтгэл бүрэн байлдан дагуулагдана.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН (4)

Төгс болгуулах гэж юу гэсэн үг вэ? Байлдан дагуулагдах гэж юу гэсэн үг вэ? Байлдан дагуулагдахын тулд хүмүүс ямар шалгуурыг хангах ёстой вэ? Төгс болгуулахын тулд ямар шалгуурыг хангах ёстой вэ? Байлдан дагуулах, төгс болгох нь хоёулаа хүнийг бүрэн төгс болгох зорилготой, ингэснээр тэр анхдагч

төрхөө сэргээж, завхарсан сатанлаг зан чанар болон Сатаны нөлөөнөөс ангижирч болох юм. Энэхүү байлдан дагуулалт нь хүнийг хүн болгох үйл явцын эхэнд болдог; үнэндээ энэ нь ажлын эхний алхам юм. Төгс болгох нь хоёр дахь алхам бөгөөд төгсгөлийн ажил билээ. Хүн бүр байлдан дагуулагдах үйл явцыг туулах ёстой. Тэгэхгүй бол тэд Бурханыг мэдэх ямар ч аргагүй, Бурхан байдаг гэдгийг ч мэдэхгүй, өөрөөр хэлбэл, тэдний хувьд Бурханыг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Хэрвээ хүмүүс Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй бол тэдний хувьд бас Бурханаар бүрэн төгс болгуулах боломжгүй байдаг, чи бүрэн төгс болгуулах энэхүү шалгуурыг хангадаггүй. Хэрвээ чи бүр Бурханыг ч хүлээн зөвшөөрдөггүй бол Түүнийг яаж мэдэж чадах юм бэ? Яаж Түүнийг эрэлхийлж чадах юм бэ? Чи Түүнд гэрчлэл хийж ч чадахгүй, тэр ч бүү хэл Түүнийг сэтгэл хангалуун болгох итгэлтэй байж ч чадахгүй. Иймээс бүрэн төгс болгуулахыг хүсдэг хэний ч хувьд эхний алхам нь байлдан дагуулалтын ажлыг туулах явдал байх ёстой. Энэ бол эхний нөхцөл. Гэвч байлдан дагуулах, төгс болгох нь хоёулаа хүмүүсийг хүн болгож, өөрчлөхийн төлөө байдаг бөгөөд аль аль нь хүнийг удирдах ажлын нэг хэсэг юм. Хүнийг бүрэн гүйцэд болгоход энэ хоёр алхам хоёулаа хэрэгтэй бөгөөд алийг нь ч орхигдуулж болохгүй. “Байлдан дагуулагдах” гэдэг нь тийм ч сайхан сонсогддоггүй нь үнэн боловч үнэн хэрэгтээ хэн нэгнийг байлдан дагуулах үйл явц нь түүнийг өөрчлөх үйл явц юм. Байлдан дагуулагдмагц завхарсан зан чанар чинь бүрэн арилаагүй байж болох ч чи ядаж л үүнийг мэдэж авсан байна. Байлдан дагуулалтын ажлаар дамжуулан чи дорд хүн чанараа, мөн ихээхэн дуулгаваргүй байдлаа мэдэж авсан байх болно. Хэдийгээр чи байлдан дагуулалтын ажлын богинохон хугацаанд эдгээр зүйлийг хаяж, эсвэл өөрчилж чадахгүй ч тэдгээрийг мэдэж авах бөгөөд энэ нь төгс болгуулах суурийг чинь тавина. Иймээс байлдан дагуулах болон төгс болгох нь хоёулаа хүмүүсийг өөрчилж, тэднийг завхарсан сатанлаг зан чанараас нь салгахын тулд хийгддэг, ингэснээр тэд өөрсдийгөө Бурханд бүрэн өгч чадна. Байлдан дагуулагдана гэдэг нь ердөө хүмүүсийн зан чанарыг өөрчлөх эхний алхам, мөн хүмүүс өөрсдийгөө Бурханд бүрэн өгөх эхний алхам бөгөөд төгс болгуулах алхмаас доогуур юм. Байлдан дагуулагдсан хүний амь зан чанар төгс болгуулсан хүнийхээс хамаагүй бага өөрчлөгддөг. Байлдан дагуулагдах болон төгс болгуулах нь үзэл баримтлалын хувьд нэг нэгээсээ өөр, учир нь тэдгээр нь ажлын өөр өөр үе шат бөгөөд хүмүүсийг өөр өөр стандартад байлгадаг; байлдан дагуулалт нь хүмүүсийг доогуур стандартад байлгадаг байхад төгс болголт нь илүү өндөр стандартад байлгадаг. Төгс болгуулсан хүмүүс нь зөв

шударга хүмүүс, ариун болгуулсан хүмүүс юм; тэд бол хүн төрөлхтнийг удирдах ажлын биелэлт буюу эцсийн бүтээгдэхүүн билээ. Хэдийгээр тэд төгс хүмүүс биш ч утга учиртай амьдралаар амьдрахаар эрж хайдаг хүмүүс юм. Харин байлдан дагуулагдсан хүмүүс Бурханы оршин тогтнолыг үгээрээ л хүлээн зөвшөөрдөг; Бурхан бие махбодтой болж, Үг махбодоор илэрсэн, Бурхан шүүлт, гэсгээлтийн ажил хийхийн тулд газар дээр ирсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн тэд, Бурханы шүүлт болон гэсгээлт, цохилт болон цэвэршүүлэлт нь бүгд хүнд ашиг тустай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэд саяхнаас л бага зэрэг хүний төрхтэй болж эхэлсэн. Тэдэнд амьдралын талаарх зарим нэг ойлголт байдаг ч мөн л бүдэг бадаг хэвээр үлддэг. Өөрөөр хэлбэл, тэд хүн чанарыг л эзэмшиж эхэлж байгаа. Энэ нь байлдан дагуулагдахын үр нөлөө юм. Хүмүүс төгс болгуулах замд хөл тавих үед хуучин зан чанараа өөрчлөх чадвартай болдог. Түүнчлэн, тэдний амь өссөөр байдаг ба тэд аажмаар үнэнд илүү гүн гүнзгий ордог. Тэд дэлхий ертөнцийг үзэн ядаж, үнэнийг эрэлхийлдэггүй бүх хүнийг үзэн ядаж чаддаг. Тэд ялангуяа өөрсдийгөө үзэн яддаг, гэхдээ үүнээс ч илүүтэйгээр өөрсдийгөө тодорхой мэддэг. Тэгээд үнэнээр амьдрахыг хүсэж, үнэнийг эрэлхийлэхийг зорилгоо болгодог. Тэд уураг тархиныхаа бий болгосон бодол дотор амьдрахыг хүсдэггүй бөгөөд хүний өөрийгөө зөвтгөдөг байдал, онгироо, ихэрхүү занг жигшдэг. Тэд ёс зүйн өндөр мэдрэмжтэй ярьдаг, ялган таних чадвар, мэргэн ухаантайгаар аливааг зохицуулж, Бурханд үнэнч, дуулгавартай байдаг. Гэсгээлт, шүүлтийн тохиолдлыг туулбал тэд идэвхгүй, сул дорой болдоггүйгээр үл барам, Бурханы энэхүү гэсгээлт, шүүлтэд талархдаг. Бурханы шүүлт, гэсгээлтгүйгээр байж чадахгүй; энэ нь тэднийг хамгаалдаг гэж тэд итгэдэг. Тэд амар амгалан, баяр хөөр, өлсгөлөнгөө дарах талх эрж хайх итгэлийг эрэлхийлдэггүй. Түр зуурын махан биеийн зугаа цэнгэлийн араас ч хөөцөлддөггүй. Энэ нь төгс болгуулсан хүмүүст гардаг зүйл юм. Хүмүүс байлдан дагуулагдсанахаа дараа Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч тийнхүү хүлээн зөвшөөрсөн нь хязгаарлагдмал байдлаар тэднээс харагддаг. Үг нь махбодоор илэрсэн гэдэг нь үнэндээ юу гэсэн үг вэ? Бие махбодтой болох гэж юу гэсэн үг вэ? Бие махбодтой болсон Бурхан юу хийсэн бэ? Түүний ажлын зорилго, ач холбогдол юу вэ? Түүний маш их ажлыг туулж, махбод дахь Түүний үйл хэргийг туулсны дараа чи юу олж авсан бэ? Энэ бүх зүйлийг ойлгосны дараа л чи байлдан дагуулагдсан хүн болно. Хэрвээ чи, Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг гэж л хэлдэг боловч хаях учиртай зүйлийг хаядаггүй, орхих ёстой махан биеийн зугаа цэнгэлийг орхиж чаддаггүй, харин ч урьдынх шигээ махан

биеийн тав тухыг байнга улиглан хүсэж, ах эгч нарын эсрэг атгаг сэжгийг тавьж явуулж чаддаггүй, олон энгийн хэрэгжүүлэлтийг гүйцэтгэхдээ ямар ч төлөөс төлдөггүй бол хараахан байлдан дагуулагдаагүйг чинь тэр нь нотолдог. Тэр тохиолдолд, чи ихийг ойлгодог байлаа ч гэсэн, тэр бүхэн нь ямар ч хэрэггүй байх болно. Байлдан дагуулагдсан хүмүүс нь анхан шатны өөрчлөлт, анхан шатны оролтод хүрсэн хүмүүс юм. Бурханы шүүлт, гэсгээлтийг туулах нь хүмүүст Бурханы талаарх анхан шатны мэдлэг болон үнэний талаарх анхан шатны ойлголтыг өгдөг. Чи илүү гүн гүнзгий бодит байдал, илүү дэлгэрэнгүй үнэн рүү бүрэн орж чадахгүй байж болох боловч махан биеийн зугаа цэнгэл, эсвэл хувийн байр суурьтай чинь холбоотой олон энгийн үнэнийг бодит амьдралдаа хэрэгжүүлж чаддаг. Энэ бүхэн нь байлдан дагуулагдах үйл явцад хүмүүст гардаг үр нөлөө юм. Зан чанарын өөрчлөлтийг ч бас байлдан дагуулагдсан хүмүүсээс харж болно; жишээлбэл, тэдний хувцаслаж, биеэ авч явдаг байдал, амьдардаг байдал бүгд өөрчлөгдөж болно. Бурханд итгэх итгэлийн талаарх тэдний үзэл бодол өөрчлөгдөж, тэд өөрсдийн эрэл хайгуулын зорилгын талаар тодорхой мэдэж, илүү өндөр хүсэл эрмэлзэлтэй болдог. Байлдан дагуулалтын ажлын явцад тэдний амь зан чанарт ч бас холбогдох өөрчлөлт гардаг. Өөрчлөлт гардаг боловч тэдгээр нь өнгөцхөн, анхан шатных бөгөөд төгс болгуулсан хүмүүсийн зан чанар болон эрэл хайгуулын зорилго дахь өөрчлөлтөөс хавьгүй дор байдаг. Хэрвээ байлдан дагуулагдах явцад хүний зан чанар огтхон ч өөрчлөгддөггүй, тэрээр өчүүхэн төдий ч үнэнийг олж авдаггүй бол ийм хүн зүгээр л хог новш бөгөөд огт хэрэггүй! Байлдан дагуулагдаагүй хүмүүс төгс болгуулж чадахгүй! Хэрвээ хүн зөвхөн байлдан дагуулагдахыг л хичээвэл, байлдан дагуулалтын ажлын үеэр зан чанарт нь зарим нэг зохих өөрчлөлт харагддаг ч гэсэн тэрээр бүрэн төгс болгуулж чадахгүй. Тэр өөрийн олж авсан анхны үнэнийг ч бас алдана. Байлдан дагуулагдсан болон төгс болгуулсан хүмүүсийн зан чанарын өөрчлөлтөд үлэмж их ялгаа бий. Гэхдээ байлдан дагуулагдах нь өөрчлөлтийн эхний алхам мөн; энэ нь суурь билээ. Анхны энэ өөрчлөлт дутмаг байгаа нь, тухайн хүн Бурханыг үнэндээ огт мэддэггүй гэдгийн баталгаа юм, учир нь энэхүү мэдлэг шүүлтээс ирдэг бөгөөд ийм шүүлт нь байлдан дагуулалтын ажлын үндсэн хэсэг билээ. Иймээс төгс болгуулсан бүхэн эхлээд байлдан дагуулагдах ёстой; эс бөгөөс тэдний хувьд төгс болгуулах ямар ч аргагүй.

Чи бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрдөг, Үг махбодоор илэрснийг хүлээн зөвшөөрдөг гэж хэлдэг атлаа Түүний нүднээс далдуур зарим зүйлийг хийж, Түүний шаарддаг зүйлд харшилдаг зүйл хийдэг бөгөөд зүрх

сэтгэлдээ Түүнээс ер айдаггүй. Энэ нь Бурханыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг үү? Чи Түүний хэлдэг зүйлийг хүлээн зөвшөөрдөг боловч хийж чадах зүйлээ хэрэгжүүлдэггүй, Түүний замыг ч баримталдаггүй. Энэ нь Бурханыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг үү? Чи Түүнийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч Түүнийг хэзээ ч хүндэлдэггүй ба Түүнээс сэрэмжлэх л сэтгэлтэй байдаг. Түүний ажлыг харж, хүлээн зөвшөөрсөн бөгөөд Тэр бол Бурхан гэдгийг мэддэг хэрнээ хөндий хайнга, огт өөрчлөгдөхгүй хэвээр үлдвэл чи мөн л байлдан дагуулагдаагүй хүн юм. Байлдан дагуулагдсан хүмүүс чадах бүхнээ хийх ёстой бөгөөд илүү өндөр үнэнд орж чадахгүй, эдгээр үнэн нь тэдний хувьд хүршгүй хэдий ч ийм хүмүүс зүрх сэтгэлдээ үүнд хүрэхийг хүсдэг. Учир нь, тэдний хүлээн авч чадах зүйлд хязгаар байдаг ба хэрэгжүүлж чаддаг зүйл нь бас хэмжээ, хязгаартай байдаг. Гэхдээ тэд ядаж л чадах бүхнээ хийх ёстой бөгөөд хэрвээ чи эдгээр зүйлийг хийж чадвал энэ нь байлдан дагуулалтын ажлаас үүдэн гарсан үр нөлөө юм. “Хүний чадахгүй маш олон үгийг Тэр хэлсэн гэдгийг харвал хэрвээ Тэр Бурхан биш юм бол өөр хэн байх вэ?” гэж чи хэллээ гэж үзье. Ийм бодолтой байлаа гээд Бурханыг хүлээн зөвшөөрдөг гэсэн үг биш. Хэрвээ чи Бурханыг хүлээн зөвшөөрдөг бол бодит үйлдлээрээ харуулах ёстой. Чуулганыг удирдаж байгаа ч зөв шударга байдлыг хэрэгжүүлж чаддаггүй бол, мөнгө, эд хөрөнгөд шунаж, чуулганы санг өөртөө үргэлж халаасалдаг бол энэ нь Бурхан байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг мөн үү? Бурхан бол төгс хүчит бөгөөд хүндлэл хүртүүштэй. Хэрвээ чи Бурхан байдаг гэдгийг үнэхээр хүлээн зөвшөөрдөг бол яаж айхгүй байж чадах юм бэ? Чи тийм жигшүүртэй үйл хийх чадвартай бол Түүнийг үнэхээр хүлээн зөвшөөрдөг үү? Чи Бурханд итгэдэг гэж үү? Чиний итгэдэг зүйл чинь тодорхойгүй Бурхан; тиймээс чи айдаггүй! Бурханыг үнэхээр хүлээн зөвшөөрч, мэддэг хүмүүс бүгд Түүнээс айдаг ба Түүнийг эсэргүүцэх, эсвэл өөрсдийн мөс чанарыг зовоох зүйл хийхээс айдаг; тэд ялангуяа, Бурханы хүслийн эсрэг гэдгийг нь мэддэг юуг ч хийхээс айдаг. Үүнийг л Бурханы оршин тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаад тооцож болно. Эцэг эх чинь Бурханд итгэхийг чинь болиулахаар оролдох үед чи юу хийх ёстой вэ? Үл итгэгч нөхөр чинь чамд сайн хандаж байх үед чи Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Ах эгч нар чинь чамайг үзэн ядах үед Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Хэрвээ чи Түүнийг хүлээн зөвшөөрдөг бол энэ бүх хэрэг явдал дээр зохих ёсоор үйлдэж, бодит байдлыг амьдран харуулна. Хэрвээ чи бодитой үйлдэл хийж чадахгүй, харин зөвхөн Бурханы оршин тогтнолыг хүлээн зөвшөөрдөг гэж л хэлбэл зүгээр л хоосон яригч юм! Чи Түүнд итгэж, Түүнийг хүлээн зөвшөөрдөг гэж хэлдэг

боловч ямар байдлаар Түүнийг хүлээн зөвшөөрдөг вэ? Ямар байдлаар чи Түүнд итгэдэг вэ? Чи Түүнээс айдаг уу? Түүнийг хүндэлдэг үү? Сэтгэлийнхээ гүнд Түүнийг хайрладаг уу? Чи зовуурилж, түшиж тулах хэн ч үгүй байх үедээ Бурханы хайр татам байдлыг мэдэрдэг ч дараа нь энэ бүхнээ таг мартдаг. Тэр нь Бурханыг хайрлаж байгаа хэрэг биш, Бурханд итгэж байгаа ч хэрэг биш! Тэгвэл эцсийн эцэст хүн юунд хүрээсэй гэж Бурхан хүсдэг вэ? Өөрийгөө ихэд чухалчилж, юмыг хүлээн авч, ойлгохдоо хурдан гэж бодож, бусдыг хянаж, бусдыг дорд үзэж, харагдах байдлаар нь хүмүүсийг шүүж, гэм зэмгүй хүмүүсийг дээрэлхэж, чуулганы мөнгөнд шунах гэх мэт Миний дурдсан энэ бүх байдал буюу энэ бүх сатанлаг завхарсан зан чанарын нэг хэсгээс салах үед л байлдан дагуулагдсан чинь харагдана.

Байлдан дагуулалтын ажил хүмүүс та нар дээр хийгддэг нь хамгийн гүн гүнзгий ач холбогдолтой: Нэг талаар, энэхүү ажлын зорилго нь бүлэг хүмүүсийг төгс болгох явдал, өөрөөр хэлбэл, тэднийг төгс болгосноор тэд бүлэг ялагч—бүрэн төгс болгуулсан эхний бүлэг хүмүүс буюу анхны үр жимс болж болох юм. Нөгөө талаар, энэ нь бүтээгдсэн зүйлсэд Бурханы хайрыг эдлүүлж, Бурханы бүрэн дүүрэн, хамгийн агуу авралыг хүртээж, хүнд өршөөл, хайр энэрлийг л эдлүүлээд зогсохгүй үүнээс ч чухал нь гэсгээлт, шүүлтийг эдлүүлэхийн төлөө байдаг. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл Өөрийнхөө ажлаар Бурханы хийсэн бүхэн бол хүнийг огтхон ч үзэн ядаагүй хайр билээ. Чиний харсан гэсгээлт, шүүлт ч гэсэн бас хайр, илүү жинхэнэ, илүү бодитой хайр, хүмүүсийг хүний амьдралын зөв зам руу хөтөлдөг хайр юм. Өөр нэг талаар, энэ нь Сатаны өмнө гэрчлэл хийхийн төлөө юм. Дахиад нэг талаас бол, энэ нь ирээдүйн сайн мэдээний ажлыг түгээх суурийг тавихын төлөө байдаг. Түүний хийсэн бүх ажил нь хүмүүсийг хэвийн хүн шиг амьдруулахын тулд хүний амьдралын зөв зам руу хөтлөх зорилготой байсан, учир нь хүмүүс хэрхэн амьдрахаа мэддэггүй бөгөөд энэхүү удирдамжгүйгээр чи хоосон амьдралаар л амьдарна; амьдрал чинь үнэ цэнгүй, утга учиргүй байх ба чи хэвийн хүн байж огт чадахгүй. Энэ нь хүнийг байлдан дагуулахын хамгийн гүн гүнзгий ач холбогдол билээ. Та нар бүгд Моабын удам юм; та нар дээр байлдан дагуулалтын ажил хийх нь агуу аврал мөн. Та нар бүгд нүгэлт, завхай газар амьдардаг бөгөөд бүгд завхай, нүгэлтэй. Өнөөдөр та нар Бурханыг хараад зогсохгүй, бүр ч чухал нь гэсгээлт, шүүлтийг хүлээн авч, үнэхээр гүн гүнзгий авралыг хүртсэн, өөрөөр хэлбэл, Бурханы хамгийн агуу хайрыг хүлээн авсан. Өөрийн хийдэг бүхэндээ Бурхан та нарыг үнэхээр хайрладаг. Түүнд ямар ч муу санаа зорилго байхгүй. Та нарын нүглээс

болж л Тэр та нарыг шүүдэг, ингэснээр та нар өөрсдийгөө шинжилж, энэхүү үлэмж их авралыг хүлээн авна. Энэ бүхэн нь хүнийг бүрэн төгс болгох зорилгоор хийгддэг. Эхнээсээ эцсээ хүртэл Бурхан хүнийг аврахын тулд чадах бүхнээ хийсээр ирсэн бөгөөд Өөрийн бүтээсэн хүмүүсийг Өөрийн гараар бүрэн устгахыг хүсдэггүй. Өнөөдөр Тэр та нарын дунд ажиллахаар ирсэн; энэ нь бүр ч илүү их аврал биш гэж үү? Хэрвээ Тэр та нарыг үзсэн ядсан бол та нарыг биечлэн удирдахын тулд ийм их хэмжээний ажлыг мөн л хийх байсан уу? Яагаад Тэр ингэж зовох ёстой юм бэ? Бурхан та нарыг үзэн яддаггүй, эсвэл та нарын эсрэг муу санаа агуулдаггүй. Бурханы хайр бол хамгийн жинхэнэ хайр гэдгийг та нар мэдэх ёстой. Хүмүүс дуулгаваргүй учраас л Тэр шүүлтээр дамжуулан тэднийг аврах хэрэгтэй болсон; тэгэхгүй бол хүмүүсийг аврах боломжгүй байх байв. Та нар хэрхэн амьдрахыг мэддэггүй, бүр хэрхэн амьдрах талаар ч ойлгодоггүй учраас, мөн энэхүү завхай, нүгэлтэй газарт амьдардаг ба өөрсдөө завхай, бузар диаволууд учраас та нарыг бүр их доройтуулж Тэр тэвчдэггүй, одоогийнх шигээ энэхүү бохир бузар газарт амьдарч, Сатанд хүссэнээр нь гишгэлүүлэхийг чинь харж тэвчдэггүй, та нарыг Үхэгсдийн орон руу унагаж ч тэвчдэггүй. Тэрээр энэ бүлэг хүмүүсийг олж авч, та нарыг бүрэн аврахыг л хүсдэг. Энэ нь та нар дээр байлдан дагуулалтын ажлыг хийхийн үндсэн зорилго бөгөөд энэ нь гагцхүү авралын төлөө байдаг. Чам дээр хийгддэг бүхэн хайр, аврал юм гэдгийг хэрвээ чи харж чаддаггүй бол, хэрвээ чи энэ нь зүгээр л арга барил, хүнийг тарчлаах зам, итгэхийн аргагүй зүйл гэж боддог бол зовлон, бэрхшээл туулахын тулд өөрийнхөө ертөнц рүү буцсан нь дээр! Хэрвээ чи энэ урсгалд байж, энэ шүүлт, энэ энгүй авралыг эдэлж, хүний ертөнцийн хаанаас ч олдохгүй энэ бүх ерөөлийг эдэлж, энэ хайрыг эдлэхийг хүсэж байгаа бол сайн бай: Байлдан дагуулалтын ажлыг хүлээн авахын тулд энэ урсгалд бай, тэгвэл төгс болгуулж чадна. Өнөөдөр чи Бурханы шүүлтийн улмаас бага зэрэг зовлон шаналал, цэвэршүүлэлт туулж болох ч энэхүү зовлон шаналалд үнэ цэн, утга учир бий. Бурханы гэсгээлт, шүүлт хүмүүсийг цэвэршүүлж, хайр найргүй илчилдэг хэдий ч зорилго нь нүглийнх нь төлөө тэднийг шийтгэж, тэдний махан биеийг шийтгэхийн төлөө байдаг—энэ ажлын юу ч тэдний махан биеийг яллан сүйрүүлэхээр зорьдоггүй. Үгийн хатуу чанд илчлэлт нь бүгд чамайг зөв зам руу хөтлөх зорилготой. Та нар энэ ажлын маш ихийг биечлэн туулсан ба энэ нь та нарыг муу зам руу хөтлөөгүй нь тодорхой! Энэ бүхэн нь чамаар хэвийн хүн чанарыг амьдран харуулуулахын төлөө байдаг бөгөөд энэ бүхэнд хэвийн хүн чанараараа хүрэх боломжтой. Бурханы ажлын алхам бүр нь чиний хэрэгцээнд

үндэслэж, сул талын чинь дагуу, бодит биеийн хэмжээний чинь дагуу хийгддэг бөгөөд дааж давшгүй ямар ч ачааг та нарт өгдөггүй. Үүнийг чи одоо тодорхой мэддэггүй бөгөөд Би чамд хатуу хандаж байгаа мэт санагддаг, үнэндээ чамайг өдөр бүр гэсгээж, шүүж, зэмлэдгийн шалтгаан нь Би чамайг үзэн яддагаас болдог гэж чи үргэлж итгэдэг. Гэхдээ чиний амсдаг зүйл гэсгээлт, шүүлт мөн хэдий ч энэ нь үнэндээ чамайг гэх хайр, хамгийн агуу хамгаалалт билээ. Хэрвээ чи энэ ажлын илүү гүн гүнзгий утга учрыг ухаарч чадахгүй бол чиний хувьд үргэлжлүүлэн туулах боломжгүй болно. Энэхүү аврал чамд тайтгарал авчрах ёстой. Ойлгож ухамсарлахаас бүү татгалз. Өдий хүрсэн болохоор чи байлдан дагуулалтын ажлын ач холбогдлыг тодорхой ойлгосон байх ёстой бөгөөд энэ талаар янз бүрийн үзэл бодол өвөрлөх ёсгүй!

ЧИ ИРЭЭДҮЙН ҮҮРЭГТЭЭ ХЭРХЭН ХАНДАХ ЁСТОЙ ВЭ?

Чи эрин үеийн ач холбогдлыг зохистой дамжуулдаг хэлээр, эрин үе бүрд Бурханы илэрхийлсэн зан чанарыг бодитой байдлаар ярьж чадах уу? Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг туулдаг чи Бурханы зөвт зан чанарыг нарийвчлан дүрсэлж чадах уу? Чи Бурханы зан чанарыг тодорхой, нарийн зөв гэрчилж чадах уу? Чи зөв шударга байдлаар өлсөж, цангадаг, чамаар хариулуулахаар хүлээж байгаа өрөвдөлтэй, ядуу, чин сүсэгт шашны итгэгчдэд өөрийн үзсэн, туулсан зүйлийг хэрхэн дамжуулах вэ? Чамаар хариулуулах гээд ямар янзын хүмүүс чамайг хүлээж байгаа бол? Чи төсөөлж чадах уу? Мөрөн дээрх ачаа, даалгавар, үүрэг хариуцлагаа чи мэдэж байна уу? Түүхэн үүрэг хариуцлагын мэдрэмж чинь хаана байна вэ? Чи яаж дараагийн эрин үеийн эзэн болох вэ? Чамд эзэн хүний хүчтэй мэдрэмж бий юу? Бүх зүйлийн эзэн гэдгийг чи хэрхэн тайлбарлах вэ? Энэ нь үнэхээр дэлхий дээрх бүх амьд амьтан болон бүх зүйлийн эзэн үү? Ажлын дараагийн үе шат руу урагшлах ямар төлөвлөгөө чамд байна вэ? Чамайг хоньчноо болгохоор хэдэн хүн хүлээж байгаа вэ? Чиний даалгавар хүнд үү? Тэд ядуу, өрөвдөлтэй, сохор, аргаа барсан бөгөөд харанхуйд уйлж байна—зам хаана байна вэ? Харвах од мэт гэрэл гэнэт бууж, хүнийг маш олон жилийн турш дарангуйлсан харанхуйн хүчийг сарниулахыг тэд ямар их хүлээдэг билээ. Тэд ямар их дэнслэн найдаж, үүнийг өдөр шөнөгүй мөрөөдөж байгааг хэн мэдэх юм бэ? Гүнээ зовж буй энэ хүмүүс гэрэл гарах өдөр ч гэсэн суллагдах итгэл найдваргүйгээр харанхуй гянданд хоригдсоор байдаг;

тэд хэзээ гашуудан уйлахаа болих вэ? Амар заяа үзээгүй энэ сул дорой сүнснүүдийн золгүй явдал аймшигтай бөгөөд өршөөлгүй хүлээс болон цэвдэг түүх тэднийг аль хэдийн ийм байдалтай болгон хүлсэн. Тэдний гашуудан уйлах чимээг хэн сонссон бэ? Гунигтай царайг нь хэн харсан бэ? Бурханы зүрх сэтгэл хэчнээн гашуудаж, түгшиж байдгийг чи ер нь бодож үзэж байсан уу? Өөрийн гараар бүтээсэн гэмгүй хүн төрөлхтөн нь ийм тарчлаан амсаж байгааг Тэр яаж тэвчиж чадах юм бэ? Эцсийн эцэст, хүн төрөлхтөн бол хордсон хохирогчид. Хэдийгээр хүн өнөөг хүртэл золоор амьд үлдсэн ч гэсэн хүн төрөлхтнийг муу ёрын нэгэн аль хэдийн хордуулсан гэдгийг хэн мэдэх билээ? Чи хохирогчдын нэг гэдгээ мартчихсан уу? Бурханыг гэх хайраасаа болоод чи амьд үлдсэн энэ хүмүүсийг аврахаар чармайхыг хүсэхгүй байна уу? Хүн төрөлхтнийг Өөрийн мах цус шигээ хайрладаг Бурханы ачийг хариулахын тулд хамаг эрч хүчээ зориулахыг хүсэхгүй байна уу? Эцсийн эцэст Бурханаар ашиглуулан энэхүү ер бусын амьдралаар амьдрахыг чи хэрхэн тайлбарлах вэ? Чамд сүсэг бишрэлтэй, Бурханд үйлчилдэг хүний утга учиртай амьдралаар амьдрах шийдвэр болон итгэл үнэхээр байна уу?

ЕРӨӨЛҮҮДИЙГ ТА НАР ЮУ ГЭЖ ОЙЛГОДОГ ВЭ?

Энэхүү эринд төрсөн хүмүүсийг Сатан болон бузар чөтгөрүүд завхруулсан хэдий ч ийм завхрал тэдэнд бас дээд зэргийн аврал авчирсан бөгөөд энэ аврал нь уул талыг бүрхсэн Иовын мал хуй, хэмжээлшгүй их эд хөрөнгөөс ч агуу төдийгүй шалгалтынхаа дараа Иовын хүлээн авсан Еховаг нүдээр харах ерөөлөөс ч илүү агуу билээ. Иов үхлийн шалгалтыг туулсныхаа дараа л Еховагийн ярихыг сонсож, хуй салхин дундаас Еховагийн хоолойг сонссон. Гэсэн ч тэрээр Еховагийн царайг хараагүй, Түүний зан чанарыг мэдээгүй. Иов ердөө махан биеийг таашаалаар хангадаг материаллаг эд хөрөнгө, ойр тойрны бүх хотын доторх хамгийн хөөрхөн хүүхдүүд болон тэнгэрийн тэнгэрэлчүүдийн хамгаалалтыг л олж авсан. Тэрээр Еховаг хэзээ ч хараагүй бөгөөд зөв шударга гэж нэрлэгдсэн хэдий ч Еховагийн зан чанарыг хэзээ ч мэдээгүй юм. Өнөөгийн хүмүүсийн материаллаг таашаал түр зуур хомсхон, гаднын ертөнцийн орчин нь дайсагнасан байдалтай байдаг гэж хэлж болох ч эрт дээр үеэс хүнд хэзээ ч илчлээгүй, үргэлж нууц байсаар ирсэн зан чанараа болон амбасын үеийн нууцаа Би, бүхнээс дорд боловч Өөрийн хамгийн агуу авралыг өгсөн хүмүүст илчилсэн. Түүнчлэн Би анх удаа эдгээр зүйлийг илчилсэн юм; Би ийм ажил урьд

нь хэзээ ч хийж байгаагүй. Хэдий та нар Иовоос хамаагүй дорд боловч та нарын олж авсан, харсан зүйл түүнийхээс хол давсан. Та нар элдэв янзын зовлон туулж, янз бүрийн тарчлаан амссан хэдий ч тэр зовлон Иовын шалгалттай огтхон ч адилгүй; харин энэ нь өөрсдийн тэрслүү байдал, эсэргүүцэл болон Миний зөвт зан чанараас болж хүмүүсийн хүлээн авсан шүүлт, гэсгээлт юм; энэ бол зөвт шүүлт, гэсгээлт, хараал билээ. Нөгөө талаар, Иов нь Еховагийн агуу хайр, энэрлийг хүлээн авсан израильчуудын дундах зөв шударга хүмүүсийн нэг байв. Тэр ямар ч ёрын муу үйл үйлдээгүй, Еховаг эсэргүүцээгүй; харин ч Еховад итгэлтэйгээр үнэнч байлаа. Тэрээр зөв шударга байдлынхаа улмаас шалгалтуудад өртсөн ба Еховагийн итгэлт зарц байсан учраас ширүүн догшин шалгалтуудыг туулсан. Өнөөгийн хүмүүс бузар, зөв шударга бус байдлаасаа болж Миний шүүлт, хараалыг амсдаг. Иов мал хуй, эд хөрөнгө, зарц нар, үр хүүхэд, эрхэм нандин бүхнээ алдах үедээ амссан зовлонтой тэдний зовлон огт адилгүй хэдий ч тэд догшин ширүүн цэвэршүүлэлт, шатаалтыг амсдаг. Иовын туулснаас илүү ноцтой нь гэвэл, хүмүүс сул дорой байдгаас болж ийм шалгалтыг багасгах юм уу арилгадаггүй; харин энэ нь удаан явагдаж, тэдний амьдралын сүүлчийн өдрийг хүртэл үргэлжилнэ. Энэ бол шийтгэл, шүүлт, хараал юм; энэ нь өршөөлгүй шатаалт, үүнээс ч илүүтэйгээр хүн төрөлхтний зүй ёсны “өв залгамжлал” мөн. Энэ бол хүмүүсийн хүртэх учиртай зүйл бөгөөд энд Миний зөвт зан чанар илэрхийлэгддэг. Энэ бол мэдээжийн үнэн. Гэхдээ хүмүүсийн олж авсан зүйл одоо туулж буй зовлонгоос нь асар их давдаг. Та нарын туулдаг зовлон бол ердөө л мунхаг байдлаас чинь үүдсэн бүтэлгүйтэл, харин та нарын олж авдаг зүйл зовлонгоос чинь зуу дахин их билээ. Хуучин Гэрээн дэх Израилийн хуулийн дагуу бол, Намайг эсэргүүцдэг бүхэн, Намайг ил тод шүүдэг бүхэн, Миний замыг дагахын оронд Надад бузар тахилыг зоригтой өргөдөг бүхэн сүм дэх галаар гарцаагүй устгагдана, эсвэл сонгогдсон хүмүүсийн зарим нь тэднийг чулуугаар цохиж хөнөөнө, тэдний өөрсдийн овгийн үр удам төдийгүй бусад садан төрөл нь ч Миний хараалыг амсана. Ирэх амьдралдаа тэд эс чөлөөлөгдөж, Миний боолуудын боол болно, Би тэднийг харь үндэстнүүдийн дунд цөлж, тэд эх нутагтаа эргэн ирж чадахгүй байх болно. Тэдний үйлдэл, зан авирт үндэслэвэл, өнөөгийн хүмүүсийн туулсан зовлон израильчуудын амссан шийтгэл шиг төдийлөн ноцтой биш. Одоо амсаж буй зүйл чинь залхаан цээрлүүлэлт юм гэж хэлдэг нь үндэслэлгүй биш, учир нь та нар үнэхээр хэрээс хэтэрсэн. Хэрвээ та нар Израильд байсан бол мөнхийн нүгэлтнүүдийн нэг болоод, аль хэдийн израильчуудаар хэдэн хэсэг тасчуулж,

Еховагийн сүмд тэнгэрээс буух галд шатах байсан. Тэгвэл одоо та нар юу олж авсан юм бэ? Та нар юу хүлээн авч, юу эдэлсэн юм бэ? Би та нарт Өөрийн зөвт зан чанарыг илчилсэн ч хамгийн чухал нь хүн төрөлхтнийг золин аврахын төлөөх тэвчээрээ илчилсэн. Та нарт хийсэн бүхэн минь тэвчээрийн ажил юм; энэ нь Миний удирдлагын төлөө, түүнчлэн хүн төрөлхтний зугаа цэнгэлийн төлөө хийгддэг гэж хэлж болно.

Хэдийгээр Иов Еховагийн шалгалтыг туулсан ч тэр ердөө л Еховад шүтэн мөргөдөг зөв шударга хүн байсан юм. Тэдгээр шалгалтыг туулж байхдаа ч тэр Еховагийн талаар гомдоллоогүй, харин Түүнтэй учирснаа эрхэмлэн нандигнажээ. Өнөөгийн хүмүүс Еховагийн байгааг эрхэмлэдэггүйгээр үл барам, Түүний илрэлтийг голж, жигшиж, гомдоллож, доромжилдог. Та нар илүү ихийг олж авсан биш үү? Та нарын зовлон үнэхээр тийм их байсан гэж үү? Та нар Мариа, Иаков нараас илүү золтой байсан бус уу? Та нарын эсэргүүцэл үнэхээр тийм өчүүхэн байсан гэж үү? Миний та нараас шаардсан зүйл, Миний та нараас хүссэн зүйл дэндүү их, хэтэрхий олон байсан гэж үү? Миний уур хилэн шууд та нар дээр биш, Намайг эсэргүүцсэн израильчуудын дээр л буусан; та нарын олж авсан зүйл ердөө Миний өршөөлгүй шүүлт, илчлэл, мөн хайр найргүй догшин ширүүн цэвэршүүлэлт байсан. Тэгсэн хэр нь хүмүүс өчүүхэн төдий ч дуулгаваргүйгээр Намайг эсэргүүцэж, няцаасаар байдаг. Бүр Надаас өөрсдийгөө холдуулж, Намайг үгүйсгэдэг хүмүүс ч бий; тийм хүмүүс бол Мосег эсэргүүцсэн Кора, Датан нарын бүлэглэлээс дээрдэх юмгүй. Хүмүүсийн зүрх сэтгэл хэтэрхий хатуу цэвдэг, уг чанар нь дэндүү гэжүүд. Тэд хуучин арга замаа хэзээ ч өөрчилдөггүй. Тэд өдрийн хурц гэрэлд янхан мэт ил болсон гэж Би хэлдэг бөгөөд Миний үг “сонсоход ч эвгүй” байх хэмжээний хатуу байж, хүмүүсийн уг чанарыг ив ил болгодог—гэсэн ч тэд ердөө толгой дохин, хэдхэн нулимс унагаж, өөрсдийгөө хүчлэн багахан гунигладаг. Энэ бүхэн дуусмагц тэд уулын зэрлэг араатнуудын хаан мэт догширдог ба өчүүхэн төдий ч мэдрэмжгүй байдаг. Ийм зан чанартай хүмүүс Иовоос зуу дахин илүү зол завшаантай гэдгээ яаж мэдэх юм бэ? Эрин үеүдийн туршид бараг үзэгдээгүй, урьд нь хэний ч эдлээгүй ерөөлүүдийг эдэлж байгаагаа тэд яаж ухаарч чадах юм бэ? Шийтгэл агуулдаг ийм ерөөлүүдийг хүмүүсийн мөс чанар яаж мэдэрч чадах юм бэ? Шуудхан хэлэхэд, Миний ажлын үлгэр жишээ болж, Миний бүхий л зан чанар, бүх үйлдлийг гэрчилж чаддаг байж, Сатаны зовлон шаналлаас чөлөөлөгдөхийг л Би та нараас шаарддаг. Гэхдээ хүмүүс үргэлж Миний ажилд эгдүүцдэг бөгөөд үүнд зориуд дайсагнадаг. Ийм хүмүүс Израилийн хуулийг эргүүлэн авчирч, Израильд

гаргасан уур хилэнгээ тэдэн дээр буулгахад Намайг турхирахгүй байж яаж чадах юм бэ? Хэдийгээр та нарын дунд Надад “дуулгавартай, хүлцэнгүй” хүн олон байгаа ч Корагийн бүлгийн адил хүмүүс бүр ч олон бий. Би бүрэн алдар суугаа олж авмагцаа тэнгэрийн галыг ашиглан тэднийг үнс чандруу болтол шатаана. Би хүмүүсийг үгээрээ гэсгээхээ болино; харин Израилийн ажлыг хийхээсээ өмнө Би Намайг эсэргүүцсэн, аль эрт Надаар таягдан хаягдсан “Корагийн бүлгийг” бүрмөсөн шатаана гэдгийг та нар мэдэх ёстой. Намайг таашаах боломж хүн төрөлхтөнд дахиж олдохгүй; харин тэд Миний уур хилэн, тэнгэрээс буух галыг л харна. Би бүх төрлийн хүмүүсийн янз бүрийн төгсгөлийг илчилж, тэднийг бүгдийг нь ангилан хуваана. Би тэрслүү үйл бүрийг нь анхааралдаа аваад Өөрийн ажлыг дуусгана, ингэснээр хүмүүсийн төгсгөл нь газар дээр байх үеийн Миний тогтоол, мөн түүнчлэн Надад хандах тэдний хандлагад үндэслэн шийдэгдэнэ. Тэр цаг ирэх үед тэдний төгсгөлийг өөрчилж чадах зүйл үгүй байх болно. Хүмүүс өөрсдийн төгсгөлийг илчлэг! Тэгээд Би хүмүүсийн төгсгөлийг тэнгэрлэг Эцэгт гардуулан өгнө!

БУРХАНЫ ТУХАЙ ЧИНИЙ ОЙЛГОЛТ ЮУ ВЭ?

Хүмүүс удаан хугацаанд Бурханд итгэсэн боловч тэдний ихэнх нь “Бурхан” гэдэг үгийг ойлгодоггүй, зүгээр л мунгинан дагадаг. Яагаад хүн чухам Бурханд итгэх ёстойг, эсвэл Бурхан чухам юу болох талаар тэдэнд ямар ч таамаг байдаггүй. Хэрвээ хүмүүс зөвхөн Бурханд итгэж, дагахаа мэддэг боловч Бурхан юу болохыг мэддэггүй, мөн Бурханыг таньдаггүй бол энэ нь асар том хошигнол биш гэж үү? Хүмүүс өдий хүрчхээд тэнгэрийн олон нууцыг нүдээр харж, хүний урьд өмнө хэзээ ч ойлгож байгаагүй гүн гүнзгий мэдлэгийн тухай ихээхэн сонссон ч гэсэн хүний хэзээ ч тунгаан бодож үзээгүй хамгийн энгийн үнэний талаар мэддэггүй. Зарим хүн: “Бид олон жил Бурханд итгэсэн. Бурхан юу болохыг бид яаж мэдэхгүй байх юм бэ? Энэ чинь биднийг дорд үзэж байгаа хэрэг биш гэж үү?” хэмээж болох юм. Гэвч бодит байдал дээр бол хэдийгээр өнөөдөр хүмүүс Намайг дагаж байгаа ч өнөөгийн ажлын талаар юу ч мэддэггүй бөгөөд Бурханы тухай нарийн төвөгтэй асуултуудыг бүү хэл, хамгийн илэрхий, хамгийн амархан асуултуудыг ч ухаарч чаддаггүй. Чиний үл тоомсорлодог, мэдэж чаддаггүй тэр бүх асуулт бол ойлгох хэрэгтэй хамгийн чухал асуулт гэдгийг мэдэх хэрэгтэй, учир нь чи зөвхөн олон нийтийг даган, өөрийгөө юугаар зэвсэглэх ёстой вэ гэдэгт ямар ч анхаарал хандуулдаггүй, мөн санаа тавьдаггүй.

Яагаад Бурханд итгэх ёстойгоо чи үнэхээр мэддэг үү? Бурхан юу болохыг үнэхээр мэддэг үү? Хүн гэж юу болохыг үнэхээр мэддэг үү? Бурханд итгэдэг хүний хувьд, хэрвээ чи эдгээр зүйлийг ойлгож чадахгүй бол Бурханд итгэгчийн нэр хүндийг алдахгүй гэж үү? Өнөөдрийн Миний ажил бол хүмүүст мөн чанарыг нь ойлгуулж, Өөрийнхөө бүх үйл хэргийг ойлгуулж, Бурханы жинхэнэ нүүр царайг мэдүүлэх явдал юм. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний төгсгөл, Миний ажлын сүүлчийн үе шат билээ. Тийм учраас Би та нарт амьдралын бүх нууцыг урьдчилан хэлж байна, ингэснээр та бүгд тэдгээрийг Надаас хүлээж авч чадах юм. Та нар хэтэрхий их дутагдалтай, хэтэрхий багыг эзэмшдэг учраас хүлээн авч чадахгүй, дааж чадахгүй байсан ч гэсэн энэ нь эцсийн эрин үеийн ажил учраас урьд нь та нарын хэзээ ч хүлээн авч байгаагүй амийн бүх үнэнийг Би та нарт хэлэх ёстой. Харанхуй нөмрөх үед та нар замаасаа дахин гажаад, ёрын муу нэгний явуулгад автах вий гэсэндээ Би Өөрийн ажлыг дуусгаж, хийх учиртай ажлаа гүйцэлдүүлж, юу хийхийг даалгаж буйгаа та нарт бүрэн мэдэгдэхийг хүсдэг. Та нарын ойлгодоггүй олон зам, мэддэггүй олон асуудал бий. Та нар тун мэдлэггүй; Би та нарын биеийн хэмжээ болон дутагдлыг сайн мэднэ. Тиймээс, хэдийгээр та нарын ойлгож чадахгүй олон үг байдаг ч урьд нь та нарын хэзээ ч хүлээн авч байгаагүй энэ бүх үнэнийг Би та нарт бас л хэлмээр байна, учир нь одоогийн биеийн хэмжээгээрээ Миний төлөө гэрчлэлд зогсож чадах эсэхэд чинь Би санаа зовсоор байдаг. Би та нарыг дорд үзэж байгаа юм биш; та нар бүгдээрээ Миний албан ёсны сургалтыг хараахан туулаагүй адгууснууд бөгөөд та нарын дотор хэр их алдар байгааг Би яавч харж чадахгүй. Хэдийгээр Би та нар дээр ажиллахдаа асар их эрч хүч зарцуулсан боловч та нарт идэвхтэй хүчин зүйл бараг байхгүй мөртөө сөрөг хүчин зүйл хуруу дарам цөөн байдаг ба Сатанд шившиг авчирдаг гэрчлэл л болдог мэт санагддаг. Та нарт байгаа бусад зүйл бараг бүгдээрээ Сатаны хор. Та нар Надад аврагдахын аргагүй мэт харагддаг. Одоогийн нөхцөл байдалд Би та нарын янз бүрийн илэрхийлэл, биеэ авч явах байдлыг хардаг, тэгээд эцэст нь жинхэнэ биеийн хэмжээг чинь мэддэг. Тийм учраас Би та нарын төлөө санаа зовсоор байна: Өөрөө амьдралаа мэдэг гээд орхисон бол хүмүүс өнөөдрийнхөөсөө дээр байх байсан уу, эсвэл өнөөдрийнхтэй адилхан байх байсан уу? Та нар нялхамсуу биеийн хэмжээндээ сэтгэл зовохгүй байна уу? Та нар үнэхээр Израилийн сонгогдсон хүмүүс шиг байж, цаг үргэлж ганцхан Надад үнэнч байж чадах уу? Та нарын харуулдаг зүйл чинь эцэг эхээсээ төөрсөн хүүхдүүдийн дүрсгүйтдэг зан биш, харин эзнийхээ ташуураас хол байгаа амьтдаас гардаг зэрлэг догшин

байдал юм. Та нарт бас бүгдэд нь байдаг сул тал, та нарын нийтлэг эмгэг болох уг чанараа та нар мэдэх ёстой. Тиймээс өнөөдөр Би та нараас Миний төлөөх гэрчлэлдээ бат зогсохыг л шаарддаг. Ямар ч нөхцөлд хуучин эмгэгээ дахин бүү сэдрээ. Хамгийн чухал зүйл бол гэрчлэл хийх явдал юм—энэ нь Миний ажлын гол цөм билээ. Зүүдэнд нь ирсэн Еховагийн илчлэлийг Мариа хүлээн зөвшөөрч, итгээд дуулгавартай дагасантай адилаар та нар Миний үгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Зөвхөн энэ нь л ариун явдал гэж тооцогддог. Та нар Миний үгийг хамгийн их сонсдог хүмүүс учраас Надаар хамгийн их ерөөгдсөн хүмүүс юм. Би үнэ цэнтэй бүх эзэмшлээ та нарт өгч, та нарт бүхнийг хайрласан атал байр суурь чинь Израилийн ард түмнийхээс асар өөр; эгээ л тэнгэр газар мэт ялгаатай байдаг. Гэсэн ч тэдэнтэй харьцуулахад та нар хамаагүй илүү ихийг хүлээн авсан; тэд Миний илрэлтийг цөхрөн хүлээж байхад та нар Надтай хамт таатай өдрүүдийг өнгөрөөн, Миний баялгийг эдэлдэг. Ийм ялгаатай байж та нар хашхирч, Надтай маргалдаж, эд хөрөнгө булаалдах ямар эрхтэй юм бэ? Та нар ихийг олж авсан бус уу? Би та нарт маш ихийг өгсөн боловч хариуд нь Надад өгч байгаа зүйл чинь зүрх шимшрүүлсэн уй гашуу, зовнил болон номхоршгүй эгдүүцэл, дургүйцэл байдаг. Та нар маш зэвүүн атлаа бас өрөвдөлтэй тул Өөрийн бүх дургүйцлийг дарж, та нарт ахин дахин эсэргүүцлээ илэрхийлэхээс өөр сонголт Надад байхгүй. Ажлын энэ хэдэн мянган жилийн туршид Би хүн төрөлхтөнд хэзээ ч эсэргүүцэл үзүүлээгүй, учир нь хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд та нарын дундах “заль мэх” л хамгийн их алдаршсан гэдгийг Би олж мэдсэн, тэр нь эртний алдарт өвөг дээдсийн чинь та нарт үлдээсэн нандин өв хөрөнгөтэй адил мэт байдаг. Хүнээс дор тэр гахай, нохойнуудыг Би хэчнээн их үзэн яддаг гээч. Та нар хэтэрхий мөс чанаргүй! Та нар хэтэрхий жудаггүй! Та нарын зүрх сэтгэл хэтэрхий хатуу! Хэрвээ Би ийм үг болон ажлыг израильчуудад аваачсан бол аль хэдийн алдрыг олж авах байлаа. Гэвч та нарын дунд бол энэ нь хүршгүй; та нарын дунд зөвхөн харгис хайнга байдал, үл тоомсорлол болон та нарын шалтаг л байдаг. Та нар дэндүү мэдрэмжгүй, даанч үнэ цэнгүй!

Та нар өөртөө байгаа бүхнийг Миний ажлын төлөө зориулах ёстой. Надад ашиг тустай ажил хийх ёстой. Ойлгодоггүй бүхнийг чинь Би та нарт тайлбарлахыг хүсэж байна, ингэвэл та нар өөрсдөдөө дутагдаж байгаа бүхнийг Надаас олж авч чадна. Хэдий та нарын дутагдал тоолоход хэтэрхий олон боловч Би та нар дээр хийх ёстой ажлыг үргэлжлүүлэн хийж, та нарт сүүлчийн өршөөлөө хайрлахыг хүсэж байна, ингэснээр та нар Надаас ашиг тус хүртэж, та нарт байхгүй, мөн дэлхий дээр хэзээ ч харагдаж байгаагүй алдрыг олж авч

болох юм. Би маш олон жил ажилласан боловч хэн ч, хэзээ ч Намайг мэдээгүй. Би өөр хэнд ч, хэзээ ч хэлээгүй нууцуудаа та нарт хэлэхийг хүсэж байна.

Хүмүүсийн дунд бол Би тэдний харж чадахгүй Сүнс, тэдний хэзээ ч харилцаж чадахгүй Сүнс байлаа. Газар дээрх ажлынхаа гурван үе шатнаас (дэлхий ертөнцийн бүтээл, золин аврал, сүйрэл) үүдэн Би хүмүүсийн дунд ажлаа хийхээр өөр өөр цаг үед (хэзээ ч илэрхий бишээр) тэдний дунд гарч ирдэг. Анх удаа хүмүүсийн дунд ирсэн минь Золин авралын эрин үед байсан. Мэдээж, Би иудей гэр бүлд ирсэн; тийм болохоор газар дээр ирсэн Бурханыг эхлээд харах хүмүүс нь иудейчүүд байв. Би энэ үе шатны ажлыг биечлэн хийсэн шалтгаан нь Өөрийн махбод болсон биеийг золин авралын ажилдаа нүглийн тахил болгон ашиглахыг хүссэн юм. Тиймээс Намайг эхлээд харах хүмүүс нь Нигүүлслийн эрин үеийн иудейчүүд байлаа. Энэ бол эхний удаа махбодоор ажилласан минь юм. Хаанчлалын эрин үед Миний ажил байлдан дагуулж, төгс болгохын төлөө байдаг учраас Би хариулах ажлаа дахин махбодоор хийдэг. Энэ бол хоёр дахь удаа махбодод ажиллаж байгаа минь юм. Ажлын сүүлчийн хоёр үе шатанд хүмүүсийн харилцдаг зүйл харагдашгүй, хүршгүй Сүнс биш, харин Сүнс махбодод биеллээ олсон хүн билээ. Тиймээс хүний нүдээр бол Би дахиад Бурханы ямар ч гадаад төрх, мэдрэмжгүй хүн болсон. Түүнчлэн, хүмүүсийн хардаг Бурхан зөвхөн эрэгтэй ч биш, бас эмэгтэй бөгөөд энэ нь хүмүүст хамгийн гайхмаар, адармаатай байдаг. Миний ер бусын ажил олон олон жилийн турш хадгалагдсан хуучин итгэл үнэмшлийг ахин дахин нураасан. Хүмүүс мэл гайхдаг! Бурхан ердөө Ариун Сүнс, Сүнс, долоо дахин эрчимжсэн Сүнс, бүхнийг хамарсан Сүнс төдийгүй, мөн хүн—жирийн хүн, туйлын эгэл хүн юм. Тэр бол зөвхөн эрэгтэй ч биш, бас эмэгтэй. Тэд хоёулаа хүнээс төрсөн гэдгээрээ адилхан бөгөөд нэг нь Ариун Сүнснээс олдсон, нөгөө нь хүнээс төрсөн боловч Сүнснээс шууд гарсан гэдгээрээ адилгүй. Хоёулаа Бурханы махбод болох Тэд Эцэг Бурханы ажлыг гүйцэтгэдгээрээ адилхан бөгөөд нэг нь золин авралын ажил хийдэг, нөгөө нь байлдан дагуулалтын ажил хийдэг гэдгээрээ адилгүй. Хоёулаа Эцэг Бурханыг төлөөлдөг боловч нэг нь өгөөмөр сэтгэл, өршөөлөөр дүүрэн Золин Аврагч, харин нөгөө нь уур хилэн, шүүлтээр дүүрэн зөвт байдлын Бурхан билээ. Нэг нь золин авралын ажлыг эхлүүлдэг Дээд Командлагч, харин нөгөө нь байлдан дагуулах ажлыг гүйцэтгэдэг зөвт Бурхан юм. Нэг нь Эхлэл, нөгөө нь Төгсгөл. Нэг нь нүгэлгүй махбод, нөгөө нь золин авралыг гүйцээж, ажлыг үргэлжлүүлдэг махбод бөгөөд хэзээ ч нүгэлгүй. Хоёулаа нэг Сүнс, гэвч Тэд өөр өөр махбодод оршдог ба өөр өөр газарт төрсөн. Мөн Тэд хэдэн мянган

жилээр тусгаарлагдсан. Тэгсэн хэр нь Тэдний бүх ажил харилцан нэгийгээ нөхдөг, хэзээ ч зөрчилддөггүй бөгөөд эн зэрэгцүүлэн ярьж болно. Хоёулаа хүн, гэхдээ нэг нь нялх хүү, харин нөгөө нь нярай охин. Энэ олон жилд хүмүүсийн харсан зүйл зөвхөн Сүнс, зөвхөн хүн, эрэгтэй хүн төдийгүй, бас хүний үзэлтэй нийцэхгүй олон зүйл байсан тул хүмүүс Намайг хэзээ ч бүрэн ойлгож чаддаггүй. Би оршин байдаг хэр нь хий хоосон мөрөөдөл мэт тэд Надад хагас итгэж, хагас эргэлзсээр байдаг, тийм учраас энэ өдрийг хүртэл хүмүүс Бурхан юу болохыг бас л мэдэхгүй хэвээр байгаа юм. Чи Намайг ганц энгийн өгүүлбэрээр товч дүгнэж үнэхээр чадах уу? Чи “Есүс бол Бурхан, Бурхан бол Есүс” гэж хэлж үнэхээр зүрхлэх үү? “Бурхан бол Сүнс, Сүнс бол Бурхан” гэж хэлэх зориг чамд үнэхээр бий юү? “Бурхан бол ердөө махбодоор хувцасласан хүн” гэж чи хэлж зүрхлэх үү? “Есүсийн дүр бол Бурханы агуу дүр мөн” гэж чи үнэхээр хэлж зүрхлэх үү? Чи Бурханы зан чанар болон дүрийг хэл ярианы чадвараараа нэгд нэггүй тайлбарлаж чадах уу? Чи “Бурхан эмэгтэй хүнийг биш, зөвхөн эрэгтэй хүнийг Өөрийн дүрээр бүтээсэн” гэж хэлж үнэхээр зүрхлэх үү? Хэрвээ чи ингэж хэлбэл Миний сонгосон хүмүүс дотор ямар ч эмэгтэй хүн байхгүй байх байсан бөгөөд хүн төрөлхтний дотор эмэгтэй хүний төрөл гэж бүр ч байхгүй байх байв. Одоо чи Бурхан юу болохыг үнэхээр мэдэх үү? Бурхан хүн үү? Бурхан Сүнс үү? Бурхан үнэхээр эрэгтэй юү? Миний хийхийг хүсдэг ажлыг зөвхөн Есүс гүйцэлдүүлж чадах уу? Хэрвээ чи Миний мөн чанарыг товчхон дүгнэхийн тулд дээр хэлснээс зөвхөн нэгийг нь л сонгох юм бол чи хэтэрхий мэдлэггүй үнэнч итгэгч юм. Хэрвээ Би ердөө ганцхан л удаа махбод болсон биеэр ажилласан бол та нар Намайг тодорхойлох байсан уу? Чи ганц хяламхийж хараад л Намайг нэвт шувт мэдэж үнэхээр чадах уу? Амьдралынхаа туршид үзэж амссан бүхнийхээ дүнд чи Намайг үнэхээр бүрэн дүүрэн дүгнэж чадах уу? Хэрвээ хоёр удаа бие махбодтой болохдоо Би адилхан ажил хийсэн бол та нар Надад хэрхэн хандах байсан бэ? Та нар Намайг загалмайд үүрд цовдлон орхих байсан уу? Бурхан чиний хэлдэг шиг тийм энгийн юм гэж үү?

Хэдийгээр та нарын итгэл маш чин сэтгэлийн боловч та нарын дундаас хэн нь ч Намайг бүрэн тайлбарлаж чадахгүй, хэн нь ч өөрсдийн хардаг бүх баримтыг бүрэн гэрчилж чадахгүй. Энэ талаар бодоод үз: Өнөөдөр та нарын ихэнх нь үүргээ хөсөр хаяад оронд нь махан биеийн араас хөөцөлдөж, махан биеийг ханган, махан биеийн ташаалд шунадаг. Та нар өчүүхэн үнэнийг эзэмшдэг. Тэгэхээр харсан бүхнээ гэрчилж яаж чадах юм бэ? Та нар Миний гэрчлэгчид байж чадна гэдэгтээ үнэхээр итгэлтэй байна уу? Хэрвээ нэг л өдөр чи

өнөөдрийн харсан бүхнээ гэрчилж чадахгүй бол бүтээгдсэн зүйлийн чиг үүргээ алдсан байх болно, мөн чиний оршин тогтнол ямар ч утга учиргүй байна. Чи хүн байх үнэ цэнгүй байх болно. Чи хүн биш байх болно гэж хэлж ч болох юм! Би та нар дээр хэмжээлшгүй их ажил хийсэн, гэвч одоогоор чи юу ч сурахгүй, юу ч мэдэхгүй, үр ашиггүй ажиллаж байгаа учраас ажлаа өргөжүүлэх цаг минь ирэхэд чи бүлх залгисан мэт гөлрөн ширтэж, ямар ч нэмэргүй байх болно. Тэр нь чамайг бүх цаг үеийн нүгэлтэн болгохгүй гэж үү? Тэр цаг ирэхэд чи гүн гүнзгий харууслыг мэдрэхгүй гэж үү? Гутрал цөхрөлд живэхгүй гэж үү? Би сэлгүүцэж, уйдсандаа энэ бүх ажлыг хийж байгаа юм биш, харин хожмын ажлынхаа суурийг тавихын тулд хийж байгаа юм. Би мухардалд ороод, ямар нэг шинэ зүйл хийхээс өөр аргагүй болсон юм биш. Чи Миний хийдэг ажлыг ойлгох ёстой; энэ нь гудамжинд тоглож буй хүүхдийн хийдэг зүйл биш, харин Миний Эцэгийг төлөөлөн хийгддэг ажил юм. Би Өөрөө энэ бүхнийг ганцаараа хийж байгаа юм биш; харин Өөрийн Эцэгийг төлөөлдөг гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Энэ зуур та нарын үүрэг бол зүгээр л дагах, дуулгавартай байх, өөрчлөгдөх болон гэрчлэх явдал юм. Та нар яагаад Надад итгэх ёстой вэ гэдгийг л ойлгох учиртай; энэ бол та нарын дор бүрнээ ойлгох ёстой хамгийн чухал асуулт мөн. Миний Эцэг Өөрийн алдрын төлөө, дэлхийг бүтээсэн мөчөөсөө л та бүгдийг Миний төлөө урьдчилан тогтоосон. Тэрээр Миний ажлын төлөө болон Өөрийнхөө алдрын төлөө л та нарыг урьдчилан тогтоосон билээ. Миний Эцэгээс болж та нар Надад итгэдэг; Миний Эцэг урьдчилан тогтоосон учраас л та нар Намайг дагадаг. Үүний алийг нь ч та нар өөрсдөө сонгосон юм биш. Та нар бол Намайг гэрчлүүлэх зорилгоор Миний Эцэгийн Надад өгсөн хүмүүс юм гэдгийг ойлгох чинь бүр ч чухал юм. Тэр та нарыг Надад өгсөн учраас та нар Миний өгдөг зам болон Миний заадаг зам, бас үгийг даган мөрдөх ёстой, учир нь Миний замыг даган мөрдөх нь та нарын үүрэг билээ. Энэ нь Надад итгэх итгэлийн чинь анхдагч зорилго юм. Тиймээс Би та нарт ингэж хэлдэг: Та нар бол ердөө л Миний замыг мөрдүүлэхийн тулд Миний Эцэгийн Надад өгсөн хүмүүс билээ. Гэсэн ч та нар зөвхөн Надад итгэдэг; та нар израиль гэр бүлээс гаралтай биш, харин эртний могойн төрөл учраас Минийх биш. Миний төлөө гэрчлэл хийхийг л Би та нараас шаардаж байна, гэхдээ өнөөдөр та нар Миний замаар алхах ёстой. Энэ бүхэн нь ирээдүйн гэрчлэлийн төлөө байдаг. Хэрвээ та нар зөвхөн Миний замыг сонсдог хүмүүс шиг л үйлдэх юм бол ямар ч үнэ цэнгүй байх бөгөөд Миний Эцэг та нарыг Надад өгсний ач холбогдол алдагдана. Та нарт хэлэх гэж Миний зүтгээд байгаа зүйл бол энэ: Та нар Миний замаар алхах ёстой.

ЖИНХЭНЭ ХҮН БАЙХЫН УТГА УЧИР

Хүнийг удирдах нь үргэлж Миний үүрэг байж ирсэн. Түүнчлэн хүнийг байлдан дагуулах нь дэлхийг бүтээж байхдаа Миний тогтоосон зүйл юм. Эцсийн өдрүүдэд Би хүнийг бүрэн байлдан дагуулна, хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийг байлдан дагуулах нь Сатаныг ялсны минь нотолгоо гэдгийг хүмүүс мэдэхгүй байж магад. Гэвч Сатаны барьж авч, үр хүүхдээ болгосон, гэрийг нь харж ханддаг үнэнч зарцаа болгосон хүмүүсийг Би байлдан дагуулна гэдгээ Өөрийн дайсантай тулаанд орох үедээ түүнд аль эрт хэлсэн билээ. Байлдан дагуулахын анхдагч утга нь ялан дийлж, доог тохуу болгох юм. Израиль хэлэнд энэ нь бүрмөсөн ялж, сүйрүүлнэ, Намайг дахин эсэргүүцэх чадваргүй болгоно гэсэн утгатай. Гэвч өнөөдөр та нарын дунд бол байлдан дагуулах гэсэн утгаар хэрэглэгддэг. Миний ажлыг саатуулж, үймүүлж чадах нь байтугай, дахин Намайг эсэргүүцэх чадваргүй болтол нь хүн төрөлхтний ёрын муу нэгнийг бүрэн устгаж, бут цохих нь цаг ямагт Миний санаа зорилго байж ирсэн гэдгийг та нар мэдэх учиртай. Иймээс хүний хувьд энэ үг нь байлдан дагуулах гэсэн утгатай болсон билээ. Энэ нэр томъёо ямар ч утгатай байлаа гэсэн Миний ажил бол хүн төрөлхтнийг ялах явдал. Учир нь хүн төрөлхтөн Миний удирдлагад хавсралт болдог нь үнэн ч нарийндаа бол тэд Миний дайсан гэдэг нь яриангүй. Хүн төрөлхтөн бол Надтай сөргөлдөж, дуулгаваргүй байдаг ёрын муу нэгэн. Хүн төрөлхтөн бол чухамдаа Миний хараасан ёрын муу нэгний үр удам. Хүн төрөлхтөн бол чухамдаа Надаас урвасан тэргүүн тэнгэрэлчийн хойч үе. Хүн төрөлхтөн бол үнэндээ аль эрт Надад гологдсоноосоо хойш эвлэршгүй дайсан минь болсон диаволын залгамж халаа. Бүх хүн төрөлхтний дээр тэнгэр бүрхэн харанхуйлж, огтхон ч цэлмэх шинжгүй байх агаад хүний ертөнц түнэр харанхуйд автаж, улмаар тэнд амьдарч байгаа хүн нүднийхээ өмнө сунгасан гараа ч тэр, толгой өнгийлгөх үедээ нарыг ч олж харж чадахгүй байх ажээ. Хөл доорх зам нь шалбаагтай, хотгор хонхортой, тахир мурий нугачаатай; газар тэр аяараа хүүр цогцсоор бүрхээстэй. Харанхуй булан үхэгсдийн хүүрээр дүүрч, сэрүүхэн, сүүдэртэй буланд чөтгөр бөөнөөрөө үүрлэжээ. Хүний ертөнцийн хаа сайгүй чөтгөрүүд сүрэглэн ирж буцна. Элдэв янзын араатны үр сад бузар буртагт баригдчихаад ширүүн тулаанд орж, үүний дуу чимээ нь зүрхэнд айдас хуруулна. Ийм цаг үед, ийм дэлхий ертөнц, “газрын диваажинд” амьдралын жаргал цэнгэлийг эрж хайхын тулд хүн хаачдаг вэ? Амьдралын хүрэх газраа олохын тулд хаачих вэ? Сатаны хөлд эртнээс дэвслүүлсэн хүн төрөлхтөн анхнаасаа л

Сатаны дүрд орсон жүжигчин байсан—хамгийн гол нь хүн төрөлхтөн Сатаны биелэл бөгөөд Сатанд гэрчлэл хийгч нотолгооны үүрэг гүйцэтгэдэг нь тов тодорхой. Ийм хүн төрөлхтөн, гажуудсан бөөн шаар шавхруу, хүний энэ завхарсан гэр бүлийн үр удам Бурханд гэрчлэл хийж яахан чадах билээ? Миний суу алдар хаанаас ирдэг вэ? Миний гэрчлэлийг хүн хаанаас нь ярьж эхэлж болох вэ? Учир нь хүн төрөлхтнийг аль эрт завхруулсан Миний дайсан, эрт үед бүтээж алдар суу, амьдран харуулалтаараа дүүргэсэн хүмүүсийг минь аль эрт авч бузарлачхаад Миний эсрэг зогсож байна. Алдар сууг минь булааж, Сатаны муу муухай, мөн сайн, мууг мэдүүлэгч модны жимсний шүүсийг ихэд хольсон хорыг л хүнд шингээжээ. Анх Би хүн төрөлхтнийг бүтээсэн; хүн төрөлхтний өвөг дээдэс Адамыг бүтээсэн. Түүнд бие хаа, дүр төрх заяагдаж, тэрээр ид хав, амин чанараар бялхаж, Бурханы алдар суу түүнийг дагалдсан билээ. Бурхан хүнийг бүтээсэн алдар суут өдөр энэ байлаа. Дараа нь Адамын биеэс Еваг бүтээсэн нь мөн л хүний өвөг дээдэс байсан, улмаар бүтээсэн хүмүүс минь Миний амьсгалаар дүүрч, суу алдраар минь бялхаж байсан билээ. Адам анх гараас минь мэндэлсэн бөгөөд Миний дүрийн төлөөлөл байсан юм. Иймээс “Адам” гэдэг нь анхандаа Миний амин эрч хүч, алдар сууг шингээсэн, бие, дүртэй, сүнс болон амьсгалтай, Миний бүтээсэн оршихуй хэмээх утгатай байв. Тэр Намайг төлөөлж, Миний дүрийг авч, амьсгалыг минь хүртэх чадвартай, сүнс бүхий цорын ганц бүтээгдсэн зүйл байсан юм. Эхэндээ Ева Миний бүтээхээр тогтоосон, амьсгалыг хүртсэн хоёр дахь хүн байсан тул “Ева” гэдэг уг нь Миний амин чанараар дүүрэн, алдар сууг минь хүртсэн, алдрыг минь үргэлжлүүлэх бүтээгдсэн зүйл гэсэн утгатай байлаа. Адамаас гарсан тул Ева мөн л Миний дүртэй байсан, учир нь тэр Миний дүрээр бүтсэн хоёр дахь хүн билээ. “Ева” гэдэг нь анхандаа сүнс, мах, яснаас бүтсэн амьд хүн, мөн хүн төрөлхтний дундах Миний хоёр дахь гэрчлэл төдийгүй хоёр дахь дүр гэсэн утгатай байв. Тэд хүн төрөлхтний өвөг дээдэс, хүний ариун нандин эрдэнэс, анхнаасаа сүнстэй хүмүүс байсан юм. Гэвч хүн төрөлхтний өвөг дээдсийн үр удмыг ёрын муу нэгэн дэвсэлж, эрхэндээ оруулж, хүний ертөнцийг түнэр харанхуйд автуулж, улмаар тэднийг Миний оршин тогтнолд итгэхээргүй болгожээ. Бүр ч жигшүүртэй нь, ёрын муу нэгэн хүмүүсийг завхруулж, бүгдийнх нь дээр дэвсэлж байхдаа тэдэнд хайрласан алдар суу, гэрчлэл, амин чанар, тэдэнд өгсөн амьсгал, амь, мөн хүний ертөнц дэх бүх алдар суу, хүн төрөлхтөнд зарлагадсан амьдралын бүх эх булгийг минь харгисаар булаан авч байна. Хүн төрөлхтөн гэрэлд байхаа больж, хүмүүс Миний олгосон бүх зүйлийг алдсан бөгөөд Миний өгсөн алдар

сууг хөсөр хаяжээ. Бүх бүтээгдсэн зүйлийн Эзэн гэдгийг минь тэд яахан хүлээн зөвшөөрч чадах билээ? Тэнгэр дэх оршин тогтнолд минь яаж итгэсээр байх билээ? Газар дээрх алдрын минь илэрхийллийг тэд яаж олж чадах билээ? Өвөг дээдэс нь хүндэлдэг байсан Бурханыг энэ ач зээ нар өөрсдийг нь бүтээсэн Эзэн хэмээн хүлээн авч яахан чадах билээ? Адам, Евад Миний хайрласан алдар суу, дүр, гэрчлэл, мөн хүн төрөлхтний оршин тогтнолыг тэтгэдэг Миний олгосон амийг хөөрхийлөлтэй энэ ач зээ нар ёрын муу нэгэнд өгөөмрөөр “бэлэглэсэн”; ёрын муу нэгний дэргэд байгаагаа огт хайхралгүй, бүх алдар сууг минь түүнд өгдөг. “Шаар шавхруу” гэх нэр томьёо үүнээс л үүдэлтэй бус уу? Ийм хүн төрөлхтөн, ёрын муу чөтгөрүүд, алхаж яваа үхдэлүүд, Сатаны дүрүүд, Миний дайснууд алдар сууг минь эзэмшиж яахан чадах билээ? Хүмүүсийн дунд оршдог алдар суу, гэрчлэл болон нэгэн цагт бүгд Минийх байгаад эрт цагт хүмүүст өгсөн бүхнээ Би эргүүлэн олж авна—хүн төрөлхтнийг Би бүрэн байлдан дагуулна. Гэвч бүтээсэн хүмүүс минь Миний дүр, алдар суу бүхий ариун хүмүүс байсан гэдгийг чи мэдэх учиртай. Тэд Сатаных байгаагүй, түүнд дэвслүүлж ч яваагүй, Сатаны хорын өчүүхэн ч ул мөргүй, гагцхүү Миний илэрхийлэл байлаа. Иймээс Би Өөрийн гараар бүтээсэн зүйл, өөр этгээдийн харьяа бус, Өөрийн хайрладаг ариун хүмүүсийг л хүсэж байгаагаа хүн төрөлхтөнд хэлдэг. Түүнчлэн Би тэднийг таашааж, Өөрийн алдар суу хэмээн тооцно. Харин Сатаны завхралд өртөөд өнөөдөр Сатанд харьяалагдаж, Миний анхдагч бүтээл байхаа больсон хүн төрөлхтнийг Би хүсдэггүй. Хүний ертөнцөд буй алдар суугаа эргүүлэн олж авахыг Би зорьж буй тул Сатаныг ялсан алдрынхаа нотолгоо болгон хүн төрөлхтний дундаас амьд үлдэгсдийг бүрэн байлдан дагуулна. Гэрчлэлээ л Би Өөрийн биежилт, Өөрийн таашаалын бай болгодог. Миний хүсэл энэ билээ.

Хүн төрөлхтөн өнөөдөр байгаа газартаа хүрэхэд олон түмэн жил шаардагдсан авч анх Миний бүтээсэн хүн төрөлхтөн аль эрт доройтолд оржээ. Хүн төрөлхтөн Миний хүсдэг хүн төрөлхтөн байхаа больсон тул Миний нүдээр бол хүн төрөлхтөн хэмээн нэрлэгдэх эрхгүй болсон. Харин ч тэд Сатаны олзолсон хүн төрөлхтний хог шаар, Сатанд бариулж, нөмрөх хувцас нь болсон илжирсэн амьд хүүр билээ. Хүмүүс Миний оршин тогтнолд итгэдэггүй, Намайг ирж байхад ч угтан авдаггүй. Хүсэлтэд минь дурамжхан хариу үзүүлж, түр зуур буулт хийхээс биш амьдралын баяр гунигийг чин сэтгэлээсээ Надтай хуваалцдаггүй. Хүмүүс Намайг ойлгохын аргагүй гэж үздэг тул дурамжхан инээмсэглэж, эрх мэдэлтэнд тал засаж буй хандлагатай байдаг, учир нь хүмүүс Миний ажлыг огт мэддэггүй, өнөө үе дэх Миний хүслийг бүр ч мэддэггүй. Би та

нартай илэн далангүй байя: Цаг нь ирэхээр Намайг шүтэн мөргөдөг хэн бүхний зовлон та нарынхыг бодвол тэвчихэд амар байх болно. Надад итгэх итгэлийн чинь хэмжээ үнэндээ Иовынхоос давдаггүй, иудейн фарисайчуудын итгэл ч та нарынхаас илүү байдаг тул галын өдөр ирэхэд та нарын зовлон Есүст зэмлүүлсэн фарисайчууд, Мосег эсэргүүцсэн 250 удирдагч, дүрэлзэх галд сүйрсэн Содомын зовлонгоос ч хүнд байх болно. Мосе хадыг цохиход Еховагийн хайрласан ус оргилсон нь түүний итгэлээс үүдэлтэй. Давид Ехова Намайг магтан лир хөгжим хөгжимдөж, зүрх сэтгэл нь баяр баяслаар дүүрдэг байсан нь түүний итгэлээс үүдэлтэй. Иов уул толгодыг бүрхсэн мал сүрэг, асар их эд хөрөнгөө алдан, бие нь яр шарханд баригдсан нь түүний итгэлээс үүдсэн. Ехова Миний дуу хоолойг сонсож, Ехова Миний алдар сууг харж чадсан нь ч түүний итгэлээс үүдэлтэй. Есүс Христийг Петр дагаж чадсан нь түүний итгэлээс улбаатай. Миний төлөө загалмайд цовдлогдож, алдар суут гэрчлэл хийж чадсан нь ч түүний итгэлээс улбаатай. Хүний Хүүгийн алдар суут дүрийг Иохан харсан нь түүний итгэлээс улбаатай. Эцсийн өдрүүдийн үзэгдлийг харсан нь түүний итгэлээс бүр ч их улбаатай. Харь үндэстний гэгдэх үй олон хүн Миний илчлэлийг олж авч, хүмүүсийн дунд ажлаа хийхээр махбодод эргэн ирсэн гэдгийг минь олж мэдсэн нь ч бас тэдний итгэлээс үүдэлтэй. Хатуу үгэнд минь цохиулдаг атлаа тэдгээрээс үүдэн тайтгарч, аврагддаг бүх хүн ч бас итгэлээсээ болж тэгдэг бус уу? Надад итгэдэг атлаа бэрхшээл туулдаг хүмүүс ертөнцөд мөн л гологдсон бус уу? Миний үгийн гадна амьдарч, шалгалтад зовохоос зайлсхийдэг хүмүүс бүгд ертөнцөд туугдаж яваа бус уу? Энд тэнд найгах намрын навчис адил тэдэнд, тайтгаруулсан үг минь бүү хэл амрах газар ч үгүй. Миний гэсгээлт, цэвэршүүлэлт тэднийг дагадаггүй ч тэд газраас газарт туугдаж, тэнгэрийн хаанчлалын гаднах гудмаар тэнэж яваа гуйлгачид бус уу? Ертөнц үнэхээр чиний амрах газар гэж үү? Миний гэсгээлтээс зайлсхийснээр чи ертөнцөөс баяслын багахан ч болов инээмсэглэл олж авч үнэхээр чадна гэж үү? Зүрх сэтгэл дэх илэрхий хоосролоо зуурдын баяслаар далдалж үнэхээр чадах уу? Гэр бүлийнхнээ бүгдийг нь хуурч болох ч гэлээ Намайг чи хэзээ ч хуурч чадахгүй. Итгэл чинь дэндүү хомс тул өнөөг хүртэл чи амьдралаас ямар ч баяр баясал олж авахад хүчин мөхөстлөө. Амьдралынхаа хагасыг Миний төлөө чин сэтгэлээсээ зарцуулах нь дутуу дулимаг, ажилд нухлуулсан байдалтайгаар махан биеийн төлөө бүхий л амьдралаа үрж, хүн үүрч бараг чадахааргүй бүх зовлонг туулснаас дээр гэж чамайг Би шавдуулъя. Өөрийгөө тэгтлээ нандигнаж, Миний гэсгээлтээс зугтах ямар хэрэг байна? Зуурдын гэсгээлтээс минь

нуугдаад гагцхүү мөнхийн ичгүүр, мөнхийн гэсгээлтэд унах ямар хэрэгтэй юм бэ? Үнэндээ Би Өөрийн хүслийг хэнд ч тулгадаггүй. Бүх төлөвлөгөөнд минь захирагдахад үнэхээр бэлэн хүн байвал түүнд Би муухай хандахгүй. Харин Иов Ехова Надад итгэдэг байсны адилаар бүх хүн Надад итгэхийг Би шаарддаг. Итгэл чинь Томасын итгэлээс давбал та нар сайшаалыг минь хүртэж, үнэнч байснаараа та нар жаргалыг минь олж, өөрсдийн цаг үед Миний алдар сууг гарцаагүй олно. Харин дэлхий ертөнцөд итгэж, диаволд итгэдэг хүмүүс яг л Содом хотын олон түмний адилаар зүрх сэтгэл нь цэвдэг болж, салхинд хийссэн элс нүдэнд нь орж, диаволын тахил аманд нь орж, балартсан оюун ухаан нь ертөнцийг булаан авсан ёрын муу нэгэнд аль эрт эзэмдүүлсэн байдаг. Тэдний бодол бараг тэр чигтээ эрт үеийн диаволд олзлуулсан. Иймээс хүн төрөлхтний итгэл салхинд хийсэж, Миний ажлыг анзаарах ч чадваргүй байдаг. Тэд ажилд минь хааш яаш хандаж, ширүүн дориунаар шинжлэх гэж үлгэн салган оролдохоос цаашгүй байдаг бөгөөд Сатаны хоронд аль эрт эзэмдүүлснээс нь энэ үүдэлтэй.

Хүмүүс Надаар бүтээгдэж, бүтээлийн минь арвин объектыг бүгдийг нь эдэлсэн тул хүн төрөлхтнийг Би байлдан дагуулна. Гэвч хүмүүс бас Намайг голсон; тэдний зүрх сэтгэлд Би байдаггүй, тэд Намайг оршин тогтнолынх нь садаа гэж үзээд, Намайг үнэхээр харсан атлаа мөн л голж, Намайг ялж болох бүх аргыг сэдэхээр тархиа гашилгадаг. Хүмүүс өөрсдөд нь нухацтай хандах, хатуу шаардлага тавихыг Надад зөвшөөрдөггүй, мөн зөв шударга бус байдлыг нь шүүж, гэсгээх боломж олгодоггүй. Тэд үүнийг сонирхох нь байтугай яршигтай гэж үздэг. Иймд Надаас идэж, ууж, найрладаг атлаа Намайг мэддэггүй хүн төрөлхтнийг авч, ялан дийлэх нь Миний ажил юм. Би хүн төрөлхтнийг аюулгүй болгоод, дараа нь Өөрийн тэнгэрэлчүүд, алдар сууг авч оршин суудаг газартаа буцна. Учир нь хүмүүсийн үйлдэл эртнээс сэтгэлийг минь шархлуулж, ажлыг минь хэдэн хэсэг нураасан юм. Би баяртайгаар алхан одохоосоо өмнө ёрын муу нэгний булаасан суу алдрыг буцаан олж аваад, хүн төрөлхтөнд үргэлжлүүлэн амьдрах, “амар тайван, сэтгэл хангалуун амьдарч, ажиллах”, “тариалангийн талбайгаа хагалах” боломж олгохоор зорьдог бөгөөд тэдний амьдралд дахин оролцохгүй. Харин Би одоо ёрын муу нэгний гараас алдар суугаа бүрмөсөн буцаан олж авч, дэлхийг бүтээхдээ хүнд хайрласан алдар суугаа бүхэлд нь эргүүлэн авахаар зорьж байна. Газар дэлхий дээрх хүн төрөлхтөнд Би алдар суугаа дахин хэзээ ч хайрлахгүй. Учир нь хүмүүс алдар сууг минь хадгалж чадаагүйн дээр Сатаны дүрээр үүнийг сольсон. Хүмүүс Миний ирэхийг

нандигнадаггүй, мөн Миний алдрын өдрийг ч өндрөөр үнэлдэггүй. Миний гэсгээлтийг хүртээд баярладаггүй, алдар сууг минь эргүүлэн өгөхийг бүр ч хүсдэггүй, ёрын муу нэгний хороос ангижрахыг ч хүсдэггүй. Хүн төрөлхтөн өнөөх л янзаараа Намайг хуурсан хэвээр, хүмүүс урьдын адил баяртайгаар инээмсэглэж, жаргалтай царайлсан хэвээр. Миний алдар суу орхин одсоны дараа хүн төрөлхтөнд нүүрлэх түнэр харанхуйн гүн гүнзгийг тэд мэддэггүй. Ялангуяа, Миний өдөр бүх хүн төрөлхтөн дээр ирэхдээ Ноагийн үеийн хүмүүсийнхээс ч илүү хатуурхахыг мэддэггүй, учир нь Миний алдар суу Израилийг орхих үед Израиль хэчнээн их харанхуйлсныг тэд мэддэггүй бөгөөд түнэр харанхуй шөнийг даван туулах ямар хэцүүг үүр цайх үед хүн мартдаг билээ. Нар дахин далд орж, хүн төрөлхтнийг харанхуй нөмрөх үед харанхуйд хүн дахин уйлж, шүдээ хавирна. Миний алдар суу Израилийг орхих үед зовлонт тэр өдрүүдийг тэсвэрлэх нь израильчуудад хэчнээн хэцүү байсныг та нар мартав уу? Одоо үе бол та нар Миний алдар сууг харах үе, мөн Миний алдрын өдрийг хуваалцах үе билээ. Миний алдар суу бузар булай газар нутгийг орхин одоход хүн харанхуйд уйлна. Одоо үе бол Миний ажиллах алдрын өдөр, мөн хүн төрөлхтнийг зовлонгоос гэтэлгэх өдөр, учир нь Би шаналан, гай зовлонгийн цаг үеийг тэдэнтэй хуваалцахгүй. Харин хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулж, хүн төрөлхтний ёрын муу нэгнийг бүрэн ялахыг л хүснэ.

ЧИ ИТГЭЛИЙН ТАЛААР ЮУ МЭДЭХ ВЭ?

Хүний дотор итгэлийн тухай эргэлзээтэй үг л байдаг, харин итгэл гэж юу болохыг хүн мэддэггүй, яагаад итгэдгээ бүр ч мэддэггүй. Хүн хэтэрхий багыг ойлгодог, мөн тэр өөрөө хэтэрхий учир дутагдалтай; тэр ердөө л бодлогогүй, мунхгаар Надад итгэдэг. Тэр итгэл гэж юу болох, мөн яагаад Надад итгэдгээ мэддэггүй хэдий ч хэнээрхэн итгэсээр байдаг. Миний хүнээс хүсдэг зүйл бол Намайг ийм байдлаар хэнээрхэн дуудаж, эсвэл Надад зорилгогүй байдлаар итгэх явдал биш. Учир нь, Миний хийдэг ажил хүнд Намайг харуулж, мэдүүлэхийн төлөө байдаг болохоос биш Намайг гайхан биширч, өөр нүдээр хараасай гэсэндээ биш юм. Би өмнө нь маш олон тэмдэг гайхамшиг үзүүлж, олон ер бусын зүйл үйлдсэн тул тухайн үеийн израильчууд Намайг гүнээ бахдан биширч, өвчтэйг анагааж, чөтгөрийг хөөх хосгүй чадварыг минь ихэд дээдэлсэн юм. Тухайн үеийн иудейчүүд Миний анагаах хүч чадлыг чадварлаг агаад ер бусын гэж бодсон бөгөөд олон үйл хэргийг минь хараад тэд бүгд Намайг

дээдлэн хүндэтгэж, бүх хүч чадлыг минь ихэд бахдан биширсэн. Тиймээс ер бусын зүйл үзүүлэхийг минь харсан хэн боловч Намайг ойр дагасан, улмаар өвчтэйг эдгээхийг минь харахаар мянга мянган хүн Намайг хүрээлсэн билээ. Би маш олон тэмдэг, гайхамшиг үзүүлсэн, гэвч хүн Намайг ердөө л чадварлаг эмч мэтээр үзсэн юм; Би бас тухайн үеийн хүмүүст сургаалын олон үг хэлсэн боловч тэд Надад ердөө л шавь нараасаа дээгүүрт тавигдах багш төдий хандсан! Өнөөдөр ч гэсэн хүмүүс Миний ажлын түүхэн тэмдэглэлийг харсныхаа дараа Намайг өвчтэйг анагаадаг агуу эмч, мэдлэггүй хүмүүсийн багш хэмээн тайлбарласаар байна. Мөн тэд Намайг өршөөлт Эзэн Есүс Христ хэмээн тодорхойлсон. Бичвэрүүдийг тайлбарладаг хүмүүс анагаах чадвараараа Надаас илүү байж болно, эсвэл одоо шавь нар нь багшаасаа давуу мэдлэгтэй болсон ч байж болно, гэвч нэр алдар нь дэлхий даяар цуурайтсан, асар алдартай ийм хүмүүс Намайг ердөө л шалихгүй эмч гэж дорд үздэг! Миний үйл хэрэг далайн эргийн элсэн ширхгээс ч олон бөгөөд Миний мэргэн ухаан Соломоны үр удмаас ч агуу атал хүмүүс Намайг шалихгүй эмч, мөн хүний үл таних багш л гэж боддог! Өөрсдийг нь эмчилнэ гэсэндээ л маш олон хүн Надад итгэдэг. Намайг хүч чадлаа ашиглан биеэс нь бузар сүнснүүдийг зайлуулах байх гэсэндээ, бас Надаас зүгээр л амар амгалан, баяр хөөр хүртэнэ гэсэндээ маш олон хүн Надад итгэдэг. Надаас илүү их материаллаг эд хөрөнгө шаардахын тулд маш олон хүн Надад итгэдэг. Мөн энэ амьдралаа амар амгалан өнгөрөөж, ирэх ертөнцөд эсэн мэнд, эрүүл саруул байхын тулд маш олон хүн Надад итгэдэг. Тамын зовлонгоос зайлсхийж, тэнгэрийн ерөөлийг хүлээж авахын тулд маш олон хүн Надад итгэдэг. Зөвхөн түр зуурын тав тухын төлөө маш олон хүн Надад итгэдэг хэдий ч ирэх ертөнцөд ямар нэг зүйл олж авахаар эрж хайдаггүй. Би Өөрийн уур хилэнг хүн дээр буулгаж, нэгэн цагт хүнд байсан бүхий л баяр баясал, амар амгаланг булаан авах үед хүн эргэлзсэн. Би хүнд тамын зовлон өгч, тэнгэрийн ерөөлийг буцааж авах үед хүний ичгүүр нь уур хилэн болж хувирсан. Хүн өөрийг нь анагаагаач гэж Надаас гуйх үед Би ямар ч анхаарал тавилгүй, хүнд зэвүүцсэн; харин хүн ёрын муу эм болон хар шидийн замыг эрж хайхын тулд Надаас холдсон юм. Надаас нэхсэн бүхнийг нь хүнээс булаан авсны дараа хүн ул мөргүй алга болсон. Тиймээс, Намайг хэтэрхий их нигүүлсэл өгдөг учраас л, энэ нь маш их ашигтай байдаг учраас л хүн Надад итгэдэг гэж Би хэлдэг. Иудейчүүд Миний нигүүлслээс болж Надад итгэж, явсан газар бүрд минь Намайг дагасан. Эдгээр мэдлэг, туршлага хомс мунхаг хүмүүс Миний үзүүлсэн тэмдэг, гайхамшигийг олж харахыг л эрмэлзсэн.

Тэд Намайг хамгийн агуу гайхамшгийг үзүүлж чаддаг иудей овгийн тэргүүн гэж үзсэн. Тиймээс хүмүүсээс чөтгөрийг хөөн зайлуулах үед тэдний дунд бөөн яриа дэгдэж, Намайг Елиа, Мосе гэгцгээж, бүх эш үзүүлэгчээс хамгийн эртнийх нь, бүх эмчээс хамгийн агуу нь хэмээсэн юм. Би бол амь, зам, үнэн гэж Миний хэлснээс бусдаар хэн ч Миний оршихуй, ялгамж чанарыг мэдэж чадаагүй. Тэнгэр бол Миний Эцгийн амьдардаг газар гэж Намайг хэлснээс бусдаар бол Бурханы Хүү, Бурхан Өөрөө гэдгийг маань хэн ч мэдээгүй. Би бүх хүн төрөлхтөнд золин авралыг авчирч, хүн төрөлхтнийг гэтэлгэнэ гэж Намайг хэлснээс бусдаар бол хүн төрөлхтний Золин аврагч гэдгийг минь хэн ч мэдээгүй; хүмүүс Намайг энэрэнгүй, өршөөнгүй хүн гэж л мэддэг. Намайг Өөрөө Өөрийнхөө талаар бүхнийг тодорхой тайлбарлахаас нааш хэн ч Намайг мэдээгүй, мөн Намайг амьд Бурханы Хүү гэдэгт хэн ч итгээгүй. Хүн ийм л байдлаар Надад итгэж, ийм маягаар Намайг хуурах гэж оролддог. Хүн Миний талаар ийм үзэл бодолтой байж, Намайг яаж гэрчилж чадах билээ?

Хүн Надад итгэдэг боловч Надад гэрчлэл хийж чаддаггүй, Өөрийгөө таниулахаас минь өмнө Намайг гэрчилж ч чадахгүй. Хүмүүс зөвхөн намайг бүтээлүүд болон бүх ариун хүнээс давуу гэдгийг, Миний хийдэг ажлыг хүн хийж чадахгүй гэдгийг хардаг. Тиймээс иудейчүүдээс эхлээд өнөө үеийн хүмүүс хүртэл Миний суу алдарт үйл хэргийг харсан хэн боловч ердөө л Намайг сониучирхах сэтгэлдээ автсан байсан, харин ганц ч бүтээл Надад амаараа гэрчлэл хийж чадаагүй. Миний Эцэг л Надад гэрчлэл хийж, бүх бүтээлийн дунд Надад зам гаргаж өгсөн. Эс бөгөөс, Намайг яаж ч ажиллалаа гэсэн, бүтээлийн Эзэн гэдгийг минь хүн хэзээ ч мэдэхгүй байх байв, учир нь хүн Надаас авахыг л мэддэг ба Миний ажлаас болж Надад итгэдэг юм биш. Намайг гэм зэмгүй бөгөөд аль ч талаараа нүгэлтэн биш учраас, олон тооны нууцыг тайлбарлаж чаддаг учраас, олон түмнээс дээд нэгэн учраас, эсвэл хүн Надаас маш их ашиг тус хүртсэн учраас л хүн Намайг мэддэг хэдий ч цөөхөн хүн л Намайг бүтээлийн Эзэн гэдэгт итгэдэг. Ийм учраас хүн яагаад Надад итгэдгээ мэддэггүй гэж Би хэлдэг; хүн Надад итгэхийн зорилго, ач холбогдлыг мэддэггүй. Хүний бодит байдал нь учир дутагдалтай, ийм болохоор Надад гэрчлэл хийхэд бараг тохирдоггүй. Та нарын жинхэнэ итгэл тун өчүүхэн, олж авсан зүйл чинь хэтэрхий бага тул та нарт маш цөөхөн гэрчлэл байдаг. Түүнчлэн та нар хэтэрхий бага ойлголттой агаад тун учир дутагдалтай, ийм болохоор Миний үйл хэрэгт гэрчлэл хийхэд бараг тэнцэхгүй. Та нар үнэндээ нэлээд шийдэмгий, гэвч та нар Бурханы мөн чанарыг амжилттай гэрчилж чадна гэдэгтээ итгэлтэй байна уу? Та

нарын туулсан, үзэж харсан зүйл өмнөх бүх үеийн эш үзүүлэгчид, ариун хүмүүсийнхээс давдаг, гэхдээ та нар өмнөх үеийн эш үзүүлэгчид болон ариун хүмүүсийн үгээс илүү агуу гэрчлэл өгч чадах уу? Одоо та нарт Миний хайрладаг зүйл Мосегийнхоос давж, Давидынхаас илүү гардаг, иймээс та нарын гэрчлэл Мосегийнхоос давж, үг чинь Давидынхаас илүү байхыг Би шаарддаг. Би та нарт зуу дахин ихийг өгдөг тул та нараас ч бас Надад тэр хэрээр эргүүлэн төл гэж шаарддаг. Би бол хүн төрөлхтөнд амь хайрладаг Нэгэн гэдгийг та нар мэдэх ёстой бөгөөд та нар Надаас амь хүлээн авдаг тул Надад гэрчлэл хийх ёстой. Энэ бол та нарын үүрэг, мөн Миний та нарт илгээдэг, Миний төлөө та нарын хийх учиртай зүйл юм. Би та нарт Өөрийн бүх алдрыг хайрлаж, сонгогдсон хүмүүс болох израильчуудын хэзээ ч аваагүй амийг хайрласан. Зүй нь бол та нар Надад гэрчлэл хийж, залуу насаа Надад зориулж, амиа өгөх учиртай. Миний алдар суугаа хайрласан хэн боловч Надад гэрчлэл хийж, Миний төлөө амиа өгөх ёстой. Үүнийг Би аль эрт урьдчилан тогтоосон. Миний та нарт алдар суугаа хайрлаж байгаа нь та нарын ерөөл бөгөөд Миний алдрыг гэрчлэх нь та нарын үүрэг билээ. Та нар ерөөл хүртэхийн тулд л Надад итгэсэн бол Миний ажил ач холбогдол багатай байх бөгөөд та нар ч бас үүргээ биелүүлэхгүй байх болно. Израильчууд Миний өршөөл, хайр энэрэл болон агуу байдлыг л харсан бол иудейчүүд Миний тэвчээр болон золин авралыг л харсан. Тэд Миний Сүнсний ажлаас тун өчүүхнийг л ойлгосон; тэдний ойлголтын түвшин та нарын харсан, сонссоны арван мянганы нэг л байсан. Та нарын харсан зүйл тэдний ахлах тахилчдынхаас ч даван гардаг. Өнөөдөр та нарын ойлгосон үнэн тэднийхийг давдаг; та нарын өнөөдөр харсан зүйл Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үед ойлгож мэдэж байснаас ч илүү байдаг бөгөөд та нарын туулсан зүйл Мосе, Елиагийнхаас ч даван гардаг. Учир нь израильчууд зөвхөн Еховагийн хуулийг ойлгож, Еховагийн барааг араас нь л харсан юм; иудейчүүд Есүсийн золин авралыг л ойлгож, Есүсийн хайрласан нигүүлслийг л хүлээн авсан бөгөөд иудей овгийн гэр доторх Есүсийн дүрийг л харсан билээ. Өнөөдөр та нар Еховагийн алдар, Есүсийн золин аврал болон Миний өнөөдрийн бүх үйл хэргийг хардаг. Түүнчлэн та нар Миний Сүнсний үгийг сонсож, Миний мэргэн ухааныг ухамсарлаж, Миний гайхамшигийг мэдэж авч, Миний зан чанарын талаар олж мэдсэн. Би бас та нарт удирдлагын төлөвлөгөөгөө бүгдийг нь ярьсан. Та нарын харсан зүйл элэгсэг, өршөөнгүй Бурхан төдийгүй, мөн зөвт байдал бүрдсэн Бурхан билээ. Та нар Миний гайхамшигт ажлыг харж, уур хилэн, сүр жавхлангаар дүүрэн болохыг минь ч мэдсэн. Цаашлаад та нар израилийн гэрт

догшин уур хилэнгээ буулгасныг минь мэдэх ба өнөөдөр энэ нь та нар дээр ирсэн. Та нар Исаиа, Иохан нараас ч илүүтэйгээр Миний тэнгэр дэх нууцуудыг ойлгосон; та нар өмнөх үеийн бүх ариун хүнээс илүүгээр Миний хайр татам, эрхэм байдлыг мэддэг. Та нар Миний үнэн, зам, амийг төдийхнийг хүлээн авсан хэрэг бус, харин Иоханыхаас ч агуу үзэгдэл, илчлэлийг хүлээн авсан юм. Та нар илүү олон нууцыг ойлгож, Миний үнэн төрхийг харсан; та нар Миний шүүлтийг илүү их хүлээн авч, Миний зөвт зан чанарыг илүү их мэдсэн. Иймээс та нар эцсийн өдрүүдэд төрсөн хэдий ч, та нарын ойлголт урьд үе, өнгөрсөн үеийнхнийхтэй адил, та нар бас өнөөдрийн зүйлсийг туулсан бөгөөд энэ бүгдийг Би биечлэн хийсэн билээ. Би та нарт дэндүү ихийг өгч, та нар ч Надаас ихийг харсан болохоор та нараас Миний шаарддаг зүйл хэрээс хэтэрсэн юм биш. Тиймээс, өмнөх үеийн ариун хүмүүст хандан Намайг гэрчлээч гэж Би та нараас хүсдэг, энэ бол Миний зүрх сэтгэлийн цорын ганц хүсэл билээ.

Эхлээд Миний Эцэг Надад гэрчлэл хийсэн боловч Би илүү агуу алдрыг хүлээн авч, бүтээгдсэн зүйлсийн амнаас гэрчлэлийн үг сонсохыг хүсдэг— иймээс та нараар үүргийг чинь гүйцэтгүүлэх гэсэндээ Би та нарт бүхнээ зориулж, хүмүүсийн дундах ажлаа төгсгөл болгодог. Та нар Надад яагаад итгэдгээ ойлгох ёстой; хэрвээ зүгээр л Миний шавь юм уу өвчтөн болж, эсвэл тэнгэр дэх ариун хүмүүсийн минь нэг болохыг хүсдэг бол Намайг дагаж байгаа чинь утга учиргүй байх болно. Ийм байдлаар Намайг дагах нь зүгээр л хий дэмий хичээл зүтгэл байх байсан; ийм байдлаар Надад итгэх нь ердөө л өдөр хоногоо дэмий нөхцөөж, залуу насаа үрэн таран хийж байгаа хэрэг байх байсан. Тэгээд эцэст нь та нар юу ч хүлээн авахгүй. Энэ нь хий дэмий хөдөлмөр байх бус уу? Би иудейчүүдийн дундаас аль эрт явж одсон, Би хүний эмч эсвэл тэднийг анагаагч эм байхаа ч больсон. Би хүний хүссэнээр дөрлүүлж, нядлуулах ачлагын амьтан байхаа больсон; харин ч хүнийг шүүж, гэсгээн, хүнд Өөрийгөө мэдүүлэхээр хүмүүсийн дунд ирсэн юм. Нэгэн цагт Би золин авралын ажил хийсэн гэдгийг чи мэдэх ёстой; нэг үе Би Ехова байсан хэдий ч хожим нь Есүс болсны адилаар нэгэнтээ Би Есүс байсан боловч үүрд Есүс хэвээр үлдэж чадахгүй. Би хүн төрөлхтний Бурхан, бүтээлийн Эзэн боловч үүрд Есүс юм уу Ехова хэвээр байж чадахгүй. Би хүний хувьд эмч гэж тооцогддог нэгэн байсан, гэхдээ Бурхан бол ердөө л хүн төрөлхтнийг эмчилдэг эмч гэж тодорхойлж болохгүй. Иймээс хэрвээ чи Надад итгэхдээ хуучны үзэл бодлыг баримталбал юунд ч хүрэхгүй. “Бурхан хүнд хэчнээн хайртай гээч; Тэр намайг эдгээж, хүнд ерөөл, амар амгалан, баяр хөөр өгдөг. Бурхан хүнд хэчнээн сайн гээч; Түүнд

итгэх л юм бол бид мөнгө, эд баялгийн талаар санаа зовох хэрэггүй...” хэмээн чи энэ өдөр Намайг яаж ч магтлаа гэсэн, Би анхны ажлаа тасалдуулж бас л чадахгүй. Өнөөдөр чи Надад итгэвэл зөвхөн алдрыг минь хүлээн аваад зогсохгүй, Надад гэрчлэл хийх эрхтэй болох бөгөөд бусад бүх зүйл хоёрдугаарт тавигдана. Үүнийг чи тодорхой мэдэх ёстой.

Одоо чи Надад яагаад итгэдгээ үнэхээр мэдэх үү? Миний ажлын зорилго болоод ач холбогдлыг чи үнэхээр мэдэх үү? Үүргээ үнэхээр мэдэх үү? Миний гэрчлэлийг үнэхээр мэдэх үү? Чи Надад зүгээр л итгэдэг боловч Миний алдар болоод гэрчлэл чамаас харагддаггүй бол Би чамайг аль эрт таягдан хаячихжээ. Их мэдэгчид бол харин Миний нүдэнд бүр ч том өргөс, гэрт маань тэд Миний замын садаа л байдаг, тэд бол Миний ажлаас бүрмөсөн шигшигдэх өчүүхэн ч хэрэггүй, ямар ч үнэ цэнгүй үрийн сүүлнүүд бөгөөд Би тэднийг аль эртнээс жигшсэн юм. Миний уур хилэн ихэнхдээ гэрчлэлгүй хүмүүс дээр бууж, Миний таяг тэднээс ер холдож байгаагүй. Би аль эрт тэднийг муу ёрын нэгний гарт шилжүүлсэн бөгөөд тэдэнд Миний ерөөл огтхон ч байхгүй. Цаг нь ирэх үед тэдний гэсгээлт мунхаг эмэгтэйчүүдийнхээс илүү гашуун байх болно. Одоо Би Өөрийн хийх үүрэгт ажлаа л хийж байгаа; Би эдгээр үрийн сүүлийн хамтаар бүх буудайг багцалж бооно. Энэ бол Миний одоогийн ажил юм. Намайг шигших үед эдгээр үрийн сүүл бүгд шигшигдэнэ, тэгээд буудайн үр тариаг агуулахад хурааж, шигшигдсэн үрийн сүүлийг үнс нурам болтол нь шатаахаар галд хийх болно. Одоо Миний ажил бол зүгээр л бүх хүнийг багцлан боох буюу бүрэн байлдан дагуулах явдал юм. Дараа нь Би бүх хүний төгсгөлийг илчлэхийн тулд шигшиж эхлэх болно. Иймээс чи одоо Намайг яаж сэтгэл хангалуун байлгахыг болон Надад итгэх зөв замд яаж орохыг мэдэх ёстой. Би чиний одоогийн үнэнч зан, дуулгавартай байдал, одоогийн хайр болон гэрчлэлийг л хүсдэг. Энэ мөчид чи гэрчлэл гэж юу болох, хайр гэж юу болохыг мэдэхгүй байсан ч гэсэн өөрт байгаа бүхнээ Надад авчирч, өөртөө байгаа цорын ганц үнэт эрдэнэс болох үнэнч зан, дуулгавартай байдлаа Надад өгөх ёстой. Хүний үнэнч зан, дуулгавартай байдал бол Миний Сатаныг ялсан гэдгийн, түүнчлэн хүнийг Би бүрэн байлдан дагуулсан гэдгийн гэрчлэл гэдгийг чи мэдэх ёстой. Чи Надад итгэхдээ Надад гэрчлэл хийж, өөр хэнд ч биш Надад үнэнч байж, эцсээ хүртэл Надад дуулгавартай байх үүрэгтэй. Ажлынхаа дараагийн алхмыг эхлэхээс минь өмнө чи Надад хэрхэн гэрчлэл хийх вэ? Надад чи яаж үнэнч, дуулгавартай байх вэ? Чи өөрийн чиг үүрэгт бүх үнэнч байдлаа зориулах уу, эсвэл зүгээр л бууж өгөх үү? Чи Миний зохицуулалт бүрд (үхэл, сүйрэл байсан ч гэсэн) захирагдахыг илүүд үзэх үү,

эсвэл Миний гэсгээлтээс зайлсхийхийн тулд замын хагасаас зугтах уу? Надад гэрчлэл хийж, Надад үнэнч, дуулгавартай байг гэсэндээ Би чамайг гэсгээдэг. Мөн одоогийн гэсгээлт нь Миний ажлын дараагийн алхмыг нээж, ажлыг саадгүй урагшлуулахын төлөө байдаг. Тиймээс чамайг ухаалаг байж, өөрийн амь болоод оршин тогтнолын ач холбогдлыг ямар ч үнэ цэнгүй атга шороо мэт үзэхгүй байхыг Би зөвлөж байна. Миний ирэх ажил яг ямар байхыг чи мэдэх үү? Ирэх өдрүүдэд Миний яаж ажиллахыг, Миний ажил хэрхэн өрнөхийг чи мэдэх үү? Чи Миний ажлыг мэдэрч туулж байгаагийнхаа ач холбогдлыг төдийгүй, Надад итгэх итгэлийнхээ ач холбогдлыг мэдэх хэрэгтэй. Би маш их ажил хийсэн, чиний бодсон шиг замынхаа хагаст больж яаж чадах билээ? Би ийм өргөн цар хүрээтэй ажил хийсэн; яаж үүнийгээ үгүй хийж чадах билээ? Үнэхээр ч Би энэ эрин үеийг дуусгавар болгохоор ирсэн. Энэ бол үнэн, гэвч үүнээс гадна Би шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг эхлүүлж, хамгийн гол нь хаанчлалын сайн мэдээ түгээх гэж байгааг чи мэдэх ёстой. Тиймээс одоогийн ажил нь зөвхөн эрин үеийг эхлүүлж, ирэх цагийн сайн мэдээг түгээж, ирээдүйд эрин үеийг төгсгөл болгох суурийг тавихын төлөө юм гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Миний ажил чиний боддог шиг тийм ч энгийн биш, чиний итгэдэг шиг ямар ч үнэ цэнгүй, утга учиргүй ч биш. Тиймээс Би чамд бас л ингэж хэлэх ёстой: Чи Миний ажилд амиа зориулах учиртай бөгөөд цаашлаад өөрийгөө Миний алдрын төлөө зориулах ёстой. Надад гэрчлэл хийхийг чинь Би удаан хүсэн хүлээсэн, Миний сайн мэдээг түгээхийг чинь бүр ч удаан хүсэн хүлээсэн. Чи Миний зүрх сэтгэлд байгаа зүйлийг ойлгох учиртай.

УНАЖ БУЙ НАВЧИС ҮНДЭС РҮҮГЭЭ БУЦАХАД ЧИ ӨӨРИЙН ХИЙСЭН ЁРЫН МУУ БҮХЭНДЭЭ ХАРАМСАНА

Та нарын дунд хийсэн ажлыг минь та нар бүгд нүдээрээ харж, Миний хэлсэн үгийг өөрсдөө сонсож, та нарт хандах хандлагыг минь бүгд мэдсэн тул Би яагаад энэ ажлыг та нарт хийж байгааг мэдэх ёстой. Би та нарт үнэнээр нь хэлье, та нар бол эцсийн өдрүүд дэх байлдан дагуулалтын ажлын минь хэрэгсэл, Харь үндэстнүүдийн дунд Миний ажлыг өргөжүүлэх багаж зэвсэг төдийхөн юм. Харь үндэстнүүдийн дунд Өөрийн ажлыг илүү сайн өргөжүүлж, Өөрийн нэрийг түгээхийн тулд, өөрөөр хэлбэл, Израилийн гаднах аливаа үндэстнүүдийн дунд түгээхийн тулд Би та нарын зөвт бус, бохир заваан байдал,

эсэргүүцэл, тэрслүү байдлаар дамжуулан ярьдаг. Ингэснээр Миний нэр, Миний үйл хэрэг, Миний дуу хоолой Харь үндэстнүүд даяар тархаж, улмаар Израилийн бус тэр бүх үндэстэн Надаар байлдан дагуулагдаж, Намайг шүтэн мөргөж, Израиль болон Египет газар нутгийн гаднах Миний ариун газрууд болж болох юм. Миний ажлыг өргөжүүлэх нь үнэндээ байлдан дагуулах ажлыг минь өргөжүүлэх, Миний ариун газрыг өргөжүүлэх явдал билээ; энэ нь газар дээрх Миний тулах цэгийн өргөжилт юм. Та нар бол Миний байлдан дагуулдаг Харь үндэстнүүдийн дундах бүтээл төдий гэдгээ тодорхой мэдэж байх ёстой. Анх та нарт байр суурь ч байгаагүй, ашиглуулах үнэ цэн ч байгаагүй бөгөөд ямар ч хэрэггүй байсан. Би бүх газар нутгийг байлдан дагуулах загвар болгож, бүх газар нутгийг байлдан дагуулах “лавлах материал” болгохын тулд овоолсон өтөг бууцнаас өтнүүдийг өргөж гаргасан учраас л та нар Надтай холбоо тогтоож, одоо Надтай хамт цугларах хувьтай болсон. Дорд байр сууриас чинь болж Би та нарыг байлдан дагуулалтын ажлынхаа загвар, үлгэр дуурайл болгон сонгосон юм. Зөвхөн энэ шалтгааны улмаас л Би та нарын дунд ажиллаж, үг хэлдэг ба та нартай хамт амьдарч, түр оршин суудаг. Өөрийн удирдлагаас л болж, мөн овоолсон өтөг бууцан дундах өтнүүдийг туйлын их зэвүүцдэгээсээ болж Би та нарын дунд үг хэлж байгаа ба хилэгнэх хэмжээнд очсоныг та нар мэдэх ёстой. Та нарын дунд ажиллаж байгаа минь Ехова Израильд ажиллаж байсантай огтхон ч адилгүй бөгөөд ялангуяа Есүсийн Иудейд хийсэн ажилтай адилгүй. Би асар их тэвчээртэйгээр үг хэлж, ажилладаг ба уур хилэнтэйгээр, мөн шүүлттэйгээр энэ доройтсон хүмүүсийг байлдан дагуулдаг. Ехова Өөрийн ардуудыг Израильд удирдаж байсантай энэ огт адилгүй. Израиль дахь Түүний ажил хоол хүнс, амийн ус хайрлахын төлөө байсан бөгөөд Өөрийн ардуудыг хангаж байхдаа Тэрээр хайр, энэрлээр дүүрэн байлаа. Өнөөдрийн ажил нь сонгогдоогүй, хараагдсан үндэстэн дунд хийгддэг. Тэнд элбэг дэлбэг хоол хүнс байдаггүй, цангаа тайлах амийн ус ч байдаггүй, элбэг арвин эд материалын хангамж бүр ч байдаггүй; тэнд зөвхөн арвин их шүүлт, хараал, гэсгээлтийн хангамж л байдаг. Овоолсон өтөг бууцанд амьдардаг энэ өтнүүд нь Израильд Миний хайрласан шиг уул толгодыг бүрхсэн хонь мал, асар их эд баялаг, газар нутаг даяарх хамгийн хөөрхөн хүүхдүүдийг олж авахад огт тэнцэхгүй. Орчин үеийн Израиль Миний ард түмэнд нь өгдөг хонь мал, алт мөнгөн зүйлсийг тахилын ширээн дээр өргөж, хуулийн дор Еховагийн шаардаж байсан аравны нэгийг даван гарсан тул Би тэдэнд бүр ч ихийг—хуулийн дор Израилийн хүртсэнээс зуу дахин ихээс ч илүүг өгсөн. Израильд Миний өгсөн зүйл

Абрахамын олж авсан бүхнээс давсан, мөн Исаакын олж авсан бүхнээс давсан билээ. Би Израилийн гэр бүлийг үржүүлж, олшруулна, Израилийн ард түмнээ газар дэлхий даяар тараана. Миний ерөөж, халамжилдаг хүмүүс бол мөн л Израилийн сонгогдсон хүмүүс буюу Надад бүх зүйлээ зориулдаг, Надаас бүх зүйлийг олж авсан хүмүүс юм. Тэд Намайг оюун санаандаа хадгалдаг учраас дөнгөж төрсөн хурга, тугалаа Миний ариун тахилын ширээн дээр тахил болгодог бөгөөд Миний эргэн ирэхийг хүлээсэндээ саяхан мэндэлсэн ууган хөвгүүдээ ч өргөн барих хэмжээнд өөрсдөдөө байгаа бүхнийг Миний өмнө өргөдөг. Тэгвэл та нар яадаг вэ? Та нар Миний уурыг хүргэж, Надаас юм шаардаж, Надад өргөл өргөдөг хүмүүсийн тахилыг хулгайлдаг ба Надад халдаж байгаагаа мэддэггүй; тиймээс та нар харанхуй дахь уйлаан болон шийтгэлийг л хүртдэг. Та нар олон удаа Миний уурыг хүргэсэн бөгөөд нэлээд олон хүн эмгэнэлт төгсгөлтэй учирч, аз жаргалтай гэр орон нь эзгүй булш болох хэмжээнд Би Өөрийн дүрэлзсэн галыг доош цутгасан. Энэ өтнүүдэд зориулсан эцэс төгсгөлгүй уур хилэн л Надад байдаг бөгөөд тэднийг ерөөх санаа зорилго байхгүй. Өөрийн ажлын төлөө л Би та нарыг тусгайлан үзэж, өргөсөн ба асар их доромжлолыг тэвчиж, та нарын дунд ажилласан. Эцгийн минь хүслийн төлөө байгаагүй бол Би овоолсон өтөг бууцан дотор эргэлдэж байдаг өтнүүдтэй хамт нэг гэрт амьдарч яахан чадах билээ? Би та нарын үйлдэл, үг бүхнийг туйлаас жигшдэг бөгөөд ямартай ч та нарын бохир заваан, тэрслүү байдлыг бага зэрэг “сонирхдог” учраас энэ нь Миний үгийн асар их цуглуулга болсон. Эс бөгөөс Би та нарын дунд удаан хугацаагаар яавч үлдэхгүй байх байсан. Тиймээс Би та нарт ердөө л өрөвдөж, хөөрхийлсөн хандлагаар ханддаг; Надад та нарыг гэх ганц дусал ч хайр байхгүй гэдгийг та нар мэдэх ёстой. Надад ердөө та нарыг тэвчих тэвчээр л байгаа, учир нь Би үүнийг Өөрийнхөө ажлын төлөө л хийдэг. Би бохир заваан, тэрслүү байдлыг “түүхий эд” болгон сонгосон учраас л та нар Миний үйл хэргийг харсан; эс бөгөөс Би энэ өтнүүдэд Өөрийн үйл хэргийг яавч илчлэхгүй байх байсан юм. Би та нар дээр дурамжхан ажилладаг ба Израильд хийсэн ажлаа дуртайяа, мэрийн хийсэнтэй минь огтхон ч адилгүй. Би Өөрийгөө хүчлэн та нарын дунд үг хэлэнгээ уураа барьж байна. Хэрвээ илүү агуу ажлын минь төлөө байгаагүйсэн бол ийм өтнүүдийг байнга харахыг Би яаж тэвчиж чадах юм бэ? Миний нэрийн төлөө байгаагүйсэн бол Би аль хэдийн хамгийн өндөрт гарч, энэ өтнүүдийг овоолсон өтөг бууцтай нь хамт үнс нурам болтол шатаах байлаа! Миний суу алдрын төлөө байгаагүйсэн бол нүдний минь өмнө толгойгоо сэгсрэн Намайг илт эсэргүүцэхийг энэ муу ёрын чөтгөрүүдэд Би яаж зөвшөөрч чадах юм

бэ? Өөрийн ажлыг өчүүхэн төдий ч саад бартаагүйгээр төвөггүй хэрэгжүүлэхийн төлөө байгаагүйсэн бол Намайг дураараа хүчирхийлэхийг өт-шиг энэ хүмүүст зөвшөөрч яаж чадах юм бэ? Израилийн тосгон дахь зуун хүн Намайг эсэргүүцэхийн тулд ийнхүү боссон бол хэдий тэд Надад тахил өргөсөн ч гэсэн, бусад хотын хүмүүс хэзээ нэгэн цагт дахин тэрслэхээс сэргийлэхийн тулд Би тэднийг устгаж, газрын гаваар оруулах байсан юм. Би бүхнийг залгигч гал бөгөөд халдахыг тэвчдэггүй. Хүмүүсийг бүгдийг нь Би бүтээсэн учраас Миний хэлсэн, хийсэн юуг ч хүн дуулгавартай дагах ёстой ба тэрсэлж болохгүй. Миний ажилд хошуу дүрэх эрх хүмүүст байхгүй, Миний ажил болон Миний үгийн юу зөв, юу буруу болохыг задлан шинжлэхэд тэд бүр ч тохирохгүй. Би бол бүтээлийн Эзэн бөгөөд бүтээгдсэн зүйлс Намайг хүндлэх зүрх сэтгэлээр Миний шаарддаг бүхнийг биелүүлэх ёстой; тэд Надад учирлахаар оролдох ёсгүй, ялангуяа эсэргүүцэх ёсгүй. Би Өөрийн эрх мэдлээр ард түмнээ засагладаг бөгөөд Миний бүтээлийн хэсэг болох бүх хүн Миний эрх мэдэлд захирагдах ёстой. Хэдийгээр өнөөдөр та нар Миний өмнө зоригтой, давилуун байж, Миний зааж сургадаг үгэнд дуулгаваргүй хандаж, ямар ч айдсыг мэддэггүй ч тэрслүү байдлыг чинь Би зөвхөн тэвчээрээр хариулдаг; шалихгүй жаахан өтнүүд овоолсон өтөг бууцан дахь хог шороог хөдөлгөснөөс болоод Би уурсаж, ажилдаа нөлөөлөхгүй. Эцгийнхээ хүслийн төлөө Би зэвүүцэж, үзэн яддаг бүх зүйлийнхээ үргэлжилсэн оршин тогтнолыг тэвчдэг агаад бүх айлдвар маань дуусах хүртэл, мөн Өөрийн эцсийн мөчийг хүртэл ийнхүү тэвчинэ. Санаа бүү зов! Би нэргүй өттэй ижил түвшинд очиж чадахгүй, мөн ур чадварынхаа хэмжээг чамтай харьцуулахгүй. Би чамайг үзэн яддаг ч тэвчиж чадна. Чи Надад дуулгаваргүй ханддаг ч Эцгийн минь Надад амласан, чамайг гэсгээх өдрөөс минь зугтаж чадахгүй. Бүтээгдсэн өтийг бүтээлийн Эзэнтэй харьцуулж болно гэж үү? Намар цагт, унаж буй навчис үндэс рүүгээ буцдаг; чи “эцгийнхээ” гэр лүү буцаж, Би Эцгийнхээ хажууд буцан очно. Намайг Эцгийн минь энхрий зөөлөн хайр дагалдаж, чамайг эцгийн чинь дэвслэлт дагана. Надад Миний Эцгийн алдар байх болно, чамд эцгийн чинь ичгүүр байна. Чамд хань болгохын тулд Би удаан хугацаанд барьж байсан гэсгээлтээ ашиглана, чи хэдэн арван мянган жилийн турш завхарсаар ирсэн хуршсан махан биеэрээ Миний гэсгээлттэй тулгарна. Чамд хийсэн, тэвчээр дагалдсан үгийн ажлаа Би дуусгасан байх болно, чи Миний үгэн дэх гай гамшгийг туулах үүрэг гүйцэтгэж эхэлнэ. Би асар ихээр баярлан хөөрч, Израильд ажиллана; чи цурхиран уйлж, шүдээ хавиран, шавар шавхай дунд амьдарч, насан эцэслэнэ. Би анхдагч хэлбэрээ эргүүлэн

олж аваад, чамтай хамт бузар заваанд үлдэхээ болино, харин чи анхдагч үзэшгүй муухай байдлаа эргүүлэн олж аваад, овоолсон өтөг бууцыг нүхлэн амьдарсаар байна. Миний ажил болон үг дуусах үед энэ нь Миний хувьд баяр хөөртэй өдөр байх болно. Эсэргүүцэл, тэрслүү байдал чинь дуусах үед энэ нь чиний цурхиран уйлах өдөр байх болно. Би чамайг өрөвдөхгүй, чи Намайг дахин хэзээ ч харахгүй. Би чамтай ярилцахаа болино, чи Надтай дахин хэзээ ч тааралдахгүй. Би тэрслүү байдлыг чинь үзэн ядна, чи Миний хайр татам байдлыг санана. Би чамайг цохиж, чи Намайг дурсан санана. Би баяртайяа чамаас салж одно, чи Надад өртэйгээ мэднэ. Би чамайг дахин хэзээ ч харахгүй, харин чи Надад үргэлж найдлага тавина. Чи одоогоор Намайг эсэргүүцдэг учраас Би чамайг үзэн ядна, харин Би одоо чамайг гэсгээдэг учраас чи Намайг үгүйлэн санана. Би чамтай хамт амьдрахыг хүсдэггүй боловч үүнийг чи гашуунаар хүсэн эрмэлзэж, үүрд уйлна, учир нь чи Надад хийсэн бүхэндээ харамсана. Чи тэрслүү байдал болон эсэргүүцэлдээ харуусаж, харамссандаа бүр нүүрээ газарт наан, Миний өмнө унаад, Надад ахин хэзээ ч дуулгаваргүй хандахгүй хэмээн тангараглана. Гэхдээ чи зүрх сэтгэлдээ ганцхан Намайг хайрлах боловч Миний дуу хоолойг хэзээ ч сонсож чадахгүй. Би чамайг өөрөөсөө ичихэд хүргэнэ.

Одоо Би, Намайг аргалах цадиггүй махан биеийг чинь харж байгаа бөгөөд чамд зүгээр л бага зэрэг анхааруулга өгч байгаа ч чамд “үйлчлэхийн” тулд гэсгээлт ашиглахгүй. Чи Миний ажилд ямар үүрэг гүйцэтгэдгээ мэдэх ёстой, тэгвэл Би сэтгэл хангалуун байх болно. Үүнээс цааших асуудлууд дээр хэрвээ чи Намайг эсэргүүцвэл, Миний мөнгийг зарцуулбал, Ехова Надад зориулсан тахилыг идвэл, өтнүүд та нар нэг нэгнээ хазвал, эсвэл нохой шиг амьтад та нар тэмцэлдэж, өөр хоорондоо хүч хэрэглэвэл—Би алийг нь ч анхаарахгүй. Та нар өөрсдийгөө ямархуу зүйл болохоо л мэдэж байх хэрэгтэй ба тэгвэл Миний сэтгэл ханана. Энэ бүхнээс гадна, хэрвээ та нар нэг нэг рүүгээ зэвсэг далайж, үгээрээ өөр хоорондоо тэмцэлдэхийг хүсэж байвал тэгж болно; тийм зүйлсэд хөндлөнгөөс оролцох хүсэл Надад байхгүй, хүмүүсийн хоорондох хэрэг явдал Надад ямар ч хамаагүй. Би та нарын хоорондох зөрчилдөөнүүдийг анхаардаггүй юм биш; зүгээр л Би та нарын нэг биш, тиймээс та нарын дунд оршдог асуудлуудад оролцдоггүй. Би Өөрөө бүтээгдсэн зүйл биш бөгөөд энэ дэлхийнх биш тул хүмүүсийн үймсэн амьдрал болон тэдний хоорондох замбараагүй, зохисгүй харилцаануудыг үзэн яддаг. Би ялангуяа шуугин хашхиралдсан бөөн хүнийг үзэн яддаг. Гэхдээ Би бүтээгдсэн зүйл нэг бүрийн

зүрх сэтгэл дэх хольцыг гүн гүнзгий мэддэг бөгөөд та нарыг бүтээхээсээ өмнө Би хүний зүрх сэтгэлийн гүнд оршдог шударга бус байдлыг аль хэдийн мэдэж байсан, мөн хүний зүрх сэтгэл дэх бүх шударга бус, зальжин байдлыг мэдэж байсан. Тиймээс хүмүүсийг зөвт бус зүйл хийх үед ямар ч ул мөр байхгүй байсан ч гэсэн, зүрх сэтгэлдээ өвөрлөсөн зөвт бус байдал чинь Миний бүтээсэн бүх зүйлийн баялаг байдлаас даван гардаг гэдгийг Би мөн л мэднэ. Та нар дор бүрнээ үй олон хүний оройд хүртэл өргөгдсөн; олон түмний өвөг дээдэс байхаар өргөгдсөн. Та нар туйлын зэрлэг балмад ба бүх өтний дунд галзууран гүйж, амар тайван орогнох газар эрж хайн, өөрсдөөсөө жаахан өтнүүдийг залгихаар оролддог. Зүрх сэтгэл чинь хорлонтой, зэвүүн байдаг бөгөөд далайн ёроолд живсэн хий үзэгдлүүдийг ч даван гарсан. Та нар өтөг бууцны ёроолд оршин сууж, дээрээс доорх хүртэл өтнүүдийг үймүүлэн амар тайванг нь алдагдуулж, өөр хоорондоо хэсэг зуур тэмцэлдээд, дараа нь тайвширдаг. Та нар өөрсдийн байрыг мэддэггүй мөртөө өтөг бууцан дотор бие биетэйгээ тэмцэлдсээр байдаг. Тийм тэмцлээс та нар юу олж авч чадах юм бэ? Хэрвээ та нар үнэхээр Намайг хүндэлдэг зүрх сэтгэлтэй байсан бол Миний ар хударгаар бие биетэйгээ тэмцэлдэж яаж чадах юм бэ? Байр суурь чинь хэчнээн өндөр байх нь хамаагүй, чи бол өтөг баасан доторх өмхий үнэртэй өчүүхэн өт хэвээр бус уу? Чи далавч ургуулан, тэнгэрийн тагтаа болж чадах уу? Өмхий үнэртэй, өчүүхэн жаахан өтнүүд та нар Ехова Миний тахилын ширээнээс тахил хулгайлдаг; ингэснээрээ та нар сүйрч, бүтэлгүйтсэн нэр хүндээ аварч, Израилийн сонгогдсон ардууд болж чадна гэж үү? Ичгүүргүй өөдгүй амьтад! Тахилын ширээн дээрх тэр тахилуудыг хүмүүс Намайг хүндэлдэг сайхан сэтгэлийнхээ илэрхийлэл болгон Надад өргөсөн юм. Тэдгээр нь Миний хяналт, Миний хэрэглээнд зориулагддаг тул чи хүмүүсийн Надад өгсөн бяцхан хүүрзгэнийг Надаас дээрэмдэж яаж болох юм бэ? Чи Иудас болохоос айдаггүй гэж үү? Газар нутаг чинь цусан талбай болохоос айхгүй байна уу? Ичгүүргүй амьтан! Хүмүүсийн өргөн барьсан хүүрзгэнүүд өт чиний ходоодыг тэжээхийн төлөө байдаг гэж чи бодож байна уу? Чамд Миний өгсөн зүйл бол чамд өгөхдөө үнэн сэтгэлээсээ, дуртайяа өгдөг зүйл юм; Миний чамд өгөөгүй зүйл Миний мэдэлд байх ёстой. Чи зүгээр л Миний тахилуудыг дураараа хулгайлж болохгүй. Ажиллаж буй Нэгэн бол бүтээлийн Эзэн—Ехова Би бөгөөд хүмүүс Надаас болж тахил өргөдөг. Энэ нь ийш тийш гүйсний чинь нөхөн төлбөр гэж чи бодож байна уу? Үнэхээр ичгүүргүй юм! Чи хэний төлөө ийш тийш гүйдэг юм бэ? Өөрийнхөө төлөө биш гэж үү? Чи яагаад Миний тахилуудыг хулгайлдаг юм бэ? Чи яагаад Миний түрийвчнээс мөнгө

хулгайлдаг юм бэ? Чи Искаротын Иудасын хүү биш гэж үү? Ехова Надад өгсөн тахилуудыг тахилчид эдлэх учиртай. Чи тахилч мөн үү? Чи Миний тахилуудыг маадайн идэж зүрхэлдэг ба бүр тэдгээрийг ширээн дээр тавьдаг; чи ямар ч үнэ цэнгүй! Үнэ цэнгүй өөдгүй амьтан! Ехова Миний гал чамайг үнс нурам болгон шатаана!

МАХАН БИЕТЭЙ ХЭН Ч УУР ХИЛЭНГИЙН ӨДРӨӨС ЗУГТАЖ ЧАДАХГҮЙ

Өнөөдөр Би та нарын оршин тогтнолын төлөө, мөн Өөрийнхөө ажлыг төвөггүй явуулахын төлөө, бүхий л орчлон ертөнц даяарх Өөрийн нээлтийн ажлыг илүү зохистой, төгс байдлаар явуулахын төлөө та нарт сануулга өгч, бүх улс, үндэстний хүмүүст Өөрийн үг, эрх мэдэл, сүр жавхлан, шүүлтийг илчилдэг. Та нарын дунд Миний хийдэг ажил бол бүхий л орчлон ертөнц даяар хийх Миний ажлын эхлэл билээ. Одоо аль хэдийн эцсийн өдрүүдийн цаг үе болсон хэдий ч “эцсийн өдрүүд” гэдэг нь эрин үеийн л нэр гэдгийг мэдэж ав; яг л Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийн адилаар энэ нь сүүлчийн хэдхэн жил, сарыг бус, нэг эрин үеийг хэлдэг бөгөөд бүхий л эрин үеийг илтгэдэг. Гэсэн ч эцсийн өдрүүд нь Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үеэс нэлээд ялгаатай. Эцсийн өдрүүдийн ажил Израильд биш, харин Харь үндэстнүүдийн дунд явагддаг; энэ нь Израилийн гаднах бүх үндэстэн, овгийн хүмүүсийг Миний сэнтийн өмнө байлдан дагуулах явдал юм, ингэснээр орчлон ертөнц даяарх Миний алдар суу бүхий л сансар, огторгуйг дүүргэж чадна. Ингэснээр Би илүү агуу алдрыг олж авч, ингэснээр газар дээрх бүх бүтээл Миний алдрыг үндэстэн бүрд, үеийн үед үүрд дамжуулан, тэнгэр газар дахь бүх бүтээл газар дэлхий дээр олж авсан бүх алдрыг минь харж чадна. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил бол байлдан дагуулалтын ажил юм. Энэ нь газар дээрх бүх хүний амьдралын удирдамж биш, харин газар дээрх хүн төрөлхтний барагдашгүй, олон мянган жилийн урт удаан зовлонт амьдралын төгсгөл билээ. Үүний үр дүнд, эцсийн өдрүүдийн ажил нь Израиль дахь хэдэн мянган жилийн ажилтай адил байж чадахгүй, Бурханыг хоёр дахь удаа бие махбодтой болох хүртэл хоёр мянган жил үргэлжилсэн Иудей дахь хэдхэн жилийн ажилтай ч адил байж чадахгүй. Эцсийн өдрүүдийн хүмүүс махбодоор дахин илэрсэн Золин Аврагчтай л учирч, Бурханы хувийн үг, ажлыг хүлээн авдаг. Эцсийн өдрүүд дуусах хүртэл хоёр мянган жил болохгүй; энэ нь Есүс Иудейд Нигүүлслийн эрин үеийн ажлыг

явуулсан үеийнх шиг богинохон байх болно. Учир нь эцсийн өдрүүд бол бүхий л эрин үеийн төгсгөл юм. Эдгээр нь Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт, төгсгөл бөгөөд хүн төрөлхтний зовлонт амьдралын аяныг дуусгадаг. Энэ нь бүх хүн төрөлхтнийг шинэ эрин үед аваачдаггүй, хүн төрөлхтний амьдралыг ч үргэлжлүүлдэггүй; тэгэх нь Миний удирдлагын төлөвлөгөөнд, эсвэл хүний оршин тогтнолд ямар ч ач холбогдол агуулахгүй. Хүн төрөлхтөн энэ маягаараа үргэлжлүүлсээр байвал эрт орой хэзээ нэгэн цагт диаволд бүхлээрээ залгиулж, Надад харьяалагддаг тэр сүнснүүд эцэстээ түүний гарт сүйрэх байсан. Миний ажил зургаан мянган жил л үргэлжилдэг бөгөөд бүх хүн төрөлхтнийг хянах муу ёрын нэгний хяналт ч бас зургаан мянган жилээс хэтрэхгүй гэж Би амласан. Ингээд одоо цаг нь боллоо. Би үргэлжлүүлэх ч үгүй, цаашид хойшлуулах ч үгүй: Эцсийн өдрүүдэд Би Сатаныг ялна, Би Өөрийн бүх алдрыг эргүүлэн авч, газар дээр Надад харьяалагддаг бүх сүнсийг буцаан авна, ингэснээр зовлонд нэрвэгдсэн эдгээр сүнс зовлонгийн далайгаас зугтаж, тийнхүү газар дээрх Миний ажил бүхэлдээ дуусна. Энэ өдрөөс хойш Би дахин хэзээ ч газар дээр махбод болохгүй, Миний бүхнийг хянагч Сүнс дахин хэзээ ч газар дээр ажиллахгүй. Газар дээр Би нэг л зүйлийг хийх болно: Би газар дээрх итгэмжит хот минь болох ариун хүн төрөлхтнийг дахин бүтээнэ. Гэхдээ Би бүхий л дэлхий ертөнцийг устгахгүй, бүх хүн төрөлхтнийг ч сөнөөхгүй гэдгийг мэдэж ав. Би үлдсэн тэр гуравны нэгийг нь буюу Намайг хайрладаг, Надаар бүрэн байлдан дагуулагдсан гуравны нэгийг нь авч үлдээд, энэ гуравны нэгийг хуулийн доорх израильчуудын адилаар газар дээр үржүүлж, өсгөн олшруулж, тэднийг элбэг дэлбэг хонь мал, газар дэлхийн бүх эд баялгаар тэтгэнэ. Энэ хүн төрөлхтөн Надтай хамт үүрд үлдэх боловч өнөөдрийн хөөрхийлөлтэй бузар хүн төрөлхтөн биш, харин Миний олж авсан бүх хүнээс бүрдсэн хүн төрөлхтөн байх болно. Ийм хүн төрөлхтнийг Сатан сүйтгэж, үймүүлж, бүслэн авахгүй ба энэ нь Сатаныг ялснаас минь хойш газар дээр оршин тогтнох цорын ганц хүн төрөлхтөн байх болно. Энэ нь өнөөдөр Миний байлдан дагуулсан, Миний амлалтыг хүртсэн хүн төрөлхтөн юм. Иймээс, эцсийн өдрүүдэд байлдан дагуулагдсан хүн төрөлхтөн нь бас өршөөгдөн уучлагдаж, Миний мөнхийн ерөөлийг хүртэх хүн төрөлхтөн юм. Энэ нь Сатаныг ялан дийлсний минь цорын ганц нотолгоо, Сатантай хийсэн тулааны минь цорын ганц олз омог байх болно. Дайны эдгээр олз омгийг Би Сатаны эзэмшлээс аварсан бөгөөд Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний цорын ганц биелэлт, үр жимс юм. Тэд үндэстэн, шашны урсгал

бүрээс болон орчлон ертөнц даяарх газар нутаг, улс орон бүрээс гаралтай. Тэд өөр өөр яс үндэс, хэл, зан заншил, арьсны өнгөтэй ба бөмбөрцгийн бүх үндэстэн, урсгал даяар, тэр ч бүү хэл дэлхийн өнцөг булан бүрд тархсан байдаг. Эцэст нь тэд бүрэн төгс хүн төрөлхтөн буюу Сатаны хүчинд авташгүй хүмүүсийн цугларалтыг бүрдүүлэхийн тулд нэгдэх болно. Хүн төрөлхтний дундах, Миний аварч, байлдан дагуулаагүй хүмүүс далайн гүнд чимээ аниргүй живж, бүхнийг залгигч галд минь мөнхөд шатаагдана. Би Египетийн ууган хөвгүүд, ууган төлийг устгаад, хурганы мах идэж, хурганы цус ууж, хаалганыхаа тотгонд хурганы цусаар тэмдэг тавьсан израильчуудыг л үлдээж байсныхаа адилаар хуучин, туйлын бузар энэ хүн төрөлхтнийг устгана. Миний байлдан дагуулсан хүмүүс болон Миний гэр бүлийнхэн ч бас Хурга Миний махыг идэж, Хурга Миний цусыг уудаг, Надаар золин авруулсан, Надад шүтэн мөргөдөг хүмүүс биш гэж үү? Ийм хүмүүсийг Миний алдар үргэлж дагалддаггүй гэж үү? Хурга Миний махгүй хүмүүс аль хэдийн далайн гүнд чимээгүйхэн живээгүй гэж үү? Өнөөдөр та нар Намайг эсэргүүцдэг ба өнөөдөр Миний үг Израилийн хөвгүүд, ач гуч нарт хэлсэн Еховагийн үгтэй яг адилхан. Гэсэн ч та нарын зүрх сэтгэлийн гүн дэх хөшүүн байдал Миний уур хилэнг хуримтлуулж, махан биед чинь илүү их зовлонг, нүгэлд чинь илүү их шүүлтийг, зөв шударга бус байдалд чинь илүү их уур хилэнг авчирч байна. Өнөөдөр та нар Надад ингэж хандаж байхад Миний уур хилэнгийн өдрөөс хэн зугтаж чадах юм бэ? Хэний зөв шударга бус байдал гэсгээлтийн харцнаас минь зайлж чадах юм бэ? Төгс Хүчит Миний гараас хэний нүгэл мултарч чадах юм бэ? Төгс Хүчит Миний шүүлтээс хэний эсэргүүцэл зайлж чадах юм бэ? Ехова Би Харь үндэстний үр удам болох та нартай ийнхүү ярьж, та нарт хэлдэг Миний үг Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийн бүх айлдвараас давдаг, гэхдээ та нар Египетийн бүх хүнээс илүү хатуу юм. Намайг тайвнаар ажлаа хийх зуур та нар Миний уур хилэнг хуримтлуулдаг бус уу? Төгс Хүчит Миний өдрөөс та нар яаж эсэн мэнд зугтаж чадах билээ?

Би та нарын дунд ийм маягаар ажиллаж, үг хэлсэн, Би маш их эрч хүч, хүчин чармайлт зарцуулсан, гэвч Миний ний нуугүй хэлдэг зүйлийг та нар ер нь хэзээ сонсож байсан юм бэ? Та нар Төгс Хүчит Надад хаана мэхийн ёсолж байсан юм бэ? Та нар Надад яагаад ингэж ханддаг юм бэ? Яагаад та нарын хэлдэг, хийдэг бүхэн Миний уурыг хүргэдэг юм бэ? Яагаад та нарын зүрх сэтгэл ийм хатуу юм бэ? Би ер нь та нарыг цохин унагаж байсан уу? Яагаад та нар Намайг уй гашуу, түгшүүртэй болгохоос өөрийг хийдэггүй юм бэ? Та нар Ехова Миний уур хилэн өөрсөд дээр чинь буух өдрийг хүлээгээ юу? Дуулгаваргүй байдлаас чинь болж

уураа илгээхийг минь та нар хүлээж байна уу? Миний хийдэг бүхэн та нарын төлөө байдаг бус уу? Гэтэл та нар Ехова Надад үргэлж ингэж хандаж ирсэн: тахилыг минь хулгайлж, бэлтрэг, зулзагануудыг тэжээхийн тулд Миний тахилын ширээн дээрх өргөлийг чонын үүрэн дэх гэртээ аваачиж; хүмүүс бие биетэйгээ тэмцэлдэж, ууртай харц, сэлэм жадтайгаар бие биетэйгээ нүүр тулж, баас шиг бохир заваан болгох гэж Төгс Хүчит Миний үгийг жорлон руу чулууддаг. Ёс жудаг чинь хаана байна? Хүн чанар чинь зэрлэг догшин болжээ! Зүрх сэтгэл чинь аль эрт чулуу болон хувирчээ. Миний уур хилэнгийн өдөр ирэх үе бол Төгс Хүчит Миний эсрэг өнөөдөр үйлддэг муу муухайг чинь шүүх үе байх болно гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Ийм маягаар Намайг хууран, Миний үгийг шавар шавхайд хаяж, сонсохгүй байснаар—Миний ар хударгаар ингэж авирласнаар Миний хилэнт харцнаас зайлсхийж чадна гэж та нар бодож байна уу? Миний тахилыг хулгайлж, Миний эд хөрөнгөд санаархахдаа та нар Ехова Миний нүдэнд аль хэдийн харагдсан гэдгээ мэдэхгүй байна уу? Миний тахилыг хулгайлах үедээ тахил өргөдөг тахилын ширээний өмнө хулгайлсан гэдгээ та нар мэдэхгүй байна уу? Намайг ийм маягаар хуурч чадахуйц ухаалаг гэдэгтээ та нар яаж итгэж чадав аа? Миний уур хилэн та нарын жигшүүрт нүглийг зүгээр орхиж яаж чадах юм бэ? Миний догшин уур омог муу ёрын үйлийг чинь зүгээр өнгөрөөж яаж чадах юм бэ? Өнөөдөр үйлддэг муу муухай чинь та нарт гарах гарц нээж өгөхгүй, харин маргаашийн гэсгээлтийг чинь хуримтлуулдаг; энэ нь Төгс Хүчит Миний гэсгээлтийг та нар луу өдөөдөг. Та нарын муу үг, муу үйл Миний гэсгээлтээс зайлж яаж чадах юм бэ? Залбирал чинь яаж Миний чихэнд хүрч чадах юм бэ? Та нарын зөв шударга бус байдалд Би гарах гарц нээж өгч яаж чадах юм бэ? Намайг эсэргүүцдэг муу үйлийг чинь Би яаж зүгээр өнгөрөөж чадах юм бэ? Могойнх шиг хорт хэлийг чинь Би яаж таслахгүй байж чадах юм бэ? Зөв шударга байдлынхаа төлөө та нар Намайг дууддаггүй, харин зөв шударга бус байдлынхаа үр дүнд уур хилэнг минь хуримтлуулдаг. Би та нарыг яаж уучилж чадах юм бэ? Төгс Хүчит Миний нүдэнд үг, үйлдэл чинь бузар заваан байдаг. Төгс Хүчит Миний нүд та нарын зөв шударга бус байдлыг өршөөлгүй гэсгээлт гэж хардаг. Миний зөвт гэсгээлт, шүүлт та нарыг орхиж яахан чадах билээ? Та нар Надад ингэж хандан, Намайг уйтгар гунигтай, уур хилэнтэй болгодог учраас Ехова Би та нарыг гараасаа бултуулж, та нарыг гэсгээж, хараах өдрөө орхиж яахан чадах билээ? Бүх муу үг, яриа чинь аль хэдийн Миний чихэнд хүрснийг та нар мэдэхгүй гэж үү? Та нарын зөв шударга бус байдал Миний зөвт байдлын ариун өмсгөлийг аль хэдийн буртагласныг

мэдэхгүй гэж үү? Дуулгаваргүй байдал чинь аль эрт дүрсхийх уурыг минь хүргэсэн гэдгийг мэдэхгүй гэж үү? Аль хэдийнээс та нар Намайг хилэгнүүлж, тэвчээрийг минь барснаа мэдэхгүй гэж үү? Та нар Миний махбодыг аль хэдийн сүйдэлж, навсайлгаж орхисноо мэдэхгүй гэж үү? Би өнөөг хүртэл тэвчсэн, тийм болохоор Би уураа гаргаж, цаашид та нарт хүлээцтэй хандахгүй. Та нарын муу үйл аль хэдийн нүдэнд минь өртөж, Миний хашхираан аль хэдийн Эцэгийн минь чихэнд хүрсэн гэдгийг та нар мэдэхгүй байна уу? Надад ингэж хандахыг чинь Тэр яаж зөвшөөрч чадах юм бэ? Та нарт Миний хийдэг аливаа ажил та нарын төлөө байдаг бус уу? Гэтэл та нараас хэн чинь Ехова Миний ажлыг илүү их хайрлах болсон бэ? Би сул дорой учраас, мөн зовлон зүдүүр туулсан учраас Эцэгийнхээ хүсэлд үнэнч бус байдаг гэж үү? Та нар Миний зүрх сэтгэлийг ойлгохгүй байна уу? Би та нартай Еховагийн адилаар ярьж байна; Би та нарын төлөө өчнөөн ихийг орхиогүй гэж үү? Эцэгийнхээ ажлын төлөө энэ бүх зовлонг туулахад Би бэлэн байгаа хэдий ч Өөрийнхөө зовлонгоос үүдэн өөрсдөд чинь авчрах гэсгээлтээс та нар яаж чөлөөлөгдөж чадах юм бэ? Та нар Надаас маш ихийг эдлээгүй гэж үү? Өнөөдөр, Миний Эцэг Намайг та нарт хайрласан; та нар Миний элбэг дэлбэг үгээс хавьгүй ихийг эдэлсэн гэдгээ мэдэхгүй байна гэж үү? Миний амийг та нарын амиар болон эдэлдэг зүйлсээр чинь сольсон гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Миний Эцэг Сатантай тулалдахын тулд Миний амийг ашиглаж, бас та нарт Миний амийг хайрлаж, та нарт зуу дахин ихийг хүртээж, маш олон уруу таталтаас зайлсхийх боломж олгосныг мэдэхгүй гэж үү? Миний ажлаар л дамжуулан олон уруу таталт, олон ширүүн гэсгээлтээс чөлөөлөгдсөн гэдгээ та нар мэдэхгүй гэж үү? Надаас болж л Миний Эцэг та нарыг өнөөг хүртэл баясуулан цэнгүүлдэг гэдгийг мэдэхгүй гэж үү? Зүрх сэтгэлд чинь эвэр ургачихсан мэт та нар өнөөдөр яаж ийм хатуу, нугаршгүй хэвээр үлдэж чадна вэ? Намайг газар дэлхийгээс явсны дараа болох уур хилэнгийн өдрөөс өнөөдөр үйлдэж буй муу муухай чинь яаж мултарч чадах юм бэ? Ийм хатуу, нугаршгүй хүмүүсийг Би яаж Еховагийн уур хилэнгээс зугтаалгаж чадах юм бэ?

Өнгөрснийг бодоод үз: Та нар луу чиглэсэн харц минь хэзээ ууртай, дуу хоолой минь хэзээ ширүүн байсан юм бэ? Би хэзээ өчүүхэн зүйлээс болж та нартай маргалдаж байсан бэ? Би хэзээ та нарыг үндэслэлгүйгээр зэмлэж байсан бэ? Би хэзээ та нарыг нүүрэн дээр чинь зэмлэсэн бэ? Би ажлынхаа төлөө л, та нарыг уруу таталт болгоноос хамгаалахын тулд л Эцэгийгээ дууддаг бус уу? Яагаад та нар Надад ингэж ханддаг юм бэ? Та нарын махан биеийг цохиж унагахын тулд Би эрх мэдлээ ер нь ашигласан гэж үү? Та нар яагаад

Миний ачийг ингэж хариулдаг юм бэ? Надад яаж хандах гэж байгаа нь мэдэгдэхгүй байсныхаа дараа та нар халуун ч биш, хүйтэн ч биш байдаг, тэгснээ Намайг аргалахаар оролдож, Надаас юм нуудаг ба ам чинь зөв шударга бус шүлсээр дүүрэн байдаг. Та нарын хэл Миний Сүнсийг хуурч чадна гэж бодож байна уу? Хэл чинь Миний уур хилэнгээс зугтаж чадна гэж бодоо юу? Хэл чинь Ехова Миний үйл хэргийг хүссэнээрээ шүүмжилж болно гэж бодоо юу? Би хүнээр шүүгддэг Бурхан гэж үү? Өчүүхэн өт хорхой Намайг ингэж доромжлохыг Би зөвшөөрч чадна гэж үү? Ийм дуулгаваргүй хөвгүүдийг Би мөнхийн ерөөлдөө байлгаж яаж чадах юм бэ? Та нарын үг, үйлдэл аль хэдийн ил болж, та нарыг ялласан. Би тэнгэрийг дэлгэж, бүх зүйлийг бүтээхдээ ямар ч бүтээлд дураараа оролцохыг зөвшөөрөөгүй, Миний ажлыг, Миний удирдлагыг хүссэнээрээ тасалдуулахыг ямар ч зүйлд бүр ч зөвшөөрөөгүй. Би хэнийг ч, юуг ч тэвчээгүй; Надад хүнлэг бус, харгис ханддаг тэднийг Би яаж өршөөж чадах юм бэ? Миний үгийн эсрэг тэрсэлдэг хүмүүсийг Би яаж уучилж чадах юм бэ? Надад дуулгаваргүй байдаг хүмүүсийг Би яаж өршөөж чадах юм бэ? Хүний хувь заяа Төгс Хүчит Миний гарт байдаг бус уу? Би чиний зөв шударга бус, дуулгаваргүй байдлыг яаж цэвэр ариун гэж үзэж чадах юм бэ? Нүгэл чинь Миний ариун байдлыг бузарлаж яаж чадах юм бэ? Би зөв шударга бус хүмүүсийн хольцоор бохирдохгүй, зөв шударга бус хүмүүсийн өргөлийг ч таалахгүй. Хэрвээ чи Ехова Надад үнэнч байсан бол Миний тахилын ширээн дээрх тахилуудыг өөртөө авч чадах байсан уу? Миний ариун нэрийг доромжлохын тулд хорт хэлээ ашиглаж чадах байсан уу? Ийм маягаар чи Миний үгийн эсрэг тэрсэлж чадах байсан уу? Миний алдар суу, ариун нэрийг чи муу ёрын нэгэн болох Сатанд үйлчлэх хэрэгсэл мэтээр үзэж чадах байсан уу? Ариун хүмүүсээр эдлүүлэхийн тулд Миний амь өгөгдсөн. Амиар минь хүссэнээрээ тоглож, өөр хоорондох зөрчилдөөнийхөө хэрэгсэл болгон ашиглахыг чинь Би яаж зөвшөөрч чадах юм бэ? Та нар яаж ийм харгис цэвдэг байж, сайны зам болон Надад хандах хандлагадаа яаж ийм дутуу дулимаг байж чадна вэ? Эдгээр амийн үгэнд Би ёрын муу үйлийг чинь аль хэдийн бичсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Египетийг гэсгээх үеийн минь уур хилэнгийн өдрөөс та нар яаж зугтаж чадах юм бэ? Та нар ийм маягаар ахин дахин Намайг эсэргүүцэж, Надад тэрслэхийг Би яаж зөвшөөрч чадах юм бэ? Би та нарт илэн далангүй хэлье, цаг нь ирэхэд та нарын гэсгээлт Египетийнхээс илүү тэсвэрлэшгүй байх болно! Та нар Миний уур хилэнгийн өдрөөс яаж зугтаж чадах юм бэ? Би үнэнээр та нарт хэлье: Миний тэвчээр ёрын муу үйлийн чинь төлөө бэлтгэгдсэн ба тэр өдрийн гэсгээлтийн

чинь төлөө оршдог. Намайг тэсгэл алдах үед уур хилэнт шүүлт амсах хүмүүс нь та нар бус уу? Бүх зүйл Төгс Хүчит Миний гарт байдаг бус уу? Тэнгэрийн дор Надад ингэж дуулгаваргүй хандахыг чинь Би яаж зөвшөөрч чадах билээ? Ирнэ гэгдэж байсан атлаа хэзээ ч ирээгүй Мессиаатай уулзсан учраас та нарын амьдрал маш хэцүү байх болно. Та нар Түүний дайснууд биш үү? Есүс та нарын анд нөхөр байсан ч та нар Мессиагийн дайсан юм. Та нар Есүстэй анд нөхөр ч гэсэн, ёрын муу үйл чинь жигшүүрт хүмүүсийн савыг дүүргэсэн гэдгийг мэдэхгүй гэж үү? Та нар Еховатай маш ойр дотно байдаг ч ёрын муу үг чинь Еховагийн чихэнд хүрч, уур хилэнг нь бадраасан гэдгийг мэдэхгүй гэж үү? Тэр яаж чамтай ойр дотно байж, муу үйлээр дүүрэн савыг чинь шатаахгүй байж чадах юм бэ? Тэр яаж чиний дайсан биш байх юм бэ?

АВРАГЧ АЛЬ ХЭДИЙН “ЦАГААН ҮҮЛЭН” ДЭЭР ЭРГЭН ИРСЭН

Аврагчийн ирэхийг нүдээр үзэж чадах юм сан хэмээн хүн хэдэн мянган жилийн туршид эгээрэн хүссэн. Мянга мянган жилийн турш Өөрийг нь санан бэтгэрч, хүсэн мөрөөссөн хүмүүсийн дунд Аврагч Есүс цагаан үүл хөлөглөн, Өөрийн биеэр бууж ирэхийг хүн харахыг хүссэн. Хүн бас Аврагч эргэн ирж, бидэнтэй эргэн нэгдээсэй гэж хүсэн хүлээж байсан. Өөрөөр хэлбэл, хэдэн мянган жилийн туршид хүмүүсээс алс байсан Аврагч Есүсийг буцаад ирээсэй, иудейчүүдийн дунд хийсэн золин аврах ажлаа дахин нэг удаа хэрэгжүүлж, хүнд энэрэнгүй, хайр энэрэлтэй хандаасай, хүний нүглийг уучилж, хүний нүглийг үүрч, тэр ч бүү хэл хүний бүх гэм бурууг үүрч, хүнийг нүглээс гэтэлгээсэй хэмээн хүн хүсэмжилдэг. Тэд Аврагч Есүсийг өмнөхтэйгөө адил хайр татам, нөхөрсөг, эрхэм бөгөөд хэзээ ч хүнд хилэгнэдэггүй, хэзээ ч хүнийг зэмлэдэггүй Аврагч байгаасай, энэ Аврагч нь хүний бүх нүглийг уучилж, хариуцлагыг нь үүрч, бүр хүний төлөө өмнөх шигээ загалмай дээр нас эцэслээсэй гэж хүсэн хүлээдэг. Есүсийг явснаас хойш Түүнийг дагаж байсан шавь нар болоод Түүний нэрийн ачаар аврагдсан ариун хүмүүс бүгд цөхрөнгөө баран Түүнийг санан бэтгэрч, хүлээсээр ирсэн юм. Нигүүлслийн эрин үед Есүс Христийн нигүүлслээр аврагдсан бүх хүн Аврагч Есүс цагаан үүлэн дээр буун ирж, бүх хүний дунд гарч ирэх эцсийн өдрүүд дэх тэр нэгэн баярт өдрийг хүсэмжилсээр байна. Мэдээж энэ бол мөн өнөөдөр Аврагч Есүсийн нэрийг хүлээн авч байгаа бүх хүний хамтын хүсэл юм. Есүс Христ газар дэлхий дээр байхдаа хэлсэн “Би яг л явсан

шигээ ирнэ” гэх үгээ биелүүлэхээр гэнэт ирэхийг нь орчлон ертөнц даяарх Аврагч Есүсийн авралыг мэддэг бүх хүн цөхрөнгөө баран хүсэн хүлээсээр ирлээ. Цовдлуулж, дахин амилсныхаа дараа Есүс цагаан үүлэн дээр тэнгэр өөд буцан явж, Хамгийн Дээд Нэгний баруун талд Өөрийн байрыг эзэлсэн гэж хүн боддог. Үүний адилаар, Есүс Өөрийг нь хэдэн мянган жилийн турш цөхрөнгөө баран хүсэн хүлээсэн хүмүүсийн дунд дахин, цагаан үүлэн дээр (энэ үүл нь Есүс тэнгэр лүү буцахдаа хөлөглөсөн үүлийг хэлж байна) бууж ирэх ба иудейчүүдийн дүр төрх болон хувцастай байх юм. Тэрээр хүний өмнө гарч ирснийхээ дараа тэдэнд хоол хүнс хайрлаж, тэдний төлөө амийн ус ундруулаад, хүмүүсийн дунд хайр, нигүүлслээр дүүрэн, амьд, бодитоор амьдрах болно. Энэ бүх үзэл нь хүмүүсийн боддог зүйл юм. Гэвч Аврагч Есүс ингээгүй; Тэр хүний төсөөлснөөс эсрэг зүйл хийсэн. Эргэн ирэхийг нь хүсэн хүлээж байсан хүмүүсийн дунд Тэр ирээгүй, бас цагаан үүл хөлөглөж бүх хүнд харагдаагүй. Тэр аль хэдийн ирчихсэн боловч хүн мэддэггүй бөгөөд мэдлэггүй хэвээр үлддэг. Хүн Түүнийг зүгээр л зорилгогүй хүлээж байгаа бөгөөд Түүнийг аль хэдийн “цагаан үүлэн” дээр (тэр үүл бол Түүний Сүнс, Түүний үг, Түүний бүхий л зан чанар болоод Тэр юу болох юм) бууж ирчхээд, одоо эцсийн өдрүүдэд бий болгох бүлэг ялагчдынхаа дунд байгаа гэдгийг мэддэггүй. Хүн үүнийг мэдэхгүй: Ариун Аврагч Есүс хүнийг гэсэн хайр, энхрийллээр дүүрэн боловч бузар буртаг, ариун бус сүнснүүдийн амьдран суудаг “сүмүүдэд” ажиллаж яаж чадах юм бэ? Түүний ирэхийг хүн хүлээсээр байгаа боловч зөв шударга бусын махыг идэж, зөв шударга бусын цусыг ууж, зөв шударга бусын хувцас өмсдөг, Түүнд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй, Түүнийг үргэлж сүрдүүлж юм авдаг хүмүүст Тэр яаж харагдаж чадах юм бэ? Хүн Аврагч Есүсийг хайраар дүүрч, энэрэл ундарсан бөгөөд золин авралаар дүүрэн нүглийн тахил юм гэдгийг л хүн мэддэг. Харин Тэр бас зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн, шүүлтээр бялхаж, эрх мэдлийг эзэмшсэн, эрхэм чанараар дүүрэн Бурхан Өөрөө мөн гэдгийг хүн огт мэддэггүй. Иймээс хүн хэдийгээр Золин аврагчийн эргэж ирэхийг эгээрэн хүсэн хүлээж, мөрөөсөл болдог бөгөөд “Тэнгэр” хүртэл хүний залбиралд уярсан ч гэсэн, Өөрт нь итгэдэг ч Өөрийг нь мэддэггүй хүмүүст Аврагч Есүс харагддаггүй.

“Ехова” бол Израиль дахь ажлынхаа үед Миний авсан нэр бөгөөд хүнийг өрөвдөж, хүнийг харааж, хүний амьдралыг замчилж чаддаг израильчуудын (Бурханы сонгосон хүмүүс) Бурхан гэсэн утгатай юм. Энэ нь агуу хүч чадлыг эзэмшсэн, мэргэн ухаанаар дүүрэн Бурхан гэсэн утгатай. “Есүс” бол Иммануел бөгөөд хайраар дүүрэн, энэрлээр дүүрэн, хүнийг золин авардаг нүглийн тахил

гэсэн утгатай юм. Тэр Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийсэн, Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба удирдлагын төлөвлөгөөний нэг хэсгийг л төлөөлж чадна. Өөрөөр хэлбэл, Ехова л Израилийн сонгогдсон хүмүүсийн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан, Мосегийн Бурхан, Израилийн бүх ард түмний Бурхан юм. Иймээс өнөөгийн эрин үед иудей хүмүүсээс бусад бүх израильчууд Еховаг шүтэн мөргөдөг. Тэд тахилын ширээн дээр Түүнд тахил өргөж, сүмд тахилчийн хувцас өмсөн Түүнд үйлчилдэг. Тэдний найддаг зүйл нь Еховагийн дахин илрэлт юм. Зөвхөн Есүс л хүн төрөлхтний Золин аврагч билээ. Тэр бол хүн төрөлхтнийг нүглээс золин аварсан нүглийн тахил юм. Өөрөөр хэлбэл, Есүсийн нэр Нигүүлслийн эрин үеэс гаралтай ба Нигүүлслийн эрин үеийн золин авралын ажлаас болж бий болсон юм. Нигүүлслийн эрин үеийн хүмүүст дахин төрж, аврагдах боломж олгохын тулд Есүс гэх нэр бий болсон бөгөөд энэ нь бүхий л хүн төрөлхтний золин авралын төлөөх онцгой нэр юм. Иймээс Есүс хэмээх нэр золин авралын ажлыг төлөөлж, Нигүүлслийн эрин үеийг илэрхийлдэг. Ехова хэмээх нэр нь хуулийн дагуу амьдарч байсан Израилийн ард түмний төлөөх онцгой нэр юм. Эрин үе, ажлын үе шат болгон дахь Миний нэр ул үндэсгүй биш, харин бэлгэдлийн ач холбогдлыг агуулдаг: Нэр болгон нэг эрин үеийг төлөөлдөг. “Ехова” нь Хуулийн эрин үеийг төлөөлдөг бөгөөд Израилийн ард түмний шүтэн мөргөдөг Бурханаа дууддаг хүндэтгэсэн нэр юм. “Есүс” нь Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба Нигүүлслийн эрин үед золин аврагдсан бүх хүний Бурханы нэр билээ. Хэрэв хүн эцсийн өдрүүдэд бас л Аврагч Есүсийг ирээсэй гэж хүсэн хүлээж, Түүнийг мөн л Иудейд байсан төрхөөрөө ирнэ гэж бодвол бүхэл бүтэн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө Золин авралын эрин үед зогсож, цаашид ахин дэвших боломжгүй болох байлаа. Түүнчлэн эцсийн өдрүүд хэзээ ч ирэхгүй, эрин үе хэзээ ч төгсөхгүй байх байв. Аврагч Есүс зөвхөн хүн төрөлхтний золин аврал болон авралын төлөө байдаг учраас тэр юм. Нигүүлслийн эрин үе дэх бүх нүгэлтний төлөө Би Есүс хэмээх нэрийг авсан бөгөөд бүхий л хүн төрөлхтнийг төгсгөлд аваачих нэр минь энэ биш. Ехова, Есүс, Мессиа нь бүгд Миний Сүнсийг төлөөлдөг боловч, эдгээр нэр Миний удирдлагын төлөвлөгөөний өөр өөр эрин үеийг л илэрхийлдэг болохоос Намайг бүрэн дүүрэн төлөөлдөггүй. Газар дэлхий дээрх хүмүүсийн Намайг дууддаг нэрс нь Миний бүх зан чанарыг болон Би юу болохыг тодорхойлж чадахгүй. Тэдгээр нь зүгээр л, өөр өөр эрин үед Намайг дууддаг өөр өөр нэр юм. Иймээс сүүлийн эрин үе буюу эцсийн өдрүүдийн эрин үе ирэхэд Миний нэр дахин өөрчлөгдөнө. Намайг Мессиа гэх нь байтугай Ехова,

Есүс ч гэж нэрлэхгүй, харин хүчирхэг Төгс Хүчит Бурхан Өөрөө гэж нэрлэх ба энэ нэрийн дор Би бүхий л эрин үеийг төгсгөх болно. Намайг нэг үе Ехова гэдэг байсан. Түүнчлэн Мессиа гэж дууддаг байсан ба хүмүүс хайрлаж хүндэлсэндээ Аврагч Есүс гэж нэг үе нэрлэсэн. Гэвч өнөөдөр Би өнгөрсөн үед хүмүүсийн мэддэг байсан Ехова юм уу Есүс биш, харин эцсийн өдрүүдэд эргэж ирсэн Бурхан, энэ эрин үеийн төгсгөлийг авчрах Бурхан билээ. Би бол газрын мухраас өндийн босож, Өөрийн бүх зан чанараар бялхдаг, эрх мэдэл, нэр төр, алдар суугаар дүүрэн Бурхан Өөрөө билээ. Хүмүүс Надтай хэзээ ч харьцаж байгаагүй, Намайг хэзээ ч мэдэж байгаагүй бөгөөд Миний зан чанарыг хэзээд мэдэхгүй байсаар ирсэн. Дэлхийг бүтээснээс эхлээд өнөөдрийг хүртэл нэг ч хүн Намайг хараагүй. Энэ бол эцсийн өдрүүдэд хүнд харагддаг атлаа хүмүүсийн дунд нуугдаж байдаг Бурхан билээ. Тэрээр хүмүүсийн дунд үнэн, бодитоор амьдран суудаг ба төөнөх нар, дүрэлзэх гал адил хүч чадлаар дүүрч, эрх мэдлээр бялхан байдаг. Миний үгээр шүүгдэхгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй, дүрэлзэх галаар ариусгагдахгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй. Яваандаа бүх үндэстэн Миний үгээс болоод ерөөгдөнө, мөн Миний үгээс болж бут ниргүүлнэ. Энэ маягаар, эцсийн өдрүүдэд бүх хүн Намайг эргэж ирсэн Аврагч гэдгийг, бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулдаг Төгс Хүчит Бурхан гэдгийг, бас нэгэнтээ хүний төлөөх нүглийн тахил байсан боловч эцсийн өдрүүдэд мөн бүх зүйлийг шатаах нарны дөл, бүх зүйлийг илчлэх зөвт байдлын Нар болдгийг минь харна. Эцсийн өдрүүдийн Миний ажил энэ юм. Би бол зөвт Бурхан агаад төөнөх нар, дүрэлзэх гал гэдгийг бүх хүнд харуулахын тулд энэ нэрийг авч, энэ зан чанарыг эзэмшсэн юм. Ингэснээр цорын ганц жинхэнэ Бурхан болох Намайг бүх хүн шүтэн мөргөж, тэгснээрээ тэд Миний жинхэнэ царайг харах юм: Би бол зөвхөн израильчуудын Бурхан биш, мөн зөвхөн Золин аврагч биш, харин тэнгэр, газар, тэнгис далай даяарх бүх бүтээлийн Бурхан билээ.

Аврагч эцсийн өдрүүдэд ирэхдээ мөн л Есүс гэгдэн, дахин Иудейд төрж, Иудейд ажлаа хийсэн бол, Би зөвхөн Израилийн ард түмнийг л бүтээж, Израилийн ард түмнийг л золин аварсан ба Харь үндэстнүүдтэй ямар ч хамаагүй гэдгийг энэ нь нотлох байсан. “Би бол тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн Эзэн” хэмээх Миний үгтэй энэ нь зөрчилдөх байсан бус уу? Би Иудейг орхисон бөгөөд Харь үндэстнүүдийн дунд ажлаа хийдэг, учир нь Би бол зөвхөн Израилийн ард түмний Бурхан биш, харин бүх бүтээлийн Бурхан билээ. Би Израилийн ард түмний Бурхан Ехова төдийгүй Харь үндэстнүүдийн дундах Өөрийн сонгосон бүх хүний Бүтээгч тул эцсийн өдрүүдэд Харь үндэстнүүдийн

дунд гарч ирдэг. Би Израиль, Египет, Ливаныг төдийгүй Израилийн чанад дахь бүх Харь үндэстнийг бүтээсэн. Ийм учраас Би бол бүх бүтээлийн Эзэн билээ. Би Израилийг ердөө л ажлынхаа эхлэлийн цэг болгон ашиглаж, Иудей болон Галилыг золин аврах ажлынхаа түшиц газар болгон хэрэглэсэн, харин одоо бүхий л эрин үеийг төгсгөхдөө Харь үндэстнүүдийг суурин газраа болгон ашиглана. Би Израильд ажлын хоёр үе шатыг (Хуулийн эрин үе ба Нигүүлслийн эрин үеийн ажлын хоёр үе шат) хийсэн бөгөөд Израилийн чанад дахь газар нутаг даяар бас ажлын хоёр үе шатыг (Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе) хэрэгжүүлсээр байна. Харь үндэстнүүдийн дунд Би байлдан дагуулах ажлыг хийж, эрин үеийг ийнхүү төгсгөнө. Хэрвээ хүн, эцсийн өдрүүдэд шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажил хийж эхэлсэн гэдгийг минь мэдэлгүй, Намайг дандаа Есүс Христ гэж дууддаг бол, мөн Аврагч Есүсийн ирэхийг үргэлж хэнхэглэн хүлээдэг бол тийм хүмүүсийг Би Надад итгэдэггүй хүмүүс гэж хэлнэ. Тэд бол Намайг мэддэггүй хүмүүс бөгөөд Надад итгэх итгэл нь хуурамч юм. Тийм хүмүүс Аврагч Есүсийн тэнгэрээс ирэхийг нүдээр үзэж чадах уу? Тэд Миний ирэхийг биш, харин иудейчүүдийн Хааны ирэхийг л хүлээдэг билээ. Ариун бус, хуучин энэ ертөнцийг бүрэн устгахыг минь тэд хүсэн мөрөөсдөггүй, харин өөрсдөө золин аврагдах гэсэндээ Есүсийн хоёр дахиа ирэхийг хүсэн хүлээдэг. Есүс энэхүү бузартсан, зөв шударга бус газраас бүх хүн төрөлхтнийг дахин нэг удаа золин аврахыг тэд хүлээдэг. Ийм хүмүүс эцсийн өдрүүд дэх Миний ажлыг гүйцэлдүүлэх хүмүүс болж яаж чадах юм бэ? Хүний хүсэл Миний хүслийг биелүүлж, Миний ажлыг хэрэгжүүлэх чадалгүй, учир нь хүн ердөө л Миний урьд нь хийсэн ажлыг биширч, нандигнадаг болохоос Намайг үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан Өөрөө гэдгийг огт мэддэггүй. Хүн Намайг Ехова, бас Есүс гэдгийг л мэддэг болохоос хүн төрөлхтнийг төгсгөлд аваачих эцсийн өдрүүдийн Нэгэн гэдгийг огт мэддэггүй. Хүний хүсэн хүлээдэг, мэддэг зүйл нь бүгд түүний үзлээс улбаатай бөгөөд энэ нь ердөө л тэдний хоёр нүдээрээ харж чадах зүйл байдаг. Тэр нь Миний хийдэг ажилтай нийцдэггүй, харин зөрчилддөг. Хэрвээ Миний ажил хүний санаагаар болдог байсан бол энэ хэзээ дуусах билээ? Хүн төрөлхтөн хэзээ амралтад орох юм бэ? Бас Би яаж долоо дахь өдөр Амралтын өдөрт орж чадах юм бэ? Би хүний санаа зорилгын дагуу бус, Өөрийнхөө төлөвлөгөө, зорилгын дагуу ажилладаг.

САЙН МЭДЭЭ ТҮГЭЭХ АЖИЛ НЬ БАС ХҮНИЙГ АВРАХ АЖИЛ МӨН

Газар дээрх Миний ажлын зорилгыг, өөрөөр хэлбэл, Миний хүрэхийг хүсэж байгаа эцсийн зорилтыг, мөн энэ ажил бүрэн төгс болохоос өмнө Би үүгээр ямар түвшинд хүрэх ёстойг бүх хүн ойлгох хэрэгтэй. Хүмүүс өнөөдрийг хүртэл Надтай цуг алхчхаад Миний ажил чухам ямар учиртайг ойлгодоггүй бол тэд Надтай хамт дэмий алхаж байсан бус уу? Намайг дагадаг бол хүмүүс Миний хүслийг мэддэг байх ёстой. Би газар дээр хэдэн мянган жилийн турш ажиллаж байгаа бөгөөд өнөөдөр ч гэсэн Өөрийн ажлыг энэ маягаар хэрэгжүүлж байна. Миний ажил асар олон төслийг хамардаг хэдий ч зорилго нь нэг хэвээрээ байдаг; жишээлбэл, Би хүнд шүүлт, гэсгээлтээр дүүрэн ханддаг хэдий ч Миний хийдэг зүйл түүнийг аврахын төлөө л байдаг, хүнийг бүрэн төгс болсны дараа Өөрийн сайн мэдээг илүү сайн түгээж, Өөрийн ажлыг бүх Харь үндэстний дунд өргөжүүлэхийн төлөө байдаг. Иймээс өнөөдөр, олон хүн аль эртнээс сэтгэлийн гүн хямралд орчхоод байгаа энэ үед ч Би ажилласаар байдаг, хүнийг шүүж, гэсгээхийн тулд хийх ёстой ажлаа Би үргэлжлүүлдэг. Хүн Миний хэлдэг зүйлээс залхчихсан бөгөөд Миний ажлыг анхаарах ямар ч хүсэлгүй байдаг нь үнэн ч гэсэн, Би Өөрийн үүргээ хэрэгжүүлсээр байгаа, учир нь Миний ажлын зорилго өөрчлөгдөлгүй үлддэг бөгөөд Миний анхны төлөвлөгөө ч нурахгүй. Миний шүүлт бол хүнийг Надад илүү дуулгавартай болгохын төлөө, Миний гэсгээлт бол илүү үр дүнтэй өөрчлөгдөх боломжийг хүнд олгохын төлөө юм. Миний хийдэг зүйл Миний удирдлагын төлөө байдаг хэдий ч хүнд ашиг тусгүй зүйл хийж байсан удаа Надад ер үгүй билээ. Үүний учир нь Би Израилын гаднах бүх үндэстнийг яг л израильчууд шиг дуулгавартай болгож, тэднийг жинхэнэ хүн болгохыг хүсдэг, ингэснээр Би Израилын гаднах газар нутагт түшиц газартай болох юм. Энэ бол Миний удирдлага; энэ бол Харь үндэстнүүдийн дунд Миний хэрэгжүүлж буй ажил юм. Одоо ч гэсэн Миний удирдлагыг олон хүн ойлгохгүй л байдаг, учир нь тэд эдгээр зүйлийг огт сонирхдоггүй, гагцхүү өөрсдийнхөө ирээдүй болон хүрэх газарт л санаа тавьдаг. Намайг юу ч хэлсэн байсан тэд Миний хийдэг ажлыг тоосон шинжгүй хэвээрээ л байж, харин ирээдүйд хүрэх газартаа л гагцхүү анхаарлаа төвлөрүүлдэг. Хэрвээ байдал энэ янзаар үргэлжлээд байвал Миний ажил яаж өргөжиж чадах юм бэ? Миний сайн мэдээ яаж дэлхий даяар түгж чадах юм бэ? Миний ажил түгэх үед Би та нарыг бутаргана, мөн Ехова Израилын овог бүрийг

бут ниргэсэнтэй адилаар Би та нарыг бут ниргэнэ гэдгийг мэдэж ав. Өөрийн сайн мэдээг газар дэлхий даяар түгээж, Өөрийн ажлыг Харь үндэстэнд хүргэж, томчуул, хүүхдүүд ялгаагүй Миний нэрийг алдаршуулдаг, Миний ариун нэрийг бүх овог, үндэстний хүмүүс ам амандаа магтан өргөмжилдөг болгохын тулд энэ бүхнийг хийнэ. Ингэснээр энэхүү төгсгөлийн эринд Миний нэр Харь үндэстнүүдийн дунд алдаршиж, Миний үйл хэргийг Харь үндэстнүүд харж, үйл хэргийн минь улмаас тэд Намайг Төгс Хүчит гэж дуудах бөгөөд Миний үг удалгүй биелэх болно. Би бол израилчуудын цор ганц Бурхан төдийгүй, бүх Харь үндэстний, тэр ч байтугай хараасан үндэстнүүдийнхээ ч Бурхан гэдгээ Би бүх хүнд мэдүүлнэ. Би бол бүх бүтээлийн Бурхан гэдгээ бүх хүнд харуулна. Энэ бол Миний хамгийн агуу ажил, эцсийн өдрүүдийн ажлын төлөвлөгөөний минь зорилго ба эцсийн өдрүүдэд биелүүлэх цорын ганц ажил юм.

Хэдэн мянган жилийн турш Миний удирдсаар ирсэн ажил эцсийн өдрүүдэд л хүнд бүрэн илчлэгддэг. Одоо л Би хүнд Өөрийн удирдлагын нууцыг бүрэн нээж байгаа бөгөөд Хүн Миний ажлын зорилгыг мэдэж аваад зогсохгүй, Миний бүх нууцын талаар ойлголттой болсон. Санааг нь зовоодог хүрэх газрынх нь тухай бүх зүйлийг Би хүнд хэлсэн. 5,900 гаруй жилийн турш далдалж байсан Өөрийнхөө бүх нууцыг Би аль хэдийн хүнд дэлгэсэн. Ехова гэж хэн бэ? Мессиа гэж хэн бэ? Есүс гэж хэн бэ? Та нар энэ бүхнийг мэдэх ёстой. Миний ажлын эргэлтийн цэг энэ хэдэн нэрд бий. Та нар үүнийг ойлгов уу? Миний ариун нэрийг хэрхэн тунхаглах ёстой вэ? Намайг аль нэг нэрээр минь дуудаж гуйдаг үндэстнүүдэд Миний нэрийг хэрхэн түгээх ёстой вэ? Миний ажил өргөжиж байгаа бөгөөд Би ажлаа аливаа бүх үндэстэнд бүхэлд нь түгээнэ. Миний ажил та нарын дотор нэгэнт хэрэгжсэн тул Ехова Израилд Давидын гэрийн хоньчдыг бут ниргэсэнтэй адилаар Би та нарыг бут ниргэж, үндэстэн бүрийн дунд тараан бутаргана. Учир нь, эцсийн өдрүүдэд Би бүх үндэстнийг хэдэн хэсэг бутартал нь няц дарах бөгөөд ард түмнийг нь шинээр хуваарилна. Намайг дахин эргэж ирэхэд үндэстнүүд Миний дүрэлзэх галаар тогтоосон хилээр аль хэдийн хуваагдчихсан байх болно. Тэр үед Би хүн төрөлхтөнд Өөрийгөө төөнөх нар мэт шинээр илэрхийлж, тэдний хэзээ ч харж байгаагүй Ариун Нэгний дүрээр Өөрийгөө ил тод харуулж, урьд Ехова Би Иудейн овгуудын дунд алхаж байсантайгаа адилаар үй олон үндэстний дунд алхана. Тэр цагаас эхлэн Би газар дээрх хүн төрөлхтний амьдралыг зална. Тэнд тэд Миний алдар сууг гарцаагүй харах ба өөрсдийнх нь амьдралыг залж чиглүүлэх агаар дахь үүлэн баганыг харах нь гарцаагүй, учир нь Би ариун газарт илрэх болно. Хүн Миний

зөвт байдлын өдрийг, түүнчлэн Миний алдар суут илрэлийг харна. Тэр нь Би газар дээр ноёрхол тогтоож, Өөрийн олон хөвгүүнийг алдар суу руу аваачих үе байх болно. Газар дээрх хүмүүс хаа сайгүй мэхийх бөгөөд Миний асрыг хүн төрөлхтний дунд, Миний өнөөдрийн хэрэгжүүлж буй ажлын хадан дээр бат бэх босгоно. Хүмүүс бас сүмд Надад үйлчилнэ. Бохир, жигшүүрт зүйлсэд дарагдсан тахилын ширээг Би яйртал цохиод шинээр хийнэ. Нялх хурга, тугалуудыг ариун тахилын ширээн дээр овоолно. Би өнөөдрийн сүмийг буулгаад шинийг барина. Зэвүүн хүмүүсээр дүүрсэн, одоо байгаа сүм нурах бөгөөд Миний барьсан сүм Надад үнэнч зарц нараар дүүрнэ. Тэд Миний сүмийн суу алдрын төлөө дахин нэг өндийн босож, Надад үйлчилнэ. Намайг агуу алдар суу хүртэх тэр өдрийг та нар гарцаагүй харах ба Би хуучин сүмийг буулгаад шинийг барих тэр өдрийг ч гарцаагүй харна. Түүнчлэн Миний асар хүний ертөнцөд хүрч ирэх тэр өдрийг та нар гарцаагүй харна. Би сүмийг хэмх цохимогцоо Намайг бууж ирэхийг харах хүмүүсийн нүдэн дээр Өөрийнхөө асрыг хүний ертөнцөд авчирна. Бүх үндэстнийг бут цохисныхоо дараа Би тэднийг нэг дор шинээр цуглуулж, тэр цагаас Өөрийн сүмийг барьж, Өөрийн тахилын ширээг тавина, тэгснээр бүгд Надад тахил өргөж, Миний сүмд Надад үйлчилж, Харь үндэстэн дэх Миний ажилд өөрсдийгөө үнэнчээр зориулах болно. Тэд өнөөгийн израилчууд шиг тахилчийн өмсгөл, титмээр гоёх ба Ехова Миний алдар суу тэдний дунд дуурьсаж, Миний сүр жавхлан тэдний дээр эргэлдэж, тэдэнтэй хамт орших болно. Харь үндэстнүүд дэх Миний ажил ч бас ийм маягаар гүйцэлдэнэ. Харь үндэстнүүд дэх Миний ажил Израилд хийсэн Миний ажил шиг байх болно, яагаад гэвэл, Би Израил дахь ажлаа өргөжүүлж, үүнийгээ Харь үндэстнүүдэд түгээх юм.

Одоо үе бол Миний Сүнс агуу зүйлс хийж буй цаг бөгөөд Би Харь үндэстнүүдийн дунд Өөрийн ажлыг эхэлж буй цаг билээ. Түүгээр ч зогсохгүй, одоо бол Миний бүх бүтээгдсэн зүйлийг ангилж, нэг бүрийг нь тус тусын ангилалд нь хуваарилах цаг юм, ингэснээр Миний ажил илүү түргэн, илүү үр дүнтэй явагдах болно. Иймээс бүхий л оршихуйгаа Миний бүх ажилд өргөн барьж, цаашлаад чамд хийсэн Миний бүх ажлыг тодорхой ялган таньж, итгэлтэй болж, Миний ажлыг илүү сайн үр дүнд хүргэхийн тулд бүх хүч чадлаа зориулаач гэж л Би та нараас шаарддаг. Энэ бол чиний ойлгох ёстой зүйл юм. Өөр хоорондоо тэмцэлдэж, буцах зам хайж эсвэл махан биеийн тав тух хөөцөлдөхөөс татгалз, эдгээр нь Миний ажлыг хойшлуулах ба гайхалтай ирээдүйг чинь баллах болно. Тэгэх нь чамд хамгаалалт өгөх нь байтугай харин

ч сүйрэл авчирна. Тэгвэл тэнэглэж байгаа хэрэг болох бус уу? Өнөөдөр чиний шуналтайгаар эдлэн буй зүйлс чинь ирээдүйг чинь яг баллаж буй юм, харин өнөөдөр чиний амсаж буй зовлон чинь л чамайг яг хамгаалж буй билээ. Мултарч гарахад хэцүү уруу таталтад урхидуулахаас бултаж, төөрөлдөж яваад өтгөн мананд ороод нарыг олж чадахгүй болохоос зайлсхийхийн тулд чи эдгээр зүйлийг тодорхой мэдэж байх ёстой. Өтгөн манан сарнихад чи агуу өдрийн шүүлтэд орсноо мэднэ. Тэр үед Миний өдөр хүн төрөлхтөнд ойртсон байх болно. Чи Миний шүүлтээс яаж зугтах юм бэ? Төөнөх нарны халууныг чи яаж тэсэх юм бэ? Миний хайрласан элбэг хангалуун бүхнийг хүн цээжиндээ нандигнахын оронд хэний ч анзаарахааргүй газарт хаядаг. Миний өдөр хүн дээр буух үед хүн элбэг дэлбэг байдлыг минь олж чадахаа болино, эсвэл аль эрт өөрт нь хэлсэн үнэний гашуун үгийг минь ч олж чадахаа болино. Тэрээр гэрлийн гэгээг алдаж, харанхуйд унасан учраас уйлж, орилно. Өнөөдөр та нар ердөө л Миний аман дахь хурц илдийг харж байна. Та нар Миний гартаа барьж буй таяг, эсвэл хүнийг шатаадаг дөлийг минь хараахан үзээгүй байгаа, тийм учраас л та нар одоо ч гэсэн Миний өмнө хямсгар, цадиггүй загнадаг. Тийм болохоор л та нар одоо ч гэсэн гэрт минь Надтай тэмцэлдэж, Миний амаараа хэлсэн зүйлтэй өөрийн хүний хэлээр маргадаг. Хүн Надаас айдаггүй, өнөөдрийг хүртэл Надтай дайсагнасаар ирсэн хэр нь бас л ямар ч айдасгүй байдаг. Та нар амандаа зөв шударга бусын хэл ба шүдтэй. Та нарын үг болон үйл хэрэг Еваг нүгэлд уруу татсан могойнхтой адилхан. Та нар бие биедээ нүдийг нүдээр, шүдийг шүдээр төлдөг бөгөөд өөртөө байр суурь, нэр алдар, ашиг хонжоо булааж авах гэж Миний дэргэд тэмцэлддэг, гэхдээ Би үг, үйл хэргийг чинь сэмхэн ажиглаж байгааг мэддэггүй. Та нарыг Миний дэргэд ирэхээс ч өмнө Би зүрх сэтгэлийн чинь хамгийн гүнийг чагнан мэдсэн. Хүн Миний атгаас мултарч, Миний нүдний ажиглалтаас бултахыг үргэлж хүсдэг боловч Би түүний үг, үйл хэргээс хэзээ ч далдирч байгаагүй. Харин ч тэдгээр үг, үйл хэргийг зориуд хараандаа тусгадаг, ингэснээр Би хүний зөв шударга бус байдлыг гэсгээж, түүний тэрслүү занг шүүж чадна. Тиймээс хүний далд үг, үйл хэрэг үргэлж Миний шүүх суудлын өмнө байж байдаг ба хүний тэрслүү чанар дэндүү их учраас Би хүнийг шүүхээ хэзээ ч зогсоож байгаагүй. Миний ажил бол Миний Сүнсний дэргэд хүний хэлсэн үг, хийсэн ажлыг бүгдийг шатааж, ариусгах явдал юм. Ийнхүү^а, Намайг дэлхийгээс одсон ч хүмүүс Надад үнэнч хэвээр үлдэх ба ариун зарц нарын минь Надад

а. Эх бичвэрт “Ийнхүү” гэдэг үг байдаггүй.

үйлчилдгийн адилаар үйлчилж, газар дээрх Миний ажилд бүрэн төгс болох өдрөө хүртэл үргэлжлэх боломжийг бүрдүүлнэ.

ХУУЛИЙН ЭРИН ҮЕ ДЭХ АЖИЛ

Израильчууд дээр хийсэн Еховагийн ажил нь газар дээрх Бурханы эх нутаг буюу Түүний байдаг ариун газрыг хүн төрөлхтний дунд байгуулжээ. Тэрээр Өөрийн ажлыг Израилийн ард түмнээр хязгаарласан юм. Эхэндээ Тэр Израилийн гадна ажиллаагүй, харин ажлынхаа цар хүрээг хязгаарлахын тулд тохиромжтой гэж үзсэн хүмүүсээ сонгон авчээ. Израиль бол Бурхан Адам, Ева хоёрыг бүтээсэн газар бөгөөд тэрхүү газрын шорооноос Ехова хүнийг бүтээсэн; энэ газар нь газар дэлхий дээрх Түүний ажлын үндэс болсон юм. Ноагийн, бас Адамын үр удам болох израильчууд нь газар дээрх Еховагийн ажлын суурь хүмүүс байсан билээ.

Тухайн үед, Израиль дахь Еховагийн ажлын ач холбогдол, зорилго, алхмууд нь Өөрийн ажлыг дэлхий даяар эхлүүлэх буюу Израилийг төвөө болгон аажмаар Харь үндэстнүүд рүү түгэх явдал байлаа. Энэ бол орчлон ертөнц даяар ажиллахдаа Түүний баримталдаг зарчим—загвар байгуулаад дараа нь орчлон ертөнцийн бүх хүн сайн мэдээг нь хүлээн авах хүртэл загвараа өргөжүүлэх явдал мөн. Эхний израильчууд Ноагийн үр удам байв. Энэ хүмүүст зөвхөн Еховагийн амьсгал өгөгдсөн ба тэд амьдралын үндсэн хэрэгцээгээ хангахуйц зүйлийг ойлгож байсан боловч Ехова ямархуу Бурхан болохыг, хүний төлөөх Түүний хүсэл юу болохыг мэдээгүй, бүх бүтээлийн Эзэнийг хэрхэн хүндэтгэх ёстойгоо бүр ч мэдээгүй. Дуулгавартай дагах^а дүрэм журам, хууль байсан эсэх, эсвэл бүтээгдсэн зүйл нь Бүтээгчийн төлөө хийх ёстой үүрэг байсан эсэх тухайд бол, Адамын үр удам эдгээрийн алийг ч мэддэггүй байлаа. Гэр бүлээ тэжээхийн тулд эр нөхөр нь хөлсөө урсган хөдөлмөрлөж, эхнэр нь нөхөртөө захирагдаж, Еховагийн бүтээсэн хүн төрөлхтнийг үргэлжлүүлэх ёстой гэдгийг л тэд мэддэг байв. Өөрөөр хэлбэл, Еховагийн амьсгал болон амийг л агуулж байсан ийм хүмүүс Бурханы хуулийг хэрхэн дагахыг, эсвэл бүх бүтээлийн Эзэнийг хэрхэн сэтгэл хангалуун байлгахыг мэддэггүй байжээ. Тэд дэндүү багыг ойлгодог байлаа. Иймээс, хэдийгээр тэдний зүрх сэтгэлд гажууд, ов мэхтэй зүйл юу ч байгаагүй, тэдний дунд атаархал, хэрүүл тэмцэл хааяахан

а. Эх бичвэрт “дуулгавартай дагах” гэх хэллэг байдаггүй.

гардаг байсан ч тэд бүх бүтээлийн Эзэн Еховаг мэддэггүй, ойлгодоггүй байв. Хүний эдгээр өвөг дээдэс зөвхөн Еховагийн зүйлийг идэж, Еховагийн зүйлийг эдлэхийг л мэддэг байсан боловч Еховаг хэрхэн хүндлэхийг мэддэггүй байжээ; Ехова бол өвдөг сөгдөн шүтэн мөргөх ёстой Нэгэн гэдгийг тэд мэддэггүй байлаа. Иймээс тэднийг яаж Түүний бүтээл гэж нэрлэж болох юм бэ? Хэрвээ тэгсэн бол “Ехова бол бүх бүтээлийн Эзэн” болон “Тэрээр Өөрийгөө харуулж, Өөрийгөө алдаршуулж, Өөрийгөө төлөөлүүлэхээр хүнийг бүтээсэн” гэдэг үгийг хий дэмий хэлсэн болох бус уу? Еховаг огт хүндэлдэггүй хүмүүс яаж Түүний алдрын гэрчлэл болж чадах юм бэ? Тэд яаж Түүний алдрын илрэл болж чадах юм бэ? Тэгвэл “Би хүнийг Өөрийн дүрээр бүтээсэн” гэх Еховагийн үг, муу ёрын нэгэн болох Сатаны гар дахь зэвсэг болох бус уу? Тэгвэл эдгээр үг нь Ехова хүнийг бүтээсний ичгүүрийн тэмдэг болох бус уу? Ажлын тэрхүү үе шатыг гүйцэлдүүлэхийн тулд Ехова хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа Адамаас эхлээд Ноаг хүртэл тэдэнд зааварчилж, залж чиглүүлээгүй юм. Харин ч үерээр дэлхийг устгасны дараа л Тэр, Ноа болон бас Адамын үр удам болох израильчуудыг албан ёсоор залж чиглүүлж эхэлсэн билээ. Израиль дахь ажил болон айлдвар нь Израилийн газар нутаг даяар амьдарч байсан Израилийн бүх ард түмэнд удирдамж өгсөн бөгөөд Ехова хүнд амьсгал үлээн оруулж, Өөрийн амийг өгөөд, тоос шорооноос бүтээгдсэн хүнийг бий болгож чадахаар үл барам, хүн төрөлхтнийг шатааж, харааж, Өөрийн таягийг ашиглан хүн төрөлхтнийг удирдаж чадна гэдгийг хүмүүст харуулсан юм. Иймээс, Ехова газар дээрх хүний амьдралыг залж чиглүүлж, хүн төрөлхтний дунд өдөр шөнийн цагийн дагуу үг хэлж, ажиллаж чадна гэдгийг ч бас тэд харжээ. Хүн Еховагийн атгасан шорооноос үүссэн, түүнчлэн хүнийг Ехова бүтээсэн гэдгийг Өөрийн бүтээлүүдэд мэдүүлэхийн тулд л Тэр энэ ажлыг хийсэн юм. Үүгээр ч зогсохгүй, бусад ард түмэн болон үндэстэн (үнэндээ тэд Израилиас тусгаар байгаагүй, харин Израилиас салбарласан ч мөн л Адам, Евагаас үүссэн байв) Израилиас Еховагийн сайн мэдээг хүлээн аваг гэсэндээ Тэрээр Өөрийн ажлыг Израильд анх хийсэн бөгөөд ингэснээр орчлон ертөнц дээрх бүх бүтээгдсэн зүйл Еховаг хүндэлж, дээдэлж чадах байлаа. Ехова Өөрийн ажлыг Израильд эхлэлгүй, харин оронд нь хүн төрөлхтнийг бүтээхээд газар дээр дураар нь амьдруулсан бол, тэр тохиолдолд махан биеийнхээ уг чанараас болоод хүн (уг чанар гэдэг нь хүн харж чадахгүй зүйлээ хэзээ ч мэдэж чадахгүй гэсэн үг бөгөөд Ехова хүн төрөлхтнийг бүтээснийг мэдэхгүй, Тэр яагаад үүнийг хийснийг бүр ч мэдэхгүй гэсэн үг юм), Ехова хүн төрөлхтнийг бүтээсэн гэдгийг, эсвэл Тэр бол бүх

бүтээлийн Эзэн гэдгийг хэзээ ч мэдэхгүй байх байв. Хэрвээ Ехова хүнийг бүтээж, газар дээр тавьчихаад, дараа нь хэсэг хугацаанд удирдамж өгөхийн тулд хүн төрөлхтний дунд үлдэхийн оронд зүгээр л гар дахь тоосоо гөвөөд, явчихсан бол бүх хүн устан мөхөх байв; бүр Түүний бүтээсэн тэнгэр, газар, бүх зүйл, бүх хүн төрөлхтөн устан мөхөхийн сацуу Сатанаар гишгэлүүлэх байсан юм. Ийм маягаар, “Газар дээр буюу бүтээлүүдийнхээ дунд зогсох ариун газар Түүнд байх ёстой” гэсэн Еховагийн хүсэл сүйрэх байлаа. Иймээс хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа Тэрээр амьдралыг нь залж чиглүүлэхийн тулд тэдний дунд үлдэж, тэдний дундаас тэдэнд хандан үг хэлж чаддаг байсан нь бүгд Түүний хүслийг гүйцэлдүүлж, Түүний төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө байсан юм. Израильд Түүний хийсэн ажил нь бүх зүйлийг бүтээхээсээ өмнө гаргасан төлөвлөгөөгөө биелүүлэх л зорилготой байсан, тиймээс эхлээд израильчуудын дунд ажилласан явдал болон бүх зүйлийг бүтээсэн нь хоорондоо зөрчилдөөгүй, харин хоёулаа Түүний удирдлага, Түүний ажил, Түүний алдрын төлөө, мөн хүн төрөлхтнийг бүтээснийх нь утга учрыг гүнзгийрүүлэхийн төлөө байсан билээ. Тэрээр Ноагаас хойш хоёр мянган жилийн турш газар дээрх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлсэн ба энэ хугацаандаа бүх зүйлийн Эзэн Еховаг хэрхэн хүндэлж, амьдралдаа биеэ хэрхэн авч явж, хэрхэн үргэлжлүүлэн амьдрах, хамгийн гол нь яаж Еховаг гэрчилж, Түүнд дуулгавартай байж, Түүнд хүндлэл үзүүлж, Давид болон түүний тахилчдын адилаар хөгжмөөрөө Еховаг магтан дуулахыг хүмүүст ойлгуулсан билээ.

Ехова ажлаа хийсэн хоёр мянган жилээс өмнө хүн юу ч мэддэггүй байсан бөгөөд бараг бүх хүн төрөлхтөн доройтолд орж, дэлхийг үерээр устгахаас өмнө садар самуун болон завхрал нь гүнзгийрч, зүрх сэтгэлд нь Ехова огт байхгүй, Түүний зам бүр ч байхгүй байсан. Тэд Еховагийн хийх гэж байгаа ажлыг огт ойлгоогүй; тэд эрүүл ухаангүй, тэр ч бүү хэл мэдлэггүй, амьсгалдаг машин шиг байсан бөгөөд хүн, Бурхан, дэлхий ертөнц, амь гэх мэтийг ер мэддэггүй байлаа. Газар дээр тэд могойтой адилаар олон уруу таталт явуулж, Еховад халдсан олон зүйл хэлсэн боловч мэдлэггүй байснаас нь болоод Ехова тэднийг гэсгээж, сахилгажуулаагүй юм. Үерийн дараа л, Ноаг 601 настай байхад Ехова Ноад албан ёсоор харагдаж, түүнийг болон гэр бүлийг нь залж чиглүүлж, үерээс амьд гарсан шувууд, амьтдыг Ноа болон түүний үр удмын хамтаар Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэл нийтдээ 2,500 жил удирджээ. Тэрээр Израильд ажилласан, өөрөөр хэлбэл, албан ёсоор нийт 2,000 жил ажилласан бөгөөд Израильд болон Израилийн гадна нэгэн зэрэг ажилласан хугацаа нь 500 жил байсан тул нийтдээ

2,500 жил болсон байна. Энэ хугацаанд Тэрээр, Еховад үйлчлэхийн тулд сүм барьж, тахилчийн өмсгөл өмсөх ёстой гэдгийг, мөн гутлаараа сүмийг бохирдуулж, сүмийн оройгоос гал бууж өөрсдийг нь шатаахаас зайлсхийхийн тулд сүм рүү үүрээр хөл нүцгэн орох ёстой гэдгийг израильчуудад зааварчилсан билээ. Тэд үүргээ биелүүлж, Еховагийн зохицуулалтад захирагдсан юм. Тэгээд сүмд Еховад залбирдаг байсан ба Еховагаас илчлэл хүлээн авсныхаа дараа буюу Еховаг үг хэлсний дараа тэд хурсан олныг удирдан хөтөлж, Еховад— өөрсдийн Бурханд хүндлэл үзүүлэх ёстой гэдгийг тэдэнд зааж сургажээ. Мөн Ехова тэдэнд сүм болон тахилын ширээ барих ёстой гэж хэлсэн бөгөөд тэднийг хязгаарлаж, Еховаг хүндлэх зүрх сэтгэлтэй болгохын тулд Еховагийн тогтоосон цагт буюу Алгасал баяраар шинэ төрсөн тугал, хургыг бэлдэж, Еховад үйлчлэх тахил болгон тахилын ширээн дээр өргөх ёстой гэж хэлсэн юм. Тэд энэ хуулийг дуулгавартай дагах эсэх нь Еховад үнэнч зангийнх нь хэмжүүр болж байв. Ехова бас тэдэнд зориулан Өөрийн бүтээлийн долоо дахь өдрийг Амралтын өдөр болгон тогтоосон юм. Амралтын өдрийн маргаашийг Тэрээр нэг дэх өдөр буюу Еховаг магтах, Түүнд тахил өргөх, Түүнд зориулан хөгжим тоглох өдөр болгожээ. Энэ өдөр Ехова, тахилын ширээн дээрх тахилыг хүмүүст идүүлэхээр хуваахын тулд бүх тахилчийг дуудан цуглуулсан, ингэснээр тэд Еховагийн тахилын ширээн дээрх тахилыг эдэлж чадах байв. Тэгээд Ехова, тэд бол ерөөгдсөн, Түүнтэй хамт хуваалцдаг ба Түүний сонгосон хүмүүс мөн гэж хэлжээ (энэ нь израильчуудтай хийсэн Еховагийн гэрээ байлаа). Ийм учраас өнөөдрийг хүртэл Израилийн ард түмэн, Ехова бол зөвхөн тэдний Бурхан бөгөөд Харь үндэстнүүдийн Бурхан биш гэж хэлсээр байдаг.

Хуулийн эрин үед Ехова, өөрийг нь даган Египетээс гарсан израильчуудад дамжуулах олон тушаалыг Мосед буулгажээ. Эдгээр тушаалыг Ехова израильчуудад өгсөн бөгөөд египетчүүдтэй ямар ч хамаагүй байв; тэдгээр нь израильчуудыг хязгаарлах зорилготой байсан бөгөөд тэдэнд шаардлага тавихын тулд Тэрээр тушаалуудыг ашиглажээ. Тэд Амралтын өдрийг сахидаг эсэх, эцэг эхээ хүндэлдэг эсэх, хуурамч шүтээн шүтдэг эсэх гэх мэт нь нүгэлтэй юу, эсвэл зөв шударга уу гэдгийг нь шүүх зарчмууд байлаа. Тэдний дундаас зарим нь Еховагийн галд цохиулсан, зарим нь чулуу шидүүлж алуулсан, мөн зарим нь Еховагийн ерөөлийг хүртсэн бөгөөд эдгээр тушаалыг дуулгавартай дагасан эсэхийнх нь дагуу энэ нь шийдэгддэг байв. Амралтын өдрийг сахиагүй хүмүүсийг чулуугаар шидэж алдаг байжээ. Амралтын өдрийг сахиагүй тахилчид Еховагийн галд цохиулдаг байв. Эцэг эхдээ хүндлэл үзүүлдэггүй хүмүүсийг ч

бас чулуу шидэж алдаг байлаа. Энэ бүгдийг Ехова сайшаадаг байв. Амьдралыг нь удирдах хугацаанд хүмүүс Түүний үгийг сонсож, дуулгавартай дагаж, Түүний эсрэг тэрслэхгүй байг гэсэндээ Ехова Өөрийн тушаалууд болон хуулийг тогтоожээ. Шинэ төрсөн хүн төрөлхтнийг хяналтдаа байлгаж, Өөрийнхөө хожмын ажлын суурийг илүү сайн тавихын тулд Тэр эдгээр хуулийг ашигласан юм. Иймээс Еховагийн хийсэн ажилд үндэслэн эхний эрин үеийг Хуулийн эрин үе гэж нэрлэжээ. Ехова олон айлдвар хэлж, ихээхэн ажил хийсэн боловч хүмүүсийг зөвхөн эерэгээр залж чиглүүлж байсан ба хэрхэн хүн байхыг, яаж амьдрахыг, Еховагийн замыг хэрхэн ойлгохыг энэ мэдлэггүй хүмүүст заажээ. Ихэнхдээ, Түүний хийсэн ажил нь хүмүүсээр Өөрийн замыг сахиулж, Өөрийн хуулийг дагуулахын төлөө байв. Уг ажил багахан завхарсан хүмүүс дээр хийгдсэн; энэ нь тэдний зан чанарыг өөрчлөх, эсвэл амийн ахиц гаргах хэмжээнд хүртэл өргөжөөгүй. Тэрээр хүмүүсийг хязгаарлаж, хянахын тулд хуулийг хэрэглэхэд л анхаарч байв. Тухайн үеийн израильчуудын хувьд Ехова бол зүгээр л сүм дэх Бурхан, тэнгэр дэх Бурхан байлаа. Тэрээр үүлэн багана, галан багана байсан юм. Еховагийн тэднээс шаардсан бүхэн нь, өнөөдрийн хүмүүсийн Түүний хууль, тушаал гэж үздэг зүйлийг дагах явдал байв—үүнийг дүрэм ч гэж хэлж болно—учир нь Еховагийн хийсэн зүйл тэднийг өөрчлөхийн төлөө биш, харин хүнд байх учиртай илүү их зүйлийг тэдэнд өгч, тэдэнд Өөрийн амаар зааварчлахын төлөө байсан. Учир нь бүтээгдсэний дараа, хүний эзэмших ёстой зүйл хүнд огт байгаагүй юм. Иймээс Ехова хүмүүст, газар дээр амьдрахдаа эзэмших учиртай зүйлсийг нь өгч, Өөрийн удирдсан хүмүүсийг өвөг дээдэс болох Адам, Евагаас нь илүү гаргасан, учир нь Еховагийн тэдэнд өгсөн зүйл анх Адам, Ева хоёрт өгсөн зүйлээс нь илүү байлаа. Ямартай ч, Еховагийн Израильд хийсэн ажил нь зөвхөн хүн төрөлхтнийг залж чиглүүлэх, хүн төрөлхтөнд өөрсдийнх нь Бүтээгчийг таниулах л зорилготой байв. Тэр тэднийг байлдан дагуулаагүй, өөрчлөөгүй, харин ердөө л залж чиглүүлсэн юм. Энэ бол Хуулийн эрин үе дэх Еховагийн ажлын үр дүн билээ. Энэ бол Израилийн бүхий л газар нутаг дахь Түүний ажлын цаад шалтгаан, жинхэнэ түүх, мөн чанар бөгөөд хүн төрөлхтнийг Еховагийн гарын хяналтад байлгахын төлөөх зургаан мянган жилийн ажлынх нь эхлэл юм. Эндээс Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх илүү олон ажил төрөн гарсан юм.

ЗОЛИН АВРАЛЫН ЭРИН ҮЕИЙН АЖЛЫН ЦААД ҮНЭН ТҮҮХ

Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө болох зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь эхний Хуулийн эрин үе; Нигүүлслийн эрин үе (энэ нь бас Золин авралын эрин үе юм); эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шат буюу гурван эрин үеэс бүрддэг. Энэ гурван эрин үе дэх Миний ажил өөр өөр эрин үеийн дагуу агуулгаараа ялгардаг боловч энэхүү ажил нь үе шат бүрд хүний хэрэгцээнд нийцдэг—илүү нарийн хэлбэл, энэ нь Сатаны эсрэг Миний явуулдаг дайнд Сатаны хэрэглэдэг арга мэхийн дагуу хийгддэг. Миний ажлын зорилго бол Сатаныг ялж, мэргэн ухаан, төгс хүчээ харуулж, мөн Сатаны бүх арга мэхийг илчилж, улмаар Сатаны эзэмшил дор амьдардаг бүхий л хүн төрөлхтнийг аврах явдал билээ. Энэ нь Өөрийн мэргэн ухаан, төгс хүчийг харуулж, мөн Сатаны тэвчишгүй муу муухайг илчлэхийн төлөө байдаг; цаашлаад сайн мууг ялгах, Би бол бүх зүйлийн Захирагч гэдгийг мэдэх, Сатан бол хүн төрөлхтний дайсан, адгийн муу, ёрын нэгэн гэдгийг тодорхой харах боломжийг бүтээгдсэн зүйлсэд олгож, мөн сайн ба муу, үнэн ба гажууд онол, ариун байдал ба бузар булай болон юу агуу, юу жигшүүртэй гэдгийн хоорондох ялгааг туйлын тодорхой ялган таних боломж олгохын төлөө байдаг. Тийнхүү хүн төрөлхтнийг завхруулдаг нь Би биш, зөвхөн Бүтээгч болох Би л хүн төрөлхтнийг аварч, таашаан эдэлж чадах зүйлсийг нь хүмүүст хүртээж чадна хэмээн мэдлэггүй хүн төрөлхтөн Надад гэрчлэл хийж чаддаг болно; Би бол бүх зүйлийн Захирагч, Сатан бол Миний бүтээсэн зүйлсийн нэг төдий бөгөөд хожим нь Надаас урвасан юм гэдгийг тэд мэдэж авна. Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гурван үе шатанд хуваагддаг ба Би бүтээгдсэн зүйлсээр Өөртөө гэрчлэл хийлгэж, тэдэнд Өөрийн хүслийг ойлгуулж, Би бол үнэн гэдгийг мэдүүлэх үр дүнд хүрэхийн тулд ийнхүү ажилладаг. Тиймээс зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнийхөө эхний ажлын үеэр Би хуулийн ажил хийсэн нь Ехова хүмүүсийг залж чиглүүлсэн ажил байлаа. Хоёр дахь үе шат нь Иудейн тосгодод Нигүүлслийн эрин үеийн ажлыг эхлүүлсэн юм. Есүс Нигүүлслийн эрин үеийн бүх ажлыг төлөөлдөг; Тэрээр бие махбодтой болж, загалмайд цовдлогдсон бөгөөд бас Нигүүлслийн эрин үеийг эхлүүлсэн билээ. Тэрээр золин авралын ажлыг гүйцэлдүүлж, мөн Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэхийн тулд цовдлогдсон, иймээс Түүнийг “Өрлөг жанжин”, “Нүглийн тахил”, “Золин аврагч” гэж нэрлэжээ. Үүний үр дүнд, Есүсийн

ажил болон Еховагийн ажил агуулгаараа ялгаатай байсан хэдий ч зарчим нь адилхан байсан юм. Ехова Хуулийн эрин үеийг эхлүүлэн, газар дээрх Бурханы ажилд зориулсан эхлэлийн цэг буюу суурийг тавьж, мөн хууль, тушаал гаргажээ. Энэ нь Түүний явуулсан ажлын хоёр хэсэг бөгөөд тэдгээр нь Хуулийн эрин үеийг төлөөлдөг. Нигүүлслийн эрин үед Есүсийн хийсэн ажил нь хууль гаргаагүй, харин тэдгээрийг гүйцэлдүүлж, улмаар Нигүүлслийн эрин үеийг авчирч, хоёр мянган жил үргэлжилсэн Хуулийн эрин үеийг дуусгасан юм. Тэрээр Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэхийн тулд ирсэн зам гаргагч байсан ч Түүний ажлын гол хэсэг золин авралд оршдог. Иймээс Түүний ажил ч бас шинэ эрин үеийг эхлүүлэх, мөн цовдлолоороо дамжуулан золин авралын ажлыг гүйцэлдүүлэх гэсэн хоёр хэсгээс бүрддэг бөгөөд дараа нь Тэр явж одсон. Тийнхүү Хуулийн эрин үе төгсөж, Нигүүлслийн эрин үе эхэлсэн билээ.

Есүсийн хийсэн ажил тухайн эрин үеийн хүний хэрэгцээний дагуу байв. Түүний ажил хүнийг золин аварч, нүглийг нь уучлахын төлөө байсан болохоор Түүний зан чанар бүхэлдээ даруу байдал, тэвчээр, хайр, чин сүсэг, хүлээцтэй байдал, өршөөл, энэрэн хайрлах сэтгэл байлаа. Тэрээр хүнд арвин их нигүүлсэл, ерөөл болон хүмүүсийн эдэлж чадах бүх зүйлийг авчирсан бөгөөд хүмүүсийн эдэлдэг бүхэн нь амар тайван, баяр хөөр ба Есүсийн хүлээцтэй байдал, хайр, өршөөл, энэрэл байсан юм. Тухайн үед хүмүүст учирсан эдэлж болох арвин их зүйл—зүрх сэтгэл доторх амар тайван, уужуу байдлын мэдрэмж, сүнсний тайтгарал, Аврагч Есүст түшиглэх байдал нь—бүгд тэдний амьдарч байсан эрин үетэй хамаатай байв. Нигүүлслийн эрин үед хүнийг Сатан аль хэдийн завхруулсан байлаа, иймээс бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлыг биелүүлэх нь арвин их нигүүлсэл, эцэс төгсгөлгүй хүлээцтэй байдал, тэвчээр шаардсан, үүнээс ч илүүтэйгээр, ажлын үр дүнд хүрэхийн тулд хүний нүглийг цайруулах хангалттай тахилыг шаардсан юм. Нигүүлслийн эрин үед хүмүүсийн харсан зүйл нь ердөө хүний нүглийг цайруулах Миний тахил—Есүс байв. Бурхан өршөөнгүй, хүлээцтэй байж чадна гэдгийг л тэд мэддэг бөгөөд Есүсийн өршөөл, энэрлийг л хардаг. Энэ нь бүхэлдээ, тэд Нигүүлслийн эрин үед төрснөөс болсон билээ. Иймээс золин аврагдаж чадахаасаа өмнө тэд, Есүсийн хайрласан олон янзын нигүүлслийг эдлэх ёстой болжээ, ингэснээр л үр ашгийг нь хүртэх болно. Ийм маягаар, нигүүлсэл эдэлснээр тэд нүглээ уучлуулж, бас Есүсийн хайрласан тэсвэр, тэвчээрийг эдэлснээр золин авруулах боломжтой болж чадах байлаа. Есүсийн тэсвэр, тэвчээрээр л дамжуулан тэд уучлал хүлээн авч, Есүсийн хайрласан элбэг дэлбэг нигүүлслийг эдлэх эрхийг олж авсан юм. Яг л Есүсийн

хэлсэнчлэн: Би зөв шударга хүмүүсийг биш, харин нүгэлтнүүдийг золин аварч, нүгэлтнүүдэд нүглээ уучлуулах боломж олгохоор ирсэн. Махбод болох үедээ Есүс шүүлт, хараал, хүний халдахыг тэвчдэггүй зан чанарыг авчирсан бол хүн хэзээ ч золин аврагдах боломжгүй байсан бөгөөд үүрд нүгэлтэй хэвээр үлдэх байлаа. Ийм байсан бол зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө Хуулийн эрин үед зогсож, Хуулийн эрин үе зургаан мянган жилээр сунжрах байв. Хүний нүгэл улам их, улам хүнд болж, хүнийг бүтээсний ач холбогдол нь бүхэлдээ талаар болох байлаа. Хүмүүс хуулийн дор Еховад үйлчилж л чадах байсан боловч нүгэл нь анх бүтээгдсэн хүмүүсийнхээс давах байсан юм. Есүс хүн төрөлхтнийг улам их хайрлаж, хүний нүглийг уучилж, хүнд хангалттай өршөөл, өгөөмөр сэтгэл авчрах тусам тэд Есүсээр авруулж, Есүсийн асар их үнээр буцаан худалдаж авсан төөрсөн хурганууд гэж нэрлэгдэх улам их эрхтэй болсон билээ. Сатан ч бас энэ ажилд хөндлөнгөөс оролцож чадахгүй, учир нь нярай хүүхдээ энгэртээ тэвэрдэг энэрэлт эхийн адилаар Есүс дагалдагчдаа хандаж байв. Тэрээр тэдэнд уурлаж, тэднийг жигшээгүй, харин тайтгарлаар дүүрэн байлаа; тэдний дунд Есүс хэзээ ч уурсан хилэгнээгүй, харин нүглийг нь тэвчсэн бөгөөд мунхаглал, мэдлэггүй байдлыг нь хараагүй дүр үзүүлж, “Бусдыг дал дахин долоон удаа уучил” хэмээн хэлэхэд хүрч, Түүний зүрх сэтгэл бусдын зүрх сэтгэлийг уяраасан. Ингэснээр л хүмүүс Түүний тэвчээрээр дамжуулан нүглээ уучлуулсан юм.

Есүс бие махбодтой болохдоо огт сэтгэл хөдлөлгүй байсан хэдий ч шавь нараа үргэлж тайтгаруулж, хангаж, тэдэнд тусалж, тэднийг дэмжсэн билээ. Тэр хэчнээн их ажил хийж, хэчнээн их зовлон туулсан ч бай, хүмүүст хэзээ ч хэтэрсэн шаардлага тавиагүй, харин тэдний нүгэлд үргэлж тэвчээртэй, хүлээцтэй хандсан, тийм болохоор Нигүүлслийн эрин үеийн хүмүүс Түүнийг “хайр татам Аврагч Есүс” хэмээн энхрийлэн нэрлэдэг байв. Тухайн үеийн хүмүүс буюу бүх хүний хувьд Есүст юу байгаа, Тэр юу болох нь өршөөл, энэрэл байлаа. Тэрээр хүмүүсийн гэм бурууг хэзээ ч санаагүй бөгөөд хэзээ ч гэм бурууд нь үндэслэн тэдэнд хандаж байсангүй. Өөр эрин үе байсан учраас хүмүүсийг цадталаа идэг гэсэндээ элбэг арвин хоол хайрладаг байлаа. Тэрээр бүх дагалдагчдаа нигүүлсэнгүй хандаж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, үхсэн хүнийг амилуулж байв. Хүмүүсийг Өөртөө итгүүлж, Түүний хийдэг бүхэн чин сэтгэлээр, үнэнчээр хийгддэг гэдгийг үзүүлэхийн тулд Тэрээр илжирсэн цогцсыг амилуулахад ч хүрсэн бөгөөд үхсэн хүн ч Түүний гарт амилж болно гэдгийг харуулсан. Ийм маягаар Тэр чимээгүйхэн тэвчиж, тэдний дунд

золин авралын ажлаа явуулсан билээ. Есүс, загалмайд цовдлогдохоосоо ч өмнө хүний нүглийг аль хэдийн Өөртөө үүрч, хүний төлөөх нүглийн тахил болсон. Тэрээр цовдлогдохоосоо ч өмнө хүн төрөлхтнийг золин аврахын тулд загалмайн замыг нээсэн байв. Эцэст нь, загалмайд цовдлогдож, загалмайн төлөө Өөрийгөө золиосолж, Өөрийн бүх өршөөл, энэрэл, ариун байдлыг хүн төрөлхтөнд хайрлажээ. Тэрээр хүмүүст үргэлж хүлээцтэй хандаж, хэзээ ч хонзогноогүй бөгөөд тэдний нүглийг уучилж, гэмшихийг захиж, мөн тэсвэр, тэвчээр, хайр агуулж, Түүний мөрийг даган, загалмайн төлөө өөрсдийгөө золиослохыг тэдэнд зааж сургасан юм. Ах, эгч нарыг гэх Түүний хайр Мариаг гэх хайраас нь давсан. Түүний хийсэн ажил бүхэлдээ өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулахыг зарчмаа болгосон ба энэ бүхэн нь Түүний золин авралын төлөө байв. Тэр хаана ч очсон, Өөрийг нь дагаж байсан бүх хүнд нигүүлсэнгүй ханддаг байлаа. Тэрээр ядууг баян, суунги хүнийг алхдаг, сохрыг хардаг, дүлийг сонсдог болгож байв. Тэр ч бүү хэл, хамгийн дорд, ядуу хүмүүс, нүгэлтнүүдийг урьж, Өөртэйгээ нэг ширээнд суулгаж, тэднийг хэзээ ч гололгүй, харин үргэлж тэвчээртэй байж, “Хоньчин зуун хониноосоо нэгийг нь алдвал ерөн есөн хонио орхиод төөрсөн хонио хайхаар явна, тэгээд олох үедээ ихэд баярлан баясна” хэмээн хэлж ч байсан юм. Эм хонь хургаа хайрладгийн адилаар Тэр дагалдагчдаа хайрласан билээ. Тэд мунхаг, мэдлэггүй агаад Түүний нүдээр бол нүгэлтнүүд, түүнчлэн нийгмийн хамгийн доод давхаргын гишүүд байсан хэдий ч бусдын жигшдэг энэ нүгэлтнүүдийг Тэрээр нүдний цэцгий мэт авч үзжээ. Тэр тэднийг тоосон тул тахилын ширээн дээр өргөл болсон хурга мэтээр Өөрийн амийг тэдний төлөө өгсөн юм. Тэрээр зарц нь мэт тэдний дунд явж, Өөрийгөө тэдэнд ашиглуулж, нядлуулж, тэдэнд болзолгүйгээр захирагдсан. Дагалдагчдаа Тэрээр хайр татам Аврагч Есүс байсан боловч өндөр индрээс хүмүүст зааж сургадаг фарисайчуудад өршөөл, энэрлийг бус, харин жигшил, зэвүүцэл харуулсан юм. Фарисайчуудын дунд Тэр их ажил хийгээгүй, хааяа нэг сургаж, зэмлэж байсан ба тэдний дунд золин авралын ажил хийгээгүй, мөн тэмдэг, гайхамшиг ч үзүүлээгүй. Өөрийн бүх өршөөл, энэрлийг дагалдагчдаа хайрлаж, энэ нүгэлтнүүдийн төлөө бүр эцсээ хүртэл тэвчиж, загалмайд цовдлогдон, бүх хүн төрөлхтнийг бүрэн золин аврах хүртлээ доромжлол болгоныг амссан юм. Энэ нь Түүний бүхий л ажил байлаа.

Есүсийн золин авралгүйгээр хүн үүрд нүгэлд амьдарч, нүглийн үр, чөтгөрүүдийн үр сад болох байлаа. Тийнхүү үргэлжилсэн бол бүхий л дэлхий ертөнц Сатаны орогнодог орон буюу тэрний оршин суудаг газар болох байв.

Гэхдээ золин авралын ажил нь хүнд өршөөл, энэрэл үзүүлэхийг шаарддаг; тийм арга замаар л хүн төрөлхтөн уучлал хүлээн авч, эцэстээ бүрэн төгс болгуулж, Бурханаар бүрэн авхуулах эрхийг олж авч чадах байсан юм. Ажлын энэ үе шатгүйгээр зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө өрнөж чадахгүй байх байлаа. Хэрвээ Есүс цовдлогдоогүй бол, хэрвээ Тэр ердөө л өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг зайлуулсан бол хүмүүс нүглээ бүрэн уучлуулж чадахгүй байх байсан юм. Есүс газар дэлхий дээр ажлаа хийн өнгөрүүлсэн гурван жил хагасын хугацаандаа золин авралын ажлынхаа хагасыг л гүйцэлдүүлсэн; дараа нь загалмайд цовдлогдож, нүгэлт махан биеийн төрхтэй болж, ёрын муу нэгэнд өгөгдсөнөөр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж, хүн төрөлхтний хувь заяаг захирах болжээ. Сатаны гарт хүргэгдсэнийхээ дараа л Тэр хүн төрөлхтнийг золин аварсан юм. Гучин гурван жил хагасын хугацаанд Тэрээр газар дээр зовж, дооглуулж, гүтгүүлж, хаягдаж, тэр ч бүү хэл толгой хоргодох газаргүй, амрах газаргүй болоход хүрсэн бөгөөд дараа нь цовдлогдож, Түүний бүхий л оршихуй—ариун агаад гэм зэмгүй бие—загалмайд хадагдсан. Тэрээр бүх төрлийн зовлонг туулсан юм. Эрх мэдэлтэй хүмүүс Түүнийг тохуурхаж, ташуурдаж, цэргүүд бүр нүүр лүү нь нулимсан; гэсэн ч Тэр чимээгүй байж, эцсээ хүртэл тэвчин, үхэн үхтэлээ нөхцөл болзолгүй захирагдаж, улмаар бүх хүн төрөлхтнийг золин аварсан билээ. Тэр үед л Тэрээр амрах боломжтой болсон. Есүсийн хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг л төлөөлдөг; энэ нь Хуулийн эрин үеийг төлөөлдөггүй, эцсийн өдрүүдийн ажлыг ч орлодоггүй. Энэ бол хүн төрөлхтний туулсан хоёр дахь эрин үе болох Нигүүлслийн эрин үе—Золин авралын эрин үе дэх Есүсийн ажлын мөн чанар билээ.

БҮХ ХҮН ТӨРӨЛХТӨН ӨНӨӨГ ХҮРТЭЛ ХЭРХЭН ХӨГЖСӨНИЙГ ЧИ МЭДЭХ ЁСТОЙ

Зургаан мянга гаруй жил хийгдсэн бүхий л ажил эрин үе өнгөрөхийн хэрээр аажмаар өөрчлөгджээ. Энэхүү ажлын өөрчлөлт нь дэлхий ертөнцийн ерөнхий нөхцөл байдал болон нийт хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагад үндэслэсээр ирсэн юм; тийнхүү удирдлагын ажил гагцхүү аажмаар өөрчлөгдсөн билээ. Үүнийг бүтээлийн эхэн үед төлөвлөөгүй. Дэлхий ертөнц бүтээгдэхээс өмнө, эсвэл бүтээгдсэний дараахан Ехова, ажлын эхний үе шат нь хуулийн үе шат, ажлын хоёр дахь үе шат нь нигүүлслийн үе шат, эсвэл ажлын гурав дахь үе шат нь байлдан дагуулалтын үе шат байна, үүнийг эхлээд Моабын үр удмын зарим

хүнээс эхлүүлж, үүгээр дамжуулан бүх орчлон ертөнцийг байлдан дагуулна гэж төлөвлөөгүй. Дэлхийг бүтээснийхээ дараа Тэр эдгээр үгийг огт хэлээгүй, Моабын дараа ч ингэж хэлээгүй; үнэндээ Лотоос өмнө ч Тэр ингэж огт айлдаагүй юм. Бурханы бүх ажил аяндаа хийгддэг. Яг ийм маягаар л Түүний бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө хөгжсөн; дэлхий ертөнцийг бүтээхээсээ өмнө Тэрээр “Хүн Төрөлхтний Хөгжлийн Хураангуй Хүснэгт” гэх мэтийн төлөвлөгөө зохиогоогүй. Өөрийнхөө ажлаар Бурхан Өөрийнхөө юу болохыг шууд илэрхийлдэг; Тэр төлөвлөгөө зохиох гэж тархиа гашилдаггүй. Мэдээж, нэлээд олон эш үзүүлэгч асар олон зөгнөл хэлсэн, гэхдээ Бурханы ажил үргэлж нарийн нягт төлөвлөгдсөөр ирсэн гэж хэлж мөн л болохгүй; тэдгээр зөгнөл нь тухайн үеийн Бурханы ажлын дагуу хэлэгдсэн. Түүний хийдэг бүх ажил нь хамгийн бодитой ажил юм. Тэрээр эрин үе бүрийн хөгжилд нийцүүлэн, аливаа зүйлсийн өөрчлөлтөд үндэслэн ажлаа хэрэгжүүлдэг. Түүний хувьд, ажлаа хэрэгжүүлэх гэдэг нь өвчнийг эмчлэх эм бичиж өгөхтэй адил; Тэрээр ажлаа хийх зуураа ажигладаг ба ажиглалтынхаа дагуу ажлаа үргэлжлүүлдэг. Ажлынхаа үе шат болгонд Бурхан Өөрийн асар их мэргэн ухаан, чадварыг илэрхийлэх чадвартай; Тэрээр тодорхой нэг эрин үеийн ажлын дагуу Өөрийн үлэмж арвин мэргэн ухаан, эрх мэдлийг илчилдэг ба тухайн эрин үеийн турш Өөрийн буцаан авчирсан бүх хүнд бүхий л зан чанараа харуулдаг. Тэрээр эрин үе болгонд хийгдэх хэрэгтэй ажлын дагуу хүмүүсийн хэрэгцээг хангаж, хийх ёстой ажлаа хийдэг. Мөн Сатаны завхруулсан түвшинд үндэслэн хэрэгтэй зүйлээр нь хүмүүсийг хангадаг. Ехова анх Адам, Еваг бүтээх үедээ газар дээр Бурханыг харуулах боломжийг тэдэнд олгосон ба ингэснээр тэд бүтээлийн дунд Бурханд гэрчлэл хийж чадах байв. Гэвч Ева могойд уруу татагдсанахаа дараа нүгэл үйлдэж, Адам ч мөн адил зүйл хийсэн; тэд цэцэрлэг дэх сайн, мууг мэдүүлэгч модны жимсийг хоёулаа идсэн. Тиймээс, Ехова тэдэн дээр нэмэлт ажил явуулах хэрэгтэй болсон юм. Тэдний нүцгэн байгааг хараад Тэр амьтны арьсаар хийсэн хувцсаар биеийг нь халхалсан. Дараа нь Тэрээр Адамд: “Чи эхнэрийнхээ үгийг сонсож, бүү ид гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир чамайг газар шороонд буцтал ... чамаас болж газар хараагдлаа; учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцна” гэжээ. Эмэгтэйд хандан Тэрээр: “Жирэмсний чинь зовлон зүдүүрийг Би улам ихэсгэнэ. Өвдөж зовж чи үр хүүхдээ төрүүлнэ. Эр нөхрөө чи эрмэлзэнэ, нөхөр чинь чамайг захирах болно” гэв. Тэр үеэс эхлээд Тэр тэднийг Еден цэцэрлэгээс хөөж, орчин үеийн хүн одоо газар дэлхий дээр амьдардагтай адилаар цэцэрлэгийн гадна

амьдруулах болсон юм. Бурхан хүнийг бүр анх бүтээх үедээ, бүтээгдсэнийх нь дараа хүнийг могойгоор уруу татуулаад, дараа нь хүн, могой хоёрыг хараана гэж төлөвлөөгүй байв. Түүнд үнэндээ тийм төлөвлөгөө байгаагүй; ердөө аливаа зүйлийн өрнөл л Түүнд бүтээлүүдийнхээ дунд хийх шинэ ажлыг өгсөн юм. Ехова газар дээр Адам, Евагийн дунд энэ ажлаа гүйцэтгэсний дараа хүн төрөлхтөн хэдэн мянган жилийн турш үргэлжлүүлэн хөгжсөн ба “Ехова, дэлхий дээрх хүмүүсийн хорлонт муу нь үлэмж их бас зүрхнийх нь хамаг бодол санаархал ямагт муу муухай болсныг хараад, Өөрөө хүнийг газар дээр бүтээсэндээ харамсан зүрхэндээ ихэд халаглав... Гэвч Ноа Еховагийн мэлмийд тааллыг олжээ.” Өөрийнх нь бүтээсэн хүн төрөлхтөн могойд уруу татагдсанахаа дараа хэтэрхий нүгэлтэй болсон учраас энэ үед Еховагийн хийх илүү их шинэ ажил гарч ирсэн юм. Энэ нөхцөл байдлаас болоод Ехова бүх хүн төрөлхтний дундаас Ноагийн гэр бүлийг өршөөхөөр сонгож, дараа нь дэлхийг үерээр устгах ажлаа хэрэгжүүлжээ. Яг энэ өдрийг хүртэл хүн төрөлхтөн ийм байдлаар үргэлжлүүлэн хөгжиж, улам бүр завхарсан ба хүний хөгжил оргилдоо хүрэх цаг ирэхэд энэ нь хүн төрөлхтний төгсгөл байх болно. Дэлхийн яг эхлэлээс төгсгөл хүртэл Түүний ажлын дотоод үнэн үргэлж ийм байсаар ирсэн бөгөөд үргэлж ийм байна. Энэ нь хүмүүс төрлийнхөө дагуу ангилагдахтай адилхан байх болно; хүн нэг бүр тодорхой ангилалд харьяалагдахаар бүр анхнаасаа урьдчилан тогтоогддог юм огт биш; харин ч хөгжлийн үйл явцыг туулсныхаа дараа л хүн болгон аажмаар ангилагддаг. Эцэст нь, бүрэн аврал хүртэж чадахгүй хэн боловч “өвөг дээдсүүд” рүүгээ буцан очно. Хүн төрөлхтний дундах Бурханы ажлын аль нь ч дэлхий бүтээгдэх үед хэдийнээ бэлтгэгдсэн байгаагүй; харин энэ бол хүн төрөлхтний дундах ажлаа алхам алхмаар илүү бодитой, жинхэнэ байдлаар хэрэгжүүлэх боломжийг Бурханд олгосон зүйлсийн хөгжил юм. Жишээ нь, Ехова Бурхан эмэгтэй хүнийг уруу татуулахын тулд могойг бүтээгээгүй; тэр нь Түүний тусгай төлөвлөгөө байгаагүй, Түүний зориуд урьдчилан төлөвлөсөн зүйл ч байгаагүй. Энэ нь гэнэтийн тохиолдол байсан гэж хэлж болно. Тиймээс, үүнээс болоод Ехова, Адам Ева хоёрыг Еден цэцэрлэгээс хөөж, дахин хэзээ ч хүнийг бүтээхгүй гэж амласан юм. Гэхдээ энэ суурин дээр л хүмүүс Бурханы мэргэн ухааныг олж мэддэг. Урьд нь Миний хэлсэнчлэн: “Би Сатаны явуулгад үндэслэн мэргэн ухаанаа хэрэгжүүлдэг.” Хүн төрөлхтөн хэчнээн завхарсан ч бай, эсвэл могой тэднийг хэрхэн уруу татсан ч бай, Еховад мэргэн ухаан нь байсаар байдаг; тийм болохоор Тэр дэлхий ертөнцийг бүтээснээсээ хойш шинэ ажил эрхэлсэн ба энэхүү ажлын нэг ч алхам хэзээ ч давтагдаж байгаагүй. Сатан тасралтгүй

явуулга хийж, хүн төрөлхтнийг байнга завхруулсаар ирсэн ба Ехова Бурхан Өөрийн ухаалаг ажлыг зогсолтгүй явуулсан билээ. Тэр хэзээ ч бүтэлгүйтээгүй, мөн дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш ажиллахаа хэзээ ч болиогүй. Хүмүүсийг Сатан завхруулсны дараа Тэрээр хүн төрөлхтний завхралын эх сурвалж болсон дайсныг ялахын тулд хүмүүсийн дунд ажилласаар байсан юм. Энэхүү тулаан дэлхийн үүслээс эхлэн өрнөсөн ба дэлхий ертөнцийн төгсгөл хүртэл үргэлжилнэ. Энэ бүх ажлыг хийхдээ Ехова Бурхан Сатанаар завхруулагдсан хүмүүст Өөрийн агуу авралыг хүртээгээд зогсохгүй, мөн тэдэнд Өөрийн мэргэн ухаан, төгс хүчин, эрх мэдлийг харуулсан. Түүнчлэн, эцэст нь Тэрээр тэдэнд зөвт зан чанараа харуулж—хорон мууг шийтгэн, сайныг шагнана. Тэр яг энэ өдрийг хүртэл Сатантай тулалдсан ба хэзээ ч ялагдаагүй. Учир нь Тэр бол ухаалаг Бурхан бөгөөд Түүний мэргэн ухаан Сатаны явуулгад үндэслэн хэрэгждэг. Тиймээс Бурхан тэнгэр дэх бүх зүйлийг Өөрийн эрх мэдэлд захирагдуулаад зогсохгүй, бас газар дээрх бүх зүйлийг хөлийнхөө гишгүүр дор амраадаг, ялангуяа хүн төрөлхтөн рүү дайран довтолж, зовоодог хорон муу хүмүүсийг Өөрийн гэсгээлтэд унагадаг. Энэ бүх ажлын үр дүн нь Түүний мэргэн ухаанаас үүдэн гардаг. Хүн төрөлхтний оршин тогтнолоос өмнө Тэр хэзээ ч Өөрийн мэргэн ухааныг илчлээгүй, учир нь Түүнд тэнгэрт ч, газар дээр ч, эсвэл бүх орчлон ертөнцийн хаана ч ямар ч дайсан байгаагүй бөгөөд байгаль дээрх ямар нэг зүйлд халдан довтолсон харанхуй хүчнүүд байгаагүй юм. Тэргүүн тэнгэрэлчийг Өөрөөс нь урвасны дараа Тэрээр хүн төрөлхтнийг газар дээр бүтээсэн ба хүн төрөлхтнөөс болоод Тэр тэргүүн тэнгэрэлч болох Сатантай хийсэн мянган жилийн дайнаа—ээлж дараалсан үе шат бүрд улам эрчимждэг дайныг албан ёсоор эхлүүлсэн юм. Түүний төгс хүчин болон мэргэн ухаан энэ үе шат болгонд байсан. Тэр үед л тэнгэр, газар дахь бүх зүйл Бурханы мэргэн ухаан, төгс хүчин, ялангуяа Бурханы бодит байдлыг харсан юм. Тэр өнөөдөр ч ийм бодит байдлаар Өөрийн ажлыг хэрэгжүүлсээр байгаа; түүнчлэн, Тэрээр Өөрийн ажлыг хэрэгжүүлэнгээ мэргэн ухаан, төгс хүчээ ч бас илчилдэг. Тэрээр та нарт ажлын үе шат бүрийн дотоод үнэнийг харуулж, Бурханы төгс хүчийг яг яаж тайлбарлахыг харуулахын сацуу Бурханы бодит байдлын тодорхой тайлбарыг харуулдаг.

Иудас Есүсээс урвасан тухайд, энэ нь дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө урьдчилан тодорхойлогдсон байсан бус уу гэж зарим хүн гайхдаг. Үнэндээ тухайн үеийн бодит байдалд үндэслэн Ариун Сүнс эдгээр төлөвлөгөөг гаргасан юм. Харин үргэлж мөнгө хөрөнгө завшиж байсан Иудас гэдэг нэртэй хүн тэнд

байж таарсан тул уг хүн энэ дүрд тоглож, ийм маягаар үйлчлэхээр сонгогдсон. Энэ нь тухайн үеийн эх сурвалжийг ашигласан жинхэнэ жишээ байлаа. Есүс эхэндээ энэ талаар мэдээгүй; Тэрээр сүүлд нь Иудасыг илчлэгдсэний дараа л энэ тухай мэдсэн. Хэрвээ өөр хэн нэгэн энэ дүрд тоглож чадах байсан бол Иудасын оронд тэр хүн үүнийг хийх байв. Урьдчилан тогтоогдсон зүйл нь үнэндээ тухайн хоромд Ариун Сүнсний хийсэн зүйл байсан юм. Ариун Сүнсний ажил үргэлж аяндаа хийгддэг; Тэр Өөрийн ажлыг хэдийд ч төлөвлөж, хэдийд ч биелүүлж чадна. Ариун Сүнсний ажил бодитой, үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй, үргэлж хамгийн шинэхэн байдаг гэж Би яагаад үргэлж хэлдэг вэ? Дэлхий ертөнц бүтээгдэх үед Түүний ажил аль хэдийн төлөвлөгдсөн байгаагүй; ийм зүйл огт болоогүй! Ажлын алхам бүр нь тус тусын цаг хугацаандаа зүй зохистой үр дүндээ хүрдэг ба алхмууд нь нэг нэгэндээ саад болдоггүй. Маш олон удаа, чиний оюун санаан дахь төлөвлөгөө Ариун Сүнсний хамгийн сүүлийн үеийн ажилтай ердөө дүйцдэггүй. Түүний ажил хүний бодол шиг тийм энгийн байдаггүй, хүний төсөөлөл шиг төвөгтэй ч байдаггүй—энэ нь хүмүүсийн одоогийн хэрэгцээнд нийцүүлэн хэдийд ч, хаана ч хүмүүсийг хангахаас бүрдэнэ. Хүмүүсийн мөн чанарыг Түүн шиг тодорхой мэддэг хэн ч байхгүй бөгөөд яг энэ шалтгааны улмаас хүмүүсийн бодит хэрэгцээнд Түүний ажил шиг тохирч чадах зүйл юу ч үгүй. Тиймээс хүний үзэл бодлоор бол Түүний ажил хэдэн мянган жилийн өмнөөс урьдчилан төлөвлөгдсөн мэт санагддаг. Одоо та нарын дунд ажиллаж, та нарын байгаа байдлыг ажиглангаа ажиллаж, үг хэлж байх зуураа Тэр янз бүрийн байр байдалтай тулгараад яг оносон үг хэлдэг ба хүмүүст яг хэрэгтэй байгаа үгийг хэлдэг. Түүний ажлын эхний алхам буюу гэсгээлтийн цаг үеийг аваад үз. Гэсгээлтийн цаг үеийн дараа хүмүүс элдэв янзын зан авир гаргаж, тодорхой арга замаар тэрслүү авирласан; янз бүрийн эерэг байдал гарч ирсэн, зарим нэг сөрөг байдал ч бас гарч ирсэн. Тэд сөрөг байдалдаа нэг цэгт хүрч, өөрсдийн унах хамгийн доод хязгаарыг харуулсан. Бурхан энэ бүх зүйлд үндэслэн Өөрийн ажлыг явуулж, улмаар Өөрийнхөө ажлаар илүү дээр үр дүнд хүрэхийн тулд эдгээрийг ашигласан. Өөрөөр хэлбэл, Тэрээр тухайн нэг хугацаан дахь хүмүүсийн байгаа байдалд үндэслэн хүмүүсийг хангах ажлаа хийдэг; Тэрээр Өөрийн ажлын алхам бүрийг хүмүүсийн бодит байр байдлын дагуу хэрэгжүүлдэг. Бүх бүтээл Түүний гарт байдаг; Тэр яаж тэднийг мэдэхгүй байж болох юм бэ? Бурхан хүмүүсийн байр байдалд нийцүүлэн, хийгдэх ёстой ажлын дараагийн алхмыг хэдийд ч, хаана ч хэрэгжүүлдэг. Энэ ажил яавч олон мянган жилийн өмнөөс төлөвлөгдөөгүй; энэ

нь хүний үзэл юм! Тэрээр Өөрийн ажлын үр нөлөөг ажиглангаа ажилладаг ба Түүний ажил тасралтгүй гүнзгийрч, хөгжиж байдаг; Өөрийн ажлын үр дүнг ажигласныхаа дараа Тэрээр тухай бүрд нь ажлынхаа дараагийн алхмыг хэрэгжүүлдэг. Тэр аажмаар шилжихийн тулд олон зүйлийг ашигладаг ба цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Өөрийн шинэ ажлыг хүмүүст илэрхий болгодог. Ийм байдлаар ажиллах нь хүмүүсийн хэрэгцээг хангаж чадна, учир нь Бурхан хүмүүсийг дэндүү сайн мэддэг билээ. Ийнхүү Тэр Өөрийн ажлыг тэнгэрээс хэрэгжүүлдэг. Үүний адилаар, бие махбодтой болсон Бурхан ийм маягаар ажлаа хийж, бодит нөхцөл байдлын дагуу зохицуулалт хийж, хүмүүсийн дунд ажилладаг. Дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө Түүний ажлын аль нь ч зохицуулагдсан байгаагүй, мөн урьдчилан нарийн нямбай төлөвлөгдсөн ч байгаагүй. Дэлхий бүтээгдсэнээс хойш хоёр мянган жилийн дараа хүн төрөлхтөн маш их завхарсныг Ехова харсан болохоор эш үзүүлэгч Исаагийн амыг ашиглан, Хуулийн эрин үе дууссаны дараа Нигүүлслийн эрин үед Ехова хүн төрөлхтнийг золин аврах ажлаа явуулна хэмээн зөгнөсөн. Энэ нь Еховагийн төлөвлөгөө байсан, мэдээж энэхүү төлөвлөгөө ч бас тухайн үед Түүний ажигласан нөхцөл байдлын дагуу хийгдсэн; Тэрээр Адамыг бүтээснийхээ яг дараахан энэ тухай бодоогүй нь лавтай. Исаа ердөө л зөгнөл хэлсэн, харин Ехова Хуулийн эрин үед үүнд зориулаад урьдчилан бэлтгээгүй; харин ч Тэр үүнийг Нигүүлслийн эрин үеийн эхэнд хийж эхэлсэн ба Иосефийн зүүдэнд элч харагдаж, Бурхан махбод болно гэх мэдээгээр түүнийг гэгээрүүлэх үед л Түүний бие махбодтой болох ажил нь эхэлсэн. Хүмүүсийн төсөөлдөг шигээр Бурхан энэ дэлхийг бүтээснийхээ яг дараа бие махбодтой болох ажилдаа бэлтгээгүй; энэ нь хүн төрөлхтний хөгжлийн хэмжээ болон Сатантай хийсэн Түүний дайны төлөв байдлын дагуу л шийдэгдсэн юм.

Бурхан махбод болох үед Түүний Сүнс хүн дээр бууж ирдэг; өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс бие махбодоор хувцасладаг. Тэрээр зарим тодорхой хязгаарлагдмал алхмуудыг авчралгүйгээр Өөрийн ажлыг газар дээр хийхээр ирдэг; Түүний ажил ямар ч хязгааргүй байдаг. Ариун Сүнсний махбодоор хийдэг ажил мөн л Түүний ажлын үр дүнгээр тодорхойлогддог ба Тэрээр махбодод байхдаа ажлаа хэр удаан хугацаанд хийхээ тодорхойлохын тулд ийм зүйлсийг ашигладаг. Ариун Сүнс ажлынхаа алхам бүрийг шууд илчилдэг ба явахынхаа хэрээр Өөрийн ажлыг шинжилж шалгадаг; энэхүү ажил хүний төсөөллийн хязгаараас даван гарахуйц тийм ч ер бусын биш. Энэ нь тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн Еховагийн ажилтай адилхан; Тэр нэгэн зэрэг төлөвлөж,

ажилласан. Тэр гэрлийг харанхуйгаас салгаад, өглөө, орой бий болсон—үүнд нэг өдрийг зарцуулжээ. Хоёр дахь өдөр нь Тэрээр тэнгэрийг бүтээсэн ба үүнд мөн нэг өдрийг зарцуулсан; дараа нь газар дэлхий, далай тэнгис, болон тэдгээрт суурьших бүх бүтээлийг бүтээхэд мөн л нэг өдөр шаардагдсан юм. Энэ нь зургаа дахь өдрийг хүртэл үргэлжилсэн ба тэр үед Бурхан хүнийг бүтээгээд газар дээрх бүх зүйлийг түүгээр удирдуулжээ. Тэгээд долоо дахь өдөр нь Тэр бүх зүйлийг бүтээж дуусаад амарсан юм. Бурхан долоо дахь өдрийг ерөөж, үүнийг ариун өдөр болгон тогтоосон. Тэрээр бүх зүйлийг бүтээхээсээ өмнө биш, харин аль хэдийн бүтээснийхээ дараа энэхүү ариун өдрийг тогтоохоор шийдсэн билээ. Энэ ажил ч бас аяндаа хийгдсэн; бүх зүйлийг бүтээхээсээ өмнө Тэр дэлхийг зургаан өдөрт бүтээгээд долоо дахь өдөр нь амарна гэж шийдээгүй байсан; энэ нь бодит баримттай огтхон ч нийцдэггүй. Тэр ийм зүйл хэлээгүй, ингэж ч төлөвлөөгүй. Бүх зүйлийн бүтээл нь зургаа дахь өдөр дуусаад, долоо дахь өдөр нь амарна гэж Тэр яавч хэлээгүй; харин тухайн үед Өөрт нь юу сайн санагдаж байсны дагуу л бүтээсэн. Тэр бүх зүйлийг бүтээж дуусмагц аль хэдийн зургаа дахь өдөр болсон байв. Хэрвээ бүх зүйлийг бүтээж дуусахад тав дахь өдөр байсан бол Тэрээр зургаа дахь өдрийг ариун өдөр болгон тогтоох байлаа. Гэхдээ Тэр үнэндээ бүх зүйлийг зургаа дахь өдөр бүтээж дууссан ба тийнхүү долоо дахь өдөр нь ариун өдөр болж, өнөөдрийг хүртэл уламжлагдан иржээ. Тиймээс, Түүний одоогийн ажил үүнтэй адилаар хийгдэж байгаа. Тэр та нарын нөхцөл байдлын дагуу хэрэгцээг чинь хангаж, үгээ хэлдэг. Өөрөөр хэлбэл, Сүнс хүмүүсийн нөхцөл байдлын дагуу үг хэлж, ажилладаг; Тэр бүхнийг ажиглан харж, хэдийд ч хаана ч ажилладаг. Миний хийдэг, хэлдэг, та нарт үүрүүлж, та нарт олгож байгаа зүйл бүгд ялгаагүй та нарт хэрэгтэй зүйлс юм. Тиймээс Миний ажлын аль нь ч бодит байдлаас салангид байдаггүй; бүгд бодитой байдаг, учир нь “Бурханы Сүнс бүгдийг ажиглан харж байдаг” гэдгийг та нар бүгд мэднэ. Хэрвээ энэ нь бүгд цагаасаа өмнө шийдэгдсэн байсан бол хэтэрхий төлөвлөгдсөн байх бус уу? Бурхан бүхэл бүтэн зургаан мянган жилийн төлөвлөгөөг гаргасан, дараа нь хүн төрөлхтнийг тэрслүү, эсэргүү, шударга бус, зальжин байж, махан биеийн завхрал, сатанлаг зан чанар, нүдний шунал тачаал, хувийн дур сонирхолтой байхаар урьдчилан төлөвлөсөн гэж чи бодож байх шиг байна. Эдгээрийн алийг нь ч Бурхан урьдчилан төлөвлөөгүй, харин Сатан завхруулснаас болоод энэ бүхэн тохиолдсон юм. Зарим хүн: “Сатан ч бас Бурханы атганд байсан бус уу? Сатан ийм байдлаар хүнийг завхруулна, дараа нь хүмүүсийн дунд Өөрийн ажлыг явуулна гэж Бурхан урьдчилан төлөвлөсөн”

хэмээн хэлж магадгүй. Сатан хүн төрөлхтнийг завхруулна гэдгийг Бурхан үнэхээр урьдчилан төлөвлөх үү? Бурхан хүн төрөлхтнийг хэвийн амьдруулахыг л хүсэн эрмэлздэг тул тэдний амьдралд үнэхээр хөндлөнгөөс оролцоно гэж үү? Тэгэх юм бол Сатаныг ялж, хүн төрөлхтнийг аврах нь хий дэмий хичээл чармайлт болох бус уу? Хүн төрөлхтний тэрслүү байдлыг урьдчилан төлөвлөсөн байж яаж болох юм бэ? Энэ нь Сатаны хөндлөнгийн оролцооноос болж тохиолдсон зүйл юм; үүнийг Бурхан урьдчилан төлөвлөсөн байж яаж болох юм бэ? Та нарын бодож байгаа Бурханы атган дахь Сатан болон Миний ярьж байгаа Бурханы атган дахь Сатан маш өөр. Та нарын “Бурхан төгс хүчтэй бөгөөд Сатан түүний гарт байдаг” гэж хэлдгийн дагуу бол Сатан Түүнээс хэзээ ч урваж чадахгүй. Бурхан төгс хүчтэй гэж чи хэлсэн бус уу? Та нарын мэдлэг хэтэрхий хийсвэр ба бодит байдалтай үл тохирдог; хүн Бурханы бодлыг ухан ойлгож хэзээ ч чадахгүй, Бурханы мэргэн ухааныг ойлгож хэзээ ч чадахгүй! Бурхан бол төгс хүчтэй; энэ нь огтхон ч худлаа биш. Бурхан анх түүнд эрх мэдлийн нэг хувийг өгсөн учраас тэргүүн тэнгэрэлч Бурханаас урвасан юм. Мэдээж энэ нь Ева могойн уруу таталтад автсантай адил гэнэтийн явдал байсан. Гэвч Сатан урвалтаа яаж явуулах нь хамаагүй, тэр Бурхантай адил төгс хүчтэй биш. Та нарын хэлснээр, Сатан ердөө л хүчирхэг; тэр юу хийх нь хамаагүй, Бурханы эрх мэдэл түүнийг үргэлж ялна. Энэ бол “Бурхан төгс хүчтэй бөгөөд Сатан Түүний гарт байдаг” гэсэн үгийн цаана буй жинхэнэ утга билээ. Тиймээс, Сатантай хийх дайн нэг удаад нэг алхмаар явагдах ёстой. Түүнчлэн, Сатаны ов мэхийн хариуд Бурхан Өөрийн ажлыг төлөвлөдөг— өөрөөр хэлбэл, Тэрээр тухайн эрин үед тохирсон байдлаар хүмүүст аврал авчирч, төгс хүчин, мэргэн ухаанаа илчилдэг. Үүнтэй адилаар, эцсийн өдрүүд дэх ажлыг Нигүүлслийн эрин үеэс өмнө урьдчилан төлөвлөөгүй юм; урьдчилан төлөвлөлт нь: нэгдүгээрт, хүний гадаад зан чанарыг өөрчилнө; хоёрдугаарт, хүнийг гэсгээлт, шалгалтад өртүүлнэ; гуравдугаарт, хүнээр үхлийн шалгалт туулуулна; дөрөвдүгээрт, Бурханыг хайрлах цаг үеийг хүнээр туулуулж, бүтээгдсэн зүйлийн шийдвэрийг илэрхийлүүлнэ; тавдугаарт, Бурханы хүслийг хүнд харуулж, Бурханыг бүрэн мэдүүлнэ; эцэст нь хүнийг бүрэн төгс болгоно гэсэн байдлаар эмх цэгцтэйгээр хийгддэггүй. Тэр энэ бүх зүйлийг Нигүүлслийн эрин үед төлөвлөөгүй; харин Тэрээр өнөө үед эдгээрийг төлөвлөж эхэлсэн юм. Сатан ажиллаж байгаа, Бурхан ч мөн адил. Сатан завхарсан зан чанараа илэрхийлдэг байхад Бурхан шууд ярьж, мөн чанарын зарим зүйлийг илчилдэг. Энэ бол өнөөдөр хийгдэж байгаа ажил бөгөөд үүнтэй адил төрлийн ажиллах зарчим дэлхийг бүтээгдсэний дараа аль эртнээс хэрэглэгдэж байсан юм.

Эхлээд Бурхан Адам, Еваг бүтээсэн ба бас могойг бүтээсэн. Бүх зүйлийн дотроос энэхүү могой хамгийн хортой нь байв; үүний бие хор агуулж байсан ба могойг далимдуулан ашиглахын тулд Сатан хорыг нь хэрэглэжээ. Могой Еваг уруу татан нүгэл үйлдүүлсэн юм. Евагийн дараа Адам нүгэл үйлдсэн ба дараа нь тэр хоёр сайн мууг ялган таньж чаддаг болжээ. Могой Еваг уруу татаж, Ева Адамыг уруу татна гэдгийг Ехова мэдэж байсан бол яагаад тэднийг бүгдийг нь цэцэрлэг дотор тавьсан юм бэ? Хэрвээ Тэр эдгээр зүйлийг урьдчилан таамаглаж чадсан бол яагаад могойг бүтээгээд, Еден цэцэрлэг дотор тавьсан юм бэ? Яагаад Еден цэцэрлэгт сайн мууг мэдүүлэгч модны жимс байсан бэ? Тэр тэдэнд жимсийг идүүлэх гээгүй гэж үү? Еховаг ирэхэд Адам ч, Ева ч Түүнтэй нүүр тулж зүрхлээгүй ба тэр үед л, сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идэж, могойн арга зальд автсаныг нь Ехова мэдсэн. Эцэст нь Тэр могойг харааж, Адам Ева хоёрыг ч бас хараажээ. Тэр хоёрыг модны жимснээс идэх үед Ехова юу хийж байгааг нь огт мэдээгүй. Хүн төрөлхтөн ёрын муу, садар самуун болох хүртлээ завхарч, тэр ч байтугай зүрх сэтгэлдээ өвөрлөсөн бүхэн нь ёрын муу, зөв шударга бус болохдоо тулсан; энэ нь бүгд бузар байсан. Тиймээс Ехова хүн төрөлхтнийг бүтээсэндээ харамссан юм. Үүний дараа Тэр дэлхийг үерээр устгах ажлаа хэрэгжүүлсэн ба үүнээс Ноа болон түүний хөвгүүд амьд үлдсэн билээ. Зарим зүйл үнэндээ хүмүүсийн төсөөлдөг шиг тийм ч ахисан түвшинтэй, ер бусын байдаггүй. Зарим хүн: “Тэргүүн тэнгэрэлч Өөрөөс нь урвана гэдгийг Бурхан мэдэж байсан байж яагаад үүнийг бүтээсэн юм бэ?” гэж асуудаг. Эдгээр нь бодит баримт: Газар дэлхий хараахан оршин тогтноогүй байх үед тэргүүн тэнгэрэлч тэнгэрийн тэнгэрэлчүүдээс хамгийн том нь байсан юм. Энэ нь тэнгэр дэх бүх тэнгэрэлчийг захирч байсан; энэ нь Бурханы олгосон эрх мэдэл байв. Бурханыг оролцуулахгүйгээр тэрээр тэнгэрэлчүүдээс хамгийн том нь байсан. Хожим нь Бурхан хүн төрөлхтнийг бүтээсний дараа тэргүүн тэнгэрэлч Бурханы эсрэг бүр ч том урвалтыг газар дээр үйлджээ. Энэ нь хүн төрөлхтнийг удирдаж, Бурханы эрх мэдлээс давахыг хүссэн учраас Бурханаас урвасан гэж Би хэлдэг. Тэргүүн тэнгэрэлч Еваг нүгэлд уруу татсан бөгөөд өөрийн хаанчлалыг газар дээр байгуулж, хүн төрөлхтнийг Бурханаас урвуулж, оронд нь өөртөө дуулгавартай байлгахыг хүссэн учраас ингэсэн юм. Өөрийг нь дуулгавартай дагаж чадах маш олон зүйл байгааг тэргүүн тэнгэрэлч харсан—тэнгэрэлчүүд, газар дээрх хүмүүс ч бас түүнд дуулгавартай байж чадах байсан. Араатан, шувууд, модод, ой шугуй, уулс, гол болон газар дээрх бүх зүйл хүмүүсийн буюу Адам, Ева хоёрын халамжид байсан, харин Адам, Ева хоёр тэргүүн тэнгэрэлчид

дуулгавартай байсан. Тиймээс тэргүүн тэнгэрэлч Бурханы эрх мэдлийг давж, Бурханаас урвахыг хүсжээ. Дараа нь тэр олон тэнгэрэлчийг Бурханы эсрэг тэрслэхэд хүргэсэн ба тэгээд тэд хожим нь янз бүрийн бузар сүнснүүд болсон юм. Өнөөдрийг хүртэлх хүн төрөлхтний хөгжил тэргүүн тэнгэрэлчийн завхралаас үүдээгүй гэж үү? Тэргүүн тэнгэрэлч Бурханаас урваж, хүн төрөлхтнийг завхруулсан учраас л хүмүүс өнөөдөр ийм байдалтай байгаа юм. Энэхүү алхам алхмаар хийгддэг ажил нь хүмүүсийн төсөөлдөг шиг хийсвэр бөгөөд энгийн огт биш. Сатан тодорхой учир шалтгаантайгаар урвасан, гэсэн ч хүмүүс ийм энгийн зүйлийг ойлгож чаддаггүй. Тэнгэр, газар болон бүх зүйлийг бүтээсэн Бурхан яагаад бас Сатаныг бүтээсэн юм бэ? Бурхан Сатаныг маш их үзэн яддаг тул Сатан бол Түүний дайсан, тэгвэл Тэр яагаад Сатаныг бүтээсэн юм бэ? Сатаныг бүтээснээрээ Тэр дайсныг бүтээсэн бус уу? Бурхан үнэндээ дайсныг бүтээгээгүй юм; харин ч Тэрээр тэнгэрэлчийг бүтээсэн ба дараа нь тэнгэрэлч Түүнээс урвасан билээ. Өөрийнх нь байр суурь маш өндөр болсон учраас тэр Бурханаас урвахыг хүсжээ. Энэ нь тохиолдлын хэрэг байсан гэж хэлж болох боловч энэ нь бас зайлшгүй байдал байлаа. Хүн тодорхой хэмжээнд хүртэл өсөж төлөвшсөнийхөө дараа зайлшгүй нас бардагтай энэ нь адилхан; юмс яг тэр үе шат хүртэл хөгжсөн. Зарим хөгийн мунхаг хүмүүс: “Сатан Таны дайсан байхад Та яагаад үүнийг бүтээсэн юм бэ? Тэргүүн тэнгэрэлч Танаас урвана гэдгийг Та мэдээгүй гэж үү? Та мөнхөөс мөнхөд харж чаддаггүй гэж үү? Та тэргүүн тэнгэрэлчийн уг чанарыг мэдээгүй гэж үү? Энэ нь Танаас урвана гэдгийг тодорхой мэдэж байсан байж Та яагаад үүнийг тэргүүн тэнгэрэлч болгосон юм бэ? Энэ нь Танаас урваад зогсохгүй, хүн төрөлхтнийг завхруулахын тулд маш олон тэнгэрэлчийг удирдан мөнх бусын ертөнцөд бууж ирсэн, гэтэл өнөөдрийг хүртэл Та зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө дуусгаж чадаагүй л байна” гэж хэлдэг. Эдгээр үг зөв үү? Ийм маягаар бодох үедээ чи өөртөө дэмий төвөг удаж байгаа бус уу? Бас, “Сатан хүн төрөлхтнийг өнөөдрийг хүртэл завхруулаагүй бол Бурхан хүн төрөлхтөнд ийм аврал авчрахгүй байх байсан. Тэгсэн бол Бурханы мэргэн ухаан, төгс хүчин харагдахгүй байх байсан; Түүний мэргэн ухаан хаана илчлэгдэх юм бэ? Тиймээс Бурхан хүн төрөлхтнийг Сатаны төлөө бүтээсэн, ингэснээр Тэр дараа нь Өөрийн төгс хүчийг илчилж чадах байсан—тэгэхгүй бол хүн Бурханы мэргэн ухааныг яаж олж мэдэж чадах юм бэ? Хэрвээ хүн Бурханыг эсэргүүцээгүй, Түүний эсрэг тэрслээгүй бол Түүний үйл хэрэг илчлэгдэх шаардлагагүй байсан. Хэрвээ бүх бүтээл Түүнд шүтэн мөргөж, дуулгавартай байсан бол Түүнд хийх ажил байхгүй байх байсан” гэж

хэлдэг хүмүүс ч бий. Энэ нь бодит байдлаас бүр ч хол хөндий юм, учир нь Бурхан огт бузар биш учраас бузрыг бүтээж чадахгүй. Тэрээр дайснаа ялж, Өөрийн бүтээсэн хүмүүсийг аварч, Өөрийг нь үзэн яддаг, эсэргүүцдэг, Өөрөөс нь урвадаг бөгөөд хамгийн анх Өөрийнх нь ноёрхол дор байж, бүр анхнаасаа Өөрт нь харьяалагдаж байсан чөтгөрүүд болон Сатаныг ялахын тулд л үйл хэргээ илчилдэг. Бурхан эдгээр чөтгөрийг ялахыг хүсдэг ба ингэснээрээ Өөрийн төгс хүчийг бүх зүйлд илчилдэг. Хүн төрөлхтөн болоод газар дээрх бүх зүйл одоо Сатаны эзэмшил дор байдаг ба хорон санаатны эзэмшил дор оршдог. Хүмүүс Өөрийг нь мэдэж, улмаар Сатаныг ялж, Түүний дайснуудыг бүрмөсөн ялан дийлэг гэсэндээ Бурхан Өөрийн үйл хэргийг бүх зүйлд илчлэхийг хүсдэг. Өөрийн үйл хэргийг илчилснээр энэ ажлыг бүхэлд нь гүйцэлдүүлдэг. Өөрийнх нь бүх бүтээл Сатаны эзэмшил дор байдаг тул Бурхан тэдэнд Өөрийн төгс хүчийг илчилж, улмаар Сатаныг ялахыг хүсдэг. Хэрвээ Сатан байгаагүй бол Тэр Өөрийн үйл хэргийг илчлэх хэрэггүй байх байв. Сатаны хөндлөнгийн оролцоо байгаагүй бол Бурхан хүн төрөлхтнийг бүтээгээд Еден цэцэрлэгт амьдруулах байсан юм. Сатаны урвалтаас өмнө Бурхан яагаад Өөрийн бүх үйл хэргийг тэнгэрэлчүүд юм уу тэргүүн тэнгэрэлчид хэзээ ч илчлээгүй юм бэ? Хэрвээ тэнгэрэлчүүд болон тэргүүн тэнгэрэлч Бурханыг мэддэг, Түүнд дуулгавартай байдаг байсан бол Бурхан тэдгээр утга учиргүй ажлыг хэрэгжүүлэх хэрэггүй байх байлаа. Сатан болон чөтгөрүүдийн оршин тогтнолын улмаас хүмүүс ч бас Бурханыг эсэргүүцэж, тэрслүү зан чанараар бялхдаг. Тиймээс Бурхан Өөрийн үйл хэргийг илчлэхийг хүсдэг. Тэр Сатантай дайн хийхийг хүсдэг учраас Сатаныг ялахын тулд Өөрийн эрх мэдэл болон бүх үйл хэргийг ашиглах ёстой; ийм маягаар, хүмүүсийн дунд Түүний явуулдаг авралын ажил нь хүмүүст Түүний мэргэн ухаан, төгс хүчийг харуулна. Бурханы өнөөдөр хийж байгаа ажил утга учиртай бөгөөд “Таны хийдэг ажил зөрчилдөөнтэй бус уу? Ажлын энэ дэс дараалал чинь зүгээр л Өөртөө төвөг удсан хэрэг биш үү? Та Сатаныг бүтээсэн, тэгээд Танаас урваж, Таныг эсэргүүцэх боломжийг үүнд олгосон. Та хүмүүсийг бүтээгээд дараа нь тэднийг Сатанд гардуулан өгч, Адам Ева хоёрыг уруу таталтад өртүүлсэн. Та энэ бүх зүйлийг зориуд хийчхээд яагаад хүн төрөлхтнийг жигшсээр байдаг юм бэ? Яагаад Та Сатаныг үзэн яддаг юм бэ? Энэ бүхэн нь Таны хийсэн зүйл биш гэж үү? Танд үзэн ядах юм юу байгаа юм бэ?” гэж зарим хүний хэлдэгтэй яавч адилгүй. Нэлээд олон мунхаг хүн тийм зүйл хэлнэ. Тэд Бурханыг хайрлахыг хүсдэг боловч сэтгэлийнхээ гүнд Бурханы талаар гомдоллодог. Хэчнээн зөрчилдөөнтэй вэ! Чи үнэнийг ойлгодоггүй, хэтэрхий

олон ер бусын бодолтой байдаг ба тэр ч байтугай Бурхан алдаа гаргасан гэдэг—чи ямар хөгийн юм бэ! Үнэнээр тоглодог хүн бол чи; харин Бурхан алдаа гаргасан юм биш! Зарим хүн бүр ахин дахин гомдоллож, “Та Сатаныг бүтээсэн, Та Сатаныг хүмүүсийн дунд шидэж, тэднийг Сатанд өгсөн. Хүмүүс сатанлаг зан чанартай болмогц Та тэднийг уучлаагүй; харин оронд нь тодорхой хэмжээнд тэднийг үзэн ядсан. Эхэндээ Та тэднийг тодорхой хэмжээнд хайрласан, гэтэл одоо тэднийг жигшдэг. Та хүн төрөлхтнийг үзэн ядсан, гэхдээ Та бас хүн төрөлхтнийг хайрласан. Яг юу болоод байгаа юм бэ? Энэ нь зөрчилдөөн бус уу?” гэдэг. Та нар үүнийг хэрхэн харахаас үл хамааран, энэ нь тэнгэрт болсон зүйл; ийм байдлаар тэргүүн тэнгэрэлч Бурханаас урваж, хүн төрөлхтөн завхарсан ба хүмүүс ингэж өнөөг хүртэл үргэлжлүүлсэн. Та нар үүнийг яаж илэрхийлэхээс үл хамааран бүхий л түүх бол энэ. Гэвч, та нарыг аврахын тулд, Сатаныг ялахын тулд Бурханы өнөөдөр хийж буй ажлын цаад зорилгыг та нар ойлгох ёстой.

Тэнгэрэлчүүд нэн сул дорой, яриад байх ямар ч чадваргүй байсан учраас эрх мэдэл өгөнгүүт биеэ тоож эхэлсэн. Ялангуяа бусад тэнгэрэлчээс өндөр байр суурьтай байсан тэргүүн тэнгэрэлчийн хувьд ийм байсан юм. Тэнгэрэлчүүдийн дундах хаан тэрээр олон сая тэнгэрэлчийг удирдан захирч байсан ба Еховагийн дор түүний эрх мэдэл өөр ямар ч тэнгэрэлчийнхээс давжээ. Тэрээр энэ, тэрийг хийхийг хүсэж, дэлхийг хянахын тулд хүний ертөнц рүү тэнгэрэлчүүдийг удирдан буухыг хүссэн юм. Бурхан Өөрийгөө орчлон ертөнцийг захирдаг Нэгэн гэж хэлсэн; гэтэл тэргүүн тэнгэрэлч өөрийгөө орчлон ертөнцийг захирдаг гэж хэлсэн—тэр үеэс хойш тэргүүн тэнгэрэлч Бурханаас урвасан юм. Бурхан тэнгэрт өөр ертөнцийг бүтээсэн бөгөөд тэргүүн тэнгэрэлч энэ ертөнцийг захирахын сацуу мөнх бусын ертөнцөд буухыг хүссэн. Бурхан ингэхийг нь зөвшөөрч чадна гэж үү? Тиймээс Тэр тэргүүн тэнгэрэлчийг цохиж, агаар луу доош шидсэн юм. Хүмүүсийг завхруулснаас нь хойш тэднийг аврахын тулд Бурхан Сатантай дайтах болсон; Тэр түүнийг ялахын тулд энэ зургаан мянганыг ашигласан юм. Та нарын үзлээр бол Бурхан төгс хүчтэй байдаг бөгөөд Бурханы одоо явуулж байгаа ажилтай нийцдэггүй; энэ нь туйлын бодит бус бөгөөд маш утгагүй! Үнэндээ тэргүүн тэнгэрэлчийг урвасны дараа л Бурхан түүнийг дайснаа гэж зарласан. Урвалтынхаа улмаас л тэргүүн тэнгэрэлч мөнх бусын ертөнцөд ирснийхээ дараа хүн төрөлхтнийг гишгэлсэн ба энэ шалтгааны улмаас хүн төрөлхтөн өдийг хүртэл хөгжсөн билээ. Ийм юм тохиолдсоны дараа Бурхан Сатанд: “Би чамайг ялж, Өөрийн бүтээсэн бүх хүнд аврал авчирна” гэж

тангарагласан юм. Сатан эхэндээ үнэмшээгүй ба “Та үнэндээ надад юу хийж чадах юм бэ? Та үнэхээр намайг агаар луу цохиж чадна гэж үү? Та үнэхээр Намайг ялж чадна гэж үү?” хэмээн хариулжээ. Бурхан агаар луу цохисныхоо дараа тэргүүн тэнгэрэлчид цаашид анхаарал хандуулаагүй бөгөөд хожим нь Сатаны байнгын үймээнийг үл хайхран хүн төрөлхтнийг аварч, Өөрийн ажлыг хийж эхэлсэн. Сатан энэ, тэрийг хийж чаддаг байсан ч энэ бүхэн нь урьд нь түүнд Бурханы өгсөн эрх мэдлийн ач байв; тэр эдгээр зүйлийг өөртөө аван агаарт гарсан ба өнөөг хүртэл хадгалсаар ирсэн. Тэргүүн тэнгэрэлчийг агаар луу цохихдоо Бурхан эрх мэдлийг нь буцааж аваагүй тул Сатан хүн төрөлхтнийг үргэлжлүүлэн завхруулжээ. Нөгөө талаар, бүтээгдсэнийх нь дараа Сатаны завхруулсан хүн төрөлхтнийг Бурхан аварч эхэлсэн. Бурхан тэнгэрт байхдаа Өөрийн үйл хэргийг илчлээгүй; гэхдээ газар дэлхийг бүтээхээсээ өмнө Тэрээр тэнгэрт бүтээсэн дэлхийнхээ хүмүүст Өөрийн үйл хэргийг харуулж, тэгснээрээ тэнгэр дээрх хүмүүсийг удирдан хөтөлсөн. Тэр тэдэнд мэргэн ухаан, оюуны чадамж өгч, тэрхүү дэлхийд амьдруулахаар тэрхүү хүмүүсийг удирдан хөтөлсөн. Мэдээж та нарын хэн ч энэ тухай өмнө нь сонсож байгаагүй. Дараа нь, Бурхан хүмүүсийг бүтээсний дараа тэргүүн тэнгэрэлч тэднийг завхруулж эхэлсэн; газар дээр бүх хүн төрөлхтөн эмх замбараагүй байдалд автсан. Тэр үед л Бурхан Сатаны эсрэг дайнаа эхлүүлсэн ба тэр үед л хүмүүс Түүний үйл хэргийг харж эхэлсэн билээ. Эхэндээ тийм үйл хэрэг хүн төрөлхтнөөс нуугдмал байв. Агаар луу цохигдсоныхоо дараа Сатан өөрийнхөө юмыг хийж, Бурхан ч Өөрийнхөө ажлыг үргэлжлүүлэн хийсэн ба эцсийн өдрүүдийг хүртэл Сатантай тасралтгүй дайтсан билээ. Одоо үе бол Сатан устгагдах ёстой цаг үе. Анх Бурхан түүнд эрх мэдэл өгсөн, дараа нь Тэр үүнийг агаар руу цохисон ч тэр эсэргүүцсэн хэвээр үлдсэн. Дараа нь, тэр газар дээр хүн төрөлхтнийг завхруулсан боловч Бурхан тэнд хүн төрөлхтнийг удирдаж байлаа. Сатаныг ялахын тулд Бурхан хүмүүсийг удирдах Өөрийн удирдлагыг ашигладаг. Хүмүүсийг завхруулснаар Сатан тэдний хувь заяаг эцэслэж, Бурханы ажлыг үймүүлдэг. Нөгөө талаар, Бурханы ажил бол хүн төрөлхтний аврал билээ. Бурханы ажлын аль алхам нь хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаггүй вэ? Аль алхам нь хүмүүсийг цэвэрлэж, тэднийг зөв шударга авирладаг болгож, хайр татам хүмүүсийн дүрийг амьдран харуулдаг болгохын төлөө байдаггүй вэ? Харин Сатан үүнийг хийдэггүй. Тэр хүн төрөлхтнийг завхруулдаг; хүн төрөлхтнийг завхруулах ажлаа орчлон ертөнц даяар тасралтгүй явуулдаг. Мэдээж Бурхан ч бас ажлаа хийн, Сатанд ямар ч анхаарал хандуулдаггүй.

Сатан хэчнээн их эрх мэдэлтэй байх нь хамаагүй, тэр эрх мэдлийг Бурхан л өгсөн; Бурхан үнэндээ Өөрийн бүх эрх мэдлийг үүнд ердөө өгөөгүй, тиймээс Сатан юу ч хийсэн бай, Бурханаас давж хэзээ ч чадахгүй ба үргэлж Бурханы атганд байх болно. Бурхан Өөрийн ямар ч үйл хэргийг тэнгэрт байхдаа илчлээгүй. Тэр ердөө л Сатанд багахан хэмжээний эрх мэдэл өгч, бусад тэнгэрэлчийг түүгээр хянуулсан. Тиймээс, Сатан юу ч хийлээ гэсэн, Бурханы эрх мэдлээс давж чадахгүй, учир нь анх Бурханы түүнд өгсөн эрх мэдэл хязгаарлагдмал юм. Бурхан ажиллаж байхад Сатан үймүүлдэг. Эцсийн өдрүүдэд түүний үймээн самуун дууссан байх болно; үүний нэгэн адил Бурханы ажил ч бас дуусаж, Бурханы бүрэн төгс болгохыг хүсдэг хүмүүс бүрэн төгс болгуулна. Бурхан хүмүүсийг эерэгээр чиглүүлдэг; Түүний амь бол хэмжээлшгүй агаад хязгааргүй амийн ус билээ. Сатан хүнийг тодорхой хэмжээнд завхруулсан; эцэст нь амийн амьд ус хүнийг бүрэн төгс болгоно, тэгээд Сатан хөндлөнгөөс оролцож, өөрийн ажлыг явуулах боломжгүй болно. Тийнхүү Бурхан энэ хүмүүсийг бүрэн олж авч чадна. Сатан одоо ч гэсэн үүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар байгаа; тэр байнга Бурханы эсрэг сөрөн зогсдог ч Бурхан түүнд огт анхаарал хандуулдаггүй. “Би Сатаны бүх харанхуй хүчийг, үүний бүх харанхуй нөлөөг ялна” гэж Бурхан хэлсэн. Энэ нь одоо махбодоор хийгдэх ёстой ажил бөгөөд энэ нь бас махбод болохын утга учир буюу эцсийн өдрүүдэд Сатаныг ялах ажлын үе шатыг дуусгаж, Сатанд харьяалагддаг бүх зүйлийг арчин хаях явдал юм. Бурхан Сатаныг ялах нь зайлшгүй! Үнэндээ Сатан аль хэдийн бүтэлгүйтсэн. Агуу улаан лууны газар нутаг даяар сайн мэдээ тархаж эхлэх үед, өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан ажлаа эхлүүлж, энэ ажлыг явуулж эхлэх үед Сатан бүрмөсөн ялагдсан, учир нь бие махбодтой болохын гол зорилго нь Сатаныг ялан дийлэхийн төлөө байсан билээ. Бурхан дахин нэг удаа махбод болж, ямар ч хүч зогсоож чадахгүй Өөрийн ажлыг хэрэгжүүлж эхлэхийг Сатан хармагцаа энэ ажлын бараанаар мэгдэн сандарч, цаашид гай тарьж зүрхлээгүй. Эхэндээ Сатан өөрт нь ч бас маш их мэргэн ухаан өгөгдсөн гэж бодсон ба Бурханы ажлыг үймүүлж, түйвээсэн; гэхдээ тэр, Бурхан дахин нэг удаа махбод болж, Өөрийнхөө ажилд хүн төрөлхтний төлөөх илчлэл, шүүлт болгон Сатаны тэрслүү байдлыг ашиглаж, улмаар хүмүүсийг байлдан дагуулж, Сатаныг ялна гэж бодоогүй юм. Бурхан Сатанаас илүү ухаалаг бөгөөд Бурханы ажил түүнээс хамаагүй хол давдаг. Тиймээс өмнө нь Миний хэлж байсанчлан: “Миний хийдэг ажил Сатаны ов мэхний хариуд хэрэгждэг; эцэстээ Би Өөрийн төгс хүчийг болон Сатаны хүчин мөхөс байдлыг илчилнэ.” Бурхан урд талд нь Өөрийн ажлыг хийх үед Сатан

араас нь дагах ба эцэстээ бүрмөсөн устгагдана—өөрийг нь юу цохисныг ч тэр мэдэхгүй! Аль хэдийн сүйрэн унаж, няцлуулмагцаа л тэр үнэнийг ухаарна, харин тэр үед аль хэдийн галт нууранд шатчихсан байх болно. Тэгэхэд Сатан бүрэн үнэмшихгүй гэж үү? Учир нь тэр үед түүнд ашиглах арга заль байхгүй байх болно!

Алхам алхмаар хийгддэг энэхүү бодит ажил Бурханы зүрх сэтгэлийг хүн төрөлхтний төлөөх уй гашууд үргэлж автуулдаг тул Сатантай хийсэн Түүний дайн зургаан мянган жилийн турш үргэлжилсэн бөгөөд Бурхан: “Би дахин хэзээ ч хүн төрөлхтнийг бүтээхгүй, тэнгэрэлчүүдэд ч дахин эрх мэдэл олгохгүй” гэж хэлсэн юм. Тэр үеэс эхлээд, тэнгэрэлчүүд газар дээр ажиллахаар ирэхдээ зарим нэг ажил хийхэд нь л Бурханыг дагаж байсан; Тэр тэдэнд дахин хэзээ ч эрх мэдэл өгөөгүй. Израильчуудын харсан тэнгэрэлчүүд ажлаа яаж хийж байсан бэ? Тэд хүмүүсийн зүүдэнд үзэгдэж, Еховагийн үгийг дамжуулж байсан. Есүс цовдлогдсоныхоо дараа гурав хоноод дахин амилах үед тэнгэрэлчүүд бул чулууг хажуу тийш түлхсэн; Бурханы Сүнс энэ ажлыг биечлэн хийгээгүй юм. Тэнгэрэлчүүд иймэрхүү ажил л хийж байсан; тэд туслах дүрд тоглосон боловч ямар ч эрх мэдэлгүй байсан, учир нь Бурхан тэдэнд дахин хэзээ ч эрх мэдэл олгохгүй. Хэсэг хугацаанд ажилласны дараа газар дээр Бурханы ашиглаж байсан хүмүүс Бурханы байр суурийг авч, “Би орчлон ертөнцийг даван гармаар байна! Би гурав дахь тэнгэрт зогсмоор байна! Бид бүрэн эрх мэдэлтэйгээр хаанчлахыг хүсэж байна!” гэж хэлсэн. Тэд хэдэн өдөр ажилласныхаа дараа биеэ тоосон; тэд газар дээр бүрэн эрх мэдэлтэй байж, өөр улс байгуулж, бүх зүйлийг хөлийнхөө дор байлгаж, гурав дахь тэнгэрт зогсохыг хүссэн. Чи ердөө л Бурханы ашигладаг хүн гэдгээ мэдэхгүй гэж үү? Чи яаж гурав дахь тэнгэр лүү гарч чадах юм бэ? Бурхан чимээгүйхнээр, хашхиралгүйгээр газар дээр ажиллахаар ирээд, ажлаа сэмхэн дуусгасныхаа дараа явж оддог. Тэр хэзээ ч хүмүүс шиг хашхирдаггүй, харин ч Өөрийн ажлыг бодитоор хэрэгжүүлдэг. Тэр сүмд ороод, “Би та нарыг бүгдийг арчин хаяна! Би та нарыг харааж, гэсгээнэ!” гэж хэзээ ч хашхирдаггүй. Тэр зүгээр л Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийдэг ба хийж дуусмагцаа явдаг. Өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөж, индэр дээрээс бусдад зааж сургаж, урт сүржин илтгэл тавьж, бодит бус асуудлыг хэлэлцдэг шашны тэр пасторууд голдоо ортол биеэ тоосон байдаг! Тэд бол тэргүүн тэнгэрэлчийн үр удам билээ!

Зургаан мянган жилийн ажлаа өнөөдрийг хүртэл хийснийхээ дараа Бурхан олон үйл хэргээ аль хэдийн илчилсэн ба үүний гол зорилго нь Сатаныг ялж, бүх хүн төрөлхтөнд аврал авчрах явдал байлаа. Тэрээр энэ боломжийг ашиглан

тэнгэрт байгаа бүх зүйл, газар дээрх бүх зүйл, далай тэнгис дэх бүх зүйл болон газар дээрх Бурханы бүтээл нэг бүрд Өөрийн төгс хүчийг харуулж, Өөрийн бүх үйл хэргийг үзүүлдэг. Мөн Сатаныг ялах боломжийг шүүрэн авснаараа Тэр хүмүүст Өөрийн бүх үйл хэргийг илчилж, тэднээр Өөрийгөө магтуулж, Сатаныг ялсан мэргэн ухаанаа өргөмжлүүлдэг. Газар дээрх, тэнгэр дэх болон далай тэнгис доторх бүх зүйл Бурханд алдар сууг авчирч, Түүний төгс хүчийг магтаж, Түүний үйл хэрэг нэг бүрийг магтаж, Түүний ариун нэрийг хашхирна. Энэ нь Тэр Сатаныг ялсны нотолгоо; Сатаныг эрхэндээ оруулсны нотолгоо. Үүнээс ч чухал нь, хүн төрөлхтнийг аварсных нь нотолгоо юм. Бурханы бүх бүтээл Түүнд алдар суу авчран, дайснаа ялж, ялгууснаар буцан ирснийх нь төлөө Түүнийг магтах ба Түүнийг агуу ялгуусан Хаан хэмээн шагшин магтана. Түүний зорилго ердөө л Сатаныг ялах явдал биш, иймээс Түүний ажил зургаан мянган жилийн турш үргэлжилсэн юм. Тэр Сатаны ялагдлыг ашиглан хүн төрөлхтнийг авардаг; Сатаны ялагдлыг ашиглан Өөрийн бүх үйл хэрэг, бүх алдар сууг илчилдэг. Тэрээр алдаршина, үй түмэн тэнгэрэлч Түүний бүх алдрыг харна. Тэнгэр дэх зарлага элчүүд, газар дээрх хүмүүс болон газар дээрх бүх бүтээл Бүтээгчийн алдар сууг харна. Энэ бол Түүний хийдэг ажил юм. Тэнгэр дэх болон газар дээрх Түүний бүтээл бүгдээрээ Түүний алдар сууг харах бөгөөд Сатаныг бүрэн ялсныхаа дараа Тэр ялгууснаар эргэн ирж, хүн төрөлхтнөөр Өөрийгөө магтуулж, улмаар Өөрийнхөө ажилд давхар ялалт байгуулна. Эцэстээ бүх хүн төрөлхтнийг Тэр байлдан дагуулах ба эсэргүүцэж, тэрсэлдэг хэнийг ч арчин хаяна; өөрөөр хэлбэл, Сатанд харьяалагддаг бүх хүнийг Тэр арчин хаяна. Чи одоо Бурханы маш олон үйл хэргийг харж байгаа мөртөө мөн л эсэргүүцэн, тэрсэлдэг ба захирагддаггүй; чи дотроо олон зүйл өвөрлөж, хүссэн бүхнээ хийдэг. Чи өөрийн шунал тачаал, дур сонирхлыг дагадаг; энэ нь бүгд тэрслүү байдал, эсэргүүцэл юм. Махан биеийн төлөө, шунал тачаалынхаа төлөө, түүнчлэн дуртай зүйлс, дэлхий ертөнц, Сатаны төлөө Бурханд итгэх нь бузар заваан юм; энэ нь уг чанартаа эсэргүү, тэрслүү байдаг. Өнөө үед төрөл бүрийн итгэл байдаг: Зарим хүн гай гамшгаас хоргодох газар эрж хайдаг, бусад нь ерөөл хүртэхээр эрэлхийлдэг; зарим нь нууцуудыг ойлгохыг хүсдэг байхад бусад нь мөнгөний араас хөөцөлддөг. Эдгээр нь төрөл бүрийн эсэргүүцэл бөгөөд бүгд доромжлол юм! Хүн эсэргүүцэж, тэрсэлнэ гэдэг нь ийм үйлдлүүдийг хэлдэг бус уу? Өнөө үед олон хүн дургүйцэж, гомдоллож, шүүлт хийдэг. Энэ нь бүгд хорон муу санаатны хийдэг зүйл юм; тэдгээр нь хүний эсэргүүцэл, тэрслүү байдлын жишээ билээ. Тийм хүмүүс Сатанд эзэмдүүлж, эзлэгддэг. Бурханы

олж авдаг хүмүүс бол Түүнд бүрэн захирагддаг хүмүүс; тэд Сатанаар завхруулагдсан ч Бурханы одоогийн ажлаар авруулж, байлдан дагуулагдсан, гай зовлон туулж, эцэст нь Бурханаар бүрэн авхуулсан, цаашид Сатаны эзэмшил дор амьдрахаа больж, шударга бус байдлаас ангижирсан, ариун байдлыг амьдран харуулахыг хүсдэг хүмүүс юм—ийм хүмүүс бол хамгийн ариун хүмүүс; үнэхээр ариун хүмүүс юм. Хэрвээ чиний одоогийн үйлдлүүд Бурханы шаардлагын нэгээхэн хэсэгтэй ч тохирдоггүй бол чи таягдан хаягдана. Энэ нь маргаангүй. Бүх зүйл өнөөдрийн хэрэг явдлаас хамаардаг; хэдийгээр чамайг урьдчилан тогтоож, сонгосон ч өнөөдрийн үйлдэл чинь төгсгөлийг чинь тодорхойлно. Хэрвээ чи одоо хөл нийлүүлж чадахгүй бол таягдан хаягдана. Хэрвээ одоо хөл нийлүүлж чадахгүй юм бол чи яаж дараа нь хөл нийлүүлж чадах юм бэ? Одоо чиний өмнө ийм агуу гайхамшиг гарч ирсэн ч чи мөн л итгэдэггүй. Бурхан Өөрийн ажлыг дуусгаад, цаашид дахин ийм ажил хийхгүй бол чи дараа нь яаж Түүнд итгэх юм бэ? Тэр үед чиний хувьд Түүнийг дагах бүр ч боломжгүй байх болно! Хожим нь Бурхан, бие махбодтой болсон Бурханы ажилд хандах хандлага, мэдлэг, туршлагад чинь тулгуурлан нүгэлтэй юу, зөв шударга уу гэдгийг чинь тодорхойлж, төгс болгуулах уу, эсвэл таягдан хаягдах уу гэдгийг чинь тодорхойлно. Чи одоо тодорхой харах ёстой. Ариун Сүнс ингэж ажилладаг: Чиний өнөөдрийн үйлдлийн дагуу Тэр төгсгөлийг чинь тодорхойлдог. Өнөөдрийн үгийг хэн хэлдэг вэ? Өнөөдрийн ажлыг хэн хийдэг вэ? Өнөөдөр таягдан хаягдах уу гэдгийг чинь хэн шийддэг вэ? Чамайг төгс болгохыг хэн шийддэг вэ? Энэ бүхнийг Би Өөрөө хийдэг бус уу? Би бол эдгээр үгийг хэлдэг Нэгэн; Би бол ийм ажлыг хийдэг Нэгэн. Хүмүүсийг харааж, гэсгээж, шүүх нь бүгд Миний ажлын хэсгүүд. Эцэст нь чамайг таягдан хаяхыг ч бас Би шийднэ. Энэ бүх зүйл Миний мэдэх хэрэг! Чамайг төгс болгох нь Миний хэрэг ба чамд ерөөл эдлүүлэх нь ч бас Миний мэдэх хэрэг юм. Энэ нь бүгдээрээ Миний хийдэг ажил. Чиний төгсгөлийг Ехова урьдчилан тогтоогоогүй; үүнийг өнөөдрийн Бурхан тогтоож байгаа. Энэ нь одоо тодорхойлогдож байгаа; харин дэлхий ертөнц бүтээгдэхээс ч өмнө тодорхойлогдоогүй. Зарим хөгийн хүмүүс: “Таны нүд нэг л болохгүй байх шиг байна, Та намайг харах ёстой байдлаараа харахгүй байна. Эцэстээ Сүнс яг юу илчлэхийг Та харах болно!” гэж хэлдэг. Есүс анх Иудасыг шавиа болгон сонгосон. “Өөрөөс нь урвах шавийг Тэр яаж сонгож чадав аа?” гэж хүмүүс асуудаг. Эхэндээ Иудаст Есүсээс урвах санаа байгаагүй; энэ нь ердөө дараа нь тохиолдсон. Тухайн үед Есүс Иудаст нэлээд таатай хандаж байсан; Тэр Иудасаар Өөрийгөө дагуулж, санхүүгийн асуудлаа түүнд хариуцуулсан. Иудас

мөнгө завшихыг мэдэж байсан бол Есүс түүнд хэзээ ч тийм асуудал хариуцуулахгүй байсан юм. Энэ хүн шударга бус, зальхай, ах эгч нараа хуурна гэдгийг Есүс анх мэдээгүй гэж хэлж болно. Хожим нь, Иудас хэсэг хугацаанд Өөрийг нь дагасны дараа ах, эгч нараа аргалж, мөн Бурханыг аргалж байхыг нь Есүс харсан. Иудас мөнгөний хүүдийнээс мөнгө авдаг зуршилтай болохыг хүмүүс ч бас олж мэдээд, дараа нь Есүст энэ тухай хэлсэн. Тэр үед л Есүс юу болоод байгааг мэдсэн. Есүс цовдлолын ажлыг явуулах байсан, мөн Өөрөөс нь урвах хүн хэрэгтэй байсан ба Иудас энэ дүрд тоглоход яг тохирох хүн байж таарсан учраас л Есүс: “Бидний дундаас нэг нь Надаас урвана. Хүний Хүү энэхүү урвалтыг ашиглан цовдлогдоод, гурван өдрийн дараа дахин амилна” гэж хэлсэн юм. Тухайн үед Есүс үнэндээ Өөрөөс нь урвана гээд Иудасыг сонгосон юм биш; харин ч эсрэгээрээ Иудасыг үнэнч шавь нь байгаасай гэж Тэр хүссэн. Санаандгүйгээр Иудас Эзэнээс урвасан шунахай дорд амьтан байж таарсан тул Есүс энэ нөхцөл байдлыг ашиглан Иудасыг энэхүү ажилд сонгожээ. Хэрвээ Есүсийн арван хоёр шавь бүгд үнэнч байж, тэдний дундаас нэг нь ч Иудас шиг байгаагүй бол Есүсээс урвах хүн нь эцэстээ шавь нараас нь өөр хүн байх байсан юм. Гэвч тухайн үед тэдний дунд хээл хахууль авах дуртай Иудас гэх нэгэн байж таарсан. Тиймээс Есүс ажлаа гүйцээхийн тулд энэ хүнийг ашигласан юм. Энэ хэчнээн энгийн байсан гээч! Есүс Өөрийнхөө ажлын эхэнд үүнийг урьдчилан тогтоогоогүй; харин бүх зүйл тодорхой цэгт хүртэл өрнөсний дараа л энэ шийдвэрийг гаргажээ. Энэ нь Есүсийн шийдвэр, өөрөөр хэлбэл Бурханы Сүнсний Өөрийн шийдвэр байлаа. Анх Есүс Иудасыг сонгосон; Иудас дараа нь Есүсээс урвасан бөгөөд энэ нь зорилгоо биелүүлэхийн тулд Ариун Сүнсний хийсэн зүйл байв. Энэ нь тухайн үед Ариун Сүнсний хийсэн ажил байсан юм. Есүс Иудасыг сонгох үедээ Өөрөөс нь урвана гэж огт мэдээгүй. Искаротын Иудас гэдгийг л мэдэж байсан. Та нарын төгсгөл ч гэсэн, өнөөдрийн дуулгавартай байдлын чинь түвшин болон амийн өсөлтийн түвшний чинь дагуу тодорхойлогддог болохоос дэлхий ертөнц бүтээгдэх үед та нарын төгсгөл урьдчилан тогтоогдсон гэх хүний үзлээр тодорхойлогддоггүй. Чи эдгээр зүйлийг тодорхой ухамсарлах ёстой. Энэ бүх ажил чиний төсөөлдөг шиг хийгддэггүй юм.

НЭРШИЛ БОЛОН ЯЛГАМЖ ЧАНАРЫН ТАЛААР

Хэрвээ чи Бурханаар ашиглагдахад тохирсон байхыг хүсвэл Бурханы ажлыг мэдэх ёстой, өмнө нь (Шинэ болон Хуучин Гэрээнд) Түүний хийсэн ажлыг мэдэх ёстой, түүнчлэн Түүний өнөөдрийн ажлыг мэдэх ёстой; өөрөөр хэлбэл, чи 6,000 жилийн турш хийгдсэн Бурханы ажлын гурван үе шатыг мэдэх ёстой. Хэрвээ чамаас сайн мэдээ түгээхийг хүсвэл Бурханы ажлыг мэдэхгүйгээр чи үүнийг хийж чадахгүй. Библи болон Хуучин Гэрээний талаар, мөн тухайн үеийн Есүсийн ажил болон үгийн талаар танай Бурхан юу хэлсэн тухай хэн нэгэн чамаас асууж магадгүй. Хэрвээ чи тэдэнд Библийн дотоод түүхийг ярьж чадахгүй бол тэд үнэмшихгүй. Эхэндээ Есүс Өөрийн шавь нарт Хуучин Гэрээний талаар маш ихийг ярьсан. Тэдний уншсан бүхэн нь Хуучин Гэрээнийх байсан; Шинэ Гэрээ нь Есүсийг цовдлогдсоноос хойш хэдэн арван жилийн дараа л бичигдсэн юм. Сайн мэдээ түгээхийн тулд та нар үндсэндээ Библийн дотоод үнэн, Израиль дахь Бурханы ажил буюу Еховагийн хийсэн ажлыг ойлгох ёстой, бас Есүсийн хийсэн ажлыг ойлгох учиртай. Эдгээр нь бүх хүний хамгийн их анхаардаг асуудлууд бөгөөд ажлын тэрхүү хоёр үе шатны дотоод түүх бол тэдний сонсоогүй зүйл юм. Сайн мэдээ түгээхдээ, өнөөдрийн Ариун Сүнсний ажлын тухай яриаг эхлээд хойш тавь. Ажлын энэ үе шат тэдний хувьд хүршгүй байдаг, учир нь та нарын эрэлхийлдэг зүйл бол хамгийн өндөр дээд зүйл— Бурханы тухай мэдлэг болон Ариун Сүнсний ажлын тухай мэдлэг бөгөөд энэ хоёроос илүү өндөр дээд зүйл гэж үгүй. Хэрвээ та нар эхлээд өндөр дээд зүйлийн талаар ярих юм бол энэ нь тэдний хувьд хэтэрхий их байх болно, учир нь Ариун Сүнсний тийм ажлыг хэн ч туулж байгаагүй; энэ нь урьд өмнө тохиолдож байгаагүй ба хүн хүлээн зөвшөөрөхөд амархан биш байдаг. Тэдний туршлага нь Ариун Сүнсний зарим нэг тохиолдлын ажлыг агуулсан өнгөрсөн үеийн хуучин зүйл байдаг. Тэдний туулдаг зүйл нь өнөөдрийн Ариун Сүнсний ажил биш, эсвэл өнөөдрийн Бурханы хүсэл биш. Тэд ямар ч шинэ гэрэлгүйгээр, ямар ч шинэ зүйлгүйгээр хуучин ёс заншлын дагуу үйлдсээр байдаг.

Есүсийн эрин үед Ариун Сүнс Өөрийн ажлыг ихэвчлэн Есүсийн дотор хийсэн байхад сүмд тахилчийн өмсгөл өмсөн Еховад үйлчилж байсан хүмүүс гуйвшгүй үнэнчээр үүнийгээ хийсэн. Тэд ч бас Ариун Сүнсний ажилтай байсан боловч Бурханы өнөөгийн хүслийг ухаарах чадваргүй байсан ба хуучин хэрэгжүүлэлтийн дагуу зүгээр л Еховад үнэнч хэвээр үлдэж, шинэ удирдамжгүй байсан юм. Есүс ирж, шинэ ажил авчирсан атал сүмд үйлчилж байсан тэр хүмүүст шинэ

удирдамж байгаагүй, шинэ ажил ч байгаагүй. Сүмд үйлчлэнгээ тэд зүгээр л хуучин хэрэгжүүлэлтийг баримталж байсан бөгөөд сүмийг орхихгүйгээр ямар ч шинэ оролттой болж чадахгүй байв. Есүс шинэ ажил авчирсан ба Өөрийн ажлыг хийхийн тулд сүм рүү яваагүй. Тэр гагцхүү сүмийн гадна Өөрийн ажлыг хийсэн, учир нь Бурханы ажлын цар хүрээ аль эрт өөрчлөгдсөн байлаа. Тэрээр сүм дотор ажиллаагүй ба тэнд Бурханд үйлчлэх үедээ хүн аливаа зүйлийг байгаагаар нь л байлгаж байсан бөгөөд ямар ч шинэ ажлыг бий болгож чадаагүй юм. Үүний адилаар, өнөөгийн шашны хүмүүс Библийг шүтсээр байдаг. Хэрвээ чи тэдэнд сайн мэдээ түгээвэл тэд Библийн үгийн аар саар хэсгийг чам руу чулуудаж, ихээхэн нотолгоо олж, чамайг сандраан, хэлэх үггүй болгоно; тэгээд тэд чамд хаяг зүүж, итгэл бишрэлдээ мунхаг юм байна гэж бодно. “Та нар Бурханы үг болох Библийг ч мэддэггүй, тэгээд Бурханд итгэдэг гэж яаж хэлж чадаж байна аа?” гэж тэд хэлнэ. Тэгээд чамайг дорд үзэж, “Та нарын итгэдэг Нэгэн чинь Бурхан юм бол яагаад Тэр та нарт Хуучин болон Шинэ Гэрээний талаар бүгдийг хэлээгүй юм бэ? Нэгэнт Тэр Өөрийн алдрыг Израилиас Зүүн зүгт аваачсан юм бол яагаад Израильд хийгдсэн ажлыг мэддэггүй юм бэ? Тэр яагаад Есүсийн ажлыг мэддэггүй юм бэ? Хэрвээ та нар мэдэхгүй бол Тэр та нарт хэлээгүй гэдгийг энэ нь нотолж байна; Тэр хоёр дахь удаа бие махбодтой болсон Есүс юм бол яагаад эдгээр зүйлийг мэддэггүй юм бэ? Есүс Еховагийн хийсэн ажлыг мэдэж байсан; Тэр яагаад мэддэггүй юм бэ?” хэмээн хэлнэ. Цаг нь ирэхэд тэд чамаас ийм асуултууд асууна. Тэдний тархи ийм зүйлсээр дүүрэн байдаг; тэд асуухгүй байж яаж чадах юм бэ? Энэ урсгал дотор байгаа хүмүүс Библид анхаарлаа төвлөрүүлдэггүй, учир нь та нар өнөөдөр Бурханы алхам алхмаар хийсэн ажилтай мөр зэрэгцэн явсан, алхам алхмаар хийгддэг энэ ажлыг өөрсдийн нүдээр харсан, ажлын гурван үе шатыг тодорхой харсан, иймээс Библийг доош тавьж, үүнийг судлахаа болих хэрэгтэй болсон. Гэхдээ тэд үүнийг судлахгүй байж чадахгүй, учир нь тэд алхам алхмаар хийгддэг энэ ажлын талаар огт мэддэггүй. Зарим хүн: “Бие махбодтой болсон Бурханы хийсэн ажил болон өнгөрсөн үеийн эш үзүүлэгчид, элч нарын хийсэн ажлын хоорондох ялгаа юу вэ? Давидыг ч бас Эзэн гэж нэрлэдэг байсан, Есүс ч мөн адил; хэдийгээр тэдний хийсэн ажил ялгаатай байсан ч тэднийг адилхан нэрлэж байсан. Тэдний ялгамж чанар адилхан биш гэж яагаад хэлдэг юм бэ? Иоханы харсан зүйл үзэгдэл байсан, энэ нь ч бас Ариун Сүнснээс ирсэн бөгөөд Ариун Сүнсний хэлэх гэсэн үгийг тэр хэлж чадсан; тэгвэл яагаад Иоханы ялгамж чанар Есүсийнхээс өөр байсан юм бэ?” гэж асууна. Есүсийн хэлсэн үг Бурханыг бүрэн

төлөөлж чаддаг байсан ба Бурханы ажлыг бүрэн төлөөлсөн. Иоханы харсан зүйл нь үзэгдэл байсан ба тэр Бурханы ажлыг бүрэн дүүрэн төлөөлөх чадваргүй байв. Иохан, Петр, Паул нар Есүсийн адилаар олон үг хэлсэн, гэхдээ тэд яагаад Есүстэй адил ялгамж чанартай байгаагүй юм бэ? Энэ нь үндсэндээ тэдний хийсэн ажил өөр байснаас болдог. Есүс Бурханы Сүнсийг төлөөлсөн ба шууд ажиллаж байсан Бурханы Сүнс байв. Тэрээр шинэ эрин үеийн ажил буюу өмнө нь хэний ч хийж байгаагүй ажлыг хийсэн юм. Тэрээр шинэ замыг нээж, Еховаг төлөөлж, Бурханыг Өөрийг нь төлөөлж байсан, харин Петр, Паул, Давид нарын хувьд хэн гэж дуудагдаж байснаас үл хамааран тэд зөвхөн Бурханы бүтээлийн ялгамж чанарыг л төлөөлж байсан ба Есүс юм уу Еховагаар илгээгдсэн байв. Иймээс тэд хэчнээн их ажил хийсэн ч, хэчнээн агуу гайхамшиг үзүүлсэн ч ердөө Бурханы бүтээлүүд байсан бөгөөд Бурханы Сүнсийг төлөөлөх чадваргүй байлаа. Тэд Бурханы нэрийн дор ажилласан, эсвэл Бурханаар илгээгдсэнийхээ дараа ажилласан; цаашлаад Есүс юм уу Еховагийн эхлүүлсэн эрин үед ажилласан бөгөөд өөр ямар ч ажил хийгээгүй. Эцсийн эцэст тэд ердөө л Бурханы бүтээлүүд байсан юм. Хуучин Гэрээнд олон эш үзүүлэгч зөгнөл хэлсэн, эсвэл зөгнөлийн ном бичсэн. Хэн ч тэднийг Бурхан гэж хэлээгүй боловч Есүсийг ажиллаж эхэлмэгц Бурханы Сүнс Түүнийг Бурхан гэж гэрчилсэн. Яагаад тэр вэ? Өдийд чи аль хэдийн мэдчихсэн байх ёстой! Урьд нь, элчүүд болон эш үзүүлэгчид олон янзын захидал бичиж, олон зөгнөл хэлсэн. Хожим нь хүмүүс тэдгээрийн заримыг Библид оруулахаар сонгосон ба зарим нь алга болсон. Тэдний хэлсэн бүхэн Ариун Сүнснээс ирсэн гэж хүмүүс хэлдэг байхад яагаад үүний заримыг сайн гэж үзээд, заримыг нь муу гэж үзсэн юм бэ? Яагаад заримыг нь сонгож, бусдыг нь сонгоогүй вэ? Хэрвээ тэдгээр нь үнэхээр Ариун Сүнсний хэлсэн үг байсан бол хүмүүс шилж сонгох хэрэгтэй байсан гэж үү? Есүсийн хэлсэн үг, хийсэн ажлын тухай тэмдэглэл яагаад Дөрвөн Сайн Мэдээ бүрд өөр байдаг вэ? Энэ нь тэдгээрийг тэмдэглэсэн хүмүүсийн алдаа биш гэж үү? Зарим хүн: “Паул болон Шинэ Гэрээний бусад зохиогчдын бичсэн захидлууд ба хийсэн ажил зарим талаар хүний хүслээс бий болж, хүний үзэлтэй холилдсон, тэгвэл Таны (Бурханы) өнөөдөр хэлж буй үгэнд ямар ч хүний хольц байхгүй гэж үү? Тэдгээр нь үнэхээр хүний ямар ч үзлийг агуулдаггүй юу?” хэмээн асууна. Бурханы хийдэг ажлын энэ үе шат нь Паул болон олон элч, эш үзүүлэгчийн хийснээс шал өөр юм. Ялгамж чанар нь ялгаатайгаар үл барам үндсэндээ хийсэн ажил нь ч ялгаатай байдаг. Паул цохигдож, Эзэний өмнө унасныхаа дараа ажиллахдаа Ариун Сүнсээр удирдуулсан бөгөөд илгээгдсэн нэгэн болсон

юм. Иймээс тэр чуулгануудад захидал бичсэн бөгөөд эдгээр захидал нь бүгд Есүсийн сургаалыг дагасан. Паул Эзэн Есүсийн нэрийн дор ажиллахаар Эзэнээр илгээгдсэн боловч Бурхан Өөрөө ирэхдээ ямар ч нэрийн дор ажиллаагүй ба Өөрийнхөө ажилд өөр хэнийг ч биш, харин Бурханы Сүнсийг төлөөлж байлаа. Бурхан Өөрийн ажлыг шууд хийхээр ирсэн: Түүнийг хүн төгс болгоогүй бөгөөд Түүний ажил ямар нэг хүний сургаалд тулгуурлан явагдаагүй. Ажлын энэ үе шатанд Бурхан хувийн туршлагаа ярьснаар удирдаагүй, харин ч Өөрт нь юу байгаагийн дагуу Өөрийн ажлыг шууд хэрэгжүүлсэн. Жишээлбэл, үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт, гэсгээлтийн цаг үе, үхлийн шалгалт, Бурханыг хайрлах цаг үе... Энэ бүх ажил урьд нь хэзээ ч хийгдэж байгаагүй бөгөөд хүний туршлага биш, харин өнөөгийн эрин үеийн ажил юм. Миний хэлсэн үгээс аль нь хүний туршлага вэ? Тэдгээр нь бүгд Сүнснээс шууд ирсэн, Сүнснээс гарсан бус уу? Чиний хэв чанар маш дорд учраас л чи үнэнийг нэвт харж чадахгүй байгаа юм! Миний ярьдаг амийн бодитой зам нь замыг залж чиглүүлэхийн төлөө байдаг бөгөөд өмнө нь хэн ч ярьж байгаагүй, урьд нь хэн ч энэ замыг туулж байгаагүй, хэн ч энэ бодит байдлыг мэдээгүй. Намайг эдгээр үгийг айлдахаас өмнө хэн ч, хэзээ ч үүнийг ярьж байгаагүй. Хэн ч, хэзээ ч ийм туршлагын талаар ярьж байгаагүй, мөн тэд хэзээ ч ийм нарийн ширийнийг яриагүй, түүнчлэн, эдгээр зүйлийг илчлэхийн тулд хэн ч, хэзээ ч тийм байдлыг зааж үзүүлээгүй. Өнөөдөр Миний хөтлөн явдаг энэ замаар хэн ч, хэзээ ч яваагүй ба хэрвээ хүн явж байсан бол энэ нь шинэ зам биш байх байсан юм. Паул, Петр хоёрыг жишээ болгон аваад үз. Есүсийг замаар анхлан явахаас өмнө тэдэнд хувийн туршлага гэж байгаагүй. Зөвхөн Есүсийг энэ замаар явсны дараа л тэд Есүсийн хэлсэн үг, явсан замыг туулсан; үүнээс тэд ихээхэн туршлага олж авч, захидлууд бичсэн. Иймээс хүний туршлага нь Бурханы ажилтай адилгүй бөгөөд Бурханы ажил нь хүний үзэл болон туршлагаар тодорхойлогддог мэдлэгтэй адилгүй. Өнөөдөр Би шинэ замаар явж, шинэ ажил хийж байгаа бөгөөд Миний ажил, айлдвар Иохан болон бусад бүх эш үзүүлэгчийнхээс өөр гэж Би ахин дахин хэлсэн. Би хэзээ ч эхэлж туршлага олж аваад, дараа нь үүнийгээ та нарт ярьж байгаагүй—хэзээ ч тэгж байгаагүй. Хэрвээ тэгсэн бол тэр нь та нарыг аль эрт удаашруулчих байсан биш үү? Урьд нь, олон хүний ярьдаг байсан мэдлэг өндөр байсан боловч тэдний бүх үг сүнслэг гэгддэг хүмүүсийн үгэнд л үндэслэдэг байсан. Тэд замыг залж чиглүүлээгүй, харин энэ нь тэдний туршлагаас, харсан зүйлээс нь, мэдлэгээс нь гарч ирсэн. Зарим нь тэдний үзэл байсан, зарим нь тэдний нэгтгэн дүгнэсэн туршлага байсан юм. Өнөөдөр Миний ажлын шинж чанар тэднийхээс шал өөр.

Би бусдаар хөтлүүлэн явж үзээгүй, бас бусдаар төгс болгуулахыг ч хүлээн зөвшөөрөөгүй. Түүнчлэн, Миний ярьсан, нөхөрлөсөн бүхэн өөр хэнийхтэй ч адилгүй бөгөөд өөр хэн ч, хэзээ ч ярьж байгаагүй. Өнөөдөр та нар хэн бэ гэдгээс үл хамааран, та нарын ажил Миний хэлсэн үгийн үндсэн дээр хэрэгждэг. Эдгээр айлдвар болон ажилгүйгээр хэн эдгээр зүйлийг (үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт, гэсгээлтийн цаг үе...) туулах чадвартай байж, хэн тийм мэдлэгийн талаар ярьж чадах юм бэ? Чи үнэхээр үүнийг тодорхой харж чадахгүй юу? Ажлын үе шатаас үл хамааран, Намайг үг хэлэнгүүт та нар Миний үгийн дагуу нөхөрлөж эхэлдэг ба тэдгээрийн дагуу ажилладаг, энэ нь та нарын хэний ч бодсон зам биш. Өдий хүрчхээд чи ийм энгийн, тодорхой асуултыг ойлгож чадахгүй байсаар л байна уу? Энэ нь хэн нэгний бодож олсон зам биш, мөн ямар нэг сүнслэг хүнийх дээр ч үндэслэсэн биш. Энэ нь шинэ зам бөгөөд нэгэнтээ Есүсийн хэлж байсан ихэнх үг ч хэрэглэгдэхээ больсон. Миний ярьдаг зүйл бол шинэ зууныг нээх ажил бөгөөд бие даасан ажил юм; Миний хийдэг ажил, хэлдэг үг бүгд шинэ. Энэ нь өнөөдрийн шинэ ажил биш гэж үү? Тухайн үед Есүсийн ажил ч бас ийм байсан. Түүний ажил ч бас сүм дэх хүмүүсийнхээс өөр байсан ба фарисайчуудын ажлаас ч ялгаатай байсан, мөн Израилийн бүх ард түмний хийсэнтэй огтхон ч адил төстэй байгаагүй. Үүнийг нүдээр харсныхаа дараа хүмүүс: “Үүнийг үнэхээр Бурхан хийсэн гэж үү?” гэцгээн шийдэж чадаагүй юм. Есүс Еховагийн хуулийг баримтлаагүй; хүнд зааж сургахаар ирэх үедээ Түүний хэлсэн бүхэн шинэ байсан бөгөөд эртний ариун хүмүүс, Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийн хэлснээс өөр байсан, үүнээс болоод хүмүүс эргэлзсэн хэвээр үлдсэн. Үүнээс үүдэн хүнтэй харьцахад маш төвөгтэй болсон юм. Ажлын энэ шинэ үе шатыг хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө та нарын дийлэнх нь тэрхүү сүнслэг хүмүүсийн суурин дээр хэрэгжүүлж, орох замаар алхсан. Гэхдээ өнөөдөр Миний хийдэг ажил асар их ялгаатай тул та нар энэ нь зөв үү, буруу юу гэдгийг шийдэж чаддаггүй. Урьд нь ямар замаар явсныг чинь Би тоодоггүй, мөн хэний “хоолыг” идсэнийг чинь, эсвэл хэнийг “эцгээ” болгосныг чинь ч сонирхдоггүй. Нэгэнт Би ирж, хүнийг залж чиглүүлэх шинэ ажлыг авчирсан учраас Намайг дагадаг бүхэн Миний хэлсний дагуу үйлдэх ёстой. Төрсөн “гэр бүл” чинь хэчнээн хүчирхэг байх нь хамаагүй чи Намайг дагах ёстой, хуучин хэрэгжүүлэлтийнхээ дагуу үйлдэх ёсгүй, чамайг “үрчилсэн эцэг” огцрох ёстой ба чи хүртэх ёстой ноогдол хувиа эрж хайхын тулд өөрийн Бурханы өмнө очих ёстой. Чи тэр чигтээ Миний гарт байгаа ба үрчилсэн эцэгтээ хэтэрхий сохроор итгэх ёсгүй; тэр чамайг бүрэн дүүрэн хянаж чадахгүй. Өнөөдрийн ажил бол бие даасан

ажил. Өнөөдөр Миний хэлдэг бүхэн өнгөрсөн үеийн суурин дээр үндэслээгүй нь илэрхий; энэ нь шинэ эхлэл бөгөөд хэрвээ чи үүнийг хүний гараар бүтээгдсэн гэдэг бол аврагдахын аргагүй үнэхээр сохор хүн юм!

Исаиа, Езекиел, Мосе, Давид, Абрахам, Даниел нар Израилийн сонгогдсон хүмүүсийн дундах удирдагчид буюу эш үзүүлэгчид байсан. Яагаад тэднийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Яагаад Ариун Сүнс тэдэнд гэрчлэл хийгээгүй вэ? Есүсийг ажлаа эхэлж, үгээ хэлж эхлэнгүүт Ариун Сүнс яагаад Есүст гэрчлэл хийсэн бэ? Яагаад Ариун Сүнс бусдад нь гэрчлэл хийгээгүй вэ? Махан биетэй байсан тэр хүмүүсийг бүгдийг нь “Эзэн” гэж нэрлэж байсан. Тэднийг юу гэж нэрлэж байснаас үл хамааран тэдний ажил өөрсдийнх нь оршихуй, мөн чанарыг төлөөлж байсан ба оршихуй болон мөн чанар нь тэдний ялгамж чанарыг төлөөлж байв. Тэдний мөн чанар нь нэршилтэй нь хамаагүй байсан; харин тэдний илэрхийлж байсан зүйл болон амьдран харуулж байсан зүйл мөн чанарыг нь төлөөлдөг байв. Хуучин Гэрээнд Эзэн гэж дуудуулах нь маш энгийн зүйл байсан ба хүнийг юу ч гэж дуудаж болно, гэхдээ түүний мөн чанар болон төрөлхийн ялгамж чанар нь хувиршгүй байсан. Тэрхүү хуурамч Христүүд, хуурамч эш үзүүлэгчид, хууран мэхлэгчдийн дунд “Бурхан” гэж дуудуулдаг хүмүүс ч бас байдаг бус уу? Тэгвэл яагаад тэд Бурхан биш вэ? Учир нь тэд Бурханы ажлыг хийх чадваргүй. Угтаа тэд бол хүн, хүмүүсийг мэхлэгчид болохоос Бурхан биш, иймээс тэдэнд Бурханы ялгамж чанар байдаггүй. Давид ч гэсэн арван хоёр овгийн дунд Эзэн гэж нэрлэгддэг байгаагүй гэж үү? Есүсийг ч бас Эзэн гэж нэрлэдэг байсан; яагаад Есүс ганцаараа бие махбодтой болсон Бурхан гэж нэрлэгдсэн бэ? Иеремиаг ч бас хүний Хүү гэдэг байсан бус уу? Есүсийг ч гэсэн хүний Хүү хэмээн нэрлээгүй гэж үү? Яагаад Есүс Бурханы өмнөөс цовдлогдсон бэ? Түүний мөн чанар өөр байснаас болоогүй гэж үү? Түүний хийсэн ажил өөр байснаас болоогүй гэж үү? Алдар цол хамаатай гэж үү? Хэдийгээр Есүсийг ч бас хүний Хүү гэж нэрлэж байсан боловч Тэр бол анх удаа бие махбодтой болсон Бурхан байсан, Тэрээр эрх мэдэл эзэмшиж, золин авралын ажлыг гүйцэтгэхийн тулд ирсэн. Есүсийн ялгамж чанар, мөн чанар нь хүний Хүү хэмээн нэрлэгдэж байсан бусад хүмүүсийнхээс өөр байсан гэдгийг энэ нь нотолдог. Ариун Сүнсний ашиглаж байсан хүмүүсийн хэлсэн бүх үг Ариун Сүнснээс ирсэн гэж өнөөдөр та нараас хэн чинь хэлж зүрхлэх вэ? Тийм зүйл хэлж зүрхлэх хүн байна уу? Хэрвээ чи тийм зүйл хэлдэг бол яагаад Езрагийн зөгнөлийн ном хаягдсан бэ, мөн яагаад эртний ариун хүмүүс болон эш үзүүлэгчдийн номуудад ч мөн адил зүйл тохиолдсон бэ? Хэрвээ тэдгээр нь бүгд

Ариун Сүнснээс ирсэн юм бол яагаад та нар тийм дураараа сонголт хийж зүрхэлдэг юм бэ? Чи Ариун Сүнсний ажлыг сонгох эрхтэй юу? Израилийн олон түүх мөн хаягдсан. Хэрвээ чи өнгөрсөн үеийн энэ бүх бичвэр Ариун Сүнснээс ирсэн гэж итгэдэг юм бол яагаад зарим ном хаягдсан бэ? Хэрвээ тэдгээр нь бүгд Ариун Сүнснээс ирсэн бол бүгдийг нь хадгалж, чуулгануудын ах, эгч нарт уншуулахын тулд илгээх ёстой байсан. Тэдгээрийг хүний хүслээр сонгож, эсвэл хаях ёсгүй; тэгэх нь буруу юм. Паул, Иохан нарын туршлага хувийн хэрсүү ухаантай нь холилдсон гэж хэлдэг нь тэдний туршлага болон мэдлэг Сатанаас ирсэн гэсэн үг биш, харин тэдэнд өөрсдийнх нь туршлага, хэрсүү ухаанаас гарсан зүйл байсан л гэсэн үг юм. Тэдний мэдлэг тухайн үеийн бодит туршлагынх нь дагуу байсан ба энэ бүхэн нь Ариун Сүнснээс ирсэн гэдгийг хэн итгэлтэйгээр хэлж зүрхлэх юм бэ? Хэрвээ Дөрвөн Сайн Мэдээ нь бүгд Ариун Сүнснээс ирсэн юм бол яагаад Матай, Марк, Лук, Иохан нар дор бүрнээ Есүсийн ажлын талаар өөр өөр зүйл хэлсэн юм бэ? Хэрвээ та нар үүнд итгэхгүй бол Петр Эзэнийг гурван удаа үгүйсгэсэн тухай Библийн тэмдэглэлийг аваад үз: Тэдгээр нь бүгд өөр бөгөөд тус бүрдээ өөрсдийн гэсэн онцлог шинжтэй байдаг. Олон мунхаг хүн: “Бие махбодтой болсон Бурхан ч бас хүн, иймээс Түүний хэлдэг үг бүхэлдээ Ариун Сүнснээс ирж чадах уу? Хэрвээ Паул, Иохан хоёрын үг хүний хүсэлтэй холилдсон байсан юм бол Түүний хэлдэг үг үнэхээр хүний хүсэлтэй холидоогүй гэж үү?” хэмээн асуудаг. Ийм зүйл хэлдэг хүмүүс харалган бөгөөд мэдлэггүй юм! Дөрвөн Сайн Мэдээг анхааралтай уншаад үз; Есүсийн хийсэн зүйл, хэлсэн үгийн талаар юу бичсэнийг унш. Тэмдэглэл бүр нь нэлээд өөр байдаг ба тус бүрдээ өөрсдийн гэсэн харах өнцөгтэй байдаг. Хэрвээ эдгээр номын зохиогчдын бичсэн зүйл бүгд Ариун Сүнснээс ирсэн бол бүгд адилхан, нэг янз байх ёстой байлаа. Тэгвэл яагаад ялгаатай байдаг вэ? Хүн үүнийг тодорхой харж чадахгүй бол туйлын мунхаг биш гэж үү? Хэрвээ чамаас Бурханд гэрчлэл хийхийг хүсвэл чи ямар гэрчлэл хийж чадах вэ? Бурханыг тийм байдлаар мэдэх нь Бурханд гэрчлэл хийж чадах уу? Хэрвээ бусад хүмүүс чамаас, “Иохан, Лук нарын тэмдэглэл хүний хүсэлтэй холилдсон юм бол та нарын Бурханы хэлсэн үг хүний хүсэлтэй холидоогүй гэж үү?” хэмээн асуувал чи тодорхой хариулт өгч чадах уу? Лук, Матай нар Есүсийн үгийг сонсож, Есүсийн ажлыг харсныхаа дараа өөрсдийн мэдлэгийн тухай ярьж, Есүсийн хийсэн ажлын тухай зарим баримтыг дурсамж маягаар тоочсон. Тэдний мэдлэг бүхэлдээ Ариун Сүнсээр илчлэгдсэн гэж чи хэлж чадах уу? Библиэс гадна, тэднээс илүү өндөр мэдлэгтэй олон сүнслэг хүн байсан; яагаад тэдний үгийг

дараагийн үеийнхэн нь авч үзээгүй вэ? Тэд ч бас Ариун Сүнсээр ашиглагдаагүй гэж үү? Өнөөдрийн ажилд Би Есүсийн ажлын сууринд үндэслэн Өөрийн хэрсүү ухааныг яриагүй, мөн Есүсийн ажлын цаад шалтгаантай харьцуулан Өөрийн хувийн мэдлэгийг ч яриагүй гэдгийг мэдэж ав. Есүс тухайн үед ямар ажил хийсэн бэ? Тэгвэл Би өнөөдөр ямар ажил хийж байгаа вэ? Миний хийж, хэлж байгаа зүйл урьд өмнө нь тохиолдож байгаагүй. Өнөөдөр Миний алхдаг замаар өмнө нь хэзээ ч хүн явж байгаагүй, өнгөрсөн эрин үеийн хүмүүс хэзээ ч алхаж байгаагүй. Өнөөдөр энэ нь нээгдсэн ба энэ нь Сүнсний ажил биш гэж үү? Хэдийгээр Ариун Сүнсний ажил байсан ч гэсэн, өнгөрсөн үеийн удирдагчид бүгдээрээ бусдын тавьсан суурин дээр өөрсдийн ажлыг явуулсан; гэхдээ Бурханы Өөрийн ажил бол өөр. Есүсийн ажлын үе шат ч бас адилхан байсан: Тэрээр шинэ замыг нээсэн юм. Тэр ирэхдээ тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, хүн гэмшиж, нүглээ улайх ёстой гэж хэлсэн билээ. Есүс Өөрийн ажлыг дуусгасны дараа Петр, Паул болон бусад хүмүүс Есүсийн ажлыг үргэлжлүүлж эхэлжээ. Есүс загалмайд цовдлогдож, тэнгэр өөд гарсны дараа цовдлолын замыг түгээхийн тулд Сүнс тэднийг илгээсэн. Хэдийгээр Паулын үг өндөр дээд байсан ч тэвчээр, хайр, зовлон, толгойгоо бүтээх, баптисм хүртэх, эсвэл дагах ёстой бусад сургаал гэх мэт Есүсийн хэлсэн зүйлийн суурин дээр үндэслэж байв. Энэ бүхнийг Есүсийн хэлсэн үгэнд суурилан хэлсэн юм. Тэд шинэ зам нээж чадаагүй, учир нь тэд бүгдээрээ Бурханы ашиглаж байсан хүмүүс юм.

Тухайн үеийн Есүсийн айлдвар болон ажил хоосон сургаал баримтлаагүй ба Тэрээр Хуучин Гэрээний хуулийн ажлын дагуу Өөрийн ажлыг гүйцэтгээгүй. Энэ нь Нигүүлслийн эрин үед хийгдэх ёстой ажлын дагуу хийгдсэн юм. Тэрээр Өөрийн авчирсан ажлын дагуу, Өөрийн хувийн төлөвлөгөөний дагуу, мөн Өөрийн үйлчлэлийн дагуу хөдөлмөрлөсөн; Тэр Хуучин Гэрээний хуулийн дагуу ажиллаагүй. Түүний хийсэн юу ч Хуучин Гэрээний хуулийн дагуу байгаагүй ба Тэрээр эш үзүүлэгчдийн үгийг биелүүлэхийн тулд ажиллахаар ирээгүй. Бурханы ажлын үе шат болгон нь эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг биелүүлэх зорилгоор хийгддэггүй бөгөөд Тэр хоосон сургаалыг мөрдөхийн тулд, эсвэл эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг зориуд биелүүлэхийн тулд ирээгүй. Гэсэн ч Түүний үйлдэл эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг нураагаагүй, өмнө нь Түүний хийсэн ажилд ч саад учруулаагүй. Түүний ажлын өвөрмөц шинж нь ямар ч сургаал мөрдөхгүйгээр Өөрийн хийх ёстой ажлыг хийх явдал байв. Тэр эш үзүүлэгч, эсвэл зөнч байгаагүй, харин Өөрийн хийх ёстой ажлыг бодитоор

хийхээр ирсэн гүйцэтгэгч байсан бөгөөд Өөрийн шинэ эрин үеийг нээж, шинэ ажлыг хэрэгжүүлэхээр ирсэн юм. Мэдээж Есүс Өөрийн ажлыг хийхээр ирэхдээ Хуучин Гэрээний эртний эш үзүүлэгчдийн хэлсэн олон үгийг ч бас биелүүлсэн. Иймээс өнөөдрийн ажил ч гэсэн Хуучин Гэрээний эртний эш үзүүлэгчдийн зөгнөлүүдийг биелүүлсэн юм. Би зүгээр л “шарласан хуучин хуанлийг” барихаа больсон төдий, тэгээд л тэр. Учир нь Миний хийх ёстой ажил илүү их байгаа, Миний та нарт хэлэх ёстой үг олон байгаа, энэхүү ажил болон үг Библийн эшлэлүүдийг тайлбарлахаас хавьгүй илүү ач холбогдолтой, яагаад гэвэл, тиймэрхүү ажил та нарт ямар ч ач холбогдолгүй, үнэ цэнгүй бөгөөд та нарт тусалж, эсвэл та нарыг өөрчилж чадахгүй. Би шинэ ажил хийхээр зорьсон болохоос Библийн ямар нэг эшлэлийг биелүүлэх гээгүй. Хэрвээ Бурхан Библийн эртний эш үзүүлэгчдийн үгийг биелүүлэхийн тулд л газар дэлхий дээр ирсэн бол бие махбодтой болсон Бурхан болон тэдгээр эртний эш үзүүлэгчийн хэн нь илүү агуу байх вэ? Эцсийн эцэст эртний эш үзүүлэгчид Бурханыг захирдаг уу, эсвэл Бурхан эртний эш үзүүлэгчдийг захирдаг уу? Чи эдгээр үгийг хэрхэн тайлбарлах вэ?

Эхэндээ Есүс Өөрийн үйлчлэлийг хараахан албан ёсоор эхлээгүй байх үедээ Өөрийг нь дагаж байсан шавь нарын адилаар заримдаа сүмд цуглаанд оролцож, магтан дуу дуулж, магтаал өргөж, Хуучин Гэрээг уншдаг байлаа. Тэр баптисм хүртээд боссоны дараа Сүнс албан ёсоор Түүн дээр буун ирж, ажиллан эхлэн, Түүний ялгамж чанар болон хийх гэж байсан үйлчлэлийг нь илчилсэн юм. Үүнээс өмнө хэн ч Түүний ялгамж чанарыг мэдээгүй ба Мариагаас гадна Иохан ч мэдээгүй. Баптисм хүртэх үедээ Есүс 29 настай байлаа. Түүний баптисм дууссаны дараа тэнгэр нээгдэж: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” гэх дуун гарчээ. Есүсийг баптисм хүртэнгүүт Ариун Сүнс ийм маягаар Түүнд гэрчлэл хийж эхэлсэн юм. 29 насандаа баптисм хүртэхээс өмнө Есүс хэвийн хүний амьдралаар амьдарч, идэх ёстойгоо идэж, хэвийн байдлаар унтаж, хувцасласан бөгөөд Түүний юу ч бусдаас ялгаатай байгаагүй, гэхдээ мэдээж зөвхөн хүний махан биеийн нүдээр л ийм байсан. Нас ахихын хэрээр Түүний оюун ухаан нэмэгдсэн гэж Библид бичсэн байдагчлан заримдаа Тэр бас сул дорой байсан, заримдаа бас аливааг тодорхой ялган таньж чаддаггүй байсан. Эдгээр үг нь, Тэр эгэл жирийн, хэвийн хүн чанартай байсан бөгөөд ялангуяа бусад хэвийн хүмүүсээс өөр байгаагүй гэдгийг л харуулж байгаа юм. Тэр ч бас хэвийн хүн шиг өсөж торнисон ба Түүнд онцгой зүйл юу ч байгаагүй. Гэсэн ч Тэр Бурханы халамж, хамгаалалт дор байлаа. Баптисм хүртсэнийхээ

дараа Тэр соригдож эхэлсэн, үүний дараа Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж, ажиллаж эхэлсэн ба хүч чадал, мэргэн ухаан, эрх мэдэл эзэмшсэн байлаа. Энэ нь, Түүнийг баптисм хүртэхээс өмнө Ариун Сүнс Түүн дотор ажиллаагүй, эсвэл Түүний дотор байгаагүй гэсэн үг биш. Түүнийг баптисм хүртэхээс өмнө ч гэсэн Ариун Сүнс дотор нь оршиж байсан боловч албан ёсоор ажиллаж эхлээгүй байв, учир нь Бурхан Өөрийн ажлыг хийх үед цаг хугацааны хязгаар байдаг, түүнчлэн хэвийн хүмүүст хэвийн өсөлтийн үйл явц байдаг. Ариун Сүнс үргэлж Түүний дотор амьдарсан. Есүс төрөх үедээ бусдаас өөр байсан ба үүрийн цолмон гарч ирсэн; Түүнийг төрөхөөс өмнө тэнгэрэлч Иосефийн зүүдэнд ирж, Мариа хүү төрүүлэх бөгөөд тэр хүүхэд Ариун Сүнснээс олдсон тухай түүнд хэлжээ. Есүсийг баптисм хүртсэний дараа Ариун Сүнс ажлаа эхэлсэн боловч Ариун Сүнс Есүс дээр дөнгөж л бууж ирсэн гэсэн үг биш юм. Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт бууж ирсэн гэж хэлсэн нь Түүний үйлчлэл албан ёсоор эхэлснийг хэлж байгаа юм. Бурханы Сүнс Түүн дотор өмнө нь байсан боловч цаг нь болоогүй байсан учраас хараахан ажиллаж эхлээгүй байсан бөгөөд Сүнс ажлаа яаран эхлээгүй юм. Баптисмаар дамжуулан Сүнс Түүнд гэрчлэл хийсэн. Түүнийг уснаас гарч ирэх үед Сүнс Түүн дэх ажлаа албан ёсоор эхэлсэн ба Бурханы махбод болсон бие үйлчлэлээ хэрэгжүүлж эхэлсэн, мөн золин авралын ажлыг эхлүүлсэн гэдгийг энэ нь илтгэсэн, өөрөөр хэлбэл, Нигүүлслийн эрин үе албан ёсоор эхэлсэн юм. Иймээс Бурхан ямар ажил хийх нь хамаагүй Бурханы ажилд тодорхой цаг байдаг. Баптисм хүртсэний дараа Есүст ямар нэг тодорхой өөрчлөлт гараагүй; Тэр Өөрийн анхны махбодод л байсан. Тэр зүгээр л Өөрийн ажлыг эхэлж, Өөрийн ялгамж чанарыг илчилсэн ба эрх мэдэл, хүч чадлаар дүүрэн байсан билээ. Энэ талаараа Тэр өмнөхөөсөө өөр байсан юм. Түүний ялгамж чанар өөр байсан, өөрөөр хэлбэл, Түүний байр сууринд илт өөрчлөлт гарсан; энэ нь Ариун Сүнсний гэрчлэл байсан бөгөөд хүний хийсэн ажил биш байлаа. Эхэндээ хүмүүс мэдээгүй бөгөөд Ариун Сүнс тийм маягаар Есүсийг гэрчлэнгүүт бага зэрэг мэдэж авчээ. Хэрвээ Ариун Сүнс Өөрийг нь гэрчлэхээс өмнө Есүс агуу ажил хийчихсэн боловч Бурханы Өөрийн гэрчлэлгүй байсан бол Түүний ажил хэчнээн агуу байх нь хамаагүй хүмүүс хэзээ ч Түүний ялгамж чанарыг мэдэхгүй байх байв, учир нь хүний нүд үүнийг харж чадахгүй байх байсан юм. Ариун Сүнсний гэрчлэлийн үе шатгүйгээр хэн ч Түүнийг бие махбодтой болсон Бурхан хэмээн танихгүй байх байв. Ариун Сүнс Өөрийг нь гэрчилсний дараа Есүс өмнөхтэйгээ адилаар, ямар ч ялгаагүйгээр үргэлжлүүлэн ажилласан бол энэ нь үр нөлөө үзүүлэхгүй байх байсан бөгөөд

үүнээс бас Ариун Сүнсний ажил үндсэндээ харагддаг. Гэрчлэл хийснийхээ дараа Ариун Сүнс Өөрийгөө харуулах хэрэгтэй болсон, ингэснээр Тэр бол Бурхан бөгөөд Түүн дотор Бурханы Сүнс байгаа гэдгийг чи тодорхой харж чадах байв; Бурханы гэрчлэл буруу байгаагүй ба Түүний гэрчлэл зөв байсныг энэ нь нотолж чадах байлаа. Хэрвээ Ариун Сүнсний гэрчлэлийн өмнөх болон дараа Түүний ажил адилхан байсан бол бие махбодтой болсон Бурханы үйлчлэл болон Ариун Сүнсний ажлыг тодотгохгүй байх байв, улмаар ямар ч тодорхой ялгаа байхгүй байх учраас хүн Ариун Сүнсний ажлыг таньж чадахгүй байх байсан юм. Гэрчлэл хийснийхээ дараа Ариун Сүнс энэ гэрчлэлээ хадгалах хэрэгтэй байсан тул Өөрийн мэргэн ухаан, эрх мэдлийг Есүст илэрхийлэх хэрэгтэй болсон ба энэ нь өнгөрсөн үеүдийнхээс өөр байлаа. Мэдээж энэ нь баптисмын үр дүн байгаагүй, баптисм бол ердөө ёслол төдий бөгөөд баптисм нь Түүний үйлчлэлээ хэрэгжүүлэх цаг болсныг харуулах арга зам байсан юм. Тийм ажил нь Бурханы агуу хүч чадлыг ил болгож, Ариун Сүнсний гэрчлэлийг ил болгохын төлөө байсан ба Ариун Сүнс энэ гэрчлэлээ эцсийг нь хүртэл хариуцах байв. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээс өмнө Есүс бас номлол сонсож, олон янзын газарт номлож, сайн мэдээ түгээсэн. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх цаг нь хараахан болоогүй байсан учраас, бас Бурхан Өөрөө даруухнаар махбодод нуугдаж байсан учраас Тэр ямар нэгэн агуу ажил хийгээгүй бөгөөд цаг нь болох хүртэл ямар ч ажил хийгээгүй юм. Тэрээр хоёр шалтгааны улмаас баптисмаас өмнө ажил хийгээгүй: Нэгдүгээрт, Ариун Сүнс ажиллахын тулд Түүн дээр албан ёсоор бууж ирээгүй байсан (өөрөөр хэлбэл, тийм ажил хийх хүч чадал, эрх мэдлийг Ариун Сүнс Есүст хайрлаагүй байсан) учраас хэдий Өөрийн ялгамж чанарыг мэдэж байсан ч Есүс дараа хийхээр төлөвлөж байсан ажлаа хийж чадаагүй бөгөөд баптисм хүртэх өдрөө хүртэл хүлээх ёстой болсон юм. Энэ нь Бурханы цаг хугацаа бөгөөд хэн ч, бүр Есүс Өөрөө ч үүнийг зөрчиж чадаагүй; Есүс Өөрөө Өөрийнхөө ажилд саад учруулж чадаагүй. Мэдээж энэ нь Бурханы даруу байдал, түүнчлэн Бурханы ажлын хууль байсан; хэрвээ Бурханы Сүнс ажиллахгүй бол хэн ч Түүний ажлыг хийж чадахгүй. Хоёрдугаарт, Тэр баптисм хүртэхээсээ өмнө зүгээр л маш эгэл, жирийн хүн байсан бөгөөд бусад хэвийн, энгийн хүмүүсээс ямар ч ялгаагүй байсан; энэ нь бие махбодтой болсон Бурхан ер бусын байгаагүйн нэг тал юм. Бие махбодтой болсон Бурхан нь Бурханы Сүнсний зохицуулалтыг зөрчөөгүй; Тэр дэг журамтай байдлаар, маш хэвийн байдлаар ажилласан. Зөвхөн баптисмын дараа л Түүний ажил эрх мэдэл, хүч чадалтай болсон юм. Өөрөөр

хэлбэл, хэдийгээр Тэр бие махбодтой болсон Бурхан байсан боловч ямар ч ер бусын үйлс хийгээгүй бөгөөд бусад хэвийн хүмүүсийн адилаар өссөн. Хэрвээ Есүс Өөрийн ялгамж чанарыг аль хэдийн мэдэж, баптисм хүртэхээсээ өмнө хаа сайгүй агуу ажил хийж, хэвийн хүмүүсээс өөр байж, ер бусын гэдгээ харуулсан бол Иохан ажлаа хийх боломжгүй байгаад зогсохгүй Бурханы хувьд ч гэсэн Өөрийн ажлын дараагийн алхмыг эхлэх аргагүй байх байлаа. Тэгсэн бол Бурханы хийсэн зүйл буруудсаныг энэ нь нотлох байсан бөгөөд Бурханы Сүнс болон Бурханы махбод болсон бие нэг эх сурвалжаас ирээгүй гэж хүнд харагдах байв. Иймд Библид бичигдсэн Есүсийн ажил нь баптисм хүртсэнийхээ дараа Түүний хийсэн ажил буюу гурван жилийн хугацаанд хийсэн ажил байв. Баптисм хүртэхээс өмнө Түүний хийсэн зүйлийг Библид тэмдэглээгүй байдаг, учир нь Тэр баптисм хүртэхээсээ өмнө энэ ажлыг хийгээгүй. Тэр ердөө эгэл хүн байсан ба эгэл хүнийг төлөөлж байлаа; Есүс Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээс өмнө хэвийн хүмүүсээс ямар ч ялгаагүй байсан бөгөөд бусад хүмүүс Түүнээс ямар ч ялгаа олж харж чадаагүй. 29 настай болсныхоо дараа л Бурханы ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлэхээр ирсэн гэдгээ Есүс мэдсэн; өмнө нь Тэр Өөрөө мэдээгүй, учир нь Бурханы хийсэн ажил ер бусын байгаагүй юм. Тэр арван хоёр настайдаа синагогын цуглаанд оролцох үед Мариа Түүнийг хайж байсан бөгөөд Тэр бусад хүүхдийн адилаар нэг л өгүүлбэр хэлсэн: “Ээж ээ! Би Өөрийн Эцэгийн хүслийг юунаас ч илүү дээгүүрт тавих ёстойг та мэдэхгүй гэж үү?” Мэдээж Ариун Сүнснээс олдсон болохоор Есүс зарим талаар онцгой байж чадаагүй гэж үү? Гэхдээ Түүний онцгой байдал нь Тэр ер бусын байсан гэсэн утгатай биш, харин Тэр өөр ямар ч жаахан хүүхдүүдээс илүүгээр Бурханыг хайрлаж байсан гэсэн үг юм. Хэдийгээр Тэр хүний төрхтэй байсан боловч мөн чанар нь онцгой, бусдаас өөр байлаа. Харин баптисм хүртсэнийхээ дараа л Тэр Ариун Сүнс Өөрийнх нь дотор ажиллаж байгааг үнэхээр мэдэрч, Бурхан Өөрөө гэдгээ мэдэрчээ. Тэр 33 настай болох үедээ л Ариун Сүнс Өөрөөр нь дамжуулан цовдлолын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн гэдгийг үнэхээр ухаарсан юм. 32 настайдаа Тэр зарим дотоод үнэнийг мэдэж авсан, яг л Матайн Сайн Мэдээнд бичсэн байдагчлан: “Симон Петр, ‘Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн’ гэв... Тэр цагаас эхлэн Есүс Иерусалим руу хэрхэн явах ёстойгоо, ахлагч, ахлах тахилч нар, хуулийн багш нараас их зовлон амсаж, алуулж, гурав дахь өдөр нь амилах зэргээ шавь нартаа хэлэв.” Тэр ямар ажил хийх ёстойгоо урьд нь мэддэггүй байсан боловч тодорхой цаг хугацаанд мэдсэн. Тэр төрөнгүүтээ тэрийг бүрэн мэдэж байсан юм биш; Ариун Сүнс Түүн дотор аажмаар ажилласан ба ажил нь тодорхой үйл явцтай

байсан. Хэрвээ бүр эхнээсээ л Тэр бол Бурхан, Христ, бие махбодтой болсон хүний Хүү бөгөөд цовдлолын ажлыг гүйцэлдүүлэх ёстой гэдгээ мэдэж байсан бол яагаад Тэр өмнө нь ажиллаагүй юм бэ? Яагаад шавь нартаа Өөрийн үйлчлэлийн талаар хэлснийхээ дараа л Есүс уй гашууг мэдэрч, үүний төлөө үнэн сэтгэлээсээ залбирсан юм бэ? Яагаад Иохан Түүний замыг нээж, Түүнд баптисм хүртээсний дараа л Тэр өмнө нь ойлгоогүй байсан олон зүйлээ ойлгосон юм бэ? Энэ бол бие махбодтой болсон Бурханы ажил байсан гэдгийг энэ нь нотолдог ба иймээс Түүний хувьд ойлгож, биелүүлэх үйл явц гэж байсан, учир нь Тэр бол Бурханы махбод болсон бие байсан бөгөөд Түүний ажил Сүнсний шууд хийсэн ажлаас өөр байв.

Бурханы ажлын алхам бүр ав адилхан урсгалыг дагадаг, иймээс дэлхий бүтээгдсэн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэл Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний алхам бүрийг дараагийнх нь нягт дагадаг. Хэрвээ зам засах хэн ч байгаагүй бол араас нь явах хэн ч байхгүй байх байв; араас нь явдаг хүмүүс байгаа болохоор зам засдаг хүмүүс бас байгаа юм. Ийм маягаар тус ажил алхам алхмаар уламжлагдаж ирсэн. Нэг алхам нь нөгөөгөө дагадаг ба замыг нээх хүн үгүй бол ажлыг эхлүүлэх боломжгүй бөгөөд Бурхан Өөрийн ажлыг урагшлуулах аргагүй байх байлаа. Ямар ч алхам нөгөөтэйгээ зөрчилддөггүй ба урсгал үүсгэх дарааллаар нэг нь нөгөөгөө дагадаг; үүнийг бүгдийг нь нэг Сүнс хийдэг. Гэхдээ хүн замыг нээж байна уу, эсвэл үргэлжлүүлж байна уу гэдгээс үл хамааран, энэ нь тэдний ялгамж чанарыг тодорхойлдоггүй. Тийм биш гэж үү? Иохан замыг нээж, Есүс ажлыг нь үргэлжлүүлсэн, иймд Есүсийн ялгамж чанар Иоханыхаас дор байсан гэдгийг энэ нь нотолдог уу? Есүсээс өмнө Ехова Өөрийн ажлыг хэрэгжүүлсэн, иймээс Ехова бол Есүсээс илүү агуу гэж чи хэлж чадах уу? Тэд замыг зассан уу, эсвэл үргэлжлүүлсэн үү гэдэг нь чухал биш; харин тэдний ажлын мөн чанар болон төлөөлж буй ялгамж чанар нь хамгийн чухал юм. Тийм биз дээ? Бурхан хүмүүсийн дунд ажиллахаар зорьсон тул зам засах ажлыг хийж чадах хүмүүсийг өсгөх хэрэгтэй болсон. Иохан дөнгөж номлож эхлэх үедээ “Та нар Эзэний замыг бэлдэж, Түүний замыг шулуун болгогтун.” “Гэмшицгээ: учир нь тэнгэрийн хаанчлал ойрхон байна” гэж хэлсэн юм. Тэр бүр эхнээсээ л ингэж ярьсан, тэгвэл яагаад эдгээр үгийг хэлж чадсан юм бэ? Эдгээр үгийг хэлсэн дарааллын хувьд тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг эхлээд ярьсан хүн нь Иохан байсан ба Есүс дараа нь ярьсан. Хүний үзлээр бол, шинэ замыг нээсэн хүн нь Иохан байсан бөгөөд иймээс мэдээж Иохан Есүсээс илүү агуу байлаа. Гэхдээ Иохан өөрийгөө Христ гэж хэлээгүй, Бурхан түүнийг Бурханы хайртай

Хүү гэж гэрчлээгүй, харин замыг нээж, Эзэний замыг бэлтгэхэд л түүнийг ашигласан төдий юм. Тэр Есүсийн замыг зассан боловч Есүсийн өмнөөс ажиллаж чадаагүй. Хүний бүх ажлыг ч бас Ариун Сүнс хадгалж ирсэн юм.

Хуучин Гэрээний эрин үед Ехова замыг залж явсан, Еховагийн ажил Хуучин Гэрээний бүхий л эрин үе болон Израиль дахь бүх ажлыг төлөөлсөн. Мосе ердөө л газар дээрх энэ ажлыг баримталсан бөгөөд түүний хөдөлмөрийг хүний хамтын ажиллагаа гэж тооцдог. Тухайн үед Ехова үг хэлж, Мосег дуудан, Израилийн ард түмэн дундаас Мосег өргөж, Мосегоор тэднийг удирдуулан цөл рүү болон Канаан руу явуулсан. Энэ нь Мосегийн өөрийн ажил байгаагүй, харин Еховагийн биечлэн удирдан чиглүүлсэн ажил байсан тул Мосег Бурхан гэж нэрлэж болохгүй. Мосе ч бас хууль тогтоосон, гэхдээ энэ хуулийг Ехова биечлэн зарлигдсан. Тэрээр ердөө л Мосегоор үүнийг хэлүүлсэн юм. Есүс ч бас тушаал гаргасан, мөн Хуучин Гэрээний хуулийг хүчингүй болгож, шинэ эрин үеийн тушаалыг гаргасан. Есүс яагаад Бурхан Өөрөө мөн бэ? Учир нь энд ялгаа бий. Тухайн үед Мосегийн хийсэн ажил эрин үеийг төлөөлөөгүй, шинэ замыг ч нээгээгүй; түүнийг Ехова удирдан чиглүүлж байсан ба тэр ердөө л Бурханы ашиглаж байсан нэгэн байв. Есүсийг ирэх үед Иохан зам засах ажлын алхмыг гүйцэтгэж, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж эхэлсэн (Ариун Сүнс үүнийг эхлүүлсэн юм). Есүс ирэх үедээ Өөрийн ажлыг шууд хийсэн боловч Түүний ажил болон Мосегийн ажил хоорондоо асар их ялгаатай байлаа. Исаиа ч бас олон зөгнөл хэлсэн, гэтэл тэр яагаад Бурхан Өөрөө байгаагүй вэ? Есүс тийм ч олон зөгнөл хэлээгүй, гэтэл Тэр яагаад Бурхан Өөрөө байсан бэ? Тухайн үеийн Есүсийн ажил бүгд Ариун Сүнснээс ирсэн гэж хэн ч хэлж зүрхлээгүй, мөн энэ нь бүгд хүний хүслээс гарсан, эсвэл бүхэлдээ Бурханы Өөрийн ажил байсан гэж ч хэлж зүрхлээгүй. Хүн ийм зүйлсийг судалж шинжлэх ямар ч аргагүй байсан. Исаиагийн хийсэн тэр ажил, хэлсэн тийм зөгнөлүүд бүгд Ариун Сүнснээс ирсэн гэж хэлж болно; тэдгээр нь шууд Исаиагаас өөрөөс нь гараагүй, харин Еховагаас ирсэн илчлэл байсан юм. Есүс асар их хэмжээний ажил хийгээгүй, олон үг хэлээгүй, олон зөгнөл ч хэлээгүй. Түүний номлож байгаа нь хүнд тийм ч өндөр дээд санагдаагүй, гэсэн ч Тэр Бурхан Өөрөө байсан бөгөөд үүнийг хүн тайлбарлашгүй юм. Иоханд, Исаиад, эсвэл Давидад хэн ч, хэзээ ч итгэж байгаагүй, хэн ч, хэзээ ч тэднийг Бурхан, Давид Бурхан, Иохан Бурхан гэж дуудаж байгаагүй; хэн ч, хэзээ ч ингэж хэлээгүй ба зөвхөн Есүсийг л Христ гэж дуудсан. Бурханы гэрчлэлийн дагуу, Түүний хийсэн ажил, хэрэгжүүлсэн үйлчлэлийн дагуу энэ ангилал хийгдсэн. Абрахам, Давид, Иошуа, Даниел,

Исаиа, Иохан, Есүс гэх зэрэг Библийн агуу хүмүүсийн тухайд гэвэл, тэдний хийсэн ажлаар дамжуулан хэн нь Бурхан Өөрөө байсан, ямар төрлийн хүмүүс нь эш үзүүлэгчид, аль нь элч нар байсан бэ гэдгийг чи ялган таньж чадна. Хэнийг нь Бурхан ашиглаж байсан, хэн нь Бурхан Өөрөө байсан гэдэг нь тэдний хийсэн ажлын мөн чанар болон төрлөөр ялгагдаж, тодорхойлогддог. Хэрвээ чи тодорхой ялган таньж чаддаггүй бол Бурханд итгэх гэдэг юу гэсэн үг болохыг мэдэхгүй байгааг чинь энэ нь нотолно. Есүс маш олон үг хэлж, маш их ажил хийж, ялангуяа олон гайхамшиг үзүүлсэн учраас Тэр бол Бурхан юм. Үүний адилаар Иохан ч гэсэн ихээхэн ажил хийж, олон үг хэлсэн, Мосе ч гэсэн адилхан; яагаад тэднийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Адамыг Бурхан шууд бүтээсэн; зүгээр л бүтээл гэж дуудагдахын оронд тэр яагаад Бурхан гэж дуудагдаагүй вэ? Хэрвээ хэн нэгэн чамд “Өнөөдөр Бурхан маш их ажил хийж, олон үг хэлсэн; Тэр бол Бурхан Өөрөө. Тэгвэл Мосе ч гэсэн маш олон үг хэлсэн болохоор бас Бурхан Өөрөө байх ёстой!” гэж хэлбэл чи түүнээс эргүүлээд ингэж асуух ёстой: “Тэр үед яагаад Бурхан Иоханыг биш, Есүсийг Бурхан Өөрөө хэмээн гэрчилсэн бэ? Иохан Есүсээс өмнө ирээгүй гэж үү? Иохан, Есүс хоёрын ажлын аль нь илүү агуу байсан бэ? Хүний хувьд Иоханы ажил Есүсийнхээс илүү агуу харагдаж байсан, тэгвэл яагаад Ариун Сүнс Иоханд биш, харин Есүст гэрчлэл хийсэн бэ?” Өнөөдөр ч гэсэн үүнтэй адил зүйл тохиолдож байгаа! Мосе Израилийн ард түмнийг удирдаж байх тэр үед Ехова үүлэн дундаас түүнтэй ярьсан. Мосе шууд яриагүй, харин ч Ехова түүнийг шууд залж чиглүүлж байсан. Энэ нь Хуучин Гэрээний Израилийн ажил байсан юм. Мосегийн дотор Сүнс ч, Бурханы оршихуй ч байгаагүй. Тэрээр уг ажлыг хийж чадаагүй тул түүний хийсэн ажил болон Есүсийн хийсэн ажлын хооронд ихээхэн ялгаа байдаг. Яагаад гэвэл, тэдний хийсэн ажил өөр байсан! Тухайн хүн Бурханаар ашиглагддаг, эсвэл эш үзүүлэгч, элч, эсвэл Бурхан Өөрөө мөн эсэхийг түүний ажлын шинж чанараар ялган таньж болох ба энэ нь эргэлзээг чинь эцэслэнэ. Зөвхөн хурга л долоон лацыг нээж чадна гэж Библид бичигдсэн байдаг. Эрин үеүдийн туршид тэр агуу хүмүүсийн дунд судрыг тайлбарлагчид олон байсан, иймээс чи тэднийг бүгдийг нь Хурга гэж хэлж чадах уу? Тэдний тайлбар бүгд Бурханаас ирдэг гэж чи хэлж чадах уу? Тэд бол ердөө судрыг тайлбарлагчид; тэдэнд Хурганы ялгамж чанар байхгүй. Тэд яаж долоон лацыг нээхэд тохирох юм бэ? “Зөвхөн Хурга л долоон лацыг нээж чадна” гэдэг нь үнэн боловч Тэр зөвхөн долоон лацыг нээхээр ирдэг юм биш; энэ ажлыг хийх шаардлагагүй, энэ нь тохиолдлоор хийгддэг. Тэр Өөрийн ажлын талаар тов тодорхой мэдэж

байдаг; Түүний хувьд судрыг тайлбарлахад их цаг зарцуулах шаардлагатай юу? Зургаан мянган жилийн ажилд “Судрыг тайлбарлах Хурганы эрин үе” гэдгийг нэмэх ёстой гэж үү? Тэр шинэ ажил хийхээр ирсэн боловч бас өнгөрсөн үеийн ажлын талаар зарим илчлэл өгч, зургаан мянган жилийн ажлын тухай үнэнийг хүмүүст ойлгуулдаг. Библийн хэтэрхий олон эшлэлийг тайлбарлах хэрэггүй; өнөөдрийн ажил л гол нь, тэр л чухал. Бурхан гагцхүү долоон лацыг эвдэхийн тулд ирсэн юм биш, харин авралын ажил хийхээр ирсэн гэдгийг ч мэдэх ёстой.

Есүс эцсийн өдрүүдэд бууж ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Тэр яг яаж бууж ирэх вэ? Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр авруулсан чинь үнэн. Чи Бурханы авралаас үүдэн нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй хамт буухыг хүссээр байдаг—тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: Чи зүгээр л золин аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд Бурхан чамайг биечлэн өөрчилж, цэвэрлэх ёстой; чи зөвхөн золин авруулсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй.

Ажлын энэ шинэ үе шатны эхлэл байхгүй бол сайн мэдээ тунхаглагчид, номлогчид, судрыг тайлбарлагчид, агуу сүнслэг хүмүүс гэгддэг та нар хэр хол явахыг хэн мэдэх билээ! Ажлын энэ шинэ үе шатны эхлэлгүйгээр, та нарын ярьдаг зүйл хоцрогдсон байх болно! Энэ нь нэг бол сэнтийд залрах, эсвэл хаан болох биеийн хэмжээг бэлтгэх; өөрийгөө үгүйсгэх, эсвэл биеэ захирах; тэвчээртэй байх, эсвэл бүх зүйлээс хичээл сурах; даруу байдал юм уу хайр байна. Энэ нь улиг болсон зүйл биш гэж үү? Энэ нь зүгээр л нэг зүйлийг өөр нэрээр дуудаж байгаа хэрэг юм! Нэг бол толгойгоо бүтээж, талх хуваах, эсвэл гараа тавин залбирах, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах. Ямар нэг шинэ ажил байж чадах уу? Хөгжлийн хэтийн ирээдүй байж чадах уу? Хэрвээ чи ийм байдлаар үргэлжлүүлбэл хоосон сургаалыг сохроор дагаж, тогтсон журмыг мөрдөнө. Ажил чинь маш сүрлэг гэж та нар итгэдэг ч энэ нь бүгд эртний

“хөгшчүүлийн” уламжилж, заасан зүйл байсан гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нарын хэлдэг, хийдэг бүхэн тэр хөгшчүүлийн сүүлчийн үг биш гэж үү? Энэ нь тэр хөгшчүүлийн нас барахынхаа өмнө даалгасан зүйл биш гэж үү? Та нарын үйлдэл өнгөрсөн үеийн тэдгээр элч, эш үзүүлэгчийнхээс илүү гарсан, тэр ч бүү хэл бүх зүйлээс давсан гэж чи бодож байна уу? Ажлын энэ үе шатны эхлэл нь, хаан болж, сэнтийд залрахыг зорьсон Витнесс Лигийн ажлыг гайхан бишрэхийг чинь эцэс болгосон ба биеэ тоосон зан, сагсуурлыг чинь зогсоосон, ингэснээр та нар ажлын энэ үе шатанд хөндлөнгөөс оролцож чаддаггүй. Ажлын энэ үе шат байгаагүй бол та нар аврагдахын аргагүй болтлоо илүү гүн живэх байсан юм. Та нарын дунд хуучин зүйл хэтэрхий их байгаа! Азаар, өнөөдрийн ажил та нарыг буцаан авчирсан; тэгээгүй бол та нар ямар чиглэлд явах байсныг хэн мэдэх билээ! Бурхан бол үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан тул чи яагаад шинэ зүйлийг эрж хайдаггүй юм бэ? Яагаад үргэлж хуучин зүйлстэй зууралддаг юм бэ? Тиймээс өнөөдөр Ариун Сүнсний ажлыг мэдэх нь хамгийн чухал ач холбогдолтой юм!

ТА НАР БАЙР СУУРИЙН ЕРӨӨЛИЙГ ХОЙШ ТАВЬЖ, ХҮНИЙГ АВРАХ БУРХАНЫ ХҮСЛИЙГ ОЙЛГОХ ЁСТОЙ

Хүний үзэл бодлоор бол, Моабын үр удам бүрэн төгс болгуулах боломжгүй, тийм болгуулах ч эрхгүй. Нөгөө талаар, Давидын хүүхдүүдэд гарцаагүй найдвар байгаа бөгөөд үнэндээ бүрэн төгс болгуулж чадна. Хэрвээ хүн Моабын үр удам мөн бол бүрэн төгс болгуулж чадахгүй. Одоо ч гэсэн та нарын дунд хийгдэж байгаа ажлын ач холбогдлыг та нар мэдэхгүй хэвээр байдаг; энэ үе шатанд та нар зүрх сэтгэлдээ өөрсдийн хэтийн ирээдүйг агуулдаг бөгөөд тэдгээрийг орхихыг хүсдэггүй. Өнөөдөр Бурхан яагаад та нар мэтийн хамгийн зохисгүй хүмүүсийн бүлэгт ажиллахаар сонгосныг хэн ч тоодоггүй. Тэрээр энэ ажилд алдаа гаргасан байж болно гэж үү? Энэхүү ажил нь түр зуурын хайнга явдал уу? Моабын хүүхдүүд гэдгийг чинь үргэлж мэддэг байсан Бурхан яагаад яг та нарын дунд ажиллахаар бууж ирсэн юм бэ? Та нар хэзээ ч ингэж бодож байгаагүй юу? Бурхан Өөрийн ажлыг хийхдээ үүнийг хэзээ ч бодолцож үздэггүй юу? Тэр яаруу байдлаар авирладаг уу? Моабын үр удам гэдгийг чинь Тэр бүр эхнээсээ мэддэг байгаагүй гэж үү? Та нар эдгээр зүйлийг бодолцож үзэхээ мэддэггүй юм уу? Та нарын үзэл хааччихаа вэ? Эрүүл саруул сэтгэлгээ чинь самуурчихсан юм уу? Ухаалаг байдал болон мэргэн ухаан чинь хааччихаа вэ? Та нар тийм уужим

сэтгэлтэй болохоор ийм жаахан хэрэг явдлыг анхаардаггүй юм уу? Оюун санаа чинь өөрийн хэтийн ирээдүй, хувь заяа гэх мэт зүйлсэд хамгийн мэдрэмтгий байдаг боловч өөр юуны ч тухайд бол хөшүүн, мангуу, үнэхээр мэдлэггүй байдаг. Та нар ер нь яг юунд итгэдэг юм бэ? Өөрсдийн хэтийн ирээдүйд үү? Эсвэл Бурханд уу? Чи үзэсгэлэнтэй сайхан хүрэх газартаа л итгэдэггүй гэж үү? Хэтийн ирээдүйдээ л итгэдэггүй гэж үү? Амийн замын хэр ихийг чи одоо ойлгодог вэ? Чи хэр ихийг олж авсан бэ? Одоо Моабын үр удам дээр хийгдэж байгаа ажил та нарыг доромжлохын тулд хийгддэг гэж чи бодож байна уу? Энэ нь үзэшгүй муухай байдлыг чинь ил болгохын тулд зориуд хийгддэг үү? Та нараар гэсгээлтийг хүлээн зөвшөөрүүлээд, дараа нь та нарыг галт нуур луу шидэхийн тулд зориуд хийгддэг үү? Та нарт ямар ч хэтийн ирээдүй байхгүй гэж Би хэзээ ч хэлээгүй, та нар устгагдаж, мөхөх ёстой гэж бүр ч хэлээгүй. Би олны өмнө тийм зүйл зарласан гэж үү? Ямар ч найдвар байхгүй гэж чи хэлдэг, гэхдээ энэ нь чиний гаргасан дүгнэлт биш гэж үү? Энэ нь чиний өөрийн сэтгэхүйн үр нөлөө биш гэж үү? Чиний өөрийн дүгнэлт тооцогдох уу? Хэрвээ Би чамайг ерөөгдөөгүй гэж хэлбэл чи гарцаагүй сүйрлийн бай байх болно; хэрвээ Би чамайг ерөөгдсөн гэж хэлбэл чи гарцаагүй устгагдахгүй. Би чамайг Моабын удам гэж л хэлж байна; чамайг устгагдана гэж Би хэлээгүй. Зүгээр л Моабын үр удам хараагдсан бөгөөд нэг төрлийн завхарсан хүмүүс юм. Нүглийг урьд нь дурдсан; та нар бүгд нүгэлтэй биш гэж үү? Нүгэлтнүүд бүгд Сатанаар завхруулагдаагүй гэж үү? Нүгэлтнүүд бүгд Бурханыг эсэргүүцэж, Түүний эсрэг тэрсэлдэггүй гэж үү? Бурханыг эсэргүүцдэг хүмүүс хараагдах бус уу? Нүгэлтнүүд бүгд устгагдах ёстой бус уу? Тэр тохиолдолд мах цустай хүмүүсийн дундаас хэн аврагдаж чадах юм бэ? Та нар яаж өнөөдрийг хүртэл амьд үлдэж чадсан байх юм бэ? Та нар Моабын үр удам учраас сөрөг болсон; та нар бас нүгэлт хүмүүс гэж тооцогддог бус уу? Та нар яаж өдий хүрсэн юм бэ? Төгс болгох талаар дурдах үед та нар жаргалтай болдог. Асар их гай зовлон туулах ёстой гэдгээ сонссоны дараа энэ нь та нарыг бүр ч их ерөөлтэй болгоно гэж та нарт санагддаг. Гай зовлонгоос гарч ирсний дараа ялагч болж чадна, түүнчлэн энэ нь чамайг гэх Бурханы агуу ерөөл, агуу өргөмжлөл гэж чи боддог. Моабыг дурдангуут та нарын дунд үймээн үүсдэг; насанд хүрэгчид, хүүхдүүд ялгаагүй үгээр хэлэхийн аргагүй уйтгар гунигийг мэдэрч, зүрх сэтгэлд чинь ямар ч баяр хөөр байдаггүй ба та нар бүгд төрсөндөө харамсдаг. Ажлын энэ үе шат Моабын үр удам дээр хийгдэж буйн ач холбогдлыг та нар ойлгодоггүй; та нар өндөр байр суурь эрж хайхаа л мэддэг бөгөөд ямар ч найдвар байхгүй гэж бодогдох болгонд

ухарч няцдаг. Төгс болгох болон ирээдүйд хүрэх газрыг дурдангуут та нар баярладаг; та нар ерөөл хүртэж, сайн хүрэх газартай болохын тулд Бурханд итгэлээ өгсөн. Зарим хүн одоо өөрсдийн байр сууриас болж айн сандардаг. Тэд дорд үнэ цэн, доогуур байр суурьтай учраас төгс болгуулахаар эрэлхийлэхийг хүсдэггүй. Эхлээд төгс болгох тухай ярьсан, дараа нь Моабын үр удмын тухай дурдсан тул хүмүүс урьд нь дурдагдсан төгс болгох замыг няцаасан. Учир нь та нар эхнээс нь дуустал энэ ажлын ач холбогдлыг хэзээ ч мэдээгүй, мөн үүний ач холбогдлыг ч тоодоггүй. Та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан бөгөөд өчүүхэн төдий үймээнийг ч тэвчиж чаддаггүй. Байр суурь чинь хэтэрхий дорд гэдгийг харах үедээ та нар сөрөг болж, үргэлжлүүлэн эрж хайх итгэлээ алддаг. Хүмүүс ердөө нигүүлсэлд хүрсэн түвшин болон амар амгалангийн таашаалыг л итгэлийн бэлгэ тэмдэг гэж авч үзээд, ерөөл эрж хайхыг Бурханд итгэх итгэлийнх нь үндэс гэж үздэг. Тун цөөхөн хүн Бурханыг мэдэхээр эрж хайдаг, эсвэл өөрсдийн зан чанар дахь өөрчлөлтийг эрж хайдаг. Өөрсдийнхөө итгэлд хүмүүс, тохиромжтой хүрэх газар, хэрэгтэй бүх нигүүлслийг Бурханаар өөрсдөдөө өгүүлж, Бурханыг өөрсдийн зарц болгож, хэзээ ч, хэдийд ч хоорондоо зөрчилтэй байхгүйн тулд амар тайван, нөхөрсөг харилцаагаа хадгалахад Бурханыг хүргэхээр чармайдаг. Өөрөөр хэлбэл, тэдний Бурханд итгэх итгэл нь, өөрсдийнх нь бүх шаардлагад нийцэж, Библиэс уншсан “Би та нарын бүх залбирлыг сонсоно” хэмээх үгийн дагуу залбирсан бүхнийг нь тэдэнд өгөх амлалтыг Бурханаас шаарддаг. Бурхан үргэлж хаана ч, хэдийд ч хүмүүстэй сайхан харилцаатай байдаг өршөөнгүй Аврагч Есүс байсан учраас хэнийг ч шүүхгүй, хэнтэй ч харьцахгүй байхыг тэд Бурханаас хүлээдэг. Хүмүүс Бурханд ингэж итгэдэг: Тэд ердөө ичгүүр сонжуургүйгээр Бурханд шаардлага тавин, өөрсдөө тэрслүү, эсвэл дуулгавартай байх нь хамаагүй Бурхан зүгээр л бүх зүйлийг тэдэнд сохроор хайрлана. Тэд Бурханаас тасралтгүй “өр цуглуулдаг” бөгөөд Бурхан ямар ч эсэргүүцэлгүйгээр тэдэнд “өрөө төлж”, түүнчлэн, хоёр дахин ихийг төлөх ёстой; өөрсдөөс нь ямар нэгэн юм авсан ч бай, үгүй ч бай Бурхан өөрсдийнх нь л эрхшээлд байж болох ба Тэрээр хүмүүсийг дур зоргоороо зохион байгуулж болохгүй, тэр ч бүү хэл, олон жилийн турш нуусан Өөрийн мэргэн ухаан, зөвт зан чанарыг хүссэн үедээ, өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр хүмүүст илчилж болохгүй. Тэд зүгээр л өөрсдийн нүглийг Бурханд улайж, Бурхан зүгээр л тэдгээрийг уучилна, Бурхан үүнээс залхаж болохгүй бөгөөд энэ нь үүрд үргэлжилнэ. Бурхан хүнээр үйлчлүүлэхийн төлөө биш, харин хүнд үйлчлэхийн төлөө ирсэн, мөн хүний зарц байхаар ирсэн гэж Библид

тэмдэглэгдсэн байдаг тул тэд зүгээр л Бурханд тушаан, Бурхан өөрсдийг нь дуулгавартай дагана. Та нар үргэлж ингэж итгэсэн бус уу? Та нар Бурханаас ямар нэг зүйл олж авч чадахгүй үедээ зугтахыг хүсдэг; ямар нэгэн зүйлийг ойлгохгүй байх үедээ ихэд дургүйцэж, бүр Түүн рүү төрөл бүрийн хараал зүхэл чулуудахдаа тулдаг. Өөрийн мэргэн ухаан, гайхамшгийг бүрэн илэрхийлэх боломжийг та нар Бурханд Өөрт нь ер олгодоггүй; харин оронд нь зүгээр л түр зуурын амар амгалан, тав тух эдлэхийг хүсдэг. Одоог хүртэл Бурханд итгэх итгэлийн чинь хандлага ердөө нэгэн хэвийн хуучин үзэл бодлоос бүрдсэн. Хэрвээ Бурхан та нарт ялимгүй сүр жавхлан үзүүлэх л юм бол та нар аз жаргалтай бус болдог. Биеийн хэмжээ чинь яг хэр том болохыг та нар одоо харж байна уу? Үнэн хэрэгтээ хуучин үзэл бодол чинь өөрчлөгдөөгүй байхад өөрсдийгөө Бурханд үнэнч гэж бүү бод. Чамд юу ч тохиолдохгүй байх үед бүх зүйл төвөггүй явагдаж байна гэж чи бодоод, Бурханыг дээд зэргээр хайрладаг. Гэхдээ багахан зүйл тохиолдох үед чи Үхэгсдийн орон руу унадаг. Бурханд үнэнч байгаа нь энэ үү?

Хэрвээ байлдан дагуулалтын ажлын сүүлчийн үе шат Израильд эхлэх байсан бол тийм байлдан дагуулалтын ажил ямар ч утга учиргүй байх байв. Уг ажлыг Хятадад, хүмүүс та нар дээр хийх үед л хамгийн их ач холбогдолтой юм. Та нар бол хамгийн ядуу дорой хүмүүс буюу хамгийн дорд байр суурьтай хүмүүс; та нар энэ нийгмийн хамгийн дорд түвшний хүмүүс бөгөөд анх Бурханыг хамгийн бага хүлээн зөвшөөрсөн хүмүүс юм. Та нар Бурханаас хамгийн их холдсон, хамгийн их хохирсон хүмүүс билээ. Энэ үе шатны ажил зөвхөн байлдан дагуулалтын төлөө байдаг учраас хожмын гэрчлэлийг хийлгэхээр та нарыг сонгох нь хамгийн зохистой бус уу? Хэрвээ байлдан дагуулалтын ажлын эхний алхам нь хүмүүс та нар дээр хийгдээгүй байсан бол дараагийн байлдан дагуулалтын ажлыг урагш явуулахад хэцүү болох байсан, учир нь дараа болох байлдан дагуулалтын ажил өнөөдөр хийгдэж байгаа энэ ажлын бодит баримтад үндэслэн үр дүнд хүрнэ. Одоогийн байлдан дагуулалтын ажил нь нийт байлдан дагуулалтын ажлын зөвхөн эхлэл юм. Та нар бол байлдан дагуулагдах эхний бүлэг; байлдан дагуулагдах бүх хүн төрөлхтний төлөөлөл юм. Бурханы өнөөдөр хийдэг бүх ажил сайн бөгөөд Бурхан хүмүүст өөрсдийн тэрслүү занг мэдэх боломж олгоод зогсохгүй, бас байр суурийг нь илчилдэг гэдгийг үнэхээр мэдлэгтэй хүмүүс харах болно. Түүний үгийн зорилго, утга учир нь хүмүүсийг гонсойлгохын төлөө байдаггүй, мөн тэднийг унагаахын төлөө ч байдаггүй. Харин Түүний үгээр дамжуулан гэгээрэл, аврал авхуулахын төлөө байдаг;

Түүний үгийн замаар тэдний сүнсийг сэрээхийн төлөө байдаг. Дэлхий ертөнц бүтээгдсэн цагаас хойш хүн Бурхан байдаг гэдгийг мэдэхгүйгээр, Бурхан байдаг гэдэгт ч итгэхгүйгээр Сатаны эзэмшил дор амьдарсан. Энэ хүмүүс Бурханы агуу авралд багтаж, Бурханаар асар их өргүүлж байгаа нь үнэндээ Бурханы хайрыг харуулдаг; үнэхээр ойлгодог бүх хүн ингэж бодно. Тийм мэдлэггүй хүмүүс яах вэ? “Ай, Бурхан биднийг Моабын үр удам гэж хэлдэг; Тэр Өөрийн амаар үүнийг хэлсэн. Бид сайн үр дүнд хүрч бас л чадна гэж үү? Хэн биднийг Моабын үр удам болгосон юм бэ? Урьд нь Түүнийг маш их эсэргүүцэхэд хэн биднийг хүргэсэн юм бэ? Бурхан биднийг яллахаар ирсэн; Тэр бүр эхнээсээ л биднийг үргэлж шүүж байсныг чи харахгүй байна уу? Бид Бурханыг эсэргүүцсэн тул ингэж гэсгээгдэх ёстой” гэж тэд хэлнэ. Эдгээр үг зөв үү? Өнөөдөр Бурхан та нарыг шүүж, гэсгээж, ялладаг боловч чамайг ялладгийн зорилго нь чамд өөрийг чинь мэдүүлэхийн төлөө юм гэдгийг чи мэдэх ёстой. Чамд өөрийг чинь мэдүүлж, зан чанарыг чинь өөрчилж, түүнчлэн үнэ цэнийг чинь мэдүүлж, Бурханы бүх үйлдэл зөвт агаад Түүний зан чанар, Түүний ажлын хэрэгцээний дагуу байдаг, Тэр хүнийг аврахын төлөө Өөрийн төлөвлөгөөний дагуу ажилладаг, Тэр бол хүнийг хайрлаж, хүнийг аварч, мөн хүнийг шүүж, гэсгээдэг зөвт Бурхан юм гэдгийг харуулах гэсэндээ Бурхан яллаж, харааж, шүүж, гэсгээдэг. Хэрвээ чи дорд байр суурьтай, завхарсан, дуулгаваргүй гэдгээ л мэддэг боловч өнөөдөр чам дээр хийдэг шүүлт, гэсгээлтээрээ дамжуулан Бурхан Өөрийн авралыг ил болгохыг хүсдэг гэдгийг мэддэггүй бол туршлагажих ямар ч аргагүй бөгөөд цааш үргэлжлүүлж бүр ч чадахгүй. Бурхан хөнөөх юм уу устгахын тулд ирээгүй, харин шүүж, харааж, гэсгээж, аврахын тулд ирсэн юм. Түүний 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөө төгсөх хүртэл—Тэрээр төрөл бүрийн хүний төгсгөлийг илчлэхээс өмнө—газар дээрх Бурханы ажил авралын төлөө байх болно; үүний зорилго нь гагцхүү Өөрийг нь хайрладаг хүмүүсийг бүрмөсөн бүрэн төгс болгож, Өөрийн ноёрхол дор аваачихын төлөө байдаг. Бурхан хүмүүсийг хэрхэн авардаг нь хамаагүй, энэ нь бүхэлдээ, тэднийг хуучин сатанлаг уг чанараас нь салгаснаар хийгддэг; өөрөөр хэлбэл, тэднээр амийг эрж хайлгуулснаар Бурхан тэднийг авардаг. Хэрвээ тэгэхгүй бол Бурханы авралыг хүлээн авах ямар ч аргагүй байх болно. Аврал бол Бурханы Өөрийн ажил бөгөөд амийг эрэлхийлэх нь аврал хүлээн авахын тулд хүний хийх ёстой зүйл юм. Хүний нүдээр аврал бол Бурханы хайр бөгөөд Бурханы хайр нь гэсгээлт, шүүлт, хараал байж болохгүй; аврал нь хайр, энэрэл, түүнчлэн тайтгарлын үгсийг агуулах ёстой, мөн Бурханы хайрласан хязгааргүй их ерөөлийг агуулах ёстой. Бурхан хүнийг аврах үедээ

Өөрийн ерөөл, нигүүлслээр дамжуулан сэтгэлийг нь хөдөлгөдөг болохоор хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд өгч чаддаг гэж хүмүүс боддог. Өөрөөр хэлбэл, Тэр хүний сэтгэлийг хөдөлгөж байгаа нь түүнийг аварч байгаа хэрэг юм. Ийм аврал нь наймаацсанаар хийгддэг. Бурхан өөрсдөд нь зуу дахин ихийг өгөх үед л хүн Бурханы нэрийн өмнө захирагдаж, Түүний төлөө сайн ажиллаж, Түүнд алдар суу авчрахаар чармайна. Энэ нь хүн төрөлхтний төлөөх Бурханы санаа зорилго биш юм. Бурхан завхарсан хүн төрөлхтнийг аврахын тулд газар дээр ажиллахаар ирсэн; үүнд ямар ч худал хуурмаг байхгүй. Эс бөгөөс Тэр ажлаа хийхийн тулд биечлэн ирэхгүй байх байсан нь лавтай. Урьд нь Түүний авралын арга барил хамгийн их хайр, энэрлийг харуулж байсан болохоор Тэр бүх хүн төрөлхтний төлөө Өөрт байгаа бүхнээ Сатанд өгсөн юм. Өнөөдөр өнгөрсөн үетэй огт адилгүй: Өнөөдөр та нарт хайрласан аврал эцсийн өдрүүдэд, бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах үед тохиолдож байгаа; та нарыг аврах арга барил хайр юм уу энэрэл биш, харин хүнийг илүү бүрэн дүүрэн аврахын төлөөх гэсгээлт, шүүлт юм. Тиймээс та нарын хүлээн авдаг бүхэн гэсгээлт, шүүлт, өршөөлгүй цохилт байдаг боловч энэ хэрцгий цохилтод өчүүхэн төдий ч шийтгэл байхгүй гэдгийг мэдэж ав. Миний үг хэчнээн хатуу ширүүн байхаас үл хамааран та нарт тохиолддог зүйл бол ердөө тун хүний үнэргүй санагддаг цөөхөн хэдэн үг бөгөөд Би хэчнээн их уурласан ч бай, та нар дээр буун ирдэг зүйл нь мөн л сургаалын үг бөгөөд Би та нарт хор хөнөөл учруулах гээгүй, эсвэл та нарыг цаазлах гээгүй. Энэ нь бүгд баримт бус уу? Өнөөдөр зөвт шүүлт байсан ч бай, эсвэл хайр найргүй цэвэршүүлэлт, гэсгээлт байсан ч бай, бүгд авралын төлөө байдаг гэдгийг мэдэж ав. Өнөөдөр бүх зүйлийг төрлөөр нь ангилж, эсвэл хүний төрлүүдийг ил болгож байгаа эсэхээс үл хамааран, Бурханы бүх үг болон ажлын зорилго нь Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүсийг аврах явдал юм. Зөвт шүүлт нь хүнийг ариусгахын төлөө, хайр найргүй цэвэршүүлэлт нь хүнийг цэвэрлэхийн төлөө; хатуу үг, эсвэл цээрлүүлэлт нь хоёулаа ариусгаж, аврахын төлөө байдаг. Тиймээс өнөөдрийн авралын арга барил нь өнгөрсөн үеийнхтэй адилгүй. Өнөөдөр зөвт шүүлтээр дамжуулан та нарт аврал ирсэн ба энэ нь та нарыг төрлөөр нь ангилах сайн хэрэгсэл юм. Түүнчлэн, хайр найргүй гэсгээлт нь та нарын дээд зэргийн аврал болдог—энэхүү гэсгээлт, шүүлтийн өмнө та нар юу хэлэх юм бэ? Та нар эхнээсээ дуустлаа үргэлж авралыг эдлээгүй гэж үү? Та нар бие махбодтой болсон Бурханыг харж, Түүний бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг ухаарсан; үүнээс гадна, удаа дараагийн цохилт, сахилгажуулалтыг туулсан. Гэхдээ та нар бас дээд зэргийн нигүүлслийг хүртээгүй гэж үү? Та нарын ерөөл өөр хэнийхээс

ч илүү их биш гэж үү? Та нарын нигүүлсэл бүр Соломоны эдэлсэн алдар суу болон эд баялгаас илүү элбэг дэлбэг билээ! Энэ талаар бодоод үз: Хэрвээ Миний ирсэн санаа зорилго та нарыг аврахын оронд яллаж, шийтгэхийн төлөө байсан бол өдөр хоногууд чинь ийм удаан үргэлжлэх байсан гэж үү? Мах цустай нүгэлт оршихуй болох та нар өнөөдрийг хүртэл амьд үлдэж чадах байсан уу? Хэрвээ Миний зорилго ердөө та нарыг шийтгэхийн төлөө байсан бол Би яах гэж махбод болж, ийм том ажил үйлс эхлүүлэх юм бэ? Та нар шиг эгэл хүмүүсийг шийтгэхэд ганцхан үг айлдахад л болчих биш үү? Би та нарыг зориуд ялласныхаа дараа мөн л устгах хэрэгтэй юм гэж үү? Та нар Миний энэ үгэнд одоо ч итгэхгүй л байна уу? Би ердөө хайр, энэрлээр л дамжуулан хүнийг аварч чадах юм гэж үү? Эсвэл Би хүнийг аврахын тулд зөвхөн цовдлол ашиглах юм гэж үү? Миний зөвт зан чанар хүнийг бүрмөсөн дуулгавартай болгоход илүү тохиромжтой биш гэж үү? Энэ нь хүнийг бүрэн дүүрэн аварч чадах бус уу?

Би зөвхөн үг хэлж, хүний махан биеийг шийтгэхгүй байгаа болохоор хэдий Миний үг хатуу байж болох ч тэдгээрийг бүгдийг нь хүний авралын төлөө хэлдэг. Эдгээр үг хүнийг гэрэлд амьдруулж, гэрэл оршин байдгийг мэдүүлж, гэрэл бол эрхэм нандин гэдгийг мэдүүлдэг, үүнээс ч илүүтэйгээр эдгээр үг хүнд хэр ач тустайг мэдүүлж, бас Бурхан бол аврал юм гэдгийг мэдүүлдэг. Хэдийгээр Би гэсгээлт, шүүлтийн олон үг хэлсэн боловч тэдгээр нь та нар дээр үнэндээ хийгдээгүй. Би Өөрийн ажлыг хийж, Өөрийн үгийг хэлэхээр ирсэн бөгөөд хэдийгээр Миний үг хатуу чанд байж болох ч та нарын завхрал, тэрслүү байдлыг шүүн тэдгээрийг хэлдэг. Үүнийг хийх Миний зорилго бол хүнийг Сатаны эзэмшлээс аврах явдал хэвээр үлддэг; Би хүнийг аврахын тулд Өөрийн үгийг ашиглаж байгаа; Миний зорилго бол Өөрийн үгээр хүнийг хорлох явдал биш. Өөрийнхөө ажлаар үр дүнд хүрэхийн тулд Миний үг хатуу байдаг. Зөвхөн ийм ажлаар л дамжуулан хүн өөрийгөө мэдэж авч, тэрслүү зан чанараасаа салж чадна. Үгийн ажлын хамгийн их ач холбогдол нь үнэнийг ойлгосныхоо дараа хэрэгжүүлж, зан чанартаа өөрчлөлт гаргаж, өөрсдийнхөө тухай болон Бурханы ажлын тухай мэдлэгтэй болох боломжийг хүмүүст олгох явдал юм. Үг хэлэх арга замаар ажиллах нь л Бурхан, хүн хоёрыг ярилцах боломжтой болгодог бөгөөд үг л үнэнийг тайлбарлаж чадна. Ийм маягаар ажиллах нь хүнийг байлдан дагуулах хамгийн сайн арга барил юм; үг айлдахаас өөр ямар ч арга үнэн болон Бурханы ажлын талаар илүү тодорхой ойлголтыг хүнд өгч чадахгүй. Тиймээс Өөрийнхөө ажлын сүүлчийн үе шатанд Бурхан хүний хараахан ойлгоогүй байгаа бүх үнэн болон нууцыг дэлгэхийн тулд хүнтэй ярьдаг бөгөөд Бурханаас үнэн зам

болон амийг олж авч, тэгснээрээ Бурханы хүслийг биелүүлэх боломжийг тэдэнд олгодог. Хүн дээр хийдэг Бурханы ажлын зорилго нь тэдэнд Бурханы хүслийг хангалуун болгох боломж олгохын төлөө байдаг бөгөөд тэдэнд аврал авчрахын тулд хийгддэг. Тиймээс хүнийг аврах хугацаандаа Тэр хүнийг шийтгэх ажил хийдэггүй. Хүнд аврал авчрах хугацаандаа Бурхан мууг шийтгэж, сайныг шагнадаггүй, мөн бүх төрлийн хүмүүсийн хүрэх газрыг ч илчилдэггүй. Харин ч Өөрийнх нь ажлын эцсийн үе шат гүйцэлдсэний дараа л мууг шийтгэж, сайныг шагнах ажлыг хийх бөгөөд тэр үед л төрөл бүрийн хүмүүсийн төгсгөлийг илчилнэ. Шийтгүүлдэг хүмүүс нь үнэндээ аврагдаж чадахгүй хүмүүс байдаг байхад аврагддаг хүмүүс нь хүнийг аврах авралынх нь хугацаанд Бурханы авралыг хүртсэн хүмүүс байх болно. Бурханы авралын ажил явагдаж байх зуур аврагдаж чадах хүн нэг бүр боломжит дээд хэмжээгээр аврагдах бөгөөд нэг нь ч хаягдахгүй, учир нь Бурханы ажлын зорилго хүнийг аврахын төлөө байдаг. Бурхан хүнийг аврах хугацаанд зан чанартаа өөрчлөлт гаргаж чаддаггүй бүх хүн, түүнчлэн Бурханд бүрэн захирагдаж чаддаггүй бүх хүн шийтгэлийн бай болно. Ажлын энэ үе шат буюу үгийн ажил нь хүмүүст өөрсдийнх нь ойлгодоггүй бүх зам болон нууцыг тайлж өгнө, ингэснээр тэд Бурханы хүслийг болон хүнд тавих Бурханы шаардлагыг ойлгож, улмаар Бурханы үгийг хэрэгжүүлж, зан чанартаа өөрчлөлт гаргах урьдач нөхцөлтэй болж чадна. Бурхан Өөрийн ажлыг хийхдээ зөвхөн үг ашигладаг бөгөөд бага зэрэг тэрслүү байсных нь төлөө хүмүүсийг шийтгэдэггүй; учир нь одоо үе бол авралын ажлын цаг үе билээ. Хэрвээ тэрслүү авирладаг хэн боловч шийтгүүлдэг байсан бол хэн ч аврагдах боломжгүй байх байв; хүн бүр шийтгүүлж, Үхэгсдийн орон руу унах байлаа. Хүнийг шүүдэг үгийн зорилго нь өөрсдийгөө мэдэж, Бурханд захирагдах боломжийг хүнд олгохын төлөө байдаг; харин тэднийг ийм шүүлтээр шийтгэхийн төлөө байдаггүй. Үгийн ажлын хугацаанд олон хүн өөрсдийн тэрслүү байдал, эсэргүүцэл, түүнчлэн бие махбодтой болсон Бурханд хандах дуулгаваргүй байдлыг илчилнэ. Гэхдээ Тэр үүнээс болж энэ бүх хүнийг шийтгэхгүй, харин оронд нь, голдоо хүртэл завхарсан, аврагдах аргагүй хүмүүсийг л хаях болно. Тэр тэдний махан биеийг Сатанд өгч, цөөн хэдэн тохиолдолд махан биеийг нь дуусгавар болгоно. Үлдсэн хүмүүс үргэлжлүүлэн дагаж, харьцалт, засалт туулна. Хэрвээ энэ хүмүүс дагаж байх зуураа харьцалт, засалтыг хүлээн авч чадахгүй хэвээр байж, улам илүү доройтвол аврагдах боломжоо алдсан байх болно. Үгийн байлдан дагуулалтад захирагдсан хүн нэг бүр аврагдах асар их боломжтой байх болно; энэ хүмүүсийг нэг бүрчлэн

аврахдаа Бурхан дээд зэргийн өршөөл үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, тэдэнд дээд зэргийн хүлээцтэй байдал үзүүлнэ. Хүмүүс буруу замаас буцаж байгаа цагт, мөн гэмшиж байгаа цагт Бурхан тэдэнд Өөрийнх нь авралыг хүртэх боломж олгоно. Хүмүүс эхлээд Бурханы эсрэг тэрслэх үед тэднийг үхүүлэх хүсэл Бурханд байдаггүй; харин ч тэднийг аврахын тулд чадах бүхнээ хийдэг. Хэрвээ хүн үнэхээр аврагдах боломжгүй бол Бурхан тэднийг хаяна. Бурхан аврагдаж чадах хүн бүрийг аврахыг хүсдэг учраас тодорхой хүмүүсийг шийтгэхдээ алгуур байдаг. Тэр зөвхөн үгээр хүмүүсийг шүүж, гэгээрүүлж, залж чиглүүлдэг бөгөөд тэднийг үхүүлэхийн тулд саваа ашигладаггүй. Хүмүүст аврал авчрахын тулд үг ашиглах нь ажлын сүүлчийн үе шатны зорилго, ач холбогдол юм.

ӨӨРИЙН ҮЗЛЭЭР БУРХАНЫГ ХЯЗГААРЛАСАН ХҮН БУРХАНЫ ИЛЧЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ЯАХАН ЧАДАХ БИЛЭЭ?

Бурханы ажил үргэлж урагшилж байгаа бөгөөд Түүний ажлын зорилго өөрчлөгддөггүй хэдий ч ажилладаг арга барил нь ямагт өөрчлөгдөж, улмаар Бурханыг дагадаг хүмүүс ч бас байнга өөрчлөгдөж байдаг. Бурхан илүү их ажил хийх тусам Бурханы талаарх хүний мэдлэг төдий чинээ бүрэн гүйцэд болдог. Бурханы ажлын үр дүнд хүний зан чанарт ч бас зохих өөрчлөлт гардаг. Гэвч Бурханы ажил үргэлж өөрчлөгдөж байдаг учраас Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс болон үнэнийг мэддэггүй мулгуу хүмүүс Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болдог. Бурханы ажил хэзээ ч хүний үзэлтэй нийцдэггүй, учир нь Бурханы ажил үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд Тэр хуучин ажлыг хэзээ ч давтдаггүй, харин өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийдэг. Бурхан ажлаа давтдаггүй, харин хүн урьдын хийсэн ажилд нь үндэслэн Бурханы одоогийн ажлыг байнга шүүдэг болохоор шинэ эрин үеийн ажлын үе шат болгоныг хэрэгжүүлэхэд Бурханд маш хэцүү байдаг. Хүн хэтэрхий олон бэрхшээлтэй! Бодол санаа нь дэндүү хуучинсаг! Бурханы ажлыг хэн ч мэддэггүй мөртөө хүн бүр үүнийг хязгаарладаг. Бурханаас холдох үедээ хүн амь, үнэн болон Бурханы ерөөлийг алддаг атлаа амийг ч, үнэнийг ч хүлээн зөвшөөрдөггүй, хүн төрөлхтөнд Бурханы хайрладаг илүү агуу ерөөлийг бүр ч хүлээн зөвшөөрдөггүй. Бүх хүн Бурханыг олж авахыг хүсдэг хэр нь Бурханы ажлын ямар ч өөрчлөлтийг тэвчиж чаддаггүй. Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс Бурханы ажил бол хувиршгүй бөгөөд үүрд зогсонги байдалтай байдаг

хэмээн итгэдэг. Тэдний бодлоор бол Бурханаас мөнхийн аврал хүртэхийн тулд хуулийг л мөрдөх хэрэгтэй бөгөөд гэмшиж, нүглээ улайж л байвал Бурханы хүсэл үргэлж хангалуун байна. Бурхан бол хуулийн доорх Бурхан, хүний төлөө загалмайд цовдлогдсон Бурхан л байж чадна гэж тэд боддог; тэд бас Бурхан Библиэс хэтрэн гарах ёсгүй, гарч ч чадахгүй гэж боддог. Яг ийм санал бодол нь тэднийг хуучны хуулиудад бат дөнгөлж, үхмэл дүрэм журмуудад хүлсэн юм. Бурханы шинэ ажил ямар ч байлаа гэсэн, зөгнөлөөр баталгаажих ёстой, мөн ийм ажлын үе шат болгонд Түүнийг “чин” сэтгэлээсээ дагадаг бүх хүнд бас илчлэл үзэгдэх ёстой; эс бөгөөс тэр ажил Бурханых байж таарахгүй гэж бүр ч олон хүн боддог. Хүний хувьд Бурханыг мэдэж авах нь угаасаа хялбар ажил биш. Үүнээс гадна, хөгийн зүрх сэтгэл, өөрийгөө чухалчилдаг, ихэрхүү тэрслүү уг чанарыг нь харгалзан үзвэл Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьд бүр ч хэцүү билээ. Хүн Бурханы шинэ ажлыг анхааралтай шинжилдэггүй, төлөв даруухнаар хүлээн зөвшөөрдөг ч үгүй; харин ч Бурханы илчлэл болон удирдамжийг хүлээнгээ басамжилсан хандлага баримталж байдаг. Энэ нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцдэг хүмүүсийн зан авир биш гэж үү? Ийм хүмүүс яаж Бурханы сайшаалыг хүртэж чадах юм бэ?

Нигүүлслийн эрин үед Еховагийн ажил хоцрогдсон гэдгийг Есүс хэлж байсны адилаар өнөөдөр Би Есүсийн ажил ч бас хоцрогдсон гэж хэлдэг. Зөвхөн Хуулийн эрин үе гэж байгаад Нигүүлслийн эрин үе байгаагүй бол Есүс цовдлогдохгүй, бүх хүн төрөлхтнийг золин аварч чадахгүй байх байсан юм. Хэрвээ Хуулийн эрин үе л байсан бол хүн төрөлхтөн өнөөдрийг хүрч ер нь чадах байсан гэж үү? Түүх урагшилдаг, түүх бол Бурханы ажлын байгалийн хууль биш гэж үү? Энэ нь бүхий л орчлон ертөнц даяар хүнийг удирдах Түүний удирдлагын дүрслэл биш гэж үү? Түүх урагшилдаг бөгөөд Бурханы ажил ч мөн адил. Бурханы хүсэл тасралтгүй өөрчлөгдөж байдаг. Тэрээр зургаан мянган жилийн турш ажлын ганц үе шатанд үлдэж болохгүй, учир нь хүн бүрийн мэддэгчлэн Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд цовдлолтой адил ажлыг хийсээр байж, загалмайд нэг, хоёр, гурван удаа... цовдлогдож яавч чадахгүй. Ингэж бодох нь тэнэг хэрэг болно. Бурхан нэг ажлыг үргэлжлүүлэн хийдэггүй; Би та нарт өдөр бүр шинэ үг хэлж, шинэ ажил хийдгийн адилаар Түүний ажил ямагт өөрчлөгдөж, үргэлж шинэ байдаг. Энэ бол Миний хийдэг ажил бөгөөд гол түлхүүр нь “шинэ”, “гайхалтай” хэмээх үг юм. “Бурхан хувиршгүй, Бурхан үргэлж Бурхан байх болно” хэмээх үг яах аргагүй үнэн; Бурханы мөн чанар өөрчлөгддөггүй, Бурхан үргэлж Бурхан бөгөөд хэзээ ч Сатан болж чадахгүй

боловч Түүний ажил мөн чанартай нь адил тогтмол, хувиршгүй гэдгийг энэ нь нотолдоггүй. Бурхан хувиршгүй гэж ч тунхагладаг, тэгвэл Бурханы үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүйг ч илэрхийлж чадах юм бэ? Бурханы ажил тасралтгүй түгж, байнга өөрчлөгддөг ба Бурханы хүсэл тасралтгүй илэрхийлэгдэж, хүнд мэдэгдэж байдаг. Бурханы ажлыг туулахын хэрээр хүний зан чанар зогсолтгүй өөрчлөгддөг, мэдлэг нь ч мөн адил. Тэгвэл энэхүү өөрчлөлт хаанаас гардаг юм бэ? Бурханы үргэлж өөрчлөгддөг ажлаас үүддэг биш үү? Хүний зан чанар өөрчлөгдөж болдог юм бол Миний ажил, үг ч бас тасралтгүй өөрчлөгдөхийг хүн яагаад зөвшөөрч чаддаггүй юм бэ? Би хүний хязгаарлалтад захирагдах ёстой гэж үү? Чи хүчээр тулгасан маргаан, мушгин гуйвуулсан логик ашиглаж байгаа бус уу?

Дахин амилсныхаа дараа Есүс шавь нартаа харагдаж, “Та бүхэнд Эцэгийнхээ амлалтыг илгээж буйг болгоогтун. Та бүхэн дээрээс ирэх хүчийг хүлээн авах хүртэл Иерусалим хотод үлд” хэмээн хэлсэн. Эдгээр үгийг хэрхэн тайлбарлаж болохыг ч мэдэх үү? Чи одоо Түүний хүч чадлыг хүртсэн үү? “Хүч чадал” гэж юуг хэлдгийг ч ойлгож байна уу? Эцсийн өдрүүдэд үнэний Сүнсийг хүнд хайрлах болно гэж Есүс тунхагласан. Одоо үе бол эцсийн өдрүүд; үнэний Сүнс хэрхэн үг илэрхийлдгийг ч ойлгодог уу? Үнэний Сүнс хаана гарч ирж, ажилладаг вэ? Эш үзүүлэгч Исаиагийн зөгнөлийн номд Есүс нэртэй хүүхэд Шинэ Гэрээний эрин үед төрнө гэж ерөөсөө дурдаагүй; ердөө Иммануел нэртэй нярай хүү төрнө гэж л бичигдсэн. Яагаад “Есүс” гэдэг нэр дурдагдаагүй вэ? Хуучин Гэрээний хаана ч энэ нэр гардаггүй, тэгвэл чи яагаад Есүст итгэсээр байдаг юм бэ? Есүсийг хоёр нүдээрээ харсныхаа дараа л итгэж эхлээгүй чинь лавтай биз дээ? Эсвэл чи илчлэл хүлээн аваад итгэж эхэлсэн юм уу? Бурхан чамд үнэхээр ийм нигүүлсэл үзүүлнэ гэж үү? Тэгээд чамд ийм агуу ерөөл хайрлана гэж үү? Чи юунд үндэслэн Есүст итгэсэн бэ? Бурхан өнөөдөр махбод болсон гэдэгт яагаад итгэдэггүй юм бэ? Бурханаас чамд илчлэл ирээгүй гэдэг нь Бурхан бие махбодтой болоогүй гэдгийг нотолдог гэж чи яагаад хэлдэг юм бэ? Бурхан Өөрийн ажлыг эхлэхийн өмнө хүмүүст мэдэгдэх ёстой гэж үү? Эхлээд тэдний зөвшөөрлийг авах ёстой гэж үү? Исаиа тэжээлийн онгоцонд эрэгтэй хүүхэд төрнө гэдгийг л тунхагласан; харин Мариа Есүсийг төрүүлнэ гэж хэзээ ч зөгнөөгүй юм. Тэгвэл чи яг юунд үндэслээд Мариагийн төрүүлсэн Есүст итгэдэг юм бэ? Итгэл чинь будилж төөрөлдсөн биш л байлтай? Бурханы нэр өөрчлөгддөггүй гэж зарим нь хэлдэг. Тэгвэл Еховагийн нэр яагаад Есүс болсон юм бэ? Мессиа ирнэ гэж зөгнөсөн атал яагаад Есүс гэдэг нэртэй хүн ирсэн юм

бэ? Бурханы нэр яагаад өөрчлөгдсөн бэ? Ийм ажил аль эрт хийгдээгүй гэж үү? Бурхан өнөөдөр илүү шинэлэг ажил хийж болохгүй гэж үү? Өчигдрийн ажил ч өөрчлөгдөж болох бөгөөд Еховагийн ажлыг Есүсийн ажил үргэлжлүүлж болно. Тэгвэл Есүсийн ажлыг өөр нэг ажил залгамжилж болохгүй гэж үү? Хэрвээ Еховагийн нэр Есүс болж өөрчлөгдөж болдог юм бол Есүсийн нэр ч бас өөрчлөгдөж болохгүй гэж үү? Энэ нь хачин жигтэй зүйл биш; ердөө хүмүүс л дэндүү бодлогогүй. Бурхан үргэлж Бурхан байх болно. Түүний ажил болон Түүний нэр яаж ч өөрчлөгдсөн бай, зан чанар, мэргэн ухаан нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханыг зөвхөн Есүсийн нэрээр л нэрлэж болно гэж боддог бол мэдлэг чинь хэтэрхий хязгаарлагдмал юм байна. Есүс гэдэг нь үүрд Бурханы нэр байна, Бурхан үргэлж, үүрд Есүс гэх нэртэй байна, энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж чи баталж зүрхлэх үү? Есүсийн нэр Хуулийн эрин үеийг дуусгасан бөгөөд сүүлчийн эрин үеийг ч бас дуусгана гэж чи итгэлтэйгээр баталж зүрхлэх үү? Есүсийн нигүүлсэл эрин үеийг дуусгаж чадна гэж хэн хэлж чадах юм бэ? Чи эдгээр үнэнийг тодорхой ойлгодоггүй бол сайн мэдээг номлож чадахгүйгээр үл барам, өөрөө ч бат зогсож чадахгүй. Чи шашны тэр хүмүүсийн бүх бэрхшээлийг шийдвэрлэж, бүх төөрөгдлийг нь няцаах өдөр ирвэл ажлын энэ үе шатны талаар туйлын их итгэлтэй бөгөөд өчүүхэн ч эргэлзээ тээдэггүй гэдгийг чинь энэ нь нотолно. Хэрвээ чи төөрөгдлийг нь няцааж чадахгүй бол тэд чамайг зохиомлоор буруутгаж, гүжирдэнэ. Энэ нь гутамшигтай байх бус уу?

Иудейчүүд бүгд Хуучин Гэрээг уншсан бөгөөд эрэгтэй хүүхэд тэжээлийн онгоцонд төрнө гэх Исаиагийн зөгнөлийг мэддэг байсан. Тэгвэл энэ зөгнөлийг бүрэн мэддэг байсан мөртөө тэд яагаад Есүсийг мөн л хяхаж хавчсан юм бэ? Энэ нь тэдний тэрслүү уг чанар болон Ариун Сүнсний ажлыг мэддэггүйгээс нь болоогүй гэж үү? Тухайн үед фарисайчууд, зөгнөгдсөн эрэгтэй хүүхдийн талаар өөрсдийнх нь мэддэг зүйлээс Есүсийн ажил өөр байна гэж бодсон; харин бие махбодтой болсон Бурханы ажил Библийг нийцдэггүй учраас өнөөдрийн хүмүүс Бурханыг голдог. Бурханд хандах тэдний тэрслүү байдлын мөн чанар адилхан биш гэж үү? Чи Ариун Сүнсний бүх ажлыг эргэлзээгүй хүлээн зөвшөөрч чадах уу? Хэрвээ энэ нь Ариун Сүнсний ажил бол зөв урсгал мөн бөгөөд чи ямар ч болгоомжлолгүйгээр хүлээн зөвшөөрөх ёстой; чи юуг нь хүлээн зөвшөөрөхөө шилж сонгох ёсгүй. Хэрвээ чи Бурханыг илүү гүнзгий ойлгож, Түүнд илүү болгоомжтой ханддаг бол ингэх чинь шаардлагагүй бус уу? Чи Библиэс нэмэлт баталгаа хайх хэрэггүй; хэрвээ энэ нь Ариун Сүнсний ажил мөн бол хүлээн зөвшөөрөх ёстой, учир нь чи дагахын тулд Бурханд итгэдэг бөгөөд Түүнийг

судалж шинжлэх ёсгүй. Би бол чиний Бурхан мөн гэдгийг нотлох нэмэлт нотолгоог чи хайх ёсгүй, харин Би чамд ашиг тустай эсэхийг ялган таньж чаддаг байх учиртай—хамгийн чухал зүйл бол энэ юм. Чи Библийн дотроос маргашгүй нотолгоо ихийг оллоо ч гэсэн энэ нь чамайг Миний өмнө бүрэн дүүрэн авчирч чадахгүй. Чи Миний өмнө биш, ердөө Библийн хязгаарлалт дотор л амьдардаг; Библи Намайг мэдэхэд чинь тусалж чадахгүй, Намайг гэх хайрыг чинь ч гүнзгийрүүлж чадахгүй. Эрэгтэй хүүхэд төрнө гэж Библид зөгнөсөн ч Бурханы ажлыг хүн мэддэггүй тул уг зөгнөл хэн дээр биелэхийг хэн ч ухан ойлгож чадаагүй, үүнээс үүдэн фарисайчууд Есүсийн эсрэг зогссон юм. Миний ажил хүний ашиг сонирхлын төлөө байдаг гэдгийг зарим нь мэддэг атлаа Есүс бид хоёрыг харилцан үл нийцэх, бүрмөсөн салангид хоёр оршихуй гэж бодсоор байдаг. Тухайн үед Есүс хэрхэн хэрэгжүүлэх, хэрхэн цугларах, залбирлаараа хэрхэн гуйх, бусдад хэрхэн хандах гэх мэт сэдэвтэй хэдэн цуврал сургаалыг л Нигүүлслийн эрин үед шавь нартаа айлдсан. Түүний гүйцэтгэсэн ажил нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан бөгөөд шавь нар нь болон Өөрийг нь дагадаг хүмүүс хэрхэн хэрэгжүүлэх учиртай талаар л Тэр нарийвчлан тайлбарласан. Тэрээр Нигүүлслийн эрин үеийн ажлыг л хийсэн ба эцсийн өдрүүдийн нэг ч ажлыг хийгээгүй юм. Ехова Хуулийн эрин үед Хуучин Гэрээний хуулийг тогтоох үедээ яагаад Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийгээгүй юм бэ? Яагаад Тэр Нигүүлслийн эрин үеийн ажлыг урьдчилан тодорхой болгоогүй юм бэ? Хүн хүлээн зөвшөөрөхөд энэ нь тус болох байсан биш үү? Тэрээр эрэгтэй хүүхэд төрж, эрх мэдэлд хүрнэ гэдгийг л зөгнөсөн болохоос Нигүүлслийн эрин үеийн ажлыг урьдчилан гүйцэтгээгүй юм. Эрин үе бүр дэх Бурханы ажил тодорхой хил хязгаартай байдаг; Тэр тухайн эрин үеийнхээ ажлыг л хийдэг бөгөөд ажлын дараагийн үе шатыг хэзээ ч урьдчилан гүйцэтгэдэггүй. Энэ маягаар л эрин үе болгон дахь Түүний бэлгэдлийн ажил илүү товойн гарч чаддаг. Есүс зөвхөн эцсийн өдрүүдийн тэмдгүүдийн талаар, хэрхэн тэвчээртэй байж, хэрхэн аврагдах тухай, хэрхэн гэмшиж, нүглээ улайх, мөн хэрхэн загалмай үүрч, зовлонг тэвчих талаар л ярьсан; Тэрээр, эцсийн өдрүүдийн хүн хэрхэн орох ёстой, Бурханы хүслийг хангахын тулд хэрхэн эрж хайх ёстой талаар хэзээ ч яриагүй. Ийм байхад Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг Библиэс хайх нь утгагүй биш үү? Зүгээр л Библи тэй зууралдсанаар чи юу харж чадах юм бэ? Библи тайлбарлагч ч бай, номлогч ч бай, өнөөдрийн ажлыг хэн урьдчилан харж чадах юм бэ?

“Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун.” Та нар одоо

Ариун Сүнсний үгийг сонсов уу? Бурханы үг та нар дээр ирсэн. Та нар сонсож байна уу? Бурхан эцсийн өдрүүдэд үгийн ажил хийдэг бөгөөд ийм үг нь Ариун Сүнсний үг юм, учир нь Бурхан бол Ариун Сүнс бөгөөд бас махбод ч болж чадна; тиймээс урьд нь ярьж байсан Ариун Сүнсний үг бол өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы үг юм. Ариун Сүнс ярьж байгаа тул Түүний дуу хоолой тэнгэрээс дуугарч, хүнд сонсогдох ёстой гэж боддог мулгуу хүн олон бий. Ингэж боддог хэн боловч Бурханы ажлыг мэддэггүй. Үнэн хэрэгтээ, Ариун Сүнсний айлдсан айлдварууд нь махбод болсон Бурханы хэлсэн зүйл юм. Ариун Сүнс хүнтэй шууд ярьж чадахгүй; Хуулийн эрин үед ч гэсэн Ехова хүмүүстэй шууд яриагүй. Өнөөдрийн энэ эрин үед Түүний тэгж ярих магадлал бүр ч бага биш үү? Бурхан ажлаа гүйцэтгэхийн тулд айлдвар айлддаг учраас махбод болох ёстой, эс бөгөөс Түүний ажил зорилгоо биелүүлж чадахгүй. Бие махбодтой болсон Бурханыг үгүйсгэдэг хүмүүс бол Сүнснийг юм уу Бурханы ажилладаг зарчмыг мэддэггүй хүмүүс юм. Одоо үе бол Ариун Сүнсний эрин үе гэж боддог атлаа Түүний шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс бол тодорхойгүй, хийсвэр итгэл дунд амьдардаг хүмүүс юм. Ийм хүмүүс Ариун Сүнсний ажлыг хэзээ ч хүлээн авахгүй. Шууд ярьж, ажлаа гүйцэтгэхийг л Ариун Сүнснээс хүсдэг бөгөөд бие махбодтой болсон Бурханы үг болон ажлыг хүлээн авдаггүй хүмүүс шинэ эрин үед хөл тавьж, Бурханы бүрэн авралыг хүртэж хэзээ ч чадахгүй!

БУРХАНЫГ БОЛОН БУРХАНЫ АЖЛЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л ТҮҮНИЙГ СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙЛГАЖ ЧАДНА

Бие махбодтой болсон Бурханы ажил хоёр хэсгээс бүрддэг. Эхний удаа бие махбодтой болоход нь хүмүүс Түүнд итгээгүй, Түүнийг мэдээгүй ба Есүсийг загалмайд цовдолсон. Хоёр дахь удаад ч гэсэн хүмүүс Түүнийг мэдэх нь байтугай, Түүнд итгээ ч үгүй ба Христийг дахин нэг удаа загалмайд цовдолсон. Хүн Бурханы дайсан биш гэж үү? Бурханыг мэддэггүй бол хүн яаж Түүний дотнын нэгэн байж чадах юм бэ? Бурханд гэрчлэл хийх шаардлагыг яаж хангах юм бэ? Хүн Бурханыг хайрлаж, Бурханд үйлчилж, Бурханыг алдаршуулж байна гэж хэлдэг нь бүгд зальжин худал үг биш гэж үү? Хэрэв чи амьдралаа эдгээр бодит бус, практик бус зүйлсэд зориулах юм бол чиний хөдөлмөр талаар өнгөрөх бус уу? Бурхан хэн бэ гэдгийг ч мэдэхгүй байж чи яаж Бурханы дотнын нэгэн байж чадах юм бэ? Иймэрхүү эрэл хайгуул чинь тодорхойгүй, хийсвэр биш

гэж үү? Ов мэхтэй хэрэг бус уу? Хүн хэрхэн Бурханы дотнын нэгэн болох вэ? Бурханы дотнын нэгэн байхын бодит ач холбогдол юу вэ? Чи Бурханы Сүнсний дотнын нэгэн байж чадах уу? Сүнс хэчнээн агуу, өргөмжит болохыг чи харж чадах уу? Үл үзэгдэх, биет бус Бурханы дотнын нэгэн байна гэдэг тодорхойгүй, хийсвэр зүйл биш үү? Ийм эрэл хайгуулд ямар бодит ач холбогдол байна вэ? Энэ нь бүгд худал, хуурмаг биш гэж үү? Чи Бурханыг мэддэггүй бөгөөд нүдэнд үзэгдэж, гарт баригддаггүй, өөрийнхөө үзлээр бий болгосон, оршин байдаггүй “бүх зүйлийн Бурханыг” эрэлхийлдэг учраас чиний эрж хайдаг зүйл Бурханы дотнын хүн болох явдал боловч яг үнэндээ чи Сатаны бууны нохой юм. Тойруулж хэлбэл, тийм “Бурхан” бол Сатан юм, харин шулуухан хэлбэл энэ нь чи өөрөө юм. Чи өөрийнхөө л дотнын нэгэн байхыг эрэлхийлдэг хэр нь Бурханы дотнын хүн байхаар эрэлхийлж байна гэж хэлдэг—энэ чинь доромжлол биш үү? Ийм эрэл хайгуул ямар үнэ цэнтэй юм бэ? Хэрвээ Бурханы Сүнс махбод болохгүй бол Бурханы мөн чанар нь хүний хувьд хэлбэргүй агаад дүрсгүй, материаллаг бус төрлийн, ойртохын аргагүй хийгээд ойлгогдошгүй, үл үзэгдэх, үл мэдрэгдэх нэгэн амийн Сүнс төдий юм. Хүн ийм материаллаг бус, гайхмаар, ойлгошгүй Сүнсний ойр дотно нэгэн байж яаж чадах юм бэ? Энэ чинь инээдтэй хэрэг биш үү? Тийм утгагүй бодол нь бодит бус, үндэслэлгүй юм. Бүтээгдсэн хүн угаасаа Бурханы Сүнснээс өөр төрлийнх байхад энэ хоёр яаж бие биетэйгээ ойр дотно байж чадах юм бэ? Хэрвээ Бурханы Сүнс махбодод биеллээ олоогүй бол, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болоогүй, бүтээл болж, Өөрийгөө даруу болгоогүй бол бүтээгдсэн хүн Түүний дотнын нэгэн байх эрхгүй, бас байж чадах ч үгүй байсан бөгөөд сүнс нь тэнгэрт орсны дараа Бурханы дотнын нэгэн болох боломжтой үнэн сүсэгт итгэгчдээс бусад ихэнх хүн Бурханы Сүнсний дотнын нэгэн болж чадахгүй байх байв. Хэрвээ хүн бие махбодтой болсон Бурханы удирдамж дор тэнгэр дэх Бурханы дотнын нэгэн болохыг хүсдэг бол тэд гайхмаар тэнэг, хүн-бус биш гэж үү? Хүмүүс ердөө л үл үзэгдэх Бурханд “үнэнч байхыг” зорьдог ба харж болох Бурханд өчүүхэн ч анхаарал хандуулдаггүй, учир нь үл үзэгдэх Бурханыг эрэлхийлэх маш амархан. Хүн үүнийг хүссэнээрээ хийж болно. Харин үзэгдэх Бурханыг эрж хайх нь тийм ч амаргүй. Тодорхойгүй Бурханыг эрж хайдаг хүн Бурханыг олж авч огт чадахгүй, учир нь тодорхойгүй, хийсвэр зүйлс нь бүгд хүний төсөөлөл бөгөөд хүний олж авах боломжтой зүйл биш юм. Хэрвээ та нарын дунд ирсэн Бурхан өндөр дээд, өргөмжит агаад чиний ойртохын аргагүй нэгэн байсан бол Түүний хүслийг та нар хэрхэн ойлгож ухаарч чадах юм бэ? Түүнийг яаж мэдэж, ойлгож чадах юм бэ? Хэрвээ Тэр ажлаа л

хийгээд, хүнтэй ямар ч хэвийн харилцаа үүсгэдэггүй байсан бол, эсвэл ямар ч хэвийн хүн чанаргүй, жирийн хүмүүс ойртох аргагүй нэгэн байсан бол, тэгээд хэдийгээр Тэр та нарын төлөө их ажил хийсэн ч, та нар Түүнтэй огт харилцдаггүй, Түүнийг харж чаддаггүй байсан бол та нар яаж Түүнийг мэдэж чадах билээ? Хэвийн хүн чанарыг эзэмшсэн энэ махбод байгаагүй сэн бол хүн Бурханыг мэдэх ямар ч аргагүй байх байлаа; Бурхан бие махбодтой болсны хүчинд л хүн махбод дахь Бурханы дотнын нэгэн байх эрхтэй болдог. Хүмүүс Бурхантай харилцдаг болж, Түүнтэй хамт амьдарч, цагийг хамт өнгөрөөснөөр аажмаар Түүнийг мэдэж эхэлдэг учраас Бурханы дотнын хүн болдог. Ингээгүй бол хүний эрэл хайгуул талаар өнгөрөх байсан бус уу? Өөрөөр хэлбэл, дан ганц Бурханы ажлын хүчинд биш, харин бие махбодтой болсон Бурханы бодитой, хэвийн байдлын хүчинд хүн Бурханы дотнын хүн болж чаддаг. Бурхан бие махбодтой болсон учраас л хүн үүргээ биелүүлэх, мөн жинхэнэ Бурханыг шүтэн мөргөх боломжтой болсон билээ. Энэ нь хамгийн бодит, жинхэнэ үнэн биш гэж үү? Чи одоо ч гэсэн тэнгэр дэх Бурханы дотнын нэгэн баймаар байна уу? Бурхан Өөрийгөө тодорхой түвшинд хүртэл даруу болгосноор буюу махбод болсноор л хүн Түүний дотнын, итгэлт нэгэн болж чадна. Бурхан бол Сүнс: Туйлын өргөмжит, ойлгохын аргагүй энэхүү Сүнсний дотнын хүн байхад хүн яаж тэнцэх юм бэ? Бурханы Сүнс махбодод буун ирж, хүнтэй адил гадаад төрхтэй бүтээл болсноор л хүн Түүний хүслийг ойлгож, Түүгээр үнэхээр авхуулж чадна. Тэр махбодоор үг хэлж, ажиллаж, хүний баяр баясгалан, уйтгар гуниг, гай зовлонг хуваалцаж, хүнтэй нэг дэлхийд амьдарч, хүнийг хамгаалж, залж чиглүүлдэг ба үүгээрээ дамжуулан хүнийг цэвэрлэж, Түүний аврал болон ерөөлийг олж авах боломжийг хүнд олгодог. Хүн эдгээр зүйлийг олж авч, Бурханы хүслийг үнэхээр ойлгосноор л Бурханы дотнын нэгэн байж чаддаг, энэ л бодитой. Хэрвээ Бурхан хүнд үзэгддэггүй, баригддаггүй байсан бол хүн яаж Түүний дотнын нэгэн байж чадах юм бэ? Энэ чинь хоосон сургаал бус уу?

Өнөөдрийг хүртэл Бурханд итгэгчхээд олон хүн тодорхойгүй, хийсвэр зүйлийг эрж хайсаар л байна. Тэд Бурханы өнөөгийн ажлын бодит байдлыг огт ухааралгүйгээр одоо ч бичиг үсэг, хоосон сургаал дунд амьдарсаар байдаг. Түүнчлэн ихэнх нь “Бурханыг хайрладаг шинэ үеийнхэн”, “Бурханы дотнын хүн”, “Бурханыг хайрлах үлгэр жишээ, үлгэр дуурайл”, “Петрийн хэв маяг” гэх мэт шинэ хэллэгүүдийн бодит байдал руу хараахан ороогүй байгаа; харин эрэл хайгуул нь тодорхойгүй, хийсвэр хэвээр, хоосон сургаал дунд тэмтэцсээр байгаа бөгөөд тэд эдгээр үгийн бодит байдлын тухай ямар ч ойлголтгүй байдаг

юм. Бурханы Сүнс махбод болох үед чи Түүний махбод дахь ажлыг харж, хүрч болно. Гэсэн ч чи Түүний дотнын нэгэн болох чадваргүй хэвээр, Түүний итгэлт анд болж чадахгүй хэвээр байвал хэрхэн Бурханы Сүнсний итгэлт нэгэн болж чадах юм бэ? Хэрвээ чи өнөөдрийн Бурханыг мэдэхгүй бол Бурханыг хайрладаг шинэ үеийнхний нэг болж яаж чадах юм бэ? Эдгээр хэллэг нь зүгээр л хоосон бичиг үсэг, сургаал бус уу? Чи Сүнсийг харж, Түүний хүслийг ухаарч чаддаг уу? Эдгээр хэллэг нь хоосон үг бус уу? Чи зүгээр л эдгээр хэллэг, нэр томъёог ярилаа гээд хангалтгүй, бас чи зөвхөн шийдэмгий байдлаар Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй. Эдгээр үгийг ярих төдийд л сэтгэл чинь ханадаг бөгөөд энэ нь өөрийн чинь хүсэл, бодит бус уран сэтгэмж, үзэл, бодлыг хангахын төлөө л байдаг. Хэрвээ чи өнөөдрийн Бурханыг мэдэхгүй бол юу ч хийлээ гэсэн, Бурханы чин зүрхний хүслийг хангаж чадахгүй. Бурханы итгэлт анд байна гэдэг юу гэсэн үг вэ? Чи үүнийг ойлгохгүй л байна уу? Бурханы дотнын нэгэн бол хүн учраас Бурхан ч гэсэн хүн, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болж, хүн болсон. Ижил төрлийн хүмүүс л бие биеэ итгэлт анд гэж дуудаж чадна, тэр үед л тэднийг ойр дотно хүмүүст тооцож болно. Хэрвээ Бурхан Сүнс байсан бол бүтээгдсэн хүн яаж Түүний дотнын нэгэн болж чадах юм бэ?

Бурханд итгэх итгэл, үнэний эрэл хайгуул, тэр ч байтугай биеэ авч яваа байдал чинь бүгд бодит байдалд үндэслэх ёстой: Хийдэг бүхэн чинь бодит байх ёстой, чи хий хоосон, уран зөгнөлт зүйлийг эрэлхийлэх ёсгүй. Ингэж авирлах нь ямар ч үнэ цэнгүй, цаашлаад тийм амьдралд утга учир гэж үгүй. Эрэл хайгуул болон амьдрал чинь худал хуурмаг, ов мэхнээс цаашгүй зүйлсийн дунд өнгөрч, чи үнэ цэнтэй, ач холбогдолтой зүйлсийг эрж хайдаггүй учраас чиний олж авдаг цорын ганц зүйл бол үнэнтэй хамаагүй утгагүй бодол, хоосон сургаал л байдаг. Тиймэрхүү зүйлс нь чиний оршин тогтнолын үнэ цэн, утга учиртай ямар ч холбоогүй бөгөөд чамайг зөвхөн хоосон газар л аваачиж чадна. Ингэснээр чиний бүхий л амьдрал ямар ч үнэ цэн, утга учиргүй байх болно—хэрвээ чи утга учиртай амьдралыг эрж хайхгүй юм бол зуун жил амьдарлаа ч гэсэн бүгд хий дэмий байх болно. Үүнийг яаж хүний амьдрал гэж хэлж болох юм бэ? Энэ чинь үнэндээ амьтны амьдрал биш үү? Үүний адилаар, хэрвээ та нар Бурханд итгэх замыг дагах гэж хичээдэг боловч харж болох Бурханыг эрж хайх ямар ч оролдлого хийлгүй, оронд нь үл үзэгдэх, биет бус Бурханыг шүтэн мөргөдөг бол иймэрхүү эрэл хайгуул нь бүр ч дэмий биш гэж үү? Эцэстээ чиний эрэл хайгуул нуранги овоо л болох болно. Иймэрхүү эрэл хайгуул чамд ямар ашигтай юм бэ? Хүний хамгийн том бэрхшээл бол өөрийн харж, хүрч чадахгүй, туйлын нууцлаг,

гайхалтай зүйлс болон хүмүүсийн төсөөлшгүй, жирийн хүмүүсийн хүрч чадахааргүй зүйлсийг л хайрладаг явдал юм. Эдгээр зүйл хэдий чинээ бодит бус байна, хүн төдий чинээ дүгнэж шинжлэн, бүр бусад бүх зүйлийг умартан эдгээрийг эрж хайж, олж авахаар оролддог. Тэдгээр нь хэдий чинээ бодит бус байна, хүн төдий чинээ нарийвчлан судалж, шинжилдэг төдийгүй тэдгээрийн талаар нарийн нягт бодож сэтгэдэг. Эсрэгээр, хэдий чинээ бодит зүйл байна, хүн төдий чинээ үл тоодог; тэдгээрийг харахдаа хамраа сөхөж, тэр ч байтугай үл тоомсорлодог. Өнөөдөр Миний хийж буй бодит ажилд ханддаг та нарын хандлага яг энэ биш үү? Иймэрхүү зүйлс хэдий чинээ бодитой байна, та нар төдий чинээ сэжиглэдэг. Тэдгээрийг судалж шинжлэх цаг огт гаргалгүй, зүгээр л үл тоодог; эдгээр бодитой, шалгуур султай шаардлагыг та нар басдаг ба тэр ч байтугай хамгийн бодит энэ Бурханы талаар ч гэсэн тоо томшгүй их үзэл өвөрлөдөг бөгөөд зүгээр л Түүний бодит байдал, энгийн байдлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдаг. Тэгвэл та нар тодорхойгүй итгэлийг л баримталдаггүй гэж үү? Та нар өнгөрсөн үеийн тодорхойгүй Бурханд тууштай итгээд өнөөгийн бодит Бурханыг сонирхдоггүй. Өчигдрийн Бурхан, өнөөдрийн Бурхан нь хоёр өөр эрин үеийнх болохоор ингэдэг бус уу? Бас өчигдрийн Бурхан нь тэнгэр дэх агуу сүрлэг Бурхан, харин өнөөдрийн Бурхан нь газар дээрх өчүүхэн хүн болохоор ингэдэггүй гэж үү? Түүнчлэн, хүний шүтэн мөргөдөг Бурхан нь түүний үзлээс бий болсон нэгэн, харин өнөөдрийн Бурхан нь газар дээр бий болсон бодит махбод гэдгээс болдоггүй гэж үү? Эцсийн эцэст, өнөөдрийн Бурхан хэтэрхий бодитой учраас хүн Түүнийг эрэлхийлдэггүй бус уу? Учир нь өнөөдрийн Бурханы хүнээс яг тэдний хийх хамгийн дургүй, ичгэвтэр санагддаг зүйлийг нь хүсдэг юм. Энэ нь хүнийг зовоож байгаа хэрэг биш үү? Энэ нь хүний шарх сорвийг ил гаргахгүй гэж үү? Ингэснээр, бодит байдлыг эрж хайдаггүй олон хүн бие махбодтой болсон Бурханы дайсан буюу антихрист болсон. Энэ нь илэрхий баримт биш гэж үү? Өнгөрсөн үед, Бурхан хараахан махбод болоогүй байхад чи шашны зүтгэлтэн, эсвэл үнэн сүсэгт итгэгч байсан байж болно. Харин Бурхан махбод болсны дараа үнэн сүсэгтэй тэр олон итгэгч өөрсдийн мэдэлгүй антихрист болсон юм. Энд юу болоод байгааг чи мэдэж байна уу? Чи Бурханд итгэхдээ бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэн үнэнийг эрж хайхын оронд худал хуурмагт эзэмдүүлдэг. Энэ нь бие махбодтой болсон Бурханы эсрэг дайсагналын чинь хамгийн тодорхой эх үүсвэр бус уу? Бие махбодтой болсон Бурханыг Христ гэж нэрлэдэг, иймээс бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй бүх хүн антихрист бус уу? Тэгэхээр чиний итгэж, хайрладаг нэгэн үнэхээр махбод дахь энэ Бурхан

мөн үү? Үнэхээр энэхүү амьдарч, амьсгалж байгаа хамгийн бодит бөгөөд ер бусын энгийн Бурхан мөн үү? Чиний эрэл хайгуулын зорилго яг юу юм бэ? Энэ нь тэнгэрт байгаа юу, газарт байгаа юу? Энэ нь үзэл үү, үнэн үү? Энэ нь Бурхан уу, эсвэл сахиулсан уу? Үнэндээ, үнэн бол амьдралын онч мэргэн үгсээс хамгийн бодитой нь бөгөөд бүх хүн төрөлхтний дундах онч мэргэн үгсээс хамгийн дээд нь билээ. Учир нь энэ бол Бурханы хүнд тавьдаг шаардлага бөгөөд Бурханы биечлэн хийдэг ажил учраас үүнийг амьдралын онч мэргэн үгс гэж нэрлэдэг. Энэ онч мэргэн үг нь ямар нэг зүйлээс дүгнэж гаргасан зүйл биш, мөн агуу хүмүүсийн хэлсэн алдартай эшлэл ч биш; Харин тэнгэр газар, бүх зүйлийн Захирагчаас хүн төрөлхтөнд хэлсэн айлдвар бөгөөд энэ бол хүний нэгтгэн дүгнэсэн хэдэн үг биш, харин Бурханы төрөлх амь билээ. Иймээс үүнийг амьдралын бүх онч мэргэн үгийн хамгийн дээд нь гэж нэрлэдэг. Хүн үнэнийг хэрэгжүүлэхээр эрэлхийлэх нь үүргээ биелүүлж байгаа хэрэг юм, өөрөөр хэлбэл, энэ нь Бурханы шаардлагыг хангах гэсэн эрэл хайгуул юм. Энэхүү шаардлагын мөн чанар нь хэний ч хүрч чадахааргүй хоосон сургаал биш, харин бүх үнэнээс хамгийн бодитой нь юм. Эрэл хайгуул чинь ямар ч бодит байдлыг агуулаагүй хоосон сургаалаас цаашгүй бол чи үнэний эсрэг тэрсэлдэг хүн биш үү? Чи үнэн рүү дайрч довтолдог хүн биш үү? Тийм хүн яаж Бурханыг хайрлахаар эрж хайх юм бэ? Бодит байдалгүй хүмүүс бол бүгд үнэнээс урвадаг хүмүүс бөгөөд угаасаа тэрслүү юм!

Чи яаж ч эрэлхийллээ гэсэн хамаагүй, юун түрүүнд Бурханы өнөөдөр хийж байгаа ажлыг ойлгож, энэхүү ажлын утга учрыг мэдэх ёстой. Бурхан эцсийн өдрүүдэд ирэхдээ ямар ажил, ямар зан чанарыг авчирдаг, мөн хүний юуг бүрэн төгс болгох вэ гэдгийг чи ойлгож, мэдэх ёстой. Махбодод ирээд Түүний хийсэн ажлыг чи мэдэхгүй, ойлгохгүй бол яаж Түүний хүслийг ойлгон ухаарч, Түүний дотнын хүн болж чадах юм бэ? Үнэндээ, Бурханы дотнын нэгэн байна гэдэг нь төвөгтэй зүйл биш боловч амархан хэрэг ч бас биш юм. Хэрвээ хүмүүс нэгд нэггүй ойлгож, хэрэгжүүлж чадвал энэ нь төвөгтэй бус болдог; хэрвээ нэгд нэггүй ойлгож чадахгүй бол энэ нь нэлээд хэцүү болдог төдийгүй эрэл хайгуул нь тэднийг тодорхойгүй байдал руу амархан хөтөлдөг. Хэрвээ хүн Бурханыг эрэлхийлэхдээ өөрийн гэсэн тулгуур байр суурьгүй, ямар үнэнийг баримтлах ёстойгоо мэдэхгүй бол ямар ч үндэс суурьгүй байна гэсэн үг учраас бат зогсоход тэдэнд амаргүй болдог. Өнөөдөр, үнэнийг ойлгодоггүй, сайн мууг ялгадаггүй, хайрлах, үзэн ядахыг хэлж мэддэггүй маш олон хүн байна. Тийм хүмүүс бат зогсож бараг чадахгүй. Бурханд итгэхийн гол түлхүүр нь үнэнийг хэрэгжүүлж,

Бурханы хүслийг анхаарч, Бурхан махбодод ирэх үедээ хүн дээр хийдэг ажил, Түүний үг хэлдэг зарчмыг мэдэж чаддаг байх явдал юм. Олныг бүү дага. Чи орох ёстой зүйлдээ зарчимтай байж, тэдгээрийг баримтлах ёстой. Дотор чинь байгаа Бурханы гэгээрүүлсэн тэдгээр зүйлийг чанд мөрдөх нь чамд тустай. Тэгэхгүй бол чи өнөөдөр нэг чиглэлд, маргааш нөгөө чиглэлд эргэлдэн, бодитой ямар нэг зүйлийг хэзээ ч олж авахгүй. Ийм байх нь чиний аминд ямар ч ашиггүй. Үнэнийг ойлгодоггүй хүмүүс үргэлж бусдыг дагадаг: Хүмүүс үүнийг Ариун Сүнсний ажил гэж хэлэх юм бол чи ч гэсэн Ариун Сүнсний ажил мөн байна гэж хэлнэ; хэрвээ хүмүүс үүнийг муу ёрын сүнсний ажил гэж хэлбэл чи ч гэсэн эргэлзэж эхлэн, эсвэл бас үүнийг муу ёрын сүнсний ажил байна гэж хэлнэ. Чи бусдын үгийг үргэлж тоть шиг давтдаг бөгөөд өөрөө юуг ч ялган салгах чадваргүй, бас өөрийнхөөрөө бодож сэтгэж чаддаггүй. Энэ бол баримтлах байр суурьгүй, ялган салгах чадваргүй хүн бөгөөд ийм хүн бол хэнд ч хэрэггүй хүн юм! Чи дандаа бусдын үгийг давтдаг: Өнөөдөр үүнийг Ариун Сүнсний ажил гэж хэлж байгаа ч нэг өдөр үүнийг Ариун Сүнсний ажил биш, харин хүний үйл хэргээс цаашгүй гэж хэн нэгэн хүн хэлж магадгүй—гэсэн ч чи үүнийг ялган салгаж чадахгүй бөгөөд бусад хүний хэлэхийг сонсоод чи ч бас тэгж хэлнэ. Энэ нь үнэндээ Ариун Сүнсний ажил, гэвч чи үүнийг хүний ажил гэж хэлдэг; чи Ариун Сүнсний ажлыг гутаадаг хүмүүсийн нэг болсон бус уу? Чи ийнхүү ялган салгаж чадахгүй байгаа учраас Бурханыг эсэргүүцсэн бус уу? Хэн мэдэх вэ, магадгүй нэг өдөр “энэ бол муу ёрын сүнсний ажил” гэж хэлэх эргүү амьтан гарч ирж болох юм, тэгвэл чи энэ үгийг сонсонгуутаа яахаа мэдэхээ больж, дахиад л бусдын үгэнд автах болно. Хэн нэгэн чамайг үймүүлэх болгонд чи баримтлах байр сууриндаа бат зогсож чаддаггүй бөгөөд энэ бүхэн үнэнийг эзэмшээгүйгээс чинь л болж байгаа юм. Бурханд итгэж, Бурханы тухай мэдлэгийг эрж хайна гэдэг энгийн зүйл биш. Зүгээр л хамтдаа цугларч, номлол сонссоноор тэдгээрийг олж авч чадахгүй, ганцхан урам зоригоороо чи төгс болгуулж чадахгүй. Чи туулж, мэдэж, үйлдэлдээ зарчимтай байж, Ариун Сүнсний ажлыг олж авах ёстой. Чи туршлагыг туулснаар олон зүйлийг ялган салгаж чадна—сайныг муугаас, зөв шударга байдлыг хорон муу явдлаас ялган салгаж, мөн аль нь мах цусных, аль нь үнэнийх вэ гэдгийг ялгаж чадна. Чи энэ бүх зүйлийг ялган салгаж чаддаг байх ёстой, ингэснээр ямар ч нөхцөлд чи хэзээ ч төөрөхгүй. Энэ л чиний биеийн жинхэнэ хэмжээ юм.

Бурханы ажлыг мэднэ гэдэг энгийн хэрэг биш. Чи эрэл хайгуулдаа стандарт, зорилготой байх ёстой бөгөөд үнэн замыг хэрхэн эрж хайхаа мэддэг, энэ нь үнэн

зам мөн эсэх, Бурханы ажил мөн эсэхийг хэрхэн хэмжихээ мэддэг байх ёстой. Үнэн замыг эрж хайх хамгийн үндсэн зарчим юу вэ? Энэ замд Ариун Сүнсний ажил бий эсэх, эдгээр үг нь үнэний илэрхийлэл мөн эсэх, хэнийг гэрчилдэг болох, мөн энэ нь чамд юу авчирч чадах вэ гэдгийг чи харах учиртай. Үнэн зам, хуурамч зам хоёрыг ялгаж салгахад үндсэн мэдлэгийн хэд хэдэн тал шаардлагатай ба үүнээс хамгийн гол нь Ариун Сүнсний ажил бий эсэхийг харах явдал юм. Учир нь, Бурханд итгэх хүний итгэлийн мөн чанар нь Бурханы Сүнсэнд итгэх итгэл бөгөөд бие махбодтой болсон Бурханд итгэх хүний итгэл ч гэсэн энэхүү махбод нь Бурханы Сүнсний биелэл гэдгээс үүдэлтэй, өөрөөр хэлбэл, тийм итгэл бол мөн л Сүнсэнд итгэх итгэл билээ. Сүнс, махбод хоёр хоорондоо ялгаатай боловч энэхүү махбод нь Сүнснээс ирдэг агаад махбод болсон Үг учраас хүний итгэж байгаа зүйл бас л Бурханы төрөлх мөн чанар юм. Тэгэхээр, үнэн зам мөн эсэхийг ялгахдаа чи юун түрүүнд Ариун Сүнсний ажил байгаа эсэхийг харж, дараа нь энэ замд үнэн байгаа эсэхийг харах ёстой. Үнэн бол хэвийн хүн чанарын амь зан чанар, өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг анх бүтээх үедээ хүнд тавьсан шаардлага буюу бүх хэвийн хүн чанар юм (үүнд хүний эрүүл ухаан, мэдлэг, мэргэн ухаан, хүн байхын үндсэн мэдлэг багтана). Өөрөөр хэлбэл, энэ зам хүнийг хэвийн хүн чанарын амьдрал руу хөтөлж чадах эсэх, ярьсан үнэн нь хэвийн хүн чанарын бодит байдлын дагуу шаардлагатай эсэх, энэ үнэн нь бодитой, жинхэнэ эсэх, цагаа олсон эсэхийг харах хэрэгтэй. Хэрвээ үнэн байгаа бол энэ нь хүнийг хэвийн, бодит туршлага руу аваачиж чадна; түүнчлэн хүн улам хэвийн болж, хүний эрүүл ухаан улам бүрэн төгс болж, хүний махан бие дэх амьдрал болон сүнслэг амьдрал улам эмх цэгцтэй болж, хүний мэдрэмж улам хэвийн болдог. Энэ нь хоёр дахь зарчим юм. Бас нэгэн өөр зарчим байдаг нь, хүний Бурханы талаарх мэдлэг нь өсөн нэмэгддэг эсэх, тийм ажил болон үнэнийг туулах нь хүний дотор Бурханыг хайрлах хайрыг бадрааж, Бурхантай улам ойртуулж чаддаг эсэх юм. Үүнээс энэхүү зам нь үнэн зам мөн эсэхийг хэмжиж болно. Хамгийн гол нь, энэ зам ер бусын биш, бодит эсэх, мөн энэ нь хүний амийг хангаж чаддаг эсэх юм. Эдгээр зарчимд нийцэж байвал энэ замыг үнэн зам хэмээн дүгнэж болно. Ирээдүйн туршлагын чинь явцад та нараар өөр замыг хүлээн зөвшөөрүүлж, эсвэл ирээдүйд бас нэгэн шинэ эрин үеийн ажил байх болно гэж зөгнөх гэсэндээ ч Би эдгээр үгийг хэлж байгаа юм биш. Харин өнөөдрийн зам бол үнэн зам мөн гэдэгт та нарыг итгэлтэй байг гэсэндээ, мөн та нарыг өнөөдрийн ажилд зөвхөн хагас хугас итгэж, мэдлэг олж авч чадахгүй бүү байг гэсэндээ Би ингэж хэлдэг. Итгэлтэй байгаа хэр нь будилан

дагадаг хүмүүс ч олон байдаг; ийм итгэлтэй байдал нь ямар ч зарчимгүй байдаг ба эрт орой хэзээ нэгэн цагт тэд таягдан хаягдах болно. Дагахдаа маш гал цогтой хүмүүс ч гэсэн гурван хэсэгт нь итгэлтэй, таван хэсэгт нь эргэлзээтэй байдаг ба энэ нь тэдний ямар ч ул суурьгүйг харуулдаг. Та нарын хэв чанар хэтэрхий ядмаг, суурь чинь хэтэрхий өнгөц учраас ялган салгах талаар ямар ч ойлголтууд байна. Бурхан Өөрийн ажлыг давтдаггүй, бодитой бус ажил хийдэггүй, хүнд хэрээс хэтэрсэн шаардлага тавьдаггүй, бас хүний эрүүл ухаанаас давсан ажил хийдэггүй. Түүний хийдэг бүх ажил хүний хэвийн ухааны хүрээнд байж, хэвийн хүн чанарын эрүүл ухаанаас давдаггүй бөгөөд Түүний ажил хүний хэвийн шаардлагын дагуу байдаг. Хэрвээ Ариун Сүнсний ажил мөн бол хүн улам хэвийн болж, хүн чанар улам хэвийн болдог. Хүн өөрийн ялзарсан сатанлаг зан чанар болон хүний мөн чанарын талаар улам их мэдлэгтэй болж, үнэнийг улам ихээр хүсэн тэмүүлдэг. Өөрөөр хэлбэл, хүний амь улам өсөж, хүний завхарсан зан чанар улам их өөрчлөгдөж чадна—энэ бүхэн нь Бурхан хүний амь болохын уг утга учир юм. Хэрвээ тухайн зам нь хүний мөн чанар болох зүйлсийг илчилж, хүний зан чанарыг өөрчилж чадахгүй, түүнчлэн хүнийг Бурханы өмнө аваачиж, Бурханы талаарх үнэн зөв ойлголтыг хүнд өгч чадахгүй, тэр ч байтугай хүн чанарыг нь улам дорд болгож, эрүүл ухааныг нь улам хэвийн бус болгож байвал энэ зам үнэн зам байх учиргүй бөгөөд энэ нь муу ёрын сүнсний ажил юм уу хуучин зам байж болох юм. Товчхондоо гэвэл, энэ нь Ариун Сүнсний өнөөгийн ажил байж таарахгүй. Та нар энэ олон жил Бурханд итгэхээд үнэн зам, хуурамч замыг ялган салгах, үнэн замыг эрж хайх зарчмын талаар өчүүхэн төдий ч ойлголтууд байна. Ихэнх хүн эдгээр асуудлыг сонирхдог ч үгүй; тэд ердөө л олонхын явж байгаа зүгт явж, олонхын хэлснийг давтдаг. Энэ яаж үнэн замыг эрж хайж байгаа хүн байх юм бэ? Тийм хүмүүс яаж үнэн замыг олох юм бэ? Хэрвээ чи энэ хэдэн гол зарчмыг ойлгож ухаарах юм бол юу ч боллоо гэсэн хууртахгүй. Өнөөдөр хүн аливааг ялган салгаж чаддаг байх нь амин чухал; энэ нь хэвийн хүн чанарын эзэмшсэн байх ёстой зүйл бөгөөд туршлагадаа хүний эзэмших учиртай зүйл юм. Хэрвээ өнөөдөр ч гэсэн хүмүүс дагах явцдаа юуг ч ялган салгадаггүй, хүний эрүүл ухаан нь одоо ч өсөөгүй л байвал хүмүүс хэтэрхий мунхаг байна, эрэл хайгуул нь ч гэсэн алдаж, ташуурсан байна. Чиний өнөөдрийн эрэл хайгуулд өчүүхэн ч ялгаж салгах явдал алга, чиний хэлдгээр чи үнэн замыг олсон ч гэсэн үүнийгээ олж авсан уу? Ямар нэг зүйлийг ялган салгаж чадаж байгаа юу? Үнэн замын мөн чанар нь юу вэ? Үнэн замд чи үнэн замыг олж аваагүй, үнэнээс юуг ч олж аваагүй. Өөрөөр хэлбэл, Бурханы чамаас шаарддаг зүйлийг биелүүлээгүй, тиймээс чиний

завхралд ямар ч өөрчлөлт гараагүй. Хэрвээ чи энэ маягаар эрэлхийлсээр байвал эцэстээ таягдан хаягдах болно. Өнөөдрийг хүртэл дагасан тул чи сонгосон замаа зөв зам гэдэгт итгэлтэй байж, дахин эргэлзэх ёсгүй. Олон хүн байнга эргэлздэг бөгөөд зарим нэг жижиг асуудлаас болж үнэнийг эрэлхийлэхээ больдог. Тийм хүмүүс бол Бурханы ажлын талаар ямар ч мэдлэггүй хүмүүс бөгөөд Бурханыг будилан дагадаг хүмүүс юм. Бурханы ажлыг мэддэггүй хүмүүс Түүний дотнын нэгэн болж, Бурханыг гэрчлэх чадваргүй байдаг. Зөвхөн ерөөл эрж хайж, тодорхойгүй, хийсвэр зүйлийг л эрэлхийлдэг хүмүүст үнэнийг даруйхан эрж хай гэж Би зөвлөө, ингэснээр тэдний амьдрал утга учиртай болно. Өөрсдийгөө цаашид бүү хуур!

БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАНЫ ҮЙЛЧЛЭЛ БА ХҮНИЙ ҮҮРГИЙН ЯЛГАА

Та нар Бурханы ажлын үзэгдлийг мэдэж авч, Түүний ажлын ерөнхий чиглэлийг ухаарах ёстой. Энэ нь эерэг оролт юм. Үзэгдлийн тухай үнэнийг яг таг эзэмшингүүт оролт чинь найдвартай болно; Бурханы ажил яаж өөрчлөгдөх нь хамаагүй, чи зүрх сэтгэлдээ тууштай байж, үзэгдлүүдийн талаар тодорхой мэдэж, оролт болон эрэл хайгуул чинь зорилготой болно. Ийм маягаар, чиний доторх бүхий л туршлага, мэдлэг илүү гүнзгийрч, улам нарийсна. Ерөнхий чиг хандлагыг бүхэлд нь ойлгомогц амь чинь ч хохирол амсахгүй, чи ч төөрөлдөхгүй. Хэрвээ чи ажлын эдгээр алхмыг мэдэж авахгүй бол алхам бүрд хохирол амсах бөгөөд хэдхэн өдрийн дотор үүнийг өөрчилж чадахгүй, хоёр долоо хоногийн дотор ч зөв замд орж чадахгүй. Энэ нь саатал учруулахгүй гэж үү? Эерэг оролт болон хэрэгжүүлэлтийн замд та нарын эзэмших ёстой зүйл их байдаг. Бурханы ажлын үзэгдлийн тухайд бол, чи дараах зүйлсийг ухаарах ёстой: Түүний байлдан дагуулалтын ажлын ач холбогдол, төгс болгуулах ирээдүйн зам, шалгалт, гай зовлон туулснаар юунд хүрэх ёстой, шүүлт, гэсгээлтийн утга учир, Ариун Сүнсний ажлын зарчмууд болон төгс болгох, байлдан дагуулах зарчмууд. Эдгээр нь бүгд үзэгдлүүдийн тухай үнэнд харьяалагддаг. Үлдсэн нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе, Хаанчлалын эрин үе дэх ажлын гурван үе шат, мөн түүнчлэн ирээдүйн гэрчлэл юм. Эдгээр нь ч бас үзэгдлүүдийн тухай үнэн бөгөөд хамгийн гол, хамгийн чухал нь юм. Одоо та нарын хэрэгжүүлж, орох ёстой зүйл маш их байдаг ба энэ нь одоо илүү олон давхаргатай, илүү дэлгэрэнгүй байдаг. Хэрвээ чамд эдгээр үнэний талаарх

мэдлэг байхгүй бол хараахан ороогүй байгааг чинь энэ нь нотолдог. Ихэнхдээ үнэний талаарх хүмүүсийн мэдлэг хэтэрхий өнгөц байдаг; тэд зарим энгийн үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг ба ялихгүй асуудлуудыг ч хэрхэн зохицуулахаа мэддэггүй. Хүмүүс үнэнийг хэрэгжүүлж чаддаггүйн шалтгаан нь тэдний тэрслүү зан чанараас болдог, мөн өнөөдрийн ажлын талаарх мэдлэг нь хэтэрхий өнгөц, өрөөсгөл байдгаас болдог. Тиймээс, хүмүүсийн хувьд төгс болгуулна гэдэг тийм ч амархан ажил биш. Чи дэндүү тэрслүү бөгөөд хуучин байдлаа хэтэрхий их хадгалдаг; үнэний талд зогсох чадваргүй, хамгийн илэрхий үнэнийг ч хэрэгжүүлэх чадваргүй. Ийм хүмүүс аврагдаж чадахгүй бөгөөд байлдан дагуулагдаагүй хүмүүс юм. Хэрвээ чиний оролт нарийн ширийн юмгүй, бас зорилгогүй бол өсөлт чинь удаан байх болно. Хэрвээ чиний оролт өчүүхэн ч бодит байдалгүй бол эрэл хайгуул чинь талаар болно. Хэрвээ чи үнэний мөн чанарыг мэдэхгүй бол өөрчлөгдөөгүй хэвээр үлдэнэ. Хүний амийн өсөлт ба зан чанарын өөрчлөлт нь бодит байдалд орсноор, түүнчлэн нарийвчилсан туршлага руу орсноор явагддаг. Хэрвээ орох үедээ чи олон нарийвчилсан туршлагатай байвал, мөн ихээхэн бодит мэдлэг болон оролттой байвал зан чанар чинь хурдан өөрчлөгдөнө. Одоогоор чи хэрэгжүүлэлтийн талаар тов тодорхой мэдэхгүй байсан ч гэсэн, ядаж л Бурханы ажлын үзэгдлийн талаар тодорхой мэдэж байх ёстой. Эс бөгөөс чи орох чадваргүй байх болно; үнэний мэдлэгтэй болж байж л орох боломжтой. Туршлагыг чинь Ариун Сүнс гэгээрүүлсэн үед л чи үнэний талаар илүү гүнзгий ойлгож, илүү гүн орж чадна. Та нар Бурханы ажлыг мэдэж авах ёстой.

Анх, хүн төрөлхтөн бүтээгдсэний дараа Бурханы ажлын үндэс суурь болон үйлчилж байсан хүмүүс нь израильчууд байв. Израиль бүхэлдээ Еховагийн газар дээрх ажлын суурь байсан билээ. Еховагийн ажил нь хууль тогтоосноор дамжуулан хүнийг шууд удирдаж, хариулах явдал байсан бөгөөд ингэснээр хүн хэвийн амьдралаар амьдарч, газар дээр хэвийн байдлаар Еховаг шүтэн мөргөж чадах байсан юм. Хуулийн эрин үе дэх Бурханыг хүн харж ч, хүрч ч чадахгүй байлаа. Тэрээр Сатаны завхруулсан анхны хүмүүсийг л удирдан чиглүүлж, тэдэнд зааж сургаж, тэднийг хариулж байсан учраас Түүний үг хууль, тогтоол болон хүний биеэ авч явах стандартыг л агуулж байсан бөгөөд тэдний амийг үнэнээр хангаагүй юм. Түүний удирдлага дор байсан израильчууд Сатаны гүн гүнзгий завхруулсан хүмүүс биш байв. Түүний хуулийн ажил нь ердөө авралын ажлын хамгийн эхний үе шат, авралын ажлын эхлэл байсан ба үнэндээ хүний амь зан чанарын өөрчлөлттэй бараг ямар ч хамаагүй байлаа. Тиймээс, авралын

ажлын эхэн үед Израиль дахь ажлынхаа төлөө Тэрээр махбодтой болох хэрэггүй байсан юм. Ийм учраас Түүнд хүнтэй харилцахдаа ашиглах зууч буюу хэрэгсэл шаардлагатай байв. Тиймээс, бүтээгдсэн зүйлсийн дунд Еховагийн өмнөөс ажиллаж, ярьдаг хүмүүс бий болсон бөгөөд ийнхүү хүний хөвгүүд болон эш үзүүлэгчид хүмүүсийн дунд ажиллах болжээ. Хүний хөвгүүд Еховагийн өмнөөс хүмүүсийн дунд ажиллав. Еховагаар “хүний хөвгүүд” гэж дуудагдана гэдэг нь тийм хүмүүс Еховагийн өмнөөс хууль тогтоосон гэсэн үг юм. Тэд бас Израилийн ард түмний дундах тахилчид, Еховагийн харж хандаж, хамгаалж байсан тахилчид байсан бөгөөд Еховагийн Сүнс тэдний дотор ажилладаг байжээ; тэд хүмүүсийн дундах удирдагчид байсан ба Еховад шууд үйлчилж байв. Нөгөөтээгүүр, эш үзүүлэгчид бүх газар нутаг, овгийн хүмүүст Еховагийн өмнөөс ярихад өөрсдийгөө зориулсан хүмүүс байсан юм. Тэд ч бас Еховагийн ажлыг зөгнөж байлаа. Хүний хөвгүүд ч бай, эсвэл эш үзүүлэгчид ч бай, бүгдийг нь Еховагийн Сүнс Өөрөө өргөсөн ба тэдэнд Еховагийн ажил байсан юм. Хүмүүсийн дунд тэд Еховаг шууд төлөөлдөг хүмүүс байсан; тэд Ариун Сүнсний Өөрийн махбод болсон бие байсан учраас биш, харин Ехова өөрсдийг нь өргөсөн учраас л ажлаа хийсэн билээ. Тиймээс, Бурханы өмнөөс ярьж, ажилласнаараа адилхан байсан хэдий ч Хуулийн эрин үе дэх хүний хөвгүүд ба эш үзүүлэгчид нь Бурханы махбод болсон бие байгаагүй юм. Нигүүлслийн эрин үе болон сүүлчийн үе шатан дахь Бурханы ажил яг эсрэгээрээ байсан, учир нь авралын ажил болон хүнийг шүүх шүүлтийг хоёуланг нь бие махбодтой болсон Бурхан Өөрөө хийсэн тул Өөрийнх нь оронд ажиллах хүний хөвгүүд болон эш үзүүлэгчдийг дахин нэгэнтээ өргөх хэрэггүй байв. Хүний нүдээр бол, тэдний ажлын мөн чанар, арга барилын хооронд үндсэн ялгаа байхгүй. Энэ шалтгааны улмаас хүмүүс бие махбодтой болсон Бурханы ажлыг эш үзүүлэгчид болон хүний хөвгүүдийн ажилтай байнга андуурч будилдаг. Бие махбодтой болсон Бурханы харагдах байдал нь үндсэндээ эш үзүүлэгч, хүний хөвгүүдийнхтэй адилхан байсан. Бие махбодтой болсон Бурхан нь эш үзүүлэгчдийг бодвол бүр ч илүү хэвийн, илүү бодитой байв. Тиймээс хүн тэднийг ялгаж чаддаггүй. Хүн гагцхүү харагдах байдалд анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд хэдий хоёулаа адилхан ажиллаж, үг хэлдэг ч тэдний хооронд үндсэн ялгаа байдаг гэдгийг огт мэддэггүй. Хүний ялган таних чадвар хэтэрхий дульхан байдаг учраас энгийн асуудлуудыг ялган таньж чаддаггүй, нарийн төвөгтэй зүйлийг бол бүр ч чаддаггүй. Эш үзүүлэгчид болон Ариун Сүнсний ашигласан тэр хүмүүс үг хэлж, ажилласан нь бүгд хүний үүргийг биелүүлж, бүтээгдсэн зүйлийн чиг үүргийг

гүйцэтгэхийн төлөө байсан бөгөөд энэ нь хүний хийх учиртай зүйл байсан юм. Харин бие махбодтой болсон Бурханы үг ба ажил нь Түүний үйлчлэлийг хэрэгжүүлэхийн төлөө байсан. Түүний гадаад хэлбэр хэдий бүтээгдсэн зүйлийнх байсан ч Түүний ажил нь Өөрийн чиг үүргийг биш, харин Өөрийн үйлчлэлийг биелүүлэхийн төлөө байв. “Үүрэг” гэсэн нэр томьёо нь бүтээгдсэн зүйлтэй холбоотой хэрэглэгддэг байхад “үйлчлэл” нь Бурханы махбод болсон биетэй холбоотойгоор хэрэглэгддэг. Энэ хоёрын хооронд үндсэн ялгаа бий; тэдгээр нь харилцан солигддоггүй. Хүний ажил бол зөвхөн үүргээ биелүүлэх явдал байхад Бурханы ажил бол удирдаж, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал юм. Тиймээс, хэдийгээр Ариун Сүнс олон элчийг ашиглаж, олон эш үзүүлэгч Түүгээр дүүргэгдэж байсан ч тэдний ажил ба үг ердөө л бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлэхийн төлөө байв. Тэдний зөгнөл бие махбодтой болсон Бурханы хэлсэн амийн үгээс хэтрэн гарч, хүн чанар нь бие махбодтой болсон Бурханыхаас ч давсан байж болох ч тэд үйлчлэл хийж байсан юм биш, харин үүргээ л биелүүлж байсан билээ. Хүний үүрэг нь хүний чиг үүргийг хэлдэг; энэ нь хүний хүрч болох зүйл юм. Харин, бие махбодтой болсон Бурханы хэрэгжүүлдэг үйлчлэл нь Түүний удирдлагатай холбоотой ба үүнд хүн хүршгүй юм. Бие махбодтой болсон Бурхан ярьж, ажиллаж, гайхамшгийг үзүүлж байсан ч Өөрийн удирдлага дунд агуу ажил хийж байгаа ба тийм ажлыг хүн Түүний оронд хийж чадахгүй. Хүний ажил бол Бурханы удирдлагын ажлын тодорхой үе шатанд, бүтээгдсэн зүйлийн үүргээ л биелүүлэх явдал юм. Бурханы удирдлагагүй бол, өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы үйлчлэл алдагдсан бол бүтээгдсэн зүйлийн үүрэг ч гэсэн алдагдах байв. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх Бурханы ажил нь хүнийг удирдах явдал байхад хүн үүргээ биелүүлнэ гэдэг нь Бүтээгчийн шаардлагад нийцэхийн тулд үүрэг даалгавраа биелүүлэх явдал бөгөөд үйлчлэлээ хэрэгжүүлж байгаа хэрэг гэж үзэж яавч болохгүй. Бурханы төрөлхийн мөн чанарт—Түүний Сүнсэнд—Бурханы ажил бол Өөрийнх нь удирдлага, харин бүтээгдсэн зүйлийн гадаад хэлбэртэй бие махбодтой болсон Бурханы хувьд, Түүний ажил бол Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал юм. Тэр ямар ч ажил хийлээ гэсэн, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж байгаа; хүн Бурханы удирдлагын цар хүрээн дотор, Түүний удирдамж дор чадах бүхнээ хийж л болно.

Хүний үүргийн биелэлт гэдэг нь үнэндээ хүнд угаасаа байсан бүхнийг буюу хүний хувьд төрөлхөөсөө боломжтой зүйлийг биелүүлэх явдал юм. Тэр үед түүний үүрэг биелдэг. Үйлчлэлийн үеэрх хүний дутагдал нь алгуур туршлагаар болон шүүлт туулах үйл явцаар дамжуулан аажмаар багасдаг; тэдгээр нь хүний

үүрэгт нөлөөлөх юм уу саад болдоггүй. Үйлчлэлд нь саад тотгор гарч болзошгүй гэж айсандаа үйлчлэхээ больж, бууж өгч, эсвэл ухарч няцдаг хүмүүс бол бүх хүний дотроос хамгийн хулчгар нь юм. Хэрвээ хүмүүс үйлчлэлийн үеэр өөрсдийн илэрхийлэх ёстой зүйлийг илэрхийлж чадахгүй, эсвэл өөрсдийнх нь хувьд төрөлхөөсөө боломжтой зүйлийг биелүүлж чадахгүй, харин оронд нь мунхаглаж, хийсэн дүр үзүүлбэл бүтээгдсэн зүйлд байх ёстой чиг үүргээ алджээ. Тийм хүмүүс бол “тааруухан” гэгддэг хүмүүс юм; тэд бол хэрэггүй хог хаягдал мөн. Тийм хүмүүсийг яаж бүтээгдсэн зүйл гэж зохис ёсоор нэрлэж болох юм бэ? Тэд гаднаа гяланцаг, дотроо паланцаг завхарсан оршихуй биш гэж үү? Хүн өөрийгөө Бурхан гэж нэрлэсэн ч бурханлаг чанарын оршихуйг илэрхийлж чадахгүй, Бурханы Өөрийн ажлыг хийж чадахгүй, эсвэл Бурханыг төлөөлж чадахгүй бол Бурхан биш гэдэг нь эргэлзээгүй, учир нь түүнд Бурханы мөн чанар байхгүй, Бурханы төрөлхөөсөө биелүүлж чаддаг зүйл түүний дотор оршин байдаггүй. Хэрвээ хүн төрөлхөөсөө хүрч чадахуйц зүйлээ алдвал түүнийг цаашид хүн гэж үзэж болохгүй ба тэрээр бүтээгдсэн зүйлийн байр сууринд зогсох юм уу Бурханы өмнө очиж, Түүнд үйлчлэх үнэ цэнгүй. Түүнчлэн, тэрээр Бурханы нигүүлслийг хүртэх, эсвэл Бурханаар халамжлуулж, хамгаалуулж, төгс болгуулах үнэ цэнгүй. Бурханы итгэлийг алдсан олон хүн Бурханы нигүүлслийг алдсаар байдаг. Тэд өөрсдийн буруу үйлийг үзэн яддаггүйгээр үл барам, Бурханы зам бол буруу гэсэн үзэл санааг ичгүүр сонжуургүйгээр түгээдэг ба тэрслүү хүмүүс бүр Бурханы оршин тогтнолыг ч үгүйсгэдэг. Тийм тэрслүү байдалтай ийм хүмүүс яаж Бурханы нигүүлслийг эдлэх эрхтэй байж чадах юм бэ? Өөрсдийн үүргийг биелүүлдэггүй хүмүүс Бурханы эсрэг маш их тэрсэлдэг ба Түүнд их өртэй, гэсэн ч тэд эргээд Бурханы буруу хэмээн зад шүүмжилдэг. Тийм төрлийн хүмүүс яаж төгс болгуулахад тохирох юм бэ? Энэ нь таягдан хаягдаж, шийтгүүлэхийн дохио биш гэж үү? Бурханы өмнө үүргээ биелүүлдэггүй хүмүүс аль хэдийн хамгийн жигшүүрт гэмт хэрэг үйлдсэн, үүнд үхэх шийтгэл ч хангалтгүй атал тэд Бурхантай маргах ичгүүр сонжуургүй зантай байж, Түүнтэй өрсөлддөг. Тийм хүмүүсийг төгс болгох нь ямар хэрэгтэй юм бэ? Хүмүүс үүргээ биелүүлж чадахгүй бол гэм буруутай, өртэйгөө мэдрэх ёстой; тэд сул дорой, нэмэргүй байдлаа, тэрслүү байдал, завхралаа үзэн ядах ёстой, түүнчлэн өөрсдийн амийг Бурханд өгөх учиртай. Зөвхөн тэр үед л тэд Бурханыг үнэхээр хайрладаг бүтээгдсэн зүйл мөн бөгөөд ийм хүмүүс л Бурханы ерөөл, амлалтыг эдэлж, Түүгээр төгс болгуулахад тохирдог. Тэгвэл та нарын ихэнх нь ямар вэ? Та нарын дунд амьдардаг Бурханд та нар хэрхэн ханддаг вэ? Түүний өмнө

үүргээ хэрхэн биелүүлсэн бэ? Та нар амиа золиослоод ч хамаагүй, хийх ёстой бүхнээ чадлынхаа хэрээр хийсэн үү? Та нар юу золиосолсон бэ? Та нар Надаас ихийг хүлээн аваагүй гэж үү? Та нар ялган таньж чадах уу? Надад хэр үнэнч вэ? Надад хэрхэн үйлчилсэн бэ? Би та нарт юу өгч, та нарын төлөө юу хийсэн бэ? Та нар энэ бүхнийг хэмжиж үзсэн үү? Та нар бүгдээрээ өөрсдийн доторх өчүүхэн мөс чанараараа үүнийг хэмжиж, харьцуулж үзсэн үү? Та нарын үг, үйлдэл хэнд зохистой вэ? Та нарын тийм өчүүхэн золиослол Миний өгсөн бүхнийг хүртэхэд зохистой гэж үү? Надад өөр ямар ч сонголт байгаагүй ба Би та нарт үнэн сэтгэлээсээ хандсан ч та нар Миний талаар хорон муу сэжиг өвөрлөж, Надад хоёрдмол сэтгэлээр ханддаг. Тэр нь та нарын үүрэг, та нарын цорын ганц чиг үүрэг юм. Тийм биш гэж үү? Та нар бүтээгдсэн зүйлийн үүргээ огтхон ч биелүүлээгүй гэдгээ мэдэхгүй гэж үү? Та нарыг яаж бүтээгдсэн зүйл гэж үзэж болох юм бэ? Илэрхийлж, амьдран харуулж байгаа зүйл чинь юу болохыг та нар тодорхой мэддэггүй гэж үү? Та нар үүргээ биелүүлж чадаагүй боловч Бурханы хүлээцтэй байдал, элбэг дэлбэг нигүүлслийг олж авахаар чармайдаг. Тийм нигүүлсэл нь та нар шиг үнэ цэнгүй, олиггүй хүмүүст зориулан бэлтгэгдээгүй, харин юу ч гуйлгүйгээр, баяртайяа золиосолдог хүмүүст зориулагдсан. Та нар шиг ийм хүмүүс, ийм тааруухан хүмүүс тэнгэрийн нигүүлслийг эдлэхэд огт тохирохгүй. Зовлон зүдүүр болон эцэс төгсгөлгүй шийтгэл л өдөр хоногуудыг чинь дагана! Хэрвээ та нар Надад үнэнч байж чадахгүй бол хувь заяа чинь зовлонгийнх байх болно. Хэрвээ та нар Миний үг болон Миний ажилд хариуцлагатай байж чадахгүй бол төгсгөл чинь шийтгэл байх болно. Бүх нигүүлсэл, ерөөл болон хаанчлалын гайхалтай амьдрал та нартай ямар ч хамаагүй байх болно. Энэ нь та нарын хүртэх ёстой төгсгөл бөгөөд хийсэн зүйлийн чинь үр дагавар юм! Мунхаг, биеэ тоосон хүмүүс чадлынхаа хэрээр хичээдэггүй, үүргээ ч биелүүлдэггүйгээр үл барам, харин ч өөрсдийн хүртэх эрхтэй зүйлийг хүсэж байгаа мэтээр нигүүлсэл гуйн гараа сунгасан. Тэгээд гуйсан зүйлээ авч чадаагүй бол бүр ч итгэлгүй болдог. Тийм хүмүүсийг яаж ухаантай гэж үзэж болох юм бэ? Та нар дорд хэв чанартай, эрүүл ухаангүй, удирдлагын ажлын үеэр хэрэгжүүлэх ёстой үүргээ огт биелүүлэх чадваргүй. Та нарын үнэ цэн аль хэдийн огцом унасан. Та нарт тийм нигүүлсэл үзүүлсний хариуг Надад буцаан төлж чадахгүй байх чинь аль хэдийнээ туйлын тэрслүү үйлдэл бөгөөд та нарыг яллаж, хулчгар зан, чадваргүй байдал, олиггүй зан, үнэ цэнгүй байдлыг чинь харуулахад энэ нь хангалттай. Та нар гараа сунгах ямар эрхтэй юм бэ? Миний ажилд өчүүхэн төдий ч тус болох чадваргүй, үнэнч байх

чадваргүй, Миний төлөө гэрчлэлд зогсох чадваргүй байдаг чинь та нарын буруу үйл, алдаа дутагдал атал харин ч та нар Над руу дайрч довтолж, Миний талаар худал ярьж, Намайг зөвт бус гэж гомдоллодог. Энэ нь та нарын үнэнч зан уу? Та нарын хайр уу? Та нар үүнээс илүү өөр ямар ажил хийж чадах вэ? Хийгдсэн бүх ажилд та нар ямар хувь нэмэр оруулсан бэ? Та нар хэр ихийг зарлагадсан бэ? Би та нарыг буруутгаагүйгээрээ аль хэдийн асар их хүлээцтэй байдал харуулсан хэр нь та нар одоо ч Надад ичгүүргүйгээр шалтаг тоочиж, нууцаар Миний тухай гомдоллодог. Та нарт хүн чанарын өчүүхэн ч гэсэн ул мөр байгаа юу? Хэдийгээр хүний үүрэгт хүний оюун санаа болон үзэл холилддог ч чи үүргээ биелүүлж, үнэнч зангаа харуулах ёстой. Хүний ажил дахь хольц нь түүний хэв чанарын асуудал, харин хүн үүргээ биелүүлдэггүй бол энэ нь түүний тэрслүү занг харуулдаг. Хүний үүрэг болон түүний ерөөгдөх, хараагдах эсэхийн хооронд ямар ч хамаарал байхгүй. Үүрэг бол хүний биелүүлэх учиртай зүйл; энэ нь тэнгэрээс өгсөн ажил бөгөөд нөхөн төлбөр, нөхцөл болзол, учир шалтгаанаас хамаарах ёсгүй. Тэгвэл л өөрийн үүргийг биелүүлж байгаа хэрэг юм. Ерөөгдөх гэдэг нь хүн шүүлт туулсныхаа дараа төгс болгуулж, Бурханы ерөөлийг эдлэх явдал билээ. Хараагдах гэдэг нь шүүлт, гэсгээлт туулсны дараа хүний зан чанар өөрчлөгдөхгүй байх явдал бөгөөд тэд төгс болгуулдаггүй, харин шийтгүүлдэг. Гэвч ерөөгдсөн үү, эсвэл хараагдсан уу гэдгээс үл хамааран, бүтээгдсэн зүйлс өөрсдийн үүргийг биелүүлж, хийх учиртай зүйлээ хийж, чаддаг зүйлээ хийх ёстой; энэ бол Бурханыг эрэлхийлдэг хүний хийх ёстой хамгийн наад захын зүйл юм. Чи зөвхөн ерөөгдөхийн тулд үүргээ биелүүлэх ёсгүй ба хараагдахаас айсандаа үүргээ биелүүлэхээс татгалзах ёсгүй. Би та нарт энэ нэг зүйлийг хэлье: Үүргээ биелүүлэх нь хүний хийх учиртай зүйл бөгөөд хэрвээ хүн үүргээ биелүүлж чадахгүй бол энэ нь түүний тэрслүү зан юм. Үүргээ биелүүлэх үйл явцаар л дамжуулан хүн аажмаар өөрчлөгддөг ба энэхүү үйл явцаар үнэнч байдлаа харуулдаг. Тийм болохоор, чи үүргээ биелүүлж чаддаг байх тусмаа, төдий чинээ их үнэнийг хүлээн авч, илэрхийлэл чинь төдий чинээ бодитой болно. Өөрсдийн үүргийг биелүүлэхдээ зүгээр л оромдож, үнэнийг эрж хайдаггүй хүмүүс эцэстээ таягдан хаягдана, учир нь тийм хүмүүс үнэнийг хэрэгжүүлэхдээ үүргээ биелүүлдэггүй ба үүргээ биелүүлэхдээ үнэнийг хэрэгжүүлдэггүй. Тэд бол өөрчлөгдөлгүй үлддэг хүмүүс бөгөөд хараагдах болно. Тэдний илэрхийлэл хольцтой байдгаар үл барам, илэрхийлдэг бүхэн нь хорон муу байдаг.

Нигүүлслийн эрин үед Есүс ч бас маш олон үг хэлж, ихээхэн ажил хийсэн.

Тэр Исаиагаас ямар ялгаатай байсан бэ? Даниелээс ямар ялгаатай байсан бэ? Тэр чухамдаа эш үзүүлэгч байсан уу? Яагаад Түүнийг Христ гэдэг вэ? Тэдний хоорондох ялгаа юу вэ? Тэд бүгдээрээ үг хэлдэг хүмүүс байсан бөгөөд тэдний үг хүмүүст бараг адилхан харагддаг байсан юм. Тэд бүгд үг хэлж, ажил хийсэн. Хуучин Гэрээний эш үзүүлэгчид зөгнөл хэлдэг байсны адилаар Есүс ч бас тэгсэн. Яагаад тэр вэ? Энд байгаа ялгаа нь ажлын шинж чанарт үндэслэдэг. Энэ асуудлыг ялган танихын тулд чи махан биеийн шинж чанарыг авч үзэх ёсгүй, мөн тэдний үгийн гүн гүнзгий, өнгөц байдлыг ч авч үзэх ёсгүй. Чи үргэлж тэдний ажил болон тэдний ажлын хүнд үзүүлдэг үр нөлөөг эхлээд авч үзэх ёстой. Тухайн үед эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлүүд нь хүний амийг хангаагүй бөгөөд Исаиа, Даниел зэрэг хүмүүсийн хүлээн авсан онгод нь амийн зам биш, ердөө л зөгнөл байсан. Еховагийн шууд илчлэл байгаагүй бол эгэл хүмүүсийн хийх боломжгүй тэр ажлыг хэн ч хийж чадахгүй байх байсан. Есүс ч гэсэн олон үг хэлсэн, гэхдээ тийм үг нь амийн зам байсан ба хүн үүнээс хэрэгжүүлэх замыг олж чадсан юм. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, Есүс бол амь учраас хүний амийг хангаж чадсан; хоёрдугаарт, Тэр хүний гажуудлыг өөрчилж чадсан; гуравдугаарт, Тэрээр эрин үеийг үргэлжлүүлэхийн тулд Еховагийн ажлыг залгамжилж чадсан; дөрөвдүгээрт, Тэр хүний доторх хэрэгцээг ухаарч, хүнд юу дутагдаж байгааг ойлгож чадсан; тавдугаарт, Тэр шинэ эрин үеийг эхлүүлж, хуучин эринийг төгсгөж чадсан. Тийм учраас Түүнийг Бурхан, Христ гэж нэрлэдэг; Тэр Исаиагаас төдийгүй бусад бүх эш үзүүлэгчээс өөр юм. Эш үзүүлэгчдийн ажилтай харьцуулахын тулд Исаиаг авч үзье. Нэгдүгээрт, тэр хүний амийг хангаж чадаагүй; хоёрдугаарт, шинэ эрин үеийг эхлүүлж чадаагүй. Тэрээр Еховагийн удирдлага дор ажиллаж байсан болохоос шинэ эрин үеийг эхлүүлэх гэж ажиллаагүй. Гуравдугаарт, түүний хэлсэн зүйл өөрөөс нь давсан байв. Тэрээр Бурханы Сүнснээс шууд илчлэл хүлээн авч байсан ба бусад нь тэдгээрийг сонсчихоод ч ойлгохгүй байсан юм. Түүний үг бол ердөө л зөгнөлөөс цаашгүй, Еховагийн оронд хийсэн ажлын нэг талаас хэтрэхгүй байсан гэдгийг батлахад энэ цөөн хэдэн зүйл дангаараа хангалттай билээ. Гэхдээ тэр Еховаг бүрэн төлөөлж чадаагүй. Тэр бол Еховагийн зарц, Еховагийн ажлын хэрэгсэл байсан юм. Тэрээр зөвхөн Хуулийн эрин үе дотор, Еховагийн ажлын цар хүрээн дэх ажлыг л хийж байсан; тэр Хуулийн эрин үеэс цааш ажиллаагүй. Харин Есүсийн ажил өөр байв. Есүс Еховагийн ажлын цар хүрээг давсан; Тэрээр бие махбодтой болсон Бурхан болж ажилласан бөгөөд бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд цовдлогдсон. Өөрөөр хэлбэл, Тэр Еховагийн хийсэн ажлын

гаднах шинэ ажлыг гүйцэтгэсэн юм. Энэ нь шинэ эрин үеийг эхлүүлэх явдал байв. Дээр нь нэмээд Тэр хүний хүрч чадахгүй зүйлсийн талаар хэлж чаддаг байлаа. Түүний ажил нь Бурханы удирдлага доторх ажил байсан бөгөөд бүх хүн төрөлхтөнтэй холбоотой байв. Тэр цөөн хэдхэн хүн дээр ажиллаагүй, Түүний ажил цөөн тооны хүмүүсийг удирдахын төлөө ч байгаагүй. Бурхан яаж бие махбодтой хүн болсон, тухайн үед Сүнс яаж илчлэл өгсөн, Сүнс ажлаа хийхийн тулд хэрхэн хүн дээр бууж ирсэн гэх мэтийн тухайд бол эдгээр нь хүний харж, эсвэл хүрч чадахгүй зүйлс юм. Эдгээр баримт нь Тэр бол бие махбодтой болсон Бурхан мөн гэдгийн нотолгоо болох ямар ч боломжгүй. Иймээс, хүнд мэдэгдэхүйц байдаг Бурханы үг ба ажилд л үндэслэн ялгааг нь харж болно. Зөвхөн энэ л бодитой. Яагаад гэвэл, Сүнсний хэрэг явдал чамд харагддаггүй ба Бурхан Өөрөө л тодорхой мэддэг, Бурханы махбод болсон бие ч бүгдийг нь мэдэхгүй; чи Түүний хийсэн ажлаас нь л Бурхан мөн эсэхийг нь баталж чадна. Түүний ажлаас, нэгдүгээрт, Тэр шинэ эрин үеийг нээж чаддаг; хоёрдугаарт, Тэр хүний амийг хангаж, хүний дагах замыг харуулж чаддаг гэдгийг харж болно. Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг тогтооход энэ хангалттай. Хамгийн наад зах нь, Түүний хийдэг ажил Бурханы Сүнсийг бүрэн төлөөлж чадах ба Бурханы Сүнс Түүн дотор байгаа гэдгийг ийм ажлаас харж болно. Бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил нь үндсэндээ шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг удирдан чиглүүлж, шинэ ертөнцийг нээхийн төлөө байдаг учраас Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг батлахад эдгээр нь дангаараа хангалттай. Тиймээс энэ нь Түүнийг, Исаиа, Даниел болон бусад агуу эш үзүүлэгчдээс ялгаж байгаа юм. Исаиа, Даниел болон бусад нь бүгд өндөр боловсролтой, соёлтой хүмүүс байсан; тэд Еховагийн удирдлага доорх гайхамшигтай хүмүүс байлаа. Бие махбодтой болсон Бурханы махбод ч бас мэдлэг ухаантай, эрүүл ухаанаар дутмаг биш байсан боловч хүн чанар нь нэн хэвийн байв. Тэр эгэл хүн байсан ба хүний энгийн нүд Түүний ямар нэг онцгой хүн чанарыг ялган таньж, эсвэл бусдынхаас ялгаатай хүн чанарыг олж харж чадаагүй юм. Тэр огтхон ч ер бусын юм уу өвөрмөц байгаагүй ба илүү өндөр боловсрол, мэдлэг, онолыг эзэмшиж байгаагүй. Түүний ярьж байсан амь болоод хөтөлсөн зам нь онолоор дамжуулж, мэдлэгээр дамжуулж, амьдралын туршлагаар дамжуулж, эсвэл гэр бүлийн хүмүүжлээр дамжуулж олдоогүй. Харин ч тэдгээр нь Сүнсний шууд ажил буюу Бурханы махбод болсон биеийн ажил байлаа. Хүн Бурханы талаар асар их үзэлтэй байдаг ба эдгээр үзэл нь ялангуяа хэтэрхий олон бүдэг бадаг, ер бусын элементээс бүрддэг учраас хүний нүдээр бол тэмдэг, гайхамшиг үзүүлж

чаддаггүй, хүний сул талуудтай хэвийн Бурхан нь мэдээж Бурхан биш байлаа. Эдгээр нь хүний эндүү ташаа үзэл биш гэж үү? Хэрвээ Бурханы махбод болсон бие хэвийн хүн байгаагүй бол Түүнийг яаж махбод болсон гэж хэлж болох юм бэ? Махбодтой байна гэдэг нь ердийн, хэвийн хүн байх явдал юм; хэрвээ Тэр ер бусын оршихуй байсан бол бие махбодтой биш байх байв. Махбодтой гэдгээ батлахын тулд бие махбодтой болсон Бурхан нь хэвийн махбодыг эзэмших хэрэгтэй байлаа. Энэ нь зүгээр л бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцэлдүүлэхийн төлөө байсан юм. Гэвч, эш үзүүлэгчид болон хүний хөвгүүдийн хувьд ийм байгаагүй. Тэд бол Ариун Сүнсний ашиглаж байсан, авьяас чадвартай хүмүүс байсан; хүний нүдээр бол тэдний хүн чанар нэн агуу байсан ба тэд хэвийн хүн чанараас давсан олон үйл үйлдсэн юм. Энэ шалтгааны улмаас, хүн тэднийг Бурхан мэт үзсэн. Одоо та нар бүгдээрээ үүнийг тодорхой ойлгох ёстой, учир нь энэ бол өнгөрсөн эрин үеийн хүмүүсийн хамгийн амархан төөрч будилдаг асуудал байсаар ирсэн юм. Нэмж хэлэхэд, бие махбодтой болох нь бүх зүйлээс хамгийн нууцлаг нь бөгөөд бие махбодтой болсон Бурханыг хүлээн авах нь хүний хувьд хамгийн хэцүү байдаг. Миний хэлдэг зүйл, чиг үүргээ биелүүлэхэд чинь, мөн бие махбодтой болохын нууцыг ойлгоход чинь тус дэм болдог. Энэ нь бүгд Бурханы удирдлага болон үзэгдэлтэй холбоотой. Та нар үүнийг ойлговол үзэгдлийн талаар буюу Бурханы удирдлагын ажлын талаар илүү их мэдлэг олж авахад илүү тустай байх болно. Ийм маягаар, та нар бас өөр өөр хүмүүсийн биелүүлэх ёстой үүргийн талаар илүү их ойлголт олж авна. Хэдий эдгээр үг та нарт замыг шууд харуулдаггүй ч оролтод чинь асар их тус болдог, учир нь та нарын одоогийн амьдралд үзэгдэл ихээхэн дутагдаж байгаа бөгөөд энэ нь та нарын оролтод ихээхэн садаа тээг болно. Хэрвээ та нар эдгээр асуудлыг ойлгож чадаагүй бол та нарт орох урам зориг байхгүй байх болно. Тэгвэл ийм эрэл хайгуулаар та нар үүргээ яаж чадлынхаа хэрээр биелүүлж чадах юм бэ?

БУРХАН БОЛ БҮХ БҮТЭЭЛИЙН ЭЗЭН

Өмнөх хоёр эрин үеийн ажлын нэг үе шат нь Израильд, нөгөө нь Иудейд явагдсан. Ерөнхийдөө, энэ хоёр үе шатны ажлын аль нь ч Израилийг орхиогүй, тус бүр нь анхны сонгогдсон хүмүүс дээр явагдсан. Тиймээс Ехова Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэж израильчууд итгэдэг. Есүс Иудейд ажиллаж, Өөрийн цовдлолын ажлыг хэрэгжүүлсэн учраас иудейчүүд Түүнийг Иудейн

хүмүүсийн золин Аврагч гэж үздэг. Тэрээр өөр бусад ард түмний биш, гагцхүү иудейчүүдийн хаан юм; Тэр англичуудыг золин авардаг Эзэн биш, бас америкчуудыг золин авардаг Эзэн ч биш, харин израильчуудыг золин авардаг Эзэн; Тэрээр Израильд иудейчүүдийг золин аварсан гэж тэд боддог. Үнэндээ, Бурхан бол бүх зүйлийн Эзэн билээ. Тэр бол бүх бүтээлийн Бурхан юм. Тэр зөвхөн израильчуудын, бас зөвхөн иудейчүүдийн ч Бурхан биш; Тэр бол бүх бүтээлийн Бурхан. Түүний ажлын өмнөх хоёр үе шат Израильд явагдсан нь хүмүүст тодорхой үзлийг бий болгожээ. Ехова Өөрийн ажлыг Израильд хийсэн, Есүс Өөрөө ажлаа Иудейд хэрэгжүүлсэн, түүнчлэн Тэр ажиллахын тулд махбод болсон—ямар ч байсан энэ ажил Израилиас цааш дэлгэрээгүй гэж тэд боддог. Бурхан египетчүүд эсвэл энэтхэгчүүдийн дунд ажиллаагүй; Тэр израильчуудын дунд л ажиллаж байсан. Тиймээс хүмүүс янз бүрийн үзэл бий болгож, Бурханы ажлыг тодорхой цар хүрээгээр хязгаарладаг. Тэд, Бурхан ажиллахдаа, сонгогдсон хүмүүсийн дунд, Израильд ажиллах ёстой; Бурхан израильчуудаас өөр хэн дээр ч ажилладаггүй, Түүний ажилд үүнээс илүү том цар хүрээ гэж үгүй гэдэг. Тэд бие махбодтой болсон Бурханыг дэгтэй байлгах тухайд нэн хатуу чанд байж, Израилийн хил хязгаараас цааш явахыг Түүнд зөвшөөрдөггүй. Энэ бүгд ердөө л хүний үзэл бус уу? Бурхан тэнгэр, газар, бүх зүйлийг бүгдийг бүтээж, бүх бүтээлийг бүтээсэн учраас Тэр Өөрийн ажлыг зөвхөн Израилиар хязгаарлаж яахан болох билээ? Тийм байсан бол Тэр бүх бүтээлийг бүтээхийн хэрэг юу байх билээ? Тэр дэлхийг бүхэлд нь бүтээсэн, Тэр Өөрийн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөг зөвхөн Израильд ч биш, харин орчлон ертөнц дээрх хүн бүрд хэрэгжүүлсэн. Хятад, Америкийн Нэгдсэн Улс, Нэгдсэн Вант Улс, эсвэл Орост амьдардгаас үл хамааран хүн бүр Адамын үр удам; тэднийг бүгдийг нь Бурхан бүтээсэн. Тэднээс нэг нь ч Бурханы бүтээлийн хил хязгаараас зугтаж, нэг нь ч “Адамын үр удам” хэмээх хаяг шошгоос ангижирч чадахгүй. Тэд бүгд Бурханы бүтээгдсэн зүйл, бүгд Адамын үр сад, мөн бүгд Адам, Ева хоёрын ялзарсан үр удам юм. Бурханы бүтээл бол зөвхөн израильчууд ч биш, харин бүх хүн; ердөө л зарим нь хараагдаж, зарим нь ерөөгдсөн билээ. Израильчуудын тухайд олон хүлээн зөвшөөрмөөр зүйл байдаг; тэд хамгийн бага ялзарсан байсан учраас Бурхан эхэндээ тэдэн дээр ажиллаж байв. Хятадуудыг тэдэнтэй харьцуулшгүй; хавьгүй илүү дорд муу. Тиймээс Бурхан анхандаа Израилийн ард түмний дунд ажилласан бөгөөд Түүний ажлын хоёр дахь үе шат нь зөвхөн Иудейд хэрэгжсэн юм. Энэ нь хүний дунд олон үзэл, дүрэм журам гарахад хүргэсэн. Үнэндээ, хэрвээ хүний үзлийн

дагуу үйлдсэн бол Бурхан зөвхөн израильчуудын л Бурхан байх байсан, ийм учраас Тэр Өөрийн ажлыг Харь үндэстнүүдэд дэлгэрүүлж чадахгүй байх байсан, учир нь Тэр бүх бүтээлийн Бурхан биш, зөвхөн израильчуудын Бурхан байх байсан юм. Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд алдаршиж, Харь үндэстнүүдэд түгэх болно гэж зөгнөлд хэлсэн. Яагаад ингэж зөгнөсөн бэ? Хэрвээ Бурхан зөвхөн израильчуудын Бурхан байсан бол Тэр Израильд л ажиллах байв. Цаашлаад, Тэр энэ ажлыг түгээхгүй, ийм зөгнөлийг айлдахгүй байх байлаа. Тэр энэ зөгнөлийг айлдсан учраас Харь үндэстнүүдийн дунд болоод бүх улс үндэстэн, газар нутагт Өөрийн ажлыг гарцаагүй дэлгэрүүлнэ. Нэгэнт Тэр үүнийг хэлсэн учраас Тэр үүнийг хийх ёстой; энэ бол Түүний төлөвлөгөө, учир нь Тэр тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээсэн Эзэн, бүх бүтээлийн Бурхан билээ. Тэр израильчуудын дунд, эсвэл бүх Иудей даяар ажиллаж байна уу гэдгээс үл хамааран Түүний хийдэг ажил нь бүх орчлон ертөнцийн, бүх хүн төрөлхтний ажил юм. Агуу улаан лууны улс орон—Харь үндэстэнд Түүний өнөөдрийн хийж буй ажил нь бас л бүх хүн төрөлхтний ажил билээ. Израиль нь газар дээрх Түүний ажлын суурь байж болно; үүний адилаар Хятад улс ч гэсэн Харь үндэстнүүдийн дундах Түүний ажлын суурь болж болно. “Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд алдарших болно” гэсэн зөгнөлийг Тэр одоо биелүүлсэн бус уу? Харь үндэстнүүдийн дундах Түүний ажлын эхний алхам нь агуу улаан лууны улс оронд хийж байгаа Түүний энэ ажил юм. Тэрхүү бие махбодтой болсон Бурхан энэ газар нутагт ажиллаж, энэ хараагдсан хүмүүсийн дунд ажиллах ёстой нь ялангуяа хүний үзэлтэй нийцдэггүй; энэ хүмүүс бол хамгийн дорд, ямар ч үнэ цэнгүйн дээр тэд анх Еховад хаягдсан билээ. Хүмүүс бусад хүнд хаягдаж болно, харин тэд Бурханд хаягдсан бол хамгийн дорд байр суурьтай, хамгийн дорд үнэ цэнтэй байдаг. Бурханы бүтээгдсэн зүйлийн хувьд, Сатанд эзэмдүүлж, бусад хүнд хаягдах нь маш зовлонтой санагддаг зүйл боловч, бүтээгдсэн зүйл Бүтээгчдээ хаягдана гэдэг нь тэд үүнээс дорд байр суурьтай болох боломжгүй гэсэн үг юм. Моабын үр удам хараагдаж, энэхүү харанхуй бүдүүлэг улсад төрсөн; Харанхуйн нөлөөнд байдаг бүх хүнээс Моабын үр удам л эргэлзээгүй хамгийн дорд байр суурьтай. Энэ хүмүүс эдүгээ хүртэл хамгийн дорд байр суурьтай байсан учраас тэдэнд хийгдсэн ажил хүний үзлийг эвдэж хамгийн сайн чаддаг бөгөөд мөн Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнд бүхэлд нь хамгийн үр ашигтай юм. Энэ хүмүүсийн дунд ийм ажил хийх нь хүний үзлийг эвдэх хамгийн сайн арга зам бөгөөд үүгээрээ Бурхан эрин үеийг эхлүүлдэг; үүгээр Тэр хүний

бүх үзлийг эвддэг; үүгээр Тэр Нигүүлслийн эрин үе даяарх ажлыг төгсгөдөг. Түүний анхны ажил Израилийн хил хязгаар дотор Иудейд хэрэгжсэн; Тэр эрин үеийг эхлүүлэх ямар ч ажлыг Харь үндэстнүүдийн дунд хийгээгүй. Ажлын эцсийн үе шат нь зөвхөн Харь үндэстнүүдийн дунд хэрэгжээд зогсохгүй, хараагдсан хүмүүсийн дунд илүү их хэрэгждэг. Энэ нэг зүйл бол Сатаныг хамгийн их гутаан доромжлох боломжтой нотолгоо учраас Бурхан, орчлон ертөнц дээрх бүх бүтээлийн Бурхан, бүх зүйлийн Эзэн, амьтай бүхний хувьд шүтэн мөргөх объект нь “болдог”.

Бурхан ямар шинэ ажил эхлүүлснийг одоо ч ойлгоогүй хүмүүс өнөөдөр бий. Харь үндэстнүүдийн дунд Бурхан шинэ эхлэлийн үүдийг нээсэн. Тэр шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг санаачилсан, Тэр энэ ажлыг Моабын үр удам дээр гүйцэтгэдэг. Энэ Түүний хамгийн шинэ ажил бус уу? Түүхэнд хэн ч энэ ажлыг өмнө нь туулж байгаагүй. Үүнийг ойлгох нь байтугай хэн ч энэ талаар сонсож байгаагүй. Бурханы мэргэн ухаан, Бурханы гайхамшиг, Бурханы ойлгогдошгүй байдал, Бурханы агуу байдал, Бурханы ариун байдал бүгд ажлын энэ үе шат буюу эцсийн өдрүүдийн ажлаар дамжин илрэхэд хүрдэг. Хүний үзлийг эвдэх шинэ ажил энэ бус уу? “Бурхан Моабыг харааж, Моабын үр удмыг хаях болно гэж хэлсэн байхад одоо яаж тэднийг аварч болох юм бэ?” хэмээн боддог хүмүүс бий. Эдгээр нь Бурханы хараасан, Израилиас хөөгдөн гарсан Харь үндэстнүүд юм; израильчууд тэднийг “Харийн ноход” гэж нэрлэж байсан. Хүн бүрийн үзэл бодлоор бол, тэд зөвхөн Харийн ноход байгаад зогсохгүй, бүр долоон дор, сүйрлийн хөвгүүд юм; өөрөөр хэлбэл, тэд Бурханы сонгосон хүмүүс биш. Тэд Израилийн газар нутаг дотор төрсөн боловч Израилийн ард түмэнд харьяалагддаггүй бөгөөд Харь үндэстнүүд рүү хөөгдсөн. Тэд бол хамгийн дорд хүмүүс юм. Тэд хүн төрөлхтний дундаас хамгийн дорд нь учраас л Бурхан шинэ эрин үеийг эхлүүлэх ажлаа тэдний дунд хэрэгжүүлдэг, учир нь тэд ялзарсан хүн төрөлхтний төлөөлөгч билээ. Бурханы ажил сонголттой агаад зорилготой; өнөөдөр энэ хүмүүст хийж буй Түүний ажил нь мөн бүтээл дээр гүйцэтгэдэг ажил юм. Ноа Бурханы бүтээсэн зүйл байсан, түүний үр удам ч мөн адил. Дэлхий дээрх мах, цуснаас бүтсэн хэн боловч Бурханы бүтээсэн зүйл билээ. Бурханы ажил бүх бүтээлд чиглэдэг; бүтээгдсэнийхээ дараа хараагдсан эсэхээс энэ нь хамаардаггүй. Түүний удирдлагын ажил нь хараагдаагүй, сонгогдсон хүмүүст зөвхөн биш, бүх бүтээлд чиглэдэг. Бурхан Өөрийн ажлыг бүтээлийнхээ дунд хэрэгжүүлэхийг хүсдэг тул Тэр үүнийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь гарцаагүй, Тэрээр Өөрийнх нь ажилд ашиг тустай хүмүүсийн дунд ажиллана.

Тиймээс хүмүүсийн дунд ажиллахдаа Тэрээр бүх тогтсон ёсыг эвддэг; Түүний хувьд “хараагдсан”, “гэсгээгдсэн”, “ерөөгдсөн” гэдэг үг ямар ч утгагүй! Иудей хүмүүс бол сайн, Израилийн сонгогдсон хүмүүс ч бас адил; тэд бол сайн хэв чанар, хүн чанартай хүмүүс мөн. Ехова эхэндээ Өөрийн ажлыг тэдний дунд эхлүүлж, Өөрийн хамгийн анхны ажлыг гүйцэтгэсэн, гэхдээ өнөөдөр тэдэн дээр байлдан дагуулах ажлыг гүйцэтгэх нь утгагүй байх байлаа. Хэдийгээр тэд бас бүтээлийн нэг хэсэг, тэдэнд олон эерэг зүйл байж болох ч ажлын энэ үе шатыг тэдний дунд гүйцэтгээд утгагүй байх болно; Бурхан хүмүүсийг байлдан дагуулж чадахгүй, бас бүх бүтээлийг үнэмшүүлж ч чадахгүй байх болно. Ийм л учраас агуу улаан лууны улс орны хүмүүст Өөрийн ажлыг шилжүүлэх хэрэгтэй юм. Үүний хамгийн чухал ач холбогдол нь, Тэрээр эрин үеийг эхлүүлж, бүх дүрэм журам, хүний үзлийг эвдэж, Нигүүлслийн эрин үеийн ажлыг бүхэлд нь дуусгах билээ. Хэрвээ Түүний одоогийн ажил израильчуудын дунд явагдсан бол, Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө эцэс болох үед Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан, израильчууд л Бурханы сонгосон хүмүүс, израильчууд л Бурханы ерөөл, амлалтыг өвлөх эрхтэй гэж хүн бүхэн бодох байв. Эцсийн өдрүүдэд агуу улаан лууны улсын Харь үндэстэнд бие махбодтой болсон Бурхан, Бурхан бол бүх бүтээлийн Бурхан хэмээх ажлыг гүйцэлдүүлдэг; Тэрээр Өөрийн удирдлагын ажлыг бүхэлд нь гүйцээж, агуу улаан лууны улс оронд Өөрийн ажлын гол хэсгийг дуусгадаг. Ажлын энэ гурван үе шатны гол цөм нь хүнийг аврах—тухайлбал, бүх бүтээл Бүтээгчид шүтэн мөргөдөг болгох юм. Тиймээс ажлын үе шат бүр асар их утга учиртай; Бурхан утга учиргүй, үнэ цэнгүй юу ч хийхгүй. Нэг талаар, ажлын энэ үе шат нь шинэ эрин үеийн үүдийг нээж, өмнөх хоёр эрин үеийг төгсгөдөг; нөгөө талаар энэ нь, хүний бүх үзэл болоод хүний итгэл, мэдлэгийн бүх хуучин арга замыг эвддэг. Өмнөх хоёр эрин үеийн ажил хүний өөр үзлийн дагуу явагдсан; энэ үе шат нь харин хүний үзлийг бүрэн таягдан хаяж, ингэснээрээ хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулна. Моабын үр удмыг байлдан дагуулснаар, Моабын үр удмын дунд явагдсан ажлаар дамжуулан Бурхан орчлон ертөнц даяарх бүх хүнийг байлдан дагуулна. Түүний ажлын энэхүү үе шатны гүн гүнзгий ач холбогдол, Түүний ажлын энэ үе шатны хамгийн үнэ цэнтэй тал нь энэ юм. Байр суурь чинь дорд, үнэ цэн чинь доогуур гэдгээ одоо мэдсэн ч гэсэн чи хамгийн баяр хөөртэй зүйлтэй учирсан гэдгээ мэдрэх болно: Чи асар их ерөөл өвлөж, үлэмж их амлалтыг хүлээж авсны дээр Бурханы энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд тусалж чадна. Чи Бурханы жинхэнэ төрхийг харсан, Бурханы төрөлх зан чанарыг мэддэг, Бурханы хүслийг

биелүүлдэг. Бурханы ажлын өмнөх хоёр үе шат Израильд явагдсан. Хэрвээ эцсийн өдрүүд дэх Түүний ажлын энэ үе шат мөн л израильчуудын дунд явагдсан бол зөвхөн израильчууд л Бурханы сонгосон хүмүүс юм байна гэж бүх бүтээл бодоод зогсохгүй, Бурханы удирдлагын төлөвлөгөө ч бас бүхэлдээ хүссэн үр дүндээ хүрч чадахгүй. Түүний ажлын хоёр үе шат Израильд явагдаж байх үед, Харь үндэстнүүдийн дунд ямар ч шинэ ажил, бас шинэ эринийг эхлүүлэх ямар ч ажил явагдаагүй. Өнөөдрийн ажлын үе шат—шинэ эринийг эхлүүлэх ажлыг эхлээд Харь үндэстнүүдийн дунд явуулдаг бөгөөд улмаар эхлээд Моабын үр удам дунд хэрэгжүүлж, ингэснээрээ бүхэл бүтэн эрин үеийг эхлүүлдэг. Бурхан хүний үзэл дотор агуулагддаг аливаа мэдлэгийг сүйтгэж, нэгийг ч үлдээхийг зөвшөөрөөгүй. Тэрээр Өөрийн байлдан дагуулах ажилдаа хүний үзлийг, тэдгээр хүний мэдлэгийн хуучин, эртний арга замыг сүйтгэсэн. Бурхан байхад ямар ч дүрэм журам байхгүй, Бурханы юу нь ч хуучин биш, Түүний хийдэг ажил бол бүхэлдээ чөлөөлөгдсөн, бүхэлдээ эрх чөлөөтэй бөгөөд Түүний хийдэг бүхэн зөв гэдгийг Тэр хүмүүст харуулдаг. Бүтээлийн дунд Түүний хийдэг ямар ч ажилд ч бүрэн захирагдах ёстой. Түүний хийдэг бүх ажил утга учиртай бөгөөд хүний сонголт, үзлийн дагуу биш, харин Түүний хүсэл, мэргэн ухааны дагуу хийгддэг. Тэр Өөрийнх нь ажилд ач тустай зүйлсийг л хийдэг; хэрвээ ямар нэг зүйл Түүний ажилд ашиг тусгүй бол хэчнээн сайн байсан ч Тэр үүнийг хийхгүй! Тэр Өөрийн ажлын утга учир, зорилгын дагуу ажлынхаа хүлээн авагч болон байршлыг сонгож ажилладаг. Тэр ажиллаж байхдаа өнгөрсөн үеийн дүрмийг баримталдаггүй, хуучин хэв загварыг ч дагадаггүй. Харин Тэр ажлын ач холбогдлын дагуу Өөрийн ажлыг төлөвлөдөг. Эцэст нь Тэр жинхэнэ үр дүн, хүлээсэн зорилгодоо хүрнэ. Хэрвээ чиг эдгээр зүйлийг өнөөдөр ойлгохгүй бол энэхүү ажил чамд ямар ч үр нөлөө үзүүлэхгүй.

АМЖИЛТ ЭСВЭЛ БҮТЭЛГҮЙТЭЛ НЬ ХҮНИЙ АЛХДАГ ЗАМААС ХАМААРДАГ

Ихэнх хүмүүс ирээдүйн хүрэх газрынхаа төлөө, эсвэл түр зуурын зугаа цэнгэлийн төлөө Бурханд итгэдэг. Ямар ч харьцалт туулаагүй хүмүүсийн хувьд тэнгэрт орохын төлөө, шагнал хүртэхийн төлөө Бурханд итгэдэг. Тэд төгс болгуулахын төлөө, эсвэл Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхийн төлөө Бурханд итгэдэггүй. Өөрөөр хэлбэл, ихэнх хүн өөрсдийн хариуцлагыг биелүүлэхийн тулд юм уу өөрсдийн үүргийг гүйцэтгэхийн тулд Бурханд

итгэдэггүй. Утга учиртай амьдралаар амьдрахын тулд Бурханд итгэдэг хүмүүс ховорхон, мөн хүн амьд байгаа тул Бурханыг хайрлах ёстой, учир нь энэ нь Тэнгэрээр тогтоогдож, газраар зөвшөөрөгдсөн бөгөөд хүний хүлээсэн үүрэг мөн гэж итгэдэг хүмүүс байдаггүй. Ийм маягаар, хэдийгээр өөр өөр хүмүүс өөрсдийн хувийн зорилгыг эрэлхийлдэг боловч тэдний эрэл хайгуулын зорилго болон үүний ар дахь сэдэл бүгд төстэй байдгаас гадна ихэнхийнх нь сүсэг бишрэлийн бай ихээхэн адил байдаг. Сүүлийн хэдэн мянган жилийн турш олон итгэгч нас барсан ба олон итгэгч нас бараад дахин төрсөн. Бурханыг эрж хайдаг хүн ердөө ганц хоёроор зогсохгүй, тэр ч бүү хэл нэг, хоёр мянгаар ч зогсохгүй, гэхдээ энэ хүмүүсийн ихэнх нь өөрсдийн хэтийн ирээдүй, эсвэл ирээдүйн сайн сайхан итгэл найдварынхаа араас хөөцөлддөг. Христэд үнэнч хүмүүс ховорхон. Олон үнэн сүсэгт итгэгч өөрсдийн урхи торонд ороогдон нас нөгчсөн, түүнчлэн ялалт авчирсан хүмүүсийн тоо ч өчүүхэн бага. Өнөөг хүртэл, хүмүүсийн бүтэлгүйдэг шалтгаан, эсвэл ялалтын нууцыг хүмүүс мэдэхгүй хэвээр байгаа. Христийг эрж хайхад донтсон хүмүүс одоо ч сэхээрээгүй, эдгээр нууцын үнэн мөнийг олж мэдээгүй, учир нь тэд ердөө мэддэггүй. Хэдий тэд эрэл хайгуулдаа уйгагүй хүчин чармайлт гаргадаг ч тэдний алхдаг зам нь амжилтын зам биш, харин өмнөх үеийнхнийх нь нэгэнтээ алхаж байсан бүтэлгүйтлийн зам юм. Ийм маягаар, хэрхэн эрж хайснаас үл хамааран тэд харанхуй руу хөтөлдөг замаар алхдаггүй гэж үү? Тэдний олж авдаг зүйл гашуун үр жимс биш гэж үү? Өнгөрсөн үед амжилтад хүрсэн хүмүүсийг дуурайдаг хүмүүст эцэстээ зол завшаан тохиолдох уу, эсвэл гай гамшиг тохиолдох уу гэдгийг урьдчилан таамаглахад хэцүү. Тэгвэл бүтэлгүйтсэн хүмүүсийн мөрийг даган эрж хайдаг хүмүүсийн хувьд хэчнээн дор байх вэ? Тэд бүр ч их бүтэлгүйтэх боломжтой бус уу? Тэдний алхдаг замд ямар үнэ цэн байх билээ? Тэд цагаа дэмий үрж байгаа бус уу? Хүмүүс эрэл хайгуулдаа амжилтад хүрэх, эсвэл бүтэлгүйтэхээс үл хамааран, товчхондоо үүнд шалтгаан байдаг ба тэдний амжилт эсвэл бүтэлгүйтэл нь дур зоргоороо эрж хайснаар тодорхойлогддог биш юм.

Хүний Бурханд итгэх итгэлийн хамгийн үндсэн шаардлага нь үнэнч шударга зүрх сэтгэлтэй байж, өөрийгөө бүрэн зориулж, үнэхээр дуулгавартай байх явдал юм. Хүний хувьд, жинхэнэ итгэлийн хариуд бүх амьдралаа өгч, үүгээр дамжуулан бүхий л үнэнийг олж авч, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэх нь хамгийн хэцүү байдаг. Энэ нь бүтэлгүйдэг хүмүүсийн хүршгүй зүйл бөгөөд Христийг олж чаддаггүй хүмүүсийн хувьд бүр ч хүршгүй юм. Хүн өөрийгөө Бурханд бүрэн зориулахдаа тийм ч сайн биш учраас, Бүтээгчийн өмнө үүргээ

биелүүлэхийг хүсдэггүй учраас, үнэнийг харсан ч үүнээс зайлсхийж, өөрийн замаар явдаг учраас, үргэлж бүтэлгүйтсэн хүмүүсийн замыг даган эрж хайдаг учраас, мөн Тэнгэрийг үргэлж эсэргүүцдэг учраас дандаа бүтэлгүйтэж, Сатаны заль мэхэнд үргэлж автаж, өөрийнхөө урхи торонд ордог. Хүн Христийг мэддэггүй учраас, үнэнийг ойлгож, туулахдаа чадамгай биш учраас, Паулыг дэндүү их шүтэж, тэнгэрт хэтэрхий их шунадаг учраас, өөрт нь дуулгавартай байхыг Христээс үргэлж шаардаж, Бурханд тушаадаг учраас тэр агуу хүмүүс болон дэлхий ертөнцийн эрээн барааныг туулсан хүмүүс мөн л үхдэг бөгөөд Бурханы гэсгээлт дунд насан эцэслэдэг. Тийм хүмүүс эмгэнэлт үхлээр үхдэг ба тэдний үр дагавар буюу үхэл нь үндэслэлгүй биш юм гэж л Би хэлж чадна. Тэдний бүтэлгүйтэл нь Тэнгэрийн хуулинд бүр ч илүү тэвчишгүй биш гэж үү? Үнэн нь хүний ертөнцөөс үүддэг боловч хүмүүсийн дундах үнэнийг Христ дамжуулдаг. Энэ нь Христээс буюу Бурханаас Өөрөөс нь үүсэн гардаг ба хүний хүрч чадах зүйл биш. Гэхдээ Христ зөвхөн үнэнээр л хангадаг; үнэний төлөөх эрэл хайгуулдаа хүн амжилттай байх эсэхийг шийдэхийн тулд Тэр ирдэггүй. Тиймээс үнэн дэх амжилт, эсвэл бүтэлгүйтэл нь бүгд хүний эрэл хайгуулаас хамаардаг. Хүн үнэнд амжилт олох уу, эсвэл бүтэлгүйтэх үү гэдэг нь хэзээ ч Христтэй хамаатай байгаагүй, харин энэ нь хүний эрэл хайгуулаар тодорхойлогддог. Хүний хүрэх газар, түүний амжилт, эсвэл бүтэлгүйтлийг Бурханд хариуцуулж, Бурханд Өөрт нь үүрүүлж болохгүй, учир нь энэ бол Бурханы Өөрийн асуудал биш, харин Бурханы бүтээлүүдийн биелүүлэх ёстой үүрэгтэй шууд холбоотой. Ихэнх хүмүүс Паул, Петр хоёрын эрэл хайгуул болон хүрэх газрын талаар бага зэрэг мэддэг ч Петр, Паул хоёрын үр дүнгээс өөрийг мэддэггүй ба Петрийн амжилтын ар дахь нууцыг, эсвэл Паулыг бүтэлгүйтэхэд хүргэсэн дутагдлыг мэддэггүй. Иймээс хэрвээ та нар тэдний эрэл хайгуулын мөн чанарыг нэгд нэггүй ойлгож огт чадахгүй бол олонхын чинь эрэл хайгуул ч бас бүтэлгүйтнэ, та нараас цөөн хэд нь амжилтад хүрсэн ч гэсэн Петртэй эн тэнцүү байж мөн л чадахгүй. Хэрвээ эрэл хайгуулын чинь зам зөв бол амжилтад хүрэх найдвар чамд байна; хэрвээ үнэнийг эрж хайн явж байгаа зам чинь буруу бол чи үүрд амжилтад хүрч чадахгүй байх ба Паултай адил төгсгөлтэй тулгарна.

Петр төгс болгуулсан хүн байв. Тэрээр гэсгээлт, шүүлт туулж, Бурханыг гэх цэвэр хайрыг олж авсныхаа дараа л бүрэн дүүрэн төгс болгуулсан; түүний алхсан зам нь төгс болгуулах зам байлаа. Өөрөөр хэлбэл, Петрийн алхсан зам бүр эхнээсээ л зөв байсан ба Бурханд итгэх сэдэл нь зөв байсан, иймээс тэр төгс болгуулсан нэгэн болж, урьд өмнө нь хүний хэзээ ч алхаж байгаагүй шинэ

замаар явсан юм. Харин Паулын алхсан зам эхнээсээ л Христийг эсэргүүцэх зам байсан бөгөөд Ариун Сүнс түүнийг ашиглаж, билиг авьяас, бүх давуу талыг нь Өөрийн ажилд ашиглахыг хүссэн учраас л тэр Христийн төлөө хэдэн арван жил ажилласан билээ. Тэрээр ердөө л Ариун Сүнсний ашигласан хүн байсан бөгөөд Есүс түүний хүн чанарт нааштай хандсанаас болж биш, харин билиг авьяасаасаа болж ашиглагдсан юм. Тэр цохигдсон учраас л Есүсийн төлөө ажиллаж чадсан болохоос биш, үүнийг хийхдээ баяртай байсан юм биш. Ариун Сүнсний гэгээрэл, удирдамжаас болж тэр ийм ажил хийж чадсан бөгөөд хийсэн ажил нь түүний эрэл хайгуулыг юм уу хүн чанарыг яавч төлөөлөөгүй. Паулын ажил зарцын ажлыг төлөөлж байсан, өөрөөр хэлбэл, тэрээр элчийн ажил хийсэн юм. Харин Петр өөр байлаа: Тэр ч бас зарим нэг ажил хийсэн; энэ нь Паулын ажил шиг агуу байгаагүй ч тэрээр өөрийн оролтыг эрэлхийлэх зуураа ажилласан бөгөөд түүний ажил Паулын ажлаас өөр байв. Петрийн ажил нь Бурханы бүтээлийн үүргийг биелүүлсэн явдал байсан юм. Тэр элчийн байр сууринаас ажиллаагүй, харин Бурханыг хайрлахаар эрэлхийлэнгээ ажилласан билээ. Ажлынх нь явцад Паулд бас хувийн эрэл хайгуул байсан: Түүний эрэл хайгуул гагцхүү ирээдүйн итгэл найдвар болон сайхан хүрэх газрын төлөөх хүслийнх нь төлөө байсан юм. Ажлынхаа үеэр тэр цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, мөн харьцалт, засалтыг ч хүлээн зөвшөөрөөгүй. Хийсэн ажил нь Бурханы хүслийг хангаж, хийсэн бүхэн нь Бурханд таалагдсаар байгаа цагт эцэстээ түүнийг шагнал хүлээж байгаа гэж итгэсэн. Түүний ажилд ямар ч хувийн туршлага байгаагүй—энэ нь бүхэлдээ ажиллахын төлөө хийгдсэн бөгөөд өөрчлөгдөх эрэл хайгуулын дунд хийгдээгүй. Түүний ажил дахь бүх юм наймаа байсан, харин Бурханы бүтээлийн үүрэг юм уу дуулгавартай байдлын алийг ч агуулаагүй. Өөрийнх нь ажлын явцад Паулын хуучин зан чанарт ямар ч өөрчлөлт гараагүй. Түүний ажил ердөө бусдад үйлчлэх явдал байсан ба зан чанарт нь өөрчлөлт гаргаж чадаагүй юм. Паул төгс болгуулалгүйгээр, мөн харьцалт туулалгүйгээр шууд ажилласан ба шагнал авах гэсэн сэдэлтэй байв. Петр бол өөр байлаа: Тэрээр засалт, харьцалт туулсан, цэвэршүүлэлт туулсан хүн байв. Петрийн ажлын зорилго болон сэдэл нь үндсэндээ Паулынхаас өөр байсан юм. Хэдийгээр Петр их хэмжээний ажил хийгээгүй ч зан чанарт нь олон өөрчлөлт гарсан ба эрж хайсан зүйл нь үнэн болон бодит өөрчлөлт байлаа. Түүний ажил зүгээр л гагцхүү ажлын төлөө хийгдээгүй. Паул хэдийгээр их ажил хийсэн ч энэ нь бүхэлдээ Ариун Сүнсний ажил байсан бөгөөд Паул энэ ажилд хамтран ажилласан хэдий ч үүнийг туулаагүй. Ариун Сүнс өөрөөр нь дамжуулж

их ажил хийгээгүй учраас л Петр хавьгүй бага ажил хийсэн юм. Тэдний ажлын хэмжээ төгс болгуулсан эсэхийг нь тодорхойлоогүй; нэгнийх нь эрэл хайгуул шагнал авахын төлөө байсан, нөгөөгийнх нь Бурханы хүслийг хангалуун байлгахын тулд хайр татам дүр төрхийг амьдран харуулж чадах хэмжээнд Бурханыг гэх туйлын хайранд хүрч, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхийн төлөө байсан юм. Гаднаа тэд өөр байсан, мөн чанар нь ч бас өөр байсан. Хэр их ажил хийсэнд нь үндэслээд тэдний хэн нь төгс болгуулсныг чи тодорхойлж чадахгүй. Петр Бурханыг хайрладаг нэгний дүрийг амьдран харуулахыг, Бурханыг дуулгавартай дагадаг нэгэн байхыг, харьцалт, засалтыг хүлээн зөвшөөрдөг нэгэн байхыг, Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлдэг нэгэн байхаар эрэлхийлсэн. Тэрээр өөрийгөө Бурханд зориулж, өөрийгөө бүхэлд нь Бурханы гарт даатгаж, үхэх хүртлээ Түүнд дуулгавартай байж чадсан юм. Энэ нь түүний хийхээр шийдсэн зүйл, түүнчлэн түүний биелүүлсэн зүйл байлаа. Түүний төгсгөл эцэстээ яагаад Паулынхаас өөр байсны үндсэн шалтгаан нь энэ юм. Петрт Ариун Сүнсний хийсэн ажил нь түүнийг төгс болгохын төлөө байсан бөгөөд Паулд хийсэн ажил нь түүнийг ашиглахын төлөө байсан. Яагаад гэвэл, тэдний уг чанар болон эрэл хайгуулын талаарх үзэл бодол адилхан байгаагүй юм. Хоёулаа Ариун Сүнсний ажилтай байсан. Петр энэ ажлыг өөртөө хэрэгжүүлж, бас үүгээр бусдыг хангасан; харин Паул Ариун Сүнсний ажлыг бүхэлд нь бусдад өгөөд, өөрөө үүнээс юу ч олж аваагүй. Ийм маягаар Ариун Сүнсний ажлыг маш олон жил туулсны дараа ч Паулд гарсан өөрчлөлт нь бараг байхгүйтэй адил байв. Тэрээр бараг төрөлх байдлаараа үлдсэн ба урьдын Паул хэвээрээ байлаа. Олон жилийн ажлын хүнд хэцүүг туулсныхаа дараа тэр ердөө хэрхэн “ажиллахыг” сурч, тэвчээртэй байж сурсан боловч түүний хуучин уг чанар—ихэд өрсөлддөг, ашиг хонжоонд шунадаг уг чанар нь хэвээр үлдсэн юм. Маш олон жил ажилласныхаа дараа тэрээр завхарсан зан чанараа мэдээгүй, хуучин зан чанараасаа ч салж чадаагүй бөгөөд эдгээр нь түүний ажлаас илт харагдсаар байв. Түүнд ердөө арай илүү ажлын туршлага байсан боловч тийм өчүүхэн туршлага нь дангаараа түүнийг өөрчилж чадаагүй ба оршин тогтнолын талаарх түүний үзэл бодлыг, эсвэл эрэл хайгуулынх нь ач холбогдлыг өөрчилж чадаагүй. Тэрээр Христийн төлөө олон жил ажиллаж, Эзэн Есүсийг дахин хэзээ ч хяхан хавчаагүй хэдий ч түүний зүрх сэтгэл дэх Бурханы талаарх мэдлэгт ямар ч өөрчлөлт гараагүй. Өөрөөр хэлбэл, тэр өөрийгөө Бурханд зориулахын тулд ажиллаагүй, харин ирээдүйн хүрэх газрынхаа төлөө албан хүчээр ажилласан гэсэн үг юм. Учир нь эхэндээ тэр Христийг хяхан хавчиж байсан бөгөөд Христэд

дуулгавартай байгаагүй; тэрээр Христийг зориуд эсэргүүцдэг төрөлхийн тэрслүү хүн, мөн Ариун Сүнсний ажлын талаар ямар ч мэдлэггүй хүн байлаа. Өөрийнх нь ажил бараг дуусаж байх үед тэрээр Ариун Сүнсний ажлыг мэдэхгүй хэвээр байсан бөгөөд Ариун Сүнсний хүсэлд өчүүхэн төдий ч анхаарал хандуулалгүйгээр, зүгээр л зан авирынхаа дагуу дур зоргоороо үйлдсэн юм. Иймээс түүний уг чанар Христэд дайсагнаж байсан ба үнэнийг дуулгавартай дагаагүй. Ариун Сүнсний ажилд хаягдсан, Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, бас Христийг эсэргүүцдэг ийм хүн яаж аврагдаж чадах юм бэ? Хүн аврагдаж чадах уу, үгүй юу гэдэг нь хэр их ажил хийснээс, эсвэл хэр их зориулснаас хамаардаггүй, харин Ариун Сүнсний ажлыг мэддэг эсэхээр, үнэнийг хэрэгжүүлж чаддаг эсэхээр болон эрэл хайгуулын талаарх үзэл бодол нь үнэнтэй нийцдэг эсэхээр тодорхойлогддог.

Петр Есүсийг дагаж эхэлсний дараа төрөлхийн илчлэлүүд тохиолдсон хэдий ч уг чанартаа тэрээр анхнаасаа Ариун Сүнсэнд захирагдаж, Христийг эрж хайх хүсэлтэй нэгэн байсан юм. Тэрээр Ариун Сүнсэнд жинхэнээсээ дуулгавартай байв: Тэр нэр алдар, эд хөрөнгө хөөгөөгүй, харин үнэнд дуулгавартай байхаар зорьж байлаа. Петр хэдийгээр Христийг мэддэг гэдгээ гурван удаа үгүйсгэж, Эзэн Есүсийг сорьсон ч хүний тийм өчүүхэн сул тал нь түүний уг чанартай ямар ч холбоогүй байсан ба ирээдүйн эрэл хайгуулд нь нөлөөлөөгүй, мөн түүний сорилт антихристийн үйл байсан гэдгийг хангалттай баталж чадахгүй. Хүний хэвийн сул тал бол дэлхий дээрх бүх хүнд байдаг зүйл—Петр өөр байх ёстой гэж чи бодож байна уу? Петр хэд хэдэн тэнэг алдаа хийсэн учраас хүмүүс түүний талаар тодорхой үзэл бодол өвөрлөдөг бус уу? Паулын хийсэн бүх ажил, бичсэн бүх захидлаас болж хүмүүс Паулыг ихэд биширдэг бус уу? Хүн яаж хүний мөн чанарыг нэвт харж чадах юм бэ? Үнэхээр эрүүл ухаантай хүмүүс тийм ялихгүй зүйлийг харж чадна биз дээ? Петрийн олон жилийн шаналгаат туршлага нь Библид тэмдэглэгдээгүй хэдий ч Петрт бодитой туршлага байгаагүй, эсвэл Петр төгс болгуулаагүй гэдгийг энэ нь нотолдоггүй. Бурханы ажлыг хүн яаж бүрэн ухан ойлгож чадах юм бэ? Библи дэх бичвэрүүдийг Есүс биечлэн сонгоогүй, харин дараагийн үеийнхэн эмхэтгэсэн. Тийм болохоор Библид бичигдсэн бүхнийг хүний санаагаар сонгосон бус уу? Түүнчлэн Петр, Паул хоёрын төгсгөлийг захидлуудад тодорхой өгүүлээгүй, иймээс хүн өөрийн үзэмжээр, мөн өөрийн дур сонирхлоор Петр, Паул хоёрыг үнэлдэг. Паул маш их ажил хийсэн учраас, түүний “хувь нэмэр” асар их байсан учраас тэрээр олон нийтийн итгэлийг олсон. Хүн зөвхөн өнгөц байдалд

анхаарал хандуулдаггүй гэж үү? Хүн яаж хүний уг чанарыг нэвт харах чадвартай байх юм бэ? Үүнээс гадна, Паул олон мянган жилийн турш шүтлэг бишрэлийн бай байсан болохоор түүний ажлыг хэн яаран үгүйсгэж зүрхлэх юм бэ? Петр ердөө л загасчин байсан, иймээс түүний хувь нэмэр яаж Паулынх шиг их байж чадах юм бэ? Тэдний оруулсан хувь нэмрийн тухайд бол Паул Петрээс өмнө шагнуулах ёстой байсан ба Паул Бурханы сайшаалыг хүртэхэд илүү тохирсон нэгэн байх ёстой байлаа. Паулд хандахдаа Бурхан ердөө л билиг авьяасаар нь дамжуулан түүнийг ажиллуулсан, харин Бурхан Петрийг төгс болгосон гэж хэн төсөөлж чадах билээ? Ямартай ч Эзэн Есүс бүр эхнээсээ л Петр, Паул хоёрын төлөө төлөвлөгөө зохиосон юм биш: Харин ч тэд төрөлхийн уг чанарынхаа дагуу төгс болгуулж, эсвэл ажилласан юм. Иймээс хүмүүсийн хардаг зүйл нь ердөө хүний гадаад талын хувь нэмэр байдаг байхад Бурханы хардаг зүйл нь хүний мөн чанар, түүнчлэн эхнээсээ хүний эрэлхийлдэг зам болон хүний эрэл хайгуулын ар дахь сэдэл юм. Хүмүүс өөрсдийн үзлийн дагуу, өөрсдийн үзэмжээр хүнийг хэмждэг ч хүний эцсийн төгсгөл нь түүний харагдах байдлаар тодорхойлогддоггүй. Иймээс хэрвээ эхнээсээ дагадаг зам чинь амжилтын зам бөгөөд эрэл хайгуулын талаарх үзэл бодол чинь анхнаасаа зөв бол чи Петртэй адил; хэрвээ алхаж буй зам чинь бүтэлгүйтлийн зам бол ямар ч төлөөс төлсөн бай, хүрэх газар чинь Паулынхтай адилхан байх болно гэж Би хэлдэг. Ямар ч тохиолдолд, чиний хүрэх газар болон амжилтад хүрэх үү, бүтэлгүйтэх үү гэдэг чинь хоёулаа чиний зориулалтаас, эсвэл төлсөн төлөөсөөс биш, харин эрж хайж байгаа зам чинь зөв үү, үгүй юу гэдгээр тодорхойлогддог. Петр, Паул хоёрын мөн чанар, зорьсон зорилго өөр байсан; хүн эдгээр зүйлийг олж мэдэх чадваргүй бөгөөд Бурхан л тэдгээрийг бүхэлд нь мэдэж чадна. Учир нь Бурхан хүний мөн чанарыг хардаг байхад хүн өөрийнхөө мөн чанарын талаар юу ч мэддэггүй. Хүн, хүний доторх мөн чанарыг юм уу бодит биеийн хэмжээг нь харах чадваргүй, тиймээс Паул, Петр хоёрын бүтэлгүйтэл болон амжилтын шалтгааныг тодорхойлох чадваргүй юм. Ихэнх хүн Петрийг биш, Паулыг шүтдэгийн шалтгаан нь Паул олон нийтийн ажлын төлөө ашиглагдсан ба хүн энэ ажлыг харж чаддаг тул хүмүүс Паулын “гавьяаг” хүлээн зөвшөөрдөг. Харин Петрийн туршлага хүнд харагддаггүй, түүний эрж хайсан зүйл хүний хувьд хүршгүй тул хүн Петрийг огт сонирхдоггүй.

Петр харьцалт, цэвэршүүлэлт туулснаар төгс болгуулсан. Тэрээр: “Би цаг ямагт Бурханы хүслийг хангалуун байлгах ёстой. Хийж байгаа бүхэндээ би зөвхөн Бурханы хүслийг хангахаар эрж хайдаг ба гэсгээгдэж, шүүгдэж байсан ч

үүнийг баяртайяа хийнэ” гэж хэлсэн юм. Петр өөрт байгаа бүхнийг Бурханд өгсөн ба түүний ажил, үг, бүхий л амьдрал тэр чигтээ Бурханыг хайрлахын төлөө байв. Тэр бол ариун байдлыг эрж хайдаг хүн байсан бөгөөд туршлагажих тусам түүний зүрх сэтгэлийн гүн дэх Бурханыг гэх хайр улам их болж байлаа. Харин Паул зөвхөн гадна талын ажил хийсэн бөгөөд хэдийгээр шаргуу ажилласан ч түүний ажил хөдөлмөр ажлаа зохих ёсоор хийж, улмаар шагнал авахын төлөө байсан юм. Ямар ч шагнал авч чадахгүй гэдгээ мэдэж байсан бол тэр өөрийн ажлыг орхих байв. Петр өөрийн зүрх сэтгэл доторх жинхэнэ хайрыг л анхаарч байсан бөгөөд тэр нь бодитой, мөн биелүүлж болохуйц зүйл байлаа. Тэр шагнал авах эсэх талаар анхаараагүй, харин өөрийнх нь зан чанар өөрчлөгдөж чадах эсэхийг анхаарсан. Паул бүр ч илүү шаргуу ажиллах талаар анхаарч, гадна талын ажил, зориулалт болон хэвийн хүмүүсийн туулдаггүй хоосон сургаалын талаар анхаарсан. Тэрээр зүрх сэтгэлийнхээ гүн дэх өөрчлөлтийг ч, Бурханыг гэх жинхэнэ хайрыг ч огт анхаараагүй. Петрийн туршлага нь Бурханыг гэх жинхэнэ хайр, жинхэнэ мэдлэгт хүрэхийн төлөө байв. Түүний туршлага нь Бурхантай илүү ойр дотно харилцаатай болж, бодитоор амьдран харуулахын төлөө байжээ. Паулын ажил нь Есүсийн даалгасан зүйлээс болсон ба өөрийн хүсэн эрмэлзэж байсан зүйлийг олж авахын төлөө байсан ч эдгээр нь өөрийнхөө талаарх болон Бурханы талаарх мэдлэгтэй нь хамаагүй байв. Түүний ажил гагцхүү гэсгээлт, шүүлтээс зугтахын төлөө байсан. Петрийн цэвэр ариун хайрыг эрж хайж, Паул зөвт байдлын титмийг эрж хайжээ. Петр Ариун Сүнсний ажлыг олон жил туулсан бөгөөд Христийн талаар бодитой мэдлэгтэй, түүнчлэн өөрийнхөө талаар гүн гүнзгий мэдлэгтэй байсан. Иймээс Бурханыг гэх түүний хайр цэвэр байв. Олон жилийн цэвэршүүлэлт нь Есүс болон амийн талаарх түүний мэдлэгийг дээшлүүлсэн ба түүний хайр нөхцөлгүй хайр, идэвх санаачилгатай хайр байсан, тэрээр хариуд нь юу ч гуйгаагүй, ямар нэг ашиг тус хүртэнэ гэж ч найдаагүй. Паул олон жилийн турш ажилласан мөртөө Христийн талаар асар их мэдлэг эзэмшээгүй бөгөөд өөрийнх нь талаарх түүний мэдлэг ч бас өчүүхэн бага байлаа. Түүнд Христийг гэх хайр ердөө байгаагүй ба түүний ажил, явсан замнал нь эцсийн нэр хүндийг олж авахын төлөө байсан. Түүний эрж хайсан зүйл хамгийн цэвэр хайр биш, харин хамгийн сайхан титэм байв. Тэр идэвхтэйгээр эрж хайгаагүй, харин ч идэвхгүй байсан; тэр үүргээ биелүүлээгүй, харин Ариун Сүнсний ажилд баригдсанаа дараа албан хүчээр эрж хайсан юм. Иймээс тэр бол шаардлага хангасан Бурханы бүтээл байсан гэдгийг эрэл хайгуул нь нотолдоггүй; харин Петр бол өөрийн үүргийг биелүүлж,

Бурханы шаардлагыг хангасан бүтээл байлаа. Бурханд хувь нэмрээ оруулсан бүх хүн шагнал хүртэх ёстой ба хувь нэмэр хэдий чинээ их байна, Бурханы тааллыг хүртэх нь төдий чинээ баталгаатай гэж хүн боддог. Хүний үзэл бодлын мөн чанар нь арилжаа наймааны шинжтэй байдаг бөгөөд Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд идэвхтэйгээр эрж хайдаггүй. Бурханы хувьд, хүмүүс Бурханыг гэх жинхэнэ хайр болон Бурханд бүрэн дуулгавартай байдлыг эрж хайх тусам, өөрөөр хэлбэл, Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлэхээр эрж хайх тусам, Бурханы сайшаалыг төдий чинээ хүртэж чадна. Бурханы үзэл бодол бол анхдагч үүрэг болон байр сууриа сэргээхийг хүнээс шаардах явдал юм. Хүн бол Бурханы бүтээл, иймээс хүн Бурханд ямар нэгэн шаардлага тавьж даврах ёсгүй ба Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхээс өөрийг хийх ёсгүй. Паул, Петр хоёрын хүрэх газар хувь нэмрийнх нь хэмжээгээр биш, харин Бурханы бүтээлийн үүргээ биелүүлж чадсан эсэхээр хэмжигдсэн; тэдний хүрэх газар нь хэр их ажил хийсэн, эсвэл бусад хүмүүс тэднийг хэрхэн үнэлсний дагуу биш, харин анхнаасаа юу эрж хайснаар нь тодорхойлогдсон. Иймээс Бурханы бүтээлийн хувиар өөрийн үүргийг идэвхтэйгээр биелүүлэхээр хичээх нь амжилтад хүрэх зам; Бурханыг гэх жинхэнэ хайрын замыг эрж хайх нь хамгийн зөв зам; хуучин зан чанараа өөрчилж, Бурханыг гэх цэвэр хайрыг эрж хайх нь амжилтад хүрэх зам юм. Амжилтад хүрэх ийм зам нь Бурханы бүтээлийн анхдагч үүргээ, түүнчлэн анхдагч дүр төрхөө сэргээх зам юм. Энэ нь сэргэлтийн зам бөгөөд түүнчлэн эхнээсээ эцэс хүртэлх Бурханы бүх ажлын зорилго билээ. Хэрвээ хүний эрэл хайгуулд хувийн хэмжээлшгүй шаардлага болон зохисгүй хүсэл эрмэлзэл нь холилдвол үүгээр хүрэх үр дүн хүний зан чанарыг өөрчилж чадахгүй. Энэ нь сэргэлтийн ажилтай зөрөлддөг бөгөөд Ариун Сүнсний хийдэг ажил биш гэдэг нь эргэлзээгүй тул ийм төрлийн эрэл хайгуулыг Бурхан хүлээн зөвшөөрдөггүй гэдгийг нотолдог. Бурханы хүлээн зөвшөөрдөггүй эрэл хайгуул ямар ач холбогдолтой байх юм бэ?

Паулын хийсэн ажил хүний өмнө харагдсан, харин зүрх сэтгэлийнх нь гүн дэх Бурханыг гэх хайр хэр цэвэр байсан, Бурханыг хэр их хайрласан бэ гэдэг нь хүний харж чадахгүй зүйл юм. Хүн түүний хийсэн ажлыг л харж чаддаг ба түүнийг Ариун Сүнс гарцаагүй ашиглаж байсан гэдгийг л мэддэг тул чуулгануудыг хангаж чаддаг байсан болохоор Паул Петрээс илүү дээр байсан, ажил нь илүү их байсан гэж боддог. Петр хувийн туршлагадаа л анхаарч, ховорхон ажлынхаа явцад цөөн хэдэн хүнийг л олж авсан. Түүний цөөн хэдхэн, бараг хүн мэдэхгүй захидал байдаг боловч зүрх сэтгэлийнх нь гүн дэх Бурханыг

гэсэн хайр хэр их байсныг хэн мэдэх билээ? Паул өдөр бүр Бурханы төлөө ажилласан: Хийх ажил байгаа л бол тэр хийсэн. Ийм маягаар титмийг авч, Бурханыг хангалуун байлгаж чадна гэж түүнд санагдсан, гэхдээ ажлаараа дамжуулан өөрийгөө өөрчлөх арга замыг эрж хайгаагүй. Петр амьдралдаа Бурханы хүслийг хангаагүй л бол сэтгэл нь тавгуйтдэг байв. Бурханы хүслийг хангаагүй л бол тэр харуусаж, Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгахаар чармайж чадах тохиромжтой арга замыг эрж хайдаг байлаа. Өөрийнхөө амьдралын хамгийн бага, хамгийн ялихгүй талуудад хүртэл тэрээр Бурханы хүслийг хангахыг өөрөөсөө шаардсаар байсан юм. Хуучин зан чанарынхаа тухайд бол тэр бүр ч хатуу чанга байж, үнэнд илүү гүнзгий орохын тулд өөртөө тавьсан шаардлагадаа бүр ч нарийн чанд хандаж байлаа. Паул зөвхөн өнгөц нэр төр, байр суурийг л эрж хайсан. Тэр хүмүүсийн өмнө онгирохоор хичээсэн бөгөөд амийн оролтод илүү гүнзгий орохоор эрж хайгаагүй. Тэрээр бодит байдал биш, хоосон номлолыг л анхаарч байв. “Паул Бурханы төлөө маш их ажил хийсэн, гэтэл Бурхан яагаад түүнийг дурсан санадаггүй юм бэ? Петр Бурханы төлөө багахан ажил гүйцэтгэсэн, чуулгануудад их хувь нэмэр оруулаагүй, тэгвэл Бурхан яагаад түүнийг төгс болгосон юм бэ?” гэж зарим хүн хэлдэг. Петр Бурханыг тодорхой хэмжээнд хайрласан бөгөөд үүнийг Бурхан шаардсан; зөвхөн ийм хүмүүс л гэрчлэлтэй байдаг. Тэгвэл Паул ямар вэ? Паул Бурханыг ямар хэмжээнд хайрласан бэ? Паулын ажил юуны төлөө байсан бэ? Мөн Петрийн ажил юуны төлөө байсан бэ? Петр тийм ч их ажил хийгээгүй, гэхдээ түүний зүрх сэтгэлийн гүнд юу байсныг чи мэдэх үү? Паулын ажил чуулгануудыг хангаж, чуулгануудыг дэмжихтэй хамаатай байв. Петрийн туулсан зүйл бол өөрийнх нь амь зан чанарын өөрчлөлт байсан; тэрээр Бурханыг гэх хайрыг туулсан юм. Чи тэдний мөн чанар дахь ялгааг мэдсэн болохоор эцсийн эцэст хэн нь үнэхээр Бурханд итгэснийг болон хэн нь Бурханд үнэхээр итгээгүйг харж чадна. Тэдний нэг нь Бурханыг үнэхээр хайрласан, нөгөө нь Бурханыг үнэхээр хайрлаагүй; нэг нь зан чанартаа өөрчлөлт гаргасан, нөгөө нь тэгээгүй; нэг нь даруухнаар үйлчилсэн ба хүмүүст амар анзаарагдаагүй, харин нөгөөх нь хүмүүсээр шүтэгдсэн, агуу нэр хүндтэй байсан; нэг нь ариун байдлыг эрж хайсан, нөгөөх нь тэгээгүй, хэдий тэр бузар биш байсан ч цэвэр хайрыг эзэмшээгүй; нэг нь жинхэнэ хүн чанартай, нөгөө нь тийм биш байсан; нэг нь Бурханы бүтээлийн эрүүл ухааныг эзэмшсэн, нөгөөх нь тэгээгүй. Энэ нь Паул, Петр хоёрын мөн чанар дахь ялгаа юм. Петрийн алхсан зам нь амжилтын зам байсан, бас хэвийн хүн чанарыг сэргээж, Бурханы бүтээлийн үүргээ сэргээх зам

байсан. Петр амжилттай бүх хүнийг төлөөлдөг. Паулын алхсан зам нь бүтэлгүйтлийн зам бөгөөд өнгөц төдий захирагдаж, өөрсдийгөө зарлагаддаг, Бурханыг жинхэнээсээ хайрладаггүй бүх хүнийг төлөөлдөг. Паул үнэнийг эзэмшээгүй бүх хүнийг төлөөлдөг. Бурханд итгэх итгэлдээ Петр бүх зүйл дээр Бурханыг хангалуун байлгахаар эрж хайсан ба Бурханаас ирсэн бүхэнд дуулгавартай хандахаар хичээсэн. Тэрээр өчүүхэн төдий ч гомдолгүйгээр гэсгээлт, шүүлт, түүнчлэн цэвэршүүлэлт, гай зовлон, амьдралынхаа гачигдлыг хүлээн зөвшөөрч чадсан бөгөөд эдгээрийн юу ч Бурханыг гэх хайрыг нь өөрчилж чадаагүй. Энэ нь Бурханыг гэсэн туйлын хайр байсан бус уу? Бурханы бүтээлийн үүргийг биелүүлсэн бус уу? Гэсгээлт, шүүлт, гай зовлонгийн үед ч чи үргэлж үхэх хүртлээ дуулгавартай байж чадах бөгөөд энэ нь Бурханы бүтээлийн хүрэх ёстой зүйл, мөн Бурханыг гэх хайрын цэвэр ариун байдал юм. Хэрвээ хүн ийм түвшинд хүрч чадах юм бол Бурханы бүтээл байхад тохирох бөгөөд Бүтээгчийн хүслийг үүнээс илүү хангалуун байлгах юу ч үгүй. Чи Бурханы төлөө ажиллаж чаддаг гэж төсөөл, гэхдээ чи Бурханд дуулгавартай ханддаггүй ба Бурханыг үнэхээр хайрлах чадваргүй. Ийм маягаар чи Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхгүйгээр үл барам Бурханаар яллагдана, учир нь чи үнэнийг эзэмшдэггүй, Бурханд дуулгавартай байх чадваргүй, Бурханд дуулгаваргүй хүн юм. Чи Бурханы төлөө ажиллах талаар л анхаардаг бөгөөд үнэнийг хэрэгжүүлэх, эсвэл өөрийгөө мэдэх талаар анхаардаггүй. Бүтээгчийг ойлгодоггүй, мэддэггүй бөгөөд Бүтээгчид дуулгавартай байдаггүй, мөн Түүнийг хайрладаггүй. Чи бол төрөлхийн Бурханд дуулгаваргүй хүн, иймээс тийм хүмүүсийг Бүтээгч хайрладаггүй.

Зарим хүн: “Паул тоймгүй их хэмжээний ажил хийсэн ба чуулгануудын төлөө асар их ачаа үүрч, маш их хувь нэмэр оруулсан. Паулын арван гурван захидал нь Нигүүлслийн эрин үеийн 2,000 жилд дэмжлэг үзүүлсэн ба Дөрвөн Сайн Мэдээний дараа ордог. Түүнтэй эн зэрэгцэж чадах хэн байх юм бэ? Иоханы Илчлэлийг хэн ч тайлж чаддаггүй байхад Паулын бичсэн захидлууд амиар хангадаг, түүний хийсэн ажил чуулгануудад ач тустай байсан. Өөр хэн ийм зүйлийг биелүүлж чадах вэ? Тэгэхэд Петр ямар ажил хийсэн юм бэ?” гэдэг. Хүн бусдыг хувь нэмрийнх нь дагуу хэмждэг. Бурхан хүнийг хэмжихдээ уг чанарынх нь дагуу ханддаг. Амийг эрж хайдаг хүмүүсийн дундаас Паул өөрийнхөө мөн чанарыг мэддэггүй хүн байсан. Тэрээр огтхон ч даруухан, дуулгавартай байгаагүй, Бурханыг эсэргүүцдэг мөн чанараа ч мэддэг байгаагүй. Иймээс тэрээр нарийн ширийн туршлага туулаагүй хүн байсан бөгөөд үнэнийг хэрэгжүүлдэггүй хүн байлаа. Харин Петр өөр байжээ. Тэр өөрийн дутагдал, сул

талыг болон Бурханы бүтээлийн хувиар өөрийн завхарсан зан чанарыг мэддэг байсан тул зан чанараа өөрчилж чадах хэрэгжүүлэлтийн замтай байв; тэрээр зөвхөн хоосон сургаалтай ч бодит байдалгүй хүмүүсийн нэг байгаагүй юм. Өөрчлөгддөг хүмүүс бол аврагдсан шинэ хүмүүс бөгөөд үнэнийг эрэлхийлэхэд тэнцдэг хүмүүс юм. Өөрчлөгддөггүй хүмүүс нь төрөлхийн хоцрогдмол хүмүүст харьяалагддаг; тэд бол аврагдаагүй хүмүүс, өөрөөр хэлбэл, Бурханы жигшин голдог хүмүүс билээ. Тэдний ажил хэчнээн их байсан ч тэднийг Бурхан санахгүй. Чи үүнийг өөрийнхөө эрэл хайгуултай харьцуулах үед эцсийн эцэст Петр шиг хүн үү, Паул шиг хүн үү гэдэг чинь илэрхий байх учиртай. Хэрвээ чиний эрэл хайгуулд ямар ч үнэн байхгүй хэвээр бол, мөн өнөөдөр ч гэсэн чи Паул шиг биеэ тоосон, эрээ цээргүй, уран ярьж, бардамнадаг хэвээр бол бүтэлгүй өөдгүй хүн гэдэг чинь эргэлзээгүй юм. Хэрвээ чи Петр шиг эрж хайж, хэрэгжүүлэлт болон жинхэнэ өөрчлөлтийг эрэлхийлж, биеэ тоосон юм уу эрх дураараа биш, харин үүргээ биелүүлэхээр зорьдог бол ялалтад хүрч чадах Бурханы бүтээл байх болно. Паул өөрийн мөн чанарыг, эсвэл завхралыг мэдээгүй, дуулгаваргүй байдлаа бүр ч мэдээгүй. Тэрээр Христийг жигшүүртэйгээр эсэргүүцэж байснаа хэзээ ч дурдаагүй, мөн тийм ч их харамсаагүй. Тэрээр зөвхөн товч тайлбар тавьсан ба зүрх сэтгэлийнхээ гүнд Бурханд бүрэн захирагдаагүй. Хэдий тэр Дамаскийн замд хөсөр унасан боловч зүрх сэтгэлийн гүнээс өөрийгөө шинжлээгүй. Тэр ажиллаж байгаа төдийдөө л сэтгэл ханаж байсан бөгөөд өөрийгөө мэдэж, хуучин зан чанараа өөрчлөх нь хамгийн чухал асуудал гэдгийг анхаарч үзээгүй. Тэр ердөө үнэнийг ярьж байгаадаа, мөс чанараа тайтгаруулахын тулд бусдыг хангаж байгаадаа, өөрийгөө тайвшруулж, урьдын нүглээ уучлахын тулд Есүсийн шавь нарыг хавчихаа больсондоо сэтгэл хангалуун байсан. Түүний зорьсон зорилго нь ирээдүйн титэм болон түр зуурын ажлаас цаашгүй байсан, түүний зорьсон зорилго нь үлэмж элбэг нигүүлсэл байсан. Тэрээр хангалттай үнэнийг эрж хайгаагүй, урьд нь ойлгоогүй байсан үнэн рүү илүү гүнзгий орохоор ч эрэлхийлээгүй. Иймээс өөрийнх нь талаарх түүний мэдлэгийг худлаа байсан гэж хэлж болох бөгөөд тэрээр гэсгээлт, шүүлтийг хүлээн зөвшөөрөөгүй. Тэр ажиллаж чаддаг байсан гэдэг нь өөрийн уг чанар, эсвэл мөн чанарыг мэдэж байсан гэсэн үг биш; тэрээр гадна талын хэрэгжүүлэлтэд л анхаарлаа төвлөрүүлж байв. Түүнчлэн, түүний зорьж байсан зүйл нь өөрчлөлт биш, харин мэдлэг байсан юм. Түүний ажил бүхэлдээ Дамаскийн замд Есүс харагдсаны үр дүн байлаа. Энэ нь анхнаасаа түүний хийхээр шийдсэн зүйл байгаагүй, мөн хуучин зан чанар нь засалтыг хүлээн

зөвшөөрсний дараа тохиолдсон ажил ч байгаагүй. Тэр яаж ч ажилласан бай, хуучин зан чанар нь өөрчлөгдөөгүй, иймээс түүний ажил урьдын нүглийг нь цайруулж чадаагүй, харин тухайн үеийн чуулгануудад тодорхой үүрэг гүйцэтгэсэн төдий юм. Хуучин зан чанар нь өөрчлөгдөөгүй ийм хүн—өөрөөр хэлбэл, аврал хүртээгүй хүн бол бүр ч үнэнгүй хүн бөгөөд Эзэн Есүсээр хүлээн зөвшөөрөгдөх хүмүүсийн нэг болж яасан ч чадаагүй. Тэрээр Есүс Христийг гэх хайр, хүндлэлээр дүүрэн хүн биш, үнэнийг эрж хайхдаа чадамгай хүн ч биш бөгөөд бие махбодтой болохын нууцыг эрж хайсан хүн бүр ч биш байлаа. Тэр зүгээр л мушгин маргах чадвартай хүн байсан бөгөөд өөрөөсөө илүү дээр хэнд ч, эсвэл үнэнийг эзэмшсэн хэнд ч бууж өгдөггүй хүн байв. Тэр өөрийнх нь эсрэг байсан, эсвэл өөртэй нь дайсагнаж байсан хүмүүст юм уу үнэнд атаархан, агуу дүр төрхтэй, гүн гүнзгий мэдлэгтэй авьяаслаг хүмүүсийг илүүд үздэг байжээ. Харин үнэн замыг эрж хайдаг, үнэнээс өөр юуг ч анхаардаггүй ядуу дорд хүмүүстэй харилцах дургүй байсан ба оронд нь зөвхөн хоосон сургаал ярьдаг, өргөн их мэдлэг эзэмшсэн шашны байгууллагын ахмад хүмүүстэй харилцдаг байлаа. Тэрээр Ариун Сүнсний шинэ ажлыг огт хайрлаагүй ба Ариун Сүнсний шинэ ажлын хөдөлгөөнийг анхаараагүй. Харин ч ердийн үнэнээс илүү дээгүүр байсан ёс заншил, хоосон сургаал түүнд таалагддаг байв. Өөрийн төрөлх мөн чанар болон эрж хайсан бүхий л зүйлээрээ тэр, Бурханы гэр дэх үнэнч зарц гэгдэх нь бүү хэл, үнэнийг эрж хайсан Христэд итгэгч гэж ч нэрлэгдэх эрхгүй, учир нь түүний хоёр нүүрт зан хэтэрхий их байсан ба дуулгаваргүй байдал нь дэндүү их байсан билээ. Хэдийгээр түүнийг Эзэн Есүсийн зарц гэдэг байсан ч тэр тэнгэрийн хаанчлалын хаалгаар ороход огт тохирохгүй, учир нь эхнээсээ эцэс хүртэлх түүний үйлдлийг зөв шударга гэж хэлж болохгүй. Түүнийг ердөө л хоёр нүүрт нэгэн, зөв шударга бусыг үйлдсэн атлаа бас Христийн төлөө ажилласан нэгэн гэж үзэж болно. Хэдийгээр түүнийг ёрын муу гэж хэлж болохгүй ч зөв шударга бусыг үйлдсэн хүн гэж нэрлэвээс зохилтой. Тэр ихээхэн ажил хийсэн ч хийсэн ажлынхаа хэмжээгээр үнэлэгдэх ёсгүй, харин ажлын чанар болон мөн чанараар л үнэлэгдэх ёстой. Зөвхөн ийм маягаар л энэ асуудлын учрыг нь олох боломжтой. Тэр үргэлж ингэж итгэдэг байсан: “Би ажиллах чадвартай, би ихэнх хүмүүсээс илүү дээр; би хэнээс ч илүүгээр Эзэний ачааг хайхардаг, хэн ч над шиг гүн гүнзгий гэмшдэггүй, учир нь их гэрэл над дээр тусаж, би их гэрлийг харсан, иймээс миний гэмшил өөр хэнийхээс ч илүү гүнзгий.” Тухайн үед тэр зүрх сэтгэл дотроо ингэж бодож байсан юм. Өөрийнхөө ажлын төгсгөлд Паул: “Би тэмцэж, замналаа дуусгасан, надад зориулж зөвт

байдлын титэм зэхэгдсэн байгаа” гэж хэлсэн. Түүний тэмцэл, ажил, замнал нь бүхэлдээ зөвт байдлын титмийн төлөө байсан ба тэр идэвхтэйгээр урагшлаагүй; хэдий тэр өөрийнхөө ажилд хааш яаш хандаагүй боловч түүний ажил ердөө л алдаагаа засаж залруулахын төлөө, мөс чанарынхаа буруушаалтыг болиулахын төлөө байсан гэж хэлж болно. Тэрээр аль болох хурдан ажлаа гүйцэлдүүлж, замналаа дуусгаж, тэмцэлдээ тэмцэхийг л хүсэж найдсан, ингэснээр хүсэн эрмэлзэж байсан зөвт байдлын титмээ илүү хурдан олж авч чадах байсан юм. Түүний хүсэн эрмэлзэж байсан зүйл нь өөрийн туршлага болон жинхэнэ мэдлэгээр Эзэн Есүстэй уулзах биш, харин Эзэн Есүстэй уулзах үедээ хийсэн ажилдаа тохирох шагналыг хүлээн авахын тулд ажлаа аль болох хурдан дуусгах явдал байв. Тэр өөрийгөө тайвшруулж, ирээдүйн титмээр наймаа хийхийн тулд өөрийн ажлыг ашигласан. Түүний эрж хайсан зүйл нь үнэн, эсвэл Бурхан биш, харин зөвхөн титэм байлаа. Тийм эрэл хайгуул яаж стандартад нийцэж чадах юм бэ? Түүний сэдэл, ажил, төлсөн төлөөс болон бүхий л хичээл чармайлтад нь түүний гайхалтай уран зөгнөл шингэсэн ба тэр бүхэлдээ өөрийн хүслийн дагуу л ажилласан. Бүхий л ажилдаа тэрээр төлөөс төлөхдөө өчүүхэн төдий ч дуртай байгаагүй; тэр зүгээр л наймаа хийж байв. Тэрээр үүргээ биелүүлэхийн тулд биш, харин наймааны зорилгод хүрэхийн тулд л дуртайяа хичээл чармайлт гаргасан. Тийм хүчин чармайлтад ямар нэгэн үнэ цэн байгаа юу? Түүний цэвэр бус хичээл чармайлыг хэн сайшаах юм бэ? Тийм хичээл чармайлыг хэн сонирхох юм бэ? Түүний ажил нь ирээдүйн төлөөх мөрөөдлөөр дүүрэн, гайхалтай төлөвлөгөөгөөр дүүрэн байсан ба хүний зан чанарыг өөрчлөх ямар ч замыг агуулаагүй. Түүний сайхан сэтгэлийн ихэнх нь дүр эсгэлт байсан; түүний ажил амиар хангаагүй, харин соёлч боловсон дүр үзүүлж байсан; энэ нь наймаа хийх явдал байсан юм. Ийм ажил нь анхдагч үүргээ сэргээх замд хүнийг хөтөлж яаж чадах юм бэ?

Петрийн эрж хайсан бүхэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байв. Тэр Бурханы хүслийг хангахаар эрэлхийлсэн ба зовлон зүдүүр, гай тогторыг үл хайхран Бурханы хүслийг хангахад бэлэн байлаа. Бурханд итгэгчийн хувьд үүнээс илүү сайн эрэл хайгуул гэж үгүй. Паулын эрж хайсан зүйл өөрийнх нь махан бие, үзэл, төлөвлөгөө, арга ухаантай холилдсон. Тэр яавч шаардлага хангасан Бурханы бүтээл байгаагүй, Бурханы хүслийг хангахаар эрэлхийлсэн хүн ч байгаагүй. Петр Бурханы зохион байгуулалтад захирагдахаар хичээсэн ба хэдийгээр хийсэн ажил нь их биш байсан ч түүний эрэл хайгуулын ар дахь сэдэл болон алхсан зам зөв байсан; хэдий тэр олон хүнийг олж авч чадаагүй ч үнэний

замыг эрэлхийлж чадсан юм. Үүнээс үүдэн, тэр бол шаардлага хангасан Бурханы бүтээл байсан гэж хэлж болно. Өнөөдөр чи ажилчин биш байлаа ч гэсэн, Бурханы бүтээлийн үүргийг биелүүлж, Бурханы бүх зохион байгуулалтад захирагдахаар эрэлхийлж чаддаг байх ёстой. Чи Бурханы хэлсэн бүхэнд дуулгавартай байж, бүх төрлийн гай зовлон, цэвэршүүлэлтийг туулж чаддаг байх ёстой ба сул дорой хэдий ч зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлаж чаддаг байх ёстой. Өөрсдийн амийн төлөө хариуцлага үүрдэг хүмүүс Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхэд бэлэн байдаг ба тийм хүмүүсийн эрэл хайгуулд хандах үзэл бодол зөв байдаг. Эдгээр нь Бурханд хэрэгтэй хүмүүс юм. Хэрвээ чи их ажил хийж, бусад хүмүүс чамаас юм сурч авсан боловч чи өөрөө өөрчлөгдөөгүй, ямар ч гэрчлэл хийгээгүй, эсвэл ямар нэг жинхэнэ туршлагатай болоогүй, тийм болохоор амьдралынхаа эцэст ч гэсэн чиний хийсэн юу ч гэрчлэл хийгээгүй бол чи өөрчлөгдсөн хүн мөн үү? Чи үнэнийг эрж хайдаг хүн мөн үү? Тухайн үед Ариун Сүнс чамайг ашигласан ч чамайг ашиглах үедээ ажилд ашиглаж болох хэсгийг чинь л ашигласан бөгөөд ашиглагдаж болохгүй хэсгийг чинь Тэр ашиглаагүй. Хэрвээ чи өөрчлөгдөхөөр эрж хайсан бол ашиглагдах явцдаа аажмаар төгс болгуулах байсан. Гэсэн ч эцэстээ авхуулж чадах эсэхэд чинь Ариун Сүнс ямар ч хариуцлага хүлээдэггүй бөгөөд энэ нь эрэл хайгуулын чинь байдлаас хамаардаг. Чиний хувийн зан чанарт ямар ч өөрчлөлт байхгүй бол эрэл хайгуулд хандах үзэл бодол чинь буруугаас энэ нь болдог. Хэрвээ чи ямар ч шагнал хүртээгүй бол тэр нь өөрийн чинь асуудал бөгөөд чи өөрөө үнэнийг хэрэгжүүлээгүй, Бурханы хүслийг биелүүлж чаддаггүйгээс болдог. Иймээс чиний хувийн туршлагаас илүү чухал зүйл гэж юу ч үгүй, хувийн оролтоос чинь илүү шийдвэрлэх зүйл гэж юу ч үгүй! Зарим хүн эцэст нь, “Би Таны төлөө маш их ажил хийсэн, хэдийгээр биширмээр амжилт гаргаагүй байж болох ч би хичээнгүйлэн чармайсаар ирсэн. Та намайг зүгээр л тэнгэр лүү аваачиж, амийн жимс идүүлж болохгүй гэж үү?” хэмээн хэлнэ. Би ямар хүмүүсийг хүсдэгийг чи мэдэх ёстой; ариун бус хүмүүс хаанчлалд орохыг зөвшөөрөхгүй, ариун бус хүмүүс ариун газрыг балиартуулахыг зөвшөөрөхгүй. Хэдийгээр чи их ажил хийж, олон жилийн турш ажилласан ч эцэст нь өрөвдмөөр бузар хэвээр байвал Миний хаанчлалд орохыг хүсэх чинь Тэнгэрийн хуулиар тэвчишгүй юм! Дэлхий ертөнц бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл Надад ая тал зассан хүмүүст Би Миний хаанчлалд амархан орох боломжийг хэзээ ч олгож байгаагүй. Энэ бол тэнгэрийн дүрэм бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй! Чи амийг эрж хайх ёстой. Өнөөдөр, төгс болгуулах хүмүүс Петртэй адил төрлийнх юм: Тэд бол зан чанараа

өөрчлөхөөр эрж хайдаг хүмүүс бөгөөд Бурханд гэрчлэл хийж, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхэд бэлэн байдаг хүмүүс юм. Тийм хүмүүс л төгс болгуулна. Хэрвээ чи зөвхөн шагнал горилоод, амь зан чанараа өөрчлөхөөр эрэлхийлдэггүй бол бүх хичээл чармайлт чинь талаар өнгөрнө—энэ бол өөрчлөгдөшгүй үнэн юм!

Петр, Паул хоёрын мөн чанар дахь ялгаанаас чи амийг эрэлхийлдэггүй бүх хүн дэмий хөдөлмөрлөдөг гэдгийг ойлгох ёстой! Чи Бурханд итгэж, Бурханыг дагадаг тул зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлах ёстой. Чи завхарсан зан чанараа хаях ёстой, Бурханы хүслийг биелүүлэхээр эрж хайх ёстой ба Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой. Чи Бурханд итгэж, Бурханыг дагадаг тул бүх зүйлийг Түүнд өргөн барих ёстой ба хувийн сонголт хийж, шаардлага тавих ёсгүй, мөн чи Бурханы хүслийг биелүүлэх ёстой. Чи бүтээгдсэн тул чамайг бүтээсэн Эзэнийг дуулгавартай дагах ёстой, учир нь чи төрөлхөөсөө өөрийгөө захирч чадахгүй бөгөөд хувь заяагаа хянах ямар ч чадваргүй. Чи Бурханд итгэдэг хүн тул ариун байдал болон өөрчлөлтийг эрж хайх ёстой. Нэгэнт чи Бурханы бүтээл тул өөрийн үүргийг мөрдөж, байр сууриа хадгалах ёстой ба үүргээсээ хэтрэн гарах учиргүй. Энэ нь чамайг хязгаарлахын төлөө, эсвэл хоосон сургаалаар чамайг нухчин дарахын төлөө байдаггүй, харин энэ бол үүргээ биелүүлж чадах зам чинь бөгөөд зөв шударгыг үйлддэг бүх хүний хүрч чадах, хүрэх ёстой зам юм. Хэрвээ чи Петр, Паул хоёрын мөн чанарыг харьцуулбал хэрхэн эрж хайх ёстойгоо мэдэх болно. Петр, Паул хоёрын алхсан замын нэг нь төгс болгуулах зам, нөгөө нь таягдан хаягдах зам юм; Петр болон Паул нь хоёр өөр замыг төлөөлдөг. Хэдийгээр аль аль нь Ариун Сүнсний ажлыг хүлээн авч, хоёулаа Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг олж авч, аль аль нь Эзэн Есүсийн даалгасан зүйлийг хүлээн зөвшөөрсөн ч тус бүрээс нь гарсан үр дүн адилхан байгаагүй: Нэг нь үнэхээр үр дүнд хүрсэн ба нөгөө нь тэгээгүй. Тэдний мөн чанараас, хийсэн ажлаас, гаднаа илэрхийлж байсан зүйлээс, тэдний эцсийн төгсгөлөөс чи ямар замаар явах учиртайгаа, аль замыг нь сонгон алхах хэрэгтэйгээ ойлгох ёстой. Тэд гарцаагүй хоёр өөр замаар алхсан. Паул, Петр хоёр зам тус бүрийн хамгийн сайн төлөөлөгч байсан тул бүр анхнаасаа энэ хоёр замын үлгэр жишээ болсон. Паулын туршлагын гол зүйлс юу вэ, тэр яагаад үүндээ хүрээгүй вэ? Петрийн туршлагын гол зүйлс юу вэ, тэр хэрхэн төгс болгуулсан бэ? Хэрвээ чи тус бүрийнх нь анхаарч байсан зүйлсийг харьцуулах юм бол Бурхан яг ямар төрлийн хүнийг хүсдэг, Бурханы хүсэл юу болох, Бурханы зан чанар юу болох, ямар төрлийн хүн эцэстээ төгс болгуулах, мөн

түүнчлэн ямар төрлийн хүн төгс болгуулж чадахгүйг мэднэ; мөн төгс болгуулах хүмүүсийн зан чанар ямар байх, төгс болгуулахгүй хүмүүсийн зан чанар ямар байхыг мэдэх бөгөөд мөн чанарын эдгээр асуудлыг Петр, Паул хоёрын туршлагаас харж болно. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, иймээс Тэр бүх бүтээлийг Өөрийн эрх мэдэл дор оруулж, Өөрийн эрх мэдэл дор захирагдуулдаг; Тэр бүх зүйлийг захирч, бүх зүйлийг Өөрийн гарт байлгана. Амьтан, ургамал, хүн төрөлхтөн, уул, гол нуур зэргийг оролцуулаад Бурханы бүх бүтээл бүгдээрээ Түүний эрх мэдэлд байх ёстой. Тэнгэр дэх болон газар дээрх бүх зүйл Түүний эрх мэдэл дор орох ёстой. Тэдэнд ямар ч сонголт байж болохгүй ба бүгд Түүний зохион байгуулалтад захирагдах ёстой. Үүнийг Бурхан зарлигдсан ба энэ нь Бурханы эрх мэдэл юм. Бурхан бүх зүйлийг захирдаг бөгөөд бүх зүйлийг цэгцэлж, жагсаан, Бурханы хүслийн дагуу төрлийнх нь дагуу ангилж, тус бүрийн байр суурийг нь оноодог. Хэчнээн том байх нь хамаагүй юу ч Бурханыг даван гарч чадахгүй, мөн бүх зүйл Бурханы бүтээсэн хүн төрөлхтөнд үйлчилдэг бөгөөд нэг ч зүйл Бурханд дуулгаваргүй байж, эсвэл Бурханд ямар нэгэн шаардлага тавьж зүрхэлдэггүй. Иймээс Бурханы бүтээл болохын хувьд хүн бас үүргээ биелүүлэх ёстой. Хүн бүх зүйлийн эзэн үү, эсвэл захирагч уу гэдгээс үл хамааран, бүх зүйлийн дундах хүний байр суурь хэчнээн өндөр байх нь хамаагүй тэр бол ердөө Бурханы эрх мэдэл дор буй өчүүхэн хүн, шалихгүй хүн, Бурханы бүтээлээс цаашгүй бөгөөд Бурханаас дээгүүр байж хэзээ ч чадахгүй. Бурханы бүтээл болохын хувьд хүн Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхээр эрж хайж, өөр сонголт хийлгүйгээр Бурханыг хайрлахаар хичээх ёстой, учир нь Бурхан хүний хайрыг хүртвээс зохино. Бурханыг хайрлахаар эрж хайдаг хүмүүс ямар нэг хувийн эрх ашгийг, эсвэл өөрсдийн хүсэн хүлээдэг зүйлийг эрж хайх ёсгүй; энэ нь эрэл хайгуулын хамгийн зөв зүйтэй арга барил юм. Хэрвээ эрж хайдаг зүйл чинь үнэн бол, хэрэгжүүлдэг зүйл чинь үнэн бол, олж авсан зүйл чинь зан чанарын өөрчлөлт бол чиний явж байгаа зам зөв байна. Хэрвээ эрж хайдаг зүйл чинь махан биеийн ерөөл бол, хэрэгжүүлдэг зүйл чинь чиний өөрийн үзлээс гарсан үнэн бол, мөн зан чанарт чинь ямар ч өөрчлөлт гараагүй, махбод дахь Бурханд огтхон ч дуулгаваргүй хандаж, тодорхой бус байдалтай амьдарсаар байгаа бол чиний эрж хайдаг зүйл чамайг гарцаагүй там руу аваачна, учир нь чиний алхдаг зам бүтэлгүйтлийн зам юм. Төгс болгуулах уу, таягдан хаягдах уу гэдэг чинь чиний өөрийн эрэл хайгуулаас хамаардаг, өөрөөр хэлбэл, амжилт эсвэл бүтэлгүйтэл нь хүний алхаж буй замаас хамаардаг.

БУРХАНЫ АЖИЛ БА ХҮНИЙ АЖИЛ

Хүний ажлын хэр их нь Ариун Сүнсний ажил, хэр их нь хүний туршлага байдаг вэ? Хүмүүс эдгээр асуултыг ойлгодоггүй хэвээр гэж хэлж болох ба үүний шалтгаан нь тэд Ариун Сүнсний ажлын зарчмыг ойлгодоггүй. “Хүний ажил” гэж хэлэхдээ Би мэдээж Ариун Сүнсний ажилтай хүмүүс буюу Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийг хэлж байна. Би хүний хүслээс гардаг ажлыг хэлээгүй, харин Ариун Сүнсний ажлын цар хүрээн дотор буй элчүүд, ажилчид, эгэл ах эгч нарын ажлыг хэлж байна. Энд “хүний ажил” гэдэг нь бие махбодтой болсон Бурханы ажлыг биш, харин хүмүүс дээр хийдэг Ариун Сүнсний ажлын цар хүрээ, зарчмыг хэлдэг. Эдгээр зарчим нь Ариун Сүнсний ажлын зарчим, цар хүрээ мөн боловч бие махбодтой болсон Бурханы ажлын зарчим, цар хүрээтэй адилгүй. Хүний ажилд хүний мөн чанар ба зарчим байдаг, харин Бурханы ажилд Бурханы мөн чанар ба зарчим бий.

Ариун Сүнсний урсгал дахь ажил нь Бурханы Өөрийн ажил ч бай, эсвэл ашиглагдаж буй хүмүүсийн ажил ч бай хамаагүй, Ариун Сүнсний л ажил юм. Бурханы Өөрийн мөн чанар бол Сүнс бөгөөд үүнийг Ариун Сүнс, эсвэл долоо дахин эрчимжсэн Сүнс гэж нэрлэж болно. Ямартай ч Тэд бол Бурханы Сүнс юм, харин Бурханы Сүнс өөр өөр эрин үед өөр өөр нэрээр нэрлэгдсэн. Гэхдээ Тэдний мөн чанар нэг хэвээр. Тиймээс, Бурханы Өөрийн ажил бол Ариун Сүнсний ажил; бие махбодтой болсон Бурханы ажил ч Ариун Сүнсний ажлаас өөрцгүй. Ашиглагдаж буй хүмүүсийн ажил ч бас Ариун Сүнсний ажил юм. Гэсэн ч Бурханы ажил бол Ариун Сүнсний бүрэн гүйцэд илэрхийлэл бөгөөд туйлын үнэн, харин ашиглагдаж буй хүмүүсийн ажилд хүний олон зүйл холилдсон байдаг ба Ариун Сүнсний шууд илэрхийлэл биш, Түүний бүрэн гүйцэд илэрхийлэл бүр ч биш. Ариун Сүнсний ажил янз бүр байдаг бөгөөд ямар ч нөхцөлөөр хязгаарлагддаггүй. Ариун Сүнсний ажил нь өөр өөр хүмүүст ялгаатай байдаг; өөр өөр мөн чанарыг харуулдаг; мөн эрин үе, түүнчлэн улс орноор ялгаатай байдаг. Мэдээж Ариун Сүнс олон өөр аргаар, олон зарчмын дагуу ажилладаг хэдий ч тухайн ажлыг яаж хийдэг, эсвэл ямар хүмүүс дээр хийдэг нь хамаагүй, мөн чанар нь үргэлж өөр өөр байдаг; өөр өөр хүмүүс дээр хийдэг бүх ажил нь зарчимтай байдаг ба бүгд өөрсдийнхөө байны мөн чанарыг төлөөлж чаддаг. Учир нь Ариун Сүнсний ажил цар хүрээний хувьд нэлээд тодорхой, нэлээд нарийн хэмжүүртэй байдаг. Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь хүмүүс дээр хийгддэг ажилтай адилгүй бөгөөд ажил хийгдэж буй хүмүүсийн

хэв чанарын дагуу ажил ч бас ялгаатай байдаг. Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь хүмүүс дээр хийгддэггүй бөгөөд энэ нь хүмүүс дээр хийгддэг ажлаас өөр. Товчхондоо, ажил яаж хийгддэг нь хамаагүй, өөр өөр объект дээр хийсэн ажил хэзээ ч адилхан байдаггүй бөгөөд Түүний ажилладаг зарчим нь өөр өөр хүмүүсийн байр байдал, уг чанарын дагуу ялгаатай байдаг. Ариун Сүнс төрөлх мөн чанарт нь үндэслэн өөр өөр хүмүүс дээр ажилладаг бөгөөд тэрхүү мөн чанараас нь хэтэрсэн шаардлагыг тэдэнд тавьдаггүй, төрөлх хэв чанараас нь давсан ажлыг ч тэдэн дээр хийдэггүй. Иймээс, хүн дээр хийдэг Ариун Сүнсний ажил нь тэрхүү ажлын байны мөн чанарыг харах боломжийг хүмүүст олгодог. Хүний төрөлх мөн чанар өөрчлөгддөггүй; төрөлхийн хэв чанар нь хязгаарлагдмал. Ариун Сүнс хүмүүсийн хэв чанарын хязгаарлалтад нийцүүлэн хүмүүсийг ашиглаж, эсвэл тэдэн дээр ажилладаг болохоор хүмүүс ашиг тусыг нь хүртэж болох юм. Ашиглагдаж буй хүмүүс дээр Ариун Сүнс ажиллах үед тэр хүмүүсийн бүхий л авьяас чадвар, төрөлхийн хэв чанар юу ч үлдэлгүйгээр гарч ирдэг. Тэдний төрөлхийн хэв чанар тухайн ажилд үйлчлэхэд хэрэглэгддэг. Тэрхүү ажлаар үр дүнд хүрэхийн тулд Тэрээр хүмүүсийн ашиглаж болох хэсгүүдийг ажилдаа ашигладаг гэж хэлж болох юм. Эсрэгээрээ, Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь Сүнсний ажлыг шууд илэрхийлдэг бөгөөд хүний оюун санаа, бодол холилдоогүй; хүний авьяас билиг ч, хүний туршлага ч, эсвэл төрөлхийн нөхцөл байдал ч үүнд хүрч чадахгүй. Ариун Сүнсний тоймгүй олон ажил бүгд хүнд ач тусаа өгч, хүнийг босгон байгуулах учиртай. Гэхдээ зарим хүн төгс болгуулж чаддаг байхад бусад нь төгс болгуулах нөхцөл байдлыг эзэмшээгүй байдаг, өөрөөр хэлбэл, тэд төгс болгуулж чадахгүй, бараг аврагдаж чадахгүй ба хэдийгээр тэдэнд Ариун Сүнсний ажил байсан байж болох ч эцэст нь таягдан хаягддаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнсний ажил хүмүүсийг босгон байгуулахын төлөө байдаг хэдий ч Ариун Сүнсний ажилтай байсан бүх хүн бүрмөсөн төгс болгуулна гэж хэлж болохгүй, учир нь олон хүний эрэл хайгуулдаа дагадаг зам нь төгс болгуулах зам биш байдаг. Тэдэнд Ариун Сүнсний нэг талын ажил л байдаг, харин хүний субъектив хамтын ажиллагаа ч, зөв эрэл хайгуул ч байдаггүй. Тиймээс, энэ хүмүүс дээрх Ариун Сүнсний ажил нь төгс болгуулж байгаа хүмүүст үйлчилж эхэлдэг. Ариун Сүнсний ажлыг хүмүүс шууд харж чадахгүй, өөрсдөө үүнд шууд хүрч ч чадахгүй. Харин ажиллах авьяас билигтэй хүмүүс л үүнийг илэрхийлж чаддаг ба хүмүүсийн илэрхийлдэг илэрхийллээр дамжуулан Ариун Сүнсний ажлыг дагалдагчдад өгдөг гэсэн үг юм.

Ариун Сүнсний ажил нь олон янзын хүмүүс, олон өөр нөхцөл байдлаар дамжин биелж, гүйцэлддэг. Бие махбодтой болсон Бурханы ажил хэдийгээр бүхэл бүтэн эриний ажлыг төлөөлж, бүхий л эрин дэх хүмүүсийн оролтыг төлөөлж чадах боловч хүмүүсийн нарийвчилсан оролт дээрх ажлыг бие махбодтой болсон Бурхан бус, харин Ариун Сүнсний ашигладаг хүмүүс хийх хэрэгтэй хэвээр юм. Тиймээс, Бурханы ажил буюу Бурханы Өөрийн үйлчлэл нь Бурханы махбод болсон биеийн ажил бөгөөд хүн оронд нь хийж чадахгүй. Ариун Сүнсний ажил нь өөр төрлийн олон хүнээр дамжин гүйцэлддэг; ганцхан хүн үүнийг бүрэн биелүүлж чадахгүй, ганцхан хүн бүрмөсөн илэрхийлж ч чадахгүй. Чуулгануудыг удирддаг хүмүүс ч бас Ариун Сүнсний ажлыг бүрэн төлөөлж чадахгүй; тэд зарим нэг удирдах ажлыг л хийж чадна. Тиймээс Ариун Сүнсний ажлыг, Бурханы Өөрийн ажил, ашиглагдаж буй хүмүүсийн ажил болон Ариун Сүнсний урсгалд байгаа бүх хүн дээрх ажил хэмээх гурван хэсэгт хувааж болно. Бурханы Өөрийн ажил бүхий л эринийг удирдан чиглүүлэх явдал; ашиглагддаг хүмүүсийн ажил нь Бурханыг ажлаа хийсний дараа илгээгдэх юм уу даалгавар хүлээн авснаар Бурханы бүх дагалдагчийг удирдан хөтлөх явдал бөгөөд тэд бол Бурханы ажилтай хамтран ажилладаг хүмүүс юм; урсгалд байгаа хүмүүс дээр Ариун Сүнсний хийдэг ажил нь Өөрийн бүх ажлыг хадгалах буюу Өөрийн бүхий л удирдлага болон гэрчлэлийг хадгалахын сацуу төгс болгуулж чадах хүмүүсийг төгс болгох явдал юм. Энэ гурван хэсэг нь хамтдаа Ариун Сүнсний бүрэн гүйцэд ажил боловч Бурханы Өөрийн ажилгүйгээр удирдлагын ажил тэр чигтээ зогсонги байдалд орно. Бурханы Өөрийн ажил бүх хүн төрөлхтний ажлыг хамардаг ба энэ нь бас бүхэл бүтэн эриний ажлыг төлөөлдөг. Өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн ажил нь Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн, чиг хандлага бүрийг төлөөлдөг, харин элч нарын ажил нь Бурханы Өөрийн ажлын дараа явагдаж, араас нь дагадаг ба эрин үеийг удирддаггүй, мөн бүхий л эрин дэх Ариун Сүнсний ажлын чиг хандлагыг ч төлөөлдөггүй. Тэд хүний хийх учиртай ажлыг л хийдэг бөгөөд энэ нь удирдлагын ажилтай ямар ч хамаагүй байдаг. Бурханы Өөрөө хийдэг ажил бол удирдлагын ажил доторх төсөл юм. Хүний ажил нь зөвхөн ашиглагдаж байгаа хүмүүсийн үүрэг бөгөөд удирдлагын ажилтай холбоогүй. Энэ хоёр хоёулаа Ариун Сүнсний ажил хэдий ч ялгамж чанар болон ажлын төлөөллийн ялгаанаас үүдэн Бурханы ажил болон хүний ажлын хооронд тодорхой, мөн чанарын ялгаа байдаг. Түүнчлэн, өөр өөр ялгамж чанартай байнууд дээр Ариун Сүнсний хийдэг ажлын хэмжээ ялгаатай байдаг. Эдгээр нь Ариун Сүнсний ажлын зарчим ба цар хүрээ юм.

Хүний ажил өөрийнх нь туршлага болон хүн чанарыг төлөөлдөг. Хүний хангадаг зүйл болон хийдэг ажил нь өөрийг нь төлөөлдөг. Хүний ойлголт, үндэслэл, логик болон баялаг төсөөлөл бүгд түүний ажилд агуулагддаг. Ялангуяа хүний туршлага ажлыг нь төлөөлж чаддаг ба хүний туршлага ажлынх нь бүрэлдэхүүн хэсэг болдог. Хүний ажил туршлагыг нь илэрхийлж чадна. Зарим хүн сөргөөр туршлагажих үед тэдний нөхөрлөлийн ихэнх нь сөрөг элементүүдээс бүрдэнэ. Хэрэв хэсэг хугацаанд тэдний туршлага эерэг байж, тэд ялангуяа эерэг талын замыг эзэмшдэг бол нөхөрлөл нь тун зоригжуулам байдаг ба хүмүүс тэднээс эерэг хангалт олж авч чадна. Хэрэв ажилчин хэсэг хугацаанд идэвхгүй болбол нөхөрлөл нь үргэлж сөрөг элементүүдийг тээнэ. Ийм нөхөрлөл дарамттай бөгөөд түүний нөхөрлөлийн дараа бусад нь өөрийн эрхгүй сэтгэлээр унана. Дагалдагчдын байр байдал удирдагчийнхаас хамааран өөрчлөгддөг. Ажилчин дотроо ямархуу байна, түүнийгээ л илэрхийлдэг бөгөөд хүний байр байдлаас хамаарч Ариун Сүнсний ажил байнга өөрчлөгддөг. Тэрээр хүний туршлагын дагуу ажиллаж, хүнийг хүчилдэггүй боловч туршлагынх нь хэвийн явцын дагуу хүмүүст шаардлага тавьдаг. Өөрөөр хэлбэл, хүний нөхөрлөл Бурханы үгээс ялгаатай. Хүмүүсийн нөхөрлөдөг зүйл өөрсдийнх нь ойлголт болон туршлагыг дамжуулж, Бурханы ажилд үндэслэсэн ойлголт, туршлагыг нь илэрхийлдэг. Бурханыг ажиллаж, үг хэлсний дараа, юуг хэрэгжүүлж, юунд орох учиртайгаа олж мэдээд, дараа нь дагалдагчдад дамжуулах нь тэдний хариуцлага юм. Тиймээс хүний ажил өөрийнх нь оролт болон хэрэгжүүлэлтийг төлөөлдөг. Мэдээж ийм ажилд хүний сургамж, туршлага, эсвэл зарим нэг бодол холилдсон байдаг. Ариун Сүнс яаж ч ажилласан бай, хүн дээр, эсвэл бие махбодтой болсон Бурхан дээр ажиллах нь хамаагүй, ажилчид үргэлж юу болохоо илэрхийлж байдаг. Хэдийгээр Ариун Сүнс ажиллаж байгаа боловч тухайн ажил хүн төрөлхөөсөө юу болоход суурилдаг, учир нь Ариун Сүнс суурьгүйгээр ажилладаггүй. Өөрөөр хэлбэл, ажил оргүй хоосноос гарч ирдэггүй, харин үргэлж бодит орчин болон бодитой нөхцөл байдлын дагуу хийгддэг. Ийм маягаар л хүний зан чанар өөрчлөгдөж, хуучин үзэл, бодлууд нь өөрчлөгдөж болно. Хүний илэрхийлдэг зүйл нь түүний харж, туулдаг, мөн төсөөлж чадах зүйлс бөгөөд хоосон сургаал, эсвэл үзэл байлаа ч гэсэн, үүнд хүний сэтгэхүйгээр хүрч болохуйц байдаг. Хүний ажил ямар ч хэмжээтэй байсан бай, хүний туршлагын цар хүрээнээс давж чадахгүй, мөн хүний ойлгодог зүйл, эсвэл хүний төсөөлж, ухан ойлгож чадах зүйлийн цар хүрээнээс ч давж чадахгүй. Бурханы илэрхийлдэг зүйл нь Бурхан Өөрөө юу

болох бөгөөд үүнд хүн хүршгүй—өөрөөр хэлбэл, үүнд хүний сэтгэхүйгээр хүрэх аргагүй. Тэрээр бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлэх ажлаа илэрхийлдэг бөгөөд энэ нь хүний туршлагын нарийн учиртай хамаагүй, харин Өөрийнх нь удирдлагатай холбоотой байдаг. Хүн өөрийн туршлагыг илэрхийлдэг бол Бурхан Өөрийн оршихуйг буюу Өөрийн төрөлх зан чанарыг илэрхийлдэг бөгөөд үүнд хүн хүршгүй. Хүний туршлага нь Бурханы оршихуйн илэрхийлэлд тулгуурлан олж авсан ойлголт болон мэдлэг юм. Ийм ойлголт болон мэдлэгийг хүний оршихуй гэдэг бөгөөд хүний төрөлх зан чанар, бодит хэв чанарт үндэслэн илэрхийлэгддэг—ийм учраас тэдгээрийг ч бас хүний оршихуй гэж нэрлэдэг. Хүн үзэж, туулдаг зүйлээ нөхөрлөж чаддаг. Өөрсдийн үзэж туулаагүй зүйлийг, эсвэл сэтгэхүйгээрээ хүрч чадахгүй зүйлийг буюу өөрийнх нь дотор эс орших зүйлсийг хэн ч нөхөрлөж чадахгүй. Хэрвээ хүний илэрхийлдэг зүйл туршлагаас нь гардаггүй бол энэ нь түүний төсөөлөл юм уу хоосон номлол байдаг. Энгийнээр хэлбэл, түүний үгэнд ямар ч бодит байдал байдаггүй. Чи нийгмийн зүйлстэй огтхон ч харилцдаггүй бол нийгмийн төвөгтэй харилцааны талаар тодорхой нөхөрлөж чадахгүй. Хэрвээ чамд гэр бүл гэж байхгүй бол бусад хүмүүс гэр бүлийн асуудлын талаар ярилцах үед чи тэдний ярьж байгаа зүйлсийн ихэнхийг ойлгож чадахгүй. Иймээс хүний нөхөрлөдөг зүйл болон хийдэг ажил нь түүний дотоод оршихуйг төлөөлдөг. Хэрвээ хүн гэсгээлт, шүүлтийн талаарх ойлголтынхоо тухай нөхөрлөсөн боловч чамд энэ талаар ямар ч туршлага байхгүй бол чи түүний мэдлэгийг үгүйсгэж зүрхлэхгүй, тэр ч байтугай үүнд зуун хувь итгэлтэй байж ч зүрхлэхгүй. Яагаад гэвэл, түүний нөхөрлөл бол чиний хэзээ ч туулж байгаагүй, хэзээ ч мэдээгүй зүйл бөгөөд оюун санаа чинь үүнийг төсөөлж чадахгүй. Чи ирээдүйд шүүлт, гэсгээлт туулах замыг л түүний мэдлэгээс авч чадна. Гэхдээ энэ зам нь хоосон онолын мэдлэгийн зам л байж чадна; энэ нь чиний ойлголтыг орлож чадахгүй, туршлагыг чинь орлож бүр ч чадахгүй. Түүний хэлж байгаа зүйл нэлээд зөв юм гэж чи бодож магад боловч энэ нь олон талаар хэрэгжишгүй болохыг өөрийнхөө туршлагаар олж мэддэг. Магадгүй сонсож буй зарим зүйл чинь огт хэрэгжишгүй гэж санагддаг; тухайн үедээ чи энэ талаар үзэл өвөрлөдөг ба үүнийг хүлээн зөвшөөрдөг ч гэсэн маш дурамжхан хийдэг. Харин туршлагажих явцад чамд үзэл өгсөн мэдлэг чиний хэрэгжүүлэлтийн зам болдог ба хэрэгжүүлэх тусмаа чи сонссон үгийнхээ жинхэнэ үнэ цэн, утга учрыг улам бүр ойлгодог. Өөрийн гэсэн туршлагатай болсныхоо дараа чи туулсан зүйлээсээ олж авсан мэдлэгийн тухай ярьж чадна. Түүнчлэн, хэнийх нь мэдлэг жинхэнэ, бодитой, хэнийх нь мэдлэг хоосон

сургаалд тулгуурласан, үнэ цэнгүй болохыг ялгаж чаддаг болно. Иймд чиний ярьдаг мэдлэг үнэнтэй нийцэж байгаа эсэх нь чамд бодит туршлага байгаа эсэхээс ихээхэн хамаардаг. Чиний туршлагад үнэн байгаа цагт мэдлэг чинь бодитой, үнэ цэнтэй байх болно. Туршлагаараа дамжуулан чи бас ялган таних чадвар, ойлголттой болж, мэдлэгээ гүнзгийрүүлж, биеэ хэрхэн авч явах тухай мэргэн ухаан, ерөнхий мэдлэгээ арвижуулж чадна. Үнэнийг эзэмшдэггүй хүмүүсийн илэрхийлсэн мэдлэг хэчнээн сүрлэг байлаа ч гэсэн, хоосон сургаал юм. Энэ төрлийн хүмүүс махан биеийн аливаа асуудалд маш ухаалаг байж болох боловч сүнслэг асуудлын тухайд ялган салгаж чаддаггүй. Учир нь ийм хүмүүст сүнслэг асуудалтай холбоотой туршлага огт байдаггүй билээ. Тэд бол сүнслэг асуудалд гэгээрээгүй, сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй хүмүүс юм. Чи ямар ч төрлийн мэдлэгийг илэрхийлдэг бай, энэ нь чиний оршихуй мөн л бол чиний хувийн туршлага, чиний бодит мэдлэг мөн. Зөвхөн хоосон сургаалын талаар ярьдаг хүмүүс буюу үнэнийг ч, бодит байдлыг ч эзэмшдэггүй хүмүүсийн ярьдаг зүйлийг ч бас тэдний оршихуй гэж хэлж болно, учир нь тэдний сургаал гүн эргэцүүлээс урган гарсан, оюун санааных нь гүн бодлогошролын үр дүн юм—гэхдээ энэ нь ердөө л хоосон сургаал, төсөөллөөс цаашгүй! Янз бүрийн хүмүүсийн туршлага өөрсдийнх нь доторх зүйлсийг төлөөлдөг. Ямар ч сүнслэг туршлагагүй хүн үнэний мэдлэгийн талаар ярьж чадахгүй, янз бүрийн сүнслэг зүйлсийн талаарх зөв мэдлэгийг ч ярьж чадахгүй. Хүн дотор нь байгаа зүйлийг л илэрхийлдэг—энэ нь гарцаагүй. Хэрвээ хүн сүнслэг зүйлс болоод үнэний талаар мэдлэгтэй болохыг хүсвэл бодит туршлагатай байх ёстой. Хэрвээ чи хүний амьдралын ерөнхий мэдлэгийн талаар тодорхой ярьж чадахгүй бол сүнслэг зүйлсийн талаар бүр хэчнээн багыг ярьж чадах билээ? Чуулганыг удирддаг, хүмүүсийг амиар хангадаг, хүмүүст элч болдог хүмүүс бодит туршлагатай байх ёстой; тэд сүнслэг зүйлсийн талаар зөв ойлголттой, үнэний талаар зөв үнэлэлт, туршлагатай байх ёстой. Ийм хүмүүс л чуулганыг удирддаг ажилчид юм уу элчүүд байхад тохирно. Эс бөгөөс тэд зөвхөн хамгийн доод талын дагалдагч болж чадах ба удирдагч болж чадахгүй, хүмүүсийг амиар хангаж чаддаг элч байж бүр ч чадахгүй. Яагаад гэвэл, элч нарын чиг үүрэг нь яаран гүйж, тэмцэхийн төлөө бус, харин аминд үйлчлэх ажил хийж, зан чанараа өөрчлөхөд нь бусдыг удирдахын төлөө байдаг. Энэ чиг үүргийг гүйцэтгэдэг хүмүүс нь хүнд бэрх хариуцлага үүрэх даалгавар авдаг бөгөөд энэ нь хэн бүхний үүрч чадах зүйл биш юм. Ийм ажлыг амийн оршихуйтай буюу үнэний туршлагатай хүмүүс л хийж чадна. Хаяж орхидог, яаран гүйдэг, эсвэл

өөрсдийгөө зарлагадахыг хүсдэг хэн бүхэн үүнийг хийж чадахгүй; үнэний туршлагагүй, засалт, шүүлт амсаагүй хүмүүс энэ төрлийн ажлыг хийж чадахгүй. Ямар ч туршлагагүй, бодит байдалгүй хүмүүс өөрсдөө иймэрхүү оршихуйгүй байдаг учраас бодит байдлыг тодорхой харж чаддаггүй. Иймээс энэ төрлийн хүн удирдах ажил хийж чадахгүйгээр үл барам, удаан хугацаанд үнэнгүй явбал таягдуулах бай болно. Чиний илэрхийлдэг ойлголт амьдралдаа туулсан бэрхшээл, ямар асуудлаар гэсгээгдэж, шүүгдэж байсны чинь нотолгоо болдог. Шалгалтуудын хувьд ч энэ нь бас үнэн юм: Хүний цэвэршүүлэгдсэн зүйл, сул дорой байдаг зүйл нь түүний туулсан зүйл, замтай болсон зүйлс юм. Жишээ нь, хэрвээ хүний гэрлэлт бүтэлгүйтсэн бол тэр үргэлж “Бурханд баярлалаа, Бурханыг магтъя, би Бурханы зүрх сэтгэлийн хүслийг хангалуун байлгаж, нэг насны амьдралаа өргөн барьж, гэрлэлтээ тэр чигт нь Бурханы гарт даатгах ёстой. Би Бурханд бүхий л амьдралаараа дэнчин тавихад бэлэн байна” хэмээн нөхөрлөдөг. Хүний доторх бүх зүйл нь нөхөрлөлөөр дамжуулан, тэр юу болохыг харуулж чаддаг. Тухайн хүний ярианы хурд, чанга, эсвэл аяархан ярьдаг эсэх нь туршлагын асуудал биш учраас түүнд юу байгаа, тэр юу болохыг төлөөлж чадахгүй. Эдгээр зүйл нь тухайн хүний зан араншин болон уг чанар сайн уу, муу юу гэдгийг л хэлж чадах боловч түүнд туршлага байгаа эсэхтэй эн тэнцүү байж чадахгүй. Ярьж байх үедээ өөрийгөө илэрхийлэх чадвар, эсвэл ярианы чадвар болон хурд нь ердөө дадал зуршлаар бий болдог зүйл бөгөөд хүний туршлагыг орлож чадахгүй. Хувийн туршлагынхаа талаар ярих үедээ чи өөрийнхөө чухал гэж үздэг зүйлийг болон дотроо байгаа зүйлийг нөхөрлөдөг. Миний яриа Миний оршихуйг төлөөлдөг боловч Миний хэлдэг зүйлд хүн хүрэхийн аргагүй. Миний хэлдэг зүйл бол хүний туулдаг зүйл биш, мөн хүний харж чадах зүйл биш; мөн хүний хүрч чадах зүйл биш, харин Би юу болох юм. Зарим хүн Миний нөхөрлөдөг зүйлийг үзэж туулсан зүйлс маань гэж л ойлгодог, гэхдээ энэ нь Ариун Сүнсний шууд илэрхийлэл гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Мэдээж Миний хэлдэг зүйлс Миний туулсан зүйл мөн. Би удирдлагын ажлыг зургаан мянган жил хийсэн. Би хүн төрөлхтөн бүтээгдэхээс эхлээд одоог хүртэлх бүхнийг туулсан; Би яаж энэ талаар ярьж чадахгүй байх юм бэ? Хүний уг чанарын тухайд гэвэл Би үүнийг тодорхой харсан; Би үүнийг аль эртнээс ажигласан. Тийм байхад Би яаж үүнийг тодорхой ярьж чадахгүй байх юм бэ? Хүний мөн чанарыг тодорхой харсан тул Би хүнийг гэсгээж, шүүхэд тохирно, учир нь бүх хүн Надаас үүссэн боловч Сатанаар завхруулагдсан. Мэдээж Би бас Өөрийн хийсэн ажлыг үнэлж дүгнэхэд тохирно. Хэдийгээр энэ ажлыг Миний махбод хийгээгүй ч, энэ

нь Сүнсний шууд илэрхийлэл бөгөөд Надад юу байгаа, Би хэн болох юм. Тиймээс Би үүнийг илэрхийлж, Өөрийн хийх учиртай ажлыг хийхэд тохирно. Хүмүүсийн ярьдаг зүйл бол тэдний туулсан зүйлс юм. Энэ нь тэдний үзсэн зүйл, оюун ухаанаараа хүрч чадах зүйл бөгөөд мэдрэхүйгээрээ мэдэрч чадах зүйлс юм. Энэ л тэдний нөхөрлөж чадах зүйл билээ. Бурханы махбод болсон биеийн хэлсэн үг нь Сүнсний шууд илэрхийлэл бөгөөд Сүнсний хийсэн ажлыг илэрхийлдэг. Махбод нь үүнийг туулаагүй, хараагүй ч махбодын мөн чанар нь Сүнс учраас Түүний оршихуйг илэрхийлсээр байдаг ба Тэрээр Сүнсний ажлыг илэрхийлдэг. Махан бие үүнд хүрэх боломжгүй ч энэ нь Сүнсний аль хэдийн хийчихсэн ажил юм. Бие махбодтой болсныхоо дараа Тэрээр махбодын илэрхийллээр дамжуулан хүмүүст Бурханы оршихуйг мэдүүлж, Бурханы зан чанар болон Түүний хийсэн ажлыг харуулдаг. Хүний ажил нь юунд орох ёстой, юу ойлгох хэрэгтэйг хүмүүст илүү тодорхой болгож өгдөг; энэ нь хүмүүсийг үнэний тухай ойлголт, туршлага руу хөтөлдөг. Хүний ажил хүмүүст дэмжлэг үзүүлэхийн төлөө; Бурханы ажил нь хүн төрөлхтөнд шинэ зам, шинэ эринийг нээж, мөнх бус хүмүүсийн мэдэхгүй зүйлсийг хүмүүст илчилж, Бурханы зан чанарыг мэдэх боломж олгохын төлөө байдаг. Бурханы ажил бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлэхийн төлөө байдаг.

Ариун Сүнсний бүх ажил нь хүмүүст ашиг тус хүртээхийн төлөө хийгддэг; Энэ нь бүхэлдээ хүмүүсийг босгон байгуулахын төлөө юм; хүмүүст ашиг тусаа өгдөггүй ажил гэж нэгээхэн ч үгүй. Үнэн гүн гүнзгий ч бай, өнгөцхөн ч бай, мөн үнэнийг хүлээн зөвшөөрдөг хүмүүсийн хэв чанар ямар ч бай хамаагүй, Ариун Сүнсний хийдэг бүхэн хүмүүст ашиг тустай юм. Гэвч Ариун Сүнсний ажил шууд хийгдэх боломжгүй; харин Түүнтэй хамтран ажилладаг хүмүүсээр дамжин илэрхийлэгдэх ёстой. Тэгж байж л Ариун Сүнсний ажил үр дүнтэй болж чадна. Мэдээж Ариун Сүнсийг шууд ажиллах үед энэ нь огт хольцгүй байдаг; харин Ариун Сүнс хүнээр дамжуулан ажиллах үед тун их хольцтой болж, Ариун Сүнсний анхдагч ажил биш болдог. Ийм болохоор үнэн тодорхой хэмжээгээр өөрчлөгддөг. Дагалдагчид Ариун Сүнсний анхдагч санаа зорилгыг биш, харин Ариун Сүнсний ажил болон хүний туршлага, мэдлэгийн хослолыг хүлээн авдаг. Дагалдагчдын хүлээн авч байгаа Ариун Сүнсний ажлын нэг хэсэг нь зөв байдаг, харин ажилчид өөр өөр учраас хүний хүлээн авсан мэдлэг, туршлага ялгаатай байдаг. Ариун Сүнсний гэгээрэл болон удирдамжтай ажилчид удирдамж болон гэгээрэлд үндэслэн улам туршлагажна. Эдгээр туршлага дотор хүний оюун ухаан, туршлага, түүнчлэн хүн чанарынх нь оршихуй холилддог ба үүний дараа

тэд олж авах ёстой мэдлэг болон ойлголтоо олж авдаг. Энэ бол үнэнийг туулсны дараах хүний хэрэгжүүлэлтийн зам юм. Хүмүүсийн туршлага, туулдаг зүйлс өөр өөр учраас энэхүү хэрэгжүүлэлтийн зам нь үргэлж адилхан байдаггүй. Ийм маягаар, гэгээрлийг хүлээн авдаг хүмүүс өөр өөр учраас Ариун Сүнсний ижилхэн гэгээрлээс өөр өөр мэдлэг, хэрэгжүүлэлт урган гардаг. Зарим хүн хэрэгжүүлэх явцдаа жижиг алдаа гаргадаг бол зарим нь томоохон алдаа гаргадаг, харин зарим нь зөвхөн алдаа л гаргаж байдаг. Яагаад гэвэл, хүмүүсийн ойлгох чадвар ялгаатай, бас төрөлх хэв чанар нь ч ялгаатай байдаг. Зарим хүн номлол сонссоныхоо дараа нэг янзаар ойлгодог ба зарим нь үнэнийг сонссоныхоо дараа өөрөөр ойлгодог. Зарим хүн ялимгүй гаждаг, харин зарим нь үнэний жинхэнэ утга учрыг огтхон ч ойлгодоггүй. Тиймээс хүний ойлголт бусдыг хэрхэн удирдан хөтлөхийг нь тодорхойлдог; хүний ажил ердөө оршихуйнх нь илэрхийлэл учраас энэ нь яг үнэн юм. Үнэний талаар зөв ойлголттой хүнээр удирдуулсан хүмүүс ч бас үнэний тухай зөв ойлголттой байх болно. Ташаа ойлголттой хүмүүс байсан ч гэсэн, бүгдээрээ биш, цөөн хэд нь л алдаа мадагтай байна. Хэрвээ хүн үнэний талаар андуу ташаа ойлголттой бол түүнийг дагадаг хүмүүс ч бас эргэлзээгүй алдаа мадагтай байх бөгөөд энэ хүмүүс жинхэнэ утгаараа алдаа мадагтай байна. Дагалдагчдын үнэнийг ойлгох түвшин ажилчдаас ихээхэн хамаардаг. Мэдээж, Бурханаас ирдэг үнэн бол алдаа мадаггүй зөв, туйлын тодорхой байдаг. Харин ажилчид бүхэлдээ зөв байдаггүй, бас тэднийг бүрэн найдвартай гэж хэлж болохгүй. Хэрэв ажилчдад үнэнийг хэрэгжүүлэх маш бодитой арга зам байгаа бол дагалдагчид ч бас хэрэгжүүлэлтийн замтай байх болно. Харин ажилчдад үнэнийг хэрэгжүүлэх арга зам байхгүй, зөвхөн хоосон сургаал л байдаг бол дагалдагчид ямар ч бодит байдалгүй байна. Дагалдагчдын хэв чанар ба уг чанар нь төрөлхөөс заяагдсан бөгөөд ажилчидтай хамаагүй боловч дагалдагчдын үнэнийг ойлгож, Бурханыг мэдэх хэмжээ нь ажилчдаас хамаардаг (зарим хүний хувьд л ийм байдаг). Ажилчин ямар байна, удирдаж буй дагалдагчид нь ч тийм байна. Ажилчин өөрийн оршихуйг юу ч үлдээлгүй илэрхийлж байдаг. Өөрийг нь дагадаг хүмүүст тавьдаг шаардлагууд нь түүний хүрэхийг хүсэж буй, эсвэл хүрч чадах зүйлс юм. Ихэнх ажилчид өөрсдийн хийдэг зүйлд үндэслэн дагалдагчдадаа шаардлага тавьдаг ч дагалдагчдынх нь огт хүрч чадахгүй зүйл олон байдаг бөгөөд хүний хүрч чадахгүй зүйл оролтод нь саад болдог.

Засалт, харьцалт, шүүлт, гэсгээлт туулсан хүмүүсийн ажилд хамаагүй бага гажуудал байдаг бөгөөд тэдний ажлын илэрхийлэл хавьгүй нарийн зөв байдаг.

Ажиллахдаа өөрийнхөө төрөлх байдалд найддаг хүмүүс нэлээд том алдаа гаргадаг. Төгс болгуулаагүй хүмүүсийн ажил өөрсдийнх нь төрөлх байдлыг хэтэрхий их илэрхийлдэг бөгөөд энэ нь Ариун Сүнсний ажилд томоохон саад болдог. Хүний хэв чанар хэчнээн сайн байлаа ч, Бурханы даалгасан ажлыг хийхээсээ өмнө тэр бас засалт, харьцалт, шүүлт туулах ёстой. Хэрвээ ийм шүүлт туулаагүй бол тэд ажлаа хэчнээн сайн хийлээ ч гэсэн, үнэний зарчимтай нийцэхгүй ба үргэлж өөрсдийнх нь төрөлх байдал, хүний сайн сайхан л байдаг. Засалт, харьцалт, шүүлт туулсан хүмүүсийн ажил засалт, харьцалт, шүүлт туулаагүй хүмүүсийн ажлаас хавьгүй илүү нарийн зөв байдаг. Шүүлт туулаагүй хүмүүс, хүний оюуны чадамж, төрөлхийн авьяастай ихээхэн хутгалдсан хүний махан бие болон бодлыг л илэрхийлдэг. Энэ нь Бурханы ажлын тухай хүний нарийн зөв илэрхийлэл биш юм. Тийм хүмүүсийг дагадаг хүмүүс төрөлх хэв чанарынхаа дагуу тэдний өмнө ирдэг. Учир нь тэд Бурханы анхдагч санаа зорилготой бараг холбоогүй, үүнээс хэт хазайсан дэндүү их ойлголт, туршлагыг илэрхийлдэг учраас ийм төрлийн хүний ажил нь хүмүүсийг Бурханы өмнө биш, өөрийнх нь өмнө л аваачиж чадна. Иймээс Бурханы шүүлт, гэсгээлтийг туулаагүй хүмүүс Бурханы даалгасан ажлыг гүйцэтгэхэд тэнцдэггүй. Шалгуурт нийцсэн ажилчны ажил хүмүүсийг зөв замд аваачиж, үнэнд улам их орох боломж олгож чаддаг. Түүний ажил хүмүүсийг Бурханы өмнө авчирч чаддаг. Түүнчлэн, түүний хийдэг ажил нь хүнээс хүнд ялгаатай байж болдог, дүрэмд баригддаггүй бөгөөд хүмүүст чөлөөлөлт, эрх чөлөө, амиа аажмаар өсгөх, үнэнд илүү гүн орох чадавх олгодог. Харин шалгуурт нийцээгүй ажилчны ажил хамаагүй тааруухан байдаг. Бас ажил нь мунхаг байдаг. Тэрээр хүмүүсийг дүрэм рүү л аваачиж чаддаг ба хүмүүсээс шаарддаг зүйл нь хүнээс хүнд ялгаатай байдаггүй; тэрээр хүмүүсийн бодит хэрэгцээний дагуу ажилладаггүй. Ийм төрлийн ажилд, хэтэрхий олон дүрэм, хоосон сургаал байдаг бөгөөд хүмүүсийг бодит байдал руу ч, амийн өсөлтийн хэвийн хэрэгжүүлэлт рүү ч аваачиж чаддаггүй. Энэ нь хүмүүсээр үнэ цэнгүй цөөн хэдэн дүрэм журмыг баримтлуулдаг. Ийм удирдамж нь хүмүүсийг буруу замаар оруулж л чадна. Тэр чамайг өөртэйгөө адилхан болгож, өөрт нь юу байгаа, өөрөө юу болох руугаа л аваачиж чадна. Дагалдагчдын хувьд удирдагчид нь шалгуур хангадаг эсэхийг ялган таних гол түлхүүр бол тэдний удирдан чиглүүлдэг зам, ажлын үр дүнг харах, мөн дагалдагчид нь үнэнтэй нийцэлтэй зарчмыг хүлээн авдаг эсэх, өөрчлөгдөхөд нь тохирсон хэрэгжүүлэлтийн замыг хүлээн авдаг эсэхийг харах хэрэгтэй. Чи өөр өөр хүмүүсийн янз бүрийн ажлыг хооронд нь ялгах хэрэгтэй; чи

мунхаг дагалдагч байх ёсгүй. Энэ нь хүмүүсийн оролтын хэрэг явдалд нөлөөлдөг. Хэрвээ чи аль хүний удирдлагад зам байгаа, алинд нь байхгүй болохыг ялган салгаж чадахгүй бол амархан мэхлэгдэнэ. Энэ бүгд чиний өөрийн амьтай шууд хамаатай. Төгс болгуулаагүй хүмүүсийн ажилд төрөлх байдал дэндүү их байдаг; үүнд хүний хүсэл дэндүү их холилдсон байдаг. Тэдний оршихуй нь төрөлх байдал, тэдэнд төрөлхөөс заяагдсан зүйл юм. Энэ нь харьцалт туулсны дараах амь, эсвэл өөрчлөгдсөний дараах бодит байдал биш. Ийм хүн яаж амийг эрэлхийлж буй хүмүүст дэмжлэг үзүүлж чадах юм бэ? Хүнд анхнаасаа байдаг амь нь түүний төрөлх оюуны чадамж, эсвэл авьяас билиг юм. Ийм төрлийн оюуны чадамж, авьяас билиг нь хүнд тавих Бурханы нарийн шаардлагаас нэлээд зөрүүтэй байдаг. Хэрвээ хүн төгс болгуулаагүй, завхарсан зан чанар нь засалт, харьцалт туулаагүй бол түүний илэрхийлдэг зүйлс болон үнэний хооронд томоохон зай гарна; түүний илэрхийлдэг зүйл өөрийнх нь төсөөлөл, өрөөсгөл туршлага гэх мэт тодорхойгүй зүйлстэй холилдоно. Түүнчлэн тэр яаж ч ажилладаг бай, ерөнхий зорилго болон бүх хүний оролтод тохирох үнэн огт байхгүй мэт хүмүүст санагддаг. Хүмүүст тавьдаг шаардлагуудын ихэнх нь тэдний чадвараас давдаг бөгөөд чадахгүй зүйлийг нь хийлгэхээр тэднээс шаардаж буй мэт байдаг. Энэ бол хүний хүслийн ажил юм. Хүний завхарсан зан чанар, бодол болон үзэл нь түүний бүх биеэр нэвчсэн байдаг. Хүн үнэнийг хэрэгжүүлэх зөн билигтэй төрөөгүй, мөн үнэнийг шууд ойлгох зөн билиг ч түүнд байдаггүй. Хүний завхарсан зан чанартай зэрэгцээд ийм төрөлх байдалтай хүн ажиллах аваас саад учруулахгүй гэж үү? Харин төгс болгуулсан хүнд хүмүүсийн ойлгох ёстой үнэний туршлага болон тэдний завхарсан зан чанарын тухай мэдлэг байдаг, ингэснээр түүний ажил дахь тодорхойгүй, бодитой бус зүйлс аажмаар багасаж, хүний хольц нь цөөрч, ажил болон үйлчлэл нь Бурханы шаарддаг стандартад улам бүр ойртдог. Тиймээс, түүний ажил үнэн-бодит байдалд орсон бөгөөд бас бодитой болсон. Хүний оюун ухаанд орших бодлууд ялангуяа Ариун Сүнсний ажилд саад учруулдаг. Хүнд баялаг төсөөлөл, үндэслэлтэй логик болон аливаа хэрэг явдлыг зохицуулах урт хугацааны туршлага бий. Хэрвээ хүний эдгээр талыг засаж, зөвтгөхгүй бол бүгд ажилд садаа болдог. Тиймээс хүний ажил, ялангуяа төгс болгуулаагүй хүмүүсийн ажил хамгийн нарийн зөв түвшинд хүрч чадахгүй.

Хүний ажилд цар хүрээ, хязгаарлалт гэж бий. Нэг хүн тодорхой үе шатны ажлыг л хийнэ үү гэхээс бүхий л эрин үеийн ажлыг хийж чадахгүй—эс бөгөөс тэрээр хүмүүсийг нэг төрлийн дүрэм журам руу хөтлөх байлаа. Хүний ажил

зөвхөн тодорхой цаг хугацаа, үе шатанд л хэрэглэгдэж болно. Учир нь хүний туршлагад цар хүрээ байдаг. Хүний ажлыг Бурханы ажилтай харьцуулж болохгүй. Хүний хэрэгжүүлэлтийн зам болон үнэний тухай мэдлэг нь бүгд тодорхой цар хүрээнд тохиромжтой. Иймд хүний алхдаг замыг бүхэлдээ Ариун Сүнсний хүсэл гэж хэлж болохгүй, учир нь хүнийг Ариун Сүнс л гэгээрүүлж чадах бөгөөд Ариун Сүнс түүнийг бүрэн дүүргэж чадахгүй. Хүний туулж болох зүйлс бүгд хэвийн хүн чанарын цар хүрээн дотор байдаг ба хэвийн хүний оюун ухаан дахь бодлын хүрээнээс хальж чадахгүй. Үнэний бодит байдлыг амьдран харуулж чаддаг бүх хүн энэ цар хүрээн дотор туршлагаждаг. Тэд үнэнийг туулах үед, энэ нь үргэлж Ариун Сүнсний гэгээрүүлсэн хэвийн хүний амьдралын туршлага байдаг ба хэвийн хүний амьдралаас гаждаг туршлагажих зам биш юм. Тэд хүний амьдралаар амьдарсан суурин дээрээ Ариун Сүнсний гэгээрүүлсэн үнэнийг туулдаг. Түүнчлэн, энэ үнэн нь хүнээс хүнд янз бүр байдаг бөгөөд гүн гүнзгий байдал нь тухайн хүний байр байдлаас хамаардаг. Тэдний алхдаг зам нь үнэнийг эрэлхийлдэг хэвийн хүний амьдрал, мөн Ариун Сүнсний гэгээрүүлсэн хэвийн хүний алхдаг зам гэж хэлж болно. Тэдний алхдаг замыг Ариун Сүнсний алхдаг зам гэж хэлж болохгүй. Эрэлхийлдэг хүмүүс нь адилгүй учраас хэвийн хүний туршлагад Ариун Сүнсний ажил ч бас адилгүй байдаг. Түүнчлэн, хүмүүсийн туулдаг орчин болон туршлагын цар хүрээ адилгүй байдаг учраас, мөн оюун ухаан, бодол нь холилдсон байдаг учраас тэдний туршлага янз бүрийн түвшинд хольцтой байдаг. Хүн бүр тус тусын өөр нөхцөл байдлынхаа дагуу үнэнийг ойлгодог. Үнэний жинхэнэ утга учрын талаарх тэдний ойлголт бүрэн бус байдаг ба ердөө л ганц юм уу цөөн хэдэн тал байдаг. Хүний туулдаг үнэний цар хүрээ нь хүн бүрийн нөхцөл байдалд тулгуурлан хүнээс хүнд үргэлж ялгаатай байдаг. Ийм маягаар, нэг үнэний талаар өөр өөр хүмүүсийн илэрхийлсэн мэдлэг адилхан байдаггүй. Өөрөөр хэлбэл, хүний туршлага үргэлж хязгаартай байж, Ариун Сүнсний хүслийг бүрэн төлөөлж чаддаггүй бөгөөд хүний илэрхийлж буй зүйл Бурханы хүсэлтэй маш ойр нийцэж байсан ч гэсэн, мөн хүний туршлага Ариун Сүнсний явуулдаг төгс болгох ажилтай тун ойр байсан ч гэсэн хүний ажлыг Бурханы ажил гэж үзэж болохгүй. Хүн зөвхөн Бурханы зарц байж, даалгасан ажлыг нь хийж л чадна. Хүн Ариун Сүнсний гэгээрлээс олж авсан мэдлэг болон хувийн туршлагаараа олж авсан үнэнийг илэрхийлж л чадна. Хүн Ариун Сүнсний гарц байхад тэнцдэггүй, мөн болзлыг нь хангадаггүй. Өөрийнх нь ажил бол Бурханы ажил гэж хэлэх эрхгүй. Хүнд хүний ажиллах зарчим гэж байдаг, бүх хүн янз бүрийн

туршлага, олон янзын нөхцөл байдалтай байдаг. Хүний ажилд Ариун Сүнсний гэгээрэл дор олж авсан бүх туршлага нь багтдаг. Эдгээр туршлага хүний оршихуйг л төлөөлж чадна уу гэхээс Бурханы оршихуй, Ариун Сүнсний хүслийг төлөөлдөггүй. Тиймээс хүний алхдаг замыг Ариун Сүнсний алхдаг зам гэж хэлж болохгүй, учир нь хүний ажил Бурханы ажлыг төлөөлж чаддаггүй бөгөөд хүний ажил болон туршлага нь Ариун Сүнсний бүрэн гүйцэд хүсэл биш юм. Хүний ажил дүрэмд баригдахдаа амархан бөгөөд ажлынх нь арга барил хязгаарлагдмал хүрээнд хялбархан баригдаж, хүмүүсийг чөлөөтэй зам руу хөтөлж чаддаггүй. Ихэнх дагалдагч хязгаарлагдмал хүрээн дотор амьдардаг ба туршлагажих зам нь ч хязгаарлагдмал цар хүрээтэй байдаг. Хүний туршлага үргэлж хязгаарлагдмал байдаг; ажлын арга барил нь ч бас хэдхэн төрлөөр хязгаарлагддаг ба Ариун Сүнсний ажил юм уу Бурханы Өөрийн ажилтай харьцуулж болохгүй. Учир нь хүний туршлага эцсийн эцэст хязгаарлагдмал билээ. Харин Бурхан ажлаа хийхдээ дүрэм журамд баригддаггүй; үүнийг яаж ч хийлээ гэсэн ганцхан арга барилаар хязгаарлагддаггүй. Бурханы ажилд ямар ч дүрэм гэж байдаггүй—Түүний бүх ажил хязгаарлалтгүй, чөлөөтэй байдаг. Хүн Түүнийг дагахдаа хэчнээн ч их хугацаа зарцууллаа гэсэн Бурханы ажиллах арга замыг захирдаг ямар ч хуулийг нэгтгэн дүгнэж чаддаггүй. Түүний ажил зарчимтай хэдий ч үргэлж шинэ арга замаар хийгдэн, ямагт шинэ өрнөлтэй байдаг, үүнд хүн хүрэх аргагүй. Ганцхан цаг үед Бурхан хэд хэдэн өөр төрлийн ажил, хүмүүсийг удирдах өөр өөр арга замтай байж, хүмүүсийг үргэлж шинэ оролт, шинэ өөрчлөлттэй байлгаж болно. Тэр үргэлж шинэ арга замаар ажиллаж байгаа учраас Түүний ажлын хуулийг чи ялган таньж чадахгүй бөгөөд тиймээс л Бурханыг дагалдагчид дүрэмд баригддаггүй. Бурханы Өөрийн ажил үргэлж хүмүүсийн үзлээс зайлсхийж, үзлийг нь сөрдөг. Чин сэтгэлээсээ Түүнийг дагаж, эрэлхийлдэг хүмүүс л зан чанараа өөрчилж, ямар нэг дүрэм журамд баригдах юм уу шашны үзэлд авталгүйгээр чөлөөтэй амьдарч чаддаг. Хүний ажил өөрийнхөө хувийн туршлага, хүрч чадах зүйлд үндэслэн хүмүүст шаардлага тавьдаг. Эдгээр шаардлагын стандарт нь тодорхой цар хүрээн дотор хязгаарлагдаж, хэрэгжүүлэх арга барил нь ч бас маш хязгаарлагдмал байдаг. Тиймээс дагалдагчид өөрийн мэдэлгүй энэ хязгаарлагдмал цар хүрээн дотор амьдардаг; цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эдгээр зүйл дүрэм журам, зан үйл болдог. Хэрвээ Бурханаар биечлэн төгс болгуулж, шүүгдээгүй хүн нэг цаг үеийн ажлыг удирдвал дагалдагчид нь бүгд шашны хуучинсаг үзэлтнүүд болж, Бурханыг эсэргүүцэхдээ мэргэжилтэн болдог. Тиймээс, хэрвээ хүн шаардлага хангасан удирдагч мөн юм

бол шүүлт туулж, төгс болголтыг хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Шүүлт туулаагүй хүмүүс хэдий Ариун Сүнсний ажилтай байж болох ч гэсэн тодорхойгүй, бодит бус зүйлсийг л илэрхийлдэг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд хүмүүсийг тодорхойгүй, ер бусын дүрэм журам руу хөтөлнө. Бурханы гүйцэтгэдэг ажил хүний махан биетэй нийцдэггүй. Энэ нь хүний бодолтой нийцдэггүй, харин хүний үзлийг сөрдөг; мөн шашны тодорхойгүй өнгө аясаар гутаагддаггүй. Бурханы ажлын үр дүнд Түүгээр төгс болгуулаагүй хэн нэгэн хүрч чадахгүй, мөн үүнд хүний сэтгэхүй хүршгүй юм.

Хүн оюун санаандаа байгаа ажлыг маш амархан гүйцэтгэдэг. Жишээлбэл, шашны ертөнцийн пастор, удирдагчид авьяас билиг, байр сууриндаа тулгуурлан ажлаа хийдэг. Удаан хугацаанд тэднийг дагасан хүмүүст тэдний авьяас билиг халдварлаж, оршихуйн зарим нь нөлөөлнө. Тэд хүмүүсийн авьяас билиг, ур чадвар, мэдлэгт анхаарч, мөн ер бусын зүйл, бодит бус гүн гүнзгий олон сургаалд (мэдээж, эдгээр гүн гүнзгий сургаалд хүрэхийн аргагүй) анхаарал хандуулдаг. Тэд хүмүүсийн зан чанарын өөрчлөлтөд анхаарлаа төвлөрүүлдэггүй, харин хүмүүсийг номлох, ажиллахад сургаж, тэдний мэдлэг болон элбэг арвин шашны сургаалыг сайжруулахад анхаардаг. Хүмүүсийн зан чанар хэр их өөрчлөгдсөнийг, хүмүүс үнэнийг хэр их ойлгож байгааг тэд анхаардаггүй. Тэд хүмүүсийн хэвийн болон хэвийн бус байдлын талаар мэдэх гэж оролдох нь байтугай, мөн чанарынх нь талаар ч хайхардаггүй. Хүмүүсийн үзлийг сөрдөггүй, үзлийг нь ч илчилдэггүй, дутагдал, завхралынх нь төлөө хүмүүсийг засаж бүр ч чаддаггүй. Тэднийг дагадаг ихэнх хүн авьяас билгээрээ үйлчилдэг ба илэрхийлдэг бүхэн нь бодит байдалтай хамааралгүй, хүмүүст амь өгч огт чадахгүй шашны үзэл, теологийн онол байдаг. Үнэндээ тэдний ажлын мөн чанар нь авьяасыг хөгжүүлж, юу ч үгүй хүнийг хөгжүүлээд, хожим нь ажиллаж, удирдахаар явах шашны сургуулийн авьяаслаг төгсөгч болгох явдал юм. Бурханы зургаан мянган жилийн ажлаас чи ямар нэг хууль дүрмийг олж мэдэж чадах уу? Хүний хийдэг ажилд маш олон дүрэм, хязгаарлалт байдаг ба хүний уураг тархи хэтэрхий онолдох дуртай. Тиймээс хүний илэрхийлдэг зүйл бол өөрийнх нь туршлагын цар хүрээн доторх ухаарал, мэдлэг юм. Хүн үүнээс өөр зүйлийг илэрхийлж чадахгүй. Хүний туршлага болон мэдлэг нь түүний төрөлхийн авьяас билгээс, эсвэл зөн билгээс гардаггүй; харин Бурханы удирдамж, шууд хариулгаас гарч ирдэг. Хүн зөвхөн энэ хариулгыг хүлээн авах чадвартай болохоос биш, бурханлаг чанар юу болохыг шууд илэрхийлж чаддаг чадвар байхгүй. Хүн өөрөө эх сурвалж байж чадахгүй; зөвхөн эх сурвалжаас ус

хүлээж авдаг сав л байж чадна; энэ бол хүний зөн билиг, хүн болгонд байх ёстой чадвар юм. Хэрвээ хүн Бурханы үгийг хүлээн авах чадвараа алдаж, хүний зөн билгээ гэвэл хамгийн эрхэм нандин зүйлээ ч бас алдаж, бүтээгдсэн хүний үүргийг алддаг. Хэрвээ хүнд Бурханы үг юм уу ажлын тухай мэдлэг, туршлага байхгүй бол тэр хүн өөрийн үүргийг буюу бүтээл болохынхоо хувьд гүйцэтгэх ёстой үүргээ алдаж, бүтээлийн эрхэм чанараа алддаг. Махбодоор юм уу Сүнсээр шууд илэрхийлэгдсэн эсэх нь хамаагүй бурханлаг чанар юу болохыг илэрхийлэх нь Бурханы зөн билиг юм; энэ нь Бурханы үйлчлэл билээ. Хүн өөрийн туршлага, эсвэл мэдлэгийг Бурханы ажлын үеэр юм уу дараа нь илэрхийлдэг (өөрөөр хэлбэл, тэр юу болохоо илэрхийлдэг); энэ бол хүний зөн билиг, үүрэг бөгөөд хүний биелүүлэх ёстой зүйл юм. Хэдийгээр хүний илэрхийлэл Бурханы илэрхийлдэг зүйлээс хамаагүй дутуу боловч хүний илэрхийлэл олон дүрэм журамд баригддаг, хүн биелүүлэх ёстой үүргээ биелүүлж, хийх ёстой зүйлээ хийх учиртай. Хүн үүргээ биелүүлэхийн тулд боломжтой бүхнийг хийх ёстой бөгөөд өчүүхэн төдий ч биеэ нөөсөн явдал байх ёсгүй.

Олон жил ажилласны дараа хүн тэр хугацааныхаа ажлын туршлага, хуримтлуулсан мэргэн ухаан, дүрэм журмыг нэгтгэн дүгнэнэ. Удаан хугацааны турш ажилласан хүн Ариун Сүнсний ажлын хөгжил хөдөлгөөнийг хэрхэн мэдрэхээ мэддэг; Ариун Сүнс хэзээ ажиллаж байгаа, хэзээ ажиллахгүй байгааг мэддэг; ачаа үүрч байх үедээ хэрхэн нөхөрлөхөө мэддэг; Ариун Сүнсний ажлын хэвийн байдал болон хүмүүсийн амийн өсөлтийн хэвийн байдлыг мэддэг. Энэ бол олон жил ажилласан, Ариун Сүнсний ажлыг мэддэг хүн юм. Олон жил ажилласан хүмүүс эргэлзээгүйгээр, тайван ярьдаг; хэлэх юмгүй байхдаа ч гэсэн тайван дөлгөөн байдаг. Дотроо тэд Ариун Сүнсний ажлыг эрж хайн залбирсаар байж чаддаг. Тэд ажилдаа туршлагажсан байдаг. Удаан хугацаанд ажилласан, ихээхэн туршлагатай, олон хичээл сурсан хүмүүсийн дотор Ариун Сүнсний ажилд саад учруулах зүйл олон байдаг; энэ бол удаан хугацааны ажлынх нь дутагдалтай тал юм. Дөнгөж ажиллаж эхэлсэн хүн хүний сургамж, туршлагаар дутмаг, ялангуяа Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар мэдэх ч үгүй байдаг. Гэхдээ ажлын явцад тэрээр Ариун Сүнс хэрхэн ажилладгийг аажмаар мэдэрч сурдаг ба Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд юу хийх, бусдын яг сул талыг цохихын тулд юу хийх гэх мэт ажиллаж байгаа хүмүүсийн эзэмших шаардлагатай ердийн мэдлэгийг мэдэж авдаг. Цаг хугацаа өнгөрөх тусам тэрээр ажиллах тухай тийм мэргэн ухаан, ерөнхий мэдлэгийг арван хуруу шигээ мэддэг болж, ажиллах үедээ тэдгээрийг хялбархан ашиглаж байгаа мэт

санагддаг. Гэвч, Ариун Сүнс ажиллах байдлаа өөрчлөх үед тэр, хуучин ажлын мэдлэг болон хуучин ажлын дүрэмтэйгээ л зууралддаг бөгөөд ажлын шинэ хөдөлгөөний тухай тун бага мэддэг. Олон жилийн ажил, Ариун Сүнсний оролцоо болон удирдамжаар дүүрэн байсан нь түүнд ажиллах сургамж, туршлагыг улам их өгдөг. Ийм зүйлс нь түүнийг бардамнал бус, харин өөртөө итгэх итгэлээр дүүргэдэг. Өөрөөр хэлбэл, тэрээр өөрийнхөө ажилд сэтгэл хангалуун байж, Ариун Сүнсний ажлаас олж авсан ерөнхий мэдлэгтээ ханамжтай байдаг. Ялангуяа, бусад хүмүүсийн олж аваагүй, ухаараагүй зүйлс нь түүнд өөртөө илүү их итгэх итгэлийг өгдөг; түүний доторх Ариун Сүнсний ажил хэзээ ч алга болохгүй, харин бусад нь ингэж онцгойлуулах эрхгүй юм шиг санагддаг. Олон жилийн турш ажилласан, ашиглалтын үнэ цэн ихтэй түүн шиг төрлийн хүмүүс л үүнийг эдлэхэд тохирно. Эдгээр зүйл Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авахад нь асар их саад болдог. Тэрээр шинэ ажил хүлээн авч чадах байсан ч гэсэн ганцхан шөнийн дотор хийж чадахгүй. Үүнийг хүлээн зөвшөөрөхийнхөө өмнө хэд хэдэн нугачааг давах нь гарцаагүй. Түүний хуучин үзэлтэй харьцаж, хуучин зан чанарыг нь шүүсний дараа л энэ нөхцөл байдал аажмаар өөрчлөгдөж болно. Эдгээр алхмыг туулахгүйгээр тэр бууж өгч, хуучин үзэлтэй нь үл зохилдох шинэ сургаал болон ажлыг хялбархан хүлээн авахгүй. Энэ бол хүний доторх харьцахад хамгийн хэцүү зүйл бөгөөд үүнийг өөрчлөх нь амаргүй. Хэрвээ, ажилчин болохын хувьд тэр Ариун Сүнсний ажлыг ойлгох чадвартай, хөгжил хөдөлгөөнийг нь дүгнэх чадвартай, түүнчлэн ажлын туршлагадаа хязгаарлагдахгүй байж, хуучин ажлын үр дүнд шинэ ажлыг хүлээн зөвшөөрч чаддаг бол ухаалаг агаад уг ажилд тэнцсэн ажилчин юм. Хүмүүс ихэвчлэн ийм байдаг: Тэд ажлын туршлагаа дүгнэж чадалгүй хэдэн жил ажилладаг, эсвэл ажилтай холбоотой туршлага, мэргэн ухаанаа нэгтгэн дүгнэсний дараа шинэ ажлыг хүлээн авахад нь саад тулгараад, хуучин болон шинэ ажлыг зөвөөр ойлгож, тэдгээрт зөв зүйтэй хандаж чаддаггүй. Хүмүүсийн учрыг олоход үнэхээр хэцүү! Та нарын ихэнх нь ийм байдаг. Олон жил Ариун Сүнсний ажлыг туулсан хүмүүсийн хувьд шинэ ажлыг хүлээн авахад хэцүү байдаг бөгөөд хойш тавьж чадахгүй үзлээр үргэлж дүүрэн байдаг байхад харин дөнгөж ажиллаж эхэлсэн хүмүүст ажлын тухай ерөнхий мэдлэг дутмаг байдаг ба хамгийн энгийн хэрэг явдлуудыг ч яаж шийдэхээ мэддэггүй. Хүмүүс та бүхэн үнэхээр хэцүү! Жаахан зиндаа дээгүүр болмогцоо биеэ тоож, ихэрхүү зан гаргаж, хэзээ төрснөө мартдаг. Тэд залуусыг үргэлж дорд үздэг, гэсэн атлаа өөрсдөө шинэ ажлыг хүлээн авч чаддаггүй, олон жилийн турш цуглуулж, хадгалсан хуучин үзлээсээ

салж чаддаггүй. Мэдлэггүй тэр залуус Ариун Сүнсний шинэ ажлын багахныг хүлээн авах чадвартай, нэлээд урам зоригтой байдаг ч асуудал тулгарах үед үргэлж будилж, яахаа мэддэггүй. Тэд урам зоригтой байдаг ч мэдлэггүй. Тэд Ариун Сүнсний ажлын талаар өчүүхэн мэдлэгтэй байхын дээр түүнийгээ амьдралдаа ашиглаж чаддаггүй; энэ нь зүгээр л тэр чигтээ хэрэггүй хоосон сургаал юм. Та нар шиг хүмүүс хэтэрхий олон байдаг; хэчнээн нь энэ ажилд тохирох бол? Хэд нь Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг дуулгавартай дагаж, Бурханы хүсэлтэй нийцэж чадах бол? Одоог хүртэл дагалдагч байсаар ирсэн та бүхэн маш дуулгавартай байсан мэт санагдаж байгаа ч үнэндээ та нар өөрсдийн үзлийг орхиогүй, одоог хүртэл Библиэс эрж хайж, тодорхойгүй байдалд итгэж, үзэлдээ хэрэн хэсүүчилдэг. Өнөөдрийн бодит ажлыг анхааралтай судалж, гүн рүү нь ордог хэн ч үгүй. Та нар хуучин үзлээрээ өнөөдрийн замыг хүлээн зөвшөөрч байгаа. Ийм итгэл үнэмшлээс та нар юу олж авч чадах юм бэ? Та нарын дотор илчлэн харуулаагүй маш олон үзэл нуугддаг гэж хэлж болох ба та нар тэдгээрийг нуун далдалж, амархан илчлэхгүйн тулд дээд зэргийн хичээл чармайлт гаргаж байгаа. Та нар шинэ ажлыг чин сэтгэлээсээ хүлээн авдаггүй, хуучин үзлээсээ салахаар төлөвлөдөггүй; та нарт хэтэрхий олон амьдралын гүн ухаан байдаг ба тэдгээр нь нэлээд их. Та нар хуучин үзлээ хаядаггүй, шинэ ажилтай дурамжхан харьцдаг. Та нарын зүрх сэтгэл хэтэрхий зусар бөгөөд шинэ ажлын алхмуудыг үнэн сэтгэлээсээ авч үздэггүй. Та нар шиг ийм гологдлууд сайн мэдээ түгээх ажлыг хийж чадах уу? Үүнийг бүхий л орчлон ертөнц даяар түгээх ажлыг хийж чадна гэж үү? Та нарын энэ хэрэгжүүлэлт зан чанараа өөрчилж, Бурханыг мэдэхэд чинь саад учруулж байна. Хэрвээ та нар ийнхүү үргэлжлүүлбэл таягдан хаягдах болно.

Та нар Бурханы ажлыг хүний ажлаас яаж ялгахаа мэддэг байх ёстой. Хүний ажлаас чи юу харж болох вэ? Хүний ажилд хүний туршлагын маш олон элемент байдаг; хүн өөрийнхөө юу болохыг илэрхийлдэг. Бурханы Өөрийн ажил ч бас Тэр юу болохыг илэрхийлдэг боловч Түүний оршихуй нь хүнийхээс өөр юм. Хүний оршихуй нь хүний туршлага болон амьдралыг (амьдралдаа туулж, тулгардаг зүйлс, хүнд байдаг амьдралын гүн ухааныг) төлөөлдөг ба өөр өөр орчинд амьдарч байгаа хүмүүс өөр өөр оршихуйг илэрхийлдэг. Нийгмийн туршлагатай эсэх, гэр бүлдээ яг хэрхэн амьдарч, туршлагаждаг вэ гэдгийг чинь чиний илэрхийлдэг зүйлээс харж болдог бол бие махбодтой болсон Бурханы ажлаас Түүнд нийгмийн туршлага байгаа эсэхийг харах аргагүй. Бурхан хүний мөн чанарыг сайн мэддэг бөгөөд бүх төрлийн хүмүүст хамаатай төрөл бүрийн

хэрэгжүүлэлтийг илчилж чадна. Тэрээр хүний ялзарсан зан чанар, тэрслүү үйлдлийг бүр ч сайн илчилж чаддаг. Тэрээр ертөнцийн хүмүүс дунд амьдардаггүй боловч эгэл хүмүүсийн уг чанарыг болон ертөнцийн хүмүүсийн бүх завхралыг мэддэг. Энэ нь Түүний оршихуй юм. Тэр дэлхий ертөнцтэй харьцдаггүй хэдий ч дэлхий ертөнцтэй харьцах дүрмийг мэддэг, учир нь Тэр хүний уг чанарыг бүрэн ойлгодог билээ. Хүний нүдээр харж, чихээр сонсох аргагүй өнгөрсөн болон өнөөдрийн Сүнсний ажлын тухай Тэр мэднэ. Үүнд амьдралын гүн ухаан бус мэргэн ухаан болон хүмүүсийн хувьд ойлгоход хэцүү санагддаг гайхамшиг багтдаг. Энэ нь Түүний оршихуй бөгөөд хүмүүст ил, бас хүмүүсээс нуугдмал байдаг. Тэрээр ер бусын хүн юу болохыг илэрхийлдэггүй, харин Сүнсний төрөлх шинж чанар ба оршихуйг илэрхийлдэг. Тэрээр дэлхийг тойрон аялдаггүй боловч бүх зүйлийг нь мэддэг. Тэр мэдлэггүй, ойлголтгүй “хүн дүрст сармагчнууд”-тай холбогддог боловч мэдлэгээс өндөр, агуу хүмүүсээс дээгүүр үгийг илэрхийлдэг. Тэрээр хүн чанаргүй, хүн төрөлхтний ёс журам болон амьдралыг ойлгодоггүй мулгуу, хөшүүн бүлэг хүмүүсийн дунд амьдардаг боловч хэвийн хүн чанарыг амьдран харуулахыг хүн төрөлхтнөөс хүсэхийн зэрэгцээ хүн төрөлхтний адгийн, дорд хүн чанарыг илчилдэг. Энэ бүхэн бол Түүний оршихуй бөгөөд мах цуснаас бүрдсэн ямар ч хүнээс дээр юм. Түүний хувьд, ярвигтай, төвөгтэй, бузар булай нийгмийн амьдралыг туулах шаардлагагүйгээр хийх хэрэгтэй ажлаа хангалттай хийж, завхарсан хүн төрөлхтний мөн чанарыг бүрэн илчилдэг. Тийм бузар булай нийгмийн амьдрал Түүний махбодыг босгон байгуулдаггүй. Түүний үг, ажил нь хүний дуулгаваргүй байдлыг л илчилдэг бөгөөд дэлхий ертөнцтэй харьцахад зориулсан туршлага, сургамжаар хүнийг хангадаггүй. Тэрээр хүнийг амиар хангахдаа нийгэм болон хүний гэр бүлийг мөрдөн шалгах шаардлагагүй байдаг. Хүнийг илчилж, шүүх нь Түүний махбодын туршлагын илэрхийлэл биш; харин хүний дуулгаваргүй байдлыг аль хэдийн мэдэж, хүн төрөлхтний завхралд зэвүүцсэний дараа хүний шударга бус байдлыг илчлэх явдал юм. Түүний хийдэг ажил нь бүгд Түүний зан чанарыг хүнд илчилж, Түүний оршихуйг илэрхийлэх явдал юм. Тэр л энэ ажлыг хийж чадна; энэ нь мах, цуснаас бүтсэн хүний хийж чадах зүйл биш. Түүний ажлаас хүмүүс Тэр ямар төрлийн хүн бэ гэдгийг таньж чадахгүй. Бас Түүний ажилд үндэслэн Түүнийг бүтээгдсэн хүн хэмээн ангилж чадахгүй. Түүний оршихуй нь Түүнийг бүтээгдсэн хүн хэмээн ангилах аргагүй болгодог. Хүн Түүнийг хүн биш гэж л тооцож чадах боловч ямар ангилалд оруулахаа мэддэггүй тул Бурхан гэж ангилахаас өөр аргагүйд хүрдэг. Хүний хувьд ингэх нь үндэслэлгүй зүйл биш,

учир нь Бурхан хүний хийж чадахгүй маш их ажлыг хүмүүсийн дунд хийсэн билээ.

Бурханы хийдэг ажил Түүний махбодын туршлагыг төлөөлдөггүй; хүний хийдэг ажил хүний туршлагыг төлөөлдөг. Хүн бүр хувийн туршлагынхаа тухай ярьдаг. Бурхан үнэнийг шууд илэрхийлж чадна, харин хүн зөвхөн үнэнийг туулсныхаа дараа холбогдох туршлагыг илэрхийлж чадна. Бурханы ажилд дүрэм гэж үгүй бөгөөд цаг хугацаа, газар зүйн хил хязгаарт баригддаггүй. Тэр хэзээ ч, хаана ч Өөрийнхөө юу болохыг илэрхийлж чадна. Тэр хүссэнээрээ ажилладаг. Хүний ажилд нөхцөл байдал, орчин гэж бий; эс бөгөөс хүн ажиллаж чадахгүй, бас Бурханы тухай мэдлэг, үнэний тухай туршлагаа илэрхийлж чадахгүй. Бурханы Өөрийн ажил уу, хүний ажил уу гэдгийг танихын тулд чи энэ хоёрын ялгааг л харьцуулах ёстой. Хэрвээ Бурханы Өөрийн хийдэг ажил гэж байхгүй, зөвхөн хүний ажил л байсан бол чи хүмүүсийн сургаал нь өндөр бөгөөд хэн ч үүнд хүрч чаддаггүй гэдгийг мэдэх болно; тэдний ярианы өнгө, аливааг зохицуулах зарчим, ажилдаа туршлагажсан, тогтвортой байдал нь бусдын хувьд хүршгүй байдаг. Та нар бүгд хэв чанар сайтай, өндөр дээд мэдлэгтэй энэ хүмүүсийг гайхан биширдэг боловч Бурханы ажил болон үгээс чи хүн чанар нь хэр өндөр болохыг харж чаддаггүй. Тэр харин ч энгийн бөгөөд ажиллах үедээ хэвийн, бодитой байдаг ч мөнх бус хүмүүсийн хувьд бас хэмжээлшгүй байдаг, тиймээс хүмүүс Түүнийг нэг талаар биширч хүндэлдэг. Магадгүй хүний ажлын туршлага, төсөөлөл, оюун дүгнэлт нэлээд өндөр, хүн чанар нь нэлээд сайн байж болох юм; ийм шинж чанар нь хүмүүсийн бахдал бишрэлийг л олж авдаг боловч тэдэнд хүндлэл болон айдас түгшүүр төрүүлдэггүй. Сайн ажиллаж чаддаг, ялангуяа гүн туршлагатай, үнэнийг хэрэгжүүлж чаддаг хүмүүсийг бүгд биширдэг боловч тэд биширч, атаархахаас бус, огт эмээдэггүй. Гэхдээ Бурханы ажлыг туулсан хүмүүс Бурханыг биширдэггүй; харин ч Бурханы ажил бол хүний хүрч чадахааргүй, хүнд ойлгогдошгүй, шинэлэг гайхалтай гэдгийг мэдэрдэг. Хүмүүс Бурханы ажлыг туулах үедээ Тэр бол хэмжээлшгүй, ухаалаг, гайхалтай гэдгийг эхлээд мэдэж, өөрийн эрхгүй Түүнийг хүндэлж, Түүний хийдэг ажлын нууцыг мэдэрдэг ба үүнд хүний оюун ухааны мэдлэгийн хүрээ хүрэхээргүй юм. Хүмүүс зөвхөн Түүний шаардлагад нийцэж, Түүний хүслийг биелүүлж чаддаг байхыг л хүсдэг; тэд Түүнээс давахыг хүсдэггүй, учир нь Түүний хийдэг ажил хүний бодол, төсөөллөөс хамаагүй давуу бөгөөд хүн оронд нь хийж чадахгүй. Хүн өөрөө ч хангалтгүй байдлаа мэддэггүй атал Бурхан шинэ замыг нээж, хүнд шинэ, илүү сайхан ертөнцийг авчрахаар ирдэг тул хүн төрөлхтөн шинэ ахиц дэвшилд хүрч,

шинээр эхэлдэг. Бурханы талаар хүмүүсийн мэдэрдэг зүйл бишрэл биш, харин ч зөвхөн бишрэлээр зогсохгүй. Тэдний хамгийн гүнзгий туршлага нь хайр, хүндлэл байдаг; Бурхан бол үнэхээр гайхалтай гэдэг мэдрэмж юм. Тэрээр хүний хийж чадахгүй ажлыг хийж, хэлж чадахгүй зүйлийг хэлдэг. Бурханы ажлыг туулсан хүмүүс үргэлж үгээр илэрхийлэхийн аргагүй мэдрэмжтэй байдаг. Илүү гүнзгий туршлагатай хүмүүс Бурханыг гэх хайрыг ойлгож чаддаг; тэд Бурханы хайр татам байдлыг мэдэрч, Түүний ажил маш ухаалаг, маш гайхалтай гэдгийг мэдэрдэг, улмаар тэдний дунд хязгааргүй их хүч үүсдэг. Энэ бол айдас, эсвэл түр зуурын хайр, хүндлэл биш, харин хүнийг гэсэн Бурханы энэрэл, хүлээцтэй байдлын тухай гүн гүнзгий мэдрэмж юм. Гэвч, Түүний гэсгээлт, шүүлтийг туулсан хүмүүс сүр жавхланг нь мэдэрч, Тэр ямар ч халдлагыг тэвчдэггүй гэдгийг мэдэрдэг. Түүний ихээхэн ажлыг туулсан хүмүүс хүртэл Түүнийг ойлгож чаддаггүй; Түүнийг үнэн голоосоо хүндэлдэг бүх хүн Бурханы ажил хүний үзэлтэй нийцдэггүй, хүний үзэлтэй үргэлж сөргөлддөг гэдгийг мэддэг. Хүмүүс бишрэлээр дүүрэн байж, Өөрийг нь дагаж байгаа мэт царайлах нь Түүнд хэрэггүй; харин ч жинхэнэ хүндлэл, жинхэнэ дуулгавартай байдал л хэрэгтэй. Бурханы ихээхэн ажилд, жинхэнэ туршлагатай хэн боловч Бурханыг хүндэлдэг ба энэ нь зүгээр нэг бишрэлээс илүү юм. Хүмүүс Бурханы гэсгээлт, шүүлтийн ажлаас үүдэн Түүний зан чанарыг харсан бөгөөд тиймээс зүрхнийхээ угаас Бурханыг хүндэтгэн биширдэг. Бурханыг хүн хүндэлж, дуулгавартай дагах учиртай, учир нь Түүний оршихуй болон зан чанар бүтээгдсэн зүйлийнхтэй адилгүй, үүнээс дээгүүр юм. Бурхан бол өөрөө оршин тогтнодог, үүрд мөнхийн, бүтээгдсэн бус зүйл бөгөөд Бурханыг л хүндэлж, дуулгавартай дагавал зохино; хүн ийм шаардлага хангадаггүй. Тиймээс, Бурханы ажлыг туулсан, Бурханыг жинхэнээсээ мэддэг хүмүүс Түүнийг хүндэлдэг. Харин Түүний талаарх үзлээ орхидоггүй—Түүнийг Бурхан гэж ер үздэггүй хүмүүст—Бурханыг гэх хүндлэл байдаггүй, хэдийгээр тэд Бурханыг дагадаг ч байлдан дагуулагддаггүй; тэд бол угаасаа дуулгаваргүй хүмүүс юм. Бүтээгдсэн бүх зүйл Бүтээгчийг хүндэлдэг зүрх сэтгэлтэй болж, Түүнд шүтэн мөргөж, ямар ч болзолгүйгээр Түүний ноёрхолд захирагдах үр дүнд хүрэхийн тулд Тэрээр ингэж ажилладаг. Энэ бол Түүний бүх ажлын хүрэхээр зорьж буй эцсийн үр дүн юм. Хэрвээ ийм ажлыг туулсан хүмүүс Бурханыг өчүүхэн ч хүндэлдэггүй бол, мөн урьдын дуулгаваргүй байдал нь огтхон ч өөрчлөгддөггүй бол таягдан хаягдах нь гарцаагүй. Хэрвээ Бурханыг гэх хүний хандлага зөвхөн бишрэх юм уу зайнаас хүндлэх явдал боловч Түүнийг өчүүхэн ч хайрладаггүй бол энэ нь Бурханыг хайрлах сэтгэлгүй хүний хүрсэн үр

дүн бөгөөд ийм хүнд төгс болгуулах нөхцөл дутдаг. Хэрвээ ийм их ажил хүний жинхэнэ хайрыг олж авч чадахгүй бол ийм хүн Бурханыг олж аваагүй бөгөөд үнэнийг жинхэнээсээ эрэлхийлдэггүй. Бурханыг хайрладаггүй хүн үнэнийг хайрладаггүй, тиймээс Бурханыг олж авч чаддаггүй, Бурханы сайшаалыг хүртэж бүр ч чаддаггүй. Ийм хүмүүс Ариун Сүнсний ажлыг яаж ч туулж, шүүлтийг яаж ч туулсан бай, Бурханыг хүндэлж чаддаггүй. Тэд бол уг чанар нь өөрчлөгдөшгүй, туйлын хорон муу зан чанартай хүмүүс юм. Бурханыг хүндэлдэггүй бүх хүн таягдан хаягдаж, шийтгэлийн бай болж, ёрын мууг үйлддэг хүмүүсийн адилаар шийтгүүлж, зөв шударга бусыг үйлдсэн хүмүүсээс ч илүү зовох болно.

БУРХАНЫ АЖЛЫН ГУРВАН ҮЕ ШАТЫГ МЭДЭХ НЬ БУРХАНЫГ МЭДЭХ ЗАМ ЮМ

Хүн төрөлхтнийг удирдах ажил нь гурван үе шатанд хуваагддаг, энэ нь хүн төрөлхтнийг аврах ажил гурван үе шатанд хуваагддаг гэсэн үг юм. Энэ гурван үе шат нь дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй, харин Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе болон Хаанчлалын эрин үеийн ажлын гурван үе шат юм. Дэлхийг бүтээх ажил нь бүхий л хүн төрөлхтнийг бий болгох ажил байсан. Энэ нь хүн төрөлхтнийг аврах ажил байгаагүй бөгөөд хүн төрөлхтнийг аврах ажилтай ямар ч хамаагүй, учир нь дэлхий ертөнц бүтээгдэх үед хүн төрөлхтнийг Сатан ялзруулаагүй байсан тул хүн төрөлхтнийг аврах ажлыг гүйцэтгэх хэрэггүй байлаа. Хүн төрөлхтнийг аврах ажил нь хүн төрөлхтөн ялзарсан үеэс л эхэлсэн ба хүн төрөлхтнийг удирдах ажил ч бас хүн төрөлхтөн ялзарсан үеэс л эхэлсэн. Өөрөөр хэлбэл, хүнийг удирдах Бурханы удирдлага нь хүн төрөлхтнийг аврах ажлын үр дүнд эхэлсэн бөгөөд дэлхийг бүтээх ажлаас болж үүсээгүй. Хүн төрөлхтөн ялзарсан зан чанартай болсны дараа л удирдлагын ажил бий болсон, иймд хүн төрөлхтнийг удирдах ажил дөрвөн үе шат юм уу дөрвөн эрин үеийг биш, харин гурван хэсгийг агуулдаг. Зөвхөн энэ л зөв хэллэг юм. Сүүлчийн эрин үе төгсөх үед хүн төрөлхтнийг удирдах ажил бүрэн төгсгөлдөө очсон байх болно. Удирдлагын ажлын төгсгөл гэдэг нь бүх хүн төрөлхтнийг аврах ажил бүрэн дуусаж, тэр үеэс эхлэн хүн төрөлхтний хувьд энэ үе шат дууссан байх болно гэсэн үг юм. Бүх хүн төрөлхтнийг аврах ажилгүйгээр хүн төрөлхтнийг удирдах ажил гэж байхгүй, ажлын гурван үе шат ч гэж байхгүй. Яг нарийндаа хүн төрөлхтний доройтлын улмаас, мөн хүн төрөлхтөнд аврал маш яаралтай

хэрэгтэй байсан учраас л Ехова дэлхийн бүтээлийг төгсгөж, Хуулийн эрин үеийн ажлыг эхэлсэн. Тэр үед л хүн төрөлхтнийг удирдах ажил эхэлсэн, өөрөөр хэлбэл, тэр үед л хүн төрөлхтнийг аврах ажил эхэлсэн юм. “Хүн төрөлхтнийг удирдах” гэдэг нь газар дээр шинээр бүтээгдсэн хүн төрөлхтний (өөрөөр хэлбэл, хараахан ялзраагүй хүн төрөлхтний) амьдралыг чиглүүлэх гэсэн үг биш. Харин энэ нь Сатаны ялзруулсан хүн төрөлхтнийг аврах, өөрөөр хэлбэл, ялзарсан хүн төрөлхтнийг өөрчлөх явдал юм. Энэ нь “хүн төрөлхтнийг удирдахын” утга учир билээ. Хүн төрөлхтнийг аврах ажил нь дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй учраас хүн төрөлхтнийг удирдах ажил ч бас дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй, харин дэлхийн бүтээлээс ангид ажлын гурван үе шатыг хамардаг. Хүн төрөлхтнийг удирдах ажлыг ойлгохын тулд, гурван үе шатны ажлын түүхийг мэдэж байх шаардлагатай—энэ бол аврагдахын тулд хүн бүрийн мэдэж байх ёстой зүйл юм. Бурханы бүтээл болохын хувьд та нар хүнийг Бурхан бүтээсэн гэдгийг мэдэх ёстой, хүн төрөлхтний ялзалын эх сурвалжийг, түүнчлэн хүний аврагдах үйл явцыг мэдэх ёстой. Та нар Бурханы тааллыг хүртэхийн тулд дүрэм журмын дагуу хэрхэн үйлдэхийг л мэддэг боловч Бурхан хүн төрөлхтнийг хэрхэн авардаг талаар болон хүн төрөлхтний ялзалын эх сурвалжийн талаар мэдэхгүй бол Бурханы бүтээлийн хувиар та нарт дутагдаж байгаа зүйл энэ юм. Чи Бурханы удирдлагын ажлын илүү өргөн хүрээний талаар мэдэхгүй мөртөө хэрэгжүүлж болох эдгээр үнэнийг ойлголоо гээд сэтгэл ханах ёсгүй—ингэдэг бол чи хэтэрхий ягшмал үзэлтэй юм. Ажлын гурван үе шат нь Бурхан хүнийг удирдахын дотоод түүх, бүхий л дэлхий ертөнцийн сайн мэдээний ирэлт, бүх хүн төрөлхтний дундах хамгийн агуу нууц төдийгүй сайн мэдээг түгээх суурь билээ. Хэрвээ чи зөвхөн өөрийн амьтай холбоотой энгийн үнэнийг ойлгоход анхаараад бүх нууц болон үзэгдлээс хамгийн агуу нь болох энэ зүйлийн талаар юу ч мэдэхгүй бол чиний амь харахаас цаашгүй, гологдол бараатай адил байх бус уу?

Хүн зөвхөн хэрэгжүүлэлт дээр л төвлөрөөд Бурханы ажил болон хүний мэдэх ёстой зүйлийг хоёрдогч зүйл гэж үзвэл ялихгүй юманд ямааны гарз болох биш үү? Чи мэдэх ёстой зүйлээ мэдэх ёстой; хэрэгжүүлэх ёстой зүйлээ хэрэгжүүлэх л ёстой. Энэ л үнэнийг эрж хайдаг хүн юм. Сайн мэдээ түгээх цаг чинь ирэхэд хэрвээ чи, Бурхан бол агуу бөгөөд зөвт Бурхан, дээдийн дээд Бурхан, ямар ч агуу хүнтэй харьцуулшгүй Бурхан, Тэр бол бүхнээс дээд Бурхан... хэмээх эдгээр хамаа намаагүй, өнгөц үгийг хэлж, чухал ач холбогдолтой, мөн чанартай үг хэлж тун чадахгүй байвал; хэрвээ чи Бурханыг мэдэх талаар юм уу Бурханы ажлын талаар хэлэх үггүй, түүнчлэн үнэнийг тайлбарлаж, хүнийг дутагдаж байгаа

зүйлээр нь хангаж чадахгүй бол чам шиг хүн үүргээ сайн биелүүлж чадахгүй. Бурханд гэрчлэл хийж, хаанчлалын сайн мэдээ түгээх нь тийм ч энгийн зүйл биш. Чи эхлээд үнэнээр болон ойлгох ёстой үзэгдлээр зэвсэглэх ёстой. Чи Бурханы ажлын өөр өөр талуудын үзэгдэл болон үнэний талаар тодорхой мэддэг болох үедээ зүрх сэтгэлдээ Бурханы ажлыг мэдэж авах бөгөөд зөвт шүүлт ч бай, цэвэршүүлэлт ч бай, Бурхан юу хийхээс үл хамааран хамгийн агуу үзэгдлийг өөрийн суурь болгон эзэмшиж, хэрэгжүүлэх зөв үнэнийг мөн эзэмших ба ингэснээр Бурханыг эцсээ хүртэл дагаж чадна. Бурхан ямар ч ажил хийлээ гэсэн ажлынх нь зорилго өөрчлөгддөггүй, Түүний ажлын гол цөм өөрчлөгддөггүй бөгөөд хүний төлөө гэх Түүний хүсэл өөрчлөгддөггүй гэдгийг чи мэдэх ёстой. Түүний үг хэчнээн хатуу байсан ч, орчин нөхцөл хэчнээн бэрх байсан ч Түүний ажлын зарчим өөрчлөгдөхгүй ба хүнийг аврах Түүний санаа зорилго өөрчлөгдөхгүй. Энэ нь хүний төгсгөл юм уу хүний хүрэх газрын талаарх илчлэлийн ажил биш, сүүлчийн шатны ажил биш, Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөг төгсгөх ажил биш л бол, мөн Тэрээр хүнийг хүн болгох цаг үед байгаа л бол Түүний ажлын гол цөм өөрчлөгдөхгүй. Түүний ажлын гол цөм үргэлж хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг; Бурханд итгэх итгэлийн чинь суурь энэ байх ёстой. Ажлын гурван үе шатны зорилго нь бүх хүн төрөлхтнийг аврах буюу Сатаны эзэмшлээс хүнийг бүрэн аврах явдал юм. Ажлын гурван үе шат нь дор бүрнээ өөр өөр зорилго, ач холбогдолтой хэдий ч тус бүрдээ хүн төрөлхтнийг аврах ажлын нэг хэсэг бөгөөд хүн төрөлхтний шаардлагаас хамааран явагдсан авралын өөр өөр ажил билээ. Чи ажлын энэ гурван үе шатны зорилгыг мэддэг болмогцоо ажлын үе шат бүрийн ач холбогдлыг хэрхэн ойлгохоо мэддэг болж, Бурханы хүслийг хангалуун байлгахын тулд хэрхэн үйлдэхээ ойлгох болно. Хэрвээ чи энэ цэгт хүрч чадвал энэхүү хамгийн агуу үзэгдэл Бурханд итгэх итгэлийн чинь суурь болно. Чи зөвхөн хэрэгжүүлэх амархан замыг юм уу гүн гүнзгий үнэнийг эрж хайх ёсгүй, харин үзэгдлийг хэрэгжүүлэлттэй хослуулах ёстой, тэгснээр хэрэгжүүлж болох үнэн болон үзэгдэлд үндэслэсэн мэдлэг хоёулаа байх болно. Тэр үед л чи үнэнийг бүрэн дүүрэн эрэлхийлдэг хүн болно.

Ажлын гурван үе шат нь Бурханы бүхий л удирдлагын гол цөм бөгөөд Бурханы зан чанар болон Тэр юу болох нь ажлын гурван үе шатаар илэрхийлэгддэг. Бурханы ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс нь Бурхан Өөрийнхөө зан чанарыг хэрхэн илэрхийлдгийг ухаарч чаддаггүй, мөн Бурханы ажлын мэргэн ухааныг ч мэддэггүй. Тэд бас хүн төрөлхтнийг авардаг Түүний

олон арга зам болон бүх хүн төрөлхтний төлөөх Түүний хүслийн талаар мэдэхгүй хэвээр үлддэг. Ажлын гурван үе шат нь хүн төрөлхтнийг аврах ажлын бүрэн илэрхийлэл билээ. Ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс Ариун Сүнсний ажилладаг олон янзын арга зам болон зарчмыг мэдэхгүй байх болно, мөн ажлын тодорхой нэг үе шатнаас үлдсэн дүрэм журмыг л чандлан баримталдаг хүмүүс нь Бурханыг дүрэм журмаар хязгаарладаг хүмүүс бөгөөд Бурханд итгэх тэдний итгэл тодорхойгүй байдаг. Тийм хүмүүс хэзээ ч Бурханы авралыг хүлээн авахгүй. Бурханы ажлын гурван үе шат л Бурханы бүхий л зан чанарыг бүрэн илэрхийлж чадна, мөн бүх хүн төрөлхтнийг аврах Бурханы санаа зорилго болон хүн төрөлхтний авралын бүхий л үйл явцыг бүрэн дүүрэн илэрхийлж чадна. Энэ бол Бурхан Сатаныг ялж, хүн төрөлхтнийг олж авсны баталгаа, Бурханы ялалтын баталгаа, мөн Бурханы бүхий л зан чанарын илэрхийлэл юм. Бурханы ажлын гурван үе шатнаас нэг үе шатыг нь л ойлгодог хүмүүс Бурханы зан чанарын зөвхөн нэг хэсгийг л мэддэг. Ажлын энэ нэг л үе шат нь хүний үзэлд дүрэм журмыг амархан бий болгож, Бурханыг амархан тодорхойлдог ба Бурханы зан чанарын энэ ганц хэсгийг Бурханы бүхий л зан чанарын төлөөлөл болгон хэрэглэдэг. Түүнчлэн хүний ихэнх төсөөлөл дотроо холилдсон байдаг, ингэснээр хүн Бурханы зан чанар, оршихуй, мэргэн ухаан болон Бурханы ажлын зарчмыг хязгаарлагдмал цар хүрээн дотор чандлан хязгаарлаж, Бурхан нэг удаа ийм байсан бол үргэлж ийм хэвээрээ үлдэж, хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж итгэдэг. Ажлын гурван үе шатыг мэддэг, ойлгодог хүмүүс л Бурханыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдэж чадна. Ядаж л тэд Бурханыг израильчуудын юм уу иудейчүүдийн Бурхан гэж тодорхойлохгүй, мөн Түүнийг хүн төрөлхтний төлөө үүрд загалмай дээр цовдлогдох Бурхан гэж үзэхгүй. Хэрвээ хүн Бурханыг ажлынх нь нэг үе шатнаас л мэдэж авбал мэдлэг нь хэтэрхий өчүүхэн бөгөөд далай дахь нэг дуслас цаашгүй юм. Тийм биш бол шашны хуучинсаг үзэлтнүүд яагаад Бурханыг амьдаар нь загалмайд цовдлох юм бэ? Энэ нь, хүн Бурханыг тодорхой цар хүрээн дотор хязгаарладгаас болдоггүй гэж үү? Олон хүн Бурханы янз бүрийн өөр өөр ажлыг мэддэггүй учраас, түүнчлэн дуслын төдий мэдлэг, хоосон сургаалаар Ариун Сүнсний ажлыг хэмждэг учраас Бурханыг эсэргүүцэж, Ариун Сүнсний ажилд саад болдоггүй гэж үү? Тийм хүмүүсийн туршлага өнгөцхөн байдаг хэдий ч тэд уг чанартаа биеэ тоосон, өөрсдийгөө өөгшүүлсэн байдаг бөгөөд Ариун Сүнсний ажлыг басамжилж, Ариун Сүнсний сахилгажуулалтыг үл ойшоодог төдийгүй Ариун Сүнсний ажлыг “баталгаажуулахын” тулд өөрсдийн хуучирсан, ялихгүй

ёс зүйг ашигладаг. Тэд бас дүр эсгэж, өөрсдийнхөө эрдэм мэдлэгтэй гэдэгт болон дэлхийг хөндлөн гулд туулах чадвартай гэдэгтээ бүрэн итгэлтэй байдаг. Тийм хүмүүс нь Ариун Сүнсний жигшин голдог хүмүүс биш гэж үү, мөн тэднийг шинэ эрин үе таягдан хаяхгүй гэж үү? Бурханы өмнө ирж, Түүнийг илт эсэргүүцдэг энэ хүмүүс бол зүгээр л хэчнээн гайхалтай болохоо үзүүлэхээр оролдож байгаа мэдлэггүй, мэдээлэлгүй өөдгүй амьтад биш үү? Тэд Библийн хомс мэдлэгээрээ дэлхийн “академид” цадиггүй авирлахыг хичээж, хүмүүст заах өнгөц сургаалаараа Ариун Сүнсний ажлыг өөрчлөхийг хичээж, үүнийг өөрсдийнхөө бодлын дагуу байлгахаар оролддог. Мөн алсын хараагүй юм байж Бурханы 6,000 жилийн ажлыг нэг дор халт харахаар хичээдэг. Энэ хүмүүст дурдвас зохистой эрүүл ухаан гэж огт байхгүй? Үнэндээ хүн Бурханы талаар хэдий чинээ их мэдлэгтэй байна, Түүний ажлыг шүүхдээ төдий чинээ алгуурладаг. Цаашлаад тэд өнөөдрийн Бурханы ажлын талаарх өөрсдийн мэдлэгийг жаахан л ярьдаг боловч шүүмжлэх гэж яардаггүй. Хүмүүс Бурханыг хэдий чинээ бага мэднэ, төдий чинээ биеэ тоосон, өөртөө хэт итгэлтэй байдаг ба Бурханы оршихуйг улам улайран тунхагладаг—гэвч тэд зөвхөн онол ярьдаг ба ямар ч бодит баримт байдаггүй. Тийм хүмүүс ямар ч үнэ цэнгүй. Ариун Сүнсний ажлыг тоглоом гэж үздэг хүмүүс хөнгөн хуумгай юм! Ариун Сүнсний шинэ ажилтай учрах үедээ хянуур байдаггүй, харин ам хуурайгүй чалчиж, хурдан шүүдэг хүмүүс, Ариун Сүнсний ажлын зөв зүйтэй байдлыг дур зоргоороо үгүйсгэдэг, мөн доромжилж гутаадаг, ийм бүдүүлэг хүмүүс нь Ариун Сүнсний ажлыг мэддэггүй бус уу? Цаашлаад тэд асар их биеэ тоосон, төрөлхийн бардам, задарсан хүмүүс биш гэж үү? Тийм хүмүүс Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх өдөр ирлээ ч гэсэн Бурхан тэднийг тэвчихгүй. Тэд Бурханы төлөө ажилладаг хүмүүсийг дорд үзээд зогсохгүй, Бурханыг Өөрийг нь доромжилдог. Тийм найдваргүй хүмүүс энэ эрин үед ч, дараагийн эрин үед ч уучлагдахгүй, тамд үүрд мөхөх болно! Тийм бүдүүлэг, дураараа хүмүүс Бурханд итгэж байгаа дүр үзүүлдэг ба хүмүүс ийм байх тусмаа Бурханы захиргааны зарлигийг амархан зөрчих магадлалтай байдаг. Төрөлхийн задарсан, хэзээ ч хэнд ч дуулгавартай байгаагүй, биеэ тоосон тэр хүмүүс бүгд энэ замаар алхдаг биш үү? Үргэлж шинээрээ, хэзээ ч хуучин байдаггүй Бурханыг тэд өдрөөс өдөрт эсэргүүцдэггүй гэж үү? Өнөөдөр та нар Бурханы ажлын гурван үе шатны чухал ач холбогдлыг яагаад мэдэх ёстойгоо ойлгох хэрэгтэй. Миний хэлж байгаа үг та нарт ач тустай бөгөөд зүгээр дэмий хоосон яриа биш. Хэрвээ та нар эдгээрийг зүгээр л морин дэл дээр давхингаа цэцэгсийг бахдах мэт уншвал Миний шаргуу

ажил талаар өнгөрөх бус уу? Та нар дор бүрнээ өөрсдийн уг чанарыг мэдэх ёстой. Ихэнх хүн маргалдахдаа сайн байдаг ба онолын асуултуудад түгдрэлгүй хариулдаг боловч мөн чанартай холбоотой асуултуудад юу ч хэлж чаддаггүй. Өнөөдөр ч гэсэн та нар дэмий зүйл ярьж, хуучин зан чанараа өөрчилдөггүй ба та нарын ихэнх чинь илүү өндөр дээд үнэнд хүрэхийн тулд эрэлхийлдэг замаа өөрчлөхийг боддоггүй, харин идэвх зүтгэлгүй амьдардаг. Тийм хүмүүс Бурханыг яаж эцэст нь хүртэл дагаж чадах юм бэ? Та нар аргалаад замын төгсгөлд хүрлээ ч гэсэн, энэ нь та нарт ямар ашиг тустай байх юм бэ? Хэтэрхий оройтохоосоо өмнө санаагаа өөрчилж, нэг бол үнэхээр эрэлхийлж, эсвэл эртхэн больсон нь дээр. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр та нар бусдыг мөлжигч болно—та нар тийм дорд, жигшүүртэй үүрэг гүйцэтгэхийг хүсэж байна уу?

Ажлын гурван үе шат нь Бурханы бүхий л ажлын тэмдэглэл, хүн төрөлхтнийг аврах Бурханы авралын тэмдэглэл бөгөөд санаанаас зохиосон зүйл биш. Хэрвээ та нар Бурханы бүхий л зан чанарын талаарх мэдлэгийг эрж хайхыг үнэхээр хүсвэл Бурханы гүйцэтгэсэн ажлын гурван үе шатыг мэдэх ёстой, түүнчлэн ямар нэг үе шатыг нь орхигдуулах ёсгүй. Энэ бол Бурханыг мэдэхээр эрж хайдаг хүмүүсийн биелүүлэх ёстой наад захын зүйл юм. Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийг хүн өөрөө зохиож чадахгүй. Энэ нь хүний өөрийн төсөөлж чадах зүйл биш, мөн ганцхан хүнд зориулсан Ариун Сүнсний тусгай ивээлийн үр дүн ч биш. Харин энэ нь хүн Бурханы ажлыг туулсны дараа гардаг мэдлэг бөгөөд Бурханы ажлын баримтуудыг туулсны дараа л гарч ирдэг Бурханы тухай мэдлэг юм. Тийм мэдлэгийг амархан олж авч болдоггүй, үүнийг мөн заалгаж ч болдоггүй. Энэ нь бүхэлдээ хувийн туршлагатай холбоотой. Ажлын гурван үе шатны гол цөм нь хүн төрөлхтнийг аврах Бурханы аврал юм, гэхдээ авралын ажил дотор, ажиллах хэд хэдэн арга барил болон Бурханы зан чанарыг илэрхийлэх арга агуулагдаж байдаг. Үүнийг ялган таних нь хүний хувьд хамгийн хэцүү байдаг ба хүн ойлгоход хэцүү байдаг. Эрин үеүдийн зааг, Бурханы ажил дахь өөрчлөлт, ажлын байршил дахь өөрчлөлт, энэ ажлын хүлээн авагч дахь өөрчлөлт гэх мэт нь бүгдээрээ ажлын гурван үе шатанд багтдаг. Ялангуяа, Ариун Сүнсний ажиллах арга зам дахь ялгаа, түүнчлэн Бурханы зан чанар, дүр, нэр, ялгамж чанар дахь хувиралт болон бусад өөрчлөлт нь бүгдээрээ ажлын гурван үе шатны нэг хэсэг юм. Ажлын нэг үе шат нь нэг хэсгийг л төлөөлж чаддаг ба тодорхой цар хүрээн дотор хязгаарлагддаг. Энэ нь бусад тал байтугай эрин үеүдийн зааг юм уу Бурханы ажилд гарсан өөрчлөлтийг агуулдаггүй. Энэ нь мэдээж илэрхий баримт юм. Ажлын гурван үе шат нь хүнийг аврах Бурханы

ажлын бүрэн дүүрэн байдал билээ. Хүн бүхэн Бурханы авралын ажлаас Түүний ажил болон зан чанарыг мэдэх ёстой, энэ баримтгүйгээр Бурханы талаарх мэдлэг чинь хоосон үг, хийсвэр онолоос л бүрддэг. Тийм мэдлэг нь хүнийг үнэмшүүлж ч чадахгүй, байлдан дагуулж ч чадахгүй; энэ нь бодит байдалтай нийцэхгүй бөгөөд үнэн биш юм. Энэ нь маш элбэг арвин, чихэнд чимэгтэй байсан ч гэсэн, Бурханы төрөлх зан чанарын тухай мэдлэгтэй нийцэхгүй бол Бурхан чамайг өршөөхгүй. Тэр чиний мэдлэгийг сайшаахгүйгээр үл барам Түүнийг доромжилсон ял оноож чамайг залхаан цээрлүүлэх болно. Бурханыг мэдэх үгийг хөнгөн хуумгай ярихаар болчихдог юм биш. Чи хэлэмгий доломгой, уран үгтэй бөгөөд үг чинь харыг цагаан, цагааныг хар болтол маргаж чадахуйц үнэхээр ухаалаг байсан ч Бурханы тухай мэдлэгийг ярина гэдэг чиний чадвараас давна. Бурхан бол чиний яаран шүүж, хамаагүй магтаж, хайхрамжгүйгээр гүтгэж болдог нэгэн биш. Чи хаа хамаагүй хүн бүхнийг магтдаг хэр нь Бурханы эрхэм дээд нигүүлслийг дүрслэхэд тохирох үг олох гэж чармайдаг—энэ нь бүтэлгүйтсэн хүн бүрийн сурч авсан зүйл юм. Маш олон хэлний мэргэжилтэн Бурханыг дүрслэх чадвартай хэдий ч тэдний дүрсэлдэг зүйлийн үнэн зөв байдал нь, хязгаарлагдмал үгсийн сантай ч баялаг туршлага эзэмшсэн, Бурханд харьяалагддаг хүмүүсийн хэлсэн үнэний зууны нэгтэй л дүйцдэг. Тиймээс Бурханы талаарх мэдлэг нь үгийн ухаалаг хэрэглээ юм уу баялаг үгсийн санд биш, харин үнэн зөв, бодит байдалд оршдог бөгөөд хүний мэдлэг болон Бурханы тухай мэдлэг нь огтхон ч хамаагүй гэдгийг харж болно. Бурханыг мэдэх хичээл нь хүн төрөлхтний ямар ч байгалийн шинжлэх ухаанаас дээгүүр юм. Энэ нь Бурханыг мэдэхээр эрж хайж байгаа тун цөөн хүний л сурч чадах хичээл болохоос авьяас чадвартай ямар ч хүний хүрч чадах зүйл биш юм. Иймээс та нар Бурханыг мэдэх болон үнэнийг эрэлхийлэх явдлыг хүүхэд ч хийж чадах зүйл гэж үзэх ёсгүй. Чи гэр бүлийн амьдрал, ажил мэргэжил, гэрлэлтдээ бүрэн амжилт гаргасан байж болох ч үнэн болон Бурханыг мэдэх хичээлийн тухайд гэвэл үзүүлэх зүйл юу ч үгүй, юунд ч хүрээгүй байдаг. Та нарын хувьд үнэнийг хэрэгжүүлэх тун хэцүү бөгөөд Бурханыг мэдэх нь бүр ч том хэцүү асуудал гэж хэлж болно. Энэ нь та нарын бэрхшээл, мөн энэ нь бүх хүн төрөлхтөнд тулгардаг бэрхшээл юм. Бурханыг мэдэх үйлсэд зарим нэг ахиц гаргасан хүмүүсийн дотор, стандартад нийцэх бараг хэн ч байдаггүй. Бурханыг мэднэ гэдэг нь юу гэсэн үг болохыг, яагаад Бурханыг мэдэх шаардлагатайг, Бурханыг мэдэхийн тулд ямар түвшинд хүрэх ёстойг хүн мэддэггүй. Энэ нь хүн төрөлхтний хувьд маш будилаантай зүйл бөгөөд үнэхээр хүн төрөлхтөнд тулгарсан хамгийн

том оньсого болсон юм—хэн ч энэ асуултад хариулж чаддаггүй, хэн ч энэ асуултад хариулахыг хүсдэггүй, учир нь өнөөг хүртэл хүн төрөлхтний дотроос хэн ч энэ ажлын судалгаанд амжилт гаргаж байгаагүй. Ажлын гурван үе шатны оньсого хүмүүст тайлагдах үед Бурханыг мэддэг авьяастай бүлэг хүмүүс ээлж дараалан гарч ирж магад юм. Мэдээж ийм байгаасай гэж Би найдаж байна, түүнчлэн Би энэ ажлыг биелүүлэх явцдаа явж байгаа бөгөөд ойрын ирээдүйд тийм авьяастнууд гарч ирэхийг харна гэж найдаж байна. Тэд ажлын энэ гурван үе шатны баримтыг гэрчлэх хүмүүс болох ба мэдээж ажлын энэ гурван үе шатыг ч гэсэн гэрчлэх эхний хүмүүс байх юм. Гэхдээ Бурханы ажил төгсөх өдөр тийм авьяастнууд гарч ирэхгүй юм уу эсвэл бие махбодтой болсон Бурханаар төгс болгуулахыг биечлэн хүлээн зөвшөөрсөн хүн ганц хоёрхон байгаа бол энэ нь хүнийг хамгаас их шаналган зовоож, харамсалд хүргэх зүйл болох болно. Гэхдээ энэ нь зүгээр л хамгийн муугаар бодсон тохиолдол юм. Юу ч болсон гэсэн, үнэхээр эрэлхийлдэг хүмүүс энэ ерөөлийг олж авч чадна гэж Би одоо ч найдаж байна. Цаг хугацааны эхлэлээс хойш ийм ажил урьд нь хэзээ ч байгаагүй; хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд ийм үйл ажиллагаа хэзээ ч тохиолдож байгаагүй. Хэрвээ чи үнэхээр Бурханыг мэддэг эхний хүмүүсийн нэг болж чадвал бүх бүтээл дундах хамгийн дээд нэр төрийн хэрэг болохгүй гэж үү? Энэ нь, хүн төрөлхтний дундаас Бурханд хамгаас илүү сайшаагдсан бүтээл биш гэж үү? Тийм ажлыг хийхэд амархан биш боловч эцэст нь үр дүндээ хүрэх болно. Хүйс, үндэс угсаанаасаа үл хамааран Бурханыг мэддэг бүх хүн бол эцэстээ Бурханы хамгийн агуу алдар сууг хүлээн авч, Бурханы эрх мэдлийг эзэмшдэг цорын ганц хүмүүс байх болно. Энэ бол өнөөдрийн ажил, мөн түүнчлэн ирээдүйн ажил билээ; энэ нь 6,000 жилийн ажил дахь эцсийн, хамгийн дээд ажил бөгөөд төрөл бүрийн хүнийг илчилдэг нэг төрлийн ажиллах арга зам юм. Хүнд Бурханыг мэдүүлэх ажлаар дамжин хүний өөр өөр зэрэглэл илчлэгддэг: Бурханыг мэддэг хүмүүс нь Бурханы ерөөлийг хүртэж, Түүний амлалтыг хүлээн авахад тохирдог байхад Бурханыг мэддэггүй хүмүүс Бурханы ерөөлийг хүртэж, Түүний амлалтыг хүлээн авахад тэнцдэггүй. Бурханыг мэддэг хүмүүс бол Бурханы дотнын хүмүүс бөгөөд Бурханыг мэддэггүй хүмүүсийг Бурханы дотнын хүмүүс гэж нэрлэж болохгүй; Бурханы дотнын хүмүүс нь Бурханы ямар ч ерөөлийг хүлээн авч чадна, харин Түүнтэй дотно биш хүмүүс Түүний ажлын юуг ч биелүүлж чадахгүй. Гай зовлон, цэвэршүүлэлт, шүүлт ч бай, эдгээр зүйл нь бүгд эцсийн эцэст хүнийг Бурханы талаарх мэдлэгт хүргэж, Бурханд захирагдахын төлөө байдаг. Энэ бол эцэстээ хүрэх цорын ганц үр дүн

юм. Ажлын гурван үе шатыг бүгдийг нээлттэй болгох нь Бурханы талаарх хүний мэдлэгт ашигтай бөгөөд Бурханы талаар бүрэн дүүрэн, нэгд нэггүй мэдлэгийг олж авахад хүнд тусалдаг. Энэ бүх ажил хүнд тустай юм.

Бурханы Өөрийн ажил бол хүний мэдэх ёстой үзэгдэл юм, учир нь Бурханы ажлыг хүн биелүүлж чадахгүй ба хүн эзэмшдэггүй. Ажлын гурван үе шат нь Бурханы удирдлагын бүрэн дүүрэн байдал бөгөөд хүний мэдэх ёстой хамгийн агуу үзэгдэл юм. Хэрвээ хүн энэ хамгийн агуу үзэгдлийг мэдэхгүй бол Бурханыг мэдэхэд амаргүй, Бурханы хүслийг ойлгоход амаргүй байдаг төдийгүй хүн энэ замаар алхахад улам бүр бэрх болно. Үзэгдэлгүйгээр хүн өнөөдрийг хүрч чадахгүй байх байсан. Өнөөдрийг хүртэл үзэгдэл л хүнийг хамгаалж, хамгийн агуу хамгаалалтаар хүнийг хангасан. Ирээдүйд та нарын мэдлэг илүү гүнзгийрэх ёстой бөгөөд ажлын гурван үе шатан дахь Түүний бүх хүслийг болон Түүний ухаалаг ажлын мөн чанарыг мэдэж авах ёстой. Энэ л та нарын жинхэнэ биеийн хэмжээ юм. Ажлын сүүлчийн үе шат нь дангаараа байдаггүй, харин өмнөх хоёр үе шаттайгаа хамт бүрдүүлсэн бүхэл нэг цогц болдог бөгөөд өөрөөр хэлбэл, ажлын гурван үе шатны нэгийг нь л хийгээд авралын бүх ажлыг дуусгах боломжгүй. Ажлын сүүлчийн үе шат нь хүнийг бүрэн аварч чадах хэдий ч хүнийг Сатаны нөлөөнөөс аврахад энэ ганц үе шатыг л дангаар нь хэрэгжүүлэх хэрэгтэй, ажлын өмнөх хоёр үе шат нь шаардлагагүй гэсэн үг биш. Гурван үе шатны аль ч ганц үе шатыг бүх хүн төрөлхтний мэдэх ёстой цорын ганц үзэгдэл гэж тогтоож болохгүй, учир нь авралын ажлын бүрэн бүтэн байдал нь ажлын гурван үе шат болохоос тэдгээрийн дундах ганц үе шат биш. Авралын ажил биелээгүй цагт Бурханы удирдлага бүрэн төгсөж чадахгүй байх болно. Бурханы оршихуй, зан чанар болон мэргэн ухаан нь авралын ажлын бүрэн бүтэн байдалд илэрхийлэгдсэн байдаг бөгөөд бүр эхнээсээ хүнд илчлэгдэлгүй, харин авралын ажилд аажмаар илэрхийлэгдэж ирсэн билээ. Авралын ажлын үе шат бүр Бурханы зан чанарын нэг хэсгийг болон Түүний оршихуйн нэг хэсгийг илэрхийлдэг; харин ажлын ямар ч үе шат Бурханы оршихуйн бүрэн дүүрэн байдлыг шууд, бүрэн илэрхийлдэггүй. Тиймээс ажлын гурван үе шат дууссаны дараа авралын ажил бүрэн төгсөнө, иймээс хүн Бурханы бүрэн дүүрэн байдлыг мэдэхдээ Бурханы ажлын гурван үе шатаас салж болохгүй. Ажлын нэг үе шатнаас хүн ердөө Бурханы ажлын ганц хэсэгт илэрхийлэгдсэн зан чанарыг нь л олж авдаг билээ. Энэ нь өмнөх ба дараах үе шатанд илэрхийлэгдсэн зан чанар болоод оршихуйг төлөөлж чадахгүй. Учир нь, хүн төрөлхтнийг аврах ажлыг нэг цаг үед, эсвэл нэг газарт тэр дор нь дуусгаж болдоггүй, харин энэ нь

өөр өөр цаг үе, газрууд дахь хүний хөгжлийн түвшний дагуу аажмаар гүнзгийрдэг. Энэ нь үе шаттайгаар явагддаг ажил бөгөөд ганц үе шатанд дуусдаггүй. Иймээс Бурханы бүхий л мэргэн ухаан нь бие даасан нэг үе шатны оронд гурван үе шатанд биеждэг. Түүний бүхий л оршихуй болон бүхий л мэргэн ухаан нь энэ гурван үе шатанд оршдог бөгөөд үе шат бүр Түүний оршихуйг агуулж, Түүний ажлын мэргэн ухааны тэмдэглэл болдог. Хүн энэ гурван үе шатанд илэрхийлэгдсэн Бурханы бүхий л зан чанарыг мэдэх ёстой. Бурханы энэ бүх оршихуй нь бүх хүн төрөлхтөнд үнэхээр тун чухал байдаг ба хэрвээ хүмүүс Бурханыг шүтэхдээ үүнийг мэдэхгүй бол Буддаг шүтдэг хүмүүсээс ялгаагүй. Хүмүүсийн дундах Бурханы ажил бүх хүнд нээлттэй бөгөөд Бурханыг шүтэн мөргөдөг бүх хүн үүнийг мэддэг байх ёстой. Бурхан хүмүүсийн дунд авралын ажлын гурван үе шатыг хэрэгжүүлсэн учраас ажлын энэ гурван үе шатны туршид Түүнд юу байгаа болон Тэр юу болохын илэрхийллийг хүн мэдэх ёстой. Энэ нь хүний заавал хийх ёстой зүйл юм. Бурхан хүний биелүүлж чадахгүй, мөн хүний мэдэх ёсгүй зүйлийг хүнээс нуудаг, харин Бурхан хүний мэдэх ёстой, хүний эзэмших ёстой зүйлийг хүнд үзүүлдэг. Ажлын гурван үе шат нь дор бүрнээ өмнөх үеийнхээ суурин дээр хийгддэг; энэ нь авралын ажлаас тусдаа бие даан хийгдсэн ажил биш. Эрин үед болон хэрэгжүүлэх ажилд асар их ялгаа байдаг хэдий ч гол цөм нь мөн л хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг ба авралын ажлын үе шат бүр нь өмнөхөөсөө алхам алхмаар гүнзгийрдэг. Ажлын үе шат бүр нь өмнөх ажлыг хүчингүй болгохгүй байх суурин дээр үргэлжилдэг. Ийм байдлаар Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй ажлаараа хүнд урьд өмнө нь хэзээ ч илэрхийлж байгаагүй зан чанарынхаа талуудыг байнга илэрхийлж, шинэ ажил, шинэ оршихуйгаа хүнд үргэлж илчилж байдаг бөгөөд шашны хуучинсаг үзэлтнүүд үүнийг эсэргүүцэхийн тулд боломжтой бүхнийг хийж, илт эсэргүүцдэг боловч Бурхан хийхээр зорьсон шинэ ажлаа үргэлж хийдэг. Түүний ажил үргэлж өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнээс үүдэн хүний эсэргүүцэлтэй үргэлж тулгарч байдаг. Гэхдээ Түүний зан чанар төдийгүй Түүний ажлын эрин үе, хүлээн авагчид ч бас үргэлж өөрчлөгдөж байдаг. Түүнчлэн Тэр үргэлж өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийж, тэр ч байтугай өмнө нь хийсэн ажилтайгаа зөрчилдөж, харшилж байгаа мэт хүнд харагддаг ажлыг хэрэгжүүлж байдаг. Хүн нэг төрлийн ажил, хэрэгжүүлэх нэг арга замыг л хүлээн зөвшөөрч чаддаг. Тэдгээртэй зөрчилдсөн, эсвэл тэдгээрээс дээр ажил юм уу хэрэгжүүлэх аргыг хүлээн зөвшөөрөх нь хэцүү байдаг. Гэвч Ариун Сүнс үргэлж шинэ ажил хийж байдаг учраас Бурханы шинэ ажлыг

эсэргүүцдэг шашны мэргэжилтнүүдийн бүлэг ээлж дараалан гарч ирдэг. Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй тухай мэдлэг хүнд байдаггүй, Бурханы ажлын зарчмын мэдлэг байдаггүй, түүнчлэн хүнийг авардаг Бурханы олон арга замын талаарх мэдлэг байдаггүй учраас л энэ хүмүүс мэргэжилтнүүд болсон. Тиймээс энэ нь Ариун Сүнснээс ирдэг ажил уу, эсвэл Бурханы Өөрийн ажил уу гэдгийг хүн огт ялган салгах чадваргүй байдаг. Энэ нь өмнө нь хэлсэн үгтэй таарч байвал хүлээн зөвшөөрч, өмнөх ажлаас ялгаатай байвал эсэргүүцэж голох хандлагыг олон хүн баримталдаг. Өнөөдөр та нар бүгдээрээ тийм зарчмыг мөрддөггүй гэж үү? Авралын ажлын гурван үе шат та нарт ямар ч агуу үр нөлөө үзүүлээгүй бөгөөд өмнөх хоёр үе шатны ажил нь эгээ л мэдэх хэрэггүй ачаа гэж итгэдэг хүмүүс байдаг. Хүмүүсийг будилуулахаас зайлсхийхийн тулд ажлын гурван үе шатны эхний хоёр үе шатыг олон түмэнд тунхаглах ёсгүй, харин аль болох хурдан нуух ёстой гэж тэд боддог. Ажлын өмнөх хоёр үе шатыг мэдэгдэх нь илүүц алхам, энэ нь Бурханыг мэдэхэд ямар ч нэмэргүй гэж ихэнх хүн итгэдэг—энэ бол та нарын үзэл. Өнөөдөр ийм маягаар үйлдэх нь зөв гэж та нар бүгд итгэдэг боловч Миний ажлын чухал ач холбогдлыг ухаарах өдөр та нарт ирнэ: Би ямар ч ач холбогдолгүй ажил хийдэггүй гэдгийг мэдэж ав. Би ажлын гурван үе шатыг та нарт тунхаглаж байгаа тул энэ нь та нарт ач тустай байж л таарна; ажлын энэ гурван үе шат нь Бурханы бүхий л удирдлагын гол цөм тул орчлон ертөнц даяарх хүн бүрийн анхаарлыг татах нь гарцаагүй. Нэг өдөр та нар бүгдээрээ энэ ажлын чухал ач холбогдлыг ухаарах болно. Та нар Бурханы ажлын зарчмыг мэддэггүй, мөн Ариун Сүнсний ажилд хөнгөн хуумгай ханддаг учраас Бурханы ажлыг эсэргүүцэж, өөрсдийн үзлийг ашиглан өнөөдрийн ажлыг хэмждэг гэдгээ мэдэж ав. Та нар өөрсдийн үзэл болон төрөлхийн биеэ тоосон зангаасаа үүдэн Бурханыг эсэргүүцэж, Ариун Сүнсний ажилд саад болдог. Энэ нь Бурханы ажил буруугаас болдоггүй, харин та нар угаасаа хэтэрхий дуулгаваргүйгээс болдог. Зарим хүн Бурханд итгэсний дараа хүн хаанаас бий болсныг ч баттай хэлж чаддаггүй атлаа Ариун Сүнсний ажлын зөв, бурууг үнэлж, олон нийтийн өмнө үг хэлж зүрхэлдэг. Тэр ч байтугай тэд Ариун Сүнсний шинэ ажилтай элч нарт хүртэл сургаал айлдаж, гар хөлөө гозолзуулан, элий балай зүйл ярьдаг; тэдний хүн чанар хэтэрхий дорд бөгөөд тэдэнд өчүүхэн төдий ч эрүүл ухаан байдаггүй. Тийм хүмүүс Ариун Сүнсний ажилд гологдож, тамын галд шатаагдах өдөр ирэх бус уу? Тэд Бурханы ажлыг мэддэггүй, харин Түүний ажлыг шүүмжилж, мөн Түүнд хэрхэн ажиллахыг нь заахаар оролддог. Тийм ухаангүй хүмүүс Бурханыг яаж мэдэж чадах юм бэ? Хүн

Бурханыг эрж хайж, мэдрэх явцдаа Түүнийг мэдэж авдаг; харин Бурханыг дураараа шүүмжлэх явцдаа Ариун Сүнсний гэгээрлээр дамжуулан мэдэж авдаг юм биш. Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг хэдий чинээ үнэн зөв байна, тэд Түүнийг төдий чинээ бага эсэргүүцдэг. Харин хүмүүс Бурханыг хэдий чинээ бага мэднэ, Түүнийг төдий чинээ амархан эсэргүүцдэг. Чиний үзэл, чиний хуучин уг чанар, чиний хүн чанар, зан байдал, ёс суртахуун, үзэл баримтлал бол Бурханыг эсэргүүцэх хөрөнгө бөгөөд ёс суртахуун нь завхарсан, хэв чанар нь өөдгүй, хүн чанар нь дорд болох тусмаа чи төдий чинээ Бурханы дайсан байдаг. Үзэл ихтэй, өөрийгөө зөвтгөдөг зан чанартай хүмүүс бие махбодтой болсон Бурханд бүр ч их дайсагнадаг ба тийм хүмүүс бол антихристүүд юм. Хэрвээ чиний үзлийг залруулахгүй бол энэ чинь үргэлж Бурханы эсрэг байх болно; чи хэзээ ч Бурхантай нийцэлтэй байж чадалгүй, үргэлж Түүнээс тусдаа байх болно.

Хуучин үзлээ хойш тавьснаар л чи шинэ мэдлэгийг олж авч чадна, гэхдээ хуучин мэдлэг нь хуучин үзэлтэй заавал адил байх албагүй. “Үзэл” гэдэг нь хүний төсөөлсөн, бодит байдалтай нийцэхгүй зүйлсийг хэлдэг. Хэрвээ хуучин мэдлэг нь хуучин эрин үед аль хэдийн хоцрогдсон бөгөөд хүнийг шинэ ажилд ороход нь саад болдог бол ийм мэдлэг ч бас үзэл юм. Хүн ийм мэдлэгт зөв хандлага баримталж чадвал, мөн хуучин, шинэ хоёрыг хослуулснаар Бурханыг хэд хэдэн өөр талаас нь мэдэж чадвал тэрхүү хуучин мэдлэг нь хүнд нэмэр болж, шинэ эрин үед орох үндэс суурь нь болдог. Бурханыг мэдэх хичээл нь, Бурханы шинэ ажлын бүх зохицуулалтад захирагдахын тулд Бурханыг мэдэх замд хэрхэн орох, Бурханыг мэдэхийн тулд ямар үнэнийг ойлгох ёстой, өөрийн үзэл болон хуучин зан чанараас хэрхэн ангижрах зэрэг олон зарчмыг эзэмшихийг чамаас шаарддаг. Хэрвээ чи эдгээр зарчмыг Бурханыг мэдэх хичээлд орох суурь болгон ашиглавал мэдлэг чинь улам бүр гүн гүнзгий болно. Хэрвээ чи ажлын гурван үе шатны талаар, өөрөөр хэлбэл, Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний ажлын талаар тодорхой мэдлэгтэй бол, мөн хэрвээ чи Бурханы ажлын өмнөх хоёр үе шатыг одоогийн үе шаттай бүрэн хамааруулж, энэ нь нэг Бурханы хийсэн ажил юм гэдгийг харж чадвал хамгийн бат бэх суурь чинь энэ болно. Ажлын гурван үе шатыг нэг Бурхан хийсэн; энэ бол хамгийн агуу үзэгдэл бөгөөд Бурханыг мэдэх цорын ганц зам юм. Ажлын гурван үе шатыг Бурхан Өөрөө л хийж чадна, ямар ч хүн ийм ажлыг Түүний өмнөөс хийж чадахгүй—өөрөөр хэлбэл, эхлэлээс авхуулаад өнөөдрийг хүртэл Бурхан л Өөрийн ажлыг Өөрөө хийж чадна. Бурханы ажлын гурван үе шат хэдийгээр өөр өөр эрин үед, өөр өөр газарт явагдаж, мөн ажил бүр нь ялгаатай байсан ч энэ

нь бүгд нэг Бурханы хийсэн ажил юм. Бүх үзэгдлийн дотроос хүний мэдэх ёстой хамгийн агуу үзэгдэл энэ бөгөөд хүн үүнийг бүрэн ойлговол бат зогсож чадна. Өнөөдөр төрөл бүрийн шашин болон урсгалд тулгараад байгаа хамгийн том асуудал бол Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, Ариун Сүнсний ажил болон Ариун Сүнсний бус ажлыг ялган салгаж чаддаггүй, иймээс өмнөх хоёр үе шатны ажилтай адилаар энэ үе шатны ажлыг ч бас Ехова Бурхан хийсэн эсэхийг тэд тодорхой харж чадахгүй. Хэдийгээр ихэнх хүмүүс Бурханыг дагадаг ч энэ нь зөв зам эсэхийг хүмүүс одоо ч тодорхой харж чадахгүй. Энэ зам нь Бурхан Өөрөө биечлэн удирддаг зам мөн эсэх, бие махбодтой болсон Бурхан бодит эсэхэд хүн санаа зовдог бөгөөд ийм зүйлсийг хэрхэн ялган таних талаар ихэнх хүнд ямар ч сэжүүр байдаггүй. Бурханыг дагадаг хүмүүс замыг тодорхойлж чаддаггүй бол ярьсан сургаалууд нь энэ хүмүүсийн дунд үр дүнгээ бүрэн өгч чадалгүй, ердөө хагас хугас үр нөлөөтэй байдаг, энэ нь хүмүүсийн амийн оролтод нөлөөлдөг. Хэрвээ хүн ажлын гурван үе шатнаас, эдгээр нь өөр өөр цаг үед, өөр өөр газарт, өөр өөр хүмүүсийн дунд Бурханы Өөрийн хийсэн ажил юм гэдгийг харж чадвал; мөн ажил нь өөр байсан ч энэ бүгдийг нэг Бурхан хийсэн ба энэ нь нэг Бурханы хийсэн ажил тул алдаа мадаггүй зөв байж таарна, хэдийгээр хүний үзэлтэй зөрөлдөж байсан ч энэ нь нэг Бурханы хийсэн ажил мөн гэдгийг үгүйсгэх аргагүйг харж чадвал; хэрвээ хүн, энэ нь нэг Бурханы ажил мөн гэдгийг баттай хэлж чадвал хүний үзэл дурдахын ч хэрэггүй, ердөө ялихгүй зүйл болох болно. Хүний үзэгдэл тодорхой бус бөгөөд хүн зөвхөн Еховаг Бурхан, Есүсийг Эзэн гэж л мэдэн, өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы тухайд сэтгэл нь хоёрддог учраас олон хүн Ехова болон Есүсийн ажлаас салж ядан, өнөөдрийн ажлын талаар олон үзэлд баригддаг ба ихэнх хүн үргэлж эргэлзэн, өнөөдрийн ажлыг нухацтай авч үздэггүй. Ажлын үл үзэгдэх өмнөх хоёр үе шатны талаар хүнд ямар ч үзэл байдаггүй, учир нь хүн ажлын өмнөх хоёр шатны бодит байдлыг ойлгодоггүй ба тэдгээрийг өөрийн биеэр хараагүй юм. Ажлын энэ үе шатуудыг харж чадахгүй учраас хүн хүссэнээрээ төсөөлдөг; хүн юу ч төсөөллөө гэсэн ийм төсөөллийг батлах баримт байдаггүй, мөн засаж залруулах хүн ч байдаггүй. Хүн зан аашаа зоргоор нь тавьж, сэрэмж болгоомжоо салхинд хийсгээд, төсөөлөлдөө умбадаг, мөн энэ төсөөллийг батлах ямар ч баримт байхгүй учраас ямар нэг үндэслэл бий эсэхээс үл хамааран хүний төсөөлөл нь “баримт” болдог. Тиймээс хүн ой ухаандаа өөрийн төсөөлсөн Бурханд итгэн, бодит байдлын Бурханыг эрж хайдаггүй. Нэг хүнд нэг төрлийн итгэл байвал зуун хүний дунд зуун төрлийн итгэл байх болно. Хүн Бурханы ажлын бодит байдлыг

хараагүй учраас тийм итгэлийг эзэмшдэг, учир нь тэр үүнийг зөвхөн чихээр сонссоноос биш, нүдээр үзээгүй. Хүн үлгэр, домог сонссон байдаг боловч Бурханы ажлын баримтын талаарх мэдлэгийг сонссон байх нь ховор. Тиймээс нэг жил итгэсэн хүмүүс өөрсдийн үзлээр Бурханд итгэдэг. Насан туршдаа Бурханд итгэсэн хүмүүс ч бас тэгдэг. Баримтыг харж чаддаггүй хүмүүс Бурханы талаарх үзэл бүхий итгэлээсээ хэзээ ч мултарч чадахгүй. Өөрийгөө хуучин үзлийн хүлээсээс чөлөөлж, шинэ хүрээнд орлоо гэж хүн итгэдэг. Бурханы жинхэнэ царайг харж чадахгүй хүмүүсийн мэдлэг бол үзэл, цуурхал л төдий гэдгийг хүн мэдэхгүй гэж үү? Хүн өөрийнхөө үзлийг алдаа мадаггүй зөв гэж бодон, эдгээр үзэл Бурханаас ирдэг гэж боддог. Өнөөдөр хүн Бурханы ажлыг нүдээр харах үедээ олон жилийн турш хуримтлагдсан үзлээ зоргоор нь тавьдаг. Өнгөрсөн үеийн төсөөлөл, санаа нь энэ үе шатны ажилд саад болсон ба ийм үзлийг орхиж, тийм санааг няцаах нь хүний хувьд хэцүү болсон. Алхам алхмаар явагдах энэ ажлын тухайд бол, өнөөдрийг хүртэл Бурханыг дагасан олон хүний үзэл улам бүр ноцтой болсон бөгөөд энэ хүмүүст бие махбодтой болсон Бурханы эсрэг эвлэршгүй үзэн ядалт аажмаар үүссэн. Энэхүү үзэн ядалтын эх сурвалж нь хүний үзэл, төсөөлөлд оршдог. Хүний үзэл, төсөөлөл нь өнөөдрийн ажил буюу хүний үзэлтэй нийцдэггүй ажлын дайсан болжээ. Баримт нь хүнд төсөөлөлдөө умбах боломж олгодоггүй, түүнчлэн хүн дураараа няцаахыг зөвшөөрдөггүй, мөн хүний үзэл, төсөөлөл нь баримт байгааг тэвчдэггүй, цаашлаад хүн баримтын үнэн зөв байдлыг бодож үздэггүй, зүгээр л өөрийн үзлийг дураар нь тавьж, өөрийн төсөөллийг ашигладаг учраас л ийм зүйл болсон юм. Үүнийг хүний үзлийн алдаа л гэж хэлж болохоос биш, Бурханы ажлын алдаа гэж хэлж болохгүй. Хүн хүссэн бүхнээ төсөөлж болох ч Бурханы ажлын ямар ч үе шат юм уу үүний өчүүхэн төдий хэсгийг ч дураараа няцааж болохгүй; Бурханы ажлын баримт нь хүн халдашгүй юм. Чи төсөөллөө зөнгөөр нь орхиж, тэр ч бүү хэл Ехова болон Есүсийн ажлын талаар сайхан түүхүүдийг эмхэтгэн гаргаж болох ч Ехова болон Есүсийн ажлын үе шат бүрийн баримтыг няцааж болохгүй; энэ бол зарчим төдийгүй захиргааны зарлиг бөгөөд эдгээр асуудлын чухал ач холбогдлыг та нар ойлгох ёстой. Ажлын энэ үе шат нь хүний үзэлтэй нийцдэггүй, харин ажлын өмнөх хоёр үе шатны хувьд тийм байгаагүй гэж хүн итгэдэг. Өөрийн төсөөлөлдөө хүн, өмнөх хоёр үе шатны ажил нь өнөөдрийн ажилтай яавч адилгүй гэж итгэдэг, гэвч Бурханы ажлын зарчмууд бүгд адилхан, Түүний ажил үргэлж бодитой байдаг бөгөөд эрин үеэс үл хамааран Түүний ажлын баримтыг эсэргүүцэж, сэргэлдэх хүн үргэлж асар олон

гарч ирдэг гэснийг чи ер нь бодож үзэж байсан уу? Өнөөдөр энэ үе шатны ажлыг эсэргүүцэж, сэргөлдөж байгаа бүх хүн өнгөрсөн үед ч гэсэн Бурханыг эсэргүүцэж байсан нь эргэлзээгүй, учир нь тийм хүмүүс бүгд Бурханы дайсан юм. Бурханы ажлын баримтыг мэддэг хүмүүс нь ажлын гурван үе шатыг нэг Бурханы ажил гэж үзэн, өөрсдийн үзлийг орхиж чаддаг. Эдгээр нь Бурханыг мэддэг хүмүүс бөгөөд ийм хүмүүс бол Бурханыг үнэхээр дагадаг хүмүүс юм. Бурханы бүхий л удирдлага төгсөх дөхөхөөр Бурхан бүх зүйлийг төрлийнх нь дагуу ангилах болно. Бүтээгчийн гар хүнийг бүтээсэн ба эцэст нь Тэр хүнийг Өөрийн эрх мэдэл дор бүрэн эргүүлэн авчрах ёстой; ажлын гурван үе шатны төгсгөл энэ юм. Эцсийн өдрүүдийн ажлын үе шат болон Израиль, Иудей дахь өмнөх хоёр үе шат нь бүхий л орчлон ертөнц дэх Бурханы удирдлагын төлөвлөгөө билээ. Хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй ба энэ нь Бурханы ажлын баримт юм. Хүмүүс энэ ажлын ихэнхийг туулаагүй, нүдээр үзээгүй хэдий ч баримт бол баримт хэвээрээ л байна, үүнийг ямар ч хүн үгүйсгэх аргагүй. Орчлон ертөнцийн газар болгонд байгаа Бурханд итгэдэг хүмүүс бүгдээрээ ажлын гурван үе шатыг хүлээн зөвшөөрөх болно. Хэрвээ чи ажлын тодорхой нэг үе шатыг л мэддэг, нөгөө хоёр үе шатыг нь ойлгодоггүй, өнгөрсөн үед Бурханы хийсэн ажлыг ойлгодоггүй бол Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний бүх үнэнийг ярьж чадахгүй ба Бурханы талаарх мэдлэг чинь өрөөсгөл байна, учир нь чи Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй, Түүнийг ойлгодоггүй тул Бурханд гэрчлэл хийхэд тохирохгүй. Эдгээр зүйлийн талаарх чиний одоогийн мэдлэг гүн гүнзгий ч бай, өнгөц ч бай, эцэст нь та нар мэдлэгтэй болж, бүрэн үнэмших ёстой, тэгээд бүх хүн Бурханы ажлыг бүхэлд нь харж, Бурханы эрх мэдэл дор захирагдана. Энэ ажлын төгсгөлд бүх шашин нэг болж, бүх бүтээл Бүтээгчийн эрх мэдэл дор эргэн ирж, бүх бүтээл нэгэн жинхэнэ Бурханыг шүтэн мөргөж, бүх муу шашин үгүй болж, хэзээ ч дахин гарч ирэхгүй.

Ажлын гурван үе шатыг яагаад ингэж ахин дахин дурддаг вэ? Эрин үеүдийн улиран өнгөрөх, нийгмийн хөгжил болон байгалийн өөрчлөлт бүгд ажлын гурван үе шатан дахь хувиралт өөрчлөлтийг дагадаг. Хүн төрөлхтөн өөрөө хөгждөггүй, харин Бурханы ажилтай хамт өөрчлөгддөг. Бүх бүтээл болон бүх шашин, бүх урсгалын хүмүүсийг нэг Бурханы эрх мэдэл дор аваачихын тулд Бурханы ажлын гурван үе шатыг дурддаг билээ. Чи ямар шашинд ч харьяалагддаг бай, эцэстээ бүгд Бурханы эрх мэдэл дор захирагдана. Бурхан Өөрөө л энэ ажлыг гүйцэтгэж чадна; шашны ямар ч тэргүүн үүнийг хийж чадахгүй. Дэлхий дээр хэд хэдэн томоохон шашин бий, эдгээр нь тус бүрдээ өөрийн тэргүүн буюу удирдагчтай

байдаг бөгөөд дагалдагчид нь дэлхий даяар янз бүрийн улс орон, бүс нутгуудад тархсан байдаг; том ч бай жижиг ч бай, бараг улс орон бүр дотроо хэд хэдэн шашны урсгалтай байдаг. Гэвч дэлхий дээр хэчнээн ч шашин байлаа гэсэн, орчлон ертөнц дээрх бүх хүн эцэстээ нэг Бурханы удирдамж дор оршин тогтнодог бөгөөд тэдний оршин тогтнолыг шашны тэргүүн буюу удирдагчид залж чиглүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, шашны тодорхой нэг тэргүүн буюу удирдагч хүн төрөлхтнийг залж чиглүүлдэггүй; харин тэнгэр газар, бүх зүйлийг төдийгүй хүн төрөлхтнийг бүтээсэн Бүтээгч бүх хүн төрөлхтнийг удирддаг, энэ бол баримт юм. Дэлхийд хэд хэдэн том шашин байдаг хэдий ч тэдгээр нь хэчнээн агуу байсан ч бүгд Бүтээгчийн эрх мэдэл дор оршдог бөгөөд аль нь ч энэ эрх мэдлийн хүрээг даван гарч чаддаггүй. Хүн төрөлхтний хөгжил, нийгмийн дэвшил, байгалийн шинжлэх ухааны хөгжил нь тус бүрдээ Бүтээгчийн зохицуулалттай салшгүй холбоотой бөгөөд энэ ажил нь шашны тодорхой нэг тэргүүний хийж чадах зүйл биш юм. Шашны тэргүүн бол тухайн шашныхаа удирдагч төдий л бөгөөд Бурханыг төлөөлж чадахгүй, тэнгэр газар, бүх зүйлийг бүтээсэн Нэгнийг ч төлөөлж чадахгүй. Шашны тэргүүн бүхий л шашин доторх бүх хүнийг удирдаж чаддаг боловч тэнгэрийн доорх бүх бүтээлийг захирч чадахгүй—энэ бол нийтээр хүлээн зөвшөөрсөн баримт юм. Шашны тэргүүн бол зүгээр л удирдагч бөгөөд Бурхантай (Бүтээгчтэй) эн зэрэгцэж чадахгүй. Бүх зүйл Бүтээгчийн гарт байдаг ба эцэстээ тэд бүгд Бүтээгчийн гарт эргэн очих болно. Хүн төрөлхтнийг Бурхан бүтээсэн бөгөөд ямар ч шашин бай, Бурханы эрх мэдэл дор эргэн очих болно—энэ нь гарцаагүй. Бурхан л бүх зүйлийн дотроос Хамгийн Дээд нь бөгөөд бүх бүтээлийн доторх хамгийн дээд захирагч хүртэл Түүний ноёрхол дор эргэн очих ёстой. Хүн хэчнээн ч өндөр байр суурьтай байлаа гэсэн хүн төрөлхтнийг тохиромжтой хүрэх газарт хүргэж чадахгүй, хэн ч бүх зүйлийг төрлөөр нь ангилж чадахгүй юм. Ехова Өөрөө хүн төрөлхтнийг бүтээж, тус бүрийг нь төрлөөр нь ангилсан ба төгсгөлийн цаг үе ирэхэд Тэр мөн л Өөрийн ажлыг Өөрөө хийж, бүх зүйлийг төрлөөр нь ангилна—энэ ажлыг Бурханаас өөр хэн ч хийж чадахгүй. Эхнээсээ өнөөдрийг хүртэл явагдсан ажлын гурван үе шатыг бүгдийг нь Бурхан Өөрөө хийсэн ба нэг Бурхан хийсэн. Ажлын гурван үе шатны баримт нь хүн төрөлхтнийг Бурхан удирдсан тухай баримт бөгөөд хэний ч үгүйсгэж чадахгүй баримт юм. Ажлын гурван үе шат төгсмөгц бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдаж, бүгд Бурханы эрх мэдэл дор эргэн очно, учир нь бүхий л орчлон ертөнц даяар зөвхөн энэ нэг Бурхан оршдог бөгөөд өөр шашин гэж байхгүй. Дэлхийг бүтээх чадваргүй нэгэн үүнийг төгсгөлд нь аваачиж

чадахгүй, харин дэлхийг бүтээсэн Тэр үүнийг төгсгөлд нь аваачих чадвартай байх нь гарцаагүй. Тиймээс оюун ухаанаа хөгжүүлэхэд нь л хүнд тусалж чадахаас биш, эрин үеийг төгсгөж чадахгүй нэгэн бол Бурхан биш байх нь гарцаагүй, бас хүн төрөлхтний Эзэн биш байх нь гарцаагүй. Тэрээр ийм агуу ажил хийж чадахгүй; ийм ажлыг биелүүлж чадах цорын ганц нэгэн байдаг бөгөөд энэ ажлыг хийж чаддаггүй бүхэн бол Бурхан биш, дайснууд гэдэг нь гарцаагүй. Бүх муу ёрын шашин нь Бурхантай нийцдэггүй бөгөөд Бурхантай нийцдэггүй тул тэд Бурханы дайснууд мөн. Бүх ажлыг энэхүү нэг жинхэнэ Бурхан хийдэг, бүх орчлон ертөнцийг энэхүү нэг Бурхан захирдаг. Түүний ажил Израильд байна уу, Хятадад байна уу хамаагүй, энэ ажлыг Сүнс хийж байна уу, махбод хийж байна уу хамаагүй, бүгдийг нь Бурхан Өөрөө хийдэг ба өөр хэн ч орлож чадахгүй. Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан учраас л эрх чөлөөтэй ажиллаж, ямар ч нөхцөл байдалд баригддаггүй—энэ бол хамгийн агуу үзэгдэл билээ. Чи Бурханы бүтээлийн хувиар Бурханы бүтээлийн үүргийг биелүүлж, Бурханы хүслийг ойлгохыг хүсвэл Бурханы ажлыг ойлгох ёстой, бүтээлийн төлөөх Бурханы хүслийг ойлгох ёстой, Түүний удирдлагын төлөвлөгөөг ойлгох ёстой ба Түүний хийдэг ажлын бүх ач холбогдлыг ойлгох ёстой. Үүнийг ойлгодоггүй хүмүүс Бурханы бүтээл байхад тэнцэхгүй! Бурханы бүтээл болохын хувьд чи хаанаас ирснээ ойлгодоггүй, хүн төрөлхтний түүхийг болон Бурханы хийсэн бүх ажлыг ойлгодоггүй, түүнчлэн хүн төрөлхтөн өнөөг хүртэл хэрхэн хөгжсөнийг ойлгодоггүй, бүх хүн төрөлхтнийг хэн захирдгийг мэддэггүй бол үүргээ биелүүлж байна гэж тооцогдохгүй. Бурхан өнөөдрийг хүртэл хүн төрөлхтнийг удирдсаар ирсэн ба хүнийг газар дэлхий дээр бүтээснээсээ хойш хэзээ ч орхиогүй. Ариун Сүнс хэзээ ч ажиллахаа болиогүй, хүн төрөлхтнийг удирдахаа хэзээ ч зогсоогоогүй, хүн төрөлхтнийг хэзээ ч орхиогүй. Гэвч хүн төрөлхтөн Бурханыг мэдэх нь байтугай Бурхан байдгийг ч ухаардаггүй, Бурханы бүх бүтээлийн хувьд үүнээс гутамшигтай зүйл гэж байх уу? Бурхан Өөрөө хүнийг удирддаг боловч хүн Бурханы ажлыг ойлгодоггүй. Чи Бурханы бүтээл боловч өөрийнхөө түүхийг ойлгодоггүй, аян замд чинь хэн чамайг удирдаж ирснийг мэддэггүй, Бурханы хийсэн ажлыг мэдэхгүй бол Бурханыг мэдэж чаддаггүй. Хэрвээ чи одоо ч гэсэн мэдэхгүй хэвээр байвал чи хэзээ ч Бурханд гэрчлэл хийх эрхгүй. Өнөөдөр Бүтээгч дахин нэг удаа биечлэн бүх хүнийг удирдаж, Өөрийн мэргэн ухаан, төгс хүч, аврал болон гайхамшигт байдлыг бүх хүнд харуулдаг. Гэтэл чи одоо ч ухаарч ойлгоогүй—тиймээс чи аврал хүлээн авахгүй нэгэн биш гэж үү? Сатанд харьяалагддаг хүмүүс Бурханы үгийг ойлгодоггүй, харин

Бурханд харьяалагддаг хүмүүс Бурханы дуу хоолойг сонсож чаддаг. Миний хэлж буй үгийг ухаарч, ойлгодог бүх хүн нь аврагдаж, Бурханд гэрчлэл хийх хүмүүс юм; Миний хэлж буй үгийг ойлгодоггүй бүх хүн нь Бурханд гэрчлэл хийж чадахгүй, таягдуулах хүмүүс юм. Бурханы хүслийг ойлгодоггүй, Бурханы ажлыг ухаардаггүй хүмүүс Бурханыг мэдэж чадахгүй бөгөөд тийм хүмүүс Бурханыг гэрчилдэг хүн биш. Бурханд гэрчлэл хийе гэж хүсвэл Бурханыг мэдэх ёстой; Бурханы тухай мэдлэгт Бурханы ажлаар дамжин хүрдэг. Иймээс, эцсийн дүнд Бурханыг мэдмээр байвал Бурханы ажлыг мэдэх ёстой: Бурханы ажлыг мэдэх нь хамгийн чухал юм. Ажлын гурван үе шат төгсөх үед Бурханд гэрчлэл хийдэг хүмүүсийн бүлэг, өөрөөр хэлбэл, Бурханыг мэддэг хүмүүсийн бүлэг бүтээгдэнэ. Энэ хүмүүс бүгд Бурханыг мэдэх ба үнэнийг хэрэгжүүлж чаддаг байна. Тэд хүн чанар, эрүүл ухааныг эзэмшиж, Бурханы авралын ажлын гурван үе шатыг бүгд мэднэ. Энэ нь эцэстээ биелэх ажил бөгөөд энэ хүмүүс бол 6,000 жилийн удирдлагын ажлын биелэлт, Сатаны эцсийн ялагдлыг гэрчлэх хамгийн хүчтэй гэрчлэл юм. Бурханд гэрчлэл хийж чаддаг хүмүүс нь Бурханы амлалт, ерөөлийг хүлээн авч чадах бөгөөд Бурханы эрх мэдлийг эзэмшиж, Бурханд гэрчлэл хийдэг бүлэг, бүр эцсээ хүртэл үлдэх бүлэг хүмүүс байх болно. Та нар бүгдээрээ, эсвэл ердөө тэн хагас нь юм уу цөөн хэд чинь л энэ бүлгийн гишүүн болж магадгүй—энэ нь та нарын хүсэл болон эрэл хайгуулаас хамаардаг.

ЗАВХАРСАН ХҮН ТӨРӨЛХТӨНД БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАНЫ АВРАЛ ИЛҮҮ ИХ ХЭРЭГТЭЙ

Бурханы ажлын бай нь Сатаны сүнс, эсвэл ямар нэг биегүй хоосон зүйл биш, харин махан биеэс бүтсэн, Сатаны завхралд өртсөн хүн учраас Бурхан махбод болсон билээ. Чухамдаа хүний махан бие завхарсан учраас Бурхан махан биетэй хүнийг Өөрийн ажлын бай болгосон; түүнчлэн, хүн завхралын бай учраас Бурхан авралын ажлынхаа бүх үе шатанд хүнийг Өөрийн ажлын цорын ганц бай болгосон юм. Хүн бол мах, цуснаас бүтсэн мөнх бус оршихуй бөгөөд хүнийг аварч чадах Нэгэн бол гагцхүү Бурхан билээ. Иймээс, ажлаа хийхийн тулд, Өөрийнхөө ажлыг илүү дээр үр дүнд хүргэхийн тулд Бурхан хүнтэй адил шинж чанартай махбод болох ёстой. Хүн махан биетэй, мөн нүглийг ялан дийлж, махан биеийг орхих чадваргүй учраас Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан махбод болох ёстой. Бие махбодтой болсон Бурханы мөн чанар болон ялгамж чанар нь хүний мөн чанар, ялгамж чанараас асар их ялгаатай байдаг ч

Түүний гадаад төрх хүнийхтэй адилхан; Тэрээр хэвийн хүний дүр төрхтэй, хэвийн хүний амьдралаар амьдардаг бөгөөд Түүнийг харсан хүмүүс хэвийн хүнээс ялгаж огт чадахгүй. Хэвийн хүн чанараар бурханлаг ажлаа хийхэд нь Түүнд энэхүү хэвийн төрх байдал, хэвийн хүн чанар хангалттай. Түүний махбод нь хэвийн хүн чанараар ажиллах боломж олгон, хүмүүсийн дунд ажлаа хийхэд нь тусалдаг, түүнчлэн хүмүүсийн дунд авралын ажлаа явуулахад нь Түүний хэвийн хүн чанар тусалдаг. Хэдийгээр Түүний хэвийн хүн чанар хүмүүсийн дунд ихээхэн шуугиан тарьсан ч тийм шуугиан Түүний ажлын хэвийн үр дүнд нөлөөлөөгүй. Товчхондоо Түүний хэвийн махбодын ажил нь хүнд дээд зэргийн ач тустай. Ихэнх хүмүүс Түүний хэвийн хүн чанарыг хүлээн зөвшөөрдөггүй хэдий ч Түүний ажил үр дүнд хүрч мөн л чадах ба Түүний хэвийн хүн чанарын ачаар эдгээр үр дүнд хүрдэг. Үүнд эргэлзэх юмгүй. Махбод дахь Түүний ажлаас хүн, Түүний хэвийн хүн чанарын талаар хүмүүсийн дунд байдаг үзлээс арав дахин, эсвэл бүр хэдэн арав дахин ихийг олж авдаг бөгөөд эцэстээ эдгээр үзэл нь бүгд Түүний ажилд залгиулдаг. Түүний ажлын хүрсэн үр дүн, өөрөөр хэлбэл, Түүний тухай хүний мэдлэг нь Бурханы талаарх хүний үзлээс хавьгүй их байдаг. Махбодоор хийдэг Түүний ажлыг төсөөлж, хэмжих аргагүй, учир нь Түүний махбод махан биетэй ямар ч хүнийхтэй адилгүй; гадаад бүрхүүл нь хэдий адилхан ч мөн чанар нь ижил биш. Түүний махбод хүмүүсийн дунд Бурханы талаарх олон үзлийг төрүүлдэг ч бас ихээхэн мэдлэг олж авах боломжийг хүнд олгодог ба тэр ч бүү хэл адилхан гадаад бүрхүүлтэй ямар ч хүнийг байлдан дагуулж чадна. Учир нь Тэр зүгээр ч нэг хүн биш, харин хүний гадаад бүрхүүлтэй Бурхан бөгөөд хэн ч Түүнийг бүрэн ухаан мэдэж, ойлгож чадахгүй. Үл үзэгдэх, гарт үл баригдах Бурханыг бүгд хайрлаж, угтан авдаг. Хэрвээ Бурхан хүнд үл үзэгдэх Сүнс л байвал Бурханд итгэх нь хүнд маш хялбар байх болно. Хүн өөрийн төсөөллийг зөнд нь орхиж, өөрийгөө баясгаж, жаргалтай байлгахын тулд дуртай дүр зургаа Бурханы дүр төрх болгон сонгож чадна. Ийм маягаар, хүмүүс өөрсдийнхөө Бурханы хамгийн дуртай зүйлийг болон хийгээсэй гэж хүсдэг зүйлийг нь ямар ч эргэлзээгүйгээр хийж болох юм. Үүнээс ч илүүтэйгээр, өөрөөс нь өөр хэн ч Бурханд үнэнч, сүсэгтэй биш бөгөөд бусад хүмүүс бүгд Харь үндэстний ноход, Бурханд үнэнч бус гэж хүмүүс итгэдэг. Энэ бол Бурханд итгэх итгэл нь тодорхойгүй агаад хоосон номлолд тулгуурласан хүмүүсийн эрж хайдаг зүйл гэж хэлж болно; тэдний эрж хайдаг зүйл хоорондоо төдийлөн ялгаагүй бүгд ижилхэн байдаг. Ердөө тэдний төсөөлөлд байгаа Бурханы дүр л өөр боловч мөн чанар нь үнэндээ адилхан.

Хүн Бурханд итгэхдээ хэнэггүй байдаг ба хүссэнээрээ Бурханд итгэдэг. Хүмүүс өөр хэний ч биш өөрийн Бурханд итгэж байгаа учраас энэ бол хэний ч саад болж чадахгүй “хүний эрх, эрх чөлөө” юм; энэ бол тэдний хувийн өмч бөгөөд бараг хүн бүр ийм төрлийн хувийн өмчтэй байдаг. Хүмүүс энэ өмчийг үнэт эрдэнэс гэж үздэг, харин Бурханы хувьд үүнээс илүү дорд, үнэ цэнгүй юу ч үгүй, учир нь хүний энэ хувийн өмч бол Бурханыг эсэргүүцдэгийн хамгийн илэрхий шинж юм. Бие махбодтой болсон Бурханы ажлаас болоод Бурхан, биет хэлбэртэй агаад хүн харж, хүрч болох махбод болдог. Тэрээр хэлбэргүй Сүнс биш, харин хүний хүрч, харж болох махбод юм. Гэсэн хэдий ч, хүмүүсийн итгэдэг Бурханын ихэнх нь хэлбэргүй, бас хэлбэрт үл баригдах, биегүй бурхад байдаг. Ийм маягаар, бие махбодтой болсон Бурхан нь Бурханд итгэдэг ихэнх хүмүүсийн дайсан болсон бөгөөд үүний нэгэн адилаар, Бурхан бие махбодтой болсон баримтыг хүлээн зөвшөөрч чаддаггүй хүмүүс Бурханы дайснууд болсон. Хүн үзэлтэй байх нь түүний бодлоос, эсвэл тэрслүү байдлаас болдог юм биш, харин хүний энэ хувийн өмчөөс болж байгаа юм. Чухамдаа энэ өмчөөс болж ихэнх хүн үхдэг ба хүрч, харж болохгүй, бодит байдал дээр оршдоггүй энэхүү тодорхойгүй Бурхан хүний амийг сүйрүүлдэг. Хүний амийг сүйрүүлдэг нь бие махбодтой болсон Бурхан биш, тэнгэрийн Бурхан бүр ч биш, харин хүний өөрийнх нь төсөөллийн Бурхан юм. Бие махбодтой болсон Бурхан махбодод ирсний цорын ганц шалтгаан нь завхарсан хүний хэрэгцээнээс болсон билээ. Энэ нь Бурханы биш, хүний хэрэгцээнээс болдог бөгөөд Түүний бүх золиослол болон зовлон нь Бурханы Өөрийн ашиг тусын төлөө биш, харин хүн төрөлхтний төлөө байдаг. Бурханы хувьд ашиг, алдагдал, эсвэл шагнал гэж үгүй; Тэрээр хожмын ургацыг хураахгүй, харин анхнаасаа Өөрийнх нь байсан зүйлийг хураана. Хүн төрөлхтний төлөө Түүний хийдэг, золиосолдог бүхэн нь асар их шагнал олж авахын төлөө биш, харин гагцхүү хүн төрөлхтний төлөө байдаг. Хэдийгээр махбод дахь Бурханы ажил төсөөлөхийн аргагүй олон бэрхшээл агуулдаг ч эцэстээ хүрдэг үр дүн нь Сүнсний шууд хийсэн ажлаас хавьгүй илүү давдаг. Махбодын ажил ихээхэн бэрхшээл дагуулдаг бөгөөд махбодод Сүнстэй адил агуу ялгамж чанар байдаггүй, Сүнстэй адил ер бусын үйл хэргийг гүйцэтгэж чаддаггүй, Сүнстэй адил эрх мэдэл эзэмшиж бүр ч чаддаггүй. Гэхдээ бусдаас ялгарах юмгүй энэ махбодын хийсэн ажлын мөн чанар нь Сүнсний шууд хийсэн ажлаас хавьгүй илүү бөгөөд энэхүү махбод Өөрөө бүх хүн төрөлхтний хэрэгцээ юм. Аврагдах хүмүүсийн хувьд, Сүнсний хэрэглээний үнэ цэн нь махбодынхоос хамаагүй доогуур байдаг: Сүнсний ажил уул нуруу, гол

мөрөн, нуур, далай тэнгис гээд бүх орчлон ертөнцийг хамрах чадвартай атал махбодын ажил нь Өөрийн харилцдаг хүн бүртэй илүү үр дүнтэйгээр холбогддог. Үүнээс гадна биет хэлбэртэй Бурханы махбодыг хүн илүү их ойлгож, итгэж чадах бөгөөд энэ нь Бурханы тухай хүний мэдлэгийг улам гүнзгийрүүлж, хүнд Бурханы бодит үйл хэргийн талаар илүү гүн гүнзгий сэтгэгдэл үлдээж чаддаг. Сүнсний ажил нууц далд байдаг; мөнх бус хүмүүсийн хувьд үүнийг ухан ойлгоход хэцүү, харахад бүр ч хэцүү, иймээс тэд зөвхөн хий хоосон төсөөлөлд түшиглэж л чадна. Гэхдээ махбодын ажил хэвийн, бодит байдалд үндэслэдэг, баялаг мэргэн ухаантай байдаг бөгөөд энэ нь хүний нүдээр харж болох баримт юм; хүн Бурханы ажлын мэргэн ухааныг өөрийн биеэр туулах боломжтой, элбэг арвин төсөөллөө ашиглах шаардлагагүй байдаг. Энэ бол махбод дахь Бурханы ажлын үнэн зөв байдал болон жинхэнэ үнэ цэн мөн. Сүнс хүнд үл үзэгдэх зүйлсийг болон хүн төсөөлөхөд амаргүй зүйлсийг л хийж чаддаг, тухайлбал Сүнсний гэгээрэл, Сүнсний хөдөлгөлт, Сүнсний удирдамж зэрэг нь оюун ухаантай хүнийг ямар нэгэн тодорхой утга учраар хангадаггүй. Тэдгээр нь зөвхөн сэтгэл хөдөлгөх юм уу өргөн хүрээтэй утга учраар хангахаас биш, үгээр зааварчилгаа өгч чадахгүй. Харин махбод дахь Бурханы ажил асар өөр байдаг: Үүнд үгийн нарийн зөв удирдамж байдаг ба тодорхой хүсэл, тодорхой шаардсан зорилготой байдаг. Иймээс хүн тэмтчин бэдэрч, төсөөллөө ашиглах хэрэггүй, таамаглал дэвшүүлэх бүр ч хэрэггүй. Энэ бол махбод дахь ажлын тодорхой байдал бөгөөд Сүнсний ажлаас ялгагдах асар том ялгаа юм. Сүнсний ажил хязгаарлагдмал цар хүрээнд л тохиромжтой бөгөөд махбодын ажлыг орлож чадахгүй. Махбодын ажил нь Сүнсний ажлаас хавьгүй илүү үнэн зөв, чухал шаардлагатай зорилго болон хавьгүй илүү бодит, үнэ цэнтэй мэдлэгийг хүнд өгдөг. Завхарсан хүний хувьд үнэн зөв үгс, эрэлхийлэх тодорхой зорилго болон харж, хүрч болох зүйлээр хангадаг ажил л хамгийн үнэ цэнтэй юм. Бодитой ажил, цагаа олсон удирдамж л хүний дур сонирхолд таарч тохирдог бөгөөд бодит ажил л хүнийг завхарсан, доройтсон зан чанараас нь аварч чадна. Үүнийг бие махбодтой болсон Бурхан л биелүүлж чадна; бие махбодтой болсон Бурхан л хүнийг урьдын завхарсан, доройтсон зан чанараас нь аварч чадна. Сүнс бол Бурханы төрөлх мөн чанар хэдий ч иймэрхүү ажлыг зөвхөн Түүний махбод л хийж чадна. Хэрвээ Сүнс дангаараа ажилласан бол Түүний ажил үр дүнтэй байх боломжгүй байсан—энэ бол илэрхий үнэн юм. Энэхүү махбодоос болж ихэнх хүн Бурханы дайсан болсон ч гэсэн Түүнийг ажлаа дуусгах үед Түүний эсрэг байдаг хүмүүс дайснууд нь байхаа болиод

зогсохгүй, харин ч эсрэгээрээ Түүний гэрчлэгчид болно. Тэд Түүгээр байлдан дагуулагдсан, Түүнтэй нийцэлтэй, Түүнээс салшгүй гэрчлэгчид болно. Тэрээр, махбод дахь ажлынхаа ач холбогдлыг хүнд мэдүүлэх ба хүний оршин тогтнол дахь энэ махбодын ач холбогдол, хүний амийн өсөлтөн дэх Түүний бодит үнэ цэнийг хүн мэдэх болно, түүнчлэн энэ махбод бол хүний салж үл түвдэх амийн амьд булаг болно гэдгийг ч мэднэ. Хэдийгээр Бурханы махбод болсон бие нь Бурханы ялгамж чанар, байр сууринд нийцэхэд хол, мөн Түүний бодит байр суурьтай нийцэхгүй мэт хүнд санагдавч Бурханы жинхэнэ дүр төрхгүй, эсвэл Бурханы жинхэнэ ялгамж чанаргүй энэ махбод нь Бурханы Сүнсний шууд хийж чадахгүй ажлыг хийж чадна. Энэ бол бие махбодтой болсон Бурханы жинхэнэ ач холбогдол, үнэ цэн бөгөөд энэхүү ач холбогдол, үнэ цэнийг хүн ойлгож, хүлээн зөвшөөрч чаддаггүй. Бүх хүн төрөлхтөн Бурханы Сүнсийг дээдэлж, Бурханы махбодыг дорд үздэг хэдий ч тэдний хэрхэн харж, боддогоос үл хамааран махбодын бодит ач холбогдол болон үнэ цэн нь Сүнснийхээс хавьгүй хол давдаг. Мэдээж завхарсан хүн төрөлхтний хувьд л ийм байдаг. Үнэнийг эрж хайдаг, Бурханы илрэлтийг хүсэн хүлээдэг хүн бүрийн хувьд Сүнсний ажил нь зөвхөн сэтгэл хөдөлгөж, онгодоор хангаж, тайлбарлашгүй, төсөөлшгүй гайхалтай байдлын мэдрэмж, мөн агуу, ер бусын, бишрэм атлаа бүх хүний олж авч, хүрч чадахааргүй мэдрэмжийг л өгдөг. Хүн, Бурханы Сүнс хоёрын хооронд асар их зай байгаа мэт, тэд хэзээ ч адилхан байж чадахгүй мэт, хүн Бурхан хоёрыг үл үзэгдэх заагаар тусгаарласан мэт алсаас л бие биеэ харж чадна. Үнэндээ, Сүнс хүн хоёр нэг төрлийн зүйл биш, нэг ертөнцөд хамт хэзээ ч оршихгүй, Сүнсэнд хүний гэх юу ч байдаггүй учраас энэ нь хүнд Сүнсний өгсөн төөрөгдөл юм. Иймээс хүнд хамгийн их хэрэгтэй ажлыг Сүнс шууд хийж чаддаггүй учраас хүнд Сүнс хэрэггүй. Махбодын ажил нь хүнд эрэлхийлэх бодит зорилго, тодорхой үгсийг болон Тэр бол бодитой агаад хэвийн, эгэл жирийн агаад даруухан гэх мэдрэмжийг өгдөг. Хэдий хүн Түүнээс айдаг байж болох ч ихэнх хүмүүсийн хувьд Тэр харилцахад тун хялбар байдаг: Хүн Түүний царайг харж, дуу хоолойг нь сонсож чадах ба Түүнийг алсаас харах шаардлагагүй. Энэхүү махбод нь хүнтэй адил нэг ертөнцөд оршдог учраас хүний хувьд хүрч болохуйц санагддаг бөгөөд хол юм уу ойлгошгүй биш, харин ч харж, хүрч болохуйц байдаг.

Махан биед амьдардаг бүх хүний хувьд зан чанараа өөрчлөхөд эрэлхийлэх зорилго шаардлагатай байдаг бөгөөд Бурханыг мэдэхэд Бурханы бодит үйл хэрэг болон жинхэнэ нүүр царайг харах шаардлагатай байдаг. Хоёуланд нь

Бурханы махбод болсон бие л хүрч чадах ба хоёуланг нь хэвийн, бодитой махбодоор л биелүүлж чадна. Ийм учраас бие махбодтой болох шаардлагатай бөгөөд энэ нь завхарсан бүх хүн төрөлхтөнд хэрэгтэй. Хүмүүс Бурханыг мэдэх шаардлагатай учраас тодорхойгүй, ер бусын бурхдын дүр төрхийг зүрх сэтгэлээс нь зайлуулах ёстой, хүмүүс завхарсан зан чанараасаа салах шаардлагатай учраас тэд эхлээд завхарсан зан чанараа мэдэх ёстой. Хэрвээ хүмүүсийн зүрх сэтгэлээс тодорхойгүй бурхдын дүр төрхийг зайлуулах тэр ажлыг зөвхөн хүн хийвэл зохих үр дүнд хүрч чадахгүй. Хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа тодорхойгүй бурхдын дүр төрхийг дан ганц үгээр ил болгож, хаяж, бүрэн зайлуулж чадахгүй. Хэрвээ ингэвэл эцэстээ эдгээр гүн үндэслэсэн зүйлийг хүмүүсээс зайлуулах боломжгүй хэвээр байх болно. Эдгээр тодорхойгүй, ер бусын зүйлсийг бодитой Бурхан болон Бурханы жинхэнэ дүрээр орлуулж, хүмүүст тэдгээрийг аажмаар мэдүүлснээр л зохих үр дүнд хүрч чадна. Өнгөрсөн хугацаанд эрж хайж байсан Бурхан нь тодорхойгүй, ер бусын гэдгийг хүн танин мэддэг. Энэ үр дүнд, Сүнсний шууд удирдлага биш, хэн нэгэн хүний сургаал бүр ч биш, харин бие махбодтой болсон Бурхан л хүрч чадна. Бие махбодтой болсон Бурханы хэвийн ба бодит байдал нь хүний төсөөлөлд байгаа тодорхойгүй, ер бусын Бурханы эсрэг байдаг учраас бие махбодтой болсон Бурханыг албан ёсоор Өөрийн ажлыг хийх үед хүний үзэл бүгд ил болдог. Бие махбодтой болсон Бурхантай сөргүүлэн тавьснаар л хүний анхдагч үзлийг илчлэх боломжтой. Бие махбодтой болсон Бурхантай харьцуулахгүйгээр хүний үзэл илчлэгдэх боломжгүй; өөрөөр хэлбэл, бодит байдалтай зэрэгцүүлэн тавихгүйгээр тодорхойгүй зүйлс илчлэгдэх боломжгүй. Хэн ч үг ашиглан энэ ажлыг хийж чадахгүй, хэн ч үгээр энэ ажлыг тодорхой илэрхийлж чадахгүй. Бурхан Өөрөө л Өөрийнхөө ажлыг хийж чадахаас биш, Түүний өмнөөс өөр хэн ч энэ ажлыг хийж чадахгүй. Хүний хэл хэр баялаг байх нь хамаагүй, хүн Бурханы бодитой болон хэвийн байдлыг тодорхой илэрхийлэх чадваргүй. Бурхан хүмүүсийн дунд биечлэн ажиллаж, Өөрийнхөө дүр болон оршихуйг бүрэн харуулах л юм бол хүн Бурханыг илүү бодитоор мэдэж, Түүнийг илүү тодорхой харж чадна. Энэ үр дүнд махан биетэй ямар ч хүн хүрч чадахгүй. Мэдээж Бурханы Сүнс ч бас энэ үр дүнд хүрэх чадваргүй. Бурхан завхарсан хүнийг Сатаны нөлөөнөөс аварч чадна, гэхдээ энэ ажлыг Бурханы Сүнс шууд биелүүлж чадахгүй; харин үүнийг Бурханы Сүнсний өмсдөг махбод буюу Бурханы махбод болсон бие л хийж чадна. Энэ махбод нь хүн бас Бурхан, хэвийн хүн чанартай хүн, бас бүрэн бурханлаг чанартай Бурхан юм. Иймээс, энэ махбод хэдийгээр

Бурханы Сүнс биш бөгөөд Сүнснээс асар их ялгаатай ч тэр бол хүнийг авардаг бие махбодтой болсон Бурхан Өөрөө буюу Сүнс, түүнчлэн махбод билээ. Түүнийг юу гэж нэрлэх нь хамаагүй, эцсийн эцэст Бурхан Өөрөө хүн төрөлхтнийг авардаг. Учир нь Бурханы Сүнсийг махбодоос салгашгүй бөгөөд махбодын ажил ч бас Бурханы Сүнсний ажил юм; зүгээр л энэ ажлыг Сүнсний ялгамж чанараар хийдэггүй, харин махбодын ялгамж чанараар хийдэг. Сүнсээр шууд хийх хэрэгтэй ажил нь бие махбодтой болохыг шаарддаггүй бөгөөд махбодоор хийх шаардлагатай ажлыг Сүнсээр шууд хийж болохгүй, үүнийг бие махбодтой болсон Бурхан л хийж чадна. Энэ нь энхүү ажилд шаардагддаг зүйл бөгөөд завхарсан хүн төрөлхтний шаарддаг зүйл юм. Бурханы ажлын гурван үе шатанд зөвхөн нэг үе шатыг л Сүнс шууд хийсэн ба үлдсэн хоёр үе шатыг Сүнс биш, харин бие махбодтой болсон Бурхан хийсэн. Сүнсний хийсэн Хуулийн эрин үеийн ажил нь хүний завхарсан зан чанарыг өөрчлөхтэй хамаагүй, Бурханы талаарх хүний мэдлэгтэй ч хамаагүй байсан. Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе дэх Бурханы махбодын ажил нь харин хүний завхарсан зан чанар болон Бурханы талаарх түүний мэдлэгтэй хамаатай бөгөөд авралын ажлын чухал, шийдвэрлэх хэсэг юм. Тиймээс завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон Бурханы аврал илүү их хэрэгтэй, бие махбодтой болсон Бурханы шууд ажил илүү хэрэгтэй байдаг. Хүн төрөлхтөнд өөрсдийг нь хариулах, дэмжих, услах, тэжээх, шүүх, гэсгээх бие махбодтой болсон Бурхан хэрэгтэй бөгөөд бие махбодтой болсон Бурханы илүү их нигүүлсэл, илүү агуу золин аврал хэрэгтэй. Махбод дахь Бурхан л хүний дотнын нэгэн, хүний хоньчин, байнгын туслагч байж чадах бөгөөд энэ бүхэн нь өнөөдөр болон өнгөрсөн үед бие махбодтой болсны хэрэгцээ шаардлага билээ.

Хүн Сатаны завхралд өртсөн, Бурханы бүх бүтээлийн хамгийн дээд нь юм, иймээс ч хүнд Бурханы аврал хэрэгтэй. Бурханы авралын бай бол Сатан биш, харин хүн, аврагдах зүйл бол диавол биш, харин хүний махан бие болон сүнс юм. Сатан бол Бурханы устгах бай, хүн бол Бурханы авралын бай бөгөөд хүний махан биеийг Сатан завхруулсан болохоор эхлээд хүний махан бие аврагдах ёстой. Хүний махан бие нь хамгийн гүн гүнзгий завхарч, Бурханыг эсэргүүцдэг, тэр ч байтугай Бурханы оршин тогтнолыг ил тод эсэргүүцэж, үгүйсгэдэг зүйл болсон. Энэ завхарсан махан бие дэндүү зөрүүд бөгөөд махан биеийн завхарсан зан чанартай харьцаж, өөрчлөхөөс илүү хэцүү зүйл гэж үгүй. Сатан хүний махан биед ирж үймүүлдэг ба Бурханы ажилд саад болж, Бурханы төлөвлөгөөг сүйтгэхийн тулд хүний махан биеийг ашигладаг, тиймээс хүн

Бурханы дайсан, Сатан болсон юм. Хүнийг аврахын тулд эхлээд байлдан дагуулах ёстой. Үүнээс болж Бурхан мөчөөгөө өгөлгүйгээр, зорьсон ажлаа хийхээр, Сатантай тулалдахаар махбодод ирдэг. Түүний зорилго бол завхарсан хүнийг аварч, Өөрийнх нь эсрэг тэрсэлсэн Сатаныг ялж, устгах явдал юм. Хүнийг байлдан дагуулах ажлаараа дамжуулан Тэрээр Сатаныг ялахын зэрэгцээ завхарсан хүн төрөлхтнийг авардаг. Тиймээс энэ нь хоёр зорилгод нэгэн зэрэг хүрдэг ажил юм. Тэр хүнтэй илүү сайн харилцаж, хүнийг илүү сайн байлдан дагуулахын тулд махбодоор ажиллаж, үг хэлж, бүх ажлаа хийдэг. Бурхан сүүлчийн удаа бие махбод болж, Түүний эцсийн өдрүүдийн ажил махбодоор гүйцэлдэнэ. Тэрээр бүх хүнийг төрлийнх нь дагуу ангилж, Өөрийн бүх удирдлагыг дуусгаж, мөн махбод дахь бүх ажлаа дуусгана. Газар дээрх бүх ажил нь дуусгавар болоход Тэр бүрэн ялсан байх болно. Махбодод ажиллаж байх үедээ Бурхан хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулж, бүрэн олж авсан байх болно. Энэ нь Түүний бүх удирдлага дуусгавар болно гэсэн үг бус уу? Бурхан махбод дахь ажлаа дуусган, Сатаныг бүрэн ялж, ялалтаа мандуулах үед хүнийг завхруулах боломж Сатанд дахин олдохгүй. Эхний удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь хүнийг нүглээс золин аварч, уучлах явдал байсан. Одоо энэ нь хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүрэн олж авах ажил юм, ингэснээр Сатан цаашид өөрийн ажлыг хийх аргагүй болж, бүрмөсөн ялагдаж, Бурхан бүрэн ялсан байх болно. Энэ бол махбодын ажил, мөн Бурханы Өөрийн хийдэг ажил юм. Бурханы ажлын гурван үе шатны эхний ажлыг махбод биш, Сүнс шууд хийсэн. Харин Бурханы ажлын гурван үе шатны сүүлчийн ажлыг Сүнс шууд хийдэггүй, бие махбодтой болсон Бурхан хийдэг. Дундах үе шатны золин авралын ажлыг ч бас махбод дахь Бурхан хийсэн. Бүхий л удирдлагын ажлаас хамгийн чухал ажил нь хүнийг Сатаны нөлөөнөөс аврах явдал юм. Гол ажил нь завхарсан хүнийг бүрэн байлдан дагуулж, улмаар байлдан дагуулагдсан хүний Бурханыг хүндлэх анхдагч зүрх сэтгэлийг нь сэргээж, хэвийн хүний амьдрал буюу Бурханы бүтээлийн хэвийн амьдралтай болгох явдал юм. Энэ ажил чухал бөгөөд удирдлагын ажлын цөм нь билээ. Авралын ажлын гурван үе шатанд, ажлын эхний үе шат болох Хуулийн эрин үе нь удирдлагын ажлын цөмөөс хол байсан; үүнд авралын ажил өчүүхэн төдий үзэгдэж байсан ба энэ нь Сатаны эзэмшлээс хүнийг аврах Бурханы ажлын эхлэл байгаагүй. Хуулийн дор хүн зөвхөн хуулийг мөрдөхөө л мэддэг байсан ба хүнд илүү их үнэн байгаагүй, мөн Хуулийн эрин үе дэх ажил хүний зан чанарыг өөрчлөхтэй бараг хамаагүй, Сатаны эзэмшлээс хүнийг хэрхэн аврах тухай ажилтай бүр ч холбоогүй байсан

учраас ажлын эхний үе шатыг Сүнс шууд хийжээ. Тиймээс хүний завхарсан зан чанартай хамаагүй туйлын энгийн ажлын энэ үе шатыг Бурханы Сүнс гүйцэтгэсэн юм. Ажлын энэ үе шат удирдлагын цөмтэй өчүүхэн холбоотой бөгөөд хүнийг аврах албан ёсны ажилтай тийм ч их уялдаа холбоогүй байсан тул ажлаа биечлэн хийхийн тулд Бурхан махбод болох шаардлагагүй байлаа. Сүнсний хийсэн ажил далд утгатай, ойлгошгүй, хүний хувьд ихэд айдас төрүүлэм, ойртохын аргагүй байдаг; Сүнс нь авралын ажлыг шууд хийхэд тохиромжгүй, хүнийг амиар шууд хангахад тохиромжгүй байдаг. Хүний хувьд хамгийн тохиромжтой нь Сүнсний ажлыг хүнд ойр арга зам болгон өөрчлөх явдал бөгөөд өөрөөр хэлбэл, Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан эгэл жирийн, хэвийн хүн болох нь хүнд хамгийн тохиромжтой. Сүнсний ажлыг орлохын тулд Бурхан бие махбодтой болохыг энэ нь шаарддаг бөгөөд хүний хувьд үүнээс илүү тохиромжтой арга гэж үгүй. Ажлын энэ гурван үе шатны дундаас хоёр үе шатыг махбодоор гүйцэтгэдэг ба энэ хоёр үе шат нь удирдлагын ажлын гол шат юм. Хоёр удаа бие махбодтой болсон нь харилцан бие биеэ нөхөж, нэг нэгнээ иж бүрэн болгодог. Бурхан бие махбодтой болсон эхний үе шат нь хоёр дахь үе шатны суурийг тавьсан, мөн Бурхан хоёр удаа бие махбодтой болсон нь нэгэн бүхэл болдог ба өөр хоорондоо нийцэлтэй байдаг гэж хэлж болно. Бурханы ажлын энэ хоёр үе шат нь бүхий л удирдлагын ажилд нэн чухал учраас Бурхан үүнийг Өөрийн махбодын ялгамж чанараар гүйцэтгэдэг. Хоёр удаа бие махбодтой болсон Бурханы ажилгүйгээр удирдлагын бүхий л ажил зогсож, хүн төрөлхтнийг аврах ажил хоосон ярианаас цаашгүй болох байсан гэж хэлж бараг болно. Энэ ажил чухал эсэх нь хүн төрөлхтний хэрэгцээ, хүн төрөлхтний доройтлын бодит байдал, Сатаны дуулгаваргүй байдлын хэмжээ болон ажилд саад хийж байгаа байдалд нь үндэслэдэг. Даалгаварт тохирох зөв нэгнийг, ажилчны гүйцэтгэсэн ажлын шинж чанар болон чухал байдалд үндэслэн тогтоодог. Энэ ажлын чухал байдлын тухайд бол ажлын ямар арга барил ашиглахтай хамаатайгаар—Бурханы Сүнсний шууд хийдэг ажил, эсвэл бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил, эсвэл хүнээр дамжин хийгддэг ажил—энэ гурвын дундаас эхлээд таягдан хаягдах зүйл бол хүнээр дамжин хийгддэг ажил бөгөөд ажлын шинж чанарт үндэслэн, Сүнсний ажлын шинж чанарыг махбодынхтой харьцуулан харвал махбодоор хийгддэг ажил нь Сүнсээр шууд хийгддэг ажлыг бодвол хүнд илүү их ач тустай байж, илүү их давуу тал олгодог гэдгийг эцэст нь тодорхойлж болно. Ажлыг махбодоор хийх үү, эсвэл Сүнсээр хийх үү гэдэг нь тухайн үеийн Бурханы бодлоор шийдэгддэг. Ажлын үе шат бүрд

ач холбогдол, үндэслэл бий. Тэдгээр нь үндэслэлгүй төсөөлөл биш, мөн тэдгээрийг дураараа гүйцэтгэдэг ч юм биш; тэдгээрт тодорхой мэргэн ухаан бий. Энэ бол Бурханы ажлын ард буй үнэн юм. Ялангуяа бие махбодтой болсон Бурхан хүмүүсийн дунд биечлэн ажиллах ийм агуу ажилд Бурханы төлөвлөгөө бүр ч их байдаг. Иймээс Бурханы мэргэн ухаан болон Түүний оршихуй бүхэлдээ, ажиллаж байх үеийнх нь үйлдэл, бодол, санаа бүрд тусгалаа олдог; энэ бол илүү бодит, системтэй Бурханы оршихуй юм. Эдгээр нарийн бодол санааг төсөөлж, итгэхэд, тэр ч бүү хэл мэдэхэд хүний хувьд хэцүү байдаг. Хүний хийсэн ажил нь ерөнхий зарчмын дагуу хийгддэг ба хүний хувьд тун сэтгэл ханамжтай байдаг. Гэсэн ч Бурханы ажилтай харьцуулахад ердөө дэндүү их ялгаа бий; хэдийгээр Бурханы үйл хэрэг агуу, Бурханы ажил өргөн цар хүрээтэй боловч тэдгээрийн ард хүний төсөөлж чадахааргүй олон нарийн, нягт нямбай төлөвлөгөө, зохицуулалт байдаг. Түүний ажлын үе шат бүр зарчмын дагуу явагддагаар зогсохгүй, хүний хэлээр тодорхой илэрхийлэх боломжгүй олон зүйлийг агуулдаг бөгөөд эдгээр нь хүнд үл үзэгдэх зүйлс юм. Сүнсний ажил, эсвэл бие махбодтой болсон Бурханы ажил байх нь хамаагүй, тус бүрдээ Түүний ажлын төлөвлөгөөг агуулж байдаг. Тэр ул суурьгүй ажилладаггүй, бас ач холбогдолгүй ажил хийдэггүй. Сүнс шууд ажиллах үедээ Өөрийн гэсэн зорилготой байдаг бөгөөд ажиллахын тулд хүн болох үедээ (өөрөөр хэлбэл, гадаад бүрхүүлээ өөрчлөх үедээ) бүр ч зорилготой байдаг. Өөр яах гэж Тэр Өөрийн ялгамж чанарыг дуртайяа өөрчлөх юм бэ? Өөр яах гэж Тэр дуртайяа дорд үзэгдэж, хавчигдах хүн болох юм бэ?

Ажил гэдэг үүднээс яривал махбод дахь Түүний ажил туйлын ач холбогдолтой бөгөөд ажлыг бүрэн дуусгадаг Нэгэн бол Сүнс биш, бие махбодтой болсон Бурхан билээ. Бурхан хэзээ нэг цагт газар дэлхий дээр ирж, хүмүүст харагдаж, улмаар бүх хүн төрөлхтнийг биечлэн шүүж, хэнийг нь ч үлдээлгүй нэг нэгээр нь туршиж магадгүй гэж зарим хүн итгэдэг. Ингэж боддог хүмүүс бие махбодтой болох ажлын энэ үе шатыг мэддэггүй. Бурхан хүмүүсийг нэг нэгээр нь шүүдэггүй ба нэг нэгээр нь туршдаггүй; ийнхүү хийвэл шүүлтийн ажил биш. Бүх хүн төрөлхтний завхрал адилхан бус уу? Бүх хүн төрөлхтний мөн чанар ижилхэн бус уу? Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний завхарсан мөн чанар, Сатаны завхруулсан хүний мөн чанар, хүний бүх нүгэл билээ. Хүний ялихгүй, аар саар алдааг Бурхан шүүдэггүй. Шүүлтийн ажил бэлгэдлийн чанартай бөгөөд ялангуяа тодорхой нэг хүнд зориулж хийгддэггүй. Харин ч энэ нь, бүх хүн төрөлхтнийг шүүх ажлыг төлөөлөхийн тулд бүлэг хүмүүсийг шүүдэг ажил юм. Бүлэг хүмүүс дээр

Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээр махбод дахь Бурхан, бүх хүн төрөлхтний ажлыг төлөөлүүлэхийн тулд Өөрийг ажлыг ашигладаг ба үүний дараа энэ нь аажмаар тархдаг. Шүүлтийн ажил ч гэсэн ийм байдаг. Бурхан тодорхой нэг төрлийн хүн, эсвэл тодорхой бүлэг хүмүүсийг шүүдэггүй, харин бүх хүн төрөлхтний зөвт бус байдал буюу тухайлбал, Бурханд хандах хүний эсэргүүцэл, Бурханыг хүндэлдэггүй байдал, эсвэл Бурханы ажлыг үймүүлдэг байдал зэргийг шүүдэг. Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний Бурханыг эсэргүүцдэг мөн чанар бөгөөд энэ ажил нь эцсийн өдрүүдийн байлдан дагуулалтын ажил юм. Хүний харсан бие махбодтой болсон Бурханы ажил болон үг нь өнгөрсөн хугацаанд хүмүүсийн бодож төсөөлж ирсэн эцсийн өдрүүд дэх агуу цагаан сэнтийн өмнөх шүүлтийн ажил билээ. Бие махбодтой болсон Бурханы одоо хийж буй ажил нь чухамдаа агуу цагаан сэнтийн өмнөх шүүлт юм. Өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан бол эцсийн өдрүүдэд бүх хүн төрөлхтнийг шүүдэг Бурхан мөн. Энэ махбод болон Түүний ажил, үг, бүхий л зан чанар нь Тэр бүхэлдээ билээ. Хэдийгээр Түүний ажлын цар хүрээ хязгаарлагдмал, бүх орчлон ертөнцийг шууд хамардаггүй ч шүүлтийн ажлын мөн чанар нь бүх хүн төрөлхтнийг шууд шүүх шүүлт юм—энэ нь зөвхөн Хятадын сонгогдсон хүмүүсийн төлөө байдаггүй, цөөн тооны хүмүүсийн төлөө ч байдаггүй. Махбод дахь Бурханы ажлын үеэр, энэ ажлын цар хүрээ нь хэдийгээр бүх орчлон ертөнцийг хамардаггүй ч бүх орчлон ертөнцийн ажлыг төлөөлдөг бөгөөд Өөрийн махбодын ажлын цар хүрээн дэх ажлыг дуусгасныхаа дараа Тэрээр, Есүсийг амилж, тэнгэр өөд гарсны дараа сайн мэдээ нь бүх орчлон ертөнц даяар тархсантай адилаар энэхүү ажлыг бүх орчлон ертөнцөд нэн даруй өргөжүүлнэ. Сүнсний ажил, эсвэл махбодын ажлын аль нь ч бай, хязгаарлагдмал цар хүрээнд хийгддэг ажил боловч бүх орчлон ертөнцийн ажлыг төлөөлдөг. Эцсийн өдрүүдэд Бурхан, Өөрийн бие махбодын ялгамж чанараар гарч ирж ажлаа хийдэг ба махбод дахь Бурхан бол агуу цагаан сэнтийн өмнө хүнийг шүүдэг Бурхан юм. Сүнс юм уу махбод байх нь хамаагүй, шүүлтийн ажлыг хийгч нь эцсийн өдрүүдэд хүн төрөлхтнийг шүүдэг Бурхан билээ. Энэ нь Түүний ажилд үндэслэн тодорхойлогддог ба Түүний гадаад төрх байдал болон өөр хэд хэдэн хүчин зүйлийн дагуу тодорхойлогддоггүй. Хэдийгээр хүн эдгээр үгийн талаар үзэл өвөрлөдөг ч бие махбодтой болсон Бурхан бүх хүн төрөлхтнийг шүүж, байлдан дагуулдаг бодит баримтыг хэн ч үгүйсгэж чадахгүй. Хүн энэ талаар юу гэж бодох нь хамаагүй, эцсийн эцэст баримт бол баримт. “Ажлыг Бурхан хийдэг боловч махбод бол Бурхан биш” гэж хэн ч хэлж чадахгүй. Энэ нь утгагүй, учир нь энэ ажлыг махбод дахь Бурханаас өөр хэн ч хийж чадахгүй. Энэ ажил

хэдийнээ дууссан тул энэ ажлын дараа хүнийг шүүх Бурханы шүүлтийн ажил хоёр дахь удаагаа гарч ирэхгүй; хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурхан бүхий л удирдлагын ажлыг аль хэдийн гүйцэлдүүлсэн бөгөөд Бурханы ажлын дөрөв дэх үе шат гэж байхгүй. Шүүгддэг нэгэн нь махан биеэс бүтсэн, завхарсан хүн болохоос Сатаны сүнс шууд шүүгддэггүй учраас шүүлтийн ажил нь сүнсний ертөнцөд биш, харин хүмүүсийн дунд хийгддэг. Хүний махан биеийн завхралыг шүүх ажилд махбод дахь Бурханаас илүү таарч, тохирох өөр хэн ч байхгүй. Хэрэв шүүлтийг Бурханы Сүнс шууд явуулсан бол бүгдийг хамрахгүй байх байв. Түүнчлэн Сүнс хүнтэй нүүр тулан уулзаж чадахгүй учраас ийм ажлыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьд хэцүү байх байсан ба үүнээс болоод үр дүн нь тэр даруй харагдахгүй, тэр ч бүү хэл Бурханы халдашгүй зан чанарыг хүн илүү тодорхой харж чадахгүй байх байлаа. Махбод дахь Бурхан хүн төрөлхтний завхралыг шүүсэн цагт л Сатаныг бүрэн ялж болно. Хэвийн хүн чанар эзэмшдэг хүнтэй адил байснаар махбод дахь Бурхан хүний зөвт бус байдлыг шууд шүүж чаддаг; энэ бол Түүний төрөлхийн ариун байдал болон Түүний ер бусын байдлын тэмдэг юм. Бурхан л хүнийг шүүх байр суурьтай байж, хүнийг шүүхэд тохирно, учир нь Тэр үнэн болон зөвт байдлыг эзэмшдэг тул хүнийг шүүх чадвартай. Үнэн болон зөвт байдалгүй хүмүүс бусдыг шүүхэд тохирохгүй. Хэрвээ энэ ажлыг Бурханы Сүнс хийсэн бол Сатаныг ялах ялалт биш байх байлаа. Сүнс төрөлхөөсөө мөнх бус хүмүүсээс илүү өндөр дээд бөгөөд Бурханы Сүнс бол төрөлхийн ариун, махан биеэс илүү ялгуусан. Хэрвээ Сүнс энэ ажлыг шууд хийсэн бол хүний бүх дуулгаваргүй байдлыг шүүж, хүний бүх зөвт бус байдлыг илчилж чадахгүй байх байсан юм. Учир нь шүүлтийн ажлыг бас Бурханы талаарх хүний үзлээр дамжуулан хийдэг ба хүнд хэзээ ч Сүнсний талаарх үзэл байгаагүй, иймээс Сүнс хүний зөвт бус байдлыг сайн илчилж чадахгүй, ийм зөвт бус бус байдлыг бүрэн ил болгож бүр ч чадахгүй. Бие махбодтой болсон Бурхан бол Өөрийг нь мэддэггүй бүх хүний дайсан юм. Хүний үзэл болон Бурханыг эсэргүүцэх эсэргүүцлийг шүүснээр Тэр хүн төрөлхтний бүх дуулгаваргүй байдлыг ил болгодог. Махбод дахь Түүний ажлын үр дүн нь Сүнсний ажлынхаас илүү илэрхий байдаг. Иймээс бүх хүн төрөлхтнийг шүүх шүүлтийг Сүнс шууд явуулдаггүй, харин энэ нь бие махбодтой болсон Бурханы ажил юм. Махбод дахь Бурханыг хүн харж, хүрч болох ба махбод дахь Бурхан хүнийг бүрэн байлдан дагуулж чадна. Махбод дахь Бурхантай харилцахдаа хүн эсэргүүцлээс дуулгавартай байдал руу, хавчлагаас хүлээн зөвшөөрөл рүү, үзлээс мэдлэг рүү, гололтоос хайр луу хөгжин дэвшдэг—эдгээр нь бие

махбодтой болсон Бурханы ажлын үр дүн юм. Түүний шүүлтийг хүлээн зөвшөөрснөөр л хүн аврагдаж, амнаас нь гарсан үгээр дамжуулан Түүнийг аажмаар мэдэж авч, Түүнийг эсэргүүцэх явцдаа Түүгээр байлдан дагуулагдаж, гэсгээлтийг нь хүлээн зөвшөөрснөөр амийн хангалтыг Түүнээс хүртдэг. Энэ бүх ажил нь махбод дахь Бурханы ажил бөгөөд Сүнсний ялгамж чанараар Бурханы хийсэн ажил биш. Бие махбодтой болсон Бурханы хийсэн ажил хамгийн агуу, хамгийн гүн гүнзгий ажил бөгөөд Бурханы ажлын гурван үе шатны шийдвэрлэх чухал хэсэг нь бие махбодтой болох ажлын хоёр үе шат билээ. Хүн гүн гүнзгий завхарсан учраас бие махбодтой болсон Бурханы ажилд асар их саад болдог. Ялангуяа эцсийн өдрүүдийн хүмүүс дээр хийгддэг ажил асар хэцүү, гаднын орчин муу бөгөөд төрөл бүрийн хүний хэв чанар тун дорд байдаг. Гэсэн ч энэ ажил дуусах үедээ ямар ч алдаа мадаггүйгээр, зохих үр дүнд хүрнэ; энэ бол махбодын ажлын үр дүн бөгөөд энэ үр дүн нь Сүнсний ажлынхаас илүү үнэмшилтэй. Бурханы ажлын гурван үе шат махбодоор гүйцэлдэх бөгөөд үүнийг бие махбодтой болсон Бурхан дуусгах ёстой. Хамгийн чухал, хамгийн шийдвэрлэх ажлыг махбодоор хийдэг бөгөөд хүнийг аврах ажлыг махбод дахь Бурхан биечлэн гүйцэтгэх ёстой. Хэдий бүх хүн төрөлхтөнд, махбод дахь Бурхан нь хүнтэй хамаагүй мэт санагддаг ч үнэндээ энэ махбод нь бүх хүн төрөлхтний хувь заяа, оршин тогтнолтой холбоотой.

Бурханы ажлын үе шат бүр бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг бөгөөд бүх хүн төрөлхтөнд чиглэдэг. Хэдий энэ нь Түүний махбод дахь ажил боловч бүх хүн төрөлхтөнд чиглэдэг; Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан бөгөөд бүх бүтээгдсэн болон бүтээгдээгүй зүйлийн Бурхан юм. Хэдийгээр махбод дахь Түүний ажил хязгаарлагдмал цар хүрээ дотор байдаг, мөн энэ ажлын бай хязгаарлагдмал ч гэсэн ажлаа хийхээр махбод болох бүрдээ Тэр дээд зэргийн бэлгэдлийн чанартай ажлын байг сонгодог; Тэрээр энгийн, бусдаас ялгарах юмгүй бүлэг хүмүүс дээр ажиллахаар сонгодоггүй, харин махбод дахь ажлынх нь төлөөлөгч байж чадах бүлэг хүмүүсийг ажлынхаа бай болгон сонгодог. Махбод дахь Түүний ажлын цар хүрээ хязгаарлагдмал учраас энэ бүлэг хүмүүс сонгогддог бөгөөд Түүний махбод болсон биед зориулан тусгайлан бэлтгэгддэг, мөн махбодоор хийх Түүний ажилд зориулан тусгайлан сонгогддог. Бурхан Өөрийн ажлын байг сонгох нь үндэслэлгүй биш, харин зарчмын дагуу хийгддэг: Ажлын бай нь махбод дахь Бурханы ажилд ашиг тустай байж, бүх хүн төрөлхтнийг төлөөлж чаддаг байх ёстой. Тухайлбал иудейчүүд Есүсийн биечлэн хийсэн золин авралыг хүлээн авахдаа бүх хүн төрөлхтнийг төлөөлж

чадсан бөгөөд бие махбодтой болсон Бурханы биечлэн хийдэг байлдан дагуулалтыг хүлээн авахдаа хятадууд бүх хүн төрөлхтнийг төлөөлж чаддаг. Иудейчүүд бүх хүн төрөлхтнийг төлөөлдөгт үндэслэл байдаг, хятад хүмүүс Бурханы биечлэн хийсэн байлдан дагуулалтыг хүлээн авахдаа бүх хүн төрөлхтнийг төлөөлдөгт мөн л үндэслэл бий. Золин авралын ач холбогдлыг иудейчүүдийн дунд хийгдсэн авралын ажлаас илүүгээр илчилж чадах өөр юу ч байхгүй, байлдан дагуулалтын ажлын бүрэн гүйцэд байдал болон амжилтыг хятадуудын дундах байлдан дагуулалтын ажлаас илүүгээр илчилж чадах юу ч байхгүй. Бие махбодтой болсон Бурханы ажил ба үг цөөхөн бүлэг хүмүүст л чиглэдэг мэт харагдавч үнэн хэрэгтээ Тэр энэ цөөхөн бүлэг хүмүүсийн дунд бүх орчлон ертөнцийн ажлыг хийж, бүх хүн төрөлхтөнд хандан үгээ хэлдэг. Махбод дахь Түүний ажил дууссаны дараа Түүнийг дагадаг хүмүүс өөрсдийнх нь дунд хийсэн Бурханы ажлыг түгээж эхэлнэ. Махбод дахь Түүний ажлын хамгийн сайн зүйл нь Тэр үнэн зөв үгс, захиас болон хүн төрөлхтний төлөөх тодорхой хүслээ Өөрийг нь дагадаг хүмүүст үлдээж чадна, ингэснээр Түүний дагалдагчид хожим нь махбод дахь Түүний бүх ажлыг болон бүх хүн төрөлхтний төлөөх Түүний хүслийг энэ замыг хүлээн зөвшөөрдөг хүмүүст илүү үнэн зөвөөр, илүү бодитоор дамжуулж чадна. Хүмүүсийн дундах махбод дахь Бурханы ажил л Бурхан хүнтэй хамт байж, хамт амьдардаг тухай баримтыг үнэхээр биелүүлдэг. Энэ ажил л Бурханы царайг харж, Бурханы ажлыг үзэж, Бурханы Өөрийн үгийг сонсох гэсэн хүний хүслийг биелүүлдэг. Бие махбодтой болсон Бурхан, Еховагийн нуруу л хүн төрөлхтөнд харагддаг эрин үеийг төгсгөдөг ба тодорхойгүй Бурханд итгэх хүн төрөлхтний итгэлийн эрин үеийг ч бас дуусгавар болгодог. Ялангуяа сүүлчийн удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь бүх хүн төрөлхтнийг илүү бодит, илүү жинхэнэ, илүү сайхан эрин үед аваачдаг. Тэрээр хууль болон дүрэм журмын эрин үеийг дуусгавар болгоод зогсохгүй, илүү чухал нь, бодитой агаад хэвийн, зөвт агаад ариун, удирдлагын төлөвлөгөөний ажлыг нээж, хүн төрөлхтний нууц болон хүрэх газрыг харуулдаг, хүн төрөлхтнийг бүтээж, удирдлагын ажлыг дуусгавар болгодог, хэдэн мянган жилийн туршид нуугдмал байсан Бурханыг хүн төрөлхтөнд илчилдэг. Тэрээр тодорхойгүй байдлын эрин үеийг бүрэн дуусгавар болгож, бүх хүн төрөлхтөн Бурханы царайг харахаар эрж хайсан ч харж чаддаггүй байсан тэр эринийг дуусгаж, бүх хүн төрөлхтөн Сатанд үйлчилсэн эрин үеийг төгсгөж, бүх хүн төрөлхтнийг цоо шинэ эрин үе рүү хөтөлдөг. Энэ бүхэн нь Бурханы Сүнсний оронд махбод дахь Бурхан ажилласны үр дүн юм. Бурхан махбодоороо

ажиллах үед Түүнийг дагадаг хүмүүс оршдог, бас эс оршдог мэт санагддаг тэдгээр зүйлийн хойноос хөөцөлдөн, тэмтчихээ больж, тодорхойгүй Бурханы хүслийг тааварлахаа больдог. Бурхан махбод дахь ажлаа түгээх үед Түүнийг дагадаг хүмүүс махбодоор хийсэн ажлыг нь бүх шашин, урсгалд дамжуулж, Түүний бүх үгийг бүх хүн төрөлхтний чихэнд хүргэнэ. Түүний сайн мэдээг хүлээн авдаг хүмүүсийн сонсдог бүхэн нь Түүний ажлын баримт байх болно, хүний биечлэн үзэж, сонссон зүйлс байх болно, мөн цуу яриа биш, баримт байх болно. Эдгээр баримт нь Түүний ажлаа түгээдэг нотолгоо, бас ажлаа түгээхдээ ашигладаг багаж хэрэгсэл билээ. Баримт байхгүй бол Түүний сайн мэдээ бүх улс орон, бүх газар нутаг даяар түгэхгүй байх байсан; баримт байхгүйгээр зөвхөн хүний төсөөллөөр бол Тэр бүх орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлыг хэзээ ч хийж чадахгүй байх байсан юм. Сүнс бол хүний хувьд мэдрэгдэшгүй, үзэгдэшгүй бөгөөд Сүнсний ажил нь Бурханы хийсэн ажлын талаарх ямар ч нэмэлт баримт, нотолгоог хүнд үлдээх чадваргүй. Хүн Бурханы бодит нүүр царайг хэзээ ч харахгүй ба оршин байдаггүй тодорхойгүй Бурханд үргэлж итгэнэ. Хүн Бурханы нүүр царайг хэзээ ч харахгүй, мөн Бурханы биечлэн хэлсэн үгийг хэзээ ч сонсохгүй. Хүний төсөөлөл эцсийн эцэст хоосон бөгөөд Бурханы жинхэнэ нүүр царайг орлож чадахгүй; Бурханы төрөлх зан чанар болон Бурханы Өөрийн ажлыг хүн дуурайж чадахгүй. Хүмүүсийн дунд Өөрийн ажлыг биечлэн хийдэг бие махбодтой болсон Бурхан л тэнгэр дэх үл үзэгдэх Бурхан болон Түүний ажлыг газар дээр авчирч чадна. Энэ бол Бурхан хүнд илрэн харагддаг, мөн хүн Бурханыг харж, Бурханы жинхэнэ нүүр царайг мэдэж авах хамгийн тохиромжтой арга бөгөөд үүнийг бие махбодтой болоогүй Бурхан биелүүлж чадахгүй. Энэ үе шатыг хүртэл ажлаа хийснээр Бурханы ажил аль хэдийн хамгийн сайн үр дүнд хүрч, бүрэн амжилттай болсон. Махбод дахь Бурханы биечлэн хийсэн ажил Түүний бүхий л удирдлагын ажлын ерэн хувийг аль хэдийн биелүүлсэн. Энэхүү махбод Өөрийнхөө бүх ажлыг илүү сайн эхлэл рүү аваачиж, Өөрийнхөө бүх ажилд дүгнэлт гаргаж, зарлан тунхагласан бөгөөд энэ бүх ажилд эцсийн иж бүрэн нэмэлтийг хийсэн. Тиймээс Бурханы ажлын дөрөв дэх үе шатыг хийх бие махбодтой болсон өөр Бурхан гэж байхгүй бөгөөд гурав дахь удаа бие махбодтой болсон Бурханы гайхалтай ажил гэж хэзээ ч байхгүй.

Махбод дахь Бурханы ажлын үе шат бүр бүхий л эрин үеийн ажлыг нь төлөөлдөг бөгөөд хүний ажилтай адилаар тодорхой нэг хугацааг төлөөлдөггүй. Иймээс сүүлчийн удаа бие махбодтой болсон Бурханы ажлын төгсгөл нь Түүний

ажил бүрмөсөн төгсгөлдөө очсон гэсэн үг биш, учир нь махбод дахь Түүний ажил бүхий л эрин үеийг төлөөлдөг бөгөөд Өөрийн ажлыг махбодоор хийдэг үеийг нь зөвхөн төлөөлдөггүй. Бие махбодтой байх хугацаандаа Тэр бүхий л эрин үеийн ажлаа төгсгөдөг ба үүний дараа энэ нь бүх газар нутагт түгдэг. Бие махбодтой болсон Бурхан Өөрийн үйлчлэлийг биелүүлснийхээ дараа Өөрийг нь дагадаг хүмүүст ирээдүйн ажлаа даалгана. Ийм маягаар, бүхэл эрин үе дэх Түүний ажил тасалдалгүйгээр явагдана. Түүний ажил орчлон ертөнц даяар түгмэгц бие махбодтой болсон бүхий л эрин үеийн ажил бүрэн гүйцэлдсэн гэж тооцож болно. Бие махбодтой болсон Бурханы ажил шинэ эринийг эхлүүлдэг ба Түүний ажлыг үргэлжлүүлдэг хүмүүс бол Түүний ашигладаг хүмүүс юм. Хүний хийдэг ажил бүгд махбод дахь Бурханы үйлчлэл дотор байдаг бөгөөд энэ цар хүрээнээс хэтрэн гарах чадваргүй. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан Өөрийн ажлыг хийхээр ирээгүй бол хүн хуучин эрин үеийг дуусгаж, шинэ эрин үеийг эхлүүлж чадахгүй байх байлаа. Хүний хийдэг ажил ердөө л хүний хувьд хийх боломжтой үүргийнх нь хүрээнд байдаг бөгөөд Бурханы ажлыг төлөөлдөггүй. Бие махбодтой болсон Бурхан л ирж, хийх ёстой ажлаа гүйцээж чадна, Түүнээс өөр хэн ч Түүний өмнөөс энэ ажлыг хийж чадахгүй. Мэдээж Миний хэлж байгаа зүйл бие махбодтой болсны ажилтай холбоотой. Энэ удаа бие махбодтой болсон Бурхан эхлээд хүний үзэлтэй үл нийцэх ажлын алхмыг хийдэг, дараа нь Тэр хүний үзэлд нийцдэггүй илүү их ажлыг хийдэг. Ажлын зорилго нь хүнийг байлдан дагуулах явдал юм. Нэг талаараа бие махбодтой болсон Бурхан ердөө хүний үзэлтэй нийцдэггүйн дээр хүний үзэлтэй үл нийцэх илүү их ажил хийдэг тул хүн Түүний талаар илүү их шүүмжлэлт үзэл санаатай болдог. Харин Тэр ердөө л Түүний талаар тоо томшгүй олон үзэлтэй хүмүүсийн дунд байлдан дагуулах ажил хийдэг. Тэд Түүнд хэрхэн ханддагаас үл хамааран Түүнийг үйлчлэлээ биелүүлмэгц бүх хүн Түүний эрх мэдэлд захирагдана. Энэ ажлын баримт нь зөвхөн Хятад хүмүүсийн дунд тусгалаа олоод зогсохгүй, бас бүх хүн төрөлхтөн хэрхэн байлдан дагуулагдахыг төлөөлдөг. Энэ хүмүүс дээр хүрсэн үр дүн нь бүх хүн төрөлхтөн дээр биелэх үр дүнгийн анхдагч хэлбэр бөгөөд ирээдүйд Түүний хийх ажлын үр дүн нь эдгээр хүмүүст гарсан үр дүнгээс ч улам давна. Махбод дахь Бурханы ажил сүр дуулиантай байдаггүй, үл ойлгогдох зүйлсээр ч хүрээлэгддэггүй. Энэ нь үнэн бодит, мөн нэг дээр нэгийг нэмбэл хоёр гардаг шиг тов тодорхой ажил юм. Энэ нь хэнээс ч нуугдаж, хэнийг ч мэхэлдэггүй. Хүмүүсийн хардаг зүйлс бодит бөгөөд жинхэнэ зүйлс, хүний олж авдаг зүйлс ч бодит мэдлэг болон үнэн юм. Ажил дуусахад хүн Түүний талаар

шинэ мэдлэгтэй болох ба үнэхээр эрэлхийлдэг хүмүүс Түүний талаар ямар нэгэн үзэлтэй байхаа болино. Энэ нь дан ганц хятад хүмүүс дээрх Түүний ажлын үр дүн биш, харин бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулах Түүний ажлын үр дүнг ч бас төлөөлдөг, учир нь энэ махбод, энэ махбодын ажил болон энэ махбодын бүх зүйл бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажилд хамгийн их ач тустай байдаг. Тэдгээр нь Түүний өнөөгийн ажилд тустай, мөн Түүний хожмын ажилд ч тустай. Энэ махбод бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүх хүн төрөлхтнийг олж авна. Бүх хүн төрөлхтөн Бурханыг харж, Бурханд дуулгавартай байж, Бурханыг мэдэх үүнээс илүү дээр ажил гэж үгүй. Хүний хийдэг ажил хязгаарлагдмал цар хүрээг л хамардаг бөгөөд Бурхан ажлаа хийх үедээ тодорхой нэг хүнтэй ярьдаггүй, харин бүх хүн төрөлхтөнтэй, Түүний үгийг хүлээн зөвшөөрдөг бүх хүнтэй ярьдаг. Түүний тунхагладаг төгсгөл бол тодорхой нэг хүний төгсгөл биш, харин бүх хүн төрөлхтний төгсгөл билээ. Тэр хэнийг ч тусгайлан харж ханддаггүй, мөн хэнийг ч хэлмэгдүүлдэггүй, Тэр бүх хүн төрөлхтний төлөө ажиллаж, үгээ хэлдэг. Тиймээс энэ удаа бие махбодтой болсон Бурхан бүх хүн төрөлхтнийг аль хэдийн төрлийнх нь дагуу ангилж, бүх хүн төрөлхтнийг аль хэдийн шүүж, бүх хүн төрөлхтөнд тохирох хүрэх газрыг зохицуулчихсан. Хэдий Бурхан зөвхөн Хятадад Өөрийн ажлыг хийж байгаа ч үнэндээ бүх орчлон ертөнцийн ажлыг аль хэдийн шийдвэрлэчихсэн. Тэрээр бүх хүн төрөлхтний дунд Өөрийнх нь ажил түгсний дараа Өөрийн айлдвар болон зохицуулалтыг алхам алхмаар хийхээр хүлээж тэвчихгүй. Тэгвэл хэт хожимдсон байх бус уу? Одоо Тэр хожмын ажлаа урьдчилан дуусгаж бүрэн чадна. Ажиллаж байгаа Нэгэн бол махбод дахь Бурхан учраас хязгаарлагдмал цар хүрээн дотор хязгааргүй ажил хийж байгаа, үүнийхээ дараа Тэр хүнээр өөрийнх нь үүргийг гүйцэтгүүлнэ; энэ бол Түүний ажлын зарчим юм. Тэр хүнтэй хамт хэсэгхэн зуур л амьдарч чадах бөгөөд бүх эрин үеийн ажил дуусах хүртэл хүнийг дагалдаж чадахгүй. Тэр Бурхан учраас Өөрийн хожмын ажлыг урьдчилан зөгнөдөг. Дараа нь Тэр Өөрийн үгээр бүх хүн төрөлхтнийг төрлийнх нь дагуу ангилж, хүн төрөлхтөн Түүний үгийн дагуу алхам алхмаар явагддаг ажилд нь орох болно. Хэн ч зугтан зайлж чадахгүй ба бүгд үүний дагуу хэрэгжүүлэх ёстой. Тиймээс ирээдүйд эрин үеийг Сүнс удирдахгүй, харин Түүний үг удирдана.

Махбод дахь Бурханы ажил махан биеэр хийгдэх ёстой. Хэрэв үүнийг Бурханы Сүнс шууд хийсэн бол ямар ч үр дүн гарахгүй. Үүнийг Сүнс хийсэн ч гэсэн тийм ч их ач холбогдолгүй, эцэстээ ямар ч үнэмшилгүй болох болно. Бүтээгчийн ажил ач холбогдолтой эсэх, юуг төлөөлдөг, юуны төлөө хийгддэг,

Бурханы ажил эрх мэдэл, мэргэн ухаанаар дүүрэн эсэхийг болон хамгийн үнэ цэнтэй, ач холбогдолтой эсэхийг бүх бүтээл мэдэхийг хүсдэг. Түүний хийдэг ажил бүх хүн төрөлхтнийг аврахын төлөө, Сатаныг ялахын төлөө, мөн бүх зүйлийн дунд Түүнд гэрчлэл хийхийн төлөө байдаг. Иймээс Түүний хийдэг ажил асар их ач холбогдолтой байх ёстой. Хүний махан бие Сатанаар завхруулагдаж, хамгийн их сохорч, гүн гүнзгий хорлогдсон. Бурхан махбодоор биечлэн ажилладгийн хамгийн үндсэн шалтгаан нь, Түүний авралын бай махан биеэс бүтсэн хүн бөгөөд Бурханы ажилд саад хийхийн тулд Сатан ч бас хүний махан биеийг ашигладгаас болдог. Сатантай хийдэг тулаан нь үнэндээ хүнийг байлдан дагуулах ажил бөгөөд үүний зэрэгцээ хүн бас Бурханы авралын бай юм. Ийм болохоор бие махбодтой болсон Бурханы ажил тун чухал. Сатан хүний махан биеийг завхруулж, хүн Сатаны биелэл болсон ба Бурханд ялагдах бай болсон юм. Ийм маягаар, Сатантай тулалдах, хүн төрөлхтнийг аврах ажил бүгд газар дэлхий дээр болдог бөгөөд Сатантай тулалдахын тулд Бурхан хүн болох ёстой байдаг. Энэ бол хамгийн бодитой ажил юм. Бурхан махбодоор ажиллах үедээ үнэндээ махан биеэр Сатантай тулалдаж байдаг. Тэр махбодоор ажиллах үедээ сүнсний ертөнцөд Өөрийн ажлыг хийж, сүнсний ертөнц дэх бүх ажлаа газар дээр бодит болгодог. Байлдан дагуулагддаг нэгэн нь Түүнд дуулгаваргүй байдаг хүн, харин ялагддаг нэгэн нь Түүнтэй дайсагнадаг Сатаны биелэл (мэдээж энэ нь ч бас хүн) бөгөөд эцэстээ аврагддаг нэгэн нь бас л хүн юм. Ийм болохоор Бурханы хувьд бүтээлийн гадаад бүрхүүлтэй хүн болох нь бүр ч илүү чухал юм, ингэснээр Тэр Сатантай бодитоор тулаан хийж, Өөрт нь дуулгаваргүй байдаг, Өөртэй нь адилхан гадаад бүрхүүлтэй хүнийг байлдан дагуулж, Өөртэй нь яг ижилхэн гадаад бүрхүүлтэй, Сатанд хорлогдсон хүнийг аварч чадна. Түүний дайсан бол хүн, Түүний байлдан дагуулалтын бай бол хүн, мөн Түүний авралын бай бол Өөрийнх нь бүтээсэн хүн билээ. Тиймээс Тэр хүн болох ёстой бөгөөд ийм маягаар Түүний ажил хавьгүй илүү хялбар болдог. Тэр Сатаныг ялан дийлж, хүн төрөлхтнийг байлдан дагуулж чаддаг, түүнчлэн хүн төрөлхтнийг аварч чаддаг. Хэдий энэ махбод хэвийн агаад бодит боловч ердийн нэг махбод биш: Тэр ердөө л нэг хүн чанартай махбод биш, харин хүн чанартай, бас бурханлаг чанартай махбод юм. Энэ нь Түүний хүнээс ялгарах ялгаа бөгөөд Бурханы ялгамж чанарын тэмдэг билээ. Зөвхөн ийм махбод л Түүний хийхээр зорьдог ажлыг хийж, махбод дахь Бурханы үйлчлэлийг биелүүлж, хүмүүсийн дундах Түүний ажлыг бүрэн гүйцэлдүүлж чадна. Хэрэв ийм байгаагүй сэн бол хүмүүсийн дундах Түүний ажил ямагт хоосон, өө сэвтэй байх байлаа. Бурхан

хэдийгээр Сатаны сүнстэй тулаан хийж, ялалтаа мандуулж чадах ч завхарсан хүний хуучин уг чанарыг хэзээ ч шийдвэрлэж чадахгүй бөгөөд Бурханд дуулгаваргүй, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс хэзээ ч Түүний ноёрхол дор орохгүй, өөрөөр хэлбэл, Тэр хэзээ ч хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүх хүн төрөлхтнийг олж авч чадахгүй билээ. Хэрвээ газар дээрх Түүний ажил шийдвэрлэгдэхгүй бол Түүний удирдлага хэзээ ч дуусгавар болохгүй, бүх хүн төрөлхтөн амралтад орж чадахгүй. Хэрвээ Бурхан Өөрийн бүх бүтээлтэй хамт амралтад орж чадахгүй бол ийм удирдлагын ажил хэзээ ч үр дүнтэй байхгүй бөгөөд үүний үрээр Бурханы алдар суу алга болно. Хэдийгээр Түүний махбод ямар ч эрх мэдэлгүй ч Түүний хийдэг ажил үр дүндээ хүрсэн байх болно. Энэ бол Түүний ажлын зайлшгүй чиглэл юм. Түүний махбод эрх мэдэлтэй эсэхээс үл хамааран Бурханы Өөрийн ажлыг хийх чадвартай л бол Тэр бол Бурхан Өөрөө мөн. Энэ махбод хэр хэвийн, эгэл жирийн байх нь хамаагүй, хийх ёстой ажлаа хийж чадна, учир нь энэ махбод бол ердийн нэг хүн биш, харин Бурхан билээ. Хүний хийж чадахгүй ажлыг энэ махбод хийж чаддагийн шалтгаан нь Түүний дотоод мөн чанар ямар ч хүнийхтэй адилгүй бөгөөд Тэр хүнийг аварч чаддагийн шалтгаан нь Түүний ялгамж чанар өөр ямар ч хүнийхээс өөр байдгаас болдог. Тэр бол хүн, үүнээс ч илүүтэйгээр Бурхан учраас, Тэрээр махан биетэй жирийн хүний хийж чадахгүй ажлыг хийж чаддаг учраас, Өөртэй нь хамт газар дэлхий дээр амьдарч байгаа завхарсан хүнийг аварч чадах учраас энэхүү махбод хүн төрөлхтөнд нэн чухал юм. Хэдий хүнтэй ижилхэн ч гэсэн бие махбодтой болсон Бурхан нь хүн төрөлхтний хувьд ямар ч үнэ цэнтэй хүнээс илүү чухал, учир нь Тэр Бурханы Сүнсний хийж чадахгүй ажлыг хийж чаддаг бөгөөд Бурханы Сүнснээс илүүтэйгээр Бурханд Өөрт нь гэрчлэл хийж чаддаг, Бурханы Сүнснээс илүүтэйгээр хүн төрөлхтнийг бүрэн олж авч чаддаг. Үүний үр дүнд хэдий энэ махбод хэвийн, эгэл жирийн ч гэсэн хүн төрөлхтөнд оруулсан Түүний хувь нэмэр, хүн төрөлхтний оршин тогтнол дахь Түүний ач холбогдол нь Түүнийг ихэд эрхэм нандин болгодог бөгөөд энэ махбодын жинхэнэ үнэ цэн, ач холбогдол ямар ч хүний хувьд хэмжээлшгүй юм. Хэдийгээр энэ махбод Сатаныг шууд устгаж чадахгүй ч гэсэн Өөрийн ажлыг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулж, Сатаныг ялж, Сатаныг Өөрийн ноёрхолд бүрэн захирагдуулж чадна. Бурхан бие махбодтой болсон болохоор Сатаныг ялан дийлж, хүн төрөлхтнийг аварч чаддаг. Тэр Сатаныг шууд устгадаггүй, харин махбод болж, Сатаны завхруулсан хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажил хийдэг. Ийм маягаар Тэр бүтээлүүдийн дунд Өөртөө илүү сайн гэрчлэл хийж,

завхарсан хүн төрөлхтнийг илүү сайн аварч чаддаг. Бие махбодтой болсон Бурхан Сатаныг ялах нь Бурханы Сүнс Сатаныг шууд устгаснаас илүү их гэрчлэл хийдэг, мөн илүү үнэмшилтэй байдаг. Махбод дахь Бурхан, Бүтээгчийг мэдэхэд нь хүнд илүү сайн тусалж, бүтээлүүдийн дунд Өөртөө илүү сайн гэрчлэл хийж чаддаг.

БУРХАНЫ ОРШДОГ МАХБОДЫН МӨН ЧАНАР

Эхний удаа бие махбодтой болохдоо Бурхан газар дээр гучин гурван жил хагас амьдарсан бөгөөд түүнийхээ гурван жил хагаст нь л үйлчлэлээ гүйцэтгэсэн. Тэрээр ажиллаж байх үедээ болон Өөрийн ажлыг эхлэхээс өмнө аль алинд нь хэвийн хүн чанартай байсан юм; Тэрээр хэвийн хүн чанартаа гучин гурван жил хагас амьдарсан. Сүүлийн гурван жил хагасын туршид Тэрээр бие махбодтой болсон Бурхан гэдгээ илчилсэн юм. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө бурханлаг чанараа харуулалгүй, жирийн, хэвийн хүн чанартайгаар гарч ирсэн ба албан ёсоор Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхэлсний дараа л бурханлаг чанар нь илэрхийлэгдсэн. Эхний тэр хорин есөн жил дэх Түүний амьдрал, ажил нь Тэр бол жинхэнэ хүн, хүний хүү, бие махбод гэдгийг харуулж байв; учир нь Түүний үйлчлэл хорин есөн наснаас нь хойш л жинхэнээсээ эхэлсэн юм. “Бие махбодтой болох” нь Бурхан махбодоор илрэх явдал; Бурхан Өөрийн бүтээсэн хүн төрөлхтний дунд махбодын дүрээр ажилладаг. Иймээс, бие махбодтой болохын тулд Бурхан эхлээд махбод буюу хэвийн хүн чанартай махбод байх ёстой; энэ нь хамгийн үндсэн урьдач нөхцөл юм. Үнэндээ, Бурхан бие махбодтой болохын цаад учир нь Бурхан махбодод амьдарч, ажилладаг бөгөөд чухам мөн чанартаа Бурхан махбод болж, хүн болдог. Бие махбодтой болсон Бурханы амьдрал, ажлыг хоёр үе шатанд хувааж болно. Эхнийх нь үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө Түүний амьдардаг амьдрал. Тэрээр хэвийн хүний гэр бүлд, туйлын хэвийн хүн чанартайгаар амьдарч, хүний амьдралын хэвийн ёс суртахуун, хуулийг дуулгавартай дагаж, хүний хэвийн хэрэгцээ (хоол, хувцас, нойр, орон байр), хүний хэвийн сул талууд болон хүний хэвийн сэтгэл хөдлөлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү эхний үе шатанд Тэрээр бурханлаг биш, бүхэлдээ хэвийн хүн чанартайгаар амьдарч, хүний бүх хэвийн үйл ажиллагааг эрхэлдэг. Хоёр дахь үе шат нь Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлсний дараа Түүний амьдардаг амьдрал юм. Тэр мөн л эгэл хүний бүрхүүлтэй хэвийн хүн чанарт оршин, гаднаа ямар ч ер бусын

тэмдэг үзүүлдэггүй. Гэсэн ч Тэр гагцхүү Өөрийн үйлчлэлийн төлөө л амьдардаг ба энэ хугацаанд Түүний хэвийн хүн чанар бүхэлдээ бурханлаг чанарынх нь хэвийн ажлыг хадгалахын төлөө оршдог, учир нь тэр үед Түүний хэвийн хүн чанар үйлчлэлээ хэрэгжүүлж чадахуйц хэмжээнд төлөвшсөн байдаг. Иймээс Түүний амьдралын хоёр дахь үе шат нь хэвийн хүн чанараараа Өөрийнхөө үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь хэвийн хүн чанар болон бүрэн дүүрэн бурханлаг чанарын хоёулангийнх нь амьдрал юм. Амьдралынхаа эхний үе шатанд Тэр бүрэн энгийн хүн чанараар амьдardгийн шалтгаан бол Түүний хүн чанар нь бурханлаг ажлыг нь хараахан бүрэн хадгалж чаддаггүй, хараахан төлөвшөөгүй байдаг; Түүний хүн чанар төлөвшиж гүйцэн, Өөрийн үйлчлэлийг үүрэх чадвартай болсны дараа л Тэр гүйцэтгэх учиртай үйлчлэлээ хэрэгжүүлж эхэлж чадна. Махбод болохын хувиар Тэр өсөж, төлөвших хэрэгтэй тул Түүний амьдралын эхний үе шат нь хэвийн хүн чанарын амьдрал байдаг байхад хоёр дахь үе шатанд Түүний хүн чанар нь ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэх чадвартай болдог учраас Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх үеийн бие махбодтой болсон Бурханы амьдрал нь хүн чанар болон бүрэн бурханлаг чанарыг хоёуланг нь агуулсан амьдрал байдаг. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан төрсөн мөчөөсөө л Өөрийн үйлчлэлийг жинхэнээсээ эхэлж, ер бусын тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол Түүнд бие махбодын мөн чанар байхгүй байх байсан юм. Тиймээс Түүний хүн чанар бие махбодынх нь мөн чанарын төлөө оршдог; хүн чанаргүй ямар ч махан бие байж болохгүй бөгөөд хүн чанаргүй хүн бол хүн биш. Ийм маягаар, Бурханы махбодын хүн чанар бол Бурханы махбод болсон биеийн төрөлхийн чанар юм. “Бурхан махбод болох үедээ тэр чигтээ бурханлаг чанартай бөгөөд огтхон ч хүн биш” гэж хэлэх нь доромжлол юм, учир нь энэхүү мэдэгдэл ердөө оршин байдаггүй бөгөөд бие махбодтой болох зарчмыг зөрчдөг. Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлснийхээ дараа ч гэсэн, ажлаа хийх үедээ Тэрээр хүний гадаад бүрхүүлтэй бурханлаг чанар дотроо амьдарсаар байдаг; яг тэр үед Түүний хэвийн хүн чанар нь хэвийн махбодоор ажлаа гүйцэтгэх боломжийг Өөрийн бурханлаг чанарт олгох цорын ганц зорилготой байдаг. Иймээс ажил гүйцэтгэгч нь Түүний хүн чанарт оршин буй бурханлаг чанар юм. Түүний хүн чанар биш, харин бурханлаг чанар ажиллаж байгаа ч энэхүү бурханлаг чанар нь Түүний хүн чанар дотор нуугдаж байдаг; мөн чанартаа, Түүний хүн чанар биш, харин бүрэн бурханлаг чанар ажлыг нь хийдэг. Гэхдээ ажлыг гүйцэтгэгч нь Түүний махбод юм. Бурхан хүний бүрхүүлтэй, хүний мөн чанартай, бас Бурханы мөн чанартайгаар махан биед

амьдардаг Бурхан болдог учраас Тэр бол хүн, гэхдээ бас Бурхан гэж хэлж болох юм. Тэр бол Бурханы мөн чанартай хүн учраас бүтээгдсэн бүх хүнээс дээгүүр, Бурханы ажлыг гүйцэтгэж чадах өөр ямар ч хүнээс дээгүүр байдаг. Иймээс Түүнийх шиг хүний бүрхүүлтэй бүх хүний дундаас, хүн чанарыг эзэмшдэг бүх хүний дундаас зөвхөн Тэр л бие махбодтой болсон Бурхан Өөрөө бөгөөд бусад нь бүгд бүтээгдсэн хүн билээ. Хэдийгээр тэд бүгдээрээ хүн чанартай ч гэсэн, бүтээгдсэн хүмүүст хүн чанар л байдаг байхад бие махбодтой болсон Бурхан бол өөр: Түүний махбод хүн чанартай байдгаар зогсохгүй, үүнээс ч чухал нь бурханлаг чанартай байдаг. Түүний хүн чанарыг махбодынх нь гадаад төрхөөс болон өдөр тутмын амьдралаас нь харж болно, гэхдээ Түүний бурханлаг чанарыг ухамсарлахад хэцүү байдаг. Яагаад гэвэл, Түүний бурханлаг чанар Түүнд хүн чанар байгаа үед л илэрхийлэгддэг ба хүмүүсийн төсөөлдөгтэй адил ер бусын байдаггүй, үүнийг харах нь хүмүүст туйлын хэцүү байдаг. Өнөөдөр ч гэсэн бие махбодтой болсон Бурханы жинхэнэ мөн чанарыг ойлгох нь хүмүүст хамгийн хэцүү. Намайг энэ талаар ийм ихийг ярьсны дараа ч гэсэн энэ нь та нарын дийлэнхэд нууц хэвээр байдаг гэж Би бодож байна. Үнэндээ, энэ асуудал маш энгийн: Бурхан махбод болдог тул Түүний мөн чанар нь хүн чанар ба бурханлаг чанарын хослол юм. Энэ хослолыг Бурхан Өөрөө буюу газар дээрх Бурхан Өөрөө гэж нэрлэдэг.

Есүсийн газар дээр амьдарсан амьдрал нь махбодын хэвийн амьдрал байлаа. Тэрээр махбодынхоо хэвийн хүн чанараар амьдарсан. Өөрийн ажлыг хийж, үгээ хэлж, эсвэл өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах, тийм ер бусын зүйлсийг хийх эрх мэдэл нь ерөнхийдөө Түүнийг үйлчлэлээ эхлэх хүртэл нь харагдаагүй. Хорин есөн наснаас өмнөх, Өөрийнхөө үйлчлэлийг эхлэхээс өмнөх амьдрал нь Түүнийг ердөө л хэвийн махбод бүхий бие байсан гэдгийг хангалттай нотолсон. Үүнээс болж, мөн Тэр Өөрийн үйлчлэлийг хараахан эхлээгүй байсан учраас хүмүүс Түүнээс ямар ч бурханлаг байдлыг олж хараагүйн дээр ердөө л тухайн үед зарим хүн Түүнийг Иосефын хүү гэж итгэдэг байсан тул ердийн хүн, эгэл хүн л гэж харж байсан юм. Хүмүүс Түүнийг жирийн хүний хүү гэж бодсон бөгөөд Бурханы махбод болсон бие гэж таних ямар ч аргагүй байлаа; Өөрийнхөө үйлчлэлийг гүйцэтгэх явцад олон гайхамшиг үзүүлж байхад нь хүртэл ихэнх хүн Түүнийг Иосефын хүү гэсээр байсан, учир нь Тэр бол гаднаа хэвийн хүн чанарын бүрхүүлтэй Христ байсан юм. Түүний хэвийн хүн чанар болон ажлын аль аль нь, анх удаа бие махбодтой болсны ач холбогдлыг биелүүлэхийн төлөө, Бурхан махбодод бүрмөсөн ирж, үнэхээр эгэл

жирийн хүн болсныг батлахын төлөө оршиж байлаа. Тэрээр Өөрийн ажлыг эхлэхээс өмнө хэвийн хүн чанартай байсан нь эгэл жирийн махбод байсных нь нотолгоо байв; дараа нь Тэр ажилласан нь ч бас эгэл жирийн махбод байсныг нь нотолсон, учир нь Тэр хэвийн хүн чанартай махбодоор тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж байсан билээ. Тэр гайхамшиг үзүүлж чаддаг байсны шалтгаан нь Түүний махбод Бурханы эрх мэдэлтэй, Бурханы Сүнсний өмссөн махбод байсан юм. Бурханы Сүнснээс болоод Тэр ийм эрх мэдэлтэй байсан ба Тэр махбод байгаагүй гэсэн үг биш. Өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Өөрийн үйлчлэлээр гүйцэтгэх хэрэгтэй байсан ажил, Түүний хүн чанарт нуугдсан бурханлаг чанарын илэрхийлэл байсан бөгөөд Тэр ямар ч тэмдэг үзүүлж, эрх мэдлээ яаж ч харуулсан байсан, хэвийн хүн чанараар амьдарч, хэвийн махбод хэвээр байсан. Загалмай дээр үхсэнийхээ дараа дахин амилах хүртлээ Тэр хэвийн махбод дотор оршиж байсан. Нигүүлсэл хайрлаж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь бүгд Түүний үйлчлэлийн нэг хэсэг байсны дээр эдгээр нь бүгд Өөрийн хэвийн махбодод байхдаа гүйцэтгэсэн Түүний ажил байв. Цовдлогдохоосоо өмнө, Тэр юу ч хийж байсан, хэвийн хүний махбодоо хэзээ ч орхиогүй. Тэр бол Бурханы ажлыг хийж буй Бурхан Өөрөө байсан ч Бурханы махбод болсон бие байсан учраас хоол идэж, хувцас өмсөж, хүний хэвийн хэрэгцээтэй, хүний хэвийн эрүүл ухаан, хэвийн сэтгэхүйтэй байсан. Энэ бүхэн нь Тэр хэвийн хүн байсны нотолгоо бөгөөд Бурханы махбод болсон бие ер бусын биш, харин хэвийн хүн чанартай махбод байсныг нотолсон. Түүний ажил бол эхний удаа бие махбодтой болсон Бурханы ажлыг гүйцэлдүүлж, эхний удаа бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэх учиртай үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал байв. Бие махбодтой болохын ач холбогдол нь эгэл, жирийн хүн Бурханы Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг; өөрөөр хэлбэл, Бурхан бурханлаг ажлаа хүн чанараар хэрэгжүүлж, улмаар Сатаныг ялдаг. Бие махбодтой болох гэдэг нь Бурханы Сүнс махбод болдог, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болдог гэсэн үг; тэрхүү махбодын хийдэг ажил нь махбодод биеллээ олж, махбодоор илэрхийлэгддэг Сүнсний ажил юм. Бурханы махбодоос өөр хэн ч бие махбодтой болсон Бурханы үйлчлэлийг хэрэгжүүлж чадахгүй; өөрөөр хэлбэл, өөр хэн ч биш, зөвхөн Бурханы махбод болсон бие, энэхүү хэвийн хүн чанар л бурханлаг ажлыг илэрхийлж чадна. Бурхан анх ирэх үедээ хорин есөн нас хүрэхээсээ өмнө хэвийн хүн чанартай байгаагүй бол, хэрвээ төрөнгүүтээ л гайхамшиг үзүүлж, хэлд ормогцоо л тэнгэрийн хэлээр ярьж, газар дээр анх хөл тавьсан үеэсээ л хорвоогийн бүх хэрэг явдлыг ухан

ойлгож, хүн бүрийн бодол, санаа зорилгыг ялган таньж чаддаг байсан бол, ийм хүнийг хэвийн хүн гэж нэрлэж болохгүй байх байсан бөгөөд ийм махбодыг хүний махан бие гэж нэрлэж болохгүй байх байлаа. Хэрвээ Христ ийм байсан бол Бурхан бие махбодтой болохын мөн чанар, утга учир алдагдах байв. Тэр хэвийн хүн чанартай байдаг нь махбод болсон Бурхан мөн гэдгийг нь нотолдог; Тэрээр хүний хэвийн өсөлтийн үйл явцыг туулдаг нь хэвийн махбод мөн гэдгийг нь улам батлан харуулдаг; түүнчлэн, Тэр бол махбод болсон Бурханы Үг, Бурханы Сүнс гэдгийг Түүний ажил хангалттай нотолдог. Ажлынхаа хэрэгцээнээс болж л Бурхан махбод болдог; өөрөөр хэлбэл, ажлын энэ үе шатыг махбодоор хийх ёстой, хэвийн хүн чанараар гүйцэтгэх ёстой. Энэ нь “Үг махбод болох”, “Үг махбодоор илрэхийн” урьдач нөхцөл, Бурхан хоёр удаа бие махбодтой болсны цаад үнэн түүх билээ. Есүс насан туршдаа гайхамшиг үзүүлсэн, газар дээрх ажлаа дуусгах хүртэл хэвийн хүн чанарын ямар ч шинж тэмдгийг харуулаагүй, Түүнд хүний хэвийн хэрэгцээ, сул тал, хүний сэтгэл хөдлөл байгаагүй, амьдралын үндсэн хэрэгцээ шаардлагагүй байсан, хэвийн хүн шиг ч боддоггүй байсан гэж хүмүүс итгэж магадгүй. Тэд Түүнийг хүний хэрээс хэтэрсэн оюун ухаантай, ер бусын хүн чанартай л гэж төсөөлдөг. Нэгэнт Тэр Бурхан учраас хэвийн хүмүүс шиг бодож, амьдрах ёсгүй, хэвийн хүн буюу жинхэнэ хүн л хэвийн хүний бодлыг бодож, хүний хэвийн амьдралаар амьдарч чадна гэж тэд итгэдэг. Эдгээр нь бүгд хүний санаа, хүний үзэл бөгөөд эдгээр үзэл Бурханы ажлын анхдагч санаа зорилгод харшилдаг. Хүний хэвийн сэтгэхүй нь хүний хэвийн эрүүл ухаан, хэвийн хүн чанарыг хадгалдаг; хэвийн хүн чанар нь махбодын хэвийн үйл ажиллагааг хадгалдаг; махбодын хэвийн үйл ажиллагаа нь махбодыг бүхэлд нь хэвийн амьдруулдаг. Бурхан тийм махбодод ажиллаж байж л бие махбодтой болсон зорилгоо биелүүлж чадна. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан зөвхөн махбодын гадаад бүрхүүлтэй боловч хэвийн хүний бодлыг боддоггүй бол энэхүү махбодод жинхэнэ хүн чанар бүү хэл, хүний эрүүл ухаан ч байхгүй. Хүн чанаргүй ийм махбод нь бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэх учиртай үйлчлэлийг биелүүлж яаж чадах юм бэ? Хэвийн оюун ухаан нь хүний амьдралын бүх талыг хадгалдаг; хэвийн оюун ухаангүй бол хүн, хүн биш байх болно. Өөрөөр хэлбэл, хэвийн бодол боддоггүй хүн бол сэтгэцийн өвчтэй бөгөөд ямар ч хүн чанаргүй, зөвхөн бурханлаг чанартай Христийг Бурханы махбод болсон бие гэж хэлж болохгүй. Тэгвэл Бурханы махбод болсон бие ямар ч хэвийн хүн чанаргүй байж яаж болох юм бэ? Христэд ямар ч хүн чанар байхгүй гэж хэлэх нь доромжлол бус уу? Хэвийн хүмүүсийн явуулдаг бүх

үйл ажиллагаа нь хүний хэвийн оюун ухааны ажиллагаанд түшиглэдэг. Үүнгүйгээр, хүмүүс этгээд авирлах байсан; тэр ч бүү хэл тэд хар цагаан, сайн мууг ялгаж чадахгүй байх байсан; тэгээд хүний ёс зүй, ёс суртахууны зарчимгүй байх байсан. Үүний адилаар, хэрвээ бие махбодтой болсон Бурхан хэвийн хүн шиг боддоггүй байсан бол жинхэнэ бие махбод буюу хэвийн махбод биш байх байсан юм. Юм боддоггүй тийм махбод бурханлаг ажлыг гүйцэтгэж чадахгүй байх байлаа. Тэрээр хэвийн махан биеийн үйл ажиллагааг хэвийн байдлаар явуулж чадахгүй, газар дээр хүмүүстэй хамт амьдарч бүр ч чадахгүй байх байв. Тэгээд Бурхан бие махбодтой болсны ач холбогдол, Бурхан махбодод ирэхийн гол мөн чанар алдагдах байсан юм. Бие махбодтой болсон Бурханы хүн чанар нь махбод дахь хэвийн бурханлаг ажлыг хадгалахын төлөө оршдог; Түүний хэвийн хүний сэтгэхүй нь хэвийн хүн чанар болоод махбодынх нь бүх хэвийн үйл ажиллагааг хадгалдаг. Түүний хэвийн хүний сэтгэхүй нь махбод дахь Бурханы ажлыг хадгалахын тулд оршдог гэж хэлж болох юм. Хэрвээ энэхүү махбодод хүний хэвийн оюун ухаан байгаагүй бол Бурхан махбодоор ажиллаж чадахгүй байх байсан ба махбодоор хийх хэрэгтэй зүйлс нь хэзээ ч гүйцэлдэхгүй байх байлаа. Бие махбодтой болсон Бурханд хүний хэвийн оюун ухаан байдаг хэдий ч Түүний ажилд хүний бодол холилддоггүй; Тэр хүний хэвийн бодлоор бус, харин оюун ухаантай хүн чанарыг эзэмшсэн урьдач нөхцөл дор хэвийн оюун ухаантай хүн чанараар Өөрийн ажлыг явуулдаг. Түүний махбодын бодол хэчнээн сүрлэг байх нь хамаагүй, Түүний ажилд логик юм уу сэтгэлгээ холилддоггүй. Өөрөөр хэлбэл, Түүний ажил нь Түүний махан биеийн оюун ухаанаас төрөн гардаггүй, харин Түүний хүн чанар дахь бурханлаг ажлын шууд илэрхийлэл юм. Түүний бүх ажил нь Түүний биелүүлэх ёстой үйлчлэл бөгөөд нэгийг нь ч Түүний уураг тархи бодож олдоггүй. Жишээлбэл, өвчтэйг эдгээх, чөтгөрийг зайлуулах болон цовдлол нь Түүний хүний оюун ухааны үр дүн байгаагүй, хүний оюун ухаантай ямар ч хүн үүнийг хийж чадахгүй байх байсан юм. Үүний адилаар, өнөөдрийн байлдан дагуулалтын ажил бол бие махбодтой болсон Бурханы хэрэгжүүлэх ёстой үйлчлэл боловч энэ нь хүний хүслийн ажил биш, харин Түүний бурханлаг чанарын хийх ёстой ажил, махан биетэй ямар ч хүний хийж чадахгүй ажил билээ. Иймээс бие махбодтой болсон Бурханд хүний хэвийн оюун ухаан, хэвийн хүн чанар байх ёстой, учир нь Тэр хэвийн оюун ухаантай хүн чанараар Өөрийн ажлыг гүйцэтгэх ёстой. Энэ бол бие махбодтой болсон Бурханы ажлын мөн чанар, бие махбодтой болсон Бурханы жинхэнэ мөн чанар юм.

Есүс ажлаа гүйцэтгэхээс өмнө ердөө л хэвийн хүн чанараараа амьдарч байлаа. Тэр бол Бурхан мөн гэдгийг хэн ч таньж чадаагүй, бие махбодтой болсон Бурхан гэдгийг нь хэн ч олж мэдээгүй; хүмүүс Түүнийг тун жирийн хүн гэж л мэддэг байсан. Түүний туйлын эгэл жирийн, хэвийн хүн чанар нь Бурхан бие махбодтой болсны нотолгоо, мөн Нигүүлслийн эрин үе нь Сүнсний ажлын эрин үе биш, харин бие махбодтой болсон Бурханы ажлын эрин үе гэдгийн нотолгоо байлаа. Энэ нь, Бурханы Сүнс махбодод бүрэн биеллээ олж, бие махбодтой болсон Бурханы эрин үед Түүний махбод Сүнсний бүх ажлыг гүйцэтгэнэ гэдгийн нотолгоо байв. Хэвийн хүн чанартай Христ бол дотор нь Сүнс биеллээ олсон махбод бөгөөд хэвийн хүн чанар, хэвийн эрүүл ухаан, хүний бодлыг эзэмшиж байдаг. “Биеллээ олно” гэдэг нь Бурхан хүн болж, Сүнс махбод болдог гэсэн үг; илүү тодорхой хэлэх юм бол, энэ нь Бурхан Өөрөө хэвийн хүн чанартай махбодод оршиж, үүгээрээ Өөрийн бурханлаг ажлыг илэрхийлдэг үе юм—энэ нь биеллээ олсон буюу бие махбодтой болсон гэсэн үг билээ. Эхний удаад бие махбодтой болох үед Бурханы ажил нь золин аврахын төлөө байсан учраас өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах шаардлагатай байсан. Бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд Тэрээр энэрэнгүй, өршөөнгүй байх хэрэгтэй байв. Цовдлогдохоосоо өмнө Түүний хийсэн ажил нь өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах явдал байсан нь хүнийг нүгэл, бузар муухайгаас аврах авралыг нь зөгнөсөн юм. Энэ нь Нигүүлслийн эрин үе байсан учраас Түүний хувьд өвчтэй хүмүүсийг эдгээж, улмаар тухайн эрин үе дэх нигүүлслийн бэлгэдэл болох тэмдэг, гайхамшигийг үзүүлэх шаардлагатай; учир нь Нигүүлслийн эрин үе бол хүмүүсийн Есүст итгэх итгэлийн бэлгэ тэмдэг болох амар тайван, баяр баясал, материаллаг ерөөлөөр бэлгэдсэн нигүүлслийг өгөхөд төвлөрсөн. Өөрөөр хэлбэл, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж, нигүүлсэл хайрлах нь Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн махбодын төрөлхийн чадвар байсан ба махбодод биеллээ олсон Сүнсний ажил байсан юм. Гэхдээ тийм ажил гүйцэтгэж байх явцдаа Тэр махбодод амьдарч байсан бөгөөд махбодоос хэтрэн гараагүй. Тэр анагааж эдгээх ямар үйл хийсэн нь хамаагүй, мөн л хэвийн хүн чанартай байсан бөгөөд хэвийн хүний амьдралаар амьдарсан хэвээр байсан. Бие махбодтой болсон Бурханы эрин үед махбод нь Сүнсний бүх ажлыг гүйцэтгэдэг гэж хэлдгийн минь шалтгаан бол, Тэр ямар ч ажил хийлээ гэсэн үүнийгээ махбодоор хийсэн билээ. Гэвч Түүний ажлаас болоод хүмүүс Түүний махбодыг бүрэн дүүрэн бие махбодын мөн чанартай гэж үзээгүй, учир нь энэхүү махбод гайхамшиг үзүүлж, зарим нэг онцгой мөчид махан биеэс даван

гарсан зүйлсийг хийж байсан юм. Мэдээж, Түүнийг үйлчлэлээ эхэлсний дараа л дөчин өдрийн турш соригдох, уулан дээр хувирах гэх мэтийн энэ бүх явдал тохиолдсон. Иймээс Есүсийн хувьд, Бурхан бие махбодтой болохын утга учир бүрэн гүйцэлдээгүй, харин зөвхөн хагас биелсэн. Өөрийн ажлыг эхлэхээс өмнө махбодод амьдарсан Түүний амьдрал бүх талаараа тун хэвийн байсан. Ажлаа эхэлснийхээ дараа Тэрээр махбодынхоо гадаад бүрхүүлийг л хадгалсан. Түүний ажил бурханлаг чанарын илэрхийлэл байсан учраас махан биеийн хэвийн ажиллагаанаас даван гарсан юм. Эцсийн эцэст, Бурханы махбод болсон бие нь мах, цустай хүмүүсийн биеэс ялгаатай байлаа. Мэдээж, Түүний өдөр тутмын амьдралд бусдын адилаар хоол, хувцас, нойр, орон байр шаардагдаж, бүх хэвийн хэрэгцээ хэрэгтэй байсан ба Тэрээр хэвийн хүний эрүүл ухаантай, хэвийн хүн шиг бодолтой байсан. Түүний хийсэн ажил ер бусын байснаас бусдаар бол хүмүүс Түүнийг хэвийн хүн гэж үзсээр байлаа. Үнэндээ Тэр юу ч хийсэн бай, жирийн, хэвийн хүн чанараар амьдарсан бөгөөд Тэр ажлаа гүйцэтгэж байсан учраас өөр ямар ч хэвийн хүмүүсийнхээс илүүгээр Түүний эрүүл ухаан тун хэвийн, бодол нь нэн тодорхой байсан. Ийм бодол, эрүүл ухаантай байх нь бие махбодтой болсон Бурханд чухал байсан, учир нь эрүүл ухаан нь тун их хэвийн, бодол нь маш тодорхой байдаг махбодоор бурханлаг ажил илэрхийлэгдэх хэрэгтэй байв—зөвхөн ийм маягаар л Түүний махбод бурханлаг ажлыг илэрхийлж чадах байсан юм. Газар дээр амьдарсан гучин гурван жил хагасынхаа туршид Есүс хэвийн хүн чанараа хадгалсан боловч гурван жил хагасын үйлчлэлийн ажлаас нь үүдэн хүмүүс Түүнийг маш гайхалтай, өмнөхөөсөө хамаагүй илүү ер бусын болсон гэж боджээ. Бодит байдал дээр Есүсийн хэвийн хүн чанар нь Түүнийг үйлчлэлээ эхлэхээс өмнө нь ч, дараа нь ч өөрчлөгдөөгүй хэвээр үлдсэн; Түүний хүн чанар цаг ямагт адилхан байсан боловч Өөрийнхөө үйлчлэлийг эхлэхийн өмнөх ба дараах ялгааных нь улмаас Түүний махбодтой холбоотой хоёр өөр үзэл бодол гарч ирсэн. Хүмүүс юу гэж бодож байсан нь хамаагүй, бие махбодтой болсон Бурхан анхдагч, хэвийн хүн чанараа бүхий л хугацаанд хэвээр хадгалсан, учир нь Бурхан нэгэнт бие махбод болсон болохоор махбодод буюу хэвийн хүн чанартай махбодод амьдарч байсан юм. Тэр Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдгээс үл хамааран, Түүний махбодын хэвийн хүн чанарыг арилгаж болохгүй, учир нь хүн чанар бол махан биеийн үндсэн мөн чанар билээ. Есүсийг үйлчлэлээ хэрэгжүүлэхээс өмнө Түүний махбод тун хэвийн хэвээр байж, ердийн хүний бүх үйл ажиллагааг гүйцэтгэж байсан; Тэрээр ердөө ч ер бусын

харагдаагүй, ямар ч гайхалтай тэмдэг үзүүлээгүй. Тухайн үед Тэрээр Бурханыг шүтэн мөргөдөг маш эгэл хүн байсан, гэхдээ Түүний эрэл хайгуул өөр ямар ч хүнийхээс илүү үнэнч, илүү чин шударга байсан билээ. Түүний туйлын хэвийн хүн чанар ийнхүү илэрхийлэгдэж байсан юм. Өөрийнхөө үйлчлэлийг явуулахаас өмнө Тэр ямар ч ажил хийгээгүй учраас хэн ч Түүний ялгамж чанарыг мэдээгүй, Түүний махбод бусад бүх хүнийхээс өөр гэдгийг хэн ч таньж чадаагүй, учир нь Тэр ганц ч ид шид үзүүлээгүй, Бурханы ажлын өчүүхэн хэсгийг ч гүйцэтгээгүй байсан. Гэхдээ, үйлчлэлээ гүйцэтгэж эхэлснийхээ дараа Тэрээр хэвийн хүн чанарын гадаад бүрхүүлээ хадгалж, хэвийн хүний эрүүл ухаантай амьдарсаар байсан хэр нь Бурханы Өөрийн ажлыг хийж, Христийн үйлчлэлийг Өөртөө авч, мах цуснаас бүрдсэн, үхэх үйлтэй хүмүүсийн хийж чадахааргүй ажлыг хийж эхэлсэн учраас Тэр хэвийн хүн чанаргүй бөгөөд бүрэн дүүрэн хэвийн махбод биш, харин бүрэн бус махбод гэж хүмүүс боджээ. Түүний гүйцэтгэсэн ажлаас болоод хүмүүс Түүнийг хэвийн хүн чанаргүй, махбод дахь Бурхан гэлцсэн. Энэ нь эндүү ташаа ойлголт юм, учир нь хүмүүс Бурхан бие махбодтой болохын ач холбогдлыг ухаараагүй. Энэхүү буруу ойлголт нь, махбодоор хийгдсэн Бурханы ажил нь хэвийн хүн чанартай махбодоор илэрхийлэгдсэн бурханлаг ажил байснаас үүдэн гарсан. Бурхан махбодоор хувцаслаж, махбод дотор оршсон бөгөөд хүн чанараар хийсэн ажил нь Түүний хүн чанарын хэвийн байдлыг бүрхэгдүүлсэн юм. Ийм учраас хүмүүс Бурханд хүн чанар байхгүй, гагцхүү бурханлаг чанар бий гэж итгэжээ.

Эхний удаа бие махбодтой болохдоо Бурхан бие махбодтой болсон Бурханы ажлыг гүйцэлдүүлээгүй; Тэр ердөө ажлын эхний үе шатыг гүйцээсэн ба Бурхан үүнийг махбодоор хийх шаардлагатай байв. Иймээс, бие махбодтой болох ажлыг дуусгахын тулд Бурхан дахин нэг удаа махбодод эргэн ирээд махбодын бүх л хэвийн, бодитой байдлыг амьдран харуулдаг, өөрөөр хэлбэл, Бурханы Үгийг бүхэлдээ хэвийн, эгэл махбодоор илэрхийлж, улмаар махбодоор хийж чадалгүй орхисон ажлаа гүйцээдэг. Бурханы махбод болсон хоёр дахь бие нь мөн чанараараа эхнийхтэй адил боловч эхнийхээсээ бүр илүү бодитой, бүр илүү хэвийн байдаг. Үүний үр дүнд, Бурханы махбод болсон хоёр дахь биеийн туулдаг зовлон эхнийхээс илүү их байх боловч энэхүү зовлон нь махбод дахь Түүний үйлчлэлийн үр дүн бөгөөд завхарсан хүний зовлонгоос ялгаатай байдаг. Энэ нь бас Түүний махбодын хэвийн, бодитой байдлаас урган гардаг. Тэр Өөрийн үйлчлэлийг туйлын хэвийн, бодитой махбодоор хэрэгжүүлдэг учраас махбод нь асар их зовлон зүдүүрийг туулах ёстой. Энэхүү махбод хэвийн,

бодитой байх тусам Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхдээ төдий чинээ их зовно. Бурханы ажил огтхон ч ер бусын биш, маш эгэл жирийн махбодоор илэрхийлэгддэг. Түүний махбод хэвийн бөгөөд хүнийг аврах ажлыг ч бас үүрэх ёстой учраас Тэрээр ер бусын махан биеэс ч илүү их зовдог—энэ бүх зовлон нь Түүний махбодын бодитой, хэвийн байдлаас үүсэн гардаг. Бурханы махбод болсон хоёр биеийн үйлчлэлээ гүйцэтгэх явцдаа туулсан зовлонгоос бие махбодтой болохын мөн чанарыг харж болно. Махбод нь хэвийн байх тусам ажлаа хийх явцдаа Тэр төдий чинээ их зовлон бэрхшээл туулах ёстой байдаг; ажлыг хийж буй махбод бодитой байх тусам хүмүүсийн үзэл төдий чинээ хатуу болдог, мөн төдий чинээ их аюул Түүнд тохиолдох магадлалтай байдаг. Түүнчлэн махбод нь бодитой байх тусам, мөн махбод нь хэвийн хүний бүрэн эрүүл ухаан болон хэрэгцээтэй байх тусам Тэр Бурханы ажлыг махбодоор хийх төдий чинээ чадвартай байдаг. Есүсийн махбод загалмай дээр цовдлогдсон, Тэр Өөрийн махбодыг нүглийн тахил болгосон; хэвийн хүн чанартай махбодын тусламжтайгаар Тэр Сатаныг ялж, хүнийг загалмайнаас бүрэн аварсан. Хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурхан нь бүрэн төгс махбодоор байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэж, Сатаныг ялдаг. Бүрмөсөн хэвийн, бодитой махбод л байлдан дагуулалтын ажлыг бүхэлд нь хэрэгжүүлж, хүчирхэг гэрчлэл хийж чадна. Өөрөөр хэлбэл, хүнийг байлдан дагуулах нь ер бусын ид шид, илчлэлээр бус, махбод дахь Бурханы бодитой, хэвийн байдлаар дамжин үр дүнд хүрдэг. Бие махбодтой болсон энэ Бурханы үйлчлэл нь үг хэлж, улмаар хүнийг байлдан дагуулж, төгс болгох явдал юм; өөрөөр хэлбэл, махбодод биеллээ олсон Сүнсний ажил буюу махбодын үүрэг нь үг хэлж, тэгснээрээ хүнийг бүрэн байлдан дагуулж, илчилж, төгс болгож, таягдан хаях явдал билээ. Иймээс байлдан дагуулалтын ажлаар дамжуулан махбод дахь Бурханы ажил бүрэн гүйцэлдэнэ. Эхний золин авралын ажил нь бие махбодтой болсон Бурханы ажлын ердөө л эхлэл байсан; байлдан дагуулалтын ажлыг хийдэг махбод нь бие махбодтой болохын бүх ажлыг гүйцээнэ. Хүйсийн хувьд нэг нь эрэгтэй, нөгөө нь эмэгтэй бөгөөд үүгээр Бурхан бие махбодтой болохын утга учрыг биелүүлж, Бурханы талаарх хүний үзлийг арилгадаг: Бурхан эрэгтэй, эмэгтэй аль нь ч болж чадах ба мөн чанартаа бол бие махбодтой болсон Бурхан хүйсгүй юм. Тэрээр эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн бөгөөд Түүний хувьд хүйсийн ялгаа байхгүй. Ажлын энэ үе шатанд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй, иймээс энэхүү ажил нь үгийн тусламжтайгаар үр дүндээ хүрнэ. Түүнчлэн, үүний шалтгаан нь энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажил бол

өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах явдал биш, харин үгээ хэлж, хүнийг байлдан дагуулах явдал юм, өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон энэхүү биеийн эзэмшсэн төрөлх чадвар нь өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах биш, харин үг хэлэх, хүнийг байлдан дагуулах билээ. Хэвийн хүн чанараар хийдэг Түүний ажил ид шидийг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах биш, харин үг хэлэх явдал тул Бурханы махбод болсон хоёр дахь бие нь хүмүүст эхнийхээсээ хавьгүй илүү хэвийн мэт санагддаг. Бурхан бие махбодтой болох нь худал биш гэдгийг хүмүүс хардаг; гэвч бие махбодтой болсон энэхүү Бурхан нь бие махбодтой болсон Есүсээс өөр бөгөөд хоёулаа бие махбодтой болсон Бурхан мөн хэдий ч Тэд ав адилхан биш. Есүс хэвийн хүн чанартай, жирийн хүн чанартай байсан боловч Түүнийг олон тэмдэг, гайхамшиг дагалдаж байсан. Энэ удаа бие махбодтой болсон Бурханаас хүн ямар ч тэмдэг, гайхамшиг харахгүй, өвчтэйг эдгээж байгааг ч, чөтгөрийг зайлуулж байгааг ч, тэнгис дээгүүр алхахыг ч, эсвэл дөчин өдрийн турш мацаг барихыг ч харахгүй... Тэр Есүсийн хийсэнтэй адилхан ажлыг хийдэггүй бөгөөд энэ нь Түүний махбод мөн чанараараа Есүсийнхээс өөр учраас биш, харин өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Түүний үйлчлэл биш учраас тэр юм. Тэр Өөрийн ажлыг сүйтгэдэггүй, Өөрийн ажлыг үймүүлдэггүй. Нэгэнт Тэр Өөрийн бодит үгээр хүнийг байлдан дагуулдаг тул хүнийг ид шидээр эрхшээлдээ оруулах гэсний хэрэггүй, иймээс энэ үе шат нь бие махбодтой болох ажлыг төгсгөхийн төлөө байдаг. Өнөөдөр чиний хардаг бие махбодтой болсон Бурхан бол бүхэлдээ махбод бөгөөд Түүнд ер бусын зүйл огт байхгүй. Тэр бусдын адил өвддөг, яг л бусдын адилаар хоол, хувцас хэрэгтэй болдог; Тэр бүхэлдээ махбод юм. Хэрвээ энэ удаа, бие махбодтой болсон Бурхан ер бусын тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж, эсвэл нэг үгээр үхүүлж чаддаг байсан бол байлдан дагуулалтын ажлыг явуулж яаж чадах юм бэ? Энэхүү ажил Харь үндэстний дунд түгж яаж чадах юм бэ? Өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Нигүүлслийн эрин үеийн ажил буюу золин авралын ажлын эхний алхам байсан бөгөөд Бурхан хүнийг загалмайнаас аварчихсан болохоор уг ажлыг Тэр дахиж хийхгүй. Хэрвээ эцсийн өдрүүдэд өвчтэйг эдгээн, чөтгөрийг зайлуулж, хүний төлөө цовдлогдсон Есүстэй адилхан нэг “Бурхан” гарч ирэх юм бол тэр “Бурхан” хэдийгээр Библи дэх Бурханы тодорхойлолттой адилхан, хүлээн зөвшөөрөхөд хүнд хялбар байх ч мөн чанартаа Бурханы Сүнсний өмссөн махбод биш, харин муу ёрын сүнсний өмссөн махан бие байна. Учир нь Өөрийнхөө аль хэдийн дуусгасан зүйлийг хэзээ ч давтдаггүй нь Бурханы ажлын зарчим билээ. Иймээс

хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь эхнийхийн ажлаас өөр байдаг. Эцсийн өдрүүдэд Бурхан байлдан дагуулалтын ажлыг эгэл жирийн, хэвийн махбодоор биелүүлдэг; Тэрээр өвчтэйг эдгээдэггүй, хүний төлөө цовдлогдохгүй, харин гагцхүү махбодоор үг хэлж, махбодоор хүнийг байлдан дагуулдаг. Зөвхөн тийм махбод л Бурханы махбод болсон бие юм; тийм махбод л махбод дахь Бурханы ажлыг гүйцээж чадна.

Энэ үе шатанд бие махбодтой болсон Бурхан зовлон бэрхшээл туулж байсан ч, эсвэл Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж байсан ч, бие махбодтой болохын утга учрыг биелүүлэхийн төлөө үүнийг хийдэг, учир нь энэ бол Бурхан сүүлчийн удаа бие махбодтой болж байгаа хэрэг юм. Бурхан ердөө хоёр удаа л бие махбодтой болж чадна. Гурав дахь удаа гэж байхгүй. Эхний бие махбод нь эрэгтэй байсан, хоёр дахь нь эмэгтэй, иймээс Бурханы махбодын дүр хүний оюун санаанд гүйцэлдсэн; түүнчлэн, хоёр удаа бие махбодтой болсон нь махбодоор хийх Бурханы ажлыг аль хэдийн дуусгасан. Эхний удаад бие махбодтой болсон Бурхан, бие махбодтой болохын утга учрыг биелүүлэхийн тулд хэвийн хүн чанарыг эзэмшиж байсан. Энэ удаа ч Тэр бас хэвийн хүн чанартай байдаг, гэхдээ энэ удаа бие махбодтой болсны утга учир нь өөр: Энэ нь илүү гүн гүнзгий бөгөөд Түүний ажил илүү гүн ач холбогдолтой. Бурхан дахин нэг удаа махбод болсны шалтгаан нь бие махбодтой болохын утга учрыг биелүүлэхийн төлөө байдаг. Бурхан Өөрийн ажлын энэ үе шатыг бүрмөсөн дуусгах үед бие махбодтой болохын бүхий л утга учир буюу махбод дахь Бурханы ажил дуусах ба махбодоор хийгдэх өөр ажил цаашид байхаа болино. Өөрөөр хэлбэл, одоогоос эхлээд Бурхан Өөрийнхөө ажлыг хийхийн тулд дахин хэзээ ч махбодод ирэхгүй. Зөвхөн хүн төрөлхтнийг аварч, төгс болгохын тулд л Бурхан бие махбодтой болох ажлыг хийдэг. Өөрөөр хэлбэл, Өөрийнх нь ажлын төлөө байгаагүй л бол Бурхан махбодод ирэх нь ердийн хэрэг биш юм. Махбодод ажиллахаар ирснээрээ Тэр, Бурхан бол махбод, хэвийн, эгэл жирийн хүн атлаа дэлхийг ялгууснаар хаанчилж, Сатаныг ялж, хүн төрөлхтнийг золин аварч, хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадна гэдгийг Сатанд харуулдаг! Сатаны ажлын зорилго нь хүн төрөлхтнийг завхруулахын төлөө байхад Бурханы зорилго нь хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг. Сатан хүнийг ёроолгүй нүх рүү урхиддаг байхад Бурхан хүнийг тэндээс авардаг. Сатан бүх хүнээр өөрийгөө шүтүүлдэг, харин Бурхан тэднийг Өөрийнхөө ноёрхолд оруулдаг, учир нь Тэр бол бүтээлийн Эзэн билээ. Энэ бүх ажлыг Бурхан хоёр удаа бие махбодтой болсноор гүйцээсэн. Түүний махбод нь мөн чанартаа хүн чанар болон

бурханлаг чанарын нэгдэл бөгөөд хэвийн хүн чанартай байдаг. Иймээс Бурханы махбод болсон биегүйгээр Бурхан хүн төрөлхтнийг аврах үр дүнд хүрч чадахгүй бөгөөд махбодынх нь хэвийн хүн чанар байгаагүй бол махбод дахь Түүний ажил амжилттай болж мөн л чадахгүй байх байсан. Бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь хэвийн хүн чанарыг эзэмших ёстойд оршдог; тэгэхгүй бол энэ нь бие махбодтой болох Бурханы анхдагч санаа зорилгод харшлах байв.

Бие махбодтой болохын утга учир Есүсийн ажлын үе шатанд бүрэн биелээгүй гэж Би яагаад хэлдэг вэ? Учир нь Үг бүхэлдээ махбод болоогүй юм. Есүсийн хийсэн зүйл нь махбод дахь Бурханы ажлын ердөө нэг хэсэг байсан; Тэр зөвхөн золин авралын ажлыг л хийсэн ба хүнийг бүрмөсөн олж авах ажлыг хийгээгүй. Энэ шалтгааны улмаас Бурхан эцсийн өдрүүдэд дахин нэгэнтээ махбод болсон. Ажлын энэ үе шатыг ч бас эгэл жирийн махбодоор хийдэг; хүн чанар нь өчүүхэн төдий ч ер бусын биш, туйлын хэвийн хүн үүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан бүрэн төгс хүн болсон; Тэр бол уг ажлыг хэрэгжүүлж буй Бурханы ялгамж чанартай хүн, бүрэн төгс хүн, бүрэн төгс махбод юм. Хүний нүдээр Тэр бол огтхон ч ер бусын биш махан бие бөгөөд хурлын том танхимд шашны талаарх дотоод үнэнийг илчлэх нь бүү хэл, ямар ч гайхамшигтай тэмдэг үзүүлдэггүй, ямар ч ид шид үзүүлдэггүй, тэнгэрийн хэлээр ярьж чаддаг тун эгэл жирийн хүн билээ. Бурханы махбод болсон хоёр дахь биеийн ажил нь хүмүүст эхний махбодын ажилтай тун адилгүй санагддаг, иймээс энэ хоёрт нийтлэг зүйл огт байхгүй мэт санагддаг бөгөөд эхнийхийн ажлын юуг ч энэ удаа харж чадахгүй. Хэдийгээр Бурханы махбод болсон хоёр дахь биеийн ажил эхний удаагийнхаас ялгаатай ч Тэдний эх сурвалж ав адилхан биш гэдгийг энэ нь нотолдоггүй. Тэдний эх сурвалж адил эсэх нь Тэдний гадаад бүрхүүлээс биш, харин махбодоор хийгддэг ажлын шинж чанараас хамаардаг. Өөрийнхөө ажлын гурван үе шатны явцад Бурхан хоёр удаа бие махбодтой болсон ба хоёуланд нь бие махбодтой болсон Бурханы ажил шинэ эрин үеийг нээж, шинэ ажлыг эхлүүлдэг; ингэж бие махбодтой болсон нь нэг нэгнээ харилцан нөхдөг. Энэ хоёр махбод үнэндээ нэг эх сурвалжаас ирсэн гэдгийг хүний нүдээр танин мэдэх боломжгүй юм. Энэ нь хүний нүдний юм уу хүний оюун ухааны чадвараас хэтийдсэн зүйл гэдгийг хэлэх нь илүүц билээ. Гэхдээ мөн чанартаа бол Тэд адилхан, учир нь Тэдний ажил нэгэн Сүнснээс үүсдэг. Бурханы махбод болсон хоёр бие адилхан эх сурвалжаас гарч ирсэн эсэхийг Тэдний төрсөн эрин үе, төрсөн газраар юм уу, эсвэл тиймэрхүү бусад хүчин зүйлээр дүгнэж болохгүй, харин Тэдний илэрхийлсэн бурханлаг ажлаар л дүгнэж болно. Бурханы махбод

болсон хоёр дахь бие нь Есүсийн хийсэн ажлын алийг ч хийдэггүй, учир нь Бурханы ажил тогтсон заншлыг мөрддөггүй, харин тухай бүрдээ шинэ зам нээдэг. Бурханы махбод болсон хоёр дахь бие нь хүмүүсийн оюун санаан дахь эхний махбодын талаарх сэтгэгдлийг гүнзгийрүүлж, бэхжүүлэх гэж зорьдоггүй, харин үүний дутууг нөхөж, төгс болгож, Бурханы талаарх хүний мэдлэгийг гүнзгийрүүлж, хүмүүсийн зүрх сэтгэлд оршдог бүх дүрмийг эвдэж, тэдний зүрх сэтгэл дэх Бурханы эндүү ташаа төрхийг арилгахаар зорьдог. Бурханы ажлын аль ч тусгаар үе шат нь хүнд Бурханы талаарх бүрэн гүйцэд мэдлэгийг өгч чадахгүй; үе шат бүр нь бүхэл биш, зөвхөн нэг хэсэг мэдлэгийг л өгдөг гэж хэлж болно. Хэдийгээр Бурхан Өөрийн зан чанарыг бүрэн илэрхийлсэн ч хүний ойлгох чадвар хязгаарлагдмал учраас Бурханы талаарх мэдлэг нь хагас хугас хэвээр үлддэг. Хүний хэлийг ашиглаад Бурханы зан чанарыг бүхэлд нь илэрхийлэх боломжгүй; түүнчлэн, Түүний ажлын ганц үе шат Бурханыг бүрэн илэрхийлж яахан чадах билээ? Тэр Өөрийн хэвийн хүн чанарын халхавч дор махбодоор ажилладаг ба хүн Түүнийг бие махбодын бүрхүүлээр нь биш, харин бурханлаг чанарын илэрхийллээр нь л мэдэж болно. Олон янзын ажлаар нь дамжуулан Өөрийг нь мэдэх боломжийг хүнд олгохын тулд Бурхан махбодод ирсэн бөгөөд Түүний ажлын ямар ч хоёр үе шат адилхан биш юм. Зөвхөн ийм маягаар л хүн махбод дахь Бурханы ажлын талаар ганц талд хязгаарлагдаагүй, бүрэн дүүрэн мэдлэгтэй болж чадна. Хэдийгээр Бурханы махбод болсон хоёр биеийн ажил ялгаатай байдаг ч махбодын мөн чанар ба Тэдний ажлын эх сурвалж нь ижил; Тэд ердөө л ажлын хоёр өөр үе шатыг хэрэгжүүлэхийн тулд оршдог, мөн хоёр өөр эрин үед гарч ирдэг. Ямартай ч Бурханы махбод болсон биес нь нэгэн адил мөн чанар болон нэгэн адил гарал үүсэлтэй байдаг—энэ бол хэний ч үгүйсгэж чадахгүй үнэн билээ.

БУРХАНЫ АЖИЛ БА ХҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Хүмүүсийн дундах Бурханы ажлыг хүнээс салгах аргагүй, учир нь хүн энэ ажлын бай бөгөөд Бурханы бүтээл дотроос Бурханд гэрчлэл хийж чадах цорын ганц бүтээл юм. Хүний амьдрал болон хүний бүх үйл ажиллагааг Бурханаас салгах аргагүй, бүгдийг нь Бурханы гар хянадаг бөгөөд нэг ч хүн Бурханаас тусгаар оршиж чадахгүй гэж ч хэлж болно. Энэ нь бодит баримт тул үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Бурханы хийдэг бүхэн хүн төрөлхтний тусын тулд байдаг бөгөөд Сатаны заль мэхийн эсрэг чиглэдэг. Хүнд хэрэгтэй бүхэн Бурханаас

ирдэг, Бурхан бол хүний амийн эх сурвалж билээ. Тиймээс хүн Бурханаас салж ердөө чаддаггүй. Цаашлаад Бурханд ч хүнээс салах санаа хэзээ ч байгаагүй. Бурханы хийдэг ажил бүх хүн төрөлхтний төлөө байдаг бөгөөд бодол нь үргэлжид сайн байдаг. Тэгвэл хүний хувьд, Бурханы ажил болон Бурханы бодлын (өөрөөр хэлбэл, Бурханы хүслийн) аль аль нь хүний мэдэх ёстой “үзэгдэл” юм. Ийм үзэгдэл нь бас Бурханы удирдлага бөгөөд хүний хийж чадахгүй ажил билээ. Ажлынхаа явцад хүнд Бурханы тавьдаг шаардлагыг хүний “хэрэгжүүлэлт” гэж нэрлэдэг. Үзэгдэл бол Бурханы Өөрийн ажил буюу хүн төрөлхтний төлөөх Түүний хүсэл, Түүний ажлын зорилго, ач холбогдол билээ. Үзэгдлийг бас удирдлагын нэг хэсэг гэж болно, учир нь энэхүү удирдлага бол Бурханы ажил бөгөөд хүнд чиглэдэг, энэ нь хүмүүсийн дунд Бурханы хийдэг ажил гэсэн үг юм. Энэ ажил бол хүн Бурханыг мэдэж авах нотолгоо болон зам бөгөөд хүний хувьд туйлын чухал. Хэрвээ Бурханы ажлын талаарх мэдлэгт анхаарал хандуулахын оронд хүмүүс, Бурханд итгэх итгэлийн тухай хоосон сургаал болон чухал биш аар саар зүйлсэд л анхаарлаа хандуулбал Бурханыг ердөө мэдэхгүйгээс гадна Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадахгүй. Бурханы ажил нь Бурханы талаарх хүний мэдлэгт асар тустай бөгөөд үүнийг үзэгдэл хэмээдэг. Эдгээр үзэгдэл бол Бурханы ажил, Бурханы хүсэл, түүнчлэн Бурханы ажлын зорилго болон ач холбогдол юм; эдгээр нь бүгд хүнд тустай. Хэрэгжүүлэлт гэдэг нь хүний хийх ёстой зүйл, Бурханыг дагадаг бүтээлүүдийн хийх ёстой зүйлийг хэлдэг бөгөөд энэ нь бас хүний үүрэг юм. Хүний хийх ёстой зүйл бол анхнаасаа хүний ойлгосон зүйл биш, харин Өөрийнхөө ажлын явцад хүнээс Бурханы шаарддаг зүйл юм. Бурханыг ажиллахын хэрээр эдгээр шаардлага аажмаар илүү гүн гүнзгий, илүү өндөр болдог. Жишээ нь, Хуулийн эрин үед хүн хуулийг дагах ёстой байсан, харин Нигүүлслийн эрин үед загалмай үүрэх ёстой байв. Хаанчлалын эрин үе бол өөр: Хүнд тавих шаардлага нь Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийнхээс илүү өндөр. Үзэгдэл илүү өндөр болохын хэрээр хүнд тавигдах шаардлага бүр ч их өндөр болж, илүү тодорхой, илүү бодитой болдог. Үүний адилаар, үзэгдэл ч бас улам бодитой болдог. Энэ олон бодит үзэгдэл хүнийг Бурханд дуулгавартай байхад туслахаар зогсохгүй, Бурханы талаарх хүний мэдлэгт тус болдог.

Өмнөх эрин үеүдтэй харьцуулахад Хаанчлалын эрин үеийн Бурханы ажил илүү бодитой, хүний мөн чанар болон түүний зан чанарын өөрчлөлтөд илүү их чиглэдэг бөгөөд Өөрийг нь дагадаг бүх хүнд Бурханыг Өөрийг нь илүү их

гэрчилж чаддаг. Өөрөөр хэлбэл, Хаанчлалын эрин үед Бурхан ажиллангаа, өмнөх аль ч үеийнхээс илүүтэйгээр хүнд Өөрийгөө харуулдаг бөгөөд энэ нь хүний мэдэх ёстой үзэгдэл өмнөх аль ч эрин үеийнхээс илүү өндөр байдаг гэсэн үг юм. Хүмүүсийн дундах Бурханы ажил урьд өмнө үзэгдээгүй нутаг дэвсгэрт орсон учраас Хаанчлалын эрин үед хүний мэдэж авдаг үзэгдэл нь бүх удирдлагын төлөвлөгөөн дэх хамгийн өндөр дээд нь билээ. Бурханы ажил урьд үзэгдээгүй нутаг дэвсгэрт орсон тул хүний мэдэх үзэгдэл бүх үзэгдлээс хамгийн өндөр дээд нь болсон ба үүнээс улбаалан хүний хэрэгжүүлэлт ч бас өмнөх аль ч эрин үеийнхээс илүү өндөр болсон, учир нь хүний хэрэгжүүлэлт үзэгдэлтэй зэрэгцэн өөрчлөгддөг бөгөөд үзэгдлийн төгс төгөлдөржилт нь ч бас хүнд тавигдах шаардлага төгс болсныг илтгэдэг. Бурханы бүх удирдлага зогсмогц хүний хэрэгжүүлэлт ч бас зогсох бөгөөд Бурханы ажил үгүй бол хүн өмнөх үеийн сургаалыг мөрдөхөөс өөр сонголтгүй, эсвэл ердөө хаашаа ч хандах аргагүй байх болно. Шинэ үзэгдэлгүйгээр хүний шинэ хэрэгжүүлэлт гэж байхгүй; бүрэн гүйцэд үзэгдэлгүйгээр хүний төгс хэрэгжүүлэлт гэж байхгүй; илүү өндөр үзэгдэлгүйгээр хүний илүү өндөр хэрэгжүүлэлт гэж байхгүй байх болно. Хүний хэрэгжүүлэлт Бурханы мөрийн хамтаар өөрчлөгддөгийн адилаар хүний мэдлэг, туршлага ч бас Бурханы ажилтай хамт өөрчлөгддөг. Хүн хэчнээн чадварлаг байх нь хамаагүй Бурханаас салшгүй хэвээр бөгөөд Бурхан хормын төдийд л ажиллахаа больсон бол Түүний уур хилэнгээс болж хүн нэн даруй үхэх байв. Хүний мэдлэг өнөөдөр хэчнээн өндөр байх нь хамаагүй, туршлага нь хэчнээн гүн гүнзгий байх нь хамаагүй хүн Бурханы ажлаас салшгүй учраас түүнд бардамнах зүйл юу ч үгүй—учир нь хүний хэрэгжүүлэлт болон Бурханд итгэх итгэлээсээ эрж хайх ёстой зүйл үзэгдлээс салшгүй билээ. Бурханы ажил бүрд хүний мэдэх ёстой үзэгдэл байдаг ба үүнийг дагаад хүнд тавьдаг зохих шаардлагууд гэж бий. Эдгээр үзэгдлийг суурь болгохгүйгээр хүн ердөө хэрэгжүүлж ч чадахгүй, мөн Бурханыг тууштай дагаж ч чадахгүй. Хэрвээ хүн Бурханыг мэддэггүй, эсвэл Бурханы хүслийг ойлгодоггүй бол хийдэг бүхэн нь хий дэмий болж, Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй. Хүн хэчнээн их билиг авьяастай байх нь хамаагүй, Бурханы ажлаас болон Бурханы удирдамжаас мөн л салшгүй. Хүний үйлдэл хэчнээн сайн байх нь, эсвэл тэд хэчнээн олон үйлдэл хийх нь хамаагүй Бурханы ажлыг орлож мөн л чадахгүй. Тиймээс ямар ч нөхцөл байдалд хүний хэрэгжүүлэлт үзэгдлээс салшгүй. Шинэ үзэгдлийг хүлээж авдаггүй хүмүүст шинэ хэрэгжүүлэлт байдаггүй. Тэд хоосон сургаалыг баримталж, үхмэл хуулийг мөрддөг учраас хэрэгжүүлэлт нь үнэнтэй ямар ч

холбоогүй байдаг; тэдэнд ямар ч шинэ үзэгдэл байдаггүй, үүний үр дүнд тэд шинэ эрин үеийн юуг ч хэрэгжүүлдэггүй. Тэд үзэгдлийг алдсан, тэгснээрээ бас Ариун Сүнсний ажлыг алдаж, үнэнийг алдсан. Үнэнгүй хүмүүс бол утгагүй байдлын үр сад, Сатаны биелэл юм. Хүн ямар төрлийн хүн байх нь хамаагүй, Бурханы ажлын үзэгдэлгүйгээр байж чадахгүй, мөн Ариун Сүнстэй хамт биш бол байж чадахгүй; хүн үзэгдлийг алдмагцаа Үхэгсдийн оронд унаж, харанхуйд амьдардаг. Үзэгдэлгүй хүмүүс бол Бурханыг мунхгаар дагагсад, Ариун Сүнсний ажилгүй хүмүүс бөгөөд тамд амьдарч байгаа. Ийм хүмүүс үнэнийг эрэлхийлдэггүй, харин оронд нь Бурханы нэрийг хаяг пайз адил өлгөдөг. Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй, Бурханы бүхий л удирдлага дахь ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс үзэгдлийг мэддэггүй тул үнэнгүй хүмүүс юм. Тэгвэл үнэнийг эзэмшээгүй хүмүүс бүгд мууг үйлдэгсэд биш гэж үү? Үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг, Бурханы талаарх мэдлэгийг эрж хайхыг хүсдэг, Бурхантай үнэхээр хамтран ажилладаг хүмүүс бол үзэгдлийг үндэс сууриа болгодог хүмүүс мөн. Тэд Бурхантай хамтран ажилладаг учраас Бурханы сайшаалыг хүртдэг бөгөөд хүний хэрэгжүүлэх ёстой зүйл бол энэхүү хамтын ажиллагаа юм.

Үзэгдэлд хэрэгжүүлэлтийн олон зам агуулагддаг. Хүнд тавьсан бодитой шаардлагууд нь ч бас үзэгдэл дотор агуулагддаг, хүний мэдэх ёстой Бурханы ажил ч бас агуулагддаг. Өнгөрсөн үед янз бүрийн газарт зохион байгуулагдаж байсан онцгой цуглаан юм уу томоохон цуглааны үеэр хэрэгжүүлэлтийн замын зөвхөн нэг талын тухай л ярьдаг байсан. Ийм хэрэгжүүлэлт нь Нигүүлслийн эрин үед хэрэгжүүлэх ёстой зүйл байсан бөгөөд Бурханы талаарх мэдлэгтэй бараг холбоогүй байсан, учир нь Нигүүлслийн эрин үеийн үзэгдэл нь зөвхөн Есүсийн цовдлолын үзэгдэл байсан ба өөр илүү агуу үзэгдэл байгаагүй. Хүн цовдлолоор дамжуулан хүн төрөлхтнийг золин аварсан Түүний ажлаас илүүг мэдэх учиргүй байсан тул Нигүүлслийн эрин үед хүний мэдвэл зохих өөр үзэгдэл байгаагүй юм. Ийм маягаар хүн Бурханы талаар хомсхон мэдлэгтэй байсан бөгөөд Есүсийн хайр, энэрлийн тухай мэдлэгээс гадна түүний хэрэгжүүлэх хэдхэн энгийн, өчүүхэн зүйлс буюу өнөөдрийнхөөс асар хол зөрүүтэй зүйл байдаг байв. Өнгөрсөн үед цугларалт нь ямар ч хэлбэртэй байсан бай, хүн Бурханы ажлын талаарх бодитой мэдлэгийг ярих чадваргүй байсан, тэр ч байтугай хүний орох хамгийн тохиромжтой хэрэгжүүлэлтийн зам аль болохыг хэн ч тодорхой хэлж чадаагүй. Хүн хүлээцтэй, тэвчээртэй байдлын сууринд хэдхэн энгийн зүйл нэмсэн төдий; түүний хэрэгжүүлэлтийн мөн чанарт ердөө ямар ч өөрчлөлт

байгаагүй, учир нь нэг эрин үе дотор Бурхан ямар ч шинэлэг ажил хийгээгүй, хүнд тавьсан цорын ганц шаардлага нь тэвчээртэй, хүлээцтэй байдал, эсвэл загалмай үүрэх явдал байсан юм. Ийм хэрэгжүүлэлтээс гадна, Есүсийн цовдлолоос өөр илүү өндөр үзэгдэл байгаагүй. Урьд нь Бурхан асар их ажил хийгээгүй учраас, хүнд зөвхөн хязгаарлагдмал шаардлага тавьсан учраас өөр үзэгдлүүдийн тухай огт дурдаагүй. Ийм маягаар хүн юу ч хийсэн бай, хүний хэрэгжүүлэх цөөн хэдэн энгийн, өнгөц зүйлс бүхий эдгээр хязгаарыг давж чадаагүй. Өнөөдөр, илүү их ажил хийгдсэн, Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийнхээс хэд дахин их ажил хийгдсэн учраас Би өөр үзэгдлүүдийн тухай ярьдаг. Хүнд тавих шаардлага ч бас өмнөх эрин үеүдийнхээс хэд дахин өндөр болсон. Хэрвээ хүн энэ ажлыг бүхэлд нь мэдэж чадахгүй бол энэ ажил асар их ач холбогдолтой байхгүй; хэрвээ хүн үүнд насан туршийн хичээл чармайлтаа зориулахгүй бол энэ ажлыг бүрэн мэдэхэд хэцүү байх болно гэж хэлж болох юм. Байлдан дагуулалтын ажилд дан ганц хэрэгжүүлэлтийн замын талаар яривал хүнийг байлдан дагуулах боломжгүй. Хүнд ямар ч шаардлага тавихгүйгээр зөвхөн үзэгдлийн талаар яривал хүнийг байлдан дагуулах бас л боломжгүй. Хэрэгжүүлэлтийн замаас өөр зүйл ярихгүй байх аваас хүний амин газрыг цохиж, хүний үзлийг сарниах боломжгүй байх тул хүнийг бүрэн байлдан дагуулах ч бас боломжгүй байх болно. Үзэгдэл бол хүнийг байлдан дагуулах гол хэрэгсэл юм, гэхдээ үзэгдлээс гадна ямар ч хэрэгжүүлэлтийн зам байгаагүй бол хүн дагах аргагүй, тэр ч бүү хэл орох арга барилгүй байх байсан. Энэ нь эхнээсээ эцэс хүртлээ Бурханы ажлын зарчим байсаар ирсэн: Үзэгдэлд хэрэгжүүлж болох зүйл байдаг бөгөөд ийм хэрэгжүүлэлт дээр нэмээд үзэгдэл ч бас байдаг. Хүний амь болон зан чанарын аль алинд нь гардаг өөрчлөлтийн түвшин нь үзэгдэл дэх өөрчлөлтийг дагалддаг. Хүн зөвхөн өөрийн хүчин чармайлтад найдсан бол ямар нэгэн өндөр түвшний өөрчлөлтөд хүрэх боломжгүй байх байсан. Үзэгдэл нь Бурханы Өөрийн ажил болон Бурханы удирдлагын тухай өгүүлдэг. Хэрэгжүүлэлт гэдэг нь хүний хэрэгжүүлэлтийн зам болон хүний оршин тогтнолын замыг хэлдэг; Бурханы бүх удирдлагад, үзэгдэл болон хэрэгжүүлэлтийн хоорондох харилцаа нь Бурхан, хүн хоёрын хоорондох харилцаа юм. Хэрвээ үзэгдлүүдийг хасах юм уу хэрэгжүүлэлтийг дурдахгүйгээр тэдгээрийн талаар яривал, эсвэл зөвхөн үзэгдэл л байгаад хүний хэрэгжүүлэлтийг арилгасан бол тийм зүйлийг Бурханы удирдлага гэж үзэж болохгүй, Бурханы ажил хүн төрөлхтний төлөө байдаг гэж хэлж бүр ч болохгүй; ийм маягаар хүний үүрэг үгүй болоод зогсохгүй Бурханы ажлын зорилго үгүйсгэгдэх болно. Хэрвээ эхнээсээ эцэс хүртлээ хүн Бурханы

ямар нэгэн ажлын оролцоогүйгээр зөвхөн хэрэгжүүлэх шаардлагатай байсан бол, түүнчлэн хүнд Бурханы ажлыг мэдэх шаардлага байгаагүй бол ийм ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэж бүр ч болохгүй. Хэрвээ хүн Бурханыг мэдээгүй, Бурханы хүслийг мэдээгүй бөгөөд өөрийн хэрэгжүүлэлтийг тодорхойгүй, хийсвэр байдлаар, сохроор хэрэгжүүлдэг байсан бол хэзээ ч бүрэн шаардлага хангасан бүтээл болохгүй байх байлаа. Иймээс энэ хоёр зүйл хоёулаа зайлшгүй чухал юм. Хэрвээ зөвхөн Бурханы ажил байсан бол, өөрөөр хэлбэл, хүний хамтын ажиллагаа юм уу хэрэгжүүлэлт байхгүй зөвхөн үзэгдэл байсан бол ийм зүйлийг Бурханы удирдлага гэж нэрлэж болохгүй. Хэрвээ зөвхөн хүний хэрэгжүүлэлт болон оролт л байсан бол хүний орсон зам хэр өндөр байх нь хамаагүй, энэ ч бас зөвшөөрөхийн аргагүй юм. Хүний оролт ажил болон үзэгдэлтэй зэрэгцэн аажмаар өөрчлөгдөх ёстой; үүнийг дур зоргоороо өөрчилж болохгүй. Хүний хэрэгжүүлэлтийн зарчим чөлөөтэй, задгай биш, харин ч тодорхой хил хязгаар дотор байдаг. Ийм зарчим нь ажлын үзэгдэлтэй зэрэгцэн өөрчлөгддөг. Тиймээс Бурханы удирдлага нь эцэстээ Бурханы ажил болон хүний хэрэгжүүлэлтээс хамаардаг.

Удирдлагын ажил нь хүн төрөлхтнөөс л болж бий болсон, энэ нь хүн төрөлхтний оршин тогтнолоос л болж бий болсон гэсэн үг юм. Хүн төрөлхтнөөс өмнө буюу анх тэнгэр, газар болон бүх зүйл бүтээгдэх үед ямар ч удирдлага байгаагүй. Хэрвээ Бурханы бүх ажилд хүнд ашиг тустай хэрэгжүүлэлт байгаагүй, өөрөөр хэлбэл, хэрвээ Бурхан завхарсан хүн төрөлхтөнд тохирсон шаардлага тавиагүй бол (хэрвээ Бурханы хийсэн ажилд хүний хэрэгжүүлэлтэд тохирох ямар ч зам байгаагүй бол) энэ ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэж болохгүй байх байв. Хэрвээ Бурханы бүхий л ажил хэрхэн хэрэгжүүлэх талаар завхарсан хүн төрөлхтөнд л яриад, Бурхан Өөрийн ямар ч үйл хэргийг явуулаагүй, бүхнийг чадагч чадвар болоод мэргэн ухааныхаа өчүүхэн хэсгийг ч үзүүлээгүй бол Бурханы хүнд тавих шаардлага хэр өндөр байх нь хамаагүй, Бурхан хүмүүсийн дунд хэр удаан амьдарсан нь хамаагүй, хүн Бурханы зан чанарын юуг ч мэдэхгүй байх байсан; хэрвээ тийм байсан бол энэ төрлийн ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэхэд бүр ч зохихгүй. Энгийнээр хэлбэл, Бурханы удирдлагын ажил бол Бурханы хийдэг ажил бөгөөд Бурханаар авхуулсан хүмүүсийн Бурханы удирдамж дор хийдэг бүх ажил юм. Ийм ажлыг удирдлага гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дундах Бурханы ажил, мөн Түүнийг дагадаг бүх хүмүүсийн хамтын ажиллагааг нийтэд нь удирдлага гэж нэрлэдэг. Энд, Бурханы ажлыг үзэгдэл, харин хүний хамтын ажиллагааг

хэрэгжүүлэлт гэж нэрлэдэг. Бурханы ажил өндөр байх тусам (өөрөөр хэлбэл, үзэгдэл өндөр байх тусам) Бурханы зан чанар хүнд улам ил болдог бөгөөд хүний үзэлтэй нийцэхгүй байх тусам хүний хэрэгжүүлэлт болон хамтын ажиллагаа төдий чинээ өндөр байдаг. Хүнд тавих шаардлага өндөр байх тусам Бурханы ажил хүний үзэлтэй төдий чинээ зөрөлддөг, үүнээс улбаалан хүний шалгалт, хүнээс шаарддаг стандарт ч бас өндөр болдог. Энэ ажлын эцэст бүх үзэгдэл бүрэн төгс болж, хүний хэрэгжүүлэх шаардлагатай зүйлс төгс төгөлдрийн оргилд хүрсэн байх болно. Энэ нь бас бүгд төрлийнхөө дагуу ангилагдах үе байх болно, учир нь хүний мэдэх шаардлагатай зүйлсийг хүнд харуулсан байх болно. Иймээс үзэгдэл оргилдоо хүрч, ажил ч дуусах тийшээ хандах үед хүний хэрэгжүүлэлт ч бас дээд цэгтээ хүрсэн байх болно. Хүний хэрэгжүүлэлт Бурханы ажилд үндэслэдэг, харин Бурханы удирдлага нь хүний хэрэгжүүлэлт болон хамтын ажиллагааны ачаар л бүрэн илэрхийлэгддэг. Хүн бол Бурханы ажлын үзмэр, Бурханы бүх удирдлагын ажлын бай, бас Бурханы бүхий л удирдлагын үр дүн юм. Хэрвээ Бурхан хүний хамтын ажиллагаагүйгээр ганцаараа ажилласан бол Түүний бүх ажлын биелэлт болох зүйл юу ч байхгүй байх байсан ба ийм маягаар Бурханы удирдлага өчүүхэн төдий ч ач холбогдолгүй байх байлаа. Бурханы ажлаас гадна, Өөрийнх нь ажлыг илэрхийлж, бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг нь нотлоход тохирох байг Бурхан сонгосноор л удирдлагынхаа зорилгыг биелүүлж, энэ бүх ажлыг ашиглан Сатаныг бүрэн ялах зорилгодоо хүрч чадна. Тиймээс хүн бол Бурханы удирдлагын ажлын салшгүй чухал хэсэг бөгөөд гагцхүү хүн л Бурханы удирдлагыг үр өгөөжтэй болгож, эцсийн зорилгыг нь биелүүлж чадна; хүнээс өөр ямар ч амьд зүйл ийм үүрэг гүйцэтгэж чадахгүй. Хэрвээ хүн удирдлагын ажлын жинхэнэ биелэлт болно гэвэл завхарсан хүн төрөлхтний дуулгаваргүй байдлыг бүрэн арилгах ёстой. Хүнд өөр өөр цаг үед тохирох хэрэгжүүлэлт өгөгдөж, Бурхан хүмүүсийн дунд харгалзах ажлыг гүйцэтгэхийг энэ нь шаарддаг. Зөвхөн ийм маягаар л удирдлагын ажлын биелэлт болох бүлэг хүмүүсийг эцэстээ олж авна. Хүмүүсийн дундах Бурханы ажил дан ганц Бурханы ажлаар дамжуулан Бурханд Өөрт нь гэрчлэл хийж чадахгүй; Түүний ажилд тохирох амьд хүмүүс ийм гэрчлэлд бас шаардлагатай. Бурхан эхлээд энэ хүмүүс дээр ажиллаж, тэднээр дамжуулан Түүний ажил илэрхийлэгдэж, улмаар бүтээгдсэн зүйлсийн дунд Түүний ийм гэрчлэл хийгдэх болно. Ингээд Бурхан ажлынхаа зорилгод хүрсэн байх болно. Бурхан бүх бүтээгдсэн зүйлийн дунд Өөрийгөө шууд гэрчилж чадахгүй учраас Сатаныг ялахын тулд ганцаараа ажилладаггүй.

Хэрэв Тэр ганцаараа ажилладаг байсан бол хүнийг бүрэн үнэмшүүлэх боломжгүй байх тул хүнийг байлдан дагуулахын тулд Бурхан түүн дээр ажиллах ёстой бөгөөд тэгж байж л бүх бүтээгдсэн зүйлийн дундах гэрчлэлийг олж авч чадна. Хэрвээ Бурхан ганцаараа ажиллаж, хүний хамтын ажиллагаа гэж байхгүй, эсвэл хүн хамтран ажиллах шаардлагагүй байсан бол хүн Бурханы зан чанарыг хэзээ ч мэдэж чадахгүй, Бурханы хүслийг үүрд мэдэхгүй байх байсан; тэгвэл Бурханы ажлыг Бурханы удирдлагын ажил гэж нэрлэж болохгүй байх байсан юм. Хүн Бурханы ажлыг ойлголгүйгээр, өөрөө л чармайж, эрж хайж, шаргуу ажиллах байсан бол дүрсгүйтэж томоогүйтэх байв. Ариун Сүнсний ажилгүйгээр, хүний хийдэг зүйл Сатаных бөгөөд тэрээр тэрслүү, мууг үйлдэгч юм; Сатан завхарсан хүн төрөлхтний хийдэг бүхнээс харагддаг ба Бурханд нийцэлтэй юу ч байдаггүй, хүний хийдэг бүхэн Сатаны илрэл юм. Яригдсан бүхэнд үзэгдэл болон хэрэгжүүлэлтгүй юм гэж юу ч байхгүй. Үзэгдлийн суурин дээр хүн хэрэгжүүлэлт болон дуулгавартай байдлын замыг олж авдаг, ингэснээр үзлээ хойш тавьж, өмнө нь эзэмшээгүй зүйлсээ олж авч болох юм. Бурхан хүнээс Өөртэй нь хамтран ажиллахыг, Өөрийнх нь шаардлагад бүрэн захирагдахыг шаарддаг бөгөөд Бурханы Өөрийн хийсэн ажлыг харж, Бурханы төгс хүчийг мэдэрч, Бурханы зан чанарыг мэдэхийг хүн шаарддаг. Эдгээр нь товчхондоо Бурханы удирдлага юм. Бурханы хүнтэй нэгдэх нэгдэл нь удирдлага бөгөөд энэ нь хамгийн агуу удирдлага билээ.

Үзэгдлийг агуулдаг зүйл нь үндсэндээ Бурханы Өөрийн ажлыг хэлдэг бөгөөд хэрэгжүүлэлттэй холбоотой зүйл нь хүний хийх ёстой зүйлийг агуулдаг, Бурхантай ямар ч хамаагүй байдаг. Бурханы ажлыг Бурхан Өөрөө гүйцэтгэдэг, хүний хэрэгжүүлэлтийг хүн өөрөө биелүүлдэг. Бурханы Өөрийн хийх ёстой ажлыг хүн хийх хэрэггүй, хүний хэрэгжүүлэх ёстой зүйл Бурханд хамаагүй. Бурханы ажил бол Түүний Өөрийн үйлчлэл бөгөөд хүнтэй ямар ч холбоогүй. Энэ ажлыг хүн хийх хэрэггүй, цаашлаад Бурханы хийдэг ажлыг хүн хийх чадваргүй. Хүний хэрэгжүүлэх шаардлагатай зүйлийг хүн хийх ёстой бөгөөд амиа золиослох ч бай, гэрчлэлд зогсоохын тулд өөрийг нь Сатанд өгсөн ч бай— эдгээрийг бүгдийг нь хүн гүйцэлдүүлэх ёстой. Өөрийнхөө хийх учиртай бүх ажлыг Бурхан Өөрөө хийдэг, харин хүний хийх ёстой ажлыг хүнд харуулж, үлдсэн ажлыг нь хүнээр хийлгэхээр үлдээдэг. Бурхан нэмэлт ажил хийдэггүй. Тэр зөвхөн Өөрийн үйлчлэл дэх ажлыг л хийж, хүнд замыг үзүүлж, замыг нээх ажил л хийдэг ба замыг засах ажил хийдэггүй; үүнийг бүх хүн ойлгох ёстой. Үнэнийг хэрэгжүүлэх гэдэг нь Бурханы үгийг хэрэгжүүлэх гэсэн үг, энэ бүхэн нь

хүний үүрэг, хүний хийх ёстой зүйл бөгөөд Бурхантай ямар ч хамаагүй. Хэрэв хүн Бурханаас, хүнтэй адилаар үнэн дотор цэвэршүүлэлт, тарчлаан амсахыг шаардвал хүн дуулгаваргүй байгаа хэрэг. Бурханы ажил бол Өөрийн үйлчлэлийг гүйцэлдүүлэх, харин хүний үүрэг бол Бурханы бүх удирдамжийг ямар ч эсэргүүцэлгүйгээр дуулгавартай дагах явдал юм. Бурханы ажиллаж, амьдардаг байдлаас үл хамааран хүн биелүүлэх ёстой зүйлдээ хүрэх л ёстой. Бурхан Өөрөө л хүнд шаардлага тавьж чадна, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө л хүнд шаардлага тавихад тохирдог. Хүнд ямар ч сонголт байх ёсгүй бөгөөд бүрэн захирагдаж, хэрэгжүүлэхээс өөрийг хийх ёсгүй; энэ бол хүний эзэмших ёстой эрүүл ухаан юм. Бурханы Өөрийн хийх ёстой ажил дуусмагц хүн алхам алхмаар үүнийг туулах шаардлагатай. Эцэст нь Бурханы бүх удирдлага дууссан байх үед хүн Бурханы шаарддаг зүйлийг мөн л хийгээгүй байвал шийтгүүлэх ёстой. Хэрэв хүн Бурханы шаардлагыг биелүүлдэггүй бол энэ нь хүний дуулгаваргүй байдлаас болж байгаа юм; энэ нь Бурхан ажлаа хангалттай сайн хийгээгүй гэсэн үг. Бурханы үгийг хэрэгжүүлж, Бурханы шаардлагыг биелүүлж, үнэнч байж, үүргээ биелүүлж чаддаггүй бүх хүн шийтгүүлнэ. Өнөөдөр та нараас шаардаг зүйлс нэмэлт шаардлага биш, харин хүний үүрэг, бүх хүний биелүүлэх ёстой үүрэг юм. Хэрэв та нар үүргээ ч гүйцэтгэж чадахгүй, үүргээ сайн гүйцэтгэж чадахгүй бол өөрсдөдөө төвөг удаж байгаа бус уу? Та нар үхлийг өөртөө татаж байгаа бус уу? Та нар яаж ирээдүй, хэтийн зүйлсийг хүлээж чадаж байна вэ? Бурханы ажил хүн төрөлхтний төлөө хийгддэг, харин хүний хамтын ажиллагаа Бурханы удирдлагын төлөө байдаг. Бурхан хийх ёстой бүхнээ хийсний дараа хүн биеэ дайчлан хэрэгжүүлж, Бурхантай хамтран ажиллах шаардлагатай. Бурханы ажилд хүн хичээл зүтгэлээ гамналгүй, үнэнч зангаа зориулах ёстой, мөн тоо томшгүй олон үзэлд баригдаж, эсвэл идэвхгүйгээр үхлээ хүлээн суух ёсгүй. Бурхан Өөрийгөө хүний төлөө золиосолж чадна, тэгвэл хүн яагаад Бурханд үнэнч байдлаа өргөж болохгүй гэж? Бурхан хүнд хоёргүй сэтгэлээр ханддаг атал хүн яагаад өчүүхэн ч болов хамтран ажиллаж болохгүй гэж? Бурхан хүн төрөлхтний төлөө ажилладаг атал хүн яагаад Бурханы удирдлагын төлөө зарим нэг үүргээ биелүүлж болохгүй гэж? Бурханы ажил энэ хүртэл ирчихээд байхад та нар юу ч хийхгүй харсаар, сонссон ч хөдлөхгүй суусаар. Ийм хүмүүс мөхлийн бай биш гэж үү? Бурхан аль хэдийн Өөрийн бүх зүйлийг хүнд зориулсан, гэтэл яагаад хүн өнөөдөр өөрийн үүргийг үнэн сэтгэлээсээ гүйцэтгэж чадахгүй байна вэ? Бурханы хувьд, Түүний ажил эн тэргүүний зүйл бөгөөд Түүний удирдлагын ажил хамгийн чухал нь билээ. Хүний хувьд, Бурханы үгийг

хэрэгжүүлж, Бурханы шаардлагыг биелүүлэх нь эн тэргүүний зүйл. Үүнийг та нар бүгд ойлгох учиртай. Та нарт хэлсэн үг мөн чанарын чинь угт хүрч, Бурханы ажил урьд өмнө байгаагүй хүрээнд орсон. Олон хүн энэ замын үнэн, худлыг мөн л ойлгодоггүй; тэд хүлээсээр, харсаар, өөрсдийн үүргийг үл биелүүлдэг. Үүний оронд тэд Бурханы үг, үйлдэл бүрийг шалгаж, юу идэж, юу өмсдөгт нь анхаарал хандуулдаг ба тэдний үзэл улам бүр ноцтой болдог. Ийм хүмүүс дэмий санаа зовж байгаа хэрэг биш гэж үү? Ийм хүмүүс яаж Бурханыг эрж хайдаг хүмүүс байж чадах юм бэ? Тэд яаж Бурханд захирагддаг санаа зорилготой хүмүүс болж чадах билээ? Тэд өөрсдийн үнэнч байдал болоод үүргийг умартаж, оронд нь Бурхан хаа байгаад хамаг анхаарлаа хандуулдаг. Тэд үнэхээр зэвүү хүргэм! Хэрэв хүн ойлгох учиртай бүхнээ ойлгож, хэрэгжүүлэх учиртай бүхнээ хэрэгжүүлсэн бол Бурхан Өөрийн ерөөлийг хүнд гарцаагүй хайрлана, учир нь хүнээс Түүний шаарддаг зүйл бол хүний үүрэг бөгөөд хүний хийх ёстой зүйл билээ. Хэрэв хүн ойлгох учиртай зүйлээ ойлгож, хэрэгжүүлэх учиртай зүйлээ хэрэгжүүлж чадахгүй бол шийтгүүлнэ. Ийм хүмүүс илт эсэргүүцэх зүйл хийдэггүй байлаа ч гэсэн, Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс Бурханд дайсагнадаг бөгөөд шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс үүнийг эсэргүүцэж байдаг. Бурханы шаардсан үнэнийг хэрэгжүүлдэггүй бүх хүн нь Ариун Сүнсний ажилд онцгой анхаарал хандуулдаг байсан ч гэсэн Бурханы үгийг дуулгавартай дагадаггүй, санаатайгаар эсэргүүцдэг хүмүүс юм. Бурханы үгийг дуулгавартай дагадаггүй, Бурханд захирагддаггүй хүмүүс бол тэрслүү агаад Бурханыг эсэргүүцдэг. Үүргээ биелүүлдэггүй хүмүүс бол Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс бөгөөд Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс бол Ариун Сүнсний ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс билээ.

Бурханы ажил болоод Түүний удирдлага тодорхой цэгт хүрэх үед Түүний зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүс бүгд Түүний шаардлагыг биелүүлэх чадвартай байдаг. Бурхан Өөрийн стандартын дагуу, хүний хүрч чадах зүйлийн дагуу хүнд шаардлага тавьдаг. Өөрийн удирдлагын талаар ярихын сацуу Тэр бас хүний замыг зааж, амьд үлдэх замаар хүнийг хангадаг. Бурханы удирдлага болон хүний хэрэгжүүлэлт нь хоёулаа ажлын нэг үе шат бөгөөд нэгэн зэрэг явагддаг. Бурханы удирдлагын тухай яриа нь хүний зан чанарын өөрчлөлттэй холбоотой байдаг бол хүний хийх ёстой зүйл болоод хүний зан чанарын өөрчлөлтийн талаарх яриа Бурханы ажилтай хамаатай байдаг; энэ хоёрыг ямар ч үед салгахын аргагүй. Хүний хэрэгжүүлэлт алхам алхмаар өөрчлөгдөж байгаа. Учир нь Бурханы хүнд тавих шаардлага үргэлж өөрчлөгдөж, Бурханы ажил ч

бас үргэлж өөрчлөгдөн, ахин дэвшиж байгаа. Хэрэв хүний хэрэгжүүлэлт хоосон сургаалд баригдсан хэвээр байвал хүнд Бурханы ажил болон удирдамж байхгүйг энэ нь нотолдог; хэрэв хүний хэрэгжүүлэлт хэзээ ч өөрчлөгдөж, гүнзгийрч байгаагүй бол энэ нь, хүний хэрэгжүүлэлт хүний хүслийн дагуу явагдсаны баталгаа бөгөөд үнэний хэрэгжүүлэлт биш юм; хэрэв хүн алхах замгүй бол тэр аль хэдийн Сатаны гарт унаж, Сатаны хяналтад орж, муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн гэсэн үг билээ. Хэрвээ хүний хэрэгжүүлэлт гүнзгийрэхгүй бол Бурханы ажил хөгжихгүй бөгөөд Бурханы ажилд ямар ч өөрчлөлт байхгүй бол хүний оролт зогсоно; энэ нь зайлшгүй. Бурханы бүх ажлын хугацаанд хэрвээ хүн үргэлж Еховагийн хуулийг мөрддөг байсан бол Бурханы ажил урагшлахгүй, бүхий л эрин үеийг төгсгөл болгох бүр ч боломжгүй байх байв. Хэрэв хүн үргэлж загалмайтай зууралдаж, тэвчээр, даруу байдлыг хэрэгжүүлсэн бол Бурханы ажил үргэлжлэн урагшлах боломжгүй байх байлаа. Зөвхөн хуулийг сахиж, загалмайтай зууралдан, тэвчээр, даруу байдлыг хэрэгжүүлдэг хүмүүсийн дунд зургаан мянган жилийн удирдлагыг дуусгавар болгох ердөө боломжгүй. Харин Бурханыг мэддэг, Сатаны савраас мултарч, Сатаны нөлөөллөөс бүрэн ангижирсан эцсийн өдрүүдийн хүмүүсийн дунд Бурханы удирдлагын бүх ажил дуусна. Энэ бол Бурханы ажлын зайлшгүй чиглэл юм. Яагаад шашны чуулган дахь хүмүүсийн хэрэгжүүлэлтийг хоцрогдсон гэж хэлдэг вэ? Учир нь тэдний хэрэгжүүлдэг зүйл өнөөдрийн ажлаас тусдаа байдаг. Нигүүлслийн эрин үед тэдний хэрэгжүүлж байсан зүйл зөв байсан боловч эрин үе өнгөрч, Бурханы ажил өөрчлөгдөхийн хэрээр хэрэгжүүлэлт нь аажмаар хоцрогдсон билээ. Энэ нь шинэ ажил болон шинэ гэрлийн ард үлдсэн. Ариун Сүнсний ажил анхдагч сууриндаа үндэслэн хэд хэдэн алхмаар гүнзгийрсэн. Гэсэн ч тэр хүмүүс Бурханы ажлын анхны үе шатанд гацаж, хуучин хэрэгжүүлэлт, хуучин гэрэлтэй зууралдсаар байдаг. Бурханы ажил гурав юм уу таван жилийн дотор ихээхэн өөрчлөгдөж чадна, тэгвэл 2,000 жилийн хугацаанд бүр ч их өөрчлөгдөхгүй гэж үү? Хэрвээ хүнд шинэ гэрэл юм уу хэрэгжүүлэлт байхгүй бол Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлээгүй байна гэсэн үг. Энэ бол хүний алдаа; урьд нь Ариун Сүнсний ажилтай байсан хүмүүс өнөөдөр хоцрогдсон хэрэгжүүлэлтийг мөрдсөөр байдгаас болж Бурханы шинэ ажлын оршин тогтнолыг үгүйсгэж болохгүй. Ариун Сүнсний ажил үргэлж урагшилж байдаг ба Ариун Сүнсний урсгалд байгаа бүх хүн ч бас алхам алхмаар гүнзгийрч, өөрчлөгдөж байх ёстой. Тэд ганцхан үе шатанд зогсох ёсгүй. Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс л анхны ажлынх нь дунд үлддэг ба Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн

зөвшөөрдөггүй. Дуулгаваргүй хүмүүс л Ариун Сүнсний ажлыг олж авах чадваргүй байх болно. Хэрвээ хүний хэрэгжүүлэлт Ариун Сүнсний шинэ ажилтай хөл нийлүүлдэггүй бол өнөөдрийн ажлаас гарцаагүй салсан байх бөгөөд өнөөдрийн ажилтай нийцэхгүй нь гарцаагүй. Ийм хоцрогдсон хүмүүс Бурханы хүслийг биелүүлж ердөө чадахгүй, эцэстээ Бурханы гэрчлэлд зогсох хүмүүс болж бүр ч чадахгүй. Түүнчлэн бүхий л удирдлагын ажил ийм бүлэг хүмүүсийн дунд дуусгавар болж чадахгүй. Нэгэнтээ Еховагийн хуулийг мөрддөг байсан хүмүүс, нэг үе загалмайн төлөө зовсон хүмүүсийн хувьд гэвэл, эцсийн өдрүүдийн ажлын үе шатыг хүлээн зөвшөөрч чадахгүй бол хийсэн бүхэн нь хий дэмий, хэрэггүй болно. Ариун Сүнсний ажлын хамгийн тодорхой илэрхийлэл нь амьдралтай ойрхон бөгөөд өнгөрсөнтэй зууралддаггүй. Өнөөдрийн ажилтай хөл нийлүүлээгүй, өнөөдрийн хэрэгжүүлэлтээс салсан хүмүүс бол Ариун Сүнсний ажлыг хүлээн зөвшөөрөлгүй, эсэргүүцдэг хүмүүс юм. Ийм хүмүүс Бурханы өнөөгийн ажлыг эсэргүүцдэг. Хэдий тэд өнгөрсөн үеийн гэрэлтэй зууралддаг ч Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс гэдгийг нь үгүйсгэж болохгүй. Хүний хэрэгжүүлэлт дэх өөрчлөлт, өнгөрсөн болоод өнөөдрийн хэрэгжүүлэлтийн хоорондох ялгаа, өмнөх эрин үед хэрхэн хэрэгжүүлж байсан, өнөөдөр үүнийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар яагаад эхнээс нь дуустал ингэж их яриад байна вэ? Ариун Сүнсний ажил байнга урагшилдгаас болж хүний хэрэгжүүлэлт дэх ийм хуваагдлыг үргэлж ярьдаг, тиймээс хүний хэрэгжүүлэлт ч бас байнга өөрчлөгдөх шаардлагатай. Хэрэв хүн нэг үе шатанд гацсан хэвээр үлдвэл Бурханы шинэ ажил болон шинэ гэрэлтэй хөл нийлүүлэх чадваргүйг энэ нь нотолдог; энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөө өөрчлөгдөөгүй гэдгийг нотолдоггүй. Ариун Сүнсний урсгалын гадна байгаа хүмүүс үргэлж өөрсдийнх нь зөв гэж боддог боловч үнэндээ тэдэн дээрх Бурханы ажил аль хэдийн зогссон ба Ариун Сүнсний ажил тэдэнд байдаггүй. Шинэ ажлаа гүйцэлдүүлэхээр Бурханы зорьдог өөр бүлэг хүмүүс буюу өөр бүлэг хүмүүс рүү Бурханы ажил аль хэдийн шилжсэн. Шашны хүмүүс Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй, өнгөрсөн үеийн хуучин ажилтай л зууралддаг учраас Бурхан тэр хүмүүсийг орхисон бөгөөд шинэ ажлыг нь хүлээн зөвшөөрдөг хүмүүс дээр энэхүү шинэ ажлаа хийдэг. Тэд бол Бурханы шинэ ажилд хамтран ажилладаг хүмүүс бөгөөд ийм маягаар л Түүний удирдлага гүйцэлдэж чадна. Бурханы удирдлага үргэлж урагшилж, хүний хэрэгжүүлэлт үргэлж илүү өндөрт өсөн дээшилж байдаг. Бурхан үргэлж ажиллаж байгаа ба хүнд үргэлж хэрэгцээ байдаг, тэгснээр хоёулаа оргилдоо хүрч, Бурхан хүн хоёр бүрэн нэгддэг. Энэ

бол Бурханы ажлын биелэлтийн илэрхийлэл, Бурханы бүхий л удирдлагын эцсийн үр дүн юм.

Бурханы ажлын үе шат бүрд хүнд тавигддаг харгалзах шаардлагууд бас бий. Ариун Сүнсний урсгал доторх бүх хүн Ариун Сүнстэй хамт, Ариун Сүнсний сахилгажуулалттай байдаг, харин Ариун Сүнсний урсгалын гаднах хүмүүс Сатаны захиргаан дор, Ариун Сүнсний ямар ч ажилгүй байдаг. Ариун Сүнсний урсгалд байгаа хүмүүс бол Бурханы шинэ ажлыг хүлээн авч, Бурханы шинэ ажилд хамтран ажилладаг хүмүүс юм. Хэрвээ энэ урсгал доторх хүмүүс хамтран ажиллах чадваргүй, энэ хугацаанд Бурханы шаардсан үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй бол сахилгажуулагдан, цаанадаж Ариун Сүнсэнд хаягдах болно. Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөг хүмүүс Ариун Сүнсний урсгал дотор амьдарч, Ариун Сүнсний халамж, хамгаалалтыг хүртэнэ. Үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүсийг Ариун Сүнс гэгээрүүлдэг бөгөөд үнэнийг хэрэгжүүлэх хүсэлгүй хүмүүсийг Ариун Сүнс сахилгажуулж, бүр шийтгэж ч болох юм. Ямар төрлийн хүн байхаас үл хамааран Ариун Сүнсний урсгалд л байгаа цагт, Өөрийнх нь нэрийн төлөө шинэ ажлыг нь хүлээн зөвшөөрдөг бүх хүний хувьд Бурхан хариуцлага үүрэх болно. Түүний нэрийг алдаршуулдаг, үгийг нь хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүс Түүний ерөөлийг хүртэнэ; Түүнд дуулгаваргүй байж, Түүний үгийг хэрэгжүүлдэггүй хүмүүс Түүнээс шийтгэл хүртэнэ. Ариун Сүнсний урсгалд байгаа хүмүүс бол шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөг хүмүүс бөгөөд шинэ ажлыг хүлээн зөвшөөрсөн тул Бурхантай зохих ёсоор хамтран ажиллах ёстой, мөн үүргээ биелүүлдэггүй босогчид болж болохгүй. Энэ бол хүнд Бурханы тавьдаг цорын ганц шаардлага юм. Харин шинэ ажлыг хүлээн авдаггүй хүмүүсийн хувьд бол өөр: Тэд Ариун Сүнсний урсгалын гадна байдаг, Ариун Сүнсний сахилгажуулалт, зэмлэл тэдэнд хамаагүй байдаг. Энэ хүмүүс бүхий л өдөржингөө махан бие, оюун санаан дотроо амьдарч, уураг тархиных нь дүн шинжилгээ, судалгаанаас үүссэн хоосон сургаалын дагуу бүхнийг хийдэг. Энэ нь Ариун Сүнсний шинэ ажлын шаарддаг зүйл биш, Бурхантай хийх хамтын ажиллагаа бүр ч биш. Бурханы шинэ ажлыг хүлээн авдаггүй хүмүүсийн дэргэд Бурхан байдаггүй, түүнчлэн Бурханы ерөөл, хамгаалалт байдаггүй. Тэдний үг, үйлдлийн ихэнх нь Ариун Сүнсний ажлын урьдын шаардлагатай зууралддаг; тэдгээр нь хоосон сургаал болохоос үнэн биш юм. Энэ хүмүүсийн цугларалт нь шашин төдийхөн юм гэдгийг батлахад эдгээр хоосон сургаал, дүрэм журам хангалттай; тэд бол сонгогдсон хүмүүс ч биш, Бурханы ажлын бай ч биш. Тэд бүгдийн цугларалтыг шашны томоохон цуглаан гэж л нэрлэхээс биш чуулган

гэж нэрлэж болохгүй. Энэ бол өөрчлөгдөшгүй баримт юм. Тэдэнд Ариун Сүнсний шинэ ажил байдаггүй; тэдний хийдэг зүйл шашны үнэр ханхлуулж, амьдран харуулдаг зүйл нь шашнаар бялхдаг мэт санагддаг; тэд Ариун Сүнстэй хамт байдаггүй, ажлыг нь эзэмшдэггүй, тэр ч бүү хэл, Ариун Сүнсний сахилгажуулалт, эсвэл гэгээрлийг хүлээн авах эрхгүй. Энэ хүмүүс цөмөөрөө амьгүй цогцос, сүнслэг байдалгүй өтнүүд юм. Тэдэнд хүний тэрслүү байдал, эсэргүүцлийн талаар ямар ч мэдлэг байхгүй, хүний бүх муу үйлийн тухай ямар ч мэдлэг байдаггүй, үүгээр ч үл барам тэд Бурханы ажил, Бурханы одоогийн хүслийг бүгдийг нь мэддэггүй. Тэд бүгдээрээ мэдлэггүй, олиггүй хүмүүс, мөн итгэгчид гэж дуудахад ч зохихгүй өөдгүй амьтад! Тэдний хийдэг юу ч Бурханы удирдлагын ажилтай хамаагүй байдаг ба Бурханы төлөвлөгөөнд хохирол учруулж бүр ч чаддаггүй. Тэдний үг, үйлдэл хэтэрхий жигшүүртэй, хэтэрхий өрөвдөлтэй бөгөөд зүгээр л дурдахын ч хэрэггүй. Ариун Сүнсний урсгалд байдаггүй хүмүүсийн хийсэн зүйлс Ариун Сүнсний шинэ ажилтай ямар ч хамаагүй байдаг. Ийм учраас тэд юу ч хийлээ гэсэн тэдэнд Ариун Сүнсний сахилгажуулалт байдаггүй, түүнчлэн Ариун Сүнсний гэгээрэл байдаггүй. Учир нь тэд цөмөөрөө үнэнийг хайрладаггүй, Ариун Сүнсээр жигшигдэж, гологдсон хүмүүс юм. Тэд махан биеэр алхаж, Бурханы пайзын дор хүссэн бүхнээ үйлддэг учраас тэднийг мууг үйлдэгчид гэдэг. Бурханыг ажиллаж байх үед тэд Түүнд зориуд өсөрхөж, Түүний эсрэг зүгт явдаг. Хүн Бурхантай хамтран ажиллаж чаддаггүй нь өөрөө туйлын тэрслүү хэрэг бөгөөд Бурханыг санаатайгаар эсэргүүцдэг тэр хүмүүс тохирох залхаан цээрлүүлэлтээ хүртэхгүй гэж үү? Энэ хүмүүсийн муу үйлийг дурдангуут зарим хүн тэднийг хараахаар тэсэн яддаг, харин тэгэхэд Бурхан тэднийг үл ойшоодог. Хүний хувьд тэдний үйлдэл Бурханы нэртэй холбоотой харагддаг боловч үнэндээ Бурханы хувьд тэд Түүний нэр болон гэрчлэлтэй ямар ч холбоогүй байдаг. Энэ хүмүүс юу ч хийлээ гэсэн энэ нь Бурхантай хамаагүй: Энэ нь Түүний нэр болон Түүний өнөөдрийн ажлын аль алинтай ямар ч хамаагүй байдаг. Энэ хүмүүс өөрсдийгөө доромжилж, Сатаныг илтгэдэг; тэд бол уур хилэнгийн өдөрт зориулан муу үйлийг хурааж байгаа мууг үйлдэгчид юм. Уур хилэнгийн өдөр хараахан ирээгүй байгаа учраас өнөөдөр тэд юу ч хийлээ гэсэн, Бурханы удирдлагад саад болоогүй, Бурханы шинэ ажилтай ямар ч хамаагүй байгаа тохиолдолд тийм хүмүүс харгалзах залхаан цээрлүүлэлтэд өртөхгүй. Бурхан аль хэдийн харьцчихсан байх ёстой гэж хүмүүсийн итгэдэг зүйл их байдаг бөгөөд тэрхүү мууг үйлдэгчид аль болох хурдан залхаан цээрлүүлэлтэд өртөх ёстой гэж тэд

боддог. Гэхдээ Бурханы удирдлагын ажил хараахан төгсгөлдөө очоогүй, уур хилэнгийн өдөр арай ирээгүй байгаа учраас зөв шударга бус хүмүүс шударга бус үйлээ үргэлжлүүлэн хийсээр байна. Зарим хүн, “Шашны хүмүүс Ариун Сүнстэй хамт байдаггүй, тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй бөгөөд тэд Бурханы нэрийг шившиглэдэг; тэгвэл Бурхан тэдний цадиггүй зан авирыг хүлцэн тэвчихийн оронд яагаад тэднийг устгадаггүй юм бэ?” гэж хэлдэг. Сатаныг харуулж, махан биеийг илэрхийлдэг энэ хүмүүс бол мэдлэггүй, олиггүй хүмүүс юм; тэд бол гажууд хүмүүс билээ. Тэд Бурхан хүмүүсийн дунд хэрхэн ажилладгийг ойлгож авахаасаа өмнө Бурханы уур хилэн ирэхийг харахгүй бөгөөд бүрэн байлдан дагуулагдмагцаа тэр мууг үйлдэгчид бүгд залхаан цээрлүүлэлтээ хүртэж, нэг нь ч уур хилэнгийн өдрөөс зугтан зайлж чадахгүй. Одоо үе бол хүнийг шийтгэх цаг биш бөгөөд Бурханы удирдлагад хохирол учруулах хүмүүс байхгүй бол байлдан дагуулалтын ажлыг явуулах цаг юм, харин байгаа тохиолдолд тэд хийсэн үйлдлийнхээ ноцтой байдалд үндэслэн шийтгэл хүртэх болно. Хүн төрөлхтнийг удирдах Бурханы удирдлагын явцад Ариун Сүнсний урсгал дотор байгаа бүх хүн Бурхантай холбоотой байдаг. Ариун Сүнсний жигшин, голдог хүмүүс Сатаны нөлөөн дор амьдардаг ба хэрэгжүүлдэг зүйлс нь Бурхантай ямар ч холбоогүй байдаг. Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрч, Бурхантай хамтран ажилладаг хүмүүс л Бурхантай холбоотой байдаг, учир нь Бурханы ажил хүн хүлээн зөвшөөрдөг эсэхээс үл хамааран бүх хүнд чиглэдэг биш, харин үүнийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс рүү л чиглэдэг. Бурханы хийдэг ажилд үргэлж бай байдаг бөгөөд дур зоргоор хийгддэггүй. Сатантай холбоотой хүмүүс Бурханд гэрчлэл хийхэд тохирдоггүй, Бурхантай хамтран ажиллахад бүр ч тохирдоггүй.

Ариун Сүнсний ажлын үе шат бүр ч бас хүний гэрчлэлийг шаарддаг. Ажлын үе шат бүр Бурхан, Сатан хоёрын хоорондох тулаан бөгөөд тулааны бай нь Сатан байдаг байхад энэхүү ажлаар төгс болгуулах нэгэн нь хүн юм. Бурханы ажил үр өгөөжөө өгөх эсэх нь Бурханыг гэрчлэх хүний гэрчлэлийн байдлаас хамаардаг. Энэ гэрчлэл нь Өөрийг нь дагадаг хүмүүсээс Бурханы шаарддаг зүйл юм; энэ нь Сатаны өмнө хийгддэг гэрчлэл, мөн Түүний ажлын үр дүнгийн нотолгоо билээ. Бурханы удирдлага нь бүхэлдээ гурван үе шатанд хуваагддаг бөгөөд үе шат бүрд хүнд тохирох шаардлага тавигддаг. Түүнчлэн эрин үе өнгөрч, урагшлахын хэрээр бүх хүн төрөлхтөнд тавих Бурханы шаардлага улам өндөр болдог. Тиймээс хүн “Үг нь махбодоор илэрсэн” баримтыг харах хүртэл Бурханы удирдлагын энэ ажил алхам алхмаар оргилдоо хүрч, ийм маягаар хүнд

тавих шаардлага улам өндөр болж, хүний гэрчлэл хийх шаардлага ч бас улам өндөрсдөг. Хүн Бурхантай үнэхээр хамтран ажиллах чадвартай байх тусам Бурхан алдар сууг төдий чинээ олж авдаг. Хүний хамтын ажиллагаа бол түүний хийх хэрэгтэй гэрчлэл бөгөөд түүний хийдэг гэрчлэл нь хүний хэрэгжүүлэлт юм. Тиймээс Бурханы ажил эцсийн үр дүнтэй байх эсэх нь, мөн жинхэнэ гэрчлэлтэй байж чадах эсэх нь хүний хамтын ажиллагаа болон гэрчлэлтэй нягт холбогддог. Ажил дуусах үед, өөрөөр хэлбэл, Бурханы бүх удирдлага төгсгөлдөө очих үед, хүн илүү өндөр гэрчлэл хийх шаардлагатай болно, мөн Бурханы ажил төгсгөлдөө очих үед хүний хэрэгжүүлэлт болон оролт дээд цэгтээ хүрнэ. Өмнө нь хүнээс, хууль болоод тушаалуудыг сахиж, тэвчээртэй, даруухан байхыг шаарддаг байсан. Харин өнөөдөр хүнээс, Бурханы бүх зохицуулалтад дуулгавартай байж, Бурханыг туйлын их хайрлаж, эцэст нь гай зовлонгийн дунд ч гэсэн Бурханыг хайрласаар байхыг шаарддаг. Энэ гурван үе шат нь, бүхий л удирдлагынхаа хугацаанд алхам алхмаар хүнд тавьдаг Бурханы шаардлагууд юм. Бурханы ажлын үе шат бүр сүүлийнхээсээ илүү гүнзгийрдэг ба үе шат бүрд хүнд тавих шаардлага сүүлийнхээсээ илүү гүн гүнзгий болдог, ийм маягаар Бурханы бүхий л удирдлага алгуурхан хэлбэрждэг. Яагаад гэвэл, хүнд тавих шаардлага улам өндөр болох тусам хүний зан чанар Бурханы шаардсан стандартад бүр их дөхдөг, зөвхөн тэр үед л бүх хүн төрөлхтөн Сатаны нөлөөллөөс аажмаар ангижирдаг ба Бурханы ажил бүрэн дуусгавар болоход бүх хүн төрөлхтөн Сатаны нөлөөллөөс аврагдсан байх болно. Тэр цаг ирэхэд Бурханы ажил төгсгөлдөө хүрсэн байх бөгөөд хүн зан чанараа өөрчлөхийн тулд Бурхантай цаашид хамтран ажиллах хэрэггүй болж, бүх хүн төрөлхтөн Бурханы гэрэлд амьдарна, тэр үеэс хойш Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл юм уу тэрслүү байдал гэж байхаа болино. Бурхан ч бас хүнд ямар ч шаардлага тавихгүй, хүн Бурхан хоёрын хооронд илүү эв зохицолтой хамтын ажиллагаа байх болно, энэ нь хүн, Бурхан хоёрын хамтын амьдрал буюу Бурханы удирдлага бүрэн дуусгавар болсны дараа, Бурхан хүнийг Сатаны савраас бүрэн аварсаны дараа бий болсон амьдрал байх болно. Бурханы мөрийг ойрхон дагаж чадахгүй хүмүүс ийм амьдралд хүрч чадахгүй. Тэд бүгд харанхуйд унаж, гашуудан уйлж, шүдээ хавирна; тэд бол Бурханд итгэдэг ч Түүнийг дагадаггүй, Бурханд итгэдэг ч Түүний бүх ажилд дуулгавартай байдаггүй хүмүүс юм. Хүн Бурханд итгэдэг тул Бурханы мөрийг алхам алхмаар ойрхон дагах ёстой; мөн “Хургыг хаашаа ч явсан дагах” ёстой. Зөвхөн энэ хүмүүс л үнэн замыг эрж хайдаг хүмүүс бөгөөд зөвхөн тэд л Ариун Сүнсний ажлыг мэддэг хүмүүс юм. Бичиг үсэг, хоосон

номлолыг боол мэт дагадаг хүмүүс бол Ариун Сүнсний ажлаар таягдан хаягдсан хүмүүс билээ. Цаг үе бүрд Бурхан шинэ ажил эхлүүлдэг, цаг үе бүрд хүмүүсийн дунд шинэ эхлэл байх болно. Хэрэв хүн ганцхан эрин үед хэрэглэгддэг “Ехова бол Бурхан”, “Есүс бол Христ” гэсэн үнэнийг л дагадаг бол хэзээ ч Ариун Сүнсний ажлыг дагаж дийлэхгүйгээр барахгүй, үүрд Ариун Сүнсний ажлыг олж авах чадваргүй байх болно. Бурхан хэрхэн ажилладгаас үл хамааран, хүн өчүүхэн ч эргэлзээгүйгээр, ойрхон дагадаг. Ингэвэл Ариун Сүнс яаж хүнийг таягдан хаяж чадах юм бэ? Бурхан юу ч хийдэг бай, хүн энэ нь Ариун Сүнсний ажил гэдэгт итгэлтэй байгаад, Ариун Сүнсний ажилд эргэлзэлгүйгээр хамтран ажиллаж, Бурханы шаардлагад нийцэхээр хичээж байвал яалаа гэж шийтгүүлэх юм бэ? Бурханы ажил хэзээ ч зогсоогүй, Түүний мөр хэзээ ч зогсоогүй, удирдлагын ажлаа дуусгахаас өмнө Тэр үргэлж завгүй байсан ба хэзээ ч зогсдоггүй. Гэхдээ хүн бол өөр: Ариун Сүнсний ажлын өчүүхэн хэсгийг олж авсныхаа дараа хүн үүнийг хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж үздэг; өчүүхэн хэмжээний мэдлэг олж авчихаад Бурханы илүү шинэ ажлын мөрийг дагахаар урагш явдаггүй; Бурханы ажлын өчүүхэн хэсгийг харчихаад Бурханыг ямар нэг модон хүн мэт даруй тодорхойлж, Бурхан үүрд өөрийнх нь хардаг шиг төрхтэй байна, өнгөрсөнд ямар байсан, ирээдүйд ч мөн тийм байх болно гэж итгэдэг; өнгөц төдий мэдлэг олж аваад хүн бардамнан, өөрийгөө мартаж, ердөө оршин байдаггүй Бурханы зан чанар болон оршихуйг дураараа тунхаглаж эхэлдэг; Ариун Сүнсний ажлын нэг үе шатыг мэддэг болчихоод, ямар хүн Бурханы шинэ ажлыг тунхаглаж байгаа нь хамаагүй, хүн үүнийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдгээр нь Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн зөвшөөрч чаддаггүй хүмүүс юм; тэд бол шинэ зүйлсийг хүлээн авах чадваргүй хэтэрхий хуучинсаг хүмүүс билээ. Ийм хүмүүс Бурханд итгэдэг ч бас Бурханыг голдог. Израильчууд “Есүст итгэлгүй, зөвхөн Еховад итгэж байсан” нь буруу байсан гэж хүн итгэдэг ч дийлэнх хүмүүс “зөвхөн Еховад итгэж, Есүсийг голох”, “Мессиагийн ирэлтийг хүсэн хүлээдэг ч Есүс хэмээх Мессиаг эсэргүүцэх” дүрд тоглодог. Тэгэхээр хүмүүс Ариун Сүнсний ажлын нэг үе шатыг хүлээн авсныхаа дараа Сатаны ноёрхол дор амьдарсаар байж, Бурханы ерөөлийг мөн л хүлээн авдаггүйд гайхах юмгүй. Энэ нь хүний тэрслүү байдлын үр дүн биш гэж үү? Өнөөдрийн шинэ ажилтай хөл нийлүүлээгүй, дэлхий даяарх Христийн шашны хүмүүс бүгд өөрсдийгөө азтай байх болно гэж найдан, Бурхан хүсэл бүрийг нь биелүүлнэ гэж боддог. Гэсэн атлаа, Бурхан яагаад тэднийг гурав дахь тэнгэр лүү аваачихыг итгэлтэй хэлж чаддаггүй, мөн Есүс хэрхэн цагаан үүл хөлөглөн тэднийг авахаар ирэх талаар ч

бат итгэлтэй байж чаддаггүй, түүгээр ч үл барам төсөөлсөн тэр өдөр нь Есүс үнэхээр цагаан үүл хөлөглөн ирэх эсэхийг ч баттай хэлж чаддаггүй. Тэд бүгдээрээ түгшиж, яахаа мэддэггүй; урсгал бүрээс ирсэн, янз бүрийн цөөн тооны хүмүүсийг Бурхан нэг бүрчлэн авах эсэхийг ч мэддэггүй. Бурханы одоо хийдэг ажил, өнөөгийн эрин үе, Бурханы хүсэл—эдгээрийн алийг нь ч тэд ухаардаггүй бөгөөд хуруугаараа хоног тоолохоос өөр юу ч хийж чаддаггүй. Хурганы мөрийг эцсээ хүртэл дагадаг хүмүүс л эцсийн ерөөлийг хүртэж чадна, харин эцсээ хүртэл дагах чадваргүй атлаа бүхнийг олж авсан гэж боддог тэр “ухаалаг хүмүүс” Бурханы илрэлтийг харж чадахгүй. Тэд бүгд өөрсдийгөө газар дэлхий дээрх хамгийн ухаантай хүн гэж үздэг, Бурханы ажлын үргэлжилсэн хөгжлийг ямар ч шалтгаангүй тасалдаг бөгөөд Бурханд “чин үнэнч байж, Бурханыг дагаж, Бурханы үгийг сахидаг” болохоор Бурхан өөрсдийг нь тэнгэр лүү авч явна гэдэгт асар их итгэдэг юм шиг санагддаг. Тэд Бурханы хэлсэн үгэнд “чин үнэнч” ханддаг ч Ариун Сүнсний ажлыг эсэргүүцэж, заль мэх, ёрын мууг үйлддэг учраас үг, үйлдэл нь маш жигшүүртэй байдаг. Эцсийг нь хүртэл дагадаггүй, Ариун Сүнсний ажилтай эн зэрэгцэж чаддаггүй, зөвхөн хуучин ажилтай зууралддаг хүмүүс Бурханд үнэнч байж чадахаагүйгээр үл барам, харин ч эсрэгээрээ Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болж, шинэ эринд гологдон, шийтгэгдэх хүмүүс болсон. Тэднээс илүү өрөвдөлтэй хүмүүс гэж байх уу? Хуучин хуулийг голж, шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөг бүх хүн мөс чанаргүй гэж олонх нь итгэдэг. Зөвхөн “мөс чанарын” талаар ярьдаг, Ариун Сүнсний ажлыг мэддэггүй энэ хүмүүсийн хувьд, эцэстээ мөс чанар нь өөрсдийнх нь хэтийн ирээдүйг сүйрүүлэх болно. Бурханы ажил дүрэм журам мөрддөггүй, Өөрийнх нь ажил байлаа ч гэсэн Бурхан мөн л үүнтэй зууралддаггүй. Үгүйсгэх ёстой зүйлийг үгүйсгэж, таягдах ёстой зүйлийг таягдан хаях ёстой. Гэсэн ч хүн Бурханы удирдлагын ажлын өчүүхэн хэсгээс зуурч, өөрийгөө Бурхантай дайсагнасан байр сууринд тавьдаг. Энэ нь хүний утгагүй байдал биш гэж үү? Хүний мэдлэггүй байдал биш гэж үү? Бурханы ерөөлийг олж авахгүй байх вий гэж эмээж, болгоомжлох тусам хүмүүс илүү их ерөөл олж авч чадахгүй бөгөөд эцсийн ерөөлийг хүртэж бүр чадахгүй. Хуулийг боол мэт сахидаг хүмүүс бүгд хуулинд туйлын үнэнч болохоо харуулдаг ба хуулинд үнэнч байдлаа харуулах тусмаа төдий чинээ Бурханыг эсэргүүцдэг босогчид болдог. Учир нь одоо үе бол Хуулийн эрин үе биш, харин Хаанчлалын эрин үе бөгөөд өнөөдрийн ажлыг урьдын ажилтай жишиж болохгүй, өнгөрсөн үеийн ажлыг өнөөдрийн ажилтай харьцуулж ч болохгүй. Бурханы ажил өөрчлөгдсөн, хүний хэрэгжүүлэлт ч бас

өөрчлөгдсөн; энэ нь хуулиас зуурч, загалмай үүрэх явдал биш, тиймээс хууль болон загалмайд хандах хүмүүсийн үнэнч байдал Бурханы сайшаалыг хүртэхгүй.

Хүн Хаанчлалын эрин үед бүрмөсөн бүрэн төгс болгуулна. Байлдан дагуулалтын ажлын дараа хүн цэвэршүүлэлт, гай зовлон амсах болно. Энэ гай зовлонгийн үеэр ялан гарч, гэрчлэлд зогсож чадах хүмүүс бол эцэстээ бүрэн төгс болгуулах хүмүүс юм; тэд бол ялагчид билээ. Энэ гай зовлонгийн үеэр хүн энэ цэвэршүүлэлтийг хүлээн авах шаардлагатай бөгөөд энэ цэвэршүүлэлт нь Бурханы ажлын сүүлийн тохиолдол юм. Бурханы бүх удирдлагын ажил дуусгавар болохын өмнө хүн сүүлийн удаа цэвэршүүлэгдэж, Бурханыг дагадаг бүх хүн энэхүү сүүлчийн туршилтыг, энэ сүүлчийн цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрөх ёстой. Гай зовлонд автсан хүмүүс Ариун Сүнсний ажилгүй, Бурханы удирдамжгүй байдаг боловч үнэхээр байлдан дагуулагдсан, Бурханыг үнэхээр эрж хайдаг хүмүүс эцэстээ бат зогсоно; тэд бол хүн чанартай, Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс юм. Бурхан юу ч хийдэг бай, энэ ялагчид үзэгдлээс салахгүй бөгөөд гэрчлэлдээ бүтэлгүйтэлгүйгээр үнэнийг хэрэгжүүлсээр байх болно. Тэд бол эцэстээ үлэмж гай зовлонгоос гарч ирэх хүмүүс юм. Үймээн самууныг өөрсдийнхөө төлөө ашигладаг хүмүүс өнөөдөр бусдын хүчээр хоолоо олж идсээр байх ч эцсийн гай зовлон, эцсийн туршилтаас нэг нь ч зугтаж чадахгүй. Ялах хүмүүсийн хувьд тийм гай зовлон нь үлэмж их цэвэршүүлэлт юм; харин үймээн самууныг өөрсдийнхөө төлөө ашигладаг хүмүүсийн хувьд энэ нь бүрэн таягдан хаягдах ажил мөн. Тэднийг яаж ч шалгасан бай, зүрх сэтгэлд нь Бурхан байдаг хүмүүсийн үнэнч байдал өөрчлөгдөхгүй хэвээр үлддэг; харин зүрх сэтгэлд нь Бурхан байдаггүй хүмүүсийн хувьд, Бурханы ажил махан биед нь ашиггүй болмогц тэд Бурханыг үзэх үзэл бодлоо өөрчилж, бүр Бурханаас салж оддог. Ийм хүмүүс бол эцэстээ бат зогсохгүй, Бурханы ерөөлийг л хайдаг, өөрсдийгөө Бурханы төлөө зарцуулж, зориулах хүсэлгүй хүмүүс юм. Ийм олиггүй хүмүүс Бурханы ажил дуусгавар болох үед бүгд хөөгдөх ба огт өрөвдүүлэх үнэ цэнгүй. Хүн чанаргүй хүмүүс Бурханыг үнэхээр хайрлах чадваргүй. Орчин нөхцөл нь амар тайван, аюулгүй, эсвэл ашигтай байгаа үед тэд Бурханд бүрэн дуулгавартай байдаг боловч хүссэн зүйлээ алдвал, эсвэл эцэстээ няцаагдвал даруй бослого гаргадаг. Ердөө ганцхан шөнийн дотор тэд инээмсэглэсэн, “сайхан сэтгэлтэй” хүн байснаа муухай царайтай, хэрцгий алуурчин болж, өчигдрийн өглөгийн эзэнтэйгээ ямар ч шалтаг, шалтгаангүйгээр гэнэт заналт дайсан мэт харьцдаг. Нүд цавчилгүй хөнөөж мэдэх энэ

чөтгөрүүдийг хэрвээ хөөхгүй бол тэд далд аюул болохгүй гэж үү? Хүнийг аврах ажил нь байлдан дагуулалтын ажил дууссаны дараа биелдэггүй. Байлдан дагуулалтын ажил дууссан хэдий ч хүнийг ариусгах ажил дуусаагүй; хүн бүрэн ариусгагдаж, Бурханд үнэхээр захирагддаг хүмүүс бүрэн төгс болгуулж, зүрх сэтгэлдээ Бурхангүй дүр эсгэгчид арилмагц л ийм ажил дуусна. Бурханы ажлын сүүлийн үе шатанд Түүнийг сэтгэл хангалуун болгодоггүй хүмүүс бүрмөсөн таягдан хаягдах ба таягдан хаягддаг хүмүүс нь диаволынх юм. Тэд Бурханы сэтгэлийг хангалуун байлгах чадваргүй тул Бурханы эсрэг тэрсэлдэг бөгөөд хэдий энэ хүмүүс өнөөдөр Бурханыг дагадаг ч эцэстээ үлдэх хүмүүс мөн гэдгийг энэ нь баталдаггүй. “Бурханыг эцсээ хүртэл дагадаг хүмүүс аврал хүртэнэ” гэдэг үгэнд байгаа “дагах” гэдгийн утга учир нь гай зовлонгийн дунд бат зогсох гэсэн үг юм. Өнөөдөр, Бурханыг дагах нь амархан гэж олон хүн итгэдэг, гэхдээ Бурханы ажил дуусах гэж байх үед ч “дагах” гэдгийн жинхэнэ утгыг мэдэх болно. Өнөөдөр ч байлдан дагуулагдсанахаа дараа Бурханыг дагах чадвартай байлаа ч төгс болгуулах хүмүүсийн нэг мөн гэдгийг чинь энэ нь баталдаггүй. Шалгалт туулах чадваргүй, гай зовлонгийн дунд ялгуусан байх чадваргүй хүмүүс эцэстээ бат зогсож чадахгүй тул Бурханыг эцсээ хүртэл дагаж чадахгүй. Бурханыг үнэхээр дагадаг хүмүүс ажлынхаа туршилтыг давж гарах чадвартай байдаг байхад Бурханыг үнэхээр дагадаггүй хүмүүс Бурханы ямар ч шалгалтыг тэсэн гарах чадваргүй байдаг. Эрт орой хэзээ нэгэн цагт тэд хөөгдөнө, харин ялагчид хаанчлалд үлдэнэ. Хүн Бурханыг үнэхээр эрж хайдаг эсэх нь түүний ажлын туршилтаар, өөрөөр хэлбэл, Бурханы шалгалтаар тодорхойлогддог бөгөөд хүний өөрийн шийдвэртэй ямар ч хамаагүй. Бурхан аливаа хүнийг дур зоргоороо голдоггүй; Түүний хийдэг бүхэн хүнийг бүрэн үнэмшүүлж чадна. Тэрээр хүнд үл үзэгдэх юмс, эсвэл хүн үнэмшихээргүй ажил хийдэггүй. Хүний итгэл үнэн худал эсэх нь баримтаар нотлогддог ба хүн үүнийг шийдэж чадахгүй. “Буудай үрийн сүүл болж чадахгүй, үрийн сүүл буудай болж чадахгүй” гэдэг нь эргэлзээгүй. Бурханыг үнэхээр хайрладаг бүх хүн эцэстээ хаанчлалд үлдэх ба Бурхан Өөрийг нь үнэхээр хайрладаг хэнд ч зохисгүй хандахгүй. Хаанчлал дахь ялагчид өөр өөр чиг үүрэг болон гэрчлэлдээ үндэслэн тахилч юм уу дагагч болж үйлчлэх бөгөөд гай зовлон дунд ялгуусан байдаг бүх хүн хаанчлал доторх тахилчдын бүлэг болно. Орчлон ертөнц даяарх сайн мэдээний ажил дуусгавар болох үед тахилчдын бүлэг байгуулагдана. Тэр цаг ирэхэд хүн Бурханы хаанчлалд үүргээ гүйцэтгэж, хаанчлал дотор Бурхантай хамт амьдрах ёстой. Тахилчдын бүлэгт ахлах тахилчид болон тахилчид байх ба

үлдсэн хэсэг нь Бурханы хөвгүүд, ардууд байх болно. Энэ бүхэн нь гай зовлонгийн үеэр Бурханд хийсэн гэрчлэлээр нь тодорхойлогддог; тэдгээр нь дур зоргоороо өгдөг цол биш. Хүн байр сууриа олмогц Бурханы ажил зогсоно, учир нь бүгд төрлөөрөө ангилагдаж, анхдагч байр сууриндаа эргэн очдог бөгөөд энэ нь Бурханы ажил гүйцэлдсэний тэмдэг, Бурханы ажил болон хүний хэрэгжүүлэлтийн эцсийн үр дүн, мөн Бурханы ажлын үзэгдэл болон хүний хамтын ажиллагааны биелэлт юм. Эцэст нь хүн Бурханы хаанчлалд амарч, Бурхан ч гэсэн оршин суудаг газартаа амрахаар буцна. Энэ нь Бурхан, хүн хоёрын 6,000 жилийн хамтын ажиллагааны эцсийн үр дүн байх болно.

ХРИСТИЙН МӨН ЧАНАР БОЛ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙН ХҮСЭЛД ДУУЛГАВАРТАЙ БАЙХ ЯВДАЛ ЮМ

Бие махбодтой болсон Бурханыг Христ гэдэг ба Христ бол Бурханы Сүнсний өмссөн махбод билээ. Энэхүү махбод нь махан биетэй ямар ч хүнтэй адилгүй. Христ бол мах, цуснаас бүрдсэн бус, харин Сүнсний биелэл учраас ийм ялгаа байгаа юм. Түүнд хэвийн хүн чанар, бүрэн дүүрэн бурханлаг чанарын аль аль нь бий. Түүний бурханлаг чанарыг ямар ч хүн эзэмшдэггүй. Түүний хэвийн хүн чанар нь махбод дахь бүх хэвийн үйл ажиллагааг хангадаг байхад бурханлаг чанар нь Бурханы Өөрийн ажлыг гүйцэтгэдэг. Түүний хүн чанар ч бай, бурханлаг чанар ч бай, аль аль нь тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захирагддаг. Христийн мөн чанар бол Сүнс буюу бурханлаг чанар юм. Тиймээс, Түүний мөн чанар нь Бурханы Өөрийн мөн чанар байдаг; энэхүү мөн чанар Өөрийнх нь ажилд саад болохгүй, Тэрээр Өөрийнхөө ажлыг сүйтгэх ямар нэг зүйлийг хийж яавч чадахгүй, Өөрийнх нь хүсэлд харшилдаг үгийг хэзээ ч хэлдэггүй. Тиймээс, бие махбодтой болсон Бурхан нь Өөрийнхөө удирдлагад саад болох ямар нэг ажлыг бүр хэзээ ч хийхгүй. Үүнийг бүх хүн ойлгох ёстой. Ариун Сүнсний ажлын мөн чанар нь хүнийг аврахын төлөө, Бурханы Өөрийн удирдлагын төлөө байдаг. Үүний адилаар, Христийн ажил ч бас хүнийг аврахын төлөө, Бурханы хүслийн төлөө байдаг. Бурхан махбод болсон болохоор мөн чанар нь Түүний махбод дотор биеллээ олж, улмаар Түүний махбод ажлыг нь хариуцахад хангалттай болдог. Тиймээс, бие махбодтой болсон байх хугацаанд Бурханы Сүнсний бүх ажил нь Христийн ажлаар солигддог бөгөөд бие махбодтой болсон хугацааны туршид бүх ажлын цөм нь Христийн ажил байдаг. Үүнийг өөр ямар ч эрин үеийн ажилтай хольж болохгүй. Бурхан махбод болсон тул махбодынхоо ялгамж

чанараар ажилладаг; Тэр махбодоор ирдэг тул хийх учиртай ажлаа махбодоор хийж дуусгадаг. Бурханы Сүнс ч бай, Христ ч бай, хоёулаа Бурхан Өөрөө бөгөөд хийх учиртай ажлаа хийж, биелүүлэх учиртай үйлчлэлээ биелүүлдэг.

Бурханы мөн чанар нь өөрөө эрх мэдэл эзэмшдэг боловч Өөрөөс нь гардаг эрх мэдэлд Тэр бүрэн захирагдаж чаддаг. Сүнсний ажил ч бай, махбодын ажил ч бай, аль нь ч нөгөөтэйгөө зөрчилддөггүй. Бурханы Сүнс бол бүх бүтээлийн дээрх эрх мэдэл юм. Бурханы мөн чанартай махбод ч бас эрх мэдэл эзэмшдэг, гэхдээ махбод дахь Бурхан нь тэнгэрлэг Эцэгийн хүслийг дуулгавартай дагадаг бүх ажлыг хийж чаддаг. Үүнд нэг ч хүн хүрч, ухан ойлгож чадахгүй. Бурхан Өөрөө эрх мэдэл боловч Түүний махбод эрх мэдэлд нь захирагдаж чадна. “Эцэг Бурханы хүслийг Христ дуулгавартай дагадаг” гэдэг үгийн цаад учир энэ билээ. Бурхан бол Сүнс бөгөөд авралын ажлыг хийж чаддаг, хүн болох үедээ ч үүнийг хийж чаддаг. Ямартай ч, Бурхан Өөрөө Өөрийнхөө ажлыг хийдэг; Тэр саад ч болдоггүй, хөндлөнгөөс ч оролцдоггүй, өөр хоорондоо зөрчилддөг ажил бүр ч хийдэггүй, учир нь Сүнс, махбод хоёрын хийдэг ажлын мөн чанар адилхан юм. Сүнс ч бай, махбод ч бай, хоёулаа нэг хүслийг биелүүлэхийн төлөө ажиллаж, адилхан ажлыг удирддаг. Сүнс, махбод хоёр харьцуулшгүй хоёр өөр чанартай хэдий ч мөн чанар нь адилхан; хоёулаа Бурханы Өөрийн мөн чанар болон ялгамж чанарыг агуулдаг. Бурханд Өөрт нь дуулгаваргүй байдлын ямар ч элемент байхгүй; Түүний мөн чанар нь сайн. Тэр бол бүх гоо үзэсгэлэн, сайн сайхан, бүх хайрын илэрхийлэл билээ. Бурхан махбодод байхдаа ч гэсэн, Эцэг Бурханд дуулгаваргүй хандах юу ч хийдэггүй. Амиа золиослоод ч хамаагүй, Тэр бүх зүрх сэтгэлээрээ тийнхүү үйлдэхэд бэлэн байх ба өөр ямар ч сонголт хийхгүй. Бурханд Өөрийгөө зөвтгөж, чухалчилдаг, ихэрхүү, биеэ тоосон байдлын ямар ч элемент байдаггүй; шударга бус зангийн ямар ч элемент байдаггүй. Бурханд дуулгаваргүй байдаг бүхэн Сатанаас гардаг; Сатан бол бүх муу муухай, хорон муугийн эх сурвалж билээ. Хүнийг Сатан завхруулж, боловсруулсан учраас л Сатаныхтай адил чанартай байдаг. Христийг Сатан завхруулаагүй, иймээс Тэр зөвхөн Бурханы шинж чанарыг агуулдаг ба Сатаны шинж чанарын аль нь ч байдаггүй. Ажил хэчнээн хэцүү бэрх ч бай, махбод хэчнээн сул дорой ч бай хамаагүй, Бурхан махбодод амьдрах зуураа Бурханы Өөрийн ажилд саад болох зүйл хэзээ ч хийхгүй, Эцэг Бурханы хүслийг дуулгаваргүй байдлаар бүр ч хаяхгүй. Эцэг Бурханы хүслээс урвасны оронд махбодын зовлон эдлэхийг илүүд үзнэ; Есүс “Эцэг минь, хэрвээ боломжтой бол энэ аягыг Надаас өнгөрүүлээч; гэхдээ Миний хүслээр биш, харин Таны хүслээр

болог” гэж залбиран хэлсэнтэй энэ нь яг адилхан юм. Хүмүүс өөрийнхөө сонголтыг хийдэг, харин Христ тэгдэггүй. Хэдий Тэр Бурханы Өөрийн ялгамж чанартай ч махбодын өнцгөөс Эцэг Бурханы хүслийг мөн л эрж хайдаг ба Өөрт нь Эцэг Бурханы даалгасан зүйлийг биелүүлдэг. Энэ нь хүний хүрч чадахгүй зүйл юм. Сатанаас гардаг зүйл Бурханы мөн чанартай байж чаддаггүй; харин Бурханд дуулгаваргүй байж, эсэргүүцдэг мөн чанартай байж л чадна. Сатан Бурханд бүрэн дуулгавартай байж чаддаггүй, Бурханы хүслийг дуртайяа дуулгавартай дагаж бүр ч чаддаггүй. Христээс бусад бүх хүн Бурханыг эсэргүүцэх зүйл хийж магадгүй бөгөөд Бурханы даалгасан ажлыг нэг ч хүн шууд өөртөө авч чадахгүй; нэг ч хүн Бурханы удирдлагыг өөрсдийн гүйцэтгэх үүрэг гэж үзэж чаддаггүй. Христийн мөн чанар нь Эцэг Бурханы хүсэлд захирагдах явдал юм; Бурханы эсрэг дуулгаваргүй байдал бол Сатаны шинж чанар мөн. Энэ хоёр чанар нь нийцдэггүй ба Сатаны шинж чанартай хэнийг ч Христ гэж нэрлэж болохгүй. Хүн Бурханы ажлыг оронд нь хийж чаддаггүйн шалтгаан гэвэл хүнд Бурханы ямар ч мөн чанар байдаггүй. Хүн хувийн ашиг сонирхол, хэтийн ирээдүйнхээ тусын тулд Бурханы төлөө ажилладаг, харин Христ бол Эцэг Бурханы хүслийг биелүүлэхийн тулд ажилладаг.

Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь удирддаг. Хэдий Тэр махбодтой ч, хүн чанар нь тэр чигтээ махан биетэй хүнийхтэй адилгүй. Түүнд Өөрийн гэсэн цор ганц зан араншин байдаг бөгөөд үүнийг ч гэсэн бурханлаг чанар нь удирддаг. Түүний бурханлаг чанарт ямар ч сул тал байхгүй; Христийн сул тал гэж хүн чанарынх нь сул талыг хэлдэг. Энэ сул тал нь Түүний бурханлаг чанарыг тодорхой хэмжээнд хязгаарладаг боловч ийм хязгаарлалт нь хэмжээ хязгааргүй бус, харин тодорхой цар хүрээ, цаг хугацаан дотор байдаг. Бурханлаг чанарынхаа ажлыг хэрэгжүүлэх цаг нь болоход, Түүний хүн чанараас үл хамааран энэ нь хийгддэг. Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь бүрэн чиглүүлдэг. Түүний хүн чанарын хэвийн амьдралаас гадна хүн чанарынх нь бусад бүх үйлдэлд бурханлаг чанар нь нөлөө үзүүлж, нөлөөлж, удирдаж байдаг. Христ хүн чанартай хэдий ч бурханлаг чанарынх нь ажлыг энэ нь тасалдуулдаггүй бөгөөд яг нарийндаа энэ нь Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь чиглүүлдгээс үүдэлтэй; Түүний хүн чанар нь бусадтай харилцахдаа биеэ хэрхэн авч явах тухайд төлөвшөөгүй байдаг ч бурханлаг чанарынх нь хэвийн ажилд нөлөөлдөггүй. Христийн хүн чанар завхраагүй гэж хэлэхдээ Би, Түүний хүн чанарыг бурханлаг чанар нь шууд захирч чаддаг, мөн Тэрээр жирийн хүнийг бодвол илүү эрүүл ухаантай байдаг гэх утгаар хэлдэг юм.

Ажилдаа бурханлаг чанараар удирдуулахад Түүний хүн чанар хамгийн тохиромжтой байдаг; Түүний хүн чанар нь бурханлаг чанарын ажлыг хамгийн сайн илэрхийлж чаддаг, мөн ийм ажилд хамгийн сайн захирагдаж чаддаг. Бурхан махбодод ажиллахдаа махан биетэй хүний биелүүлэх учиртай үүргээс хэзээ ч хараа салгадаггүй; Тэрээр тэнгэр дэх Бурханыг чин зүрх сэтгэлээр шүтэн мөргөх чадвартай. Түүнд Бурханы мөн чанар байдаг бөгөөд Түүний ялгамж чанар бол Бурханы Өөрийн ялгамж чанар юм. Тэр гагцхүү газар дээр ирээд, бүтээгдсэн зүйлийн гадаад бүрхүүлтэй бүтээгдсэн зүйл болж, урьд нь Түүнд байгаагүй хүн чанарыг эзэмшсэн. Тэрээр тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөж чаддаг, энэ нь Бурханы Өөрийн оршихуй бөгөөд хүн дуурайшгүй билээ. Түүний ялгамж чанар бол Бурхан Өөрөө. Махбодын өнцгөөс л Тэрээр Бурханыг шүтэн мөргөдөг; тиймээс, “Христ тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөдөг” гэх үг буруу биш. Тэрээр хүнээс яг Өөрийн оршихуйг л шаарддаг; хүнээс ийм зүйл шаардахынхаа өмнө Өөрөө энэ бүхэндээ аль хэдийн хүрсэн байдаг. Тэр Өөрөө ангид байх зуураа бусдад хэзээ ч шаардлага тавихгүй, учир нь энэ бүхэн Түүний оршихуйг бүрдүүлдэг. Тэр ажлаа хэрхэн хэрэгжүүлдэг нь хамаагүй, Бурханд дуулгаваргүй ханддаг байдлаар авирлахгүй. Тэр хүнээс юу ч шаарддаг байлаа гэсэн, ямар ч шаардлага нь хүний хүрч чадах зүйлээс хэтэрдэггүй. Түүний хийдэг бүхэн Бурханы хүслийг биелүүлдэг бөгөөд Түүний удирдлагын төлөө байдаг. Христийн бурханлаг чанар бүх хүнээс дээр байдаг; тиймээс Тэр бол бүтээгдсэн бүх зүйлээс хамгийн өндөр дээд эрх мэдэл юм. Энэ эрх мэдэл нь Түүний бурханлаг чанар, өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн зан чанар, оршихуй бөгөөд энэ нь Түүний ялгамж чанарыг тодорхойлдог. Тиймээс, Түүний хүн чанар хэчнээн хэвийн ч бай, Түүнд Бурханы Өөрийн ялгамж чанар байдаг гэдэг нь маргаангүй; Тэр ямар өнцгөөс ярьж, Бурханы хүслийг яаж ч дуулгавартай дагадаг байлаа гэсэн, Түүнийг Бурхан Өөрөө биш гэж хэлж болохгүй. Мунхаг, мэдлэггүй хүмүүс Христийн хэвийн хүн чанарыг өө сэв гэж үздэг. Тэр бурханлаг чанарын оршихуйгаа яаж ч илэрхийлж, илчиллээ гэсэн, хүн Түүнийг Христ гэж хүлээн зөвшөөрөх чадваргүй. Христ Өөрийн дуулгавартай, даруу байдлыг харуулах тусам, тэнэг хүмүүс Христийг улам хөнгөн хуумгай авч үздэг. Түүнд гадуурхаж, басамжилсан хандлагаар ханддаг атлаа ихэмсэг дүртэй “агуу хүмүүс”-ийг шүтэхээр ширээн дээр залдаг хүмүүс ч байдаг. Бурханд хандах хүний эсэргүүцэл, дуулгаваргүй байдал нь, бие махбодтой болсон Бурханы мөн чанар Бурханы хүсэлд захирагддаг баримтаас, мөн Христийн хэвийн хүн чанараас үүдэн гардаг; энэ нь Бурханд хандах хүний эсэргүүцэл, дуулгаваргүй

байдлын эх үүсвэр юм. Христэд хүн чанарынх нь гадаад төрх байгаагүй, бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Эцэг Бурханы хүслийг ч эрж хайгаагүй, харин оронд нь супер хүн чанарыг эзэмшсэн байсан бол хүмүүсийн дунд ямар ч хүн дуулгаваргүй хандахгүй байсан байх. Хүн тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд итгэхэд үргэлж бэлэн байдгийн шалтгаан нь тэнгэр дэх Бурханд хүн чанар байдаггүй, бүтээгдсэн зүйлийн ганц ч чанар байдаггүй. Тиймээс хүн үргэлж тэнгэр дэх Бурханд хамгийн их хүндэтгэлтэйгээр ханддаг боловч Христэд басамжилсан хандлага гаргадаг.

Газар дээрх Христ нь Бурханы Өөрийн өмнөөс ажиллах чадвартай хэдий ч махбод дахь дүрээ бүх хүнд харуулах санаа зорилготойгоор ирдэггүй. Тэрээр бүх хүнд Өөрийгөө харуулахаар ирдэггүй; Өөрийнх нь гараар удирдуулах боломжийг хүмүүст олгож, улмаар шинэ эрин үе рүү оруулах гэж Тэр ирдэг. Христийн махбодын чиг үүрэг нь Бурханы Өөрийн ажлын төлөө, өөрөөр хэлбэл, махбод дахь Бурханы ажлын төлөө байдаг болохоос махбодынхаа мөн чанарыг хүмүүст бүрэн ойлгуулахын төлөө байдаггүй. Тэр яаж ч ажиллалаа гэсэн, Түүний хийдэг юу ч махбодын хийж чадах зүйлээс хэтэрдэггүй. Тэр яаж ч ажиллалаа гэсэн, хэвийн хүн чанартай махбодоор ажилладаг бөгөөд Бурханы жинхэнэ төрх байдлыг хүнд бүрэн илчилдэггүй. Үүнээс гадна, махбод дахь Түүний ажил хэзээ ч хүний төсөөлдөг шиг ер бусын, үнэлж баршгүй байдаггүй. Христ махбод дахь Бурханыг Өөрийг нь төлөөлж, Бурханы Өөрийн хийх учиртай ажлыг биечлэн хэрэгжүүлдэг хэдий ч тэнгэр дэх Бурханы оршин тогтнолыг үгүйсгэдэггүй, Өөрийнхөө үйл хэргийг ч улайран тунхагладаггүй. Харин ч Тэрээр махбод дотроо даруухнаар нуугдсан хэвээр үлддэг. Христээс гадна, өөрсдийгөө Христ хэмээн хуурамчаар зарладаг хүмүүст Түүний чанарууд байдаггүй. Тэрхүү хуурамч Христүүдийн биеэ тоож, өөрсдийгөө өргөмжилдөг зан чанартай харьцуулж үзэх үед, ямархуу махбод үнэхээр Христ вэ гэдэг нь илэрхий болдог. Тийм хуурамч Христүүд хэдий чинээ хуурамч байна, төдий чинээ бардамнадаг бөгөөд хүнийг мэхлэхийн тулд төдий чинээ тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвартай байдаг. Хуурамч Христүүдэд Бурханы чанар байдаггүй; хуурамч Христэд хамаардаг ямар ч элемент Христэд холилдоогүй байдаг. Бурхан махбодын ажлыг гүйцэтгэхийн тулд л махбод болдог болохоос, зүгээр л Өөрийгөө хүмүүст харуулах гэсэндээ тэгдэггүй. Харин ч Тэр Өөрийнхөө ажлаар ялгамж чанараа бататгаж, Өөрийнхөө илчилдэг зүйлээр мөн чанараа баталгаажуулдаг. Түүний мөн чанар үндэслэлгүй биш; ялгамж чанараа Тэр Өөрийн гараар булаан аваагүй; энэ нь Түүний ажил болон мөн чанараар

тодорхойлогддог. Хэдий Тэр Бурханы Өөрийн мөн чанартай, Бурханы Өөрийн ажлыг хийх чадвартай ч эцсийн эцэст бас л Сүнстэй адилгүй махбод билээ. Тэр бол Сүнсний чанартай Бурхан биш; харин махбодын бүрхүүлтэй Бурхан юм. Тиймээс, Тэр хэчнээн хэвийн, хэчнээн сул дорой ч байсан бай, мөн Эцэг Бурханы хүслийг яаж ч эрж хайдаг бай хамаагүй, Түүний бурханлаг чанарыг үгүйсгэх аргагүй. Бие махбодтой болсон Бурханд хэвийн хүн чанар болон хэвийн хүн чанарын сул талууд оршдог төдийгүй, бурханлаг чанарынх нь гайхалтай, тайлагдашгүй байдал, түүнчлэн махбод дахь бүх үйл хэрэг нь ч бас оршдог. Тиймээс, Христийн дотор хүн чанар, бурханлаг чанарын аль аль нь үнэхээр, бодитоор оршдог. Энэ нь огтхон ч хоосон, ер бусын зүйл биш. Тэрээр ажил гүйцэтгэх үндсэн зорилготойгоор газар дээр ирдэг; газар дээр ажил гүйцэтгэхийн тулд хэвийн хүн чанартай байх шаардлагатай; эс бөгөөс, Түүний бурханлаг чанарын хүч чадал хэчнээн их байсан ч, анхдагч чиг үүргээ сайтар биелүүлж чадахгүй. Түүний хүн чанар асар их ач холбогдолтой хэдий ч энэ нь Түүний мөн чанар биш. Түүний мөн чанар бол бурханлаг чанар юм; тиймээс газар дээрх үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэх мөчид Тэрээр бурханлаг чанарынхаа оршихуйг илэрхийлж эхэлдэг. Түүний хүн чанар нь гагцхүү махбодынхоо хэвийн амьдралыг хангахын төлөө оршдог, ингэснээр Түүний бурханлаг чанар махбодод хэвийн ажиллаж чаддаг; бурханлаг чанар л Түүний ажлыг бүхэлд нь чиглүүлдэг. Өөрийн ажлыг дуусгах үедээ Тэр үйлчлэлээ хэрэгжүүлсэн байх болно. Хүний мэдэх учиртай зүйл бол Түүний бүхий л ажил бөгөөд Өөрийн ажлаар л дамжуулан Тэр Өөрийг нь мэдэх боломжийг хүнд олгодог. Тэрээр ажлынхаа явцад бурханлаг чанарынхаа оршихуйг нэлээд бүрэн илэрхийлдэг бөгөөд энэ нь хүн чанар холилдсон зан чанар юм уу хүний бодол, зан авир холилдсон оршихуй биш. Бүх үйлчлэл нь дуусах цаг ирэхэд Тэр илэрхийлэх учиртай зан чанараа аль хэдийн бүрэн, төгс илэрхийлсэн байх болно. Түүний ажил ямар нэг хүний заавраар явагддаггүй; Түүний зан чанарын илэрхийлэл ч бас нэлээд чөлөөтэй байдаг бөгөөд оюун санаагаар хянуулж, эсвэл бодлоор боловсруулагддаггүй, харин аяндаа илчлэгддэг. Энэ нь хэний ч хийж чадахгүй зүйл юм. Хүрээлэн буй орчин хахир хатуу, тааламжгүй байсан ч гэсэн, Тэрээр тохиромжтой цагт нь зан чанараа илэрхийлж чаддаг. Христ болох Нэгэн нь Христийн оршихуйг илэрхийлдэг бол Христ биш хүмүүст Христийн зан чанар байдаггүй. Тиймээс, Түүнийг бүгд эсэргүүцэж, Түүний талаар үзэлтэй боллоо ч гэсэн, Христийн илэрхийлсэн зан чанар Бурханых мөн гэдгийг хүний үзэлд үндэслээд хэн ч үгүйсгэж чадахгүй. Чин зүрх сэтгэлээр Христийг эрэлхийлдэг,

эсвэл Бурханыг зориуд эрж хайдаг бүх хүн, Түүний бурханлаг чанарын илэрхийлэлд үндэслээд Христ мөн гэдгийг нь хүлээн зөвшөөрнө. Хүний үзэлтэй нийцдэггүй ямар нэг талаас нь болж Христийг тэд хэзээ ч үгүйсгэхгүй. Хүн хэдий маш мунхаг боловч хүний хүсэл юу болох, Бурханаас юу үүддэг болохыг бүгд яг таг мэдэж байдаг. Гагцхүү өөрсдийнхөө санаа зорилгоос үүдэн олон хүн Христийг санаатайгаар эсэргүүцдэг. Хэрвээ ийм биш байсан бол, Христийн оршин тогтнолыг үгүйсгэх шалтгаан ганц ч хүнд байхгүй байх байв, учир нь Христийн илэрхийлдэг бурханлаг чанар үнэхээр оршин байдаг ба Түүний ажлыг энгийн нүдээр харж болно.

Христийн ажил болон илэрхийлэл мөн чанарыг нь тодорхойлдог. Тэрээр Өөрт нь даалгасан зүйлийг чин сэтгэлээр гүйцэлдүүлж чаддаг. Тэрээр тэнгэр дэх Бурханыг чин сэтгэлээр шүтэн мөргөж чаддаг бөгөөд Эцэг Бурханы хүслийг үнэн зүрх сэтгэлээсээ эрж хайдаг. Энэ бүгд Түүний мөн чанараар тодорхойлогддог. Иймээс Түүний төрөлхийн илэрхийлэл ч гэсэн мөн чанараар нь тодорхойлогддог; үүнийг “төрөлхийн илэрхийлэл” гэж нэрлэдгийн минь шалтгаан нь Түүний илэрхийлэл бол даган дуурайсан явдал биш, хүний олгосон боловсролын үр дүн ч биш, хүний олон жилийн боловсруулалтын үр дүн ч бас биш. Тэр үүнийг сураагүй, эсвэл Өөрийгөө үүгээр гоёогүй; харин ч энэ нь Түүний дотор төрөлхөөсөө байдаг. Хүн, Түүний ажил, илэрхийлэл, хүн чанар болон хэвийн хүн чанарынх нь бүхий л амьдралыг үгүйсгэж болох боловч тэнгэр дэх Бурханыг үнэн сэтгэлээсээ шүтдэг мөргөдгийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй; тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлэхээр ирснийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй, мөн Эцэг Бурханыг эрж хайдаг чин сэтгэлийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй. Хэдий Түүний дүр мэдрэхүйд таатай биш, яриа нь ер бусын өнгө аясгүй, ажил нь хүний төсөөлдөг шиг газар донсолгож, тэнгэр чичрүүлэм биш боловч Тэр бол үнэхээр тэнгэрлэг Эцэгийн хүслийг үнэн сэтгэлээсээ биелүүлж, тэнгэрлэг Эцэгт бүрэн захирагдаж, үхэн үхтэлээ дуулгавартай байдаг Христ мөн юм. Учир нь Түүний мөн чанар бол Христийн мөн чанар билээ. Энэхүү үнэнд хүн итгэхэд хэцүү боловч энэ нь бодит баримт мөн. Христийн үйлчлэл бүрэн гүйцэлдэх үед, Түүний зан чанар болон оршихуй нь тэнгэр дэх Бурханы зан чанар, оршихуйг төлөөлдөг болохыг хүн Түүний ажлаас харж чадна. Тэр үед, Тэрээр үнэхээр махбод болсон Үг мөн бөгөөд мах цуснаас бүрдсэн хүнтэй адилгүй гэдгийг Түүний бүх ажлын нийлбэр цогц баталж чадна. Газар дээрх Христийн ажлын алхам бүр өөрийн гэсэн бэлгэдлийн ач холбогдолтой байдаг боловч алхам бүрийн бодит ажлыг туулдаг хүн Түүний ажлын ач холбогдлыг ухаарч чаддаггүй.

Ялангуяа хоёр дахь удаа бие махбодтой болохдоо Бурханы гүйцэтгэдэг ажлын хэд хэдэн алхмын хувьд ийм байдаг. Христийн үгийг л үзэж дуулснаас биш, Түүнийг хэзээ ч харж байгаагүй ихэнх хүн Түүний ажлын талаар ямар ч үзэлгүй байдаг; Христийг харж, үгийг нь сонссон, мөн ажлыг нь туулсан хүмүүст Түүний ажлыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдаг. Христийн гадаад төрх, хэвийн хүн чанар хүнд таалагддаггүй учраас тэр биш үү? Христийг явсны дараа ажлыг нь хүлээн зөвшөөрдөг хүмүүст ийм бэрхшээл гарахгүй, учир нь тэд ердөө л Түүний ажлыг хүлээн зөвшөөрдөг ба Христийн хэвийн хүн чанартай харилцдаггүй. Хүн Бурханы талаарх үзлээ орхиж чаддаггүй, харин ч Түүнийг няхуур судалдаг; энэ нь, хүн Түүний гадаад төрхийг л анхаардгаас биш, ажил болон үгэнд нь үндэслэн Түүний мөн чанарыг таньж чаддаггүйгээс болдог. Хэрвээ хүн Христийн гадаад төрхийг нүдээ анин өнгөрөөж, эсвэл Христийн хүн чанарын талаар ярилцахаас зайлсхийж, ажил болон үгийг нь ямар ч хүн биелүүлэх аргагүй бурханлаг чанарынх нь тухай л ярьдаг бол хүний үзэл хоёр дахин багасаж, бүх бэрхшээл нь шийдвэрлэгдэх хэмжээнд ч хүрнэ. Бие махбодтой болсон Бурханы ажлын үеэр хүн Түүнийг тэвчиж чаддаггүй, Түүний талаарх тоо томшгүй үзлээр дүүрэн байдаг бөгөөд эсэргүүцэж, дуулгаваргүй байх тохиолдол түгээмэл байдаг. Хүн Бурханы оршин тогтнолыг тэвчиж, Христийн номхон даруу, нууцлаг байдлыг хүлцэж, тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагадаг Христийн мөн чанарыг уучилж чаддаггүй. Тиймээс, Тэр ажлаа дуусгасны дараа хүнтэй хамт мөнхөд үлдэж чадахгүй, учир нь хүн Түүнийг өөрсөдтэй нь хамт амьдрахыг зөвшөөрөхийг хүсдэггүй. Хүн Түүнийг ажлынх нь хугацаанд хүлцэж чадахгүй бол үйлчлэлээ хэрэгжүүлчихээд өөрсдийнх нь хажууд амьдарч, Түүний үгийг аажмаар туулахыг нь харахыг хэрхэн тэвчиж чадах билээ? Тэр үед Түүнээс болж олон хүн унахгүй гэж үү? Хүн Түүнд газар дээр ажиллахыг л зөвшөөрдөг; энэ нь хүний хүлцэх хамгийн дээд хязгаар юм. Хэрвээ Түүний ажил байгаагүй бол хүн Түүнийг аль хэдийн газар дэлхийгээс хөөн зайлуулчих байсан, тэгэхээр ажил нь дуусчихвал Түүнд хэчнээн хүлээцгүй хандах билээ? Тэр үед хүн Түүнийг цаазалж, үхтэл нь тамлахгүй гэж үү? Хэрвээ Түүнийг Христ гэдэггүй байсан бол Тэр хүн төрөлхтний дунд ажиллаж чадахгүй байх байсан; хэрвээ Тэр Бурханы Өөрийн ялгамж чанараар ажиллалгүй, ердөө л хэвийн хүн шиг ажилласан бол хүн Түүний ажлын өчүүхэн хэсгийг тэвчих нь байтугай, айлдсан ганц өгүүлбэрийг нь ч тэвчихгүй байх байсан юм. Иймээс Тэр Өөрийнхөө ажилд энэ ялгамж чанараа л авч явах болдог. Ингэхгүй байсныг бодвол, Түүний ажил ийм маягаар илүү хүчирхэг байдаг, учир нь хүмүүс бүгд зэрэг зиндаа, агуу

ялгамж чанарыг дуулгавартай дагахыг хүсдэг. Хэрвээ Тэр ажиллахдаа, эсвэл Бурхан Өөрөө болон гарч ирэхдээ Бурханы Өөрийн ялгамж чанарыг авч яваагүй бол, ажил хийх боломж Түүнд огт байхгүй байх байв. Түүнд Бурханы мөн чанар, Христийн оршихуй байдаг хэмээх бодит баримтыг үл харгалзан, хүн Түүнд уужуу сэтгэл гаргаж, хүн төрөлхтний дунд санаа амар ажлаа явуулах боломж олгохгүй байх байв. Тэрээр ажилдаа Бурханы ялгамж чанарыг авч явдаг; хэдийгээр ийм ажил нь, тийм ялгамж чанаргүйгээр хийснээс олон арав дахин илүү хүчтэй боловч хүн Түүнд одоо ч бүрэн дуулгавартай байдаггүй, учир нь хүн Түүний мөн чанарт биш, зэрэг зиндаанд нь л захирагддаг. Тэгвэл, нэг л өдөр Христ албан тушаалаасаа буувал ганц өдөр ч гэсэн амьд явах боломжийг хүн Түүнд олгох байсан гэж үү? Өөрийн гараар хийсэн ажлаас нь хожмын он жилүүдэд гарах үр нөлөөг харахын тулд Бурхан хүнтэй хамт газар дээр амьдрахыг хүсдэг. Гэвч хүн Түүний байгааг ганц ч өдөр тэвчиж чадахгүй, иймээс Түүнд болихоос өөр арга байхгүй. Хүмүүсийн дунд хийх ёстой ажлаа хийж, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх боломжийг Бурханд олгосон гэдэг нь хэдийнээ хүний хүлээцтэй байдал, нигүүлслийн хамгийн дээд хязгаар билээ. Түүний биечлэн байлдан дагуулсан хүмүүс Түүнд ийм нигүүлсэл үзүүлдэг хэдий ч, нэг ч хором хэтрүүлэлгүй, ажлаа дуустал үлдэхийг л Түүнд зөвшөөрдөг. Тэгвэл Түүний байлдан дагуулаагүй хүмүүс яах вэ? Тэрээр хэвийн хүний бүрхүүлтэй Христ учраас хүн бие махбодтой болсон Бурханд ийм маягаар ханддаг бус уу? Хэрвээ Түүнд хэвийн хүн чанар бус, бурханлаг чанар л байсан бол, хүний бэрхшээлүүд хамгийн хялбархан шийдвэрлэгдэх байсан бус уу? Мөн чанар нь тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захирагддаг Христийнх яг мөн байлаа ч гэсэн Түүний бурханлаг чанарыг хүн дурамжхан хүлээн зөвшөөрч, эгэл хүний бүрхүүлийг нь огт сонирхдоггүй. Тийм болохоор Тэр баяр баясгалан, уй гашуугийн аль алийг нь хуваалцахаар хүмүүсийн дунд байх ажлаа цуцлахаас өөр аргагүй болсон, учир нь хүн Түүний оршин тогтнолыг цаашид тэвчиж чадахгүй.

ХҮНИЙ ХЭВИЙН АМЬДРАЛЫГ СЭРГЭЭЖ, ТҮҮНИЙГ ГАЙХАЛТАЙ САЙХАН ХҮРЭХ ГАЗАРТ АВААЧИХ НЬ

Хүн өнөөгийн ажил болон ирээдүйн ажлын тухай бага сага ойлгодог боловч хүн төрөлхтний орох хүрэх газрыг ойлгодоггүй. Бүтээл болохынхоо хувьд хүн бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой: Бурхан юу ч хийлээ гэсэн хүн дагах ёстой

ба та нар Миний яв гэсэн замаар явах ёстой. Чамд аливааг өөрөө удирдах ямар ч арга байхгүй бөгөөд чи өөрийгөө хянах чадваргүй; бүгдийг Бурханы эрхшээлд даатгах ёстой бөгөөд бүх зүйл Түүний гарт байдаг. Хэрвээ Бурханы ажил хүнд төгсгөл буюу гайхалтай хүрэх газрыг цагаас нь өмнө өгчихсөн бол, хэрвээ Бурхан үүнийг хүний сэтгэлийг татаж, хүнийг Өөрийнхөө дагагч болгохын тулд ашигласан бол, ингэж Тэрээр хүнтэй наймаацсан бол энэ нь байлдан дагуулалт ч биш, хүний амийн ажил ч биш болох байлаа. Бурхан хүнийг хянаж, зүрх сэтгэлийг нь олж авахын тулд төгсгөлийг ашиглах байсан бол үүгээрээ хүнийг төгс болгохгүй, мөн хүнийг олж авч ч чадахгүй байх байсан, харин ч хүнийг хянахын тулд хүрэх газрыг ашиглаж байгаа явдал болох байв. Хүн ирээдүйн төгсгөл, эцсийн хүрэх газар ба итгэж найдах сайн зүйл байгаа эсэхэд хамгаас их анхаардаг. Хэрвээ байлдан дагуулалтын ажлын явцад хүнд сайхан итгэл найдварыг өгсөн бол, хэрэв хүнийг байлдан дагуулахаасаа өмнө эрэлхийлбэл зохих хүрэх газрыг нь өгсөн бол хүний байлдан дагуулалт амжилттай үр дүнд хүрэхгүйгээр үл барам, байлдан дагуулалтын ажлын үр дүнд ч мөн нөлөөлөх байсан. Өөрөөр хэлбэл, хүний хувь заяа, хэтийн ирээдүйг булаан авч, хүний тэрслүү зан чанарыг шүүж, гэсгээснээр байлдан дагуулалтын ажил амжилттай үр дүнд хүрдэг. Хүнтэй наймаацаж, өөрөөр хэлбэл хүнд ерөөл, нигүүлсэл өглөө гээд үр дүнгүй, харин хүнийг “эрх чөлөө”-нөөс нь салгаж, хэтийн ирээдүйг нь үгүй хийх замаар хүний үнэнч байдлыг илчилснээр үүнд хүрдэг. Энэ нь байлдан дагуулах ажлын мөн чанар юм. Хэрвээ хүнд бүр эхнээс нь сайхан итгэл найдвар өгөөд, гэсгээлт, шүүлтийн ажлыг дараа нь хийсэн бол өөрт нь хэтийн ирээдүй байгаа гэсэн үндсэн дээр хүн энэхүү гэсгээлт, шүүлтийг хүлээн зөвшөөрөх байсан бөгөөд эцэстээ Бүтээгчийг бүх бүтээл нь болзолгүйгээр дуулгавартай дагаж, шүтэн мөргөхгүй байх байсан; хүн зөвхөн харанхуй, мунхгаар дуулгавартай байж, үгүй бол Бурханд сохроор шаардлага тавих байсан, иймээс хүний зүрх сэтгэлийг бүрэн байлдан дагуулах боломжгүй болох байлаа. Үүний үр дүнд, байлдан дагуулалтын энэ ажлаар хүнийг олж авч чадахгүй, цаашлаад Бурханд гэрчлэл хийх боломжгүй болох байлаа. Ийм бүтээлүүд үүргээ биелүүлж чадахгүй, Бурханд нөхцөл болзол л тавих байсан; энэ нь байлдан дагуулалт бус, харин ердөө л өршөөл, ерөөл байх байв. Хувь заяа, хэтийн ирээдүйгээс өөр юу ч бодолгүй, тэдгээрийг тахин шүтдэг нь хүний хамгийн том асуудал юм. Хүн хувь заяа, хэтийн ирээдүйнхээ төлөө Бурханыг эрэлхийлдэг; Бурханд хайртайдаа Түүнийг шүтэн мөргөдөггүй. Иймээс хүнийг байлдан дагуулахдаа, хүний аминч үзэл, шунал болон Бурханыг шүтэн мөргөхөд нь

хамгийн их саад болдог зүйлстэй харьцаж, авч хаяна. Ийнхүү хүний байлдан дагуулалт үр дүнд хүрнэ. Үүний үрээр, хүнийг байлдан дагуулах эхний үе шатанд, хүний жолоогүй хүсэл санаархал болон хамгийн аюултай сул талуудыг арилгаж, үүний дүнд Бурханыг гэх хүний хайрыг илчилж, хүний амьдралын талаарх мэдлэг, Бурханы талаарх үзэл бодол, өөрийнх нь оршин тогтнолын утга учрыг өөрчлөх нь чухал юм. Ийм маягаар Бурханыг гэх хүний хайр цэвэрлэгддэг, өөрөөр хэлбэл, хүний зүрх сэтгэл байлдан дагуулагддаг. Гэвч бүх бүтээлд хандах хандлагадаа Бурхан, байлдан дагуулахын төлөө л байлдан дагуулдаггүй; харин хүнийг олж авахын тулд, Өөрийнхөө алдрын төлөө, мөн хүний хамгийн эртний, анхдагч төрхийг сэргээхийн төлөө байлдан дагуулдаг. Тэр байлдан дагуулахын төлөө л байлдан дагуулдаг байсан бол байлдан дагуулалтын ажлын ач холбогдол алдагдах байлаа. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг байлдан дагуулсныхаа дараа хэрэгсэхгүй орхиж, түүний амьдрал, үхэлд ямар ч анхаарал хандуулдаггүй байсан бол энэ нь хүн төрөлхтнийг удирдаж байгаа хэрэг биш, хүнийг аврахын төлөө байлдан дагуулсан хэрэг ч биш болох байв. Хүнийг байлдан дагуулсныхаа дараа олж авах, мөн хүн эцэстээ гайхалтай хүрэх газарт очих явдалд л авралын ажлын гол цөм оршдог бөгөөд ингэснээр л хүнийг аврах авралын зорилгод хүрч чадна. Өөрөөр хэлбэл, хүн сайхан хүрэх газарт очиж, амралтад орно гэсэн ийм л хэтийн ирээдүй бүх бүтээлд байх ёстой, энэ л Бүтээгчийн хийх ёстой ажил юм. Хэрвээ хүн энэ ажлыг хийсэн бол хэтэрхий хязгаарлагдмал болох байлаа: Энэ нь хүнийг тодорхой цэгт аваачиж болох ч мөнхийн хүрэх газарт нь хүргэж чадахгүй байх байв. Хүний хувь заяаг хүн шийдэж чаддаггүй, цаашлаад хүний хэтийн ирээдүй, хожмын хүрэх газрыг ч баталгаажуулж чадахгүй. Харин Бурханы хийдэг ажил бол өөр. Тэрээр хүнийг бүтээсэн тул хүнийг удирдан чиглүүлдэг; Тэр хүнийг авардаг тул бүрмөсөн аварч, бүрэн дүүрэн олж авна; Тэр хүнийг удирдан чиглүүлдэг тул зүй зохистой хүрэх газарт нь аваачна; Тэр хүнийг бүтээсэн, бас удирддаг тул хувь заяа, хэтийн ирээдүйнх нь тухайд хариуцлага хүлээх ёстой. Бүтээгчийн хийдэг ажил энэ юм. Хүнийг хэтийн ирээдүйгээс нь салгаснаар байлдан дагуулалтын ажил биелдэг хэдий ч эцсийн эцэст хүн Бурханы түүнд зориулж бэлдсэн зүй зохистой хүрэх газарт хүргэгдэх ёстой. Бурхан хүнийг бүтээдэг учраас л хүн хүрэх газартай, хувь заяа нь баталгаатай байдаг билээ. Энд хэлж буй тохиромжтой хүрэх газар гэдэг нь хүний өнгөрсөнд устгагдсан итгэл найдвар, хэтийн ирээдүй биш; энэ хоёр нь ондоо юм. Хүний итгэж найдаж, эрэлхийлдэг зүйл нь хүнд тохирсон хүрэх газар бус, харин махан биеийн хэрээс хэтэрсэн хүслээ гүйцээх

гэсэн эрэл хайгуулаас улбаатай тэмүүлэл юм. Харин Бурханы хүнд бэлдсэн зүйл бол ариун болгуулсан үед нь хүнд ирэх ерөөл, амлалт бөгөөд Бурхан дэлхий ертөнцийг бүтээснийхээ дараа үүнийг хүнд зориулж бэлтгэсэн, энэ нь хүний сонголт, үзэл, төсөөлөл, махан биеэр бохирдоогүй байдаг. Энэхүү хүрэх газрыг тодорхой нэг хүнд зориулж бэлтгээгүй, харин энэ нь бүх хүн төрөлхтний амралтын газар юм. Иймээс энэ хүрэх газар нь хүн төрөлхтөнд хамгийн тохиромжтой хүрэх газар билээ.

Бүтээгч бүх бүтээлийг зохион байгуулахаар зорьдог. Чи Түүний хийж байгаа аливаа зүйлийг хэрэгсэхгүй орхих юм уу дуулгаваргүй байх ёсгүй, Түүнд тэрслүү хандах ч ёсгүй. Хийж буй ажил нь эцэстээ зорилгодоо хүрэх үед Тэр ийнхүү алдрыг олж авна. Өнөөдөр, чамайг Моабын үр удам, агуу улаан лууны үр сад гэж яагаад хэлэхгүй байна вэ? Яагаад сонгогдсон хүмүүсийн талаар ярихгүй, бүтээлийн талаар л ярьдаг юм бэ? Бүтээл гэдэг нь хүний анхдагч цол байсан, мөн энэ нь түүний төрөлхийн ялгамж чанар юм. Эрин үе болон ажлын мөчлөг өөр учраас л өөр өөр нэр байдаг; үнэндээ хүн бол энгийн бүтээл билээ. Хамгийн ялзарсан нь ч бай, хамгийн ариун нь ч бай хамаагүй, бүх бүтээл бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой. Байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэх үедээ Бурхан хэтийн ирээдүй, хувь заяа, хүрэх газрыг чинь ашиглан та нарыг хянадаггүй. Үнэндээ ингэж ажиллах шаардлагагүй. Байлдан дагуулалтын ажлын зорилго нь хүнээр бүтээлийн үүргийг нь гүйцэтгүүлэх, Бүтээгчийг шүтэн мөргүүлэх явдал, үүний дараа л хүн гайхалтай сайхан хүрэх газарт орж чаддаг. Хүний хувь тавилан Бурханы гараар удирдуулдаг. Чи өөрийгөө удирдах чадваргүй: Өөрийнхөө төлөө үргэлж яарч, завгүй байдаг мөртөө хүн өөрийгөө удирдах чадваргүй хэвээр л байдаг. Хэрвээ чи өөрийнхөө хэтийн ирээдүйг мэдэж чадах байсан бол, өөрийнхөө хувь заяаг хянаж чадах байсан бол бүтээл хэвээр байх байсан гэж үү? Товчхондоо гэвэл, Бурхан яаж ч ажилладаг бай, Түүний бүх ажил хүний төлөө байдаг. Жишээлбэл, хүнд үйлчлүүлэхээр Бурханы бүтээсэн тэнгэр, газар, бүх зүйлийг аваад үз: Сар, нар, одыг Тэр хүний төлөө бүтээсэн, амьтан, ургамал, хавар, зун, намар, өвөл гэх зэрэг нь бүгд хүний оршин тогтнолын төлөө бүтээгдсэн байдаг. Иймээс Тэр хүнийг яаж ч гэсгээж, шүүлээ гэсэн, энэ нь бүгд хүний авралын төлөө юм. Тэр хүнийг махан биеийн итгэл найдвараас нь салгадаг хэдий ч энэ нь хүнийг ариусгахын төлөө байдаг бөгөөд хүнийг ариусгадгийн шалтгаан нь түүнийг амьд үлдээхийн төлөө юм. Хүний хувь заяа нь Бүтээгчийн гарт байдаг, иймд хүн өөрийгөө удирдаж яаж чадах юм бэ?

Байлдан дагуулалтын ажил гүйцэлдмэгц хүн үзэсгэлэнтэй сайхан ертөнц

рүү хүргэгдэнэ. Энэ амьдрал нь мэдээж газар дээр үргэлжлэх боловч хүний өнөөдрийн амьдралаас шал өөр байх болно. Энэ нь бүх хүн төрөлхтөн байлдан дагуулагдсаны дараах хүн төрөлхтний амьдрал, хүний газар дээрх шинэ эхлэл байх болно, хүн төрөлхтөн ийм амьдралаар амьдарч байгаа нь шинэ, үзэсгэлэнтэй ертөнцөд орсны баталгаа болно. Энэ нь Бурхан болоод хүний газар дээрх амьдралын эхлэл байх болно. Хүн ариусгагдаж, байлдан дагуулагдсанахаа дараа Бүтээгчийн өмнө захирагдах явдал нь ийм сайхан амьдралын урьдач нөхцөл болох ёстой. Иймээс байлдан дагуулалтын ажил нь хүн төрөлхтөн гайхалтай хүрэх газарт орохын өмнөх, Бурханы ажлын сүүлчийн үе шат юм. Ийм амьдрал нь хүний газар дээрх ирээдүйн амьдрал бөгөөд газар дээрх хамгийн сайхан амьдрал, хүний хүсэмжилдэг төрлийн амьдрал, дэлхийн түүхэнд урьд өмнө нь хүний хэзээ ч хүрч байгаагүй тийм амьдрал билээ. Энэ нь 6,000 жилийн удирдлагын ажлын эцсийн үр дүн, хүн төрөлхтний хамгийн их хүсэн эрмэлздэг зүйл, энэ нь мөн хүнд өгсөн Бурханы амлалт юм. Гэвч энэхүү амлалт нь тэр дороо биелж чаддаггүй: Эцсийн өдрүүдийн ажил дуусаж, хүн бүрэн байлдан дагуулагдсаны дараа, өөрөөр хэлбэл, Сатан бүрмөсөн ялагдсаны дараа л хүн ирээдүйн хүрэх газарт орох болно. Хүн цэвэршүүлэгдсэнийхээ дараа нүгэлт уг чанаргүй байх болно, учир нь Бурхан Сатаныг ялсан байх буюу дайсны хүчний түрэмгийлэл байхгүй болж, хүний махан биед халдаж чадах дайсны хүч үгүй болно гэсэн үг юм. Иймд хүн эрх чөлөөтэй, ариун болно—тэрээр мөнх байдал руу орсон байх болно. Харанхуйн дайсагнасан хүчийг хүлсэн үед л хүн тэрслүү байдал, эсэргүүцэлгүй, хаа ч явсан эрх чөлөөтэй байх болно. Сатан хүлэгдэж байж л хүний бүх зүйл сайн сайхан байх болно; Сатан газар дэлхийн хаа сайгүй төвөг учруулсаар л байгаагаас болж, мөн Бурханы удирдлагын бүхий л ажил хараахан төгсөөгүй байгаа болохоор л одоогийн нөхцөл байдал үүсээд байгаа юм. Сатан ялагдмагц хүн бүрэн чөлөөлөгдөнө; хүн Бурханыг олж авч, Сатаны нөлөөнөөс гарах үедээ зөвт байдлын Нарыг харна. Хэвийн хүнд тохирох амьдрал сэргэнэ; сайн мууг ялган таних чадвар, хэрхэн хооллож, хувцаслах тухай ойлголт болон хэвийн амьдрах чадвар гэх мэт хэвийн хүний эзэмших ёстой бүхэн сэргэнэ. Ева могойд уруу татагдаагүй байсан бол хүн анх бүтээгдсэнийхээ дараа ийм хэвийн амьдралтай байх ёстой байсан. Хүн газар дээр хооллож, хувцаслаж, хэвийн хүний амьдралаар амьдрах ёстой байсан юм. Гэвч хүн доройтолд орсны дараа энэ амьдрал бүтэшгүй мөрөөдөл болсон бөгөөд өнөөдөр ч гэсэн хүн ийм зүйлийг төсөөлж зүрхэлдэггүй. Үнэндээ, хүний хүсэмжилдэг энэхүү сайхан амьдрал нь зайлшгүй хэрэгцээ юм: Хэрвээ хүнд ийм

хүрэх газар байгаагүй бол газар дээрх доройтсон амьдрал нь хэзээ ч дуусахгүй байх байсан, хэрвээ тийм сайхан амьдрал байгаагүй бол Сатаны хувь заяанд, эсвэл газар дээр Сатаны ноёрхдог эрин үед эцэс төгсгөл гэж байхгүй байх байлаа. Харанхуйн хүч хүршгүй ертөнцөд хүн очих ёстой бөгөөд тэр үед Сатан ялагдсан нь батлагдах болно. Ийм маягаар Сатаны тарьдаг үймээн үгүй болмогц Бурхан Өөрөө хүн төрөлхтнийг удирдана, Тэр хүний амьдралыг бүхэлд нь захирч, удирдана; тэр үед л Сатан жинхэнээсээ ялагдсан байх болно. Хүний өнөөдрийн амьдрал нь гол төлөв бохир заваан амьдрал байдаг, энэ нь бас л зовлон зүдүүр, цөхрөлийн амьдрал юм. Үүнийг Сатаны ялагдал гэж нэрлэж болохгүй; хүн цөхрөлийн тэнгисээс, хүний амьдралын бэрхшээл, Сатаны нөлөөллөөс хараахан амь гараагүй байгаа ба Бурханы талаар одоо ч хэтэрхий бага мэдлэгтэй байна. Хүний бүх бэрхшээл Сатанаас үүдэлтэй, Сатан л хүний амьдралд зовлон зүдүүр авчирсан бөгөөд Сатаныг хүлэгдсэний дараа л хүн цөхрөлийн тэнгисээс бүрмөсөн амь гарч чадна. Гэхдээ хүнээр Сатантай хийх тулааны олз омог хийж, хүний зүрх сэтгэлийг байлдан дагуулж, олж авснаар Сатаныг амжилттай хүлдэг.

Өнөөдөр, газар дээр хэвийн хүний амьдралтай болохоосоо өмнө хүн ялагч болж, төгс болгуулахыг эрэлхийлж байдаг бөгөөд Сатаныг хүлэгдэхээс өмнө хүний эрж хайдаг зорилго нь энэ юм. Ялагч болж, төгс болгуулж, их тус хүргэх гэсэн хүний эрэл хайгуул нь мөн чанартаа Сатаны нөлөөнөөс зугтахын төлөө байдаг: Хүний эрэл хайгуул нь ялагч болох явдал боловч эцсийн үр дүнд нь тэр Сатаны нөлөөнөөс мултрах болно. Сатаны нөлөөнөөс мултарснаар л хүн газар дээр Бурханыг шүтэн мөргөдөг, хэвийн хүний амьдралаар амьдарч чадна. Өнөөдөр, ялагч болж, төгс болгуулах гэсэн эрэл хайгуул нь хүний газар дээр хэвийн хүний амьдралтай болохоосоо өмнө эрэлхийлж байдаг зүйлс юм. Үндсэндээ, цэвэрлэгдэж, үнэнийг хэрэгжүүлж, мөн Бүтээгчийг шүтэн мөргөхийн тулд тэдгээрийг эрэлхийлдэг. Хэрвээ хүн газар дээр хэвийн хүний, бэрхшээл, цөхрөлгүй амьдралтай байвал ялагч болох эрэл хайгуул хийхгүй. “Ялагч болох”, “төгс болгуулах” гэдэг нь Бурханы хүнд эрэлхийл гэж өгдөг зорилго бөгөөд эдгээр зорилгын эрэл хайгуулын тусламжтайгаар Тэрээр хүнийг үнэнийг хэрэгжүүлж, утга учиртай амьдралыг амьдран харуулдаг болгодог. Зорилго нь хүнийг бүрэн төгс болгож, олж авах явдал бөгөөд ялагч болох, төгс болгуулах эрэл хайгуул гэдэг бол арга барил төдий юм. Хэрвээ ирээдүйд хүн гайхалтай хүрэх газарт орвол тэнд ялагч болох болон төгс болгуулах тухай огт ярихгүй; тэнд зөвхөн бүтээл бүр үүргээ биелүүлж байх болно. Өнөөдөр, хүнээр эдгээрийг

эрэлхийлүүлж байгаа нь ердөө л хүний эрх хэмжээг тодорхойлохын тулд бөгөөд, ингэснээр хүний эрэл хайгуул нь илүү зорилттой бөгөөд бодитой байж чадах юм. Эс бөгөөс, хүн тодорхойгүй хийсвэр байдалд амьдарсаар, мөнх амьруу орохоор эрэлхийлэх байсан, тэгсэн бол хүн улам ч өрөвдөлтэй байх байсан биш гэж үү? Зорилго ч үгүй, зарчим ч үгүй, ийм маягаар эрэлхийлэх нь өөрийгөө хуурсан хэрэг биш гэж үү? Эцсийн эцэст энэ эрэл хайгуул нь угаасаа үр өгөөжгүй байх байв; эцэст нь хүн Сатаны эзэмшил дор амьдарсаар л, өөрийгөө тэндээс чөлөөлөх чадалгүй байх байв. Яагаад ийм зорилгогүй эрэл хайгуулд өөрийгөө зүтгүүлнэ вэ? Хүн мөнхийн хүрэх газарт орох үедээ Бүтээгчийг шүтэн мөргөнө, хүн аврал олж авч, мөнх байдалд орсон учраас ямар нэг зорилгыг эрэлхийлэхгүй, цаашлаад Сатанд бүслэгдэх вий гэж санаа зовох хэрэггүй болно. Энэ үед хүн байх байраа мэдэж, үүргээ биелүүлэх бөгөөд гэсгээгдэж, шүүгдээгүй байсан ч гэсэн хүн бүр үүргээ биелүүлж байх болно. Тэр үед хүн ялгамж чанар, байр суурийнхаа аль алины хувьд бүтээл байх болно. Дээд, доодын ялгаа гэж цаашид байхаа болино; хүн бүхэн зүгээр л өөр өөр чиг үүрэг гүйцэтгэх болно. Гэсэн ч хүн мөн л дэг журамтай, хүн төрөлхтөнд тохиромжтой хүрэх газарт амьдарч байх болно, хүн Бүтээгчийг шүтэн мөргөхийн төлөө үүргээ биелүүлнэ, тэгээд ийм хүн төрөлхтөн нь үүрд мөнхийн хүн төрөлхтөн болох болно. Тэр үед хүн Бурханы гэрэлтүүлсэн амьдралыг, Бурханы халамж, хамгаалалт доорх амьдралыг, Бурхантай хамт байх амьдралыг олж авсан байх болно. Хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдарч, бүх хүн зөв замд орно. 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөө нь Сатаныг бүрэн дүүрэн ялчихсан байх болно, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийнхөө бүтээл дээр хүний анхдагч дүрийг сэргээсэн байх болно, ингэснээр Бурханы анхдагч санаа зорилго биелсэн байх болно. Анх Сатаныг ялзруулахаас өмнө хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдарч байсан. Дараа нь Сатаныг ялзруулах үед хүн хэвийн амьдралаа алдсан, ийнхүү Бурханы удирдлагын ажил болон хүний хэвийн амьдралыг сэргээхийн төлөө Сатантай хийх тулаан эхэлсэн. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажил төгсгөл болох үед л бүх хүн төрөлхтний амьдрал газар дээр албан ёсоор эхэлнэ, тэр үед л хүн гайхалтай амьдралтай болох ба анх хүнийг бүтээсэн зорилгоо болон хүний анхдагч төрхийг Бурхан сэргээнэ. Иймээс газар дээрх хэвийн хүн төрөлхтний амьдралтай болмогцоо хүн ялагч болох юм уу төгс болгуулахаар эрэлхийлэхгүй, учир нь хүн ариун байх болно. Хүмүүсийн ярьдаг “ялагчид”, “төгс болгуулах” гэдэг нь Бурхан, Сатан хоёрын тулааны үеэр хүнийг эрэлхийл гэж өгсөн зорилго бөгөөд хүн ялзарсан

учраас л тэдгээр нь оршдог. Чамд зорилго өгч, чамайг тэрхүү зорилгыг эрэлхийлэхэд хүргэснээр Сатан ялагдах болно. Ялагч байж, төгс болгуулж, хэрэгтэй хүн байхыг чамаас хүсдэг нь Сатаныг шившиглэхийн тулд гэрчлэл хийхийг чамаас шаардаж байгаа хэрэг юм. Эцэстээ хүн газар дээр хэвийн хүний амьдралаар амьдарч, ариун байх бөгөөд ийм зүйл тохиолдох үед тэд бас л ялагч болохоор эрж хайна гэж үү? Тэд бүгд бүтээл биш гэж үү? Ялагч байх, төгс болгуулсан нэгэн байх тухайд ярихад, эдгээр үг нь Сатан руу болон хүний бохир заваан байдал руу чиглэсэн байдаг. Энэхүү “ялагч” гэдэг нь Сатаныг болон дайсны хүчийг ялахтай холбоогүй гэж үү? Чи өөрийгөө төгс болгуулсан гэж хэлэх үед чиний доторх юу төгс болгуулсан байдаг юм бэ? Чи Бурханыг гэх дээдийн дээд хайранд хүрэхийн тулд ялзарсан сатанлаг зан чанараасаа ангижирсан бус уу? Ийм зүйлсийг хүний доторх бохир заваан зүйлс болон Сатантай холбогдуулан хэлдэг; Бурхантай хамаатуулж хэлдэггүй.

Өнөөдөр чи ялагч болж, төгс болгуулахаар эрэлхийлэхгүй бол ирээдүйд хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдрах үед ийм эрэл хайгуул хийх завшаан гарахгүй. Тэр үед бүх төрлийн хүний төгсгөл илчлэгдсэн байх болно. Тэр үед ямар төрлийн зүйл вэ гэдэг чинь тодорхой болно, тэгээд чи ялагч болох юм уу төгс болгуулахыг хүсвэл тэгэх боломжгүй байх болно. Зөвхөн хүн тэрслүү байдлынхаа төлөө илчлэгдсэнийхээ дараа шийтгэгдэнэ. Тэр үед хүн бусдаасаа дээгүүр байр суурийг эрэлхийлэхгүй, зарим нь ялагч болох, бусад нь төгс болгуулах, өөр зарим нь Бурханы ууган хөвгүүд байх, бусад нь Бурханы хөвгүүд байх зэргээр тэд эрэлхийлэхгүй; эдгээр зүйлийг тэд эрэлхийлэхгүй. Бүгд Бурханы бүтээл байж, бүгд газар дээр амьдарна, тэгээд бүгд газар дээр Бурхантай хамт амьдрах болно. Одоо үе бол Бурхан, Сатан хоёрын тулааны цаг үе, энэхүү тулаан хараахан дуусах болоогүй цаг үе, хүнийг хараахан бүрэн олж аваагүй байгаа цаг үе бөгөөд шилжилтийн үе юм. Иймээс хүнээс ялагч юм уу Бурханы ардын нэг болохоор эрэлхийлэхийг шаарддаг. Өнөөдөр байр сууринд ялгаа байдаг боловч цаг нь ирэхээр ийм ялгаа үгүй болно: Ялалт байгуулсан бүх хүний байр суурь адилхан байх болно, тэд бүгд шаардлага хангасан хүн төрөлхтөн байх бөгөөд газар дээр эрх тэгш амьдарна, өөрөөр хэлбэл, тэд бүгд шаардлага хангасан бүтээл байж, бүгдэд ав адилхан зүйл өгөгдөнө гэсэн үг юм. Бурханы ажлын эрин үеүд өөр өөр, ажлынх нь бай ч бас өөр өөр байдаг учраас хэрвээ энэхүү ажлыг та нар дээр хийсэн бол та нар төгс болгуулж, ялагч болох эрхтэй; хэрвээ хилийн чанадад хийсэн байсан бол тэндхийн хүмүүс байлдан дагуулагдах эхний бүлэг хүмүүс, мөн төгс болгуулах

эхний бүлэг хүмүүс болох эрхтэй байх байсан. Өнөөдөр энэ ажлыг хилийн чанадад хийдэггүй, иймээс тэд төгс болгуулж, ялагчид болох эрхгүй бөгөөд эхний бүлэг хүмүүс болох боломжгүй юм. Бурханы ажлын бай өөр, Бурханы ажлын эрин үе өөр, үүний хамрах хүрээ өөр учраас эхний бүлэг буюу ялагчид гэж байдаг шиг төгс болгуулсан хоёр дахь бүлэг ч бас байх болно. Эхний бүлэг төгс болгуулмагц үлгэр дуурайл, загвар бий болно, ингээд ирээдүйд төгс болгуулах хүмүүсийн хоёр, гурав дахь бүлэг гарах боловч мөнхөд тэд бүгд адилхан байх ба байр суурийн ямар ч ангилал гарахгүй. Тэд ердөө л өөр өөр цаг үед төгс болгуулсан байх бөгөөд байр суурь нь ямар ч ялгаагүй байх болно. Хүн бүхэн бүрэн төгс болгуулж, бүхий л орчлон ертөнцийн ажил дууссан байх цаг ирэх үед байр суурийн ялгаа гэж үгүй байх ба бүгд эрх тэгш байр суурьтай байх болно. Өнөөдөр та нарыг ялагч болгох гэж энэ ажлыг та нарын дунд хийдэг. Хэрвээ үүнийг Британид хийсэн бол та нар эхний бүлэг болгуулахтай адилаар Британи эхний бүлэг болох байсан. Өнөөдөр та нар дээр ажил хийж байгаа нь ердөө нигүүлслээр ерөөж байгаа хэрэг бөгөөд хэрвээ энэ ажлыг та нар дээр хийгээгүй бол та нар хоёр, гурав, дөрөв, тав дахь бүлэг болох байсан. Энэ нь зүгээр л ажлын дэс дараалал дахь ялгаанаас үүдэлтэй; эхний бүлэг, хоёр дахь бүлэг гэдэг нь нэг нь нөгөөгөөсөө дээр, доор байгааг заадаггүй, ердөө л хүмүүсийн төгс болгуулсан дарааллыг заадаг. Өнөөдөр эдгээр үгийг та нарт хэлж байна, гэхдээ яагаад та нарт арай эртхэн мэдэгдээгүй юм бэ? Учир нь, үйл явцгүйгээр хүмүүс туйлшрах хандлагатай байдаг. Жишээлбэл, Есүс тухайн үед: “Би явсан шигээ ирэх болно” гэж хэлсэн. Өнөөдөр олон хүн энэ үгэнд ухаанаа алдаж, цагаан нөмрөг өмсөн, тэнгэр лүү өргөгдөхөө хүлээхийг л хүсдэг. Тиймээс хэтэрхий эрт хэлж болохгүй олон үг байдаг; хэрвээ хэтэрхий эрт хэлчихвэл хүн туйлшрах хандлага гаргана. Хүний биеийн хэмжээ хэтэрхий жижиг бөгөөд эдгээр үгийн бодит үнэнийг нэвт харах чадваргүй байдаг.

Хүн газар дээр жинхэнэ хүний амьдралтай болж, Сатаны бүхий л хүч хүлэгдэх үед тэр газар дээр амар хялбар амьдарна. Аливаа зүйл өнөөдрийнх шигээ ярвигтай байхгүй: Хүний харилцаа, нийгмийн харилцаа, гэр бүлийн төвөгтэй харилцаа—эдгээр нь маш их хүндрэл бэрхшээл, зовлон учруулдаг! Хүний энэ амьдрал үнэхээр золгүй! Хүн байлдан дагуулагдмагц зүрх сэтгэл, оюун санаа нь өөрчлөгдөнө. Тэр Бурханыг хүндэлдэг, Бурханыг хайрладаг зүрх сэтгэлтэй болно. Орчлон ертөнц дээрх Бурханыг хайрлахаар эрж хайдаг бүхэн байлдан дагуулагдмагц, өөрөөр хэлбэл, Сатан ялагдаж, Сатан буюу харанхуйн бүх хүч хүлэгдмэгц газар дээрх хүний амьдрал хүндрэл бэрхшээлгүй болох ба

хүн газар дээр эрх чөлөөтэй амьдарч чадна. Хэрвээ хүний амьдралд махан биеийн харилцаа байдаггүй, махан биеийн ярвигтай байдал байдаггүй байсан бол хамаагүй амар байх байлаа. Хүний махан биеийн харилцаа нь хэтэрхий ярвигтай бөгөөд хүнд тийм зүйлс байгаа нь тэр өөрийгөө Сатаны нөлөөллөөс хараахан чөлөөлөөгүй гэдгийн нотолгоо юм. Хэрвээ чи ах эгч нар болгонтойгоо адилхан харилцаатай, гэр бүлийн гишүүн бүртэйгээ адилхан харилцаатай байсан бол санаа зовних юмгүй, хэний ч талаар сэтгэлээ зовоох хэрэггүй байх байсан. Үүнээс дээр зүйл гэж үгүй ба энэ маягаар хүн зовлон шаналлынхаа хагасыг хөнгөлөх байв. Газар дээр хэвийн хүний амьдралаар амьдарснаар, хүн тэнгэрэлчтэй төстэй байх болно; махан биетэй хэвээр боловч хүн тэнгэрэлчтэй тун адилхан байх болно. Энэ бол сүүлчийн амлалт, хүнд хайрласан эцсийн амлалт юм. Өнөөдөр хүн гэсгээлт, шүүлтийг туулдаг; хүн ийм зүйлсийг туулах нь утга учиргүй гэж чи боддог уу? Гэсгээлт, шүүлтийн ажлыг ямар ч шалтгаангүйгээр хийж болох уу? Хүнийг гэсгээж, шүүнэ гэдэг нь түүнийг ёроолгүй нүхэнд оруулах явдал юм гэж өмнө нь хэлсэн, энэ нь хүний хувь заяа, хэтийн ирээдүйг булаан авна гэсэн утгатай. Энэ нь ганцхан хүнийг цэвэрлэхийн төлөө байдаг. Хүнийг зориудаар ёроолгүй нүхэнд оруулсны дараа Бурхан түүнийг хэрэгсэхгүй орхидог хэрэг биш. Харин ч энэ нь хүний доторх тэрслүү байдалтай харьцахын төлөө байдаг, ингэснээр эцэстээ хүний доторх зүйлс цэвэрлэгдэж, хүн Бурханы тухай жинхэнэ мэдлэгтэй болж, ариун хүн шиг болох болно. Энэ биелбэл бүгд гүйцэлдэх нь тэр. Үнэндээ, хүний доторх харьцах учиртай тэдгээр зүйлтэй харьцаж, хүн цангинасан гэрчлэл хийх үед Сатан ч бас ялагдана, хүний дотор анхнаасаа байдаг тэдгээр зүйл бүрэн цэвэрлэгдээгүй байж болох ч Сатаныг ялагдмагц эдгээр нь цаашид төвөг учруулахгүй ба тэр үед хүн бүрэн цэвэрлэгдсэн байх болно. Хүн хэзээ ч ийм амьдрал туулж байгаагүй, гэхдээ Сатаныг ялагдах үед бүх зүйл зохицуулагдаж, хүний доторх тэдгээр ялихгүй зүйл бүгд шийдэгдэнэ; үндсэн асуудал шийдвэрлэгдмэгц бусад бүх бэрхшээл эцэс болно. Бурхан хүмүүсийн дунд ажлаа өөрийн биеэр хийж буй, газар дээр бие махбодтой болсон энэ хугацаанд Түүний хийж байгаа бүх ажил нь Сатаныг ялахын төлөө байдаг бөгөөд хүнийг байлдан дагуулж, та нарыг бүрэн төгс болгох замаар Тэр Сатаныг ялах болно. Та нар цангинасан гэрчлэл хийх үе ч гэсэн Сатаны ялагдлын тэмдэг байх болно. Сатаныг ялахын тулд хүн эхлээд байлдан дагуулагдаж, эцэстээ бүрмөсөн төгс болгуулдаг. Гэхдээ мөн чанартаа энэ нь Сатаны ялагдлын зэрэгцээ бүх хүн төрөлхтнийг цөхрөлийн энэ хоосон тэнгисээс аварч буй аврал юм. Энэхүү ажил бүхий л орчлон ертөнц

даяар явагддаг уу, Хятадад явагддаг уу гэдгээс үл хамааран бүх ажил нь Сатаныг ялж, бүхий л хүн төрөлхтөнд аврал авчрахын төлөө байдаг бөгөөд ингэснээр хүн амралтын газарт орох боломжтой болно. Бие махбодтой болсон Бурхан буюу энэхүү хэвийн махбод чухамдаа Сатаныг ялахын төлөө оршдог. Бие махбодтой Бурханы ажлыг тэнгэрийн доорх, Бурханыг хайрладаг бүх хүнд аврал авчрахад ашигладаг, энэ нь бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулахын төлөө, цаашлаад Сатаныг ялахын төлөө байдаг. Бурханы бүх удирдлагын ажлын гол цөм нь бүх хүн төрөлхтөнд аврал авчрахын тулд Сатаныг ялахтай салшгүй холбоотой. Яагаад энэ ажлын үеэр ихэнхдээ та нараар гэрчлэл хийлгэх тухай ярьдаг вэ? Энэ гэрчлэл нь хэнд чиглэдэг вэ? Сатан руу чиглэдэггүй гэж үү? Энэ гэрчлэлийг Бурханд хийдэг, Бурханы ажил үр дүндээ хүрсэн гэдгийг гэрчлэхийн тулд хийдэг. Гэрчлэл хийх нь Сатаныг ялах ажилтай холбоотой; Сатантай хийх тулаан гэж байгаагүй бол гэрчлэл хийхийг хүнээс шаардахгүй байх байсан. Хүнийг аврахын зэрэгцээ Сатаныг ялах ёстой учраас Өөрийг нь Сатаны өмнө гэрчлэхийг Бурхан хүнээс шаарддаг, үүнийг хүнийг аварч, Сатантай тулалдахдаа ашигладаг. Үүний үр дүнд, хүн авралын бай, Сатаныг ялах хэрэгслийн аль аль нь болдог, иймээс хүн Бурханы бүхий л удирдлагын ажлын цөм нь байдаг бол Сатан ердөө л дайсан бөгөөд сүйрлийн бай юм. Чамд чи юу ч хийгээгүй мэт санагдаж болох юм, гэхдээ чиний зан чанар дахь өөрчлөлтийн улмаас гэрчлэл бий болсон бөгөөд энэ гэрчлэл нь Сатан руу чиглэдэг ба хүнд зориулагддаггүй. Хүн ийм гэрчлэлийг эдлэхэд тохирохгүй. Бурханы хийсэн ажлыг хүн яаж ойлгож чадах юм бэ? Бурханы тэмцлийн бай нь Сатан; харин хүн бол зөвхөн авралын бай юм. Хүн ялзарсан сатанлаг зан чанартай бөгөөд энэ ажлыг ойлгох чадваргүй. Энэ нь Сатаны завхралаас болдог бөгөөд хүний төрөлх чанар биш, харин үүнийг Сатан чиглүүлдэг. Өнөөдөр Бурханы үндсэн ажил бол Сатаныг ялах, өөрөөр хэлбэл, хүнийг бүрмөсөн байлдан дагуулах явдал, ингэснээр хүн Сатаны өмнө Бурханд эцсийн гэрчлэлийг хийж, ийм маягаар бүх зүйл гүйцэлдэх болно. Олон тохиолдолд, чиний энгийн нүдэнд юу ч хийгдээгүй мэт харагддаг боловч үнэндээ ажил аль хэдийн дууссан. Биелсэн бүх ажил харагдахуйц байхыг хүн шаарддаг, гэсэн ч Би чамд ил болголгүйгээр ажлаа дуусгасан, учир нь Сатан захирагдсан, өөрөөр хэлбэл, Сатан бүрмөсөн ялагдаж, Бурханы бүх мэргэн ухаан, хүч чадал, эрх мэдэл Сатаныг ялсан билээ. Хийгдэх ёстой гэрчлэл нь яг энэ бөгөөд хүн дээр тодорхой илэрдэггүй ч, энгийн нүдээр харагддаггүй ч Сатан аль хэдийн ялагдсан. Энэ ажил бүхэлдээ Сатаны эсрэг чиглэж, Сатантай хийх тулааны

улмаас хэрэгжсэн юм. Иймээс хүний амжилттай болсон гэж хардаггүй олон зүйл байдаг ч Бурханы нүдээр бол аль эрт амжилттайгаар дуусгавар болсон байдаг. Энэ нь Бурханы бүх ажлын дотоод бодит үнэний нэг билээ.

Сатаныг ялагдмагц буюу хүнийг бүрэн байлдан дагуулмагц, энэ бүх ажил нь авралын төлөө гэдгийг, энэхүү авралын арга зам нь Сатаны гараас хүмүүсийг булаан авах явдал гэдгийг хүн ойлгоно. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажил нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шатанд хуваагддаг. Ажлын энэ гурван үе шат нь бүгд хүн төрөлхтний авралын төлөө, өөрөөр хэлбэл, Сатаны асар их ялзруулсан хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг. Гэхдээ бас үүний зэрэгцээ эдгээр нь Бурханы Сатантай хийх тулааны төлөө байдаг. Тиймээс авралын ажил гурван үе шатанд хуваагддагийн адилаар Сатантай хийх тулаан ч мөн гурван үе шатанд хуваагдаж, Бурханы ажлын энэ хоёр тал нэгэн зэрэг явагддаг. Сатантай хийх тулаан нь үнэндээ хүн төрөлхтний авралын төлөө байдаг бөгөөд хүн төрөлхтний авралын ажил нь ганцхан үе шатанд амжилттай дуусгаж болох зүйл биш тул Сатантай хийх тулаан ч гэсэн шатлал, мөчлөгт хуваагдаж, хүний хэрэгцээ, Сатаны ялзруулсан хэмжээний дагуу Сатантай дайн хийгддэг. Хоёр арми хоорондоо тулалддагийн адилаар Бурхан энэ тулаанд Сатаны эсрэг зэвсгээр байлдах болно гэж хүн төсөөлөлдөө боддог байх. Хүний оюун ухаан ингэж л төсөөлөх чадвартай ба туйлын тодорхойгүй, хийсвэр санаа хэдий ч хүн ингэж л итгэдэг. Хүнийг аврах арга зам нь Сатантай хийх тулаанаар дамждаг гэж Намайг энд хэлсэн учраас тулаан ингэж явагддаг гэж хүн төсөөлдөг. Хүний авралын ажилд гурван үе шат байдаг, өөрөөр хэлбэл, Сатантай хийдэг тулаан нь Сатаныг нэгмөсөн ялахын тулд гурван үе шатанд хуваагддаг гэж хэлж болно. Гэвч Сатантай тулалдах бүхий л ажлын дотоод үнэн нь хүнд нигүүлсэл хайрлах, хүний нүглийн тахил болох, хүний нүглийг уучлах, хүнийг байлдан дагуулах, хүнийг төгс болгох гэсэн ажлын хэд хэдэн алхмаар дамжин үр дүнд хүрдэгт оршдог. Үнэндээ Сатантай хийх тулаан нь Сатаны эсрэг зэвсгээр байлдах бус, харин хүний аврал, хүний амийн ажил болон хүний зан чанарыг өөрчилснөөр хүн Бурханд гэрчлэл хийх боломжтой болох явдал юм. Сатан ингэж ялагддаг. Хүний ялзарсан зан чанарыг өөрчлөх замаар Сатаныг ялдаг. Сатан ялагдсан үед буюу хүн бүрэн аврагдсан үед шившиглэгдсэн Сатан бүрэн хүлэгдэх болно, энэ маягаар хүн бүрэн аврагдсан байх болно. Иймээс хүний авралын мөн чанар нь Сатантай хийх тулаан бөгөөд хүний аврал нь үндсэндээ энэ дайны тусгал болдог. Хүнийг байлдан дагуулах эцсийн үе шат нь Сатантай хийх тулааны

сүүлчийн үе шат төдийгүй Сатаны эзэмшлээс хүнийг бүрэн аврах ажил юм. Хүнийг байлдан дагуулахын дотоод утга учир нь, Сатаны биелэл болсон Сатаны ялзруулсан хүн байлдан дагуулагдсанахаа дараа Бүтээгч рүү эргэн очих явдал бөгөөд үүгээр дамжуулан тэр Сатаныг хаяж, Бурхан руу бүрмөсөн буцаж очно. Ийм замаар хүн бүрэн аврагдсан байх болно. Иймээс байлдан дагуулалтын ажил нь Сатаны эсрэг тулааны сүүлчийн ажил бөгөөд Сатаныг ялахын төлөөх Бурханы удирдлагын эцсийн үе шат юм. Энэ ажилгүйгээр хүний бүрэн аврал эцсийн дүндээ боломжгүй болно, Сатаныг бүрэн ялах ч боломжгүй болж, хүн төрөлхтөн хэзээ ч гайхалтай хүрэх газарт орж, Сатаны нөлөөнөөс чөлөөлөгдөж чадахгүй байх байсан юм. Үүний үр дүнд, Сатантай хийх тулаан дуусахаас нааш хүнийг аврах ажил дуусна гэж байхгүй, учир нь Бурханы удирдлагын ажлын цөм нь хүн төрөлхтний авралын төлөө байдаг. Хамгийн эртний хүн төрөлхтөн Бурханы гарт байсан боловч Сатаны уруу таталт, ялзралын улмаас хүн Сатанд хүлэгдэж, ёрын муу нэгний гарт орсон. Тиймээс Бурханы удирдлагын ажлын ялах учиртай бай нь Сатан болсон юм. Сатан хүнийг эрхшээлдээ оруулсан учраас, мөн хүн бол Бурханы бүх удирдлагаа хэрэгжүүлэхдээ ашигладаг хөрөнгө учраас хүнийг аваръя гэвэл түүнийг Сатаны гараас эргүүлээд булаах ёстой, өөрөөр хэлбэл, Сатанд олзлогдсон байсан хүнийг буцаан олж авах ёстой гэсэн үг. Тиймээс, хүний хуучин зан чанарын өөрчлөлт, анхдагч эрүүл ухааныг нь сэргээх өөрчлөлтөөр дамжуулан Сатаныг ялах ёстой. Ийм маягаар, олзлогдсон хүнийг Сатаны гараас эргүүлээд булаан авч болно. Хэрвээ хүнийг Сатаны нөлөө болон хүлээснээс чөлөөлбөл Сатан шившиг болж, эцсийн эцэст хүнийг буцаан олж авч, Сатан ялагдах болно. Сатаны харанхуй нөлөөнөөс чөлөөлөгдсөн учраас хүн энэ бүх тулааны олз омог болж, Сатан нь энэ тулаан дуусмагц шийтгэгдэх бай болно, үүний дараа хүн төрөлхтнийг аврах бүхий л ажил дууссан байх болно.

Бурхан бүтээлүүдэд ямар ч өс санадаггүй ба Сатаныг ялахыг л хүсдэг. Гэсгээлт ч бай, шүүлт ч бай, Түүний бүх ажил Сатан руу чиглэдэг; үүнийг хүн төрөлхтний авралын төлөө хийдэг, энэ нь бүгд Сатаныг ялахын төлөө бөгөөд эцсийг нь үзтэл Сатантай тулалдах гэсэн нэг л зорилготой байдаг! Сатаныг ялж байж л Тэр амрах болно. Бурханы хийдэг бүх ажил Сатан руу чиглэдэг учраас, мөн Сатаны ялзруулсан хүмүүс бүгд Сатаны эзэмшлийн хяналтад, Сатаны эзэмшил дор амьдардаг учраас Сатаны эсрэг тулалдаж, түүнээс ангижрахгүй л бол Сатан энэ хүмүүсийг тавихгүй ба хүмүүс авхуулж чадахгүй байх байсан. Тэд авхуулаагүй бол энэ нь Сатан ялагдаагүй, дийлдээгүй гэдгийг нотлох байсан.

Иймээс Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөнд, эхний үе шатанд нь Тэр хуулийн ажил хийж, хоёр дахь үе шатанд нь Нигүүлслийн эрин үеийн ажил буюу цовдлолын ажил хийж, гурав дахь үе шатанд нь хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажил хийсэн. Энэ бүх ажил нь Сатаны хүн төрөлхтнийг ялзруулсан хэмжээ рүү чиглэдэг, энэ нь бүгд Сатаныг ялахын тулд, үе шат бүр нь Сатаныг ялахын төлөө байдаг. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажлын мөн чанар нь агуу улаан лууны эсрэг тулаан бөгөөд хүн төрөлхтнийг удирдах ажил бол мөн Сатаныг ялах ажил, Сатантай тулаан хийх ажил юм. Бурхан 6,000 жилийн турш тулалдаж, эцэстээ хүнийг шинэ ертөнцөд аваачихын тулд 6,000 жилийн турш ийнхүү ажилласан. Сатан ялагдсан үед хүн бүрэн чөлөөлөгдөнө. Өнөөдрийн Бурханы ажлын чиглэл энэ биш гэж үү? Хүнийг бүрэн чөлөөлж, сулласнаар хүн ямар ч дүрэмд захирагдахгүй, ямар ч хүлээс, хоригт хязгаарлагдахгүй байх явдалд чухамдаа өнөөдрийн ажил чиглэдэг юм. Энэ бүх ажил нь та нарын биеийн хэмжээ болон хэрэгцээний дагуу хийгддэг, өөрөөр хэлбэл, хэрэгжүүлж чадах зүйлийг чинь л та нарт өгдөг. Энэ нь та нарт ямар нэгэн зүйл тулгаж, “хэрээс чинь хэтэрсэн зүйл даалгаж буй” хэрэг биш; харин ч энэ бүх ажил бодит хэрэгцээний чинь дагуу явагддаг. Ажлын үе шат болгон нь хүний бодит хэрэгцээ, шаардлагын дагуу, мөн Сатаныг ялахын төлөө байдаг. Үнэндээ, анх Бүтээгч болон Түүний бүтээлүүдийн хооронд ямар ч саад тотгор байгаагүй. Саад тотгор бүхнийг Сатан учруулсан. Сатаны учруулсан үймээн, ялзралын улмаас хүн юуг ч харж, юунд ч хүрч чадахаа больсон. Хүн бол хохирогч, хууртсан нэгэн билээ. Сатан ялагдмагц бүтээлүүд Бүтээгчийг харна, мөн Бүтээгч бүтээлүүдээ харах ба тэднийг биечлэн удирдаж чадна. Энэ нь л газар дээр хүнд байх ёстой амьдрал юм. Иймээс Бурханы ажил үндсэндээ Сатаныг ялахын төлөө байдаг бөгөөд Сатаныг ялагдмагц бүх зүйл шийдвэрлэгдэх болно. Бурхан хүмүүсийн дунд ирнэ гэдэг нь энгийн нэг хэрэг биш гэдгийг өнөөдөр чи харлаа. Өдөр хоногийг та нараас алдаа зөрчил олоход зориулж, ийм тийм гэж хэлэх гэж, эсвэл зүгээр л Өөрийнхөө ямар харагддаг, мөн яаж хэлж ярьж, ямаршуухан амьдардгийг та нарт харуулах гэж Тэр ирээгүй. Бурхан та нарт Өөрийг нь харах боломж олгох гэж, та нарын нүдийг нээх гэж, эсвэл Өөрийн хэлсэн нууц болон Өөрийн нээсэн долоон лацыг та нарт сонсгох гэж л махбод болоогүй. Харин Тэр Сатаныг ялах гэж махбод болсон. Тэр хүнийг аварч, Сатантай тулалдахын тулд хүмүүсийн дунд махбодтойгоор биечлэн ирсэн бөгөөд Түүний бие махбодтой болдгийн ач холбогдол энэ билээ. Сатаныг ялахын тулд л биш бол энэ ажлыг Тэр биечлэн хийхгүй байх байсан. Бурхан хүмүүсийн дунд ажлаа хийж,

Өөрийгөө хүнд биечлэн илчилж, Өөрийг нь харах боломжийг хүнд олгох гэж газар дээр ирсэн; энэ шалихгүй асуудал гэж үү? Энэ бол үнэхээр энгийн нэг хэрэг биш! Хүний төсөөлдөг шигээр, Бурхан хүнд харагдах гэж, мөн тодорхойгүй, хий хоосон биш, харин бодитой гэдгээ, өндөр дээд атлаа даруу гэдгээ хүнд ойлгуулах гэж ирдэг юм биш. Ийм энгийн байж болно гэж үү? Сатан хүний махан биеийг ялзруулсан учраас, мөн Бурханы аврахаар зорьдог нэгэн нь хүн учраас л чухамдаа Бурхан Сатантай тулалдаж, хүнийг биечлэн хариулахын тулд махбодтой болох ёстой болсон. Энэ нь л Түүний ажилд ашиг тустай юм. Сатаныг ялж, хүнийг илүү сайн аврахын тулд Бурханы хоёр удаа махбод болсон бие оршин байдаг. Учир нь, Бурханы Сүнс байна уу, Бурханы махбод болсон бие байна уу хамаагүй Сатантай тулалддаг нэгэн нь Бурхан л байж чадна. Товчхондоо гэвэл, Сатантай тулалддаг нэгэн нь тэнгэрэлч байж болохгүй, Сатаны ялзруулсан хүн байж бүр ч болохгүй. Тэнгэрэлчүүд үүнийг хийх хүч чадалгүй бол хүн бүр ч хүчин мөхөс. Ийм болохоор, хэрвээ Бурхан хүний амийг боловсруулахыг хүсвэл, мөн хүнийг аврахаар газар дээр биечлэн ирэхийг хүсвэл Өөрийн биеэр махбод болох ёстой, өөрөөр хэлбэл, Тэрээр биечлэн махбодтой болж, төрөлхийн ялгамж чанар, хийх ёстой ажлынхаа хамтаар хүмүүсийн дунд ирж, хүнийг биечлэн аврах ёстой. Ингэлгүй, энэ ажлыг Бурханы Сүнс юм уу хүн хийсэн бол энэ тулаан ямар ч үр дүнд хүрэхгүй, хэзээ ч төгсөхгүй байсан билээ. Сатаны эсрэг дайнд Өөрийн биеэр явахын тулд Бурхан хүмүүсийн дунд махбод болсон үед л хүнд аврагдах боломж гарч ирнэ. Үүнээс гадна, тэр үед л Сатан шившиглэгдэж, завших ямар ч боломж бололцоогүй, хэрэгжүүлэх ямар ч арга мэхгүй үлдэх болно. Бие махбодтой болсон Бурханы хийдэг ажлыг Бурханы Сүнс биелүүлэх аргагүй, махан биетэй аливаа хүн Бурханы өмнөөс хийж бүр ч чаддаггүй, учир нь Түүний хийдэг ажил хүний амийн төлөө, хүний ялзарсан зан чанарыг өөрчлөхийн төлөө байдаг билээ. Хүн энэ тулаанд оролцсон бол зөвхөн хөөрхийлөлтэйгөөр сандран зугтаж, хүний ялзармал зан чанарыг ер өөрчлөх чадваргүй байх байсан юм. Тэр хүнийг загалмайнаас аварч, бүх тэрслүү хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадалгүй, харин зарчмаас хэтэрдэггүй жаахан хуучин ажил эсвэл Сатаныг ялахтай хамаагүй ажил л хийж чадах байсан. Тэгвэл хийж яах юм бэ? Сатаныг ялах нь байтугай хүн төрөлхтнийг ч олж авч чадахгүй ажил ямар ач холбогдолтой юм бэ? Иймээс Сатантай Бурхан Өөрөө л тулалдаж чадах ба хүн үүнийг ердөө хийх чадваргүй юм. Хүний үүрэг бол дуулгавартай байж дагах явдал, учир нь хүн тэнгэр, газрыг бүтээхтэй дүйцэхүйц ажлыг хийх чадваргүй,

түүнчлэн Сатантай тулалдах ажлыг ч хийж чадахгүй. Хүн Бурханы Өөрийн удирдлага дор Бүтээгчийн сэтгэлийг хангалуун байлгаж л чадах ба үүний дүнд Сатан ялагддаг; энэ бол хүний хийж чадах цорын ганц зүйл юм. Иймээс шинэ тулаан эхлэх бүрд, өөрөөр хэлбэл, шинэ эрин үеийн ажил эхлэх бүрд энэ ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийж, үүгээр дамжуулан бүхий л эрин үеийг удирдаж, бүх хүн төрөлхтөнд илүү шинэ замыг нээдэг. Шинэ эрин үе бүрийн үүрийн гэгээ нь Сатантай хийх тулааны шинэ эхлэл юм, үүгээр дамжуулан хүн илүү шинэ, илүү үзэсгэлэнтэй ертөнцөд, Бурхан Өөрөө удирддаг шинэ эрин үед ордог. Хүн бол бүх зүйлийн эзэн боловч авхуулсан хүмүүс нь Сатантай хийсэн бүх тулааны үр жимс болох болно. Сатан бол бүх зүйлийг ялзруулагч, бүх тулааны дараах ялагдагч, мөн эдгээр тулааны дараа шийтгэгдэх нэгэн билээ. Бурхан, хүн, Сатан гурвын дундаас Сатан л жигшигдэн, гологдох нэгэн юм. Сатанаар авхуулсан ч Бурханаар буцаан авхуулаагүй хүмүүс нь харин Сатаны өмнөөс шийтгэл хүртэх хүмүүс болох болно. Энэ гурваас Бурханыг л бүх зүйл шүтэн мөргөх ёстой. Харин Сатаны ялзруулсан боловч Бурханы буцаан олж авсан, Бурханы замыг дагадаг хүмүүс нь Бурханы амлалтыг хүлээн авч, Бурханы төлөө муу хүмүүсийг шүүх хүмүүс болдог. Бурхан гарцаагүй ялж, Сатан лавтай ялагдана, харин хүмүүсийн дунд ялах хүмүүс, ялагдах хүмүүс гэж байх болно. Ялдаг хүмүүс нь ялагчдад харьяалагдаж, ялагддаг хүмүүс нь ялагдагчдад харьяалагдана; энэ бол хүн болгоныг төрлийнх нь дагуу ангилж байгаа явдал бөгөөд энэ нь Бурханы бүх ажлын эцсийн үр дүн. Энэ бол Бурханы бүх ажлын зорилго бөгөөд хэзээ ч өөрчлөгдөхгүй. Бурханы удирдлагын төлөвлөгөөний үндсэн ажлын цөм нь хүний аврал дээр төвлөрдөг ба Бурхан үндсэндээ энэ цөмийн төлөө, энэ ажлын төлөө, Сатаныг ялахын тулд махбод болдог. Бурхан анх удаа махбод болсон нь ч Сатаныг ялахын тулд байсан: Хүн төрөлхтнийг золин аврах ажил болох эхний тулааны ажлыг дуусгахын тулд Тэр биечлэн махбод болж, загалмайд биечлэн цовдлогдсон юм. Үүний адилаар, ажлын энэ үе шатыг ч гэсэн хүмүүсийн дунд ажлаа хийж, үгээ хэлж, Өөрийг нь харах боломжийг хүнд олгохын тулд махбод болсон Бурхан биечлэн хийдэг. Мэдээж Тэр зам зуураа зарим нэг өөр ажлыг хийх нь гарцаагүй боловч Өөрийн ажлыг биечлэн хийдгийн үндсэн шалтгаан нь Сатаныг ялах, хүн төрөлхтнийг байлдан дагуулах, энэ хүмүүсийг олж авахын төлөө байдаг. Иймээс бие махбодтой болсон Бурханы ажил үнэхээр энгийн хэрэг бус. Хэрвээ Түүний зорилго нь, Бурхан бол даруу, нууцлаг, бодитой гэдгийг хүмүүст харуулах л байсан бол, энэ ажлыг хийхийн төлөө л байсан бол махбод болох хэрэг байхгүй байх байлаа. Бурхан махбод болоогүй ч гэсэн,

даруу, нууцлаг, агуу, ариун байдлаа хүнд шууд илчилж чадах байсан, гэхдээ ийм зүйлс нь хүнийг удирдах ажилтай ямар ч хамаагүй. Тэдгээр нь хүнийг аварч, эсвэл бүрэн төгс болгох чадваргүй, Сатаныг ялж бүр ч чадахгүй. Хэрвээ Сатаны ялагдал нь зөвхөн Сүнс сүнснийхээ эсрэг хийх тулаантай л хамааралтай байсан бол, ийм ажлын бодит үнэ цэн бүр ч бага байх байсан; энэ нь хүнийг олж авах чадваргүй байж, хүний хувь заяа, хэтийн ирээдүйг баллах байсан. Иймээс өнөөдрийн Бурханы ажил нь гүн гүнзгий ач холбогдолтой. Энэ нь хүнд зөвхөн Түүнийг харуулж, хүний нүдийг нээж, хүнийг багахан сэтгэл хөдлөл, урам зоригоор хангахын төлөө биш юм; тийм ажил ямар ч ач холбогдолгүй. Хэрвээ чи ийм төрлийн мэдлэгийн талаар л ярьж чаддаг бол бие махбодтой болсон Бурханы жинхэнэ ач холбогдлыг мэддэггүй гэдгийг чинь энэ нь нотолдог.

Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийдэг. Эхний үе шат буюу дэлхий ертөнцийн бүтээлийг Бурхан Өөрөө биечлэн хийсэн бөгөөд хэрвээ тэгээгүй бол хэн ч хүн төрөлхтнийг бүтээж чадахгүй байх байлаа; хоёр дахь үе шат нь бүх хүн төрөлхтнийг золин аврах явдал байсан ба үүнийг ч бас Бурхан Өөрөө биечлэн хийсэн; гурав дахь үе шат бол харваас илэрхий юм: Бурханы бүх ажлын төгсгөлийг Бурхан Өөрөө хийх хэрэгцээ бүр ч их бий. Бүх хүн төрөлхтнийг золин аврах, байлдан дагуулах, олж авах, төгс болгох ажлыг бүгдийг нь Бурхан Өөрөө биечлэн хийдэг. Хэрвээ Тэр энэ ажлыг биечлэн хийгээгүй бол Түүний ялгамж чанарыг хүн төлөөлж чадахгүй, ажлыг нь ч хүн хийж чадахгүй байх байв. Сатаныг ялах, хүн төрөлхтнийг олж авах, хүнд газар дээр хэвийн амьдрал өгөхийн тулд Тэр хүмүүсийг биечлэн удирдаж, хүмүүсийн дунд биечлэн ажилладаг; бүхий л удирдлагын төлөвлөгөөнийхөө төлөө, бүх ажлынхаа төлөө энэ ажлыг Тэр биечлэн хийх ёстой. Бурхан өөрт нь үзэгдэж, өөрийг нь баярлуулах гэж ирсэн гэдэгт л хүн итгэвэл тэрхүү итгэлд ямар ч үнэ цэн, ач холбогдол байхгүй. Хүний ойлголт хэтэрхий өнгөц! Бурхан энэ ажлыг Өөрөө хэрэгжүүлснээр л бүрэн дүүрэн, нэгд нэггүй хийж чаддаг. Хүн үүнийг Бурханы өмнөөс хийх чадваргүй. Түүнд Бурханы ялгамж чанар, эсвэл мөн чанар байхгүй учир Түүний ажлыг хийх чадваргүй, хийлээ ч гэсэн ямар ч үр дүнгүй байх байсан. Бурхан эхний удаад махбод болсон нь золин авралын төлөө, бүх хүн төрөлхтнийг нүглээс золин аврахын төлөө, мөн хүнийг цэвэрлүүлж, нүглээ уучлуулах чадвартай болгохын тулд байсан. Байлдан дагуулах ажлыг ч бас Бурхан хүмүүсийн дунд биечлэн хийдэг. Хэрвээ энэ үе шатанд Бурхан зүгээр л зөгнөл хэлэх байсан бол Түүний оронд эш үзүүлэгч юм уу авьяас билигтэй хүнийг олж болох байв; хэрвээ зөгнөл л хэлэх байсан бол

хүн Бурханыг орлож чадна. Харин хүн Бурханы Өөрийн ажлыг биечлэн хийж, хүний амийг боловсруулахаар оролдсон бол энэ ажлыг хийнэ гэдэг хүний хувьд боломжгүй байх байсан юм. Үүнийг Бурхан Өөрөө биечлэн хийх ёстой: Бурхан энэ ажлыг хийхийн тулд Өөрийн биеэр махбод болох ёстой. Үгийн эрин үед хэрвээ зөгнөл л хэлэх байсан бол, эш үзүүлэгч Исаиа ч юм уу Елиа энэ ажлыг хийж чадах байсан, үүнийг Бурхан Өөрөө биечлэн хийх хэрэггүй байх байлаа. Энэ үе шатанд хийдэг ажил нь ердөө л зөгнөл хэлэх явдал биш учраас, мөн хүнийг байлдан дагуулж, Сатаныг ялахад үгийн ажлыг хэрэглэх нь илүү чухал учраас энэхүү ажлыг хүн хийж чадахгүй, Бурхан Өөрөө биечлэн хийх ёстой. Ехова Хуулийн эрин үед Бурханы ажлын нэг хэсгийг хийгээд, дараа нь эш үзүүлэгчдээр дамжуулан зарим нэг үг хэлж, зарим ажлыг хийсэн. Хүн Еховагийн ажлыг орлож чадах байсан учраас, мөн зөнчид Түүний өмнөөс аливаа зүйлийг зөгнөж, зарим нэг зүүдийг тайлж чадах байсан учраас тэр юм. Эхэнд хийсэн ажил нь хүний зан чанарыг шууд өөрчлөх ажил байгаагүй ба хүний нүгэлтэй хамааралгүй байсан, хүн зөвхөн хуулийг мөрдөх шаардлагатай байсан юм. Иймээс Ехова махбод болж, Өөрийгөө хүнд илчлээгүй; үүний оронд Тэр Мосе болон бусад хүнтэй шууд ярьж, Өөрийнхөө өмнөөс тэднийг яриулж, ажиллуулан, хүн төрөлхтний дунд шууд ажиллахад тэднийг хүргэсэн. Бурханы ажлын эхний үе шат нь хүнийг удирдах явдал байлаа. Энэ нь Сатантай хийх тулааны эхлэл байсан боловч энэхүү тулаан хараахан албан ёсоор эхлээгүй байв. Сатантай хийх албан ёсны тулаан нь Бурханыг анх удаа бие махбодтой болоход эхэлж, өнөөдрийг хүртэл үргэлжилсээр ирсэн. Энэхүү дайны эхний тулаан нь бие махбодтой болсон Бурхан загалмайд цовдлогдох үе юм. Бие махбодтой болсон Бурханы цовдлол нь Сатаныг ялсан ба энэ нь дайны эхний амжилттай үе шат байсан. Бие махбодтой болсон Бурхан хүний амийн төлөө шууд ажиллаж эхэлсэн үе нь хүнийг буцаан олж авах ажлын албан ёсны эхлэл байсан бөгөөд энэ нь хүний хуучин зан чанарыг өөрчлөх ажил байсан учраас Сатантай тулаан хийх ажил байлаа. Эхэндээ Еховагийн хийсэн ажлын үе шат нь газар дээрх хүний амьдралыг удирдах төдий байсан. Энэ нь Бурханы ажлын эхлэл байсан бөгөөд ямар ч тулаан, томоохон ажлыг хараахан агуулаагүй боловч айсуй тулааны суурийг тавихын төлөө байсан юм. Дараа нь Нигүүлслийн эрин үе дэх ажлын хоёр дахь үе шат нь хүний хуучин зан чанарыг өөрчлөх явдлыг хамарч байсан, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө хүний амийг боловсруулсан. Бурхан үүнийг биечлэн хийх ёстой байлаа: Бурхан биечлэн махбод болох шаардлагатай болсон. Хэрвээ Тэр махбод болоогүй бол ажлын

энэ үе шатанд Түүнийг хэн ч орлож чадахгүй байсан, учир нь энэ нь Сатантай шууд тулалдах ажлыг төлөөлж байсан юм. Хэрвээ хүн энэ ажлыг Бурханы өмнөөс хийсэн бол, Сатаны өмнө зогсох үед нь Сатан бууж өгөхгүй бөгөөд түүнийг ялна гэдэг боломжгүй байх байв. Бие махбодтой болсон Бурхан л түүнийг ялахаар ирсэн, учир нь бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь бурханлаг хэвээр байдаг, Тэр хүний амь, Бүтээгч хэвээрээ байгаа; юу ч болсон бай Түүний ялгамж чанар болон мөн чанар өөрчлөгдөхгүй. Иймээс Сатаныг бүрэн буулгаж авахын тулд Тэр махбод болж, ажил хийсэн. Эцсийн өдрүүдийн ажлын үе шатанд хэрвээ хүн энэ ажлыг хийж, шууд үг хэлэх ёстой байсан бол тэр үг хэлж чадахгүй, зөгнөл хэлсэн бол хүнийг байлдан дагуулж чадахгүй байх байлаа. Бурхан махбод болсноор Сатаныг ялж, бүрэн буулгаж авдаг. Тэрээр Сатаныг бүрмөсөн ялж, хүнийг бүрэн байлдан дагуулж, хүнийг бүрэн олж авахад ажлын энэ үе шат дуусаж, амжилтад хүрнэ. Бурханы удирдлагыг хүн орлож чадахгүй. Ялангуяа эрин үеийг чиглүүлж, шинэ ажлыг эхлүүлэх ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийх нь бүр ч хэрэгтэй. Хүнд илчлэл хэлж өгч, зөгнөлөөр хангахыг хүн хийж болно, харин Бурханы биечлэн хийх ёстой ажил буюу Бурхан Сатан хоёрын тулааны ажлыг хүнээр хийлгэж болохгүй. Сатантай хийх тулаан гэж байгаагүй ажлын эхний үе шатанд Ехова эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлийг ашиглан Израилийн ард түмнийг биечлэн удирдсан. Үүний дараа ажлын хоёр дахь үе шат нь Сатантай хийх тулаан байсан ба Бурхан Өөрөө энэ ажлыг хийхийн тулд биечлэн махбод болж, махбодод ирсэн. Сатантай хийх тулаантай хамаатай аливаа зүйл нь бие махбодтой болсон Бурхантай ч бас хамаатай байдаг нь энэ тулааныг хүнээр хийлгэж болохгүй гэсэн үг юм. Хэрвээ хүн тулалдсан бол Сатаныг ялж чадахгүй байх байв. Хүн Сатаны эзэмшил дор байсаар байж яаж түүний эсрэг тэмцэх хүчтэй байх юм бэ? Хүн дунд нь байдаг: Хэрвээ Сатаныг түшвэл чи Сатанд хамаарна, харин Бурханыг хангалуун байлгавал Бурханд хамаарна. Энэ тулааны ажлыг хүн хийхээр оролдож, Бурханыг орлосон бол чадах байсан уу? Хэрвээ тэгсэн бол хүн аль хэдийн мөхөх байсан биш үү? Аль хэдийн газар дор орчихсон байх биш үү? Иймээс хүн Бурханы ажилд Түүнийг орлох чадваргүй, өөрөөр хэлбэл, хүнд Бурханы мөн чанар байдаггүй бөгөөд хэрвээ чи Сатантай тулалдсан бол ялж чадахгүй байх байсан. Хүн зарим нэг ажлыг л хийж чадна; тэр зарим хүнийг өөртөө татаж чадах боловч Бурханы Өөрийн ажилд Бурханыг орлож чадахгүй. Хүн яаж Сатантай тулалдаж чадах юм бэ? Тулалдаж эхлэхээс чинь өмнө Сатан чамайг олзлон авах байсан. Бурхан Өөрөө Сатантай тулалдаж, тэгээд энэ үндсэн дээр

хүн Бурханыг дагаж, Түүнд дуулгавартай байсан цагт л Бурханаар авхуулж, Сатаны хүлээснээс мултарч чадна. Мэргэн ухаан болон чадвараараа хүний хүрч чадах зүйл хэтэрхий хязгаарлагдмал; тэр хүнийг бүрэн төгс болгож, удирдаж, цаашлаад Сатаныг ялж чадахгүй. Хүний оюун билиг, мэргэн ухаан нь Сатаны явуулгыг ялан дийлэх чадваргүй байдаг, иймээс хүн яаж түүнтэй тулалдаж чадах билээ?

Төгс болгуулахыг хүсэж байгаа бүхэнд төгс болгуулах боломж бий, иймээс хүн бүр тайвшрах ёстой: Ирээдүйд та нар бүгд хүрэх газарт орно. Харин чи төгс болгуулах хүсэлгүй, гайхалтай сайхан ертөнцөд орох хүсэлгүй байвал өөрийн чинь л асуудал юм. Төгс болгуулахыг хүсдэг, Бурханд үнэнч, дуулгавартай байж, чиг үүргээ үнэнчээр биелүүлдэг—ийм бүх хүн төгс болгуулж чадна. Өнөөдөр, үүргээ үнэнчээр биелүүлдэггүй, Бурханд үнэнч биш, Бурханд захирагддаггүй, ялангуяа Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авсан боловч үүнийгээ хэрэгжүүлдэггүй—ийм бүх хүн төгс болгуулж чадахгүй. Бурханд үнэнч, дуулгавартай байхыг хүсдэг бүх хүн, жаахан мэдлэггүй байсан хэдий ч төгс болгуулж чадна; эрэлхийлэх хүсэлтэй бүх хүн төгс болгуулж чадна. Үүнд санаа зовох хэрэггүй. Чи энэ чиглэлд эрэлхийлэх хүсэлтэй л байвал төгс болгуулж чадна. Би та нараас хэнийг чинь ч хаяж, таягдахыг хүсдэггүй, гэхдээ хэрвээ хүн амжилт гаргахаар хичээхгүй бол өөрийгөө л сүйтгэж байгаа хэрэг; чамайг таягддаг нь Би биш, харин чи өөрөө юм. Чи өөрөө амжилт гаргая гэж хичээдэггүй, залхуурч үүргээ биелүүлдэггүй, үнэнч биш, үнэнийг эрэлхийлдэггүй, үргэлж хүссэнээрээ хийж, дураараа аашилж, өөрийн алдар хүнд, ашиг хонжооны төлөө тэмцэж, эсрэг хүйстэнтэй харьцахдаа цадиггүй байдаг бол нүглийнхээ ачааг өөрөө үүрэх болно; өөр хэнээр ч өрөвдүүлэх үнэ цэн чамд байхгүй. Миний зорилго бол та бүгдийг төгс болгох, ядаж л байлдан дагуулах явдал, ингэснээр ажлын энэ үе шат амжилттай дуусах боломжтой. Хүн бүрийг төгс болгож, эцэст нь Өөрөө олж авч, бүрэн цэвэрлэж, хайртай хүмүүсээ болгох нь Бурханы хүсэл билээ. Би та нарыг хоцрогдмол гэнэ үү, хэв чанар муутай гэнэ үү хамаагүй, энэ бол бүгд баримт. Миний ингэж хэлдэг нь та нарыг хаях санаатай байгаа, та нарт итгэл алдсан гэдгийг батлахгүй, чамайг аврах хүсэлгүйг минь ч батлахгүй. Өнөөдөр Би та нарыг аврах ажил хийхээр ирсэн, өөрөөр хэлбэл, Миний хийдэг ажил бол авралын ажлын үргэлжлэл юм. Төгс болгуулах боломж хүн бүрд бий: Хүсэж, эрэлхийлж л байгаа тохиолдолд та нар эцэстээ ийм үр дүнд хүрч чадах ба та нараас нэг нь ч хаягдахгүй. Хэрвээ чи дорд хэв чанартай бол, чамд тавих Миний шаардлага

дорд хэв чанарт чинь таарсан байх болно; хэрвээ чи дээд хэв чанартай бол чамд тавих Миний шаардлага дээд хэв чанарт чинь таарсан байх болно; хэрвээ чи мэдлэггүй, бичиг үсэгт тайлагдаагүй бол чамд тавих Миний шаардлага бичиг үсэгт тайлагдаагүй байдалд чинь таарсан байх болно; хэрвээ чи бичиг үсэгт тайлагдсан бол чамд тавих Миний шаардлага бичиг үсэгт тайлагдсан гэх баримтын чинь дагуу байх болно; хэрвээ чи ахимаг настай бол чамд тавих Миний шаардлага насанд чинь таарсан байх болно; хэрвээ чи зочломтгой байх чадвартай бол чамд тавих Миний шаардлага үүнд чинь таарсан байх болно; хэрвээ чи зочломтгой байж чадахгүй, харин сайн мэдээг түгээх, чуулганд үйлчлэх, бусад ерөнхий ажил хэрэгт оролцох зэрэг тодорхой чиг үүрэг л биелүүлж чадна гэвэл чамайг төгс болгох маань гүйцэтгэдэг чиг үүрэгт чинь таарсан байх болно. Үнэнч байж, эцсийг нь хүртэл дуулгавартай дагаж, Бурханыг хайрлах дээдийн дээд хайрыг эрэлхийлнэ гэдэг нь чиний биелүүлэх ёстой зүйл бөгөөд энэ гурван зүйлээс илүү сайн хэрэгжүүлэлт гэж үгүй. Эцсийн эцэст хүн энэ гурван зүйлийг биелүүлэх шаардлагатай ба хэрвээ тэдгээрийг биелүүлж чадвал төгс болгуулна. Гэвч юун түрүүнд чи үнэхээр эрэлхийлэх ёстой, урагш, дээш идэвхийлэн зүтгэх ёстой ба тэр тал дээр идэвхгүй байх ёсгүй. Хүн бүхэн төгс болгуулах боломжтой, мөн төгс болгуулах чадвартай гэж Би хэлсэн, энэ нь үнэн боловч чи эрэл хайгуулдаа сайжрахаар хичээдэггүй. Хэрвээ энэ гурван шалгуурт хүрэхгүй бол чамайг эцэст нь таягдан хаях ёстой. Бүх хүн хөл нийлүүлээсэй, Ариун Сүнсний ажил, гэгээрэлтэй байгаасай, эцсээ хүртэл дуулгавартай байж чаддаг байгаасай гэж Би хүсдэг, учир нь энэ бол та нарын дор бүрнээ биелүүлэх ёстой үүрэг билээ. Та нар бүгд үүргээ биелүүлсэн үедээ төгс болгуулсан байх болно, мөн та нар цангинасан гэрчлэлтэй байх болно. Гэрчлэлтэй бүх хүн нь Сатаныг ялж, Бурханы амлалтыг авсан хүмүүс бөгөөд ирээдүйд гайхалтай хүрэх газарт амьдрахаар үлдэх хүмүүс юм.

БУРХАН ХҮН ХОЁР АМРАЛТАД ХАМТ ОРОХ БОЛНО

Анх Бурхан амарч байсан. Тэр үед газар дэлхий дээр хүмүүс ч, өөр юу ч байгаагүй ба Бурхан ямар ч ажил хийгээгүй байлаа. Хүн төрөлхтөн оршин тогтнож, завхарсан цагаас л Бурхан удирдлагын ажлаа эхэлсэн юм; тэр цагаас хойш Тэр амрахаа болиод, харин оронд нь хүн төрөлхтний дунд завгүй байх болжээ. Хүн төрөлхтний завхралаас болж, мөн тэргүүн тэнгэрэлч тэрсэлснээс болж Бурхан амралтаа алдсан юм. Хэрвээ Бурхан Сатаныг ялж, завхарсан хүн

төрөлхтнийг аврахгүй бол дахин хэзээ ч амралтад орж чадахгүй. Хүнд амралт дутагддаг шиг Бурханд ч бас дутагддаг бөгөөд Бурхан дахин нэг удаа амрах үед хүмүүс ч бас амарна. Амралтад амьдарна гэдэг нь дайн дажингүй, бузар буртаггүй, ямарваа шударга бус байдал үлдээгүй амьдрал гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Сатаны үймээн (энд “Сатан” гэдгээр дайсны хүчийг хэлж байна), Сатаны завхралаас ангид, Бурханы эсрэг ямар нэгэн хүчний халдлагад өртдөггүй амьдрал; бүх зүйл өөрсдийн төрлийг дагаж, бүтээлийн Эзэнд шүтэн мөргөдөг, тэнгэр газар тэр аяараа амар амгалан байдаг амьдрал юм— “хүмүүсийн амар тайван амьдрал” гэдгийн утга учир энэ. Бурхан амрах үед газар дээр зөв шударга бус байдал үргэлжлэн оршихоо болино, мөн дайсны хүчний ямар ч халдлага байхаа больж, хүн төрөлхтөн шинэ ертөнцөд орно— тэд Сатаны завхруулсан хүн төрөлхтөн байхаа болиод, харин Сатанаар завхруулагдсанахаа дараа аврагдсан хүмүүс болно. Хүн төрөлхтний амралтын өдөр ч бас Бурханы амралтын өдөр байх болно. Бурхан анхнаасаа амарч чадаагүйн улмаас биш, харин хүн төрөлхтөн амралтад орох чадваргүйн улмаас Бурхан Өөрийн амралтыг алдсан. Амралтад орно гэдэг нь бүх зүйл хөдлөхөө болих юм уу хөгжихөө болино гэсэн үг биш, Бурхан ажиллахаа больж, хүмүүс амьдрахаа болино гэсэн үг ч биш. Сатан устгагдаж, ёрын муу үйлд нь хамссан хорон санаатнууд шийтгүүлж, газрын хөрснөөс арчигдаж, Бурханд дайсагнагч бүх хүч оршихоо болих үе нь амралтад орохын тэмдэг байх болно. Бурхан амралтад орно гэдэг нь хүн төрөлхтнийг аврах ажлаа хийхээ болино гэсэн үг юм. Хүн төрөлхтөн амралтад орно гэдэг нь бүх хүн Бурханы гэрэл дотор, Түүний ерөөл дор амьдарна, Сатаны завхрал байхгүй, ямар ч зөв шударга бус зүйл тохиолдохгүй гэсэн үг. Хүмүүс Бурханы халамж дор газар дээр хэвийн амьдарна. Бурхан, хүн хоёр хамтдаа амралтад орох нь хүн төрөлхтөн аврагдаж, Сатан устгагдаж, хүмүүст хийх Бурханы ажил бүхэлдээ дууссан гэсэн утгатай. Бурхан хүмүүс дээр үргэлжлүүлэн ажиллахаа болино, хүмүүс Сатаны эзэмшил дор амьдрахаа болино. Иймээс Бурхан завгүй байхаа больж, хүмүүс ч байнга ийш тийш явахаа болино; Бурхан, хүн хоёр нэгэн зэрэг амралтад орно. Бурхан анхдагч байр сууриндаа буцан очиж, хүн бүр тус тусын байрандаа эргэн очно. Бурханы бүхий л удирдлага дуусмагц Бурхан болон хүмүүсийн оршин суух хүрэх газар энэ юм. Бурханд Бурханы хүрэх газар, хүнд хүний хүрэх газар гэж бий. Амрах зуураа Бурхан бүх хүний газар дээрх амьдралыг залж чиглүүлсээр байх болно, Бурханы гэрэлд хүмүүс тэнгэр дэх цор ганц жинхэнэ Бурханд шүтэн мөргөнө. Бурхан хүн төрөлхтний дунд амьдрахаа болино, хүмүүс ч Бурхантай

хамт Бурханы хүрэх газарт амьдарч чадахгүй болно. Бурхан, хүн хоёр нэг ертөнцөд амьдарч чадахгүй; харин хоёулаа тус тусын амьдрах хэв маягтай байдаг. Бурхан бол бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлдэг Нэгэн, харин бүх хүн төрөлхтөн бол Бурханы удирдлагын ажлын биелэл юм. Удирдуулдаг нь хүмүүс бөгөөд мөн чанар нь Бурханыхтай адилгүй. “Амрах” гэдэг нь анхдагч байрандаа буцан очно гэсэн утгатай. Тиймээс Бурхан амралтад орох үедээ Өөрийн анхдагч байранд буцан очдог гэсэн үг юм. Бурхан газар дээр амьдарч, хүмүүсийн баяр баясал, зовлонг хуваалцахаар дунд нь байхаа болино. Хүмүүс амралтад орох гэдэг нь жинхэнэ бүтээл болсон гэсэн утгатай; тэд газар дээрээс Бурханд шүтэн мөргөж, хэвийн хүний амьдралаар амьдарна гэсэн үг. Хүмүүс Бурханд дуулгаваргүй байж, Бурханыг эсэргүүцэхээ болиод, Адам, Евагийн анхдагч амьдралдаа буцна. Амралтад орсны дараах Бурхан ба хүмүүсийн тус тусын амьдрал, хүрэх газар ийм байх болно. Бурхан, Сатан хоёрын дайнд Сатан ялагдах нь зайлшгүй. Ийм маягаар, Бурхан удирдлагын ажлаа дуусгасны дараа амралтад орох болон хүмүүс бүрэн аврагдаж, амралтад орох нь ч бас зайлшгүй чиг хандлага болсон. Хүний амрах газар дэлхий дээр, Бурханы амрах газар тэнгэрт байдаг. Хүмүүс амралтад Бурханд шүтэн мөргөж, газар дэлхий дээр амьдарна, харин Бурхан үлдсэн хүмүүсийг амралтад залж чиглүүлдэг ба тэднийг газар дэлхийгээс бус, тэнгэрээс залж чиглүүлнэ. Бурхан Сүнс хэвээр байна, харин хүн махан бие хэвээр байна. Бурхан, хүн хоёр хоёулаа өөр өөр амрах хэв маягтай. Бурхан амрах зуураа хүмүүсийн дунд ирж, харагдана; харин хүмүүс амарч байхдаа Бурханаар удирдуулан тэнгэрт зочилж, тэнгэрийн амьдралыг эдэлнэ. Бурхан, хүн хоёр амралтад орсны дараа Сатан оршин байхаа болино; үүний адилаар хорон муу хүмүүс ч бас оршин байхаа болино. Бурхан, хүн хоёр амралтад орохоос өмнө газар дээр нэгэнтээ Бурханыг хавчиж байсан хорон муу хүмүүс болон газар дээр Түүнд дуулгаваргүй байсан дайснууд аль хэдийн устгагдсан байх болно; тэднийг эцсийн өдрүүдийн агуу гамшиг устгасан байх болно. Тэр хорон муу хүмүүс үндсээрээ устгагдмагц газар дэлхий Сатаны дарлалыг дахин хэзээ ч амсахгүй. Тэр үед л хүн төрөлхтөн бүрэн аврал хүртэж, Бурханы ажил бүрэн дуусна. Эдгээр нь Бурхан, хүн хоёр амралтад орох урьдчилсан нөхцөл юм.

Бүх зүйлийн төгсгөл ойртоно гэдэг нь Бурханы ажлын төгсгөл, мөн түүнчлэн хүн төрөлхтний хөгжлийн төгсгөлийг илтгэдэг. Энэ нь, Сатаны завхруулсан хүмүүс хөгжлийнхөө эцсийн үе шатанд хүрч, Адам, Евагийн үр удам үржиж дууссан байх болно гэсэн үг юм. Түүнчлэн, Сатаны завхруулсан ийм хүн

төрөлхтөн цааш үргэлжлүүлэн хөгжих боломжгүй болно гэсэн утгатай юм. Анх Адам, Ева хоёр завхралд өртөөгүй байсан, харин Еден цэцэрлэгээс хөөгдсөн Адам, Ева хоёр Сатанаар завхруулагдсан байв. Бурхан, хүн хоёр хамтдаа амралтад орох үед Еден цэцэрлэгээс хөөгдсөн Адам, Ева болон тэдний үр хойч эцэст нь төгсгөлдөө очно. Ирээдүйн хүн төрөлхтөн мөн л Адам, Евагийн үр хойчоос бүрдэх боловч Сатаны эзэмшил дор амьдардаг хүмүүс биш байх болно. Харин ч аврагдаж, ариуссан хүмүүс байх болно. Мөн шүүгдэж, гэсгээгдсэн, ариун хүмүүс байх болно. Энэ хүмүүс нь анх байсан хүн төрөлхтөнтэй адилгүй; тэднийг анхны Адам, Ева хоёроос тэс өөр төрлийн хүмүүс гэж хэлэхэд бараг болно. Энэ хүмүүс нь Сатаны завхруулсан бүх хүний дундаас сонгогдсон байх бөгөөд эцэстээ Бурханы шүүлт, гэсгээлтийн үеэр бат зогссон хүмүүс байх болно; тэд завхарсан хүн төрөлхтнөөс үлдсэн сүүлчийн бүлэг хүмүүс байх болно. Энэ хүмүүс л Бурхантай хамт эцсийн амралтад орж чадна. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, гэсгээлтийн ажил буюу ариусгалтын эцсийн ажлын үеэр бат зогсож чаддаг хүмүүс Бурхантай хамт эцсийн амралтад орох хүмүүс байх болно; иймээс амралтад ордог хүмүүс бүгд эцсийн ариусгалтын ажлыг туулсныхаа дараа Сатаны нөлөөнөөс ангижирч, Бурханаар авхуулсан байх болно. Эцэст нь Бурханаар авхуулсан энэ хүмүүс эцсийн амралтад орно. Бурханы гэсгээлт, шүүлтийн ажлын мөн чанар нь хүн төрөлхтнийг ариусгаж, эцсийн амралтад нь тэднийг бэлдэхийн төлөө байдаг; тэгж цэвэрлэхгүй бол хүн төрөлхтнөөс нэг нь ч төрлийнхөө дагуу ангилагдаж, амралтад орж чадахгүй. Энэ ажил бол хүн төрөлхтөн амралтад орох цорын ганц зам билээ. Бурханы ариусгалтын ажил л хүмүүсийн зөв шударга бус байдлыг цэвэрлэх ба Түүний гэсгээлт, шүүлтийн ажил л хүн төрөлхтний дуулгаваргүй элементийг ил болгож, улмаар аврагдаж чадах хүмүүсийг чадахгүйгээс нь, үлдэх хүмүүсийг үлдэхгүй хүмүүсээс нь ялгана. Энэ ажил дуусахад үлдэх боломжтой хүмүүс бүгд цэвэрлэгдэж, илүү гайхалтай хоёр дахь амьдралыг эдлэхээр хүн төрөлхтний илүү өндөр байр байдалд орно; өөрөөр хэлбэл, тэд хүний амралтын өдрийг эхлүүлж, Бурхантай зэрэгцэн оршино. Үлдэх боломжгүй хүмүүс гэсгээгдэж, шүүгдсэний дараа жинхэнэ төрх нь бүрмөсөн илчлэгдээд, дараа нь тэд бүгд устгагдаж, Сатаны нэгэн адилаар газар дэлхий дээр амьд үлдэх боломжгүй болно. Ирээдүйн хүн төрөлхтөн дунд ийм төрлийн хүмүүс байхгүй; ийм хүмүүс нь шийтгэлийн бай бөгөөд хорон муу, зөв шударга бус хүмүүс учир эцсийн амралтын газарт ороход тохирохгүй, Бурхан хүн хоёрын хуваалцах амралтын өдөрт ороход ч тэнцэхгүй. Тэд нэгэнтээ золин аврагдсан,

бас шүүгдэн гэсгээгдсэн; тэд бас нэгэнтээ Бурханд үйлчлэл үзүүлсэн. Гэвч, сүүлчийн өдөр ирэхэд хорон муу байдлынхаа улмаас, дуулгаваргүй байдал болон золин аврагдах боломжгүй байдлынхаа улмаас тэд мөн л таягдуулж, устгагдана; хожмын ертөнцөд тэд хэзээ ч оршин тогтнохгүй, мөн ирээдүйн хүн төрөлхтний дунд цаашид амьдрахгүй. Хүн төрөлхтний дундах ариун хүмүүс амралтад ормогц сүнс ч бай, махан биед амьдарсаар байгаа хүмүүс ч бай хамаагүй, мууг үйлдэгчид болон аврагдаагүй хүмүүс бүгд устгагдана. Мууг үйлдэгч энэ сүнснүүд болон хүмүүс, зөв шударга хүмүүсийн сүнс болон зөв шударгыг үйлдэгч хүмүүсийн тухайд гэвэл, ямар эринд байгаагаас үл хамааран мууг үйлдэгчид эцэстээ бүгд устгагдаж, зөв шударга бүх хүн амьд үлдэнэ. Хүн, эсвэл сүнс аврал хүртэх эсэх нь тэр чигтээ сүүлийн эрин үеийн ажилд үндэслэн шийдэгддэггүй; харин тэд Бурханыг эсэргүүцсэн үү, дуулгаваргүй байсан уу гэдэгт үндэслэн тодорхойлогддог. Өмнөх эринд мууг үйлдээд, аврал хүртэж чадаагүй хүмүүс эргэлзээгүй шийтгэлийн бай болох бөгөөд одоогийн эринд мууг үйлддэг, аврагдаж чадахгүй хүмүүс ч бас шийтгэлийн бай болох нь гарцаагүй. Хүмүүсийг амьдардаг эринийх нь дагуу биш, харин сайн муугийн үндсэн дээр ангилдаг. Ийнхүү ангилмагцаа тэднийг тэр даруй шийтгэж, шагнадаггүй; харин Бурхан эцсийн өдрүүд дэх байлдан дагуулалтын ажлаа хийж дууссанахаа дараа л мууг шийтгэх, сайныг шагнах ажлаа гүйцэтгэнэ. Үнэндээ Тэрээр хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг гүйцэтгэж эхэлснээсээ хойш хүмүүсийг сайн муугаар нь ангилсаар ирсэн. Гэхдээ Өөрийнх нь ажил дууссаны дараа л Тэрээр зөв шударга хүмүүсийг шагнаж, хорон мууг шийтгэнэ; ажлаа дуусгаад Тэр тэднийг ангилж, дараа нь мууг шийтгэж, сайныг шагнах ажлаа нэн даруй эхэлдэг юм биш. Мууг шийтгэж, сайныг шагнах Бурханы эцсийн ажлын ар дахь бүхий л зорилго нь бүх хүнийг бүрмөсөн ариусгах явдал юм, ингэснээр Тэр цэвэр ариун хүн төрөлхтнийг мөнхийн амралтад аваачиж болох юм. Түүний ажлын энэ үе шат хамгийн чухал; энэ нь Түүний бүхий л удирдлагын ажлын сүүлчийн үе шат билээ. Хэрвээ Бурхан хорон мууг устгалгүй үлдээсэн бол бүх хүн амралтад орж чадахгүй хэвээр байх байсан бөгөөд Бурхан бүх хүн төрөлхтнийг илүү сайхан ертөнцөд аваачиж чадахгүй байх байлаа. Ийм ажил нь бүрэн гүйцэд биш юм. Бурханы ажил дуусах үед бүх хүн төрөлхтөн бүхэлдээ ариун болно; ийм маягаар л Бурхан амралтад санаа амар амьдарч чадна.

Өнөө үед хүмүүс махан биеийн зүйлсээс салж чадахгүй хэвээр байна; тэд махан биеийн таашаал, дэлхий ертөнц, мөнгө хөрөнгө, завхарсан зан чанараа орхиж чаддаггүй. Ихэнх хүмүүс эрэл хайгуулаа хааш яаш байдлаар явуулдаг.

Үнэндээ энэ хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан огт байдаггүй; тэр ч бүү хэл тэд Бурханаас айдаггүй. Зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй учир тэд Бурханы хийдэг бүхнийг ойлгож чаддаггүй ба Түүний айлддаг үгэнд итгэж бүр ч чаддаггүй. Ийм хүмүүс хэтэрхий махан биеийнх; хэтэрхий гүн завхарсан, ямар ч үнэнгүй байдаг. Тэр ч бүү хэл, Бурхан махбод болж чадна гэдэгт итгэдэггүй. Бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй—өөрөөр хэлбэл, нүдэнд үзэгддэг Бурханд юм уу Түүний үг, ажилд итгэдэггүй, харин тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд шүтэн мөргөдөг хэн боловч зүрх сэтгэлдээ Бурхангүй хүн юм. Ийм хүмүүс тэрслүү агаад Бурханыг эсэргүүцдэг. Тэдэнд хүн чанар, эрүүл ухаан дутагддаг, үнэний тухайд бол ярихын ч хэрэггүй. Түүнчлэн, энэ хүмүүсийн хувьд, нүдэнд үзэгдэж, гарт баригддаг Бурханд тэр тусмаа итгэж болохгүй мөртөө үл үзэгдэх, биет бус Бурханыг хамгийн үнэмшилтэй, хамгийн бахдалтай гэж үздэг. Тэдний эрж хайдаг зүйл нь бодит үнэн биш, амьдралын жинхэнэ мөн чанар ч биш; Бурханы хүсэл бүр ч биш юм. Харин ч тэд сэтгэл хөөрлийг эрэлхийлдэг. Тэдний хүслийг хамгийн сайн биелүүлж чадах зүйлс нь эргэлзээгүй тэдний итгэдэг, тэдний эрэлхийлдэг зүйл юм. Тэд үнэнийг эрж хайхын төлөө биш, өөрсдийнхөө хүслийг хангахын төлөө л Бурханд итгэдэг. Ийм хүмүүс мууг үйлдэгчид биш гэж үү? Тэд өөрсдөдөө туйлын итгэлтэй байдаг бөгөөд өөрсөд шиг нь ийм “сайн хүмүүсийг” тэнгэр дэх Бурхан устгана гэдэгт огтхон ч итгэдэггүй. Харин ч тэд Бурханы төлөө олон зүйл хийж, Түүнд ихээхэн “үнэнч” гэдгээ харуулсан учир Бурхан өөрсдийг нь үлдээгээд зогсохгүй, өгөөмрөөр шагнана гэдэгт итгэдэг. Хэрвээ тэд бас нүдэнд үзэгдэх Бурханыг эрэлхийлсэн бол өөрсдийнх нь хүсэл биелэхээ больмогц тэр дор нь Бурханы эсрэг хариу довтолж, уур хилэнд автах байлаа. Тэд өөрсдийнхөө хүслийг л хангахаар эрэлхийлдэг булай хүмүүс гэдгээ харуулдаг; тэд үнэнийг эрэлхийлж буй ёс жудагтай хүмүүс биш. Ийм хүмүүс бол Христийг дагадаг хорон санаатнууд гээч юм. Үнэнийг эрж хайдаггүй тэр хүмүүс үнэнд итгэж чаддаггүй ба хүн төрөлхтний ирээдүйн төгсгөлийг ухамсарлаж бүр ч чаддаггүй, учир нь тэд нүдэнд үзэгддэг Бурханы ямар ч үг, ажилд итгэдэггүй—хүмүүсийн хожмын хүрэх газарт итгэж чаддаггүй байх ч үүнд багтана. Тиймээс тэд нүдэнд үзэгдэх Бурханыг дагаж байсан ч гэсэн ёрын мууг үйлдсээр байдаг бөгөөд үнэнийг огт эрж хайдаггүй, Миний шаарддаг үнэнийг ч хэрэгжүүлдэггүй. Устгагдана гэдэгтээ итгэдэггүй энэ хүмүүс харин ч эсрэгээрээ яг устгагдах хүмүүс юм. Тэд маш ухаалаг гэдэгтээ итгэдэг бөгөөд өөрсдийгөө үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс гэж боддог. Тэд ёрын муу үйлдлээ үнэн гэж үздэг, тиймээс үүнийгээ нандигнадаг. Ийм хорон муу хүмүүс өөрсдөдөө маш итгэлтэй байдаг;

тэд үнэнийг хоосон сургаал гэж үзэн, ёрын муу үйлдлүүдээ үнэн гэж үздэг ч эцэстээ юу тарина, түүнийгээ л хураана. Хүмүүс өөртөө илүү итгэлтэй, асар биеэ тоосон байх тусмаа үнэнийг олж авч чаддаггүй; тэнгэр дэх Бурханд итгэх тусмаа Бурханыг улам их эсэргүүцдэг. Энэ хүмүүс бол шийтгэгдэх хүмүүс юм. Хүн төрөлхтөн амралтад орохоос өмнө төрөл бүрийн хүн шийтгэгдэх үү, шагнагдах уу гэдэг нь үнэнийг эрж хайсан эсэх, Бурханыг мэддэг эсэх, нүдэнд үзэгддэг Бурханд дуулгавартай байж чаддаг эсэхээр тодорхойлогдоно. Нүдэнд үзэгддэг Бурханд үйлчлэл үзүүлсэн боловч Түүнийг мэддэггүй, дуулгавартай дагадаггүй хүмүүст үнэн байдаггүй. Энэ хүмүүс бол мууг үйлдэгчид бөгөөд мууг үйлдэгчид гарцаагүй шийтгэлийн бай болно; түүнчлэн тэд хорон муу үйлдлийнхээ дагуу шийтгүүлнэ. Хүмүүс Бурханд итгэж, бас Түүнд дуулгавартай байвал зохино. Тодорхойгүй, үл үзэгдэх Бурханд л итгэдэг хүмүүс бол Бурханд итгэдэггүй, Бурханд захирагдаж чаддаггүй хүмүүс юм. Хэрвээ энэ хүмүүс, Бурханы байлдан дагуулалтын ажил дуусах үед нүдэнд үзэгддэг Бурханд мөн л итгэж чадахгүй, махбодоор үзэгддэг Бурханд дуулгаваргүй байж, эсэргүүцсээр байх юм бол энэ “тодорхойгүй үзэлтнүүд” эргэлзээгүй сүйрлийн бай болно. Та нарын дунд буй хүмүүсийн хувьд ч адилхан—бие махбодтой болсон Бурханыг үгээрээ хүлээн зөвшөөрдөг ч бие махбодтой болсон Бурханд дуулгавартай байх тухай үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй хэн боловч эцэстээ таягдан хаягдаж, устгагдах бай болно. Түүнчлэн, нүдэнд үзэгддэг Бурханыг үгээрээ хүлээн зөвшөөрч, Түүний илэрхийлсэн үнэнийг идэж, уудаг мөртөө тодорхойгүй, үл үзэгдэх Бурханыг ч бас эрж хайдаг хүмүүс ирээдүйд устгагдах бүр ч магадлалтай. Энэ хүмүүсийн аль нь ч Бурханы ажил дууссаны дараа амралтын цаг үе ирэх хүртэл үлдэж чадахгүй, мөн амралтын цаг үед ийм хүмүүстэй адил төстэй ганц ч хүн үлдэж чадахгүй. Чөтгөрлөг хүмүүс бол үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс юм; Бурханыг эсэргүүцэж, дуулгаваргүй байх нь тэдний мөн чанар бөгөөд Бурханд захирагдах санаа зорилго тэдэнд өчүүхэн төдий ч байдаггүй. Ийм хүмүүс бүгд устгагдана. Чамд үнэн байгаа эсэх, чи Бурханыг эсэргүүцдэг эсэх нь чиний харагдах байдал, хааяа яаж ярьж, яаж биеэ авч явдгаас биш, харин мөн чанараас чинь хамаардаг. Хүн устгагдах уу, үгүй юу гэдэг нь мөн чанараар нь тодорхойлогддог; энэ нь хүний зан авир, үнэний эрэл хайгуулаар илчлэгддэг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддог. Ажлыг нэг нэгэнтэйгээ ижилхэн хийдэг, ижил хэмжээний ажил хийдэг хүмүүсийн дундаас мөн чанар нь сайн, үнэнийг эзэмшдэг хүмүүс үлдэнэ, харин мөн чанар нь ёрын муу агаад нүдэнд үзэгдэх Бурханыг дуулгавартай дагадаггүй хүмүүс сүйрлийн

бай болно. Хүн төрөлхтний хүрэх газартай хамаатай Бурханы бүх ажил юм уу үг нь хүн бүрийн мөн чанарын дагуу, хүмүүстэй зүй зохистойгоор харьцана; өчүүхэн ч эндүүрэл тохиолдохгүй, мөн ганц ч алдаа мадаг гарахгүй. Хүмүүс ажил хийх үед л хүний сэтгэл хөдлөл, санаа зорилго үүнд холилддог. Бурханы хийдэг ажил хамгийн зохистой; Тэрээр аливаа бүтээлийг огтхон ч хилсээр буруутгадаггүй. Хүн төрөлхтний ирээдүйн хүрэх газрыг ухамсарлаж чаддаггүй, Миний айлддаг үгэнд итгэдэггүй хүмүүс одоо олон бий. Итгэдэггүй, мөн үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс бүгд чөтгөрүүд юм!

Одоо, эрж хайдаг ба эрж хайдаггүй хүмүүс нь хоёр өөр төрлийн хүмүүс бөгөөд хүрэх газар нь ч бас маш өөр байдаг. Үнэний мэдлэгийг эрэлхийлж, үнэнийг хэрэгжүүлэгчид бол Бурханы аврах хүмүүс юм. Үнэн замыг мэддэггүй хүмүүс бол чөтгөрүүд, дайснууд; тэд бол тэргүүн тэнгэрэлчийн үр удам бөгөөд сүйрлийн бай болох болно. Тодорхойгүй Бурханд сүсэглэн итгэгчид ч гэсэн чөтгөрүүд биш үү? Мөс чанар сайтай боловч үнэн замыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс бол чөтгөрүүд юм; Бурханыг эсэргүүцэх нь тэдний мөн чанар. Үнэн замыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс бөгөөд ийм хүмүүс олон зовлон бэрхшээл тууллаа ч гэсэн мөн л устгагдана. Дэлхий ертөнцийг орхих хүсэлгүй, эцэг эхээсээ салж тэвчдэггүй, махан биеийн зугаа цэнгэлээсээ ангижирч чаддаггүй хүмүүс бүгд Бурханд дуулгаваргүй байдаг бөгөөд бүгдээрээ сүйрлийн бай болно. Бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй хэн боловч чөтгөрлөг байдгаас гадна тэд устгагдах болно. Итгэдэг боловч үнэнийг хэрэгжүүлдэггүй, бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй, Бурханы оршин тогтнолд огт итгэдэггүй хүмүүс ч бас сүйрлийн бай болно. Үлдэх хүмүүс бол цэвэршүүлэлтийн зовлонг туулж, бат зогссон хүмүүс юм; тэд бол шалгалтыг үнэхээр даван туулсан хүмүүс билээ. Бурханыг таньдаггүй хэн боловч дайсан; өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханыг таньдаггүй хэн боловч—энэ урсгалын гадна ч бай, дотор ч бай хамаагүй—антихрист юм! Бурханд итгэдэггүй эсэргүүцэгчдээс өөр хэн Сатан, чөтгөрүүд, Бурханы дайснууд байх юм бэ? Тэд Бурханд дуулгаваргүй хүмүүс биш гэж үү? Тэд итгэлтэй гэж хэлдэг мөртөө үнэнгүй хүмүүс биш гэж үү? Тэд Бурханд гэрчлэл хийж чадахгүй атлаа ерөөл олж авахаар л эрэлхийлдэг хүмүүс биш гэж үү? Чи өнөөдөр тэр чөтгөрүүдтэй нийлж, тэдэнд мөс чанар, хайраар хандсаар байгаа, гэхдээ энэ тохиолдолд чи Сатанд сайхан сэтгэл гаргаж байгаа бус уу? Чөтгөрүүдтэй холбогдож байгаа бус уу? Хүмүүс өнөө үед сайн, мууг ялган салгаж чадахгүй хэвээр, Бурханы хүслийг эрж хайх ямар ч санаа зорилгогүйгээр

сохроор хайрлаж, өршөөсөөр байж, Бурханы санаа зорилгыг ямар нэгэн байдлаар өөрсдийн болгож чадахгүй бол тэдний төгсгөл бүр ч золгүй байх болно. Махбод дахь Бурханд итгэдэггүй хэн боловч Бурханы дайсан юм. Дайсанд хайр, мөс чанар харуулж чаддаг бол чи зөв шударга байдлын мэдрэмжгүй байгаа бус уу? Миний жигшиж, санал зөрөлддөг хүмүүстэй нийцтэй байж, тэднийг гэх хайр, хувийн сэтгэл хөдлөлөө харуулсаар байгаа бол чи дуулгаваргүй байгаа бус уу? Чи Бурханыг зориуд эсэргүүцэж байгаа бус уу? Ийм хүнд үнэн байдаг гэж үү? Хүмүүс дайснууддаа мөс чанар гаргаж, чөтгөрүүдийг хайрлаж, Сатаныг өршөөдөг бол Бурханы ажилд санаатайгаар саад хийж байгаа хэрэг бус уу? Зөвхөн Есүст л итгээд, эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй хүмүүс, түүнчлэн бие махбодтой болсон Бурханд итгэдэг гэж амаараа хэлдэг ч мууг үйлддэг хүмүүс бүгд антихристүүд бөгөөд Бурханд ч итгэдэггүй хүмүүсийг бүр дурдахын ч хэрэггүй. Энэ хүмүүс бүгд сүйрлийн бай болно. Бусдыгаа үнэлж шүүдэг хүмүүсийн стандарт зан авирт нь үндэслэдэг; үйлдэл нь сайн бол зөв шударга хүн, харин үйлдэл нь жигшүүртэй бол хорон муу хүн байдаг. Хүмүүсийг үнэлж шүүдэг Бурханы стандарт бол тэдний мөн чанар Өөрт нь дуулгавартай байгаа эсэхэд үндэслэдэг; уг хүний зан авир сайн, муу эсэх, үг яриа нь зөв буруу эсэхээс үл хамааран Бурханд дуулгавартай хүн бол зөв шударга хүн, харин дуулгаваргүй хүн бол дайсан, хорон муу хүн юм. Зарим хүн ирээдүйд сайхан хүрэх газар олж авахын тулд сайн үйл хэрэг ашиглахыг хүсдэг, зарим хүн сайн хүрэх газартай болохын тулд сайхан үг яриа ашиглахыг хүсдэг. Бурхан зан авирыг нь харж, үг яриаг нь сонссоныхоо дараа хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог гэж хүн бүр эндүүрэн итгэдэг; тиймээс олон хүн үүнийг далимдуулан Бурханыг мэхэлж түр зуурын ивээл олж авахыг хүсдэг. Ирээдүйд, амралтын байдалд амьд үлдэх хүмүүс бүгд гай зовлонгийн өдрийг туулж, бас Бурханд гэрчлэл хийсэн байх болно; тэд бүгд үүргээ биелүүлсэн, Бурханд зориуд захирагдсан хүмүүс байх болно. Үнэнийг хэрэгжүүлэхээс зайлсхийх зорилгоор үйлчлэл үзүүлэх боломжийг ашиглахыг хүсдэг хүмүүс үлдэж чадахгүй. Хүн нэг бүрийн төгсгөлийг зохицуулах зүй зохистой стандарт Бурханд бий; Тэрээр хүний үг, үйлдэлд үндэслэн эдгээр шийдвэрийг гаргадаггүй, бас нэгэн үед гаргасан зан авирынх нь дагуу ч шийддэггүй. Урьд нь Өөрт нь үйлчилснээс болоод Бурхан хүний хорон муу үйлдэлд яавч өршөөнгүй хандахгүй, мөн Бурханы төлөө нэг удаа зарлагадсанаас нь болоод хүнийг үхлээс хэлтрүүлэхгүй. Хорон муу байдлынхаа төлөө цээрлэл хүлээхээс хэн ч зайлж чадахгүй ба хэн ч ёрын муу үйлдлээ нууж,

улмаар сүйрлийн тарчлаанаас зугтаж чадахгүй. Хэрвээ хүмүүс өөрсдийнхөө үүргийг үнэхээр биелүүлж чаддаг бол, ерөөл хүртэх, золгүй явдал туулахаас үл хамааран Бурханд мөнхөд үнэнч байж, шагналын араас хөөцөлддөггүй гэсэн үг юм. Хүмүүс ерөөл харах үедээ Бурханд үнэнч байдаг ч ямар нэгэн ерөөл харж чадахгүй үедээ үнэнч байдлаа алдаж, эцэстээ Бурханд гэрчлэл хийж мөн л чаддаггүй, оногдсон үүргээ биелүүлж чаддаггүй бол Бурханд урьд нь нэгэнтээ үнэнчээр үйлчлэл үзүүлсэн байлаа ч гэсэн тэд сүйрлийн бай хэвээр байна. Товчхондоо бол хорон муу хүмүүс мөнхөд амьд үлдэж чадахгүй, амралтад ч орж чадахгүй; зөв шударга хүмүүс л амралтын эзэд юм. Хүн төрөлхтөн зөв замд ормогц хүмүүс хэвийн хүний амьдралтай болно. Тэд бүгд тус тусын үүргээ биелүүлж, Бурханд туйлын үнэнч байна. Тэд дуулгаваргүй байдал болон завхарсан зан чанараа бүрмөсөн хаяад, Бурханы төлөө, Бурханаас үүдэн амьдарна, дуулгаваргүй байдал, эсэргүүцлийн аль нь ч байхгүй байна. Бас тэд бүгд Бурханд бүрэн дуулгавартай байж чадна. Энэ нь Бурхан, хүн хоёрын амьдрал; хаанчлалын амьдрал, амралтын амьдрал байх болно.

Огтоос үл итгэгч үр хүүхэд, хамаатан саднаа чуулган руу чирдэг хүмүүс бүгд туйлын аминчхан бөгөөд зүгээр л сайхан сэтгэл гаргаж байгаа. Нөгөөдүүл нь итгэдэг эсэхийг үл хайхран, энэ нь Бурханы хүсэл мөн эсэхээс үл хамааран энэ хүмүүс хайр энэрэлтэй байхад л анхаардаг. Зарим хүн Бурханы өмнө эхнэрээ авчирдаг, эсвэл эцэг эхээ Бурханы өмнө авчирдаг бөгөөд Ариун Сүнс үүнийг зөвшөөрөх, тэдэн дээр ажлаа гүйцэтгэх эсэхээс үл хамааран Бурханы төлөө “авьяастай хүмүүсийг” сохроор сонгон авсаар байдаг. Энэ үл итгэгчдэд сайхан сэтгэл гаргах нь ямар ашиг тустай байж болох вэ? Ариун Сүнсний өмнө байдаггүй энэ үл итгэгчид Бурханыг дагахаар чармайсан ч гэсэн хүмүүсийн төсөөлдөг шиг аврал хүртэж мөн л чадахгүй. Аврал хүлээн авч чадах хүмүүсийг олж авах нь үнэндээ тийм ч амархан биш. Ариун Сүнсний ажил болон шалгалтыг туулаагүй, бие махбодтой болсон Бурханаар төгс болгуулаагүй хүмүүс бүрэн төгс болгуулж огтхон ч чадахгүй. Тиймээс, Бурханыг нэр төдий дагаж эхлэх мөчөөсөө эхлээд энэ хүмүүс Ариун Сүнсний өмнө байдаггүй. Нөхцөл байдал, бодит байр байдлаасаа шалтгаалан тэд бүрэн төгс болгуулж ер чадахгүй. Иймээс Ариун Сүнс тэдэнд их эрч хүч зарцуулахаар шийддэггүй, мөн тэднийг аливаа гэгээрлээр хангаж, ямар нэгэн байдлаар залж чиглүүлдэггүй; Тэр тэдэнд зүгээр л дагах боломж олгож, эцэст нь тэдний төгсгөлийг илчилнэ—энэ л хангалттай. Хүний урам зориг, санаа зорилго Сатанаас гардаг бөгөөд эдгээр зүйл Ариун Сүнсний ажлыг гүйцэлдүүлж яавч

чадахгүй. Хүмүүс ямархуу байх нь хамаагүй Ариун Сүнсний ажилтай байх ёстой. Хүмүүс бусад хүнийг бүрэн төгс болгож чадах уу? Нөхөр нь яагаад эхнэрээ хайрладаг вэ? Мөн эхнэр нь яагаад нөхрөө хайрладаг вэ? Хүүхдүүд нь яагаад эцэг эхдээ ачлалтай байдаг вэ? Эцэг эхчүүд яагаад үр хүүхдүүддээ ухаангүй хайрладаг вэ? Хүмүүс үнэндээ ямар санаа зорилго өвөрлөдөг вэ? Тэд өөрсдийн төлөвлөгөө, аминч хүслийг хангах зорилготой байдаг бус уу? Тэд үнэхээр Бурханы удирдлагын төлөвлөгөөний төлөө ажиллах гэдэг үү? Тэд үнэхээр Бурханы ажлын төлөө ажиллаж байгаа юу? Бүтээгдсэн зүйлийн үүргийг биелүүлэх зорилготой байдаг уу? Бурханд итгэж эхэлсэн мөчөөсөө л Ариун Сүнсний өмнө байж чадаагүй хүмүүс Ариун Сүнсний ажлыг хэзээ ч олж авч чадахгүй; энэ хүмүүс устгагдах бай гэж тогтоогдсон. Хүн тэднийг хэчнээн их хайрлах нь хамаагүй, Ариун Сүнсний ажлыг орлож чадахгүй. Хүмүүсийн урам зориг, хайр нь хүний санаа зорилгыг төлөөлдөг боловч Бурханы санаа зорилгыг төлөөлж чадахгүй, Бурханы ажлыг орлож ч чадахгүй. Бурханд нэр төдий итгэж, Түүнийг дагадаг дүр эсгэдэг боловч Бурханд итгэнэ гэж юу болохыг мэддэггүй хүмүүст байж болох хамгийн их хайр, өрөвдөх сэтгэлийг үзүүлсэн ч гэсэн тэд Бурханы энэрлийг олж авахгүй, Ариун Сүнсний ажлыг ч олж авахгүй. Бурханыг чин сэтгэлээсээ дагадаг хүмүүс хэв чанар муутай байж, олон үнэнийг ойлгож чаддаггүй байсан ч гэсэн Ариун Сүнсний ажлыг хааяа олж авч бас л чадна; харин хэв чанар сайтай хэр нь чин сэтгэлээсээ итгэдэггүй хүмүүс Ариун Сүнсний өмнө байж ер чадахгүй. Ийм хүмүүсийг аврах боломж огт байхгүй. Тэд Бурханы үгийг уншиж, хааяа номлол сонсож, эсвэл Бурханыг магтан дуулж байсан ч гэсэн эцэстээ амралтын цаг үе хүртэл амьд үлдэж чадахгүй. Хүмүүс чин сэтгэлээсээ эрж хайдаг эсэх нь бусад хүмүүс тэднийг хэрхэн үнэлж шүүдгээр, эргэн тойрных нь хүмүүс тэднийг хэрхэн үздэгээр бус, харин Ариун Сүнс тэдэн дээр ажилладаг эсэх, дэргэд нь Ариун Сүнс байдаг эсэхээр тодорхойлогддог. Түүнчлэн, тодорхой хугацаанд Ариун Сүнсний ажлыг туулсны дараа зан чанар нь өөрчлөгдсөн эсэх, Бурханы талаар мэдлэгтэй болсон эсэхээс хамаардаг. Хэрвээ Ариун Сүнс хүн дээр ажиллавал энэ хүний зан чанар аажмаар өөрчлөгдөж, Бурханд итгэх талаарх үзэл бодол нь аажмаар цэвэр ариун болно. Хүмүүс Бурханыг хэр удаан дагасан нь хамаагүй, тэд өөрчлөгдсөн л бол Ариун Сүнс тэдэн дээр ажиллаж байгаа гэсэн үг юм. Хэрвээ тэд өөрчлөгдөөгүй бол Ариун Сүнс тэдэн дээр ажиллаагүй гэсэн утгатай. Энэ хүмүүс зарим нэг үйлчлэл үзүүлдэг ч бай, сайн зол завшаан хүртэх хүсэл нь тэднийг өдөөдөг. Хааяахан л үйлчлэл үзүүлэх нь зан чанартаа өөрчлөлт гаргасныг орлож чадахгүй. Эцэстээ

тэд мөн л устгагдана, учир нь хаанчлалд үйлчлэл үзүүлэгчид хэрэггүй, мөн төгс болгуулсан, Бурханд үнэнч хүмүүст зан чанар нь өөрчлөгдөөгүй хэн ч үйлчлэх хэрэггүй байх болно. Урьд нь хэлсэн “Хүн Эзэнд итгэх үед бүхий л гэр бүлд нь зол завшаан тохиодог” гэх үг Нигүүлслийн эрин үед тохиромжтой боловч хүн төрөлхтний хүрэх газартай холбоогүй. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн нэг үе шатанд л зохимжтой. Энэ үгийн утга нь хүмүүсийн эдэлдэг амар амгалан болон материаллаг ерөөлд чиглэсэн; энэ нь Эзэнд итгэдэг хүний бүх гэр бүл аврагдана гэсэн үг биш, мөн нэг хүн сайн зол завшаан хүртэх үед бүх гэр бүлийнхэн нь бас амралтад хүргэгдэж чадна гэсэн утгатай ч биш юм. Хүн ерөөл хүртэх, зовлон амсах эсэх нь тухайн хүний мөн чанарын дагуу тодорхойлогддог болохоос бусдынхтай адил нийтлэг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддоггүй. Хаанчлалд иймэрхүү хэллэг, эсвэл дүрэм журам огт байдаггүй. Хүн эцэстээ амьд үлдэж чадвал Бурханы шаардлагыг хангаснаас болж байгаа бөгөөд эцэстээ амралтын цаг үе хүртэл үлдэж чадахгүй бол Бурханд дуулгаваргүй байж, Бурханы шаардлагыг биелүүлээгүйгээс болж байгаа юм. Хүн бүрд тохирох хүрэх газар гэж бий. Эдгээр хүрэх газар нь хувь хүн бүрийн мөн чанарын дагуу тодорхойлогддог бөгөөд бусад хүмүүстэй ямар ч хамаагүй. Хүүхдийн хорон муу үйлдлийг эцэг эхэд нь тохож болохгүй, мөн хүүхдийн зөв шударга байдлыг эцэг эхтэй нь хуваалцаж ч болохгүй. Эцэг эхийнх нь хорон муу үйлдлийг үр хүүхдэд нь тохож болохгүй, мөн эцэг эхийнх нь зөв шударгыг үр хүүхдүүдтэй нь хуваалцаж болохгүй. Хүн бүр өөрсдийн нүглийг үүрч, хүн бүр тус тусын зол завшааныг эдэлдэг. Хэн ч өөр хүнийг орлож чадахгүй; энэ нь зөв шударга байдал юм. Хүний өнцгөөс бол хэрвээ эцэг эх нь сайн зол завшаан хүртвэл үр хүүхдүүд нь ч бас хүртэж чадах бөгөөд үр хүүхдүүд нь мууг үйлдвэл эцэг эх нь тэдний нүглийг нөхөн төлөх ёстой байдаг. Энэ бол хүний үзэл бодол, аливааг хийх хүний арга зам юм; энэ нь Бурханы үзэл бодол биш. Хүн бүрийн төгсгөл, үйлдлээс нь гардаг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддог ба энэ нь үргэлж зүй зохистойгоор тодорхойлогддог. Хэн ч өрөөл бусдын нүглийг үүрч чадахгүй; тэр тусмаа хэн ч өөр хүний оронд шийтгэл хүлээж чадахгүй. Энэ нь маргаангүй. Үр хүүхдээ гэх эцэг эхийн хайр халамж байлаа гээд үр хүүхдийнхээ оронд зөв шударга үйл хийж чадна гэсэн үг биш, мөн эцэг эхээ гэсэн үр хүүхдийн ачлалт хайр байлаа гээд эцэг эхийнхээ оронд зөв шударга үйл хийж чадна гэсэн үг биш. “Тэр үед хоёр хүн талбайд байна; нэгийг нь авч, нөгөөг нь үлдээнэ. Хоёр эмэгтэй тээрэм дээр тээрэмдэж байна; нэгийг нь авч, нөгөөг нь орхино” гэх үгийн жинхэнэ утга учир энэ юм. Үр хүүхдээ гэх их хайрандаа үндэслэн мууг үйлдэгч

хүүхдүүдээ амралтад аваачиж хэн ч чадахгүй, мөн өөрийн зөв шударга үйлдлийн үндсэн дээр эхнэрээ (эсвэл нөхрөө) амралтад аваачиж хэн ч чадахгүй. Энэ бол захиргааны дүрэм; хэн ч үүнээс ангид байж чадахгүй. Эцсийн эцэст, зөв шударгыг үйлдэгчид нь зөв шударгыг үйлдэгчид, мууг үйлдэгчид нь мууг үйлдэгчид юм. Зөв шударга хүмүүс эцэстээ амьд үлдэнэ, харин мууг үйлдэгчид устгагдана. Ариун хүмүүс бол ариун; тэд бузар биш. Бузар хүмүүс бол бузар, тэдэнд ганц ч ариун хэсэг байдаггүй. Хорон муу хүмүүсийн үр хүүхдүүд зөв шударга үйл хийлээ ч гэсэн, зөв шударга хүний эцэг эх ёрын муу үйл хийлээ ч гэсэн, бүх хорон муу хүн устгагдаж, бүх зөв шударга хүн амьд үлдэнэ. Итгэдэг нөхөр, итгэдэггүй эхнэрийн хооронд ямар ч холбоо байхгүй ба итгэдэг үр хүүхэд, итгэдэггүй эцэг эх хоорондоо ямар ч холбоогүй байдаг; тэд бол огт таарахгүй хоёр төрлийн хүмүүс юм. Амралтад орохоос өмнө хүнд махан биеийн хамаатан садан байдаг ч амралтад ормогц яриад байх махан биеийн хамаатан садан гэж байхаа болино. Үүргээ биелүүлдэг хүмүүс бол биелүүлдэггүй хүмүүсийн дайсан; Бурханыг хайрладаг хүмүүс болон Бурханыг үзэн яддаг хүмүүс бол өөр хоорондоо эсрэг хүмүүс. Амралтад орох хүмүүс болон устгагдсан байх хүмүүс нь хоорондоо таарамжгүй хоёр төрлийн бүтээл юм. Үүргээ биелүүлдэг бүтээл амьд үлдэж чадна, харин үүргээ биелүүлдэггүй бүтээл сүйрлийн бай болно; үүнээс гадна, энэ нь мөнхөд үргэлжилнэ. Чи бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд нөхрөө хайрладаг уу? Мөн бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд эхнэрээ хайрладаг уу? Бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлэхийн тулд чи үл итгэгч эцэг эхдээ ачлалтай байдаг уу? Бурханд итгэх тухай хүний үзэл бодол зөв үү, буруу юу? Чи яагаад Бурханд итгэдэг юм бэ? Юу олж авахыг хүсдэг юм бэ? Бурханыг хэрхэн хайрладаг вэ? Бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлж чаддаггүй, бүрэн дүүрэн хичээл зүтгэл гаргаж чаддаггүй хүмүүс сүйрлийн бай болно. Өнөөдрийн хүмүүс хоорондоо бие махбодын харилцаатай, түүнчлэн цусан холбоотой байдаг боловч ирээдүйд энэ бүгд нуран унана. Итгэгчид, үл итгэгчид нь хоорондоо таарамжгүй; харин ч нэг нэгнийхээ эсрэг байдаг. Амралтад байгаа хүмүүс Бурхан бий гэдэгт итгэн, Бурханд дуулгавартай байна, харин Бурханд дуулгаваргүй хүмүүс бүгд устгагдсан байх болно. Газар дэлхий дээр гэр бүлүүд оршин байхаа болино; эцэг эх, үр хүүхэд, хань ижлийн харилцаа яаж байж болох юм бэ? Чухамдаа итгэл болон үл итгэлийн нийцэшгүй байдал нь ийм бие махбодын харилцааг бүрмөсөн тасалсан байх болно!

Анх хүн төрөлхтний дунд гэр бүл гэж байгаагүй; эрэгтэй, эмэгтэй буюу хоёр

өөр төрлийн хүн л оршин байсан. Гэр бүлүүд байх нь бүү хэл, ямар ч улс орон байгаагүй, харин хүний завхралын улмаас төрөл бүрийн хүмүүс тусдаа овгууд болон зохион байгуулагдаж, дараа нь улс орон, үндэстнүүд болон хөгжсөн юм. Эдгээр улс үндэстэн нь тусдаа жижиг гэр бүлүүдээс бүрдэн, ийм маягаар бүх төрлийн хүмүүс хэлний ялгаа, хил хязгаарт үндэслэн янз бүрийн угсаатан ястан болж хуваагдсан билээ. Үнэндээ дэлхий дээр хэчнээн үндэс угсаа байх нь хамаагүй, хүн төрөлхтөн цорын ганц өвөг дээдэстэй. Эхэндээ ердөө хоёр төрлийн л хүн байсан ба энэ хоёр төрөл нь эрэгтэй, эмэгтэй хүн байв. Гэвч Бурханы ажлын ахиц дэвшил, түүхийн замнал, газар зүйн өөрчлөлтийн улмаас энэхүү хоёр төрлийн хүн янз бүрийн түвшинд, улам олон төрлийн хүмүүс болж хөгжжээ. Үндсэндээ, хүн төрөлхтөн хэчнээн олон төрлийн үндэс угсаанаас бүрддэг бай хамаагүй, бүх хүн төрөлхтөн Бурханы бүтээл хэвээр юм. Хүмүүс ямар ч үндэс угсаанд харьяалагддаг бай, бүгд Түүний бүтээл мөн; тэд бүгд Адам, Евагийн үр удам билээ. Тэд хэдий Бурханы гараар бүтээгдээгүй ч Бурханы биечлэн бүтээсэн Адам, Евагийн үр удам юм. Хүмүүс ямар төрлийн оршихуйд харьяалагддаг нь хамаагүй, бүгд Түүний бүтээл мөн; тэд Бурханы бүтээсэн хүн төрөлхтөнд харьяалагддаг тул тэдний хүрэх газар нь хүн төрөлхтөнд байх ёстой зүйл бөгөөд хүмүүсийг зохион байгуулдаг дүрмийн дагуу тэд хуваагдсан. Өөрөөр хэлбэл, мууг үйлдэгчид болон зөв шударга хүмүүс нь бүгд эцсийн эцэст бүтээлүүд юм. Ёрын мууг үйлддэг бүтээлүүд эцэстээ устгагдаж, зөв шударга үйл хийдэг бүтээлүүд амьд үлдэнэ. Энэ хоёр төрлийн бүтээлд зориулсан хамгийн тохиромжтой зохицуулалт энэ юм. Мууг үйлдэгчид дуулгаваргүй байдлаасаа болоод Бурханы бүтээл гэдгээ үгүйсгэж чаддаггүй ч Сатанд олзлогдсон тул аврагдаж чадахгүй. Зөв шударгаар биеэ авч явдаг бүтээлүүд нь, амьд үлдэнэ гэх баримтдаа үндэслэн Бурханаар бүтээгдсэн ч Сатанаар завхруулагдсанахаа дараа аврал хүлээн авсан гэдгээ үгүйсгэж чадахгүй. Мууг үйлдэгчид бол Бурханд дуулгаваргүй бүтээлүүд; тэд аврагдаж чадахгүй, Сатанд аль хэдийн бүрэн олзлогдсон бүтээлүүд юм. Мууг үйлддэг хүмүүс ч бас хүмүүс; тэд бол туйлын их завхарсан, аврагдаж чадахгүй хүмүүс юм. Зөв шударгыг үйлддэг хүмүүс ч бас бүтээл учраас мөн л завхарсан, гэхдээ тэд бол завхарсан зан чанараасаа ангижрахыг хүсдэг хүмүүс бөгөөд Бурханыг дуулгавартай дагах чадвартай болсон. Зөв шударга үйлдэлтэй хүмүүс зөв шударга байдлаар бялхдаггүй; харин ч тэд аврал хүртэж, завхарсан зан чанараасаа ангижирсан; мөн Бурханд дуулгавартай байж чаддаг. Эцэстээ тэд бат зогсоно, гэхдээ энэ нь, тэднийг Сатан завхруулаагүй гэсэн үг биш юм.

Бурханы ажил дууссаны дараа Түүний бүх бүтээл дунд устгагдах хүмүүс, амьд үлдэх хүмүүс гэж байх болно. Энэ нь Түүний удирдлагын ажлын зайлшгүй чиг хандлага юм; хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй. Мууг үйлдэгчид амьд үлдэхгүй; Бурханд дуулгавартай байж, эцсээ хүртэл дагадаг хүмүүс амьд үлдэх нь тодорхой. Энэ ажил нь хүн төрөлхтний удирдлагын ажил тул үлдэх хүмүүс ба таягдан хаягдах хүмүүс гэж байх болно. Эдгээр нь өөр өөр төрлийн хүмүүсийн өөр өөр төгсгөл бөгөөд Бурханы бүтээлүүдэд зориулсан хамгийн тохиромжтой зохицуулалт юм. Хүн төрөлхтөнд зориулсан Бурханы туйлын зохицуулалт бол гэр бүлгүй, улсын хил хязгааргүй болгохын тулд гэр бүлүүдийг салгаж, улс үндэстнийг бутаргаж, улсын хил хязгаарыг нураах замаар тэднийг хуваах явдал юм, учир нь хүмүүс эцсийн эцэст нэг өвөг дээдсээс үүсэлтэй бөгөөд Бурханы бүтээл юм. Товчхондоо мууг үйлдэгч бүтээлүүд бүгд устгагдана, Бурханд дуулгавартай бүтээлүүд амьд үлдэнэ. Ийм маягаар амралтын цаг үе ирэхэд ямар ч гэр бүл, улс орон, ялангуяа үндэстэн гэж байхгүй байх болно; ийм төрлийн хүн төрөлхтөн бол хамгийн ариун хүн төрөлхтөн юм. Газар дээрх бүх зүйлийг хүмүүсээр халамжлуулах гэж Адам Ева хоёрыг анх бүтээсэн; хүмүүс анх бүх зүйлийн эзэн байсан. Хүмүүсийг бүтээсэн Еховагийн санаа зорилго нь тэдэнд газар дээр оршин байж, үүн дээрх бүх зүйлийг арчилж халамжлах боломж олгох явдал байв, учир нь хүн анх завхраагүй, мөн мууг үйлдэх чадваргүй байлаа. Гэвч хүмүүс завхралд өртсөнийхөө дараа бүх зүйлийг халамжлагч байхаа больсон. Бурханы авралын зорилго бол хүний энэ чиг үүргийг сэргээж, хүн төрөлхтний анхдагч эрүүл ухаан, анхдагч дуулгавартай байдлыг сэргээх явдал юм; амралтан дахь хүн төрөлхтөн нь Өөрийн авралын ажлаар Бурханы хүрэхээр зорьдог үр дүнгийн яг таг дүрслэл байх болно. Хэдийгээр энэ нь Еден цэцэрлэгийнх шиг амьдрал байхаа болих ч мөн чанар нь ижил байна; хүн төрөлхтөн зүгээр л урьдын завхраагүй хүмүүс байхаа болино, харин завхралд өртөөд, дараа нь аврал хүртсэн хүн төрөлхтөн байх болно. Аврал хүртсэн энэ хүмүүс эцэстээ (өөрөөр хэлбэл, Бурханы ажил дууссаны дараа) амралтад орно. Үүний адилаар, шийтгэгдсэн хүмүүсийн төгсгөл ч бас эцэстээ бүрмөсөн илчлэгдэх ба Бурханы ажил дууссаны дараа л тэд устгагдана. Өөрөөр хэлбэл, Түүний ажил дууссаны дараа мууг үйлдэгчид болон аврагдсан хүмүүс бүгд илчлэгдэнэ, учир нь бүх төрлийн хүмүүсийг (мууг үйлдэгч ч бай, аврагдсан хүмүүс ч бай) илчлэх ажил хүн бүр дээр нэгэн зэрэг хийгдэнэ. Мууг үйлдэгчид таягдан хаягдах ба үлдэж чадах хүмүүс нэгэн зэрэг илчлэгдэнэ. Тиймээс бүх төрлийн хүмүүсийн төгсгөл нэг дор илчлэгдэнэ. Бурхан аврал

хүртсэн бүлэг хүмүүсийг амралтад оруулаад, дараа нь мууг үйлдэгчдийг хойш тавьж, тэднийг бага багаар шүүж, эсвэл шийтгэхгүй; тэгэх нь баримтуудтай нийцэхгүй. Мууг үйлдэгчид устгагдаж, амьд үлдэж чадах хүмүүс амралтад орох үед орчлон ертөнц даяарх Бурханы ажил дуусна. Ерөөл хүртэх, зовлон амсах хүмүүсийн дунд эрэмбэлсэн дараалал гэж байхгүй; ерөөл хүртэх хүмүүс мөнх амьдарна, харин зовлон амсах хүмүүс мөнхөд мөхнө. Ажлын энэ хоёр үе шат нэгэн зэрэг гүйцэлдэнэ. Дуулгаваргүй хүмүүс байдаг учраас л дуулгавартай хүмүүсийн зөв шударга байдал илчлэгдэнэ, мөн ерөөл хүртсэн хүмүүс байдаг болохоор л ёрын мууг үйлдэгчдийн хорон муу үйлдлийнхээ төлөө амссан зовлон илчлэгдэнэ. Бурхан мууг үйлдэгчдийг ил болгоогүй бол Бурханыг чин сэтгэлээсээ дуулгавартай дагадаг хүмүүс хэзээ ч нар үзэхгүй байх байсан; хэрвээ Бурхан Өөрийг нь дуулгавартай дагадаг хүмүүсийг тохиромжтой хүрэх газарт нь аваачаагүй бол Бурханд дуулгаваргүй хүмүүс зохих цээрлүүлэлтээ хүртэж чадахгүй байх байсан юм. Энэ бол Бурханы ажлын үйл явц. Хэрвээ Тэр мууг шийтгэж, сайныг шагнах энэ ажлыг хийгээгүй бол Түүний бүтээлүүд тус тусын хүрэх газартаа хэзээ ч орж чадахгүй байх байлаа. Хүн төрөлхтөн амралтад ормогц мууг үйлдэгчид устгагдаж, бүх хүн төрөлхтөн зөв замдаа орсон байх болно; төрөл бүрийн хүмүүс гүйцэтгэх ёстой чиг үүргийнхээ дагуу өөрсдийн төрөлтэй хамт байх болно. Энэ л хүн төрөлхтний амралтын өдөр, хүн төрөлхтний хөгжлийн зайлшгүй чиг хандлага байх бөгөөд хүн төрөлхтөн амралтад орох үед л Бурханы агуу, эцсийн ажил үйлс бүрэн дуусна; энэ нь Түүний ажлын сүүлчийн хэсэг байх болно. Энэхүү ажил бүх хүн төрөлхтний махан биеийн доройтмол амьдралыг дуусгана, мөн түүнчлэн завхарсан хүн төрөлхтний амьдралыг төгсгөнө. Тэр үеэс хойш хүмүүс шинэ ертөнцөд орно. Хэдийгээр бүх хүн махан биед амьдардаг ч амьдралын мөн чанар нь завхарсан хүн төрөлхтний амьдралаас ихээхэн ялгаатай байдаг. Оршин тогтнолын ач холбогдол нь завхарсан хүн төрөлхтний оршин тогтнолын ач холбогдлоос ч бас ялгаатай байдаг. Хэдийгээр энэ нь шинэ төрлийн хүний амьдрал биш байх боловч аврал хүртсэн хүн төрөлхтний амьдрал, түүнчлэн хүн чанар, эрүүл ухаанаа эргүүлэн олж авсан амьдрал гэж хэлж болно. Тэд бол нэгэнтээ Бурханд дуулгаваргүй байсан, Бурханаар байлдан дагуулагдаад, дараа нь Бурханаар авруулсан хүмүүс юм; тэд бол Бурханыг доромжлоод, хожим нь Түүнд гэрчлэл хийсэн хүмүүс билээ. Түүний туршилтыг туулж, амьд үлдсэний дараах тэдний оршин тогтнол бол хамгийн учир утгатай оршин тогтнол юм; тэд бол Сатаны өмнө Бурханд гэрчлэл хийсэн хүмүүс, мөн амьдрахад тохирох хүмүүс билээ.

Устгагдах хүмүүс бол Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадахгүй хүмүүс бөгөөд амьдрахад тохирохгүй. Тэдний сүйрэл хорон муу үйлдлийнх нь үр дүн байх бөгөөд тийнхүү бүрмөсөн устгагдах нь тэдний хамгийн сайн хүрэх газар юм. Ирээдүйд хүмүүс сайн сайхан ертөнцөд орох үед хүмүүсийн олж авна гэж төсөөлдөг эхнэр нөхөр, эцэг охин, эсвэл эх хүүгийн харилцааны аль нь ч байхгүй байх болно. Тэр үед хүн бүр өөрийнхөө төрлийг дагах ба гэр бүлүүд аль хэдийн нуран унасан байх болно. Бүрэн бүтэлгүйтсэн Сатан хүн төрөлхтнийг дахин хэзээ ч үймүүлэхгүй бөгөөд хүмүүс завхарсан сатанлаг зан чанартай байхаа болино. Дуулгаваргүй тэр хүмүүс аль хэдийн устгагдсан байх ба дуулгавартай хүмүүс л үлдэнэ. Ингэснээр маш цөөхөн гэр бүл л бүрэн бүтэн үлдэнэ; бие махбодын харилцаа хэрхэн оршин тогтносоор байж болох билээ? Хүмүүсийн урьдын махан биеийн амьдрал бүрмөсөн хориглогдоно; хүмүүсийн хоорондох бие махбодын харилцаа яаж оршин тогтнож болох юм бэ? Завхарсан сатанлаг зан чанаргүйгээр, хүний амьдрал өнгөрсөн үеийн хуучин амьдрал байхаа больж, харин ч шинэ амьдрал болно. Эцэг эх нь үр хүүхдээ алдаж, үр хүүхэд нь эцэг эхээ алдана. Нөхөр нь эхнэрээ алдаж, эхнэр нь нөхрөө алдана. Одоо хүмүүс хоорондоо бие махбодын харилцаатай байдаг ч хүн бүрийг амралтад ормогц бие махбодын харилцаа гэж байхаа болино. Ийм хүмүүс л зөв шударга, ариун байдлыг эзэмшинэ; ийм хүмүүс л Бурханд шүтэн мөргөж чадна.

Бурхан хүмүүсийг бүтээж, газар дээр байрлуулаад, тэр үеэс хойш тэднийг удирдсан. Дараа нь Тэр тэднийг аварч, хүн төрөлхтний төлөөх нүглийн тахил болсон. Эцэст нь Тэр мөн л хүн төрөлхтнийг байлдан дагуулж, хүмүүсийг бүхэлд нь аварч, анхдагч төрхийг нь сэргээх ёстой болсон. Хүний анхдагч дүр, анхны төрхийг сэргээх энэхүү ажлыг Тэр бүр эхнээсээ л хийсээр ирсэн. Бурхан хаанчлалаа байгуулж, хүний анхдагч төрхийг сэргээнэ, өөрөөр хэлбэл, Бурхан газар дээр, бүх бүтээлийн дунд эрх мэдлээ сэргээнэ. Сатанаар завхруулагдсаны дараа хүн Бурханаас эмээх зүрх сэтгэлээ алдаж, Бурханы бүтээлд оногдсон чиг үүргээ ч алдаж, улмаар Бурханд дуулгаваргүй дайсан болжээ. Тэгээд хүмүүс Сатаны эзэмшилд амьдарч, Сатаны тушаалыг дагасан; тиймээс Бурхан бүтээлүүдийнхээ дунд ажиллах ямар ч аргагүй болж, тэдний айж эмээсэн хүндлэлийг олж авч бүр ч чадахаа больсон юм. Хүмүүс Бурханаар бүтээгдсэн, Бурханд шүтэн мөргөх учиртай боловч үнэндээ Бурханаас нүүр буруулж, оронд нь Сатаныг шүтжээ. Тэгээд Сатан хүний зүрх сэтгэл дэх шүтээн болов. Ийнхүү Бурхан хүний зүрх сэтгэл дэх байр сууриа алдсан, өөрөөр хэлбэл, Тэр хүнийг бүтээснийхээ утга учрыг алдсан. Тиймээс хүнийг

бүтээснийхээ утга учрыг сэргээхийн тулд Тэр хүний анхдагч төрхийг сэргээж, хүнийг завхарсан зан чанараас нь ангижруулах ёстой. Хүмүүсийг Сатанаас буцаан авахын тулд Тэр тэднийг нүглээс аврах ёстой. Ийм маягаар л Бурхан тэдний анхдагч төрх болон чиг үүргийг аажмаар сэргээж, Өөрийн хаанчлалыг сэргээж чадна. Дуулгаваргүй хөвгүүдийн эцсийн сүйрэл нь ч бас, хүмүүсийг Бурханд илүү их шүтэн мөргүүлж, газар дээр илүү сайхан амьдруулахын төлөө хийгдэнэ. Бурхан хүмүүсийг бүтээсэн тул Тэр хүнийг Өөртөө шүтэн мөргүүлнэ; Тэрээр хүний анхдагч чиг үүргийг сэргээхийг хүсдэг тул ямар ч хольцгүйгээр бүрэн сэргээнэ. Өөрийн эрх мэдлийг сэргээнэ гэдэг нь хүнийг Өөртөө шүтэн мөргүүлж, Өөртөө дуулгавартай байлгана гэсэн үг юм; мөн Бурхан хүмүүсийг Өөрөөсөө үүдэн амьдруулж, дайснаа Өөрийн эрх мэдлээр сүйрүүлнэ гэсэн утгатай. Бас Бурхан, хэний ч эсэргүүцэлгүйгээр Өөрийнхөө бүхий л зүйлийг хүмүүсийн дунд үлдээнэ гэсэн үг юм. Бурханы байгуулахыг хүсдэг хаанчлал бол Түүний Өөрийн хаанчлал билээ. Түүний хүсдэг хүн төрөлхтөн бол Түүнд шүтэн мөргөдөг, Түүнийг бүрэн дуулгавартай дагадаг, Түүний алдар сууг илтгэдэг хүмүүс юм. Хэрвээ Бурхан завхарсан хүн төрөлхтнийг аврахгүй бол хүнийг бүтээснийх нь утга учир алдагдана; Тэрээр хүмүүсийн дунд ямар ч эрх мэдэлгүй байж, Түүний хаанчлал газар дээр оршин тогтнож чадахаа болино. Хэрвээ Бурхан, Өөрт нь дуулгаваргүй байдаг дайснуудаа устгахгүй бол бүрэн алдар суугаа олж авч чадахгүй, газар дээр хаанчлалаа байгуулж ч чадахгүй. Хүн төрөлхтний дундаас Өөрт нь дуулгаваргүй хүмүүсийг бүрмөсөн устгаж, бүрэн төгс болгуулсан хүмүүсийг амралтад аваачих нь Түүний ажил дууссаны тэмдэг, Түүний агуу амжилтын тэмдэг байх болно. Хүмүүс анхдагч төрхөө сэргээж, тус тусын үүргийг гүйцэтгэж, өөрсдийн зүй ёсны байр суурийг хадгалж, Бурханы бүх зохицуулалтад захирагдаж чаддаг байх үед Бурхан, Өөрт нь шүтэн мөргөдөг бүлэг хүмүүсийг газар дээр олж авсан байх бөгөөд Өөрт нь шүтэн мөргөдөг хаанчлалыг ч газар дээр байгуулсан байх болно. Тэр газар дээр мөнхөд ялж, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс үүрд мөхнө. Энэ нь хүн төрөлхтнийг бүтээсэн Түүний анхдагч санаа зорилгыг сэргээнэ; энэ нь бүх зүйлийг бүтээсэн Түүний санаа зорилгыг сэргээж, газар дээрх, бүх зүйлийн дундах, дайснуудынх нь дундах Түүний эрх мэдлийг сэргээнэ. Эдгээр нь Түүний бүрэн ялалтын бэлгэ тэмдэг байх болно. Тэр үеэс хойш хүн төрөлхтөн амралтад орж, зөв зам дээрх амьдралыг эхлүүлнэ. Бурхан ч бас хүнтэй хамт мөнхийн амралтад орж, Бурхан, хүн хоёрын хуваалцдаг мөнхийн амьдралыг эхлүүлнэ. Газар дээрх бузар булай болон дуулгаваргүй байдал алга болж, бүхий л уйлаан ч бас үгүй болж, энэ

дэлхий дээр Бурханыг эсэргүүцдэг бүхэн оршин тогтнохоо больсон байх болно. Бурхан болон Түүний аварсан хүмүүс л үлдэнэ; Түүний бүтээл л үлдэнэ.

ЕСҮСИЙН СҮНСЛЭГ БИЕИЙГ ХАРАХ ҮЕД ЧИНЬ БУРХАН ТЭНГЭР, ГАЗРЫГ ШИНЭЭР БҮТЭЭСЭН БАЙХ БОЛНО

Чи Есүсийг харахыг хүсэж байна уу? Чи Есүстэй хамт амьдрахыг хүсэж байна уу? Чи Есүсийн хэлсэн үгийг сонсохыг хүсэж байна уу? Хэрэв тийм бол чи Есүсийг эргэн ирэхэд хэрхэн угтах вэ? Чи бүрэн бэлтгэсэн үү? Чи Есүсийг эргэн ирэхэд ямар байдлаар угтах вэ? Миний бодлоор Есүсийг дагадаг ах эгч болгон Түүнийг сайхан угтаж авахыг хүсдэг байх. Гэхдээ та нар ер нь ингэж бодож үзсэн үү: Есүсийг эргэн ирэх үед чи Түүнийг үнэхээр мэдэх үү? Түүний хэлсэн бүхнийг та нар үнэхээр ойлгох уу? Түүний хийдэг бүх ажлыг ямар ч болзолгүйгээр үнэхээр хүлээн авах уу? Библийг уншсан бүх хүн Есүс эргэн ирнэ гэдгийг мэддэг ба Библи уншсан бүх хүн Түүний эргэн ирэхийг анхааралтай хүлээдэг. Та бүгд тэр мөч ирэх тухайд л анхаардаг, та нарын үнэнч сэтгэл магтууштай, итгэл үнэмшил чинь үнэхээр атаархмаар, гэвч та нар ноцтой алдаа гаргаснаа ухаарсан уу? Есүс ямар байдлаар эргэн ирэх вэ? Есүсийг цагаан үүлэн дээр эргэн ирнэ гэдэгт та нар итгэдэг, гэхдээ Би та нараас асууя: Энэ цагаан үүл гэдэг нь юуг хэлдэг вэ? Өөрийнх нь эргэн ирэхийг маш олон дагагч нь хүлээж байхад Есүс ямар хүмүүсийн дунд бууж ирэх вэ? Есүс хамгийн түрүүнд та нарын дунд бууж ирвэл бусад нь үүнийг тун шударга бус гэж үзэх бус уу? Есүсийн төлөө гэсэн агуу чин сэтгэлтэй, үнэнч гэдгийг чинь Би мэдэж байна. Гэхдээ та нар Есүстэй ер нь уулзаж байсан уу? Та нар Түүний зан чанарыг мэдэх үү? Та нар ер нь Түүнтэй цуг амьдарч байсан уу? Та нар Түүний талаар үнэндээ хэр их ойлгодог вэ? Эдгээр үг өөрсдийг нь эвгүй байдалд орууллаа гэж зарим нь хэлнэ. Тэд: “Би Библийг эхнээс нь дуустал маш олон удаа уншсан. Би яаж Есүсийг ойлгож чадахгүй байх юм бэ? Есүсийн зан чанар байтугай, өмсөх дуртай байсан хувцасных нь өнгийг хүртэл би мэднэ. Намайг Та Түүнийг ойлгодоггүй гэж хэлэхдээ намайг басамжилж байгаа хэрэг биш үү?” гэх байх. Гэхдээ эдгээр асуудлаар маргах хэрэггүй гэж чамд Би зөвлөө; чи тайвшраад дараах асуултуудын талаар нөхөрлөсөн нь дээр: Нэгдүгээрт, чи бодит байдал гэж юу болохыг, мөн онол гэж юу болохыг мэдэх үү? Хоёрдугаарт, чи үзэл гэж юу болохыг болон үнэн гэж юу болохыг мэдэх үү? Гуравдугаарт, чи төсөөлөл

гэж юу болохыг, бодит зүйл гэж юу болохыг мэдэх үү?

Зарим хүн Есүсийг ойлгодоггүй гэдгээ үгүйсгэдэг. Гэхдээ л та нар Түүнийг өчүүхэн ч гэсэн ойлгодоггүй, мөн Есүсийн ганц ч үгийг ойлгодоггүй гэж Би хэлдэг. Яагаад гэвэл, та нар дор бүрнээ Библийн тэмдэглэлүүд, мөн бусдын хэлсэн зүйлээс болж Түүнийг дагадаг. Та нар Есүсийг хэзээ ч харж байгаагүй, цуг амьдарч ч байгаагүй, Түүнтэй түр зуур ч хамт байгаагүй. Иймд Есүсийн талаарх та нарын ойлголт ердөө л онол төдий биш гэж үү? Энэ чинь бодит байдалгүй бус уу? Зарим хүн Есүсийн хөргийг харсан, эсвэл Есүсийн гэрт биечлэн очиж байсан байх. Магадгүй зарим нь Есүсийн хувцсанд хүрч байсан байх. Гэхдээ чи Есүсийн идсэн хоолыг биечлэн амссан байсан ч гэсэн, Түүний талаарх ойлголт чинь бодитой бус, онолынх хэвээр байдаг. Ямар ч тохиолдолд чи Есүсийг хараагүй, Түүний махбодтой хамт байгаагүй бол Есүсийн талаарх ойлголт чинь үргэлж бодит байдлаас тасархай, хоосон онол хэвээр байна. Миний үг чамд жаахан сонирхолгүй байж магад, тэгвэл Би чамаас ингэж асууя: Чи хамгийн их биширдэг зохиолчийнхоо олон бүтээлийг уншсан байж болох ч цагийг хамтдаа өнгөрүүлэлгүйгээр түүнийг бүрэн ойлгож чадах уу? Зан араншин нь ямыг чи мэдэх үү? Ямаршуу амьдардгийг нь мэдэх үү? Сэтгэл санааных нь байдлын талаар ямар нэг зүйл мэдэх үү? Чи биширдэг хүнээ ч бүрэн ойлгож чадахгүй байгаа атлаа Есүс Христийг яаж ойлгож чадах юм бэ? Есүсийн талаар чиний мэдэх бүх зүйл ямар ч үнэн, бодит зүйлгүй, бүхэлдээ үзэл, төсөөлөл юм. Энэ чинь өмхий, бас махан биеэр дүүрэн. Ийм ойлголт яаж чамайг Есүсийг эргэн ирэх үед угтаж авах эрхтэй болгох вэ? Уран зөгнөл, махан биеийн үзлээр дүүрэн хүмүүсийг Есүс хүлээж авахгүй. Есүсийг ойлгодоггүй хүмүүс яаж Түүнд итгэгчид байхад тохирох билээ?

Фарисайчууд Есүсийг эсэргүүцсэний уг шалтгааныг та нар мэдмээр байна уу? Фарисайчуудын мөн чанарыг мэдэхийг хүсэж байна уу? Тэд Мессиагийн талаарх уран зөгнөлөөр дүүрэн байсан. Үүнээс гадна, тэд Мессиа ирнэ гэдэгт л итгэсэн ч амь, үнэнийг эрэлхийлээгүй. Иймээс өнөөдөр ч гэсэн тэд Мессиаг хүлээсээр л байдаг, учир нь тэдэнд амийн замын талаар ямар ч мэдлэг байдаггүй, мөн үнэний зам гэж юу болохыг мэддэггүй. Ийм мунхаг, зөрүүд, мэдлэггүй хүмүүс Бурханы ерөөлийг олж авч чадах уу, та нар хэл дээ? Тэд яаж Мессиаг харж чадах юм бэ? Тэд Ариун Сүнсний ажлын чиглэлийг мэдээгүй, Есүсийн хэлсэн үнэний замыг мэдээгүй, түүнчлэн Мессиаг ойлгоогүй учраас Есүсийг эсэргүүцсэн. Тэд Мессиаг хэзээ ч харж байгаагүй, Мессиагаар хэзээ ч хамт байгаагүй болохоор Мессиагийн нэр төдийхөнтэй зууралдах зуураа

Мессиагийн мөн чанарыг боломжит бүх аргаар эсэргүүцэх алдаа гаргасан. Энэ фарисайчууд мөн чанарын хувьд зөрүүд, биеэ тоосон, үнэнийг дуулгавартай дагаагүй. Тэдний Бурханд итгэх зарчим нь энэ: Таны номлол хэр гүн гүнзгий, Таны эрх мэдэл хэчнээн өндөр дээд ч бай, Мессиа гэж нэрлэгдээгүй л бол Та Христ биш. Тэдний энэ итгэл нь утгагүй, хөгийн биш гэж үү? Би та нараас цааш нь асууя: Та нарт Есүсийн талаар өчүүхэн ч ойлголт байхгүй юм чинь эрт үеийн фарисайчуудын алдааг гаргах нь туйлын хялбар биш гэж үү? Чи үнэний замыг ялган таньж чадах уу? Чи Христийг эсэргүүцэхгүй гэдгээ үнэхээр баталж чадах уу? Чи Ариун Сүнсний ажлыг дагаж чадах уу? Чи Христийг эсэргүүцэх эсэхээ мэдэхгүй байвал аль хэдийн үхлийн ирмэгт амьдарч байна гэж Би хэлнэ. Мессиаг мэддэггүй хүмүүс бүгд Есүсийг эсэргүүцэж, голж, гүжирдэх чадвартай байсан. Есүсийг ойлгодоггүй хүмүүс бүгд Түүнийг голж, доромжлох боломжтой. Түүнчлэн тэд Есүсийн эргэн ирэлтийг Сатаны заль мэх гэж харах боломжтой ба махбодоор эргэн ирсэн Есүсийг илүү олон хүн яллах болно. Энэ бүх зүйл та нарыг айлгахгүй байна гэж үү? Ариун Сүнсийг доромжилж, чуулгануудад хэлсэн Ариун Сүнсний үгийг сүйрүүлж, Есүсийн илэрхийлсэн бүхнийг голох явдалтай та нар нүүр тулна. Та нар ийм мунгинуу байвал Есүсээс юу олж авч чадах юм бэ? Хэрвээ та нар алдаагаа ойлгохоос зөрүүдлэн татгалзаж байгаа бол Есүсийг цагаан үүлэн дээр махбодоор эргэн ирэх үед Есүсийн ажлыг яаж ойлгож чадах юм бэ? Би та нарт үүнийг хэлье: Үнэнийг хүлээн зөвшөөрдөггүй атлаа Есүс цагаан үүлэн дээр ирэхийг сохроор хүлээдэг хүмүүс Ариун Сүнсийг гарцаагүй доромжлох бөгөөд тэд бол устгагдах төрөл мөн. Та нар ердөө л Есүсийн нигүүлслийг хүсэж, тэнгэрийн жаргалтай ертөнцөд жаргахыг хүсдэг, гэсэн атлаа Есүсийн хэлсэн үгийг хэзээ ч дуулгавартай дагаж байгаагүй, махбодоор эргэн ирэх үедээ хэлсэн үнэнийг нь хэзээ ч хүлээн аваагүй. Есүс цагаан үүлэн дээр эргэн ирэх тухай баримтын хариуд та нар юу өргөн барих вэ? Удаа дараа нүгэл үйлдэж, үүнийгээ ахин дахин улайх чин сэтгэл үү? Цагаан үүлэн дээр эргэн ирэх Есүст та нар юуг тахил болгон өргөх вэ? Өөрсдийгөө өргөмжилдөг олон жилийн ажлаа юу? Эргэн ирсэн Есүсийг өөрсдөдөө итгүүлэхийн тулд та нар юу өргөн барих вэ? Ямар ч үнэнийг дуулгавартай дагадаггүй, биеэ тоосон уг чанараа юу?

Та нар үгээрээ л үнэнч байдаг, та нарын мэдлэг ердөө л оюун ухаан, үзэл баримтлалынх байдаг, та нарын хөдөлмөр тэнгэрийн ерөөлийг олж авахын төлөө байдаг, тэгвэл итгэл чинь ямар болж таарах вэ? Өнөөдөр ч гэсэн та нар үнэний үг нэг бүрийг чихнийхээ хажуугаар өнгөрөөдөг. Та нар Бурхан гэж юу болохыг, Христ гэж хэн болохыг мэддэггүй, Еховаг хэрхэн хүндэтгэхийг

мэддэггүй, Ариун Сүнсний ажилд хэрхэн орохыг мэддэггүй, Бурханы Өөрийн ажил болон хүний мэхлэлтийг хэрхэн ялгахаа мэддэггүй. Чи Бурханы илэрхийлсэн, бодолтой чинь нийцдэггүй үнэний үгийг яллахаа л мэддэг. Даруу байдал чинь хаана байна вэ? Дуулгавартай байдал чинь хаана байна вэ? Үнэнч байдал чинь хаана байна вэ? Үнэнийг эрж хайх хүсэл чинь хаана байна вэ? Бурханыг хүндлэх хүндлэл чинь хаана байна вэ? Би та нарт хэлье, тэмдгийн улмаас Бурханд итгэдэг хүмүүс бол гарцаагүй устгагдах ангилалд багтдаг. Махбодоор эргэн ирсэн Есүсийн үгийг хүлээн зөвшөөрөх чадваргүй хүмүүс бол гарцаагүй тамын үр удам, тэргүүн тэнгэрэлчийн үр хойч, мөнхийн сүйрэлд өртөх ангилал юм. Олон хүн Миний хэлсэн зүйлийг тоохгүй байж магад, гэвч Есүс тэнгэрээс цагаан үүлэн дээр бууж ирэхийг хоёр нүдээрээ харах үед чинь зөвт байдлын Нар олон нийтэд үзэгдэнэ гэдгийг Би Есүсийг дагадаг ариун хүмүүс гэгддэг хүн бүрд хэлэхийг хүсэж байна. Есүс тэнгэрээс буун ирж буйг нүдээр үзэх тэр үе чамд маш сэтгэл догдлом мөч байж болох ч энэ үе бас шийтгүүлэхээр там руу буух үе чинь гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийн цаг үе байх бөгөөд Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэх үе байх болно. Учир нь, хүн тэмдгийг харахаас өмнө, үнэний илэрхийлэл л байх үед Бурханы шүүлт дууссан байх болно. Үнэнийг хүлээн авдаг, тэмдгийг эрж хайдаггүй хүмүүс ариусаж, Бурханы сэнтийн өмнө эргэн ирж, Бүтээгчийн тэвэрт орсон байх болно. “Цагаан үүл хөлөглөн ирээгүй Есүс бол хуурамч Христ” хэмээн муйхарлан итгэдэг хүмүүс мөнхийн шийтгэл хүртэнэ, учир нь тэд тэмдэг үзүүлдэг Есүст л итгэдэг, харин хатуу шүүлт зарлан, амийн үнэн замыг гаргадаг Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхээр Есүс цагаан үүлэн дээр ил тодоор эргэн ирэх үедээ л үүнийг шийдвэрлэх болно. Тэд хэтэрхий зөрүүд, өөртөө итгэлтэй, биеэ тоосон. Иймэрхүү өөдгүй хүмүүс яаж Есүсээр шагнуулж чадах билээ? Есүс эргэн ирнэ гэдэг нь үнэнийг хүлээн зөвшөөрөх чадвартай хүмүүсийн хувьд агуу аврал, тэгж чаддаггүй хүмүүсийн хувьд яллалтын тэмдэг юм. Та нар өөрсдийн замыг сонгох хэрэгтэй ба Ариун Сүнсийг доромжилж, үнэнийг голох ёсгүй. Та нар юм мэдэхгүй, биеэ тоосон хүн байх бус, харин Ариун Сүнсний удирдамжийг дуулгавартай дагаж, үнэнийг хүсэн хүлээж, эрж хайдаг хүн байх хэрэгтэй; ийм байдлаар л та нар ашиг тус хүртэх болно. Би та нарт Бурханд итгэх замаар хянуур явахыг зөвлөж байна. Дүгнэлт хийх гэж бүү яар; түүнчлэн, Бурханд итгэх итгэлдээ хайхрамжгүй, бодлогогүй бүү бай. Бурханд итгэдэг хүмүүс ядаж даруу агаад хүндлэлтэй байх ёстой гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Үнэнийг сонссон хэр нь хямсганадаг хүмүүс бол

ухаангүй, мэдлэггүй хүмүүс юм. Үнэнийг сонссон мөртөө хайхрамжгүйгээр дүгнэлт хийх гэж яардаг, эсвэл үнэнийг ялладаг хүмүүс бардамналд идэгдсэн байдаг. Есүст итгэдэг хэн ч бай бусдыг харааж, яллах эрхгүй. Та нар бүгд бодлоготой, үнэнийг хүлээн авдаг хүмүүс байх хэрэгтэй. Магадгүй үнэний замыг сонсож, амийн үгийг уншаад, энэ 10,000 үгээс ганц нь л чиний бодол санаа болон Библи тэй нийцэж байна гэж бодвол энэ 10,000 үгээс ганцыг нь чи цааш эрж хайх хэрэгтэй. Өөртөө хэт итгэлтэй байж, өөрийгөө хэт өндөрт өргөмжлөлгүйгээр даруу байхыг Би чамд бас зөвлөө. Бурханыг өчүүхэн төдий хүндэтгэх зүрх сэтгэлтэй бол чи илүү их гэрлийг олж авна. Чи эдгээр үгийг анхааралтай шинжилж, ахин дахин тунгаавал эдгээр нь үнэн мөн эсэх, амь мөн эсэхийг ойлгох болно. Магадгүй зарим хүн цөөн хэдэн өгүүлбэр уншчихаад л эдгээр үгийг сохроор яллаж, “Энэ чинь Ариун Сүнсний бага зэрэг гэгээрлээс цаашгүй юм байна” эсвэл “Энэ бол хүмүүсийг төөрөлдүүлэх гэж ирсэн хуурамч Христ байна” гэж хэлнэ. Ингэж хэлдэг хүмүүс мэдлэггүй байдалдаа сохорсон байдаг. Чи Бурханы ажил, мэргэн ухааны талаар хэтэрхий өчүүхэн ойлголттой тул чамд Би дахиад эхнээс нь эхэл гэж зөвлөж байна! Та нар эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд илэрдэг гээд Бурханы хэлсэн үгийг сохроор яллах ёсгүй, залилуулахаас айсандаа Ариун Сүнсийг доромжилдог нэгэн байх ёсгүй. Тэгвэл асар том эмгэнэл болох бус уу? Ихээхэн судалж шинжилснийхээ дараа ч чи эдгээр үг нь үнэн биш, зам биш, Бурханы илэрхийлэл биш гэдэгт итгэсээр байвал эцэстээ шийтгүүлж, ямар ч ерөөлгүй хоцорно. Хэрэв чи ийм тодорхой, илэн далангүй хэлсэн үнэнийг хүлээн зөвшөөрч чадахгүй бол Бурханаар авруулахад тохирохгүй бус уу? Чи Бурханы сэнтийн өмнө эргэн очихуйц ерөөгдсөн хүн биш гэж үү? Бодоод үз! Бодлогогүй, хуумгай бүү бай, Бурханд итгэх итгэлд тоглоом мэт бүү ханд. Хүрэх газрынхаа төлөө, хэтийн ирээдүйнхээ төлөө, амийнхаа төлөө бод, мөн өөрөөрөө бүү тогло. Чи эдгээр үгийг хүлээн зөвшөөрч чадах уу?

ХРИСТТЭЙ НИЙЦДЭГГҮЙ ХҮМҮҮС ГАРЦААГҮЙ БУРХАНЫГ ЭСЭРГҮҮЦЭГЧИД ЮМ

Бүх хүн Есүсийн жинхэнэ төрхийг харахыг хүсдэг бөгөөд бүгд Түүнтэй хамт байхыг хүсдэг. Ах эгч нарын хэн нь ч Есүсийг харахыг эсвэл Түүнтэй хамт байхыг хүсдэггүй гэж хэлэхгүй байх хэмээн Би бодож байна. Есүсийг харахаасаа өмнө, бие махбодтой болсон Бурханыг харахаасаа өмнө магад та нар Есүсийн

илрэлт, ярьж байгаа байдал, амьдралын хэв маяг гэх мэтийнх нь талаар төрөл бүрийн санаа бодол тээж байдаг. Гэвч Түүнийг үнэхээр харах үед та нарын санаа бодол даруй өөрчлөгдөнө. Яагаад тэр вэ? Та нар мэдэхийг хүсэж байна уу? Хүний бодлыг үл тоомсорлож болохгүй гэдэг нь үнэн боловч түүнээс ч илүүтэйгээр Христийн мөн чанарыг хүн өөрчлөхийг тэвчишгүй. Та нар Христийг үхэшгүй мөнх, эсвэл мэргэн хүн гэж боддог боловч хэн ч Түүнийг бурханлаг мөн чанартай ердийн хүн гэж үздэггүй. Тиймээс Бурханыг харахаар өдөр шөнөгүй хүсэмжилж байдаг олон хүн үнэндээ Бурхантай дайсагнадаг бөгөөд Түүнтэй нийцдэггүй. Энэ нь хүний гаргадаг алдаа бус уу? Христийн дүр төрхийг харах гавьяатай нэгэн болоход итгэлтэй, үнэнч байгаа маань л хангалттай гэж та нар одоо ч гэсэн боддог, гэвч өөрсдийгөө илүү их бодитой зүйлсээр зэвсэглэхийг Би та нарт захиж байна! Яагаад гэвэл, өнгөрсөн, одоо, ирээдүйд Христтэй уулзаж учирч байсан хүмүүсийн ихэнх нь бүтэлгүйтсэн эсвэл бүтэлгүйтэх болно; тэд бүгд фарисайчуудын үүрэг гүйцэтгэдэг. Та нарын бүтэлгүйтсэн шалтгаан юу вэ? Гол нь та нарын үзэлд сүрдэм, гайхан биширмээр Бурхан байдгаас л улбаатай юм. Гэхдээ бодит үнэн хүний хүссэнтэй адилгүй. Христ сүрдэм биш байгаад зогсохгүй, харин бүр ч жижигхэн; Тэр хүн, тэр тусмаа бүр жирийн л нэг хүн; Тэр тэнгэр өөд гарч чадах нь байтугай газар дээр эрх чөлөөтэй явж ч чаддаггүй. Ийм болохоор хүмүүс Түүнд жирийн хүнд ханддаг шигээ ханддаг; тэд Түүнтэй хамт байхдаа Түүнд хайнга хандаж, Түүнтэй хайхрамжгүй ярьж, тэр зуураа “жинхэнэ Христийн” ирэхийг хүлээсээр байдаг. Аль хэдийн ирчхээд байгаа Христийг та нар жирийн хүн гэж тооцдог бөгөөд Түүний үгийг жирийн хүний үг гэж үздэг. Энэ шалтгааны улмаас та нар Христээс юу ч аваагүй, харин оронд нь өөрсдийн муу муухай байдлыг гэрэлд бүрэн ил гаргасан.

Христтэй уулзахаасаа өмнө магад чиг, зан чанараа бүрэн өөрчлөгдсөн, өөрийгөө Христийн үнэнч дагагч, Христийн ерөөлийг хүлээн авах чамаас илүү гавьяатай хүн өөр байхгүй бөгөөд олон замаар явж, ихээхэн ажил хийж, их үр дүн гаргасан болохоороо эцэст нь титэм хүлээн авах хүмүүсийн нэг болох нь гарцаагүй хэмээн итгэдэг. Гэвч чиний мэддэггүй байж болох нэг бодит үнэн бий: Христийг харах үед хүний завхарсан зан чанар болон тэрслүү байдал, эсэргүүцэл нь ил болдог бөгөөд тэр үед ил болдог тэрслүү байдал, эсэргүүцэл нь хэзээ хэзээнйхээс ч илүү бүрэн дүүрэн, бүхэлдээ илчлэгддэг. Учир нь Христ бол хүний Хүү—хэвийн хүн чанартай, хүний Хүү учраас хүн Түүнийг дээдэлдэг ч үгүй, мөн хүндэлдэг ч үгүй. Бурхан махбодод амьдардаг болохоор л хүний тэрслүү байдал нэгд нэггүй агаад тийм тод томруунаар ил болсон. Иймээс

Христийн ирэлт нь хүн төрөлхтний бүх тэрслүү байдлыг ухан гаргаж, хүн төрөлхтний уг чанарыг илэрхий болгосон гэж Би хэлдэг. Үүнийг “барыг уулнаас буулгах” болон “чоныг үүрнээс нь гаргах” гэж нэрлэдэг. Чи өөрийгөө Бурханд үнэнч гэж хэлж зүрхлэх үү? Бурханд туйлын дуулгавартай байдаг гэж чи хэлж зүрхлэх үү? Чи тэрслүү биш гэж хэлж зүрхлэх үү? Зарим хүн, “Бурхан намайг шинэ орчинд оруулах болгонд би дургүйцэн бувтнахгүйгээр байнга захирагддаг, цаашлаад би Бурханы талаар ямар ч үзэл тээдэггүй” гэдэг. Зарим нь, “Бурхан надад ямар ч ажил өгсөн бай, би чадлынхаа хэрээр хийдэг, хэзээ ч хуумгай ханддаггүй” гэж хэлнэ. Тэгвэл Би та нараас ингэж асууя: Та нар Христтэй хамт амьдрахдаа Түүнтэй нийцэлтэй байж чадах уу? Та нар хэр удаан Түүнтэй нийцэлтэй байх вэ? Нэг өдөр үү? Хоёр өдөр үү? Нэг цаг уу? Хоёр цаг уу? Та нарын итгэлийг магтууштай байж болох ч тууштай байдал та нарт нэг их байдаггүй. Чи Христтэй жинхэнээсээ хамт амьдрах үед өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө чухалчилдаг зан чинь чиний үг, үйлдлээр дамжуулан бага багаар илчлэгддэг бөгөөд та нарын бардамнах хүсэл, дуулгаваргүй сэтгэлгээ, сэтгэл дундуур байдал ч бас аяндаа илчлэгдэнэ. Эцэст нь чиний биеэ тоосон зан улам нэмэгдсээр Христтэй гал ус мэт зөрчилдөх хэмжээнд хүрэхэд уг чанар чинь бүрэн ил болно. Тэр үед чиний үзэл далдлагдахаа больж, гомдол чинь ч гэсэн аяндаа ил гарах бөгөөд олиггүй хүн чанар чинь бүрэн ил болно. Гэхдээ тэр үед ч гэсэн чи тэрслүү байдлаа хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй, харин оронд нь ийм Христийг хүн хүлээн зөвшөөрөхөд амаргүй, Тэр хүнд хэтэрхий хатуу ханддаг, хэрвээ илүү эелдэг зөөлөн Христ байсан бол Түүнд бүрэн захирагдах байсан юм гэж итгэдэг. Та нар тэрслүү байдлаа зөвтгөх шалтгаантай, тэвчээрийг чинь барах үед л та нар Түүний эсрэг тэрсэлдэг гэж итгэдэг. Христийг Бурхан гэж үздэггүй, Түүнийг дуулгавартай дагах бодолгүй байдаг тухайгаа та нар хэзээ ч бодож байгаагүй. Тэгсэн мөртөө чи Христээс хүслийнхээ дагуу ажиллахыг муйхарлан шаарддаг бөгөөд Түүнийг нэг л зүйлийг чиний бодсоноос өөрөөр хиймэгц Түүнийг Бурхан биш, харин хүн юм байна гэж чи итгэдэг. Ийм маягаар Түүнтэй тэмцэлдсэн хүн та нарын дунд олон байдаггүй гэж үү? Эцсийн эцэст та нар хэнд итгэдэг юм бэ? Та нар ямар байдлаар эрж хайдаг вэ?

Та нар Христийг харахыг үргэлж хүсдэг, гэхдээ өөрсдийгөө ингэж өндрөөр үнэлэх хэрэггүй гэж Би та нарыг ятгах байна. Хүн бүр Христийг харж болох боловч хэн ч Христийг харахад тохирохгүй гэж Би хэлдэг. Хүний уг чанар нь ёрын муу, биеэ тоосон зан, тэрслүү байдлаар дүүрэн учраас Христийг харах мөчид уг чанар чинь чамайг үгүй хийж, үхлээр яллах болно. Ахтай (эсвэл эгчтэй)

харилцах харилцаа чинь чиний талаар ихийг өгүүлэхгүй байж болно, гэвч Христтэй харилцах үед тийм ч амар байхгүй. Хэзээ ч хамаагүй үзэл чинь үндэслэж, биеэ тоосон зан чинь соёолж, тэрслүү байдал чинь инжрээр жимсэлж болзошгүй. Иймэрхүү хүн чанартай байж чи Христтэй харилцахад хэрхэн тохирох билээ? Өдөр болгоны хором бүрд чи Түүнд Бурхан гэж хандаж үнэхээр чадах уу? Бурханд захирагдах бодит байдал чамд үнэхээр бий юү? Та нар өөрийнхөө зүрх сэтгэл дэх өндөр дээд Бурханыг Ехова гэж шүтэн мөргөдөг хэр нь нүднээ илхэн Христийг хүн гэж үздэг. Та нарын эрүүл ухаан дэндүү дорд, хүн чанар чинь даанч дорой ажээ! Та нар Христийг үргэлж Бурхан гэж үзэх чадваргүй; хааяа хааяахан дураа хүрэх үедээ л Түүнийг барьж аваад, Бурхан гэж шүтэн мөргөх бөлгөө. Тийм учраас Би та нарыг Бурханы итгэгчид биш, харин Христийг эсэргүүцдэг бүлэг хамсаатан гэж хэлж байгаа юм. Бусдад сайхан сэтгэл гаргадаг хүмүүсийн ч ачийг хариулдаг байтал та нарын дунд ийм ажил хийсэн Христ, хүний хайрыг ч хүлээсэнгүй, хүнээс хариу төлөөс, дуулгавартай байдлыг ч хүлээн авсангүй. Энэ нь сэтгэл өвтгөм зүйл биш гэж үү?

Чи олон жил Бурханд итгэж, хэзээ ч хэнийг ч хараагаагүй, эсвэл нэг ч муу үйл үйлдээгүй байж магадгүй, гэхдээ Христтэй харилцахдаа чи үнэнийг ярьж, үнэнч шударга зан гаргаж, эсвэл Христийн үгийг дуулгавартай дагаж чаддаггүй; тийм болохоор Би чамайг дэлхий дээрх хамгийн хорон муу, хорлонтой хүн гэж Би хэлдэг юм. Чи хамаатан садан, найз нөхөд, эхнэр (эсвэл нөхөр), хөвгүүд охид, эцэг эхдээ гойд найрсаг, үнэнч хайртай байж, бусдыг хэзээ ч завшиж байгаагүй байж болох боловч, хэрвээ чи Христтэй нийцэлтэй байх чадваргүй, эв зохицолтой харьцаж чаддаггүй бол хэдий хөршүүддээ тусламж үзүүлэхэд байгаа бүхнээ зарлагаддаг, эсвэл эцэг эх, гэр бүлийн гишүүдээ сайтар халамжилдаг байсан ч гэсэн, Би чамайг бас л хорон муу хүн, тэр ч байтугай зальжин арга мэхээр дүүрэн нэгэн гэж хэлнэ. Бусадтай эв найртай байдаг, эсвэл хэдхэн сайн үйл хийсэн болохоороо л өөрийгөө Христтэй нийцэлтэй гэж бүү бод. Чи тусархаг санаа зорилгоороо Тэнгэрийн ерөөлийг шударга бус аргаар олж авч чадна гэж бодож байна уу? Хэдхэн сайн үйл хийх нь дуулгавартай байдлыг чинь орлож чадна гэж чи бодож байна уу? Хэдийгээр та нарын нэг нь ч харьцалт, засалтыг хүлээн зөвшөөрч чаддаггүй, бүгдэд чинь Христийн хэвийн хүн чанарыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү санагддаг боловч та нар Бурханд дуулгавартай гэдгээ байнга зарлаж байдаг. Та нарынх шиг ийм итгэл тохирох залхаан цээрлүүлэлтээ хүртэнэ. Хий хоосон төөрөгдөлд автаж, Христийг харахыг хүсэхээ боль, учир нь та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан, бүр Түүнийг

харахад ч тохирохооргүй жаахан. Чи тэрслүү байдлаа бүрэн хаяж, Христтэй эв зохицолтой байж чаддаг болсон мөчид Бурхан чамд аяндаа харагдана. Хэрвээ чи засалт, шүүлт туулахгүйгээр Бурхантай уулзахаар очвол гарцаагүй Бурханыг эсэргүүцэгч болох бөгөөд сүйрэх тавилантай. Хүний уг чанар төрөлхийн Бурханд дайсагнадаг, учир нь бүх хүнийг Сатан хамгийн гүн ялзруулсан. Хэрвээ хүн завхрал дундаасаа гаралгүйгээр Бурхантай харилцахаар оролдвол эндээс ямар ч сайн үр дүн гарахгүй нь тодорхой; үг, үйлдэл нь түүний завхралыг алхам тутамд нь ил болгох нь гарцаагүй бөгөөд Бурхантай харилцах үед тэрслүү байдал нь бүх талаараа илчлэгдэнэ. Хүн өөрийн мэдэлгүйгээр Христийг эсэргүүцэж, Христийг хуурч, Христийг хаядаг; тэр үед хүн нэн аюултай байдалд орох ба энэ нь үргэлжилбэл тэр шийтгүүлэх нэгэн болно.

Хэрвээ Бурхантай харилцах нь ийм аюултай юм бол Бурханаас хол байсан нь дээр гэж зарим хүн бодох байх. Иймэрхүү хүмүүс ер нь юу олж авч чадах юм бэ? Тэд Бурханд үнэнч байж чадах уу? Мэдээж, Бурхантай харилцах нь маш хэцүү, гэхдээ энэ нь хүн завхралаас улбаатай болохоос биш Бурхан хүнтэй харилцах боломжгүйдээ биш юм. Та нар өөрсдийгөө таньж мэдэх үнэнд зориулж илүү хичээл зүтгэл гаргасан нь хамгийн өлзийтэй. Бурхан Яагаад та нарыг сайшаадаггүй вэ? Та нарын зан чанар яагаад Түүний дургүйг хүргэдэг вэ? Та нарын яриа яагаад Түүний зэвүүцлийг өдөөдөг вэ? Та нар бага зэрэг үнэнч зан гаргамагцаа өөрсдийгөө магтаж, жаахан хувь нэмрийнхээ төлөө шагнал шаарддаг; ялимгүй дуулгавартай байдал харуулах үедээ бусдыг дорд үзэж, аар саархан ажил хийнгүүтээ Бурханд тоомсоргүй ханддаг. Бурханыг гэртээ хүлээж авсныхаа төлөө чи мөнгө, эд зүйлс, магтаал нэхдэг. Ганц хоёр зоос өгөхдөө сэтгэл чинь өвддөг; арвыг өгөх үедээ чи ерөөл хүсэж, чамд бусдаас өөр хандахыг хүсдэг. Та нарынх шиг хүн чанарын талаар ярьж, сонсоход үнэхээр тэвчишгүй. Та нарын үг болон үйлдэлд магтууштай юм байна уу? Үүргээ биелүүлдэг хүмүүс ба биелүүлдэггүй хүмүүс; удирддаг хүмүүс ба дагадаг хүмүүс; Бурханыг гэртээ хүлээн авдаг ба хүлээн авдаггүй хүмүүс; хандивладаг ба хандивладаггүй хүмүүс; номлодог ба үгийг хүлээн авдаг хүмүүс гэх мэт бүх хүмүүс өөрсдийгөө магтдаг. Энэ та нарт инээдтэй санагдахгүй байна уу? Бурханд итгэдэг гэдгээ та нар сайн мэддэг хэдий ч Бурхантай нийцэлтэй байж чаддаггүй. Та нар ямар ч ач гавьяагүй гэдгээ сайн мэдсээр байж үргэлж л сайрхсан хэвээр байдаг. Өөрийгөө хянаж чадахаа больтлоо эрүүл ухаан чинь дордсон юм шиг та нарт санагдахгүй байна уу? Ийм эрүүл ухаантай байж та нар Бурхантай харилцахад яаж тохирох юм бэ? Энэ чухал мөчид та нар

өөрсдийнхөө төлөө санаа зовнихгүй байна уу? Та нарын зан чанар аль хэдийн Бурхантай нийцэлтэй байж чадахааргүй хэмжээнд хүртлээ доройтсон. Тийм болохоор та нарын итгэл инээдтэй биш гэж үү? Та нарын итгэл утгагүй биш гэж үү? Чи ирээдүйдээ хэрхэн хандах гэж байна вэ? Чи өөрийн алхах замыг хэрхэн сонгох гэж байна вэ?

ДУУДАГДДАГ НЬ ОЛОН Ч СОНГОГДДОГ НЬ ЦӨӨХӨН

Дагалдагчаа болгохын тулд Би газар дэлхий дээр олон хүнийг хайсан. Энэ бүх дагалдагч дунд тахилчид, удирдагчид, Бурханы хөвгүүд, Бурханы ардууд болон үйлчлэл үзүүлдэг хүмүүс бий. Надад үзүүлдэг үнэнч байдалд нь үндэслэн би тэднийг ангилдаг. Бүгд төрлөөрөө ангилагдах үед, өөрөөр хэлбэл, төрөл бүрийн хүний уг чанар тодорхой болох үед Би хүн төрөлхтнийг аврах зорилгодоо хүрэхийн тулд хүн болгоныг зөв ангилалд нь тоолж, тус бүрийг нь тохирох газарт нь тавина. Би аврахыг хүссэн хүмүүсээ бүлэг бүлгээр нь Өөрийн гэрт дуудаж, дараа нь эцсийн өдрүүдийн ажлаа тэднээр бүгдээр нь хүлээн авхуулдаг. Үүний зэрэгцээ, Би тэднийг төрлөөр нь ангилж, дараа нь үйлдэлд нь үндэслээд хүн бүрийг шагнах юм уу шийтгэдэг. Энэ бол Миний ажлыг бүрдүүлдэг алхмууд юм.

Өнөөдөр Би газар дээр, хүмүүсийн дунд амьдардаг. Хүмүүс Миний ажлыг туулж, Миний айлдварыг хардаг, үүний сацуу Би дагалдагч бүрдээ бүх үнэнийг хайрласнаар тэд Надаас амийг хүлээн авч, улмаар өөрсдийн алхах замыг олж авч болох юм. Учир нь Би бол Бурхан, амь Өгөгч билээ. Олон жилийн ажлын маань туршид хүмүүс ихийг олж авч, ихийг хаясан мөртөө Надад үнэхээр итгэдэггүй гэж Би одоо ч хэлдэг. Учир нь хүмүүс Бурхан гэдгийг минь амаараа л хүлээн зөвшөөрдөг боловч Миний хэлдэг үнэнтэй санал нийлдэггүй, түүнчлэн тэднээс Миний шаарддаг үнэнийг хэрэгжүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, хүмүүс үнэний оршин тогтнолыг бус, Бурханы оршин тогтнолыг л хүлээн зөвшөөрдөг; хүмүүс амийн оршин тогтнолыг бус, Бурханы оршин тогтнолыг л хүлээн зөвшөөрдөг; хүмүүс Бурханы мөн чанарыг бус, нэрийг нь л хүлээн зөвшөөрдөг. Би зүтгэлийнх нь төлөө, Намайг мэхлэхийн тулд сайхан сонсогдох үгийг л ашигладгийнх нь төлөө тэднийг жигшдэг; тэдний хэн нь ч Намайг үнэхээр шүтэн мөргөдөггүй. Та нарын үг могойн уруу таталтыг агуулдаг; цаашлаад, тэдгээр нь туйлын ихэрхүү, тэргүүн тэнгэрэлчийн жинхэнэ тунхаглал. Түүнээс гадна, та нарын үйл хэрэг хөсөрдөж, гутамшигтай хэмжээнд хүртлээ салбайж муудсан;

хэрээс хэтэрсэн хүсэл, шуналт санаа зорилго чинь сонсож тэвчимгүй байдаг. Та нар бүгд Миний гэрт цагаан эрвээхэй болж, зэвүүцэлтэйгээр хаягдах зүйл болсон. Та нарын хэн нь ч үнэнийг хайрладаггүй; харин ч ерөөгдөж, тэнгэр өөд гарч, Христ газар дэлхий дээр эрх мэдэл эзэмших гайхамшигт үзэгдлийг харахыг хүсдэг. Гэхдээ, маш гүн завхарсан, Бурхан гэж юу болохыг огт мэддэггүй та нар шиг хүн яаж Бурханыг дагахад тохирох билээ гэж та нар ер нь бодож байсан уу? Яаж тэнгэр өөд гарч чадах билээ? Ийм гайхамшигт дүр зургийг буюу урьд өмнө үзэгдээгүй сүр жавхлант дүр зургийг харахад яаж тохирох билээ? Ам чинь хууран мэхлэлт, бузар булай, урван тэрслэлт, биеэ тоосон үгээр дүүрсэн байдаг. Та нар Надад чин сэтгэлийн үг, ариун үг, Миний үгийг туулснаар Надад захирагдсан үгийг хэзээ ч хэлж байгаагүй. Эцэст нь, та нарын итгэл ямар вэ? Та нарын зүрх сэтгэлд ердөө хүсэл, мөнгө л байдаг, оюун ухаанд чинь материаллаг зүйл л байдаг. Өдөр бүр Надаас ямар нэгэн зүйлийг яаж авахаа тооцоолдог. Өдөр бүр Надаас хэчнээн их эд баялаг, хэчнээн их материаллаг зүйл олж авснаа тоолдог. Өдөр бүр, илүү ихийг, илүү өндөр стандартыг эдлэхийн тулд та нар бүр ч их ерөөл өөрсөд дээр чинь бууж ирэхийг хүлээдэг. Хором бүрд та нарын бодол санаанд Би биш, Надаас ирдэг үнэн ч биш, харин та нарын нөхөр, эхнэр, хөвгүүд, охид болон идэж, өмсдөг эд зүйлс чинь байдаг. Та нар яаж бүр их, дээд зэргийн таашаал авч болох талаар л боддог. Гэвч гэдсээ хагартал чихсэн ч та нар цогцос хэвээр бус уу? Гаднаа үнэхээр сайхан хувцсаар өөрсдийгөө гоёсон ч гэсэн, алхаж яваа амьгүй цогцос хэвээр бус уу? Та нар ходоодныхоо төлөө үсээ бууралттал шаргуу ажилладаг ч, Миний ажлын төлөө ширхэг үс ч золиосолдоггүй. Та нар байнга завгүй байж, махан биеийнхээ төлөө, охид хөвгүүдийнхээ төлөө биеэ зүдрээж, тархиа гашилдаг ч—нэг нь ч Миний хүслийн төлөө санаа зовниж, сэтгэл түгшдэггүй. Та нар Надаас юу олж авна гэж найдсаар байгаа юм бэ?

Ажиллаж байхдаа Би хэзээ ч яардаггүй. Хүмүүс Намайг хэрхэн дагаж байгааг үл харгалзан, ажлаа алхам бүрийн дагуу, төлөвлөгөөнийхөө дагуу хийдэг. Тиймээс Миний эсрэг бүх тэрслэлтийг чинь үл тоон Би тасралтгүй ажилласаар байгаа бөгөөд хэлэх ёстой үгээ үргэлжлүүлэн хэлсээр байдаг. Би Өөрийн үгийг сонсгох гэсэндээ урьдчилан тогтоосон хүмүүсээ Өөрийн гэрт дууддаг. Миний үгэнд захирагдаж, Миний үгийг хүсэн эрмэлздэг бүх хүнийг Би сэнтийнхээ өмнө авчирдаг; Миний үгээс нүүр буруулдаг, Намайг дуулгавартай дагадаггүй, Намайг илт эсэргүүцдэг бүх хүнд эцсийн шийтгэлийг нь хүлээлгэхээр нэг тийш хаядаг. Хүмүүс бүгд завхрал дунд, ёрын муу нэгний гар

дор амьдардаг тул Намайг дагадаг хүмүүсээс цөөхөн нь үнэнийг хүсэмжилдэг. Өөрөөр хэлбэл, ихэнх нь Намайг үнэхээр шүтэн мөргөдөггүй; тэд Намайг үнэнтэй хамт шүтэн мөргөдөггүй, харин ов мэхтэй аргаар, завхрал, тэрслэлтээр дамжуулан Миний итгэлийг олж авахаар хичээдэг. Энэ шалтгааны улмаас Би ингэж хэлдэг: Дуудагддаг нь олон ч сонгогддог нь цөөхөн. Дуудагддаг тэр хүмүүс гүнээ завхарсан бөгөөд бүгд нэгэн эрин үед амьдардаг—гэхдээ сонгогддог хүмүүс бол тэдний нэг хэсэг бөгөөд үнэнд итгэж, хүлээн зөвшөөрч, үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс юм. Энэ хүмүүс бол нэг бүхлийн тун өчүүхэн хэсэг бөгөөд тэдний дундаас Би илүү их алдрыг хүлээн авна. Эдгээр үгтэй харьцуулаад сонгогдсон хүмүүсийн дунд байгаа эсэхээ та нар мэдэх үү? Та нарын төгсгөл ямар байх бол?

Миний хэлсэнчлэн, Намайг дагадаг хүмүүс олон боловч Намайг үнэхээр хайрладаг нь цөөхөн. Магадгүй зарим нь “Хэрэв би Таныг хайрлаагүй бол ийм их төлөөс төлөх байсан гэж үү? Хэрэв Таныг хайрлаагүй бол энэ хүртэл дагах байсан гэж үү?” хэмээн хэлнэ. Мэдээж чамд олон шалтгаан байгаа, чиний хайр мэдээж тун их, гэхдээ Намайг гэх хайрын чинь мөн чанар юу вэ? “Хайр” гэж цэвэр, өө сэвгүй сэтгэл хөдлөлийг хэлдэг бөгөөд хайрлах, мэдрэх, хайхрамжтай байхад зүрх сэтгэлээ ашиглахыг хэлдэг. Хайранд ямар ч болзол, саад бэрхшээл, зай гэж үгүй. Хайранд ямар ч сэжиг, хууран мэхлэлт, заль мэх байдаггүй. Хайранд ямар ч наймаа, хольц үгүй. Хэрэв чи хайрладаг бол мэхлэхгүй, гомдоллохгүй, урвахгүй, тэрслэхгүй, шалж шаардахгүй, эсвэл ямар нэг зүйлийг олж авахаар, тодорхой хэмжээгээр олж авахаар эрэлхийлэхгүй. Хэрэв чи хайрладаг бол өөрийгөө баяртайяа зориулж, бэрхшээлийг баяртайгаар туулж, Надтай нийцэлтэй байж, Миний төлөө өөрт байгаа бүхнээ хаяж, гэр бүл, ирээдүй, залуу нас, гэрлэлтээ орхино. Эс тэгвээс, чиний хайр ердөө ч хайр биш, харин хууран мэхлэлт, урвалт байх болно! Чиний хайр ямар хайр вэ? Жинхэнэ хайр мөн үү? Эсвэл хуурамч уу? Чи хэр ихийг хаясан бэ? Чи хэр ихийг өргөн барьсан бэ? Чамаас Би хэр их хайр хүлээн авсан бэ? Чи мэдэх үү? Зүрх сэтгэл чинь ёрын муу, урвалт, хууран мэхлэлтээр дүүрэн байдаг—ийм байхад та нарын хайрын хэчнээн нь хольцтой байх вэ? Та нар Миний төлөө аль хэдийн хангалттай ихийг орхисон гэж боддог; Намайг гэх хайр чинь аль хэдийн хангалттай гэж боддог. Тэгвэл үг, үйлдэл чинь яагаад үргэлж тэрслүү, хуурамч байдаг юм бэ? Та нар Намайг дагадаг мөртөө Миний үгийг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч дараа нь Намайг хаядаг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч Надад итгэдэггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг

дагадаг атлаа Миний оршин тогтнолыг хүлээн зөвшөөрч чаддаггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг мөртөө хэн бэ гэдэгт минь тохируулж Надад ханддаггүй, цаг ямагт Надад хүндрэл учруулдаг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч бүх хэрэг явдал дээр Намайг хуурч, мэхлэхээр хичээдэг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Надад үйлчилдэг хэрнээ Надаас эмээдэггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг бүх талаар, бүх зүйл дээр эсэргүүцдэг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар ихийг зориулсан нь үнэн ч Миний шаарддаг зүйлийг хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй. Үүнийг хайр гэж үзэж болох уу? Хянуур тооцоолол нь, Намайг гэх хайрын өчүүхэн ч сэжүүр та нарын дотор байдаггүй гэдгийг харуулдаг. Маш олон жилийн ажил болон энэ бүх үгээр хангасны минь дараа та нар үнэндээ хэр ихийг олж авсан бэ? Өнгөрснөө анхааралтай харвал зохистой бус уу? Би та нарт анхааруулж байна: Миний Өөр лүүгээ дууддаг хүмүүс бол хэзээ ч завхарч байгаагүй хүмүүс биш; харин ч Миний сонгодог хүмүүс бол Намайг үнэхээр хайрладаг хүмүүс билээ. Тиймээс, та нар хэрээс хэтрүүлэхгүйн тулд үг, үйл хэрэгтээ сонор сэрэмжтэй байж, санаа зорилго, бодлоо шалгах ёстой. Эцсийн өдрүүдэд Миний өмнө хайраа өргөн барихын тулд чадах бүхнээ хий, Миний уур хилэн та нараас хэзээ ч холдохгүй байх вий!

ЧИ ХРИСТТЭЙ НИЙЦЭЛТЭЙ БАЙХ ЗАМЫГ ЭРЖ ХАЙХ ЁСТОЙ

Би хүмүүсийн дунд их ажил хийсэн бөгөөд энэ хугацаандаа бас олон ч үг илэрхийлсэн. Эдгээр үг нь бүгд хүний авралын төлөө бөгөөд хүнийг Надтай нийцэлтэй болгохын тулд илэрхийлэгдсэн юм. Гэвч Би газар дээр Өөртэй минь нийцэлтэй байдаг хүн цөөн хэдийг л олж авсан, иймээс Миний үгийг хүн нандигнадаггүй гэж Би хэлнэ, учир нь хүн Надтай нийцдэггүй билээ. Энэ мэтчилэн, Миний хийдэг ажил хүнийг ердөө л Надад шүтэн мөргүүлэхийн төлөө байдаггүй; хамгийн гол нь, хүнийг Надтай нийцэлтэй байж чаддаг болгохын төлөө байдаг. Завхарсан хүн бүхэн Сатаны урхинд амьдардаг, мөн махан биед, аминчхан хүсэлд автан амьдардаг ба тэдний дунд Надтай нийцдэг хүн нэг ч байхгүй. Надтай нийцтэй гэж хэлдэг хүмүүс байдаг ч бүгд тодорхойгүй шүтээн шүтдэг. Хэдийгээр тэд Миний нэрийг ариун хэмээн хүлээн зөвшөөрдөг ч Минийхээс эсрэг замаар явдаг, тэдний үг биеэ тоосон зан, өөртөө итгэлтэй байдлаар дүүрэн байдаг. Учир нь угтаа тэд бүгдээрээ Миний эсрэг байдаг бөгөөд Надтай нийцдэггүй. Өдөр болгон тэд Библиэс Миний ул мөрийг эрж

хайж, “тохиромжтой” эшлэлийг тохиолдлоор олоод, түүнийгээ уйгагүй уншиж, судар мэт цээжээр дууддаг. Тэд Надтай хэрхэн нийцэлтэй байхаа мэддэггүй, Надтай дайсагнах гэж юуг хэлдгийг ч мэддэггүй. Зүгээр л бичвэрүүдийг сохроор уншдаг. Тэд өөрсдийн хэзээ ч хараагүй, харж ч чадахгүй тодорхойгүй Бурханыг Библи дотор хязгаарлачхаад, үүнийгээ завтай цагтаа гаргаж хардаг. Тэд ердөө Библийн хүрээнд л Миний оршин тогтнолд итгэдэг, тэд Намайг Библийг ажилладаг; Библи байхгүй бол Би гэж үгүй, Би байхгүй бол Библи гэж үгүй. Тэд Миний оршин тогтнол болон үйлдэлд ямар ч анхаарал хандуулдаггүй, харин оронд нь Бичвэрийн үг нэг бүрд туйлын онцгой анхаарал хандуулдаг бөгөөд Бичвэрт зөгнөөгүй л бол Намайг хийхийг хүссэн зүйлээ огт хийх ёсгүй гэж олонх нь итгэдэг. Тэд Бичвэрт хэтэрхий их ач холбогдол өгдөг. Тэд үг үсгийг хэтэрхий чухалчилж, эцэстээ бүр хэлсэн үг бүрийг минь дэнсэлж, Намайг яллахад Библийн эшлэлүүдийг ашигладаг гэж хэлж болно. Тэдний эрж хайдаг зүйл нь Надтай нийцэлтэй байх зам юм уу үнэнтэй нийцэлтэй байх зам бус, харин Библийн үгтэй нийцэлтэй байх зам бөгөөд Библийг нийцэхгүй л бол бүгдийг нь, огт ялгалгүйгээр Миний ажил биш гэж тэд итгэдэг. Ийм хүмүүс фарисайчуудын ачлалт үр удам биш гэж үү? Иудейн фарисайчууд Есүсийг яллахын тулд Мосегийн хуулийг ашигласан. Тэр үед тэд Есүстэй нийцэлтэй байхыг эрж хайгаагүй, харин хуулийг үг үсэггүй хичээнгүйлэн дагаж, бүр Есүст Хуучин Гэрээний хуулийг дагаагүй, мөн Мессиа биш хэмээн ял оноогоод, эцэст нь гэм зэмгүй Есүсийг загалмайд цовдолсон. Тэд ямар мөн чанартай байсан бэ? Тэд үнэнтэй нийцэлтэй байх замыг хайгаагүй юм биш үү? Тэд Миний хүсэл болон Миний ажлын үе шат, арга барилын аль алиныг нь хайхардаггүй байсан мөртөө Бичвэрийн үг нэг бүрээр хэнээрхдэг байсан. Тэд үнэнийг эрж хайдаг биш, харин үгтэй салахгүй зууралддаг хүмүүс байсан; тэд Бурханд итгэдэг биш, харин Библид итгэдэг хүмүүс байсан юм. Үнэн хэрэгтээ тэд Библийн хоточ нохой байсан. Библийн ашиг сонирхлыг хамгаалж, Библийн нэр төрийг хадгалж, Библийн алдар хүндийг хамгаалахын тулд тэд эцэст нь өршөөнгүй Есүсийг загалмайд цовдлохдоо тулсан. Тэд ердөө Библийг хамгаалахын төлөө, хүмүүсийн зүрх сэтгэл дэх Библийн үг нэг бүрийн байр суурийг хадгалахын төлөө л үүнийг хийсэн юм. Иймээс тэд Бичвэрийн номлолыг мөрддөггүй байсан Есүсийг үхлийн ялаар яллахын тулд өөрсдийн ирээдүй болон нүглийн тахилыг хаяхыг илүүд үзсэн. Тэд Бичвэрийн үг нэг бүрийн боол байгаагүй гэж үү?

Тэгвэл өнөөдрийн хүмүүс ямар вэ? Христ үнэнийг илэрхийлэхээр ирчхээд байхад тэд тэнгэрт орж, нигүүлсэл хүртэхийн тулд Христийг энэ ертөнцөөс хөөн

зайлуулахыг илүүд үзнэ. Библийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд үнэний ирэлтийг бүрмөсөн үгүйсгэхийг илүүд үзэж, Библийн мөнх оршин тогтнолыг баталгаажуулахын тулд махбодод эргэн ирсэн Христийг загалмайд дахин цовдлохыг илүүд үзнэ. Зүрх сэтгэл нь ийм хорлонтой, Надад тийм их дайсагнадаг уг чанартай байж хүн яаж Миний авралыг хүртэж чадах юм бэ? Би хүмүүсийн дунд амьдардаг атал хүн Миний оршин байгааг мэддэггүй. Өөр дээр нь гэрлээ тусгах үед ч хүн Миний оршин байгааг мэдэхгүй хэвээр байдаг. Намайг уур хилэнгээ өөр дээр нь буулгах үед хүн Миний оршин тогтнолыг бүр ч эрс үгүйсгэдэг. Хүн үг үсэгтэй, Библи тэй нийцэхээр эрэлхийлдэг, гэхдээ үнэнтэй нийцэлтэй байх замыг хайхаар нэг ч хүн Миний өмнө ирдэггүй. Хүн тэнгэр дэх Намайг хүндэлж, тэнгэр дэх Миний оршин тогтнолд онцгой анхаарал хандуулдаг атлаа хүмүүсийн дунд амьдардаг Би бол ердөө л тун өчүүхэн нэгэн болохоор махбод дахь Миний талаар хэн ч санаа тавьдаггүй. Библийн үгтэй л, тодорхойгүй Бурхантай л нийцэлтэй байхыг эрж хайдаг хүмүүс Надад өөдгүй дорд харагддаг. Учир нь тэдний шүтэн мөргөдөг зүйл нь үхмэл үг, бас өөрсдөд нь тоо томшгүй их эд баялаг өгөх чадвартай Бурхан юм. Тэдний шүтэн мөргөдөг зүйл нь оршин байдаггүй агаад хүний эрхээр байдаг Бурхан юм. Тэгвэл ийм хүмүүс Надаас юу олж авч чадах юм бэ? Хүн ердөө л үгээр илэрхийлэхийн аргагүй дорд юм. Миний эсрэг байж, Надаас хязгааргүй ихийг шаарддаг, үнэнийг огт хайрладаггүй, Миний эсрэг тэрсэлдэг тэр хүмүүс яаж Надтай нийцэлтэй байж чадах юм бэ?

Миний эсрэг байдаг хүмүүс бол Надтай нийцэлгүй хүмүүс юм. Мөн үнэнийг хайрладаггүй хүмүүс ч Надтай нийцэлгүй хүмүүс. Миний эсрэг тэрсэлдэг хүмүүс бол бүр ч Миний эсрэг байдаг, Надтай нийцдэггүй хүмүүс билээ. Надтай нийцэлгүй бүх хүнийг Би муу ёрын нэгний гарт өгч, муу ёрын нэгний ялзралд орхиж, хорон муу үйлийг нь илчлэхийн тулд зөнгөөр нь орхиж, эцэст нь муу ёрын нэгэнд залгиулахаар шилжүүлнэ. Хэчнээн хүн Намайг шүтэн мөргөдөг нь Надад хамаагүй, өөрөөр хэлбэл, хэчнээн хүн Надад итгэдэг нь хамаагүй. Хэчнээн хүн Надтай нийцэлтэй вэ гэдэг л санааг минь чилээдэг ганц зүйл юм. Учир нь Надтай нийцэлгүй бүх хүн бол Надаас урвадаг муу ёрын хүмүүс билээ; тэд Миний дайсан бөгөөд дайснуудаа Би Өөрийн гэрт “тахихгүй.” Надтай нийцэлтэй хүмүүс Миний гэрт үүрд Надад үйлчилнэ, харин Надтай дайсагнадаг хүмүүс Миний шийтгэлийг үүрд амсана. Библийн үгийг л анхаарч, үнэний талаар юм уу Миний мөрийг эрж хайх талаар хайхрамжгүй ханддаг хүмүүс бүгд Миний эсрэг байдаг, учир нь тэд Библийн дагуу Намайг хязгаарлаж, Библийн дотор Намайг

хорьдог, тэд ийм байдлаар үйлдэх нь миний хувьд туйлын их доромжлол юм. Ийм хүмүүс яаж Миний өмнө ирж чадах юм бэ? Тэд Миний үйл хэрэгт, Миний хүсэлд, эсвэл үнэнд ямар ч анхаарал хандуулдаггүй, харин ч хүнийг үхүүлдэг үгэнд донтдог. Тийм хүмүүс яаж Надтай нийцэлтэй байж чадах юм бэ?

Би маш олон үг илэрхийлж, хүсэл болон зан чанараа ч бас илэрхийлсэн, гэсэн атал хүмүүс одоо ч Намайг мэдэж, Надад итгэх чадваргүй л байна. Эсвэл, тэд одоо ч Намайг дуулгавартай дагаж чаддаггүй гэж хэлж болно. Библид амьдрагсад, хууль дунд амьдрагсад, загалмай дээр амьдрагсад, дүрэм журмын дагуу амьдрагсад, өнөөдөр Миний хийдэг ажлын дунд амьдрагсад дундаас хэн нь Надтай нийцэлтэй вэ? Та нар ерөөл, шагнал хүртэх тухай л боддогоос биш, Надтай хэрхэн нийцэлтэй байх, Намайг эсэргүүцдэг Нэгэн болохоос хэрхэн сэргийлэх талаар хэзээ ч бодолцож үзээгүй. Би та нарт үнэхээр урам хугарч байна, учир нь та нарт Би маш ихийг өгөөд, хариуд нь та нараас өчүүхэн багыг олж авсан. Та нарын заль мэх, их зан, шунал, тансаглах хүсэл, урвалт, дуулгаваргүй байдал—эдгээрийн аль нь Надад анзаарагдалгүй өнгөрөх юм бэ? Та нар Намайг аргацааж, Намайг хуурч, Намайг гутааж, Намайг аргалж, тахилын төлөө Намайг хяхаж, сүрдүүлдэг—ийм хорон үйл яаж Миний шийтгэлээс мултарч чадах юм бэ? Та нарын эдгээр муу үйл бол Миний дайсан гэдгийн чинь нотолгоо, бас Надтай үл нийцдэгийн чинь нотолгоо юм. Та нар дор бүрнээ өөрсдийгөө Надтай маш нийцэлтэй гэж итгэдэг, гэхдээ тийм байсан юм бол эдгээр маргашгүй нотлох баримт тэгээд хэнд нь хамаарах юм бэ? Та нар өөрсдийгөө Надад туйлын чин үнэнч, итгэмжит гэдэгт итгэдэг. Та нар өөрсдийгөө маш сайхан сэтгэлтэй, өр нимгэн бөгөөд Надад маш ихийг зориулсан гэж боддог. Бас Миний төлөө хангалттай ихийг хийсэн гэж боддог. Гэвч та нар эдгээр итгэлээ өөрсдийнхөө зан авиртай жишиж үзсэн үү? Та нар бол ихэд биеэ тоосон, ихээхэн шуналтай, ихээхэн хайхрамжгүй гэж Би хэлнэ; та нарын Намайг хуурдаг арга заль нэлээд сүйхээтэй, бас та нарт жигшүүрт санаа зорилго болон арга барил их бий. Та нарын үнэнч байдал үнэхээр шалихгүй, чин сэтгэл чинь дэндүү өчүүхэн, мөс чанар чинь бүр ч дутмаг. Зүрх сэтгэл чинь дэндүү хорлонтой байдаг бөгөөд хэнийг ч, цаашлаад Намайг ч хэлтрүүлдэггүй. Та нар хүүхдүүдийнхээ төлөө, нөхрийнхөө төлөө, эсвэл өөрийнхөө бүрэн бүтэн байдлын төлөө Намайг гэртээ оруулдаггүй. Надад санаа тавихын оронд та нар өөрсдийнхөө гэр бүл, үр хүүхэд, байр суурь, ирээдүй болоод өөрсдийн жаргал цэнгэлд санаа тавьдаг. Та нар үг хэлж, үйлдэл хийх үедээ хэзээ Миний талаар бодож байсан юм бэ? Тэсгэм хүйтэн өдрүүдэд ухаан бодол чинь үр хүүхэд,

нөхөр, эхнэр, эцэг эх рүүгээ л чиглэдэг. Аагим халуун өдрүүдэд ч гэсэн та нарын бодол санаанд Намайг гэх орон зай байдаггүй. Үүргээ биелүүлэхдээ чи хувийн ашиг сонирхол, аюулгүй байдал, гэр бүлийн гишүүдээ л боддог. Чи Миний төлөө гэх юм юу хийсэн юм бэ? Хэзээ чи Миний талаар бодож байсан бэ? Хэзээ чи Миний төлөө, бас Миний ажлын төлөө ямар ч үнээр хамаагүй өөрийгөө зориулж байсан юм бэ? Надтай нийцэлтэй гэдгийн чинь нотолгоо хаана байна вэ? Надад үнэнч гэдгийн чинь бодит байдал хаана байна вэ? Дуулгавартай байдлын чинь бодит байдал хаана байна вэ? Санаа зорилго чинь хэзээ Надаас ерөөл олж авахын төлөө байгаагүй билээ? Та нар бүгд Намайг хуурч, мэхлэн, үнэнээр тоглоом хийж, үнэний оршин байгааг нуун, үнэний мөн чанараас урвадаг. Надтай ингэж дайсагнасны чинь төлөө та нарыг ирээдүйд юу хүлээж байгаа вэ? Та нар ердөө л тодорхойгүй Бурхантай нийцэлтэй байхыг болон тодорхойгүй итгэлийг эрж хайдаг, гэсэн ч та нар Христтэй нийцэлтэй биш. Ийм хорлонт үйл чинь хорон муу хүмүүст тохирсон яг тэр шийтгэлийг хүртэхгүй гэж үү? Тэр үед та нар Христтэй нийцэлгүй хэн ч уур хилэнгийн өдрөөс зугтаж чадахгүй гэдгийг ухаарч, Христтэй дайсагнадаг хүмүүст ямар төрлийн залхаан цээрлүүлэлт ирэхийг мэдэх болно. Тэр өдөр ирэх үед Бурханд итгэснийхээ төлөө ерөөгдөж, тэнгэрт орох мөрөөдөл чинь нуран унана. Харин Христтэй нийцэлтэй хүмүүсийн хувьд бол өөр хэрэг. Тэд маш ихийг алдаж, олон бэрхшээл туулсан ч хүн төрөлхтөнд өгсөн бүх өв залгамжлалыг минь хүлээн авах болно. Би л зөвт Бурхан бөгөөд Би л хүн төрөлхтнийг үзэсгэлэнтэй сайхан хүрэх газар луу аваачих чадвартай гэдгийг та нар эцэст нь ойлгоно.

ЧИ БУРХАНЫ ЖИНХЭНЭ ИТГЭГЧ МӨН ҮҮ?

Чи Бурханд итгэх итгэлийн замаар нэг, хоёроос дээш жил алхаж, энэ жилүүдэд амьдралдаа их зовлон зүдүүр амссан байж магадгүй; эсвэл магадгүй чи их зовлон зүдүүр амсалгүй, харин ч нигүүлслийг ихээр хүртсэн байж болох юм. Мөн чи зовлон, нигүүлсэл хоёрын аль алийг нь үзэлгүйгээр харин эгэл жирийн амьдралаар амьдарсан байж ч болно. Ямартай ч, чи Бурханы дагагч хэвээр тул Бурханыг дагах тухай сэдвээр нөхөрлөцгөөе. Гэвч Бурханы үг Түүнийг хүлээн зөвшөөрч, дагадаг хүмүүст чиглэдэг болохоос Түүнийг хүлээн зөвшөөрдөг ч байсан, үгүй ч байсан бүх хүнд чиглэдэггүй гэдгийг Би энэ үгсийг уншдаг бүхэнд сануулах ёстой. Хэрвээ чи Бурхан нийтэд, дэлхий дээрх бүх хүнд хандан үг хэлдэг гэж боддог бол Бурханы үг чамд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Тиймээс чи энэ

бүх үгийг зүрх сэтгэлдээ санаж, өөрийгөө байнга тэдгээрийн гадна тавихгүй байх хэрэгтэй. Ямар ч байсан, бидний гэрт юу болж байгаа талаар ярилцацгаая.

Та бүхэн одоо Бурханд итгэхийн жинхэнэ утга учрыг ойлгох хэрэгтэй. Өмнө нь Миний ярьсан Бурханд итгэхийн утга учир нь та нарын эерэг оролттой холбоотой байсан. Өнөөдөр бол өөр: Өнөөдөр, Би Бурханд итгэх итгэлийн чинь мөн чанарыг задлан шинжилмээр байна. Мэдээж, энэ нь та нарыг сөрөг талаас залж чиглүүлж буй хэрэг юм; Намайг тэгээгүй бол та нар өөрсдийн үнэн нүүр царайг үүрд мэдэлгүй, сүсэг бишрэлтэй, үнэнч байдлаараа үүрд сайрхах байсан. Хэрвээ Би зүрх сэтгэлийн гүн дэх муу муухайг чинь ил болгоогүй бол та нар дор бүрнээ толгой дээрээ титэм зүүгээд, бүх алдрыг өөрсдөдөө авч үлдэх байсан гэж хэлэхэд буруудахгүй. Биеэ тоосон, ихэрхүү уг чанар чинь өөрсдийн мөс чанараас урваж, Христийг эсэргүүцэн тэрсэлж, муу муухайгаа илчлэхэд хүргэснээр та нарын санаа зорилго, үзэл, хэрээс хэтэрсэн хүсэл, шуналаар дүүрэн нүдийг гэрэлд ил болгодог. Гэсэн ч, та нар Христийн ажлыг гэсэн насан туршийн хүсэл тэмүүллийнхээ талаар үргэлжлүүлэн чалчиж, Христийн аль эрт хэлсэн үнэнийг ахин дахин давтдаг. Энэ бол та нарын “итгэл” — “өө сэвгүй итгэл” юм. Би бүхий л хугацаанд хүнд хатуу чанд стандарт тавьж ирсэн. Хэрвээ чи санаархал болзолтойгоор үнэнч байдаг бол чиний тэр үнэнч байдал гэх зүйл Надад хэрэггүй, учир нь санаархлаараа Намайг хуурч, болзлоороо Намайг сүрдүүлдэг хүмүүсийг Би жигшин зэвүүцдэг. Би хүнийг Надад туйлын үнэнч байж, итгэл гэдэг ганц үгийн төлөө, үүнийг батлахын тулд бүх зүйлийг хийгээсэй л гэж хүсдэг. Намайг хөөргөх гэж зулгуйдахыг чинь Би үзэн яддаг, учир нь Би та нарт үргэлж чин сэтгэлээсээ ханддаг, тиймээс та нарыг ч бас Надад жинхэнэ итгэлээр хандаасай гэж хүсдэг. Итгэлийн тухайд гэвэл, өөрсдөд нь итгэл байгаа учраас Бурханыг дагадаг, эс бөгөөс ийм зовлон зүдүүрийг тэвчихгүй байсан гэж олон хүн бодож байж болох юм. Тиймээс Би чамаас үүнийг асууя: Чи Бурханы оршин тогтнолд итгэдэг юм бол яагаад Түүнийг хүндэтгэдэггүй юм бэ? Чи Бурханы оршин тогтнолд итгэдэг юм бол яагаад чамд Түүнээс жаахан ч гэсэн айх зүрх сэтгэл байдаггүй юм бэ? Чи Христийг бие махбодтой болсон Бурхан гэж хүлээн зөвшөөрдөг хэр нь Түүнийг яагаад басамжилдаг юм бэ? Чи яагаад Түүнд хүндлэлгүй ханддаг юм бэ? Чи яагаад Түүнийг ил тодоор шүүмжилдэг юм бэ? Чи яагаад үргэлж Түүний хөдөлгөөнийг тагнадаг юм бэ? Чи яагаад Түүний зохицуулалтад захирагддаггүй юм бэ? Чи яагаад Түүний үгийн дагуу үйлддэггүй юм бэ? Яагаад Түүнийг сүрдүүлж, тахилыг нь дээрэмдэхийг хичээдэг юм бэ? Чи яагаад Христийн байр сууриас үг хэлдэг юм бэ? Чи яагаад Түүний ажил болон

үг зөв эсэхийг шүүдэг юм бэ? Яагаад ар хударгаар нь Түүнийг зүхэж зүрхэлдэг юм бэ? Энэ бүхэн нь та нарын итгэл юм гэж үү?

Үг яриа, зан авирт чинь Христэд үл итгэдэг элементүүд чинь харагддаг. Хийдэг бүхний чинь сэдэл, зорилгод үл итгэл шингэсэн байдаг. Та нарын харцны золбоо хүртэл Христэд үл итгэх байдлыг агуулдаг. Та нар дор бүрнээ, хором бүрд үл итгэлийн элементийг өвөрлөж байдаг гэж хэлж болно. Энэ нь бие махбодтой болсон Бурханд үл итгэх байдал биеэр чинь гүйж буй цусанд нэвт шингэсэн учраас та нар хором мөч бүрд Христээс урвах аюулд байдаг гэсэн үг юм. Тиймээс, Бурханд итгэх замд үлдээдэг мөр чинь жинхэнэ биш гэж Би хэлдэг; Бурханд итгэх зам дээр алхахдаа чи хөлөө газарт бат тавьдаггүй—чи зүгээр л хэлбэр төдий хийж байна. Та нар Христийн үгэнд хэзээ ч бүрэн итгэдэггүй бөгөөд даруйхан хэрэгжүүлж чаддаггүй. Та нарын Христэд итгэдэггүйн шалтгаан энэ юм. Үргэлж Түүний талаар үзэлтэй байдаг чинь Түүнд итгэдэггүйн бас нэг шалтгаан мөн. Христийн ажлын талаар үргэлж эргэлзэх, Христийн үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөх, Христийн хийсэн ямар ч ажлын талаар санаа бодол өвөрлөж, энэ ажлыг зөвөөр ойлгож чадахгүй байх, яаж ч тайлбарлалаа гэсэн үзлээ хаяхад хэцүү байх зэрэг нь бүгдээрээ та нарын зүрх сэтгэлд холилдсон үл итгэлийн элементүүд юм. Та нар хэзээ ч ард хоцролгүй, Христийн ажлыг дагадаг хэдий ч зүрх сэтгэлд чинь хэт их тэрслүү байдал холилдсон байна. Энэхүү тэрслүү байдал нь Бурханд итгэх итгэлд чинь байгаа хир буртаг юм. Та нар тэгж бодохгүй байж магад, гэхдээ чи санаа зорилгоо энэ дотроос танин мэдэж чадахгүй бол мөхөх хүмүүсийн дунд байх нь гарцаагүй. Учир нь Бурхан Өөрт нь эргэлздэг хүмүүсийг бус, харин үнэхээр итгэдэг хүмүүсийг л төгс болгодог бөгөөд Түүнийг Бурхан гэж хэзээ ч итгээгүй хэр нь Түүнийг дурамжхан дагадаг хүмүүсийг бол бүр ч төгс болгохгүй.

Зарим хүн шүүлтэд байтугай, үнэнд ч баясдаггүй. Харин тэд эрх мэдэл, эд баялагт баясдаг; ийм хүмүүсийг эрх мэдэл эрэлхийлэгчид гэж нэрлэдэг. Тэд дэлхий дээрх нөлөө бүхий урсгал, шашны сургуулиас ирсэн пастор, багш нарыг л эрж хайдаг. Тэд үнэний замыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч, хагас дутуу л итгэж байдаг; тэд зүрх сэтгэл, оюун санаагаа бүрэн зориулах чадваргүй, амаараа Бурханы төлөө өөрсдийгөө зарлагадах тухай ярих боловч харц нь агуу пастор, багш нар дээр төвлөрч, Христийг зэрвэс ч хардаггүй. Зүрх сэтгэл нь нэр төр, эд баялаг, яруу алдрыг анхаардаг. Ийм өчүүхэн хүн тийм олон хүнийг байлдан дагуулах чадвартай, ийм эгэл жирийн хүн, хүнийг төгс болгох чадвартай байх боломжгүй гэж тэд боддог. Тоос тортог, өтөг бууц дундах тэдгээр хэн ч биш хүн

Бурханы сонгосон хүмүүс байх боломжгүй гэж тэд боддог. Хэрвээ ийм хүмүүсийг Бурхан авардаг байсан бол тэнгэр газар орвонгоороо эргэж, бүх хүн элгээ хөштөл инээх байсан гэж тэд үздэг. Хэрэв Бурхан энэхүү хэн ч биш хүмүүсийг төгс болгохоор сонгох юм бол өнөөх агуу хүмүүс Бурхан Өөрөө болох байсан гэж тэд боддог. Тэдний харах өнцгийг үл итгэл сэвтүүлсэн байдаг; тэд үл итгээд ч зогсохгүй, зүгээр л утгагүй араатнууд юм. Учир нь тэд байр суурь, нэр хүнд, эрх мэдлийг л үнэлдэг, зөвхөн том бүлэглэл, урсгалуудыг л хүндэтгэдэг. Тэд Христээр удирдуулж байгаа хүмүүсийг огтхон ч тоодоггүй; тэд ердөө л Христ, үнэн, амиас нүүр буруулсан урвагчид юм.

Чи Христийн даруу занг бус, харин эрхэм хүндтэй байр суурь бүхий тэр хуурамч хоньчдыг л гайхан биширдэг. Чи Христийн хайр татам байдал, мэргэн ухааныг биш, харин бузар булай ертөнцөд хөлбөрдөг тэдгээр самуун явдалтныг эрхэмлэн хайрладаг. Чи толгой хоргодох газаргүй Христийн шаналлыг шоолж, харин тахилыг эрж хайн, цадиггүй амьдардаг тэдгээр үхдэлийг гайхан биширдэг. Чи Христтэй хамт зовохыг хүсдэггүй, харин махан бие, үгээр л чамайг тэтгэж, хянаж байдаг тэр бодлогогүй антихристүүдийн тэвэрт дуртайяа очдог. Одоо ч гэсэн зүрх сэтгэл чинь тэдэн рүү, тэдний нэр хүнд, байр суурь, нөлөө рүү хандсан хэвээр байна. Гэсэн ч, чи Христийн ажилд үнэмшихэд хэцүү гэсэн хандлага баримталсан хэвээр, үүнийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй. Иймээс Христийг хүлээн зөвшөөрөх итгэл чамд байхгүй гэж Би хэлдэг. Чамд өөр ямар ч сонголт байхгүй байсан учраас л өнөөг хүртэл Түүнийг дагасан. Зүрх сэтгэлд чинь хэд хэдэн сүрлэг дүр төрх үүрд сүндэрлэж байгаа; чи тэдний үг, үйл бүрийг, мөн нөлөө бүхий үг, гарыг нь ч мартаж чаддаггүй. Та нарын зүрх сэтгэлд тэд үүрд дээдийн дээд, үүрд баатрууд хэвээрээ байдаг. Харин өнөөдрийн Христийн хувьд тийм биш. Чиний зүрх сэтгэлд Тэр үүрд ялихгүй хэвээрээ, үүрд хүндэтгэл хүлээх зохисгүй хэвээрээ. Учир нь Тэр хэтэрхий эгэл, хэтэрхий бага нөлөөтэй, ямар ч сүрлэг байдалгүй.

Ямар ч байсан, үнэнийг үнэлдэггүй бүх хүн бол үл итгэгчид, үнэнээс урвагчид юм гэж Би хэлдэг. Ийм хүмүүс хэзээ ч Христийн сайшаалыг хүртэхгүй. Чиний дотор хэр их үл итгэл байгааг, мөн Христээс хэр их урваж байгаагаа чи одоо олж тогтоов уу? Би чамд ингэж захъя: Чи үнэний замыг сонгосон тул өөрийгөө үнэн сэтгэлээсээ зориулах хэрэгтэй; хоёрдмол сэтгэлээр, хайнга бүү бай. Бурхан бол дэлхий ертөнцөд ч, хэн нэг хүнд ч биш, харин Түүнд үнэхээр итгэж, Түүнийг шүтэн мөргөж, Түүнд үнэнч агаад итгэлтэй байдаг бүх хүнд харьяалагддаг гэдгийг чи ойлгох ёстой.

Өнөөдөр та нарын дотор үл итгэх байдал их байсаар байна. Өөрсдийнхөө дотогшоо сайтар өнгийвөл та нар хариултаа гарцаагүй олно. Чи жинхэнэ хариултыг олох үедээ өөрийгөө Бурханд итгэгч биш, харин ч Түүнийг хуурч, доромжилж, Түүнээс урвадаг, Түүнд үнэнч бус нэгэн гэдгээ хүлээн зөвшөөрөх болно. Тэгээд Христ бол хүн биш, Бурхан гэдгийг ойлгоно. Ийм өдөр ирэхэд чи Христийг хүндэтгэж, Түүнээс айж, Түүнийг үнэхээр хайрлана. Одоогоор та нарын зүрх сэтгэлийн ердөө гучин хувийг итгэл дүүргэдэг бол далан хувийг нь эргэлзээ дүүргэдэг. Христийн хийдэг, хэлдэг бүхнээс болж та нарт Түүний тухай үзэл, санаа бодол, Түүнд огт итгэдэггүйгээс чинь урган гарсан үзэл, санаа бодол бий болдог. Та нар тэнгэр дэх нүдэнд үл үзэгдэх Бурханыг л гайхан биширч, айж эмээдэг бөгөөд газар дээр амьдарч байгаа Христийг үл хайхардаг. Энэ чинь мөн л та нарын үл итгэл бус уу? Та нар өнгөрсөн үед ажил хийсэн Бурханыг л хүсэмжлэхээс биш, өнөөдрийн Христтэй нүүр тулдаггүй. Энэ бүхэн бол та нарын зүрх сэтгэлд үүрд холилдсон “итгэл”, өнөөдрийн Христэд итгэдэггүй тэр итгэл юм. Би та нарыг огтхон ч дутуу үнэлж байгаа юм биш, учир нь та нарын дотор хэт их үл итгэл байдаг, та нарт ариун бус, задлан шинжлэх ёстой зүйл хэтэрхий олон байдаг. Эдгээр ариун бус зүйл нь та нарт итгэл огт байхгүйн тэмдэг юм; эдгээр нь Христээс татгалзсаны чинь тэмдэг бөгөөд та нарыг Христээс урвагч гэж тамгалдаг. Эдгээр нь Христийн тухай мэдлэгийг чинь хаах халхавч, Христээр авхуулахад чинь саад болдог саад, Христтэй нийцэлтэй байхад чинь саад хийдэг бартаа, мөн Христ та нарыг сайшаадаггүйн нотолгоо билээ. Одоо бол та нарын амьдралынхаа бүх талыг шинжлэх цаг! Ингэх нь та нарт бүхий л талаар ашиг тустай байх болно!

ХРИСТ ШҮҮЛТИЙН АЖЛЫГ ҮНЭНЭЭР ХИЙДЭГ

Эцсийн өдрүүдийн ажил бол бүгдийг төрлөөр нь ялгаж, Бурханы удирдлагын төлөвлөгөөг дуусгах ажил юм, учир нь цаг ойртож, Бурханы өдөр ирсэн. Бурхан хаанчлалд нь орсон бүх хүнийг буюу Өөрт нь эцсээ хүртэл үнэнч байсан бүх хүнийг Бурханы Өөрийн эрин үе рүү аваачдаг. Гэвч Бурханы Өөрийн эрин үе ирэх хүртэл Бурханы хийх ажил гэвэл хүний үйл хэргийг ажиглах болон хүний амьдралын талаар лавлах бус, харин тэрслүү байдлыг нь шүүх явдал юм, учир нь Бурхан Өөрийн сэнтийн өмнө ирсэн бүх хүнийг ариусгана. Өнөөдрийг хүртэл Бурханы мөрийг дагасан бүх хүн бол Бурханы сэнтийн өмнө очсон хүмүүс юм, иймээс Бурханы ажлыг эцсийн үе шатанд нь хүлээн зөвшөөрөх хүн нэг бүр

Бурханы ариусгалтын бай мөн. Өөрөөр хэлбэл, Бурханы эцсийн үе шатандаа яваа ажлыг хүлээн зөвшөөрдөг хүн бүхэн Бурханы шүүлтийн бай билээ.

Өнгөрсөн цаг үед яригдаж байсан Бурханы гэрээс эхлэх шүүлтийн тухайд, эдгээр үгэн дэх “шүүлт” гэдгээр эцсийн өдрүүдэд сэнтийнх нь өмнө ирсэн хүмүүс дээр Бурханы өнөөдөр хийдэг шүүлтийг хэлдэг. Эцсийн өдөр ирсэн үед Бурхан тэнгэрт том ширээ засаж, дээр нь цагаан бүтээлэг дэвсээд, дараа нь бүх хүнийг газарт өвдөг сөгдүүлж, Өөрөө агуу сэнтийд суунгаа хүн бүрийн нүглийг илчилж, үүгээрээ тэднийг тэнгэрт гаргах уу, гал болон хүхэрт нуурт унагах уу гэдгийг тогтоодог гэж ер бусаар төсөөлөн боддог хүмүүс байж магад. Хүний төсөөлөл ямар ч байлаа гэсэн, Бурханы ажлын мөн чанарыг өөрчилж чадахгүй. Хүний төсөөлөл гэдэг хүний харсан, сонссон зүйлийг нийлүүлж, нэгтгэсэн, хүний тархинаас гардаг, санаа бодлынх нь бүтээл төдий юм. Иймд Би, хүний төсөөлөл хэчнээн гайхамшигтай байлаа ч зураглал төдийхнөөс хэтрэхгүй ба Бурханы ажлын төлөвлөгөөг орлож чадахгүй гэж хэлдэг. Эцсийн эцэст, хүнийг Сатан завхруулсан тул хүн яаж Бурханы бодлыг ойлгож чадах юм бэ? Хүн Бурханы шүүлтийн ажлыг маш гайхамшигтай байна гэж боддог. Бурхан Өөрөө шүүлтийн ажил хийж байгаа учраас хамгаас өргөн цар хүрээтэй, эгэл хүмүүст ойлгомжгүй байх ёстой, энэ нь тэнгэр даяар цуурайтаж, газрыг доргиох ёстой гэж боддог; эс бөгөөс энэ яаж Бурханы хийсэн шүүлтийн ажил байж чадах юм бэ? Энэ нь шүүлтийн ажил болохоор Бурхан ажиллахдаа маш сүрлэг, сүр жавхлантай байх ёстой ба шүүгдэж байгаа хүмүүс цурхиран уйлж, өвдөг дээрээ сөхрөн өршөөл хүсэж байх ёстой гэж тэр боддог. Ийм дүр зураг гайхамшигтай, үнэхээр сэтгэл хөдлөм байх нь гарцаагүй... Хүн бүр Бурханы шүүлтийн ажлыг ер бусын гайхалтай гэж төсөөлдөг. Гэвч Бурхан хүмүүсийн дунд шүүлтийн ажлаа аль хэдийн эхэлчхээд байх үед ч чи үхсэн юм шиг унтсаар үлдсэн гэдгээ мэдэх үү? Чамайг Бурханы шүүлтийн ажил албан ёсоор эхэлж байна гэж бодох үед Бурхан аль хэдийн газар тэнгэрийг шинээр бүтээчихсэн байх болно гэдгийг мэдэх үү? Магадгүй тэр үед чи амьдралын утга учрыг дөнгөж ойлгосон байх боловч бөх унтсаар л буй чамайг Бурханы өршөөлгүй шийтгэлийн ажил там руу аваачих болно. Тэр үед л чи Бурханы шүүлтийн ажил аль хэдийн дууссаныг гэнэт ухаарна.

Тэдгээр ой гутам, жигшүүртэй сэдвийн талаар ярьж, үнэт цагаа үрэхээ больцгооё. Харин шүүлт гэж юу болох тухай ярилцацгаая. “Шүүлт” гэдэг үгийг дурдах үед чи Еховагийн бүх газар оронд хэлсэн үг болон Есүсийн фарисайчуудад хэлсэн зэмлэлийн үгийн тухай бодох болно. Эдгээр үг

хэдийгээр хатуу ч гэлээ хүнийг шүүх Бурханы шүүлт байгаагүй, ердөө л өөр өөр орчинд буюу өөр өөр нөхцөлд Бурханы хэлсэн үг байсан юм. Эдгээр үг нь эцсийн өдрүүдэд хүнийг шүүхдээ Христийн хэлдэг үгтэй адилгүй. Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг, хүн Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдогтой холбогдуулан хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авдаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ. Хэрэв чи эдгээр үнэнийг чухалчлан авч үздэггүй, эдгээр үнэнээс хэрхэн зайлсхийх вэ, эсвэл тэдгээртэй хамааралгүй шинэ замыг хэрхэн олох вэ гэж л үргэлж боддог бол Би чамайг хүнд нүгэлтэн гэж хэлнэ. Чи Бурханд итгэдэг атлаа үнэнийг болон Бурханы хүслийг эрж хайдаггүй, мөн чамайг Бурханд ойртуулдаг замыг ч хайрладаггүй бол Би чамайг, шүүлтээс бултахаар оролдож буй нэгэн, агуу цагаан сэнтийгээс зугтдаг хүүхэлдэй, урвагч гэж хэлнэ. Бурхан нүдэн дээр нь зугтаж байгаа тэрслүү хэнийг ч болов өршөөхгүй. Ийм хүмүүс илүү хүнд шийтгэл хүртэх болно. Бурханы өмнө шүүгдэхээр очиж, улмаар ариусгагдсан хүмүүс Бурханы хаанчлалд үүрд амьдарна. Мэдээж энэ нь ирээдүйд тохиох зүйл юм.

Шүүлтийн ажил бол Бурханы Өөрийн ажил тул мэдээж үүнийг Бурхан Өөрөө хийх ёстой; хүн Түүний оронд хийж чадахгүй. Шүүлт бол үнэнийг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулах явдал учраас, энэ ажлыг хүмүүсийн дунд хийхээр Бурхан дахиад л бие махбод болсон дүрээрээ гарч ирэх нь дамжиггүй юм. Өөрөөр хэлбэл, эцсийн өдрүүдэд Христ газар дэлхий даяарх хүмүүсийг сургахын тулд үнэнийг ашиглаж, бүх үнэнийг тэдэнд мэдэгдэнэ. Энэ бол Бурханы шүүлтийн ажил юм. Хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханы тухайд олон хүн таагүй сэтгэгдэлтэй байдаг, учир нь Бурхан шүүлтийн ажил хийхийн тулд махбод болно гэдэгт итгэхэд хүнд хэцүү байдаг. Гэсэн хэдий ч, Бурханы ажил үргэлж хүний таамаглалаас хол давдаг ба хүний оюун ухаанаар үүнийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү гэдгийг чамд Би хэлэх ёстой. Учир нь хүн бол газар дээрх өт хорхой төдий байхад Бурхан бол орчлон ертөнцийг дүүргэдэг дээдийн дээд Нэгэн билээ; хүний оюун ухаан бол өт хорхой үрждэг бохир устай нүх адил байхад Бурханы бодлоор удирдуулдаг ажлын үе шат бүр нь Бурханы мэргэн ухааны охь юм. Хүн үргэлж Бурхантай барьцахыг хүсдэг ба эцэстээ хэн нь хохирол амсах нь илэрхий юм гэж Би хэлдэг. Би та бүхэнд өөрсдийгөө алтнаас үнэтэй мэт бүү сана гэж захиx байна. Бусад нь Бурханы шүүлтийг хүлээж авч чадаж байхад чи яагаад чадахгүй гэж? Чи бусдаас хэр дээгүүр байдаг вэ? Бусад нь үнэний өмнө толгой бөхийж чадаж байхад чи ч бас яагаад чадахгүй гэж? Бурханы ажилд зогсоохын аргагүй хөдөлгөх хүч байдаг. Чамайг “хувь нэмэр” оруулсан төдийд л Тэр шүүлтийн ажлыг дахин давтахгүй бөгөөд ийм сайхан боломжийг алдсандаа чи харуусалд автана. Хэрвээ чи Миний үгэнд итгэхгүй байвал тэнгэр дэх тэр агуу цагаан сэнтий чамд шүүлт оноохыг хүлээ! Бүх израилчууд Есүсийг басамжлан үгүйсгэсэн боловч хүн төрөлхтнийг Есүс золин аварсан баримт орчлон ертөнц даяар, дэлхийн өнцөг булан бүрд түгсэн гэдгийг чи мэдэх ёстой. Бурханы аль эрт бүтээсэн бодит байдал энэ биш гэж үү? Есүс чамайг тэнгэрт аваачна гэж чи хүлээсээр л байгаа бол Би чамайг зөрүүд үжирсэн мод^а юм гэж хэлнэ. Үнэнд үнэнч биш, зөвхөн ерөөл эрж хайдаг чам шиг хуурамч итгэгчийг Есүс хүлээн зөвшөөрөхгүй. Эсрэгээрээ, Тэр чамайг хэдэн арван мянган жилийн турш галт нуурт шатаахаар хаяхдаа огтхон ч өршөөл үзүүлэхгүй.

Чи одоо шүүлт гэж юу болохыг, үнэн гэж юу болохыг ойлгож байна уу? Ойлгосон бол Би чамайг шүүлтэд дуулгавартай захирагд гэж захъя, эс бөгөөс

а. Үжирсэн мод: “ямар ч нэмэргүй” гэсэн утгатай хятад хэлц.

чи Бурханаар сайшаагдах, Бурханаар хаанчлалд нь хүргүүлэх боломжийг хэзээ ч олж авахгүй. Шүүлтийг л хүлээн зөвшөөрдөг боловч хэзээ ч ариусгагдаж чадахгүй хүмүүс, өөрөөр хэлбэл, шүүлтийн ажлын ид дундуур зугтдаг хүмүүс үүрд Бурханаар жигшигдэн, гологдох болно. Тэд Бурханаас урваж, Бурханы эсрэг тэрсэлсэн учир нүгэл нь фарисайчуудынхаас арвин агаад хүнд. Үйлчлэл үзүүлэхэд ч тохирохгүй ийм хүмүүс илүү хатуу хэр нь бас мөнхийн шийтгэлийг хүлээн авах болно. Нэгэнтээ үнэнч байдлаа үгээр харуулсан боловч, дараа нь Өөрөөс нь урвасан ямар ч урвагчийг Бурхан өршөөхгүй. Ийм хүмүүс сүнс, сэтгэл, биеийн шийтгэлээр дамжуулан цээрлүүлэлт хүртэнэ. Энэ нь яг Бурханы зөвт зан чанарын илчлэл биш гэж үү? Хүнийг шүүж, илчилдэг Бурханы зорилго энэ биш гэж үү? Шүүлтийн явцад төрөл бүрийн хорон муу үйл хийсэн бүх хүнийг Бурхан муу ёрын сүнсээр дүүрсэн газар орон луу илгээдэг бөгөөд тэдгээр муу ёрын сүнсний зоргоор махан биеийг нь устгуулахад тэдний биеэс хүүрийн үнэр ханхалдаг. Энэ нь тэдэнд тохирох цээрлүүлэлт юм. Бурхан тэдгээр үнэнч бус хуурамч итгэгч, хуурамч элч, хуурамч ажилчдын хийсэн нүгэл нэг бүрийг бүртгэлийн номд нь бичиж авдаг; тэгээд цаг нь ирэхэд Тэр тэднийг хэзээ ч бүү дахин төрөг, дахин хэзээ ч бүү гэрэл үзэг гэж бохир сүнснүүдийн дунд хаяж, бүхий л биеийг нь эдгээр бохир сүнсээр бузарлуулдаг. Нэгэн цагт үйлчлэл хийсэн боловч эцсийг нь хүртэл үнэнч үлдэж чаддаггүй эдгээр хоёр нүүртнийг Бурхан хорон муу хүмүүсийн тоонд оруулдаг ба ингэснээр тэд хорон муу нэгний зөвлөгөөн дор алхаж, эмх замбараагүй бүлгийнх нь нэг хэсэг болдог; эцэст нь Бурхан тэднийг үндсээр нь устгана. Христэд хэзээ ч үнэнч байгаагүй, ямар ч хүчин чармайлт зориулаагүй хүмүүсийг Бурхан хөсөр хаяж, хэзээ ч ойшоохгүй бөгөөд эрин үе солигдоход тэднийг бүгдийг нь устгана. Тэд Бурханы хаанчлалд орж чадах нь байтугай, газар дээр ч оршин байхаа болино. Бурханд хэзээ ч чин үнэнч байгаагүй, харин нөхцөл байдлын улмаас Түүнтэй ёс төдий харьцахаас аргагүйд хүрсэн хүмүүс нь Түүний ардуудын төлөө үйлчлэл хийдэг хүмүүсийн тоонд ордог. Ийм хүмүүсээс цөөн хэд нь л амьд үлдэж чаддаг ба ихэнх нь үйлчлэл хийхэд ч тэнцэхгүй хүмүүсийн хамтаар мөхөх болно. Эцэст нь Бурханы ардууд, хөвгүүд болон тахилч болгохоор Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс зэрэг Өөртэй нь санаа нэгтэй бүх хүнийг Бурхан хаанчлалдаа аваачна. Тэд Бурханы ажлын охь нь байх болно. Бурханы тогтоосон ангиллын алинд нь ч багтаж чаддаггүй хүмүүсийн тухайд гэвэл, тэд үл итгэгчдийн тоонд орно. Тэдний үр дүн ямар байхыг та нар лавтай төсөөлж чадна. Та нарт хэлэх ёстой бүхнээ Би аль хэдийн хэлсэн; ямар замыг сонгох нь бүгд зөвхөн өөрсдийн чинь сонголт.

Та нарын ойлгох ёстой зүйл бол энэ: Бурханы ажил Бурхантай хөл нийлүүлж чадахгүй хэнийг ч, хэзээ ч хүлээдэггүй ба Бурханы зөвт зан чанар ямар ч хүнд өршөөл үзүүлдэггүй.

БУРХАН ХҮМҮҮСИЙН ДУНД АГУУ ЗҮЙЛ ХИЙСНИЙГ ЧИ МЭДСЭН ҮҮ?

Хуучин эрин үе улирч, шинэ эрин үе ирлээ. Жилээс жилд, өдрөөс өдөрт Бурхан маш их ажил хийжээ. Тэр дэлхийд ирээд, дараа нь буцсан. Энэ мөчлөг өөрөө олон үе дамжин давтагдсан билээ. Өнөөдөр Бурхан урьдын адилаар хийх ёстой ажлаа болон хараахан гүйцээгээгүй ажлаа үргэлжлүүлэн хийдэг, учир нь өнөөдрийг хүртэл Тэрээр амралтад орж амжаагүй юм. Бүтээлийн цагаас өнөөг хүртэл Бурхан их ажил хийсэн. Гэхдээ Бурхан өнөөдөр урьдынхаас хавьгүй их ажил хийж буйн дээр Түүний ажлын цар хүрээ өмнөхөөсөө ч асар их гэдгийг чи мэдсэн үү? Ийм учраас л Би Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийсэн гэж хэлдэг. Бурханы бүх ажил хүнд ч бай, Бурханд ч бай маш чухал, учир нь Түүний ажлын хэсэг бүр хүнтэй холбоотой.

Бурханы ажил харагдашгүй, хүршгүй—дэлхий ертөнцөд бүр ч харагддаггүй юм бол агуу зүйл байж яаж чадах юм бэ? Ямар зүйлийг агуу гэж үзэх вэ? Мэдээж, Бурханы хийдэг ямар ч ажлыг агуу гэж үзэж болно гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй, гэхдээ өнөөдөр Бурханы хийж буй ажлын тухай Би яагаад ингэж хэлдэг вэ? Бурхан агуу зүйл хийсэн гэж Намайг хэлэх үед үүнд хүний хараахан ойлгоогүй олон нууц агуулагдаж байгаа нь эргэлзээгүй. Одоо тэдгээрийн тухай ярилцъя.

Есүс Өөрийнх нь оршин тогтнолыг тэвчиж чадаагүй эрин үед тэжээлийн онгоцонд төрсөн ч гэлээ дэлхий ертөнц Түүнд саад болж чадаагүй. Тэрээр Бурханы халамж дор гучин гурван жилийн турш хүмүүсийн дунд амьдарсан. Энэ олон жил амьдрахдаа Тэрээр хорвоогийн гашууныг туулж, газар дээрх гаслант амьдралыг амссан юм. Тэгээд бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд цовдлогдох асар их ачаа үүрчээ. Тэрээр Сатаны эзэмшил дор амьдарч байсан бүх нүгэлтнийг золин аварч, эцэст нь дахин амилсан биеэрээ амрах газар луугаа буцсан юм. Одоо Бурханы шинэ ажил эхэлсэн ба энэ нь бас шинэ эрин үеийн эхлэл билээ. Бурхан авралын шинэ ажлаа эхлүүлэхийн тулд золин аврагдсан хүмүүсийг гэртээ авчирдаг. Энэ удаад авралын ажил урьд өмнөхөөс ч илүү нэгд нэггүй байдаг. Хүнийг өөрөөр нь өөрчлүүлэхийн тулд Ариун Сүнс

хүний дотор ажилладаггүй, мөн энэ ажлыг хийхээр Есүсийн бие ч хүмүүсийн дунд гарч ирдэггүй бөгөөд тэр тусмаа энэ ажил өөр аргаар бүр ч хийгддэггүй. Харин ч бие махбодтой болсон Бурхан л энэ ажлыг хийж, Өөрөө удирдан чиглүүлдэг. Тэрээр хүнийг шинэ ажил руу хөтлөхийн тулд ийм маягаар хийдэг. Энэ нь агуу зүйл биш гэж үү? Бурхан энэ ажлыг хүн төрөлхтний нэг хэсгээр, эсвэл зөгнөх аргаар дамжуулан хийдэггүй; харин Бурхан Өөрөө үүнийг хийдэг. Энэ бол агуу зүйл биш бөгөөд хүнд баяр хөөрийн дээдийг авчирч чадахгүй гэж зарим нь хэлж магад. Гэвч Би та нарт Бурханы ажил ердөө энэ биш, харин хавьгүй агуу, хамаагүй илүү их зүйл юм гэдгийг хэлэх байна.

Энэ удаа Бурхан сүнслэг биеэр биш, харин тун эгэл жирийн биеэр ажиллахаар ирсэн. Түүнээс гадна, энэ нь Бурханы махбод болсон хоёр дахь бие төдийгүй, бас махбодод Бурханы эргэн ирсэн бие юм. Энэ бол маш эгэл жирийн махбод. Чи Түүнээс бусдаас онцгойроод байх зүйл юу ч олж харж чадахгүй ч урьд өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй үнэнийг Түүнээс олж авах боломжтой. Энэ өчүүхэн жаахан махбод л Бурханаас ирсэн үнэний бүх үгийн биелэл болж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг гүйцэтгэж, хүнд ойлгуулахын тулд Бурханы зан чанарыг бүхэлд нь илэрхийлдэг. Чи тэнгэр дэх Бурханыг харахыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Чи тэнгэр дэх Бурханыг ойлгохыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Чи хүн төрөлхтний хүрэх газрыг харахыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Тэр чамд өөр хэний ч хэлж чадаагүй энэ бүх нууцыг хэлнэ, Тэр бас чиний ойлгодоггүй үнэнийг хэлж өгнө. Тэр бол хаанчлалд орох чиний хаалга, шинэ эрин үе рүү дагуулах чиний хөтөч юм. Ийм эгэл жирийн махбод ойлгохын аргагүй олон нууцыг агуулдаг. Түүний үйл хэрэг чамд ойлгомжгүй байж болох ч Тэр бол хүмүүсийн боддог шиг энгийн махбод биш гэдгийг хийж буй ажлынх нь бүхий л зорилго чамд хангалттай харуулдаг. Учир нь Тэрээр Бурханы хүслийг болон эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд Бурханы үзүүлсэн хайр халамжийг төлөөлдөг. Хэдийгээр чи тэнгэр, газрыг доргиох мэт Түүний үгийг сонсож чадахгүй, галын дөл мэт дүрэлзэн буй Түүний нүдийг харж чадахгүй, мөн Түүний төмөр савааны сахилгажуулалтыг хүлээн авч чадахгүй ч Түүний үгээс Бурхан уур хилэнтэй гэдгийг сонсож, Бурхан хүн төрөлхтөнд энэрэнгүй ханддагийг мэдэж авч чадна; чи Бурханы зөвт зан чанар, мэргэн ухааныг олж харахын сацуу бүх хүн төрөлхтнийг гэх Бурханы анхаарал халамжийг ухаарч чадна. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил нь тэнгэр дэх Бурхан газар дээрх хүмүүсийн дунд амьдарч байгааг хүнд харуулж, Бурханыг мэдэх, дуулгавартай дагах, хүндэтгэх, хайрлах боломжийг хүмүүст олгохын төлөө байдаг. Ийм учраас Тэр махбодоор хоёр

дахь удаагаа эргэж ирсэн. Өнөөдөр хүмүүсийн хардаг зүйл бол хүнтэй адилхан, нэг хамар, хоёр нүдтэй, гойд зүйлгүй Бурхан ч гэлээ, хэрэв энэ хүн байгаагүй бол тэнгэр, газар асар их өөрчлөгдөх байсан, мөн энэ хүн байгаагүй бол тэнгэр бүүдийж, газар дэлхий эмх замбараагүй байдалд автан, бүх хүн төрөлхтөн өлсгөлөн, тахал дунд амьдрах байсан гэдгийг эцэст нь Бурхан та нарт харуулна. Хэрэв бие махбодтой болсон Бурхан эцсийн өдрүүдэд та нарыг аврахаар ирээгүй бол Бурхан бүх хүн төрөлхтнийг аль эрт тамд устгах байсан; хэрэв энэ махбод байгаагүй бол та нар үүрд хүнд нүгэлтэн болж, үргэлжийн мөнхөд цогцос болох байсныг Тэр та нарт харуулна. Хэрэв энэ махбод байгаагүй бол бүх хүн төрөлхтөнд зайлахын аргагүй гамшиг нүүрлэж, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд Бурханы оноох илүү хүнд шийтгэлээс зайлж зугтах боломжгүй болох байсныг та нар мэдэх ёстой. Хэрэв энэхүү эгэл жирийн махбод төрөөгүй бол та нар бүгд амьдарч чадахгүй атлаа амьдрал гуйж, үхэж чадахгүй мөртөө үхлийн төлөө залбирах байдалд орох байлаа. Хэрэв энэ махбод байгаагүй бол та нар үнэнийг олж авч, өнөөдрийн Бурханы сэнтийн өмнө ирж чадахгүй, харин жигшүүрт нүглийнхээ улмаас Бурханд шийтгүүлэх байсан юм. Хэрвээ Бурхан махбодоор эргэж ирээгүй бол хэнд ч аврагдах боломж олдохгүй байх байсан; энэ махбод ирээгүй бол Бурхан аль эрт хуучин эрин үеийг төгсгөх байсан гэдгийг та нар мэдсэн үү? Ийм байтал, хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханыг та нар голсоор байж чадна гэж үү? Та нар энэхүү эгэл жирийн хүнээс маш их ашиг тус хүртэж чадах байтал яагаад Түүнийг баяртайгаар хүлээн авахгүй байна вэ?

Бурханы ажил бол чиний ойлгож ухаарч чадахгүй зүйл юм. Хэрвээ чи сонголт чинь зөв эсэхийг ч бүрэн ухаарч чадахгүй, Бурханы ажил амжилт олох эсэхийг ч мэдэж чадахгүй бол азаа үзээд, энэхүү эгэл жирийн хүн чамд асар их тус хүргэх эсэхийг, мөн Бурхан үнэхээр агуу ажлыг хийсэн эсэхийг харж яагаад болохгүй гэж? Гэвч, Ноагийн цаг үед хүмүүс Бурханы хувьд харж тэвчишгүй байх хэмжээнд идэж уун, гэрлэж, нөхөрт гарч байсан тул Тэрээр хүн төрөлхтнийг утсгахын тулд асар их үер буулган, зөвхөн Ноагийн гэр бүлийн найман хүн болон бүх төрлийн жигүүртэн шувууд, араатан амьтдыг өршөөсөн гэдгийг Би чамд хэлэх ёстой. Гэхдээ эцсийн өдрүүдэд Бурханы өршөөсөн хүмүүс бол эцсээ хүртэл Түүнд үнэнч байсан бүх хүн юм. Энэ хоёр эрин үе нь Бурханы хувьд харж тэвчишгүй асар их завхралын үе байсан ба хоёр эрин үе дэх хүн төрөлхтөн маш их завхарч, Бурхан бол өөрсдийнх нь Эзэн гэдгийг үгүйсгэсэн хэдий ч Бурхан зөвхөн Ноагийн цаг үеийн хүмүүсийг л устгасан

билээ. Хоёр эрин үеийн хүн төрөлхтөн Бурханд асар их уй гашуу учруулсан ч Бурхан эцсийн өдрүүдийн хүмүүст өдийг хүртэл тэвчээртэй хандсан. Яагаад тэр вэ? Та нар үүнд гайхаж байгаагүй гэж үү? Хэрвээ та нар үнэхээр мэдэхгүй байгаа бол Би хэлээд өгье. Бурхан эцсийн өдрүүдэд хүмүүст нигүүлсэл хайрлаж чаддагийн учир нь хүмүүс Ноагийн цаг үеийн хүмүүсээс бага завхарснаас, эсхүл тэд Бурханд гэмшлээ харуулснаас болоогүй, эцсийн өдрүүдийн технологи маш их хөгжсөн болохоор Бурхан түүнийг нь устгаж чадахгүй байгаагаас бүр ч болоогүй. Харин ч Бурхан эцсийн өдрүүд дэх бүлэг хүмүүст ажлаа хийх ёстой ба Бурхан Өөрөө бие махбодтой болоод энэ ажлыг хийнэ. Түүнчлэн Бурхан энэ бүлгийн нэг хэсгийг авралынхаа бай, удирдлагын төлөвлөгөөнийхөө үр жимс болгохоор сонгож, энэ хүмүүсийг дараачийн эрин үед аваачна. Тиймээс, ямартай ч Бурханы төлсөн төлөөс нь бүхэлдээ эцсийн өдрүүдэд Өөрийн махбод болсон биеэр хийх гэж буй ажлынх нь бэлтгэл байв. Энэхүү махбодын ачаар л та нар өнөөдрийг хүрсэн. Бурхан махбодоор амьдардаг учир та нарт амьд үлдэх боломж бий. Энэ бүх зол завшаан нь энэхүү эгэл жирийн хүнээс улбаатай билээ. Үүгээр ч зогсохгүй, эцэст нь улс орон бүр энэ эгэл жирийн хүнийг шүтэн мөргөхийн сацуу энэ өчүүхэн жаахан хүнд талархаж, түүнийг дуулгавартай дагана, учир нь Түүний авчирсан үнэн, амь, зам нь бүх хүн төрөлхтнийг аварч, хүн Бурхан хоёрын дундах зөрчлийг зөөлрүүлж, хоорондох зайг нь багасгаж, Бурхан хүн хоёрын бодлыг холбосон юм. Тэрээр мөн Бурханы төлөө бүр ч агуу их алдар сууг олж авсан билээ. Ийм эгэл жирийн хүн чиний итгэл, бишрэлийг хүртэхэд зохисгүй гэж үү? Ийм эгэл жирийн махбод Христ гэж дуудуулахад тохирохгүй гэж үү? Ийм эгэл жирийн хүн бусад хүмүүсийн дунд Бурханы илэрхийлэл болж чадахгүй гэж үү? Хүн төрөлхтнийг гамшгаас гэтэлгэсэн ийм хүн Түүнийг гэх хайр, хүслийг чинь хүртэх эрхгүй гэж үү? Та нар Түүний амаар илэрхийлэгдсэн үнэнийг голж, та нарын дундах Түүний оршин тогтнолыг жигших юм бол эцэстээ юу болж хоцрох вэ?

Бурханы эцсийн өдрүүд дэх бүх ажил энэ эгэл жирийн хүнээр дамжин хийгддэг. Тэрээр бүхнийг чамд хайрлах болно, тэгээд ч зогсохгүй чамд хамаатай бүхнийг шийдэж чадна. Ийм хүн та нарын боддог шиг дурдахын ч хэрэггүй тийм энгийн хүн байж болох уу? Түүний үнэн та нарыг бүрэн үнэмшүүлэхэд хангалтгүй гэж үү? Түүний үйл хэргийг харах нь та нарыг бүрэн үнэмшүүлэхэд хангалтгүй гэж үү? Эсхүл Түүний авчирдаг зам цааш алхахад чинь зохисгүй гэж үү? Эцсийн эцэст Түүнийг зэвүүцэж, Түүнийг хаяж, Түүнээс зайлсхийх ямар шалтгаан та нарт байна вэ? Энэ хүн л үнэнийг илэрхийлдэг, энэ

хүн л үнэнээр хангадаг, энэ хүн л та нарт дагах зам өгдөг. Та нар эдгээр үнэн дотроос Бурханы ажлын ул мөрийг хайж олж чадахгүй хэвээр байгаа юм гэж үү? Есүсийн ажил байгаагүй бол хүн төрөлхтөн загалмайгаас бууж чадахгүй байсан, харин өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан байгаагүй бол загалмайгаас буусан хүмүүс Бурханы сайшаалыг хэзээ ч хүртэж чадахгүй, эсвэл шинэ эрин үед орж чадахгүй байх байлаа. Энэ эгэл жирийн хүн ирээгүй бол Бурханы жинхэнэ төрхийг харах боломж та нарт хэзээ ч олдохгүй, та нар шаардлага ч хангахгүй байх байсан, учир нь та нар бүгд аль эрт устгагдах ёстой байсан бай юм. Бурхан хоёр дахь удаагаа бие махбодтой болон ирсэн учраас та нарыг уучилж, өршөөл үзүүлсэн. Ямартай ч, эцэст нь та бүхэнд хэлэх ёстой үг минь бол энэ: Бие махбодтой болсон Бурхан буюу энэ эгэл жирийн хүн та нарт амин чухал юм. Энэ бол хүмүүсийн дунд Бурханы аль хэдийн хийсэн агуу зүйл билээ.

ЭЦСИЙН ӨДРҮҮДИЙН ХРИСТ Л ХҮНД МӨНХ АМИЙН ЗАМЫГ ӨГЧ ЧАДНА

Амийн зам гэдэг бол хэн дуртай нь эзэмшиж чадах зүйл биш, хэн бүхний хялбархан олж авч чадах ч зүйл биш. Учир нь амь зөвхөн Бурханаас ирдэг, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө л амийн мөн чанарыг эзэмшдэг ба Бурханд Өөрт нь л амийн зам бий. Иймээс Бурхан л амийн эх сурвалж, амийн амьд усны ширгэшгүй урсах эх ундарга юм. Бурхан дэлхий ертөнцийг бүтээснээсээ хойш амийн эрч хүчтэй холбоотой, хүнд амь авчрах ихээхэн ажил хийсэн бөгөөд хүнд амь олж авах боломж олгохын тулд асар их төлөөс төлсөн. Учир нь Бурхан Өөрөө мөнх амь, Бурхан Өөрөө хүнийг амилуулах зам билээ. Бурхан үргэлж хүний зүрх сэтгэлд оршиж, цаг үргэлжид хүмүүсийн дунд амьдардаг. Тэр хүний амьдралын хөдөлгөгч хүч, хүний оршин тогтнолын үндэс, мэндэлснээс нь хойших хүний оршин тогтнолын баялаг хөрөнгө байсаар ирсэн билээ. Тэр хүнийг дахин төрөхөд хүргэж, үүрэг бүрдээ тууштайгаар амьдрах боломж олгодог. Түүний хүч чадал, бөхөшгүй амийн хүчний ачаар хүн үеэс үед амьдарч, энэ хугацаанд Бурханы амийн хүч чадал нь хүний оршин тогтнолын гол тулгуур болж ирсэн бөгөөд Бурхан ямар ч эгэл хүний төлж байгаагүй төлөөсийг төлсөн юм. Бурханы амийн хүч нь ямар ч хүч чадлыг дийлж чадна; түүнчлэн ямар ч хүч чадлаас давуу байдаг. Түүний амь бол мөнхийн, Түүний хүч чадал ер бусын, Түүний амийн хүчийг ямар ч бүтээгдсэн зүйл, ямар ч дайсны хүч дийлж чадахгүй. Бурханы амийн хүч цаг хугацаа, орон зайг үл хамааран оршиж, гэрэлт

цацрагаа гэрэлтүүлдэг. Тэнгэр газарт асар их өөрчлөлт гарч болох ч Бурханы амь үүрд нэг хэвээр байдаг. Бүх зүйл урсан өнгөрдөг ч Бурханы амь байсаар л байдаг. Учир нь Бурхан бол бүх зүйлийн оршин тогтнолын эх сурвалж ба тэдний оршин тогтнолын үндэс билээ. Хүний амь Бурханаас эхтэй, тэнгэрийн оршин тогтнол Бурханаас үүдэлтэй ба газрын оршин тогтнол Бурханы амийн хүчнээс улбаатай. Амин чанар бүхий ямар ч зүйл Бурханы дээд эрхээс давж чадахгүй, ямар ч эрч хүчтэй зүйл Бурханы эрх мэдлийн хил хязгаарыг эвдэж чадахгүй. Ийм маягаар хэн ч бай бүгд Бурханы ноёрхол дор захирагдаж, Бурханы тушаал дор амьдрах ёстой ба хэн ч Түүний хяналтаас зугтаж чадахгүй.

Магадгүй одоо чи амийг хүлээн авч, үнэнийг олж авахыг хүсэж болно. Ямартай ч чи Бурханыг олохыг, өөрийн итгэж найдаж болох, өөрийг чинь мөнх амиар хангах Бурханыг олохыг хүсдэг. Хэрвээ мөнх амийг олж авахыг хүсвэл эхлээд чи мөнх амийн эх сурвалжийг ойлгож, Бурхан хаана байдгийг мэдэх ёстой. Зөвхөн Бурхан хувиршгүй амь бөгөөд Бурханд л амийн зам байдаг гэж Би аль хэдийн хэлсэн. Бурхан нэгэнт хувиршгүй амь учраас Тэр бол мөнх амь; Бурхан л амийн зам учраас Бурхан Өөрөө мөнх амийн зам юм. Ийм болохоор чи эхлээд Бурхан хаана байдгийг, мөнх амийн энэ замыг хэрхэн олж авахыг ойлгох ёстой. Одоо энэ хоёр асуудлыг тус тусад нь нөхөрлөцгөөе.

Хэрвээ чи мөнх амийн замыг олж авахыг үнэхээр хүсвэл, үүнийг хайх уйгагүй эрмэлзэлтэй бол энэ асуултад эхлээд хариул: Өнөөдөр Бурхан хаана байгаа вэ? Бурхан тэнгэрт амьдардаг гэж чи хариулах байх, мэдээж Тэр танай гэрт амьдрахгүй нь лавтай, тийм биз? Магадгүй чи Бурхан бүх зүйлийн дунд амьдардаг нь мэдээжийн хэрэг гэж хэлэх байх. Эсвэл чи Бурхан хүн бүрийн зүрх сэтгэлд амьдардаг, аль эсвэл Бурхан сүнсний ертөнцөд байдаг гэж хэлж магад. Би үүний алийг нь ч үгүйсгэдэггүй, гэхдээ Би энэ асуудлыг та нарт тодорхой болгох ёстой. Бурхан хүний зүрх сэтгэлд амьдардаг гэж хэлэх нь тийм ч зөв биш, бас тэр чигтээ буруу ч биш юм. Учир нь Бурханд итгэгчдийн дунд итгэл нь жинхэнэ эсвэл хуурамч, Бурханд сайшаагддаг эсвэл сайшаагддаггүй, таалалд нь нийцдэг эсвэл жигшигддэг, Бурханы төгс болгодог эсвэл таягдан хаядаг хүмүүс гэж бий. Иймд Би Бурхан цөөн хэдэн хүний л зүрх сэтгэлд амьдардаг гэж хэлнэ, харин энэ хүмүүс нь эргэлзэх юмгүйгээр Бурханд үнэхээр итгэдэг, Бурханаар сайшаагдаж, таалалд нь нийцдэг, Түүний төгс болгодог хүмүүс юм. Тэд бол Бурханаар удирдуулдаг хүмүүс мөн. Тэд Бурханаар удирдуулдаг учраас Бурханы мөнх амийн замыг аль хэдийн сонссон, үзсэн хүмүүс юм. Бурханд итгэх итгэл нь хуурамч, Бурханд сайшаагддаггүй, Бурханы үзэн ядаж,

таягдан хаядаг хүмүүс нь Бурханд гологдож, амийн замыг ололгүй, Бурхан хаана байгааг ч мэдэхгүй хэвээр үлдэх тавилантай. Эсрэгээрээ, зүрх сэтгэлд нь Бурхан амьдардаг хүмүүс Түүний хаана байгааг мэддэг. Тэд бол Бурханы мөнх амийн замаа хайрласан, Бурханыг дагадаг хүмүүс юм. Одоо чи Бурхан хаана байгааг мэдсэн үү? Бурхан хүний зүрх сэтгэлд, мөн хүний хажууд бий. Тэр зөвхөн сүнсний ертөнцөд, бүх зүйлийн дээр оршоод зогсохгүй хүний оршин байдаг газар дэлхий дээр ч байдаг. Иймээс эцсийн өдрүүд ирж, Бурханы ажлын алхмуудыг шинэ хүрээнд авчирсан. Бурхан бүх зүйлийн дундах юм бүрийг захирдаг, хүний зүрх сэтгэл дэх түшиг тулгуур төдийгүй Тэр хүмүүсийн дунд оршдог. Ийм маягаар л Тэр хүн төрөлхтөнд амийн замыг авчирч, амийн зам руу хүн төрөлхтнийг аваачдаг. Бурхан газар дэлхий дээр ирж, хүмүүсийн дунд амьдарснаар хүн амийн замыг олж, оршин тогтнох боломжтой болдог. Үүний зэрэгцээ Бурхан бас хүмүүсийн дундах Өөрийн удирдлагатай хамтран ажиллуулахын тулд бүх зүйлийн дундах юм бүрийг удирдаг чиглүүлдэг. Иймээс хэрвээ чи Бурхан тэнгэрт болоод хүний зүрх сэтгэлд байдаг гэсэн сургаалыг л хүлээн зөвшөөрдөг атлаа хүмүүсийн дундах Бурханы оршин тогтнолын үнэнийг эс зөвшөөрөх аваас амийг болон үнэний замыг хэзээ ч олж авахгүй.

Бурхан Өөрөө амь ба үнэн бөгөөд Түүний амь ба үнэн зэрэгцэн оршдог. Үнэнийг олж авах чадваргүй хүмүүс амийг хэзээ ч олж авахгүй. Үнэний удирдамж, дэмжлэг, хангалтгүйгээр чи бичиг үсэг, хоосон сургаал болон үхлийг л олж авна. Бурханы амь үргэлжид оршин байдаг бөгөөд Түүний үнэн ба амь нь зэрэгцэн оршдог. Хэрвээ үнэний эх сурвалжийг олж чадахгүй бол чи амийн тэжээлийг олж авахгүй; хэрвээ амийн хангалтыг олж авч чадахгүй бол чамд мэдээж үнэн байхгүй байх болно, иймээс үзэл, төсөөллийг эс тооцвол чиний бие бүхэлдээ өмхий махан биеэс өөр юу ч биш юм. Номын үгийг амь хэмээн тооцдоггүй, түүхийн бичээсийг үнэн гэж шүтэж болдоггүй, хуучны дүрэм журам нь Бурханы өнөөгийн хэлдэг үгийн бүртгэл болж чадахгүй гэдгийг мэдэж ав. Бурхан газар дэлхий дээр ирж, хүмүүсийн дунд амьдрахдаа илэрхийлдэг зүйл нь л зөвхөн үнэн, амь, Бурханы хүсэл бөгөөд Түүний өнөөгийн ажлын арга зам юм. Хэрвээ чи Бурханы өнгөрсөн эрин үеүдэд хэлсэн үгийн тэмдэглэлийг өнөөдөр хэрэглэх аваас чамайг археологич, бас түүхэн өвийн мэргэжилтэн гэж тодорхойлбол хамгийн оновчтой. Учир нь чи үргэлж Бурханы өнгөрсөн цаг үед хийсэн ажлын ул мөрт итгэдэг, хүмүүсийн дунд урьд нь ажиллахад нь Бурханаас үлдсэн сүүдэрт итгэдэг, хуучин цаг үед Бурханы дагалдагч нартаа өгсөн замд итгэдэг, харин Бурханы өнөөгийн ажлын чиглэлд итгэдэггүй, Бурханы өнөөгийн

алдар суутай төрх байдалд итгэдэггүй ба Бурханы өнөө үед илэрхийлсэн үнэний замд итгэдэггүй. Иймээс чи бодит байдлаас бүрэн тасарсан мөрөөдөгч гэдэг нь гарцаагүй юм. Хэрвээ чи одоо ч гэсэн хүнд амь авчрах чадалгүй бичиг үсэгтэй зууралдсаар байгаа бол чи хэрэггүй үжирсэн мод^а, учир нь чи хэт хуучинсаг, зөрүүд, үгэнд ордоггүй!

Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй, учир нь Тэр хүний хүрэх боломжгүй Бурханы мөн чанар болон Бурханы зан чанарыг, мөн ажлаа хийх мэргэн ухааныг эзэмшсэн байдаг. Өөрсдийгөө Христ гэдэг атлаа Бурханы ажлыг хийж чаддаггүй хүмүүс бол луйварчид юм. Христ бол газар дэлхий дээрх Бурханы илрэл төдий биш, харин хүмүүсийн дунд ажлаа хэрэгжүүлж, гүйцэлдүүлэхдээ Бурханы авсан онцгой махбод билээ. Энэ махбод нь газар дээрх Бурханы ажлыг зүй ёсоор гүйцэтгэж, Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы сайн төлөөлөл байж, хүнийг амиар хангаж чаддаг учир хүссэн хүн бүр үүнийг орлочхож чадахгүй. Христийг дуурайдаг хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт бүгд унах болно, учир нь тэд өөрсдийгөө Христ гэцгээдэг ч, Христийн ямар ч мөн чанарыг эзэмшдэггүй. Иймд Би, Христийн жинхэнэ байдлыг хүн тодорхойлох боломжгүй, харин Бурхан Өөрөө үүнийг хариулж, шийддэг гэж хэлдэг. Ийм байдлаар, үнэхээр амийн замыг эрж хайхыг хүсвэл чи Бурхан газар дэлхийд ирснээр хүнд амийн замыг хайрлах ажил хийдэг гэдгийг эхлээд хүлээн зөвшөөрөх ёстой, мөн эцсийн өдрүүдэд Тэрээр хүнд амийн замыг хайрлахаар газар дэлхий дээр ирдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь өнгөрсөн үе биш; харин өнөөдөр тохиолдож байгаа юм.

Эцсийн өдрүүдийн Христ амийг, мөн өнө удаан мөнхөд үргэлжлэх үнэний замыг авчирдаг. Энэ үнэн бол хүн амийг олж авах зам, нөгөөтээгүүр хүн Бурханыг мэдэж, Бурханаар сайшаагдах цорын ганц зам юм. Хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийн өгсөн амийн замыг эрж хайхгүй бол хэзээ ч Есүсийн сайшаалыг олж, тэнгэрийн хаанчлалын үүдээр орох шаардлагыг хангаж чадахгүй. Учир нь чи бол түүхийн хоригдол агаад утсан хүүхэлдэй юм. Дүрэм журам, бичиг үсэгт захирагдаж, түүхэнд дөнгөлүүлсэн хүмүүс хэзээ ч амийг олж авч чадахгүй, мөнх амийн замыг ч бас хэзээ ч олж авч чадахгүй. Яагаад гэвэл, тэдэнд байгаа бүхэн бол сэнтийгээс урсах амийн ус биш, харин ердөө л хэдэн мянган жилийн турш тогтонги байсан булингартай ус юм. Амийн усаар

а. Үжирсэн мод: “ямар ч нэмэргүй” гэсэн утгатай хятад хэлц.

хангагдаагүй хүмүүс үүрд хүүр, Сатаны зугаа, тамын хүү хэвээр үлдэнэ. Ийм маягаар, тэд Бурханыг хэрхэн харж чадах вэ? Хэрвээ чи зөвхөн өнгөрсөнтэй зууралдаж, юу ч хийлгүйгээр аливаа зүйлийг байгаагаар нь байлгахыг хичээн, байгаа байдлаа өөрчилж, түүхийг хаяхаар хичээдэггүй бол үргэлж Бурханы эсрэг байхгүй гэж үү? Бурханы ажлын алхмууд нь долгилох давлагаа, нүргэлэх аянга мэт далайцтай, хүчирхэг—гэтэл чи мунхаглалдаа хөтлөгдөж, юу ч хийлгүй зүгээр суугаад сүйрлээ хүлээж байна. Ийм байж чи яаж Хурганы мөрийг дагадаг нэгэн гэж тооцогдох юм бэ? Чи өөрийнхөө зууралддаг тэр Бурханыг үргэлж шинэ, хэзээ ч хуучирдаггүй Бурхан гэж яаж батлах вэ? Мөн шарласан номуудын чинь бичиг үсэг яаж чамайг шинэ эринд аваачих вэ? Тэдгээр нь яаж чамайг Бурханы ажлын алхмуудыг хайхад хөтлөх вэ? Мөн яаж чамайг тэнгэр лүү аваачих вэ? Чиний гарт буй зүйл бол түр зуурын тайтгарал өгөх бичиг үсэг болохоос амь өгөх чадалтай үнэн биш юм. Чиний уншдаг бичвэрүүд зүгээр л хэл яриаг чинь баяжуулдаг зүйл болохоос төгс болгуулах зам байх нь байтугай, хүний амьдралыг мэдэхэд туслах мэргэн ухааны үг ч биш юм. Энэ зөрөө чамд ямар нэг юм бодогдуулахгүй байна уу? Энэ чамд доторх нууцуудыг нь ойлгуулахгүй байна гэж үү? Чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай уулзаж чадах уу? Бурхан ирэхгүй бол чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай хамт гэр бүлийн аз жаргал эдэлж чадах уу? Чи одоо ч мөрөөдсөөр л байна уу? Тэгвэл Би чамайг мөрөөдөхөө больж, одоо хэн ажиллаж байгааг, эцсийн өдрүүдэд хүмүүсийг аврах ажлыг хэн явуулж байгааг хар гэж зөвлөж байна. Эс бөгөөс чи хэзээ ч үнэнийг олж авч чадахгүй, мөн хэзээ ч амийг олж авч чадахгүй.

Христийн хэлсэн үнэнд найдалгүйгээр амь олж авахыг хүсдэг хүмүүс бол газар дэлхий дээрх хамгийн инээдэмтэй хүмүүс, Христийн авчирсан амийн замыг хүлээн авдаггүй хүмүүс бол бүтэшгүй мөрөөдөлд автсан хүмүүс юм. Иймд Би эцсийн өдрүүдийн Христийг хүлээн авдаггүй хүмүүсийг Бурхан үүрд үзэн ядна гэж хэлдэг. Христ бол хүний эцсийн өдрүүдэд хаанчлалд орох үүд хаалга бөгөөд үүнийг хэн ч тойрч эс гарна. Христээр дамжилгүйгээр хэн ч Бурханаар төгс болгуулахгүй. Чи Бурханд итгэдэг, иймээс чи Түүний үгийг хүлээн авч, Түүний замыг дуулгавартай дагах ёстой. Чи үнэнийг ойлгохгүйгээр, амийн хангалтыг хүлээн авахгүйгээр ерөөл хүртэнэ гэж санахын ч хэрэггүй. Христэд үнэхээр итгэдэг бүх хүнийг амиар хангахын тулд Тэр эцсийн өдрүүдэд ирсэн. Энэ ажил нь хуучин эринийг төгсгөж, шинэ эринд орохын төлөө байдаг бөгөөд Түүний ажил бол шинэ эринд орох бүх хүний явах ёстой зам юм. Хэрвээ чи хүлээн зөвшөөрч чадахгүй, оронд нь яллаж, доромжилж, бүр хяхаж хавчдаг бол

мөнхийн галд шатах тавилантай бөгөөд Бурханы хаанчлалд хэзээ ч орж чадахгүй. Учир нь энэ Христ бол Өөрөө Ариун Сүнсний илэрхийлэл, Бурханы илэрхийлэл, Бурханы газар дэлхий дээрх ажлаа даалгасан Нэгэн билээ. Иймд хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийн хийсэн бүхнийг хүлээн авч чадахгүй бол Ариун Сүнсийг доромжилж байна гэж Би хэлнэ. Ариун Сүнсийг доромжилдог хүмүүсийн амсах ёстой залхаан цээрлүүлэлт бүгдэд тодорхой байдаг. Хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийг эсэргүүцэж, голбол үр дагаврыг нь өмнөөс чинь үүрч чадах хэн ч байхгүй гэж Би бас хэлдэг. Түүнчлэн энэ өдрөөс хойш Бурханы сайшаалыг хүртэх өөр боломж чамд олдохгүй; чи өөрийгөө аврахыг оролдсон ч Бурханы царайг дахин хэзээ ч харахгүй. Учир нь чиний эсэргүүцдэг зүйл хүн биш, чиний голдог зүйл ямар нэг шалихгүй хүн биш, харин Христ билээ. Чи үүний үр дагавар юу байхыг мэдэж байна уу? Чи жижиг алдаа гаргасан биш, харин асар том нүгэл үйлдсэн байх болно. Иймээс, үнэн л чамд амь авчирч, өөр юу ч биш зөвхөн үнэн л чамд дахин төрж, Бурханы царайг харах боломж олгох учраас Би бүх хүнд үнэний өөдөөс архирч, болгоомжгүй шүүмжлэл хэлэхгүй байхыг зөвлөж байна.

ХҮРЭХ ГАЗРЫНХАА ТӨЛӨӨ ХАНГАЛТТАЙ САЙН ҮЙЛ БЭЛД

Би та нарын дунд их ажил хийсэн бөгөөд мэдээж нэлээд хэдэн айлдвар ч хэлсэн. Гэсэн ч Миний үг болон ажил эцсийн өдрүүд дэх ажлын маань зорилгыг бүрэн биелүүлээгүй гэж Надад өөрийн эрхгүй санагддаг. Учир нь, эцсийн өдрүүдэд Миний ажил тодорхой нэг хүн, эсвэл тодорхой хүмүүсийн төлөө биш, харин Миний төрөлх зан чанарыг илчлэхийн төлөө байдаг. Гэсэн ч үй олон шалтгааны улмаас—магадгүй цаг хугацаа хомс юм уу ажлын завгүй хуваариас болж—хүмүүс Миний зан чанараас Миний тухай ямар ч мэдлэг олж авсангүй. Тиймээс Би, Өөрийн шинэ төлөвлөгөө, сүүлчийн ажилд орж, ажилдаа шинэ хуудас нээдэг, ингэснээр Миний оршин тогтнолоос болж Намайг хардаг бүхэн цээжээ дэлдэн, тасралтгүй цурхиран уйлна. Яагаад гэвэл, Би хүн төрөлхтний төгсгөлийг дэлхий ертөнцөд авчирдаг бөгөөд энэ мөчөөс эхлээд хүн төрөлхтний өмнө бүхий л зан чанараа ил болгодог, ийнхүү Намайг мэддэг болон мэддэггүй бүх хүн нүдээ хужирлаж, үнэхээр хүний ертөнцөд ирчихсэн, бүх зүйл үржин олширдог газар дэлхийд ирчихсэн гэдгийг минь харж болох юм. Энэ бол Миний төлөвлөгөө, хүн төрөлхтнийг бүтээснээс хойших цорын ганц “өчил” минь билээ.

Та нар Миний үйл хөдөлгөөн бүрд анхаарлаа бүрэн хандуулах болтугай, учир нь Миний саваа хүн төрөлхтөнд, Намайг эсэрүүцдэг бүх хүнд дахин нэгэнтээ ойртож байна.

Тэнгэрүүдийн хамтаар Би хийх ёстой ажлаа эхэлдэг. Тиймээс Би хүмүүсийн урсгал дундуур алхаж, тэнгэр газрын хооронд шилжин явдаг ба хэн ч Миний хөдөлгөөнийг ухамсарлаж, Миний үгийг анзаардаггүй. Тиймээс Миний төлөвлөгөө саадгүй өрнөсөөр байдаг. Бүх мэдрэмж чинь маш хөшүүн болсон болохоор л та нар Миний ажлын алхмуудыг мэддэггүй. Гэхдээ та нар Миний санаа зорилгыг ухаарах өдөр гарцаагүй ирнэ. Өнөөдөр Би та нартай хамт амьдарч, хамт зовдог бөгөөд Надад хүн төрөлхтний ханддаг хандлагыг аль эрт ойлгож авсан. Би энэ талаар цааш нь ярихыг хүсдэггүй, энэхүү аягүй сэдвээр нэмж жишээ татан та нарт ичгүүр авчрахыг бүр ч хүсдэггүй. Та нар хийсэн бүхнээ зүрх сэтгэлдээ санадаг гэж л Би найддаг, ингэснээр бид дахин уулзах тэр өдөр тайлангаа тулгаж болох юм. Би та нарын дундаас хэнийг ч хилсээр буруутгахыг хүсдэггүй, учир нь Би үргэлж голч шударга, зүй зохистой, нэр төртэйгээр үйлдэж ирсэн билээ. Мэдээж, та нар ч бас уужим сэтгэлтэй байж, тэнгэр, газар юм уу өөрийнхөө мөс чанарт харшлах юу ч хийхгүй гэдэгт Би найдаж байна. Та нараас Миний шаарддаг цорын ганц зүйл бол энэ. Аймшигтай том нүгэл үйлдсэнээсээ болоод олон хүн айн түгшиж, санаа зовдог бөгөөд ганц ч удаа сайн үйл үйлдээгүйгээсээ болж олон хүн өөрсдөөсөө ичдэг. Гэсэн ч нүглээсээ ичих нь байтугай, муу байснаа улам дордож, Миний зан чанарыг туршихын тулд хараахан ил болоогүй байсан бузар дүрийг нь нуусан багаа бүрэн хуу татдаг хүмүүс ч бас олон бий. Би аливаа нэг хүний үйлдлийг тоодог ч үгүй, анхаардаг ч үгүй. Харин ч мэдээлэл цуглуулах ч бай, газар нутгаар аялах ч бай, эсвэл Өөрийн сонирхлын дагуу ямар нэгэн зүйл хийх ч бай хамаагүй, Би Өөрийн хийх учиртай ажлыг хийдэг. Гол цаг үед Би хүмүүсийн дундах ажлаа ганц ч хором оройтолгүй, эсвэл эртдэлгүйгээр анх төлөвлөж байснаараа төвөггүй, шуурхай явуулдаг. Гэхдээ Миний ажлын алхам бүрд зарим хүн хөсөр хаягддаг, учир нь Би тэдний долигонуур занг болон хуурамч дүр эсгэдэг боол шиг дүр төрхийг жигшдэг. Миний зэвүүцдэг хүмүүс, санаатай ч бай, санаандгүй ч бай хаягдах нь гарцаагүй. Товчхондоо, Би Өөрийнхөө үзэн яддаг бүх хүнийг Өөрөөсөө хол байлгана. Миний гэрт үлдсэн хорон муу хүмүүсийг Би хэлтрүүлэхгүй гэдгийг хэлэхийн ч хэрэггүй. Хүний шийтгэлийн өдөр ойрхон байгаа учраас тэр бүх жигшүүртэй сүнсийг Өөрийн гэрээс хөөн явуулах гэж Би яардаггүй, учир нь Надад Өөрийн гэсэн төлөвлөгөө бий.

Одоо бол Би хүн бүрийн төгсгөлийг тодорхойлдог үе, харин хүнийг хүн болгож эхлэх үе шат биш. Би хүн бүрийн үг, үйлдлийг, Намайг дагасан тэдний зам, тэдний төрөлх шинж чанар болон эцэстээ тэд биеэ хэрхэн авч явсныг бүртгэлийн дэвтэртээ нэг бүрчлэн тэмдэглэдэг. Ийм маягаар, ямар ч хүн байлаа гэсэн, хэн ч Миний гараас мултрахгүй бөгөөд Миний тогтоосончлон бүгд өөрсдийн төрөлтэй хамт байх болно. Би нас, зэрэг зиндаа, зовлонгийн хэмжээ, ялангуяа өрөвдүүлж буй түвшинд нь үндэслэж бус, харин үнэнийг эзэмшдэг эсэхийнх нь дагуу хүн бүрийн хүрэх газрыг тодорхойлдог. Үүнээс өөр сонголт гэж үгүй. Бурханы хүслийг дагадаггүй бүх хүн ч бас шийтгүүлнэ гэдгийг та нар ухаарах ёстой. Энэ бол хэн ч өөрчилж чадахгүй зүйл юм. Тиймээс шийтгүүлдэг бүх хүн Бурханы зөвт байдлын улмаас тийнхүү шийтгүүлж, тоймгүй олон муу үйлийнхээ залхаан цээрлүүлэлтийг амсдаг юм. Би эхэлснээс нь хойш төлөвлөгөөндөө ганц ч өөрчлөлт хийгээгүй. Хүний тухайд гэх юм бол, ердөө л Миний үгээ чиглүүлдэг хүмүүсийн тоо хорогдож, үнэхээр сайшаадаг хүмүүсийн тоо ч бас хорогдож байх шиг байна. Гэхдээ Миний төлөвлөгөө хэзээ ч өөрчлөгдөөгүй гэж Би хэлсээр байна; харин ч хүний итгэл, хайр үргэлж өөрчлөгдөж, дандаа багасан, хүн бүр Надад зусардаж байснаа хүйтэн хөндий хандаж, бүр Намайг хаяхдаа хүрэх ч боломжтой. Би зэвүүцэж, үзэн ядаж, эцэст нь шийтгэл оноомоор болох хүртэл та нарт хандах Миний хандлага халуун дулаан ч биш, хүйтэн цэвдэг ч биш байх болно. Гэвч шийтгэлийн чинь өдөр Би та нарыг мөн л харна, харин та нар Намайг харж чадахаа болино. Та нарын дундах амьдрал Миний хувьд хэдийн залхмаар, сонирхолгүй болсон тул та нарын хорсолтой үгийн доромжлолоос зайлсхийж, тэвчихийн аргагүй бузар булай ааш авираас чинь холдож, та нар цаашид Намайг хуурч, эсвэл Надад хааш яаш байдлаар хандахаас зайлсхийхийн тулд өөр орчинд амьдрахаар сонгочихсон гэдгээ хэлэх нь илүүц юм. Та нарыг орхин явахаасаа өмнө Би үнэнтэй нийцдэггүй зүйл хийхийг цээрлэ гэж та нарт бас л захих ёстой. Харин ч та нар бүгдэд таалагдах, бүгдэд ашиг тус авчрах, мөн өөрийн чинь хүрэх газарт ашиг тустай зүйл хийх хэрэгтэй, эс бөгөөс гамшгийн дунд өөр хэн ч биш, чи л зовно.

Намайг хайрлаж, өөрсдийгөө орхидог хүмүүс дээр Миний өршөөл харагддаг. Харин хорон муу хүмүүст очдог шийтгэл нь яг нарийндаа Миний зөвт зан чанарын нотолгоо, тэр ч бүү хэл, Миний уур хилэнгийн гэрчлэл юм. Гамшиг ирэх үед Намайг эсэргүүцдэг бүхэн өлсгөлөн, тахалд нэрвэгдээд цурхиран уйлна. Бүх төрлийн хорон мууг үйлдсэн боловч Намайг олон жил дагасан хүмүүс нүглийнхээ төлөөсийг төлөхөөс зайлахгүй; тэд ч бас хэдэн сая жилийн турш

ховорхон үзэгдэх гамшигт унаж, байнга айж, түгшсэн байдалтай амьдарна. Надад үнэнч зангаа харуулсан дагагчид маань баярлан хөөрч, Миний сүр хүчийг шагшин магтана. Тэд үгээр хэлэхийн аргагүй сэтгэл ханамжийг мэдэрч, хүн төрөлхтөнд Миний урьд өмнө хэзээ ч хайрлаж байгаагүй баяр хөөр дунд амьдарна. Учир нь Би хүний сайн үйлийг нандигнаж, муу үйлийг нь жигшдэг билээ. Би хүн төрөлхтнийг анх залж чиглүүлж эхэлснээсээ хойш Өөртэйгөө санаа нэгтэй бүлэг хүмүүсийг олж авах гэж хүсэмжлэн найдсаар ирсэн юм. Харин Надтай адил санаатай биш хүмүүсийг Би хэзээ ч мартдаггүй; Би зүрх сэтгэлдээ тэднийг үргэлж үзэн ядаж, тэдэнд цээрлэл авчрах боломжийг хүлээдэг бөгөөд үүнийг Би баясан харна. Одоо Миний өдөр нэгэнт ирчихлээ, Би цаашид хүлээх хэрэггүй!

Миний сүүлчийн ажил хүнийг шийтгэхийн төлөө төдийгүй, мөн хүний хүрэх газрыг зохицуулахын төлөө байдаг. Түүнчлэн энэ нь бүх хүнд Миний үйл хэрэг, үйлдлийг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө байдаг. Миний хийсэн бүхэн зөв, мөн Миний хийсэн бүхэн бол Миний зан чанарын илэрхийлэл, харин хүний үйл хэрэг биш бөгөөд хүн төрөлхтнийг бий болгосон нь байгаль бүр ч биш, харин бүтээлийн амьд зүйл бүрийг тэжээн тэтгэдэг нь Би юм гэдгийг хүн нэг бүрд харуулахыг Би хүсдэг. Миний оршин тогтнолгүйгээр хүн төрөлхтөн мөхөж, гай зовлонгийн дайралтад л өртөнө. Үзэсгэлэнт нар, сарыг, эсвэл ногоон дэлхийг нэг ч хүн дахин хэзээ ч харахгүй; хүн төрөлхтөн гагцхүү хүйтэн шөнө, туулахын аргагүй үхлийн харанхуйн хөндийтэй л тулгарна. Би бол хүн төрөлхтний цорын ганц аврал. Би бол хүн төрөлхтний цорын ганц найдвар, түүнчлэн Би бол бүх хүн төрөлхтний оршин тогтнол тулгуурлаж байдаг Нэгэн билээ. Надгүйгээр хүн төрөлхтөн дорхноо зогсонги байдалд орно. Надгүйгээр хүн төрөлхтөн сүйрлийн гай зовлон амсаж, төрөл бүрийн сүнсний хөлд гишгэлэгдэнэ, гэхдээ хэн ч Намайг анхаардаггүй. Би өөр хэний ч хийж чадахгүй ажлыг хийсэн бөгөөд хүн зарим нэг сайн үйлээрээ Миний ачийг хариулж чадна гэж л найддаг. Тун цөөхөн хүн Миний ачийг хариулж чадсан хэдий ч Би хүний ертөнц дэх аянаа ямар ч атугай дуусгаж, ажлынхаа дараагийн алхмыг эхлүүлнэ, учир нь энэ олон жилийн турш хүмүүсийн дунд ийш, тийш гүйсэн минь бүгд үр дүнтэй байсан бөгөөд Би тун сэтгэл хангалуун байна. Би хүмүүсийн тоог биш, харин тэдний сайн үйлийг анхаардаг. Товчхондоо, та нар өөрсдийн хүрэх газарт зориулан хангалттай сайн үйл бэлдэнэ гэж Би найддаг. Тэгвэл Би сэтгэл хангалуун болно; эс бөгөөс та нарт тохиолдох гамшгаас хэн ч зугтаж чадахгүй. Гамшиг Надаас үүдэлтэй бөгөөд мэдээж Би зохион байгуулдаг. Хэрвээ та нар Миний нүдэнд сайн

харагдаж чадахгүй бол гай гамшгийн зовлон амсахаас зайлахгүй. Гай зовлонгийн дунд, та нарын үйлдэл, үйл хэрэг чинь бүхэлдээ зүй зохистой гэж тооцогдоогүй, учир нь та нарын итгэл, хайр хий хоосон бөгөөд хулчгар юм уу хатуужилтай гэдгээ л та нар харуулсан. Энэ тухайд Би зөвхөн сайн, муу гэдгийг шүүнэ. Та нарын тус тусын бүх үйлдэл, бүх илэрхийллийг Би анхаарсаар байдаг бөгөөд үүний үндсэн дээр төгсгөлийг чинь тодорхойлно. Гэхдээ Би үүнийг тодорхой болгох ёстой: Гай зовлонгийн үеэр Надад өчүүхэн төдий ч үнэнч байгаагүй хүмүүст Би цаашид өршөөнгүй хандахгүй, учир нь Миний өршөөл ердөө энэ хүртэл үргэлжилдэг. Түүнчлэн Надаас нэгэнтээ урвасан хэнд ч Би дургүй, найз нөхдийнхөө ашиг сонирхлыг худалддаг хүмүүстэй харилцах бүр ч дургүй. Тухайн хүн хэн байх нь хамаагүй, энэ бол Миний зан чанар юм. Би та нарт үүнийг хэлэх ёстой: Миний зүрх сэтгэлийг шархлуулдаг хэн ч Надаас хоёр дахь удаагаа өршөөл хүртэхгүй бөгөөд Надад үнэнч байсаар ирсэн хэн боловч зүрх сэтгэлд минь үүрд үлдэнэ.

ЧИ ХЭНД ҮНЭНЧ ВЭ?

Яг одоо та нарын туулан амьдарч буй өдөр хоног бүр тун чухал бөгөөд энэ нь хүрэх газар, хувь заяанд чинь дээд зэргийн ач холбогдолтой, иймээс та нар өнөөдөр өөрсдөдөө байгаа бүхнийг нандигнаж, өнгөрч буй хором бүрийг эрхэмлэх ёстой. Та нар энэ амьдралдаа дэмий амьдрахгүйн тулд өөртөө хамгийн их ашиг тус хүртээхэд аль болох их цаг гаргах ёстой. Намайг яагаад ийм үг хэлж байгаа талаар та нарт хачирхалтай санагдаж байж магад. Шулуухан хэлэхэд, та нарын хэний ч үйлдэлд Би сэтгэл хангалуун байдаггүй, учир нь одоогийн байдал чинь Миний найдаж байсан зүйл биш. Тиймээс Би ингэж хэлж болно: Та нар дор бүрнээ аюулын ирмэг дээр байгаа ба тусламж гуйсан урьдын хашхираан, үнэнийг эрэлхийлж, гэрлийг эрж хайх хуучны хүсэл эрмэлзэл чинь төгсгөлдөө ойртож байна. Энэ бол эцэстээ та нарын барьж буй хариу бөгөөд Миний хэзээ ч хүлээж байгаагүй зүйл юм. Би баримтын эсрэг ярихыг хүсэхгүй, учир нь та нар Намайг ихэд гонсойлгосон. Та нар үүнийг зүгээр орхихыг хүсдэггүй, бодит байдалтай нүүр тулахыг хүсдэггүй байж магадгүй, гэсэн ч Би та нараас үүнийг нухацтай асуух ёстой: Энэ бүх жилд та нарын зүрх сэтгэл яг юугаар дүүрсэн байсан бэ? Хэнд үнэнч юм бэ? Эдгээр асуулт санамсаргүй гарсан гэж битгий хэл, мөн яагаад ийм зүйл асуусныг минь Надаас бүү асуу. Үүнийг мэдэж ав: Би та нарыг дэндүү сайн мэддэг, та нарыг дэндүү их

халамжилдаг, мөн та нарын хийж байгаа бүхэнд зүрх сэтгэлээ хэтэрхий их зориулсан учраас та нараас зогсолтгүй асууж, гашуун зовлон бэрхшээл үүрсэн. Гэсэн ч та нар Надад хайхрамжгүй байдал, тэвчишгүй арга мөхөс байдлаас өөр юугаар ч хариу барьдаггүй. Та нар Надад хааш яаш хандсаар ирсэн; Би энэ талаар юу ч мэдэхгүй байх боломжтой гэж үү? Хэрвээ ингэж боддог бол та нар Надад үнэхээр сайхан сэтгэлээр ханддаггүй гэдэг баримтыг улам нотолж байна. Иймээс, та нар өөрийгөө хуурч байна гэж Би хэлдэг. Та нар бүгдээрээ яг юу хийж байгаагаа ч мэддэггүй маш ухаантай—тэгвэл Надад тайлан өгөхдөө та нар юу ашиглах вэ?

Миний санааг хамгийн их зовоодог асуулт бол та нарын зүрх сэтгэл яг хэнд үнэнч вэ гэдэг юм. Та нар дор бүрнээ бодлоо цэгцлэх гэж хичээж, хэнд үнэнч болохоо, хэний төлөө амьдардгаа өөрсдөөсөө асууна гэдэгт Би бас найддаг. Та нар иймэрхүү асуултыг хэзээ ч анхааралтай бодолцож үзээгүй байх, тэгэхээр Би та нарт хариултыг нь илчилбэл ямар вэ?

Ой ухаантай хэн боловч энэ баримтыг хүлээн зөвшөөрнө: Хүн өөрийнхөө төлөө амьдардаг ба өөртөө үнэнч байдаг. Та нарын хариулт бүхэлдээ зөв гэж Би бодохгүй байна, учир нь та нар тус тусын амьдралдаа оршиж, дор бүрнээ өөрийн зовлонтой тэмцэлдэж байгаа. Ийм болохоор та нар хайртай хүмүүстээ, мөн таалагддаг зүйлсдээ үнэнч; өөрсдөдөө бүрэн дүүрэн үнэнч биш. Та нар дор бүрнээ эргэн тойрныхоо хүмүүс, үйл явдал, эд юмсын нөлөөнд автдаг учраас өөрсдөдөө үнэхээр үнэнч биш байдаг. Өөрсдөдөө үнэнч байгааг чинь сайшаах гэж биш, харин ямар нэг зүйлд үнэнч байдгийг чинь илчлэх гэж Би эдгээр үгийг хэлдэг, учир нь маш олон жилийн турш Би та нарын хэнээс ч, хэзээ ч үнэнч байдлыг хүлээж аваагүй. Та нар Намайг энэ олон жил дагасан атлаа үнэнч байдлынхаа өчүүхэн төдийг ч Надад өгөөгүй. Харин ч хайртай хүмүүс болон таалагддаг зүйлсээ тойрон эргэлдэж, бүр цаг үргэлж, хаашаа ч явсан тэдгээрийг зүрх сэтгэлдээ ойр байлгадаг ба хэзээ ч хаяж орхиогүй. Та нар хайрладаг ямар нэг зүйлээ хүсэмжилж, тэмүүлэх тоолонд энэ нь Намайг дагаж байхад, эсвэл бүр Миний үгийг сонсож байхад чинь хүртэл тохиолддог. Тиймээс та нараас Миний шаарддаг үнэнч байдлыг та нар харин өөрсдийн “тэжээвэр амьтдад” үнэнч байж, тэднийг нандигнахад ашигладаг гэж Би хэлнэ. Хэдийгээр та нар Миний төлөө ганц, хоёр юм золиосолж байсан ч энэ нь та нарын бүх юмыг төлөөлдөггүй, Надад үнэхээр үнэнч байдаг гэдгийг чинь харуулдаггүй. Та нар дурладаг ажил үйлдээ өөрсдийгөө татан оролцуулдаг: Зарим хүн хөвгүүд, охиддоо, бусад нь нөхөр, эхнэр, эд баялаг, ажил, дарга нар, байр суурь,

эмэгтэйчүүдэд үнэнч байдаг. Үнэнч байдаг зүйлээсээ та нар хэзээ ч залхаж, дургүйцдэггүй; харин ч эдгээр зүйлийг илүү их хэмжээгээр, илүү сайн чанартайг нь эзэмшихээр улам бүр тэмүүлдэг ба хэзээ ч орхидоггүй. Намайг болон Миний үгийг та нар үргэлж дуртай зүйлсийнхээ хойгуур түлхдэг. Тэгээд тэдгээрийг хамгийн сүүлд эрэмбэлэхээс өөр арга та нарт байдаггүй. Хараахан олж мэдээгүй байгаа зүйлсдээ үнэнч байх гэж энэ сүүлчийн байрыг үлдээдэг хүмүүс ч бий. Тэдний зүрх сэтгэлд Миний өчүүхэн ч ул мөр хэзээ ч байгаагүй. Намайг та нараас хатуу чанд шаардаж, эсвэл хилсээр буруутгаж байна гэж та нар бодож байж магад—гэхдээ гэрийнхэнтэйгээ хамт цагийг жаргалтай өнгөрүүлж байхдаа та нар Надад нэг ч удаа үнэнч байгаагүй гэдэг баримтыг ер нь бодолцож үзсэн үү? Иймэрхүү үед та нар үүнээс болж шаналдаггүй гэж үү? Зүрх сэтгэл чинь баяр хөөрөөр дүүрч, ажил хөдөлмөрийнхөө төлөө шагнал хүртэх үедээ өөрсдийгөө хангалттай үнэнээр зэвсэглээгүйдээ гутардаггүй гэж үү? Миний сайшаалыг хүртээгүйнхээ төлөө та нар хэзээ цурхиран уйлсан бэ? Та нар хөвгүүд, охидынхоо төлөө тархиа гашилгаж, сэтгэлээ асар их чилээдэг ч мөн л сэтгэл ханадаггүй; тэдний өмнөөс мэрийгээгүй, тэдний төлөө чадах бүхнээ хийгээгүй гэж бодсоор байдаг. Харин Надад та нар үргэлж тоомсоргүй, хааш яаш хандаж ирсэн; Би дурсамжид чинь л байдаг боловч зүрх сэтгэлд чинь удаан үлддэггүй. Та нарын төлөөх Миний чин сэтгэлийн хүчин чармайлтыг та нар ерөөсөө мэдэрдэггүй бөгөөд тэдгээрийг хэзээ ч ойлгож байгаагүй. Та нар ердөө товчхон эргэцүүлээд, энэ нь хангалттай гэж боддог. Ийм “үнэнч байдал” бол Миний эртнээс хүсэн мөрөөдсөн зүйл биш, харин эртнээс жигшсэн зүйл билээ. Гэхдээ Намайг юу ч гэж хэлсэн бай, та нар ганц хоёрхон зүйлийг л зөвшөөрсөөр байдаг; үүнийг бүрэн хүлээн зөвшөөрч чаддаггүй, учир нь та нар бүгд “өөртөө маш итгэлтэй” бөгөөд Миний хэлсэн үгээс алийг нь хүлээн зөвшөөрөхөө үргэлж шилж, сонгодог. Хэрвээ та нар өнөөдөр ийм хэвээр байх юм бол та нарын өөртөө итгэлтэй байдалтай харьцах зарим арга Надад бий, мөн үүнээс гадна Миний бүх үг үнэн бөгөөд тэдгээрийн аль нь ч баримтуудыг гуйвуулдаггүй гэдгийг Би та нараар хүлээн зөвшөөрүүлнэ.

Хэрвээ Би яг одоо та нарын өмнө хэсэг мөнгө тавиад, дураараа сонгох эрх өгсөн бол, сонголтын чинь төлөө та нарыг яллахгүй байсан бол—та нарын ихэнх нь мөнгийг сонгож, үнэнийг хаях байсан. Та нарын дундаас арай өөдтэй нь мөнгийг орхиж, үнэнийг дурамжхан сонгож байхад энэ хоёрын дундах хүмүүс нэг гартаа мөнгө, нөгөөдөө үнэнийг барих байсан. Ийнхүү та нарын үнэн төрх илэрхий болохгүй гэж үү? Үнэн болон үнэнч байдаг зүйлийнхээ аль нэгийг

сонгох үедээ та нар бүгд ийм сонголтыг хийх бөгөөд хандлага чинь хэвээр үлдэх байсан. Тэгэхгүй гэж үү? Зөв, буруугийн хооронд хэлбэлзсэн хүмүүс та нарын дунд олон байдаггүй гэж үү? Гэр бүл ба Бурхан, хүүхдүүд ба Бурхан, эв найр ба хагарал, элбэг баян байдал ба ядуурал, байр суурь ба эгэл байдал, дэмжлэг авах ба хөсөр хаягдах зэрэг эерэг ба сөрөг, хар ба цагааны хоорондох тэмцэлд хийсэн сонголтуудаа та нар мэдэж байгаа нь лавтай. Эв найртай гэр бүл, салсан гэр бүл хоёроос та нар эхнийхийг нь сонгосон ба ингэхдээ огт эргэлзээгүй; эд баялаг, үүрэг хоёроос бас л эхнийхийг нь, бүр эрэг рүү буцах^а хүсэлгүйгээр сонгосон; тансаг байдал, ядуурал хоёроос та нар эхнийхийг нь сонгосон; өөрийнхөө хөвгүүд охид, эхнэр, нөхөр болон Миний дундаас та нар эхнийхийг нь сонгосон; үзэл, үнэн хоёроос дахиад л эхнийхийг нь сонгосон. Бүх төрлийн ёрын муу үйл хэрэгтэй чинь тулгараад Би та нарт итгэх итгэлээ бараг алдчихсан. Зүрх сэтгэл чинь зөөлрөхөөргүй маш хатуу байдаг нь Намайг эгээ л туйлын их гайхшируулдаг. Олон жилийн зүтгэл, хүчин чармайлт Надад, та нарын орхилт, цөхрөлөөс өөр юу ч авчраагүй бололтой, гэвч та нарт тавих найдлага маань өдөр ирэх бүр ихэсдэг, учир нь Миний өдөр хүн бүрийн өмнө бүрэн ил болсон билээ. Гэсэн ч та нар харанхуй, ёрын муу зүйлсийг цөхрөлтгүй эрж хайн, тэдгээрээс зууралдахаа болихоос татгалздаг. Тэгвэл та нарын төгсгөл ямар байх вэ? Та нар үүнийг ер нь анхааралтай бодож үзсэн үү? Хэрвээ та нараас дахиад сонголт хийхийг хүсвэл хандлага чинь ямар байх вэ? Мөн л эхнийх нь байх уу? Та нар бас л Миний урмыг хугалж, таагүй уй гашуу авчрах болов уу? Та нарын зүрх сэтгэл мөн л өчүүхэн төдий халуун дулаан хэвээр байх болов уу? Миний зүрх сэтгэлийг тайвшруулахын тулд юу хийхээ мэдэхгүй хэвээр байх болов уу? Энэ мөчид та нар юу сонгож байна вэ? Миний үгэнд захирагдах уу, эсвэл тэдгээрээс залхах уу? Миний өдөр яг нүдний чинь өмнө ил болсон бөгөөд та нарт тулгардаг зүйл бол шинэ амьдрал, шинэ эхлэлийн цэг юм. Гэхдээ энэхүү эхлэлийн цэг нь урьдын шинэ ажлын эхлэл биш, харин хуучин ажлын төгсгөл юм гэдгийг Би та нарт хэлэх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ нь төгсгөл үе билээ. Энэхүү эхлэлийн цэгийн юу нь ер бусын болохыг та нар бүгд ойлгож чадна гэж Би бодож байна. Гэхдээ удалгүй нэг л өдөр та нар энэ эхлэлийн цэгийн жинхэнэ утга учрыг ойлгоно, тэгвэл бид хамтдаа энэхүү эхлэлийн цэгийг өнгөрөөж, ирж буй төгсгөлийг угтацгаая! Харин шударга бус болон шударга байдалтай тулгарах үедээ та нар үргэлж эхнийхийг сонгодог нь Миний санааг зовоосоор байгаа юм.

а. Эрэг рүү буцах: “муу замаасаа буцах” гэсэн утгатай хятад хэлц үг.

Гэхдээ энэ нь бүгд та нарын урьдын явдал. Би ч гэсэн та нарын өнгөрсөн бүхнийг мартана гэдэгтээ найдаж байна, гэвч мартахад тун хэцүү байдаг. Гэсэн ч Надад үүнийг хийх тун сайн арга бий: Өнгөрснийг ирээдүй орлож, урьдын сүүдэр чинь өнөөдрийн жинхэнэ төрхөөр чинь солигдон замхраг. Тиймээс Би дахин нэг удаа сонголт хийлгэн та нарт төвөг удах ёстой: Та нар яг хэнд үнэнч юм бэ?

ХҮРЭХ ГАЗРЫН ТУХАЙ

Хүрэх газрыг дурдах бүрд та нар тун нухацтай ханддаг; түүнчлэн энэ нь та бүгдийн онцгой мэдрэмтгий байдаг зүйл юм. Зарим хүн сайхан хүрэх газар олж авахын тулд толгойгоороо газар мөргөж, Бурханы өмнө бөхөлзөхөөр тэсэн яддаг. Үгээр илэрхийлэх шаардлагагүй та нарын эрмэлзлийг Би ялган таньж чадна. Та нар махан биеэ гамшигт унагахыг хүсдэггүй, ирээдүйд үүрдийн шийтгэлд унахыг бүр ч хүсдэггүй. Та нар арай илүү эрх чөлөөтэй, арай амар хялбар амьдрахыг л хүсдэг. Тиймээс, хүрэх газрын тухай дурдах бүрд тун их түгшиж, анхаарал хандуулаагүйгээсээ болж Бурханд халдаад, зохих цээрлүүлэлтээ хүлээх вий гэхээс ихэд айдаг. Та нар хүрэх газрынхаа төлөө буулт хийхээс татгалзаагүй бөгөөд нэгэн цагт залирхаг, хөнгөмсөг явсан олон хүн гэнэт маш эелдэг, чин үнэнч болчихсон; үнэнч байгаа чинь хүмүүсийг голд нь ортол дааруулдаг. Гэсэн ч та нар бүгд “үнэнч” зүрх сэтгэлтэй бөгөөд гомдол, хууран мэхлэлт, үнэнч байдал гээд сэтгэл дэх нууцаа юу ч нуулгүйгээр Надад байнга уудалсан. Ерөнхийдөө, та нар өөрсдийнхөө оршихуйн хамгийн гүнд орших мөн чанарын зүйлсийг Надад тун илэн далангүй “улайсан”. Мэдээж, эдгээр нь Надад дэндүү танил болсон учраас Би ийм зүйлээс хэзээ ч зайлсхийж байгаагүй. Та нар Бурханы сайшаалыг хүртэхийн тулд ганц үсээ алдсанаас эцсийн хүрэх газрынхаа төлөө их гал руу орохыг илүүд үзнэ. Би та нарт хэтэрхий ягшмал хандаж байгаа юм биш; харин Миний хийдэг бүхэнтэй нүүр тулахдаа та нар чин үнэнч зүрх сэтгэлгүй байгаа юм. Та нар дөнгөж сая хэлснийг минь ойлгохгүй байж магадгүй тул Би та нарт энгийнээр тайлбарлая: Та нарт хэрэгтэй зүйл үнэн ба амь биш, биеэ хэрхэн авч явах тухай зарчим ч биш, Миний уйгагүй ажил бүр ч биш. Харин ч та нарт хэрэгтэй зүйл бол эд баялаг, байр суурь, гэр бүл, гэрлэлт зэрэг махан биеэрээ эзэмшдэг бүхэн чинь билээ. Та нар Миний үг болон ажлыг бүрмөсөн үл хэрэгсдэг тул та нарын итгэлийг хайнга гэсэн нэг үгээр дүгнэж болно. Та нар зорьсон зүйлээ биелүүлэхийн тулд юуг ч хийнэ, гэхдээ Бурханд итгэх итгэлтэй холбоотой асуудлуудын төлөө тэгэхгүй гэдгийг чинь Би олж мэдсэн.

Харин ч та нар харьцангуй үнэнч, бас харьцангуй нухацтай байдаг. Тийм учраас Би, зүрх сэтгэл нь туйлын үнэнч бус хүмүүс Бурханд итгэх итгэлдээ бүтэлгүйдэг гэж хэлдэг. Сайтар бод—та нарын дунд бүтэлгүй хүн олон байна уу?

Хүмүүс өөрсдийнхөө үйлдлээс үүдэн Бурханд итгэх итгэлдээ амжилтад хүрдэг гэдгийг та нар мэдэх учиртай; хүмүүс амжилтад хүрэхийн оронд бүтэлгүйтэх үед тэр нь ч бас өөр бусад хүчин зүйлийн нөлөөнөөс бус, өөрсдийнх нь үйлдлээс болдог. Та нар Бурханд итгэхээс илүү хэцүү, илүү их зовлон учруулах зүйлд хүрэхийн тулд юуг ч хийн, үүнд тун нухацтай хандаж, бүр ямар ч алдаа гаргахыг хүсэхгүй байх байсан гэдэгт Би итгэдэг; энэ бол амьдралдаа та нарын гаргадаг нөр их хичээл чармайлт юм. Та нар гэр бүлийнхээ нэг ч гишүүнийг мэхлэхгүй байх нөхцөл байдалд Миний махбодыг мэхлэх чадвартай. Энэ бол та нарын тууштай зан авир, амьдралын чинь зарчим билээ. Хүрэх газар чинь гойд сайхан, хүссэнээр чинь байг гэсэндээ та нар хүрэх газрынхаа төлөө Намайг мэхлэхээр хуурамч царай гаргасаар л байгаа бус уу? Та нарын үнэнч зан түр зуурынх, чин сэтгэл чинь ч ердөө түр зуурынх гэдгийг Би мэднэ. Та нарын шийдвэр, төлж байгаа төлөөс ирээдүйн төлөө биш, зөвхөн өнөөдрийн төлөө байдаг бус уу? Та нар наймаа хийх цор ганц зорилготойгоор үзэсгэлэнтэй сайхан хүрэх газрыг олж авахаар мэрийн, эцсийн ганц хүчин чармайлт гаргахыг л хүсдэг. Та нар үнэнд өртэй болохоос зайлсхийхийн тулд, бүр Миний төлсөн төлөөсийг хариулахын тулд ч тийм хүчин чармайлт гаргадаггүй. Товчхондоо та нар хүссэн зүйлээ авахын тулд ухаалаг заль мэх ашиглахыг л хүсдэг боловч үүнийхээ төлөө ил тод тэмцэхийг хүсдэггүй. Энэ нь та нарын чин хүсэл биш гэж үү? Та нар дүр эсгэх ёсгүй, мөн нойр хоолноос гартлаа хүрэх газрынхаа төлөө тархиа гашилгах ч ёсгүй. Эцэст нь, та нарын төгсгөл аль хэдийн тодорхойлогдсон байх болно гэдэг нь үнэн бус уу? Та нар дор бүрнээ нээлттэй, үнэнч зүрх сэтгэлээр өөрсдийнхөө үүргийг чадлынхаа хэрээр биелүүлж, ямар ч төлөөс төлөхөд бэлэн байх ёстой. Та нарын хэлснээр, тэр өдөр ирэхэд Өөрийнх нь төлөө зовж, төлөөс төлсөн хэнд ч Бурхан хайхрамжгүй хандахгүй. Ийм итгэл үнэмшлийг байнга баримталбаас зохистой бөгөөд хэзээ ч мартах ёсгүй. Ийм маягаар л Би та нарын тухайд сэтгэл амар байж чадна. Эс бөгөөс, Би та нарын тухайд хэзээ ч сэтгэл амар байж чадахгүй бөгөөд та нар үүрд Миний зэвүүцлийн бай байх болно. Хэрвээ та нар бүгд мөс чанараа дагаж, бүх зүйлээ Надад зориулж, Миний ажлын төлөө хүчин чармайлтаа хайрлалгүй, насан туршийн эрч хүчээ Миний сайн мэдээний ажилд зориулж чадвал та нарын ачаар зүрх сэтгэл минь баярлан догдлохгүй гэж үү?

Ийм маягаар Би та нарын тухайд бүрмөсөн санаа амар байж чадна, тийм биз дээ? Та нар Миний хүлээдэг зүйлийн өрөвдмөөр өчүүхэн хэсгийг л хийж чаддаг нь харамсалтай. Ийм байхад та нар итгэж найдаж байгаа зүйлээ Надаас олж авахаар оролдох зүрх зоригтой байж яаж чадаж байна вэ?

Хүрэх газар, хувь заяа чинь та нарт маш чухал—асар их ач холбогдолтой. Аливааг маш анхааралтай хийхгүй бол хүрэх газаргүй болж, хувь заяагаа сүйрүүлсэн байх болно гэж та нар итгэдэг. Гэхдээ, гагцхүү хүрэх газрынхаа төлөө хүчин чармайлтаа зарцуулдаг хүмүүс хий дэмий хөдөлмөрлөж байгаа хэрэг гэж та нар ер нь бодож байв уу? Ийм хүчин чармайлт жинхэнэ биш—худал хуурмаг, ов мэх юм. Хэрвээ тийм бол, хүрэх газрынхаа төлөө л ажилладаг хүмүүс эцсийн ялагдлынхаа ирмэгт байна, учир нь хүний Бурханд итгэх итгэл ов мэхээс болж бүтэлгүйтдэг билээ. Надад зусардах, долигонох юм уу Надад урам зоригтой хандахад дургүй гэдгээ Би урьд нь хэлсэн. Үнэнч хүмүүс Миний үнэн болон хүлээлттэй нүүр тулахад Би дуртай. Хүмүүс Миний зүрх сэтгэлийг туйлын их анхаарч, хайхарч байгаагаа харуулахад, мөн Миний төлөө бүхнийг орхиж ч чадах үед Би бүр их дуртай. Ийм маягаар л Миний зүрх сэтгэлийг тайтгаруулж болно. Яг одоо та нарт Миний дургүй зүйл хэд байна вэ? Миний дуртай зүйл хэд байна вэ? Хүрэх газрынхаа төлөө гаргасан ой гутам байдлынхаа бүхий л илрэлийг та нарын нэг нь ч ухаараагүй юм гэж үү?

Зүрх сэтгэлдээ Би, эерэг агаад дээш тэмүүлдэг аливаа сэтгэлийг шархлуулахыг хүсдэггүй, үүргээ чин үнэнчээр биелүүлж байгаа хэн нэгний эрч хүчийг сулруулахыг бүр ч хүсдэггүй. Гэсэн хэдий ч, та нарын хангалтгүй байдал, зүрх сэтгэлийн чинь гүнд оршдог бузар сүнснийг дор бүрд чинь Би сануулах учиртай. Та нар Миний үгтэй нүүр тулахдаа чин сэтгэлээ зориулж чадна гэж найдан Би үүнийг хийдэг, учир нь Надад хандах хүмүүсийн ов мэхийг Би хамгийн их үзэн яддаг билээ. Миний ажлын сүүлийн үе шатанд та нар үүргээ гойд сайн биелүүлж чадах ба хайнга хандахаа болиод үнэн сэтгэлээсээ өөрсдийгөө зориулна гэж л Би найддаг. Мэдээж, та нар бүгд сайхан хүрэх газартай байна гэж ч найддаг. Гэсэн хэдий ч, Надад цорын ганц, эцсийн үнэнч байдлаа өргөх хамгийн сайн шийдвэрийг та нараар гаргуулах Өөрийн гэсэн шаардлага Надад байсаар байгаа. Хэрвээ хүнд тийм цорын ганц үнэнч байдал байхгүй бол тэр хүн мэдээж Сатаны нандин эзэмшил бөгөөд Би түүнийг ашиглана гэж хадгалахаа болиод, харин эцэг эхээр нь асруулахаар гэр лүү нь явуулна. Миний ажил та нарт маш их ач тустай; Би та нараас үнэнч, өөдөө тэмүүлдэг зүрх сэтгэлийг л авна гэж найддаг ч одоог хүртэл Би гар хоосон байсаар байна. Энэ

тухай бодоод үз: Нэг өдөр Би мөн л үгээр хэлэхийн аргагүй их гомдвол та нарт хандах хандлага минь тэр үед ямар байх вэ? Би одоогийнх шигээ эелдэг байх уу? Миний зүрх сэтгэл тэр үед одоогийнх шигээ амар амгалан байх уу? Тариалангийн талбайгаа уйгагүй хагалчхаад ганц ч үр тариа хурааж чадаагүй хүний мэдрэмжийг та нар ойлгож байна уу? Хүнд цохилтод орох үедээ хүний зүрх сэтгэл хэчнээн их шархалдгийг ойлгож байна уу? Нэгэн цагт итгэл найдвараар тун дүүрэн байсан ч хэн нэгэнтэй муудалцан салах ёстой болсон хүний гашуун зовлонг та нар амсаж чадах уу? Уур нь хүрсэн хүний гаргасан уур хилэнг та нар харж байсан уу? Дайсагнал амсаж, хууртагдаж байсан хүний өс хонзонгоо авах эрмэлзэл ямар байдгийг та нар мэдэх үү? Хэрвээ та нар энэ хүмүүсийн сэтгэхүйг ойлгож байвал залхаан цээрлүүлэлтийнхээ үеэр Бурхан ямар хандлагатай байхыг төвөггүй ойлгоно гэж Би бодож байна! Эцэст нь, та нар бүгд хүрэх газрынхаа төлөө нухацтай хичээл чармайлт гаргана гэж Би найдаж байна, гэхдээ хичээл чармайлтдаа овжин арга ашиглахгүй байсан чинь дээр, эс бөгөөс Би зүрх сэтгэлдээ та нарт урам хугарсан хэвээр байх болно. Тэгвэл энэ урам хугарсан байдал юунд хүргэх вэ? Та нар өөрсдийгөө хуурч байгаа бус уу? Хүрэх газрынхаа тухай боддог атлаа үүнийгээ сүйтгэдэг хүмүүс бол хамгийн аврагдах боломжгүй хүмүүс юм. Ийм хүн уурлаж, унтууцсан ч гэсэн хэн түүнийг өрөвдөх билээ? Товчхондоо, Би та нарыг тохиромжтой, бас сайн хүрэх газартай байгаасай гэж хүссэн хэвээр байгаа бөгөөд үүнээс ч илүүтэйгээр, та нарын нэг нь ч гамшигт унахгүй гэж найдаж байна.

ГУРВАН САНУУЛГА

Бурханд итгэгчийн хувиар чи бүх зүйл дээр ганцхан Түүнд үнэнч байх ёстой ба бүх зүйл дээр Түүний хүсэлд нийцэж чаддаг байх ёстой. Гэвч, хэдийгээр хүн бүр энэ сургаалыг ойлгодог боловч хүний элдэв төрлийн бэрхшээлээс болоод— жишээ нь, мэдлэггүй байдал, мунхаглал, завхралаас нь болоод эдгээр хамгийн илэрхий, хамгийн үндсэн үнэн хүнээс бүрэн харагддаггүй тул төгсгөлийг чинь шийдэхээсээ өмнө Би та нарын хувьд хамгийн чухал хэдэн зүйлийг эхлээд хэлж өгөх учиртай. Намайг үргэлжлүүлэхээс өмнө та нар эхлээд үүнийг ойлгох ёстой: Миний хэлдэг үг бол бүх хүн төрөлхтөнд чиглэсэн үнэн юм; тэдгээрийг тодорхой нэгэн хүнд юм уу нэг төрлийн хүнд л хандаж хэлдэг юм биш. Тиймээс та нар Миний үгийг үнэний өнцгөөс хүлээн авахад анхаарлаа төвлөрүүлж, бүрэн анхаарсан, чин сэтгэлийн хандлагатай байх ёстой; Миний хэлдэг ганц ч үг юм уу

үнэнийг бүү үл ойшоо, Миний хэлдэг бүх үгэнд хөнгөн хуумгай бүү ханд. Та нар амьдралдаа үнэнтэй хамаагүй зүйл ихээхэн хийснийг Би хардаг тул үнэний зарц болж, хорлонт муу, муухай байдалд боолчлогдохгүй байж, үнэнийг гишгэлэхгүй, Бурханы гэрийн аль ч булан тохойг бузарлахгүй байхыг онцгойлон хүсэж байна. Энэ бол та нарт өгөх Миний сануулга юм. Одоо Би уг сэдвийн талаар ярья.

Нэгдүгээрт, та нар өөрсдийнхөө хувь заяаны төлөө Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхөөр зорих ёстой. Өөрөөр хэлбэл, нэгэнт та нар Бурханы гэрийн гишүүн гэж тоологдсон гэдгээ хүлээн зөвшөөрсөн тул бүх зүйл дээр Бурханд сэтгэл санааны тайвшрал авчирч, Түүнийг хангалуун байлгах учиртай. Өөрөөр хэлбэл, чи үйлдлүүддээ зарчимтай байж, үнэнд нийцэх ёстой. Хэрвээ ингэж чадахгүй бол Бурханаар жигшигдэн, гологдож, хүн бүрд үл тоогдоно. Ийм таагүй байдалд ормогцоо чи Бурханы гэрийн гишүүн гэж тоологдож чадахгүй. Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхгүй байх гэдэг нь энэ юм.

Хоёрдугаарт, Бурхан үнэнч хүнд дуртай гэдгийг та нар мэдэх учиртай. Бурхан итгэмжит мөн чанартай болохоор Түүний үгэнд үргэлж итгэж болно; түүнчлэн, Түүний үйлдэл алдаа мадаггүй агаад маргаангүй байдаг. Ийм учраас Өөрт нь туйлын үнэнч хүмүүст Бурхан дуртай. Үнэнч байдал гэдэг нь Бурханд зүрх сэтгэлээ өгөх, бүх зүйл дээр Бурханд үнэн сэтгэлээсээ хандаж, бүх зүйл дээр Түүнтэй илэн далангүй байж, бодит баримтыг хэзээ ч нуухгүй байж, дээд, доод хүмүүсээ мэхлэхээр оролдохгүй байж, Бурханд бялдуучлах зүйл хэзээ ч хийхгүй байна гэсэн үг юм. Товчхондоо үнэнч байна гэдэг нь өөрийн үйлдэл болон үгийг цэвэр байлгаж, Бурханыг ч, хүнийг ч мэхлэхгүй байх явдал билээ. Миний хэлдэг зүйл маш энгийн боловч та бүхний хувьд хоёр дахин хэцүү бэрх байдаг. Олон хүн үнэнч шударгаар ярьж, үйлдсэний оронд тамд яллагдахыг илүүд үздэг. Иймээс үнэнч бус хүмүүст өөрөөр ханддагт минь гайхах юмгүй. Мэдээж үнэнч байхад хэчнээн хэцүү байдгийг чинь Би сайн мэднэ. Та нар бүгд маш ухаантай, юмыг өөрсдийн өчүүхэн жаахан хэмжүүрээр хэмжихдээ дадамгай учраас Миний ажлыг хавьгүй илүү амархан болгодог. Та нар дор бүрнээ өөрсдийн нууцыг дотроо хадгалж байдаг тул Би та нарыг галаар “хүмүүжүүлэхийн” тулд нэг нэгээр чинь гай гамшигт оруулна, ингэснээр тэр цагаас хойш та нар Миний үгэнд бүрэн итгэлтэй болж магад юм. Эцэст нь Би “Бурхан бол итгэмжит Бурхан” гэх үгийг амнаас чинь гарган авна, тэгэхэд та нар цээжээ дэлдэн “Хүний зүрх сэтгэл зальтай юм!” хэмээн халаглана. Тэр үед та нарын сэтгэл санааны байдал ямар байх вэ? Та нар одоогийнх шигээ бардам байхгүй гэж Би төсөөлж байна. Тэр ч бүү хэл, одоогийнх шигээ “гүн гүнзгий, ойлгомжгүй” байхгүй. Зарим хүн Бурханы

өмнө ёсорхуу, зүй зохистой байж, “хүмүүжилтэй” байхаар хүч чадлаа дайчилдаг ч Сүнсний өмнө хамаг эрээ цээрээ алддаг. Та нар ийм хүмүүсийг үнэнч хүмүүсийн тоонд оруулах уу? Хэрвээ чи хоёр нүүртэй, мөн “хүн хоорондын харилцаанд” чадварлаг бол Би чамайг гарцаагүй Бурханаар даажигнадаг хүн гэж хэлнэ. Хэрвээ үг чинь шалтаг болон хэрэггүй зөвтгөлөөр дүүрэн бол Би чамайг үнэнийг хэрэгжүүлэх дургүй хүн гэж хэлнэ. Хэрвээ чамд хуваалцахыг хүсдэггүй олон нууц байдаг бол, хэрвээ чи өөрийнхөө нууцыг буюу өөрийнхөө бэрхшээлийг бусдын өмнө дэлгэж, гэрлийн замыг эрж хайх маш дургүй бол чи авралыг амархан хүртэж, харанхуйгаас хялбархан гарч ирж чадахгүй хүн юм гэж Би хэлнэ. Хэрвээ үнэний замыг эрж хайх нь чамд тун таалагддаг бол чи үргэлж гэрэлд амьдардаг хүн юм. Хэрвээ чи Бурханы гэрт үйлчлэл үзүүлэхдээ тун их баяртай байж, нэрд гаралгүйгээр хичээнгүйлэн, чин сэтгэлээсээ ажиллаж, үргэлж өгч, хэзээ ч авдаггүй бол Би чамайг үнэнч ариун хүн гэж хэлнэ, учир нь чи шагнал эрэлхийлдэггүй, зүгээр л үнэнч шударга хүн байдаг. Хэрвээ чи илэн далангүй байхыг хүсдэг бол, байгаа бүхнээ зарлагадахыг хүсдэг бол, Бурханы төлөө амиа золиосолж, гэрчлэлдээ бат зогсож чаддаг бол, мөн Бурханыг хангалуун байлгахыг л мэддэг, өөрийгөө боддоггүй, өөрийнхөө төлөө юм авдаггүй байх хэмжээнд үнэнч шударга бол ийм хүмүүс гэрлээр тэтгэгддэг, хаанчлалд үүрд амьдрах хүмүүс юм гэж Би хэлнэ. Чиний дотор жинхэнэ итгэл, жинхэнэ үнэнч зан байгаа эсэхийг, Бурханы төлөө зовсон баримт чамд байгаа эсэхийг болон Бурханд бүрэн захирагдсан эсэхээ чи мэдэх ёстой. Хэрвээ чамд эдгээр зүйл байдаггүй бол чиний дотор дуулгаваргүй байдал, заль мэх, шунал, гомдол үлдсэн байдаг. Зүрх сэтгэл чинь огт үнэнч шударга биш учраас чи Бурханд хэзээ ч эерэгээр хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд хэзээ ч гэрэлд амьдраагүй. Хүний хувь заяа эцэстээ яах нь түүнд үнэнч шударга, халуун сэтгэл байгаа эсэхээс болон цэвэр ариун сүнс байгаа эсэхээс хамаардаг. Хэрвээ чи маш үнэнч бус, хорлонт сэтгэлтэй, бохир сүнстэй хүн бол хувь заяаны чинь бүртгэлд бичигдсэнээр хүнийг шийтгэдэг газар очиж таарах нь гарцаагүй. Чи өөрийгөө маш үнэнч шударга гэж хэлдэг атлаа үнэний дагуу үйлдэж, үнэн үг хэлж хэзээ ч амждаггүй бол Бурхан чамайг шагнахыг хүлээсээр л байна уу? Бурхан чамайг Өөрийнхөө нүдний цэцгий мэт үзнэ гэж найдсаар л байна уу? Ийм бодол утгагүй бус уу? Чи бүх зүйл дээр Бурханыг мэхэлдэг; тэгвэл чам шиг бохир гартай хүнийг яаж Бурханы гэрт байлгаж болох юм бэ?

Та нарт Миний хэлэхийг хүсдэг гурав дахь зүйл бол энэ: Бурханд итгэн амьдрах явцдаа хүн бүр Бурханыг эсэргүүцэж, хууран мэхэлдэг зүйл хийсэн.

Зарим алдаа эндлийг зөрчил гэж тооцох хэрэггүй боловч зарим нь уучилшгүй байдаг; учир нь захиргааны зарлигийг зөрчдөг буюу Бурханы зан чанарт халддаг олон үйл хэрэг бий. Өөрийнхөө хувь заяанд санаа тавьдаг олон хүн эдгээр үйл хэрэг нь юу болохыг асууж магадгүй. Та нар угаасаа биеэ тоосон, ихэрхүү бөгөөд баримтад захирагдахыг хүсдэггүй гэдгээ мэдэх ёстой. Ийм учраас өөрсдийгөө эргэцүүлсний чинь дараа Би та нарт бага багаар хэлэх болно. Захиргааны зарлигуудын агуулгыг илүү сайн ойлгож, Бурханы зан чанарыг мэдэхэд хичээл чармайлт гарга гэж Би та нарт захидаг. Эс бөгөөс амаа хамхиж, ойворгон сүржин яриаг амныхаа зоргоор чалчихгүй байх нь та нарт хэцүү санагдах бөгөөд өөрийн мэдэлгүй Бурханы зан чанарт халдаж, харанхуйд унан, Ариун Сүнснийг дэргэдээсээ алдаж, гэрлийг алдана. Та нар үйлдэлдээ зарчимгүй байж, хэлэх ёсгүй юм хэлж, хийх ёсгүй зүйл хийдэг бол тохирох залхаан цээрлүүлэлтийг хүртэнэ. Хэдийгээр чи үг болон үйлдэлдээ зарчимгүй байдаг ч Бурхан аль алинд нь тун зарчимтай байдгийг мэдэх ёстой. Залхаан цээрлүүлэлт хүртэж байгаа чинь хүнд бус, Бурханд халдсанаас чинь болдог. Хэрвээ чи амьдралдаа Бурханы зан чанарын эсрэг олон зөрчил үйлдсэн бол тамын хүүхэд болох нь дамжиггүй. Хүнд чи зөвхөн үнэнтэй нийцэхгүй хэдхэн үйл хийсэн, өөр юу ч хийгээгүй мэт харагдаж болох юм. Гэхдээ Бурханы нүдээр бол чи аль хэдийн ямар ч нүглийн тахилгүй болсон хүн гэдгээ мэдэж байна уу? Чи Бурханы захиргааны зарлигийг нэгээс олон удаа зөрчсөн, түүнчлэн ямар ч гэмшсэн шинж тэмдэг үзүүлээгүй тул Бурхан хүнийг шийтгэдэг там руу унахаас өөр аргагүй. Бурханыг дагах зуураа цөөн тооны хүмүүс зарчмыг зөрчсөн зарим нэг үйл үйлдсэн боловч тэдэнтэй харьцаж, удирдамж өгсний дараа аажмаар завхралаа олж мэдээд, дараа нь бодит байдлын зөв замд орсон бөгөөд өнөөдөр ул суурьтай хэвээр байдаг. Ийм хүмүүс бол эцэстээ үлдэх хүмүүс юм. Гэвч Би үнэнч шударга хүмүүсийг эрж хайдаг; хэрвээ чи үнэнч шударга, зарчмын дагуу үйлддэг хүн бол Бурханы ойр дотнын хүн байж чадна. Хэрвээ үйлдлүүдээрээ чи Бурханы зан чанарт халддаггүй, Бурханы хүслийг эрж хайдаг, Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлтэй бол итгэл чинь стандартад нийцнэ. Бурханыг хүндэлдэггүй, зүрх сэтгэл нь айн чичирдэггүй хэн боловч Бурханы захиргааны зарлигийг зөрчих өндөр магадлалтай. Олон хүн урам зоригоороо Бурханд үйлчилдэг боловч Бурханы захиргааны зарлигийн талаар огт ойлгодоггүй, Түүний үгийн утгыг бүр ч таамагладаггүй. Иймээс сайн санаа зорилгоороо тэд үргэлж Бурханы удирдлагад саад болох зүйлс хийж дуусдаг. Ноцтой тохиолдолд, тэд хөөгдөж, Түүнийг дагах өөр ямар ч боломжгүй болдог бөгөөд

там руу хаягдаж, Бурханы гэртэй харилцах бүх харилцаа нь төгсдөг. Энэ хүмүүс мунхаг сайн санааныхаа хүчээр Бурханы гэрт ажилладаг бөгөөд эцэстээ Бурханы зан чанарыг уурлуулдаг. Хүмүүс албан тушаалтан, ноёдод үйлчилдэг арга замаа Бурханы гэрт авчирч, хэрэгжүүлэхээр оролдож, тэдгээрийг энд хялбархан хэрэглэж болно гэж хий дэмий бодож байдаг. Бурхан бол хурганы биш, харин арслангийн зан чанартай гэдгийг тэд хэзээ ч төсөөлж байгаагүй. Тиймээс Бурхантай анх удаа холбогдож байгаа хүмүүс Түүнтэй ярилцаж чаддаггүй, учир нь Бурханы зүрх сэтгэл хүнийхтэй адилгүй билээ. Олон үнэнийг ойлгосныхоо дараа л чи Бурханыг тасралтгүй мэдэж авч чадна. Энэ мэдлэг нь үг хэллэг, хоосон сургаалаас бүрддэггүй, харин Бурхантай ойр дотно болох эрдэнэс, Тэр чамд баярладгийн нотолгоо болон хэрэглэгдэж болно. Хэрвээ чи бодит мэдлэгээр дутмаг, үнэнээр зэвсэглээгүй бол урам зоригтой үйлчлэл чинь Бурханы жигшил, зэвүүцлийг л төрүүлж чадна. Одоо чи Бурханд итгэх итгэл гэдэг бол теологи судлах төдий зүйл биш гэдгийг мэдсэн байх ёстой!

Та нарт сануулж буй Миний үг товчхон хэдий ч Миний хэлсэн бүхэн та нарт хамгийн их дутагддаг зүйл юм. Одоо Миний хэлж буй зүйл хүмүүсийн дундах Миний эцсийн ажлын төлөө, мөн хүний төгсгөлийг тодорхойлохын төлөө байдгийг та нар мэдэх ёстой. Би ямар ч зорилгогүй ихээхэн ажил хийхийг хүсдэггүй, өмхөрсөн мод шиг найдваргүй хүмүүсийг үргэлжлүүлэн залж чиглүүлэхийг ч хүсдэггүй, нууцаар муу санаа өвөрлөдөг хүмүүсийг үргэлжлүүлэн удирдахыг бүр ч хүсдэггүй. Магадгүй нэг л өдөр та нар Миний үгийн ард буй чин сэтгэлийг болон хүн төрөлхтөнд оруулсан хувь нэмрийг ойлгоно. Магадгүй нэг л өдөр та нар өөрсдийн чинь төгсгөлийг тодорхойлох үнэнийг ухаарна.

ГЭМ БУРУУ НЬ ХҮНИЙГ ТАМ РУУ ХӨТӨЛНӨ

Би та нарт олон анхааруулга өгч, та нарыг байлдан дагуулахын тулд олон үнэнийг хайрласан. Одоо та нарт өмнөхөөсөө нэлээд их сайжирч, хүн ямар байх ёстой тухай олон зарчмыг ойлгож авч, итгэлтэй хүмүүст байх ёстой эрүүл ухаанаас маш ихийг эзэмшдэг болсон мэт санагддаг. Энэ бүхэн нь та нарын олон жилийн туршид хүрсэн үр дүн юм. Би та нарын амжилтыг үгүйсгэдэггүй боловч энэ олон жилийн турш Миний эсрэг тоо томшгүй олон удаа дуулгаваргүй байж, тэрсэлснийг чинь ч бас үгүйсгэдэггүй гэдгээ илэн далангүй хэлэх ёстой, учир нь та нарын дунд ганц ч ариун хүн байхгүй. Та нар бүгд ялгаагүй Сатаны завхруулсан хүмүүс юм; та нар бол Христийн дайснууд билээ. Өнөөг хүртэлх та

нарын гэм буруу болон дуулгаваргүй байдал тоо томшгүй их байсаар ирсэн тул та нарт үргэлж үглэж яншиж байгааг минь бараг л гайхах зүйлгүй. Би та нартай хамт ийм маягаар амьдармааргүй байгаа ч ирээдүй болон хүрэх газрын чинь төлөө дахиад нэг үглэе. Та нар Надад хүлээцтэй хандахын сацуу айлдвар бүрд минь итгэж, Миний үгийн гүн гүнзгий утга санааг дүгнэж чадна гэж Би найдаж байна. Миний хэлдэг зүйлд эргэлзэж болохгүй, Миний үгийг хүссэнээрээ аваад дураараа хаяж бүр ч болохгүй; ингэх нь Надад тэвчихийн аргагүй санагддаг. Миний үгийг битгий шүүмжил, бүү хөнгөн хуумгай авч үз, Би та нарыг үргэлж уруу татаж байна гэж битгий ярь, эсвэл та нарт Миний хэлсэн зүйл алдаа мадагтай гэж бүр ч битгий хэл. Эдгээр зүйл ч бас Надад тэвчихийн аргагүй санагддаг. Та нар Надад болон Миний хэлдэг зүйлд ингэж сэжиглэн хандаж, Миний үгийг хэзээ ч ойлголгүй, Намайг үл ойшоодог учраас Би та бүхэнд нухацтайгаар хэлье: Миний хэлдэг зүйлийг гүн ухаантай бүү холбо; Миний үгийг залт этгээдийн худал үгтэй бүү холбо. Тэр ч бүү хэл, Миний үгэнд басамжлалаар бүү хариул. Магадгүй ирээдүйд хэн ч та нарт Миний хэлж байгаа зүйлийг хэлж өгч чадахгүй, та нартай ийм өр зөөлнөөр ярилцахгүй, тэр ч байтугай эдгээр зүйлийг нэгд нэггүй тэвчээртэйгээр тайлбарлахгүй. Та нар сайхан цагаа дурсах юм уу чангаар эхэр татан уйлж, эсвэл өвчиндөө ёолж айсуу өдөр хоногуудыг өнгөрөөнө, аль эсвэл үнэн юм уу амийн өчүүхэн төдий ч хангалтгүйгээр харанхуй шөнүүдийг туулж, эсвэл зүгээр л ямар ч найдваргүйгээр хүлээх юм уу хамаг ухаанаа алдталаа маш их харамсах болно... Эдгээр боломжоос та нарын хэн нь ч бараг зайлсхийж чадахгүй. Учир нь та нарын нэг нь ч Бурханыг үнэхээр шүтэн мөргөдөг байр сууринд байдаггүй, харин садар самуун, муу ёрын ертөнцөд автаж, амь, үнэнтэй ямар ч хамаагүй, үнэндээ тэдгээрийн эсрэг байдаг маш олон зүйлийг өөрсдийн итгэл, сүнс, сэтгэл, биед хольдог. Тиймээс та нар гэрлийн замд хүрч чадна гэж Би найдаж байна. Та нар өөрсдийгөө халамжилж, өөрсдөдөө санаа тавих чадвартай болно, мөн ааш авир, гэм буруугаа үл хайхрангаа хүрэх газартаа хэт их ач холбогдол өгөхгүй байж чадна гэдэг бол Миний цорын ганц найдвар юм.

Бурханд удаан хугацаанд итгэсэн хүмүүс гайхалтай сайхан хүрэх газартай болно гэж чин сэтгэлээсээ найдсаар ирсэн бөгөөд өөрсдөд нь зол завшаан гэнэт тохионо гэж Бурханы бүх итгэгч найддаг. Тэгээд нэг л мэдэхэд тэнгэрт хаа нэгтээ амар амгалан сууж байх болно гэж тэд бүгд найддаг. Гэхдээ сайхан бодолтой энэ хүмүүс тэнгэрээс унаж ирэх тийм сайн зол завшааныг хүлээн авах юм уу тэнгэр дэх суудалд суухад тэнцэх эсэхээ ч огт мэдээгүй гэж Би хэлдэг. Та нар одоо өөрсдийгөө сайн мэддэг хэр нь эцсийн өдрүүдийн гай гамшиг болон

муу хүмүүсийг шийтгэдэг Төгс Хүчитийн гараас зугтаж чадна гэж найдсаар байгаа. Сайхан мөрөөдөлтэй байж, аливааг өөрсдийнхөөрөө байлгахыг хүсэх нь ганц нэг хүний гайхалтай санаа биш, харин Сатаны завхруулсан бүх хүний нийтлэг онцлог юм шиг санагддаг. Тэгсэн ч гэсэн Би та нарын хэрээс хэтэрсэн энэ хүсэл болон ерөөл хүртэх гэсэн эрмэлзлийг эцэс болгохыг хүссээр л байна. Та нарын гэм буруу тоо томшгүй, тэрслүү байсан баримтууд ч үргэлж нэмэгдэж байхад ирээдүйн төлөөх сайхан төлөвлөгөө чинь үүнтэй яаж тохирох юм бэ? Чи биеэ огт барилгүйгээр, хүссэнээрээ алдаа гаргадаг атлаа мөрөөдөл чинь биелээсэй гэж хүссээр байгаа бол гүн нойрссоор байж, хэзээ ч бүү сэр гэж Би чамайг шавдуулна—учир нь чинийх бол хий хоосон мөрөөдөл бөгөөд зөвт Бурханы өмнө Тэр чамайг онцлон үзэхгүй. Хэрвээ чи мөрөөдөл чинь биелээсэй гэж л хүсдэг бол хэзээ ч бүү мөрөөд; харин үнэн болон баримттай үүрд нүүр тул. Энэ л чиний аврагдаж болох цорын ганц зам юм. Энэхүү арга барилын тодорхой алхмууд юу вэ?

Нэгдүгээрт, бүх гэм буруугаа харж, үнэнтэй нийцдэггүй бүх ааш авир, бодлоо шинжил.

Та нарын амархан хийж чадах нэг зүйл бол энэ бөгөөд оюун ухаантай бүх хүн үүнийг хийж чадна гэж Би итгэж байна. Гэвч, гэм буруу болон үнэн гэж юу гэсэн үг болохыг огт мэддэггүй хүмүүс үүнд хамаарахгүй, учир нь үндсэндээ тэд бол оюун ухаантай хүмүүс биш юм. Би Бурханаар хүлээн зөвшөөрөгдсөн, үнэнч, захиргааны ямар ч зарлигийг ноцтой зөрчөөгүй, гэм буруугаа амархан таньж мэддэг хүмүүстэй ярилцаж байна. Энэ нь та нараас Миний шаарддаг нэг зүйл бөгөөд биелүүлэхэд амархан хэдий ч энэ нь та нараас Миний шаарддаг цорын ганц зүйл биш. Ямартай ч, энэ шаардлагыг та нар нууцаар шоолохгүй, ялангуяа үүнийг дорд үзэж, хөнгөн хуумгай хандахгүй гэж Би найдаж байна. Үүнд нухацтай хандах ёстой ба хайхрамжгүй хандаж болохгүй.

Хоёрдугаарт, гэм буруу болон дуулгаваргүй байдал бүрдээ холбогдох үнэнийг эрж хайн, энэ үнэнийг ашиглан тэдгээр асуудлыг шийдвэрлэ. Тэгээд дараа нь гэм буруутай үйл хэрэг болон дуулгаваргүй бодол, үйлдлээ үнэний хэрэгжүүлэлтээр орлуул.

Гуравдугаарт, үргэлж сүйхээтэй, байнга овжин байдаг биш, харин үнэнч хүн бай. (Энд Би та нараас үнэнч хүн байгаач гэж дахин хүсэж байна.)

Энэ гурван зүйлийг бүгдийг нь биелүүлж чаддаг бол чи хувьтай хүмүүсийн нэг буюу мөрөөдөл нь биелж, сайн зол завшаан хүртдэг хүн юм. Та нар энэ гурван таагүй хүсэлтэд нухацтай хандаж магадгүй, эсвэл хариуцлагагүй хандаж

магадгүй. Аль нь ч бай, Миний зорилго бол та нарын мөрөөдлийг биелүүлж, туйлын зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө болохоос та нараар даажигнаж, тоглоом хийх явдал биш юм.

Миний шаардлагууд энгийн байж болох ч та нарт хэлж байгаа зүйл минь нэг дээр нэгийг нэмээд хоёр гэдэг шиг тийм ч энгийн биш. Хэрвээ та нар энэ тухай хамаагүй ярьж, хий дэмий ихэрхүү үг чалчихаас өөрийг хийдэггүй бол хүсэл, төлөвлөгөө чинь үүрд хий хоосон байх болно. Олон жилийн турш зовж, шаргуу ажилласан мөртөө харуулах юм юу ч үгүй та нарыг Би огт өрөвдөхгүй. Эсрэгээрээ, Миний шаардлагад нийцээгүй хүмүүсийг Би өрөвдөх нь байтугай шагнал биш, шийтгэлээ хүртээнэ. Та нар олон жилийн турш дагалдагч байснаараа ямартай ч шаргуу ажилласан бөгөөд зүгээр л үйлчлэл үзүүлэгч байсныхаа төлөө Бурханы гэрээс аяга будаа хүртэж ёстой гэж төсөөлж байж магадгүй. Та нар ямар нэг зүйлийг ашиглаад, хариуд нь өөрсдийгөө ашиглуулахгүй байх зарчмыг үргэлж эрэлхийлж ирсэн учраас дийлэнх чинь ингэж боддог гэж Би хэлнэ. Тиймээс Би одоо та нарт тун нухацтайгаар хэлж байна: Шаргуу ажил чинь хэр гавьяатайг, чадвар чансаа чинь хэр сүрхийг, Намайг хэр ойр дагадаг, хэр их нэр цуутайг чинь, эсвэл хандлагаа хэр их сайжруулсныг чинь Би хайхардаггүй; Миний шаардлагад нийцээгүй л бол чи Миний магтаалыг хэзээ ч хүртэж чадахгүй. Энэ бүх санаа, тооцооллоо аль болох эртхэн орхиод Миний шаардлагад нухацтай хандаж эхэл; эс бөгөөс, Би ажлаа дуусгахын тулд бүх хүнийг үнс нурам болгож, хамгийн муудаа л олон жилийн ажил, зовлон шаналлаа талаар болгоно, учир нь Би Өөрийн дайснууд болон муу муухай ханхлуулсан, Сатаны төрхтэй хүмүүсийг хаанчлалдаа юм уу дараагийн эрин үед аваачиж чадахгүй.

Надад маш их найдлага бий. Та нар биеэ зүй зохистой, хүмүүжилтэй байдлаар авч явж, үүргээ үнэнчээр биелүүлж, үнэн болон хүн чанарыг эзэмшиж, байгаа бүхнээ, бүр амиа ч гэсэн Бурханы төлөө өгч чадна гэх зэргээр Би найддаг. Энэ бүх итгэл найдвар та нарын дутагдал, завхрал, дуулгаваргүй байдлаас үүддэг. Та нартай ярилцсан ярианаас минь нэг нь ч анхаарлыг чинь татахуйц байгаагүй бол Би дахиад юм хэлэхгүй байсан нь дээр бололтой. Гэхдээ та нар үүний үр дүн ямар байхыг ойлгож байгаа. Би бараг амардаггүй тул хэрвээ Би үг хэлэхгүй бол хүмүүсийн харж болох ямар нэг зүйлийг хийнэ. Би хэн нэгний хэлийг өмхийрүүлж, хэн нэгнийг мөчлөн үхүүлж, эсвэл хүмүүсийг сэтгэцийн эмгэгтэй болгож, маш олон арга замаар үзэшгүй муухай харагдуулж чадна. Бас Би өөрсдөд нь зориулж тусгайлан нэрсэн тарчлаанаа хүмүүст амсуулж чадна.

Ингэвэл Би баяр хөөртэй, маш аз жаргалтай, тун сэтгэл ханамжтай байна. “Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол” гэж дандаа хэлдэг байсан, тэгвэл одоо яагаад болохгүй гэж? Хэрвээ чи Намайг эсэргүүцэж, Надад шүүмжлэлтэй хандмаар байвал Би амыг чинь өмхийрүүлж, үүндээ эцэс төгсгөлгүйгээр баясна. Учир нь эцсийн эцэст, чиний хийсэн зүйл бол үнэн биш, тэр ч байтугай амьтай ямар ч хамаагүй байхад Миний хийдэг бүхэн бол үнэн юм; Миний бүх үйлдэл ажлын минь зарчим болон Миний тогтоосон захиргааны зарлигтай хамаатай байдаг. Тиймээс дор бүрнээ жаахан сайн чанар хуримтлуулж, ийм их мууг хийдгээ больж, завтай цагтаа Миний шаардлагуудыг анхаар гэж Би та нарыг шавдуулж байна. Тэгвэл Би баярлана. Хэрвээ та нар махан биедээ зориулдаг хичээл зүтгэлийнхээ мянганы нэгийг үнэнд нэмэрлэдэг (эсвэл хандивладаг) байсан бол байнга гэм буруу үйлдэж, өмхийрсөн амтай явахгүй байх байсан гэдгийг Би хэлэх байна. Энэ нь илэрхий биш гэж үү?

Чи хэдий чинээ их гэм буруу үйлдэнэ, сайн хүрэх газар олж авах боломж чинь төдий чинээ бага байдаг. Харин эсрэгээрээ, гэм буруу бага үйлдэх тусам, Бурханаар магтуулах боломж чинь улам их байна. Надаар уучлуулах боломжгүй болтлоо гэм буруу чинь ихэсвэл уучлагдах боломжоо чи бүрмөсөн алдсан байх болно. Тэгвэл, хүрэх газар чинь дээр биш, харин доор байна. Хэрвээ Надад итгэхгүй байгаа бол чи зориг гаргаад, бурууг үйлд, тэгээд юунд хүрэхээ хар. Хэрвээ чи үнэнийг чин сэтгэлээсээ хэрэгжүүлдэг хүн бол гэм буруугаа уучлуулах боломжтой байх нь гарцаагүй бөгөөд дуулгаваргүй байх чинь улам багасаж, улам цөөрнө. Хэрвээ чи үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэггүй хүн бол Бурханы өмнөх гэм буруу чинь гарцаагүй ихсэж, дуулгаваргүй байдлын чинь хэмжээ хязгаартаа хүртлээ улам бүр нэмэгдэх бөгөөд тэр нь бүрмөсөн устах цаг чинь байх болно. Тэр үед ерөөл хүртэх гэсэн таатай мөрөөдөл чинь сүйрнэ. Өөрийн гэм бурууг томоогүй, тэнэг хүний алдаа төдий гэж бүү үз, мөн дорд хэв чанар чинь боломж олгоогүй болохоор үнэнийг хэрэгжүүлээгүй гэх шалтаг бүү тооч. Түүнчлэн үйлдсэн гэм буруугаа гагцхүү юм мэдэхгүй хүний үйлдэл гэж бүү үз. Хэрвээ чи өөрийгөө уучилж, өр зөөлөн хандахдаа сайн бол үнэнийг хэзээ ч олж авахгүй хулчгар бөгөөд гэм буруу чинь чамайг зовоохоо хэзээ ч болихгүй, харин чамайг үнэний шаардлагад хэзээ ч нийцүүлэлгүй, үүрд Сатаны үнэнч хамтрагч хэвээр үлдээнэ гэдгийг Би хэлье. Чамд өгөх Миний зөвлөгөө мөн л энэ: Өөрийнхөө хүрэх газарт анхаараад нуугдмал гэм буруугаа анзааралгүй бүү үлдээ; гэм бурууг ноцтойгоор авч үз, хүрэх газартаа санаа зовсноосоо болоод ямар нэг гэм буруугаа бүү орхигдуул.

БУРХАНЫ ЗАН ЧАНАРЫГ ОЙЛГОХ НЬ МАШ ЧУХАЛ

Би та нарыг олон зүйлд хүрнэ гэж найддаг ч та нарын бүх үйлдэл, амьдралын чинь бүх байдал Миний шаардсан зүйлийг бүрэн биелүүлж чаддаггүй, иймээс шууд гол зүйлдээ орж, Өөрийнхөө хүслийг та нарт тайлбарлахаас өөр сонголт Надад алга. Та нарын ялган таних чадвар дульхан, сонирхох чадвар ч мөн адил тааруухан болохоор Миний зан чанар, мөн чанарын талаар бараг юу ч мэддэггүй, тиймээс тэр талаар та нарт мэдэгдэх нь яаралтай асуудал болоод байна. Өмнө нь хэр ихийг ойлгосон чинь хамаагүй, эдгээр асуудлыг ойлгохыг хүсдэг эсэхээс чинь үл хамааран Би эдгээрийг бас л дэлгэрэнгүй тайлбарлах ёстой. Эдгээр асуудал та нарын огт мэддэггүй зүйл биш боловч эдгээрт агуулагддаг утга учрын талаар та нарт ихээхэн ойлголт, мэдлэг дутагддаг. Та нарын олонх нь ердөө л бүдэг бадаг ойлголттой байдаг ба тэр нь хагас дутуу, бүрэн бус байдаг. Үнэнийг илүү сайн хэрэгжүүлж, Миний үгийг илүү сайн хэрэгжүүлэхэд нэмэр болгохын тулд та нар эдгээр асуудлыг эн түрүүнд мэдэх ёстой гэж Би бодож байна. Тэгэхгүй бол та нарын итгэл тодорхойгүй, хуурамч агаад шашны шинж тэмдгээр дүүрэн хэвээр үлдэнэ. Хэрвээ чи Бурханы зан чанарыг ойлгодоггүй бол Түүний төлөө хийх учиртай ажлаа хийх боломжгүй болно. Хэрвээ чи Бурханы мөн чанарыг мэддэггүй бол Түүнийг хүндэлж, Түүнээс айх боломжгүй болно; харин жишимгүй хааш яаш байдал, булзаарал, түүнчлэн засаж боломгүй доромжлол л байх болно. Бурханы зан чанарыг ойлгох нь үнэхээр чухал бөгөөд Бурханы мөн чанарыг мэдэх явдлыг орхигдуулж болохгүй хэдий ч эдгээр асуудлыг хэн ч нягтлан шалгаж, эсвэл нарийвчлан судлаагүй. Та нар бүгдээрээ Миний гаргасан захиргааны зарлигийг үл тоомсорлосон нь харахад илт байдаг. Хэрвээ та нар Бурханы зан чанарыг ойлгодоггүй бол Түүний зан чанарт халдаж тун болзошгүй. Түүний зан чанарт халдах нь Бурханы Өөрийн уур хилэнг хүргэхтэй адилхан бөгөөд тэр тохиолдолд үйлдлийн чинь эцсийн үр дүн нь захиргааны зарлигийг зөрчсөн хэрэг болно. Бурханы мөн чанарыг мэдэх үедээ зан чанарыг нь ч ойлгож чадах бөгөөд Бурханы зан чанарыг ойлгох үедээ захиргааны зарлигийг ч бас ойлгосон байна гэдгээ чи одоо ухаарах хэрэгтэй. Мэдээж, захиргааны зарлигт агуулагддаг зүйлийн ихээхэн нь Бурханы зан чанарыг хөнддөг боловч захиргааны зарлигт Түүний зан чанар бүхэлдээ илэрхийлэгддэггүй; иймд та нар Бурханы зан чанарын талаарх ойлголтоо дахиад нэг алхам гүнзгийрүүлэх ёстой.

Би өнөөдөр та нартай энгийн нэг яриа яриагүй, иймээс та нар Миний үгэнд анхааралтай хандахаас гадна тэдгээрийг гүнээ эргэцүүлбэл зохино. Үүгээр Би

юу гэж байна вэ гэвэл, та нар Миний хэлсэн үгэнд хэтэрхий бага хичээл чармайлт гаргасан. Мөн Бурханы зан чанарыг тунгаан бодохыг бүр ч хүсдэггүй; тийм чармайлт гаргадаг хүн ховорхон. Ийм учраас, та нарын итгэл бол гоёмсог, сүржин ярианаас цаашгүй гэж Би хэлдэг. Одоо ч гэсэн та нарын нэг нь ч эмзэг талаа засах гэж нухацтай хичээсэн нь огт үгүй. Та нарын төлөө амссан бүх зовлон шаналлын минь дараа та нар Миний урмыг хугалсан. Та нар Бурханыг огт тоодоггүй агаад амьдрал чинь үнэнгүй байдагт гайхах зүйлгүй. Ийм хүмүүсийг яаж ариун хүмүүс гэж үзэж болох юм бэ? Тэнгэрийн хууль тийм зүйлийг тэвчихгүй! Та нар энэ талаар маш бага ойлголттой байгаа тул илүү их цаг зарцуулахаас өөр сонголт Надад алга.

Бурханы зан чанар бол хүн бүхэнд маш хийсвэр санагддаг сэдэв бөгөөд түүнчлэн Түүний зан чанар хувь хүний зан ааштай адилгүй учир хэний ч хувьд хүлээн зөвшөөрөхөд амаргүй сэдэв билээ. Бурханд ч бас Өөрийн гэсэн баяр хөөр, уур хилэн, уй гашуу, аз жаргалын сэтгэл хөдлөл байдаг боловч эдгээр сэтгэл хөдлөл хүнийхээс ялгаатай. Бурханд Өөрийн гэсэн оршихуй болон эзэмшил байдаг. Түүний илэрхийлж, харуулдаг бүхэн бол Түүний мөн чанар, ялгамж чанарын төлөөлөл юм. Тэр юу болох, Түүнд юу байгаа, мөн Түүний мөн чанар, ялгамж чанар нь ямар ч хүн орлож чадахгүй зүйл юм. Түүний зан чанар нь хүн төрөлхтнийг гэх Түүний хайр, хүн төрөлхтнийг тайтгаруулах тайтгарал, хүн төрөлхтөнд хандах үзэн ядалт, мөн түүнээс гадна хүн төрөлхтний талаарх нэвт шувт ойлголтыг агуулдаг. Хүний зан ааш харин өөдрөг, золбоолог юм уу мэдрэлгүй байж болох юм. Бурханы зан чанар нь бүх зүйл болон амьд амьтдын Захирагч, Бүтээгчийн эзэмшдэг зүйл билээ. Түүний зан чанар нь нэр төр, хүч чадал, эрхэм дээд, агуу байдал болон хамгийн гол нь, дээдийн дээд байдлыг төлөөлдөг. Түүний зан чанар бол эрх мэдлийн бэлгэ тэмдэг, зөвт бүхний бэлгэ тэмдэг, сайн сайхан бүхний бэлгэ тэмдэг билээ. Түүнээс гадна, энэ нь харанхуй болон дайсны ямар ч хүчинд үл дийлдэх буюу довтлогдошгүй^а Түүний бэлгэ тэмдэг төдийгүй ямар ч бүтээгдсэн зүйлийн халдаж үл чадах (Өөрт нь халдахыг Тэр тэвчдэггүй)^б Түүний бэлгэ тэмдэг юм. Түүний зан чанар бол хамгийн дээд эрх мэдлийн бэлгэ тэмдэг билээ. Хэн ч, ямар ч хүмүүс Түүний ажлыг, Түүний зан чанарыг үймүүлж чадахгүй, болох ч үгүй. Харин хүний зан ааш бол амьтнаас

а. Эх бичвэрт “чадахгүй байхын бэлгэ тэмдэг” гэж байдаг.

б. Эх бичвэрт “түүнчлэн халдаж чадахгүй байхын (мөн халдахыг тэвчихгүйн) бэлгэ тэмдэг” гэж байдаг.

жаахан давуу гэдгийнх нь бэлгэ тэмдэг төдий юм. Хүн өөрөө дангаараа эрх мэдэлгүй, бие даасан байдалгүй, өөрийгөө дийлэх чадваргүй, харин мөн чанартаа төрөл бүрийн хүмүүс, үйл явдал, юмсын эрхшээлд навталздаг нэгэн юм. Бурханы баяр хөөр нь зөвт байдал болон гэрлийн оршин тогтнол, үүслээс бий болдог, мөн харанхуй болон ёрын муу устсанаас бий болдог. Хүн төрөлхтөнд гэрэл болон сайхан амьдрал авчрахдаа Тэр баярладаг; Түүний баяр хөөр бол зөвт баяр хөөр, эерэг бүхний оршин тогтнолын бэлгэ тэмдэг, түүнээс гадна таатай байдлын бэлгэ тэмдэг юм. Бурханы уур хилэн нь, шударга бус явдлын оршин тогтнол, хөндлөнгийн оролцооны хүн төрөлхтөнд нь учруулдаг хор хөнөөлөөс болж, мөн ёрын муу болон харанхуйн оршин тогтнолоос, үнэнийг хөөн зайлуулдаг зүйлсийн оршин тогтнолоос, цаашлаад сайн сайхан бүхнийг эсэргүүцдэг зүйлсийн оршин тогтнолоос болж төрдөг. Түүний уур хилэн бол бүх сөрөг зүйл оршин тогтнохоо болихын бэлгэ тэмдэг байдгаас гадна, Түүний ариун байдлын бэлгэ тэмдэг юм. Түүний уй гашуу нь, Өөрийнх нь итгэж найддаг боловч харанхуйд унасан хүн төрөлхтнөөс, хүн дээр хийдэг ажлынх нь үр дүн санаанд нь хүрдэггүйгээс, Өөрийнх нь хайрладаг хүн төрөлхтөн бүгд гэрэлд амьдарч чаддаггүйгээс болдог. Тэрээр гэмгүй хүн төрөлхтний төлөө, үнэнч боловч мэдлэггүй хүний төлөө, сайн боловч өөрийн гэсэн үзэл бодол дутмаг хүний төлөө гунигладаг. Түүний уй гашуу бол Түүний сайн сайхан болон өршөөлийн бэлгэ тэмдэг, гоо үзэсгэлэн, сайхан сэтгэлийн бэлгэ тэмдэг юм. Түүний аз жаргал мэдээж, Өөрийн дайснуудыг ялж, хүний чин сэтгэлийг олж авахаас үүсдэг. Үүнээс ч илүүтэйгээр, энэ нь дайсны бүх хүчийг хөөн зайлуулж, устгахаас бий болдог, мөн хүн төрөлхтөн сайн сайхан, амар амгалан амьдралыг хүлээн авдаг учраас бий болдог. Бурханы аз жаргал хүний баяр хөөртэй адилгүй; харин энэ нь сайн үр жимс хураах мэдрэмж, баяр хөөрөөс ч илүү агуу мэдрэмж юм. Түүний аз жаргал бол энэ мөчөөс эхлээд хүн төрөлхтөн зовлонгоос чөлөөлөгдөхийн бэлгэ тэмдэг, мөн хүн төрөлхтөн гэрлийн ертөнцөд орохын бэлгэ тэмдэг билээ. Нөгөө талаар, хүн төрөлхтний сэтгэл хөдлөл нь бүгд өөрийнх нь хувийн ашиг сонирхлын төлөө гарч ирдгээс биш зөвт байдал, гэрэл, эсвэл сайхан зүйлийн төлөө байдаггүй, Тэнгэрээс хайрласан нигүүлслийн төлөө бүр ч байдаггүй. Хүн төрөлхтний сэтгэл хөдлөл нь аминчхан агаад харанхуйн ертөнцөд харьяалагддаг. Тэдгээр нь Бурханы хүслийн төлөө оршдоггүй, Бурханы төлөвлөгөөний төлөө бүр ч оршдоггүй, иймээс хүн, Бурхан хоёрыг хэзээ ч зэрэгцүүлэн харьцуулж болохгүй. Бурхан үүрд дээдийн дээд, хэзээд эрхэмсэг байхад хүн үүрд олиггүй, үүрд үнэ цэнгүй байдаг. Яагаад гэвэл,

Бурхан үүрд хүн төрөлхтний төлөө золиос гаргаж, зориулж байдаг; гэтэл хүн үүрд өөртөө л авч, өөрийнхөө төлөө зүтгэдэг. Бурхан хүн төрөлхтнийг оршин байлгахын төлөө хүч чадлаа үүрд дайчилдаг байхад хүн гэрлийн төлөө юм уу зөв шударга байдлын төлөө хэзээ ч, ямар ч хувь нэмэр оруулдаггүй. Хүн хэсэг хугацаанд хичээл чармайлт гаргадаг ч гэсэн, тэр нь ганц цохилт ч дааж чаддаггүй, учир нь хүний хичээл чармайлт бусдын төлөө биш, үргэлж өөрийнх нь төлөө байдаг. Хүн үргэлж хувиа хичээдэг байхад Бурхан үүрд сэтгэл харамгүй байдаг. Бурхан бол шударга, сайн, сайхан бүхний эх сурвалж байхад хүн бол муухай, ёрын муу бүхнийг өвлөн авч, ил харуулдаг нэгэн юм. Бурхан шударга байдал болон гоо сайхны мөн чанараа хэзээ ч өөрчлөхгүй, харин хүн хэдийд ч, ямар ч нөхцөлд зөв шударга байдлаас урваж, Бурханаас холдон одохоос ер сийхгүй.

Миний хэлсэн өгүүлбэр болгон Бурханы зан чанарыг агуулдаг. Та нар Миний үгийг анхааралтай эргэцүүлсэн нь дээр, тэгвэл асар их ашиг тус хүртэх нь гарцаагүй. Бурханы мөн чанарыг ухаарахад маш хэцүү боловч та нар бүгдээрээ Бурханы зан чанарын тухай жаахан ч атугай мэднэ гэж Би итгэж байна. Тэгээд та нар Бурханы зан чанарт халдахгүй зүйл илүү ихийг хийснээ Надад харуулна гэж найдаж байна. Тэгвэл Миний санаа амарна. Жишээлбэл, Бурханыг цаг үргэлж зүрх сэтгэлдээ байлга. Аливааг үйлдэхдээ Түүний үгийн дагуу хий. Бүх зүйлээс Түүний санаа зорилгыг эрж хай, мөн Бурханыг үл хүндэлж, гутаах зүйл хийхийг цээрлэ. Чи өөрийнхөө зүрх сэтгэлийн хожмын хоосролоо дүүргэхийн тулд Бурханыг сэтгэлийнхээ мухарт хийж бүр ч болохгүй. Хэрвээ тэгэх юм бол Бурханы зан чанарт халдсан байх болно. Дахин хэлэхэд, чи насан туршдаа хэзээ ч Бурханыг хараан доромжилж, Түүнд гомдоллоогүй гэж үзье, мөн Түүний даалгасан бүхнийг зохих ёсоор биелүүлж, насан туршдаа Түүний бүх үгэнд захирагдаж чаддаг гэж үзье, тэгвэл чи захиргааны зарлигийг зөрчихөөс зайлсхийсэн байна. Жишээлбэл, хэрвээ чи хэзээ нэгэн цагт “Би яагаад Түүнийг Бурхан гэж боддоггүй юм бэ?”, “Эдгээр үг Ариун Сүнсний гэгээрлээс цаашгүй байх”, “Миний бодлоор бол, Бурханы хийдэг бүхэн зөв байх албагүй”, “Бурханы хүн чанар минийхээс давуу биш”, “Бурханы үг зүгээр л үнэмшилгүй” гэдэг ч юм уу, эсвэл өөр иймэрхүү шүүмжилсэн үг хэлж байсан бол нүглээ илүү олонтоо улайж, гэмш гэж Би чамд сануулж байна. Эс бөгөөс уучлуулах боломж чамд хэзээ ч гарахгүй, учир нь чи хүнд биш, харин Бурханд Өөрт нь халддаг. Чи хүнийг шүүмжилж байна гэж бодож болох ч Бурханы Сүнс тэгж үздэггүй. Түүний махбодыг үл хүндлэх нь Түүнийг үл хүндлэхтэй адилхан. Тэгэхээр хийсэн бүхэн

чинь Бурханы зан чанарт халдсан бус уу? Бурханы Сүнсний хийдэг бүхэн нь махбодод хийсэн Түүний ажлыг хамгаалахын төлөө, энэхүү ажлыг сайн хийхийн төлөө байдаг гэдгийг чи санах ёстой. Хэрвээ үүнийг үл ойшоовол чи Бурханд итгэхдээ хэзээ ч амжилт гаргаж чадахгүй хүн юм гэж Би хэлнэ. Чи Бурханы уур хилэнг хүргэсэн учраас чамд сургамж өгөхийн тулд Тэр тохирох шийтгэлийг ашиглана.

Бурханы мөн чанарыг мэдэж авах нь ялихгүй асуудал биш. Чи Түүний зан чанарыг ойлгох ёстой. Ийм маягаар аажмаар, өөрийн мэдэлгүйгээр Бурханы мөн чанарыг мэдэж авна. Энэ мэдлэгт орохоороо чи илүү өндөр, илүү сайхан ертөнц рүү алхаж байгаагаар олж мэднэ. Эцэст нь чи үзэшгүй муухай сүнснээсээ ичихээс гадна ичгүүрээсээ нуугдах газар хаа ч үгүй гэж санагдана. Тэр үед Бурханы зан чанарт халдах үйлдэл чинь улам бүр багасаж, зүрх сэтгэл чинь Бурханыхтай улам бүр ойртож, Түүнийг гэх хайр зүрх сэтгэлд чинь аажмаар өсөн нэмэгдэнэ. Энэ бол хүн төрөлхтөн гайхалтай сайхан ертөнцөд орж буйн тэмдэг юм. Гэхдээ та нар үүнд хараахан хүрээгүй. Та нар бүгд хувь заяаныхаа төлөө яарч тэвддэг тул Бурханы мөн чанарыг мэдэх гэж оролдох сонирхол хэнд байх юм бэ? Ийнхүү үргэлжлэх юм бол та нар өөрийн мэдэлгүй захиргааны зарлигийг зөрчинө, учир нь та нар Бурханы зан чанарын талаар дэндүү бага ойлгодог. Иймээс та нарын одоо хийдэг зүйл Бурханы зан чанарын эсрэг зөрчлийн чинь суурийг тавьж байгаа бус уу? Бурханы зан чанар Миний ажлаас салшгүй гэдгийг ойлгохыг Би та нараас шаардаж байна. Учир нь, захиргааны зарлигийг байнга зөрчдөг бол та нарын дундаас хэн чинь шийтгэлээс зугтах юм бэ? Тэгвэл Миний ажил бүхэлдээ талаар өнгөрөх байсан бус уу? Тиймээс биеэ авч явах байдлаа нягтлан шалгахын зэрэгцээ өөрсдийн хийдэг алхамд хянуур бай гэж Би бас л шаардаж байна. Энэ нь та нарт Миний тавьдаг илүү өндөр шаардлага бөгөөд та нар бүгдээрээ үүнийг нарийвчлан авч үзэж, ул суурьтай анхаарна гэж Би найдаж байна. Та нарын үйлдэл Миний уур хилэнг асар ихээр бадраах өдөр ирэх юм бол та нар өөрсдөө л үр дагаврыг нь амсах ба өөр хэн ч та нарын оронд шийтгэл хүлээхгүй.

ГАЗАР ДЭЭРХ БУРХАНЫГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ

Бурханы өмнө шагнал хүлээн авч, Бурханаар ивээгдэхийг та нар бүгд хүсдэг; Бурханд итгэж эхлэх үедээ хүн бүр ийм зүйлийг хүсдэг, учир нь хүн бүр илүү өндөр дээд зүйлсийг эрэлхийлэх бодолд автдаг бөгөөд хэн ч бусдаас хоцрохыг

хүсдэггүй. Хүмүүс ийм л байдаг. Яг энэ шалтгааны улмаас, та нарын дундаас олон хүн тэнгэр дэх Бурханд тал засахаар байнга хичээдэг ч үнэндээ Бурханыг гэх үнэнч зан, чин сэтгэл чинь өөрсдийгөө гэсэн үнэнч зан, чин сэтгэлээс чинь хавьгүй бага байдаг. Би яагаад ингэж хэлдэг вэ? Учир нь Би Бурханд үнэнч байдлыг чинь огт хүлээн зөвшөөрдөггүй, түүнчлэн та нарын зүрх сэтгэлд оршдог Бурханы оршин тогтнолыг Би үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл, та нарын шүтэн мөргөдөг Бурхан, та нарын гайхан биширдэг тодорхойгүй Бурхан огтхон ч оршин тогтнодоггүй. Би үүнийг маш баттай хэлж буйн шалтгаан нь та нар жинхэнэ Бурханаас хэтэрхий хол байдаг. Та нарын үнэнч зангийн шалтгаан нь зүрх сэтгэл дотор чинь байгаа шүтээн юм; харин та нарын агуу гэж үздэггүй, өчүүхэн ч гэж үздэггүй Бурхан Намайг та нар үгээрээ л хүлээн зөвшөөрдөг. Та нар Бурханаас хэтэрхий хол байдаг гэж Би хэлэхдээ, жинхэнэ Бурханаас хол байдаг ч тодорхойгүй Бурхан тун ойрхон байгаа мэт санагддагийг чинь хэлж байна. Би “агуу биш” гэж хэлсэн нь өнөөдөр та нарын итгэдэг Бурхан агуу чадваргүй зүгээр л нэг хүн, тийм ч сүрлэг биш хүн шиг харагддагийг хэлж байгаа юм. Мөн “өчүүхэн ч биш” гэж хэлсэн минь, хэдийгээр энэ хүн салхинд тушааж, бороог захирч чадахгүй ч гэсэн, тэнгэр газрыг доргиох ажлыг хийхийн тулд Бурханы Сүнсийг дуудаж, хүмүүсийг бүрмөсөн гайхшруулж чадна гэсэн утгатай. Гаднаа та нар бүгд газар дээрх энэ Христэд маш дуулгавартай мэт харагддаг ч мөн чанартаа Түүнд итгэдэггүй, Түүнийг хайрладаг ч үгүй. Өөрөөр хэлбэл, та нарын үнэхээр итгэдэг нэгэн чинь та нарын мэдрэмжид байдаг тэр тодорхойгүй Бурхан бөгөөд үнэхээр хайрладаг нэгэн чинь та нарын хэзээ ч биечлэн хараагүй мөртөө өдөр, шөнөгүй хүсэн тэмүүлдэг Бурхан юм. Энэ Христэд хандах та нарын итгэл өчүүхэн төдий бөгөөд та нарын хайр юу ч биш. Итгэл гэдэг бол үнэмшил ба итгэлцэл; хайр гэдэг бол хүний зүрх сэтгэл дэх хэзээ ч салшгүй дурлал, бахдал юм. Гэсэн ч өнөөдрийн Христийг гэх та нарын итгэл, хайр үүнээс хавьгүй дор байдаг. Итгэлийн тухайд гэвэл, та нар Түүнд хэрхэн итгэдэг вэ? Хайрын тухайд бол, та нар Түүнийг яаж хайрладаг вэ? Та нар Түүний мөн чанарыг мэдэх нь байтугай, зан чанарыг нь ч ойлгодоггүй, тэгвэл яаж Түүнд итгэлтэй байх юм бэ? Түүнд итгэх итгэлийн чинь бодит байдал хаана байна вэ? Та нар Түүнийг хэрхэн хайрладаг вэ? Түүнийг гэх хайрын чинь бодит байдал хаана байна вэ?

Олон хүн өнөөдрийг хүртэл эргэлзэлгүйгээр Намайг дагасан. Иймээс өнгөрсөн хэдэн жилд та нар ч бас ихээхэн зүдэрсэн. Би та нарын бүгдийнх нь төрөлх зан авир, зуршлуудыг тов тодорхой ухаарсан; та нартай нэг бүрчлэн харилцахад туйлын хүнд бэрх байсаар ирсэн. Харамсалтай нь хэдийгээр Би та

нарын талаар ихийг ухаарсан ч та нар Миний талаар юу ч ойлгодоггүй. Та нар төөрөлдөх агшиндаа хүнд мэхлүүлдэг гэж хүмүүсийн хэлдэгт гайхах зүйл алга. Үнэндээ, та нар Миний зан чанарын талаар юу ч ойлгодоггүй, Миний оюун санаанд юу байгааг ухаан мэдэж бүр ч чаддаггүй. Өнөөдөр Миний талаарх буруу ойлголт чинь улам нэмэгдэж байгаа бөгөөд Надад итгэх итгэл чинь будилсан итгэл хэвээр үлддэг. Та нар Надад итгэдэг гэж хэлэхийн оронд та нар бүгдээрээ Надад тал засаж, Надад бялдуучлахаар оролдож байна гэж хэлбэл илүү тохирно. Та нарын сэдэл маш энгийн: Бурхан ч бай, эсвэл ямар нэг тодорхой Бурхан ч бай хамаагүй, намайг шагнаж чадах хэнийг ч би дагана, агуу гамшгаас намайг зугтаалгаж чадах хэнд ч би итгэнэ. Аль нь ч надад хамаагүй. Та нарын дунд ийм хүн олон байгаа ба энэ байдал маш ноцтой. Хэрвээ нэгэн өдөр, Христийн мөн чанарыг тодорхой мэддэгээсээ болоод та нараас хэд нь Түүнд итгэдгийг харах туршилт явуулбал, та нарын нэг нь ч Миний хүссэн шиг байж чадахгүй гэдгээс Би айж байна. Иймээс та нар бүгдээрээ энэ асуултыг эргэцүүлж үзсэн нь дээр: Та нарын итгэдэг Бурхан Надаас асар өөр, тийм болохоор Бурханд итгэх итгэлийн чинь мөн чанар тэгвэл юу вэ? Та нар Бурхан гээч зүйлдээ хэдий чинээ итгэнэ, Надаас төдий чинээ холдон явна. Тэгвэл энэ асуудлын мөн чанар юу вэ? Та нараас нэг нь ч энэ асуудлыг эргэцүүлж үзээгүй нь тодорхой, гэхдээ та нар үүний ноцтой байдлыг бодож үзсэн үү? Ийм маягаар үргэлжлүүлэн итгэхийн үр дагаврыг бодож үзсэн үү?

Өнөөдөр та нар олон асуудалтай тулгардаг бөгөөд та нараас нэг нь ч асуудал шийдвэрлэхдээ чадамгай биш. Ийм нөхцөл байдал үргэлжилбэл хохирол амсах хүмүүс нь зөвхөн та нар юм. Асуудлуудыг таньж мэдэхэд чинь Би тусална, гэхдээ тэдгээрийг шийдвэрлэх нь та нараас хамаардаг.

Бусдыг сэжиглэдэггүй хүмүүсийг Би маш их үнэлдэг ба үнэнийг дуртайяа хүлээн зөвшөөрдөг хүмүүс Надад таалагддаг; ийм хоёр төрлийн хүмүүсийг Би асар их халамжилна, учир нь Миний нүдээр бол тэд үнэнч хүмүүс билээ. Хэрвээ чи ов мэхтэй бол бүх хүн, бүх хэрэг явдалд сэрэмжилж, сэжиглэж хандах бөгөөд тиймээс Надад итгэх итгэл чинь хардлагын суурин дээр үндэслэнэ. Ийм итгэлийг Би хэзээ ч хүлээн зөвшөөрч чадахгүй. Жинхэнэ итгэлгүй болохоор чамд жинхэнэ хайр бүр ч байдаггүй. Хэрвээ чи Бурханд эргэлзэж, Түүний талаар хүссэнээрээ боддог бол гарцаагүй хамгийн зальтай хүн юм. Бурхан хүнтэй адил байж чадах эсэхийг чи эргэцүүлэн боддог: уучилшгүй нүгэлтэй, жудаггүй, шударга бус, эрүүл ухаангүй, шударга ёсны мэдрэмж дутмаг, муу арга заль хэрэглэдэг, урвамтгай, зальхай, ёрын муу, харанхуйд дуртай гэх мэт. Хүмүүс

ийм бодолтой байдгийн шалтгаан нь тэдэнд Бурханы талаарх өчүүхэн төдий ч мэдлэг байдаггүйгээс болдог бус уу? Тийм итгэл нь нүглээс өөрцгүй! Түүнчлэн, Миний таалалд нийцдэг хүмүүс бол яг нарийндаа бялдууч, зусарчид бөгөөд ийм чадвар дутмаг хүмүүсийг Бурханы гэрт ч хүлээн авахгүй, тэд тэнд хөлөө олохгүй гэж итгэдэг хүмүүс ч бий. Энэ олон жилийн турш эзэмшсэн мэдлэг чинь энэ үү? Та нарын олж авсан зүйл энэ үү? Миний талаарх та нарын мэдлэг зөвхөн ийм буруу ойлголтоор зогсдоггүй; Бурханы Сүнсийг доромжилж, Тэнгэрийг гутаадаг чинь үүнээс ч дор. Ийм учраас, та нарынх шиг ийм итгэл та нарыг Надаас улам холдуулж, Намайг илүү их эсэргүүцэхэд хүргэнэ гэж Би хэлдэг. Олон жилийнхээ ажлаар та нар олон үнэнийг харсан боловч Миний чих юу сонссоныг та нар мэдэх үү? Та нараас хэр олон нь үнэнийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна вэ? Та нар үнэний төлөө төлөөс төлөхөд бэлэн гэж бүгдээрээ итгэдэг ч хэд чинь үнэний төлөө үнэхээр зовсон бэ? Зүрх сэтгэлд чинь зөв шударга бус байдал л байдаг учраас та нар, хэн ч байсан хамаагүй хүн бүр зальтай, шударга бус гэж бодоод, бие махбодтой болсон Бурхан ч гэсэн хэвийн хүнтэй адилаар нинжин сэтгэлгүй, өр зөөлөн хайргүй байж чадна гэж ч итгэхэд хүрдэг. Үүнээс ч илүүтэйгээр, эрхэм дээд ёс жудаг, өршөөнгүй, өр зөөлөн уг чанар тэнгэр дэх Бурханд л оршдог гэж та нар итгэдэг. Тийм ариун хүн оршин байдаггүй бөгөөд зөвхөн харанхуй, ёрын муу л газар дээр ноёлдог, харин Бурхан бол хүмүүсийн сайн, сайхныг гэх хүсэл эрмэлзлээ даатгадаг зүйл, хүний зохиосон үлгэр домгийн нэгэн юм гэж та нар итгэдэг. Та нарын оюун ухаанд, тэнгэр дэх Бурхан бол маш шулуун шударга, зөвт, агуу, шүтэн мөргөж, бишрэхүйц байдаг; харин газар дээрх энэ Бурхан нь тэнгэр дэх Бурханы орлогч, багаж хэрэгсэл төдий байдаг. Энэ Бурхан нь тэнгэр дэх Бурхантай эн тэнцүү байж болохгүй, Түүнтэй зэрэгцүүлэн үзэж бүр ч болохгүй гэж та нар итгэдэг. Бурханы агуу байдал болон нэр хүндийн тухайд гэвэл тэдгээр нь тэнгэр дэх Бурханы алдар сууд харьяалагддаг, харин хүний уг чанар болон завхралын тухайд бол, тэдгээр нь газар дээрх Бурханд ч байдаг шинж чанар юм. Тэнгэр дэх Бурхан мөнхөд сүрлэг байдаг байхад газар дээрх Бурхан мөнхөд ялихгүй, сул дорой, чадваргүй байдаг. Тэнгэр дэх Бурхан сэтгэл хөдлөлд автдаггүй, зөвхөн зөвт байдалтай байдаг, харин газар дээрх Бурханд хувиа хичээсэн сэдэл л байдаг ба ямар ч шударга байдал, эрүүл ухаан байдаггүй. Тэнгэр дэх Бурханд өчүүхэн төдий ч шударга бус зан байдаггүй, мөнхөд итгэмжит байдаг бол газар дээрх Бурханд шударга бус тал үргэлж байдаг. Тэнгэр дэх Бурхан хүнийг халуун дотноор хайрладаг байхад газар дээрх Бурхан хүнийг хангалтгүй халамжилдаг, тэр ч бүү

хэл хүнийг бүрмөсөн үл ойшоодог. Ийм андуу ташаа мэдлэг та нарын зүрх сэтгэлд удаан хадгалагдсан ба ирээдүйд ч гэсэн бас үүрд хадгалагдах байх. Та нар шударга бус хүний байр сууриас Христийн бүх үйл хэргийг авч үздэг ба хорон муу хүний өнцгөөс Түүний бүх ажил, ялгамж чанар, мөн чанарыг үнэлдэг. Та нар ноцтой алдаа гаргасан ба өмнөх үеийнхнийхээ хэзээ ч хийж байгаагүй зүйлийг хийсэн. Өөрөөр хэлбэл, та нар тэргүүндээ титэмтэй, тэнгэр дэх сүрлэг Бурханд л үйлчилдэг бөгөөд үл үзэгдэхийн төдий маш ялимгүй Бурханд хэзээ ч санаа тавьдаггүй. Энэ нь та нарын нүгэл биш гэж үү? Энэ нь Бурханы зан чанарын эсрэг зөрчлийн чинь сонгодог жишээ биш гэж үү? Та нар тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөдөг. Та нар сүрлэг дүр төрхийг биширч, уран үгээрээ ялгарсан хүмүүсийг хүндэлдэг. Гарыг чинь эд баялгаар дүүргэдэг Бурханд дуртайяа захирагдаж, хүсэл бүрийг чинь биелүүлж чадах Бурханыг ихэд хүсэмжилдэг. Чиний шүтэн мөргөдөггүй Нэгэн бол сүрлэг биш энэ Бурхан; чиний үзэн яддаг цорын ганц зүйл бол хэний ч өндрөөр үнэлдэггүй энэ Бурхантай холбоотой байх явдал. Хийхийг хүсдэггүй цорын ганц зүйл чинь чамд сохор зоос ч өгч байгаагүй энэ Бурханд үйлчлэх явдал бөгөөд Өөрийг нь хүсэн эрмэлзэхэд чамайг хүргэж чаддаггүй Нэгэн бол энэхүү тааламжит бус Бурхан билээ. Тийм Бурхан нь мэдлэгийн хүрээгээ тэлж, үнэт эрдэнэс олсон мэт санагдах боломжийг чамд олгож чадахгүй, хүсдэг зүйлийг чинь биелүүлж бүр ч чадахгүй. Тэгвэл чи яагаад Түүнийг дагадаг юм бэ? Чи иймэрхүү асуултуудыг бодож үзэж байсан уу? Чиний хийдэг зүйл энэ Христийг гомдоогоод зогсохгүй, үүнээс ч илүүтэйгээр тэнгэр дэх Бурханыг гомдоодог. Энэ нь Бурханд итгэх итгэлийн чинь зорилго биш гэж Би бодож байна!

Та нар Бурханыг баярлуулахыг хүсэн эрмэлздэг мөртөө Бурханаас хол байдаг. Энд ямар асуудал байна вэ? Та нар Түүний үгийг хүлээн зөвшөөрдөг ч харьцалт, засалтыг нь хүлээн зөвшөөрдөггүй, Түүний зохицуулалт бүрийг хүлээн зөвшөөрч, Түүнд бүрэн итгэлтэй байж бүр ч чаддаггүй. Тэгвэл энд ямар асуудал байна вэ? Эцсийн дүндээ, та нарын итгэл бол хоосон өндөгний хальс бөгөөд ангаахай бий болгож хэзээ ч чадахгүй. Учир нь итгэл чинь та нарт үнэнийг авчраагүй, эсвэл амийг өгөөгүй, харин ч оронд нь дэмжлэг, найдварын хуурмаг мэдрэмжийг та нарт өгсөн. Бурханд итгэх итгэлийн чинь зорилго үнэн ба амь биш, харин дэмжлэг, найдварын энэхүү мэдрэмж юм. Тиймээс, Бурханд итгэх итгэлийн замнал чинь бялдууч зан, ичгүүргүй байдлаар дамжуулан Бурханд тал засахаар хичээдгээс өөр юу ч биш бөгөөд үүнийг яавч жинхэнэ итгэл хэмээн үзэж болохгүй гэж Би хэлдэг. Ийм итгэлээс яаж ангаахай төрж

болох юм бэ? Өөрөөр хэлбэл, ийм итгэл юу биелүүлж чадах юм бэ? Бурханд итгэх итгэлийн чинь зорилго бол өөрийнхөө зорилгыг биелүүлэхэд Бурханыг ашиглах явдал юм. Цаашлаад энэ нь Бурханы зан чанарт халддагийн чинь баримт биш гэж үү? Та нар тэнгэр дэх Бурханы оршин тогтнолд итгээд, газар дээрх Бурханы оршин тогтнолыг үгүйсгэдэг ч Би та нарын үзэл бодлыг хүлээн зөвшөөрдөггүй; ул суурьтай байж, газар дээрх Бурханд үйлчилдэг хүмүүсийг л Би сайшаадаг, харин газар дээрх Христийг огт хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийг хэзээ ч сайшаадаггүй. Тийм хүмүүс тэнгэр дэх Бурханд хэчнээн үнэнч байх нь хамаагүй, эцэстээ тэд хорон санаатныг шийтгэдэг Миний гараас зайлахгүй. Энэ хүмүүс бол хорон санаатнууд; тэд бол Бурханыг эсэргүүцдэг бөгөөд Христийг хэзээ ч дуртайяа дуулгавартай дагадаггүй ёрын муу хүмүүс юм. Мэдээж тэдний тоонд Христийг мэддэггүй, цаашлаад хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс багтдаг. Тэнгэр дэх Бурханд үнэнч байгаа цагт Христэд хүссэнээрээ хандаж болно гэж чи итгэдэг үү? Тэгэх нь буруу! Чи Христийг мэдэхгүй бол тэнгэр дэх Бурханыг мэдэхгүй. Тэнгэр дэх Бурханд хэчнээн үнэнч байх чинь хамаагүй энэ нь зүгээр л нэг хоосон яриа, хуурамч дүр эсгэлт юм, учир нь газар дээрх Бурхан нь үнэн болон илүү гүнзгий мэдлэгийг хүлээн авахад хүнд ач тустайгаар үл барам, хүнийг яллаж, улмаар хорон санаатнуудыг шийтгэх баримтуудыг цуглуулахад бүр ч их ач тустай. Чи энд байгаа ашиг тустай болон хор хөнөөлтэй үр дүнг ойлгов уу? Чи тэдгээрийг туулсан уу? Та нар энэ үнэнийг аль болох хурдан ойлгоосой гэж Би хүсэж байна: Бурханыг мэдэхийн тулд чи тэнгэр дэх Бурханыг мэдээд зогсохгүй, хамгийн чухал нь газар дээрх Бурханыг мэдэх ёстой. Аль нь чухал талаар бүү будил, эсвэл хоёрдогч зүйлээр гол зүйлийг бүү орлуул. Зөвхөн ийм маягаар л чи Бурхантай үнэхээр сайн харилцаатай болж, Бурхантай илүү ойр болж, зүрх сэтгэлээ Түүнд улам ойртуулж чадна. Хэрвээ чи олон жил итгэлтэй байж, Надтай удаан хугацаанд холбоотой байсан ч Надаас хол хэвээр үлдсэн бол, чи Бурханы зан чанарт байнга халдаж байсан байж таарна, мөн чиний төгсгөлийг тооцоолоход маш хэцүү байх болно гэж Би хэлнэ. Надтай олон жил харилцаатай байсан чинь чамайг хүн чанартай, үнэнтэй хүн болгон өөрчлөөгүй, харин ч муу арга зам чинь чиний уг чанарт шингэж, чи хоёр дахин их зантай болоод зогсохгүй Миний талаарх буруу ойлголт чинь ч бас ихсэж, улмаар чи Намайг хань хамсаатан шигээ үзэж эхэлбэл өвчин эмгэг чинь өнгөцхөн биш, харин ясанд чинь нэвчсэн байна гэж Би хэлнэ. Тэгээд чи, оршуулгын чинь бэлтгэл ажил хийгдэхийг л хүлээх үлдэнэ. Тэр үед чиний Бурхан болохыг Надаас гуйж гувших хэрэггүй, учир нь чи үхэх ёстой нүгэл,

уучилшгүй нүгэл үйлдсэн билээ. Би чамд өршөөл үзүүлж чадсан ч гэсэн, тэнгэр дэх Бурхан амийг чинь авахаар зүтгэнэ, учир нь Бурханы зан чанарын эсрэг халдсан чинь энгийн асуудал биш, харин уг чанартаа тун ноцтой юм. Цаг нь ирэхэд, чамд урьдчилан хэлээгүй гэж Намайг бүү буруутга. Энэ бүхэн нь ийм байх болно: Чи газар дээрх Бурхан буюу Христэд эгэл жирийн хүн мэт хандах үедээ, өөрөөр хэлбэл, энэ Бурхан нь хүнээс өөрцгүй гэж итгэх үедээ мөхөх болно. Энэ нь та бүхэнд өгөх цорын ганц сануулга минь билээ.

ТУН НОЦТОЙ АСУУДАЛ: УРВАЛТ (1)

Миний ажил тун удахгүй дуусна. Хамт өнгөрүүлсэн он жилүүд тэвчихийн аргагүй дурсамж болжээ. Би үгээ тасралтгүй давтаж, шинэ ажлаа зогсолтгүй үргэлжлүүлсэн. Мэдээж, Миний зөвлөгөө бол Миний хийдэг ажил болгоны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Миний зөвлөгөөгүйгээр та нар бүгд төөрөлдөж, бүр яахаа ч мэдэхээ болих байсан. Одоо Миний ажил дуусах дөхөж, сүүлчийн шатандаа байна. Би зөвлөгөө өгөх ажил хийхийг, өөрөөр хэлбэл, та нарт сонсох зөвлөмж чанартай хэдэн үг хэлэхийг хүссээр байна. Та нар Миний уйгагүй хүчин чармайлтыг хий дэмий үрэхгүй байж, түүнээс ч илүүтэйгээр, хичээнгүйлэн санаа тавьж буйг минь ойлгож, Миний үгийг хүн байхын үндэс суурь хэмээн үзээсэй л гэж Би найдаж байна. Та нарын сонсоход бэлэн үг энэ мөн ч бай, биш ч бай, та нарын дуртайяа хүлээн авах, эсвэл таагүй хүлээн авах үг мөн ч бай, биш ч бай, та нар нухацтай хандах ёстой. Эс тэгвэл, үл тоомсорлосон, хайхрамжгүй зан чанар, араншин чинь Намайг маш их гонсойлгож, үнэндээ Миний зэвүүцлийг төрүүлнэ. Та бүгд Миний үгийг ахин дахин, магадгүй бүр цээжээр мэддэг болтлоо хэдэн мянган удаа уншина гэж Би ихэд найдаж байна. Ийм маягаар л та нар Миний итгэл найдварыг нураахгүй байж чадна. Гэхдээ та нарын нэг нь ч одоо ингэж амьдардаггүй. Эсрэгээрээ та нар бүгд ханатлаа идэж, уудаг садар самуун амьдралд ташуурдаг бөгөөд та нарын нэг нь ч Миний үгийг ашиглан, зүрх сэтгэл, сүнсээ баяжуулдаггүй. Ийм учраас, Би хүн төрөлхтний жинхэнэ төрхийг ингэж дүгнэсэн: Хүн хэдийд ч Надаас урваж чадна, Миний үгэнд туйлын үнэнч байж чадах хэн ч үгүй.

“Хүнийг Сатан маш их ялзруулсан тул хүн төрхтэй байхаа больсон.” Одоо ихэнх хүн энэ хэллэгийг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрдөг. Миний хэлж буй “хүлээн зөвшөөрөх” гэдэг нь жинхэнээсээ мэдэхтэй харьцуулахад зүгээр нэг өнгөцхөн хүлээн зөвшөөрөх явдал төдий учраас Би ингэж хэлдэг. Та нарын нэг

нь ч өөрсдийгөө үнэн зөвөөр үнэлж, бас нэгд нэггүй шинжилж чадахгүй тул Миний үгэнд эргэлзсэн хэвээр үлддэг. Гэхдээ та нарын дотор оршдог хамгийн ноцтой асуудлыг тайлбарлахын тулд Би энэ удаад баримт ашиглаж байна. Тэрхүү асуудал нь урвалт юм. Та нар бүгд “урвалт” гэдэг үгийг мэднэ, учир нь нөхөр нь эхнэрээсээ урвах, эхнэр нь нөхрөөсөө урвах, хүү нь эцгээсээ урвах, охин нь эхээсээ урвах, боол нь эзнээсээ урвах, найзууд нэг нэгнээсээ урвах, хамаатнууд нэг нэгнээсээ урвах, худалдагчид худалдан авагчдаасаа урвах гэх мэтчилэн ихэнх хүн бусдаас урвах ямар нэгэн зүйл хийж байсан. Энэ бүх жишээ урвалтын мөн чанарыг агуулдаг. Товчхондоо, урвалт бол амлалтаасаа буцаж, ёс суртахууны зарчмыг зөрчих буюу хүний ёс зүйд харшлах үйлдэл хийж, хүн чанараа алдсаныг харуулдаг нэг төрлийн зан авир юм. Чи хэзээ нэгэн цагт хэн нэгнээс урвах зүйл хийснээ санадаг ч бай эсвэл урьд нь олон удаа бусдаас урвасан ч бай хамаагүй, ерөнхийдөө энэ хорвоод төрсөн хүн болохын хувьд үнэнээс урвахтай адил ямар нэгэн зүйл хийсэн байх болно. Чи эцэг эх, найз нөхдөөсөө урвах чадвартай тул бусдаас урвах, түүгээр ч үл барам Надаас урваж, Миний үзэн яддаг зүйлсийг хийх чадвартай. Өөрөөр хэлбэл урвалт нь ёс суртахуунгүй өнгөцхөн үйлдэл төдий биш харин үнэнтэй зөрчилддөг зүйл юм. Энэ нь яг нарийндаа хүн төрөлхтөн Намайг эсэргүүцэж, Надад дуулгаваргүй байхын эх сурвалж юм. Ийм учраас Би үүнийг дараах өгүүлбэрээр нэгтгэн дүгнэлээ: Урвалт бол хүний уг чанар бөгөөд энэ уг чанар нь Надтай нийцдэг хүн бүрийн томоохон дайсан юм.

Надад туйлын дуулгавартай байж чадахгүй үйлдэл бол урвалт. Надад үнэнч байж чадахгүй үйлдэл бол урвалт. Намайг хуурч, Намайг мэхлэхийн тулд худал хэлэх нь урвалт. Олон үзэл өвөрлөж, тэдгээрийг хаа сайгүй тараах нь урвалт. Миний гэрчлэл, ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй байх нь урвалт. Зүрх сэтгэлээрээ Надаас хол байх үедээ хуурамч инээмсэглэл тодруулах нь урвалт. Эдгээр нь бүгд та нарын үргэлж хийж чаддаг байсаар ирсэн урвалтын үйлдлүүд бөгөөд та нарын дунд түгээмэл байдаг. Та нарын хэн нь ч үүнийг асуудал гэж бодохгүй байж болох ч, Би тэгж бодохгүй байна. Хүн Надаас урвах нь Миний хувьд ялихгүй асуудал биш, үүнийг хайхрахгүй орхиж Би яавч чадахгүй. Одоо Намайг та нарын дунд ажиллаж байхад та нар ингэж авирладаг—та нарыг харж хандах хэн ч байхгүй болох өдөр ирвэл та нар өөрсдийгөө жижигхэн уулынхаа хаан нь гэж тунхагласан дээрэмчин адил байх бус уу? Тийм зүйл болж, гай гамшиг тарьсан хойно чинь хэн засаж залруулах вэ? Зарим урвасан үйлдлүүдийг өөрсдийнхөө байнгын үйлдэл биш, ердөө тохиолдлын хэрэг

хэмээн та нар бодож, нэр төрийг чинь гутаах хэмжээний ноцтойгоор авч хэлэлцэх хэрэггүй гэж үздэг. Хэрвээ та нар үнэхээр тэгж боддог бол эрүүл ухаан дутмаг байна. Тэгж бодох нь тэрслүү байдлын үлгэр жишээ, нийтлэг шинж юм. Хүний уг чанар бол түүний амь; амьд үлдэхийн тулд түшиглэдэг зарчим нь бөгөөд хүн үүнийг өөрчилж чадахгүй. Урвалтын уг чанарыг жишээ болгон аваад үз. Хэрвээ чи хамаатан садан, найз нөхдөөсөө урвах ямар нэгэн зүйл хийж чаддаг бол энэ нь амийн чинь нэг хэсэг, төрөлх уг чанар чинь гэдэг нь нотлогддог. Энэ бол хэний ч үгүйсгэж чадахгүй зүйл. Жишээлбэл, хэрвээ хүн бусдаас хулгайлах дуртай бол заримдаа хулгай хийж, заримдаа хийдэггүй байсан ч “хулгайлах дуртай” байх нь түүний амийн нэг хэсэг болдог. Тэд хулгайлсан ч бай, үгүй ч бай, хулгай хийх нь зүгээр л нэг төрлийн үйлдэл гэдгийг энэ нь баталж чадахгүй. Харин ч хулгай хийх нь тэдний амийн нэг хэсэг, өөрөөр хэлбэл, тэдний уг чанар гэдгийг энэ нь нотолдог. Зарим хүн: Тэдний уг чанар нь ийм юм бол сайхан зүйлс харахаараа тэд заримдаа яагаад хулгайлдаггүй юм бэ? гэж асууна. Хариулт нь маш энгийн. Тэдэнд хулгайлахгүй байх маш олон шалтгаан бий. Бусдыг харж байхад авч явахад хэтэрхий том зүйл байх ч юм уу, эсвэл тохиромжтой цаг нь биш байх, хэтэрхий үнэтэй зүйл байх, хэт хатуу чанга харуул хамгаалалттай байх, магадгүй тэд үүнийг онцгойлон сонирхдоггүй, эсвэл ямар хэрэгтэйг нь мэдэхгүй байх гэх мэт шалтгаанаар тэд хулгайлахгүй байж болно. Энэ бүх шалтгаан байж болно. Гэхдээ юм хулгайлсан ч бай, үгүй ч бай, тэдэнд ийм бодол хоромхон зуур төрөөд өнгөрдөг гэж нотлох аргагүй. Харин ч эсрэгээрээ энэ бол засаж сайжруулахад бэрх уг чанарынх нь нэг хэсэг мөн. Ийм хүн ганцхан удаа хулгай хийгээд сэтгэл нь ханадаггүй; ямар нэгэн сайхан зүйлтэй таарах юм уу, тохиромжтой нөхцөл байдал гарах бүрд бусдын эд зүйлийг өөрийн болгох бодол төрдөг. Тийм учраас ийм бодлын эх үүсвэр нь зүгээр л хааяа нэг гарч ирдэг зүйл биш, харин тухайн хүний уг чанарт нь байдаг гэж Би хэлдэг.

Хэн ч үг, үйлдлээрээ жинхэнэ төрхөө илэрхийлж чадна. Энэхүү жинхэнэ төрх нь мэдээж тэдний уг чанар юм. Хэрвээ чи булзааруулж ярьдаг хүн бол булзамхай уг чанартай. Хэрвээ уг чанар чинь зальхай бол чи зальжин авирладаг бөгөөд хүмүүс чамд тун амархан мэхлэгдэнэ. Хэрвээ уг чанар чинь хорлонтой бол үгийг чинь сонсоход таатай байж болох ч үйлдэл чинь олиггүй заль мэхийг чинь далдалж чадахгүй. Хэрвээ уг чанар чинь залхуу бол хэлдэг үг бүр чинь хааш яаш, залхуу байдлынхаа улмаас хариуцлагаас зайлсхийх зорилготой байдгийн дээр үйлдэл чинь удаан, хааш яаш, мөн үнэнийг далдлахдаа нэлээд

сурамгай байдаг. Хэрвээ чиний уг чанар уян зөөлөн бол уг чинь ухаалаг, үйлдэл чинь ч бас үнэнтэй сайтар нийцнэ. Хэрвээ уг чанар чинь үнэнч бол уг чинь гарцаагүй чин сэтгэлийн, үйлдэл чинь ул суурьтай, эзнийхээ санааг зовоох юм байдаггүй. Хэрвээ уг чанар чинь тачаангуй, эсвэл мөнгөнд шунадаг бол зүрх сэтгэл чинь үргэлж ийм зүйлээр дүүрэн байж, хүмүүсийн амархан мартахааргүй, зэвүүцлийг нь төрүүлэхүйц гажууд, ёс суртахуунгүй үйлийг чи өөрийн эрхгүй үйлдэнэ. Миний хэлсэнчлэн, хэрвээ чи урвагч уг чанартай бол үүнээс өөрийгөө салгаж бараг чадахгүй. Чи бусдад буруу зүйл хийж байгаагүй болохоор урвагч уг чанар байхгүй гэж азад бүү найд. Хэрвээ ингэж бодож байвал чи үнэхээр дургүй хүрмээр юм. Намайг ярих болгонд Миний бүх үг ганцхан хүн, эсвэл ганцхан төрлийн хүнд бус, харин бүх хүнд чиглэдэг. Надаас нэг зүйл дээр урваагүй гэдэг чинь аливаа нэг зүйл дээр урваж чадахгүй гэдгийг чинь батлахгүй. Гэрлэлтэд нь бэрхшээл тохиолдоход зарим хүн үнэнийг эрж хайх итгэлээ алддаг. Зарим хүн гэр бүл салалтын үеэр Надад үнэнч байх үүргээсээ татгалздаг. Зарим хүн хоромхон зуурын баяр хөөр, сэтгэлийн таашаалыг эрж хайж Намайг орхидог. Зарим хүн гэрэлд амьдарч, Ариун Сүнсний ажлын баяр бахдалыг хүртсэний оронд харанхуй хавцал руу унахыг илүүд үздэг. Зарим хүн эд хөрөнгийн шуналаа хангахын төлөө найз нөхдийн зөвлөгөөг үл ойшоодог бөгөөд одоо ч алдаагаа хүлээн зөвшөөрч, замналаа өөрчилж чаддаггүй. Зарим хүн Надаар хамгаалуулах л гэж Миний нэрийн дор түр зуур амьдардаг байхад зарим нь амьдралд шунан, үхлээс эмээхийн эрхээр Надад жаахныг зориулдаг. Энэ болон бусад ёс суртахуунгүй үйлдэл, түүнчлэн ёс жудаггүй үйлдлүүд нь зүрх сэтгэлийнхээ гүнд Надаас аль хэдийн урвасан хүмүүсийн үйлдлүүд бус уу? Мэдээж, хүмүүс Надаас урвахаар урьдаас төлөвлөдөггүй гэдгийг Би мэднэ; тэдний урвалт бол уг чанарынх нь төрөлхийн илчлэл юм. Хэн ч Надаас урвахыг хүсдэггүй, Надаас урвах ямар нэгэн зүйл хийснээсээ болоод хэн ч аз жаргалтай байдаггүй. Харин ч тэд айн чичирдэг, тийм биз дээ? Тэгэхээр та нар эдгээр урвалтыг хэрхэн засаж залруулах, одоогийн нөхцөл байдлыг хэрхэн өөрчлөх талаар бодож байна уу?

ТУН НОЦТОЙ АСУУДАЛ: УРВАЛТ (2)

Хүний уг чанар Миний мөн чанараас нэлээд өөр, учир нь хүний завхарсан уг чанар бүхэлдээ Сатанаас үүсэлтэй; хүний уг чанарыг Сатан боловсруулж, ялзруулсан юм. Өөрөөр хэлбэл, хүн Сатаны ёрын муу, үзэшгүй муухай байдлын

нөлөөн дор амьдардаг. Хүн үнэний ертөнцөд юм уу ариун орчинд өсөж торнидоггүй, гэрэлд бүр ч амьдардаггүй. Тиймээс, ямар ч хүн төрөлхөөсөө уг чанар дотроо үнэнтэй байх боломжгүй, мөн Бурханаас эмээж, Бурханд дуулгавартай байх мөн чанартай төрж бүр ч чадахгүй. Эсрэгээрээ хүмүүс Бурханыг эсэргүүцдэг, Бурханд дуулгаваргүй, үнэнийг хайрладаггүй уг чанартай байдаг. Энэ уг чанар бол Миний ярихыг хүсэж байгаа асуудал—урвалт юм. Урвалт бол хүн бүрийн Бурханыг эсэргүүцэх эсэргүүцлийн эх сурвалж мөн. Энэ нь Надад биш, харин зөвхөн хүнд л байдаг асуудал билээ. Зарим хүн ингэж асууна: Бүх хүн Христтэй адил ертөнцөд амьдардаг байж яагаад бүх хүнд Бурханаас урвадаг уг чанар байхад Христэд байдаггүй юм бэ? Энэ бол та нарт тодорхой тайлбарлаж өгөх ёстой асуудал юм.

Хүн төрөлхтний оршин тогтнолын үндэс нь сүнс удаа дараа төрлөө олох явдал юм. Өөрөөр хэлбэл, хүний сүнс дахин төрлөө олоход хүн болгон махан бие бүхий хүний амийг олж авдаг. Хүний бие төрсний дараа, махан бие нь эцэстээ хязгаартаа хүртэл буюу сүнс бүрхүүлээ орхин явах сүүлчийн мөч хүртэл амь нь үргэлжилдэг. Энэ үйл явц нь хүний сүнс удаа дараа ирж, буцахын хэрээр ахин дахин давтагдаж, ийнхүү хүн төрөлхтний оршин тогтнолыг хадгалж байдаг. Махан биеийн амь нь бас хүний сүнсний амь бөгөөд хүний сүнс нь хүний махан биеийн оршин тогтнолыг дэмжиж байдаг. Өөрөөр хэлбэл, хүн нэг бүрийн амь сүнснээс ирдэг бөгөөд амь нь махан биед төрөлхөөсөө байдаггүй. Тиймээс хүний уг чанар махан биеэс бус, харин сүнснээс гаралтай. Сатаны уруу таталт, гай зовлон, завхралыг хэрхэн туулснаа хүн бүрийн сүнс нь л мэддэг. Хүний махан бие эдгээрийг мэдэх аргагүй. Тиймээс, хүн төрөлхтөн өөрийн эрхгүй улам харанхуй, улам бузар, улам ёрын муу болж, харин хүн Бид хоёрын хоорондох зай улам ихсээд, хүн төрөлхтний хувьд амьдрал улам харанхуй болдог. Сатан хүн төрөлхтний сүнснийг атгаж байдаг тул мэдээж хүний махан биеийг ч бас эзлэн авсан. Ийм махан бие, ийм хүн төрөлхтөн яаж Бурханыг эсэргүүцэхгүй байж чадах юм бэ? Тэд Түүнтэй төрөлхөөсөө нийцэлтэй байж яаж чадах юм бэ? Сатан Надаас урвасан учраас Би түүнийг агаар луу доош хаясан. Тэгвэл хүмүүс яаж үүнээс ангижирч чадах юм бэ? Ийм учраас урвалт бол хүний уг чанар юм. Та нар энэ шалтгааныг ойлгомогцоо Христийн мөн чанарт ч бас тодорхой хэмжээгээр итгэх учиртай гэж Би итгэж байна. Бурханы Сүнсний өмссөн махбод нь Бурханы Өөрийнх нь махбод билээ. Бурханы Сүнс бол эрхэм дээд; Тэрээр төгс хүчит, ариун, зөвт билээ. Үүний адилаар Түүний махбод ч бас эрхэм дээд, төгс хүчит, ариун, зөвт юм. Ийм махбод нь зөвт, хүн төрөлхтөнд ач тустай

зүйлийг, мөн ариун, алдар суутай, сүр хүчтэй зүйлийг л хийж чаддаг; Тэрээр үнэн, ёс суртахуун, шударга ёсыг зөрчдөг юуг ч хийж чадахгүй, Бурханы Сүнснээс урвах ямар нэг зүйлийг хийж бүр ч чадахгүй. Бурханы Сүнс ариун тул Түүний махбодыг Сатан завхруулах аргагүй; Түүний махбод хүний махан биеэс өөр мөн чанартай. Учир нь, Сатан Бурханыг биш, хүнийг завхруулсан; Сатан Бурханы бие махбодыг завхруулж яавч чадахгүй. Тиймээс хүн, Христ хоёр ижил газар амьдран суудаг баримтаас үл хамааран зөвхөн хүнийг л Сатан эзэмдэж, ашиглаж, бас урхиддаг. Үүнээс ялгаатай нь Христ үүрд Сатаны завхралд авташгүй, учир нь Сатан хамгийн өндөр газарт хүрч, Бурханд ойртон очиж хэзээ ч чадахгүй. Өнөөдөр, Сатаны завхруулсан хүн төрөлхтөн л Надаас урвадаг гэдгийг та нар бүгд ойлгох ёстой. Урвалт нь Христтэй өчүүхэн ч хамаагүй асуудал юм.

Сатаны завхруулсан бүх сүнс Сатаны эзэмшилд олзлогдсон байдаг. Христэд итгэдэг хүмүүс л тусгаарлагдаж, Сатаны баазаас аврагдаж, өнөөдрийн хаанчлалд хүргэгдсэн. Энэ хүмүүс цаашид Сатаны нөлөөн дор амьдрахгүй. Тэгсэн ч гэсэн, хүний уг чанар махан биед нь үндэслэсэн хэвээр байдаг, өөрөөр хэлбэл, та нарын сүнс аврагдсан ч уг чанар чинь урьдынх шигээ хэвээр байдаг бөгөөд Надаас урвах магадлал чинь зуун хувь хэвээр үлдэнэ. Тийм учраас, та нарын уг чанар хэтэрхий гуйвшгүй тул Миний ажил ийм удаан үргэлжилдэг. Одоо та нар үүргээ биелүүлэхдээ чадлынхаа хэрээр зовлон бэрхшээл туулж байгаа ч дор бүрнээ Надаас урваж, Сатаны эзэмшил рүү, түүний бааз руу буцаж, хуучин амьдралдаа эргэн орж чадна—энэ бол үгүйсгэхийн аргагүй баримт юм. Тэр үед та нар одоогийнх шигээ бага зэргийн хүн чанартай, хүний төрхтэй байх боломжгүй болно. Ноцтой тохиолдолд, та нар устгагдана, түүнээс гадна хэзээ ч дахин төрлөө олохгүйгээр үүрд мөхөж, хатуу шийтгүүлнэ. Энэ бол та нарын өмнө тулгарсан асуудал юм. Би нэгдүгээрт, ажлаа талаар болгохгүйн тулд, хоёрдугаарт, та нарыг бүгдийг нь гэрэл гэгээтэй өдрүүдэд амьдруулахын тулд ийм маягаар та нарт сануулж байна. Үнэн хэрэгтээ Миний ажил талаар болох эсэх нь гол асуудал биш. Та нар аз жаргалтай амьдрал, гайхалтай сайхан ирээдүйтэй байж чадах нь гол чухал юм. Миний ажил бол хүмүүсийн сүнсийг аврах ажил. Хэрвээ чиний сүнс Сатаны гарт орвол, бие чинь амар тайван амьдрахгүй. Хэрвээ Би чиний биеийг хамгаалж байгаа бол сүнс чинь Миний халамжин дор байх нь гарцаагүй. Хэрвээ Би чамайг үнэхээр үзэн ядвал чиний сүнс болон бие тэр даруй Сатаны гарт орно. Тэр үед нөхцөл байдал чинь ямар байхыг чи төсөөлж чадах уу? Хэрвээ нэг л өдөр та нар Миний үгийг ойлгохгүй

байвал Би уураа бүрэн гартал бүгдийг чинь Сатанд гардуулан өгч, шаналгаат тарчлаанд өртүүлнэ, эсвэл Надаас урвадаг зүрх сэтгэл чинь хэзээ ч өөрчлөгдөөгүй байх учраас засаршгүй хүмүүс та нарыг Би биечлэн шийтгэнэ.

Одоо та нар, дотор чинь Надаас урвах урвалт хэр их үлдсэнийг мэдэхийн тулд өөрсдийгөө аль болох хурдан шинжлэх ёстой. Та нарын хариуг Би тэсэн ядан хүлээж байна. Надтай харьцахдаа хуумгай бүү бай. Би хэзээ ч хүмүүстэй тоглоом тоглодоггүй. Хэрвээ Би ямар нэг юм хийнэ гэж хэлсэн бол гарцаагүй хийнэ. Би та нар дор бүрнээ Миний үгийг нухацтай авч үздэг хүмүүс байж, тэдгээрийг шинжлэх ухааны зөгнөлт зохиол мэт үзэхгүй гэдэгт Би найдаж байна. Би та нараас төсөөлөл биш, бодитой үйлдэл л хүсдэг. Дараа нь та нар Миний энэ асуултуудад хариулах ёстой: 1. Хэрвээ чи үнэхээр үйлчлэл үзүүлэгч мөн бол хайнга, сөрөг байдлын ямар ч элементгүйгээр Надад үнэнчээр үйлчлэл үзүүлж чадах уу? 2. Чамайг хэзээ ч үнэлж байгаагүйг минь олж мэдэх юм бол чи насан туршдаа үлдээд, Надад үйлчлэл үзүүлсээр байж чадах уу? 3. Чамайг ихээхэн хичээл зүтгэл гаргасан ч гэсэн Би чамд тун хүйтэн хөндий хандсаар байвал анзаарагдалгүйгээр Миний төлөө үргэлжлүүлэн ажиллаж чадах уу? 4. Чамайг Миний төлөө зарлага гаргасны дараа Би ялихгүй хүсэлтийг чинь биелүүлдэггүй бол чи сэтгэлээр унаж, Надад урам хугарах уу, эсвэл бүр уурсан хилэгнэж, хараал зүхэл хашхирах уу? 5. Хэрвээ чи Надад үргэлж маш үнэнч байж, Намайг ихэд хайрлаж байсан ч өвчин зовлон, ядуурлын тарчлаан амсаж, найз нөхөд, төрөл төрөгсдөдөө орхигдох юм уу амьдралдаа өөр золгүй явдал туулбал Намайг гэх үнэнч зан, хайр чинь үргэлжилсээр байх уу? 6. Зүрх сэтгэлдээ төсөөлсөн зүйлээс чинь нэг нь ч Миний хийсэнтэй таардаггүй бол чи ирээдүйн замдаа хэрхэн алхах вэ? 7. Хэрвээ чи хүртэнэ гэж найдаж байсан зүйлийнхээ нэгийг нь ч хүлээн авч чадахгүй бол Миний дагалдагч хэвээр байж чадах уу? 8. Хэрвээ чи Миний ажлын зорилго, ач холбогдлыг хэзээ ч ойлгож байгаагүй бол дураараа шүүлт хийж, дүгнэлт гаргадаггүй дуулгавартай хүн байж чадах уу? 9. Намайг хүн төрөлхтөнтэй хамт байх зуур чи Миний хэлсэн бүх үг, хийсэн бүх ажлыг эрхэмлэн нандигнаж чадах уу? 10. Чи ямар нэг юм хүлээн авахгүй байсан ч гэсэн, насан туршдаа Миний төлөө зовоход бэлэн, Миний үнэнч дагалдагч байж чадах уу? 11. Миний төлөө чи ирээдүйн амьдралын замаа бодолцон үзэхгүй, төлөвлөхгүй, бэлдэхгүй байж чадах уу? Эдгээр асуулт та нарт тавих Миний сүүлчийн шаардлагыг төлөөлдөг бөгөөд та нар бүгд Надад хариулт өгч чадна гэж Би найдаж байна. Чи эдгээр асуултын ганц, хоёрыг нь л биелүүлсэн бол үргэлжлүүлэн чармайх ёстой. Хэрвээ чи эдгээр шаардлагаас ганцыг нь ч

биелүүлж чадахгүй бол гарцаагүй там руу хаягдах төрлийн хүн юм. Ийм хүмүүст Би нэмж юм хэлэх шаардлагагүй, учир нь тэд Надтай нийцэж чадах хүмүүс яавч биш. Ямар ч нөхцөлд Надаас урваж чадах хүнийг Би яаж Өөрийн гэрт байлгаж чадах билээ? Ихэнх тохиолдолд Надаас мөн л урваж чадах хүмүүсийн тухайд бол Би өөр зохицуулалт хийхээсээ өмнө тэдний гүйцэтгэлийг ажиглана. Гэхдээ, ямар ч нөхцөл байдалд байсан бай, Надаас урваж чадах хүмүүсийг Би хэзээ ч мартаггүй; Би тэднийг сэтгэлдээ санаж, ёрын муу үйл хэрэгт нь хариу барих боломжийг хүлээнэ. Миний тавьсан шаардлагууд бол та нар өөрсдийгөө шалгах ёстой бүх асуудал юм. Та нар бүгд эдгээрийг нухацтай авч үзэн, Надтай хааш яаш харьцахгүй гэдэгт Би найдаж байна. Ойрын ирээдүйд Би та нарын өгсөн хариултыг Өөрийн шаардлагуудтай харьцуулан шалгана. Тэр үед Би та нараас өөр юу ч шаардахгүй, бас чин сэтгэлийн сануулга өгөхгүй. Оронд нь Би эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Үлдэх ёстой хүмүүс үлдэж, шагнуулах ёстой нь шагнуулж, Сатанд очих ёстой нь Сатанд өгөгдөж, хатуу шийтгүүлэх ёстой нь хатуу шийтгүүлж, мөхөх ёстой нь устгагдана. Ийнхүү Миний өдрүүдэд Намайг үймүүлэх нэг ч хүн байхаа болино. Чи Миний үгэнд итгэж байна уу? Залхаан цээрлүүлэлтэд итгэж байна уу? Намайг хуурч, Надаас урвадаг ёрын муу бүх хүнийг шийтгэнэ гэдэгт минь итгэдэг үү? Тэр өдөр удахгүй ирээсэй гэж чи хүсдэг үү, эсвэл дараа ирээсэй гэж хүсдэг үү? Чи шийтгэлээс үхтэлээ айдаг хүн үү, эсвэл шийтгэл хүлээх ёстой ч Намайг эсэргүүцэхийг илүүд үзэх хүн үү? Тэр өдөр ирэхэд чи баяр хөөр, инээд баясал дунд амьдрах уу, эсвэл уйлж, шүдээ хавирах уу гэдгээ төсөөлж чадах уу? Чи ямархуу төгсгөлтэй тулгарна гэж найдаж байна? Чи Надад зуун хувь итгэдэг үү, эсвэл зуун хувь эргэлздэг үү гэдгээ ер нь ноцтой бодож үзсэн үү? Үйлдэл, зан авир чинь ямар үр дагавар, төгсгөлд хүргэж болохыг чи ер нь нухацтай бодож байв уу? Миний бүх үг ээлж дараалан биелээсэй гэж чи үнэхээр хүсэж байна уу, эсвэл Миний үг ар араасаа биелнэ гэхээс үхтэлээ айж байна уу? Хэлсэн үгээ биелүүлэхийн тулд удахгүй явна гэдэгт минь чи итгэдэг бол үг, үйлдэлдээ хэрхэн хандах ёстой вэ? Хэрвээ чи Намайг яваасай гэж хүсдэггүй, Миний бүх үг шууд биелээсэй гэж хүсдэггүй бол ер нь яагаад Надад итгэдэг юм бэ? Чи яагаад Намайг дагаж байгаагаа үнэхээр мэдэж байна уу? Чи мэдлэгийн хүрээгээ л тэлэх зорилготой бол өөртөө ингэж төвөг удах шаардлагагүй. Хэрвээ ерөөгдөж, айсуй гамшгаас мултрахын төлөө бол чи яагаад биеэ авч явах байдалдаа санаа зовохгүй байгаа юм бэ? Миний шаардлагыг биелүүлж чадах эсэхээ өөрөөсөө яагаад асуухгүй байгаа юм бэ? Хожмын ерөөлийг хүртэх эрхтэй эсэхээ өөрөөсөө яагаад асуухгүй байгаа юм бэ?

ТА НАР ҮЙЛ ХЭРГЭЭ БОДОЛЦОЖ ҮЗЭХ УЧИРТАЙ

Өөрсдийгөө хангахын тулд та нар өдөр бүр Миний үгээс нэг хэсгийг хүртэж байх шаардлагатай гэдэг нь амьдрал дээрх үйл хэрэг, үйлдэл бүрээс чинь харагддаг, учир нь та нар хэтэрхий дутуу дулимаг агаад та нарын мэдлэг болон ойлгох чадвар хэтэрхий хомс билээ. Өдөр тутмын амьдралдаа та нар үнэн эсвэл эрүүл саруул ухаан гэж байхгүй орчин, нөхцөлд дунд амьдардаг. Та нарт амь зуух чадвар дутдаг ба Намайг эсвэл үнэнийг мэдэх суурь байдаггүй. Та нарын итгэл ердөө л тодорхойгүй, хийсвэр итгэл үнэмшил дээр эсвэл хэт онолын мэдлэг болон шашны зан үйл дээр суурилсан байдаг. Өдөр бүр Би та нарын үйл хөдлөлийг ажиглаж, санаа зорилго, ёрын муу үр жимсийг чинь шинжилж байдаг бөгөөд хэзээ ч хөдөлгөөгүй Миний тахилын ширээн дээр зүрх сэтгэл болон сүнсээ үнэхээр тавьсан нэгнийг Би ер олоогүй. Иймд Би илэрхийлэхийг хүссэн бүх үгээ ийм хүн төрөлхтөнд тоочиж цагаа үрэхийг хүсэхгүй байна. Би зүрх сэтгэлдээ зөвхөн дуусгаагүй ажлаа дуусгаж, хүн төрөлхтөн дундаас Өөрийн хараахан авраагүй хүмүүсийг аврахаар төлөвлөж байна. Гэсэн хэдий ч, Намайг дагадаг бүхэн Миний авралыг болон Миний үгийн хүнд хайрладаг үнэнийг хүлээн аваасай гэж Би хүсдэг. Нэг л өдөр нүдээ аних үедээ чи тэнгэр нь хар үүлэнд хиртсэн, орь дуу хэзээ ч тасардаггүй баргар хүйтэн ертөнцийг бус, харин агаар нь анхилуун үнэрээр дүүрсэн, амийн усны булаг урссан ертөнцийг харна гэж Би найддаг.

Өдөр бүр хүн болгоны үйл хэрэг болон бодлыг тэрхүү Нэгэний нүд харж ажиглаж байдаг, үүний зэрэгцээ тэдний маргаашийн төлөө бэлдэж байдаг. Энэ бол бүх амьд буй хүний алхах ёстой зам; энэ бол бүгдэд зориулж Миний урьдчилан тогтоосон зам бөгөөд хэн ч үүнээс зугтаж чадахгүй, бас хэнийг ч үүнээс ангид болгохгүй. Миний хэлсэн үг тоо томшгүй олон, цаашлаад Миний хийсэн ажил хэмжээлшгүй их. Хүн болгон хийх ёстой зүйлээ төрөлх уг чанар ба уг чанарынхаа хөгжлийн дагуу жам ёсоороо хэрэгжүүлж байгааг Би өдөр бүр ажигладаг. Олон хүн өөрийн мэдэлгүйгээр аль хэдийн “зөв замд” орсон бөгөөд энэ зөв замыг Би төрөл бүрийн хүнийг илчлэхийн тулд барьсан юм. Эдгээр төрөл бүрийн хүнийг Би аль хэдийн өөр өөр орчинд байрлуулсан бөгөөд тэд дор бүрнээ байгаа газраа төрөлх шинж чанараа илэрхийлсэн. Тэднийг хүлж баглах хэн ч байхгүй, тэднийг уруу татах хэн ч байхгүй. Тэд бүрэн эрх чөлөөтэй байдаг бөгөөд тэдний илэрхийлдэг зүйл аяндаа гарч ирдэг. Тэднийг хянадаг цорын ганц зүйл байдаг нь Миний үг юм. Иймээс зарим хүн үхлээс зайлсхийх гэсэндээ л

Миний үгийг дуртай дургүй уншдаг боловч хэзээ ч хэрэгжүүлдэггүй; гэтэл зарим хүний хувьд өөрсдийг нь хангаж, залж чиглүүлэх Миний үг байхгүй бол өдөр хоногийг өнгөрөөх хэцүү байдаг, иймээс тэд угаасаа л Миний үгийг цаг үргэлж зуурч байдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд хүний амьдралын нууц, хүн төрөлхтний хүрэх газар болон хүн байхын үнэ цэнийг олж нээдэг. Миний үгийн өмнө хүн төрөлхтний байгаа байдал ердөө л энэ бөгөөд Би хэрэг явдал бүхнийг зүгээр л жам ёсоор нь явуулдаг. Би үгийг минь оршин тогтнолынхоо үндэс болго гэж хүнийг албадсан ямар ч зүйл хийдэггүй. Иймд, хэзээ ч мөс чанартай байгаагүй, хэзээ ч үнэ цэнтэй оршин тогтнож байгаагүй хүмүүс аливаа зүйл хэрхэн өрнөхийг чимээгүйхэн ажиглаж байгаад дараа нь Миний үгийг зоримгоор хаяж, өөрсдийнхөө дураар аашилдаг. Тэд үнэнийг болон Надаас ирдэг бүхнийг жигшиж эхэлдэг. Түүнчлэн, Миний гэрт байхыг жигшдэг. Энэ хүмүүс үйлчлэл хийж байсан ч гэсэн хүрэх газрынхаа төлөө, мөн шийтгэлээс мултрахын тулд л Миний гэрт түр амьдардаг. Гэвч тэдний санаа зорилго, үйлдэл хэзээ ч өөрчлөгддөггүй. Энэ нь тэдний ерөөл хүсэх хүслийг, мөн хаанчлалд нэг оронгуутаа тэндээ үүрд үлдэж, бүр мөнхийн диваажинд орох хүслийг нь бадраадаг. Миний өдрийг аль болох хурдан ирээсэй гэж хүсэх тусмаа тэд үнэнийг замд нь улам их саад, тээг болж байгааг мэдэрдэг. Тэд үнэнийг эрэлхийлэх юм уу шүүлт, гэсгээлтийг хүлээн авалгүйгээр, хамгийн гол нь Миний гэрт бөхөлзөж, Миний тушааснаар хийх шаардлагагүйгээр тэнгэрийн хаанчлалын ерөөлийг үүрд эдлэхээр хаанчлалд хөл тавихаа тэсэн ядан хүлээж байдаг. Энэ хүмүүс Миний гэрт үнэнийг эрж хайх хүслээ хангах гэж ч ордоггүй, Миний удирдлагатай хамтран ажиллах гэж ч ордоггүй. Тэд зүгээр л ирж буй эрин үед устгагдахгүй байх хүмүүсийн нэг байхыг зорьдог. Иймээс тэдний зүрх сэтгэл үнэн гэж юу болох, үнэнийг яаж хүлээн зөвшөөрөхийг хэзээ ч мэдэж байгаагүй. Энэ хүмүүс үнэнийг хэрэгжүүлж үзээгүй, эсвэл ямар гүн ялзарсан гэдгээ ухамсарлаж байгаагүй мөртөө Миний гэрт “үйлчлэгч”-ийн дүрээр энэ бүх хугацаанд амьдарч байсны шалтгаан энэ юм. Тэд Миний өдөр ирэхийг “тэвчээртэйгээр” хүлээж, Миний ажлын хэв маягийн дагуу ийш тийш шидэгдэж байсан ч цуцдаггүй. Гэвч тэд хэчнээн их хүчин чармайлт гаргаж, ямар ч төлөөс төлсөн байсан хамаагүй, тэднийг үнэний төлөө зовж, Миний төлөө ямар нэгэн юм зориулж байсныг нь хэн ч хэзээ ч харж байгаагүй. Хуучин эрин үеийг төгсгөл болгох өдрийг минь тэд зүрх сэтгэлдээ хүлээж яддаг, түүнчлэн тэд Миний хүч чадал, эрх мэдэл хэр агуу болохыг мэдэхийг асар их хүсдэг. Тэдний хийх гэж хэзээ ч яарч байгаагүй зүйл бол өөрсдийгөө өөрчилж, үнэнийг эрэлхийлэх явдал

юм. Тэд Миний залхдаг зүйлийг хайрлаж, Миний хайрладаг зүйлээс залхдаг. Тэд Миний үзэн яддаг зүйлийг хүсэмжилдэг ч Миний зэвүүцдэг зүйлийг алдахаас айдаг. Тэд энэхүү хорон муу ертөнцөд амьдарч, үүнийгээ хэзээ ч жишдэггүй мөртөө Намайг энэ ертөнцийг устгах вий гэхээс маш их айдаг. Санаа зорилгын зөрчилдөөн дотроо тэд Миний жигшин зэвүүцдэг энэ ертөнцийг хайрладаг атлаа Намайг нэн даруй энэ ертөнцийг устгаасай гэж хүсэн хүлээдэг. Тэгснээр тэд үнэн замаас хазайхаасаа өмнө сүйрлийн зовлонгоос хэлтэрч, дараагийн эрин үеийн эзэд болон хувирах юм байх. Учир нь тэд үнэнийг хайрладаггүй агаад Надаас ирдэг бүхнээс залхсан байдаг. Тэд ерөөлийг алдахгүйн тулд хэсэг зуур “дуулгавартай хүмүүс” болж магадгүй боловч, тэдний ерөөлд шунадаг сэтгэхүй болон шатаж байгаа галт нуурт орж, мөхөхөөс айх айдас хэзээ ч балрахгүй. Миний өдөр ойртох тусам тэдний хүсэл аажмаар эрчээ авсаар байдаг. Гамшиг их байх тусам тэд Намайг баярлуулж, удаан хүсэн хүлээсэн ерөөлөө алдчихгүй байхын тулд хаанаас эхлэхээ мэдэхгүй улам арга мухарддаг. Миний гар ажлаа хийж эхэлмэгц энэ хүмүүс тэргүүн эгнээнд үйлчлэх гэж хүслэн болдог. Тэд Миний нүдэнд өртөхгүй байх вий гэж маш их айн, жагсаалын тэргүүн эгнээнд очих тухай л боддог. Тэд өөрсдийнх нь үйл хэрэг болон үйлдэл хэзээ ч үнэнтэй хамаагүй байсан гэдгийг огт мэдэлгүйгээр өөрсдийнхөө зөв гэж боддог зүйлийг хэлж, хийдэг бөгөөд тэдний үйл хэрэг ердөө л Миний төлөвлөгөөг үймүүлж, саад болж байдаг. Тэд асар их хүчин чармайлт гаргасан, хүнд бэрхийг туулах шийдэмгий зан болон санаа зорилго нь үнэн байж болох ч тэдний хийдэг бүхэн Надтай ямар ч хамаагүй, учир нь тэдний үйлдэл сайн санааны үүднээс гарч байхыг Би хэзээ ч хараагүй, тэр ч байтугай Миний тахилын ширээн дээр ямар нэг юм тавихыг нь Би хараагүй. Энэ олон жилийн турш Миний өмнө тэдний хийсэн үйл хэрэг энэ билээ.

Эхэндээ Би та нарыг илүү их үнэнээр хангахыг хүссэн боловч үнэнд хандах та нарын хандлага хэтэрхий цэвдэг, хайхрамжгүй байсан тул болих хэрэгтэй болсон; Би хүчин чармайлтаа дэмий үрэхийг хүсдэггүй, мөн хүмүүс үгийг минь зуурах атлаа бүх талаар Намайг эсэргүүцэж, гүтгэж, доромжлох зүйл хийж байгааг харахыг ч хүсдэггүй. Хандлага, хүн чанараас чинь болж Би, та нарын хувьд маш чухал үгийнхээ багахан хэсгээр та нарыг хангадаг бөгөөд энэ нь хүн төрөлхтний дундах Миний туршилтын ажил болдог юм. Одоо л Би гаргасан шийдвэр, төлөвлөгөө минь та нарын хэрэгцээнд нийцсэн байгааг үнэхээр баталгаажуулж, цаашлаад хүн төрөлхтөнд хандах Миний хандлага зөв болохыг баталлаа. Миний өмнө гаргасан та нарын олон жилийн зан авир, урьд нь Миний

хэзээ ч хүлээн авч байгаагүй хариултыг Надад өгсөн. Уг хариултын асуулт нь энэ: “Хүн үнэний болоод жинхэнэ Бурханы өмнө ямар хандлагатай байдаг вэ?” Хүнд зориулсан Миний хүчин чармайлт хүнийг хайрлах мөн чанарыг минь баталдаг бөгөөд хүний Миний өмнө хийсэн үйлдэл бүхэн үнэнийг үзэн ядаж, Надтай дайсагнадаг мөн чанарыг нь баталдаг. Намайг дагадаг бүхэнд Би цаг үргэлж санаа тавьдаг боловч Намайг дагадаг хүмүүс хэзээд Миний үгийг хүлээн авах чадваргүй байдаг; тэд бүр Миний өгсөн зөвлөгөөг ч хүлээн авч чаддаггүй. Юу юунаас илүүтэй энэ л Намайг гуниглуулдаг. Миний хандлага чин сэтгэлийнх агаад Миний үг зөөлөн боловч хэн ч, хэзээ ч Намайг ойлгож чадаагүй, түүнчлэн хэн ч Намайг хүлээн авч чадаагүй. Миний даалгасан ажлыг хүн бүр санаандаа нийцүүлэн хийхээр хичээдэг; тэд Миний санаа зорилгыг эрж хайх нь байтугай өөрсдөөс нь юу шаардаж байгааг минь ч асуудаггүй. Тэд байнга л Миний эсрэг тэрсэлдэг хэр нь Надад үнэнчээр үйлчилдэг гэж хэлсээр байдаг. Өөрсдийнх нь хувьд хүлээн авах аргагүй, хэрэгжүүлж чадахгүй үнэн бол үнэн биш гэж олон хүн боддог. Ийм хүмүүсийн хувьд Миний үнэн үгүйсгэгдэж, хаягдах зүйл болдог. Үүний зэрэгцээ хүмүүс Намайг аман дээрээ Бурхан гэж хүлээн зөвшөөрдөг ч үнэн, зам, амь биш, харин гаднын хүн гэж бас боддог. Хэн ч энэ үнэнийг мэддэггүй: Миний үг бол үүрд үл өөрчлөгдөх үнэн юм. Би бол хүний амийн тэжээл бөгөөд хүн төрөлхтний цорын ганц хөтөч билээ. Миний үгийн үнэ цэн болон утга учир нь хүн төрөлхтөнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн эсэхээр бус, харин үгийн өөрийнх нь мөн чанараар тодорхойлогддог. Энэ газар дэлхий дээр Миний үгийг ганц ч хүн хүлээн авахгүй байлаа ч гэсэн Миний үгийн үнэ цэн болон хүн төрөлхтөнд өгөх тусламжийг ямар ч хүн хэмжихийн аргагүй. Иймд Миний үгэнд тэрсэлж, үгийг минь няцаах юм уу, анзаардаггүй олон хүнтэй учрах үедээ Би ийм л хандлагатай байдаг: Цаг хугацаа болон баримтууд Миний гэрч болж, Миний үг бол үнэн, зам, амь юм гэдгийг харуулаг. Миний хэлсэн бүхэн зөв болохыг, энэ нь хүний эзэмших ёстой зүйл гэдгийг, мөн түүнчлэн энэ нь хүний хүлээн авах ёстой зүйл гэдгийг тэдэнд харуулаг. Намайг дагадаг бүх хүнд Би дараах баримтыг мэдэгдэх болно: Миний үгийг бүрэн хүлээн авч чаддаггүй хүмүүс, Миний үгийг хэрэгжүүлж чаддаггүй хүмүүс, Миний үгээс зорилго олж чаддаггүй хүмүүс, Миний үгийн ачаар аврал хүлээн авч чаддаггүй хүмүүс бол Миний үгээр яллагдсан, түүнчлэн Миний авралыг алдсан хүмүүс бөгөөд Миний саваа хэзээ ч тэднээс холдохгүй.

2003 оны 4 дүгээр сарын 16

БУРХАН БОЛ ХҮНИЙ АМИЙН ЭХ СУРВАЛЖ

Чи энэ ертөнцөд дуугаа хадаан мэндэлсэн тэр мөчөөс өөрийн үүргийг биелүүлж эхэлдэг. Бурханы төлөвлөгөө болон Түүний томилгооны төлөө чи үүргээ биелүүлж, амьдралын аянаа эхэлдэг. Чиний яаж өсөж торнисон, урд чинь чамайг ямар аян хүлээж байгаа нь хамаагүй, Тэнгэрийн зохион байгуулалт, зохицуулалтаас хэн ч зайлж чадахгүй бөгөөд хэн ч өөрийн хувь заяаг хянаж чаддаггүй, учир нь бүх зүйлийг захирдаг Тэр л ийм зүйл хийх чадвартай. Хүн төрөлхтөн бий болсон цагаас эхлэн Бурхан хэзээд ийнхүү ажиллаж, орчлон ертөнцийг удирдан, бүх зүйлийн өөрчлөлтийн хуулийг болон шилжилт хөдөлгөөнийг нь чиглүүлж ирсэн билээ. Бүх зүйлийн адилаар хүн Бурханы чихэрлэг амт, бороо, шүүдрээр чимээгүйхэн, өөрийн мэдэлгүй тэжээгддэг; бүх зүйлийн адилаар хүн өөрийн мэдэлгүйгээр Бурханы гарын зохион байгуулалт дор амьдардаг. Хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханы гарт байдаг ба амьдралынх нь бүх зүйлийг Бурханы нүд хардаг. Үүнд итгэх үгүй чинь хамаагүй, амьд ч бай, үхсэн ч бай аливаа бүх зүйл Бурханы бодлын дагуу хувирч, өөрчлөгдөж, шинэчлэгдэн, алга болдог. Энэ бол Бурханы бүх зүйлийг удирддаг арга зам юм.

Шөнийн харанхуй сэмхэн ойртож байхад хүн мэддэггүй, учир нь шөнө хэрхэн нөмөрдгийг ч тэр, хаанаас ирдгийг ч тэр хүний зүрх сэтгэл ухамсарлаж чаддаггүй юм. Шөнө сэмхэн дайжин одоход хүн өдрийн гэрлийг угтан авдаг боловч гэрэл хаанаас ирснийг, шөнийн харанхуйг хэрхэн хөөснийг мэддэг ч үгүй, мэдэрдэг ч үгүй. Ээлжлэн солигдох өдөр, шөнө хүнийг нэг үеэс нөгөөд, түүхийн нэг нөхцөлөөс нөгөөд аваачихын хажуугаар цаг үе болгон дахь Бурханы ажил болон эрин үе бүрд зориулсан Түүний төлөвлөгөөг гүйцэлдүүлж ирсэн. Хүн эдгээр цаг үеийн турш Бурхантай хамт алхаж ирсэн атлаа Бурхан бүх зүйл болон амьд бодгалийн хувь заяаг захирдгийг, мөн Бурхан бүх зүйлийг хэрхэн зохион байгуулж, чиглүүлдгийг мэддэггүй. Балар эртний цаг үеэс өнөөдрийг хүртэл хүн үүнийг ухаараагүй явжээ. Үүний шалтгаан нь, Бурханы үйл хэрэг хэтэрхий нуугдмал байдагт бус, Бурханы төлөвлөгөө биелэх болоогүйдээ ч бус, харин хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханаас хэтэрхий хол байдаг учраас, тиймдээ ч хэдий Бурханыг дагаж байсан ч сатанд үйлчилсээр л байдаг бөгөөд үүнийгээ ч хүртэл мэддэггүйд оршиж байгаа юм. Бурханы мөр болон илрэлтийг хэн ч идэвхийлэн эрж хайдаггүй бөгөөд Бурханы халамж, хамгаалалт дор оршихыг хэн ч хүсдэггүй. Харин оронд нь тэд энэ хорвоо, хорон муу хүн

төрөлхтний дагадаг оршин тогтнолын дүрэмд дасан зохицохын тулд ёрын муу нэгэн болох сатаны муу нөлөөнд түшиглэхийг хүсдэг. Энэ цаг үед хүн зүрх сэтгэл, сүнсээ Сатанд барих өргөл, Сатаны идэш тэжээл болгосон. Тэр ч бүү хэл хүний зүрх сэтгэл, сүнс нь Сатаны орогнож болох газар, зугаацахад тохиромжтой талбар болсон билээ. Тиймээс, хүн байх зарчим, хүний оршин тогтнолын үнэ цэн, утга учрын талаарх ойлголтоо хүн өөрөө ч мэдэлгүй гээдэг. Бурханы хууль, Бурхан, хүн хоёрын гэрээ хүний зүрх сэтгэлд аажмаар бүдгэрч, хүн Бурханыг эрж хайн, Бурханд анхаарал хандуулахаа больдог. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүн Бурхан яагаад өөрийг нь бүтээснийг, түүнчлэн Бурханы амнаас гарч байгаа үг болон Бурханаас гаралтай бүхнийг ч бас ойлгохоо больдог. Дараа нь хүн Бурханы хууль, зарлигийг эсэргүүцэж эхэлдэг ба зүрх сэтгэл, сүнс нь мэдээгүй болдог... Бурхан анх бүтээсэн хүнээ алдаж, хүн анх өөрт нь байсан үндсийг алддаг: Энэ бол энэ хүн төрөлхтний уй гашуу билээ. Чухамдаа гэвэл, бүр эхнээсээ өнөөг хүртэл Бурхан хүн төрөлхтөнд зориулан эмгэнэлт жүжиг тайзнаа тавьсан бөгөөд хүн үүний гол дүр төдийгүй хохирогч нь юм. Тэгээд энэхүү эмгэнэлт жүжгийн найруулагч нь хэн болохыг хэн ч хариулж чаддаггүй.

Ертөнцийн өргөн уудам чөлөөнд ахин дахин, далай тэнгис лаг шаварт идэгдэн хээр тал болж, хээр тал үерлэн далай тэнгис болж хувирсаар байна. Бүх зүйлийн дундах бүхнийг захирдаг Нэгнээс өөр хэн ч энэ хүн төрөлхтнийг удирдаж, замчилж чадахгүй. Энэхүү хүн төрөлхтний төлөө хөдөлмөрлөж, бэлтгэл базаах хүчирхэг нэгэн үгүй бөгөөд энэхүү хүн төрөлхтнийг гэрэл гэгээтэй хүрэх газар луу хөтөлж, хүний ертөнцийн шударга бус байдлаас чөлөөлж чадах нэгэн бүр ч байхгүй. Бурхан хүн төрөлхтний ирээдүйд халаглаж, хүн төрөлхтний уналтад гашуудан, хүн төрөлхтөн доройтол руу, эргэж ирэхээргүй зам руу алхам алхмаар урагшилж байгаад шаналдаг. Бурханы зүрх сэтгэлийг эмтрүүлж, Түүнийг хөсөр хаяад ёрын муу нэгнийг эрж хайж буй энэ хүн төрөлхтөн аль чиглэлд явж буйг хэн ч, хэзээ ч бодож үзээгүй. Ийм учраас л Бурханы уур хилэнг хэн ч мэдэрдэггүй, Бурханы таалалд нийцэх замыг хэн ч эрж хайдаггүй, Бурхантай ойртох гэж хэн ч хичээдэггүй, түүнчлэн Бурханы уй гашуу, шаналлыг ойлгох гэж хэн ч эрж хайдаггүй. Бурханы дуу хоолойг сонссоныхоо дараа ч гэсэн хүн өөрийнхөө замаар үргэлжлүүлэн явж, Бурханаас холдон, Бурханы нигүүлсэл, халамжаас зайлсхийж, Түүний үнэнээс зайлж, Бурханы дайсан болох Сатанд өөрийгөө худалдахыг илүүд үздэг. Хүн зөрүүдэлсэн хэвээр байвал Өөрийг нь эргэж ч харалгүй орхисон энэ хүн

төрөлхтөнд Бурхан хэрхэн хандах тухай хэн бодож үзсэн бэ? Хүний махан бие, сүнс тэсвэрлэшгүй, урьд хожид үзэгдээгүй гай гамшигийг Бурхан гартаа бэлтгээд байгаа учраас л хүн төрөлхтөнд дахин давтан анхааруулж, сануулаад байгааг хэн ч мэддэггүй. Энэхүү гай гамшиг нь дан ганц хүний махан биеийн бус, бас сүнсний шийтгэл байдаг. Чи үүнийг мэдэх хэрэгтэй: Бурханы төлөвлөгөө бүтэлгүйтэж, Түүний анхааруулга, сануулгад хариулахгүй байх үед Бурхан яаж уурсаж, хилэгнэх бол? Энэ нь ямар ч бүтээгдсэн зүйлийн урьд нь мэдэрч, сонсож байсантай адилгүй байх болно. Иймээс энэхүү гай гамшиг нь урьд үзэгдээгүй бөгөөд хэзээ ч давтагдахгүй гэж Би хэлнэ. Учир нь хүн төрөлхтнийг ганц л удаа бүтээж, мөн хүн төрөлхтнийг ганц л удаа аврах нь Бурханы төлөвлөгөө билээ. Энэ бол эхнийх төдийгүй эцсийнх юм. Тиймээс энэ удаад хүн төрөлхтнийг аварч байгаа Бурханы уйгагүй сэтгэл, яарсан хүлээлтийг хэн ч ойлгож чадахгүй.

Бурхан энэ дэлхийг бүтээж, Өөрийн амь хайрласан амьд бодгаль болох хүнийг дэлхийд авчирсан. Дараа нь хүн эцэг эх, төрөл төрөгсөдтэй болж, ганцаар байхаа больсон юм. Хүн энэхүү материаллаг ертөнцийг анх харснаасаа хойш Бурханы тогтоосноор оршин байх заяатай байв. Бурханаас гарсан амийн амьсгал л амьд бодгаль болгоныг өсөж, нас бие гүйцэх хүртэл нь дэмждэг билээ. Энэ явцад, хүн Бурханы халамж дор өсөж байна гэдгийг хэн ч мэдэрдэггүй, харин эцэг эхийнхээ хайр халамж дор өсөж байгаа ба хүний амийн зөн мэдрэмж өсөх үйл явцыг нь чиглүүлдэг хэмээн итгэдэг. Учир нь өөрийнх нь амийг хэн хайрлаж, амь нь хаанаас ирснийг хүн мэддэггүй бөгөөд амийн зөн мэдрэмж хэрхэн гайхамшигийг бүтээдгийг бүр ч мэддэггүй. Хоол хүнс бол амь амьдралынх нь үргэлжлэлийн үндэс, уйгагүй хичээл зүтгэл бол оршин тогтнолынх нь эх сурвалж бөгөөд оюун санаан дахь итгэл нь амь зуулгынх нь үнэт хөрөнгө гэдгийг л хүн мэддэг. Бурханы нигүүлсэл, хангалтыг хүн огт анзаардаггүй, энэ маягаар өөрт нь Бурханы хайрласан амийг дэмий үрдэг... Бурханы өдөр, шөнөгүй халамжилдаг энэхүү хүмүүсээс ганц нь ч Түүнийг шүтэн мөргөх санаачилга гаргадаггүй. Бурхан төлөвлөсөн ёсоороо, ямар ч найдлагагүй хүн дээр үргэлжлүүлэн ажилласаар л байдаг. Нэг л өдөр хүн зүүднээсээ сэрээд амийн үнэ цэн, утга учир, мөн хүнд өгсөн бүхнийхээ төлөө Бурханы төлсөн төлөөс, хүнийг Өөр лүү нь эргээсэй хэмээн хүлээдэг Бурханы яарсан сэтгэлийг гэнэт ухаарна хэмээн Тэр найддаг. Хүний амийн үүсэл ба үргэлжлэлийн нууцуудыг хэн ч, хэзээ ч судалж үзээгүй. Энэ бүхнийг ойлгодог Бурхан л, Өөрөөс нь бүх зүйлийг хүлээн авсан мөртөө талархдаггүй хүний

учруулдаг шаналал, цохилтыг чимээгүйхэн тэвчдэг. Амийн авчирдаг бүхнийг хүн жам ёсны зүйл шиг эдэлдэг ба тийм ч болохоор Бурханаас урваж, Бурханы мартан, Бурханаас сүрдүүлэн авдаг нь “мэдээжийн хэрэг” билээ. Бурханы төлөвлөгөө үнэхээр тийм чухал юм гэж үү? Хүн гэдэг, Бурханы гараас гарсан энэхүү амьд бодгаль үнэхээр тийм чухал юм гэж үү? Бурханы төлөвлөгөө мэдээж чухал; гэвч Бурханы гараар бүтээгдсэн энэхүү амьд бодгаль Түүний төлөвлөгөөний төлөө оршин тогтнодог. Иймд Бурхан энэ хүн төрөлхтнийг үзэн ядсандаа төлөвлөгөөгөө гаргуунд нь гаргачхаж чадахгүй. Бурхан Өөрийн төлөвлөгөө болон Өөрийн гаргасан амьсгалын төлөө, хүний махан бие бус, хүний амийн төлөө л бүх зовлон шаналлыг тэвчдэг билээ. Тэрээр хүний махан биеийг бус, амьсгалсан амиа буцааж авахын тулд л ингэдэг юм. Энэ бол Түүний төлөвлөгөө юм.

Энэ дэлхийд ирсэн хүн бүхэн амьдрал, үхлийг туулах ёстой бөгөөд тэдний ихэнх нь үхэл, дахин төрөлтийн мөчлөгөөр дамжин өнгөрсөн. Амьдарч байгаа нь удахгүй үхэж, үхсэн нь удахгүй эргэн ирнэ. Энэ бүхэн нь амьд бодгаль болгонд зориулан Бурханы зохицуулсан амийн замнал билээ. Гэвч энэхүү замнал, энэ мөчлөг бол Бурханы хүнд яг харуулахыг хүссэн үнэн юм: Бурханы хүнд хайрласан амь хязгааргүй бөгөөд махан бие, цаг хугацаа, орон зайд баригддаггүй. Энэ бол Бурханы хүнд хайрласан амийн нууц бөгөөд амь Түүнээс ирсэн гэдгийн нотолгоо билээ. Хүний амь Бурханаас ирсэн гэдэгт олон хүн итгэдэггүй байж болох ч Түүний оршин тогтнолд итгэдэг ч бай, үгүйсгэдэг ч бай ялгаагүй, Бурханаас ирдэг бүхнийг хүн зайлшгүй эдэлдэг. Хэрвээ нэг өдөр Бурхан гэнэт бодлоо өөрчилж, дэлхий дээр оршдог бүхнийг эргүүлэн авахыг хүсэж, өгсөн амиа буцаан авбал бүх зүйл үгүй болно. Бурхан өөрийн амиар амьтай, амьгүй бүх зүйлийг хангаж; Өөрийн агуу хүч, эрх мэдлээр бүхнийг дэг журамтай байлгадаг. Энэ бол хэний ч төсөөлж, ойлгож чадахгүй үнэн бөгөөд эдгээр ойлгох аргагүй үнэн бол Бурханы амийн хүчний яг жинхэнэ илрэл, гэрчлэл билээ. Одоо Би чамд нэг нууц хэлье: Бурханы амийн агуу байдал болон Түүний амийн хүч чадлыг ямар ч бүтээл ойлгох аргагүй. Одоо ийм байгаа, урьд нь ийм байсан, мөн хожим ч тийм байх болно. Миний хуваалцах хоёр дахь нууц бол энэ: Бүх бүтээгдсэн зүйлийн хувьд амийн хэлбэр, бүтцээрээ хэчнээн өөр байсан ч хамаагүй, амийн эх сурвалж нь Бурханаас ирдэг; чи ямар ч төрлийн амьд бодгаль байсан ялгаагүй Бурханы тогтоосон амийн замыг зөрчиж чадахгүй. Ямартай ч хүн үүнийг ойлгоосой гэж л Би хүсдэг: Бурханы халамж, хамгаалалт, хангалтгүйгээр хүн хэчнээн шаргуу зүтгэж, хэчнээн хүч гарган

тэмцлээ ч гэсэн хүлээн авах учиртай бүхнээ хүлээн авч чадахгүй. Бурханы амийн хангалтгүйгээр хүн амьдрахын үнэ цэн, амийн утга учрыг алддаг. Амийнх нь үнэ цэнийг дэмий үрдэг хүний ийм санаа амар байдлыг Бурхан яаж зөвшөөрч чадах юм бэ? Өмнө нь Миний хэлсэнчлэн, Бурхан бол чиний амийн эх сурвалж гэдгийг бүү март. Хэрвээ хүн Бурханы хайрласан бүхнийг нандигнаж чадахгүй бол Бурхан анх өгсөн зүйлээ эргүүлэн аваад зогсохгүй, Өөрийнхөө өгсөн бүхний үнийг хүнээр хоёр нугалан төлүүлнэ.

2003 оны 5 дугаар сарын 26

ТӨГС ХҮЧИТИЙН САНАА АЛДАЛТ

Чи гэрэлгүй ертөнцөд амьдарсаар ирсэн тул чиний зүрх сэтгэлд асар том нууц байгааг хэзээ ч анзаарч байгаагүй. Зүрх сэтгэл, сүнсийг чинь муу ёрын нэгэн булаан авчихсан. Нүд чинь харанхуйд халхлагдаад тэнгэрийн нарыг ч, шөнийн огторгуйд анивчих тэр одыг ч харж чаддаггүй. Чих чинь худал хуурмаг үгээр дүүрээд Еховагийн нүргэлсэн дуу хоолойг ч, сэнтийгээс урсах их усны чимээг ч сонсдоггүй. Өөрт байх ёстой бүхнээ, Төгс Хүчитийн хайрласан бүхнийг чи алдчихсан. Чи өөрийгөө аврах хүч чадалгүй, амьд гарах найдлагагүйгээр эцэс төгсгөлгүй зовлонгийн далайд орчхоод тэмцэж, сандрахаас өөрийг хийдэггүй... Тэр мөчөөс эхлээд чи ёрын муу нэгэнд хорлогдож, Төгс Хүчитийн ерөөлөөс холдож, Төгс Хүчитийн хангалтаас салж, эргэж буцалтгүй замаар алхах тавилантай болсон. Сая дуудлага ч зүрх сэтгэл, сүнсийг чинь сэрээж бараг чадахгүй. Чамайг зүг чиггүй, замын тэмдэггүй эх захгүй ертөнцөд уруу татаж оруулсан ёрын муу нэгний гарт чи дугжирдаг. Энэ үеэс хойш чи анхдагч гэм зэмгүй, цэвэр байдлаа алдаж, Төгс Хүчитийн халамжаас зайлсхийж эхэлсэн. Ёрын муу нэгэн чиний зүрх сэтгэлд бүх хэрэг явдлыг залж чиглүүлэн, чиний амь болсон. Чи түүнээс айж, зайлсхийж, түүнд эргэлзэхээ больсон; харин ч зүрх сэтгэлдээ түүнийг Бурхан мэт үздэг. Чи түүнийг тахиж, шүтэж эхэлсэн бөгөөд та хоёр бие, сүүдэр хоёр шиг салшгүй болж, хамт амьдарч, үхнэ гэж амлажээ. Чи хаанаас ирсэн, яагаад төрсөн, яагаад үхэхээ огт мэддэггүй. Чи Төгс Хүчитийг танихгүй нэгэн мэтээр хардаг; чи Түүний гарал үүслийг мэддэггүй, чиний төлөө хийсэн бүхнийг нь бүр ч мэддэггүй. Түүнээс ирдэг бүхэнд чи хорсох болсон; үүнийг нь нандигнадаггүй, үнэ цэнийг нь ч мэддэггүй. Төгс Хүчитийн хангалтыг хүлээн авсан өдрөөсөө эхлээд чи муу ёрын нэгний хажууд алхдаг. Чи муу ёрын нэгний хамтаар олон мянган жил ширүүн бороо, догшин шуургыг туулсан бөгөөд

амийн чинь эх сурвалж байсан Бурханы эсрэг түүнтэй хамт зогсдог. Чи гэмшлийн талаар юу ч мэддэггүй, мөхлийн ирмэгт ирсэн гэдгээ бүр ч мэддэггүй. Муу ёрын нэгэн чамайг уруу татаж, зовоосон гэдгийг чи мартчихаж; эхэн үеэ чи мартчихжээ. Муу ёрын нэгэн өнөөдрийг хүртэл чамайг ингэж алхам алхмаар зовоожээ. Зүрх сэтгэл, сүнс чинь мэдээ алдаж, доройтсон. Чи хүний ертөнцийн гаслан зовлонгийн талаар гомдоллохоо больсон; дэлхий ертөнц бол шударга бус гэж бодохоо ч больсон. Төгс Хүчит оршин байдаг эсэхийг бүр ч тоодоггүй. Яагаад гэвэл, чи муу ёрын нэгнийг аль хэдийн жинхэнэ эцгээ гэж үзчихээд түүнээс хагацаж чаддаггүй. Энэ бол зүрх сэтгэлийн чинь доторх нууц юм.

Үүр цайхад үүрийн цолмон зүүн зүгт гялалзаж эхэлдэг. Энэ бол урьд нь хэзээ ч байгаагүй од бөгөөд тайван амгалан, сүүмэлзсэн тэнгэрийг гэрэлтүүлж, хүмүүсийн зүрх сэтгэл дэх бөхсөн гэрлийг дахин асаадаг. Энэхүү гэрлийн ачаар хүмүүс ганцаардахаа больж, энэ нь чам дээр ч, бусад дээр ч адилхан тусдаг. Гэсэн ч чи ганцаараа харанхуй шөнө бөх унтсаар үлддэг. Чи ямар ч чимээ сонсдоггүй, ямар ч гэрэл хардаггүй; шинэ тэнгэр газар, шинэ эрин үе ирснийг мэддэггүй, учир нь эцэг чинь чамд “Үр минь, битгий бос, бас л эрт байна. Цаг агаар хүйтэн байгаа болохоор гадаа бүү гар, илд, жад нүдийг чинь сүлбэх вий” гэж хэлдэг. Чи эцгийнхээ сануулгад л итгэдэг, учир нь эцэг чинь чамаас ахмад, мөн чамайг ихэд хайрладаг болохоор чи гагцхүү эцгийн чинь зөв гэдэгт итгэдэг. Ийм сануулга, ийм хайр нь дэлхий ертөнцөд гэрэл байдаг хэмээх домогт итгэхийг чинь болиулдаг; энэ дэлхийд үнэн оршсоор байдаг эсэхийг хайхрахгүй болгодог. Чи Төгс Хүчитээр авруулна гэж горьдож зүрхлэхээ больдог. Чи байгаа байдалдаа сэтгэл ханаж, гэрэл гарч ирэхийг хүлээхээ больж, домогт өгүүлсэнчлэн Төгс Хүчитийн залран ирэхийг харуулдан хүлээхээ больдог. Чиний хувьд гэвэл, үзэсгэлэнтэй сайхан бүхэн дахин сэргэж, оршин тогтнох боломжгүй. Чиний нүдээр бол хүн төрөлхтний маргааш, хүн төрөлхтний ирээдүй зүгээр л үгүй болж, ор мөргүй арилдаг. Чи эцгийнхээ хувцаснаас бүх чадлаараа зуурч, бэрхшээл зовлонг нь хуваалцахад бэлэн байж, замын ханиа болон алсын аяныхаа зүг чигийг алдахаас ихэд айдаг. Өргөн уудам агаад будант хүний ертөнц энэ дэлхийн өөр өөр үүргийг туйлбартай, аймшиггүйгээр биелүүлдэг та нарыг олноор бий болгожээ. Үхлээс огт айдаггүй олон “дайчныг” бүтээжээ. Түүнээс гадна, энэ нь бүтээлийнхээ зорилгыг мэддэггүй, мэдээ алдаж, саажсан хүмүүсийг бөөн бөөнөөр нь бий болгосон юм. Төгс Хүчитийн нүд гүнээ шаналсан хүн нэг бүрийг хардаг. Зовж байгаа хүмүүсийн уйлааныг Тэр сонсож, зовлонд нэрвэгдсэн хүмүүсийн ичгүүргүй байдлыг харж, авралын нигүүлслийг алдсан

хүн төрөлхтний аргаа барсан байдал, айдас хүйдсийг мэдэрдэг. Хүн төрөлхтөн Түүний халамжаас татгалзаж, өөрсдийнхөө замаар алхахаар сонгож, Түүний нүдний ажиглалтаас бултахаар оролдож, дайсантай хамт гүн тэнгисийн гашуун амтыг эцсийн ганц дуслыг нь хүртэл амтлахыг илүүд үздэг. Төгс Хүчитийн санаа алдалт хүнд сонсогдохоо больсон; Төгс Хүчитийн гар энэхүү эмгэнэлт хүмүүсийг илбэхийг хүсэхээ больсон. Тэрээр удаа дараа буцаан барьж аваад, удаа дараа дахиад л алддаг, Түүний хийдэг ажил ийнхүү давтагддаг. Тухайн мөчөөс эхлээд Тэр ядарч, залхаж эхэлдэг тул хийж буй ажлаа зогсоож, хүн төрөлхтний дунд алхахаа больдог... Хүн эдгээр өөрчлөлтийн алийг нь ч огт мэддэггүй, Төгс Хүчитийн ирж, явж байгааг, мөн Түүний уйтгар гуниг, гансралыг мэддэггүй.

Энэ ертөнцийн бүх зүйл Төгс Хүчитийн бодлын дагуу, Түүний нүдэн дор хурдан өөрчлөгддөг. Хүн төрөлхтний хэзээ ч сонсож байгаагүй зүйлс гэнэтхэн ирж байхад хүн төрөлхтний эртнээс эзэмшсэн зүйлс мэдэгдэлгүйгээр алга болдог. Төгс Хүчитийн хаана байдгийг хэн ч ухаан ойлгож чаддаггүй, Төгс Хүчитийн амийн хүчний ер бусын, агуу байдлыг мэдэрч бүр ч чаддаггүй. Хүмүүсийн ухамсарлаж чадахгүй зүйлийг ухамсарлаж чаддаг болохоороо Тэр ер бусын байдаг. Хүн төрөлхтөнд орхигдсон атлаа хүн төрөлхтнийг авардаг Нэгэн болохоороо Тэр агуу байдаг. Тэрээр амьдрал, үхлийн утга учрыг мэддэг, үүнээс гадна, бүтээгдсэн хүн төрөлхтний дагах ёстой оршин тогтнолын хуулийг мэддэг. Тэр бол хүн төрөлхтний оршин тогтнолын суурь, Тэр бол хүн төрөлхтнийг дахин амилуулдаг Золин аврагч юм. Тэрээр Өөрийн ажлын төлөө, Өөрийн төлөвлөгөөний төлөө аз жаргалтай зүрх сэтгэлийг уй гашуугаар дарж, уй гашуутай зүрх сэтгэлийг аз жаргалтай болгодог.

Төгс Хүчитийн амийн хангалтаас холдсон хүмүүс оршин тогтнолын зорилгыг мэддэггүй хэдий боловч үхлээс эмээдэг. Тэд тусламж, дэмжлэггүй байдаг атлаа нүдээ анх дургүй хэвээр бөгөөд энэ дэлхий дээр өөрийн сүнсийг мэдэрдэггүй махан биед өөдгүйгээр оршин тогтнохын тулд өөрсдийгөө хатамжилдаг. Чи ийм маягаар итгэл найдваргүй, тэр ч тийм маягаар зорилгогүй амьдардаг. Зовлонгийнхоо дунд ёолон, Өөрийнх нь ирэхийг цөхрөнгөө баран хүсэн хүлээж байгаа хүмүүсийг үлгэр домгийн Ариун Нэгэн л аварна. Одоог хүртэл, ухаан алдсан хүмүүст ийм итгэл биеллээ олоогүй. Гэсэн ч хүмүүс ингэж хүсэн эрмэлзсээр байдаг. Гүнээ зовсон энэ хүмүүсийг Төгс Хүчит Нэгэн өршөөдөг; үүний зэрэгцээ, хүмүүсийн хариултыг хэтэрхий удаан хүлээх ёстой байсан тул ухаан алдсан энэ хүмүүсээс Тэр залхсан. Тэр эрж хайхыг хүсдэг, зүрх сэтгэл, сүнсийг чинь эрж хайн, чамайг цаашдаа өлсөж, цангахгүй байгаасай гэсэндээ

чамд ус, хоол хүнс авчирч, чамайг сэрээхийг хүсдэг. Эцэж ядран, энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна. Тэр хажууд чинь чамайг ажиглаж, эргэж буцахыг чинь хүлээж байгаа. Бурханаас ирсэн гэдгээ, мөн хэдийд ч юм зүг чигээ алдаж, хэдийд ч юм замдаа ухаан балартаж, хэдийд ч юм “эцэгтэй” болсон гэдгээ ухаарахыг чинь; түүнчлэн Төгс Хүчит үргэлж ажиглаж, эргэн ирэхийг чинь маш урт удаан хугацаанд хүлээж байсан гэдгийг ухааран, гэнэтхэн ой санамжаа сэргээх өдрийг чинь Тэр хүлээж байна. Тэрээр цөхөрсөн мөрөөсөлтэйгөөр ажигласаар, хариултгүй хариуг хүлээсээр ирсэн. Түүний ажиглалт, хүлээлт үнэлж баршгүй бөгөөд энэ нь хүний зүрх сэтгэл, сүнсний төлөө байдаг. Энэхүү ажиглалт, хүлээлт тодорхой бус хугацаатай байж магадгүй, мөн төгсгөлдөө хүрсэн байж ч магадгүй. Гэхдээ зүрх сэтгэл болон сүнс чинь яг одоо хаана байгааг чи мэдэх ёстой.

2003 оны 5 дугаар сарын 28

БУРХАНЫ ИЛРЭЛТ ШИНЭ ЭРИН ҮЕИЙГ АВЧИРСАН

Бурханы удирдлагын зургаан мянган жилийн төлөвлөгөө дуусаж байгаа бөгөөд Түүний илрэлтийг эрж хайдаг бүхэнд хаанчлалын үүд хаалга аль хэдийн нээгдээд байна. Хүндэт ах эгч нар аа, та бүхэн юу хүлээгээ вэ? Юу эрж хайгаа вэ? Бурханыг илрэхийг хүлээж байгаа юм уу? Түүний мөрийг хайж байна уу? Бурханы илрэлтийг хэчнээн их хүсэн хүлээдэг билээ! Бурханы мөрийг олох хэчнээн хэцүү билээ! Ийм эрин үед, ийм дэлхий ертөнцөд Бурханы илрэх өдрийг нүдээр үзэхийн тулд бид яах ёстой вэ? Бурханы мөртэй хөл нийлүүлэхийн тулд юу хийх ёстой вэ? Ийм төрлийн асуултууд Бурханыг илрэхийг хүлээж байгаа бүх хүнд тулгардаг. Та бүхэн эдгээрийг нэг бус удаа бодож үзсэн, гэхдээ үр дүн нь юу байв? Бурхан хаана илэрдэг юм бэ? Бурханы мөр хаа байгаа юм бэ? Хариултыг нь та нар олсон уу? “Бурхан Өөрийг нь дагадаг бүх хүний дунд гарч ирдэг, Түүний мөр бидний дунд байдаг; Ийм л энгийн!” гэж олон хүн хариулна; Улиг болсон хариултыг хэн ч өгч чадна, гэхдээ Бурханы илрэлт болон Түүний мөр гэдэг нь юу гэсэн утгатайг та нар ойлгодог уу? Бурханы илрэлт гэдэг нь Тэр газар дэлхий дээр ажлаа хийхээр Өөрөө биечлэн ирэхийг хэлдэг. Тэрээр эрин үеийг эхлүүлж, эрин үеийг төгсгөх ажил явуулахын тулд Өөрийн ялгамж чанар, зан чанартайгаар, мөн Өөрийн төрөлх арга замаар хүн төрөлхтний дунд буудаг. Энэ төрлийн илрэлт нь нэг төрлийн ёслол биш юм. Энэ бол тэмдэг, дүр зураг,

гайхамшиг, ямарваа агуу үзэгдэл биш, нэг төрлийн шашны зан үйл ч биш. Энэ бол хэний ч харж, хүрч болох жинхэнэ, бодит баримт билээ. Энэ төрлийн илрэлт нь ёс төдий зүйл хийхийн төлөө, эсвэл богино хугацааны даалгаврын төлөө байдаггүй; харин Түүний удирдлагын төлөвлөгөөний ажлын нэг үе шатны төлөө байдаг. Бурханы илрэлт нь үргэлж утга учиртай байдаг бөгөөд Түүний удирдлагын төлөвлөгөөтэй ямар нэг байдлаар үргэлж холбоотой байдаг. Энд буй илрэлт гээч нь Бурхан хүнийг залж, чиглүүлж, гэгээрүүлдэг төрлийн “илрэлт”-ээс тэс өөр юм. Бурхан Өөрийгөө илчлэх бүрдээ агуу ажлын нэг алхмыг хийдэг. Энэ ажил нь өөр ямар ч эрин үеийн ажлаас өөр билээ. Энэ нь хүний ухаан санаанд багтамгүй ба хүн үүнийг хэзээ ч туулж байгаагүй. Энэ бол шинэ эрин үеийг эхлүүлж, хуучин эрин үеийг төгсгөдөг ажил бөгөөд хүн төрөлхтнийг аврахын төлөө шинэчилж, сайжруулсан ажлын нэг хэлбэр юм; түүнчлэн энэ нь хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү аваачдаг ажил билээ. Энэ бол Бурханы илрэлтийн утга учир юм.

Та нар Бурханы илрэлт гэж юу болохыг ойлгомогцоо Бурханы мөрийг хэрхэн эрж хайх ёстой вэ? Энэ асуултыг тайлбарлахад хэцүү биш: Бурханы илрэлт хаа байна, мөрийг нь тэндээс олох болно. Ийм тайлбар ядах юмгүй сонсогдож болох ч хэрэгжүүлэхэд төдий л амаргүй байдаг, учир нь Бурханыг хаана гарч ирдгийг олон хүн мэддэггүй, Тэр хаана илрэхийг хүсэж байгааг, эсвэл хаана илрэх ёстойг бүр ч мэддэггүй. Ариун Сүнс хаа ажиллаж байна, тэнд Бурхан илэрдэг гэж зарим нь ойворгоноор итгэдэг. Эсвэл сүнслэг хүмүүс хаа байна, тэнд Бурхан илэрдэг гэж итгэдэг. Эсвэл алдар нэртэй хүмүүс хаа байна, тэнд Бурхан илэрдэг гэж итгэдэг. Ийм итгэл нь зөв, буруу эсэхийг түр хойш тавья. Ийм асуултыг тайлбарлахын тулд бидний зорилго эхлээд тодорхой байх ёстой: Бид Бурханы мөрийг хайж байгаа. Сүнслэг хүмүүсийг эрж хайгаагүй, алдар нэртэй хүмүүсийг бүр ч эрэлхийлээгүй байна; Бурханы мөрийг бид эрэлхийлж байна. Ийм учраас, бид Бурханы мөрийг хайж байгаа тул Бурханы хүсэл, Бурханы үг, айлдварыг хайх нь зохистой—учир нь Бурхан хаана шинэ үгээ хэлнэ, Бурханы дуу хоолой тэнд байх бөгөөд Бурханы мөр хаа байна, Бурханы үйл хэрэг тэнд байдаг. Бурханы илэрхийлэл хаа байна, тэнд Бурхан илэрдэг, Бурхан хаана илэрнэ, тэнд үнэн, зам, амь оршдог. Та нар Бурханы мөрийг эрж хайхдаа “Бурхан бол үнэн, зам, амь” гэх үгийг үл тоомсорлосон. Иймээс олон хүн үнэнийг хүлээн авах үедээ ч гэсэн Бурханы мөрийг олсон гэдэгтээ итгэдэггүй бөгөөд Бурханы илрэлтийг бүр ч хүлээн зөвшөөрдөггүй. Ямар ноцтой алдаа гээч! Бурханы илрэлтийг хүний үзэлд нийцүүлэх боломжгүй, Бурхан хүний

хүсэлтээр гарч ирэх бүр ч боломжгүй. Бурхан ажлаа хийх үедээ Өөрөө сонголтоо хийж, төлөвлөгөөгөө Өөрөө гаргадаг; түүнчлэн Өөрийн гэсэн зорилго, арга барилтай байдаг. Тэрээр ямар ч ажил хийлээ гэсэн энэ тухай хүнтэй хэлэлцэж, хүний зөвлөгөөг эрж хайх шаардлагагүй, мөн хүн нэг бүрд ажлынхаа талаар мэдэгдэх шаардлага ч байхгүй. Энэ бол хүн бүрийн мэдэх ёстой Бурханы зан чанар юм. Та нар Бурханы илрэлтийг нүдээр үзэж, Бурханы мөрийг дагая гэвэл эхлээд өөрсдийнхөө үзлээс холдох ёстой. Та нар Бурханаас ингэ, тэг гэж шаардах ёсгүй, Түүнийг өөрийнхөө баригдмал сэтгэлгээнд хорьж, үзлээрээ хязгаарлах ч ёсгүй. Харин та нар Бурханы мөрийг хэрхэн хайх ёстой, Бурханы илрэлтийг хэрхэн хүлээн авах ёстой, Бурханы шинэ ажилд хэрхэн захирагдах ёстой талаар өөрсдөөсөө асуух хэрэгтэй; хүний хийх ёстой зүйл бол энэ. Хүн бол үнэн биш, мөн үнэнийг эзэмшдэггүй тул эрж хайж, хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагах ёстой.

Чи америк, британи, өөр аль ч үндэстэн бай хамаагүй, өөрийнхөө үндэс угсааны баригдмал байдлаас гарч, өөрийгөө даван, бүтээгдсэн зүйлийн байр сууринаас Бурханы ажлыг харах хэрэгтэй. Ингэснээр чи Бурханы мөрөнд хязгаарлалт тогтоохгүй. Учир нь одоо цагт олон хүн Бурханыг тодорхой нэг улс үндэстэнд, тодорхой нэг ард түмний дунд гарч ирэх боломжгүй гэж үздэг. Бурханы ажлын ач холбогдол хэчнээн гүн гүнзгий, Бурханы илрэлт хэчнээн чухал билээ! Хүний үзэл, бодол тэдгээрийг яаж хэмжиж чадах билээ? Иймээс чи Бурханы илрэлтийг эрж хайхын тулд үндэс угсааныхаа үзлийг эвдэх ёстой гэж Би хэлдэг. Ингэснээр л чи өөрийн үзлээр хязгаарлагдахгүй; ингэснээр л чи Бурханы илрэлтийг угтан авахад тэнцэнэ. Эс бөгөөс мөнхийн харанхуйд үлдэж, Бурханы сайшаалыг хэзээ ч олж авахгүй.

Бурхан бол бүхий л хүн төрөлхтний Бурхан юм. Тэрээр Өөрийгөө ямар ч улс үндэстэн, ард түмний хувийн өмч гэж үздэггүй, харин ямар нэг хэлбэр, улс үндэстэн, ард түмэнд хязгаарлагдахгүйгээр, Өөрийн төлөвлөснөөр ажлаа явуулдаг. Чи магад энэ хэлбэрийг хэзээ ч төсөөлөөгүй байх, эсвэл энэ хэлбэрт үгүйсгэх хандлагаар ханддаг байх, эсвэл Бурханы Өөрийгөө илчилдэг улс үндэстэн, ард түмэн нь хүн болгонд ялгаварлан гадуурхагддаг, газар дэлхий дээр хамгийн хоцрогдмол байж таардаг байх. Гэвч Бурханд Өөрийн мэргэн ухаан гэж бий. Тэрээр Өөрийн агуу их хүч чадал болон үнэн, зан чанараараа дамжуулан Өөртэй нь нэг санаатай, Өөрийнхөө бүрэн төгс болгохыг хүссэн бүлэг хүмүүсийг үнэнхүү олж авсан—бүх төрлийн шалгалт, гай гамшиг болон бүх төрлийн хавчлагыг туулж, Түүгээр байлдан дагуулагдсан бүлэг Түүнийг

эцсээ хүртэл дагаж чаддаг. Ямар нэг хэлбэр, улс үндэстэнд хязгаарлагддаггүй Бурханы илрэлтийн зорилго нь ажлыг төлөвлөснөөрөө гүйцэлдүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Бурхан Иудейд махбод болох үедээ бүхий л хүн төрөлхтнийг золин аврах цовдлолын ажлыг гүйцэлдүүлэх зорилготой байсантай энэ нь яг адилхан. Гэвч Бурхан ийм зүйл хийх боломжгүй гэж иудейчүүд итгэсэн бөгөөд Бурхан махбод болж, Эзэн Есүсийн дүрээр гарч ирэх боломжгүй гэж бодсон юм. Тэдний “боломжгүй” гэдэг нь Бурханыг яллаж, эсэргүүцэх үндэслэл нь болж, эцэстээ Израилыг сүйрэлд хүргэсэн. Өнөөдөр олон хүн үүнтэй төстэй алдаа гаргажээ. Тэд Бурханы илрэлт айсуу гэж бүх чадлаараа тунхагладаг атлаа бас хажуугаар нь Түүний илрэлтийг ялладаг; “боломжгүй” гэх итгэлээрээ тэд Бурханы илрэлтийг дахин нэг удаа баригдмал төсөөлөл дотроо хязгаарладаг. Иймээс Бурханы үгтэй тулгарсныхаа дараа тачигнатал инээд алдах олон хүнийг Би харж байсан. Гэтэл энэ инээд иудейчүүдийн яллалт, доромжлолоос ер нь ялгаатай гэж үү? Та нар үнэний дэргэд хүндлэлгүй загнадаг, хүсэл тэмүүлэлтэй хандлага та нараас бүр ч гардаггүй. Та нар зүгээр л хайнга судалчхаад, санаа амар жаргалтай хүлээж суудаг. Ингэж шинжиж, хүлээснээр юу олж авч чадах юм бэ? Бурханы хувийн удирдамжийг хүлээн авч чадна гэж бодоо юу? Бурханы айлдварыг ялган таньж чадахгүй юм бол чи Бурханы илрэлтийг нүдээр үзэхэд яаж тэнцэх юм бэ? Бурхан хаана илэрнэ, тэнд үнэн илэрхийлэгдэж, Бурханы дуу хоолой тэнд байх болно. Үнэнийг хүлээн зөвшөөрч чаддаг хүмүүс л Бурханы дуу хоолойг сонсож чадах бөгөөд ийм хүмүүс л Бурханы илрэлтийг нүдээр үзэхэд тэнцдэг. Үзлээ хая! Тайван байж, эдгээр үгийг анхааралтай унш. Үнэнийг хүсэн хүлээдэг бол чамайг Бурхан гэгээрүүлэх бөгөөд Түүний хүсэл, Түүний үгийг чи ойлгох болно. “Боломжгүй” гэсэн бодлоо хая! Хүмүүс аливааг боломжгүй гэж итгэх тусам энэ нь болох магадлал өндөртэй байдаг, учир нь Бурханы мэргэн ухаан тэнгэрүүдээс ч дээгүүр халин нисдэг, Бурханы бодол хүний бодлоос дээгүүр бөгөөд Бурханы ажил хүний бодол, үзлийн хил хязгаарыг давдаг. Ямарваа зүйл хэдий чинээ боломжгүй байна, эрж хайж болох төдий чинээ их үнэн үүнд байдаг; ямарваа зүйл хэдий чинээ хүний үзэл, төсөөллөөс гадна оршино, Бурханы хүсэл тэнд бүр ч их агуулагдаж байдаг. Учир нь, Өөрийгөө хаана ч илчиллээ гэсэн Бурхан бол Бурхан хэвээр байдаг бөгөөд илрэлтийнх нь байршил, хэв маягаас үүдэн Түүний мөн чанар хэзээ ч өөрчлөгдөхгүй. Мөр нь хаана байгаагаас үл хамааран Бурханы зан чанар нэг янзаараа байдаг, мөр нь хаа ч байлаа гэсэн Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан. Яг л Эзэн Есүс бол зөвхөн израилчуудын Бурхан бус, Ази, Европ, Америкийн

бүх хүний Бурхан төдийгүй, бүхий л орчлон дахь цорын ганц Бурхан гэдэгтэй энэ нь адил билээ. Иймд Бурханы айлдвараас Түүний хүслийг эрж хайж, илрэлтийг нь олж мэдэж, Түүний мөртэй хөл нийлүүлцгээе! Бурхан бол үнэн, зам, амь билээ. Түүний үг, илрэлт зэрэгцэн оршдог бөгөөд Түүний зан чанар болон мөр хүн төрөлхтөнд цаг үргэлж нээлттэй байдаг. Хүндэт ах эгч нар аа, та нар эдгээр үгээс Бурханы илрэлтийг харж, шинэ эрин үе рүү алхахдаа Түүний мөрийг дагаж эхлэн, илрэлтийг нь хүлээдэг хүмүүст зориулан Бурханы бэлдсэн үзэсгэлэнтэй сайхан шинэ тэнгэр, газарт орж чадна гэж Би найдаж байна!

БҮХ ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХУВЬ ЗАЯАГ БУРХАН ЗАХИРДАГ

Хүн төрөлхтний гишүүд ба үнэн сүсэгт Христэд итгэгчид болохын хувьд өөрсдийн оюун санаа, бие махбодыг Бурханы даалгаврыг биелүүлэхэд зориулах нь бид бүгдийн үүрэг, хариуцлага юм. Учир нь бидний бүх оршихуй Бурханаас ирсэн бөгөөд Бурханы дээд эрхийн ачаар оршдог билээ. Хэрвээ оюун санаа, бие махбод маань Бурханы даалгавар болон хүн төрөлхтний зөв шударга үйл хэргийн төлөө зориулагдахгүй бол бидний сүнс Бурханы даалгаврын төлөө амиа золиосолсон хүмүүсээс, тэр тусмаа биднийг бүх зүйлээр хангасан Бурханаас ичнэ.

Бурхан энэ ертөнцийг бүтээсэн, энэ хүн төрөлхтнийг бүтээсэн, түүнчлэн эртний Грекийн соёл, хүний соёл иргэншлийн зохион бүтээгч нь Тэр байсан. Бурхан л энэ хүн төрөлхтнийг тайтгаруулж, Бурхан л энэ хүн төрөлхтөнд өдөр, шөнөгүй санаа тавьдаг. Хүн төрөлхтний хөгжил, дэвшил нь Бурханы дээд эрхээс салшгүй, хүний түүх болон ирээдүй Бурханы зохиомжоос салшгүй билээ. Хэрвээ чи жинхэнэ Христэд итгэгч бол аливаа улс, үндэстний мандаж, доройтох нь Бурханы зохиомжийн дагуу явагддаг гэдэгт лавтай итгэнэ. Бурхан л ганцаараа аливаа улс, үндэстний хувь заяаг мэддэг ба Бурхан ганцаараа энэ хүн төрөлхтний амьдралын замналыг хянадаг. Хэрвээ хүн төрөлхтөн сайн хувь заяатай байхыг хүсвэл, хэрвээ улс орон сайн хувь заяа хүсэж байвал хүн Бурханыг шүтэн мөргөж, Бурханы өмнө гэмшиж, нүглээ улайх ёстой, эс бөгөөс хүний хувь заяа, хүрэх газар гамшиг сүйрлээр дуусах нь гарцаагүй.

Ноагийн бүхээг барьсан цаг үеийг эргэн хар: Хүн төрөлхтөн гүн ялзарсан, Бурханы ерөөлийн замаас гажиж, Бурханаар халамжлуулахаа больсон, Бурханы амлалтыг алдчихсан байсан. Тэд Бурханы гэрэлгүйгээр харанхуйд

амьдарч байв. Тиймээс тэд садар самуун уг чанартай болж, жигшүүрт доройтолд өөрсдийгөө хаясан байв. Тийм хүмүүс Бурханы амлалтыг хүлээж авч чадахааргүй болсон; тэд Бурханы нүүрийг харахад ч, Бурханы дуу хоолойг сонсоход ч тохирохгүй байлаа. Учир нь тэд Бурханыг хаяж, Түүний хайрласан бүх зүйлийг орхиж, Бурханы сургаалыг мартчихсан байсан юм. Тэдний зүрх сэтгэл Бурханаас улам бүр холдсоноор тэд хамаг эрүүл ухаан, хүн чанараа алдан доройтож, улам ёрын муу болсон юм. Тиймээс тэд үхэл рүүгээ бүр ч ойртож, Бурханы уур хилэн, шийтгэлийг хүртсэн. Ноа л Бурханд шүтэн мөргөж, муугаас зайлсан учир Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы зааврыг сонсож чаджээ. Ноа Бурханы үгийн зааврын дагуу бүхээг барьж, бүх төрлийн амьтдыг цуглуулсан. Ингээд бүх зүйл бэлэн болсны дараа Бурхан дэлхий дээр сүйрлээ эхлүүлсэн. Ноа болон түүний гэр бүлийн долоон гишүүн л сүйрлээс амь гарсан, учир нь Ноа Еховаг шүтэн мөргөж, муугаас зайлсан билээ.

Өнөө үеийг одоо хар л даа: Бурханд шүтэн мөргөж муугаас зайлж чадах Ноа шиг зөв шударга хүмүүс байхаа больжээ. Гэсэн ч Бурхан хүн төрөлхтөнд нигүүлсэнгүй хэвээр, энэхүү төгсгөлийн эрин үед тэднийг уучилсаар байдаг. Өөрийг нь гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Бурхан эрж хайдаг. Өөрийнх нь үгийг сонсож чаддаг, Түүний даалгаврыг мартаагүй, зүрх сэтгэл, бие махбодоо Түүнд өргөн барьдаг хүмүүсийг Тэр эрж хайдаг. Өөрийнх нь өмнө хүүхэд шиг дуулгавартай байдаг, Өөрийг нь эсэргүүцдэггүй хүмүүсийг Тэр эрж хайдаг. Хэрвээ чи аливаа хүчнээс ангид байж Бурханд өөрийгөө зориулдаг бол Бурхан чамд энэрэнгүй хандаж, ерөөлөө хайрлана. Чи өндөр байр суурьтай, нэр хүндтэй, арвин мэдлэгтэй, элбэг их эд хөрөнгийн эзэн, олон дэмжигчтэй байсан ч эдгээр зүйл нь Бурханы дуудлага болон даалгаврыг хүлээн авч, Бурханы чамаас хүссэн зүйлийг хийхээр Бурханы өмнө очиход чинь саад болохгүй байвал чиний хийж байгаа бүхэн дэлхий дээрх хамгийн чухал ач холбогдолтой, мөн хүн төрөлхтний хамгийн зөвт үйл хэрэг байх болно. Хэрвээ чи өөрийн байр суурь, зорилгын төлөө Бурханы дуудлагаас татгалзвал хийсэн бүхэн чинь хараагдаж, бүр Бурханд жигшигдэнэ. Магадгүй чи ерөнхийлөгч, эрдэмтэн, пастор, эсвэл ахлагч байж болно, гэхдээ үйл хэрэгтээ зөвхөн өөрийн мэдлэг, чадварт найдвал чиний албан тушаал хэр өндөр байхаас үл хамааран үргэлж бүтэлгүйтэж, үргэлж Бурханы ерөөлөөр дутагдана, учир нь Бурхан чиний хийдэг юуг ч хүлээн зөвшөөрдөггүй, мөн чиний үйл хэргийг зөв шударга гэж зөвшөөрч, эсвэл чамайг хүн төрөлхтний тусын тулд ажиллаж байна гэж хүлээн зөвшөөрдөггүй. Чи Бурханы хамгаалалтаас хүнийг холдуулахын тулд хүн

төрөлхтний мэдлэг, хүч чадлыг ашиглахаас өөрийг хийдэггүй, мөн Бурханы ерөөлийг үгүйсгэхийн тулд үүнийг хийдэг гэж Тэр хэлнэ. Хүн төрөлхтнийг харанхуй руу, үхэл рүү, мөн Бурханыг болон Түүний ерөөлийг алдсан хязгааргүй оршин тогтнолын эхлэл рүү хөтөлж байна гэж Тэр чамайг хэлнэ.

Хүн төрөлхтөн нийгмийн шинжлэх ухааныг үүсгэсэн цагаас хойш хүний оюун санаа шинжлэх ухаан болон мэдлэгт эзэмдүүлсэн юм. Тэгээд шинжлэх ухаан, мэдлэг нь хүн төрөлхтнийг удирдах хэрэгсэл болсон ба хүнд Бурханыг шүтэн мөргөх орон зай хангалттай байхаа больж, Бурханыг шүтэн мөргөх таатай нөхцөл үгүй болсон. Хүний зүрх сэтгэл дэх Бурханы байр суурь улам доошилжээ. Зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй болохоор хүний дотоод ертөнц харанхуй, итгэл найдваргүй агаад хоосон. Иймээс ч хүн төрөлхтний оюун ухаан, зүрх сэтгэлийг дүүргэхийн тулд, Бурхан хүнийг бүтээсэн гэх үнэнтэй зөрчилддөг нийгмийн шинжлэх ухааны онолууд, хүний хувьслын онол болон бусад онолыг илэрхийлэхээр нийгмийн ухааны эрдэмтэн, түүхч, улс төрчид олноор гарч ирсэн билээ. Ийнхүү Бурхан бүхнийг бүтээсэн гэдэгт итгэдэг хүмүүс ихэд цөөрч, хувьслын онолд итгэгчдийн тоо бүр олширсон. Бурханы ажлын тухай тэмдэглэл, Хуучин гэрээний үеийн Түүний үгийг улам олон хүн үлгэр, домог мэтээр үздэг болсон. Хүмүүс зүрх сэтгэлдээ Бурханы агуу байдал болон эрхэм чанарыг, Бурхан оршдог бөгөөд бүх зүйлийг ноёрхдог гэдэг итгэл үнэмшлийг хайхрахаа байсан. Хүн төрөлхтний үхэх сэхэх, улс, үндэстний хувь заяа ч тэдэнд чухал биш болсон. Хүн идэж, уух, зугаа цэнгэл хөөцөлдөхийг л боддог хоосон ертөнцөд амьдардаг... Бурхан өнөөдөр хаана ажлаа хийдгийг эрж хайх, эсвэл Тэр хүний хүрэх газрыг хэрхэн захирч зохицуулж байдгийг хайх санаачилга гаргадаг хүн цөөхөн байдаг. Ийм маягаар хүнийг анзаараа ч үгүй байхад хүн төрөлхтний соёл иргэншил улам л хүний хүсэлд нийцэхээргүй болж байгаа бөгөөд бүр ч олон хүн ийм ертөнцөд амьдарснаараа аль хэдийн өнгөрөн одсон хүмүүсээс ч дор аз жаргалгүй байгаагаа мэдрэх болжээ. Урьд нь өндөр соёл иргэншилтэй байсан орнуудын хүмүүс хүртэл ийм гомдол тоочиж байна. Учир нь, Бурхан залж чиглүүлэхгүй л бол хүн төрөлхтний соёл иргэншлийг хадгалж үлдэхийн тулд эрх баригчид, нийгэм судлаач нар тархиа хэчнээн их гашилгавч тусыг эс олно. Хэн ч хүний амь байж чадахгүй учраас хэн ч хүний зүрх сэтгэл дэх хоосныг дүүргэж чадахгүй, ямар ч нийгмийн онол хүнийг зовоож буй хоосон байдлаас нь салгаж чадахгүй. Шинжлэх ухаан, мэдлэг, эрх чөлөө, ардчилал, амралт, тав тух гэх мэт эдгээр зүйл хүнд зөвхөн түрхэн зуурын тайтгарал өгдөг. Эдгээр зүйл байсан ч хүмүүс гарцаагүй нүгэл үйлдэж, нийгмийн шударга бус

байдалд гомдоллосон хэвээр байх болно. Эдгээр зүйл хүний эрэл хайгуул хийх хүсэл, хорхойслыг барьж чадахгүй. Учир нь хүнийг Бурхан бүтээсэн бөгөөд утга учиргүй золиос, эрэл хайгуул нь хүнийг илүү их гуниг зовлон руу л хөтөлж, хүн төрөлхтний ирээдүй эсвэл утга замтай хэрхэн нүүр тулахаа мэдэхгүй байнгын айдастай оршин байхад хүргэдэг юм. Тэр ч бүү хэл, хүн шинжлэх ухаан, мэдлэгээс айдаг, хоосон мэдрэмжээс бүр ч их айдаг болно. Энэ дэлхийд, эрх чөлөөтэй оронд байна уу, эсвэл хүний эрх үгүй оронд амьдарч байна уу гэдгээс үл хамааран чи хүн төрөлхтний хувь заяанаас зугтаж огтхон ч чадахгүй. Чи захирагч, захирагдагчийн аль нь ч бай, хүн төрөлхтний хувь заяа, нууц, хүрэх газрыг судалж шинжлэх хүслээс зугтаж огтхон ч чадахгүй, хоосон байдлын толгой эргэм мэдрэмжээс зугтаж бүр ч чадахгүй. Бүх хүн төрөлхтөнд нийтлэг байдаг ийм үзэгдлийг нийгэм судлаачид нийгмийн үзэгдэл гэж нэрлэдэг хэдий ч ийм асуудлыг шийдвэрлэхээр гарч ирж чадах агуу хүн алга л байна. Эцсийн эцэст хүн бол хүн бөгөөд Бурханы байр суурь болон амийг ямар ч хүн орлож чадахгүй. Хүн төрөлхтөнд, зүгээр нэг хүн бүр цатгалан, эрх тэгш, чөлөөтэй байх шударга нийгэм шаардлагатай байгаа юм биш; хүн төрөлхтөнд хэрэгтэй байгаа зүйл бол Бурханы аврал болон Түүний өгдөг амийн хангалт юм. Бурханы аврал болон Түүний амийн хангалтыг хүртэж байж л хүний хэрэгцээ, эрж хайх хүсэл, сүнсний хоосон мэдрэмж нь шийдэгдэж чаддаг. Хэрвээ улс, үндэстний хүмүүс Бурханы аврал, халамжийг хүлээн авч чадахгүй бол тэр улс, үндэстэн доройтлын замаар харанхуй руу алхаж, Бурханаар устгагдах болно.

Танай улс эдүгээ дээшлэн дэвжиж байж магадгүй ч чи өөрийн ард түмэнд Бурханаас төөрч холдохыг зөвшөөрвөл улс чинь Бурханы ерөөлийг улам л алдаж байгаагаа харна. Улсын чинь соёл иргэншил улам бүр хөл доор гишгэгдэж, тун удалгүй хүмүүс Бурханы эсрэг босож, Тэнгэрийг хараах болно. Тэгээд улс орны хувь заяа нэг мэдэхэд сүйрнэ. Бурханд хараагдсан тэдгээр улсад арга хэмжээ авахын тулд Бурхан хүчирхэг улсуудыг бий болгох ба тэднийг бүр газрын хөрснөөс арчиж ч магадгүй. Нэг улс, үндэстний мандаж, доройтох нь тухайн орны удирдагчид Бурханыг шүтэн мөргөдөг эсэхээс, ард иргэдээ Бурханд илүү ойр, Түүнд шүтэн мөргөдөг болгоход залдаг эсэхээс хамаардаг. Гэвч өнөөгийн энэ сүүлчийн эринд Бурханыг шүтдэг, Түүнийг жинхэнээсээ хайдаг хүмүүс улам цөөрсөн учраас Христийн шашныг улсынхаа шашин болгосон орнуудад Бурхан онцгой ивээл хайрладаг. Тэрээр дэлхийн харьцангуй зөв шударга хүрээг байгуулахын тулд тэдгээр улсыг нэгтгэдэг байхад харин бурхангүй үзэлтэй юм уу жинхэнэ Бурханыг шүтэн мөргөдөггүй

орнууд зөв шударга хүрээний дайснууд болдог. Ийм маягаар, Бурхан хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг явуулах газартай болоод зогсохгүй, мөн Бурханыг эсэргүүцдэг улс оронд хориг, хязгаарлалт тавихын тулд зөв шударга эрх мэдлийг хэрэгжүүлж чадах улс орныг олж авдаг. Гэвч тэглээ гээд илүү олон хүн Бурханыг шүтэн мөргөхөөр ирэхгүй л байна. Яагаад гэвэл, хүн Бурханаас хэтэрхий холдчихсон бөгөөд хүн Бурханыг мартаад дэндүү удаж байгаа юм. Зөв шударга байдлыг хэрэгжүүлж, зөв шударга бус байдлаас татгалздаг тийм орнууд л газар дэлхий дээр үлддэг. Гэвч энэ нь Бурханы хүслээс хол байдаг, учир нь ямар ч орны удирдагчид ард иргэдийг нь Бурхан захирахыг зөвшөөрөхгүй, ямар ч улс төрийн нам Бурханд шүтэн мөргөхийн тулд хүмүүсээ цуглуулахгүй; Бурхан улс орон, үндэстэн, эрх баригч нам бүрийн, тэр ч бүү хэл хүн бүрийн зүрхэнд эзлэх зүй ёсны байраа алдчихсан. Энэ дэлхий дээр зөв шударга хүчнүүд оршдог хэдий ч хүний зүрх сэтгэлд Бурханы эзлэх орон зай байдаггүй засаглал бол хэврэг юм. Бурханы ерөөлгүйгээр улс төрийн талбар эмх замбараагаа алдаж, ганц цохилт ч дааж чадахааргүй болно. Хүн төрөлхтний хувьд, Бурханы ерөөлгүйгээр байна гэдэг нарны гэрэлгүйгээр байхтай адилхан. Улс гүрний удирдагчид ард түмэндээ хэчнээн их хувь нэмэр орууллаа гээд, хэчнээн олон зөв шударга хурал зөвлөгөөн хийлээ гээд, аль нь ч урсгалын чиглэлийг өөрчилж чадахгүй, эсвэл хүн төрөлхтний хувь заяаг өөрчилж чадахгүй. Ард иргэд нь хоол унд, хувцас хунартай, хамтдаа энх амгалан суудаг улсыг сайн улс, сайн удирдагчидтай гэж хүмүүс боддог. Гэвч Бурхан тэгж боддоггүй. Өөрийг нь нэг ч хүн шүтэн мөргөдөггүй улс орон бол Өөрийнх нь устгах улс мөн гэж Тэр итгэдэг. Хүний санал бодол Бурханыхаас дэндүү их зөрдөг. Тиймээс хэрвээ улсын тэргүүн нь Бурханыг шүтэн мөргөдөггүй бол уг улсын хувь заяа эмгэнэлтэй болох бөгөөд тэр улс ямар ч хүрэх газаргүй байх болно.

Бурхан хүн төрөлхтний улс төрийн хэрэгт оролцдоггүй боловч улс, үндэстний хувь заяаг удирддаг. Бурхан энэ дэлхийг, бүхэл орчлон ертөнцийг удирддаг. Хүний хувь заяа, Бурханы төлөвлөгөө нь нарийн уялдаа холбоотой бөгөөд ямар ч хүн, улс, эсвэл үндэстэн Бурханы дээд эрхээс ангид байдаггүй. Хэрвээ хүн өөрийнхөө хувь заяаг мэдэхийг хүсвэл Бурханы өмнө ирэх ёстой. Бурхан Өөрийг нь дагаж, шүтэн мөргөдөг хүмүүсийг өөд нь татах ба эсэргүүцэж, голдог хүмүүст доройтол, мөхөл авчирна.

Библид өгүүлсэн Бурхан Содомыг сүйрүүлсэн явдлыг санаж, Лотын эхнэр хэрхэн давсан багана болсныг бод. Ниневегийн хүмүүс хэрхэн үнс, тааран дотор нүглээ гэмшсэнийг эргээд бод, 2,000 жилийн өмнө иудейчүүд Есүсийг

загалмайд цовдолсны дараа тэдэнд юу тохиолдсоныг сана. Иудейчүүд Израилиас хөөгдөж, дэлхий дахины улсууд руу зугтсан билээ. Олонх нь хөнөөгдөж, бүхий л Иудей үндэстэн улс орон нь сүйрсэн, урьд хожид байгаагүй шаналлыг амссан. Тэд Бурханыг загалмайд цовдолж, жигшүүрт нүгэл үйлдэж, Бурханы зан чанарыг хилэгнүүлсэн. Тэд хийсэн хэргийнхээ төлөөсийг төлж, өөрсдийнхөө үйлдлийн үр дагаврыг үүрэх болсон. Тэд Бурханыг яллаж, голсон, иймээс тэдэнд Бурханаар шийтгүүлэх хувь заяа л үлдсэн юм. Энэ бол удирдагчдынх нь ард түмэндээ авчирсан гашуун үр дагавар, гамшиг билээ.

Өнөөдөр, Бурхан Өөрийн ажлыг хийхээр дэлхийд эргэж ирсэн. Түүний эхний зогсоол бол дарангуй засаглалын үлгэр жишээ болсон газар буюу бурхангүй үзлийн бат бэх цайз, Хятад юм. Бурхан Өөрийн мэргэн ухаан, хүч чадлаар бүлэг хүмүүсийг олж авсан. Энэ хугацаанд Хятадын эрх баригч нам Түүнийг бүх аргаар мөшгөн хөөж, асар их зовлон амсуулан толгой тавьж амрах газар, орох оронгүй болгосон. Тэгсэн ч гэсэн Бурхан хийхээр зорьсон ажлаа хийсээр байна: Тэр Өөрийн дуу хоолойг хүргэхээр айлдаж, сайн мэдээ түгээж байна. Бурханы төгс хүчийг хэн ч төсөөлж чадахгүй. Хятадад буюу Бурханыг дайсан гэж үздэг улсад Бурхан Өөрийнхөө ажлыг хэзээ ч зогсоогоогүй. Харин ч илүү олон хүн Бурханы ажил ба үгийг хүлээн авсан, учир нь Бурхан хүн төрөлхтний гишүүн нэг бүрийг боломжит хамгийн дээд хэмжээнд авардаг. Ямар ч орон, ямар ч хүч Бурханы биелүүлэхээр хүссэн зүйлийн замд саад болж чадахгүй гэдэгт бид итгэдэг. Бурханы ажилд саад хийдэг, Бурханы үгийг эсэргүүцдэг, Бурханы төлөвлөгөөг үймүүлж, сүйтгэдэг хүмүүс эцэстээ Бурханаар шийтгүүлнэ. Бурханы ажлыг эсэргүүцдэг хүн там руу илгээгдэнэ; Бурханы ажлыг сөрдөг ямар ч улс устгагдана; Бурханы ажлыг эсэргүүцэхээр бослого гаргадаг ямар ч үндэстэн газрын хөрснөөс арчигдаж, оршин тогтнохоо болино. Би бүх үндэстэн, улс орон, тэр ч байтугай бүх салбарын хүмүүсийг, Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы ажлыг харж, хүн төрөлхтний хувь заяанд анхаарлаа хандуулж, Бурханыг хамгийн ариун, хамгийн хүндтэй, хамгийн дээд бөгөөд хүн төрөлхтний дунд шүтэгдэх цорын ганц объект болгож, бүх хүн төрөлхтөнд Бурханы ерөөл дор яг л Абрахамын үр удам Еховагийн амлалт дор амьдарч байсан шиг, Бурханы анх бүтээсэн Адам, Ева хоёр Еден цэцэрлэгт амьдарч байсан шиг амьдрах боломж олгохыг уриалж байна.

Бурханы ажил яг л сүрлэг давлагаа мэт нөмрөн ирдэг. Хэн ч Түүнийг саатуулан барьж чадахгүй, хэн ч Түүний алхааг зогсоож чадахгүй. Түүний үгийг анхааралтайгаар сонсдог, Түүнийг эрж хайж, Түүгээр цангадаг хүмүүс л Түүний

мөрийг дагаж, Түүний амлалтыг хүлээн авч чадна. Харин тэгээгүй хүмүүс дааж давшгүй гамшигт өртөж, яг тохирох шийтгэлээ хүртэнэ.

БУРХАНЫГ МЭДЭХ НЬ БУРХАНААС ЭМЭЭЖ, МУУГААС ЗАЙЛАХ ЗАМ ЮМ

Та нар дор бүрнээ Бурханыг дагах үйл явцдаа Бурханыг үнэхээр ойлгож, үнэхээр ухаарч, үнэхээр мэдэж авсан эсэхээ, янз бүрийн хүмүүст Бурхан ямар хандлага баримталдгийг үнэхээр мэддэг эсэхээ, мөн Бурхан чам дээр юу хийж байгааг болон үйлдэл бүрийг чинь Бурхан хэрхэн тодорхойлдгийг үнэхээр ойлгож байгаа эсэхээ харахын тулд амьдралынхаа туршид Бурханд хэрхэн итгэснээ шинээр шинжлэн шалгах ёстой. Хажууд чинь байж, урагшлах чиглэлийг чинь залж чиглүүлж, хувь заяаг чинь захирч, хэрэгцээг чинь хангадаг энэ Бурханыг чи чухамдаа хэр их ойлгож, хэр их мэддэг вэ? Тэр өдөр бүр чам дээр юу хийдгийг чи мэдэх үү? Түүний үйлдэл бүр ямар зарчим, зорилгод үндэслэдгийг мэдэх үү? Тэр чамайг хэрхэн залж чиглүүлдгийг мэдэх үү? Чамайг хангадаг Түүний арга барилыг мэдэх үү? Чамайг удирддаг Түүний арга замыг мэдэх үү? Тэр чамаас юу олж авахыг хүсдэгийг болон Тэр чамд юу гүйцэтгэхийг хүсдэгийг чи мэдэх үү? Чиний гаргаж байгаа олон төрлийн аашинд Тэр ямар хандлага баримталдгийг чи мэдэх үү? Чи Түүний хайртай хүн мөн эсэхээ мэдэх үү? Түүний баяр баясгалан, уур хилэн, уй гуниг, баяр хөөрийн уг сурвалж, тэдгээрийн ар дахь бодол, санаа болон Түүний мөн чанарын талаар чи мэдэх үү? Эцсийн эцэст итгэдэг энэ Бурхан чинь ямар Бурхан бэ гэдгийг мэдэх үү? Гэх мэт эдгээр асуулт нь чиний хэзээ ч ойлгож эсвэл бодож байгаагүй зүйл мөн үү? Бурханд итгэх үйл явцдаа чи Бурханы үгийг бодитоор мэдэрч, туулах замаар Түүний талаарх буруу ойлголтоо арилгасан уу? Бурханы сахилгажуулалт, цохилтыг хүртсэнийхээ дараа чи Бурханд жинхэнээсээ дуулгавартай байж, анхаарал тавьж эхэлсэн үү? Бурханы гэсгээлт, шүүлтийн дунд чи, хүний тэрслүү байдал болон сатанлаг уг чанарыг танин мэдэхээр дамжуулан Бурханы ариун байдлын талаар өчүүхэн ч гэсэн ойлгож авсан уу? Бурханы үгийн удирдамж болон гэгээрлийн дор чи амьдралыг үзэх шинэ үзэл бодолтой болсон уу? Бурханы илгээсэн шалгалтын дунд чи, хүний халдахыг Тэр тэвчдэггүй гэдгийг, түүнчлэн Тэр чамаас юу шаарддагийг болон Тэр чамайг хэрхэн аварч буйг мэдэрсэн үү? Бурханыг буруугаар ойлгох гэж юу болохыг, эсвэл энэ буруу ойлголтыг хэрхэн залруулахыг мэддэггүй бол чамайг хэзээ ч Бурхантай

жинхэнээсээ харилцаагүй, хэзээ ч Бурханыг ойлгож байгаагүй гэж хэлж болно, эсвэл чи наад зах нь хэзээ ч Түүнийг ойлгохыг хүсээгүй гэж хэлж болно. Хэрвээ чи Бурханы сахилгажуулалт, цохилт гэж юу болохыг мэддэггүй бол дуулгавартай байх болон анхаарал тавих гэдэг нь юу болохыг мэддэггүй нь лавтай, эсвэл чи наад зах нь хэзээ ч Бурханд үнэхээр дуулгавартай байж, анхаарал тавьж байгаагүй юм байна. Хэрвээ чи Бурханы гэсгээлт, шүүлтийг хэзээ ч туулж байгаагүй бол Түүний ариун байдлыг мэдэхгүй нь лавтай бөгөөд хүний тэрслүү байдал юу болох талаар бүр ч мэдэхгүй. Хэрвээ чамд амьдралыг үзэх зөв үзэл бодол юм уу амьдралын зөв зорилго хэзээ ч байгаагүй, харин урагшаа явахаас ч эргэлзэх хүртэл хэмжээнд амьдралынхаа ирээдүйн замд тээнэгэлзэж, тэвдсээр байгаа бол Бурханы гэгээрэл, удирдамжийг хэзээ ч хүлээн авч байгаагүй чинь илэрхий юм; чамайг үнэхээр хэзээ ч Бурханы үгээр хангагдаж, нөхөгдөж байгаагүй гэж хэлж болно. Хэрвээ чи Бурханы шалгалтыг хараахан туулаагүй бол Бурхан хүний халдахыг тэвчдэггүй гэж юу болохыг мэдэхгүй нь лавтай, мөн Бурхан чамаас эцсийн эцэст юу шаарддагийг ойлгохгүй, хүнийг удирдаж, аврах Түүний ажил юу болохыг бүр ч ойлгохгүй нь тодорхой юм. Хүн Бурханд хэчнээн олон жил итгэсэн байх нь хамаагүй, Бурханы үгээс хэзээ ч, юу ч мэдэрч ойлгоогүй бол тэр хүн авралын зам руу мэдээж алхаагүй, Бурханд итгэх итгэл нь мэдээж ямар ч бодитой агуулгагүй, Бурханы талаарх мэдлэг нь ч гэсэн мэдээж хоосон бөгөөд Бурханыг хүндлэх гэж юу болохыг огт мэддэггүй нь илэрхий юм.

Бурханд юу байгаа, Тэр юу болох, Бурханы мөн чанар, Бурханы зан чанар нь бүгд Түүний үгээр дамжин хүн төрөлхтөнд илэрхийлэгдсэн. Хүн Бурханы үгийг туулж байхдаа тэдгээрийг хэрэгжүүлэх явцад Бурханы хэлдэг үгийн цаад зорилгыг ойлгож, Бурханы үгийн эх сурвалж болон цаад шалтгааныг ойлгож, Бурханы үгийн зорьсон үр нөлөөг ойлгож, мэдэрнэ. Хүмүүсийн хувьд, үнэн болон амийг олж авч, Бурханы хүслийг ухаарч, зан чанараа өөрчилж, Бурханы дээд эрх, зохицуулалтыг дуулгавартай дагаж чаддаг болохын тулд туулж, ухаарч, олж авах ёстой бүх зүйл бол энэ юм. Хүн эдгээр зүйлийг туулж, ухаарч, олж авах зуураа Бурханы талаарх ойлголтыг аажмаар олж авсан байх бөгөөд энэ үедээ бас Түүний талаарх өөр өөр түвшний мэдлэгийг олж авсан байх болно. Энэхүү ойлголт, мэдлэг нь хүний төсөөлж зохиосон зүйлээс гарч ирдэггүй, харин ч өөрийнхөө дотор ухамсарлаж, мэдэрч, туулж, баталж байгаа зүйлээс нь гарч ирдэг. Эдгээр зүйлийг ухамсарлаж, туулж, мэдэрч, баталсны дараа л Бурханы талаарх хүний мэдлэг агуулгатай болдог; энэ үед л хүний олж

авсан мэдлэг үнэн, бодитой, алдаа мадаггүй байх бөгөөд Бурханы үгийг ухамсарлаж, туулж, мэдэрч, батлах замаар Бурханы тухай жинхэнэ ойлголт, мэдлэгийг олж авах энэ үйл явц бол Бурхан, хүн хоёрын хоорондох жинхэнэ харилцаа юм. Ийм төрлийн харилцаан дунд хүн Бурханы санаа зорилгыг үнэхээр ойлгож, ухаарч эхэлдэг ба Бурханд юу байгаа, Тэр юу болохыг, Бурханы мөн чанарыг үнэхээр ойлгож, мэдэж, Бурханы зан чанарыг аажмаар ойлгож, мэдэж, Бурхан бүх зүйлийг захирдаг баримтын талаар жинхэнэ үнэмшил болон зөв тодорхойлолттой болдог бөгөөд Бурханы ялгамж чанар, байр суурийн тухайд бодитой танин мэдэхүй, мэдлэгтэй болдог. Ийм төрлийн харилцаан дунд хүн Бурханы тухай санаа бодлоо алхам алхмаар өөрчилж, Түүнийг үндэслэлгүйгээр төсөөлж, Түүний талаар дураараа сэжиглэж, Түүнийг буруугаар ойлгож, яллаж, Түүнд шүүлт оноож, Түүнд эргэлзэхээ больдог. Тийнхүү Бурхантай маргах нь багасаж, зөрчилдөх нь багасаж, Бурханы эсрэг тэрслэх нь цөөрдөг. Эсрэгээрээ, хүн Бурханд анхаарал тавьж, дуулгавартай байх нь ихсэж, Бурханыг хүндлэх хүндлэл нь улам бодитой, улам гүн гүнзгий болдог. Ийм төрлийн харилцаан дунд хүн үнэний хангалт болон амийн баптисмыг олж аваад зогсохгүй, үүний зэрэгцээ бас Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрдэг. Ийм төрлийн харилцаан дунд хүн зан чанараа өөрчилж, аврал хүртээд зогсохгүй, үүний зэрэгцээ бүтээгдсэн зүйлээс Бурханд хандах жинхэнэ хүндлэл болон шүтлэгийг олж авдаг. Ийм төрлийн харилцаатай байснаар Бурханд итгэх итгэл нь хоосон цаас, хий дэмий амлалт юм уу сохор эрэл хайгуул, сохор шүтлэг байхаа больдог; ийм төрлийн харилцаатай байснаар л хүний амь өдөр өдрөөр боловсрон өсөх ба энэ үед л хүний зан чанар аажмаар өөрчлөгдөж, Бурханд итгэх итгэл нь бүдэг бадаг, тодорхойгүй итгэлээс жинхэнэ дуулгавартай байдал, анхаарал халамж руу, бодит хүндлэл рүү алхам алхмаар шилждэг, түүнчлэн хүн Бурханыг дагах үйл явцдаа идэвхгүй байснаа идэвхтэй байдалтай болж, сөрөг байснаа эерэг болж аажмаар ахин дэвшдэг; ийм харилцаатай байснаар л хүн Бурханы талаарх жинхэнэ ойлголт, ухаарал, мөн Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрдэг. Хүмүүсийн дийлэнх нь хэзээ ч Бурхантай жинхэнээсээ харилцаж байгаагүй учраас Бурханы талаарх мэдлэг нь онолын түвшинд, бичиг үсэг, хоосон сургаалын түвшинд хүрээд зогсдог. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дийлэнх нь Бурханд хэчнээн олон жил итгэсэн байх нь хамаагүй, Бурханыг мэдэхийн тухайд бол одоо ч эхлэлийн цэг дээрээ байж, феодалын мухар сүсэг болон романтик өнгө аястай холбоотой уламжлалт бишрэл хүндэтгэлийн хэлбэрийн суурин дээр гацаж байдаг. Бурханы талаарх

хүний мэдлэг эхлэлийн цэг дээрээ гацна гэдэг бол бараг байхгүй гэсэн үг. Бурханы байр суурь, ялгамж чанарын талаарх хүний баталгаанаас бусдаар бол хүний Бурханд итгэх итгэл нь мөн л бүдэг бадаг тодорхойгүй байдалд байдаг. Ийм болохоор хүнд Бурханыг гэх жинхэнэ хүндлэл хэр их байдаг вэ?

Чи Бурханы оршин тогтнолд хэчнээн бат итгэдэг нь хамаагүй, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь ч, Бурханыг хүндлэх хүндлэлийг чинь ч орлож чадахгүй. Чи Бурханы ерөөл, нигүүлслийг хэчнээн их эдэлсэн ч бай, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь орлож чадахгүй. Бурханы төлөө бүхнээ зориулж, бүхнээ зарлагадахыг хэчнээн их хүсэх чинь хамаагүй, энэ нь Бурханы талаарх мэдлэгийг чинь орлож чадахгүй. Магадгүй чи Бурханы хэлсэн үгийг маш сайн мэддэг болж, тэдгээрийг цээжилж, дуржигнатал уншиж чадаж байлаа ч гэсэн, энэ нь Бурханы талаарх чиний мэдлэгийг орлож чадахгүй. Бурханыг дагахдаа хүн хэчнээн шийдэмгий байлаа ч гэсэн, Бурхантай хэзээ ч жинхэнээсээ харилцаж байгаагүй бол, Бурханы үгийг жинхэнээсээ туулаагүй бол Бурханы талаарх мэдлэг нь хий хоосон, эцэс төгсгөлгүй мөрөөдөл байх болно; чи зөрж өнгөрөхдөө Бурхантай мөр шүргэлцэж, Түүнтэй нүүр тулан уулзсан ч бай, Түүний талаарх мэдлэг чинь хоосон хэвээр байх ба Бурханыг гэх хүндлэл чинь хий хоосон уриа лоозон, хүслэнт үзэл баримтлалаас өөрцгүй байх юм.

Олон хүн Бурханы үгийг бариад өдөр бүр уншдаг, бүр тэнд байгаа бүх сонгодог эшлэлийг өөрсдийн хамгийн эрхэм эрдэнэ шиг анхааралтай цээжлэхэд хүрдэг төдийгүй Бурханы үгийг хаа сайгүй номлож, Бурханы үгээр бусдыг хангаж, тусалж байдаг. Ингэх нь Бурханыг гэрчилж байгаа, Түүний үгийг гэрчилж байгаа хэрэг бөгөөд ингэх нь Бурханы замыг дагаж байна гэж тэд боддог; ингэх нь Бурханы үгээр амьдарч байна, ингэх нь Түүний үгийг бодит амьдралдаа авчирч байна, мөн ингэвэл Бурханы сайшаалыг хүртэж, аврагдаж, төгс болгуулах боломжтой гэж тэд боддог. Гэвч, тэд Бурханы үгийг номлож байхдаа ч гэсэн, хэрэгжүүлэхдээ хэзээ ч Бурханы үгийг дагаж мөрддөггүй, мөн Бурханы үгэнд илчлэгдсэн зүйлтэй өөрсдийгөө нийцүүлэхээр хичээдэггүй. Үүний оронд тэд Бурханы үгийг ашиглан бусдын хүндлэл, итгэлийг мэхлэн авч, өөрсдийн удирдлагыг эрхэлж, Бурханы алдрыг завшиж, хулгайлдаг. Тэд Бурханы ажил болон сайшаалаар шагнуулахын тулд Бурханы үгийг түгээх боломжийг ашиглах гэж хий дэмий найддаг. Хэчнээн олон жил өнгөрсөн ч гэлээ, энэ хүмүүс Бурханы үгийг номлох явцдаа Бурханы сайшаалыг хүртэж чадаагүйгээр үл барам, Бурханы үгийг гэрчлэх явцад өөрсдийн дагах ёстой замыг олж нээж чадаагүйгээр барахгүй, Бурханы үгээр бусдыг хангаж, туслах явцдаа өөрсдөдөө

тусалж, өөрсдийгөө дэмжиж чадаагүйгээс гадна, энэ бүх зүйлийг хийх явцдаа Бурханыг мэдэж, Бурханыг хүндлэх жинхэнэ хүндлэлд хүрч чадаагүйгээр зогсохгүй; харин ч Бурханы талаарх буруу ойлголт нь улам бүр гүнзгийрч, Түүнийг сэжиглэх нь улам ч ноцтой болж, Түүний талаарх төсөөлөл нь бүр их хэтрүүлэгтэй болдог. Бурханы үгийн тухай онолын хангалт болон удирдлага дор тэд загас усанд орсон мэт, өөрсдийн ур чадварыг ядах юмгүй хялбархан ашиглаж байгаа мэт, өөрсдийн амьдралын зорилго, үүрэг даалгаврыг олсон мэт, шинэ амийг олж аваад, аврагдсан мэт, Бурханы үгийг цээжээр урсган уншихынхаа хамтаар үнэнийг олж авч, Бурханы хүслийг ухаарч, Бурханыг мэдэх замыг нээн олсон мэт, Бурханы үгийг номлох явцдаа Бурхантай дандаа нүүр тулан уулзсан мэт харагддаг. Мөн, тэд үргэлж цурхиран уйлтлаа “сэтгэл нь хөдөлдөг” ба Бурханы үгэн дэх “Бурханаар” байнга удирдуулснаар, Түүний чин сэтгэлийн анхаарал, сайн санаа зорилгыг нь тасралтгүй ухаарч байгаа мэт харагддагийн зэрэгцээ хүнийг аврах Бурханы аврал болон Түүний удирдлагыг ухаарч, Түүний мөн чанарыг мэдэж авч, Түүний зөвт зан чанарыг ойлгосон мэт харагддаг. Энэ сууринд үндэслэн тэд Бурханы оршин тогтнолд улам бүр бат итгэж, Түүний эрхэм дээд байдлын талаар улам бүр ухаарч, Түүний агуу, ер бусын байдлыг бүр ч гүнзгий мэдэрч байх шиг санагддаг. Тэд Бурханы үгийн тухай өнгөц мэдлэгт автан, итгэл нь өсөж, зовлон туулах шийдэмгий байдал нь батжиж, Бурханы талаарх мэдлэг нь гүнзгийрсэн мэт харагддаг. Тэд Бурханы үгийг үнэхээр туулахаас нааш Бурханы талаарх бүх мэдлэг, бодол санаа нь өөрсдийнх нь хий хоосон төсөөлөл, таамаглалаас гарч ирдэг гэдгийг хэрхэн мэдэх билээ. Тэдний итгэл Бурханаас ирсэн ямар ч туршилтыг дийлэхгүй, тэдний сүнслэг байдал болон биеийн хэмжээ гэгддэг зүйл нь Бурханы шалгалт юм уу үзлэгийг ердөө даахгүй, тэдний шийдвэр элсэн дээр баригдсан цайзтай адил бөгөөд тэдний хэлдэг Бурханы талаарх мэдлэг нь санаанаасаа зохиосон төсөөллөөс цаашгүй. Үнэндээ, Бурханы үгэнд “их хэмжээний хүчин чармайлт” гаргасан энэ хүмүүс жинхэнэ итгэл гэж юу болох, жинхэнэ дуулгавартай байдал гэж юу болох, жинхэнэ анхаарал халамж гэж юу болох, Бурханы талаарх жинхэнэ мэдлэг гэж юу болохыг хэзээ ч ухаараагүй. Тэд онол, төсөөлөл, мэдлэг, авьяас билиг, уламжлал, мухар сүсэг, тэр ч бүү хэл хүний ёс суртахууныг хүртэл аваад, тэдгээрийг Бурханд итгэх болон Түүнийг дагах “хөрөнгө”, “зэр зэвсэг” болгон, тэр ч байтугай тэдгээрийг Бурханд итгэх итгэл, Түүнийг дагах үндэс сууриа болгодог. Үүний зэрэгцээ, тэд бас энэ хөрөнгө, зэр зэвсгийг аваад, Бурханыг мэдэж, Бурханы хяналт, шалгалт, гэсгээлт, шүүлттэй нүүр тулж,

харьцах шидэт сахиус болгодог. Эцэст нь, тэдний цуглуулсан зүйл шашны өнгө аяс, феодалын мухар сүсэг нэвчиж, романтик, хачин жигтэй, учир битүүлэг бүхэн шингэсэн Бурханы талаарх дүгнэлтээс цаашгүй зүйлээс бүрддэг. Бурханы талаарх тэдний мэдлэг, тодорхойлолт нь зөвхөн Дээд Тэнгэр, эсвэл Тэнгэр Эцэгт итгэдэг хүмүүсийнхтэй нэг хэвд цутгагдсан байдаг бол Бурханы бодитой байдал, мөн чанар, зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох гэх зэрэг бодитой Бурхантай Өөртэй нь хамаатай юм бүхэн тэдний ухаарч ойлгож чадаагүй зүйлс бөгөөд тэдний мэдлэг үүнтэй огт хамааралгүй, бүр хойд, өмнөд туйл шиг хол байдаг. Ийм маягаар хэдий тэд Бурханы үгийн хангалт, тэжээл дор амьдардаг ч гэсэн Бурханаас эмээж, муугаас зайлах замаар алхаж үнэхээр чаддаггүй. Үүний жинхэнэ шалтгаан нь тэд хэзээ ч Бурханыг мэдэж аваагүй, мөн хэзээ ч Түүнтэй жинхэнээсээ холбогдож, ярилцаж байгаагүй. Иймээс тэдний хувьд Бурхантай харилцан ойлголцолд хүрч, Бурханд үнэхээр итгэж, Бурханыг дагаж, шүтэн мөргөх боломжгүй юм. Бурханы үгийг ийнхүү үзэж, Бурханыг ийнхүү үздэг тэдний харах өнцөг, хандлага нь тэднийг гар хоосон буцахад хүргэсэн бөгөөд Бурханаас эмээж, муугаас зайлах замаар мөнхөд алхаж чадахааргүй болоход хүргэсэн. Тэдний зорьж буй зорилго болон явж байгаа чиглэл нь тэд бол мөнхөд Бурханы дайсан, үүрд мөнхөд хэзээ ч аврал хүртэж чадахгүй гэдгийг илтгэдэг.

Бурханыг олон жилийн турш дагаж, Түүний үгийн хангалтыг олон жил эдэлсэн хүний хувьд, Бурханы талаарх түүний тодорхойлолт нь мөн чанартаа хуурамч шүтээний өмнө хүндэтгэн мөргөдөг хүнийхтэй адил бол тухайн хүн Бурханы үгийн бодит байдлыг олж аваагүй гэдгийг энэ нь илтгэнэ. Учир нь тэр Бурханы үгийн бодит байдалд ердөө ороогүй бөгөөд энэ шалтгааны улмаас Бурханы үгэнд угаасаа байдаг бодит байдал, үнэн, санаа зорилго, хүн төрөлхтөнд тавьсан шаардлага зэрэг нь бүгд тэр хүнтэй огт хамаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, ийм хүн Бурханы үгийн өнгөц утгын талаар хэчнээн хүчин чармайлт гаргалаа ч энэ бүхэн нь нэмэргүй юм: Учир нь тэр ердөө үг үсгийг л эрэлхийлдэг тул түүний олж авах зүйл мөн л үг үсэг төдий байх болно. Бурханы хэлдэг үг гаднаа энгийн ч бай, гүн гүнзгий ч бай, амь руу ороход хүнд шаардлагатай бүх үнэн юм; тэдгээр нь сүнсээрээ болон махан биеэрээ амьд үлдэх боломжийг хүнд олгодог амийн усны эх булаг билээ. Тэдгээр нь хүнийг амьд үлдэхэд хэрэгтэй зүйлээр; өдөр тутмын амьдралдаа биеэ авч явахад нь зориулсан зарчим, итгэл үнэмшлээр; авралд хүрэхийн тулд явах ёстой зам, зорилго болон чиглэлээр; Бурханы өмнө бүтээгдсэн зүйл нь болохын хувьд эзэмших ёстой бүх үнэнээр; Бурханыг хэрхэн дуулгавартай дагаж, шүтэн мөргөх

тухай бүх үнэнээр хангадаг. Тэр нь хүний амьд үлдэх баталгаа, хүний өдөр тутмын талх төдийгүй, хүнийг хүчтэй, тэсвэртэй болгодог бат бөх дэмжлэг юм. Тэр нь бүтээгдсэн хүн төрөлхтөн хэвийн хүн чанарыг амьдран харуулдаг үнэн-бодит байдлаар баялаг, хүн төрөлхтнийг завхралаас чөлөөлж, Сатаны урхинаас мултлах үнэнээр баялаг, Бүтээгчээс бүтээгдсэн хүмүүст өгсөн чин сэтгэлийн сургаал, сануулга, зоригжуулалт болон тайтгарлаар баялаг байдаг. Тэр нь бүхий л эерэг зүйлийг ойлгоход хүмүүсийг удирдан гэгээрүүлдэг гэрэлт цамхаг, зөв шударга, сайн бүхнийг амьдран харуулж, эзэмшихэд хүнийг хүргэдэг баталгаа, хүмүүс, үйл явдлууд болон эд зүйлсийг бүгдийг нь хэмждэг хэмжүүр, мөн түүнчлэн хүмүүсийг аврал болон гэрлийн зам руу хөтөлдөг жолоодлогын тэмдэг юм. Бурханы үгийн бодит туршлага дунд л хүн үнэн болон амиар хангагдаж чадна; эндээс л хүн хэвийн хүн чанар гэж юу болох, утга учиртай амьдрал гэж юу болох, жинхэнэ бүтээгдсэн зүйл гэж юу болох, Бурханд үнэхээр дуулгавартай байх гэж юу болохыг ойлгож авч чадна; эндээс л Бурханыг хэрхэн анхаарч халамжлах ёстойг, бүтээгдсэн зүйлийн үүргээ хэрхэн биелүүлэх ёстойг, хэрхэн жинхэнэ хүний дүртэй болох ёстойг ойлгож авч чадна; эндээс л жинхэнэ итгэл, жинхэнэ шүтлэг мөргөл гэж юу гэсэн үг болохыг ойлгож авч чадна; тэнгэр, газар бүх зүйлийн Захирагч хэн болохыг ойлгож авч чадна; бүхнийг захирагч Нэгний бүх зүйлийг захирч, удирдаж, хангадаг арга барилыг ойлгож авч чадна; бүхнийг захирагч Нэгний оршин тогтнож, үзэгдэж, ажилладаг арга барилыг ухаарч ойлгож авч чадна. Бурханы үгийг бодитоор туулахаас өөрөөр хүнд Бурханы үг болон үнэний талаарх ямар ч жинхэнэ мэдлэг, ойлголт байдаггүй. Ийм хүн бол чухамдаа амьд үхдэл, бүрэн цогцос бөгөөд Бүтээгчтэй хамаатай бүх мэдлэг түүнтэй огтхон ч хамаагүй байдаг. Бурханы нүдээр ийм хүн хэзээ ч Түүнд итгээгүй, мөн хэзээ ч Түүнийг дагаж байгаагүй, иймээс Бурхан ийм хүнийг жинхэнэ бүтээгдсэн зүйл гэх нь байтугай Өөрийн итгэгч, дагалдагч гэж хэзээ ч үздэггүй.

Жинхэнэ бүтээл болохын хувьд, Бүтээгч гэж хэн болох, хүнийг бүтээсэн нь юуны төлөө болох, бүтээгдсэн зүйлийн үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлэх, бүтээлийн Эзэнийг хэрхэн шүтэн мөргөхийг мэдэх ёстой бөгөөд Бүтээгчийн хүсэл, сэтгэлийн үг, шаардлагыг ойлгож, ухаарч, мэдэж, анхаарч, Бүтээгчийн үгийг даган мөрдөж—Бурханаас эмээж, муугаас зайлах ёстой.

Бурханаас эмээх гэж юу вэ? Хүн яаж муугаас зайлах вэ?

“Бурханаас эмээх” гэдэг нь хэлэхийн аргагүй айдас болон аймшгийг хэлдэггүй, бултан зугтах, зайгаа барих, бишрэн шүтэх, мухар сүсэг гэсэн үг ч

биш. Харин энэ нь бишрэл, хүндлэл, итгэл, ойлголцол, анхаарал халамж, дуулгавартай байдал, зориулалт, хайр, түүнчлэн болзол тавихгүйгээр, гомдоллохгүйгээр шүтэн мөргөх, ач хариулах болон захирагдах гэсэн үг юм. Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр, хүмүүст жинхэнэ бишрэл, жинхэнэ итгэл, жинхэнэ ойлголт, жинхэнэ анхаарал халамж юм уу дуулгавартай байдал гэж байхгүй, харин зөвхөн айдас, түгшүүр, эргэлзээ, үл ойлголцол, булталт, зайлсхийлт л байх болно; Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс жинхэнээсээ зориулж, ач хариулна гэж байхгүй; Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдана гэж байхгүй, сохор шүтлэг, мухар сүсэг л байх болно; Бурханы талаарх жинхэнэ мэдлэггүйгээр хүмүүс Бурханы үгийг даган мөрдөж, Бурханаас эмээж, муугаас зайлж яавч чадахгүй. Эсрэгээр нь хүмүүсийн хийдэг үйл ажиллагаа, гаргадаг зан авир болгон нь тэрслүү, эсэргүүцэл, Бурханы тухай гүжирдсэн зэмлэл, гутаасан шүүлт, үнэн болон Бурханы үгийн жинхэнэ утга учрыг зөрчсөн муу үйлээр дүүрнэ.

Хүмүүс Бурханд үнэхээр итгэх үедээ Түүнийг жинхэнээсээ дагаж, Түүнд найдна; Бурханд үнэхээр итгэж, найдсанаар л хүмүүс жинхэнэ ойлголт, ухааралтай болж чаддаг; Бурханы талаар бодит ухааралтай болсноор л Түүнийг бодитоор анхаарч халамжилдаг; Бурханыг жинхэнээсээ анхаарч халамжилдаг байснаар л хүмүүс үнэхээр дуулгавартай болно; Бурханд жинхэнээсээ дуулгавартай байснаар л хүмүүс жинхэнээсээ зориулна; Бурханд жинхэнээсээ зориулснаар л хүмүүс болзол тавьж, гомдоллолгүй ач хариулна; жинхэнэ итгэл найдвар, жинхэнэ ойлголт, анхаарал халамж, жинхэнэ дуулгавартай байдал, жинхэнэ зориулалт, ач хариулалт байснаар л хүмүүс Бурханы зан чанар, мөн чанарыг үнэхээр мэдэж, Бүтээгчийн ялгамж чанарыг мэдэж авч чадна; Бүтээгчийг үнэхээр мэдэж авсан үедээ л хүмүүс жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдаж чадна; Бүтээгчид жинхэнээсээ шүтэн мөргөж, захирагдах үедээ л хүмүүс муу арга замаа үнэхээр хойш тавих буюу муугаас зайлж чадна.

Эдгээр нь “Бурханаас эмээж, муугаас зайлах” бүхий л үйл явцыг бүрдүүлдэг төдийгүй Бурханаас эмээж, муугаас зайлах бүхий л агуулга юм. Түүнчлэн Бурханаас эмээж, муугаас зайлахын тулд явах ёстой зам юм.

“Бурханаас эмээж, муугаас зайлах” болон Бурханыг мэдэх нь тоо томшгүй олон уялдаагаар салшгүй холбогддог ба тэдгээрийн хоорондох холбоо илэрхий юм. Хэрвээ хүн муугаас зайлахыг хүсвэл эхлээд Бурханаас үнэхээр эмээх

ёстой; хэрвээ хүн Бурханаас үнэхээр эмээхийг хүсвэл эхлээд Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй байх ёстой; хэрвээ хүн Бурханы талаар мэдлэгтэй болохыг хүсвэл Бурханы үгийг туулж, Бурханы үгийн бодит байдалд орж, Бурханы цохилт, сахилгажуулалт, гэсгээлт, шүүлтийг туулах ёстой; хэрвээ хүн Бурханы үгийг туулахыг хүсвэл эхлээд Бурханы үгтэй нүүр тулж, Бурхантай нүүр тулж, хүмүүс, үйл явдал, эд зүйлтэй холбоотой төрөл бүрийн орчинд Бурханы үгийг туулах боломжоор хангахыг Бурханаас гуйх ёстой; хэрвээ хүн Бурхан болон Бурханы үгтэй нүүр тулахыг хүсвэл эхлээд цайлган, үнэнч зүрх сэтгэл, үнэнийг хүлээн авахад бэлэн байдал, зовлон бэрхшээл туулах хүсэл, муугаас зайлах шийдвэр, эр зориг болон жинхэнэ бүтээгдсэн зүйл болох хүсэл эрмэлзэлтэй байх ёстой... Ийм маягаар алхам алхмаар урагшилснаар чи Бурхантай улам бүр ойртож, зүрх сэтгэл чинь илүү ариун болж, чиний амьдрал болон амьд байхын үнэ цэн Бурханыг мэдэж авснаас чинь үүдэн улам бүр утга учиртай, улам бүр гэрэл гэгээтэй болно. Нэг л өдөр чи Бүтээгч оньсого байхаа больсныг болон Бүтээгч хэзээ ч чамаас нуугдаагүй, Бүтээгч хэзээ ч нүүрээ чамаас нуугаагүй, Бүтээгч чамаас огтхон ч хол байдаггүй, мөн Бүтээгч чиний цаг үргэлж боддог ч мэдрэмжээрээ хүрч чаддаггүй Нэгэн байхаа больж, үнэхээр баруун зүүн талд чинь хамгаалан зогсож, чиний амийг хангаж, хувь заяаг чинь хянаж байдаг гэдгийг мэдэрнэ. Тэрээр алс хол тэнгэрийн хаяанд байдаггүй, мөн Өөрийгөө өндөрт үүлэн дунд ч нуугаагүй. Тэр чиний яг хажууд, бүх зүйлийг чинь захирч байдаг, Тэр бол чиний бүх зүйл, чамд байгаа цорын ганц зүйл юм. Тийм Бурхан л зүрх сэтгэлээсээ Түүнийг хайрлаж, Түүнээс зүүгдэж, Түүнд ойр байж, Түүнийг биширч, Түүнийг алдахаас айж, Түүнээс татгалзах, Түүнд дуулгаваргүй байх, Түүнээс холдох, Түүнээс бултах хүсэлгүй болох боломжийг чамд олгодог. Түүнд анхаарал тавьж, Түүнийг дуулгавартай дагаж, чамд өгсөн бүхнийх нь ачийг хариулж, Түүний эрх мэдэлд захирагдахыг л чи хүсдэг. Чи цаашид Түүгээр удирдуулж, хангагдаж, халамжлуулж, хамгаалагдахаас татгалзахгүй, мөн чиний төлөөх Түүний захиралт, зохицуулалтаас цаашид татгалзахгүй. Түүнийг л дагаж, Түүний хажууд Түүнтэй хамт байхыг л чи хүсэх бөгөөд Түүнийг өөрийн цорын ганц амь гэж хүлээн авах, Түүнийг өөрийн цорын ганц Эзэн, өөрийн цорын ганц Бурхан гэж хүлээн авахыг л чи хүсдэг билээ.

2014 оны 8 дугаар сарын 18

БУРХАНЫ ШҮҮЛТ, ГЭСГЭЭЛТЭЭС ИЛРЭЛТИЙГ НЬ ХАРАХУЙ

Эзэн Есүс Христийг дагадаг бусад олон зуун сая хүний адилаар бид Библийн хууль, тушаалыг мөрдөж, Эзэн Есүс Христийн арвин их нигүүлслийг эдлэн, Эзэн Есүс Христийн нэрээр цугларч, залбирч, магтаж, үйлчилдэг—энэ бүхнийг бид Эзэний халамж, хамгаалалт дор гүйцэтгэдэг. Бид ихэнхдээ сул дорой, бас ихэнхдээ хүчтэй байдаг. Бүх үйлдэл маань Эзэний сургаалын дагуу байдаг гэдэгт бид итгэдэг. Тэгвэл бид бас өөрсдийгөө тэнгэр дэх Эцэгийн хүслийг биелүүлэх зам дээр байна хэмээн итгэдгийг хэлэх нь илүүц юм. Бид Эзэн Есүсийг эргэн ирэхийг, алдар суугаа мандуулан залран ирэхийг нь, өөрсдийн хорвоо дэлхийн амьдралыг дуусгавар болохыг, хаанчлалын илрэлтийг, Илчлэлийн номд зөгнөсөн бүхнийг буюу Эзэн ирж, гамшиг авчран, сайныг шагнаж, мууг шийтгэн, Өөрийг нь дагаж, эргэн ирэхэд нь угтан авдаг бүх хүнийг Өөртэйгөө уулзуулахаар агаарт өргөхийг хүсэн хүлээдэг. Энэ тухай бодох бүрдээ бид эцсийн өдрүүдэд төрж, Эзэний ирэхийг нүдээр үзэх зол завшаантай байгаадаа баярлаж, сэтгэл хөдлөлд автахгүй байж чаддаггүй. Бид хавчлага туулсан боловч хариуд нь “алдрын мөнхийн жинг үлэмж арвинаар” олж авсан билээ. Ямар гээч ерөөл вэ! Энэ бүх хүсэл тэмүүлэл болон Эзэний хайрласан нигүүлсэл нь биднийг ямагт сэргэгээр залбирч, цуглаандаа бүр ч уйгагүй явдаг болгодог. Магад дараа жил, магад маргааш, магадгүй хүний сэтгэшгүй богинохон хугацааны дотор Эзэн гэнэт буун ирж, Өөрийг нь ихэд анхааран хүлээж байсан бүлэг хүмүүсийн дунд гарч ирнэ. Бид бүгд Эзэний илрэлтийг харах эхний бүлэгт, өргөгдөх хүмүүсийн дунд багтахын төлөө нэг нэгнээсээ урьтахаар яарч, нэг нь ч ард үлдэхийг хүсдэггүй. Энэ өдрийг ирээсэй хэмээн бид үнэ өртгийг ч нь хайхралгүйгээр бүхнээ өгч, зарим нь ажлаа орхин, зарим нь гэр бүлээ хаяж, зарим нь гэрлэлтээсээ татгалзаж, зарим нь бүр бүх хадгаламжаа хандивласан. Ямар их амь бие хайргүй зориулалт гээч! Ийм чин сэтгэл, үнэнч байдал нь урьд үеийн ариун хүмүүсийнхээс ч давах нь мэдээж! Эзэн Өөрийн таалсан хэнд ч бай нигүүлсэл хайрлаж, Өөрийн таалсан хэнд ч бай өршөөл үзүүлж байдаг болохоор бидний зориулж, зарлагадах үйлс аль хэдийн Түүний нүдэнд өртсөн гэж бид итгэдэг. Бидний чин зүрхний залбирал ч мөн Түүний чихэнд хүрсэн бөгөөд Эзэн зориулалтын маань төлөө нөхөн төлбөр өгнө гэдэгт бид итгэдэг. Тэрчлэн Бурхан дэлхийг бүтээхээсээ өмнө ч бидэнд нигүүлсэнгүй байсан бөгөөд Түүний бидэнд өгсөн ерөөл, амлалтыг хэн ч булааж чадахгүй ажээ. Бид бүгдээрээ ирээдүйгээ

төлөвлөж байгаа бөгөөд мэдээжийн хэрэг, өөрсдийн зориулалт болон зарцуулалтыг Эзэнтэй уулзахаар агаарт өргөгдөхдөө солилцох арилжааны зоос, үнэт хөрөнгө болгосон билээ. Түүнчлэн бүх улс үндэстэн, бүх ард түмнийг удирдаж, хаан болж хаанчлахаар ирээдүйн сэнтий дээр өөрсдийгөө тавихдаа бид өчүүхэн ч эргэлзээгүй. Энэ бүхнийг бид болох л ёстой зүйл, зүй ёсны хүлээлт гэж үздэг билээ.

Эзэн Есүсийн эсрэг байдаг бүх хүнийг бид басдаг; тэд бүгд эцэстээ устгагдах болно. Эзэн Есүс бол Аврагч гэдэгт битгий итгэ гэж хэн тэдэнд хэлсэн юм бэ? Мэдээж бидэнд Эзэн Есүсийг дуурайн, дэлхийн хүмүүст энэрэнгүй хандах үе байдаг, учир нь тэд ойлгодоггүй, тиймээс тэдэнд хүлцэнгүй, өршөөнгүй хандах нь зөв юм. Бидний хийдэг бүх зүйл Библийн үгийн дагуу байдаг, учир нь Библи тэй нийцдэггүй бүх зүйл буруу ном, тэрс үзэл юм. Ийм төрлийн итгэл бид бүгдийн оюун санаанд гүнээ нэвчсэн байдаг. Бидний Эзэн Библи дотор байдаг, Библиэс холдон яваагүй цагт бид Эзэнээс холдох учиргүй; энэ зарчмыг мөрдвөл бид авралд хүрэх болно. Бид нэг нэгнээ урамшуулж, бие биеэ дэмждэг бөгөөд цуглах болгондоо хэлдэг үг, хийдэг үйлдэл бүр маань Эзэний хүсэлд нийцэж, бас Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж найддаг. Орчин тойрон бидэнд ширүүн дайсагнаж байсан ч зүрх сэтгэл маань баяр баяслаар дүүрэн байдаг. Маш амархан хүрч болох ерөөлийг бодох үедээ хойш тавьж чадахгүй зүйл бидэнд бий гэж үү? Хагацах дургүй зүйл бидэнд бий гэж үү? Энэ бүхнийг хэлэх илүүц бөгөөд энэ бүгдийг Бурханы ажигч нүд харж байдаг. Овоолсон өтөг бууцнаас өргөгдсөн энэхүү цөөн хэдэн зүдэрсэн хүмүүс бид Эзэн Есүсийн эгэл дагагчдын адилаар өргөгдөхийг, ерөөгдөхийг, бүх улс үндэстнийг захирахыг мөрөөдөж суудаг. Бидний завхрал Бурханы нүдэнд ил болсон бөгөөд бидний хүсэл, шунал Бурханы нүдэнд яллагдсан билээ. Гэсэн хэдий ч энэ бүхэн маш энгийн, уялдаатай байдлаар явагддаг болохоор бидний хэн нь ч хүсэл эрмэлзэл маань зөв болов уу гэж гайхдаггүй, баримталдаг бүх зүйлийнхээ үнэн зөв эсэхэд эргэлздэг ч үгүй. Бурханы хүслийг хэн мэдэж чадах юм бэ? Яг ямар төрлийн зам дээр хүн алхаж байгааг бид эрж хайж, судлахаа мэддэггүй, бүр анхаардаг ч үгүй. Учир нь бид өргөгдөж чадах эсэхээ, ерөөгдөж чадах эсэхээ, тэнгэрийн хаанчлалд бидэнд зориулсан орон байр байгаа эсэхийг, амийн голын ус, амийн модны жимснээс хүртэх эсэхээ л анхаардаг. Эдгээр зүйлийг олж авахын төлөө л бид Эзэнд итгэж, Түүний дагагч болдог бус уу? Бидний нүгэл уучлагдсан, бид гэмшсэн, аягатай гашуун дарсыг ууж, нуруундаа загалмай үүрсэн. Бидний төлсөн төлөөсийг Эзэн хүлээн зөвшөөрөхгүй гэж хэн хэлж чадах юм бэ? Бид

хангалттай тос бэлдээгүй гэж хэн хэлж чадах юм бэ? Бид тэдгээр мунхаг охид, орхигдсон хүмүүсийн нэг баймааргүй байна. Түүнчлэн Библид “Тэр үед хэн нэгэн хүн та нарт ‘Хараач, Христ энд байна’, эсвэл ‘Христ тэнд байна’ гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ” (Матай 24:23–24). хэмээсэн байдаг тул хуурамч Христүүдэд мэхлэгдэхээс биднийг хамгаалаач хэмээн Эзэнээс гуйн тогтмол залбирдаг. Бид бүгдээрээ Библийн эдгээр эшлэлийг тогтоосон, цээжээрээ мэддэг, эдгээрийг бид нандин эрдэнэ, амь, аврагдаж, өргөгдөж чадах эсэхийг маань шийдэх баталгааны бичиг мэт үздэг...

Олон мянган жилийн турш амьд хүмүүс нас нөгчиж, хүсэл эрмэлзэл, мөрөөдлөө өөрсөдтэйгөө хамт авч одсон боловч тэнгэрийн хаанчлалд очсон эсэхийг нь хэн ч үнэхээр мэдэхгүй. Үхэгсэд нэгэнтээ тохиолдсон бүх түүхийг мартаад эргэн ирж, өвөг дээдсийнхээ сургаал, замыг үргэлжлүүлэн дагадаг. Энэ маягаар он жилүүд улирч, өдөр хоног өнгөрөвч бидний Эзэн Есүс, бидний Бурхан хийдэг бүхнийг маань үнэхээр хүлээн зөвшөөрдөг эсэхийг хэн ч мэддэггүй. Бид зөвхөн үр дүн гарахыг тэсэн ядан хүлээж, болж өнгөрөх бүх зүйлийн талаар таамаглахаас өөрийг хийж чаддаггүй. Гэвч Бурхан энэ бүх хугацаанд хэзээ ч бидэнд илэрч, бидэнд үг хэлэлгүй нам гүм байсаар ирсэн. Иймээс бид Библийг даган, тэмдгүүдийн дагуу Бурханы хүсэл, зан чанарын талаар дураараа магадалдаг. Бид Бурханы нам гүм байдалд дасал болсон; биеэ авч явах байдлынхаа зөв, бурууг өөрсдийнхөө сэтгэлгээний хэв маягаар хэмжиж дадсан; Бурханы бидэнд тавьдаг шаардлагын оронд өөрсдийн мэдлэг, үзэл, ёс зүйд түшиглэж дассан; Бурханы нигүүлслийг эдэлж дассан; хэрэгтэй цагтаа Бурханаар туслуулж дадсан; бүх зүйл дээр Бурханд гар тосож, Бурханд ингэ тэг гэж тушааж дадсан; мөн Ариун Сүнс биднийг хэрхэн чиглүүлдэгт анхаарал хандуулалгүй, дүрэм мөрдөж дассан; цаашлаад бид өөрөө өөрийнхөө эзэн байдаг өдрүүдэд дассан. Хэзээ ч нүүр тулан уулзаагүй Бурхандаа бид иймэрхүү янзтай итгэдэг. Түүний зан чанар ямар болох, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Түүний дүр ямар болох, Түүнийг ирэхэд бид мэдэх эсэх гэх мэт асуултын аль нь ч чухал биш. Тэр бидний зүрх сэтгэлд байж, бид бүгд Түүнийг хүлээж байгаа нь л чухал бөгөөд Түүнийг ийм, тийм гэж төсөөлж чадаж байгаа маань л хангалттай. Бид итгэлээ үнэлж, сүнслэг байдлаа нандигнадаг. Бид бүх зүйлийг өтөг бууц гэж харж, бүх зүйлийг уландаа гишгэдэг. Бид бол суу алдартай Эзэний дагагчид учраас аян зам хэчнээн урт, хүнд хэцүү байсан ч, ямар ч

бэрхшээл, аюул бидэнд нүүрлэсэн бай Эзэнийг дагах алхааг маань юу ч зогсоож чадахгүй. “Болор шиг тунгалаг амийн усны цэвэр гол Бурханы болон Хурганы Сэнтийгээс гарч байлаа. Голын хоёр эрэгт арван хоёр төрлийн жимс бүхий амийн мод байх бөгөөд сар бүр ургац өгөхийн сацуу: модны навчис нь улс орнуудыг эдгээхийн төлөө байв. Тэнд ямар ч хараал байхаа болино: харин Бурханы болон Хурганы сэнтий байх бөгөөд зарц нар нь Түүнд үйлчилнэ: тэд Түүний царайг харна; Түүний нэр тэдний духан дээр байх болно. Мөн тэнд ямар ч шөнө байхаа болино; дэн бас нарны гэрэл ч тэдэнд хэрэггүй. Учир нь Эзэн Бурхан тэдэнд гэрэл гэгээ өгдөг бөгөөд тэд мөнхийн мөнхөд хаанчлах болно” (Илчлэл 22:1–5). Эдгээр үгийг дуулах бүрд зүрх сэтгэл минь хязгааргүй баяр баясал, сэтгэлийн таашаалаар бялхаж, нүднээс нулимс урсдаг. Биднийг сонгосонд нь Эзэнд талархъя, нигүүлслийнх нь төлөө Эзэнд талархъя. Тэрээр энэ амьдралд бидэнд зуу дахин ихийг өгч, ирэх ертөнцөд мөнх амийг өгсөн. Хэрэв Тэр одоо биднээс үх гэж хүссэн бол бид өчүүхэн ч гомдолгүйгээр үхэх байсан юм. Өө Эзэн минь! Хурдан ирээч дээ! Таныг бид үнэхээр цөхрөнгөө баран хүсэн хүлээж, бас Таны төлөө бүх зүйлийг орхисныг маань харгалзан үзээд, минут, секунд ч бүү азнагтун.

Бурхан чимээгүй байж, бидэнд хэзээ ч үзэгдээгүй атлаа Түүний ажил хэзээ ч зогсоогүй юм. Тэрээр бүхий л газар дэлхийг шинжин, бүх зүйлийг захирч, хүний бүх үг, үйл хэргийг хардаг. Тэр удирдлагаа төлөвлөгөөнийхөө дагуу, алхам бүрийг нь тооцоолон, чимээгүйхэн, сүр дуулиан болгохгүйгээр явуулдаг хэдий ч Түүний мөр алхам алхмаар хүн төрөлхтөн рүү улам бүр ойртон урагшилж, шүүлтийн суудал нь орчлон ертөнцөд аянгын хурдаар заларч, дараа нь Түүний сэнтий бидний дунд даруй бууж ирдэг. Энэ нь ямар гээч сүр жавхлант үзэгдэл, ямар сүрлэг, гэгээн дүр зураг билээ! Сүнс бидний дунд тагтаа шиг, бас архирч буй арслан шиг ирдэг. Тэр бол мэргэн ухаан, зөвт байдал, сүр жавхлан бөгөөд эрх мэдэлтэй, хайр, өршөөлөөр дүүрэн Тэрээр бидний дунд сэмхэн ирдэг. Түүний ирснийг хэн ч мэддэггүй, Түүнийг ирэхэд хэн ч угтдаггүй, мөн Түүний хийх гэж буй бүхнийг хэн ч мэддэггүй. Хүний амьдрал урьдынхаараа үргэлжилж, зүрх сэтгэл нь ч хэвээрээ байх бөгөөд өдөр хоног өнгөрдгөөрөө өнгөрнө. Бурхан бидний дунд, бусдын л адил хүн, хамгийн шалихгүй дагагчдын нэг, эгэл итгэгчийн дүрээр амьдардаг. Тэрээр өөрийн гэсэн эрэл хайгуул, зорилготой төдийгүй эгэл хүнд байдаггүй бурханлаг чанартай. Түүний бурханлаг чанарын оршин тогтнолыг хэн ч анзаараагүй бөгөөд Түүний мөн чанар, хүний мөн чанар хоёрын ялгааг хэн ч ухаараагүй. Тэр бидний нүдэнд шалихгүй итгэгчээс өөр хэн

ч биш тул бид эрээ цээргүй, айж эмээлгүйгээр Түүнтэй хамт амьдардаг. Тэрээр бидний хөдөлгөөн бүрийг ажиглаж, бүх бодол, санаа маань Түүний өмнө ил болдог. Түүний оршин тогтнолыг хэн ч сонирхдоггүй, Түүний чиг үүргийн тухай хэн ч, юу ч төсөөлдөггүй, түүнчлэн Түүний ялгамж чанарын талаар хэн ч өчүүхэн төдий ч сэжиг аваагүй. Тэр бидэнд ямар ч хамаагүй мэтээр бид эрэл хайгуулаа л үргэлжлүүлдэг...

Санамсаргүй тохиолдлоор, Ариун Сүнс Түүгээр “дамжуулан” хэсэг үг илэрхийлэв, энэ нь маш гэнэтийн санагдавч бид ямартай ч үүнийг Бурханаас ирж буй айлдвар хэмээн таниад, Бурханаас уриалгахан хүлээн авдаг. Учир нь эдгээр үг Ариун Сүнснээс гарч байгаа цагт хэн илэрхийлэх нь хамаагүй, бид хүлээн зөвшөөрөх ёстой ба татгалзаж болохгүй. Дараагийн айлдвар нь надаар, чамаар, эсвэл түүгээр ч дамжин ирж болно. Хэн ч байлаа гэсэн, бүгд Бурханы нигүүлсэл юм. Гэвч энэ хүн хэн ч байлаа гэсэн бид шүтэн мөргөж болохгүй, учир нь энэ хүн яасан ч Бурхан байж таарахгүй, түүнчлэн бид яасан ч ийм эгэл хүнийг Бурханаа хэмээн сонгохгүй. Бидний Бурхан маш агуу агаад хүндтэй; ийм шалихгүй хүн яаж Түүний оронд зогсож чадах юм бэ? Бас дээр нь бид Бурхан ирж, биднийг тэнгэрийн хаанчлал руу авч явахыг хүлээж байгаа, гэтэл ийм шалихгүй хүн яаж тийм чухал, хүнд хэцүү даалгаврыг хийж чадах юм бэ? Эзэн дахин ирвэл бүхий л олон түмэнд харагдахуйц байдлаар цагаан үүл хөлөглөн ирэх ёстой. Тэгвэл хэчнээн суу алдартай байх билээ! Тэрээр бүлэг эгэл хүмүүсийн дунд сэмхэн нуугдаж байж яаж болох билээ?

Гэсэн хэдий ч, хүмүүсийн дунд нуугдсан энэхүү эгэл хүн л биднийг аврах шинэ ажлыг хийж байна. Тэрээр бидэнд ямар ч тайлбар өгдөггүй, яагаад ирснээ ч хэлдэггүй, харин хийхээр зорьсон ажлаа зүгээр л төлөвлөгөөнийхөө дагуу алхам бүрээр нь тооцоолон хийдэг. Түүний үг, айлдвар улам бүр олширдог. Тайтгаруулах, захих, сануулах, анхааруулахаас эхлээд зэмлэж, сахилгажуулах нь хүртэл; эелдэг зөөлөн өнгөнөөс ширүүн, сүр жавхлант үг бүгд нь хүнд өршөөл хайрлаж, айдас хүйдэс төрүүлдэг. Түүний хэлдэг бүхэн бидний зүрх сэтгэлийн гүнд нуугдсан нууцыг яг онож, Түүний үг бидний зүрх сэтгэлийг хатгаж, бидний сүнснийг хатгаж, тэсвэрлэшгүй их ичгүүрээр дүүргэн, нүүрээ хийх газаргүй болгодог. Энэ хүний зүрх сэтгэл дэх Бурхан бидэнд үнэхээр хайртай эсэх, мөн Тэрээр яг юу хийх гэж байгаа талаар бид гайхаж эхэлдэг. Магадгүй энэ бүх зовлонг туулсныхаа дараа л бид өргөгдөж чадах юм болов уу? Хожмын хүрэх газар, ирээдүйн хувь заяаныхаа талаар ... толгой дотроо бид тооцоолж байдаг. Бурхан бидний дунд ажиллахаар аль хэдийн махбод болсон гэдэгт урьдын

адилаар бидний хэн нь ч итгэхгүй л байдаг. Тэрээр маш урт удаан хугацаанд бидэнтэй хамт байж, маш олон үгийг бидэнд нүүр тулан хэлсэн боловч бид ийм эгэл хүнийг ирээдүйнхээ Бурхан хэмээн хүлээн зөвшөөрөх хүсэлгүй хэвээр байдаг, мөн ирээдүй, хувь заяаныхаа хяналтыг энэ шалихгүй хүнд даатгахыг бүр ч хүсдэггүй. Бид Түүнээс амийн усны дуусашгүй хангалтыг эдэлж, Түүгээр дамжуулан Бурхантай нүүр тулан амьдардаг. Гэвч бид тэнгэр дэх Эзэн Есүсийн нигүүлсэлд л талархдаг бөгөөд бурханлаг чанартай энэхүү эгэл хүний мэдрэмжид хэзээ ч, ямар ч анхаарал хандуулж байгаагүй. Тэрээр хүн төрөлхтний гололтыг мэдэрдэггүй мэт, хүний хүүхдэрхүү зан, мэдлэггүй байдлыг мөнхөд уучлан, Түүнд хандах хүний хүндлэлгүй занг үүрд хүлцэх мэт махбодод даруухнаар нуугдан, урьдын адилаар ажлаа хийн, сэтгэлийн үгээ илэрхийлж л байдаг.

Энэ өчүүхэн хүн биднийг Бурханы ажлын нэг алхмаас нөгөө алхам руу чиглүүлсэн гэдгийг бид мэддэггүй. Бид тоо томшгүй олон шалгалт туулж, үй олон удаа сахилгажуулалт хүртэж, үхлээр туршигддаг. Бид Бурханы зөвт, сүр жавхлант зан чанарыг мэдэж авч, бас Түүний хайр, өршөөлийг эдлэн, Бурханы агуу их хүч чадал, мэргэн ухааныг үнэлдэг болж, Бурханы хайр татам байдлыг нүдээр үзэн, хүнийг аврах гэсэн Бурханы дэврүүн хүслийг хардаг. Энэхүү эгэл хүний үгээс бид Бурханы зан чанар болон мөн чанарыг мэдэж авч, Бурханы хүслийг ойлгож, хүний уг чанар, мөн чанарыг мэдэж, аврал, төгс төгөлдөрт хүрэх замыг хардаг. Түүний үг биднийг “үхүүлж”, мөн “дахин төрүүлдэг”; Түүний үг бидэнд тайтгарал авчирдаг атлаа гэмшил, өртэй мэт мэдрэмжид бас автуулдаг; Түүний үг бидэнд баяр баясал, амар амгалан бас хязгааргүй их шаналал авчирдаг. Заримдаа бид Түүний гарт нядлагдах хурганууд шиг байдаг; заримдаа Түүний нүдний цэцгий мэт байж, энхрий хайрыг нь эдэлдэг; заримдаа Түүний дайсан мэт, харцных нь дор уур хилэнд нь үнс нурам болдог. Бид бол Түүгээр аврагдсан хүн төрөлхтөн, бид бол Түүний нүдэн дэх өт хорхой, бид бол Түүний өдөр ч байсан, шөнө ч байсан олно гэж сэтгэл шулуудсан алдагдсан хурганууд нь юм. Тэрээр бидэнд өршөөлтэй ханддаг, биднийг жигшдэг, өргөдөг, биднийг тайтгаруулж, захидаг, биднийг залж чиглүүлдэг, гэгээрүүлдэг, бас биднийг цээрлүүлж, сахилгажуулдаг, тэр ч бүү хэл хараадаг. Тэрээр бидэнд өдөр шөнөгүй ямагт санаа зовж, биднийг өдөр шөнөгүй хамгаалж, халамжлан, дэргэдээс маань алхам ч холдолгүйгээр бидний төлөө бүх хөлс, хүчээ зориулж, бүх төлөөсийг төлдөг. Энэхүү жижигхэн, эгэл махбодын айлдварууд дотроос бид Бурханд байгаа бүхнийг эдэлж, Бурханы бидэнд хайрласан хүрэх газрыг

харсан. Гэсэн хэдий ч нэрэлхүү зан бас л бидний зүрх сэтгэлд төвөг удаж, бид ийм хүнийг Бурханаа гэж дуртайяа хүлээн зөвшөөрөхийг бас л хүсдэггүй. Хэдийгээр Тэр бидэнд маш их манна өгч, маш их эдлэх зүйл өгсөн боловч үүний аль нь ч бидний зүрх сэтгэл дэх Эзэний байрыг эзэлж чадахгүй билээ. Бид энэ хүний онцгой ялгамж чанар, байр суурийг асар дурамжхан л хүндэлдэг. Намайг Бурхан гэдгийг хүлээн зөвшөөр хэмээн Тэр Өөрийн амаар биднээс хүсэхгүй л бол Түүнийг удахгүй ирэх, тэгсэн мөртөө бидний дунд ажиллаад удаж байгаа Бурхан гэдгийг нь бид хэзээ ч сайн дураараа хүлээн зөвшөөрөхгүй билээ.

Бурхан айлдваруудаа үргэлжлүүлэн, янз бүрийн арга барил, өнцөг ашиглан, бидэнд юу хийх ёстой талаар сануулахын зэрэгцээ Өөрийнхөө зүрх сэтгэлийг илэрхийлдэг. Түүний үгэнд амийн хүч чадал агуулагддаг бөгөөд алхах ёстой замыг маань зааж, үнэн гэж юу болохыг ойлгох боломж олгодог. Бид Түүний үгэнд татагдаж, Түүний ярьдаг өнгө, хэв маягт анхааран, энэхүү онц гойд зүйлгүй хүний сэтгэлийн үгийг далд ухамсартаа сонирхож эхэлдэг. Тэр бидний өмнөөс ажиллахад бүх хөлс хүчээ зориулж, бидний төлөө нойр хоолоо хасан, мэгшин уйлж, бидний төлөө санаа алдаж, өвдсөндөө ёолж, бидний хүрэх газар, авралын төлөө доог тохуу болдог ба бидний хөшүүн, тэрслүү байдал Түүний зүрхнээс нулимс, цус урсгадаг. Өөр ямар ч эгэл хүн Тэр юу болох Түүнд юу байгаа шиг байдаггүй, мөн үүнийг ямар ч завхарсан хүн эзэмшиж, олж авч чадахгүй. Тэрээр ямар ч эгэл хүнд баймгүй хүлээцтэй байдал, тэвчээрийг харуулдаг бөгөөд Түүнийх шиг хайр ямар ч бүтээгдсэн зүйлд заяадаггүй юм. Түүнээс өөр хэн ч бидний бүх бодлыг мэдэж чадахгүй, бас уг чанар болон мөн чанарын маань талаар ийм тодорхой, бүрэн мэдэж, хүн төрөлхтний тэрслүү байдал, завхралыг шүүн, тэнгэр дэх Бурханы өмнөөс ингэж бидэнд үг хэлж, бидэн дээр ажиллаж чадахгүй. Түүнээс өөр хэнд ч Бурханы эрх мэдэл, мэргэн ухаан, эрхэм чанар байдаггүй; Бурханы зан чанар болоод Бурханд юу байгаа, Тэр юу болохыг Тэр бүхэлд нь илэрхийлдэг. Түүнээс өөр хэн ч бидэнд замыг зааж, гэрэл авчирч чадахгүй. Түүнээс өөр хэн ч бүтээлээс хойш өнөөдрийг хүртэл Бурханы задлаагүй нууцуудыг илчилж чадахгүй. Түүнээс өөр хэн ч биднийг Сатаны хүлээс болон завхарсан зан чанараас маань аварч чадахгүй. Тэрээр Бурханыг төлөөлдөг. Бурханы зүрх сэтгэлийн үг болон Бурханы захиас, бүх хүн төрөлхтөнд хандсан Бурханы шүүлтийн үгийг Тэрээр илэрхийлдэг. Тэрээр шинэ эрин, шинэ үеийг эхлүүлсэн бөгөөд шинэ тэнгэр, газар, шинэ ажлыг залан авчирч, бидэнд итгэл найдвар авчран, тодорхойгүй байдалд амьдарч байсан амьдралыг маань эцэслэж, авралын замыг бүрэн тодорхой харах

боломжийг бүхий л оршихуйд маань олгосон юм. Тэрээр бидний бүхий л оршихуйг байлдан дагуулж, зүрх сэтгэлийг маань олж авсан билээ. Тэр мөчөөс хойш бидний зүрх сэтгэл ухамсартай болж, сүнс маань дахин амилах мэт болсон: Бидний дунд амьдардаг, бидний аль эртнээс голж ирсэн энэхүү эгэл, шалихгүй хүн бол унтаа сэрүүний алинд ч ямагт бидний бодолд байдаг, бидний өдөр, шөнөгүй хүсэн хүлээдэг Эзэн Есүс биш гэж үү? Тэр мөн! Үнэхээр мөн! Тэр бол бидний Бурхан! Тэр бол үнэн, зам, амь! Тэрээр бидэнд дахин амьдарч, гэрлийг харах боломж олгон, зүрх сэтгэлийг маань хэрэн хэсэхээргүй болгосон. Бид Бурханы гэрт, Түүний сэнтийн өмнө эргэн ирсэн бөгөөд Түүнтэй нүүр тулан уулзаж, Түүний дүр төрхийг нүдээр үзэж, урд байгаа замыг харсан. Энэ мөчид Тэрээр бидний зүрх сэтгэлийг бүрэн байлдан дагуулсан; бид Түүний хэн бэ гэдэгт эргэлзэхээ больж, ажил, үгийг нь эсэргүүцэхээ зогсоон, Түүний өмнө нүүрээрээ газар унан мөргөдөг. Бид үлдсэн амьдралынхаа туршид Бурханы мөрийг дагаж, Түүгээр төгс болгуулж, Түүний нигүүлслийг болон биднийг гэх хайрыг нь хариулан, Түүний зохион байгуулалт, зохицуулалтыг дуулгавартай дагаж, Түүний ажилтай хамтран ажиллаж, бидэнд даалгасан зүйлийг нь гүйцэлдүүлэхийн төлөө чадах бүхнээ хийхийг л хүсдэг билээ.

Бурханаар байлдан дагуулагдана гэдэг тулааны урлагийн тэмцээнтэй адил.

Бурханы үг бүр бидний эмзэг цэгийг онож, биднийг шархдуулж, айдсаар дүүргэдэг. Тэрээр үзэл, төсөөлөл, завхарсан зан чанарыг маань илчилдэг. Бидний хэлж, хийдэг бүхнээс эхлээд бодол, санаа болгоныг маань, уг чанар, мөн чанарыг маань Түүний үг илчилж, биднийг айдаст автуулан дагжин чичрүүлж, нүүрээ хийх газаргүй болгож орхидог. Тэрээр бидний бүх үйлдэл, зорилго, санаа төдийгүй өөрсдийн маань ч хэзээ ч олж мэдээгүй завхарсан зан чанарыг хүртэл нэг нэгээр нь хэлж өгөхөд бидэнд бүх олхиогүй өө сэв маань илчлэгдсэн мэт, бүр бүрэн үнэмшсэн мэт санагддаг. Тэрээр Өөрийг нь эсэргүүцсэний төлөө биднийг шүүж, Өөрийг нь доромжилж, ялласны төлөө биднийг гэсгээн, Түүний нүдээр бидэнд сайн зүйл нэг ч байхгүй мэт, бид бол амьд Сатан мэт бидэнд санагдуулдаг. Бидний итгэл найдвар унтардаг; бид Түүнд ямар нэг үндэслэлгүй шаардлага тавьж, эсвэл Түүнээс ямар нэг юм горьдож зүрхлэхээ больдог, мөрөөдөл маань ч нэг шөнийн дотор үгүй болдог. Энэ бол бидний хэний ч төсөөлөх аргагүй, мөн хэний ч хүлээн зөвшөөрч чадахгүй баримт юм. Хоромхон зуурын төдийд л бид дотоод тэнцвэрээ алдаж, урдах замаа цааш хэрхэн үргэлжлүүлэх, итгэлээ хэрхэн үргэлжлүүлэхээ мэдэхээ больдог. Итгэл маань эхэлсэн цэгтээ буцаад очсон мэт болж, бас бид

Эзэн Есүстэй хэзээ ч уулзаагүй, Түүнийг мэддэг болоогүй мэт санагддаг. Нүдний маань өмнөх бүх зүйл биднийг төөрөлдүүлж, шийдэж ядан тээнэгэлзэхэд хүргэдэг. Бид зүрх алдаж, урам хугардаг, зүрх сэтгэлийн маань гүнд номхоршгүй уур хилэн, ичгүүр байдаг. Бид уураа гарган, гарах гарц олох гэж хичээдэг, түүгээр ч зогсохгүй зүрх сэтгэлээ уудлахын тулд Аврагч Есүсийг үргэлжлүүлэн хүлээхээр оролддог. Бид гаднаа сагсуу ч биш, даруу ч биш ажрахгүй байгаа мэт харагдах үе байдаг ч зүрх сэтгэлдээ урьд нь хэзээ ч мэдэрч байгаагүй гарз хохирлын мэдрэмжид автдаг. Заримдаа бид гаднаа ер бусын тайван юм шиг харагдаж болох ч сэтгэл санаа маань догшин тэнгис мэт тарчлан булгилж байдаг. Түүний шүүлт, гэсгээлт бидний бүх итгэл найдвар, мөрөөдлийг үгүй хийж, хэрээс хэтэрсэн хүслийг минь эцэслэн, Тэр бол бидний Аврагч бөгөөд биднийг аврах чадвартай гэдэгт итгэх хүсэлгүй болгодог. Түүний шүүлт, гэсгээлт нь Тэр бидний дунд хэний ч давахаар оролдож зүрхлэхээргүй асар гүн ан цавыг үүсгэсэн. Түүний шүүлт, гэсгээлтээр бид амьдралдаа анх удаа ийм агуу бэрхшээл, их доог тохууг туулсан юм. Бидний дэндүү олиггүй, ариун бус байдлын дэргэд Бурханы эрхэм дээд, хүний зөрчлийг үл хүлцдэг байдлыг Түүний шүүлт гэсгээлт бидэнд үнэхээр мэдрүүлсэн. Бид хэчнээн биеэ тоосон, сагсуу болохыг, мөн хүн хэзээ ч Бурхантай эн зэрэгцэхгүй, нэг түвшинд очихгүй гэдгийг Түүний шүүлт, гэсгээлт бидэнд анх удаа ухааруулсан юм. Түүний шүүлт, гэсгээлтийн дүнд л бид ийм завхарсан зан чанартайгаар цаашид амьдралгүй, энэ уг чанар, мөн чанараас аль болох түргэн ангижирч, Түүний хувьд бузар булай, жигшүүртэй нэгэн байхаа болихыг хүсэн эрмэлздэг болсон билээ. Түүний шүүлт, гэсгээлтийн дүнд л бид Түүний үгийг баяртайяа дуулгавартай дагаж, Түүний зохион байгуулалт, зохицуулалтын эсрэг тэрслэхээ больсон. Түүний шүүлт, гэсгээлт бидэнд амьд гарах хүслийг дахин нэг удаа өгч, Түүнийг Аврагчаа хэмээн баяртайяа хүлээн авахад хүргэсэн... Бид байлдан дагуулалтын ажлаас, тамаас, үхлийн сүүдрийн хөндийгөөс гарсан юм... Төгс Хүчит Бурхан энэхүү бүлэг хүмүүс биднийг олж авсан билээ! Тэрээр Сатаныг ялж, үй олон дайснаа дарлаа!

Бид бол сатанлаг завхарсан зан чанартай зүгээр л нэг эгэл бүлэг хүмүүс, олон эриний өмнө Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс, өтөг бууцнаас Бурханы өргөсөн зүдэрсэн хүмүүс билээ. Бид нэгэнтээ Бурханыг голж, ялласан боловч одоо Түүгээр байлдан дагуулагдсан юм. Бурханаас бид амь болон мөнх амийн замыг хүлээн авсан билээ. Бид газар дэлхийн хаана ч байсан, ямар ч хавчлага, гамшгийг тууллаа гэсэн Төгс Хүчит Бурханы авралаас салж чадахгүй юм. Учир

нь Тэр бол бидний Бүтээгч, бас цорын ганц золин аврал маань билээ!

Бурханы хайр булгийн ус мэт урсаж, чамд, надад, түүнд болон үнэнийг үнэхээр эрж хайн, Бурханы илрэлтийг хүлээдэг бүх хүнд өгөгддөг.

Нар сар ээлжлэн манддагийн адилаар Бурханы ажил ч мөн хэзээ ч дуусалгүй чам дээр, над дээр, түүн дээр болон Бурханы мөрийг дагаж, шүүлт, гэсгээлтийг нь хүлээн зөвшөөрдөг бүх хүн дээр явагддаг билээ.

2010 оны 3 дугаар сарын 23



ТӨГС ХҮЧИТ БУРХАНЫ ЧУУЛГАН

Сайн мэдээний вэб сайт

<https://mn.kingdomsalvation.org>



Манай вэб сайт



Апп татах

YouTube: <https://l.kingdomsalvation.org/mn/video>

Facebook: <https://l.kingdomsalvation.org/mn/facebook>

Email: contact.mn@kingdomsalvation.org